


АХА ДАРЬСҮРЭН



Онцгой Эрх

Лха.Дарьсүрэн

Онцгой эрх

НЭГДҮГЭЭР БОТЬ

Нэгдүгээр бүлэг

Буянаар халхалсан нууц хуйвалдаан

Нэг. Үхэхийн өмнөхөн ухаан ордог

Өглөөнөөс хойш шиврээ бороо шавшсан болохоор хүрээ хотын гудамжаар хүний хөл үймээн цөөн байлаа. Баруун дамнуурчингийн өмнүүр үргэлжилсэн хүрээ сайвангуудын гудамжны эхэнд байдаг нэг гуанзны үүднээс монгол, хятад үсгээр бичсэн даавуун хаяг унжуулсан нь хэн хүний нүдэнд илхэн ажээ.

Гуанзны уужим өрөөний өмнөд хэсэгт тусгайлан бэлдсэн нэг өрөө рүү усны урсгал шиг уяхан хөдөлгөөнтэй, хөнгөн алхаатай, гоолиг биетэй үйлчлэгч бүсгүйчүүд гүйлдэнэ. Тусгайлан зассан тэр өрөөнд дэн буудал бүхий энэ гуанзыг анх байгуулсан Дайзий хэмээх япон эцэгтэй хятад эхтэй нэгэн хүн, хоёр найзынхаа хамт наргиж байгаа болохоор гуанзныхан хөл алдан хөдөлсөн ажээ.

Дайзий бол дөч хэрийн насны, намхан биетэй, цайвардуу цулцгар царайтай, үзүүрээрээ монцгордуу хамар доороо нарийн ширхэгтэй хар хилэн шиг гялалзсан шиврээ сахалтай агаад алтан хүрээтэй шил зүүж, хар пүүсүүгээр хийсэн хятад тоорцог хайш яйш духлуулан өмсжээ. Дайзийгийн баруун гар талд түүнээс хоёр ах болов уу гэмээр өндөрдүү гоолиг биетэй, нэлээн царайлаг, өтгөн хар хөмсөгнийхөө доор оч шиг гялалзсан хурц сэргэлэн нүдээр юм бүхнийг нэвт шувт ширтсэн харцтай, хөр өнгийн хятад торгон тэрлэг өмссөн Цэен гүн суужээ.

Тэрээр Богд хаант улсын эхний жилүүдэд сангийн яамнаа алба хааж байсан бөгөөд Богдыг дахин ширээнд залахад гаминтай тэмцэж гавьяа байгуулсан тул гүн зэрэг шагнагдаж, гадаад яамнаа алба хаах болсон. Дайзийгийн баруун өмнөх сандал дээр хүрээн дэх английн пүүсэнд хоршсон орос худалдаачин Сафранов гэгч бавгар сахалтай, хууздуухан сэгсгэр үстэй, үзүүрээрээ хавтгайдуу улаан хамартай, согтуу байрын онигор нүдээрээ хайнгадуу мөртөө бардам хардаг, хөвчийн хар баавгай шиг лагс том биетэй баргил хүн суужээ.

Эдгээр гурван хүний яс үндэс, зүс царай, хэл яриа өөр өөр боловч бурангуй ёсны нэгэн үзүүргүй битүү зангилаа тэднийг нягт холбосон болой. Тэр бол хуучин засаг төр, эрх ямбаа хамгаалах гэсэн үзэл санаа байлаа.

- Сафранов сан (Япон хэлэнд хүнийг нэрээр нь дуудахдаа заавал сан гэдэг хүндэтгэлийн үг зүүнэ) хүүгээс чинь сурагтай юу? Ар Хиэгтын наймаачид юу гэгч болоод байна даа гэж Дайзийг асуухад Сафранов,

- Аа хөөрхий чөтгөр л мэддэг байх даа. Унгерн, Баяр гүн хоёр Хиэгтын ойролцоо хэмх нүдүүлээд гүнтэн амиа алдаж, Унгерн Галуут нуур руу хөдөлсөн сурагтай гэж дурамжхан хэлээд шилэн аягатай архиа хөнтөрч орхиод, ширээн дээрх тавагнаас мантуу авч хамрынхаа үзүүрт ойртуулан үнэрлээд уртаар санаа алдлаа.

- Аргагүй цөвүүн цаг эхэлжээ. Сүхбаатар хүрээнд зэвсгийн хүчээр орж ирвэл сүрхий юм

болох байх. Ер нь та нар юу гэж бодож байна даа? гэж санаа зовсон байдалтай асуусан Цэен гүн, Сафронов өөд гөлөрнө.

- Аа мэдэхгүй. Улс төрийн бодлогын учир тийм ч амархан олддог зүйл биш. Эхнэрээ голсон эр шиг өглөө босоход нэг нь хуучин засаг төрөө бусниулчихаад шинэ төр байгуулчихсан байдаг. Би худалдаа наймаагаа бодохоос биш улс төрийг юман чинээнд боддоггүй. Бид чинь хэнтэй ч худалдаа хийж чадна гээд Сафронов шилтэй архианаас аягалав.

- Сафронов сан, ардын засаг тогтонгуутаа хоршоо дэлгүүр нээгээд, хувийн худалдааг хааж, хөрөнгийг чинь хураагаад, гадаадын худалдаачдыг мөлжимтгий "капиталистууд" гээд хөөгөөд явуулчих байлгүй. Энэ бол улааныхны ганц шалгарсан арга гэж Дайзийг хэлэхэд Сафронов,

- Дайзий сан, тэгвэл та өөрөө яая гэж бодож байна даа? гэлээ.

- Ардын засгийг устгах хэрэгтэй. Тэгэхгүй бол нэг шөнө ч гэсэн амар тайван хонохгүй гэж мэдээрэй гэж цэцэрхсэн Дайзий хулгайн нүдээр хоёр найзаа ажиглана.

- Тэгвэл та устгаад өг л дөө гэж Сафронов Дайзийгийн амыг асуусан байдалтай хэлээд уруулаа тоомсоргүй мушилзуулан инээв. Тийм шүү ноёд оо. Дайзий сан, та Богдтой ойр дотно хүний нэг. Тэгээд Наран улсын эзэн хаанд талтай гэдэг биз дээ. Богдод айлтгаад буман шавь нарыг зэвсэглээд, шамбалын дайн босгоод, Наран улсаар дэмжүүлбэл болох юм гээд Цэен гүн Дайзий, Сафронов хоёрыг ээлжлэн харна.

- Тэр болно шүү. Гэхдээ буман шавь нарт мөрлүүлдэг буу зэвсэг олоход бэрх. Тоолдог юм хэрэгтэй. Гэтэл Унгерн, Богд хаант улсын сангийн яамны жаал зугаа юмыг ачаад явчихсан сурагтай гэж Дайзий үглэв.

- Зэр зэвсэг авах хөрөнгийг Богдын өөрийн нь сангаас гаргуулахгүй юу гээд Сафронов дахин архи аягалаад "Монгол орны инженер Гарриман хэдэн жилийн өмнө хүрээнд ирэхдээ алтны уурхайгаас малтсан олзворынхоо тооцоог хийгээд Богдтой байгуулсан гэрээний дагуу олзворлосон алтныхаа 16.5 хувийг шимтгэлд хураалгалаа гэж ярьж байсан. Бараг тонн алт өгсөн гэж байсан. Богд түүнийхээ тэн хагасыг Түвд рүү нууц илгээсэн гэлцдэг" гэхэд Цэен гүн,

- Гаминг хүрээнд ирэхээс өмнөхөн Богд сангийн яамнаас бараг хоёр түмэн алт авч, орд руугаа зөөлгөсөн гэдэг юм. Одоо богд багагүй алттай байх ёстой гэж Сафроновын саналыг дэмжив.

- Би үүнийг мэднэ. Богдыг хаан ширээнд өргөмжилсний дараа Монголор багагүй алт өгснийг мэдсэн Сайн ноён хан, Дайчин ван хоёр тэр алтыг гаргуулж, цагаан хаанаас цэргийн тусламж авья гэж зүтгэсэн гэдэг. Богд тэр хоёрыг нудруулсан нэг нууцыг үүнтэй холбож ярьдаг юм гэж хэлээд Дайзий суудлаасаа өндийхдөө "Би Богд хаантай нэг яриад үзье. Харин гүн та, монгол ноёдтой ярилцвал ямар вэ? Ялангуяа хүрээний түвдүүд, Баяр гүний харьяаны цахруудын учрыг олж тохиролцвол тэднийг хөдөлгөж болно шүү" гээд инээмсэглэхэд Сафронов хундагануудаа дүүргээд,

- Ер нь хүрээнд байгаа орос худалдаачдаар дамжуулж, Барон Унгерны сарнисан хүчийг цуглуулахад нэлээн нэмэр болно. Ингэж хүчээ нэгтгэвэл ардын засаг юу байх вэ гээд хундагаа өргөв. Цэен, Сафронов хоёрыг гуанзанд үлдээгээд гарсан Дайзий дэн буудлын эзэнтэй аминчилж уулзаад,
- Гүнтэн нэлээд согтжээ. Одоо амраасан нь дээр биз. Сафронов жаахан сууж байгаад явах байх гэхэд халзан данжаад толгой дохиод гүнгийн өрөө рүү алхав.
- Сафронов оо, Богд гэгээн Сүхбаатарт элч явуулж, зэвсгийг нь хурааж аваад, хүрээнд орж ирэхээр нь барих юм гэнэ лээ.
- Тэр нүдэн балай Богд, Сүхбаатарыг хүүхэд шиг хуурна гэж бодсон юм байх даа. Яаж санаанд нь багтаа юм бол доо гэхэд Цэен Сафронов руу дөхөж суугаад,
- Хөөе ойхио, зүүн хүрээний чадалтай дүвчингүүд додь галсангийн жинсрэг цутгах юм гэнэ. Тэгэхээр магадгүй юм шүү гэлээ.
- Цэен минь гаминг хүрээнд орж ирэхэд Богдын тааллаар зүүн хүрээ гандангийнхан гаминг устгах гэж их дөвчигнөсөн. Тэгсэн мөртлөө гамингуудыг зуудаг нохойн чинээ айлгаж чадаагүй. Ингэхээр тэр жинсрэг олигтой юм биш.
- Сахалт аа, Богд бол монголчуудын оройн сахиус, амьд бурхан. Чи дэндүү том алдаж байна шүү. Чи ч Богдын буянаар монголын хоолонд цадсан хүн. Тэгээд яаж муулж чаддаг байна даа гээд суудлаасаа өндийгөөд нударга зангатай үүдний цаана зогсоод тэдний маргааныг чагнаж байсан данжаад орж ирээд Цэенг аргадаж дагуулан гарлаа.
- Хай гүнтэн минь одоо амар даа. Их согтсон байна шүү гээд данжаад Цэенг дагуулсаар тохилог засалтай өрөөнд оруултал гаднаас нэгэн царайлаг хүүхэн орж ирлээ. Чингээд хэдэн мөч өнгөрсний дараа эзгүй өрөөнд үлдсэн хоёр амьдын жаргалд умбаснаар гүнгийн сэтгэл санааны омог аль хэдийн мартагдаж, залуу хүүхний булбарай биеийн халуун илч, хөрч хүйтэрч яваа гүнгийн биеийг дулаацуулах нь тэрээ.
- Чи явж яах нь вэ? Одоо дахиад нэг... гээд дараагийнхаа үгийг хэлж амжаагүй Цэен, залуу хүүхний гараас чангаатал,
- Одоо боллоо шүү дээ, би ядраад байна. Орой ороод ирнэ гэж өнөө хүүхэн найланхай уяхан дуугаар хэллээ.
- Тэгвэл чи миний өвөрт жаахан хэвт л дээ. Би ацаг хөлсөнд гар татахгүй шүү гэж Цэен хошуу цорвойж гуйлаа.
- Яах юм бэ? Танаас сохор зоос авч болохгүй гэж манай данжаад хэлсэн гээд гараа тавиулахыг хичээнэ.
- Би чамд мөнгө өгсөн гэж хэлэхгүй. Тэгэхээр данжаад юу мэдэх вэ гэхэд хүүхэн хаалга руу нүдээрээ ирмээд,

- Би орой ирнэ. Тэгээд шөнөжингөө... гэснээ үл мэдэг жуумалзан инээмсэглээд Цэенгийн зулай дээрээс үнсээд,

- Одоо жаахан амар гэлээ. Цэен хүүхний гарыг барьж байснаа бэлхүүсээр нь тэврэх гэтэл өнөө хүүхэн огло үсрээд,

- Би орой ирнэ гэж байхад давраад байх юм гээд өрөөнөөс гарлаа.

Цэен орны өмнөх явган ширээн дээрх гүцнээс архи хундагалаад "Архи гэдэг чинь ийм амархан гарчихдаг байжээ. Орой болтол жаахан хажуулдаг юм уу даа. Мөн сайхан хүүхнээ... Ийм амьтнаас яаж ч салах билээ" гэж өөртөө хэлснээ "Ер нь явья байз. Хориод хоног гэртээ хариагүй, өврийнхөө хэдийг хоосолчихлоо. Эндхийн данжаадаас юм зээлж нэрээ бузарлахгүй. Ууж банзалдсан ч гэсэн ухаанаа хордуулахгүй" гэж бодоод босож хувцаслав.

Цагаагчин тахиа жилийн (1921 он) зуны дунд сарын хуучдаар орсон шиврээ бороо зогсоо зайгүй цутгаад зүүн хүрээ, хотын хоорондуур урсдаг баруун Сэлбэ савнаасаа халилаа. Өглөөнөөс хойш орсон бороо үе үе ширүүсээд, хааяа татрах авч зогсох шинжгүй. Зүүн хүрээний сүм дуганы шороо тоос бороонд угаагдсан атал олон жил сэлбэн засаагүй сүм дуганы гандаж цайсан будаг шунх, өнгө үзэмжгүй зэвхийрээд, цагийн эрхээр насаа элээж өгөршсөнийг гэрчлэх агаад шашин төрийг хослон баригч Богдын хаан ширээт төр ул сууриараа ганхсаныг төдийгүй мөхөх тавиланд хөтлөгдсөнийг нотлох гэсэн шиг сүр жавхаагүй.

Зүүн хүрээний баруугаар урссан баруун Сэлбэ дээр тавьсан их бага гүүрийн нэг нь үерт урсаад ор мөргүй алга болсон тул хүрээ хотынхон жадрын том гүүрээр цувна.

Хар пүүсүүгээр хийсэн цамц, өмд өмсөж, томдсон хятад шаахай угласан Дайзий, баруун гартаа хятад хийцтэй, маажиндсан шүхэр барьж, майрганасаар жадрын гүүрээр гарч, зүүн хүрээний

Бизъяагийн аймгийн гудамжийг өгссөөр Дэчингалбыг чиглэв. Тэрээр алгуурхан гэлдэрсээр Богдын тугдангийн (ордны) шар хашааны баруун талын явган хаалганы дэргэд иртэл нэгэн халзан лам угтан уулзаад, хашааны баруун хойд талыг эзэлсэн Дэчингалбын дуган өөд толгой дохиод замчилна.

Дайзий ламыг дагасаар дуганд ортол, дуганы хаалганы баруун зүүн талаар зассан жавдангууд ярайж, хоосон ханхай сүмийн дөрвөн баганы баруун талын эхэнд зассан, алтан сийлбэртэй, олон давхцагтай олбог дээр заларч буй богдыг харсан гийчин, эзэнгүй жавдан дээр шүхрээ шидээд богд руу дөхөв. Бясалгал хийж мэлмийгээ аньсан Богд хаан, томдсон шаахай паар паар чирэгдэх чимээ дуганд тод цуурайтахыг сонсоод зовхио нээж, орчин тойрныг ажиг. Богдын эгц өмнө, зүүн талын жавдангийн эхэнд байгаа, олон давхар олбогтой суудлын гишгүүр өөд мацсан Дайзий, хүрээ цоржийн суудал дээр залраад, Богдын өөдөөс эгцлэн харж суулаа. Тэрээр Богдтой амар мэндийн зөрөө гаргалгүй, шууд яриагаа эхлэхийг хичээж,

- Богд оо, та миний үгийг анхааралтай сонсож ав! гэж хэлсэн Дайзийгийн гадаад байдал, үг ярианы өнгийг ажваас олон сүсэгтэнд "Амьд бурхан" гэгддэг Богдыг тоосон шинжгүй.

- Ардын засгийнхан өнөө маргаашгүй Баатар вангийн хүрээн дээр (Одоогийн Батсүмбэр) ирэх нь. Сүхбаатар хүрээг эзэлбэл та, хаан ширээнээс салаад зогсохгүй, монголын шарын шашныг олон үе дамжин толгойлсон түвдийн уламжлалыг алдана гэсэн үг! Тэгээд оросын цагаан хаан шиг орох гарах оронгүй болно гэж мэдээрэй! Богд оо та миний үгийг ойлгож байна уу? гэж хүрээний халх аялгуугаар асуухад Богд барсгар царайгаа үрчийлгэн, гал буурсан илчгүй мэлмийнийхээ зовхийг хөдөлгөж ядан тэргүүн мэхийлгэн дуугүй сууна.

- Улаантнууд ирээд хамгийн түрүүн сангийн яамны сан хөмрөгийг хураана. Улаан оросууд хааныхаа алтыг хураан авч улсынх болгосон. Тэгэхээр Сүхбаатар таны илүү дутууг бүгдийг хамаад улсынх болгох нь дамжиггүй. Тэгэхдээ таны саналыг харгалзахгүй гэдгийг болгоох хэрэгтэй. Үүнээс шалтгаалж Богд гэдэг алдар нэр чинь нурманд хаясан шалзнаас өөрцгүй болно. Одооноос эхэлж ухаантай хөдлөхгүй бол монголор хэмээх алтны

уурхайн нийгэмлэгээс гэрээ ёсоор шимтгэлд авсан алт чинь яйран болж, улааныхны хоол болох нь тэр дээ. Та гамин, Барон хоёрын гарт алдаагүй тэр их алтыг ардын засагт цөлмүүлж болохгүй гэж хэзээ язааны мэддэг хүн шиг ярилаа.

- Жаа, тэгвэл их хүний үгийг сонсьё гээд Богд санаа алдлаа.

- Хаант оросын генерал, сайдууд улаан оросуудад байдгаа цөлмүүлчихээд, одоо европын улсуудаас зээл авах гэж үйл тамаа барж байгааг та харж байгаа биз дээ. Цагаан хааны сайд генералууд гадаа гараад, улаан оросыг устгах гэж тавьсан дөрвөн жилийн өр зээлийг оросын хаан ширээг гурван зуун жил эзэлсэн Романовынхны сүүлчийн угсаа Николай хоёрдугаарынхтай нийлүүлбэл орос орныг хоослоод модоо бариулах хэмжээнд хүрсэн юм. Тэгээд ч Николай II сайнаа үзэлгүй Екатеринбургт (Свердловск хот) амиа алдсан шүү дээ. Та цагааны оргодол Барон Унгернд итгэх хэрэггүй.

Тэр чинь таныг хаан ширээнд залах гэж ирээгүй гэдгийг хараа биз дээ. Тэр новш таныг хаан ширээнд залсан нэр сүрээрээ монголыг тонох арга зам боловсруулсан юм. Бодоод үз дээ. Барон Унгерн шарын шашинд орсон мөртлөө бүх хүрээ хийдийн алт мөнгө, адуу малыг дээрэмдэх нууц тушаал гаргаж, гарын үсэг зурсан байна. Ийм шавь байх уу? Ингэхээр Барон Унгерний хүчинд найдаж болохгүй. Сүхбаатар хүрээнд ирчихвэл Унгерн наашаа зүрхэлж алхахгүй. Ингээд эцсийн эцэст хаан сууриа алдахгүй гэвэл таны алт чинь тус болно. Оросын сайд генералууд бэлэн зэлэн алт мөнгөгүй учраас энэ дөрвөн жилд улааныг нугасалж дөнгөөгүй юм. Бэлэн зэлэн хөрөнгөгүй бол та ардын засгийг устгаж чадахгүй.

- Жаа, их хүн та, миний үгийг болгоож хайрла. Олноогийн хоёрдугаар онд монгол ноёд шашин төрийг надаас тусгаарлахаар муу санаа өвөрлөх болсныг та мэднэ. Би тэр үед наран улсын тэнноод (Тэнгэрийн элч) захиа явуулсныг монгол ноёд мэдээд оросын хаанд алтан хошуу хүргээд, бөөн шуугиан дэгдээсэн. Үүнээс болоод ерөнхий сайд Кинмотий Соёнзигийн төлөөний хүн Кодама, мэйжи хаан Муцухито (1867-1912) бидний холбоо барилдлага хөндийрсөн. Хойтон жил нь дахиад захиа явуулсанд мэйжи исинхаан (Соён гэгээрэлтийг сэргээн шинэчлэгч) таны зэрэг хэдэн хүнийг хүрээнд ирүүлсэнд баярлаад одоо хүртэл анхныхаа бодлоос ухраагүй.

Монголын шашныг хоёрдугаар богдоос хойш Түвдийн тэнгэр язгууртай хөвгүүд тэргүүлэх

болж, тэд цөмөөрөө манжийн эзэн хааны ивээлд багтаж, хайр хишгээс нь хуваалцаж байсан. Хятадад гарсан үймээний (Хувьсгал) дараагаар манжийн төр мөхөж, цагийн байдал эргэсэн тул надад наран улсын эзэн хаан тэнноогийн хайр хишигт багтах бодол төрсөн юм. Монголын ноёд эчнээ санаа өвөрлөж байгаа үед аль нэг их улсын оролцоогүйгээр төр шашныг төвхнүүлэх гэдэг адармаатай хэрэг. Учир иймээс тэнгэрийн элч, эзэн хаан Иосихото надад туслахгүй бол би, монголын төр шашныг хослон барьсан Түвд улсын нэр сүрийг хөөдөхөд хүрнэ.

Тиймээс монголын төр шашнаас Түвдийг тусгаарлаж болохгүй. Иосихито хаантан, миний төрийг батжуулах явдалд гар сунгавал, би юугаа ч хайрлахгүй. Ганцхан төр шашныг монголчуудын гарт алдаж болохгүй гэхэд Дайзий Богдын чин сэтгэлийн үгийг сонсоод айлган сүрдүүлж, шаардан тулгах хэрэггүй гэдгийг ойлгоод ярих үгээ зөөллөхөөр шийдэв. Дайзий чингэж Богдын үгийг анхааралтай сонсож суухдаа "Богд хаан ширээгээ монголчуудад алдахгүйн тулд юугаа ч хайрлахгүй гэдэг нь илт боллоо" гэж бодоод сэтгэлдээ сэм баярлана. Богд юуны өмнө ардын засгийнхныг устгахын тулд сан хөмрөгөө хоослох нь байтугай амиа ч зориулахад бэлэн байлаа. Тиймээс Богдын сан хөмрөг Дайзийгийн аманд өөрөө ороод ирэх эгзэг бүрдсэн тул тэрээр зүрх сэтгэлээрээ шунах нь учиртай болой.

Монголын цаг төрийн уур амьсгалыг ажиглаж байсан японы тагнуулын удирдлага, Дайзийг гэнэт дуудаж, Манжуурт ирэхийг тушаасан тул түүний сэтгэл түгшиж, сэтгэлээ шаналгаасан бодолд захирагдаад аргаа баран мухардаж байв. Монголыг хаант орос, хятадаас хөндийрүүлэх талаар муу ажилласан Дайзий, манжуурт "гар хоосон" очвол амаараа шороо үмхэх аж. Тиймээс Дайзий өөрийгөө аврах нүх сүв бэдэрнэ.

Харин Цэен гүнтэй уулзсаны дараа өөртөө гурван боломж байгааг ойлгов. Тэгээд янз бүрээр эргэцүүлэхдээ "Богдын алт эрдэнээс салгавал түүнийг эзэн хааны санд хандивлаад зөвлөхүүдийн нэг болно. Харин намайг хуучин зөвлөхүүд хавчаад, нүд үзүүрлэвэл эцэстээ сохор зоосгүй үлдэж гуйлгачин болно. Тэгэхээр ийм замаар нүцгэрч болохгүй. Харин армийн удирдлагын гарыг цайлгаад, жанжин штабт ороод сүүхээтэйхэн хөдөлбөл яваандаа нэр хүнд олж болно.

Цэргийнхэн эргэлт гаргаад огцорлоо гэхэд алт эрдэнэстэйгээ үлдэж чадна. Харин гурав дахь зам бол Чаньчунгаас Гуаньдунгийн арал дээрх Порт-Артур, Дайран хот хүрсэн өмнөд манжуурын төмөр замыг хамгаалдаг дивиз хэртэй цэргийн удирдлаганд орчихвол ирээдүйтэй. Армийнхан эзэн хааны кодоог (замналыг) Азид тогтоохын тул Их газарт цэргийн ажиллагааг идэвхжүүлж, Хятадыг аваад яваандаа манжуур, ар өвөр монголыг нэгтгэх төлөвлөгөөтэй болохоор Гуаньдунгийн цэргийг арми болгоно.

Манжуур монголыг армийн мэдэлд оруулчихвал Алс дорнодын ажиллагаа идэвхжиж тэр үед генерал болж болно. Тэгээд армийнхны гарыг олигтойхон цайлгаад удирдлагыг хээл хахуулиар гартаа хийчихвэл ерөнхий сайд болж болно. Тэр үед зарцуулсан хөрөнгөө эргүүлээд авчихна. Миний тал хүч нь сулдаад огцорлоо гэхэд үйлдвэр банкныхантай тогтоосон холбоонд цав гаргахгүй. Тийм үед бүх хөрөнгөө томхон банкинд нийлүүлж хоршоод авчихвал нэр хүнд тэнгэрт мандана гэсэн үг" гэж бодно...

Дайзий Богдтой ярилцах зуураа энэ бүхнийг тунгаагаад,

- Богд гэгээнтэн минь ээ, та юуны өмнө үлэмж хэмжээний алт, эрдэнэс хятад руу гаргаж их гүрний банкинд хийчихвэл оросын сайдууд шиг өр зээлэнд орохгүй. Эзэн хаан тэнно, бэлэн зэлэн хөрөнгөтэй хүнд цэргийн тусламж үзүүлэхдээ гар татахгүй гэдгийг та гэгээн ухаандаа тунгаах биз ээ. Учир иймээс та, одоо шийдэх нь чухал гэж уянгалуулан хэлэхийг ажваас хөрөнгө түшин хөдөлж сурсан бурангуй ёсны зуйрган бодлын илрэл байсныг Дайзий өөрөө ч үл гадарлажээ.

Дайзий хүрээнд ирээд таван жил болжээ. Түүний жинхэнэ нэр Тозияа билээ. Хиагтад байгуулсан Орос, Монгол, Хятадын гэрээний дараагаар япон улс, улс төрийнхөө харааг монгол руу чиглүүлсэн нь учиртай. 1911 онд хятадад гарсан хувьсгалаар гадаад монгол хятадаас салсан нь японы сонирхлыг татсан юм. Тиймээс Япон улс Хаалганаас Хүрээ хүртэлх замыг стратегийн ач холбогдолтой гэж үзээд энэ талаар хаант оростой тохирохыг мэрийсэн юм. Чингэж чадвал япон улс, Ар өвөр монголыг нэгтгэж, өөрийнхөө эзэмшил болгох ёстой байлаа. 1912 оны зун японы элчин И.Мутоно хаант оросын гадаад яамны сайд Сазановтой нууц гэрээ хийж, монголыг таллан хуваах талаар тохиролцсон билээ. Тиймээс гурван улсын гэрээний дараагаар монголын засаг ноёдыг өөртөө татах хийгээд Нармай монгол улсыг байгуулах зорилгоор хэд хэдэн тагнуулыг Хүрээнд явуулсан юм. Тэдний нэг бол Тозияа билээ.

Тэрээр монголын засаг ноёд, нөлөө бүхий түшмэлтэй дотно танилцаж, өөртөө дасгаад японы эзэн хааны армийн зарц болгох ёстой. Тозияа хүрээнд ирэнгүүт Богдын шадар хүмүүсийн тусламжтайгаар Да хүрээнд суурьшаад Даженсан гэж алдаршсан. Энэ нь угтаа хятад хэлний их хүн гэсэн үгний эцэст япон нэрийн сүүлд залгаж дууддаг сан хэмээх хүндэтгэлийн үг зүүсэн хэрэг болой. Харин хүрээнийхэн түүний нэрийн дуудлагыг хялбарчилж, Дайжин-Дайзий гэсэн нь угтаа япон хэлний сайд буюу их хөгшин гэдэг үгийн дуудлагатай төстэй болсон нь Тозиягийн сэтгэлд тааламжтай.

Дайзий хүрээнд нэгэн буудалтай болж, гуанз нээсэн нь их учиртай. Жил бүр даншигт ирдэг ноёд баяд Дайзийгийн буудалд буух дуртай. Дайзий монгол ноёд ихсийн сэтгэл санаан дахь эчнээ бодол, тачъяалын увдисыг үл андах тул баруун дамнуурчин төдийгүй Амгалангийн гоё сайхан хүүхнүүдэд тал засаж, их хөлсөөр гарыг нь цайлгах замаар өөртөө татаад, эцэст нь өр ширээр айлган сүрдүүлж, түүнийгээ төлүүлэхийн тулд бие сэтгэлийг арилжих арганд сургажээ. Тийм хүүхнүүдийг Дайзий монголын баяд ноёдтой сүүж холбох замаар танилцуулсны дараа ноёд баядыг өөрийнхөө гарт лавхан оруулдаг болжээ. Чингээд Дайзийгийн буудал их хүрээний ихэс дээдэс, мяндагтай лам ван гүнгүүд цугладаг нууц янхны газар болсон. Ийнхүү монгол ноёдын сэтгэлийн шохоорхлыг ашиглан урхидах замаар ноёд баяд томоохон лам нарыг янхан хүүхний тэлээнээс зүүсэн Дайзийгийн гарт нэлээн лавхан орсон хүний нэг бол эдүгээ гадаад яамнаа ажилладаг түшмэл Цэен гүн ажээ.

Дайзий Цэентэй дотно танилцаад гэр орноор нь орж гардаг болсон төдийгүй эхнэрийнх нь дүү Должинд бэлэг барих нь цөөнгүй аж. Гэсэн ч Цэен гүнгийн эхнэр, дүү хоёр Дайзийгийн буудлын нууц янхнуудын талаар ямар нэг сэжиг аваагүй байна. Дайзий, Цэен гүнтэй би чи үгүй болсон хойноо жинхэнэ нэрээ хэлжээ. Тэгээд түүнд янхан хүүхнүүдийг үнэ хөлсгүй хэрэглүүлдэг болсон.

Цэен Хиагтад ардын засаг тогтож, Барон Унгерн, Баяр гүний цэргүүд сүйрснийг дуулаад гэр

орондоо тогтохоо байж, алба ажил дээрээ үзэгдэхгүй болжээ. Тэгээд албаны хүмүүстэй дайралдахаараа "Ардын засгийнханд баригдаж, шоронд орохынхоо өмнө амьдын жаргал эдэлж авахгүй бол одоо цэвүүн цаг эхэлсэн шүү" гэж тохуурхана. Цэен чингэж гэр орноосоо хөндийрч, амьдын жаргал эдлэх болсон учрыг Тозияагаас өөр хэн ч үл мэднэ.

...Хаант оросын төр эргэж, улаан оросын засаг тогтсон чимээ умраас гарч, удаж төдөлгүй хүрээнд байсан Оросын элчинг хамгаалдаг цэргүүд дур зоргоороо тарж, зарим нь нутаг буцлаа. Оросын элчин ганцаардахын эрхэнд Колчакийн засгийн газартай холбоо барьж, бие хамгаалах цэрэг гуйж, Хятадтай холбоо тогтоохыг хүссэн нь монголд гамингууд орж ирэх аятайхан далим болжээ. Энэ эгзгийг ашигласан Чин-И өөрийнхөө зүтгэлээр гамингуудыг хүрээнд ирүүлснээс хойш жил болоод Сюй Шүжангийн гамин монголд ирсэн болой.

Сюй Шүжан монголд ирээд хятадын ерөнхий сайд Дуань Цижуйн хөргөнд Богдыг сөгтгөж, мөргүүлсэн нь монголын ихэс лам нарын дургүйцлийг хүргэсэн. Чингээд Богд хаант төрийг тараасан нь эрх дархаа алдсан ноёдуудын хор шарыг буцалгав. Чингэж уур омгоо барьж ядсан ноёд Цэен гүнтэй уулзаж, японоос тусламж гуйхаар тохиролцжээ. Цэен нэгэн өдөр Тозияатай уулзаад хэд хэдэн зүйлийг сонирхуулахдаа,

- Бидний хэсэг түшмэдүүд гэгээнтний өршөөлийг дагаж, наран улсаас цэргийн тусламж авч гамингуудыг чандруу болгох бодолтой байна. Чи бидэнд туслахгүй юу гэж гуйлаа. Тозияа монгол ноёдын санаа бодлыг тунгаасны дараа холбоочноо Мугдэн рүү явуулав. Гэтэл хоёр долоо хоноод хариу ирэв. Мугдэн дэх Японы цэргийн төлөөлөгчийн дэргэд байдаг тагнуулын удирдлагаас "Кикай- боломж" гэдэг нууц нэрээр хүрээнд суугаа Тозияад доорх удирдамжийг явуулжээ.

Кикайд. Монголын ноёдыг Семеновынхонтой уулзуулж, холбоо тогтоогоод мэдэгд. Богдтой уулзаж түүний санааг тодруулж мэд. Монгол ноёдуудтай харилцах удирдамжийг жич явуулна. Мугдэн.

Тозияа удирдлагаасаа ийм хариу аваад хэд хоносны дараа Цэен гүнтэй уулзлаа.

- Цэен минь, Юань Шихайг залгамжилсан Бэйяны талыг баримтлагчдын нэр хүнд хэцүүхэн байна. Удахгүй хятадын засгийн газар өөрчлөгдөж магадгүй. Гамингуудын мөрдөлт, хавчилт их учраас Мугдэнтэй холбоо барьж чадсангүй. Би цагаан хааны оростой уулзахыг бодно. Тэр хүртэл дуугүйхэн явж бай. Ер нь өнөө шөнөдөө манайд тухтай амарч хоно гэв.

Цэен энэ шөнөөс хойш янхан хүүхнүүдийн өврөөс салсангүй. Тозияа Цэен гүнийг лавхан шиг атгахын тулд түүний эхнэрийн дүү Должинг ашиглах ёстой байлаа. Чухам иймээс Тозияа Должинг харуутаа уян зөөлөн ааш зангаар хүндэтгэн харьцаж, ихээхэн бэлэг барьж, түүний санаа сэтгэлд нууц байгаа эмзэг бодлыг хөндөхийг хичээнэ. Тозияа Должинг ирэх тоолонд ганц хоёр хундага архи өгч дасгасаар аажимдаа хоёул шил архи хувааж уудаг болжээ. Должин нэг удаа Тозияагийн үерхдэг хүүхэнтэйгээ ирж чамбайхан наргижээ. Должин согтсондоо болоод юу болсныг мэдсэнгүй. Ухаан ороод эргэн тойрноо харвал Тозияагийн өвөрт чармай шалдан хэвтэж байв.

Үүнээс хойш Должин Тозияагийн гарт орж, урхидуулснаа ухаарсангүй. Харин түүнд бие

сэтгэлээрээ дасав. Ийнхүү Должинтой бие сэтгэлийн панз үсэргэсэн Тозияа нэг удаа,

- Би чамайг Юки гэж байя гэхэд Должин зөвшөөрлөө. Энэ өдрөөс хойш Должин, Тозияагийн дөдөр алгасахгүй ирдэг болж, нэг удаа Тозияагаас,

- Чи надтай суух уу? гэж асуусанд Тозияа зүрхээ дэлбэртэл айжээ.

Тозияа, Токиогийн цэргийн академид орсон жилээ гэрлэсэн билээ. Харин төгсөөд тагнуулын албанд шилжсэн өдрөөсөө эхнэрээсээ салах замаа бодсон. Тэрээр Барга руу явахаар бэлтгэл хийж байхдаа нэг удаа гэртээ согтуу ирээд "Би Баргад тусгай сургууль хийгээд цаашаа ар Монгол руу явна" гэж сайрхсан нь эхнэрийн сэтгэлд хор шар төрүүлжээ. Эхнэр нь нөхөртөө хаягдаж магадгүй гэж бодоод жанжин штабын даргын нэр дээр захиа бичиж, Тозияаг явуулахгүйгээр шийджээ.

Тозияа согтуугийн харгайгаар цэргийн нууц алдсан явдалдаа багагүй зэмлэл хүлээгээд зогссонгүй эхнэрээ тонилгох үүрэг авчээ. Чингээд Тозияа Токиогийн цагдаагийн газар байдаг хэдэн туршуул яргачин нарт ихээхэн хахууль өгч, эхнэрээ устгуулаад ул мөргүй болгов. Гэтэл олон жил өнгөрсний хойно Должингийн амнаас "Надтай суух уу?" гэдэг үг дуулаад эхнэрээ устгуулснаа санав. Эхнэр нь Тозияатай танилцсаны дараа "Чи надтай суух уу?" гэж билээ. Тозияа энэ бүхнийг эргэцүүлээд "Эхнэрээ устгахдаа юунд ч тороогүй юм чинь энэ зэргийн банзал хүүхнийг устгахдаа зэвүүрхэх хэрэггүй" гэж өөртөө захиана. Чингэж сэтгэлийнхээ түгшүүрийг тайвшруулсан Тозияа, хүрэн дэх гамингийн цагдаагийн нэгэн бага даргатай танилцаж, нэлээн янчаан атгуулж, хэд хэдэн зүйлийг нууц тохиролцжээ.

Тозияа нэгэн үдэш Должинтой наргиж, түүнийг архинд согтоож унагаад, гэрээсээ гарч өнөө гамин даргатай уулзаад, хоёр гамин цэргийг дагуулж иржээ. Гамин цэргүүд тохиролцсон ёсоор Должингийн өрөөнд орж түүнийг хүчиндэв. Чухам энэ үеэр Тозияа гамингийн бага даргатай хамт Должингийн өрөөнд орж ирээд баахан шуугиан дэгдээв. Тэгээд гамин цэргийн өвөрт орсон Должингийн хөнжлийг хуу татан хаяж,

- Бузар янхан. Миний сэтгэлийг гашилгасан болохоор янхан хүүхнүүдийн адилаар манайд ажилла гэж түүнийг дагуулан янхан хүүхнүүд дээр орлоо. Тэгээд зогссонгүй, бүр уур омогтоо шатаж,

- Чи хүргэн ахаа хар гээд нэгэн өрөөнд оруулав. Гэтэл тэр өрөөнд Цэен гүн янхан хүүхний өвөрт хэвтэж байв. Цэен их согтсон болохоор хамаг байдгаа хамаа намаагүй дэлгэснээ ч мэдэх ухаангүй байлаа. Должин Тозияагийн бузар булайг мэдэнгүүт түүнийг үсдэж аваад хэдэнтээ сэгсчин хаалганы хавтас мөргүүлээд, байшингаас гарч, гэр рүүгээ гүйлээ. Гэтэл харанхуй гудамжинд хүлээж байсан гамингийн бага дарга, хашааны булан тойрон хар хурдаараа гүйж яваа Должингийн араас бууджээ. Тозияа өглөө нь Цэенгийн өрөөнд орж ирээд айж гайхсан нүдээр гүнг ширтэн,

- За Цэен минь, болохоо байсан даа. Урьд шөнө Должин манайд ирж хонохдоо чиний өрөөнд санамсаргүй ороод чамайг харангуут уурлаад эгчдээ хэлэхээр гүйчихлээ. Би хойноос нь очиж саатуулах гэсэн намайг барьж аваад алчих шахлаа гээд улаан булуу болсон дух, хөх няц болтлоо хавдсан нүдээ заагаад,

- За энэ ч яах вэ? Ингэхийгээд эдгэнэ. Должин хөл хорьсон цагаар явсан тул гамингийн цагдаад баригдчихлаа. Би түүнийг суллах гэж гамингийн даргаас гуйж хээл хахууль өгсөн чинь авсангүй, харин чамайг асууж байна. Тэгээд чамайг хаана байгааг хэл гэж байцаалаа. Би арга хэрэглэж, хоёр яс хагацан мултарлаа. Тэр байтугай Богд хааныг хорино гэж байна. Нөгөө талаар бидний ярилцсан зүйлийг гадарласан бололтой. Ингэхээр чи одоо хүрээнд байж болохгүй. Би эхнэрт чинь хэл дуулгаж, Должинг суллаж авахыг хичээе. Харин чи өнөөдөртөө манайхаас гарч болохгүй. Би унаа морь бэлдье. Тэгээд өнөө шөнө хүрээнээс холдохыг бод! Гэрээрээ орж болохгүй, чамайг гамингууд гэрт чинь отож байгаа гэж ятгав.

Цэен тэр шөнө хүрээнээс гарч, Батсүмбэр уулын хормойд байдаг Баатар вангийн хошуу тамгыг дайраад, Түнхэлийн хийдэд суудаг нэгэн танил ламынд очиж хоргодсоноор хэдэн сар боллоо. Харин энэ хугацаанд Тозияа удирдлагатайгаа холбоо бариад өгсөн удирдамжийн дагуу зүүн хязгаараар орж ирсэн Барон Унгернийхантай уулзав. Тозияа Бароны дэргэд байгаа япон зөвлөхүүдтэй уулзаж, хүрээний гамин цэргийн зохион байгуулалтын хамгаалалт, агуулахын талаар тодорхой мэдээ дамжуулах үүрэг аваад, хүрээнд буцаж ирсний дараа Цэен гүн рүү хүн явуулав. Цэен, Түнхэлийн хүрээнээс ирэнгүүт Тозияагийн буулаа. Тозияа Цэен гүнд тал засан хөл алдан гүйж,

- За даа чамайг явсны дараа сүйд болсон. Гамингууд Богд хааныг бариад хорьчихлоо. Муу Юкийг минь чамайг хаачсаныг хэлүүлэх гэж байцааж тамлаж байгаад алчихлаа. Ай даа мөн хэцүү байна даа гээд хэдэнтээ худлаа мэгшээд гарынхаа араар нулимсаа арчлаа.

- Гамингууд намайг хүртэл гоочлоод чамайг олж өг гэж ээрээд болдоггүй. Тэгээд чамайг хайх нэрээр хүрээнээс гарч, Тэрэлж хүрээд тэндээсээ Гүнжийн сүм орж, Барон жанжны дэргэд алба хааж байгаа япон зөвлөхүүдтэй уулзаад ирлээ. Одоо чи Барон руу оч. Өнөө шөнө эндээ амар. Гэрээрээ орох хэрэггүй. Чи энэ зургийг Барон Унгернд аваачиж өгөх хэрэгтэй гээд хүрээний тойм зургийг гаргаж өглөө. Тозияа даавуун зураг дээр байгаа таних тэмдгийн учрыг хэлж өгөөд,

- Богдыг Хайстайд хорьж байгаа. Одоо суллахад эвтэйхэн байгаа учраас тэндээс наашаа ирэх улсуудыг чи газарчилж авчирна гээд захиа бичлээ.

Цэен тэр шөнө Тозияагийн буудалд амьдын жаргал эдэлж хоноод, маргааш үүрээр хүрээнээс гарлаа. Чингээд цагаан сарын дараагаар Манзуширийн хийд дээр аваачсан Богдыг хүрээнд авчирч, хүрээнээс гаминг хөөсөн Барон Унгернийг тавдугаар Богдын догшин хувилгаанд өргөмжлөөд, Богдыг дахин хаан ширээнд залсны дараа Цэен гүн зэрэг хүртэж гадаад яамнаа ажиллах болсон ажээ.

... Дэчингалбын дуганы хойд хэсгийг эзэлсэн гүнгэрваатай олон бурхны өмнүүр олон үе эгнүүлсэн мянган зулын гэрэл дуганыг өдөр шиг гийгүүлж, бурхдын амарлингуй дүр, зулын гэрэлд тод гялалзах агаад харин дарнадын хувилгаан, гэгээнтний царай зүс барайж, бүрсийгээд доожоо муутай харагдана. Тозияа орж ирээд хүрээ цоржийн суудал дээр суухыг ажсан Богд сэтгэлдээ дурамжхан байсан атал түүнтэй санаа бодлоо солилцож "Ардын засгийг устгах" талаар Тозияатай ярилцах тусам түүнд дургүйцэх нь байтугай ярианы явцад түүнийг хүндэтгэх сэтгэл төрж, "Энэ самурайг ашиглаж, японы эзэн хаантай холбоо тогтооё" гэж бодно.

- Жаа, их хүн таны хэлснийг тунгаалаа. Ардын засаг хүрээнд ирэхдээ миний санааг дагаж мэс зөрүүлэхгүй бол учир бий. Тэгвэл тэднийг зэвсэг хэрэглэхгүйгээр нугаслаж болно гэхэд Тозияа,

- Гэгээнтэн минь, та шавь нарынхаа гарыг харах бодолтой байгаа байх. Буман шавиа зэвсэглээгүй цагт юу бол доо. Дан биеэрээ ирсэн гаминг яаж ч чадаагүй, гар хоосон байсныг мартаж цаг болоогүй баймаар. Тэгэхээр давхар хамгаалалттай ардын засгийг зэвсэг хөдөлгөлгүй дарна гэдэг ухаантай хүний үг биш гэж хэлэхэд Богд арга буюу дуугүй болов.

- Их хүн таны үгийг сайн болгоолоо. Юу ч гэсэн ардын засаг хүрээд ирэг. Тэгээд байдлыг харья. Монголчууд дэлдэж түрүүлэхээр сүүлдэж хоцор гэж сургадаг ч дэмий хоосон үг биш гэж Богдыг зүтгэхэд,

- Богд гэгээнтэн минь, би таны үгийг сонслоо. Та наран улсаас хамжаа авна гэдгээ хэлсэн болохоор таны үгийг бодож хүлээ. Уг нь би хүрээнд удах ёсгүй хүн. Манай улсаас авах цэргийн тусламжийн цар хүрээг төдийгүй зарцуулах хөрөнгийн хэр хэмжээг мэдсэн бол ардын засаг ирэхээс өмнө буцмаар байна гэж учирлав.

Үнэндээ Тозияагийн буцах явдал үүнтэй холбоогүй байлаа. Их монгол улсыг байгуулах замаар Алс Дорнод, Хятадыг эрхшээлдээ оруулах зорилготой японы цэргийн зүтгэлтэнгүүдийн ажиллагаатай холбогдож хүрээнд ирсэн Тозияа, өнгөрсөн таван жилд эзэн хааны армид дорвитой тус болсонгүй. Азид эзэн хааны дэглэмийг тогтоох гэсэн армийнханд ямар ч нэмэргүй Тозияаг Токиогоос өгсөн удирдамжийн дагуу Мүгдэн дэх удирдлага дуудсан болой. Тозияа хагас сарын өмнө хүрээнд ирсэн буухиа элчээс энэ үүргийг авсан боловч Мүгдэнд гар хоосон очихоос зүрхшээжээ. Тэгээд Богдтой уулзаж, ардын засгийг устгахын тулд японы цэргийн тусламжинд зориулах хөрөнгийн хэмжээг мэдэж чадвал тэрээр хэл амгүйхэн шиг өнгөрөх боломжтой ажээ. Тиймээс Богдтой биечлэн уулзаж буй учир нь энэ болой.

- Та улс төрийн хэргийг надаас илүү мэдэх хүн. Тэгэхээр миний үгэнд орж хэд хоногтоо хүрээнд байсан дээр. Ардын засгийг ирсний дараа танаас асууж лавлах зүйл гарч болно шүү дээ гэхэд Тозияа сэтгэлдээ чамбайхан баярлажээ. Учир нь Богд ардын засагтай тохирч чадахгүй гэдгээ мэдэнгүүт японоос цэргийн тусламж гуйж, түүнд зарцуулах хөрөнгийг бэлэн алтаар төлөх нь эргэлзээгүй байлаа. Ингэхээр Тозияа хүрээнээс явахыг яарсангүй.

- Жаа, дээрхийн гэгээнтэн минь ээ, таны соёрхлыг дагаж би хүлээ дээ гээд Тозияа, суудлаас өндийж Дэчингалбын дуганы хаалга өөд майрганан алхав.

- Ламхай чи Сүхбаатарын үгийг юу гэж бодож байна даа? гэж Богдыг асуухад түүний ордны нууцыг төдийгүй хувийн нууцыг нь хадгалж, Богдод итгэгдсэн ялгуусан лам,

- Жаа гэгээнтэн минь ээ, Сүхбаатар тийм ч амархан эр биш байна. Та хэлсэн үгийг нь болгооно биз дээ гэлээ.

- Ламхай минь би тэр үгийг одоо хүртэл бодож байна. Тун хэрсүү залуу юм даа. Хэлсэн үгийг нь бод доо! . Ноёд ихэс та бүхний даалгасан ёсоор их орос улсаас тусламжийг олж, гадаадын

харгисуудыг сөнөөж, улс орноо бүрэн бүтэн болголоо гэж байна. Сүхбаатарын энэ үгээр бол Ардын засгийг байгуулахыг би даалгасан болж байна. Монголын бүх сайд, түшмэл, ноёдуудын өмнө миний нэрийг тун овжин барьчихаад, тэдний сэтгэлийн нь уур хилэнг өөрөөсөө аятайхан зайлуулж орхилоо. Тун яггүй эр байна.

- Жаа гэгээнтэн минь, Дүйнхорын да лам хөлөө хугалчих шахан гүйгээд байсны учир бол монголын зарим ноёд, Сайн ноён хан, Дайчин ван хоёрын санааг хэрэгжүүлж монголын төр, шашны тэргүүнд монгол хүн тавих гэсэн оролдлого болох нь илэрлээ.

- Би, эднийг ийм амархан бүтээчихнэ гэж мэдсэнгүй. Эднээс түрүүлж Жалханз хутагтаас Америк руу явуулсан бичиг юмуу эсвэл Япон руу явуулах хүний хэргийг Цэцэн ван аятайхан бүтээчих болов уу гэж найдаж байсан юм. Тиймээс Да ламын авчирсан бичгийг юман чинээд тоогоогүй юм шүү. Гэтэл тэднээс Сүхбаатар өрсөж түрүүлдэг байна. Одоо тэгээд яах билээ гээд ламхайн махлаг цагаан царай өөд ширтлээ.

- Жаа гэгээнтэн минь таны таалал мэдэж дээ. Бодоогийн үгнээс үзвэл ардын намынхан таныг хэмжээт эрхт хаан өргөмжилж, хэмжээт эрхт Ардын засаг гэгчийг байгуулах янзтай байна. Тэгэхээр ерөнхий сайдын тушаалд Бодоо ч дэвшиж магадгүй юм. Ингэхээр одоохон хөдөлж, ардын засгийг газар авахуулахгүй байвал ямарсан бол?

- Ламхай минь, чиний боддог зөв байх. Гэхдээ дав дув хөдөлж болохгүй. Би гадаад нэгэн улсаас хамжаа авахгүй бол орос, монгол улаантныг цааш харуулж чадахгүй.

- Дээрхийн гэгээнтэн минь ээ, таны тааллаар бол Жалханз хутагт, Цэцэн ван хоёрын аль нь илүү найдлагатай вэ гэж асуугаад ялгуусан лам Богдод ойртож суув.

- Америк гэдэг чинь тив алгассан болохоор Хаалган дахь элчин төлөөлөгч бидэнтэй адилхан гар хоосон хүн. Тэгэхээр Жалханзаас Цэцэн ван арай илүү овжин санаа сэдсэн байна лээ. Наран улсын цэрэг Манжуурын өмнөд хэсэг Гуаньдунгийн арал дээр байдаг болохоор зэр зэвсэг нь хүртэл бэлэн шүү дээ.

- Жаа гэгээнтэн таны тааллаар болж бурхан ивээг дээ. Их наран улсын эзэн хаан тэнгэр язгууртай болохоор хайр ивээл нь бурхны ёсонд нийлнэ гээд ялгуусан лам эрихээ татаж үзлээ.

- Ламхай минь, өнөөдөр бурханч Бадрахыг олж уулзаад, өнөө шөнө ордонд ир гэж хэлээрэй. Сойвон, донир, соёгуудын аль аль нь бурханч ламыг надтай ирж уулзсаныг мэдэх хэрэггүй гэхэд ялгуусан лам толгой дохив.

Ялгуусан лам бол Богдын хамгийн дотно хүн болохоор Бизьяагийн аймгийн их ламын хашаанд нууц байдаг бурханч лам гэгддэг Бадрахыг мэддэг ажээ. Богд итгэж найддаг зүйлээ тэр ламд хэлж, түүнийг ийш тийш нь зардаг учрыг ялгуусан ламаас өөр хэн ч мэдэхгүй.

Ялгуусан лам харуй бүрий болсон хойно зүүн хүрээний Бизьяагийн аймгийн их ламын хашааг зүглэж, хаалганы дэргэд ирээд гудамжны байдлыг ажиглаад хаалгыг нь цохилоо. Их лам хөдөөлсөн болохоор бурханч лам гэрээс гарч ирээд, хашааны явган хаалганы түгжээг тайлж, ялгуусан ламыг хашаанд оруулав.

- Богд хаан таныг ордонд морилж ирнэ үү гэж хэлүүллээ. Та Шаравпилжээлингийн (Ногоон ордны) хашааны хойд хаалган дээр очоорой, би таныг хүлээж байя гэж хэлэв. Ялгуусан лам чингэж хэргээ бүтээгээд хашаанаас гарч, гудамж уруудан явсаар бараа нь харагдахгүй боллоо.

Бурханч лам, ялгуусан ламтай тохирсон ёсоор ногоон ордны хашааны хойд хаалган дээр очиж, хашаанд ороод ялгуусан ламыг бараадсаар Найдан сэмчинд орлоо. Богд бурханч ламыг ажиглангуй харснаа мутраараа адислаад,

- Жаа шавь минь, миний дэргэд суу гээд баруун гараа дохиход ялгуусан лам сүмээс гарлаа. Энэ бол хэнийг ч оруулж болохгүй гэсэн дохио байв.

- Жаа, үнэнч шавь минь, одоо цөвүүн цаг эхэлж, гал мэс харшилсан засаг төр тогтлоо. Ингэхээр би чамайг зүүн аймгууд руу явуулна. Чи өвөрлөгч газраар орж, Сөнөд, Үзэмчин, Дархан ван, Засагт, Түшээд вангуудын хошуугаар ороод ир! Тэндхийн цагийн байдлыг ажигла. Чанчунь, Мүгдэн дэх Наран улсын цэргийн дарга нартай уулзаж, бодол санааг нь мэдэх чухал! Шанхай, Бээжингээр орж, алтны ханш ямар байгааг мэдээрэй. Тэгээд ирэх жилийн цагаан сараар Сэцэн хан аймгийн Далай вангийн хошуун дээр ирсэн байх хэрэгтэй. Намайг дуудтал хошуу хүрэн дээр бай. Явахынхаа өмнө ламхайтай уулзаж, зам зуур хэрэглэх зүйл аваарай гэхэд бурханч лам хэсэг бодолхийлснээ,

- Богд хаантан минь ээ, Шанхай, Бээжингийн рийбэн (япон), пийлэн (англи) худалдаачидтай дотносож ойртох уу, хөндийхөн яваад ирэх үү гэлээ.

Богд эдүгээ 51 настай. Тэрээр таван настайдаа монголын шарын шашны тэргүүнд тодорч, эх Ойдовдуламын хамт ах дүү долуулаа ирсэн. Богдыг монголд ирсний дараа нэгэн засаг ноён, таван настай эцэг эхгүй өнчин хүүг шавь болгон өргөж билээ. Богдын эх тэр хүүг өөрийн дэргэд байлгаж байгаад хүү Балданцэрэнд сэм даалгаж өгөхдөө "Эзэн Богд Чингэс, харь нутгаас олсон хүүхдүүдийн сорыг Өүлэн эхдээ өгөхдөө өдөр харах нүд, шөнө сонсох чих болгож өгөөч гэж гуйдаг байсан гэдэг.

Тэгэхээр чи энэ жаалхүүг дүүгийнхээ өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгон өсгөж, хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзаганд хүргэж өгөөрэй" гэж захижээ. Энэ нь угтаа Балданцэрэнгийн нэр дээр ихээхэн хөрөнгө тасалж өгөх гэсэн эхийн санаа байсныг монгол ноёд эс ухаарчээ.

Балданцэрэн гүнтэн, эхийнхээ захиснаар тэр жаал хүүг өөртөө авч, хүрээний номтой улсуудтай уулзаж, манж, монгол, хятад, япон, англи хэл заалгуулахаар хэдэн хүнтэй нууц тохирсон болой.

Тэгээд тэдгээр багш нарт өгөх зүйлийг хүрээний баян жас жаваас гаргуулдаг боловч түүнийг өгдөггүй байв. Харин хүүд ном заасан багш нар алгуурхан замаар сэм алга болдог учрыг хүрээнийхэн үл мэднэ. Тэгээд арван таван нас хүрэнгүүт зүүн хүрээний Бизьяагийн аймгийн их ламын шавь болгоод, хэдэн жил болтол Далай лам Дайчин вангийн хүрээнээс Заяын хүрээг дайраад Да хүрээнд ирүүлжээ. Чингээд Богд залуу ламыг Далай ламын бараа болгож Буриад руу илгээхэд тэрээр баруун зүгээр бадарчлан явж байгаад олноогийн таван онд хүрээнд ирсэн болой.

Богд түүнийг зүүн хүрээний барханд (судар хэвлэдэг газар) өгч, нэгэн ламын шавь болгосноор зэсэн бар сийлэхдээ чадамгайг ажигласан лам нар бурханч лам гэх болжээ. Чингэж хоёр он өнгөртөл нэгэн өдөр Богд түүнийг дуудан уулзаад "Тун удахгүй Долнуур явж магадгүй. Тиймээс зүүн хүрээнийхэнд Долнуур орж буян үйлдэнэ гэж ярьж байгаарай" гэжээ. Тэгээд удаж төдөлгүй бурханч лам Долнуур орж буян үйлдэж, бурхан бүтээхээр хүрэнээс гараад тэр шөнөдөө Богдын ордонд ирж нууц амьдрах болов. Чингэж байтал нэг өдөр Хужирбулангийн орос зөвлөхүүд Богдын ордонд үзэгдэх болсноор өдөр алгасалгүй ордонд ирж, бурханч ламыг төмөр утасны ажилд сургаж, нууц эрдэм заах болсныг ялгуусан ламаас өөр хэн ч мэдээгүй билээ. Харин нэг өдөр Богдод бараалхсан Хатанбаатар гэгээнтний зөвшөөрлөөр бурханч ламтай уулзаад,

- Гэгээнтэн чиний эрдмийг надад ярьсан. Та одоо Баргын Жанчин сүм, Халуун рашаан, Вангийн сүм рүү явна. Тэнд харчин Бавуужавын цэрэг үүрлэдэг болжээ. Тиймээс тэдний байр байдал, зэр зэмсэг, хүчний хувиарлалтыг Хулстайд (Хайлааст голын хуучин нэр) сууж буй миний төлөөний хүнд мэдэгдэж бай гэж тушаажээ.

Зүүн хязгаар тайван болж, монгол цэрэг хүрээ буцсаны дараа Богд бурханч ламыг Замын-Үүдэд байдаг утасны хороонд суулгасан нь Хүрээ, Хиагт, Хүрээ Замын-Үүдийн хооронд ярилцдаг гамингийн яриаг чагнуулах боломжтой болжээ. Тэгээд Барон Унгернг хүрээнд ирсний дараа бурханч лам хүрээнд ирж, Бизъяагийн аймгийн их ламын хашаанд суух болов.

- Жаа үнэнч шавь минь ээ, чи хол ойр явж нүд тайлсан хүн.

Би ардын засагтай ганзага нийлэхгүй. Жалханз хутагт, Цэцэн ван нар гадаад улсыг түших гэсэн боловч бүтсэнгүй. Тэгэхээр би, Наран улсын тусламжийг авах санаатай байна. Чоно хонь руу гэтэхийн өмнө хэний хотонд орохоо мэддэг гэсэн. Түүн шиг би ч гэсэн хэнийг түшихээ арван хуруу шигээ мэдэх хэрэгтэй. Шанхай, Бээжингийн худалдаачдын хэнийг бараадах вэ? гэдгийг тодруулах ёстой гэж бодож байна гэхэд бурханч лам,

- Жаа гэгээн таны айлдсаныг болгоон тогтоолоо гэхэд Богд суудлаасаа өндийлөө. Чингээд ялгуусан лам, бурханч ламыг гаргаж өгөөд буцахдаа Найдан сэмчингээс гарч, давхар байшин руугаа чиглэсэн Богдыг гүйцжээ.

- Ламхай нөгөө рийбэн Тозия, монгол ноёд түшмэдүүдийн дотроос хэнтэй илүү ойр нөхөрлөдөг вэ? гэхэд ялгуусан лам,

- Гадаад яамны Цэен гүнтэй ойр байдаг юм гэлээ.

- Чи Цэен гүнтэнг аль зэрэг таних вэ?

- Хэрэгтэй бол илүү дутууг нь мэдэж бололгүй дээ гэхэд

Богд,

- Тэгвэл бүр ч сайн юм сан гээд ордныхоо довжооны шат өөд мацахад ялгуусан лам, гэгээнтний суганаас түшив.

Намрын эхэн сарын шинийн найман. Гандан зүүн хүрээний сүм дуганы үүдээр мөргөлчид ихтэй. Сүсэгтнүүд үд өнгөрөх үед Дэчингалбын дуганы хашаа руу ширтэцгээн ам амандаа "Богд цогчинд залрах гэнэ" гэж шивэр авир шивнэлдэнэ.

Богд төрсөн өдрийнхөө түнэлээр (төрсөн өдрийн хурал) өглөө эрт цогчин дуганд залардаг байсан. Гэтэл энэ жилийн түнэлээр үд өнгөрөөж ирэхэд Богдыг угтан уулзсан хүрээ гэсгүй,

- Гэгээнтэн минь ээ, Саж ламтан танд бараалхах айлтгалтай гэнэ гэж түвдээр хэлснийг хэн ч мэдсэнгүй.

- Орой сэмчин лабиранд очиг доо. Цаадах чинь яагаад эргүү төлөг шиг тойрч давхиад байна даа. Урьд нь хүнээр хэлүүлэлгүй хүрээд ирдэг байсан биш үү гэхэд хүрээний цогчин гэсгүй,

- Гэгээнтэн минь ээ, цаг төр хямарч байгаа үед Саж ламтан цагийн эрхийг дагаа байлгүй. Ардын засаг таны ордыг тойруулаад нүд чих тавьчихсан байж болно шүү гэж сэтгэлийг нь заслаа.

Богд түнэлийн хурлын орой урам муутай байлаа. Богд түнэлийн хурлын дараагаар цогчин гэсгүйгээс өргөл барьц, жас жавын хандивыг асуудаг зантай. Гэтэл энэ жилийн өргөл барьц, жас жавын хандив их хорогдсоныг дуулаад "Сүсэгтнүүд жилдээ нэг сая лан мөнгөний алба төлж, олон шавь нарын өргөл барьц чамбайхан байдаг сан. Өнгөрсөн жил гэхэд зөвхөн ордны зоог, хэрэгсэлд 30 түмэн лан (300000) мөнгө гаргасан шүү дээ. Энэ бүхэн сүсэгтний маань... жандгийн эздийн өргөл шүү дээ. Гэтэл ардын засаг анхныхаа өдрөөс эхэлж эрх дархыг минь хэмжиж, ордны уяа морьдыг цөөлж, хурал номын хэрэгслийг хаслаа. Энэ чинь яваа яваандаа намайг мод бариулж гуйлгачин болгоод, төрөөс салгасан шигээ шашнаас минь салгана гэсэн үг! Ардын засаг, засаг ноёдын цалин пүнлүүг хассан болохоор тэднийг турхирч дотроос нь тэсрэх дарь бэлдэх хэрэгтэй. Гэхдээ гоомойтож болохгүй" гэж бодно.

Богд түнэлийн үеэр төрийн дугданд байрласан болохоор Саж лам, найман талтай сэмчинд очиж Богдтой уулзав.

- Жаа гэгээнтэн минь, одоо бидний түвдүүд хүрээнд суух газаргүй боллоо. Ардын засгийнхан шашин төрийг хослон баригч оройн дээд сахиус таныг монголын сүсэгтнээс салгахыг илт хичээдэг боллоо. Бурхны зохиолоор бидний түвдүүд монголын шашинг тэргүүлж, төрийг түшилцэж хоёр зуу гаруй жил болсон. Гэтэл улаан монголчууд бидний хайр ивээлийг таягдан хаяхад хүрснийг зүгээр өнгөрүүлж болохгүй. Хүрээнд байгаа бүх түвдүүдийг зэвсэг барин босгохоор шийдээд таны гэгээн сургаалыг хүлээж байна.

- Жамъянданзан, чи тэгээд улаан оросыг нь яая гэж бодож байна?

- Ардын засгийн газрыг эзлээд Сүхбаатарыг устгавал болох нь тэр! Тиймээс Алтанбулаг руу хүн явуулж холбоо тогтоох санаатай байна. Сүхбаатар улаан орос руу яваад эзгүй байгаа энэ эгзгийг ашиглах хэрэгтэй. Түүнийг оросоос ирэхэд нь Алтанбулагт отож байгаад устгачихвал болно шүү дээ.

- Хүн хүч чинь аль зэрэг юм бэ?

- Хүрээний түвдүүдийг Баяр гүний цахруудтай нийлүүлбэл чамлахгүй хүч бий шүү. Харин зэр зэвсэг ховорхон байна. Гэхдээ түүнийг олчихож болох байх гэж бодож байгаа. Ганцхан тал айлтгал лүндгээ хайрлавал болох нь тэр!

- Би таны хэлсэн бүхнийг болгоож сонслоо. Одоо хүрээнд 300 гаруйхан түвдүүд бий. Тэгээд нийлээд 500-600 хүн цуглах юм биз. Сүхбаатар байхгүй ч гэсэн Чойбалсан гэдэг аймшиг үлдсэн. Ингэхээр гадаад улсаас хамжаа аваагүй цагт та нарын ажил хэрэг надад нэмэр болохоосоо нэрмээс болж мэднэ.

- Бодоог хөдөлгөөд гандан хүрээний шавь нараа нэг дуунаар босговол ардын засгийг яах ийхийн зуургүй устгаж болно шүү.

- Бодоо хэдийгээр надад талтай ханддаг боловч ачир дээрээ хүрвэл өөр бодолтой хүн. Аягүй бол төр шашныг хослон барих санаатай байж мэдэх хүн. Тэгээд намайг ардын засагтай хамт устгахаас ч сийхгүй толгой. Би өөр бодолтой байгаа. Тиймээс та нарыг хөдөл гэхгүй. Өөрсдийнхөө сүсэг бишрэлээр болцгоо. Ардын засгийг устгаж чадвал би та бүхнийг шагнаана. Харин гоомой хөдлөөд миний ажилд саад болбол та нарын амийг өршөөхгүй шүү. Нөгөө талаар монгол ноёдыг ятгаж баривал, гадаад яаманд байсан Цэен гүнийг уруу татаж болохгүй гэдгийг мэдэж ав гэж хатуухан зарлиг буулгажээ.

Саж лам Богдыг ятгаж дийлээгүй учраас өөрөө дангаараа хөдөлж, зул сарын 25-наас өмнө ардын засгийг устгах гэж яарсан боловч үүрнээсээ хөдөлж чадалгүй баригдсанаас хойш нэг өдөр өнгөрөөд ордны донируудын нэг Богдод бараалхахдаа

- Гэгээнтэн минь Саж ламын ачийг бодож, Бодоод айлтгаад амь хэлтрүүлбэл ямарсан бол. Гаминтай амь хайргүй тэмцэж хаан төрийг дахин тогтооход хүчин зүтгэсэн билээ. Тэгээд таны нутгийн хүн шүү дээ гэж удам угсаа, нэр төрийг нь барьж айлдав.

- Жаа... чи намайг юу ч мэддэггүй дүлий годил, харалган мануухай гэж бодоо юу. Саж ламын тэр савсгануур зан яаж төгсөхийг би мэдэж байсан гэж зандрахад долдой хочтой донирын хүзүү чих час улайгаад байх суух газраа олсонгүй.

- Би Саж ламтны зүтгэлийг бодож байгаа. Гэхдээ ардын засаг миний үгийг сонсохоос цаашгүй гэдгийг мэдэж байгаа биз гэхэд долдой донир Богдын дэргэдээс хурдан холдохоор шийдэж суудлаасаа бостол Богд,

- Намайг сурагласан хүн байна уу гэж лавлав.

- Жаа гэгээнтэн минь ээ, хүрээний Дайзий мутрын адис хүртэхээр ирсэн. Би танд айлтгая гэж бодож байсан юм гэхэд Богд толгой дохих нь түүнийг ордонд оруулахыг зөвшөөрсөн хэрэг болой.

Богд Дайзий хэмээх Тозияаг орж иртэл сэтгэлдээ "За энэ лүд одоо явна гэдэг чинь их хэрэгтэй. Тэгэхээр надаас ам дуулах гэж ирж байгаа хэрэг" бодож суутал Тозияа ордонд орж ирлээ. Тэрээр Богдтой амар мэндийн зөрөө гаргасны дараа,

- Та Саж ламтны хэргийг юу гэж бодож байна даа гэсэн нь Богд гэгээнийг гайхахад хүргэлээ.

- Тозияа сан Саж ламыг ардын засаг өршөөх эсэхийг мэдэхгүй. Ямар ч гэсэн оролдоод үзнэ. Харин та яая гэж бодож байна гэж асуув.

- Бодоо, би түүнийг танихаас цаашгүй. Түүнийг гамингаас суллах үед надтай уулзсан юм даг. Тэр үед Саж лам барон Унгерний сүүдэр болчихсон үе байсан. За тэр яахав. Харин Бодоо өөр бодолтой байгаа бололтой. Тэр Жаа ламтай нийлж, Ховд, Улиастайг хамчихаад, Хүрээг цэвэрлэчихэж мэдэх шүү. Нөгөө талаар Бодоо, Данзан, Сүхбаатар гурав шуудайд хийсэн үхрийн эвэр шиг тар тур хийгээд байгаа явдлыг ашиглаж баймаар санагдах юм. Энэ бол танд ашигтай юм шүү.

- Бодоогамин, жааламхоёрыг долоочих шахаж байсан удаатай. Үүнийг ардын засаг мэдээд алба тушаалаас нь огцруулаад, намын гишүүнээс хөөхийн даваан дээр байна. Тэгээд сонинд "Намын суртлыг бузарлагч" гэж нэрлэснийг үзээ биз дээ. Ингэхээр балрах зам мөр нь тодроод байгаа хэрэг. Түүнийг том хэргэм зэрэгтэй ерөнхий сайд болсныг бодоод хүрэн жинс шагнасан маань ардын засагт сэжиг төрүүлчих шиг боллоо. Тэгээд ч Бодоо бүтэлтэй хүн биш. Данзан бол Жанчхүүгийн өндөр хамартанд /Америк ноёд/ тал засаад хөлөө хугалчих шахаад байгаа хүн. Тэгэхээр энэ гурав бие биентэйгээ нийлэхгүй нь илэрхий. Бодоо, Данзан хоёр хөдлөөд үзэг. Хийгүй хөдлөөд ардын засгийг устгачихвал сайн хэрэг. Гэхдээ би тэр хоёрын хэнд ч найдахгүй байна. Харин бид бол хий гаргалгүй хөдлөх хэрэгтэй. Тиймээс эдний эгзгийг олж харах нь чухал.

- Богдоо би, таны саналыг тааламжтай сонслоо. Би удахгүй буцна. Тэгэхээр та намайг явахаас өмнө нэг юм хэлнэ гэсэн байхаа гэж Тозияа эвтэйхэн асуугаад инээмсэглэв.

- Жаа тиймээ. Би Наран улсын эзэн хааны ивээлд багтах бодолтой байгааг та мэднэ. Гэтэл өмнөд манжуурын төмөр замыг хамгаалж байгаа Наран улсын цэрэг Гуаньдунгийн арал дээр түм хагасаас илүүгүй байдаг. Ардын засгийг устгахад наанадаа гурван түмэн цэрэг хэрэгтэй. Ингэхээр Наран улсын цэргийн боломжийг урьдаар дуулмаар байна. Энэ чинь алтнаас үнэтэй зүйл шүү гэхэд Тозияа сэтгэлдээ "Энэ харалган түвдийг монгол ноёдууд балай, маанаг гэдэг. Гэтэл энэ чинь их талын бодолтой хүн юм. Монгол ноёдын аль нь ч гэсэн Ляодунгийн өмнөд хэсэг Гуаньдунгийн арал дээр байгаа манай цэргийн тоог мэдэхгүй. Гэтэл Богд Чаньчунгаас Дайран хүртэлх төмөр замыг хамгаалдаг япон цэргийг мэдэж байгааг хараач. Богдын харалган нүд, хатуу чихийг онгойлгодог тусгай хүн байх нь ээ. Естой нохой хамартаа ус хүрэхээр усч болдог гэж ярьдаг. Богд монголын төр, шашныг алдахгүйн тулд оюун ухаанаа их шавхаж байна даа" гэж бодов.

- Богдтон минь би төрийн тэргүүн биш. Ердөө л эзэн хаандаа үнэнч нэгэн албат. Тэгэхээр зэр зэвсгийн талаар дур мэдэн хэлж чадахгүй.

- Наран улсын эзэн хаан хэдий чинээ зэр зэвсэг, цэрэг гаргаж чадна, тэр чинээгээр алт гаргаж чадна. Тиймээс би өөрийнхөө төлөөний хүнийг илгээхэд ч бэлэн байгаа.

- Тэгвэл таны төлөөний хүнийг хүлээн авч уулзах хоног өдөр, нууц дохиог тохиролцвол ямар вэ?

- Тозияа минь миний төлөөний хүн таныг хаанаас ч олоод уулзаж чадна. Харин түүнийг очиж уулзахаас өмнө эзэн хаандаа миний хүслийг уламжилж шийдчихсэн байвал сайн юмсан гэхэд Тозияа албан ёсны яриа дуусч байгааг мэдээд,

- Тэр тухайд би хичээн зүтгэнэ гэлээ.

Богд Тозияатай ингэж уулзсанаас хойш сар болоод нэгэн өдөр ялгуусан ламыг дуудаж уулзаад "Бурханч лам руу илгээх хүн ол. Тэгээд хүрээний рийбэн ноёнтон цагаан сараар буцна. Ирэхдээ түүнийг ямар олзтой байгааг мэдэж ир гэж захиарай" хэмээн даалгав.

Усан хар нохой жилийг (1922 он) хүрээ зурхайчид төр шашин, ихэс дээдэст түйтгэртэй жил гэж айлдсан нь Богдын чихийг дэлсэхгүйгээр өнгөрсөнгүй. Саж ламын дараагаар Бодоогийн хэрэг дэгдлээ. Богд ардын засгийг талархдаг хийгээд түүнийг түлхэн унагахыг боддог хүмүүсийн "тарыг таних" нэг аргаа хүрээнд хэвлэдэг "Уриа" сонин гэж үздэг. Тиймээс ордны сойвон, донир нартаа сонин уншихыг хатуу зарлиг болгожээ.

Богд өөрийнхөө донир, сойвонгуудаас итгэлтэй хүмүүсийг сонгож, халхын засаг ноёдын үзэл бодол ааш араншинг нь сураглуулж "алтан хошуу" хүргэсэн хүмүүст хишиг хайрлаж, заримдаа цол шагнана. Богд энэ аргаа хаан ширээнд заларсан үеэсээ л хэрэглэжээ. Богд хов зөөдөг тийм хүмүүстээ "зоригт, шадар, дураал" гэдэг цол өгдөг. Үүний учрыг мэдсэн хүмүүс шадрыг нь харалган, зоригтыг нь тэнэг, дураалыг долдой гэж хочилдог болсон. Ардын засаг тогтсоноос хойш Богдын харалган, тэнэг, долдой нар хүрээ хотын илүү дутууг Богдод дуулгаж, харалган нүдийг гэгээрүүлж, хатуу чихийг нь сонортой болгоно.

- Жаа дураал донир минь, хүрээний сонинд юу гэж бичиж байна даа гэж Богд өглөө бүр Долдой дониороос асуудаг заншлаараа лавлав.

- Хүрээний сонинд Японы нууц хэлэлцээ гэдэг зүйлийг тайлбарласан нэг өгүүлэл бичсэн байна. Түүнд Орос, Японы гэрээгээр (1905 оны Портсмутын гэрээгээр) Жирмийн чуулганы дундуур урсдаг Туур голоор Монголыг зааглан хаант орост өгөхийг Наран улс зөвшөөрсөн нууцыг илчилжээ.

- Жаа тэр Туур гол чинь хаагуур байдаг юм бэ?

- Туур гол бол Харбины баруун талд байдаг Юэлянпао гэдэг нуураас эх аван урсаж Вангийн сүмийн зүүгээр гарч, Хянганы нурууны хөндийг даган Халуун рашаанаас холгүй байдаг Эрс (Ирзши) гэдэг хотын дэргэдүүр Халх голтой нийлдэг их гол шүү дээ гэхэд Богд толгой дохив.

- Наран улс тэр хэлэлцээний дагуу өмнөд Манжуурыг авсны адилаар цагаан оросын хулгай нар (Барон Унгерн) -ыг турхирч Монгол орныг эзлүүлэхийг хичээхдээ монголыг наран

улсын цэргийн боомт газар болгож, цэргээ суурьшуулах нууц төлөвлөгөөтэй байсан. Одоо ч гэсэн тэр бодлоо орхихгүй байна гэж бичжээ. Гэтэл бас нэг сонинд "Жан Золингийн хунхууз нар (дээрэмчид) Монгол орныг дахин хятадын мэдэлд захируулж, манай газар усыг эзэмшүүлэх нууц бодлого өвөрлөсөөр байна" гэж хатуухан бичжээ гэтэл Богд,

- Жаа та, одоохон ялгуусан ламыг дуудчихаарай гэхэд Долдой донир ордноос гарлаа.

... Сүхбаатар яах аргагүй алсын бодолтой, тун холыг хардаг хүн юм даа. Тэр жил Хужирбулангийн орос зөвлөх харчин Бавуужавын цэрэгтэй байлдсан тухай айлтгал өргөхдөө цэргийн нууц эрдэмд гоц авьяастай гэж онцлоод байсан. Хатанбаатар ч түүнийг нотолж билээ. Бурханч ламыг Хатанбаатарын даалгавраар Вангийн сүмд суулгахад тэрээр Сүхбаатартай нэг удаа уулзсан байсан. Тэрээр барга Дамдинсүрэн гэгч хулгайн нуугдаж буй газрыг Сүхбаатарт зааж өгөхдөө хэрсүү хүн гэдгийг ажигласнаа ярьж билээ. Тэгэхээр Сүхбаатар цэргийн нууц эрдэмд (тагнуулд) нэвтэрхий гэдэг нь үнэн байх. Тиймээс өөрийнхөө шавийг Манжуурт илгээж, Наран улс, Жан Золингийн балгийг мэдэж чадсан хэрэг. Харин Тозияа, бурханч лам хоёрыг мэдээгүй нь их юм.

Богдыг ингэж бодож суутал гаднаас ялгуусан лам орж ирлээ.

- Жаа ламхай минь, бурханч ламаас сураг чимээ гарч байна уу гэж асуухад ялгуусан лам хоолойгоо засаад,

- Далай вангийн хошуу хийд дээр заларч байгаад наашаа гарсан. Хоёр гурав хоногоос ирнэ байх гэлээ.

- Ламхай минь ирэнгүүт нь надад дуулгаарай. Одоо Бизъяагийн аймгийн хашаа руу явуулсны хэрэггүй. Цагаан сүмд гэр барьж суулгавал олны нүд, чихнээс далд амар байх биз. Харин өнөө Цэен гүний тухай юу болж байна.

- Би болгоон бодсон. Одоо нэг хүнтэй уулзсаны дараа Цэен гүнгийн талаар айлтгая гэж бодож байна гэхэд Богд,

- Түргэн тусмаа сайн шүү гэлээ.

Голын цагаан сүм буюу Гунгаадэжидлин гэж алдаршсан сүмийн хашаанд найман ханатай гэр барьсан нь цагаан дарь буюу богдын хатны анхаарлыг санамсаргүй татжээ. Сүүлийн гурван жил Богд ялгуусан ламыг өөрийнхөө дэргэдээс салгасангүй.

Үүнийг ажигласан хүмүүс "Манай Богд хаан юм уу, Ялгуусан лам хаан юм уу?" гэж сэм ярьдгийг хатантан мэднэ.

Богд гамингийн гараас мултрад, Манзуширийн хийд дээр өвгөн лавринд залрахдаа цагаан дарийг лавринд оруулдаггүй мөртлөө ялгуусан ламыг өөрийн дэргэд байлгадаг байв. Харин хаан ширээнд дахин заларснаас хойш ялгуусан ламыг шарилын сүмд (Чойжин ламын сүм) суулгажээ. Тэгээд ардын засгийг хүрээнд ирсний дараа ялгуусан ламыг ордонд авчирч юм хумаа мэдүүлэх болов.

Цагаан сүмийг богдын хатны бясалгалын сүм болгосон болохоор тийшээ очих хүн тоотой. Харин ламхай сүүлийн хэд хоног цагаан сүмээс салсангүй. Тэрээр хааяа богдын хатантай хашаанд дайралдах боловч нүүр буруулан холдоно. Богдын хатан өөрт нь дуулгаж, зөвшөөрүүлэлгүйгээр ордонд нь гэр бариулж байгаад дотроо уурласан төдийгүй "Хааны

оронд хаан болсон ялгуусан ламыг" оролдож цаашлуулахаар шийдлээ. Тэгээд эмэгтэй хүний овжин ухаан, арга заль гаргаж, оройхон хэрд ламхайг хаждын сүмд дуудаж уулзав. Хатан сүүлийн үед хаждын дом хийж, нэгэн сүмийг хажид бурхны зан үйлээр төхөөрөмжлүүлсэн болохоор түүнийг хаждын сүм гэх болсон. Сүмийн голд шавраар урлаж, час улаан өнгөөр будсан ур сайтай нүцгэн хажид (Эмэгтэй бурхан) босгон залжээ. Дуганы хойд талын ханаар хаждын догшин дүрийг урласан дэлгэмэл бурхан өлгөсөн аж.

Махалж мариа суусан хатан өргөн нүүрэндээ нэн зохисон аальгүй нүдээр ламхайг ширтэн,

- Ламхай гэр барьж яах нь вэ? Гэгээнтэн энд залрах нь уу гэлээ.

- Жаа хатантан минь, би учрыг мэдсэнгүй. Бодвол таны таалалд нийлүүлэх гэсэн байлгүй дээ.

- Хмм. Харин та бид хоёрын таалалд тааруулах гэж бодсон бол яана гэж хэлээд хөмсгөө өргөн инээмсэглэснээ олбогноосоо босож, лам руу гэлдрэхдээ "Лхамын нямба сахиад хордчихлоо. Тэгээд хороо тайлж чадахгүй байна" гэж найланхай тачаангуй дуугаар хэлэхэд ламхай нүдээ тас аниад "Одоо яадаг билээ. Хаждын дом хийж, лхамын дульба сахиж хордсон эм хүнийг эр хүн таалж тайтгаруулдаг юм гэсэн. Одоо намайг барьж аваад нүцгэлээд унах байх даа" гэж бодоод эрихээ шаржигнуулж маани уншив. Гэтэл хатантан ламхайн дэргэд ирээд түүнийг шууд тэвэрч аваад уруулыг нь хэдэнтээ хүчтэй озож, амьсгаа давхцтал хөхөж байснаа шүдээрээ сулхан хазтал ялгуусан ламын уруул өмөрчих шиг болсонд дотроо "ёо ёо" гэж хэлээд харвал хатантан инээмсэглэсээр зогсож байлаа.

- Хатантан минь, яаж л байна даа. Би чинь сахил санваартай гэлэн шүү дээ. Энэ чинь надад алдас болно. Та намайг энэ сайхан. шунал шүглэсэн тачаангуй нүдээр битгий хараач дээ гэж уйлагнасан дуугаар арай ядан хэлтэл хатантан, тачигнатал хөхрөөд,

- Ламхай минь би тийм их тачаангуй байна уу. Тэгвэл лхамын дульбанд их хордсоны шинж дээ. Ингэж хордсон эм хүний хорыг гаргаж өгсөн лам хүний хилэнц арилж, буян болдог гэж номлодог. Би хоосон хөндий сүмд ганцаараа олон хоноод залхаж гүйцлээ. Надад одоо та л ойрхон байна. Гэгээнтэн миний хорыг мэдээд таныг над руу явуулсан байлгүй. Тэгэхээр айх хэрэггүй гээд хатан, ламхайн гараас хөтлөн хажид сүмийн дээд давхарт байдаг нямбаныхаа өрөө рүү алхахад ялгуусан лам арга буюу хөтлөгдөн дагав. Хатантан сүмийн дээд давхарт орж ирээд ханын дэргэд зассан лавир руугаа очингуут дээлийнхээ бүсийг тайлахаар завдав. Хатан хөшөө шиг зогсож буй ламхайг харснаа түүний мөрөн дээр хоёр гараа тавьж хүзүүдэн тэврээд дахин үнссэнээ эрхлэнгүй дуугаар,

- Ламхай минь, миний дээлийг тайлаач дээ. Би эр хүнээр хувцсаа тайлуулах дуртай гэхэд ялгуусан лам амандаа "Одоо яана аа. Нэгэнтээ лхамын нямба хийж хордсон эмийг эр хүн таалж хорыг нь гаргадгаас хойш одоо яая гэхэв" гэж бодоод таж магнаг дээлийг тайлтал хамаг биеэр нь цахилгаан зай гүйх адил ирвэгнэн, халуу дүүгэн шатах шиг болж, чичигнэхийг ухаарсан ламхай, тачаангуйн дөлөнд өртсөнөө ойлгоод, хатантны тунгалаг царайг ширттэл аальгүй харцтай нүд жоотийхоороо жоотийж, тачаангуйн агаар илэрнэ. Чингэж хэдэн хором өнгөрсний дараа ламхай эм хүний халуун илчинд мансуурч, алаг цоог хорвоогийн нүгэлт амьдралын жам ёсыг даган хатантны өвөрт тэнхээ сульдэн хэвтэхдээ айх аюулаас алслагдсанаа ухаарчээ. Ламхайн ёсорхог албархуу мөртлөө далдирамхай хуурамч ааш зан аль

хэдийн сарниад, гагцхүү эм хүний эрхлэмтгий, найланхай, шалиг явдалд уяран хайлж, бүсгүй хүний булбарайхан зөөлөн биеийг тэврэн шалиглахыг эрхэмлэнэ. Тачаангуйн нүгэл хилэнц, садар самуун бүхэнд дадсан хатан, ламхайн нүцгэн цээжинд хацраа наалдуулан эрхэлж, хааяа нимгэн уруулаа цорвойлгон хацар, уруулыг нь үнсэн таалахад дарь эх хэмээгчийн ааш араншинг сэтгэлдээ тунгааж хэвтсэн ламхайн дотор "Хатан эрсийг ийм замаар аргандаа оруулдаг шидтэй байжээ. Хүрээний үсчин хужаа нарын эрлийз залуусаар үсээ янзлуулж, засуулах нэрийдлээр ордонд авчирдаг байсан. Тэд хоёр, гурав хоног ордонд байдгийн далд учир увдис ийм байжээ. Дондогдулам ийм замаар хужаагийн эрлийзүүдээс багагүй хөлс авдаг байсан болохоор тэр аргаараа намайг урхидаж, Богдын алт эрдэнэсийн сургийг гаргаж мэдэх гэсэн хэрэг. Хэрвээ надтай наалдсанаа ашиглах гэвэл хужаагийн эрлийз залуустай сүүж холбож байсныг нь түрүү барьчихдаг хэрэг! Тэгвэл дарь эх нэрээр бузар булайгаа халхалсан нүгэлт эм намайг яаж ч чадахгүй" гэж бодлоо. Чухам энэхэн үед сүмийн доод давхрын хаалга чахран дуугарах чимээ ханхай сүмд тодоос тод сонсогдсонд ламхай хөнжлөөс сугарч яаран хувцаслав. Гэтэл удаж төдөлгүй хаалга зөөлөн тогших чимээг сонссон Дондогдулам,

- Хүлээж бай! хэмээн омогдонгуй хэлээд орноосоо босож сая хувцаслав. Чингээд гүнгэрваатай бурхны өмнүүр зассан олбог давхцаг дээр заларч, хэдэн судар дэлгээд царайгаа түвшин болгон амарлингуй дүртэй суухдаа товшуур дамар авч тачигнуулан дуугаргатал хатны дэргэд зарагддаг соёг (үйлчлэгч) эмэгтэй гаднаас орж ирлээ...

Цагаан сүмийн хашаанд найман ханатай гэр барьснаас хойш Богд хэд хэдэн удаа заларсан болохоор хэн ч сэжиг авсангүй. Харин хэд хоносны дараа нэгэн орой дөнгөж дөч гарч яваа залуувтар овортой эр ирж гэрт байрлах болсныг сүмийн цонхоор харсан Дондогдуламын сэтгэлд нэгэн бодол төржээ. Богд Цагаан сүм дээр донир, сойвонгуудаасаа хэнийг ч байлгасангүй. Хаалгачаас гадна ламхай Богдын дэргэд бараа болно.

- Жаа үнэнч шавь минь, явсан газрынхаа сонинг яриач гэхэд хятадаар хэдэн сар хэрэн бадарчилж явсан бурханч лам,

- Тозияа ноёнтон Мугдэнд суурьшсан Наран улсын эзэмшлийн цэргийн газарт ажилладаг зөвлөхүүдийн нэг болж хурандаа цол хүртжээ. Наран улсын эзэн хаан Иосихито хүндээр өвчилсөн болохоор хүү Хирохито эцгээ орлон улсыг тэргүүлж байгаа боловч түүнийг хаан болгох зарлиг гараагүй байна гэж яриагаа эхлэв.

- Хаан хүүгийн сүүдэр нас нь хэд хүрч байгаа юм бэ?

- Төмөр цагаан үхэр жил төрсөн юм гэхэд Богд зүүн гарын алгыг дээш харуулаад гурван хурууны дотоод есөн үеийг тоолж үзсэнээ,

- Энэ жил хорин нэгэн настай юм байна гэлээ.

- Цэцэн вангийн захиа Наран улсын хаанд хүрээгүй харин цэргийн яамны сайд Гийчий Танакагийн хүмүүсийн гарт оржээ. Танака танаас зургаа ах хүн. Тэрээр 1918 оноос хойш цэргийн яамыг толгойлж байгаад саяхан сайдаасаа огцорсон байна. Хүрээний зарим хүмүүс Жанчхүүд байгаа Америкийн төлөөлөгч болон Жан Золингийн хүмүүстэй холбоо тогтоож тусламж гуйсан боловч хэн хэн нь гахай жилээс (1923) нааш тусалж чадахгүй гэсэн бололтой.

Харин Гуаньдунд байгаа Дайрангийн япон цэргийн бүрэн эрхт төлөөлөгчтэй уулзвал Наран улсаас манайд үзүүлэх цэргийн тусламжийн талаар бүрэн ярилцаж болох юм байна. Учир нь Наран улс Гуаньдунгийн арал дээр байгаа эзэмшлийнхээ цэргийг нэмэгдүүлж тусгай арми болгох зорилготой гэдэг нь илэрхий болсон.

- Шанхай Бээжингээр ямар янзтай байна даа. Ямаршуухан угтав?

- Бээжин, Шанхай, Тяньжин дахь гадаадын томоохон нэгдэл, нийгэмлэгүүд өөрийнхөө хөрөнгийг Тяньжингийн англи банкинд хадгалуулдаг юм байна. Харин Шанхайд байгаа их гүрнүүдийн банк бол их найдвартай, баталгаа сайтай газар гэж ярилцдаг бололтой гэхэд Богд сэтгэлдээ "Би алт эрдэнэсээ Түвд рүү явуулж байхын оронд Шанхай руу илгээдэг байж дээ. Гэхдээ одоо оройтоогүй. Хүн үхэхийн өмнө хамаг юмаа ухаардаг гэдэг үнэн юмаа даа. Ардын засаг хүрээнд ирээгүй бол би, монголын ноёдод найдаж байгаад сүүлд нь бөгсөн дээрээ хүйтэнхэн жин тавиулах байжээ. Харин бурхны ивээлээр бурханч ламыг эх, ах хоёр минь өсгөж өгсөн нь аминд орлоо. Тэгээгүй бол би монголын шашинг толгойлж ирсэн Түвдүүдийн нэрийг бузарлах байж. Ардын засгийг устгаад авбал монголын засаг ноёд надтай төр, шашны эрхийг булаалдахгүй болно" гэж бодно.

Ардын засгийн анхны баяр наадам их сүртэй, өргөн дэлгэр болсон нь Богдын сэтгэлд таалагдаагүй боловч тэрээр сэтгэлийнхээ уур омог, атаа жөтөөг нүүр царайндаа илчлэхгүйг хичээж, шүд зууж өнгөрөөлөө. Баяр өнгөрсний дараа Сүхбаатар цэргийн зөвлөлийн дэргэд дотоодыг хамгаалах газар байгуулсан нь Богдын сэтгэлийг сэрхийлгэв. Тэр тусмаа зүүн хязгаараас Нанзадыг дуудан ирүүлж орлосон дарга болгосон нь Богдын зүрхэнд хурсан шар усыг хөдөлгөж, бухимдуулах болжээ.

Нанзад бол Түшээт хан аймгийн Содномдорж засгийн хүн. Хар цэргийг дарахад оролцож, цэргийн нууц эрдэмд шалгарсан аж. Нанзад Саж ламын сэдсэн хэргийг гадарлаад хүрээнд байсан Баяр гүнгийн харьяаны цахруудыг толгой дараалан барьж шүүх яаманд шилжүүлсэн хүн. Нанзад нэг үгний өөгөөр хүний санаа бодлыг тольдож чаддаг гэдэг болохоор ардын засгийг устгахаар бэлдсэн бүх хуйвалдаан Нанзадын гараас мултраагүй. Сүхбаатар түүнийг зүүн хязгаар явуулсан боловч тэрээр буцаж ирсэнд сэжиглэсэн Богд сэтгэлдээ "Одоо өнөө Бодоо, Жаа лам хоёрын боддог ч нохойн замаар орно. Хүрээний цахар Жамц, Шагдартай намайг холбогдож байсныг Нанзад мэдсэн байсан. Тэгэхээр одоо Нанзад миний ул мөрийг бүр төнхөж гарна" гэж бодно. Богд өөрийнхөө бодлыг нууцлахыг бодохын зэрэгцээ ажил хэргээ түргэтэхийг хичээнэ.

- Ламхай өнөө алтнаас чинь хэдэн хунтий бий вэ?

- Лхас руу явуулаад одоо зуугаад хунтий үлдсэн. Ер нь хоёр түм гаруйхан алт бий шүү дээ.

- Тэгвэл чи, дөчин хунтий алтыг бэлдчих гэхэд ялгуусан лам,

Хоёр. Зовлонгоор жаргах ёс

- Шоголтой нь бэлдэх үү? Шоголоос нь салгах уу гэж асуулаа.

- Шоголтой бэлдээд хоёр авдарт хийхийг бодоорой. Би учрыг нь сүүлд хэлж өгнө гэхэд ялгуусан лам,

- Жаа тэгье гэснээс цаашгүй.

Монголоос алт олзворлодог "Монголор" хэмээх нийгэмлэг 1900 онд байгуулагдсан. Монгол алт гэдэг энэ нийгэмлэгт хаант оросын "Золоторосс", "Санкт-Петербургийн олон улсын банк", "Парис Нидерландын банк", "Хятад дахь баялаг ашиглалтын синдикат" зэрэг томоохон байгууллага оролцжээ. Монголор олзворлосон алтныхаа 16,5 хувийг шимтгэлд төлөх ёстой бөгөөд 600 пүү (9,6 тн) алт олзворложээ. Богдыг хаан ширээнд залж, Богд хаант улс тогтсоноос хойш Монголор алт олзворлох хэлэлцээг Богд хаант улстай байгуулж, 1935 он хүртэл ажиллахаар тохирсон, чингээд Богдтой байгуулсан гэрээнийхээ дагуу жилдээ 4 мянган лан алт санд нь нэмэрлэдэг болсныг мэдэх хүн цөөн байв.

Богд мэлмийгээ чилээрхсэнд хойдын буянг бодож, наян тохой Мэгзэджанрайсэг бурхан бүтээлгэж, сүмийн барилгад 300 мянган лан мөнгө төлөхдөө дөрвөн аймаг шавь таван газраас мянган лан мөнгө, мянган мал тус бүрээс нь татаж авсан агаад Долнуурт Мэгзэджанрайсэг бурхныг бүтээлгэхэд мянган лан алт илгээж алтлуулсан аж.

- Ламхай минь, одоо алтаа хадгалж дараад байдаг цаг биш. Сүхбаатар бол Сайн ноён хан, Дайчин ван хоёроос илүү ухаантай хүн. Ухаан нь задарсан ийм хүнийг тэр хоёр шиг тонилгож болохгүй. Ухаантай хүн гэдэг чинь мянган жилийн юмыг алган доороо хардаг. Урагшгүй ухаантай хүн бол урд хормойноосоо цаашихыг хардаггүй. Тиймээс Сүхбаатартай ухаан зарж тэмцэх ёстой. Бид чинь түүнээс илүү хүчтэй байж гэмээнэ Сүхбаатартай тэрсэлдэх хэрэгтэй гэхэд ялгуусан лам,

- Жаа гэгээнтэн таны алтан сургаалыг болгоон сонслоо. Таны түмэн зөв гэж зөвшөөрөн хэлэв.

- Би өнөө орой цагаан сүм дээр очихгүй гэдгийг бурханч ламд дуулгаарай. Хатанг тэндээс холдуулахыг бодоорой. Эм хүн ахар бодолтой ч ухаан зарж, овжин сэргэлэн аашаа гаргавал тэлээгээр хэдэн эрсийг боомилж чаддаг адтай шүү. Сайхан бие цогцос ямар ч хүний ухааныг манантуулдаг. Тиймээс эм хүний авхаалж дотоожиндоо гэдэг ч дэмий үг биш гэж хэлэхэд ялгуусан ламын бие арзасхийх шиг болж "Гэгээнтэн энэ үгийг надад хэлж байна аа даа. Хатантай гурав, дөрөв ойртсоныг соёгоос өөр хүн мэдэхгүй. Тэгэхээр тэр лүд алтан хошуу өргөсөн байж" гэж бодлоо. Ялгуусан лам богдын үгийг бодсоор ордноос гарч ирээд ар нуруугаараа хүйтэн хөлс чийхарсныг мэдлээ.

Богд хэд хоногийн өмнө Цагаан ордноос хатнаа авчирч өөрийнхөө дэргэд байлгасан нь жирийн хэрэг биш. Гаминг ирсний дараа нэг шөнө Богд хатантайгаа дэр нийлүүлж хонотол хатан нь Богдын цээжинд хацраа нааж хэвтэхдээ "Хүрээний алтны пүүснийхэн үе үе ирж танд бараалхахдаа надад их бэлэг өгдөг. Танд бол бүр их юм өгдөг байх" гэж шалгаажээ. Богд

хатныхаа үгнээс сэжиг аваад ганц ч үг дуугаралгүй өнгөрч, хэсэг дуугүй байснаа буруу харан хэвтжээ. Гэтэл хатантан богдын мөрнөөс татаж өөр рүүгээ харуулаад түүнийг үнсэн таалснаа "Тэгээнтэн минь таны их санг гамингууд баллаж мэднэ шүү. Болгоомжтой байж үзээрэй" гээд санаа алджээ. Хатан үүнээс хойш үе үе богдын сан хөмрөгийг сэм сурагладаг болсон. Хатанг Цагаан сүмд байхад түүний соёг эмэгтэй нэг удаа Богдод бараалхахдаа "Хатантан, ламхайг ээрч хоргоогоод байдаг болсон. Тэгээд заримдаа энэ ламхай богдын оронд хаан болох хүн шүү" гэдэг болжээ. Гэхдээ зарим үед энэ ламхай богдын сан хөмрөгийг цөлмөөд алга болчихож мэдэх золиг гэдэг юм. Мөн гэрт байгаа тэр гоё залууг ямаршуухан эр вэ? Хаантан яагаад тэр хүнийг биднээс нуудаг юм бол? гэж асууж шалгаагаад байна гэж ховложээ.

Богд, хаан ширээнд заларсан жилээ энэ хүүхнийг аягачин болгож аваад сүүлдээ нууц ханилсан юм. Тэгээд хатандаа мэдэгдэхгүйг хичээж түүнийг соёг болгож билээ. Тэрээр хатны илүү дутууг ажиглаж, богдод хэлдэг учраас ордны донир, сойвонгууд аягачин хүүхнээс айдаг. Тэд соёгийн алтан хошуунд өртөхгүйг хичээж амаа хамхиж, богдод бараалхсан үед зэвүүрхэн болгоомжилно. Богд нууц амрагийнхаа үгийг сонсоод,

- Жаа, би таны ачийг мартахгүй ээ. Өнөө шөнөөс эхэлж ордонд байж миний хуян шар усыг барьж өгөөрэй гэлээ.

Богд тэр шөнөө нууц амрагаа таалж хонохдоо өөртөө хэрэгтэй нэлээн зүйлийг хэлүүлж аваад "Энэ золигийг одоо ордноос гаргаж болохгүй. Тэгвэл алтны талаар ам мэдэн бурах болно. Энэ хүүхний хоногийн тоо гүйцжээ" гэж бодоод өглөө нь ялгуусан ламыг дуудуулав.

- Соёг бүсгүйг өнөө шөнө шарилын сүм рүү явуулна. Чи тэнд нь учрыг нь олно биз гээд цагаан сүмд заларч бурханч ламтай уулзав.

- Үнэнч шавь минь, нөгөөдрөөс урагшаа яв! Тэгэхдээ үлэмж хэмжээний алт авч явах болно. Чамтай хамт сангийн хоёр лам, бадам ёгын гүрэмч лам хамт явна. Чи бол тэдний хөтөч. Тэд Бээжинд очиж тэнгэрийн сүмд өргөл өргөж, цэцэн хааны (Хубилай) гурван номын хүрдийг эргүүлэх хэргээр яваа улсууд. Бээжинд очсоны дараа тэдний учрыг олох хэрэгтэй. Цаашдаа чамд хань болж чадахгүй. Алтаа Шанхайд хадгалуулбал дээр. Харин хойтон жилийн (1923 он) намрын эхэн сарын шинийн нэгэнд Вангийн сүм дээр оч. Би өөрийнхөө төлөөний хүнийг явуулна. Түүнийг Тозияатай уулзуулаад, чи өөрөө буцаж ир. Маргааш шарилын сүм дээр очиж ламхайтай уулзаарай. Тэр бүх учрыг мэдэж байгаа гэхэд бурханч лам толгой мэхийн,

- Жаа гэгээн таны зарлигийг дагаж ёсоор болгохыг хичээе гэлээ.

- Чи тэр хүнийг сайн таних тул тусгай тэмдэг, дохио хэрэггүй. Тэр хүн вангийн сүм дээр очиж чамтай уулзах юм гээд Богд суудлаасаа өндийж гэрийн хаалга руу алхахад бурханч лам түүний араас бараа болон дагав.

Бурханч лам болзсон өдрийнхөө шөнийн хулгана цагт сүмээс гарч, ялгуусан ламыг даган Чойжин ламын сүмд ирлээ. Ялгуусан лам, занхан сүмд оронгуут хаалгачдаа,

- Жаа та явж ажлаа бод. Бид эндээ үлдье гэхэд хаалгач лам сүмээс гарлаа. Ялгуусан лам, сүмийн ард залгаж барьсан занхан сүмийн "нандин" гэж нэрлэдэг нэгэн өрөөний үүдэнд

ирээд хаалгыг онгойлгов.

Өрөөний хоёр хананы дагуу лусын хорин нэгэн хор хэмээх гаж дүрстэй амьтангууд болон гурван цагийг зөгнөсөн сүлд хэмээх амьтны баримлуудыг хуваан байрлуулжээ. Гол шүтээний өмнүүр олон үе зул асааж эгнүүлсэн тул зулын бүүдгэр гэгээнд ажиглагдахуйц харагдаж байгаа янз бүрийн дүрс бүхий аймшигт амьтдыг хаалгаар орж ирэх хүмүүсийн эгц өөдөөс харуулан байрлуулжээ.

Бурханч лам 17 жилийн өмнө Дайчин вангийн Лэгшидонгойлин (Булганы хүрээ) дээр очоод Далай ламыг бараадан Заяын хүрээнд заларч, Норовлин хэмээх доод дацангийн нэгэн сүмийн ханаар байрлуулсан лусын арван хоёр амьтдыг харсан билээ.

Тэр амьтдаас хамгийн аймшигтай нь цөөвөр чоно шиг нэгэн амьтан байв. Бурханч лам үүдний дэргэд зогсоод ялгуусан ламыг хүлээхдээ "Үүдээр оронгуут энэ хорин дөрвөн амьтан ухасхийж хөдөлнө дөө. Тэр жил Заяын хүрээний цөөвөр чоно шиг амьтны баримал ухасхийн хөдөлж ам нь ангайхад бөөн гал суунаглаад, урт улаан хэл, арзайсан соёо нь аймшигтай харагдахаар нь нүдээ аниад хүрээнийхний элэг доог болж билээ. Тэгэхээр одоо ялгуусан ламыг орсны дараа дагаж оръё" гэж бодов.

Ялгуусан лам өрөөнд түрүүлж ороод баруун хана руу алхахад лусын хоруудын баримал хөдөлж, заримын нь нүд гэрэлтэн, заримын нь ам хамраас гал дүрэлзэн, уур савсаад, ус гоожин годгодохын зэрэгцээ арслангийн хүрхэрсэн дуу, сэтгэл сэрхийлгэсэн хахир зэвүүн чимээ сүмд цуурайтахыг ажваас араатан амьтны сүрэгт ээрүүлсэн юм шиг санагдаж аймшигтай агаад учир мэдэхгүй зүрх муутай хүн ухаан алдаж унамаар ажээ.

Ялгуусан лам, сүмийн хана дагуу байрлуулсан шилэн хорготой шүүгээг чиглэн алхахад түүний гишгэлтийн аясаар сүмийн шал хотолзон хөдлөх агаад тэр тоолонд амьтан бүрийн дуу чимээ, хөдөлгөөн үргэлжлэхийг ажвал шатан доор төхөөрөмжлөн бэлдсэн оньсон хөдөлгүүрээр энэ бүхэн зохицуулагддаг болох нь илэрхий болой. Ялгуусан ламыг дагасан бурханч ламыг хананы шүүгээний дэргэд очиход аймшигт амьтдын баримал хөдлөхөө больж, дуу чимээ зогсож нам жим боллоо.

Ялгуусан лам, шилэн шүүгээний хоргыг нээж, олон үе хураасан хоргой дондортой (судрын гарчгийг бичсэн даавуу) модон шоголтой, зузаан судруудыг давхарлан хураасныг харвал ганжуур, данжуур бололтой. Ялгуусан лам тэр шоголтой судраас нэгийг аваад, хажуудаа байгаа сэнтий (арслан хөлтэй ширээ) дээр тавьж, шогол баринтгийг задлав. Тэгээд эхний хуудсыг эргүүлэхэд тэр нь түвд ганжуур болохыг мэдсэн бурханч лам, ламхайн дэргэд иртэл ламхай дараагийн хуудсыг давхраар нь авч хажуудаа тавьтал ямар ч бичиггүй хуудсуудыг цоолж, дөрөв дөрвөөр нь эгнүүлсэн цоорхойд суулгасан алтан гулдмай шаргалтан гялалзахыг хараад гайхан алмайрахдаа "Энэ алтыг тун сайн нууцалжээ. Ийм нарийн ухаан гаргана гэж хэн сэжиглэх вэ?" гэж бодлоо.

- Энэ алтны нэг хунтий нь 250 лан юм. Богд гэгээнтэн танд хүрэлцэхүйц алт, эрдэнэс өгөөрэй гэсэн юм гэж ялгуусан ламыг хэлэхэд бурханч лам сэтгэлдээ "Нэг шоголд нь нэг зуун лан алт байгаа болохоор тун их алт эрдэнэс өгөх нь" гэж бодов. Ламхай шогол бүрийг задалж үзүүлсний дараа буцаан боож, ялган тавиад хананы дэргэд байсан хоёр авдарт хуваан хийж,

баринтагтай жижиг судраар өнгөлөн далдлав. Тэгээд ламхай өнөө шилэн хорготой шүүгээний доод талын нэг шургуулгыг татаж онгойлготол том том сувд, эрдэнийн чулуу, цаасан янчаан (доллар) мөнгөн янчаан, алтан бөгж, ээмэг, бугуйвч тэргүүтнээр дүүрсэн байлаа.

- Та наанаасаа хүрэлцэхүйцээр юм аваарай. Нэрэлхсэний хэрэггүй. Хятадад эрдэнийн чулуу үнэтэй гэдэг байхаа. Шашин төрийн хэрэгт зориулж байгаа болохоор элээдхэн аваарай гэлээ.

Бурханч ламыг ийш тийш явахад Богд өөрөө дуудаж, алт мөнгө өгдөг байсныг эргэцүүлбэл эндээс авдаг байсан нь илэрхий. Чингээд ламхай, бурханч лам хоёр авч явах бараагаа янзалсаар үүр тэмдэгрэхийн хэрийд ажлаа дуусгав.

Ялгуусан лам сүмээс гарч хашаанд байгаа гэрээс хоёр лам дагуулан орж ирээд таван авдартай ном судраа даачаа тэрэгнүүдэд ачуулав. Сүмийн хашаанд хэд хэдэн морь, гурван бүхээгтэй тэрэг бэлдсэн нь бурханч ламын хэрэглэх хөсөг болой. Ламхай ачаа бараа ачиж дууссаны дараа нэгэн ламд,

-Баруун модон гэрт байгаа гурван ламыг дуудчих гэхэд өнөө лам сүмийн хашааны баруун хэсэгт байгаа модон гэрт орж, гурван ламыг дагуулан гарч ирснийг ажвал гэгээн жасын хоёр лам, гүрэмч лам болой.

Бурханч лам хөсгөө хөтөлж сүмийн баруун дааман хаалгаар гарахад ламхай өнөө лам нараа дуудаж,

- Жаа та нар модон гэрт орж хоол идээрэй. Ажлын хөлсийг чинь дуганч лам өгнө гэж хэлээд занхан сүм рүү орохдоо "Дуганч

лам маань хоолондоо хороо хийж амжсан л байх даа" гэж нүдээ аньж маани унших нь нүглээ наманчлахыг хичээсэн хэрэг болой.

Ардын засаг тогтоод жил гаруй болоход хуучин хуулиудыг устгаж, алба татвар, хэргэм зэргийн пүнлүүг (цалинг) хүчингүй болгосон нь дээдсийн уур хилэнг бадруулаад зогссонгүй, монгол ноёдыг өр зээлээр атгадаг гадаадын худалдаачдын авлагыг хүчингүй болгов.

Бодоогийн оронд Жалханз хутагт ерөнхий сайд болсонд Богд төдий их баярласангүй. Харин улам ч сэрэмжлэх боллоо. Богдын сэтгэлийг түгшээсэн олон бодлоос юуны урьд "Халх даяар алдаршсан энэ хутагт яваа яваандаа монголын шашны тэргүүнд тохоогдох эгзэг гарч магадгүй" гэж бодоод хов зөөдөг хүмүүсээс Долдой донирыг сонгож, багагүй найдлага тавиад хүрээ хотынхны үг чагнуулахыг эрхэмлэв. Долдой донир ч Богдод хэрэгтэй үг сонсгож дамжуулдаг боллоо. Тэрээр нэг удаа Богдод бараалхахдаа "Сүхбаатар Жалханз хутагттай эртнээс захиагаар харилцаж байсан гэнэ. Ер нь цаашдаа шашны эрхийг Жалханз хутагтад шилжүүлж өгөөд таныг монголоос зайлуулж магадгүй бололтой" гэж хэлжээ. Богд үүнийг дуулаад уур омогтоо шатаад "Монголчуудын хэнд нь ч шашны эрхийг өгөхгүй. Ясаа цайтал тэрсэлнэ дээ. Богдын ширээнд ганцхан түвдийн сурвалжит хүүхдүүд суух ёстой" гэж билээ.

Богд үүнээс хойш Долдой донирыг дуудахаас зүрхшинэ. Тэрээр Богдын сэтгэлийг тайвшруулах үг хэлж ирэхийн оронд зүрхийг нь дэлбэлчихмээр үг хэлж ирэх нь олонтаа. Гэвч

Богд түүний үгийг сонсож байх нь чухал гэж үзээд өөрийгөө тайвшруулна.

Долдой донир нэг өдөр Саж ламаас болж Богдод зэмлүүлсэн тул өөрийнхөө алдсыг цайруулахыг хичээж дуулсан бүхнээ Богдод айлдаж, дэндүү шударга зан гаргаад Богдыг шаналгах болсноо мэдэнгүүт өөрийнхөө алдаа ослыг хэрхэн цагаатгахаа боддог болов. Тэгээд нэг сайн арга олж, хүрээ хотоор сэлгүүцэхдээ хүүхнүүдийн сорыг хайж, цагийн аяыг хүлээнэ. Гэтэл Дархан вангийн хошуунаас Богдод мөргөж мутрын адис авахаар ирсэн нэг царайлаг залуу хүүхэнтэй санамсаргүй тааралдаад түүнийг урхидан ашиглахаар шийдэв. Тэгээд Богдын ааш занг мэдэхээр нэг өдөр бараалхахдаа саяхан сонссон зүйлээ айлтгахаар зориглов.

- Жаа гэгээнтэн минь, өнөө айхавтар хөх Нанзад Улиастайн сайд, хутагт нарын хударгаар орж нэг будлиан тарих шинжтэй байна.

- Донир оо, чи юу яриад байна.. Үг чинь их бөөрөнхий, тэгээд үнэнийг хэлэхээс халж ядаад байгаа юм шиг байна.

- Жаа.би бүгдийг хэлье. Нанзад нартан Жаа ламын аминд халдсан сурагтай. Тэднийг Улиастайд буцаж ирэхэд Жаа багш үхээгүй, хувилгаан чадлаараа төрөл арилжаад, Нанзадыг молигодож явуулаад мөн биедээ хувилсан гэдэг яриа Улиастайгаар таржээ. Тэгээд Нанзад Маажинсан руу буцаж, Жаа ламын толгойг авчрахаар явсан бололтой. Энэ мэдээг буухиа элч ирж Сүхбаатар зэрэг хүнд дуулгасан бололтой гэхэд Богд,

- Хоёр тэмээт тэгж балрах байсан юм. За одоо яая гэх вэ? Зүүн хүрээнийхэнд дуулгаж буяны хурал хуруул гээрэй. Өөр юу байна даа гэхэд Долдой донир сэтгэлдээ хадгалж явсан бодлоо нээлээ.

- Дархан вангийн хошуунаас нэг хүүхэн мутрын адис авахаар ирсэн. Бие, царай тэгш, тун сайхан хүүхэн байна билээ. Тэр хүүхнийг өнөө орой ир гэсэн юм. Та таалбал тун сайхан, залуухан хүүхэн шүү. Хатантны соёг хүүхнээс илүү царайлаг хүүхэн гэж хэлэхдээ "Богд нууц амрагаа сураггүй болгосон. Тэгэхээр одоо бас нууц амраг хэрэгтэй байх ёстой" гэж бодоод соёг хүүхнээр далим хийсэн болой.

- Жаа тэгвэл өнөө шөнө дагуулаад ирээрэй. Хатантан хаждын дом хийх хугацаа дуусах болоогүй байхаа гэхэд Долдой донир,

- Одоо арав гаруй хоног үлдсэн болохоор цагаан сүмээс наашаа ирэхгүй биз дээ. Харин ламхай бясалгалд нь саад болж, тоглоом тохуу хийгээд байгаа бололтой гэж аятайхан эвийг нь олж ховлов. Богд хэсэг дуугүй суухдаа "Ламхай тэгэх ёсгүй. Хатан сан хөмрөгийг мэдэхийн тулд ламхайг татаж чангаагаад байж мэдэх юм. Тэгээд цаадах нь хөдөлж өгөхгүй болохоор алтан хошуу хүргүүлж байгаа хэрэг" гэж бодно.

- Жаа би сонслоо. Ламхайг цагаан сүм рүү явах хэрэггүй. Өнөө гэрээ буулгаад гэгээн санд аваач гэж хэлээрэй гэхэд Долдой донир Богдын өрөөнөөс гарлаа.

Хайстай бол Богдын өвлийн орд. Богд энэ жил намрын сүүл сарын эхээр Хайстайд ирж суужээ. Богдын өвлийн ордны хоёр давхар байшингийн хэрмэнд хэдэн гэр барьсан нь ордны

донир, сойвон, соёгууд суух агаад богдод өргөл барих, мөргөхөөр ирсэн сүсэгтнийг хүлээн авдаг байв.

Долдой донир ордноос гарч өргөл мөргөлчдийн гэрт орвол хэдэн цагийн өмнө ирсэн бүсгүй, донирыг гаднаас орж ирэхийг мэдэнгүүт суудлаас босож хүндэтгэн, тэргүүн бөхийлгөн зогсоно. Донир хоймрын бурхны өмнөх хүрдийг эргүүлээд цөгцтэй зулын тосыг сэргээгээд эргэхдээ өнөө бүсгүйн тунгалаг царай, зулын гэрэлд гэрэлтэн, цог жавхаатай харагдахыг ажаад "Мөн сайхан амьтнаа. Одоо үүнийг чинь нэг.. ёстой гоё хүүхэн гэдэг чинь энэ дээ" гэж бодоод гэрийн зүүн орны дэргэд суулаа.

- Жаа би, гэгээнтэнд айлдлаа. Гэгээнтэн дурамжхан байна. Одоо яах вэ? гэж Долдой донирыг хэлэхэд өнөө бүсгүй донирын дэргэд ирж сөхрөөд,

- Дониртон минь болгоож хайрла. Би өнөө маргаашийн дотор гэгээнтний мутраас адис авахгүй бол буяны хайр хишиг надаас арилчих юм. Хоногийн тоо дуусах гээд байна шүү дээ гэж уйлагнан гуйв.

- Гэгээнтэн эрихээ татаж үзээд чиний биенд сэтгэлийн бузар шингэсэн байна гэж айлдлаа. Бие сэтгэлийнхээ бузрыг арилгуулаагүй цагт гэгээнтэнд бараалхаж болдоггүй юм.

- Донир гуай минь, би тэгээд одоо яанаа. Донир гуай минь та надад тус болж үзээч. Би таныг гомдоохгүй шүү гэхэд донир хэсэг чимээгүй сууснаа гүнээ санаа алдаад,

- За яая гэхэв. Буяны садан төрлийн холбоог бодож би ариутгал хийхээс дээ. За чи тэр орон дээр очоод хувцсаа тайлаад хэвт гэхэд өнөө бүсгүй донирын үгийг даган хувцсаа тайлан оронд орлоо. Донир босож хаалгаа түгжээд бүсгүйн дэргэд ирж, хувцсаа тайлж хөнгөлөн, гараараа бүсгүйн нүцгэн биеийг илж, доошлуулсаар давсаг хүртэл илж таалаад өвөрт нь орлоо. Тэгээд бүсгүйг тэвэрч, түүний хацрыг учир зүггүй үнсэж байснаа уруулыг нь хөхөн озно.

- Донир гуай та яаж байна аа. Би ийм ариутгал хийлгэсэн шүү. Манай хошууны хийдийн цорж ламтан ингэж таалж ариутгаад одоо болно гэсэн гэж нэг амьсгаагаар хэлтэл донир,

- Тэр цоржтон дутуу ариутгажээ. Ер нь бузрыг бузраар, хорыг хороор домнодог юм гээд донир хүүхний дээрээс өргөн хүнд цээжээрээ дарахад хөөрхий бүсгүй нүдээ тас аниад, буян заяагаа бодон биеэ сул тавьжээ. Дониртон гурвантаа ариутгал үйлдээд өндийж дээлээ хөдрөхөд өнөө бүсгүй орноос ухасхийн босч хувцаслаад,

- Донир гуай одоо гэгээнтэнд бараалхаж болох уу гэхэд Донир,

- За одоо хоёулаа богдод бараалхана аа гээд үүд рүү эргэв. Өвлийн эхэн сарын жаварлаг салхи хүүхний халуун нүүрийг

шавхуурдан, жихүүн хүйтэн хацрыг нь хайрахад бүсгүй үнэгэн лоовуузныхаа чихэвчийг буулгаад орд руу гэлдэрэхдээ "Богдоос мутрын адис авч чадвал ариун санваартны аминд халдсан ээжийн минь нүгэл хилэнц миний толгой дээр буухгүй шүү" гэж бодохноо хүрээ

цоржийн айлдсаныг санана. Энэ бүсгүйн эх нь нэгэн ламтай нууц ханилжээ. Гэтэл тэр лам эхийг нь тохуурхаад зогссонгүй бас дүүг нь татаж, далимдуулдаг байв.

Түүнийг дүүтэйгээ унтаж байхыг харсан эгч нь хар хороо барьж дийлэлгүй хутгаар чичсэн нь амин газар таарч, лам тэр дороо таалал төгсчээ. Тэгээд эх нь хар гэрт хоригдож, эрүү шүүлт даалгүй насан өөд болжээ. Бүсгүй эхийнхээ нүглийг цайруулах гэж хүрээнд ирж байдгаа барж буян үйлдээд, хошуу хийдийн цорж ламд бараалхаж хойд зам мөрийг асуутал "Чи эр хүний бие сэтгэлийн шуналд өртөж, эхийнхээ нүглийг биеэрээ эдлэх юм байна. Надаар ариутгал хийлгээд 21 хоногийн дотор богдын мутрын адис авбал эхийн чинь нүгэл чиний толгой дээр буухгүй" гэж айлджээ. Тэгээд Их хүрээнд ирсэн нь энэ билээ.

Хөөрхий бүсгүй бодолдоо дарагдан гэлдрэхдээ Богдын ордны морин шатаар өгсөж нэгэн уужим өрөөнд орж ирснээ мэдсэнгүй. Гэтэл донир,

- Наанаа хүлээж бай гэхэд бүсгүй Богдод мөргөх гэж байгаагаа санав. Донир дотогшоо ороод төдий л удаж гавилгүй гарч ирээд,

- За, одоо Богдод бараалхаж болно гэхэд бүсгүй нөгөө өрөө рүү орлоо. Уужим өрөөний нэгэн хананд тулгаж зассан хар суман лавир хэмээх битүү орон дээрээ сууж, өрөөсөн хөлөө унжуулсан Богдыг зулын бүүдгэр гэгээн дундаас олж харсан бүсгүй газар сөхрөн өвдөгнөөс нь адис автал Богд,

- Жаа, бүсгүй минь наашаа суу гэж хүнгэнэсэн дуугаар айлдахад хүүхэн шалнаас өндийн Богдын дэргэд ирж зогстол

- За, миний дэргэд суу. Тэгээд учир явдлаа айлд гэлээ. Чухам энэхэн үед долдой донир өргөл мөргөлийн гэрт орж иртэл ялгуусан лам гэрт сууж байлаа. Донир ламхайг хараад айх гайхах давхцаж, "Энэ чинь гэрийн хаяанд зогсож байгаад хамаг учрыг мэдээд орж ирж дээ. Одоо яана. За яах вэ? Хатантны айлдсан үгээр урхидаад авч болох байх" гэж бодно.

- Донир гуай, гэгээнтэн нойрсож байна уу гэхэд Долдой донир сэтгэлдээ "Энэ лүд намайг сонжиж байна. Богдыг нойрсож байгаа гэж хэлж болохгүй. Тэгвэл энэ чинь орж сэрээгээд Богдтой уулзчихна. Би үүнийг хорих эрхтэй биш" гэж бодоод,

- Гэгээнтэн нойрсох болоогүй байна. Харин та цагаан сүм дээрээс ирэв үү. Хатантан нойрсоо биз дээ гэж сөргөж асуув.

- Би шарилын сүмээс ирлээ.

- Жаа, тийм байх аа. Гэгээнтэн таныг шарилын сүм дээр залрах ёстой үзээд ир гэж байсан. Би ч бурхан заяатны илүү дутуу явдалд оролцох дургүй болохоор дуугүй байлаа. Тэр нь дээр биз дээ. Та чинь миний осол эндлийг ярьж хэлдэг хүний нэг баймаар даа.

Ялгуусан лам суудлаасаа босч гэрийн үүд рүү эргээд,

- Би гэгээнтэнд бараалхаад ирье. Та хажуулах болоогүй биз гээд гэрээс гарлаа. Ялгуусан

ламыг Богдын ордонд орж ирэхэд доод давхрын үүдний соёг, ламхайг хүндэтгэн босоход ялгуусан лам түүний дэргэдүүр гарч шат өгссөөр Богдын өрөөнд орж ирлээ. Хүн орж ирэх чимээнээр Богд хөнжлөөсөө өндийж,

- Жаа ламхай чи наашаа ойртооч гэхэд ялгуусан лам Богдын лавирын дэргэд ирээд орны хөлийн сандал дээр эмэгтэй хүний дээл хувцас байгааг ажтал Богд,

- Ламхай минь ээ, тэнгэрийн заяагаар надад нэг гүнж заяасан. Тэгээд энэ шөнө дэр нийлүүллээ. Та бие цогцсыг нь үзэж айлтгана уу гэхэд ялгуусан лам хөнжил доогуур гараа шургуулж, залуу хүүхний биеийг илээд,

- Бие цогцос ариухан дагина байна. Харин таны лагшин аяг нь аргилж дийлэх юм болов уу. Наад өвчин чинь сэдрэх юм биш биз гэж түвдээр хэллээ. Богд тэмбүү өвчин тусаад жилийн өмнөөс гайгүй болж байгаа юм. Үүнийг эмч домчоос гадна ламхай мэддэг болой.

- Би түүнийг чинь бодоод энгэр зөрүүлээгүй байна. Харин та ямар айлтгалтай явна даа гэж асуув.

- Дөнгөж сая газарчин ирлээ. Бурханч лам Шанхай руу явсан байна. Тэндээсээ Мугдэн орох гэнэ. Нөгөө гурав таны таалсан ёсоор диваажинд одсон байна.

- Жаа, тэгвэл газарчны учрыг ол. Золигт гаргачихсан нь дээр биз.

- Гэгээнтэн минь та цэргийн яамны айлтгалыг соёрхов уу?

- Үгүй, завдаж амжаагүй явна. Би ер нь үзэх шаардлага байгаа юм уу?

- Сүхбаатар Санбэйсийн хүрээнээс иржээ. Баттай дуулсан баримтаар бол Гурван Баяны харуулаар ороод ирсэн юм байна. Ачит вангийн хойгуур орж ирсэн цагаантнуудыг улаан оросын цэрэг хөөж устгасан байна. Намар Хатанбаатарт олгосон цэргийн яамны тамгыг Сүхбаатарт шилжүүлэх айлтгал өргөсөн юм гэхэд Богд,

- Тийм байх гэж бодсон юм. Хуцамхай нохой зууж сүйд болчихдоггүй мөртлөө хоргоож сүржигнэхээс цаашгүй байдаг. Цагаантнууд хий сүржигнэхээс цаашгүй улсууд. Нөгөө талаар Хатанбаатар Бароноос болж элэг буруулаад одоо шавиа гэж байгаа болохоор биднийг гялайлгахгүй. Харин Цэен гүнгийн талаар судалж мэдэх зүйл юу болж байна гэж асуув.

- Цэен гүн эх эцгээсээ гурвуулаа хүн. Их ах Баатар нь эцгийнхээ гүн зэргийг залгамжилж Бадруулалтын 31 онд (1905) Манжуур явж алба хаасан байна. Нөгөө ах нь Бээжинд алба хааж байгаад таалал төгсжээ. Дам сураг дуулбал гахай жилийн (1911 оны) хөдөлгөөнд оролцож амь эрсэдсэн чимээтэй.

- Цэенгийн ах нар яагаад өвөрлөгч газар байдаг юм бол?

- Гүнгийн эцгийн өвөг дээдэс Богд Чингэсийн удмын улсууд гэнэ. Таван зуун жилийн тэртээ Юань улсын төрийг эвдрэхэд тэнд сууж байсан монголчууд нутаг руугаа гарчээ. Харин Нагачу гэдэг ноён Мин улсад дагасан балгаар хоёр түмэн монголчууд их Хянганы цаад талд үлджээ.

Тэгээд өндөр гэгээнийг манжийн тайзугийн ордноос (Энх-амгалан хаан Канси) тахиа жил (1705 он) буцаж халхад ирэхэд хэсэг өрх шавь болон дагаж ирээд, Түшээт ханы албат болсон байна. Тэр үед Цэен гүнгийн элэнц өвөг дээдэс нутагтаа буцаж иржээ. Ер нь гүнгийн өвөг дээдэс шашин төрд зүтгэлтэй гурван хэлний номонд (манж хятад, монгол) нэвтэрхий хүмүүс байсан аж.

- Цэен гүн одоо тэгээд юутайгаа байдаг юм бэ?

- Ганц охинтойгоо байдаг юм байна. Охин нь одоо 20 настай, манж, хятад, рийбэн хэл мэддэг сайхан хүүхэн бий. Эхнэр нь зуурдаар нас баржээ. Охиныг нь ардын засгийн бага сургуульд багшлахыг гуйсан боловч гүнтэн зөвшөөрөөгүй байна.

- Жаа би сонслоо. Та маргааш шөнө Цэен гүнг Хайстайд бараалхуулахыг бодсон дээр. Би биеэрээ уулзаж ярилцъя. Нөгөө талаар танд хэлэх юм байна. Түрүүхэн Долдой донир орж ирээд таныг хатантай холбож муулаад гарлаа. Цаадахаасаа болгоомжилж яваарай.

- Сая бас үг дамжуулж байна. Ер нь амьд явах хоногийн тоо гүйцсэн юм биш үү дээ.

- Ламхай, цаадах чинь урт хошуутайн адилаар урт чихтэй хүн. Тэгэхээр аяг нь харж далим хүлээе. Цаадах чинь ардын засгийн ая зан олж сонсохын тулд хөл гараа хугалчих шахаад байгаа юм. Тэгэхээр одоохондоо байж байг! Урт хошуу хүзүү ороодог номтой. Тэгэхээр өөрийнхөө замаар таваргаж яваад ардын засгийн гарт өртөнө биз.

Ялгуусан лам Богдтой чингэж ярилцаад ордноос гарсны дараа гэгээнтэн хөнжилдөө орлоо. Тэгээд өнөө сайхан хүүхнээ илж таалсан боловч бие эрхтэн шаналаад ая нь олдсонгүй. Түүний хажуугаар Богд Цэен гүний тухай бодох тул яагаад ч болж өгөхгүй нь илэрхий боллоо. Тиймээс Богд хүүхний өвөрт хүлцэнгүй хэвтэж, сайхан анхилам үнэртэн шингээсэн хөнжилд шургасан бүсгүй Богдын цээжинд хацраа наан "Ёстой амьд бурхан юм даа. Яагаад надаар оролдохгүй байна вэ? Амьд бурхан болохоор хүний зовлонгоор жаргал хийхийг боддоггүй байх! Одоо ээжийн минь нүгэл миний толгойноос зайлна. Тэгэхээр Богдод айлтгаж ээжийнхээ нүглийг цайруулах хэрэгтэй" гэж бодно. Гэтэл Богд хүүхнийг үнсэж таалахын даваан дээр гэнэт болилоо.

- Гэгээнтэн минь, та яав аа. Би таны таалалд нийцэхгүй байна уу? Би ариутгал хийлгэсэн шүү дээ гэхэд Богд сая сэхээ авч,

- Юу? гэж гайхан асуулаа.

- Дониртон сая намайг ариутган таалсан шүү дээ. Таныг ариутгаад бараалхуул гэсэн гэж айлдсан юм.

- Аа аа. Хар лүд хамбармуудыг харж байна уу. Миний нэрийг барьж бөгснийхөө чилээг гаргадаг байна шүү. Ийм шуламнуудыг тонилгох хэрэгтэй. Естой Долдой хочиндоо таарсан нөж. Муу бармыг маргааш гэхэд золигт гаргадаггүй болов уу. Естой хоногийн тоо гүйцэж дээ гээд хөнжлөө хуу татан хаяад "Зайл, одоохон зайл. Муу янхан эм" гэж хэлэх гэтэл Богдын дуу хоолойноосоо давсангүй. Зулын гэрэлд чармай нүцгэн хэвтээд алгаараа нүүрээ дарсан

хүүхний булбарай бие цогцосыг харсан Богдын мэлмийд төдийгүй сэтгэлд нь сүр жавхлантай харагдах шиг болсонд гэнэт оволзсон уур хилэн нь аль хэдийн номхорч, үл мэдэгдэх халуун илч бие сэтгэлийг далдаас төөнөхийг гадарласан Богд хүүхний хацрыг үнсэн таалсаар, уруулыг шимэн озсоор хөнжлөө авч толгой дээгүүрээ нөмөрлөө.

Тэнгэр бүрхээд жихүүн салхи баруун урдаасаа сэнгэнээд, түнэр харанхуйд гарын хурууны үзүүр үл харагдана. Ханд чин вангийн өндрийн урд талын гудамжнаас гарсан морьтой нэгэн хүн, бөг бөг шогшуулсаар Дунд голын мөсөөр гарч Хайстайг чиглэнэ.

Цэен гүн Богдод бараалхах болсноо сонсоод хэдэнтээ айж эмээжээ. Гэвч сэтгэлийн гүнд буух ноцтой хэрэг түвэг байсангүй. Тэрээр шөнө дүлээр дуудагдсан учрыг эргэцүүлэн бодовч сэтгэлд буух юмгүй. Цэен элдвийг бодон явсаар Хайстайн хэрэмний баруун хаалганы дэргэд ирснээ мэдсэнгүй. Харин морь нь хаалганы дэргэд зогссоныг мэдэнгүүт Богдын ордны ямбаны хаалганы дэргэд явган очдог ёсыг зөрчсөндөө айж халаглаад, тэр дороо бууж, асартай дааман хаалганаас адис аваад,

- Ай бурхан гончигсум минь, эзэн хааны ордны дэргэд ёс алдан танхайрсан намайг өршөөж хайрла гэж үглээд морио хөтөлж, хаалганаас холгүй байгаа чийганы дэргэдэх шонгоос уяд ордны дааман хаалганд дөхөж очингуут хувцас хунараа засаад хаалгыг зөөлөн тогшлоо. Гэтэл гэрээс гарч ирсэн хаалгач,

- Юун хүн бэ? гэж сөөнгө дуугаар асуухад,

- Жаа би, Цэен гүн байна. Дээрхийн гэгээнтний зарлигаар ирлээ гэхэд хаалгач түгжээгээ тайлж, Цэен гүнг хашаанд оруулаад өөрөө дагуулан Богдын ордонд орлоо. Богд орон дээрээ сууж байсан болохоор Цэен ёсыг даган есөн удаа мөргөөд, дэргэд нь очиж зогстол орны толгойн дээхнэ тавьсан хар суман ширээн дээрх алтан өнгөтэй тавиурт шигтгэсэн лаануудын гэрэлд Богдын махлаг царай шаналангүй харагдав. Богдын ордонд цахилгаан гэрэл тавьсан боловч гэгээнтний нүд чилээрхсэнээс хойш цахилгаан чийдэнгийн оронд лаа асаах нь тохиромжтой ажээ. Лааны тавиурын дэргэд өргөн энтэй хадаг тавьсан агаад Богдын нандин эрхи дэргэд нь байлаа.

Богд Цэен гүнг ажиглан дуугүй суухдаа "Төр шашны төлөө бие сэтгэлээ зориулж чадах энэ хүнийг Тозияа тун овжин сонгож авчээ. Энэ хүний төр шашнаа гэсэн санаа өнөд хувирахгүй гэдэг нь илэрхий болой. Тэр жил Ханд чин ван надад мэдүүлж, гүн зэрэг шагнуулах санал тавьж байсан нь санамсаргүй хэрэг биш байв" гэж бодно.

- Гүнтэн минь, ямаршуухан амьдарч байна даа. Алба ажилтай болсон уу гэж Богдыг асуухад Цэен гүн,

- Гэгээнтэн минь ээ, би өөртөө засан тохинох засаг төрдөө сүсэглэн зүтгэж, дахин байгуулахад амь биеэ зориулсан болохоор ардын засаг төртэй нийлэх сүсэггүй байна.

- Гүнтэн та тэгээд яая гэж бодож байна вэ? Ингэж байгаад Саж ламын араас цувах болж байна уу? гээд Богд дуугүй болов.

- Бид өөртөө хавсрах хүчгүйгээр ардын засгийг амархан устгаж чадахгүй гэдэг илэрхий байна. Тиймээс би өөрийн нэгэн Наран хүнд саналаа хэлж явуулаад хариу хүлээж байна.

- Гүнтэн минь тэгвэл одоо миний үгийг болгоон тунгааж үз! Та бол эзэн Чингэстэй удмын холбоотой хүн. Тэгэхээр шашин төрөө гэдэг таны бодол түмэн зөв! Тиймээс та гамин чандрууг устгахад хүчин зүтгэсэн. Харин одоо таны эрхэм зүтгэл урьд урьдаасаа илүү хэрэгтэй.

- Гэгээнтэн минь би таны зарлигийг дагаж, төр шашнаа мандуулахад амь биеэ хайрлахгүй зүтгэнэ гэхэд Богд алтан өнгөтэй тавиуртай лааны дэргэд байгаа өргөн хадагаа хуу татан авлаа. Тэгтэл ширээн дээр байгаа алт, сувд эрдэнэсийн чулуу лааны гэрэлд гялалзан нэгэн гайхамшигт солонго өрөөнд буух шиг болжээ.

- Гүнтэн минь та үүнийг ав гэж Богдыг хэлэхэд Цэен гүн, -Гэгээнтэн минь миний байгуулсан урьдын гавьяа зүтгэл, одоогийн оноогдох үүрэг энэ эрдэнэсээс хавьгүй өчүүхэн зүйл билээ. Тиймээс эзэн хаан таны энэ их буян хишиг над шиг доод хүнд ахдана гэдгийг болгоон толилно уу гэж татгалзан айлдав. Богд Цэен гүнгийн энэ үгийг сонсоод гүн зэрэг хайрласан хийгээд донир сойвонгуудаасаа сонссон зүйлээ нэхэн санах.

.Цэен хятадуудыг нэг нүдээр үздэггүй мөртлөө тийм ч хамаагүй тэрсэлддэггүй. Тэр байтугай хятадад уурласан уур омгоо царайндаа илрүүлдэггүй тэвчээртэй хүн. Нохой жил (1905) хүрээний амбаны амь насыг бүрэлгэхээр бэлдэж байсан. Цэенгийн төр шашинд үнэнч зан чанарыг Ханд чин ван их биширдэг байсан юм гэж хэлсэн сойвонгийн үг Богдын чихнээ сонсогдох шигээ. Саж лам нэг удаа Цэен гүнгийн авхаалжийг магтахдаа "Төрийнхөө төлөө амиа гаргуунд нь хаяж мэдэх хүн" гэж билээ. Ханддорж чин ван нэг удаа Богдод бараалхаад "Эцэг нь хятадуудтай таардаггүй хүн байсан. Манжаас ар өвөр монголоо тусгаарлаж Чингэсийн эзэнт улсыг тогтооно гэдэг байсан юм. Сангийн яаманд ажиллаж байхдаа хичээнгүй нягт нямбайгаараа гайхагдаж байсан юм. Одоо нэгэнтээ гүн зэрэг олгосон учраас гурван хэлэнд нэвтэрхий ийм хүнийг гадаад яаманд алба хаалгая" гэж ятгахад Богд зөвшөөрч билээ.

- Гүнтэн минь та, сангийн яаманд ажиллаж байсан болохоор алт мөнгөний үнэ цэнийг надаас илүү мэднэ. Ардын засгийг устгахад гадаад улсын хүчин зүтгэл хэрэгтэй гэдгийг тунгаан бодсон чинь баярлууштай байна. Тиймээс та Мугдэнд байгаа өөрийн найзтайгаа очиж уулзах хэрэгтэй. Би тэр хүнийг муугүй танина. Наран улсаас манайд үзүүлэх зэр зэвсгийн тусламжийн асуудлыг та хари уцах болно. Та гадаадад гараад энэ хэргийг бүтээхэд хөрөнгө мөнгө хэрэгтэй гэдгийг мэдэж байгаа. Ялангуяа Наран улсын армийн нөлөө бүхий удирдах хүмүүстэй танилцаж тэдэнд нэр хүндтэй болно гэдэг бол ганцхан хээл хахууль мэднэ гэсэн үг. Энэ эрдэнэс, алтыг борлуулбал тэндхийн ханшаар олон сая янчаан болно. Түүнийг нь гадаадын банкинд хийж өсгөж үржүүлээд байвал та, наран улсын цэргийн ноёдын гарыг цайлгах хөрөнгөөр дутахгүй гээд ширээн дээрх алт, эрдэнэс тэргүүтнийг Цэен гүнд гардуулж өгөөд ширээн доор байсан нэгэн жижиг хайрцагт хийлгэлээ.

- Гүнтэн та, ирэх жилийн намрын эхэн сарын шинийн найман гэхэд Вангийн сүм дээр очих болно. Тэнд таныг зүс таних хүн хүлээх ёстой. Түүнтэй уулзахад цаашдын хэрэг явдал тодорхой болно. Харин охиныхоо хувьд сэтгэл зовох хэрэггүй. Бид харж хандаж байгаад

таныг тохижсон хойно араас чинь явуулна. Харин эхлээд та, өөрөө тохижиж суурьших нь чухал гэхэд Цэен гүн,

- Жаа би, төр шашныхаа төлөө таны зарлигийг дагаж хичээн зүтгэж, даалгасан бүхнийг биелүүлэхийг бодно гэж хэллээ.

- Та маргааш өглөө гэхэд хүрээнээс гарсан байх ёстой. Унаа хөсгийг чинь бэлдчихсэн байгаа. Та шарилын сүм дээр очиж ялгуусан ламтай уулзаарай. Та эхлээд зам буруулж, Алтан-Очиртын хийд дээр оч. Тэндээсээ цагаан сар өнгөрөөгөөд, Егүзэрийн хийд дээр очиж цорж ламтай нь уулзаарай. Би танд цаашаа хөдлөх тухай жич хэлж, төлөөний хүн явуулна. Цорж лам таны очсон хэрэг учрыг мэдэх ёстой хүний нэг. Та тэндээсээ Үзэмчин хошууг дамжин Вангийн сүм дээр очих ёстой гээд Богд Цэенг дагуулж ордныхоо үүд хүртэл гаргаж өглөө.

Гурав. Хүний газар уулзах учирал

Цэен, гахай жилийн (1932 оны) цагаан сар өнгөрөөгөөд Алтан-Очиртын хийдээс хөдөлж, Егүзэрийн хийд дээр ирээд цорж ламд айлтгуулав. Цорж ламтан Цэенг хүндэтгэн хүлээн авч уулзаад,

- Гүнтэн минь, гэгээнтэн таныг эндээ хүлээж бай гэсэн. Цогчин жасын хашаанд гэр барьсан. Та тэнд морилно биз гэж хэлснээс хойш дөрвөн сар Егүзэрийн хийд дээр буян бүтээх

Гурав. Хүний газар уулзах учрал нэрээр амьдарчээ. Гэтэл нэгэн өдөр цоржийн шавь ирж, Цэентэй уулзаад цорж ламтан дуудуулсныг дуулгав. Цэен, цоржийнд очтол нэгэн зүс таних хүн цоржтой ярьж сууснаа Цэенгийн бараанаар суудлаасаа босож золголоо.

- Жаа та зам зуур сайн явж ирэв үү? Хүрээ хотоор сонин юутай вэ? гэж урьд хүрээнд хэд хэдэн удаа уулзсан Майдар жасын тахилч ламаас Цэен сонирхсон зүйлээ лавлан асуув.

- Үймээн самуун ихтэй байна. Дээрхийн гэгээнтэн таныг Вангийн сүм рүү хөдөл гэж хэлүүлээ гээд өврөөсөө мяндсан шар өнгийн дугтуйтай нэгэн бичиг гаргаж өглөө. Тэгээд бас нэгэн зурвас өгсөн нь Богдоос Цэенд бичсэн захиа байв. Цэен ийнхүү Богдын захиаг уншиж суутал цорж тэдний ярианд оролцон,

- Та нөгөөдөр хүрээнээс явах болно. Таныг манай гурван лам Бүрэнгийн хүрээ хүргэж өгөөд буцаж ирнэ. Харин цаашаа номгүй гэлэн тантай хамт явж Вангийн сүм орно. Тэр хүнд бүрэн итгэж болно гэхэд Цэен авч явах зүйлээ төхөөрч бэлдэхээр гэрээс гарлаа.

Цэен, номгүй гэвш гэж алдаршсан чих хатуутай нэгэн өвгөн ламын хөтөч болон явсаар Бүрэнгийн хийд дээр ирлээ. Тэр гэвш энэ хийд дээр гавжийн дамжаа барьсан болохоор жирмийн чуулганы томоохон лам нар түүнийг хүндэтгэн "Ероолгүй номтой учраас дийлэх номгүй гэвш" гэж нэрлэсээр сүүлдээ номгүй гэвш гэж алдаршсан болой.

Номгүй гэвш, Вангийн сүм орж Богд гэгээний тавин гурван насны түнэл хуруулах нэрийдлээр цаашаа явахдаа хоёр ламаа Бүрэнгийн хийдээс буцаажээ. Зуны адаг сарын сүүлээр Вангийн сүм дээр ирсэн номгүй гэвш хөтөчийнхөө хамт цогчин жасын хашаанд том гэр бариулан суужээ. Чингээд намрын эхэн сарын шинэдээр Вангийн сүм дээр Богд гэгээнтний түнэл хурах болсныг сонссон сүсэгтнүүд хийдээр шавж, газар газрын гуйлгачингууд хийдийн цав манжны шавхруугаар гэдсээ цайлгахаар сүм дуганы гадаа зээглэн сууж, сүсэгтний өөдөөс гараа тосон юм гуйна. Сүм дугануудад хүн багтахгүй болсон учраас гэсгүй лам, гуйлгачингуудыг сүм дуганаас гаргаж зайчилсан болохоор Богдын түнэлийн хурал сонсохыг хүссэн гуйлгачингууд сүм дуганы довжоо хавиар эргэлдэнэ.

Түнэл эхэлсэн өдөр номгүй гэвш гол дуганд орохоор явж байтал навсархай хувцастай нэг гуйлгачин, гэвшийн дээлийн хормойноос адис авах гэтэл жасын даа лам түүнийг өшиглөж, хажуу тийш болгов. Тэр гуйлгачин ташуу захтай тэрлэгний тамтаг, нүцгэн биен дээрээ өмссөн болохоор намрын хайлган наранд шарагдаж хөлс цуваад, цээжний нь дагуу хирний ором зурайж, шанаагаар нь хиртэй хөлс урсана. Тэр гуйлгачин маргааш нь номгүй гэвшээс дахин адис авах гэтэл гэсгүй бэрээгээр торлогдож зайлуулав.

Түүнээс хойш тэр гуйлгачин дуганы үүдний довжоо бараадан сүсэгтний хөлийн аясаар боссон тоосонд даруулан, хорчгор нүүрнийхээ хөрсийг үрчийлгэн, гомдолтой нүдээр номгүй гэвхийг ширтэн суудаг боллоо. Цэен Богдын түнэлийн хэрэглэлийг хариуцаж байгаа болохоор жасаар эргэлдэж, манж, зав зэд пог тараах ажилд оролцож, бас цав манжны үлдэгдлийг дамжилцан гуйлгачинд өгөлцсөөр шинийн найман хүргэжээ. Найманд өглөөнөөс хойш дуганы үүдэнд сууж орой болготол түүнтэй уулзах хүн ирсэнгүй.

Хурал тарсны дараа Цэен жасынхантай зэд погийн тооцоо хийгээд жасын хашаанд байгаа гэр рүү гэлдэрч явтал түүний өөдөөс хэд хоног дуганы үүд сахиад номгүй гэвшээс адис авч чадаагүй гуйлгачин тосон ирж явлаа. Цэен тэр гуйлгачинг тулж ирэхэд "Хөөрхий энэ гуйлгачин, гэвшээс адис авах гэж хэд хоног омогтой лам нарын гарын чилээг гаргаж бэрээдүүлж, жавгийдуулж, тоосонд даруулсан юм. Одоо дагуулж ороод адис авахуулчихья. Буян болог" гэж бодлоо. Гэтэл өнөө гуйлгачин Цэенгийн бодлыг мэдсэн юм шиг,

- Буянтан минь, намайг номгүй гэвшид бараалхуулж, адис өгүүлж хайрла гэж үзэмчин аялгуугаар шулганав.

- Жаа та, хурдхан шиг ороод адис авчих гэж хэлээд түүнийг дагуулан хашаанд ортол номгүй гэвхийн дэргэд бараа болж байсан лам гэрээс гарч ирэнгүүт гуйлгачинг хараад,

- Чи яагаад ороод ирэв? гэж омогдоход Цэен,

- Зүгээр, зүгээр. Би дагуулж яваа юм гээд орлоо. Гуйлгачин гэрт орж ирэнгүүт гэвхийн өмнө очиж, хормой

дэвсэн мөргөж хивсэнд тэргүүн хүргэтэл номгүй гэвш Цэен өөд сүрхий харлаа. Цэен нүдээ ирмэн дохиж "Наад хүндээ адис өгчих" гэж мэдэгдсэнд гэвш эрихээ хумхин барьж адислав. Гэтэл нөгөө гуйлгачин ширдэгнээс өндийхдөө,

- Цэен гүнтний амрыг эрье гэж халхаар хэлэхэд Цэен нүдээ том болгон харлаа. Тэгээд номгүй гэвш рүү нүдээр дохитол тэрээр гэрээс гарахад Цэен сэтгэлдээ "Богдын төлөөний хүн ингэж ч явах гэж дээ" хэмээн бодлоо.

- Гүнтэн минь, миний хөлс, үнэр танараас зэвүүцэх хэрэггүй гэхэд хоолны шавхруугаар ходоодоо дүүргэж, хийдийн омогтой банди нарын гарт балбуулж яваа туранхай энэ хүнийг хараад Цэен гүн сэтгэлдээ "Би, Богд хаантны өгсөн хишгийг үрэн таран хийж явахад энэ хүн ингэж явдаг байна шүү" гэж бодтол Богдын хэлсэн үг санаанд бууж "Наран улсын цэргийн томоохон хүмүүсийн гарыг цайлгах хөрөнгө чамд хэрэгтэй" гэж хэлсэн нь тод сонсогдох шиг болов.

- Жаа одоо та хувцас хунараа соль. Би танд мөнгө янчаан өгнө. Тэгээд тав тухтай ярилцъя гэхэд өнөө гуйлгачин инээмсэглээд,

- Би тантай уулзахын тулд энд ирсэн. Ер нь өлсөж, цангахад учир байдаг юм шүү. Та эндээ гурав хоноод Чанчунь руу гэвштэй хамт гараарай. Тэгэхдээ эндэхийн лам нарт Манжийн хааны ордонд очиж өргөл өргөнө гэвэл сэжиггүй биз. Таныг Чанчуньгийн дэн буудалд хүлээж

байх болно гэж хэлээд гуйлгачин гэвшийн гэрээс гарлаа.

Чанчунь бол Итунхэ голын эрэг дээр байгуулсан томоохон хот юм. Орос Японы дайны дараагаар Портсмут гэдэг газар болсон гэрээний дагуу Хаант орос улс, Солонгос дахь японы нөлөөг хүлээн зөвшөөрч, Ляодунгийн өмнөд хэсэг Гуаньдунгийн арлууд дээрх Дайран, Порт-Артур хот хүрсэн төмөр замыг японд олгож, Манж нарыг төрсөн нутгаас нь хөөн зайлуулах талаар нууц хэлэлцэн тохирсон учраас япон эзэмшлийнхээ цэргийг Дайран, Порт-Артурт суулгах болжээ. Чингээд Чанчуньгаас Дайран хүртэлх дорнод хятадын төмөр зам японы мэдэлд оржээ.

Цэен Чанчуньд ирээд буудалд буусны дараа оройн зоогонд ороод гарч иртэл буудлын хөлийн өрөөний уужим танхимд байсан олон хүний дунд буй өндөрдүү туранхай хүнийг хараад гайхав. Тэр хүн тас хар өнгийн европ хувцас нямбайлан өмсөж, цас шиг цагаан цамцан дээр баруун зүгийн дэгжчүүлийн эрхэмлэдэг эрвээхэй зангиа зүүсэн нь туранхай хүрэн бор царайнд нь нэн зохижээ. Урт хоншоортой, гялалзсан өнгөтэй шаахай өмсөж, зааны ясан таяг барьсан тэр дэгжин залууг ажваас Вангийн сүмийн үүд сахиад юм гуйж байсан гуйлгачинтай зүйрлэшгүй болой. Цэен гүн, ёстой эвэртэй туулай үзсэн юм шиг гайхав. Дэгжин эр Цэенг харангуут баяр баясгалантай инээмсэглэсээр дэргэд нь ирж амар мэндийг лавлаад,

- За одоо хоёулаа танилцах уу даа. Намайг Бадрах гэдэг юм гээд,

- Гэвш гуайн лагшин данги уу гэхэд Цэен,

- Дангиа, намайг бодвол хол явж, нүд тайлсан хүн болохоор өөр юм. Одоо өрөөндөө ном бясалгаж байгаа. Хоёулаа дээшээ манай өрөөнд оръё гэв.

- Хэрэггүй, та бид хоёр нөгөөдөр бух тэргээр Мугдэн руу явна. Тэгэхээр гэвш гуайд аян замаа бод гэж хэл. Ламбугай эндээсээ Долнуур ороод тэндээсээ нутаг буцвал сэжиггүй юм шүү гэж хэлсэн Бадрах, Цэентэй галт тэрэгний буудал дээр уулзахаар цаг тохироод буудлаас гарав.

Цэен, гэвштэй ярилцаж тохирсон ёсоор ажил төрлөө зохицуулаад Хүрээ рүү явуулах захиа бичиж өгөөд Чанчуньгийн буудал руу явлаа. Тэгээд галт тэрэгний буудал дээр Бадрахтай уулзаж, вагонд сууж Мугдэнг чиглэв. Бадрах Чанчуньгаас гарснаас хойш Цэентэй төдий л их юм ярьсангүй. Тэрээр ном уншиж хэвтэхэд Цэен цонхоор газар орныг сонирхон, янжуураа уугиулна. Гэтэл Мугдэнд хүрэхийн өмнөхөн Бадрах,

- Цэен гуай таныг Мугдэнд очиход Тозияа сан угтаж уулзана. Тэр таны ирэх өдөр, галт тэргийг мэдэж байгаа. Үүнээс хойш та бид хоёр уулзахгүй байх. Тэгэхээр одоо ажил хэргээ ярилцъя гээд нэгэн жижиг сахиус хүзүүнээсээ мулталж аваад Цэенд өгөхдөө,

- Цэен гуай энэ сахиусанд Шанхай дахь Америкийн банкинд хадгалуулсан алтыг авах эрхийн томьёо, түүнийг хэрхэн хэрэглэх заавар, өөр газар шилжүүлэх заавар бий. Банкнд байгаа алтны хадгаламжийн төлөөсийг таван жилээр хийсэн. Харин та үргэлжлүүлж төлөх болно. Наран улсаас цэргийн тусламж өгөх талаар эзэн хааны зарлиг гарсан үед та, алт эрдэнэсийг зарах бүрэн эрх эдлэх ёстой. Ер нь алтыг дамлаж доллар болгох нь чухал. Энэ ажилд танд тус болох хүнийг хүрээнээс жич илгээнэ. Тэр хүн тантай ирж уулзахдаа бурхны

тиг сураглаж ирнэ. Тэр хүнд алтаа өгч дамлуулах хэрэгтэй. Таныг Мугдэнд очсоны дараагаар сонины сурвалжлагч, элчин төлөөлөгчид сонирхох байх. Та Наран улсаас цэргийн тусламж авах хэргээр Мугдэнд ирсэн тухайгаа хэнд ч цухуйлгаж болохгүй. Энэ бол маш нууц ажил. Тэгэхээр Мугдэнд ирсэн тухайгаа өөр зүйлээр тухайлбал ахтайгаа уулзах гэж ирсэн гэхэд хэн ч үнэмшинэ шүү гээд бурхны тиг сураглаж ирэх хүний хэлэх үг, уулзах дохио, хариу сорих түлхүүр зэргийг Бадрах, Цэенд дэс дараалан хэлж өглөө.

Мугдэн бол зүүн умард хятадын гурван мужийг захирсан Жан Золингийн нийслэл учраас хуучин нэрээр нь Фынтянь гэж нэрлэдэг болжээ. Жан Золин эдүгээ 47 настай, эрт өвгөрч яваа, догшин ширүүн зан авиртай учраас түүнийг "төмөр ташуур" гэж хочлох удаатай. Тэрээр орос, японы дайны үеэр Манжуурын толгодоор тэнүүчлэн, дорнод хятадын төмөр замын тээвэр рүү дайрч уулгалдаг байснаас хунхууз (дээрэмчин) гэж алдаршсан. Дайны дараагаар өмнөд манжуурыг япон эзэмших болсон тэр үед Жан Золин, японы дэмжлэгээр өөрийнхөө дээрэмчдийг хятадын цэрэгтэй нэгтгэж чадсанаар цэргийн эрхтэн болж, зүүн өмнөд хятадын гурван мужийн захирагч болсноор Мугдэнг Фынтянь гэж хуучин нэрээр нь нэрлэж, өөрийгөө Фынтяний захирагч гэж алдаршуулсан билээ.

Монголд ардын засаг тогтоход монголын зарим ноёд Жан Золин руу гар сунгах болсныг мэдсэн Богд, Жан ноёныг биш, харин түүнийг захирдаг японыг түших гэсэн нь учир утгагүй зүйл бишээ. Тиймээс Цэенг Манжуур руу явуулсан. Цэен Мугдэнд ирээд Тозияагийн д байрлалаа. Тэгээд оройн хоол зооглож байхдаа луун хээтэй, шар мяндсан дугтуйтай бичиг гаргаж Тозияад өгөхдөө,

- Богд хаан Наран улсын эзэн хаан тэнноод өргөсөн айлтгал бичиг. Та үүнийг дамжуулж, хариу айлтгалыг надад соёрхоно биз гээд гардуулав.

- Цэен минь, эзэн хаан мэйжи исин Иосихитогийн бие

чилээрхээд хоёр жил шахам болж байна. Гэхдээ энэ айлтгалыг би, армийн удирдлагаар дамжуулж, хаан хүү Хирохитоогийн гарт хүргэж чадна. Гэхдээ үүнийг шийдэхэд нэлээн хугацаа зарцуулж магадгүй шүү гэж хаяагаа манав.

- Тозияа сан, богд хаан зээл авахгүй. Өөрийнхөө сангаас шууд алт юмуу америк янчаан гаргана гэсэн. Тэгэхээр энэ асуудлыг хойшлуулж удааж болохгүй гэдгийг армийн удирдлагад дамжуулах нь чухал.

- Тэгвэл Богд хаантан Монголороос авсан алтаар биднийг хөрөнгөжүүлэх нь шив дээ. Ухаантай хүний шинж дээ. Харин Богд хаантан, манайхаас авах цэргийн тусламжинд аль зэрэг алт зориулах бол? Та энэ талаар юу бодож байна даа гэж Тозияа эвтэйхэн шалав.

- Миний бодож байгаагаар бол гар татахгүй байх.

- Тийм их алтыг монголоос наашаа авчирна гэдэг амаргүй ажил. Тун нарийн ухаан хэрэгтэй гэж Тозияаг хэлэхэд Цэен,

- Таны хэлсэн бүхнийг Богд хаантан мартаагүй. Тэгээд ч тэр алтыг чинь авчирсан байгаа

гэхэд Тозияагийн сэтгэлд нар гарах шиг болжээ. Тозияа Богдтой ярилцаж байсан үгээ санангуут дотроо "Тэгвэл олон лан алттай ирсэн байх нь ээ, энэ чинь их хөрөнгө шүү" гэж бодоод,

- Тэгвэл та, Богд хааны хэргийг амархан бүтээх юм байна гээд ширээнээс өндийлөө. Цэен Тозияаг даган өндийхдөө үл мэдэг тэнцвэр алдан гуйвснаа мэдэнгүүт "Би чинь согтож байна даа" гэж бодоод,

- Тозияа надад чамтай ярих хувийн юм бий гээд өрөөндөө оронгуут хоёр чемоданаа уудлахад алт, сувд, эрдэнэсийн чулуу Тозияагийн нүднээ тусахад "Цэен ч аргагүй л алттай ирж дээ" гэдэг бодол төрлөө.

- Тозияа би чамд их баярлаж явдаг юм. Чи миний аминд хэд хэдэн удаа орсон хүн. Тэр жил гамингаас амь зулбаж явахад чи, миний ар гэрийг харж хандаж, муу охиныг минь гамингийн гараас холдуулж, Туулын гүний Хүрээ рүү явуулж аварсан байсан. Би чиний ачаар Богдыг хаан ширээнд залалцаж гүн зэрэг хүртсэн. Ингэхээр би чамаас харамлах юм байхгүй. Чи эндээс дуртайгаа ав! Энэ бол чи бид хоёрын хөрөнгө гэж бардамналаа.

- Цэен минь, энэ чинь чамд их хэрэг болно. Энд чинь хөрөнгөтэй бол алдар нэртэй, танил талтай явдаг газар гэхэд,

- Би ч түүнийг мэдэж байна. Тэгэхээр үүнийг америк янчаан болгоод хадгалуулчих санаатай байна. Зүгээр хэвтэж байхаар үржиж байсан нь дээр биз дээ гэхэд Тозияа сэтгэлдээ "Богд хаан монголын үндэсний үзэлтнүүдийг өөрийнхөө гарт чангахан атгаж, их найдвар тавьж дээ. Монголын төр шашны ширээг түвдүүдийн удам угсаанаас салгахгүйн тулд энэ зэргийг бодолгүй яах вэ! Харин Цэен гүн алт мөнгөө хадгалуулж үржүүлэх талаар надад цухуйлгаж байгааг үзвэл Богдын алтыг Цэен хятадад авчраагүй юм байна. Таван жил надтай үерхэж дассан болохоор гарын бэл болгож авчирсан хөрөнгөөрөө баярхаж байгаа хэрэг! Цэен Богдын алтыг өөрөө авчирсан бол энэ хөрөнгөө алт хадгалуулсан газраа хийгээд хүүгээ тоолж байх ёстой. Гэтэл үүнийг доллар болгоод банкинд хадгалуулж, арвижуулахыг бодож байгааг үзвэл Цэен хятадад ирчихсэн Богдын алтыг авч хэрэглэх эрх бүхий төлөөний хүн байх нь! Тэгэхээр Цэен гүний нэрийг Манжуурт хадаахын тулд Богд энэ хөрөнгийг бас гаргасан хэрэг. Богд тэр жил надтай ярилцахдаа Гуаньдун дахь манай цэргийг сайн мэдэж байсан. Тэгэхээр түүний харалган нүд, хагуу чихийг орлодог тийм хүн хятадад байдаг байх нь. Тэр хэн бэ? Цэенг Мугдэнд ирэх тухай надад хэлсэн тэр өвөрмонгол уу? Байз байз... тэр хүн яриандаа хос эгшгийг цэвэрхэн хэлсэн байх шүү. Гэтэл өвөрлөгч аялгуунд монголын хос эгшгийг ихэвчлэн урт эгшгээр хэлдэг шүү дээ. Тэгвэл Богдын нүд, чих надтай ирж уулзахдаа аятайхан жүжиглэсэн байх нь ээ!" гэж бодож байтал Цэен, үл мэдэх үнэт чулуун шигтгээтэй хоёр бөгж авч Тозияад барихдаа,

- Чи хүрээнд байхдаа намайг яаж эрхлүүлж байлаа. Би чиний гарыг цайлгаж чадалгүй явуулсандаа харамсдаг юм. Одоо үүнийг бэлэг болгож барья гэхэд Тозияа нэрэлхүү зангаар,

- Яасан их бэлэг вэ? гээд амьд яваа насандаа олж хараагүй эрдэнэсээс нүд үл салгана.

- Тозияа сан, танай Токиогийн Иокогама гингоод эзэн хаан Иосихитогийн алт, эрдэнэс

хадгалагддаг учраас тэр гингогийн (банкны) бүх хөрөнгөний хагасыг эзэлдэг юм гэсэн үнэн үү? гэж Цэенг асуухад Тозияа,

- Цэен минь, над шиг хүн түүнийг яаж мэдэх вэ? Харин Мугдэнд байгаа Иокогама гингогийн салбарт наадахаа барьцаалан хадгалуулбал болно шүү гэлээ.

- Барьцаанд хадгалуулснаас цөмийг нь янчаан болгосон нь

дээр.

- Би тэгвэл Тяньжин, Шанхай, Бээжингийн алт, эрдэнэсийн хорхойтнуудтай холбоо барьж болно шүү.

- Тэгж үз. Ер нь эндхийн ихэс дээдэстэй холбоотой байвал миний ажил хэрэг бүтэмжтэй байх болно. Чи энэ талаар нэг юм бодно байгаа гэж хэлэхэд Тозияа Цэен гүнгийн үгнээс санаа авч хэд хоносны дараа Мугдэн дэх японы цэргийн удирдах ажилтан, Жан Золингийн ойр дотны хүмүүсийг урьж томоохон хүлээн авалт хийлээ. Тэгээд Цэен гүнгийн баян, бэлтэйг тэнгэрт тулгал давслаад, Мугдэнд ирсэн хэрэг зорилгыг тас нууж, төрсөн ахаа бараадаж байгаа юм гэдэг нэрийдлээр тэдний амыг таглав. Харин Дайрангаас ажлаар ирсэн нэг сонин сурвалжлагчтай Цэен гүнг дотно танилцуулсан болой. Чингээд сар болсны дараа Шанхай, Бээжин, Тяньжингээс хэдэн хүн ирж Цэенгийн алт эрдэнэсийг үнэ хаялцан худалдаж авснаар Цэен гүн таван сая төгрөгний хадгаламжийг Иокогама гингогийн салбарт нээжээ. Түүнээс хойш Мугдэн дэх гадаадын сурвалжлагч нар үл ялиг шуугиан дэгдээж, Цэенг Мугдэнд ирсэн явдлыг ямар нэг улс төр, цэргийн бодлоготой уялдуулах болсон учраас Тозияа нэгэн өдөр хэсэг сурвалжлагч нарыг Мугдэн дэх японы цэргийн төлөөлөгчийн газар урьж Цэентэй уулзуулав.

- Цэен гүнтэн гуай, таны өвөг дээдэстэй жирмийн чуулганы Засаг, Түшээт, Дархан, Бинт вангийнхан ямар холбоотой байсан бэ? гэж нэг сурвалжлагч нухацтай асуув.

- Миний өвөг дээдэс Богд эзэн Чингэсээс уламжлалтай. Тэгээд энд нутаглаж байсан юм. Тэгэхээр саяын таны тоочдог хошуудын их бага хүмүүс миний цусан төрөл юм шүү дээ. Цусан төрлөө та тоодоггүй хэрэг үү гэж тохуурхан хэлтэл нэг сурвалжлагч,

- Цэен гуай та, ах дүүгээ бараадахаар ирсэн хэрэг үү? Эсвэл Чингэс богдын эзэнт улсыг сэргээн тогтоож, ар өвөр монголыг нэгтгэх улс төрийн бодлогоор ирсэн үү? гэж ээрлээ.

- Чингэсийн эзэнт улсыг дахин сэргээх байтугай ар Монголоосулааны нөлөөг зайлуулж чадахгүй байна. Ийм үед таны толгойд Чингэсийн эзэнт улсыг дахин байгуулна гэж яаж багтаа вэ? Энэ чинь хүүхдийн тоглоом биш шүү.

- Халхын ноёд Жан Золингийн хүчинд найдаж цэргийн тусламж гуйж байна. Та үүнийг юу гэж бодож байна?

- Та Жан золингийн нууцыг мэдэж байдаг бол өөрөө тэр ноёдтойгоо яаж ярилцахаа мэдэх биз. Би тэр их хүнтэй энэ тухай ярих байтугай зүсийг нь ч хараагүй. Нөгөө талаар гэхэд

Манжуур хятадын нөлөөнөөс гарч, биеэ даасан засаг төртэй улс болоогүй мөртлөө ар Монголд тогтсон ардын засгийг устгаад Богд хаант төрийг сэргээн тогтооно гэдэг голионы жогорхой болно байхаа даа гэж Цэенг хэлэхэд бас нэг сурвалжлагч,

- Богд Жавзандамба хутагт, ар өвөр монголыг нэгтгэж, Нармай Монгол улс байгуулахад элэгтэй гэдэг. Тиймээс Наран улсын эзэн хаанд тусгай захиа явуулж байсан удаатай. Дам ярианаас үзвэл Богд хаан өөрийн төлөөний хүнийг Наран улсын эзэн хаан руу явуулсан гэнэ. Таны Мугдэнд ирсэн явдал үүнтэй ямар холбоотой вэ?

- Богд хаантан юу боддогоо надад айлддаггүй юм шүү. Тиймээс наад асуултаа Богд гэгээнтнээс очиж асуусан нь дээр биз. Богдын тусгай элчтэй уулзахаар эзэн хаан Иосихито Мугдэнд ирэх юм гэж та дуулсан юм биш биз. Та Наран улсын эзэн хаан хэвтэрт ороод хоёр жил болж байгааг дуулаагүй юу? Харин миний бие Мугдэнд ирсэн явдал гэвэл Дархан вангийн нутаг руу очиход Мугдэнгээр дайрдаг юм. Нөгөө талаар Тозияа сан миний хүргэн гэдгийг битгий мартаарай. Тэгэхээр та ч гэсэн хүргэн дүүгийн дээ очдог юм байгаа биз дээ гэж хариулснаар хэл ам сугалчих шахсан хүмүүсээс хоёр яс хагацсандаа Цэен сэтгэлдээ баярлаж, санаа амарчээ. Чингээд сонин сурвалжлагч нар Цэенгийн талаар цуудам зүйл ярихаа больж, Цэен ч сурвалжлагч нарт ярьсан зүйлээ батлахын тулд Дархан вангийн хошуунд амьдардаг ах Баатартай очиж золгохоор зэхэв.

Цэен, Иокогама гингогийн салбарт таван сая доллар хадгалуулсны дараа Азийн Та Да хэмээх пүүснийхэн түүнийг сонирхож, Харбин дахь орос худалдаачин Потапов гэгч ажиж байлаа. Та Да пүүсийн эзэн Хан Иньсугийн бие төлөөний хүн Цэентэй уулзав.

Сэцэн хан аймгийн захын да вангийн хошуунд ихээхэн өгөөжтэй Буйр нуур бий. Харбины Боронцов, Потапов зэрэг худалдаачид манайтай хоршиж, тэр нуурт загасны үйлдвэр байгуулах санал тавьсан юм. Бид орос хүнтэй ганзага нийлүүлснээс нутгийн халх хүнтэй хоршвол зүгээр байх гэж бодож байна. Гэтэл тань шиг бэлтэй хүн Мугдэнд байтугай Халхад ховор гэхэд,

- Би худалдаа наймаа эрхлэхийг боддоггүй. Тэгээд ч малынхаа буянаар амаа тосдож өдий хүрснээс биш усны замаг шүүрдэж гэдсээ цайлгаж сураагүй юм гэснээр тэдний яриа талаар өнгөрчээ. Цэен ирснээсээ хойш хоттой танилцаж, Биржийн гудамжны хөл үймээнд дасаж, угийн сурсан зангаараа бие сэтгэлийн хувь хуваалцах бодолд үе үе захирагддаг боловч «Дасаагүй газрын даавуу хатуу» гэдгийг бодоод сэтгэлийн шохоорхлыг барина. Гэтэл нэг орой Тозияа Цэентэй ярьж, аягатай сакэ балгаж суухдаа,

- Цэен сан, та хотоор хамаагүй явж болохгүй шүү. Энэ чинь хүрээ биш гэж ямар нэг юм сануулах гэсэн шиг хэлэв.

- Тозияа сан, хүрээнд чиний буянаар туйлж байжээ. Тийм газар ийм том хотод байдаггүй юм уу? Тэгээд ч би чинь заазлуулчихсан мал биш. Дөч хүрсэн эр хүнийг юу гэдгийг чи надаар хэлүүлэлтгүй мэдэх хойно. За тэгээд одоо амжиж амьдын жаргал эдлэхгүй бол өнөө тоотой хэдэн нас дууслаа шүү дээ.

Тиймээ. Гэхдээ эндхийнхэн архи, хүүхэн хоёр хөрөнгийг чинь хоослоод зогсохгүй толгойг

чинь уургална гэдгийг бодож яв. Да ван яасныг чи дуулаа биз дээ.

- Би да ван шиг ухаанаа архинд өгч, толгойгоо садар хүүхний тэлээнээс чиргүүлэхгүй. Тэгээд ч намайг тийм амархан урхидахгүй гэдгийг чи мэднэ шүү дээ!

- Чи миний дэн буудал, гуанзыг худалдаж авсан тэр данжаадыг сүрхий дөнгөсөн шүү. Надтай уулзаад «Танай танил гүнгийн алтан бөгжийг манай нэг хүүхэн хумсалчихаж. Тэгсэн чинь түүнийг далимдуулаад надаас янхан хүүхний хөлсийг нэхэх хэрэггүй Би танайд ирэх болгондоо гурав гурван цэнгийн гурван бөгжөө алдсан одоо эзнийг нь оллоо. Тэгэхээр янхан хүүхнүүдээсээ миний гурван гурав есөн цэн алтны үнийг төлүүлж аль» гэж ял тулгасан гэж хэлээд уйлах дөхөж билээ. Тэгээд чамайг ухаан сийлж гэдгийг мэдээд би, түүнээс авах ёстой өрөө аваагүй, өнгөрсөн юмдаг гэлээ.

- Чи юунд тэр муусайн хужааг тэгж гааруулсан юм бэ? Муу шаахайгаа үүрч ирсэн хужаагаас тийм санаа гарч байхад халхын хүүгээс илүү санаа гарах ёстой биз дээ. Ингэж байж муусайн хужаануудыг өөрсдийнх нь гараар боож, хясах хэрэгтэй.

- Эндхийн данжаадууд чинь тэр хужаа нартай адилгүй шүү.

- За юу шалив гэж дээ. Бас шаахайгаа үүрч Манжуурт ирсэн новшнууд. Тозияа сан, миний ухаан муу юманд сайн гүйдэг юм. Тэгэхээр Манжуурын хужаа нарт тийм ч амархан дөнгүүлэхгүй. Дөнгөж, давахыг бодно доо.

- За өөрөө мэд. Биржийн гудамжинд нэг луухаан бий. Гарлаараа бол монгол эцэгтэй, хятад эхтэй хүн. Тэднийхээр орвол арай элэг зөөлөн байж мэднэ гээд Тозияа тэр газрын хаягийг хэлж өглөө.

Цэен энэ ярианаас хойш дэн буудал бүхий тэр гуанзаар хэд хэд очжээ. Нэг удаа өглөөнөөс хойш зоогийн газар сууж, гурван шил маотуу авч уухдаа хүний нүд хариулж байгаад хундагатай архиа дэргэдээ байгаа цэцгийн сав руу хийчихээд согтсон хүний дүр гаргажээ. Тэгээд үйлчлэгч залууг дуудаж,

- Танайд тухтай амарчих газар бий юу? гэж асуув.

- Та хоёулаа амрах уу? Эсвэл ганцаараа юу?

- Хоёулаа бол илүү зугаатай биз гэхэд өнөө үйлчлэгч,

- За тэгвэл намайг дагаад яв гэлээ.

Тэд нэгэн тохилог зассан өрөөнд орж ирэхэд үйлчлэгч залуу,

- Одоо ингэсхийгээд хүүхнүүд орж ирнэ. Та өөртөө таалагдсаныг нь сонгоод нүдээрээ дохио өгөөрэй гэлээ.

Цэен гаднаас орж ирсэн хүүхнүүдийг ажвал чамин дэвүүр барьж инээмсэглэсэн залуу хүүхнүүд байлаа. Эрвээхэй шиг алаг цоохор болтлоо будаж оодоод, урт нарийхан хөмсгөө

өргөсхийн харсан, нарийн бэлхүүстэй, уяхан намбатай хөдөлгөөнтэй хүүхнүүдийг харвал шөнийнхөө нойронд ханаагүй болохоор уйлж нойрмоглосон нүдээр Цэенг ширтэж, алган дээрээ бөмбөрүүлж

буй эрхий хуруун чинээ хан сувдыг шохоорхон харна. Хаадын эрдэнэсийн санд ч ховор байдаг хан сувдыг алган дээрээ өнхрүүлж, хүмүүсийн анхаарлыг татаж, баян чинээлгээ гайхуулах дуртай Цэен хүүхнүүдийг харж зогсохдоо «Ихэнх нь будаг шунхаар өөрийгөө тордсон хүүхнүүд юм» гэж бодож, байхад хүүхнүүдийн харц хан сувдан дээр унажээ. Эхний хүүхнүүдийг гарсны дараа гурван хүүхэн орж ирсэн нь Цэенгийн сэтгэлд бас таалагдсангүй. Харин долоо дахь хүүхэн нь дөнгөж хорь гаруйхан насны бие цогцос тэгшхэн, царай зүс сарнаас төрсөн юм шиг тунгалагхан гэрэлтсэн, ёстой сайхан хүүхэн агаад нарийн бэлхүүсээ уяхан хөдөлгөхийг ажваас сэтгэлийн эчнээнд тачаалын галыг өрдөн шатаах дөхсөн ид шидтэй хүүхэн байлаа. Цэен түүнийг харж хэсэгхэн алмайран зогсохдоо «Ёстой эрхэлж наадаж, элдвийг нь үзэж, сэтгэлээ хужирламаар хүүхэн чинь энэ байна даа» гэж бодтол хамаг бие нь халуу дүүгэн шатах шиг болж энд тэндгүй чимчигнэнэ. Цэен тачаангуйн дөлөнд өртсөнөө мэдэнгүүт нүдээ ирмэж дохио өгтөл үйлчлэгч залуу бүсгүйн чихэнд хэдэн юм шивнээд өрөөнөөс гарлаа. Зуны чийглэг салхинд найгаж байгаа турьхан цэцэг шиг уран хөдөлгөөнтэй, бэрээмгийн өнгө шиг улаан уруулаа жимийн инээмсэглэсэн тэр хүүхний нимгэн мяндсан хувцасны цаанаас булбарай, нүцгэн бие цогцос гэрэлтэхийг харсан Цэен, хэсэгхэн алмайрч байтал өнөө бүсгүй,

- Анатава нихонго о ханашимасука (Та японоор ярьдаг уу?) гэж асуухад Цэен хүүхний гоо сайхан биеийг ширтэн бахархсаар хөшөө шиг хөдөлгөөнгүй сууна. Гэтэл өнөө хүүхэн жагар орны удвал цэцэг дэлбээгээ дэлгэж байгаа юм шиг нарийн жимбэгэр уруулаар инээмсэглэсээр дэргэд нь ирж зогсоод,

- Тэгвэл хоёулаа монголоор ярих уу гэж хорчин аялгуугаар хэлэхэд Цэен сая ухаан залгаж толгой дохиод, хүүхнийг тэвэрч авангуут нимгэн уруулыг нь шимж, үлгэж гарлаа.

- Ноёнтон гуай, жаахан хүлээ л дээ. Битгий сандар. Хамаг бие чинь салгалж чичрээд эвгүй байна. Би хувцсыг чинь тайлж өгье. Тэгээд тайвшир гэж хэлэхэд гүнгийн чихнээ сонсголонтой энхрий зөөлөн дуу тод сонсогдож янаг санагдав. Цэен чингэж янхны газар хоносны маргааш өглөө нь Тозияа өөрийн туслах Симотоог өрөөндөө дуудаж байдлыг асуув.

- Тозияа сан, Цэен янхны газар хоносон боловч давхар мэх хэрэглэжээ. Янхны газрын хүүхэн гүнг нэлээн согтоогоод шөнөжин наргихдаа өнөө хан сувдуудыг нь хумсалсан байна. Гэтэл ухаангүй юм шиг байсан Цэен гэнэт босож ирээд хүүхнийг айлган сүрдүүлж, хэнээс даалгавартай болохыг нь асууж шалгаажээ.

- Би та нарт эс хэлсэн билүү. Цэен хүүхэнд дуртай боловч тэдний тэлээнд зүүгдэх хүн биш. Харин өөрсдийн нь аргаар өөрийг нь боомилдог хүн. Тэр хоёр хан сувдыг гараасаа салгадаггүй нэг учир энэ! Симото сан чи Тяньжин, Шанхай, Бээжинд байдаг гадаадын пүүсээс их гүрний банкинд хадгалуулсан хөрөнгийг, сонирхооч. Ялангуяа Тяньжин дахь Английн олон улсын банкинд ямар ямар баячууд алт мөнгөө хадгалуулсныг нарийн мэдэх хэрэгтэй. Энэ хэргээс шалтгаалж Гэрэлээ гэдэг хүүхнийг янхны газраас зайлуулах хэрэггүй. Харин эзэнтэй нь тохирч, тэнд нь байлгах хэрэгтэй гэж чандлан тушаажээ.

Тозияа, Мугдэнд ирээд сайд нарын, цэргийн яаманд нэгэн захиа явуулж тайлан тавихдаа "Богд, эзэн хааны армид түшиглэж, цэргийн тусламж авахын тулд түмэн лан алт гаргах бодолтой байна" гэж онцолжээ. Гэтэл энэ тайланг кэмпэйтэйнхан олж (кэм-хянан цагдах үндэс, пэй-цэрэг, тай-анги буюу хянан мөрдөх цэргийн үндсэн анги гэсэн утгатай японы сөрөг тагнуулын газар) аваад цэргийн яамны нөлөө бүхий хүмүүстэй уулзаж, алс дорнод, манжуур, ар өвөр монголд явуулах тагнуулын хорлон сүйтгэх үйл ажиллагаа, Харбин дахь цагаантны дүрвэгсдийн товчоог ашиглахад зарцуулахаар сэм тохиролцжээ. Тэгээд энэ ажлыг Тозияад хариуцуулахаар шийдсэн байв. Тозияа үүнийг яг мэдээгүй боловч багцаалж байлаа.

Тэрээр армийн удирдлагад нэр төрөө сэргээхийн тулд ийм алхам хийсэн нь бас өөрийн нь зохиосон мэх болохыг хэн яахан мэдэх билээ. Тозияа Симоотоод хятад дахь их гүрний банкны хадгаламжийг сонирхох үүрэг өгснөөс хойш арваад хоноод Цэен гүн ахтайгаа уулзахаар Дархан вангийн хошуу руу явав.

Баатар гүн эдүгээ дөчин дөрөвтэй авч шанааны нь үс бууралтаж, хөгшрөх тийшээгээ оржээ. Тэрээр сүүлийн таван жил өвчнөөс салсангүй. Тэр ходоод, элэг цөсний өвчтэй болохоор хоолоо хязгаарлаад, эцэж турсны нөлөөгөөр царай шаналангүй болжээ. Хүний нутагт арав гаруй жил болсон ахыгаа эмгэг өвчинд ээрэгдсэнийг мэдсэн Цэенгийн сэтгэл эмтрэн «Ийм хүн байгаагүй юмсан» гэж харуусна.

- Цэен минь ганц охиноо үлдээгээд ирдэг чинь муу байна. Гэхдээ ардын төлөө засаг бол гоочилж зовоохгүй биз. Эцгийн алдааг охинд нь тохож, эрүүдэн шүүх ёс байхгүй байх ёстой. Харин яагаад наашаа ирэв дээ. Цэен дэргэдээ байгаа арван хоёр настай Хасбаатарын толгойг илэн, өвөр дээрээ суулгаад,

- Ах минь ардын засаг гэдэг чинь хоймор байгаа бурхан тахилаас эхлээд устгах санаатай байна. Тэгэхээр энэ толгой мөрөн дээр яваа цагт ардын засгаас алба, хэргэм горилохгүй гэж бодлоо.

- Тэгээд энд ирж яах юм бэ?

- Амьдрахыг бодно. Охиноо авчирна гэж бодож байгаа.

- Ардын засаг бурхан шүтээнийг чинь дав даруй шатаачихгүй байх. Ер нь тэгээд бурханд олон жил мөргөж духаа, цоолох шахсан монголчууд ямар аз жаргал үзсэн бэ? Хий сүсгээр сэтгэлээ гашилгаж, хоосон номлолоор тархиа манантуулснаас цаашгүй өөр сайн сайхныг үзээгүй.

- Та юу ярьж байна? Тэгвэл, таны энэ хоймор байгаа бурхан шүтээн чинь юу болж байна вэ?

- Шүтнэ гэвэл ондоо хэрэг. Би зөвхөн эцгийнхээ шүтээнийг хадгалж яваа юм. Ер нь дам сураг дуулбал бурханд залбирч гуйгаад олоогүй аз жаргалыг ардын засаг, ард түмэнд олгосон юм биш үү?

- Улааны сургаар ингэж байгаа юм чинь, хүрээнд байсан бол хамгийн түрүүнд Богдын амь насанд халдах байж дээ.

- Богд... Богд. Биднийг зуу гаруй жил мунхруулж эзэгнэсэн түвдүүд монголчуудыг юугаар гялайлгасан юм бэ?

- Ах минь чиний эдэлж яваа гүн зэргийг Богд гэгээн эцэгт минь өгсний буянаар төдий хүрээ биз дээ. Богд манжаас биднийг салгаж өглөө. Энэ чинь Богдын буян биш үү?

- Чи их төөрч яваа юм байна. Хэргэм зэргийн хувьд гэвэл надад ёс төдий зүйл! Харин монголчуудыг манжаас тусгаарлаж, хаант төр тогтоосон явдалд бол манай дэвшилт үзэлтэй хүмүүсийн гавьяа, нийгмийн хөгжлийн нэг үзэгдэл! Ардын засгийн газар тогтоно гэдэг бол манай ард түмний ухамсартай тэмцэл, түүнийг удирдан зохион байгуулсан намын гавьяа юм. Гэтэл чи ард түмний тэмцлээр тогтсон засгийг устгаж, монгол орныг японы эзэн хааны эзэмшил болгож, манжийн үеийн талхидлыг японыхоор солихоор энд ирснийг Дайран Симбун сонинд Тогава гэдэг хүн тодорхой бичсэн байна. Цэен ахаасаа энэ үгийг сонсоод тэр нэг өдөр Тозияа, Тогаватай танилцуулахдаа «Мүгдэнд ирсэн хэрэг зорилгоо энэ хүнд цухуйлгаж болно. Гэхдээ тодорхой ярих хэрэггүй» гэснийг санав.

- Ах минь за больё. Миний толгой мөрөн дээрээ тогтож байгаа цагт би тэр гуйлгачин дорд заяаны хүмүүсийн төлөө хурууныхаа үзүүрийг ч зориулахгүй. Тийм сүрхийгээрээ чи тэр муусайн гуйлгачингуудын төлөө боож үхнэ биз гэчихээд ахыгаа «чи» гэж хэлсэндээ баахан эмээж дуугүй боллоо. Тэгээд гэрийн ширдэг ширтэн, тэргүүн бөхийлгөн суухдаа тэр нэг жил хэлсэн эцгийнхээ үгийг бодов. Баатар эцгийгээ өөд болохоос өмнө очиж уулзсан. Тэгэхэд эцэг Цэенд захихдаа «Ах чинь биднээс хол, манай хамжлага нар дээр өссөн тэнэгдүү боольхой хүн. Тэгэхээр хүн ахтай, дээл захтай гэдгийг бодоод ахыгаа ад үзэлгүй яваарай. Та хоёр муудалцвал амьтан хүний элэг доог болно» гэж билээ.

Баатар дүүгийнхээ хэлсэн үгийг эргэцүүлэн бодоод «Аргагүй аавын ааш занг хуулжээ. Тэр жил (1907 он) эцэг минь надтай уулзаад «Хар бор айлын хаяа түшиж явсан чам шиг хүн, төр улсын хэрэгт зүтгэнэ гэдэг их аз! Манай удам, төр улсынхаа төлөө гэж явсан гавьяа зүтгэлтэй. Түүнээс чам шиг хар бор хүмүүстэй холилдож, тэднийг гэж явж байгаагүй. Одоо чи харь газар явж юмны хар цагааныг ялгах болсон. Тэгэхээр тэнгэрийн язгуураас гаралтайгаа бод» гэж хэлснийг санав.

- Цэен минь, би чиний ах болохоор ахархаад дургүйг чинь хүргэсэн үг хэлсэн байж магадгүй. Гэхдээ чи, миний үгийг сонсох ёстой хүн. Чиний улс орноо гэдэг бодол зөвхөн удам угсаанд тулгуурласан явцуу өрөөсгөл бодол! Харин түүнээс чинь арай илүү гүнзгий ард түмэн гэдэг юмыг бод!

- Таны тэр ард түмэн гэдэг чинь юу юм бэ? Буянаа гөвчихсөн заяагүй гуйлгачин, гахай нүцгэн нохой явган харчуул борчуул шүү дээ. Харин бид бол... гэтэл Баатар явган ширээн дээрх гансаа шүүрэн аваад,

- Дуугаа тат! гэж хашгиран хэлтэл гаднаас арван долоо найман насны нэг бүсгүй орж ирээд,

- Адиа, та хоёрыг их гэрт (хадам эцгийн) хүрээд ир гэж байна гэж өвөө хэлүүллээ гэхэд Баатар,

- Сувдаа, чи очиж бай. Бид хоёр ингэсхийгээд очно гэж хэлэх нь бүсгүйн дууны өнгөтэй тун адилхан дуулав. Саяхан уур омогтоо багтарч байсан Баатар Сувдаагийн бараанаар тун эелдэг, зөөлөн дуугаар ярих нь Цэенд гайхаш төрүүлжээ. Цэен, Сувдааг гарахад «Ах минь аавыг дуурайсан, уураа түргэн барьдаг хүн юм даа» гэж бодож суутал Баатар,

- Цэен минь, саяын бүсгүй надтай адилхан байна уу? гэж асуулаа.

- Ах аа та чинь бас охинтой хэрэг үү? гэхэд Баатар уртаар санаа алдаад мод толгойгоо нэрлээ.

- Би тэр жил хүрээнээс нааш явахын өмнө аавд хэлсэн миний үгийг санаж байна уу? Тэгэхэд чи бид хоёр л аавын дэргэд байсан шүү дээ.

- Юу билээ. Аа тийм. Хүний охиныг ганцаардуулж болохгүй. Бас тэгээд хөл хүндтэй үлдсэн юм гэж байсан билүү гээд Цэен ах өөдөө харлаа.

Баатар хорин найман насандаа (1905 он) Гирин мужид ирж Бүгдийг захирах сайд амбаны газар алба хаажээ. Тэгээд хоёр жилийн дараа эцгийнхээ биеийг чилээрхлээ гэдгийг дуулаад түр чөлөөгөөр нутагтаа очсон юм.

- Цэен минь амьдрал хүнийг яаж ч өөрчилж мэдэх ээдрээтэй зүйл. Би энд ирээд нутгийн нэг бүсгүйтэй ханилах гэж байтал аавын бие муудсан учраас нутаг руугаа очсон юм. Тэгээд буцаад ирсэн чинь Дэжид маань ор сураггүй алга болсон байлаа. Би яаж ч хайгаад сургийг нь гаргаж чадаагүй юм. Хойтон жил нь Гирин мужийн захиргаанаас бүгдийг захирагч амбан сайдын тушаалаар монголчуудад зориулж гаргадаг «Монгол үгийн бодрол» гэдэг сонинд намайг ажиллуулах болов. Гэтэл нэг өдөр Дархан вангийн хошууны нэг залуу ирж надтай уулзаад нэг ёгт үлгэр нийтэлж өгөхийг гуйлаа. Тэр үлгэрт өмнө зүгийн нэг гичий нохой умар зүгт ирээд нэг малчинтай уулзаж, сайхан нутаг бэлчээр түрээслэн авчээ. Гэсэн ч тэр нь түрээсээ өгөлгүй олон жил болжээ. Тэгэхээр малчин нэг удаа түрээсээ нэхтэл өнөө гичий олон гөлөгтэйгөө нийлж, өнөө малчинг барьчих шахжээ. Би тэр ёгт үлгэрийг хэвлэж болохгүй гэдгийг өнөө залууд тайлбарлаад буцаасан юм гэтэл Цэен,

- Муусайн хужаа нар шаахайгаа үүрч монголд ирээд наад гичий нохой шиг дураараа дургиж байсан юм гэж дургүй нь хүрсэн янзтай хэлэв.

- Түүнээс хойш би тэднийхээр очдог боллоо. Тэгээд дүү хүүхэнтэй нь танилцаад ханилсан юм. Богдыг анх хаан ширээнд залсны дараа Харбины Оросын төмөр замын захиргаанаас «Монгол сонин бичиг» гэдэг сонин гаргахаар болж, намайг урьж ажиллуулахаар шийдсэн юм. Би сонинд ажиллах тухайгаа ярилцаж тохироод эхнэр хүүхдээ иртэл зочид буудалд байхаар тохиролцлоо.

...Баатар нэг өдөр ажлаасаа тараад буудал руугаа гэлдэрчээ. Өдөр бүр буудлын гол хаалганы довжооны дэргэд суугаад юм гуйдаг гуйлгачингуудын тоо хоёроор нэмэгдсэн байлаа. Баатар довжоо руу дөхөж очтол «Буянтаан юм хайрла» гэж нэг нь алга тосов. Баатар тэрхэн зуур зогсож өврөө уудалж, хэтэвчээ автал «Буянтаан юм хайрла» гэх дуу чихэнд нь өртсөнөөр хамаг бие нь арзасхийх шиг боллоо. Баатар чихэндээ хоногшсон тэр дууг сонсоод «Энэ чинь Дэжидийн дуутай яасан адилхан юм бэ?» гэж дотроо бодоод эргэхдээ ухаан балартан

алмайрав. Дэжид ч Баатарыг таниад дуугарч чадалгүй, уйлж ч чадалгүй шавар хөшөө шиг хөдөлгөөнгүй зогсоход нулимс нь ширгэж хуурайшсан нүдний зовхи татвалзан, уруул нь хий өмөлзөнө.

Баатар эхнэр охин хоёроо буудалд дагуулж ороод тэр шөнөжингөө эхнэртэйгээ ярьж үүр цайлгалаа.

- Охиноо гараад сар болж байтал эцэг маань нас барлаа. Би чиний ажилладаг газраас хэдэн юм зээлэхээр очсон чинь маргааш маргааш гэсээр байгаад сар болгов. Тэгж байж бараг хоёр сарын дараа хэдэн юм өглөө. Нутагтаа арайхийж очсон чинь ээж минь солио тусаад тэнээд явчихсан байв. Би ээжийн хойноос явж, Долнуурт очоод байдгаа өгч хоёр хурал хуруулав. Тэгээд амьдын зовлон эх адаггүй үргэлжилсэн юм гэхэд Баатар эхнэрээ өрөвдөж,

- Одоо амьд мэнд уулзсан хойно алзахгүй. Би та хоёрыг өөр дээрээ авна. Би чиний тухай эхнэртээ ярьсан, чамайг үргэлж асууж, хаана ямаршуухан яваа бол гэж сурагладаг юм даг гэлээ.

- Баатар минь, би одоо чамд хэрэггүй. Чи намайг яасан гэж бодож байна гээд уйлах гэсэн боловч нүднээс нь нулимс гарсангүй. Түүний нүдний нулимс аль хэдийн ширгэсэн бололтой. Тэгээд хэсэг дуугүй сууж сэтгэлээ тайвшруулаад яриагаа үргэлжлүүлэв.

...Би буцах гээд чадсангүй. Улаан мөнгөгүй болохоор одоо яая гэх вэ? Хэр тааруухан ажил хайсан боловч олдсонгүй. Сүүлдээ ганц охиноо харангадуулахад хүрлээ. Тэгээд би өөрийгөө гаргуунд гаргахаар шийдсэн. Надад ганц зам үлдсэн байв. Эх эцгээс заяасан зүс царай минь аминд орж, ганц охиноо том болголоо. Гэтэл сүүлдээ эмгэг өвчинд баригдаад арай үхсэнгүй. Тэгээд наашаа зүглэсэн юм. Чамайг энд байгааг сарын өмнө санамсаргүй нэгэн сониноос олж үзээд охиныг чинь амьд мэнд дээрээ уулзуулж бараадуулья гэж бодсон юм. Одоо чи надаас охиноо ав. Намайг дагавал хүн шиг хүн болж чадахгүй. Харин би, Богдын хүрээ орж нүглээ наманчилж, та хоёрынхоо төлөө буян үйлдье гэж бодож байна...

Баатар энэ бүхнийг ярьж суухдаа тамхиа угсруулан нэрнэ.

- Ах аа та наад тамхиа болиоч. Ингэж татахаар бие чинь яаж өөдтэй байх вэ дээ гэхэд Баатар,

- Би хүний ганц бүсгүйг ингэж тамд живүүлснээ бодохоор энэ гацуун утаагаар өөрийгөө тайвшруулдаг юм. Дэжид миний үгэнд орохгүй болохоор нь Харбины нэг танил худалдаачнаас хоёр мянган янчаан зээлж өгөөд, Хүрээ орох худалдаачдад дайж явуулсан юм гэж хэлээд тамхиа шуналтай сорлоо. Чухам энэхэн үед гаднаас Сувдаа орж ирээд,

- Адиа аа, өвөө уурлаад байна шүү дээ гэхэд Баатар суудлаасаа босож,

- Цэен минь хоёулаа хадмынд орёе. Хөгшин, ах дүүгээ дуудаад ирүүлчихсэн байна билээ. Бодвол чамтай танилцуулж, нүүр хагалах гэсэн байх гэхэд Хасбаатар Цэенгийн өвөр дээрээс бууж Сувдаагийн гараас хөтлөлцсөөр гэрээс гарлаа. Баатар их гэр рүүгээ гэлдэрч явахдаа

- Цэен минь, би өвчин хуучинд баригдаад хөгшин хонины насгүй боллоо. Сувдаа минь над

дээр долоон настай ирсэн юм. Тэгээд хөгшний холын хамаатангийн гар дээр өсгөж өдий хүргэлээ. Одоо чи Сувдааг аваачиж ганц охиндоо дүү болгож, харж хандаж яв! Хэдийгээр хятад япон хэлэнд сайн ч гэсэн надаас хойш ганцаардах хүн байгаа юм гэхэд Цэен,

- Ах аа, та өөрийнхөө өвчнийг чагнаад байдаг юмаа даа. Түүнээс царай зүс чинь тийм ч доор ороогүй байна шүү гэж сэтгэлийг нь засна.

Цэенг ах руугаа явсны дараа нэг өдөр Мугдэн дэх цэргийн төлөөлөгчдийн газрын нэгэн удирдах ажилтан Тозияаг өрөөндөө дууджээ. Тозияа, дуудсан генералын өрөөнд орон ортол «Токиогоос ярья гэсэн юм байх даа. Өнөөдөр есөн сарын хоёрон. Тэгэхээр арай ярих болоогүй баймаар сан» гэж боджээ.

- Өчигдөр Токио, Иокогама хоёрт газар хөдөлсөн байна. Сүйрлийн талаар одоохондоо олигтой юм дуулдсангүй. Маргааш нөгөөдөртөө бүр тодорхой болох байх. Та гүнтэй уулзаж ярилцвал ямарсан бол! Токиогийн газар хөдлөлтөнд гүнтэн гар сунгах болов уу. Үүнийг мэдэх хэрэгтэй. Нөгөө талаар Харбинд суурьшихаар Сафронов гэдэг хүн, хүрээнээс гүнгийн охиныг дагуулан гарсан байна гэхэд Тозияа генерал руугаа гайхсан нүдээр гөлөрчээ. Гэвч генерал өөр зүйл рүү анхаарлаа хандуулсан болохоор Тозияагийн гайхсан харцыг анзааралгүй өнгөрлөө. Чухам энэхэн үед Тозияа Сафроновын тухай бодлоо.

Эцэг Сафронов, тэр жил хүүгийнхээ сургийг дуулаад удалгүй нас барсан. Уул нь Бароны Сапайяотой дотно байсан болохоор Барон Унгерн хүрээнээс гарахдаа 6000 рублийн тусгай шагнал өгч, хүү Иваныг нь Казаграндын мэдэлд шилжүүлж билээ. Гэтэл хүү нь Намнангийн хүрээний ойролцоо амь эрсэдсэн байлаа. Гэтэл хэдэн жилийн дараа Сафроновын хүү Иван Степанович Сафронов, гүнгийн охин Сайнжаргалтай хүрээнээс гарсан нь Тозияад гайхалтай санагдана.

- Гаккаа (Бага тушаалын дарга нар генералуудын цолыг хэлэлгүй чингэж хүндэлдэг нь угтаа генералаа гэсэн утгатай дүйцнэ) Да Хүрээний орос худалдаачин Сафроновын хүү Казаграндын отрядтай явж байгаад нас барсан. Харин эцэг нь ганц хүүгээсээ ёс бусаар саллаа гэж уй гашуу болж сэтгэл санаагаар унаж байгаад өөдөлсөн юм. Тэгэхээр хүрээнд эцэг хүү хоёрын аль аль нь байхгүй. Харин Сафроновын хүү Иваныг тодорхой мэдэх нэг хүн Харбин дахь оросын дүрвэгсдийн товчооны Игорь Самсонович Мешанов юм.

- Тозияа сан, тэгвэл та, Харбинтай холбоо барьж учрыг олно биз. Харин Гадаад монголын хичээнгүй сайд Цэрэндорж гэгчээс ирсэн нэг албан бичигт дурдсан Цэрэнпил гүн Харбин, Мугдэнгийн нөлөө бүхий хүмүүстэй холбоо тогтоох арга зам хайж байна. Тиймээс гүнтэнг түүнээс хөндий байлгах нь зүгээр байх шүү.

Тозияа, генералын өрөөнөөс гарч ирээд хэд хэдэн зүйлийг эргэцүүлэн бодов. Тэрээр юуны өмнө Харбинтай ярихаар шийдсэн төдийгүй генералын үгнээс санаа авч Токиогийн газар хөдлөлтийн талаар Цэенд дуулгахдаа Богдын алт хаана хадгалагдаж байгааг мэдэж авья гэж шийдэв.

Тозияа гэртээ орж ирэнгүүт Харбин руу залгуултал холбооны хүүхэн,

- Ноёнтоон, Харбины чиүса (дэд хурандаа) хэн гэдэг хүн ярьж байгааг сонирхож байна гэхэд Тозияа,

- Тайса (хурандаа) Тэцуда гэж хэлээрэй гэлээ. Тозияа цэргийн тусгай холбоогоор ийш тийшээ ярихдаа «Тэцуда-туслах» гэдэг нууц нэр хэрэглэдэг болой.

- Тайса доноогийн (ноён хурандаагийн) амрыг эрье гэх сөөнгө дуу чагнуурт паржигнахад Тозияа,

- Танай тэрүүгээр сонин юутай байна гэж асуулаа.

- Гойд сонин юм алга. Хүрээнээс Гочоо гэдэг хүн ирээд Буриадын цагаантан Тумановтой уулзаад Нармай монгол хэмээх Чингэсийн их гүрнийг сэргээн мандуулах талаар ярилцаж байгаа бололтой. Тэрээр Жан Золингоос зэр зэвсэг гуйх янзтай. Нөгөө Цэрэнпил бичээчийн талаар Гадаад монголын сайд Цэрэндоржийн бичгийг сонсоо биз дээ.

- Тэр талаар сонссон. Харин чамд нэг зүйлийг дуулгая. Хүрээнээс Сафронов гэдэг залуу манай гүнгийн охинтой гарсан сурагтай байна гэтэл,

- Тиймээ. Тэд Хайларт ирчихсэн байгаа гэж мэдэмхийрлээ.

- Тэднийг Хайлараас гарахад нь олигтойхон сүүл дагуулах хэрэгтэй. Танай тэнд хуучин Казаграндын отрядад явж байсан Мешанов гэдэг хүн байх ёстой. Түүнийг оросын дүрвэгсдийн товчооноос сураглаад хаяг, байр сууцыг мэдсэн байх хэрэгтэй. Намайг очтол тэднийг тэндээ асарч байгаарай гэж захилаа.

Тозияа Харбинтай ярьсны дараа «Хэрээ» хочит туршуулаа дуудаж, Дархан вангийн хошуу руу Цэенгийн хойноос явуулав. Гэтэл Тозияагийн туршуулыг Дархан вангийн хошуунд хүрээгүй явахад Цэен гүн Сувдааг дагуулж ирлээ. Тозияа, Цэентэй уулзаж, Сайнжаргалыг ирж явааг мэдэгдээд,

- Чи чинь юун бүсгүй дагуулаад ирэв ээ? гэж асуулаа.

- Сайнжаргалдаа дүү болгох юм гэхэд Тозияа дотроо «Баатар хоёр хүүтэй. Гэтэл гүн энэ бүсгүйг охиндоо дүү болгоно гэдэг юу гэсэн үг вэ! Монголчууд ах дүүгийнхээ хүүхдүүдийг асрах дуртай. Тэгэхээр ахынхаа охиныг авч Сайнжаргалд дүү болгох ёстой шүү дээ! Гэтэл Баатарт охин байх ёсгүй бололтой. Эсвэл нууц амрагийнх нь охин юм болов уу?» гэж гайхна.

Тозияа, гүнг ирэхэд байшингийнхаа дээд өрөөг засуулаад гүнд өгөхөөр бэлдчихсэн байлаа. Цэен, найман өрөө бүхий дээд давхраа өгсөн Тозияад баярласандаа Иокогама гингогоос арван мянган иень авчруулж, Тозияад бэлэг болгов. Тозияа Цэенг ирсний маргааш нь Харбин дахь японы тусгай төлөөлөгчийн газартай ярилаа.

- Тайса Тэцуда сан, Бид Игорь Мешановыг олсон. Тэр Сафроновыг үхсэн эсэхийг нүдээрээ үзээгүй гэнэ. Харин

Казаграндын туслах нэг өдөр түүнийг дуудаж нэг нууц бичиг өгөхдөө «Сафроновыг тусгай

үүрэг гүйцэтгэж яваад нас барсан" гэж хэлээд инээмсэглэхдээ "Тоглосон" юм гэжээ. Тэгээд өнөө бичгийг нь унштал Сафроновын хүүг тусгай нууц ажилд томилсон тухай бичиг байсан гэнэ. Харин тусгай тэмдэглэл хийхдээ үхсэн, сураггүй болсон, амьд яваа гэсэн учир нь ойлгогдохгүй юм бичсэн байсныг уншаад гайхаад өнгөрөхдөө туслахын үгийг санасан гэнэ.

- Цаад шар толгойт чинь тэр залуутай уулзаж үерхэж явсан гэнэ үү?

- Төдий сайн танихгүй гэнэ. Тэр үед Мешанов, нууцын эрхлэгч байсан болохоор Ивантай олон уулзаж байгаагүй гэнэ. Гэхдээ зүс танина гэнэ. Бид одоохондоо Мешановыг Сафроновтой уулзуулаагүй байгаа. Харин өнөө бүсгүй юу ч хэлэхгүй шазуур зуугаад байгаа гэхэд Тозияагийн дотор палхийгээд явчихлаа,

- Аа муусайн хоолны савнууд аа! Та нар гүнгийн охиныг байцааж, шоронд хийсэн юм биш биз гэж хашгиран асуухад,

- Тайсаа доноо, та чинь тэднийг ирэхээр асрамжиндаа аваарай гээ биз дээ. Манай асрамжинд байдаг улсуудыг Жан Золингийнхон нягталдаг шүү дээ. Тэр ч байтугай олигтойхон сүүл зүү гээ биз дээ.

- Аа маанагууд! Сүүлний хувьд гэвэл та нар зам зуур ямар байдалтай явааг ажиглах ёстой. Асрамжийн хувьд гэвэл би, танай тэр гаж буруу хэлээр чинь яриагүй. Юм бүхнийг шоронгийнхны этгээд хэллэгээр ойлгож, ухаардаг явдлаа тат! Одоохон гүнгийн охиныг суллаад уучлал гуй. Сөгдөж мөргөөд гуй! Бүх юмыг нь тоо ширхэг ёсоор нь эргүүлж өг! Ганц зүйл дутуу өгч болохгүй. Танайхан хүмүүсийн юмыг хураагаад олигтой юмыг нь өөрсдөө авдаг шүү. Тийм байдал гарсан бол сайхан мэдээрэй. Тэр хоёрыг Модрен буудлын дээд зэргийн өрөөнд суулгаж үнэ хөлсийг нь өөрсдөө төл. Би өнөөдөр эндээс гарна. Сафроновыг байцааж сүржигнэсэн байвал арьсыг чинь хуулна гэж мэдээрэй гээд утсаа чулуудлаа.

Тозияа, Цэенг гэртээ суулгаснаас хойш цэргийн тусгай төлөөлөгчдийн газрын нэг өрөөг төхөөрөмжлүүлж авчээ. Тозияа гэртээ байгаа ярьдаг утсаа бүгдийг нь өрөөндөө холбуулсан

байлаа. Түүгээр зогсохгүй Сувдаа, Цэен хоёрын яриаг сонсох тусгай хүмүүс бэлдсэн аж. Тозияа байшиндаа орж ирэнгүүт гэрийнхээ үйлчлэгч хижээл авгайтай уулзаад Цэенг сураглав.

- Цэен сан Сувдаа хоёр зочдын өрөөнд байгаа гэж үйлчлэгчийг хэлэхэд Тозияа дээд давхар өөд сажлав. Тозияаг орж ирэхэд Цэен угтан босож,

- Охиноос минь сураг байна уу? гэлээ.

- Цэен минь, чи өнөө орой Сувдаатай хамт галт тэргээр гар! Би онгоцоор явна. Тэднийг Жан Золингийнхон баривчилсан бололтой. Гэхдээ санаа зовох хэрэггүй. Муу юм болоогүй. Хятадууд Сафроновын хүүг жаахан өөлж, хардсан бололтой байна гэснээ,

- Ингэхэд би чинь Сафроновын хүүтэй улаан нүүрээрээ дайралдаагүй удлаа шүү. Одоо ч танигдахааргүй залуу болоо биз гэж хэлээд гүнгийн үгийг хүлээлээ. Үнэндээ Тозияа, Иваныг

зүс танихгүй болой. Яагаад ингэснээ бодоод олсонгүй. Ер нь Сафроновтой ууж архиддаг боловч гэр орноор нь орж сүйд болдоггүй байлаа. Тиймээс хүүтэй нь ганц удаа уулзсан билээ. Дөрвөн жилийн өмнөх явдлыг Тозияа сайн санах атал Иваны царай зүсийг тоймолж чадсангүй, тиймээс Цэенгийн хөлд суухаар шийджээ.

- Борон Унгерний тушаалаар Казагранд руу явахдаа манайд ирж, надад үнсүүлж аваад явсан. Багыгаа бодвол өндөр туранхайвгар мөртлөө царайлаг залуу болсон шүү. Сувдаагаас дөрөв ах, одоо хорин тавтай юмдаг. Бие нь өссөн ч зан ааш нь хувирахгүй юм даа. Инээхдээ гараа амандаа бариад инээдэг хүүхэд байсан, том болоод тэр зангаа хаяагүй шүү. Муу эцэг нь ганц хүүгээсээ салчихлаа гэж гутарч, гуныж яваад өөд болсон. Чи бид хоёр муу эцгийг нь нутаглуулах гэж багагүй гүйгээ биз дээ, Харин ямар бурхны ачаар амьд үлдээ вэ? Муу эцэг нь амьд байсан бол өдийд бараг тэнгэрт нисчих гэж байгаа даа.

Тозияа, Цэентэй чингэж ярилцахдаа «Гүнтэн, Ивантай уулзах юм бол дор нь таних юм байна» гэж бодоод цагийн дараа агаарт хөөрчээ. Тозияа, Харбины онгоцны буудал дээрээс шууд цэргийн төлөөлөгчдийн газар ирж дэд хурандаатай уулзлаа.

- Тайса доноо, Сайнжаргал их ууртай байна. Хунхуузынхан эрүүдсэн болохоор бүр дургүйг нь хүргэчихжээ гэж дэд хурандаа үгээ зөөллөн танилцуулав. Хурандаа Тозияа, дэд хурандаагийн үгнээс сэжиг авч,

- Цаад хунхуузууд чинь хүчиндчихсэн юм биш биз гэж тулган асуув.

- Үгүй байх аа!

- Юу, үгүй байхаа гэж. Хүчиндсэн үгүйг нь арван хуруу шигээ мэдэж байх ёстой хүмүүс ингэж байдаг чинь юу болж байна. Шоронгийн хянагч нар сайхан хүүхний бараа харахаар хэзээ тэсэж байлаа. Тэгээд ч тэр бузар явдлаа нууцалж чаддаг чононууд. Сафронов одоо хаана байна?

- Тайса доноо, Сафронов сан буудалд Сайнжаргалтай хамт байгаа. Архи дарс, бүх юмаар хангасан. Тэр хоёр хоол ч идэхгүй байна. Тэгээд ам нээхээрээ таныг Мугдэнгээс яаралтай дуудаж аль гэх буюу яриулаатах гээд болдоггүй. Тэгээд аргаа бараад таныг Мугдэнгээс наашаа онгоцоор гарсан гэж хэлж сэтгэлийг нь тайвшрууллаа.

- Мөн ч тэнэг гайхлууд юмаа. Та нарын өмнөөс би, нэр нүүрээ улалзуулах болж байна уу? Тэд Сайнжаргалыг яасныг мэд. Тэгээд арван минутын дараа илтгэ!

- Тайса доноо, бүгдийг нь мэдсэн л дээ. Хэлэх гэхээр хоолой дээр тээглэчихээд эвгүй байна.

- Тэгвэл тэр хүчиндсэн хуягийг нь яасан бэ?

- Бариад хорьчихсон байгаа. Тэр лүд Сайнжаргалын гарыг бэртээчихсэн байна.

- Одоохон тэр хуягийг олж ирээд Сайнжаргалын нүдэн дээр зод, нүд! Устгасан ч болно.

- Тайса доноо, Сайнжаргал зочид буудалд байгаа болохоор эвгүй юмаа даа. Нөгөө талаар Жан

Золингийнхон хэл ам татлаад байж мэдэх юм.

- Ямар ч байсан тэр хуягийг Сайнжаргалын нүдэн дээр устгах хэрэгтэй. Харин хаана вэ? гэдгийг өөрсдөө шийд гэснээ хэсэг бодоод,

- Ер нь Оросын дүрвэгсдийн товчооны мэдэлд байдаг хориход аваачаад тэнд Сайнжаргалтай уулзуулж, яаж тамласныг хэлүүлээд устгах хэрэгтэй. Харин Жан Золингийнхоос аваачихдаа

Сафроновтой нүүрэлдүүлэх хэрэг байна гэдэг эгзэг гарга. Устгачихсаны дараа юу гэж ч хэлсэн болно. Харин одоо би Сафроновтой уулзана. Намайг ирснийг зөвхөн Иванд дуулгаад аваад ир гэж тушаалаа. Тозияа, Ивантай Харбин дахь японы цэргийн төлөөлөгчийн газар уулзахаар шийджээ.

Шал ширтэж, тэргүүн бөхийлгөсөн залуу цэргийн төлөөлөгчдийн газрын нэг өрөөнд орж ирээд Тозияаг харангуут баярлан инээмсэглэснээ,

- Тозияа сан, та ашгүй ирээ юу. Таныг ирээгүй бол эд чинь баллах нь байна шүү гэж дуу алдан уулзав.

Тозияа, Иваныг гайхсан нүдээр харж «Сонин юм даа. Намайг харангуутаа ингэж сайн таних ёсгүй л баймаар сан. Дэд хурандаагаас сураг дуулаад танимгайрч байгаа хэрэг үү? Үхсэн хүн ингээд босоод ирнэ гэдэг гайхалтай хэрэг. Ардын засгийнхан гүнгийн охиныг ашиглаад ийм тоглоом зохион байгуулсан бол яана... Гэхдээ Цэентэй уулзахад учир нь олдох байлгүй дээ. Би Сафроновынхоор очихдоо хүүг нь сайн нүдэлж авсан бол яалаа гэж ингэх вэ?" гэж бодлоо.

- Иван Степанович минь биднийг уучилна биз. Цэргийн хүн болохоор учрыг ойлгох биз дээ. Цаг төр хямарч байгаа үед иймэрхүү эндүүрэл гардаг шүү гээд инээмсэглэн тал засаад

- Чи чинь том эр болжээ. Сүүлийн жилүүдэд уулзаагүй болохоор надаас өөр хүн бол, үхсэн хүний нэр зээлж ирсэн гэх нь байна гээд Иваны царай өөд ширтэнэ.

- Тозияа сан, даанч гомдмоор юм биш үү. Хүрээнийхний худлаа цуурхалд итгээд аягүй бол улааны тагнуул гэхнээ дээ гэж гоморхов.

- Иван минь цэрэг эр чинь иймэрхүү юманд гомддоггүй юм. Чи чинь хашир цэрэг шүү гээд үл мэдэг ягаарсан царайг нь ширтэхдээ «Яг үнэнийг нь хэлчихээр царайны өнгө хувираад ягаарчихлаа шүү. Цэентэй уулзуулах үедээ нэлээн сайн ажиглая» гэж бодлоо.

- За Иван минь чи чинь яаж хөглөж явна даа гэхэд залуугийн сэтгэл тайвширч яриагаа эхлэв.

- Галуут нуурын суурин руу довглохын өмнө Улаан цэргийн байрлал, хүн хүчийг мэдэх ёстой байлаа. Бид тагнуулд гараад улаан цэргийн дарга хувцсаар хувцаслаад, Галуут нуурын сууринд очсон чинь Казаграндын хэсгээс урвасан нэг бага даргатай улаан халз дайралдав. Би сэжиглэгдсэн боловч баригдалгүй амьд гараад, нуураас баруун урагш өртөө шахам газар байгаа Унгерний штаб дээр ирж мэдэгдэв. Биднийг байраа өөрчилж амжаагүй байхад улааны цэргүүд орж ирлээ. Хурандаа Казагранд улаан армиас зугтааж, монгол руу ухарсан тул

Унгерн намайг дуудаж хурандаа Казаграндыг олж устгах нууц тушаал өгсөн юм. Ингээд би Сухаревын хэсэгтэй монголд орж ирлээ. Бид Казаграндын мөрийг хөөж Заяын хүрээнд гүйцэж очсон. Сухарев түүнийг баривчлах гэтэл Казагранд биднийг баривчлахаар болж заяын сэмчин дуганд уулзсан бидний хооронд зэвсэгт мөргөлдөөн боллоо. Тэгэхэд би баруун мөрөөрөө буудуулж шархадсан юм. Сухарев, Казаграндыг устгаад, тэдний хэсгийг өөрийнхдөө нийлүүлээд, Эрдэнэ зуу руу хөдлөв. Би Заяын хүрээнд үлдэж, биеэ тэнхрүүлээд Барон Унгерн руу очиж байдлыг илтгэх ёстой байлаа. Гэтэл хэрэг явдал буруугаар эргэж, би нууцаар амьдрах боллоо. Тэгээд гурван сарын дараа хүрээ чиглэсэн юм.

Иван, Степанович Заяын хүрээнээс Да хүрээг чиглэсэн боловч Эрдэнэ зуугийн орчим цохигдсон Сухаревын үлдэгдэлтэй дайралдаж, Хүрээний хойгуур гарч, Харбин чиглэхээр шийдлээ. Тэд Тэрэлжээр дайрч, Хэрлэнгийн зүүн хүрээ хүрэхэд Иван Степанович, хүрээнд үлдсэн хүмүүстэй холбоо тогтоох тусгай даалгавар авч тэндхийн нэгэн орос худалдаачныд байрлав. Тэгээд цагийн байдлыг харж байгаад Хүрээнд нууцаар ирсэн.

- Намайг хүрээнд ирэхэд та, явчихсан байлаа. Эцэг маань нас бараад ганцхан манай зарц авгай Аня гуай хашаа байшинг минь харж үлджээ. Хүрээнд хэдэн сар нуугдаж амьдарлаа. Гэтэл Улиастайгаас Анёхин гэдэг танил худалдаачин ирж явааг мэдээд нэг шөнө хүрээнээс гарч Лүн хүрч, туулын гарам дээр Анёхины хөсгийг амдав. Тэгээд Анёхинтай уулзаад хэд хэдэн болзол тавьж, Улиастайд амьдарч байгаад буцаж ирсэн хүн болж гэртээ ирлээ. Намайг ардын засгийнхан нэг их сэрдэж, хардсангүй. Нэг өдөр Богдын шадар, ялгуусан лам ирж, Цэен гүний охиныг авч Харбин орвол дээр гэж зөвлөв. Би ч зөвшөөрлөө. Ингээд ялгуусан лам надад хувийн хэргээр Харбин руу явах бичиг олж өгөв. Тэгээд зогссонгүй Сэцэн хан аймгийн Далай ван, Үйзэн ван, Хурц вангийн хүрээ хийдийн жасаас улаа шүүс хэрэглэх бичиг олгосон юм.

- Чи тэгээд Сайнжаргалыг хүрээнээс яаж авч гарав даа.

- Сайнжаргал надаас өмнө Үйзэн вангийн хошууны Алтан Очиртын хийд дээр ирчихсэн байсан. Энэ бүхнийг Богдын дэргэдийн хүмүүс зохицуулсан байлаа гэж Иван Степановичийг хэлэхэд Тозияа үг бүрийг анхааралтай сонсоно. Тозияа тэр оройгоо Сайнжаргалтай уулзаж түүний сэтгэлийг тайтгаруулж, учир байдлыг тайлбарлав.

- Сайнжаргал аа, Жан Золингийнхон, Сафроновын талаар худлаа мэдээ аваад түүнийг шалгах гэж будилсан байна. Харин үүнийг далимдуулж хэтрүүлсэн хүмүүсийг хууль ёсоор шийтгэх ёстой. Тиймээс чамайг элэг доог хийсэн шоронгийн хуягуудыг надад зааж өг гэж гуйлаа.

- Шоронгийн ахлах хуяг намайг элэг барьж, үйл тамыг минь үзэх шахсан. Харин нэг хөгшин хуяг байгаагүй бол би зэрлэг амьтдын гарт үрэгдэж нэр төргүй болох байлаа гэхэд Тозияа шоронгийн ахлах хуягийг дуудуулж авчирлаа. Арьс нь язартлаа таргалсан бүдүүн намхан хятад, гаднаас орж ирэнгүүт японы цэргийн хурандаа хувцастай Тозияаг хараад сүнс нь зайлчих шахан,

- Тайса Доноо, намайг өршөөж хайрла. Би хадагтайн алтан бөгжийг авах гэж бузар ажил үйлдсэн гэхэд Тозияа,

- Бузар новш, хүнтэй тэгж зэрлэгээр харьцахыг хэн чамд зааж өгсөн бэ? гэж хашгиран асуулаа. Бүдүүн хятад ганц ч үг хэлж чадалгүй дуугүй зогсохдоо шал ширтэн, тэргүүн бөхийлгөн уруу царайлан зогсохыг харсан Сайнжаргалд, тэр нэг шөнийн хэрэг явдал нүдэнд нь үзэгдэх шиг боллоо.

...Шөнө дүл өнгөрч байхад Сайнжаргалыг шоронгийн ахлах хуягийн өрөөнд авчирлаа. Тэр өрөөнд түүний туслахаас өөр хүн байсангүй. Сайнжаргалыг тачаангуй өлөн нүдээр шуналтай харж байсан ахлах хуяг,

- Ийм сайхан хүүхэн үхэхийн өмнө надтай амьдын жаргал хуваалцсан дээр. Тэгвэл диваажинд төрж магадгүй шүү гээд Сайнжаргалын дэргэд ирж дээлийн нь энгэрээс заамдан барьж

байснаа гараа хүчтэй огцом угз татгал торгон дээлийн энгэр оёдлоороо урагдав. Тэгээд дотуураа өмссөн пансан цамцны захнаас барихад Сайнжаргал бүдүүн хуягийн гарыг хазлаа. Гараа хэгз хазуулсан бүдүүн хуяг, туслах өөдөө хараад,

- Цохиод унагачих. Тэгээд ухаан ороход нь дээр нь байж байвал сайхнаа гэж хятадаар хэллээ.

- Болохгүй. Энэ бүсгүй чинь зүгээр нэг сэжигтэн биш. Японы цэргийн тусгай төлөөлөгчийн газраас сураглаад байсан. Нөгөө оросыг нь өглөө аваад явсан. Тэгэхээр болохгүй гэж хэлтэл бүдүүн хятад,

- Тэр ямар хамаатай юм бэ? гээд Сайнжаргалын гарыг барьж авангуут нүд ирмэхийн зуур эргүүлж, ар нуруунд бариад нөгөө гараараа Сайнжаргалын цамцны энгэрийг хүү татан ураад,

- Энэ сайхан хөхийг хараач гээд хөхийг нь эрээ цээргүй илж байснаа чанга базаад, хананд тулгаж тавьсан модон вандан ханз руу чирлээ. Гэтэл туслах хуяг, ахлагчийнхаа гараас шүүрч аваад,

- Наадахаа тавь гэж хэлтэл бүдүүн хуяг,

- Би ганцаараа эдлэхгүй. Миний дараа чи яасан ч болно шүү гэтэл өнөө туслах хуяг,

- Бузар новш гэж хэлээд баруун шанаанд нь хүчтэй буулгав. Бүдүүн хуяг газраас өндийгөөд туслах руугаа дайртал гаднаас японы Цэргийн төлөөлөгчдийн газрын ажилтангууд орж ирлээ...

Тозияа бүдүүн хуягийг байцаахдаа хэргээс булзаж, өөрийгөө цагаатгах гэж мэлзсэнд уур нь хүрч, баруун гарын алганы ирмэгээр хоолой руу нь хүчтэй буулгав. Буудлын өрөөний шалан дээр хамаг биеийн хүндээр писхийн ойчсон бүдүүн хуягийн дэргэд очсон Тозияа түүний хоолойг барьж үзсэнээ багалзуурын нь мөгөөрс дотогшоо чихэгдээд амьсгалыг нь бөглөчихсөн бололтой. Муу хүний үхэл ганц ёвролтонд гэдэг үнэн юм даа. Одоо яая гэх вэ өөрийнхөө муугаас амиа алдаж байгаа хойно хохино гээд Сайнжаргал руу эргэж

- Ийм муусайн амьтдыг үхэхэд харамсах хэрэггүй. Харин ертөнцийн бузар амьтад нэгээр

хорогдлоо гэж баярлах хэрэгтэй. Одоо манай төлөөлөгчдийн газар руу очье. Аав чинь маргааш ирнэ гэхэд Сайнжаргал бүдүүн хуягийн үхдэл рүү айсан нүдээр харж, толгой дохиод буудлын өрөөнөөс хурдан гарахыг бодов.

Тозияа, Харбин дахь японы төлөөлөгчдийн газрын нууц туршуул болон оросын дүрвэгсдийн товчооны зохих хүмүүстэй уулзаж ярилцсаны дараа Казагранд болон Сухаревын хэсэгт явж байгаад Харбинд ирсэн хүмүүсийг олж уулзлаа. Тэгээд Харбины зохих албаны хүмүүст Сафроновын яриаг шалгах, түүний сургийг мэдэх хүмүүстэй уулзаж яриаг нь тэмдэглэн тулгах хийгээд ямар нэг сэжиг гарсан үед Мугдэн руу шууд мэдэгдэхийг даалгаад удирдамж өгөхдөө «Сафроновоос хараагаа салгаж болохгүй» гэж тушаажээ. Цэен охинтойгоо уулзсандаа хязгааргүй баярласан атал Жан Золингийнхон Сайнжаргалыг эрүүдэж, мөр, тохойг нь булгалж бэртээсэн төдийгүй ариун бие, алдар нэрийг нь гутаахад хүрснийг гадарлаад эчнээн дэх өшөө хорсол нь буцлав. Тэгээд халамцуухан үедээ «Тозияа сан, тэр шоронгийн чинь хятад яргачингуудыг толгой дараалан хядна. Тэгээд алтаар амийг нь төлье. Чи надад тэднийг толгой дараалан заагаад өг» гэж зогсоо зайгүй шаардана. Тэр тусмаа Тозияагийн бэлэглэсэн «намбу» хэмээх гар буугаа сугалж, харагдсан хятад руу дайрдаг болов.

Харбинаас Мугдэн рүү гарах өдөр галт тэрэгний буудал дээр очсон Цэен бүр эвгүй байдал гаргалаа. Галт тэрэг хүлээж байхдаа гар тээшээ тавцан дээр тавьжээ. Гэтэл хоёр хятад цагдаа тэдний дэргэдүүр өнгөрөхдөө тээш зөөгчдөд зам тавьж өгөх гээд халамцуу зогсож байсан Цэенг санамсаргүй түлчихсэн чинь тэрээр гар тээшин дээгүүрээ давж унах шахлаа.

- Энэ өгөр илжигнүүдийг харж байна уу? Одоо намайг унагаж алах нь? гээд цагдаа хятадыг заамдан авч өврөөсөө гар буугаа гаргалаа. Чухам энэхэн үед Тозияа, түүний гар руу амжин цохитол, гэнэт цочсон Цэен, гар бууныхаа гохыг дарчихлаа. Өнөө цагдаа баруун мөрөө барьж үзсэнээ хувцсыг нь нэвтэрсэн цусанд будагдсан гараа харангуут буугаа сугалах гэтэл Тозияаг үдэхээр ирсэн япон дарга нар, оросын дүрвэгсдийн товчооны албаны хүмүүс тэр будлианыг зохицуулж Сувдаа, Сайнжаргал, Тозияа гурав Цэенг арай ядан вагонд оруулжээ. Цэен, вагонд орохдоо үүд рүү эргэн хашгирч дүвчигнэхдээ,

- Наад муусайн илжигнүүдээ тавьчих. Би сэвсийг нь уудлаад өгье гэж хятадаар орилов. Цэен вагонд орж ирсэн хойноо ч зүгээр байсангүй. Ойр хавийнхаа хятадуудыг буудна гэж сүржигнэнэ.

Чингэсээр байгаад Цэен, орон дээр ойчиж ухаангүй боллоо. Тэгээд маргааш нь үд хүртэл унтаад үлгэн салган сэрлээ. Тозияа, Цэенгийн тавтиргүй явдлыг дуугүй өнгөрөөсөнгүй. Тэгээд зэмлэж гарлаа.

- Хммм... Тэгээд хятадуудын дураар дарлуулж байх хэрэг үү? Би гоминдааны шаарнуудад элэг бариулахгүй шүү. Нүдэндээ эвгүй харагдсан бүгдийг буудна. Муусайн гоминдаануудад зусардан бөхөлзөхгүй. Монголын мал байгаагүй бол эд чинь хамраараа газар хатгаж үхэх байсан юм.

- Цэен минь, одоо ганцхан хувийн өшөө санадаг цаг биш. Чи бол төрийн элч хүн. Тиймээс ингэж уухилж аахилж болохгүй. Юуны өмнө Богдын төлөөний хүн гэдгээ бод. Манайхан Жан Золингийнхонд учрыг гаргаад хэлчихнэ. Тэгэхээр уур омгоо барьж явах нь дээр.

- Тозияа, шарын оронд хар хүн гэгчээр чи, миний оронд тэр хунхуузаас өршөөл эрж, нялганаж байх ямар албатай юм бэ? Тэрүүнд орвол хорин гамин алчихаад амийг нь төлчихвөл тэр хунхууз алтны сургаар өөрөө бөхөлзөх болно. Наран улсын эзэн хааны буянд зүүн умард хятадын гурван мужийг захирсан нь их юм. Ер нь эцсийн эцэст цаад хунхууз чинь танай эзэн хааныг алья гэвэл хамгийн түрүүнд толгой дохих хүн дээ. Чи харж байгаарай. Миний хэлсэн үг чиний ойд унах цаг ирэх вий.

Цэен, Харбинд байхдаа охиныхоо сэтгэлийг бодоод олигтой ярьж чадаагүй. Сайнжаргал ч уур уцаар, гомдол цөхрөлдөө болоод үг дуу цөөнтэй байсан. Харин Мугдэнд ирээд дөрөв хоносны дараа,

- Аав аа, та хятадуудыг нэг нүдээрээ үздэггүй мөртлөө энд яаж байдаг юм бэ? гэж асуулаа.

- Яахав дээ. Төрийн хэргээр яваа болохоор амаа жимийж, нэг гараараа нөгөөхөө барьж явдаг ёс байдаг юм. Чи наашаа гарахын өмнө гэгээнтэнтэй уулзсан уу? Ер нь ямаршуухан амьдарч байв даа.

- Таныг явсны дараа ээжийн эгч нүүж ирсэн. Тэгээд ажаа бид хоёр амьдарч байлаа. Бид хоёр гандан, хүрээгээр очиж таны бүтээлгэ гэсэн бурхныг бүтээлгэсэн. Ардын засгийнхан бошгыг халах эвлэл гэдэг юм байгуулаад залуучууд хүрээ хотын хогийг

цэвэрлэж, баахан бужигнав. Би тэднийг хараад уур ч хүрэх шиг. Нэг хэсэгтээ их зэвүүцдэг байлаа. Жил гаран болж байтал зүүн хүрээний нэг лам ирж, таны эндээс бичсэн захиаг өглөө. Тэр лам, хааяа манайд ирдэг юм. Үнэндээ түвд, хятад, пийлэн (англи) хэлэнд сүрхий, орос хэл гадарладаг чамбай боловсролтой хүн байна билээ. Тэгээд нэг өдөр надтай уулзаад «Хүрээний бага сургуульд чам шиг номтой хүн хэрэгтэй гэнэ. Чи багшлахгүй юу» гэлээ. Тэгэхээр миний эгдүү хүрч, энэ толгой мөрөн дээр байгаа цагт ардын засгаас хайр шагнал горилох дээрээ хүрээгүй байна гэчихлээ. Түүнээс хойш сар болоод цогчин дуганы өмнөх хүрэл суварганы дэргэд дайралдав. Тэгсэн чинь Дэчингалбад орох уу гэнэ. Түүнийг дагаад дуганд ортол Богд хаантан заларч байхыг хараад ухаан алдчих шахлаа. Тэгээд Богдод мөргөтөл «Охин минь нэг хүнийг дагаж эцэг рүүгээ яв. Одоо хүрээнд шигдэх хэрэггүй. Чамайг отож манадаг хүмүүсийн тоо нэмэгдээд байна» гэлээ. Ингээд намайг бурханч лам Бадрах, үйзэн вангийн хошуун дээр хүргэж өгөөд буцсаны дараа Иван ирсэн юм. Богд хаантан намайг хүрээнээс гарахын урьд орой уулзаад «Өнөө юмаа хөндөж болохгүй. Тэд нар эхэлж дуугарвал тэн хагасыг хэрэглээрэй. Гэхдээ эзэн хааны зарлиг, лүндэг гарсан эсэхийг нүдээрээ олж үзсэний дараа шийдэх хэрэгтэй» гэсэн гэлээ.

Сайнжаргал эцэгтэйгээ ингэж ярихдаа Сувдаагийн талаар асууж лавлахад Цэен учир байдлыг нь хэлж өгөв. Харин эцэг, охин хоёрын энэ өдрийн яриаг төлөөлөгчдийн газрын тусгай өрөөнд байрлуулсан төхөөрөмжийн дэргэд суусан Тозияа чагнаж байсныг эцэг охин хоёр яахан мэдэх билээ.

Цэен, охиныгоо ирсний дараа Мугдэнгийн байдалтай танилцуулж нэг өдөр манжийн хааны алтан ордыг үзүүлж тайлбарлаж өгөв. Тэгээд гэр рүүгээ буцаж явтал охин нь эцгээсээ,

- Аав аа та, Цэрэндэжид гэдэг авгайг таних уу? гэж асуув.

- Үгүй ээ. Юун авгай юм бэ?

- Таныг явсны дараа ажаа бид хоёр гандан дээр очиж Очирвааний бүтээл хуруулав. Гэтэл нэг авгай надтай уулзаад таныг урагшаа яваа юу гэж асуулаа. Тэр авгай хоршоонд ажилладаг юм. Намайг хааяа очиход нандин юмнаасаа тусгайд нь тавьчихдагбайв. Тэгээд уулзах тоолондоо «Аваас чинь сураг чимээтэй юу?» гэж асуудаг юм. Сайнжаргал аавдаа чингэж хэлээд хүзүүнээсээ салгадаггүй нэг сахиусаа заагаад «Үүнийг надад өгсөн юм» гэлээ. Цэен нэг удаа охиноосоо өнөө сахиусыг аваад задалж үзэв. Гэтэл Богд ламын зургийн ар талд наасан нэгэн гэрэл зургийг хараад ахынхаа хадам эцэгтэй уулзсан тэр нэг өглөө ахтайгаа амьдрал ахуй ярилцсанаа санах.

...Баатарын хадам өөрийнхөө ах дүүтэй Цэенг танилцуулсны маргааш нь Баатар нэгэн гэрэл зураг гаргаж үзүүлээд,

- Дэжид Харбинаас явахын өмнө нэг өдөр охин бид хоёрыг зургаа авахуулчих гэлээ. Бид гурав нэг орос зурагчинд очиж гурвуулаа зургаа авахуулах гэтэл Дэжид дургүйцээд охин бид хоёр энэ зургийг авахуулсан юм гэж гэрэл зургийн учрыг тайлбарлаж өгөв...

Цэен, Сувдаа ах хоёрынхоо зургийг хараад Сайнжаргалын ярьсан тэр авгайг Сувдаагийн эх гэдгийг төвөггүй ойлгов. Тэгээд өнөө сахиусыг битүүлэн оёод охиндоо өгөхдөө,

- Сайхан богд лам байна гэж хэлжээ. Тэгээд нэг өдөр Мугдэнгийн Биржийн гудамжны дэлгүүрт очихдоо,

- Сайнжаргалаа, чи наад сахиусаа задалж үзсэн үү? гэж асуув.

- Би наашаа ирж явах замдаа задалж үзсэн юм.

- Чи тэгээд яагаад учрыг нь хэлээгүй юм бэ?

- Аав аа, Тозияа гуайн өрөөнд хамаагүй ярьж болдог юм уу?

- Чи солиороо юу?

- Үгүй ээ. Харбинд нэг удаа Сафронов бид хоёрыг нэг өрөөнд хорьсон юм. Тэгсэн чинь тэр өрөө нь бид хоёрын яриаг чагнахад зориулагдсан тусгай төхөөрөмжтэй байсан шүү. Тозияа сангийн байшинд тийм төхөөрөмж байхгүй гэх газаргүй. Тиймээс Цэрэндэжид эгчийн тухай яриагүй юм.

Эцэг охин хоёрыг чингэж ярьснаас хойш хэд хоноод, нэг өдөр Тозияа ажлаасаа ирэхдээ царай муутай ирлээ.

- Тозияа сан, чи яачихаа вэ? Бие чинь муу байна уу гэж Цэенг асуухад тэрээр хэсэг дуугүй бодолхийлснээ,

- Би гайгүй, Токиод хөдөлсөн газар хөдлөлтийн сүйрлээс болоод эзэн хаан монголд туслах асуудлыг түр хойшлуулж магадгүй сурагтай гэхэд,

- Би ч тэгнэ байх гэж бодсон юм. Сонинд бичсэн мэдээнээс үзвэл тун их сүйрэл болсон байсан. Ингэхээр энэ жилдээ байтугай хойтон жил ч энэ сүйрлээс гарч чадахгүй юм шиг санагдаж байна гээд Цэен санаа алдав.

- Би удахгүй Токио явна. Тэгээд армийнхантай уулзаж Монголд Богд хаант улс сэргээн байгуулах талаар ярилцъя гэж бодож байна. Ер нь байгаль дэлхийн гамшиг гэж хэцүү юм. Хятад бол бас хөдлөмтгий газартай. Ер нь Тяньжингийн банкуудаас Шанхайн олон улсын банк нь их найдвартай шүү. Газар хөдлөлт, энэ тэр болоход даатгал сайтай банкнууд байгаа юм. Та ч хашир хүн болохоор Богдын алтыг баттай газар хадгалуулсан юм байгаа биз дээ гэхэд Цэен

- Тозияа сан, үнэнээ хэлэхэд би чинь тэр алтыг хятадад ирсэн гэдгийг мэдэхээс цаашгүй хүн. Миний араас хүн ирж түүнийг авч хэрэглэх тухай Богдын зарлигийг хэлж өгөх юм гэсэн шүү гэж учирлав.

- Цэен тэр ч яах вэ? Харин намайг явсны дараа Симото гэдэг хошуучтай уулзаж байгаарай. Чи танина шүү дээ. Манайхаар дандаа ирдэг өндөр гозгор залуу бий. Нөгөө талаар Богдтой холбоо барьж Токиогийн газар хөдлөлтийн талаар мэдэгдэх гэсний хэрэггүй. Намайг Токиогоос ирэхийг хүлээх биз. Ер та өөрөө газар хөдлөлтийн талаар бодно биз дээ гэлээ.

Цэен, газар хөдлөлтийн сургийг дуулснаас хойш Богдын үгийг хэдэн удаа эргэцүүлэн боджээ. Тэгэхдээ «Газар хөдлөлтөнд зориулж өглөг өгөх үү? Ер нь японы армийнхны анхаарлыг өөр дээрээ татах хэрэгтэй. Тэгэхээр хотынхонд уу? Армийнханд уу? Хотынхонд өгсөн дээр байх. Тэгэхгүй бол намайг ямар ажлаар ирснийг мэдэх гэж шиншлээд байгаа сурвалжлагч нар ёстой шуугьж гарна. Тэгээд эзэн хааны армид тусламж үзүүллээ гэж ардын засаг мэдчихвэл улаан оросын цэргийг хүрээнээс гаргахгүй шүү» гэж бодно.

- Тозияа сан, би газар хөдлөлтөнд өртсөн Токио, Иокогама хотынхонд нэг сая иений тусламж үзүүлье гэж бодож байна гэхэд Тозияа түүний саналыг дэмжиж, тэр хөрөнгийг Токио, Иокогама хотынхонд гардуулж өгнө гэж амлав. Тозияа явахынхаа өмнө

Цэентэй сакэ балгаж, цаашдынхаа ажил төрлийг ярилцаж бас Симото хэмээх тэвнэ шиг өндөр, нарийхан биетэй атлаа хаврын гурингатсан тэмээ шиг хөв хөх царайтай хошууч, тэр хоёртой зиндаа нийлүүлж ярианд оролцоно. Цэен, Тозияаг Токио руу явах болсныг тохиолдуулж гарын, бэлэг болгож тавьтын дэвсгэрээр толгойлж боосон боодол иень өглөө Тозияа ч өөрийнхөө бэлгийг бэлдчихсэн байлаа.

- Цэен минь, энэ байшинг үүнээс хойш өөрийнхөө сууц гэж бодоорой. Манай төлөөлөгчдийн газар, манай улсад тохиолдсон уй гашуу, зовлонгоос хуваалцаж байгаа таны сэтгэлийг хүндэтгэн энэ байшинг албан ёсоор таны гарт хүлээлгэж өгөхийг надад даалгасан юм гээд бичиг баримтыг нь гардуулав. Чингэтэл Симото,

- Цэен сан, та охидуудтайгаа Солонгост очиж амрах юм биш үү. Ирэхэд чинь бид, байшингий чинь сайхан засчихаад байя. Нөгөө талаар Тозияа сангийн гэрт үйлчилдэг хүмүүсээс танайд хэн хэнийг байлгах вэ? Та бодож байгаагаа хэлээч. Тэдний хөлсийг манай газраас төлнө гэхэд Цэен сэтгэлдээ «Байшинг засна гэдэг ерийн хэрэг биш. Сайнжаргалын хэлдэг өнөө яриа

чагнадаг зүйлээ надад мэдэгдэлгүйгээр зөөх далд бодолтой юм байна» гэж бодлоо.

- Симоно сан, надад тусгай хүмүүс гаргаад хэрэггүй. Би ахынхаа хамжааны хүмүүсээс хэдэн хүн авчирна. Харин надад үйлчлүүлсэн хүмүүст төлөх цалинг газар хөдлөлтөнд хэлмэгдсэн хүмүүст өгвөл дээр гэхэд,

- Тэр чинь болдог хэрэг шүү. Ухаантай хүн гэдэг чинь нүд ирмэхийн зуур бүх юмыг тунгаах юм даа гээд урдаа байгаа хундагаа өргөөд,

- Кампай (ёроолд нь юм үлдээлгүй ууя) гэлээ.

Мугдэн хот. Монголчуудын дунд энэ хот Жийжүү гэж алдаршсан болой. Ляо мөрний зүүнээс цутгадаг Хуньхэ голын эрэг дээр одоогоос хоёр мянган жилийн тэртээ Хоучэн гэдэг суурин байгуулжээ. Тэгээд VIII зууны үед Шэнь жоу гэж нэрлэсэн аж. Юань улсын үед тэр хотыг Шэньян гэж дуудаж заншсан нь нарийн учир холбогдолтой боловч гагцхүү түүх шастирт үлджээ.

Манж угсаатны эзэн хааны ширээг үндэслэсэн Нурхач 1621 онд энэ хотыг эзлээд, 1652 онд Манж дайчин улсын нийслэл болгожээ. Олон зуун жилийн тэртээ өмнөд манжуурын жижиг толгод бүхий нүд алдам хээр талаар нутаглаж байсан малчин аймаг, отгууд од харвах адил хоромхонд өнгөрдөг амьдрал ахуйн аясаар газар тариалан эрхлэн Ляо мөрний үржил шимт хөндийг даган, хэсэг бусгаараа бөөгнөрөн суурьшсан билээ. Ийнхүү мөрний адагт суурьшсан хүмүүс газар хот байгуулаад өвөг дээдсийнхээ уламжлалт ёсыг сахин Ляо мөрнийг хониор тахидаг болсноор Шэнь ян буюу хонь хэвтэх гэсэн үгнээс гаралтай Хонин хот гэж дүрс бичгээр тэмдэглэдэг байжээ. Шэнь ян хот Манж дайчин улсын худалдаа, соёл, усан замын зангилаа болсон тэр үеэс эртний загасчингуудын жижиг завь, сал шавааралдан бөөгнөрч байсан онцлогийг харгалзан нэгэн хэсэгтээ усан зогсоол усан боомт болсноор манж үгээр нэрлэгдэх болжээ. Харин анхны манж үгний дуудлага үл ялиг сунжран Мугдэн гэсэн нь усан зогсоол гэсэн утгатай болой. Харин манжийн хааны алтан ордыг барьж тэнгэрийн хүүгийн сүр хүчийг алдаршуулан бишрүүлэхийн тулд Шэнь ян гэдэг дүрс бичгээр тэмдэглэж байсан анхны бичлэгийг үл ялиг өөрчилж, Нар тусах газар буюу Наран хот гэсэн дуудлаганд дүйцүүлж бичдэг болсныг мэдэх хүн цөөн.

Хаант Орос японы дайнаар япон улс, Чанчунь, Мугдэн, Дайран, Порт-Артур хотыг холбосон төмөр замыг өөрийн мэдэлд авснаар түүнийг хамгаалах 15 мянган цэргийг Гуаньдунгийн арал дээр байрлуулдаг болсон. Мугдэнд байдаг манжийн хааны гоёмсог алтан орд бүхий, битүү модот цэцэрлэгээс зайдуухан ногоон паалан дээвэртэй, асар бүхий хаалгатай хэрмэн хашаан дотор байдаг давхар байшин, багашигхэн мөртлөө тохилог цэцэрлэгийг Цэен гүнгийх гэдэг болсон. Гүнгийн байшингийн доод давхар хоёр танхим, дөрвөн жижиг өрөөтэйгөөс гадна гал тогоо, халуун, хүйтэн усны төхөөрөмж бүхий өрөөнүүдтэй. Дээд давхар нь долоон жижиг тасалгаа, нэгэн уужим танхимтай билээ. Эдгээрийн бие биенээр дамжин ордог нэг өрөөнд Цэен гүн суух агаад гаднаас ирсэн хүнтэй уулзах гэвэл залгаа өрөөнийхөө үүдэн талын өрөөнд хүлээн авна. Гүнгийн өрөөний өөдөөс харсан хоёр өрөөний нэг нь Сувдаагийнх, нөгөөд нь Сайнжаргал сууна. Дээд давхрын их танхимын баруун хананаас холгүй, цав цагаан гантиган хашлага бүхий усан оргилуур хийж, дотор нь далайн дун, цав цагаан шүр, утаат болор зэрэг талстуудтай чулуу хийж, шовгор орой бүхий уул хэд хэдийг

босгоод алт мөнгө, улаан, ногоон өнгөтэй, гоёмсог цацган сүүлтэй тао хэмээх ховор загас тавьжээ. Цагаан гантиган хашлагын эргэн тойронд тусгай вандан засаж, түүн дээгүүр гэрт ургадаг одой мод буюу бонсай хэмээх модыг янз янзаар нь цувруулан тавьсныг ажвал Токиогоос авчруулсан нь илэрхий. Гантиган хашлагын усан дотор цахилгаан төхөөрөмж тоноглож чийдэн асаасан тул тао загасны уран сэлэлтийг харсан хүний сэтгэл уяран тайвшрах болой.

Өрөөний нөгөө ханын дагуу хар суман модоор хийсэн, шилэн хорго бүхий шүүгээ гурвыг зэрэгцүүлж тавиад, доторх тавиур дээр нь хориод мөнгөн аяга, цагаан, ногоон хашаар хийсэн гүц, шаазан, хундага, халбага сэрээ тавьсны зэрэгцээ гурван алтан аяга хөмөрч тавьсан нь өрөөнд орсон хүний сэтгэлийг булаана. Цонхны дэргэдэх ханын дагуу зөөлөн суудалтай диван гурвыг зэрэгцүүлээд урдуур нь хаш өртэй явган ширээ тавьжээ. Цэен энэ өрөөнд Мугдэн дэх японы албан байгууллагын удирдах нөхөд, армийн нөлөө бүхий хүмүүстэй уулзалт хийж, цайлж зочлох дуртай. Цэен байшингаа ингэж төхөөрөмжлүүлээд ахынхаасаа эрэгтэй, эмэгтэй зургаан хүн авчирч өөрийн гэрт үйлчлүүлжээ. Түүнээс гадна Мугдэнгийн янхны газар танилцсан Гэрэлээ гэдэг хүүхнийг авчирч гарын үзүүрт зарна.

Цэен, Гэрэлээг харах тоолондоо сэтгэлдээ «Энэ хүүхнийг тэр нэг өдөр согтуу нүдээр ажихад ёстой лусын дагина шиг харагдаж билээ. Хувцас бурхан, бие чөтгөр гэгчээр дөч шахаж яваа энэ хүүхэн, тэр нэг мөчөөс хойш миний сэтгэлд хоногшиж билээ. Хүний үйл гэж сонин юм» гэж үглэдэг удаатай. Цэен тэр эмэгтэйг өөрийн дэргэд байлгахдаа хүйтэн хөнжилдөө жийрэг хийж өнгөрөөдөг болсон нь далдын учиртай. Цэенгийн гэрийн дотор үйлчилдэг хүмүүсийг Сувдаа удирдах боловч Гэрэлээг хүндэтгэн, гэрийн эзэгтэй шиг үзнэ.

Тозияа, эзэн хааны нийслэл рүү яваад арван сар болоход ердөө гурван удаа захиа бичжээ. Тэрээр захиандаа «Эзэн хааны арми тэнхрэнгүүтээ Монгол руу төдийгүй Манжуур, Өвөр монголруу чиглүүлсэн онцгой ажиллагааны төлөвлөгөө боловсруулна» гэхээс цаашгүй. Тэрээр японы армийн жанжин штабын хоёрдугаар удирдах газар буюу тагнуулын газарт Монголын асуудлыг эрхэлж байв. Цэен хүрээнээс богдын бие төлөөний хүн ирэхийг хүлээж суухдаа Мугдэнгийн номтой хүмүүстэй холбоо тогтоож, Сайнжаргалд англи, япон хэл заалгах болов. Сайнжаргал япон хэлнийхээ боловсролыг дээшлүүлж, англи хэл үзэж байхад Цэен, хятадын томоохон хотоор тэнэж, гадаадын худалдааны газрын томчуултай танилцаж, янхны газраар хэсүүчлэхдээ «Хүүхэн архи хоёрт толгойгоо тушааж болохгүй» гэж өөртөө үргэлж анхааруулж явдаг болой. Цэен янхны газраар орохдоо сэтгэл булаам сайхан хүүхний барааг харангуут «Ийм сайхан амьтны дэргэдүүр яаж зүгээр өнгөрөх вэ? Үзээд алддаг хэрэг» гэж бодоод сэтгэлийнхээ нууц увдист тачаалд захирагдах авч мөн л хашир хөдөлнө. Ийм үед Цэен архи бага амсаж «Архинд шунаж болохгүй. Сайхан царайны цаана шулам шүглэсэн байдаг. Тийм шулам, хүнийг архиар урхидаж, эд хөрөнгийг нь хоослоод зогсохгүй адаг сүүлд нь аминд хүрдэг номтой. Халхад алдартай Да ван Доржпалам, хүүтэйгээ хамт Бээжинд очоод янхан хүүхнүүдэд шунаж сүйрээд сүүлдээ гуйлгачин болсон. Архинд толгойгоо мэдүүлэхгүй бол сайхан хүүхнийг эдэлнэ гэдэг эр хүний жаргал» гэж бодно.

Цэен, зуны эхэн сарын хуучдаар Харбин орж, Оросын дүрвэгсдийн товчооньхонтой уулзаад төдий удалгүй царай муутай буцаж ирлээ.

- Аав аа, та яагаа вэ? Бие чинь муу байгаа юм уу? гэж асуухад Цэен,

- Аа бурхан гончигсум минь гээд өөрийнхөө унтлагын өрөөний хойд ханан дагуу байрлуулсан Ригсүмгомбо хэмээх бурхны өмнө очиж сөхрөөд

- Аа бурхан гончигсум минь, одоо яаж амьд явна даа гэж дуу алдан үглээд мөргөнө.

- Аав аа, юу болоо вэ?

- Сүйд болсон. Богд гэгээн таалал төгсжээ. Би одоо яаж амьд явна.

- Юу? Хэн тэгж байна? гэж эцгээсээ асуусан Сайнжаргал «Ингэж гутарч гуныж яваад аав минь амиа хорлочих вий дээ» гэж бодов.

- Харбины Сафронов тэгж байна.

- Үнэн юм биз дээ?

- Үнэн байна. Хүрээнээс ирсэн нэг худалдаачин орос надад захиа авчирчээ гээд өврөөсөө муутуу цаасан дээр бичсэн захиа гаргаж өгөв,

...Бидний наран гэрэлт эзэн хаан Богд гэгээнтэн зуны тэргүүн сарын 17-нд таалал төгслөө. Гэгээнтний насны буянг бодож сүм бариул! Бие хүн очтол хүрээнд ирж болохгүй. Бурханч Бадрах...

Сайнжаргал, эцгийнхээ захиаг уншаад хэсэг дуугүй байснаа,

- Аав аа одоо тэгээд яах вэ? гэж асуулаа.

- Аав нь, маргаашнаас Гэгээн сүм орж насны ерөөл хуруулж, буяны сүм босгуулах ажил хөөцөлдөнө. Чи Июкогама гингогийн салбарт очоод хэдэн юм аваад ир гэлээ.

- Аав аа, би яаж авдгийг нь мэдэхгүй шүү дээ. Тэгээд ч тэр гингогийн салбарынхан намайг танихгүй.

- Сувдаатай хамт яв! Гингогийн салбарын түшмэлүүд чамайг танина. Ер нь одоо мөнгө төгрөг зарж сурах хэрэгтэй. Дөчөөд мянган иень арван мянган янчаан аваад ир гээд ханынхаа нууц шүүгээг онгойлгож, гингогийнхоо тасалбарыг гаргаж өглөө. Тэгээд утсаа авч Симото руу залгуулж ярихдаа Богд гэгээн таалал төгссөнийг дуулгаад,

- Симото сан, Сайнжаргал Сувдаа хоёр гингогийн салбарт очно. Та очиж туслалцахыг бодохгүй юу. Мугдэнгийн шалдан банди нар их мөнгө авсан хүнийг нүд үзүүрлэдэг шүү дээ. Та нар гингогийн салбар дээр уулзана биз гээд утасныхаа чагнуурыг тавихдаа

- Охин минь Симото санд мянган иень өгчихөөрэй. Гарахдаа Гэрэлээг дуудаатах гээд бурхныхаа өмнө очиж, том цөгцтэй зулыг бадраав.

Сайнжаргал, Сувдаа хоёр хашаанаас гарангуут өмнөх талбай дээрээ байнга байж байдаг, хүн хөлгийг дуудлаа. Ноорхой хувцастай туранхай хөх хүн, агшны төдийд Сайнжаргал Сувдаа

хоёрын дэргэд ирж зогсоод суудлынхаа тоосыг өдөн шилбүүрээр цэвэрлээд тэр хоёрыг суулгав. Сайнжаргал хүн хөлөгт суунгуутаа Сувдаа руу толгой дохитол тэрээр,

- Гингогийн салбар руу яваарай гэхэд хэгээстэй дугуй бүхий тэрэгний арлаас шөрмөслөг гараараа чанга атгасан залуу алгуурхан хөдлөөд цаашлах тусам хурдаа нэмнэ.

- Сувдаа, энэ хүн өдөржингөө манай үүдэн дээр сул зогсох юм. Түүнийхээ оронд өөр хүмүүст үйлчилбэл өөрт нь их юм олдоно доо.

- Бага адиа (Сувдаа Цэнг ингэж нэрлэдэг) өөрөө Мүгдэнгээс олж авсан юм гэдэг. Тэгээд манайхан хоол унд, гадуур дотуур явах ажилдаа зардаг юм. Бага адиа заримдаа зуун иень өгч байгаа харагддаг. Ер нь өдөржингөө зогсоо зайгүй гүйгээд таван иень олохгүй шүү дээ. Тэгэхээр манай үүдэнд бие амар зогсож байсан нь илүү орлоготой байдаг байх.

Хүн хөлөг хурдаа нэмэн гүйсээр таван давхар европ байшингийн, үүдэнд иртэл гингогийн үүдний дэргэд зогсдог цагдаа байшингийн гол хаалгыг онгойлгохоор бэлдэж, Сувдаа тэрэгнээс буунгуутаа арван иень авч өгөөд Сайнжаргалын араас дагав. Тэднийг байшинд ороход хижээл насны авгай угтаж мэндлэхэд Сувдаа,

- Манай гүнгийн охин Сайнжаргару сан (Япон хэл л авиагүй тул р авиагаар орлуулдаг) гэж японоор хэлэхэд авгай,

- Яасан их завшаан бэ? Гүнгийн охинтой танилцсандаа баяртай байна. Тийшээ морилно уу гээд уужим танхимын баруун ханын хаалга руу заалаа. Тэгээд нэгэн өрөөнд орж ирэнгүүт өнөө авгай,

- Сайнжаргару сан, хичнээн юм авах вэ? Би одоохон бэлдээд ирье гэв.

- Дөчин мянган иень, арван мянган янчаан бэлдчихгүй юу гэхэд авгай тэргүүн бөхийлгөн ёсчлоод өрөөнөөс гарлаа. Сувдаа тасалбараа японоор бичиж байхдаа Сайнжаргалд яаж бичдэгийг хэлж өгөөд,

- Бас пийлэнгээр (англиар) бичиж болдог юм шүү гэлээ. Чухам энэхэн үед нөгөө өрөөнөөс гингогийн үйлчлэгч авгай орж ирээд, өрөөний ханын шүүгээнээс нэгэн хайрцаг авч, барьж явсан боодолтой зүйлээ хийгээд хайрцган дээрээ цаас нааж, япон англи хэлээр хичнээн хэмжээний иень, янчаан байгааг бичээд гарын үсэг зурж битүүмжлээд Сувдаад өгөв. Сувдаа мөнгө авахад бичдэг тасалбараа өнөө авгайд өгөөд өрөөнөөс гартал, гингогийн салбарын том танхимд байсан хоёр япон цэрэг, шаргалдуу ногоон хувцастай хошууч Симото зэрэг хүмүүс инээмсэглэсээр Сайнжаргал, Сувдаа хоёрыг угтан уулзлаа.

Дөрөв. Хоног өнгөрөх тусам бодол өөрчлөгддөг

Богд гэгээн таалал төгссөн нь Цэенгийн сэтгэлийг түгшүүлсэн авч тэрээр анхныхаа бодлоос ухарсангүй. Тэгээд хүрээнээс гарахын өмнө Богд хаантай уулзаж ярилцсанаа бодох тусам сэтгэлд нь «Юуны өмнө ардын засгийг устгаад есдүгээр Богдыг тодруулж залаад атаман Семеновыг түшвэл үү! Хаант улсаа эргээд тогтоочихсон байхад есдүгээр Богд намайг зүгээр шагнаад өнгөрөхгүй. Хаант улсын гадаад яамны сайд болгоно» гэдэг бодол эргэлдэнэ. Цэен чингэж бодохоороо хувь заяагаа бурхан сахиусандаа даатгаж, Ригсүмгомбо бурхны өмнө сөхөрч мөргөөд гүнгэрвааны дэргэд байдаг хүрдийг эргүүлдэг зуршилтай. Цэен мөнгөн хуудсаар хийсэн хүрдийг эргүүлж бурхандаа залбирч байтал Гэрэлээ орж ирээд шалан дээр дэвссэн хивсэн дээр сөхөрсөн Цэенгийн дэргэд очив.

- Аа ашгүй чи, ороод ирэв үү. Би чам дээр орох гэснээ унтаж байгаа болов уу гэж бодоод...

- Шөнө бүр чиний өвөрт унтаж сурчихаад одоо ганцаараа унтаж чадахаа больжээ. Тэгээд хүйтэн хөнжилд хэвтэхэд нойр ч хүрэхгүй юм гээд Гэрэлээ нөмөрч явсан дээлээ тайлж, орны хөл рүү чулуудаад Цэенгийн орон дээр хэвтэнгүүт хөнжлөөр нь өөрийгөө хучив. Цэен, бурхны өмнөх том зулан дээр бүхээг тавиад Гэрэлээгийн дэргэд ирж суунгуут нүцгэн цээжинд хошуугаа хүргэж үнсэнэ.

Цэен, тэр нэг өдөр Гэрэлээг, согтуу нүдээр харж, дагина гэж бодсоноосоо хойш өнжөөд очдог болсон. Тэгээд Гэрэлээгийн өвөрт орж таалахдаа «Чи надаас ондоо хүнтэй хавьтаж болохгүй шүү. Би чамд өдөр бүр тавин иень өгнө» гэж билээ. Гэрэлээ Цэенгийн болзлыг дуртай хүлээж аваад янхны газрын эзэнд «Бие муу, энэ тэр» гэж шалтаг тоочоод өөр бусдаас хөндийрчээ. Буудлын эзэн Гэрэлээгийн энэ үгэнд эгдүүцээд түүнийг зайлуулахыг хичээвч япон цэргийн төлөөлөгчийн газрынхнаас айгаад яаж ч чадахгүй болжээ. Цэенг ирэх тоолонд Гэрэлээгийн бие сайжирч, урьд урьдаасаа илүү гоёж гоодох тул буудлын эзэн сэтгэлдээ «Ингэж байгаад Цэен гүнд худалдчихья» гэж боддог болсон. Цэен ахынх руугаа яваад ирсний дараа Гэрэлээг гэртээ авчрахаар шийдэж, буудлын эзэнтэй нууц тохирч, арван мянган иень төлөөд гэртээ авчирчээ.

- Цэенээ, чи намайг яах гэж худалдаж авсан юм бэ? Хар багаасаа янхны газар толгой хавчуулж яваа надаас илүү гоё хүүхэн, цэвэрхэн охид Мугдэнд мундахгүй шүү дээ.

- Чиний үйлдсэн нүглийг буян болгоё гэж бодсон юм.

- Цэенээ, чи дөч гарсан эр гэхэд арван наймт шиг эрхэлж нялуурч байх дуртай юм. Лав шар сэмжилсэн байхаа!

- Эр хүн шар сэмжилнэ гэдэг чинь худлаа үг! Энэ чинь залуу хүүхэн чангаахаасаа нэрэлхдэг хүмүүс залуу хүүхэнтэй суусан хашруудтай шөргөөлцөж, агаархахдаа гаргасан цуурхал.

- Эр хүн, нас ахих тусмаа чадахаа больдог юм биш үү?

- Хүн сэжгээр өвдөж, сүжгээр эдгэдэг гэдэг. Одоо хөгширлөө, яаж хүүхэн чангаах вэ? гэж нэрэлхээд байвал яаж чадах вэ? Залуу хүүхний гижгийг хүргэчихээд элэг доог болно.

Нэрэлхүү зангаас болж, хүний сэтгэл хөрч хүйтэрдэг ёс бий. Тийм үед эр хүн өөрийгөө эвгүй байдалд оруулчихаад бүр ичдэг удаатай. Үүнийг ажигласан эмэгтэйчүүд нэрэлхүү хүнийг ичээж, цаашлуулахдаа шар сэмжилсэн юм гэж егдөг удаатай. Харин эр эм хүн, насаа ахих тусам үүний чинь сайн сайхныг бүр бие, сэтгэлээрээ мэдэрдэг болоод зогсдоггүй хүнээр таалуулах, хүнийг таалах ёсонд илүү авьяастай болчихдог юм.

- Чи ер нь надад хайртай юу?

- Эм хүнийг ийм үгээр өөртөө татаж болохгүй. Бүсгүй хүн, хүний сайхан ааш занд дасахдаа тун амархан байдаг. Үүнийг гадарласан зарим хүн, хүүхнүүдийг өөртөө дасгачихаад, хайргүй мөртлөө хавьтаж ойртохын тулд хайртай гэж амлачихаад сүүлдээ салж чадахгүй хавханд орчихсоноо мэдэнгүүт өөртөө харамсаж,

гасалдаг эр хүн байдаг. Би бол чамд хайргүй. Ердөө амьдын жаргал хуваалцах гэсэн юм гэтэл Цэенгийн үгэнд гомдсон Гэрэлээ буруу харж хэвтэв. Цэен хэсэг дуугүй сууснаа, хөнжилдөө ороод, Гэрэлээгийн нүцгэн мөрнөөс зөөлөн татаж өөр рүүгээ харуулаад,

- Гэрэлээ, сайхан үгээр хуурч байвал чамд сайхан санагдахгүй биз дээ гэж асуугаад нүүр рүү нь ширтэнэ.

- Үгүй л дээ. Цэенээ, чи надад хайртай болох уу?

- Мэдэхгүй. Би ёсолж, төрөлж авсан анхныхаа авгайд хайртай байгаагүй. Ердөө эр эм хоёр гэдэг чинь бие биентэйгээ суудаг ёстой юм гэж бодоод суусан. За тэгээд ноёд, баяд, хутагт хувилгаад ихэс дээдэс гээд л байна. Тэд чинь сайхан хүүхэн харахаараа төр ёс, төрсөн сэтгэлээ ялгаж ухааралгүй хайртай болчихдог. Тиймдээ засаг ноёд хэдэн хүүхэнд хайртай, хэдэн хүүхэнтэй суух ёстойгоо ч хайхардаггүй юм. Хутагт хувилгаад сахил санваар гээд байдаг мөртлөө хоёр гурав, хорь гучин нууц амрагтай байдаг. Ингэхээр бидний амьдарч байгаа энэ үед үнэнч хайр гэж байхгүй. Харин сайн цагийн мянган бурхны үед хүн бие биендээ жинхэнэ хайр сэтгэлээр дурлаж, нэг хүн нэг эхнэртэй байх юм гэдэг.

- Цэенээ, чи яахаараа ийм нялуун байдаг юм бэ?

- Гэрэлээ, чи ханьтай байж үзээгүй болохоор үүнийг мэдэхгүй, эхнэр авсан эр хүн гэдэг чинь хайрынхаа сэтгэлд шатаж, хав гөлөг шиг эрхлэмтгий байдаг юм. Харин амьдрал гэдэг чинь эрээн бараантай болохоор түүнийг ялгаж чадаагүй хүн, хоног өнгөрөх тусам өөр санаа бодолтой болчихдог. Нэг үгээр хэлэхэд аваагүй байхад авгай сайхан, алаагүй байхад үнэг сайхан гэгч болох нь тэр! Авгайгаасаа сэтгэл холдоод ирэхээр «Яах гэж авгай авлаа» гэж бодно. Би эхнэртэй болчихоод таван жилийн дараа бас тэгж боддог болсон.

- Цэенээ, чамд нэг юм хэлмээр байна. Чи уурлах уу?

- Хүүхэдтэй болчихоо юу?

- Үгүй ээ. Чи яагаад ингэж бодоо вэ?

- Хүүхнүүд хүүхэдтэй болчихоороо ингэж асуудаг юм.
- Тэгвэл чи, энэ удаа таасангүй. Чамайг хүний мөсгүй, тэлээгүй банзал гэвэл уурлах уу?
- Үгүй ээ. Энэ чинь миний үнэнийг хэлж байна шүү дээ. Хүн хүнээр буруугаа хэлүүлж сурах хэрэгтэй. Бузар булайг нь улаан цайм хэлсэн хүнд өширхөж, уурлаж болохгүй. Гэхдээ чи, надад ийм үг хэлэх гээгүй.
- Магадгүй. Харин ардын засгийн үед ийм байгаа болов уу?
- Ихсийн яриагаар бол ардын засаг тогтонгуут эхнэрүүдийг нийтийн болгоно гэдэг байсан. Одоо юу болж байгааг яаж мэдэх вэ?
- Тэртэй тэргүй, одоо чинь нийтийнх болчихоод байгаа юм биш үү!
- Аа мэдэхгүй. Үнэнийг хэлэхэд тийм болчихоод байгаа юм. Харин энэ тухай хүрээний нэг номтой лам надтай маргаж, сайн цагийн мянган бурхны үед энэ тачаангуйн хор, гэм арилна гэдэг байж билээ.
- Тэгвэл ардын засгийн үед л арилах юм байна. Хоёулаа ийм дэмий юм яриад яах вэ? Цэенээ, чи намайг ер нь юу гэж боддог вэ?
- Яг үнэнийг дуульа гэж бодож байна уу?
- Тийм яг үнэнийг чамаас сонсьё.
- Чи бол янхны газрын данжаадын даалгавраар миний дэргэд байгаа хүн. Танай данжаад бол Жан Золин болон японыхны аль алинаас авсан даалгавраа биелүүлэхийн тулд миний дэргэд чамайг хавчуулсан. Гэхдээ чи, тэднээс ямар даалгавар авахаа мэдэхгүй яваа, муурын аманд орсон хулгана шүү дээ. Чи түрүүнээс хойш үүнийг надад хэлэх гээд халгаж ядаад тойруу замаар зөндөө юм ярилаа.
- Чи энэ бүхнийг яаж мэдээ вэ?
- Хүнд эцэг эхээс заяасан нүд чихнээс гадна авьяасаар заяасан нүд чих байдаг юм шүү.
- Тэгвэл тэр чинь танай үүднээс холддоггүй хүн хөлөг үү?
- Тиймээ. Чамд энэ тухай танай данжаад хэлсэн үү?
- Тэд чинь чиний нууц хүн хөлгийг тоодоггүй юм. Тэгээд ч тэр чинь мөрөөрөө яваа хүн шиг байдаг шүү дээ.
- Тэгвэл чи, яаж мэдсэн юм бэ?
- Цэенээ, би үхээд авснаасаа босож ирэхийг л үзээгүй. Бусдыг нь сайнтай муутай, бузартай булайтай нь хамт үзсэн. Тэгээд амьдралд шаналсан хүний нүдний харцаар сэтгэлийг нь

анддаггүй боллоо.

- Тэгвэл чи, яагаад эзэндээ айлтгаагүй юм бэ?

- Муур эзэндээ эрхлэмтгий атлаа доромжлолыг нь хүлцдэггүй учраас хэзээ нэгэн цагт эзнээ багалзуурдахад бэлэн байдаг.

- Гэрэлээ тэгвэл муур шиг явбал дээр үү? Нохой шиг явбал дээр үү?

- Чи өөрөө муур шиг яваа хүн. Хятадуудыг үздэггүй мөртлөө цагийн аяыг дагаж, дуугүй яваад өдий хүрсэн! Үүнийг ганц би биш, наран эзэд хүртэл мэдэж байгаа. Тэгээд ч чи өөрөө аман дотроо хятадуудыг зүхдэг болохоор заримдаа сэтгэлийнхээ бодлыг ч үгээр чанга илэрхийлдэг болсон байна. Тэр хоёр хан сувдыг надаас авсны дараа орноосоо босоод юу гэснээ санаж байна уу?

- Тиймээ. Тэгэхэд юу гэж хэлснээ санаж байна.

- Чи тэгэхэд «Модоо барьсан өгөр илжигнүүд монголын буянд шунаад шунал нь шулам болсон болохоор хоёрхон ширхэг сувд үзээд сувдаг сэтгэлээ барьж чаддаггүй байна шүү. Ийм хувалзуудыг тонилгох хэрэгтэй! Гайгүй ээ. Цаг нь ирнэ" гэж билээ. Манай данжаадыг орж ирэхэд чиний уур омог бүр бадарч, дотроо бодсон зүйлээ үгээр илэрхийлэхдээ «Илжиг модон хударгандаа гэгчээр таарсан таар шуудайнууд юм даа. Гарцгаа гэсэн. Тэгээд биднийг өрөөнөөс гарахад хойноос "Өгөр илжиг, муусайн хужаа нар шаахайнаас өөр өмчгүй, шанцайнаас өөр хоолгүй гуйлгачингууд" гэж хашгирахдаа ямар дуугаар хэлсэн гэж санана. Естой төмөр рүү хатгаж байгаа могой шиг сэтгэл сэрхийлгэсэн дуугаар хэлж билээ. Тэр өдрийн чиний алдаа ганц энэ биш. Үйлчлэгч нарт үнэ хөлсөө урьдчилан төлөхдөө хан сувдаа хэтэвчнээсээ гаргасан явдал манай эзний шуналыг бадраасан юм. Эзэн намайг дуудаж уулзаад «Чиний гайхамшигтай хан сувдыг салга» гэж даалгасан. Тэр хан сувдуудыг алтан ээмгэнд суулгавал нэг нь тавин мянган иень хүрэх байсан. Харин энэ явдлаас айсан эзэн минь намайг аврах нь байтугай хошууч Симотоогоос айхын эрхэнд намайг цагдаагийн газар тушаах гэж хөөцөлдөж билээ. Наран эзэд чамайг хүндэтгэдэг болохоор манай эзэн намайг яаж ч чадаагүй өнгөрснийг би хожим мэдсэн. Тэр үед миний сэтгэлд нэг бодол төрсөн. Тэгээд би, тэдний гарт бие, сэтгэлээрээ худалдагдаад эцэстээ нохойн гөлөг шиг амиа алдах юм гэдгээ

ойлгосон. Цэенээ чи, надаас айсны хэрэггүй. Эд нар Сувдаа, Сайнжаргал хоёрын илүү дутууг надаар мөрдүүлэхийг хичээж байгаа. Түүнээс гадна чиний хөрөнгийг мэдэх гэж бодож байгаа юм. Би хүний газар яваа чамайг хорлохыг бодохгүй. Тэгэх тусмаа миний сэтгэлийг гашилгаж, адгуус шиг болгосон хүмүүсийн гарт чамайг тушаахгүйг бодсон юм гэж хэлэхэд Гэрэлээгийн нүднээ нулимс цийлэгнэснийг ажсан Цэен эрхий хуруугаар нулимсны дуслыг арчаад, Гэрэлээг үнсэж сэтгэлийг нь тайтгарууллаа.

- Гэрэлээ, чамд их баярлалаа. Энэ хорвоогийн нүгэлт зовлон бид хоёрыг учруулжээ. Тийм болохоор чиний сэтгэл намайг худалдаж чадахгүй гэдэгт итгэж байна.

- Цэен минь охидууд чинь надад дасчихаад надаас дандаа чамайг асуугаад байх юм. Чамайг

эзгүй хойгуур «Аав хаачсан бэ? Танд хаашаа явахаа хэлсэн үү?» гэж сураглаад байдаг. Тэгээд зогсохгүй хоол ундны мөнгө төгрөгөө надад тушаачихаад «Яасан ийсэн бэ?» гэхгүй юм гэхэд Цэен,

- Тэгвэл болж байгаа нь тэр дээ гээд Гэрэлээгийн хацрыг үнсэхэд Гэрэлээ Цэенгийн цээжийг чанга тэвэрч өөр рүүгээ ойртуулна.

- Ноён генералаа, Сафроновын хүүг асрах хүний нэг бол би юм. Энд ирсээр хоёр жил гаран боллоо. Би анх удаа уулзахдаа хэд гурван юм өгөөд ажил төрөл олж хийгээд олигтойхон амьдраарай гээд явсан юм. Гэтэл энэ маань сэтгэл санаагаар гутраад ч тэр үү нэг өөдтэй амьдрах янзгүй явна. Дам дуулбал төмөр замын газар ачаа зөөдөг сурагтай. Тэгээд арзанд толгойгоо мэдүүлчихсэн бололтой. Би үүнийг дуулаад Мугдэнгээс өчигдөр ирлээ. Уг нь болж өгвөл Тозияаг Токиогоос иртэл ийм байлгахгүй юмсан. Та оросын дүрвэгсдийн товчооныхонтой ярилцвал ажил албатай болгож болох байх. Эндээ гэж хэлэхэд Ардын засаг азийн Та Да хэмээх загасны пүүсний болон орос худалдаачин Боронцовын саналыг хүлээж аваагүй байна. Тэд нарыг Буйр нуурт загасны үйлдвэр байгуулж, газар түрээсэлж авбал би тэдэнтэй хувь нийлүүлж хоршоод өөрийнхөө бие төлөөний хүн болгоё гэж бодсон юм. Гэтэл миний бодол талаар өнгөрөх янзтай гэхэд Харбин дахь японы цэргийн төлөөлөгчийн газрын удирдах ажилтан генерал, Цэенгийн үгийг хичээнгүйлэн сонсоод,

- Би оросын дүрвэгсдийн товчооныхонтой ярилцъя. Тэд хөрөнгө мөнгөөр татуухан байгаа. Гэхдээ эзэн хааны цэргийн яам, санхүүжүүлэх шийд гаргах гэж байгаа. Бид чинь энэ хоёр жил гаруйн хугацаанд газар хөдлөлтийн сүйрлээс бүр мөсөн гарч чадаагүй байна. Танд гэж хэлэхэд ардын засгийг устгаад Богд хаант засгийг сэргээн тогтоох гэсэн таны зорилгод оросын дүрвэгсдийн товчоо багагүй үүрэгтэй. Тэгэхээр гүнтэн минь хувь хандив бодно биз гэж эвийг нь олж ярина.

- Дүрвэгсдийн товчоог санхүүжүүлэх тухайд би юм бодож байгаа. Тэд нар монголын асуудал эрхэлсэн тусгай хэсэг байгуулах юм бол би хөрөнгөөр тусалж болно шүү гэхэд генерал суудлаасаа босож гүнгийн дэргэд ирээд,

- Тэгвэл Сафроновыг монголын хэсэгт ажиллуулъя. Иван Степанович чинь монголд өссөн хүн. Монгол орныг арван хуруу шигээ мэддэг хүн, оросынхонд хэрэгтэй. Би өнөөдөр ярилцаад орой хариу хэлье гэхэд Цэен хариу талархал илэрхийлээд буудал руу явлаа.

Сафроновын хүүг дүрвэгсдийн товчоонд ажиллуулж хуучин эдэлж явсан цол хэргэмийг ахиулж, тусгай байр олголоо. Чингээд Цэен гүн, Сафроновын хоёр өрөө сууцанд тавих эд хогшил авч өгөөд тэднийд байх болов.

- Иван минь, одоо хүн шиг яваарай. Муу эцгийнхээ ясыг өндөлзүүлэх хэрэггүй. Чамайг хэл аманд ороолдоод, хүн амьтан муу хэлэхээр би байтугай муу Сайнжаргал хүртэл сэтгэл зовох юм. Охин минь чамтай үерхэж өссөн болохоор чиний нэр төрийг боддог бололтой.

- Цэен гуай Сайнжаргал та хоёр байхгүй бол би ёстой амаараа шороо үмхэх байсан шүү. Та хоёрын төлөө би, бурханд залбирч байна. Ачийг чинь хэзээ нэг цагт заавал хариулна гэхэд Цэен,

- Иван минь монголд Богд хаант төрийг сэргээн тогтоох явдалд Наран улс ямар байдлаар хандах бол? гэж асуулаа.

- Цэен ахаа, монголын талаар баримталж байгаа японы улс төрийн бодлогыг чин үнэнээр нь тайлбарлана гэдэг бэрхтэй зүйл.

Гэхдээ Соёнзогийн үеийн (1911—1912 онд ерөнхий сайд байсан) бодлогыг баримтлах байх. Хаант орос, япон хоёрын байгуулсан 1912 оны нууц гэрээгээр бол бүх монгол туургатныг нэгтгэж, японы эзэн хааны хараат улс болгох явдалд хаант орос саад хийхгүй байх үүрэгтэй. Япон үүнийгээ нуухын тулд Хаалганы замаар халхавч хийсэн юм. Хүрээнд 1913 онд ирсэн япон түшмэл Кодама, Ар өвөр монголыг нэгтгэх хийгээд Хятадаас бүрмөсөн тусгаарласан явдлыг бэхжүүлэх талаар Дайчин ван Ханддорж, Хаант оросод очиж тохиролцсон явдлыг мэдсэн, япон нэлээн дургүйцсэн юм. Ялангуяа тэр үед ерөнхий сайд байсан Ямамото (1913—1914) хүрээнд очсон Кодамагийн айлчилгааг засгийн газартай холбоогүй гэдэг нэрээр далдалж, улс төрийнхөө бодлогыг нууцалж чадсан юм.

- Сафронов минь би гадаад яаманд ажиллаж байхдаа энэ тухай мэдсэн Богд хаан хөх бар жил (1914 он) эзэн хаан тэнно Иосихарад бичсэн захианд монголчуудыг нэгтгэх явдалд наран улс сайн үйл бүтээнэ гэдэгт итгэж байна гэсэн байсныг хожим олж үзсэн юм. Гэтэл тэр үед Япон улс Германтай дайн зарлаад, номхон далай дахь Германы эзэмшил газрууд руу дайрч, Хятадын Шандун мужийг эзлээд Юань Шинхайд 21 зүйлийн тулган шаардах бичиг өгчихөөд монголын асуудалтай зууралдаагүй хойш тавьсан байсан.

- Цэен ахаа, Япон улс, хятадыг эзлэн авбал ардын засгийг устгаад, ар өвөр монголыг нэгтгэнэ гэж үзсэн учраас Богдын хүсэлтийг хойшлуулсан гэдэг. Гэтэл японы нөлөө хятадыг бүхэлд нь хамарч чадаагүйгээр барахгүй тэдний улс төрийн бодлого, эдийн засгийн байдал их хямралтай байна. Эзэн хаан Иосихито олон жил өвчнөөс салсангүй. Одоо бараг хоногоо хүлээж байгаа гэлцэнэ. Гэтэл хаан хүү Хирохито дөнгөж хорин таван настай, улс төрийн бодлогын учрыг төдий сайн ойлгохгүй. Нөгөө талаар одоогийн ерөнхий сайд Катогийн байр суурь муудаад, японд ажилчин тариачны нам родо номинто бас социал ардчилсан нам-сякай минсюто гэгч байгуулагдаад улс төрийн талаар өрсөлдөх болсон. Тэгээд зогсохгүй японы коммунист нам байгуулагдлаа. Ингээд Япон, Улаан Оростой элчин солилцохоор тохиролцоод байна. Японы дээд зиндааныхан улс төрийн болон эдийн засгийн сүйрлээс гарах замыг дайн гэж үздэг боллоо. Японы сонингууд Сито ёсны шашны тунхагийг хэвлээд байна. Түүгээр бол япон улс арван жил тутамд дайн хийж байх ёстой гэнэ. Дайн хийхгүй байгаа учраас тэнгэрийн хараалаар сүйрэхэд хүргэсэн газар хөдлөлт боллоо гэж зарлаад байна. Тиймээс Токиогийн Ясукуна сүмд хатамана (дайны бурхан) тахиж, дайн бол бүтээн байгуулалтын эцэг, соёл цэцэглэлтийн эх гэдэг сургаал гаргалаа. Ингэхээр япон ойрын хэдэн жилдээ хятад, манжуурыг эзлээд, аажимдаа монголын асуудлыг шийднэ гэлцдэг юм.

- Иван минь, япон улс Богд хааны хүсэлтийн дагуу цэргээ монгол руу илгээх юм уу эсвэл зэр зэвсгийн тусламж үзүүлэхгүй гэж үү?

- Япон, юуны өмнө хятад, манжуурыг өөрийн мэдэлд оруулаагүй цагт яаж ч чадахгүй. Тэд улааны нөлөөг азид дэлгэрүүлэхгүйн тулд юуны өмнө хятад, манжуурыг чухалчилж байгаа. Япончууд улаан оросын нөлөөг алс дорнодоос зайлуулах гэж 1921 онд Миркуловын засгийн

газар гэгчийг тогтоосон боловч аргагүйн эрхэнд өөрийнхөө цэргийг Владивостокоос татаж авсан. Үүнээс болж цэргийнхэн, японы засгийн газар болон гадаад яамны боловсруулсан «Тайван замаар хятад, манжуурыг эзлэх» гэдэг асуудлыг шүүмжлээд байна. Цэргийн яамны сайд байсан Танака одоо хөрөнгөтний Сэйюка намыг толгойлох болж, цэрэг дайныг дэмжигчид олшроод, засгийн эрхийг цэргийнхэнд шилжүүлэхийг гол зорилго болгож байна. Ингэхээр цэргийнхэн засгийн эрхийг аваагүй үед монголд цэргийн тусламж үзүүлж чадахгүй гээд японы цэрэг, улс төрийн бодлогыг тайлбарлажээ.

Цэен, Иван Степановичтай ингэж ярилцсан боловч түүний ярианд итгэсэнгүй. Гэхдээ өөрийнхөө бодолд эргэлзэн «Япон, хятад манжуурыг эзлэх гэдэг юу гэсэн үг вэ? Манжийн хаан, хятадын урвагчдын тусламжтайгаар тэнгэрийн хүүгийн ширээг булаан авч эзэн болсон. Манжийн хаан Галдангийн хөдөлгөөнийг дарах нэрийдлээр цэргээ монгол руу оруулж, Өндөр гэгээнийг залилж чадсан. Тэгээд зогсоогүй Өндөр гэгээнийг хорлосон. Мөн хоёрдугаар Богдыг гоочилж байсан гэлцдэг. Манжийн тэнгэрийг тэтгэсэн хаан, гуравдугаар Богдыг түвдээс тодруулах Лүндэг буулгаснаас хойш монголчууд найман түвдийн нүүр үзэж тэднийг оройн сахиус болгож тахиж ирсэн. Харин наймдугаар Богд монголчуудыг манжаас салгаж өгсөн буянтай хүн! Тэгэхээр есдүгээр Богдыг халхаасаа тодруулах нь зөв шүү. Алийн болгон шашин, төрөө харийн хүнээр толгойлуулах вэ?» гэж бодно. Тэрээр монголыг тусгаар улс болгож, төр шашнаа өөрснөө толгойлбол улс шиг улс болно гэж үзнэ. Гэтэл түүний энэ үзэл цагийн аяыг дагаад хэд хэдэн бодлоор солигдов.

Цэен гүн, Богд хаант улсаа мандуулаад өөрөө гадаад яамны сайд болно гэж боддог байсан. Гэтэл Сафроновын хүүтэй ярилцсанаас хойш японы тусламжтайгаар улаан нам, ардын засгийг устгаад ар өвөр монголыг нэгтгэж, Чингэсийн үеийн эзэн төрийг тогтоовол, японы эзэн хаан монголд найртай хандах болно гэж үзнэ. Тэр үед Цэен гүн, Их Монгол улсын ерөнхий сайд болно гэж горьдоно. Тиймээс сэтгэлдээ «Манжширийн хийдийн лам байгаад хожим багш болсон Бодоо ардын засгийн ерөнхий сайд болж болсон юм чинь би Их Монгол улсын ерөнхий сайд болж бололгүй яах вэ? Бодоо эрдэм боловсролоор маруухан хүн. Тэгэхэд би, манж, хятад, монголтой хүн шүү дээ» гэж өөрийгөө өөгшүүлэн бодно.

Цэен, сүүлийн үед шөнөжингөө элдвийг бодож нойроо хулжаадаг боллоо. Тэрээр бурханч Бадрахаас Шанхай дахь хадгаламжийн талаар заавар бүхий бичиг авсан атал түүнийгээ нууц шүүгээндээ нямбайлан хийснээс хойш одоо хүртэл үзэхийг бодсонгүй. Үүнийг эргэцүүлэх тусам «Ер нь яах вэ? Иваныг гуйж хүрээ рүү хүн илгээх үү? Богд хаантан таалал төгсөөд жил гаруй боллоо. Гэтэл бурхны тиг сураглаж ирэх хүн, одоо хүртэл сураггүй. Ямар ч гэсэн ялгуусан лам, Бадрах хоёр руу хүн явуулъя» гэж бодно. Цэен нэг удаа Харбинд ирж оросын дүрвэгсдийн товчооныхонтой уулзаад буцахын өмнө Иван Степановичоос,

- Чи бид хоёрт бие биенээсээ нуух юм байхгүй. Ингэхээр чи, хүрээ рүү явуулчих итгэлтэй хүн олохгүй юу гэхэд Иван Степанович

- Цэен ахаа, тэр болно шүү. Тэр хүн маань хүрээнд очоод яах юм бэ? Буцаж ирэх хүн хэрэгтэй юү? Эсвэл тэндээ бүр суух хүн юм уу гэлээ.

- Хүрээнд очоод бурханч Бадрах, ялгуусан лам хоёртой уулзаад ирвэл болох нь тэр.

- За би, таны захисан хэргийг чинь бүтээгээд ирэх итгэлтэй хүн ольё гэхэд Цэен Иван Степановичийн үгэнд баярлаад,

- Хүү минь тэгж үзээрэй. Ах нь тэр хүнд чинь шан хөлсийг нь чамлалтгүй өгнө гэлээ.

Цэен гүн энэ удаагийн ирэлтээр Харбинд гурван долоо хоноод буцахын өмнө Америкийн банкны нэгэн салбарт таван зуун мянган иений хадгаламж нээгээд Оросын дүрвэгсдийн товчоонд зуун мянган иень хандивлаад буцлаа.

Цэен, Мугдэнд ирснийхээ дараа Бадрахын өгсөн өнөө бичгийг нууцын шүүгээнээс гаргаж охинтойгоо хоёулхнаа уншлаа. Тэгээд бүр гайхах, баярлахын эрхэнд захирагдав. Бадрахын тэр өгсөн бичигт Шанхай дахь гадаад нэгэн улсын томоохон банкинд нууц хадгалуулсан алтны талаар хийсэн хэлэлцээний албан баримтыг хавсаргажээ. Тэр баримтанд дурдсанаар бол Шанхай дахь Богдын алт нь хааны нэр дээр биш харин Цэен гүнгийн нэр дээр хадгалаатай байгааг мэдээд айх, гайхах, баярлах гурав давхарлажээ,

Цэен хэдэн өдөр гайхан алмайрч, их алтны эзэн болсноо ойлгох тусам «Одоо яах вэ?» гэж бодоод учраа олж ядна. Түүний толгойд эх адаггүй олон бодол эргэлдэнэ.

...Би төр, шашны төлөө яваа болохоор энэ алтыг түүнд зориулах ёстой. Гэтэл Богд гэгээнтэн таалал төгсчихлөө. Бадрах ялгуусан лам хоёроос ямар ч хэл чимээ байдаггүй. Тэгэхээр энэ алтыг яах вэ? Үүнийг би, хувьдаа авч болохгүй. Тэгвэл цагаан хэл аманд өртөж яах ч юм билээ. Буцаагаад аваад явъя гэхээр аваачаад ардын засагт өгөлтэй нь биш! Ингэхээр миний хувийн юм болчихож байгаа хэрэг үү? Ай бурхан минь нүгэл байгаа даа. Эзэн хааныхаа буянд ингэж хар санаж болохгүй гэж бодтол ах Баатарын нь үг санаанд орлоо. Тэрээр нэг өдөр "Монголын шашныг толгойлсон найман богд монголчуудыг юугаар гялайлгасан юм бэ? Монгол хүн өөрийнхөө төр шашныг толгойлох ёстой байтал түвдүүдийн үр садыг эзэн хаан, шашны тэргүүн гээд орой дээрээ залаад өдий хүрлээ. Энэ бол бидний тэнэг, төр улсын талаар мэдлэггүйг харуулж байгаа хэрэг" гээд уурлаж байсныг санах. Тэгээд

зогссонгүй нэг удаа Ханддорж чин вантай уулзахад «Богд... Богд гэнэ. Бид энэ нүдэн балай, чихэн дүлий түвдийн гарыг харж өдий хүрлээ. Гэтэл Богд шашны манлай, оройн сахиус гэдэг нэрийдлээр яаж байгааг нь хар! Бид улс орноо хятад манжаас тусгаарлаад төрөө бэхжүүлэхийн тул хаант оросоос олон зуун мянган орос янчааны зээл авлаа. Гэтэл Богд яаж байна. Манай орны баялгийг гадаадын шунахай нарт найр тавин өгөөд түүнийхээ шанд авсан их хэмжээний алтыг биднээс нууж түвд рүү явуулсан байна. Ийм хүнийг хаан эзэн гэж болох уу? Тэр алт чинь Богдын, амин хувийн хөрөнгө биш. Улсын хөрөнгө, сан шүү дээ» гэж гэртээ цугласан санаа нэгт нөхөдтэйгөө шүүн ярилцаж билээ. Гэтэл би, одоо түмэн лан алтны эзэн болчихоод байдаг. Тэр үед чин ванг яасан тэнэг хүн бэ? гэж бодоод түүний ажил явдалд оролцоогүй хөндийрч билээ. Одоо бодвол ёстой тэнэг хүн чинь би байжээ. Яагаад энэ бүхнийг урьд өмнө мэддэггүй явав аа? Би одоо ингэж үлий сахисан амьтан шиг байдаг чинь зөв үү? Буцаад очвол яадаг бол? Ардын засаг энэ алтыг хураагаад авчихна. Аягүй бол намайг Богдын гар хөл болж байсан этгээд гээд хар гэрт түгжвэл яана? Ер нь нутаг буцаж болохгүй.

Цэен хориод хоног чингэж бодол боллоо. Сүүлийн үед түүний сэтгэлд хязгааргүй өрсөлдсөн олон бодол нь өөр шинэ бодлоор солигдож байв. Ардын засгийг устгаад Богд хаант улсын

гадаад яамны сайд болно гэсэн бодол Их Монгол улсыг байгуулаад ерөнхий сайд больё гэсэн бодлоор солигдсоны адилаар бас өөр бодлоор солигдоно.

...Ерөнхий сайд... ерөнхий сайд гэдэг чинь нэрнээс цаашгүй зүйл шив дээ. Энэ их улс, гүрний ерөнхий сайд эцэстээ саятнуудын гарын аяыг харж, үйлдвэрийн эздийн бэлээр амь торгож явдаг юм байна. Тэгээд ерөнхий сайд гэдэг насны юм биш! Цэргийнхэн бослого гаргавал амиа алдаж мэднэ. Саятан, үйлдвэр банкны эзэд бол хэн хүний гарт өртдөггүй, харин хүмүүс тэднийг царайчилж явдаг юм байна. Тэгэхээр саятан үйлдвэр, банкны эзэн болох нь энэ насны бахархал, болохно. Азийн Та-Да пүүснийхэн Буйр нуурт загасны үйлдвэр байгуулбал ихээхэн ашигтай гэсэн. Бас тэгээд зогсохгүй Халх голын сав газарт жимсний тариалан тарьж, жимсний үйлдвэр байгуулбал зүүн умард хятадыг жимсээр

хангаж их орлого олно гэдэг сэн. Бас хүрээний нэг шинжээч хятад Ханд вангийн хошууны Норовпилжээлин (Эрдэнэ арвижуулагч) дуганы ойролцоох газрыг их хэмжээний оюу эрдэнэтэй гэсэн. Тэгээд түүнийг ашиглаж чадвал дэлхийг худалдан авч болно гэж донгосож билээ. Тэр жил сангийн яаманд байхдаа албан хэргээр Лэгшиддонгойлин хийд (Ханддорж вангийн хүрээ, Булганы хүрээ) дээр очиход Үржинтэгчинлингийн нэг лам надтай уулзаад ярихдаа Норовпилжээлин дуганы тухай ярьсан юмсан. За байз юу гэлээ. Аа тийм... манай хийдийн өвгөн лам, Эрдэнэт овооны тэндээс хятадууд оюу номин түүгээд байдаг болчихлоо. Лус тахиж, дуган бариулахгүй бол шаахайгаа үүрч ирсэн гуйлгачин хужаа, шижир алтаар биеэ ороож мэдэх нь гээд дуган бариулсан гэдэг. Хужаа нарыг тэндээс оюу малтаж байхад нь өнөө өвгөн лам дайралдаад «Хай хужаа юу хийж байна вэ?» гэхэд өнөөх нь «Би шороо ухаж алт болгож байна» гэжээ. Өвгөн лам, хужаагийн доогтой үгэнд эгдүүцээд «Чи тийм их ид шидтэй илжиг үү?» гэхэд цаадах нь «Миний атгасан шороо алт болно шүү. Чи уз ваа» гээд бөөн шороо авч атгаад алгаа дэлгэхэд өнөө шороо алт болсонгүй, харин шороо хэвээрээ байсан гэдэг. Өвгөн лам шороог хараад «наадах чинь хар шороо байна шүү дээ» гэхэд хужаа инээгээд «Заяа муутай хүнд алтны өнгө шороо болж харагддаг юм шүү. Чи лав муу заяаны лам ваа» гэхэд нь өвгөн лам «Чи ч их заяатай илжиг юм даа. Алган дээрх чинь алт биш аалз байгаа юм биш үү» гэхэд өнөө хужаа айн цочихдоо алгаа сэгсэрч шороогоо унагах гэтэл шороо нь алгатай нь наалдаад салж өгөөгүй! юм гэдэг. Хужаа айхдаа «Хай ламаа, чи энэ шороог салгаж өг. Би дахиж энд ирэхгүй» гэж гуйхад өвгөн лам «Дахиж ирсэн ч наанаасаа юу ч олохгүй. Ясаа тавих болно» гээд явчихсан гэдэг. Ламын үгнээс сэжиглэсэн хужаа тэр шөнөө өөд болсноос хойш хятадууд Норовпилжээлингийн дэргэд газар ухахаа болиод алга болсон гэдэг...

Цэен энэ яриаг эргэн санахдаа бас өөр зүйл бодлоо. Тэрээр янжуур татах зуур «Хүрээний шанси үзмэрчинд энэ тухай ярихад тэрээр хэсэг бодсоноо «Оюу бол зэсний баас юм. Зэс бол дэлхийд ховор зүйл шүү» гэж билээ. Ер нь Мугдэнгийн шинжээч луухаануудтай уулзъя байз гэж бодлоо. Тэгээд нэг өдөр хотын захад байдаг өнөө шинжээч үзмэрч луухаан дээрээ очиж уулзахдаа зэсний тухай ярилаа. Ная нэлээн гарсан тэр өвгөн хятад,

- Зэс бол маш ховор зүйл. Зэсний их орд олбол үйлдвэр байгуулах хэрэгтэй. Тэгвэл ёстой баян болох нь тэр дээ гэжээ. Түүнээс хойш Цэен гүнгийн сэтгэлд нэгэн үзүүргүй бодол эргэлдэж, ёроолгүй хүсэл сэтгэлийг нь шаналгах болжээ.

...Ардын засгийг устгаад Богд хаант улс байгуулчихвал Норовпилжээлингийн оюу номинг ашиглах үйлдвэр байгуулж болно. Тэгээд Буйр, Халхын савыг өөрийн хошуу нутаг

болгочихвол уу? Ер нь монгол хүн яагаад саятан болж, үйлдвэр банкны эзэн болж болдоггүй юм бэ? Би ийм алттайгаас хойш гадаадын саятангуудаас юугаараа дутуу байгаа юм бэ? Ер нь Бадрахтай уулзахыг бодох хэрэгтэй. Тэр юм үзсэн хүн. Ламхай бол Бадрахын үгийг дагана. Харин гай болж тэр хоёр таалал төгсчихсөн бол яана? Тэгвэл Шанхайд байгаа алт миний өөрийн хөрөнгө л болж таарна шүү...

Цэен ийнхүү хэд хоног бодсоны дараа Шанхай орж банкныхантай уулзахаар шийдсэн авч нэгэнт намар болж хүйтэрсэн тул хавар болгохоор шийдэв. Чухам энэ хугацаанд Иван Степанович нэгэн залууг олж хэд хэдэн удаа туршсаны дараа хүрээ рүү явуулахаар шийдэж Цэен гүнд учир байдлыг дуулгалаа. Чингээд хүрээ явсан хүнийг хүлээж ядсан Цэен гүн, Шанхай дахь алтаа зүүдэлж, сэтгэлийн бодолд автагдсан боловч дотроо «Буурьтай хөдлөх хэрэгтэй. Хэрвээ Бадрах, ламхай хоёр хэн хэн нь таалал төгссөн бол энэ алтыг надтай булаалдах хүнгүй болно. Ер нь тэдний сургийг гартал Шанхай явахаа больё. Буурьтай хөдөлсөн дээр» гэж өөртөө хатуу сануулна. Тэгээд хүрээнээс ирэх хүнээ хүлээж ядаад хаврын сүүл сард Шанхай руу явах гэж байтал японы засаг төрд өөрчлөлт гарч, цэргийн яамны сайд байсан Танака засгийн газрыг толгойлов. Түүнээс хойш удаагүй байтал гоминдааны намын баруун жигүүрийнхэн Шанхайд бослого гаргаж, Чан Кайши бүх хятадыг эрхэндээ оруулах самуун дэгдээв. Ингээд Цэен гүн, цаг төрийн үймээнээс шалтгаалж аяллаа хойшлуулж хүрээний хүнийг хүлээж намар болгов. Намрын эхэн сарын шинэдээр Иван Степанович Мугдэнд ирлээ. Тэгэхдээ ганцаараа ирсэнгүй. Дунд зэргийн нуруутай, гуч орчим насны нэг залуу дагуулж ирсэн нь өнөө хүрээ рүү явуулсан орос залуу байлаа. Цэен гүн хүрээнээс ирсэн хүнтэйгээ уулзаж сэтгэлд тээглэсэн шаналгаа хөнгөрч, хөлд орсон хүүхэд шиг баярлаж байхад Сайнжаргал Мугдэнд ирснээс хойш бараа бараагаа хараагүй Иван Степановичтой уулзсандаа хөөр хөгжөөнтэй байлаа. Хүрээнээс ирсэн элч, Цэентэй уулзангуут үзсэн харсан бүхнээ тоочиж гарлаа.

- Цэен гуай, юуны өмнө намайг уучилна байх гэж бодож байна. Би танд олигтой мэдээ авчирсангүй гэж халхаар хэлэхэд Цэен,

- Гэхдээ арай хоосон ирээгүй биз дээ гэлээ.

- Би таны захисан хүнийг олох гэж их үйлээ үзсэн. Ялгуусан лам, Богдыг таалал төгссөний дараа Богдын хатанд хөрөнгө хуваахад их юм өгнө гэж зүтгээд хэрэг буруудсан гэнэ. Богдын хатан олон тэрэг ачааг өөрийн хөрөнгө болгож аваад Туулын гүний нутагт очиход ялгуусан лам түүнийг дагаж явсан гэнэ. Тэгээд дараа нь хатантай ханилсан гэж ярилцаж байна гэхэд Цэенгийн уур хилэн гэнэт бадарч "Тэгнэ ээ тэр муу новш. Богдын оронд Богд болчих гээд байсан муу нохойн гөлөг, хаан эзнээ таалал төгссөний дараа хань ижлийнх нь бөгс бөөрнөөс чангаадаг байна шүү. Яаж зүрхлээ болоо! Богдын буянаар овоо туйлсан хэрнээ хатантныг чангааж байхдаа юу боддог байна аа? Ичих нүүрэндээ элэг наасан лүд" гэж бодно.

- Естой төрийн янхан гэдэг чинь тэр ламхай байж дээ гэж амандаа үглэсэн Цэен, шар цайвар царайтай орос руу хяламхийн харснаа,

- Бурханч Бадрахтай уулзав уу? гэж омогтой асуулаа.

- Бурханч ламтан шоронд орсон байна. Амь хэлтэрсэн арван жилээр заагджээ. Мэнд мултрах

юм бол очно гэж хэлүүлсэн. Тэр хүртэл таныг хүлээж бай! Хүрээ рүү зүглэх хэрэггүй гэсэн. Намайг Хүрээнд байхад хоёр удаа оргох гээд баригдсан. Сүүлд нь надтай ч уулзуулахаа болив. Тэгээд би шоронгийнхоор дамжуулж уулздаг болов. Гэтэл гэнэт сэжиглэгдэхэд хүрлээ. Бурханч лам миний байдлыг мэдээд над руу хүн явуулж "Хурдан буц! Хүрээнд байх хэрэггүй! Очих ёстой хүн заавал очиж уулзана. Тэр болтол хүлээж бай" гэсэн. Тэгээд би наашаагаа гарлаа.

Шар царайтай орос яриагаа үргэлжлүүлэхдээ үе үе ширээн дээрх хундага руу нүд бэлчээнэ. Түүний сэтгэлийг ойлгосон Иван Степанович, Сайнжаргал руу нүд ирмэхэд тэрээр хоосон хундагыг дүүргэнэ. Орос залуу хундагатай архи ууж, сэтгэлээ тайвшруулсны дараа яриандаа орж,

- Хүрээний нөлөө бүхий хүмүүс есдүгээр богдыг тодруулах гэж их хөөцөлдсөн. Тэр байтугай Ялбиг гэдэг газар Цэрэндэжид гэдэг хүүхнээс төрсөн нэг хүүг Богдын хойд дүр гэж үзжээ. Үүнээс болж зарим хүрээ хийдэд зэвсэгт хөдөлгөөн гаргах гэж байгаад илэрсэн. Ингээд хүрээ хийдийнхэн шашны тэргүүнгүй болоод аргаа барж ядаж байгаа бололтой гээд шилэн хундагатай архиа хөнтөрлөө. Цэен гүн хүрээнээс ирсэн шар оросын үгийг хичээнгүйлэн сонсоод толгой руугаа мунаар нүдүүлсэн юм шиг хэд хоног сэтгэл манаран бодлогоширчээ.

... Яах вэ? Мүгдэн дэх гадаадын их гарын наймаачид надтай сэм уулзах тоолондоо "Азийн банкны төв холбоонд" хувь нийлүүлээч гэсэн. Шанхай. Шанхайн банкинд байгаа алтанд хий хоосон мөнгө төлж хадгалуулахын хооронд ер нь бүгдийг доллар, иень болгоод хадгалуулчихвал хүү нь талийж өгнө. Бадрахыг хүлээж хий суухаар Шанхайнхантай очиж уулзъя. Нарсанд байгаа Бадрах намайг гэж ирэх нь өнгөрсөн хэрэг. Юу ч гэсэн Шанхайнхантай уулзъя.

Цэен чингэж шийдээд Сайнжаргалыг дагуулж Шанхай орохоор зуны адаг сарын дундуур Мүгдэнгээс гарлаа.

Шанхай, Хятадын Шар тэнгис рүү цутгадаг Улаан мөрний цутгалан Хуанпу зян мөрний, их тохойд эрт үеэс загасчид бөөгнөрчээ. Үүрийн гэгээнээс үдшийн бүрэнхий хүртэл Улаан мөрний усанд норж, голдоо хүйт ортол даарч дагжин зүтгэж олсон загасаар амь зогоодог хүмүүс. Хуанпу мөрнийхтохойд суурьшаар томоохон суурин үүсгэсэн. Түүнийг анхандаа Хуту гэж нэрлэсэн бөгөөд цагийн эрхээр далайн усан замын боомт хот болсноор Шэнь гэж нэрлэсээр Тан улсын үед (608—907) Хуантинхай, Сүн улсын үеэс (960—1279) эхэлж Шанхай гэсэн болой. Одоогоос гурван зуун жилийн тэртээ Шанхайд худалдаачин, гар урчууд бий болж, европын худалдаачдын анхаарлыг татах болсон. Чингээд английнхан Хуанпу зян мөрний хойд тохойд Улаан мөрний бэлчир бараадуулан, эзэмшил газар авч суурьшсаны дараа америк (1848 он), францын (1849 он) худалдаачид Шанхайд ирсэн болой.

Цэен гүн, Шанхайд ирснийхээ орой Сайнжаргалаар нэгэн зурвас бичүүлээд тусгайлсан тэмдэг дарж битүүмжлээд буудалд байрладаг шуудангийн салбарт аваачиж өгөхдөө,

- Энэ бичгийг америкийн худалдааны танхимын удирдах ажилтны хэн нэгэнд өгчихвөл болох юм гэж захижээ.

Өндөрдүүхэн цагаан хятад залуу, Цэен гүнгийн захидлыг авч битүүмжилсэн лац, тэмдгийг ажиглаад,

- Цагийн доторхүргээд өгнө гэж амлахад Цэен гүн шуудангийн салбарын өрөөнөөс гарчээ. Цэен гүнг өрөөндөө орж ирсэн тэрхэн үед шуудангийн газрын үйлчлэгч залуу, тэр захидлыг Шанхай дахь японы цэргийн төлөөлөгчийн газрын нэгэн ажилтанд буюу кэмпэйтэйн бие төлөөлөгчийн гарт хүргэж өгчээ. Халзан хурандаа тэр бичгийн лац, тэмдгийг үзээд өөрийнхөө туслахыг дуудаж,

- Үүнийг эвтэйхэн задлаад доторхыг нь унших хэрэгтэй гэлээ.

- Шиү са доноо (ноён дэд хурандаа) одоо хэрэгтэй юу гэхэд,

- Тиймээ. Тун яаралтай, ердөө таван мөчийн дотор гэхэд дэд хурандаагийн туслагч өнөө бичгийг аваад гарлаа. Тэгээд хэдэн мөч болсны дараа Цэен гүнгийн бичгийг авчирч уншиж сонголоо.

Гүн миний бие, танай худалдааны танхимын хүсэлтийн дагуу өнөөдөр Шанхайд ирлээ. Ангийн үсний хоршсон нийгэмлэг байгуулах гэсэн танай саналыг маргааш ярилцах боломжтой тул төлөөний хүнийг уулзуулахыг мэдэгдье... гээд эрхий хуруу дарам хэмжээтэй тамга дарсныг ажвал Цэен гүнгийн нэрийн дараа хас тэмдэг буюу түмэн наст хэмээх хээний зөв эргэсэн сэртэнгүүд нь улаан өнгийн шунханд дарагдаад, будаг бүхий дардас болсон учраас чухам юу байгааг мэдэхэд бэрхтэй болжээ.

- Шиү са доноо, энэ чинь ерийн нэг зурвас байгаа бололтой.

- Та и (ахмадаа) хэрвээ нууц болзмол дохио бол яах вэ? Нөгөө талаар энэ болзмол тамгыг юу гэх хэрэг болж байна гэж хурандаа омогтой шалгаахад түүний туслах,

- Шиү са доноо, Шанхай дахь америкийн худалдааны танхим, ийм утгатай зурвас хэдэн арвыг хүлээж авдаг байх шүү. Нөгөө талаар халхын ноёд нэрийн хуудас хэрэглэхийн оронд ийм дийз (нэр бүхий тэмдэг) хэрэглэдэг юм шүү.

- Тай и, халхын засаг ноёд нэрээ сийлсэн тамга хэрэглэдэг ёстой болохоос гүнгүүд тийм тамга хэрэглэдэггүй!

- Шиү са доноо, ардын засаг тогтсоноос хойш монголын багахан тушаалын хүмүүс эрхэмсэг хүн болохын тулд өөрсдийгөө төрийн өмнөөс ярих эрх бүхий хүн хэмээн үздэг болжээ. Тиймээс өнөө Цэрэнпил гүн, хуурамч тамга хийж хувийн бичигт дараад, төрийн элч хэмээн шуугиан дэгдээсэн шүү дээ. Цэен гүн манжуурт хоргодож, толгой хавчуулахын тулд өөрийгөө яаж ч мандуулж мэднэ гэхэд дэд хурандаа,

- За тэгвэл яах вэ? Нэгэнт мэргэжлийн хүн ингэж айлдаж байгаа хойно таны үгийг дагая! Харин нэг зүйлийг анхааруулахад банкныхантай уулзах нь уу? гэдгийг хянаж байх ёстой. Энэ тухай жанжин штабын Тозияа сан, онцолж сануулсныг мартаж болохгүй гээд өнөө зурвасыг урьдын адил нааж, лацыг нь гэмтээлгүй битүүмжлээд үйлчлэгчийг дуудаж,

- Наад зурвасаа аваачаад өгчих. Харин гүн, охинтойгоо хаашаа хэдийд ямар хэргээр явсныг мэдэж байх хэрэгтэй гээд зурвасыг буцааж өглөө.

Цэен гүнгийн бичгийг цагийн дараа хүлээж авсан худалдааны танхимын нэг удирдах ажилтан,

- Мугдэнгийн баян хүний толгой нь эргэжээ. Ангийн үсний хоршсон нийгэмлэг байгуулах гэнэ үү? Манайхан ийм хүсэлтийг хэнд ч тавиагүй байхаа гээд туслах руугаа сүрхий харлаа. Тэгээд хэсэг бодсоноо туслахынхаа хүүхдэрхүү царайг ажиглаад,

- Үүнийг авчирч өгсөн хүн хаана байна? гэж асуулаа. Тэгээд үүдний өрөө рүү толгой дохисон туслахаа ширтэн хэсэг зуур дуугүй болсноо,

- За байз сэтгэлд нэг юм эргэлдээд байх чинь! Юу билээ. Манай банкны ерөнхийлөгчийн орлогч нэг ийм юм аминчилж яриад байсан юмсан. Тэр болж таарлаа гээд ширээн дээрх утсаа аваад чагнуурыг барьж зогсохдоо хэнтэй ярихаа утасны хорооныхонд хэлж өглөө. Гэтэл удаж төдөлгүй утасны чагнуурт,

- Байна уу гэх дууг сонссон худалдааны танхимын удирдах ажилтан,

- Хэнтэй ярих вэ гэхийг сонсоод «Олон улсын банкны дэд ерөнхийлөгчийн туслахтай» ярьж байгааг түвэггүй мэдэв.

- Танай дэд ерөнхийлөгчтэй яримаар байна гээд Цэен гүнгийн зурвасны агуулгыг хэлж өглөө.

- Би дэд ерөнхийлөгчөөс асуугаатахъя. Одоохондоо зав муутай байгаа байх. Та хаанаас ярьж байна вэ? гэлээ. Худалдааны танхимын удирдах ажилтан өөрийнхөө нэрийг хэлтэл өнөө туслах,

- Та жаахан хүлээхгүй юү? Би одоохон асуугаатахъя гэлээ. Тэгээд төдий удсангүй туслахын дуу чагнуурт цангинаж,

- Манай дэд ерөнхийлөгч энэ тухай мэдэхгүй гэж байна. Гэхдээ би, өөрөө ингэсхийгээд очно. Тэгээд ярилцах уу даа гэлээ.

Шанхайд бөөгнөрсөн америкийн худалдаа, банкны удирдах ажилтангууд чингэж ярилцсаны маргааш нь зочид буудлын эзэн, америк гаралтай, хижээл насны нэг хүн Цэенг өрөөндөө урилаа. Тэрээр буудалдаа буусан ихэс дээдсийг хүндэтгэн, өрөөндөө өөрийн биеэр хүлээн авч тал засдагийг буудлын үйлчлэгч нар андахгүй. Гүн Сайнжаргалтай хамт буудлын эзний өрөөнд ортол өндөр нуруутай, том биетэй, хөнгөн шаламгай хөдөлгөөнтэй европжуу царайтай эзэн, ширээнийхээ араас хөл алдан босож ирээд Цэенг найрсгаар угтан чихэр жимс, тансаг ундаан тавьсан ширээ рүү уриад,

- Ар монголын эрхэм их хүн манай өчүүхэн буудалд буусан явдалд миний сэтгэл баяртай байгааг уламжилж, танилцах завшаан эрсэн юм гэж англиар хэлтэл түүний дэргэд зогсож байсан залуу хятадаар орчуулж өглөө. Гэвч Цэен гүнгийн хариуг Сайнжаргал англиар хэлсэн

явдалд олзуурхсан буудлын эзэн,

- Оо танай охин чинь англиар ус цас шиг ярьдаг байсан юм уу. Даанч мэдсэнгүй. Намайг уучлаарай. Бид чинь орчуулагчгүй ярьж болох юм байна гээд орчуулагч руугаа нүдээр дохитол хэлмэрч залуу өрөөнөөс гарч одлоо. Буудлын эзэн, хэлмэрчээ гарсны дараа өрөөнийхөө давхар хаалгыг хаагаад Цэенгийн дэргэд ирэнгүүт,

- Гурвуулаа ийшээ орцгооё гэж бараг шивнэн хэлээд,

- Тэр өрөөнд тохь тухтай ярилцъя гээд ширээнийхээ хажуу ханын хаалгыг онгойлгов.

Уужим өрөөний голд шахам зассан нэгэн ширээний дэргэд буруу харж суусан халзан хүн, Цэен гүнг орж ирэх чимээнээр суудлаасаа босож, инээмсэглэсэн боловч бодлогоширч эргэлзсэн нүдээр гүнг ширтэн,

- Эрхэмсэг гүн таныг Шанхайд морилж ирсэн явдалд их баяртай байна гээд энгэрийнхээ халааснаас танилцуулах хуудсаа гаргаж үзүүлэв. Чухам энэхэн үед буудлын эзэн, хаалгаа аяархан хаагаад өөрийнхөө албаны өрөө рүү буцаж орлоо. Цэен, танилцуулах хуудсыг Сайнжаргалд өгөхөд тэрээр халзан хүний албан тушаал, алдар нэрийг эцэгтээ тайлбарлаж өглөө. Цэен Сайнжаргалын орчуулж өгсөн үгийг анхааралтай сонсоод хариу талархал илэрхийлж, өврөөсөө нэгэн бичиг гаргаж, ноёнтын өгсөн танилцуулах хуудастай тулгаж үзээд хоёуланг нь өнөө ноёнд өглөө.

- Цэен гуай та, ийшээ суугаач гэж өнөө ноёнтон хятадаар хэлээд тансаг засалтай ширээ рүү заагаад,

- Би худалдааны танхимд явуулсан таны зурвасыг авсан. Та тэр зурвастаа дарсан дийзээ (тамгаа) үзүүлээч гэхэд Цэен гүн, гуулиар хийсэн дийзээ гаргаж өглөө. Өнөө ноён, энгэрийн халааснаас томруулдаг шил гаргаж өнөө дийзний бичгийг уншиж шалгасны дараа,

- Гүнтэн минь, энэ дийзэнд байгаа хас тэмдэгний учрыг хэлж өгөөч гэв.

- Энэ бол хас тэмдэг биш. Хятад дүрс бичгийн шан буюу уул гэсэн дүрсийг японоор ханзчилж тэмдэглэсэн юм гэхэд өнөө ноёнтон,

- Би Шанхай дахь олон улсын банкны ерөнхийлөгчийн бие төлөөний хүн. Би тантай хадгалуулсан алтны талаар ярилцаж тохирох бүрэн эрхтэй гээд инээмсэглэв.

- Танай банкны ерөнхийлөгч болон түүний бие төлөөний хүн тантай уулзах боломж гаралгүй өдий хүрчихлээ. Миний ирсэн, зорилго бол танайд хадгалуулсан түмэн лан алтны төлбөрийн тооцоог хийж, заримыг нь долларын ханшинд шилжүүлэх талаар тохиролцохын зэрэгцээ алтыг шилжүүлэх тухайд тохирсон зүйлд өөрчлөлт оруулах талаар ярилцмаар байна гэж Цэен гүнг хэлэхэд,

- Эрхэм ноёнтон таны хүсэлтийг бид үг дуугүй биелүүлэх ёстой. Алтны заримыг долларын ханшинд шилжүүлэх тухайд гэвэл танд хятадын Кантон, Бээжин, Шанхай, Тяньжин, Мүгдэн,

Харбин дахь манай салбар банкнаас хэрэгцээтэй хөрөнгө авч байхыг зөвшөөрсөн тасалбар өгөхөд бэлэн байна. Харин алтыг японы засгийн газарт шилжүүлэх тухайд таны төлөөний хүн Бадрахын хийсэн гэрээний хувьд бол таны саналын дагуу дуртай улс оронд шилжүүлэх, осол эндэгдэлгүй хүргэх үүргийг бид хүлээж чадна гэдгээ мэдэгдэх ёстой. Харин манай ерөнхийлөгчийн саналын хувьд гэвэл таныг Нью-Йоркод суувал Мугдэнгээс хавьгүй дээр гэж үздэгийг уламжлах ёстой. Хэрэв Ардын засгийг устгаад Богд хаант улсыг сэргээн байгуулбал та чинь Орос Хиагтад байгаа Азийн банкны үйл ажиллагааг үргэлжлүүлэн удирдаж болох талтай юм шүү. Та чинь сангийн яаманд байсан, мэргэжлийн хүн. Тэр мэргэжлээ Нью-Йоркод очиж гүнзгийрүүлэх нь чухал шүү гэж тал засан хэлэв.

Цэен гүн банкны ерөнхийлөгчийн бие төлөөний хүнтэй уулзаж ярилцаад буудлын эзний өрөөнөөс гарахад төлөөний хүн, тэр өрөөндөө үлдэв. Буудлын эзэн, эцэг охин хоёрыг буудлын хөлийн өрөө хүртэл гаргаж өглөө. Цэен буудлын эзэнтэй ярилцан, шатны дэргэд түр саатахыг харсан шуудангийн хэсгийн үйлчлэгч хятад залуу, гартаа нэгэн бичиг барьсаар тэдний дэргэд ирээд хүлээн зогсохыг ажваас хэнд ч үл сэжиглэгдэм энгийн болой. Тэр залуу буудлын эзэн, гүнтэн хоёрын яриаг чагнахыг хичээсэн боловч нарийн зохион байгуулсан уулзалтын талаар ямар нэг сэжиг гаргаж, япон эздэд уламжлах боломж байсангүй.

Цэен, охинтойгоо Шанхайд хориод хоноод буцахад Шанхай дахь японы консулын газрын төлөөлөгч, Мугдэн рүү буухиа элч илгээж «Маш нууц» гэсэн нэгэн бичиг хүргүүлжээ. Тэр бичигт Шанхайд ирсэн Цэен гүнгийн тухай өгүүлсэн болохоор японы армийн тагнуулын газраас Мугдэнд сууж буй ахмад Симотогийн гарт оржээ.

...Цэен гүн, Шанхай дахь америкийн худалдааны танхимын дөрвөн хүнтэй зургаан удаа уулзаж, ангийн үсний хоршсон пүүс байгуулах талаар ярилцаад ямар ч амжилтгүй буцлаа. Энэ хугацаанд буудлын эзэн, Цэенд тал засаж, гурван удаа хүлээн авлаа. Хүлээн авалт буудлын эзний өрөөнд болсон. Гүнтэн Шанхайд байх хугацаандаа олон улсын банкны ажилтангуудын хэнтэй ч уулзсангүй. Харин гүнг ирснээс хойш долоо хоноод банкны ерөнхийлөгчийн төлөөний хүн, буудалд буусан англи, голланд, францын төлөөлөгчтэй уулзаж ярилцсан атал Цэен гүнийг тэр уулзалтанд урьсангүй. Шанхай дахь учир мэдэх хүмүүсийн яриагаар бол ерөнхийлөгчийн төлөөний хүн, Цэентэй холбоо тогтоох чиглэл удирдлагаасаа аваагүй учир уулзалтанд уриагүй гэдэг төсөөлөл гаргаж байна. Нөгөө талаар энэ тухай ямар нэг холбоо тогтоосон бол Нью-Йоркийн «Нейшл сити» хэмээх олон улсын банкны нэгдэл, хятад дахь өөрийн салбаруудад тусгай цахилгаан өгөх ёстой байсан гэнэ. Гэтэл энэ талаар Шанхайгаас ямар ч шийд гараагүй учраас хятад дахь америкийн банкны бүх салбарт тусгайлсан цахилгаан явуулаагүй гэж үзэж байна. Энэ тухай жич нарийн тогтоож мэдэгдэнэ...

Симото, бичгийг хэдэнтээ уншиж, өөртөө ашигтай хэд хэдэн сэжиг гаргахдаа баримт болж чадмаар зүйл дээр тулгуурлав. Тэрээр юмыг сонжихдоо хүмүүсийн алдаж болох эгзгийг оновчтой олдог болой. Тиймээс уул бичгийг няхуур хянахдаа «Банкныхны хэн ч уулзаагүй... Долоо хоноод болсон уулзалт... Гүнг уулзалтанд уриагүй... банкны салбаруудын хүлээн авах цахилгаан утас» гэсэн зүйлийг анхааралдаа аваад эргэцүүлбэл нэг л сэжигтэй санагдана. Тэр тусмаа сэтгэлд нь «Манай маанагууд ийм сэжим гаргаад түүнийхээ мөрөөр шалгалгүй үлддэг хэнэггүй гайхлууд!» гэж бодохоос уур нь хүрнэ. Тиймээс Симото, Шанхайгаас ирсэн мэдээг Токио руу илгээхдээ Тозияагийн нэр дээр явуулжээ.

Цэен гүн, Шанхайгаас ирээд сэтгэл хангалуун байсан тэр үед Симото бухимдуу байв. Учир нь Шанхайхны сэжиглэсэн баримтыг жанжин штабын нэр дээр явуулсан нь Тозияагийн дургүйг хүргээд зогссонгүй, түүний Мугдэнд ирэх шалтаг болсон бололтой. Чингээд Симото, Мугдэнд ирэх Тозияад өөрийгөө хэрхэн цагаатгах талаар бодож, юуны өмнө Цэенд Тозияаг ирэх өдрийг мэдэгдээд хүлээж байлаа. Чингээд хэд хонож байтал Тозияа Токиогоос Мугдэнд ирээд цэргийн төлөөлөгчийн газраар ч шагайсангүй шууд Цэенгийн ирж байрлав. Цэен, Тозияа хоёр уулзсаны баяр болгож хоёр өдөр баахан сэржимдсэн тул Симото, хурандаагийн барааг харж чадаагүй билээ.

- Цэен минь, манай армийн жанжин штаб, Богд хааны хойд дүрийг тодруулж Нэгдсэн Их монгол улс байгуулах явдлыг анхааралдаа авах зүйлийн нэг гэж үзэж байгаа. Харин засгийн газар өөр бодолтой байна. Тэдний бодлоор бол хятадын асуудлыг найрамдлын замаар шийдэж чадвал манжуурыг хятадаас салгаж тусгай улс болгож чадна гэж үзэж байгаа. Харин армийн удирдлага бол манжуурыг цэргийн хүчээр хятадаас тусгаарлаж, тусгай улс болгохыг хамгийн зөв зам гэж үзэж байна. Манжуурыг хятадаас тусгаарлаж биеэ даасан улс болгоод, хятадын улс төрийн дотоод зөрчлийг япон улс зөв зохицуулж чадвал бүх монгол угсаатныг нэгтгэх асуудал аяндаа нүд ирмэхийн төдийд бүтнэ гэдэгт найдаж болно! Чи дипломат ажил хийж байсан болохоор юу эс андах вэ? Монголын хаант төрийг тогтоож чадвал чи гадаад яамны сайд төдийгүй ерөнхийлөгч болж болно гэхэд Цэен хэсэг бодсоноо,

- Би монголын төрийг толгойлоод байж чадна. Аз дайрвал түүнээс илүү ашигтай зам бий гэлээ. Тозияа, Цэенгийн үгийг сонсоод сэтгэлдээ «Алтны дэргэд байсан гууль шарлана гэдэг үнэн юм даа. Хятад дахь их гүрний худалдаачдын арга залиг гадарлаад авчихсан болохоор төр улсыг атгандаа хийчихдэг үйлдвэр, банкны эздийн ов залиг үнэрлэчихсэн байна. Гүнгийн бодол өөрчлөгдөж томоохон үйлдвэр банкны эзэдтэй хоршихоор шийдсэн байх нь! Гэхдээ арми ямар хүчтэйг мэдээгүй байна. Харин баян хүн, ганц шуурганд малгүй хоцорч, модоо барьдаг ёсыг ойлгуулаад армитай тэрсэлдсэн үйлдвэр, банкны эзэд нүцгэрч болдгийг гадарлавал бодол нь эргэх ёстой» гэж бодно.

Цэен, Тозияатай уулзаад их баяртай байсан болохоор түүнээс асууж, лавлах зүйл мундсангүй. Тэрээр болор хундаганд сакэ дүүргээд,

- Тозияа минь, чи тэгээд Мугдэнд суух болж байна уу? Эсвэл Токио руугаа буцаад усанд хаясан чулуу шиг таг чиг болчих гэж байна уу? гэлээ.

- Би энд бүр сууна. Тэгэхдээ Чанчунь юм уу, Мугдэнд юм уу гэдэг асуудлыг шийдэж чадаагүй байна. Миний хүслээр болдог бол би, манжуурыг хятадаас тусгаарлах ажилд оролцож, нэгдсэн монгол улс байгуулах явдалд чадах ядахаараа тусалмаар байна.

Эзэн хаан Хирохито, өөрийн эцэг мэйжи хааны улс төрийн бодлогыг үргэлжлүүлж, Монгол туургатныг нэгтгэх асуудлыг дэмжээд байгаа юм. Монголын Нэгдсэн эзэнт улсыг байгуулахад гар бие оролцоно гэдэг их хувь заяа шүү гээд хундага өргөхдөө тагнуулын газрын даргын хэлсэн үгийг санав. Тозияаг токиогоос явахын өмнө тэрээр уулзаж ярилцахдаа «Монголын үндэсний үзэлтэнгүүдийг биедээ татаж, армийн ажиллагаанд оролцуулах улс төрийн алхам бол Чингэсийн үеийн их улс байгуулахад японы эзэн хааны арми, монголын язгууртангуудад тусална гэдгийг итгүүлэх явдал мөн! Гэхдээ самурайн жинхэнэ тангарагийг мартаж

болохгүй! Бидний гол зорилго бол Монголын нэгдсэн улс байгуулах нэрийн доор хятадын цагаан хэрэмнээс Байгаль хүртэлх нутгийг эзэн хааны эзэмшил болгож, Азид эзэн хааны дэглэмийг тогтоох ёстой гэдгийг мартаж болохгүй» гэж хатуухан тушааж билээ. Тозияа эгшний төдийд энэ бүхнийг бодоод яриагаа үргэлжлүүлж,

- Намайг өөр ажилд томилж магадгүй. Гэхдээ миний саналыг харгалзах байх гэж найдаж байгаа. Аз дайрвал Мугдэнд сууж мэднэ гэж хэлэхдээ гүнгийн сэтгэлийн бодлыг мэдэх гэж мэрийсэн хэрэг болой.

- Чи Мугдэнд суухыг бодоорой. Би чамтай ярьж зөвлөх юм их байна. Наад зах нь гэхэд муу ахын минь бие муудаад байна. Сүүлийн хэдэн жил ходоод гээд өөдөлсөнгүй. Гэтэл одоо нарийнтсан нь илэрхий боллоо. Одоо ганц халбага шингэн юмаар голоо зогоож байгаа гэнэ. Би ах руугаа явья гэж бодсон боловч чиний сургийг дуулаад хүлээж байлаа гэхэд,

- Цэен минь, ахыг чинь Токио руу аваачиж эмчлүүлбэл яасан юм бэ? гэж хэлэхдээ дотроо «Цэенгийн ах хувьсгалч бодолтой хүн. Тэгэхээр Цэенг ахтай нь уулзуулж болохгүй. Цэенгийн сэтгэл тогтвортой биш. Нэг мэдэхэд ахынхаа замаар орж мэдэх хүн. Тэгэхээр ахыг нь Цэенгээс холдуулах нь чухал» гэж бодлоо. Цэен Тозияагийн үгийг зөвшөөрч,

- Тозияа минь, би удахгүй ах руугаа явна. Харин чи охинд минь түшиг болоод байж байхыг хичээнэ биз гэхэд Тозияа дуртай зөвшөөрлөө.

Тозияа, Мугдэнд ирээд японы армиас манжуурт суух төлөөний хүний үүргийг гүйцэтгэх болсноор манжуур, өвөр монгол дахь японы тагнуулын хорлон сүйтгэгчдийг зохион байгуулах ажлыг удирдах хүмүүсийн нэг болов. Цэен гүн ах руугаа яваад улаан бар жилийн намар хүртэл дэргэд нь байв. Цэен, ахыгаа токиод аваачиж эмчлүүлэхийг чармайсан боловч ах нь дургүйцсээр байлаа. Тэгээд Цэен, Тозияагаар дамжуулан Токиогоос эм авчруулж эмчлүүлсэн боловч ахын нь бие сайжирсангүй. Чингээд өдрөөс өдөрт муудсаар дөчин еснийхөө жил дээр бурхан болов. Баатарыг нас барсны дараа нэг өдөр хадам эцэг нь Цэентэй уулзаж, Токиогоос авчруулсан эмийг гуйж авлаа. Цэен ахыгаа нутаглуулснаас хойш дөчин ес хоногийг гүйцээгээд буцах гэж байтал нэг үдэш Баатарын хадам эцэг Цэентэй уулзаж ярилцахдаа,

- Токиогоос авчруулсан тэр эм чинь хортой эм бололтой гэв.

- Та яаж мэдээ вэ?

- Би эндхийн нэг эмчтэй уулзсан. Тэр хүн эм найруулдаг мэргэжлийн хүн. Тэгээд бас хятад эмч нараар шалгуулсан чинь тэр эмийг их хортой эм байсан гэж байна. Бид тэр эмийг уулгахдаа сүүгээр даруулж уулгах ёстой байжээ гэж хэлэв. Цэен ахынхаа хадмын үгийг сонсоод,

- Тийм байж мэднэ. Тозияа тун хатуу эм шүү гэж байсан. Тэр эмийг авчирч өгсөн хүн, сүүгээр даруулж уулгахыг нь мартаад хэлээгүй байж мэднэ. Түүнээс Тозияа ахыг минь хорлох хүн биш.

Баатарын хадам, Цэен гүний энэ санааг ойлгосон болохоор зориуд бэлдсэн хортой эм өгч

явуулсан учрыг тайлбарлах хэрэггүй гэж үзсэнийг Цэен хэрхэн ойлгох билээ. Үнэндээ яаж ч тайлбарласан түүний үгийг Цэен үнэмшихгүй нь илэрхий. Тиймээс Баатарын хадам үгээ зөөллөж хэлсэн нь тэр билээ.

Цэенг буцаж ирэхэд Тозияа, Тяньжин руу явсан байлаа. Тэрээр жанжин штабаас өгсөн удирдамжийн дагуу Тяньжинд ажиллах болсон учрыг Симотогоос өөр хэн ч мэдсэнгүй. Тэрээр «эзэн хаан» гэж товлосон нэгэн нууц хуйвалдаанд холбогдох ажиглалт хийх ёстой. Цэен Мугдэнд ирсний дараа Симототой уулзаж,

- Надад эм хүргэж өгдөг байсан өнөө хорчин хүн, хаана байгаа вэ? гэхэд Симото уруулаа үл мэдэг жимийгээд,

- Тэр үү? гээд хэсэгхэн түгдэрснээ мэдэхгүй шүү. Тозияа саны итгэлтэй туслахуудын нэг байх. Би зүс үзсэнээс цаашгүй. Манай тай са доноо (ноён хурандаа) нарийн учраа бидэнтэй ярих биш. Би ч дээдсийн хэрэг явдлыг асууж, шалгаах биш гэлээ.

- Симото сан, тэр хүний аваачиж өгсөн эмийг Токиогоос авчруулсан гэдэг. Ойрдоо миний ходоод хорсоод болдоггүй. Чи надад захиж өгөхгүй юү? гэхэд Симото,

- Тиймээ. Ходоодны өвчинд тун сайн эм гэсэн. Хэрвээ танд хэрэгтэй бол би захиалж болно шүү. Ер нь манай эмч нарт бий. Саяхан Токиогоос захиж авчруулсан гэж байсан гэхэд Цэен,

- Тэгвэл бүр гялайх нь тэр шүү. Симото минь чи, хэдийг гуйгаад ч гэсэн олоод өгөөрэй гэж гуйлаа.

Симото, хэлсэн үгэндээ хүрч, маргааш нь хэдэн боодол эм авчирч өгснийг ажвал боодол, янз төрхөөрөө ахын нь ууж байсан эмтэй тун адилхан байлаа. Тэгээд Симотогийн гарыг цайлгаж хоёр зуун иень өгөөд түүнийг явсны дараа өнөө эмээ задалж үзвэл үнэр, өнгө, амт нь шал ондоо байв. Цэен тэр эмийг амсаж үзээд «Яах аргагүй хортой эмээр сольсноос зайлсангүй шүү. Тэгэхээр тэр хорчин хүн гэдэг нь хятад хүн байж таарах нь. Тозияагийн өгч явуулсан эмийг тэр новш сольж, хортой эм өгсөн байж таарах нь. Түүнээс Тозияа миний ахад муу санаж, хорлох ёсгүй хүн» гэж бодлоо. Цэен гүн, чингэж учир байдлыг гадарлах болсноор сэтгэл санаа нь тогтворгүй болжээ. Тэгээд архи уухдаа хэтрүүлж ухаан алдана. Тэрээр архи уусан үедээ «Хүний газар ганц ахаа, хужаа нарын гарт өртөөчихлөө. Ер нь хужаа нарын дунд ингэж явах гэж дээ. Надаас өөдтэй амьтан бол эдний толгой дээр цахиур хагалж байхгүй юу! Гэтэл би, хорслоо эчнээндээ хадгалж, номхон хүлцэнгүй царайлж яваад нэгийгээ хорлууллаа. Тэгээд гон бие, гозон толгой үлддэг байна шүү. Ер нь ингэж байхаар далайн чанадад гаръя. Тэнд очвол энд ингэж явснаас хамаагүй дээр» гэж өөртөө үглэнэ. Цэен ингэж бодовч бас өөрийнхөө олон бодолд ээрэгдэж, чухам аль бодлоо сонгох ухаанаа олсонгүй. Тэгээд эргэж хургасаар хэдэн сар болжээ. Түүнийг нэг удаа согтуу ирэхэд Сайнжаргал, Сувдаа хоёр загнаж, сүүлдээ уйлж гуйлаа.

- Аав аа та чинь улс төрийн хэргээр энд ирсэн хүн. Өөрийгөө боддоггүй юм гэхэд нэр сүрээ бодмоор юм гэж Сайнжаргалыг үглэхэд,

- За яах вэ? Юу ч гэсэн Тозияа ирэг. Тэгээд болохгүй бол та хоёроо дагуулаад Америкт очиж

амьдарна. Энд хятадуудыг харж хараал зүхлээ барж явсанд орвол Америкт очиж нам тайван амьдарсан минь дээр. Аав нь анхандаа Богд хаант улсаа сэргээн мандуулья гэж бодож байлаа. Гэтэл Богд хаантан минь таалал болчихлоо. Одоо манай ихэс язгууртай хүмүүс улс орноо монгол хүнээр толгойлуулж, нэгдсэн Их Монгол улс байгуулах хүсэл эрмэлзэлтэй болоод байгаа гэнэ. Наран улс Чингэсийн үеийн улс төрийг тогтооход цэргийн тусламж үзүүлэх янзтай болоод байна. Гэтэл энэ олон санаа бодлын минь аль нь биелэхийг би мэдэхгүй явна. Ер нь миний ерөнхий сайд болдог ч нохойн бодлоос цааш хэтрэхгүй байх! Нохой сар руу хараад хуцахдаа тэнд мөлжүүртэй яс бий гэж боддог гэсэн. Гэтэл би Богд хаант улс... Их Монгол улсыг байгуулахыг хүлээж ингэж явдаг ч дээ. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий бэлдэхтэй адил бүтэлгүй хэрэг болно байх... Ардын засаг тогтоод зургаан жил болж байдаг. Гэтэл миний бодол хоосон яриа, сайхан зүүднээс цааш хэтэрдэггүй гэж хэлээд уурандаа багтрах шахлаа. Сайнжаргал, Сувдаа хоёр Цэенг архинаас гаргах гэж ятгаж ядаад нэгэн өдөр Гэрэлээд,

- Ажаа, та аавд архи уухаа тат гэж хэлмээр юм. Аав жирийн хүн биш шүү дээ гэлээ.

- Та хоёрын нэг нь төрүүлсэн охин, нөгөө нь асарсан охин нь. Би бол танай хоолыг хороож, амь тээж яваа нэг муу зарц эмэгтэй. Аав чинь миний үгийг сонсох нь байтугай, эрүүлдээ ч гар далайдаг шүү дээ. Би эзнээ уурлуулж танайхаас хөөгдвөл Мугдэнгийн хог дээр хаягдаж, өлбөрч үхэхэд хүрнэ гээд учирлан уйлав. Цэен гурван сарын турш элдвийг бодож, цагийн байдлыг ажиглан, далайн чанадад гарах эсэхээ шийдэж ядаж байтал японы улс төрийн удирдагчид «гэдсэндээ хөлөө» хийлцэх шахлаа. Катогоос ерөнхий сайдын ширээг авсан Вакацукийн засгийн газрын улс төрийн бодлогыг шүүмжилсэн сэйюкай намынхан засгийн эрхийг аваад ерөнхий сайд Танакагийн цэргийн түрэмгийлэл эрч хүчээ авч хятад руу цэрэг улс төрийнхөө харааг сунгасан энэ үед Тозияа армийн тагнуулын удирдлагаас шинэ даалгавар авч, Манжийн сүүлчийн хааны ахуй амьдрал, улс төрийн бодлого, чиг баримжааг судалж Тяньжинд хоргодсоор байв. Чухам тэр үед Тозияагийн сэтгэлд нэгэн увдист бодол төрж сэтгэл санааг нь эзэмдсээр байлаа. Тэрээр эзэн хаан Хирохитогийн санг арвижуулах гэж зүтгэх албагүй гэдгээ юунаас ч илүү ойлгоно. Учир нь нялх балчир эзэн хааны зөвлөхүүд Тозияаг үл тоомсорлоно. Тиймээс Богдын алтыг армийн тагнуулын ажиллагаанд нэмэрлэх нэрээр түүнийг олж аваад, ертөнцийн бөглүү хязгаарын нэг, өмнөд америкт очиж орхивол саятан болно гэж найдна. Тэгэхээр Тозияа армийн нэрээр төдийгүй хувийнхаа харьцаагаар Цэен гүнд ойртож Богдын алтыг хаана хадгалагдаж байгааг мэдэх нь чухал зорилтын нэг болж байв. Тиймээс Тяньжингаас Мугдэн рүү шилжихийг эчнээ бодно. Тозияа, Танакагийн улс төр, цэргийн бодлогын нэг чиглэл нь манжуур руу хандаж, манжуурын эзэн болсон Жан Золинг жанжин штабынхан нүд үзүүрлэх болсон эгзгийг мэдэнгүүт, эзэн хаан Хирохитогоос нууц хуйвалдсан хуйвалдаанд санал нэмсэн нь Доихарагийн ажилд дэмжлэг болжээ. Чингээд Доихара Тозияагийн зүтгэлийг ашиглахаар шийдэж, түүнийг Мугдэнд авчирлаа. Тозияа, Мугдэнд ирэнгүүт Цэентэй уулзаж, японы улс төр, цэргийн бодлогыг тайлбарлаж яриа дэлгэв.

- Ерөнхий сайд Танака, өнгөрдөг зун азийг сэргээн мандуулах эзэн хааны төлөвлөгөөг зохиож дуусаад хаантанд танилцуулсан. Манжуурыг хятадаас тусгаарлаж биеэ даасан улс болгох явдлыг эзэн хаан дэмжсэн. Гэтэл тэнно Хирохитогийн тэр төлөвлөгөөнд Жан Золин саад хийх бололтой. Харин Чан Кайши жаахан нааштай хандаж байгаа юм.

- Чан Кайши японд очоод Токио, Нагасакийд тухтай амарсан гэдэг. Тэгээд зогсоогүй Нагасакийд байдаг хятадын нэг сурвалжит эмэгтэйтэй нөхцсөн гэнэ билээ. Чан Кайши, монгол, манжуурыг хятадаас тусгай улс болгох явдлыг ил эсэргүүцдэггүй юм. Үүнийхээ барьцаанд наран улсын армийг хятадын иргэний дайнд оролцуулахгүй далим хайгаад байгаа гэдэг. Харин Жан Золин бол... гэтэл Тозияа, Цэенгээс урьтаж,

- Тэр хунхууз яах вэ? Талийгаач эзэн хаан мэйжи исин, Иосихитогийн асрамжаар зүүн умард гурван мужийг өөртөө аваад нэг муу маршал болсондоо олзуурхаж байгаа. Түүнээс Чан Кайшигийн чадалд хүрэх хүн биш, за тэгээд цаашдаа Чан Кайшигийн гарт нудрагдаж мэдэх юм гэж бардагнан тайлбарлав.

- Тэр хунхууз чинь Орос японы дайны үед манжуурын толгодоор тэнэж дээрэм хийж явсан гэл үү? Тэгээд танай хааны асрамжаар өөрийгөө зүүн умард хятадын захирагч болгосон юм биз дээ. Миний хувьд гэвэл түүнийг чинь цаашаа хараасай гэж бодох юм. Тэднийхэн муу охиныг минь яаж доромжилсныг чи мэднэ шүү дээ. Тэжээсэн бяруу тэрэг эвддэг гэдэг. Японы арми, Жан Золинг хөөргөснийхөө горьг хэзээ нэг цагт амсах байх. Жан Золин амьд байгаа цагт манжуурыг тусгай улс болгоно гэж бодохгүй. Харин хятадын эзэн хааны ширээг өөртөө аваад манжуур монголыг хятадын боол болгох бодолтой байж мэднэ. Ер нь та нар хятадыг ятгах гэсний оронд түүнийг хядчихвал хэн хэндээ өлзийтэй байх шүү гэж уцаарлангуй хэлэв.

Тозияа, Цэенг уурлуулахгүйг хичээж дав даруй ярианыхаа сэдвийг өөрчилсөн нь Цэенгийн сэтгэлийг тайвшруулав. Тэрээр Жан Золингийн талаар Цэенгийн санаа бодлыг мэдэнгүүт хэд хоногийн өмнө Токиогоос ирсэн нууц тушаалыг саналаа. Тэр тушаалд Жан Золингийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг хятадыг судлах хэсгийнхэнд олгосон учир шалтгааныг эргэцүүлсэн Тозияа, түүнийг устгах гэж байгааг мэджээ.

Тозияа, Цэентэй чингэж ярилцсанаас хойш, хэд хоносны дараа армийн тагнуулын газрын дарга Иванэ Мицуй, Хар луу хэмээх нууц нийгэмлэгийн тэргүүн Тояама нартай холбоо барьж, Жан Золингийн талаар ямар санаа бодолтой байгаагаа илтгэв. Тэгээд удирдамж авангуут Мугдэн дэх японы тагнуулын удирдлагад багтдаг хүмүүстэй уулзаж ярилцлаа.

- Ноёдоо, Манай удирдлага Жан Золингийн бодол санааг сонирхож байна. Тиймээс бид, түүний үйл ажиллагааг хянах ёстой. Харин энэ бүхэнтэй холбогдсон бүх ажиллагааг нууцлахыг даалгасан тул Жан Золингийн үйл ажиллагааг хянаж байгаа гэдэг сэжиг гаргаж болохгүй. Их гүрнүүдтэй хуйвалдаж, эзэн хааны хударгаар арга заль хэрэглэж, Хятад манжуурын асуудалд хориг саад хийхэд хүрсэн Жан Золингийн алхаа гишгээ бүхнийг нягтлах нь чухал. Иймээс та бүхэн саналаа хэлж, нэгдсэн төлөвлөгөө боловсруулах нь чухал байна гэж айлдав. Үнэндээ Жан Золинг устгах тухай асуудлыг Чан Кайшигийн зөвлөхөөр ажилладаг

Ермити Сузуки боловсруулсан бөгөөд армийн тагнуулын газар, Хар луу нийгэмлэгт түүний төлөвлөгөөг хянаад хурандаа Дайсаку Комотогоор удирдуулахаар төлөвлөснийг Тозияа мэдэж байв. Тэр төлөвлөгөөгөөр бол Жан Золинг устгаад Зөвлөлтийн зэвсгээр зэвсэглэсэн улаан хятадууд хорлосон гэдэг цуурхал дэгдээх ёстой байв. Тозияа энэ бүхнийг хэдэн цагийн өмнө Дайран дахь цэргийн удирдлагаас мэдсэн боловч өөрийнхөндөө зүрхэлж мэдэгдсэнгүй.

Тозияа, жанжин штабаас ирэх шийдвэрийг хүлээж тавдугаар сар хүрсэн боловч Токиогоос ямар ч чимээ анир гарсангүй. Харин Цэен заримдаа ярианы далим гаргаж «Өнөө хунхууз эсэн мэнд үү?» гэхэд Тозияа өөр үгээр дүйвүүлж өнгөрөөнө.

1928 оны 5 дугаар сард Чан Кайши, өөрийнхөө армийг Шандун руу хөдөлгөлөө. Чухам энэ үед Циндо, Зийнан дахь японы цэргийн удирдлага Токиогоос өгсөн удирдамжийн дагуу өөрийнхөө цэргийг Шандунгаас гаргах болсныг цөөн хүн мэдэж байв. Хятадын улаан цэрэгтэй байлдахаар дайрсан Чан Кайшигийн талаар баримтлах чиглэлийг нууц удирдамжинд тусгахдаа «Хятадын цэргийн эсрэг ямар ч ажиллагааг явуулж болохгүй. Харин харьцаагаа нөхөрсгөөр өргөжүүлэх хэрэгтэй» гэснийг мэдсэн Тозияа энэ тухай Цэенд үг цухуйлгасангүй. Чан Кайшигийн удирдамжаар хөдөлсөн тэр цэргүүд үнэн хэрэг дээрээ Шандун дахь японы цэргийг сэм устгах зорилготой байсныг мэдсэн удирдлага өөрийнхөө цэргийг Шандунгаас гаргасан болой. Гэтэл 5 сарын 18 нд япон жанжин штабын дарга Канин, Жан Золинг Мугдэнд ирэхийг мэдэгдсэн цахилгаан явуулжээ. Энэ тухай Дайран дахь цэргийн төлөөлөгчийн удирдлага Тозияад мэдэгджээ. Гуаньдунгаас ирсэн цахилгааныг Тозияа ганц удаа уншсан боловч түүний үг үсгийг цээжилчихсэн байлаа.

...Ойрмогийн үеийн хорин дөрвөн цагт Бээжин Мугдэнгийн төмөр замын хөдөлгөөнийг хянах асуудлыг хүчтэй болгож, төмөр зам хамгаалсан хятадын цэргийг зам руу ойртуулахгүй байх хэрэгтэй...

Тозияа тэр цахилгааныг уншаад Бээжингээс Мугдэнд ирэхээр шийдсэн Жан Золинг замд нь устгах гэж байгааг ойлгов. Тозияа, цахилгааныг хүлээж авсны маргааш нь Гуаньдунгаас ирсэн буухиа элчтэй уулзаад Цэен гүнтэй уулзахыг чухалчлав. Тэгээд үдийн хоолноор Цэенгийн өрөөнд ортол гүнтэн Тозияагийн бодлыг мэдсэн юм шиг,

- Өнөө Жан ноёны талаар ямар сурагтай байна гэж асуулаа. Цэенг ингэж асуухад Тозияа, энэ тэрхнээр дүйвүүлдэг байсан атал энэ удаа тэгж булзааруулахыг хичээсэнгүй.

- Аа тийм мартчих шахлаа. Жан Золингийн хоногийн тоо гүйцсэн гэж манайхан шуугиад байна.

- Тэр хунхуузыг бодохоос миний дургүй хүрдэг юм. Болдог бол би өөрийн гараар нударчихмаар санагддаг.

- Цэен ээ, чи манайхантай хамт явахгүй юу? Би тэр талаар ярилцаж болно шүү гэхэд Цэен,

- Хаашаа яах гэж явах болж байна даа? гэж гайхан асуув.

- Юу гэх вэ дээ. Манай хэсэг хүмүүс Бээжингээс Мугдэнд ирэх ёстой Жан Золинг угтах ухаантай юм.

- Хүндэтгэн угтах юм бол би оролцоод яах вэ! Устгах юм бол ядаж нүдээрээ хармаар байна.

- Цэенээ, уг нь аль аль нь болж магадгүй юм. Угтана гэдэг чинь заавал амьд хүнийг ч хэлдэг юм биш. Хүүр чандрыг нь угтдаг ёс бий шүү гэж Тозияа аргыг нь олж хэлтэл Цэен,

- Би юу ч гэсэн бодъё. Ойрдоо бие эвгүйрхээд байна, ходоод өвдөөд зарим үед энд бөөн юм зангирч хатуураад байдаг болчихлоо гэлээ.

- Цэен минь бие чинь муу бол Сайнжаргалыг явуулбал яасан юм бэ? Эндээ гэж хэлэхэд манай төрхгүй залуу дарга нар түүний сууж яваа галт тэргийг дэлбэлчихлээ гэж бодоход нийтэд мэдэгдэж болохгүй. Дэл сул яриа гарвал түүний амь насанд халдсан явдалд японы армийнхан хамаарахгүй гэдгийг энгийн хүн гэрчилбэл сайн юмсан. Нэг үгээр хэлэхэд, Жан Золингийн вагоныг хятадууд сүйтгэсэн юм гэдгийг нотлох хэдэн үг хэлчихвэл болох нь тэр.

- Тозияа минь энэ тухай надтай ярилцсанаас өөрөө охинтой яриад үз! Сайнжаргал хятадуудаас өшөөгөө авах явдлаас татгалзахгүй биз гэхэд Тозияа эчнээ баярлаж,

- За тэгвэл би өөрөө ярилцаад үзье гээд өрөөнөөс гарлаа. Тозияа, Сайнжаргалын өрөөнд ороход тэрээр Сувдаатай хамт Тан улсын түүх уншиж байв. Тозияа тэдний дэргэд очингуут,

- Та хоёр юу уншиж байгаа юм бэ? гэснээ номын хуудас руу шагайн харснаа, аа тан улсын түүх үү гэлээ.

- Тиймээ. Тозияа сан та надтай уулзах гээ юү? гэж Сайнжаргалыг асуухад Тозияа хэсэгхэн түгдэрснээ,

- Харин ээ. Чи зав муутай байх шив дээ. Дараа болох уу даа гэхэд,

- Би завтай байна гэлээ. Тозияа Сувдаа руу харахад тэрээр түүний санааг ойлгоод Сайнжаргалын өрөөнөөс гарлаа. Тозияа энэ өдөр эцэг охин хоёртой уулзах тухайгаа нарийн боловсруулсан болохоор Сувдааг өрөөнөөс гарангуут шууд яриандаа оров.

- Сайнжаргалаа бид нэг сонин мэдээ авсан. Ойрын үед Жан Золинг устгахаар улаан хятадууд нарийн мэх гаргачихаад байгаа гэнэ. Үүнийг шалгах хэрэгтэй. Тэр ажлыг манайхан зохион байгуулсан. Учир нь хятадууд хэргээс булзаарахын тул сүүлд нь хэргээ манай армийнхан руу түлхэж магадгүй. Хятадууд зальтай, нарийн аргатай. Тэгэхээр японы армийнхан хорлочихлоо гэж цуурхаж мэднэ. Хэрэг явдал ийм байгаагүй гэдгийг нотлох хэрэгтэй. Тиймээс чамайг явалцвал зүгээр гэж үзэж байна. Манайхнаас ч чамтай хамт хүн явалцана.

- Та аавд энэ тухай дуулгав уу?

- Дуулгасан. Аав чинь чамайг явбал дээр гэж байна. Нөгөө талаар хунхууз нар чамайг доромжилсон явдал нарийн зохион байгуулсан хэрэг байсныг манайхан мэдээд зохих баримтыг нь худалдаж аваад ирсэн гэж хэлэхдээ өчигдөр хийсэн хуурамч баримтаа өрөөнөөсөө авч ирсэндээ олзуурхаж суулаа.

- Би тийм ч байх гэж бодож байсан юм. Ерийн эндүүрэл болоогүй гэдэг надад мэдэгдэж байсан л даа.

- Сайнжаргалаа чи тэр баримтыг надаас авч болно шүү. Би хувилаад ирсэн гээд энгэрийнхээ халааснаас дөрөв нугалсан бичиг гаргаж өглөө.

...Гүн Цэен монголоос ирээд японы цэргийн, тусламж авахаар нууц хэлэлцээ хийхээр хөөцөлдөж байлаа. Гүнгийн охин Мугдэнд ирэхээр хүрээнээс гарсан тул түүнийг замаас нь баривчилж, барьцаалах хэрэгтэй. Мөн тэр бүсгүйгээс эцгийн нь зорилгыг хэлүүлж, баримт гаргуулж авсны дараа суллах хэрэгтэй. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд зарим хориотой арга хэмжээг хэрэглэж болно. Фынъян мужийн ерөнхий захирагч маршал Жан Золин...

Сайнжаргал, бичгийг уншаад уруулаа хэдэнтээ хэмлэх аядсанаа,

- Тозияа сан, танд их баярлалаа. Та аавд дуулгасан бол би энэ хэрэгт биечлэн оролцоно гэх нь хорсолдоо захирагдсаныг гэрчилнэ.

- Сайнжаргал минь, тэгвэл одоо миний ярихыг сайн сонсож ав! Чи маргааш Фусин руу гарна. Тэнд очоод Бээжингээс ирэх галт тэргийг хүлээж хотын буудалд буугаарай. Манай хүмүүс Фусингийн буудлаас чамайг олж уулзана гэлээ.

Сайнжаргалыг тусгайлан бэлдсэн зөөлөн суудалтай вагонд суулгасан болохоор Фусин хүртэл ядарсангүй. Фусины буудал дээр түүнийг хэн ч угтсангүй. Тэрээр зочид буудалд хөлсний тэргээр хүргүүлэв. Сайнжаргал шөнө дүл өнгөртөл хүлээсэн атал уулзах ёстой хүмүүс үзэгдсэнгүй. Тэгээд маргааш өглөө зочид буудлын зоогийн газар ортол энгийн хувцастай зүс таних нэгэн япон дарга ирж уулзаад,

- Сайнжаргару сан, би шөнө дүл өнгөрөөж ирсэн болохоор тантай уулзаж амжсангүй гэлээ. Сайнжаргал, хэд хоногийн өмнө энэ хүнийг гудамжинд харсан. Тэрээр Тозияатай ярьж байхдаа хурандаа хувцастай байсан. Харин орой нь гүнгийн ирэхдээ энгийн хувцастай ирсэн. Тозияа түүнтэй ярилцахдаа хурандаа Комото гэж хүндэтгэж байлаа.

- Сайнжаргару сан, та 16 цаг өнгөрөөгөөд буудлаас гараарай. Би таныг машиндаа хүлээж байх болно. Галт тэрэг 17 цагт буудлаас Мугдэн руу хөдлөх ёстой гэхэд Сайнжаргал толгой дохиж хурандаагийн үгийг ойлгосноо мэдэгдэв.

Зуны дунд сарын нар баруунаа хэвийж, тэнгэрийн алсын хаяанаа өдөр ирэх тутам илч нь нэмэгдэж буй нарны шаргал туяа нүүгэлтээд оройн сэрүү орох шинжгүй халуу дүүгнэ. Зочид буудлын гол хаалганы дэргэд герман хийцний суудлын нэгэн тэрэг ирж зогсоход өдрийн 16 цаг арван найман мөч болж байлаа. Чингэтэл зочид буудлын гол хаалгаар хүрэн үйтэн хуар тэрлэгтэй, хоргой тоорцог хажуулдуулсхийн өмссөн монгол бүсгүй гарч ирээд хөнгөн тэргэнд суухыг ажваас Сайнжаргал байв. Гоёмсог хийцтэй герман маягийн суудлын тэрэг алгуурхан хөдлөөд цаашлах тусам хурдаа нэмсээр удаж төдөлгүй төмөр замын галт тэрэгний буудлаас зайдуухан байгаа нэгэн цэцэрлэгийн дэргэд зогслоо. Чингээд арваад мөч өнгөрсний дараа нэгэн залуу ирээд,

- Тайса доноо Комото сан, галт тэрэг ирлээ гэж илтгэв.

- Сайнжаргару сан, энэ залуу таны гар тээшийг вагонд оруулж өгнө гэж хэлсэн хурандаа жолооч руугаа хараад,

- Одоо буудал руу очье гэж хэлтэл өнөө залуу машинд орж, Сайнжаргалын дэргэд суулаа.

Тэднийг галт тэрэгний буудалд ирэхэд цагдаа нар буудлыг хамгаалсан байлаа. Сайнжаргалтай зэрэгцэж суусан залууг машинаас буухад хурандаа суудал доороосоо жижиг хайрцагтай нэгэн юм гаргаж өгөв. Сайнжаргал, тэр хайрцаг руу харсан боловч дотор нь юу байгааг хэрхэн мэдэх билээ.

Галт тэргэнд суух хүн төдий олонгүй болой. Сайнжаргал цагдаа нарт бичиг баримтаа үзүүлээд эхнээсээ хоёр дахь вагонд суухаар дэргэд нь очтол намхан нуруутай, япон цэргийн бага дарга, Сайнжаргалын дэргэд ирж ажиглангуй харснаа,

- Окусан (хадагтай), та пиугаа үзүүлээч гэлээ.

- Тэг л дээ. Та нар чинь юу болчихоо вэ? гэж Сайнжаргалыг японоор асуухад нөгөө бага дарга үнэмлэх бичгийг нарийвчлан шалгаад,

- Та чинь Зюйлюхээд буух юм уу? Олон юманд саваархалгүй явбал дээр шүү! Илүү юм сонирхвол эндээ үлдэнэ гэж мэдээрэй гэж сануулаад,

- Энэ юун хүн бэ? гэж гар тээшийг нь авч яваа залууг шалгаав.

- Миний тээшийг оруулж өгөх юм гэж Сайнжаргалыг хэлэхэд өнөө хэгжүүн зантай бага дарга,

- Наад барьж яваа жижиг хайрцгаа онгойлгооч гэж ээрч хоргоолоо.

Үйлчлэгч залуу япон бага даргын сонирхсон хайрцгийг онгойлгохоос өөр аргагүй болсныг мэдээд Сайнжаргал руу гайхсан харцаар ширтэн,

- Хадагтайн юмыг би яаж мэдэх вэ? гэж гонгинон хэлтэл бага дарга,

- Окусан, таны гар тээшийг задалж үзэх ёстой юм шүү гэж хэлэх тэрхэн үед буудлын гол хаалганы дэргэд зогсож байсан хурандаа Комото, гүйх шахам алхсаар тэдэн рүү дөхөж явааг харсан Сайнжаргал хугацаа хожихыг хичээж хэсэгхэн дуугүй зогссоноо Комотоог дэргэдээ ирмэгц,

- Үзэх онцын шаардлагатай бол одоо яая гэх вэ гэлээ. Харин бага дарга Сайнжаргалын энэ үгийг сонсож амжилгүй хурандаа хувцсаа өмссөн Комотоог хүндэтгэж,

- Тайса доноо, бага дарга Хамурай зорчигчдын баримтыг шалгаж байна гэж илтгэв. Гэтэл хурандаа, бага дарга руу хяламхийн хараад,

- Чи яагаад наад хүмүүсээ саатуулаад байна. Наад хадагтай чинь цэргийн тусгай газрын зөвшөөрлөөр явж байгааг мэдсээр байж юундаа ээрч хоргоогоод байна. Одоохон вагонд нь оруулж өг. Галт тэрэг хөдлөх болчихоод байна гэж омогдтол вагоноос бууж ирсэн нэгэн дэслэгч Комотоог танимхайран инээмсэглээд,

- Тайса доноо, та Мүгдэн руу явж байна уу гэж тал засаад өнөө бага даргынхаа зүүн гарын тохой руу ёврохыг ажвал «Наадуулаа саатуулалгүй оруулаач» гэсэн дохио болохыг мэдсэн бага

дарга Сайнжаргалын гар тээшийг зөөлцөж вагонд оруулалцлаа. Комото энэ удаа Сайнжаргалыг энгийн суудалтай вагонд суулгажээ.

Комотогийн туслах өнөө бага даргыг гарсны дараа вагоны цонхон доорх халаалтын хоолойн халхавч бүхий хайрцгийг онгойлгож өнөө хайрцагтай юмаа хийж янзлаад,

- За ингээд болох нь тэр. Та сайн яваарай. Бид таныг Зюйлюхээд хүлээж байя гээд вагоноос гарлаа.

Сайнжаргал галт тэрэг хөдөлснөөс хойш Синьлитун хүртэл ганцаараа явлаа. Гэтэл Синьлитунгаас хятадын цэрэг хувцастай гурван залуу суулаа. Тэдний хувцас хунарыг ажвал төмөр замыг хамгаалдаг цэргүүд бололтой. Тэр гурвын нэг нь Сайнжаргалыг сонирхоод шохоорхсон нүдээр ширтэн,

- Залуу бүсгүй Мугдэн орох нь уу? Ингэхээр бид таны уйтгарыг жаахан хуваалцах нь дээ гэж үг өдөн хятадаар шулганана.

- Дүү нар минь эгчээрээ тоглоом хийх хэрэггүй. Ихээхэн дүвчигнэвэл ажаа нь гурван бандиа хомночихож магад шүү гэхэд өнөө залуу,

- Естой хөгжилтэй юм болох нь ээ. Гурвын гурван залуу эмэгтэй хүнд хомнуулна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Естой жиүдиүцү (зэвсэгтэй хүнээс өөрийгөө хамгаалах арга) юм уу эсвэл каратэгийн (нүцгэн гараараа хамгаалах ёс) мэргэжилтэнтэй дайралдаагүй бол гайгүй байлгүй дээ гэж бардагнав.

- Магадгүй юм шүү! Жиүдиүцүгийн хувьд гэвэл Кан Зигоро гэдэг хүн 1866 онд жиүдогийн хэлбэрийг боловсруулсан. Түүнээс дөчөөд жилийн дараа одоогийн каратэгийн үндэслэл тавигдсан юм шүү гээд суудлаасаа босоод вагоноос гарахад гурван залуу бие бие рүүгээ гайхсан нүдээр ширтсээр хоцорчээ.

Сайнжаргал үнэндээ хятад даяар төдийгүй европ дахинд шуугиад арваад жил болж байгаа каратэгийн тухай гурван сарын өмнө японы «Тохо хёрон Дорно дахины тойм» гэдэг сэтгүүлээс уншсанаас цаашгүй.

Сайнжаргал вагоны хонгилд хэсэгхэн зогсоод цонхоор харж байхдаа урт чихтэй, илүү дутуу үгэнд дуртай хүмүүсийн амнаас санамсаргүй үг сонслоо. Японы жанжин штабын даалгавраар Мугдэн орох гэж яваа Жан Золингийн япон зөвлөх хошууч Нобуяа Гигагийн туслахууд энэ галт тэргэнд яваа учраас хүмүүсийг хатуу шалгасан байлаа. Сайнжаргал, вагоны цонхоор харж зогссоноо өрөөндөө орж ирэхэд гурван хятад залуу бие бие рүүгээ сүрхий харснаа Сайнжаргалын суудлыг эзлэн суусан нэг залуу могойд хатгуулсан юм шиг ухасхийн босож суудлыг нь тавьж өглөө. Сайнжаргал уншиж байгаад суудал дээрээ үлдээсэн «Зёхо тюкайсэцү мэдээлэл ба тайлбар» гэдэг сэтгүүлээ авч унших зуур элдвийг бодно.

...Тозияа, Комото хоёр энэ вагонд явж байгаа Жан Золингийн талаар надад яагаад хэлээгүй вэ? Ингэхээр Жан Золинг хятадууд биш харин япончууд өөрснөө устгахаар бэлтгэжээ! Гайхмаар юм. Дээрэмчин байх үеэс нь авахуулаад дэмжиж байсан япончууд өөрснөө түүнийг

хятадын арми гэгчид нэгтгэж өгөөд цэргийн алдар тушаал хайрласан. Естой ёсгүй ёс гэдэг чинь энэ болж байна даа. Японы арми энэ бүхнийг зохион байгуулж байгааг ажвал Жан Золинд итгэхээ больсон нь илэрхий. Жан Золин, өвөр монгол, манжуурыг хятадад нэгтгэлгүйгээр өөрөө дангаараа захирахыг эрмэлздэг. Харин түүний хүү Жан Сюэлян өөр бодолтой гэдэг. Тэр нь Чан Кайшийд талтай билээ. Япончууд Чан Кайшийд талтай болохоор түүнийг дэмждэг Жан Сюэлянд тал засаж, эцэг хүү хоёрыг эвдрэлцүүлэх арга зам хайдаг нь үнэн болов оо! Хэрвээ миний бодсон зөв бол япончууд эцгийг нь устгаад хүүгээр нь өвөр монгол, манжуурыг захируулбал манжуурыг хятадаас төвөггүй тусгаарлана гэж тооцоолсон байх ёстой. Яагаад гэвэл япончууд хятадын дотоод будлианыг зохицуулж, тайван зам гэгчээр далимдуулж, хятадад өөрийнхөө эзэмшлийг тогтоохыг хичээж байгаа. Ингэхээр япончууд манжуур, хятад хоёрыг тусгаарлах ганц зангилааг Жан Сюэлян гэж үзээд түүнд мэдэгдэлгүйгээр эцгийг нь устгаад хятадууд устгасан гэдэг нотолгоо гаргаж үнэмшүүлэх хэрэг үү? Тэгвэл энэ хэрэгт заавал намайг ашигладаг нь юу вэ? Төмөр замыг хамгаалдаг цэргийнхэн (Жан Золингийнхон) онцгой хамгаалалт бүхий галт тэргэнд ямар ч хүн суулгадаггүй. Гагцхүү цэргийн төлөөлөгчдийн газрын зөвшөөрлөөр албаны дээд хэмжээний дарга нарыг суулгах ёстой. Тэгэхээр эцгийн минь нэр сүрийг ашиглаж, хятадын төмөр замын байгууллагаас надад зөвшөөрөл авсан нь хожим сэжиг төрүүлэхгүй гэсэн санаа байх нь. Фусин дэх хятадын цэргийн удирдлага, аав бид хоёрыг андахгүй. Тэдний дарга нар азийн Та Да хэмээх пүүсний эзэнтэй холбоотой шүү дээ? гэж бодлоо.

Сайнжаргал, сэтгүүлээ барьчихаад ингэж бодож байхад өнөө гурван залуус ус балгачихсан юм шиг дуугүй сууснаа удаж төдөлгүй вагоноос гарлаа. Тэд галт тэрэгний зоогийн газар руу явлаа гэдгийг Сайнжаргал хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байв.

...Одоо цагийн дараа Зюйлюхээд бууна. Энэ хайрцагт байгаа дэлбэрэх зүйлийг яах вэ? Нэг дээрэмчнийг тонилгохын тулд олон хүний амийг золионд гаргах хэрэг үү?

Хайрцгийг ажвал жижиг хэмжээтэй учраас тийм ч сүртэй дэлбэрэлт болохгүй нь мэдээж хэрэг! Гэтэл ийм дэлбэрэлтээр Жан Золинг устгана гэдэг санаанд багтамгүй зүйл! Энэ дэлбэрэлт ердөө л ганц вагон дэлбэлэхээс цаашгүй? Иймээс вагонд тавьсан дэлбэрэх зүйл бол ердөө нүд хуурсан юм. Япончууд ийм гоомой юм хийхгүй. Тэгэхээр ямар нэг нууц зүйл байна. Тэгвэл галт тэргийг сүйрэлд учруулах дэлбэрэлт хаана болох вэ? Жан Золин гуравдугаар вагонд яваа гэдэг илэрхий... Тэгэхээр ямар арга сэдсэн байж болох вэ? Хамгийн тохиромжтой арга бол зам төмрийг гэмтээсэн үед сүйрэл учрах ёстой! Тэгвэл жинхэнэ дэлбэрэлтийг Комото удирдах хэрэг үү? Тэгвэл Зюйлюхэ хотоос Мугдэн орох төмөр замыг дэлбэлэх хэрэг! Ингээд хятадын цэрэг тухайлбал гоминдааны цэргийн хувцастай улаан хятадууд Жан Золингийн галт тэргийг дэлбэлсэн гэдгийг батлахын тул надаар гэрч хийхийг бодсон хэрэг үү? Чингэвэл би, энэ дэлбэрэх зүйлийг аваад ч нэмэргүй. Харин япончуудад дэмий сэжиг төрүүлнэ. Галт тэрэгний цуваа сүйрэх ёстой төлөвлөгөөний дагуу сүйрэх нь дамжиггүй... Аа хөөрхий хаана ч гэсэн ялгаагүй атаа жөтөө, аллага хядлага нууц хуйвалдаан үргэлжилж, бусдын газар нутагт шунасан харийнхан төдийгүй өөр хоорондоо эрх ямбаа булаалдсан, хөрөнгө чинээгээ арвижуулах гэсэн бузар хүслээс хамаг нүгэл үүсдэг юм байна...

Сайнжаргал ийнхүү элдвийг бодож суутал өнөө гурван хятад гаднаас орж ирлээ. Тэдний нэг нь яаж дуугүй суухав гэсэн шиг,

- Одоо чинь Зюйлюхээд зогсох байхаа гэхэд Сайнжаргал буухаар бэлдлээ. Галт тэрэг удаж төдөлгүй Зюйлюхээд ирж хурдаа хасах тэр зуур Сайнжаргал суудлаасаа өндийтөл нэг хятад залуу,

- Та чинь Мугдэн орохгүй юм уу? гэлээ.

- Та нартай явахад уйтгартай юм. Тэгээд ч эгч нь хааяа худлаа хэлчихмээр санагддаг. Санамсаргүй явдлаас дүү нараа молигодчихлоо. Одоо та нарын ухаанд овоо юм орж байгаа биз дээ гээд вагоноос гарахад бас нэг залуу нь,

- Өнөө каратэ мэддэг чинь бас молигодолт уу гэж асуув.

- Ажаа шигээ хэдэн оймс элээчих. Тэгвэл хүний үгний өөгөөр юмны учрыг олдог болно гээд Сайнжаргал инээмсэглэнгүүтээ вагоны хаалгыг хаатал өнөө залуус гайхсан нүдээр бие биенээ ширтсээр дуугарч чадалгүй үлдэх нь тэрээ.

Сайнжаргалыг Зюйлюхэ хотын галт тэрэгний буудалд буухад өмнөд манжуурын төмөр замын нийгэмлэг «Мантэ-цугийн» дэргэд маш нууц байгуулсан тагнуулын байгууллагын хэдэн залуус, Комотогийн туслахтай хамт Сайнжаргалыг угтан авлаа. Сайнжаргал тэдэнтэй хамт галт тэрэгний буудлын байшин руу явахдаа санамсаргүй эргэж харвал өнөө хятад залуус вагоны цонхоор Сайнжаргалынхойноо с ширтэжбайхыг ажиглав. Сайнжаргал буудлаас зайдуухан байгаа нэгэн давчуу гудамжинд хүлээж буй суудлын тэрэгний дэргэд иртэл Тозияа хөнгөн тэрэгнээс гарч ирээд Сайнжаргалыг угтан мэндлэв.

Тозияа Сайнжаргалыг суудлын тэргэнд суулгаад Мугдэн руу хурдалж, зам зуураа ямар хүмүүстэй уулзсан хийгээд вагонд хэдүүлээ явж ирснийг асуулаа. Сайнжаргал вагонд гурван хятад залуутай танилцсанаа ярьтал Тозияа элгээ хөштөл инээж,

- Муу эр хоосон буунаас айдаг гэж үнэн юм даа! Ай мөн аймхай туулайнууд бол доо. Чи тэднийг ганц сайн давжээ. Сайнжаргалаа чи, каратэ сонирхож байгаа бол багш олж өгч болно шүү. Ер нь зэвсэгтэй хүнээс өөрийгөө хамгаалж сурах хэрэгтэй. Харбинд тохиолдсоноос илүү ярвигтай юм тохиолдож мэдэх юм шүү гэхэд Сайнжаргал,

- Хүн олдвол заалгамаар юм байна билээ. Ер нь ингэхэд би сурах болов уу? гэж Тозияагаас шалгаан асуув.

- Чи сурч болно. Каратэг эмэгтэй хүнд заадаггүй юм. Каратэ бол сөрөх тагнуул, цэргийн тагнуулын хэмжээнд хэрэглэгддэг зүйл. Тэгэхээр Токиогоос хүн дуудахгүй бол эндээс заах багш олдохгүй гэлээ.

- Тозияа гуай тэгвэл Токиод очиж сурвал дээр юм биш үү? Далимд нь бас хот үзнэ гэхэд Тозияа,

- Тэгвэл бүр амархан шүү. Харин ойрын хэдэн өдрүүд чамд жаахан хэцүүхэн байж мэднэ. Тэгэхээр одоо хариад сайхан амрах хэрэгтэй гэв.

- Яагаад тэр вэ? Би ядраагүй байна шүү!

- Сайнжаргалаа, ойрын өдрүүдэд сонин сурвалжлагч нар чамтай уулзах байх. Тэгэхээр тэр талаар хоёулаа харьж байж ярилцъя гэхэд Сайнжаргал галт тэрэгний дэлбэрэлтийн талаар ярьж өгнө гэдгийг гадарлаад бүх зүйлийг ойлгосон хүн шиг,

- Тозияа сан, галт тэрэг рүү хятадынхан дайраагүй шүү дээ гэлээ.

- Сайнжаргалаа одоо ингэсхийгээд дэлбэрэлт болно. Тэгэхээр чи, галт тэргэнд сууж явсан хүмүүсээс үлдсэн цорын ганц хүний хувьд үнэн байдлыг гэрчлэх болох нь.

- Тозияа сан, галт тэрэгнээс Зюйлюхээд хүн буугаагүй хэрэг үү?

- Тиймээ. Ганцхан чи буусан юм. Тэгэхээр чи, төмөр замыг хамгаалдаг хятадын цэргүүд вагонд явсан гэдгийг сурвалжлагч нарт тайлбарлахаас өөр замгүй гэтэл Мугдэн хүртэлх дардан замын дагуу тавьсан төмөр замын ойролцоо нүргээнтсэн чимээ дэгдэж, бөөн гал харанхуй тэнгэр өөд цойлж байгаа нь машины цонхоор тод харагдлаа. Сайнжаргал харанхуйд улайрч ягаарсан их гэрлийг хараад сэтгэл сэрхийлгэсэн бодол зурсхийж, нүдэнд нь галт тэрэгний сүйрэлд өртсөн хүмүүсийн дүр төрх харагдах шиг болсонд тэрээр биеэ барин, хөмхийгөө тас зуусныг хөнгөн тэрэгний цонх руу гөлөрч, тэнгэрийн алсын хаяанаа нэлийсэн шаргал туяа, улаан дөлийн гэгээ рүү ширтсэн Тозияа хэрхэн анзаарах билээ.

...Хурандаа Комотогийн хүмүүс Фусингээс хөдөлсөн галт тэрэгний хөдөлгөөн, замын дагуух байдал төлөвийг Мугдэнгээс холгүй байрласан зам дэлбэлэх хэсэгт радио холбоогоор мэдээлж байв. Хурандаа Комотогийн даалгавраар ахмад Тэцуо Томияа төмөр замыг дэлбэлэх ажлыг удирдсан аж. Чингээд товлосон цаг хугацаандаа уул дэлбэрэлт болж, түүнийг Тозияа алсаас ажиглаж, харин дэлбэрэлт болсон газраас хэдэн зуун алхмын цаанаас Комото ажиглалт хийж байсан болой...

Тозияа дэлбэрэлтийг чингэж алсаас ажиглаж явахдаа Сайнжаргалд молигодуулсан төмөр замыг хамгаалах хятад цэргийн хувцастай залуусыг санаж, эчнээндээ нарийн арга боловсруулахдаа «Ер нь төмөр замыг хамгаалах цэргийн хувцастай гурван хүний үхдэл бэлдэж, сонин сурвалжлагч нарын амыг таглах хэрэгтэй. Тэгэхдээ тэднийг гоминдааны цэргийн хувцсаар хувцасласан улаан хятадын хорлон сүйтгэгч нар байсан гэж нотлох хэрэгтэй» гэж бодож явлаа.

Чингээд Тозияа «Хар төмөр» гэж товлосон энэ ажиллагаа амжилттай болсон тухай илтгэхээр үгээ бодно. Тозияа Мугдэнд ирэхдээ зам буруулж, хэнд ч мэдэгдэлгүй иржээ. Тэгээд шөнөжингөө элдвийг бодож, Сайнжаргалыг сонин сурвалжлагчтай хэрхэн уулзуулахаа бодож хонов. Мугдэнгийн ойролцоо болсон дэлбэрэлтээр умард хятадын гурван мужийн захирагч Жан Золин амь эрсэдсэнийнөгөөдөр Тозияа, Сайнжаргалыг дагуулж дэлбэрэлт болсон газар дээр очлоо. Мугдэн дэх гадаадын байгууллагын ажилтан, сонин сурвалжлагч нар Жан Золингийн сууж явсан галт тэргэнд Сайнжаргал явсныг мэдээд түүнтэй уулзах санал тавьсан болохоор Мугдэнгийн цэргийн төлөөлөгчийн газар тэдний саналыг арга буюу хүлээн авлаа. Сайнжаргал, Тозияагийн зөвлөсний дагуу сонин сурвалжлагч нарт хариулахдаа «Миний сууж явсан вагонд Жан Золингийн цэргийн хувцастай гурван залуу сууж явсан. Тэдний гадаад

байдал тун сэжигтэй санагдсан. Бодвол тэд нар улаан хятадууд байсан биз» гэж гэрчлэв. Сайнжаргалын үгийг баттай болгохын тулд ахмад Тэцуо Томияа сурвалжлагч нарт мэдэгдэхдээ «Би дэлбэрэлтийг тогтооход оролцсон мэргэжилтний хувьд мэдэгдэхэд уул дэлбэрэлтийг улаан оросын зэвсгээр зэвсэглэсэн улаан хятадууд хийсэн гэдэг төсөөлөл гаргасан бөгөөд түүнийг батлах баримтыг газар дээрээс нь олсон. Төмөр замыг болон вагоныг дотор талаас нь дэлбэлсэн гэдэг нь илэрхий төдийгүй замын дэр модонд шигдсэн бөмбөгний хэлтэрхийнээс үзвэл тэр нь улаан орост үйлдвэрлэсэн таних тэмдэгтэй байсан юм» гэж мэдэгдэв. Сайнжаргал сонин сурвалжлагч нартай уулзсаны дараа гадаа гарахдаа нэгэн залуутай халти зөрж өнгөрөхдөө «Энэ чинь юу билээ. Вагонд явсан гурван хятад залуугийн нэг нь шив дээ» гэж сэтгэлдээ шивнэж өөрөөсөө асуулаа. Тэгээд хөнгөн тэргэнд суухдаа өөрийнхөө бодлыг Тозияад дуулгаж,

- Өнөө гурван хятад залуугийн нэг нь тэр модны цаагуур ороод зугтчихлаа гэлээ. Тозияа тэр дороо өөрийнхөө дэргэд байсан гооргор Симоотоод учир байдлыг хэлсэнд Симоото хэдэн цэрэг дагуулж өнөө хятад залуугийн хойноос мөрдлөө. Чухам энэ үед тэрхүү байдлыг ажсан, Мүгдэнгийн нэгэн сурвалжлагч тэдний араас гэтсэн Тозияагийн хүмүүсийг тоймлоод ажиж байлаа.

Жан Золингийн амь эрсэдсэн тухай сонинууд харилцан адилгүй мэдээ нийтэлж, шуугиан дэгдээсэн тэр үед нэгэн хятад сурвалжлагч уул учрыг мэдсэн авч үнэн байдлын талаар ганц ч үг хэлж завдалгүй нүд аньжээ. Үүний учрыг мэдсэн зарим сурвалжлагч нар Тозияагийн гар хөлөөс айж дуугүй өнгөрснөөр Жан Золингийн амийг сүйтгэсэн хуйвалдааныг хэн ч мэдэж чадалгүй өнгөрсөн болой.

Хоёрдугаар бүлэг

Харь газар өнчин бүсгүй

Нэг. Хорон санаа амь гарзадна

Японы цэрэг улс төрийн нэг хуйвалдааны дараа шинэ хуйвалдааны үндэслэл тавигдаж, эзэнт гүрний улс төр, цэргийн амьдралын цар хүрээг тодорхойлдог үндсэн шинж болдог уламжлалтай.

Танака засгийн эрхэнд гарсны дараа Азид эзэн хааны дэглэм гэгчийг тогтоохыг эрхэм болгохдоо юуны өмнө манжуур, хятадын асуудлыг шийдэх явдлыг эрхэм зорилтын нэг болгов. Тэрээр хятадаас манжуурыг тусгаарлаж, биеэ даасан улс болгох нэрийдлээр зүүн умард хятадын гурван муж, ар өвөр монголд япон эзэн хааны «кодо эзэн хааны замнал» гэдэг дэглэмийг тогтоохыг чухалчилсан болой. Танакагийн сэтгэлд хоногшсон нууц бодлогыг тольдсон Жан Золин, японоос хөндийрч их гүрнүүдийг түшихээр шийдсэн явдлыг гадарласан цэргийнхэн түүний амийг бүрэлгэх төлөвлөгөө боловсруулаад эзэн хаанаас ор тас нуулаа. Японыхон Жан Золинг устгасны дараа түүнтэй өрсөлдөж байсан Чан Кайшийд тал засаж, манжуур өвөр монголын түрэмгийлэх бодлогоо зэвсэг хөдөлгөлгүй шийднэ гэдэгт итгэж байсан. Энэ бүхний учрыг мэдсэн Жан Сюэлян эцгээсээ хойш японоос хөндийрч, манжуурын засаг захиргааг хятадтай буюу хятадын төв засгийн газартай нэгтгэхийг мэрийдэг болов.

Гоминдааны цэрэг Бээжин рүү довтолсны дараа Жан Сюэлян, Мугдэнд байдаг өөрийнхөө ордны дээрээс японы тугийг авч хаяад оронд нь гоминдааны тугийг намируулах болсноор японы армийн эсрэг илэрхий дайсагнах боллоо.

Цагийн байдал улирах тусам ерөнхий сайд Танакагийн

дэгдээсэн хэрэг явдал эзэн хаан Хирохитогийн чихийг дэлдэх болж, Жан Золингийн амь насыг бүрэлгэх явдалд армийнхан оролцсон нь илэрхий болох тусам эзэн хаан Танакаад дургүйцэх болжээ. Гэтэл армийн боловсруулсан нууц төлөвлөгөөг Танака алдсан явдал сайд нарын танхим дахь хөрөнгөтний Сэйюкай нам (1900 оны 9 сарын 15-нд байгуулагдсан) тэнцвэрээ алдаж, шинэ тулгар байгуулагдсан Мэнсэйто намын (1927 оны 6 сарын 1-нд байгуулагдсан) нөлөө идэвхжиж эхлэв.

Танака өөрийгөө цагаатгаж, улс төрийн тэнцвэр олохын тулд Алс дорнодын бага хурлыг Токиод зарлан хуралдуулсан боловч өөрийгөө хамгаалж чадсангүй. Бага хурлаас «Их газарт (хятадад) явуулах улс төрийн асуудлын нэг хэсэг бол манжуурыг хятадаас тусгаарлаж, улс төрийн талаар хяналтандаа авах явдалд японы дотоод, гадаад, цэргийн бодлогыг бүх талаар чиглүүлж, хэрэгжүүлэх ёстой. Япон улс их газрын асуудлыг шийдэхэд ихээхэн бэрхшээлтэй учрах бөгөөд дайн ч хийж магадгүй» гэж уриалжээ. Чухам энэ шийдийг гаргуулахын тулд Танакаад их үүрэг оногдсон. Тиймээс «Азийн улс орнуудыг болон хятадыг эзлэх асуудлыг эзэн хаанаар зөвшөөрүүлэх нааштай алхам хийхийн тулд түүний зөвлөх Кинмоти Соёнзийг ятгаж чадна» гэж Сэйюкай намд амлажээ. Гэтэл алс дорнодын бага хурал тараагүй байхад Танака ерөнхий сайдаас огцорч, сайд нарын танхимыг Хамагутийд шилжүүлэв. Тэрээр

ерөнхий сайд болсны дараа алс дорнодын хурлаас гаргасан «Дайнд бэлтгэх шийдвэрийг» дэндүү хүч хэрэглэсэн «зүйл» гэж үзээд их газар явуулах бодлогыг хэлэлцээний замаар шийдэхээр тунхаглав.

Японы цэргийнхэн, Хамагутигийн цэрэг, улс төрийн бодлогыг эсэргүүцэж, цагаан морин жилийн (1930 он) турш засгийн газрын бодлогыг шүүмжилж «Хятад дахь байлдааны ажиллагааг яаралтай өргөжүүлэх» шаардлага тавилаа.

Тэгээд зогссонгүй ерөнхий сайдыг цэргийнхэн заналхийлэн сүрдүүлж байснаа могой жилийн өвлийн тэргүүн сарын дундуур, нэгэн өглөө Токиогийн галт тэрэгний буудал дээр очсон ерөнхий сайд Хамагутийг бууджээ. Харин Хамагутийн аз дайрч хүндхэн шархадлаа. Чингээд хонин (1931 он) жилийн хаврын дунд сарын дундуур Танакаад сайд нарынхаа танхимыг алдсан Рэйзиро

Вакацуки дахин ерөнхий сайд боллоо.

Хаврын сүүл сарын дундуур Иван Степанович Мугдэнд ирлээ. Цэен гүн олон сар уулзаагүй Сафроновыг баяр хөөртэй угтаж, хэдэн сар, дотроо хадгалж явсан санаа бодлоо дэлгэлээ. Тэр хоёр дэвэн дэлхийн сониныг уудалж, бараг үүр цайлгажээ.

- Иван минь ингэхэд халхаас ямаршуухан чимээтэй байна. Би чинь төрж өссөн нутгийнхаа нэрийг мартаж шахаад байна шүү.

- Нэлээн юм дуулдаж байна. Далай хан, Зоригт ханы нутаг ялангуяа Төгсбуянтын болон Улаангомьын хүрээний лам нар зэвсэг барин хөдөлсөн сурагтай. Тэд Шинжаантай холбоо тогтоож, баруун умард хятадын цэрэг зэвсгийн тусламж авах гэж мэрийсэн боловч бүтээгүй бололтой. Манзушир хутагт, Егүзэр нар Банчин эрдэнэтэй холбоо тогтоож байгаа бололтой. Гэхдээ бүтэх бүтэхгүйг мэдэхгүй байгаа гэнэ гэхэд Цэен,

- Тэд гар хоосон байцгааж ардын засгийг устгана гэж яаж бодоо болоо! Ядаж таван мянган хүнийг зэвсэглэх хөрөнгөтэй болоод хөдөлдөг болоосой. Иван минь тэд байтугай бэлэн алттай би энд наран улсын тусламжийг авах гэж нэлээн зовж байна. Гэтэл наран улс манжуурын асуудлыг шийдэх гэж сайд, жанжингууд нь гэдсэндээ хөлөө хийлцэх шахаад байдаг. Наран улс, Чан Кайшигийнхэн, умар зүгээс дэгдэх улааны аюулыг устгах талаар санал нэгтэй мөртлөө харин манжуурыг хятадаас тусгаарлах талаар зөрөлдөөнтэй байна. Чан Кайши, Жан Золингийн хүү хоёр сүүж нийлүүлж, хятадын нутагт байгаа наран улсын цэргийг шахаж хавчаад байдаг болсон. Тиймээс наран улсын цэрэг Шандунгаас үг дуугүй гарчихлаа. Ер нь уржнангийн дуулиант хэрэг ямар ч үр дүн өгөлгүй баахан балаг тарилаа.

- Цэен ахаа, Харбин, Бээжин дэх улаан оросын консул руу дайрсан тэр танхай залуус жирийн нэг хэрэг дэгдээгээгүй юм шүү!

- Би түүнийг мэдэж байна. Дорнод хятадын төмөр зам руу цагаан болон Жан Сюэляныхан дайрч баахан балаг тарьсан учраас Манжуур өртөөний цаана байдаг улаан оросын цэрэг Хайларт орж ирээ биз дээ. Жан Сюэлян хоёрын хооронд хүүхэд шиг ингэж дүвчигнэх хэрэггүй байсан.

- Цэен ахаа, үнэнийг хэлэхэд одоо чинь хятадад гурван засаг

тогтоод байна. Бээжинд У Пэйфугийн толгойлсон хуучин чилийн бүлэглэл орогнож байхад Ыанкинд Чан Кайшигийн толгойлсон гоминдааны хятадын төв засгийн газар дүвчигнэн улс төрийн эрхийг барьж байна. Гэтэл улаан хятадууд Зянси, Фузян зэрэг хятадын бөглүү нутагт улааны засаг тогтоох гээд алалдаад байдаг. Энэ гурав бие биендээ дайсагналцаж байгаа явдлыг японы армийнхан ашиглаж, Чан Кайшийд тал засах санаатай. Гэтэл Чан Кайши, Жан Золингийн хүүг аятайхан ятгаж, манжуурт тогтоох японы улс төрийн нөлөөнд саад хийгээд байна. Чан Кайши, дорнод хятадын төмөр зам руу Жан Сюэляныг турхирсан нь угтаа алс дорнод дахь улаан оросын нөлөөг зүүн умард хятадад дэлгэрүүлэхгүйг хичээж байгааг гэрчилж байгаа юм. Ингэснээрээ японы армийнхны толгойг эргүүлэх гэсэн «Мин-шаньфунь» гэдэг төлөвлөгөөг зохиосон юм. Энэ нь улаан оросын хилийн ойролцоох Манжуур, Жалайнуур гэдэг өртөөгөөр дорнод хятадын төмөр замыг таслан авах гэж оролдоод цагаантны оргодлуудыг ашигласан явдал. Гэтэл улаан орос цэргээ зүүн умард хятад руу оруулж, 1924 онд хятадтай байгуулсан дорнод хятадын төмөр замыг ашиглах асуудлын дагуу Харбин дахь өөрийнхөө өмчийг хамгаалах болсон нь Хайлар төдийгүй Харбиныг алдаж болох эгзэг гарсан юм. Ингээд Жан Сюэлян байдлыг ажаад байлдааны галыг зогсоосон шүү.

- Тэгвэл Чан Кайши, Жан Сюэлян, японыхны аль аль нь Харбинаас оросын хил хүрдэг төмөр замыг салгахыг чухалчилсан байх нь.

- Цэен ахаа, та тун хэрсүү хүн юм. Голыг нь олоод хэлчихлээ. Ер нь энэ чинь их ээдрээтэй асуудал. Тэгээд ч их түүх судартай.

- Иван минь чи, ахдаа тэр төмөр замынхаа учрыг сайн хэлээд өг! Ер нь хаант орос, хятад, япон гурав энэ замаас болж олон удаа муудалцсан гэдэг. Тэр түр тархийсэн маргаан одоо хүртэл тасраагүй байна.

- Япон улс азид өөрийнхөө улс төрийн ноёрхлыг тогтоохын тулд эхлээд Солонгос руу дайрч үлэмжхэн амжилт олсны дараа жил (1894 он) нь хятад руу дайрсан юм. Тэгээд хятадаас Тайван, Ляодунгийн хэсгийг тасалж авсны дараа Хаант орос, Герман, Францын шаардлагаар Ляодунгийн хэсгийг эргүүлж өгсөн.

Үүнээс хойш дөрвөн жил болоод Хаант орос Ляодунгийн өмнөд хэсэг Гуаньдунгийн арал хүртэл төмөр зам тавихаар тохирч 25 жилийн хугацаагаар газар түрээсэлж авсан юм. Дорнод хятадын төмөр замыг тавьж дууссаны дараа япончууд тэр замыг сонирхож 1904 онд Гуаньдунгийн арал дээр байсан оросын цэргийн цайз Порт-Артурыг дайрч эзэлсэн. Ингээд Орос японы дайны дараагаар япон улс Чанчуньгаас Порт-Артур хүртэлх төмөр замыг өөртөө авсан.

- Өмнөд манжуурын төмөр замын нийгэмлэг «Мантэцу» гэдгийг ингэж байгуулсан байх нь ээ. Тун эгзэгтэй хэрэг байна.

- Эзэн хан Хирохитогийн өвгөн зөвлөх Кинмоти Соёнзи, тэр үед японы ерөнхий сайд байсан үе. Тэгээд японы засгийн газар Ясуда гэдэг нийгэмлэгтэй хоршиж «Мантэцу» нийгэмлэгийг байгуулсан. Энэ чинь мансю буюу манжуур гэдэг нэрийн эхний үе, япон хэлний тэцудо буюу

төмөр зам гэсэн үгний эцсийн үеийг хураангуйлж нэрлэсэн хэрэг. Тиймээс «Мантэцу» нийгэмлэгийг өмнөд манжуурын төмөр зам гэж алдаршуулсан юм шүү.

- Цэен ахаа, Харбин дахь оросын дүрвэгсдийн товчоо монголын үндэсний үзэлтэнгүүдэд зориулж сонин гаргах санаатай байна. Тэгтэл хөрөнгө чинээ барагтай. Тэгээд таныг туслах болов уу гэж үзэж байгаа гэж Харбинаас ирсэн зорилгоо цухуйлгав.

- Иван минь сонин энэ тэр гэж сүржигнээд яах вэ! Манжуурын асуудлыг шийдээгүй цагт японы арми, Монголын нэгдсэн улс байгуулахгүй нь мэдээж хэрэг. Одоо чинь японы засгийн газар бүр тогтворгүй болоод байна. Японы сангийн яамны сайд Иноз, Вакацукигийн улс төрийн бодлогыг тууштай дэмжиж, одоогийн хямралаас ангижрах замыг сонгохдоо цэргийн зардлыг хорогдуулах явдлыг чухалчилж байна. Гэтэл цэргийн яамны сайд Казусигэ Угаки, маргаанаас үүсэх будлианыг гадарлаад, сайдын албан тушаалаас сайн дураараа огцорсон сурагтай. Угакийг Хар луу гэдэг цэргийн нууц нийгэмлэгтэй холбоотой учраас «залуу дарга» нарыг засгийн газрын эсрэг хөдлөх гэж байгааг гадарлаад хаяагаа манасан хэрэг гэж үздэг хүмүүс цөөнгүй. Одоо чинь Хар луу нийгэмлэг, армийн «залуу дарга» нар Садо Араки, Зинабуро Мазаки нарыг өндөрт өргөж, тахин шүтэх болжээ. Ингэхээр

Вакацукигийн танхим өнөө маргаашгүй унана гэсэн үг. Тиймээс японы армийн удирдлагын уур амьсгалыг харах хэрэгтэй гэж Иван Степановичийг сургажээ. Иван Степанович Мугдэнд ирсэн хэргээ бүтээж чадалгүй буцсанаас хойш Цэен гүн элдвийг эргэцүүлэн бодно.

...Ойрын үед японыхон манжуурыг хятадаас тусгаарлавал нэг хэрэг! Тэгвэл япон Монголын нэгдсэн их улс байгуулах ажилдаа орно. Тозия Токиогийн бага хурлын дараа Тяньжин руу явахын өмнө надад дотнотчилж хэлэхдээ «Би манжийн эзэн хааны удам судрыг сурвалжилж байгаа. Манжийн сүүлчийн хаан өнөө нялх хүүг олоод хаан ширээнд залах юм» гэж билээ. Согтуу хүний үг сохор ухаантай гэдэг. Лав ортой байх! гэж бодно...Цэен болж байгаа зүйлийг нарийвчлан тунгаагаад манжуур, өвөр монголыг хятадаас тусгаарлах армийн үйл ажиллагааг ажиглахаар шийдэв. Гэтэл сэтгэлд нь далайн тэртээд гарвал саятан болж болох юм гэсэн нэгэн бодол эргэлдэнэ. Гэсэн ч Цэен үүнээс өөр бодолд автагдах аж. Тэрээр Норовпилжээлингийн номин оюуг ашиглаж, Халх голын сав, Буйр нуурт загасны үйлдвэр байгуулбал монголын нэгдсэн улсын ерөнхий сайдын ширээг бараадах албагүй гэж бодно. Тэрээр монгол, хятадад алдаршсан саятан болохыг мэрийх болой. Гэсэн ч Цэен өөрийнхөө энэхүү бодолд эргэлзэж хургах нь олонтаа. Цэен гүнгийн сэтгэлд ийм бодол эргэлдэхийн зэрэгцээ бас түгшүүр буцална. Сүүлийн үед түүний сэтгэлийг түгшээсэн бодлоос «Япон улс, Нэгдсэн монгол улс байгуулах нэрийдлээр өөрийнхөө харааны улс болгочихвол яана. Тэгвэл өнгөрлөө шүү! Япончууд, манж дайчин улс шиг монголыг өөрийн эзэмшил болгож чадах овжин заль гаргаж мэдэх юм» гэж санахаас айдаас хүйдэс хүрнэ. Энэ үгийг хэдэн сарын өмнө Цэен гүнтэй уулзсан нэгэн америк худалдаачин ярьж билээ. Тэгээд Иван Степановичийн үгтэй харьцуулаад тунгаавал тэдний үг ортой байж болох аж. Цэен ингэж бодсон үедээ өөрийн мэдэлд үлдсэн алтаа яах вэ? гэж санааширна. Тэгээд түүний учир байдлыг мэдэж нэхэх хүнгүй болсныг ухаарах тусам «Төрийн төлөө оготно гэгчээр миний ингэж явдаг дэмий хэрэг! Хэрвээ ар, өвөр монголыг нэгтгээд сүүлдээ манжийн хаад шиг хандвал монголын ихэс дээдэс эвэргүй тэх шиг японы эзэн хааны гар харж царайчлах болно. Өөртөө хаан эзэнгүй болчихсон

улс орныг эд нар яаж ч чадна. Тиймээс манжуур, өвөр монголд ямар эрх олгохыг нь хардаг хэрэг!» гэж шийдсэнээ сэтгэлийнхээ хямралыг тайвшруулав.

Японы улс төрийн хямралыг ажиглаж, армийн нөлөө идэвхжих тусам Тозияа сэтгэлдээ баярлана. Тэрээр богдын алтыг хаана хадгалж байгааг мэдэж чадаагүй ч гэсэн тэр алтыг өөрөө олж авна гэдэг бодлоос ухарсангүй. Тиймээс байдлыг янз бүрийн талаас нь цэгнэж, ашигтай алхам хайна. Учир нь японы арми, сайд нарын танхим байнга солигдсон нь Тозияагийн анхны айлтгалын дотор дурдсан зүйлийг мэдэх хүнгүй болж, гагцхүү Цэен гүн армиас зэр зэвсгийн тусламж авах бодолтой хүн гэхээс цаашгүй болсон гэж бодно. Гэсэн ч Тозияад мухардах явдал мундсангүй. Тийм мухардалтаас Тозияа гарахын тулд Симотоогоор зам мөр гаргуулна гэж тооцоолжээ. Тэгээд манжийн сүүлчийн хаан агсан Пу И хэмээгчтэй уулзаж түүнийг ятгахын тулд Тяньжин руу явахын өмнө Симототой уулзаж, Цэен гүнтэй ажиллах удирдамж өглөө.

- Симото сан, чи гүнгийн талаар юу гэж бодож байна даа? Ямар нэг сэжиг гаргах талаар юм санаачлах хэрэгтэй шүү гээд Тозияа шавь руугаа ажиглангуй ширтэнэ.

- Сэнсэй (багштан) минь, Богдын алт Тяньжин дахь Английн банкинд байхгүй. Энэ гинго Монголорыг байгуулахад оролцсон төдийгүй Богд хаантай холбоотой байсан нь үнэн. Гэтэл энэ банкинд хадгалж байгаа хөрөнгөний нууц жагсаалтанд Богд хаан, Цэен хоёрын аль алины нь нэр ороогүй байна. Ингэхээр тэр алтыг Тяньжинд хадгалуулаагүй. Харин Бээжин, Шанхай Кантоны банкны талаар одоохондоо судалгаа хийж амжаагүй байна. Харин та соёрхвол ингэж чирэгдэл болгохгүйгээр мэдэх нэг арга байна. Гэхдээ хугацаа нэлээн шаардагдана.

- Тэр алтны сургийг гаргавал хугацаа энүүхэнд хэрэг!

- Тайса доноо, та Гэрэлийг янхны газраас зайлуулаагүй явдлаа одоо ашиглах хэрэгтэй. Цэен гүн Гэрэлээд дасчихсан төдийгүй

Сайнжаргал, Сувдаа хоёр гүнгийн хань болгох янзтай. Гэрэлээг хүүхэдтэй болговол бидэнд багтай найдвар гарч болно гэхэд Тозияа шавийнхаа ааш араншин, муу юмыг овжин сэтгэдэг авьяасыг

бишрээд дотроо «Хүүхэд... хүүхэд! Хүүхдийг нь төрсний дараа

Цэен гүнг устгачихвал нэг хэрэг. Харин Цэен гүн хүүдээ алтаа гэрээслэх боломжийг яаж гаргах вэ? Цэен алтны талаар гэрээслэл үлдээвэл хүүг яаж ч ашиглаж болно. Сонин санаа байна! Хэрвээ Гэрэлээгээс охин гарвал яах вэ?» гэж бодоод,

- Симото сан чиний санаснаар хүү гарахгүй охин төрвөл яах вэ? гэж сонжиж асуутал Симото,

- Монголчууд отгон хүүдээ гал голомтоо сахих гэрээслэл үлдээдэг уламжлалтай. Цэен гүнд удаан үйлчлэх хор бэлдэж өгвөл биеэ муудаад ирэхээр хүүдээ хөрөнгөө гэрээслэх нь зайлшгүй. Богдын алт одоо үнэн хэрэг дээрээ Цэенгийн хувийн хөрөнгө болоод байна. Гэрэлээ охин төрүүлсэн ч гэсэн түүнийг сольчиход их түвэг орохгүй гэлээ.

- Гүнтэнд яаж хор өгөх вэ? гэдгийг нарийн боловсруулах хэрэгтэй.

- Гүнтэн америк янжуурт дуртай хүн. Үүнийг нь ашиглаж хортой янжуур бэлдэж болно гэхэд Тозияа сэтгэлдээ «Болдог санаа. Хугацаа... хугацаа удах тусмаа надад ашигтай. Богдын алтны учрыг одоохондоо битүү ажсан хүмүүс бий. Тэгэхээр хүлээх нь дээр» гэж бодоод,

- Симото сан би чиний санааг зөвшөөрнө. Гэхдээ энэ талаар амаа татаж явах хэрэгтэй. Танака Жан Золинг устгахдаа эзэн хаанд дуулгалгүй нуугаад сүүлдээ яаж баларсныг санах хэрэгтэй. Миний айлтгал эзэн хааны архивт байгаа учраас Цэен гүнг хорлосон учрыг сэжиглүүлэх ямар ч сэжим гаргаж болохгүй. Өчүүхэн сэжиг гаргавал та бид хоёр хоёулаа дээлээ нөмөрнө гэдгийг мартаж болохгүй гэж сануулаад Тяньжин руу явжээ. Тэгээд хааяа Тяньжингаас утсаар ярихдаа ил хэргийн талаар Симотоогоос лавладаг заншилтай. Харин Симото, энэ хугацаанд Гэрэлээгийн амьдрал ахуйд холбогдолтой тодорхойлолтыг нууц янхны газраас аваад Мүгдэнгийн эмч нарыг судалж, нэгэн өвгөжөөр эмчийг сонгож, Гэрэлээг эмчлүүлэх талаар тохирчээ. Гэрэлээ олон жил янхны газар ажиллахдаа заг хүйтнээр хэдэн удаа өвдсөн аж.

Симото ингэж ажил төрлөө зохицуулаад Гэрэлээгийн очдог газар, гүнгийнхээс гардаг цаг хугацааг нарийн тогтоогоод отдог болов. Тэрээр нэгэн удаа дэлгүүрт очоод буцаж яваа Гэрэлээг амдан

уулзаад,

- Гэрэлээ сан, харьж явна уу. Би гүнд бараалхах гээд амжихгүй байна. Тозияа сан нэг захиа явуулсан байсан. Та завтай бол манайхаар ороод авчихгүй юү гээд хуурамчаар тал засан инээх нь хөндий хүйтэн санагджээ.

- Тэгье л дээ. Танай ажил дээр байгаа юм уу? гэж асуусан Гэрэлээ Симотогийн үгнээс хар авч «Симото захиа өгнө гэдэг ч худлаа хэрэг. Харин намайг албан өрөөндөө аваачаад ятгах гэсэн бодолтой байж магадгүй. Богдын алтыг гүнгээс салгах шинэ арга сэдсэн учраас Симото намайг ээрч хоргоогоод байна. Очиж ярилцвал жинхэнэ санааг нь мэдэж болно. Симото, ажил дээрээ аваачвал над шинэ даалгавар өгч, нууц хадгалах хуулийн дагуу баталгаа гаргуулах ёстой шүү дээ. Ингэхээр жинхэнэ санаа нь надад мэдэгдэнэ гэсэн үг!» гэж бодлоо. Гэрэлээ, Симотоог дагаж японы цэргийн төлөөлөгчийн газраас холгүй байдаг японы хээрийн цагдаагийн удирдах газар дахь Симотогийн өрөөнд очлоо. Симото албаны өрөөнд орж ирэнгүүт албархуу байдлаар харьцаж,

- Аа Гэрэлээ авгай та чинь гүнгийн эхнэр болчихсон гэлүү. Хуримандаа урих биз дээ. Та бид нар чинь хамтран зүтгэгч шүү дээ гэж ёжтой инээмсэглэсэнээ,

- За тэр ч яах вэ? Харин урьдчилан сануулахад та, дэндүү удаан хөдөлгөөнтэй байна. Тэр тусмаа манайд өгсөн амлалтандаа хэнэггүй хандах болсон гэдгийг сануулья гэхэд Гэрэлээ,

- Би ямар үүрэгтэйгээ мартаагүй. Гэхдээ миний ажиллагаанд хугацаа шаардагдана гэдгийг мартаж болохгүй шүү гэлээ.

- Гэрэлээ сан, та манайд амласныхаа дагуу юу ч хийхгүй байна. Харин гүнгийн өвөрт хэвтдэг болсоор овоо мяраалаа шив дээ. Наад махнаас чинь шуугаад өгч болно шүү! Жаргалаа зовлон болгохыг хүсээгүй бол ажил төрлөө бодсон дээр гэж омогдов.

- Симо то ши (японд хүний нэрийн дараа ши буюу ноён гэсэн үг залгаж дууддаг ёстой) тэр алтны сургийг гаргаж өгөх нь миний үүрэг. Би үүргээ биелүүлэхийн тулд тэр хөгшний өвөрт хэвтэж

байгаа. Түүнээс хайртай болчихоод салж чадахгүй байгаа хэрэг биш! Нөгөө талаар Богдын алт эрдэнэс хятадад байгаа их гүрний аль ч банкинд байхгүй гэдгийг би баталж чадна.

- Тийм байх ёсгүй! Энэ бол таны ажиллагаа бүтэмжгүй байгааг харуулж байгаа наад захын нотолгоо.

- Симо то ши, тэгвэл би одоо гүнгийн ажиллах хэрэггүй биз! Муу ажиллаж байгаа бол жанжин штаб, та нарын эндэх ажил муу байгааг мэдээд зогсохгүй, та нарыг ч муугаар ойлгох болно. Тиймээс би та бүхний өндөр алдар нэрийг гутаагаад яах вэ?

- Үгүй шүү. Гүнтэн танд одоо хэлэхгүй юм гэхэд жилийн дараа зайлшгүй хэлнэ гэхэд Гэрэлээ хоромхон зуур «Эд нар яагаад жил гэж байна! Жил жил гэнээ... эд чинь хүүхэд төрүүлэх талаар надтай тохиролцох гэж байгаа хэрэг үү» гэж бодоод,

- Симо то ши, гүнтэн надад хүйтэн хандсаар байгаа. Тиймээс жил байтугай хэдэн жил ч гэсэн аминыхаа нууцыг хэлэхгүй биз гэлээ.

- Хэлэх цагийг нь бий болгох хэрэгтэй. Тиймээс та гүнгийн өвөрт хэвтэх л болно. Тэгээд зогсохгүй хүүхэд төрүүлж өгөх хэрэгтэй. Гүн хүүгийнхээ дууг сонссон цагт чамд хайртай болж, хүйтэн ханддаг хандлага нь зөөлөрнө. Тэр үед гүн Богдын алтны талаар дуугарах болно. Тэр алтыг өвлүүлэх хүүтэй болсон хүн дуугүй байх ёсгүй гэхэд Гэрэлээ Симо тогийн дохигор нуруу, хөхөрч харласан царайг ширтэн,

- Симо то ши, надаас хүүхэд төрөхгүй шүү дээ. Тиймээс надаас арай залуу хүүхэн олбол илүү найдлагатай шүү гэхэд Симо то сэтгэлдээ «Энэ янхны сэтгэл хувираагүй юм байна. Хэрвээ гүнд сэтгэлтэй болсон бол ингэж хэлэх ёсгүй. Залуу хүүхнийг гүнтэй ханилуулах нь байтугай залуу хүүхний барааг харуулахгүйн тулд миний саналыг эсэргүүцэлгүй хүлээж авах ёстой» гэж бодоод,

- Танаас өөр хүн гүнгийн сэтгэлийг татаж чадахгүй. Гэтэл та авьяасаа үнэлж, өөрийгөө дайчлахгүй байна. Үүнээс хойш долоо хоногт хоёр удаа эмчид очиж бай! Нөгөө талаар одоо өөрийнхөө идэвх чармайлтыг дайчлах цаг гэдгийг мартаж болохгүй гээд эмчийн хаягийг өглөө. Гэрэлээ тэр хаягийг авч үзсэнээ гурвантаа уншаад Симо тоод буцааж өгөв. Тэрээр нэг харсан зүйлээ нүдэндээ тогтоож, сэтгэлдээ хадгалдаг онцлог авхаалжийг Симо то багагүй нэлдэг болой.

- Гэрэлээ сан, гүнгийн охидууд юу ярьж байна?

- Эцгийнхээ үгэнд итгэдэг. Тиймээс манжуурт хурдхан шиг автономи тогтоосой гэж өглөө үдэшгүй бурхандаа мөргөдөг бололтой. Харин Цэен гүн, энэ бүхэнд итгэдэг гэхэд бэрх! Тэгээд зогсохгүй хятад дахь английн худалдааныхантай их уулздаг болсон. Үүнийг та мэдэж байгаа биз.

- Тэр тухай би, танаас арай илүү мэднэ. Харин Цэен алтныхаа тухай охидуудтайгаа ярилцах юм уу? Үүнийг л та мэдэж авах ёстой шүү дээ?

- Симото ши, тэр чинь энэ тухай төрсөн ахдаа ч цухуйлгаагүй байх. Ер нь байхгүй алтны талаар юу ч ярих билээ. Энэ бол тэр алтыг хятадад байхгүй гэдгийн ерийн баталгаа болж байгаа хэрэг!

- Тийм байх ёсгүй. Цэен гүн хашир хүн. Манай эзэн хаан цэргийн тусламж өгөх шийд гаргах нь уу гэдгийг хүлээж байгаа. Ингэхээр та, ам нээхийг нь хүлээх хэрэгтэй! Одоо та гүнгийн эхнэр болсон гэж бод! Бид үүнээс хойш тантай уулзах хугацааг хойшлуулж, цөөлнө гээд эмчилгээг ариглаж гамнах, нямбай ажиллах талаар зөвлөгөө өглөө.

Гэрэлээ Симотогийн өрөөнөөс гараад гэрээ зүглэж, хэрмэн хашаа хүртлээ элдвийг бодов. Тэр тусмаа Симотогийн ярьсан үг, өөрийнхөө ярьсан бүхнийг ахин дахин хянаж, ямар нэг алдаа, осол гаргасан эсэхээ тунгаана. Тэрээр чингэж хэдэнтээ тунгаахдаа «Эд Богдын алтыг хятадад байгаа эсэхийг албан ёсны баталгаатай болгохыг чухалчилж байна. Энэ санаандаа хүрэх аргаа нарийн боловсруулжээ. Цэен алтны талаар надад хэлэхгүй гэдгийг тооцоолоод монголчуудын зан заншлыг ашиглахаар шийдэхдээ тун овжин ухаан гаргажээ. Монголчууд отгон хүүдээ гал голомтоо уламжлуулан үлдээдэг. Ингэхээр надаас төрсөн хүүхдийг япончууд өөрсдийн гараар хүмүүжүүлбэл алтны асуудлыг шийдэж чадна. Эд ийм замаар санасандаа хүрвэл эцсийн эцэст намайг ч, Цэенг ч цааш харуулах болно! Тэгэхдээ Цэенгээс хүүгийнхээ хойчийг бодож үлдээх гэрээслэлийг олж аваагүй цагт биднийг устгахгүй. Харин Цэен гүн, японд итгэхээ больж алсдаа америкийг бараадах гэж байгаа бодлыг эд мэдэж амжаагүй байна. Тиймээс яарахгүй байгаа хэрэг» гэж бодов. Гэрэлээ энэ бүгдийг тунгаасны дараа Цэенд дуулгая гэж бодсон авч эв нь таарч өгсөнгүй. Тэгээд хэд хоногтоо харзнахаар шийдээд Симотоод ямар нэг сэжиг төрүүлэхгүйн тулд эмчид очдог боллоо. Ийнхүү өдөр хоног харвасан сум шиг өнгөрч сар болоход Гэрэлээ Симотогийн талаар ярихаас улам зүрхшдэг болжээ. Учир нь японы улс төрийн амьдралд гарсан өөрчлөлт, эргэлтүүдийг сонссон Цэен гүн, үргэлж уур уцаартай явдаг болохоор Гэрэлээ түүний сэтгэлийг хямруулахгүйг мэрийнэ. Сүүлийн үед Гэрэлээг царайгаа бүрсийлгэж явдгийг ажигласан Цэен нэг орой,

- Гэрэлээ чиний бие зүгээр үү? Ойрдоо царай чинь шаналангүй байх чинь гэж нухацтай асуулаа.

- Цэен минь, чи намайг ямаршуухан хэцүү өвчинд яагаад ороолдчихсоныг хэлүүлэлтгүй мэднэ шүү дээ. Янхны газрын балгийг одоо эдлэх нь бололтой гэхэд Цэен уншиж суусан судраа хойш тавиад Гэрэлээг өрөвдөж хайрласан харцаар ширтэж гарыг алгаараа илж суухдаа Гэрэлээгийн сэтгэлийг тайвшруулах гэсэн шиг,

- Гэрэлээ чиний гар дандаа халуу дүүгдэг болжээ. Урьд өмнө өвөр чинь хүртэл хүйтэн байдаг сан. Одоо чиний өвөрт унтаад босохоор хөөрөөд байдаг болжээ. Зарим өглөө цээжнээс цус

амтагдах юм. Хааяа хамраас цус гардаг болсон гэлээ.

- Цэен минь хүйтэн цустай хүн, халуун цустай болбол сайн юм биш үү?

- Хөгшчүүлийн яриагаар бол хүйтэн цустай эм хүн халуун цустай болохоор хүүхэд олохдоо амархан гэдэг сэн.

- Цэен минь би хүүхэд гаргахгүй.

- Тэгвэл юунд эмчид очдог юм бэ? Чиний биеэс эм тариа ханхлаад байдаг болсон.

- Очихгүй байж болохгүй байна. Би өөрийнхөө хүслээр эмчлүүлж байгаа юм биш. Би хүүхэд гаргаад чамайг улаан нялцгай юмтай үлдээж амьдаар чинь хатаахыг бодохгүй байна. Би энэ хэдэн жил чиний дэргэд эмэгтэй хүн шиг амьдарлаа. Тэгээд чиний ачийг яаж хариулахаа мэдэхгүй явна.

- Симото зовоогоод байна уу?

- Тэд намайг хэдэн сардаа шаналгахгүй байх. Харин хүүхэд

гаргасны дараа гудамжны нэг булангаас буудах нь гарцаагүй хэрэг!

- Яагаад тэр вэ? Үүргээ гүйцэтгэлээ гэж үү?

- Тиймээ. Япончууд одоо хүүхдэдээ юу гэрээслэх вэ? гэдгийг чинь сонирхож байгаа. Чи үүнийг хэлүүлэлтгүй мэднэ. Нөгөө талаар хүн хөлгийг миний хойноос битгий явуулж бай! Тэр чинь чамд надаас илүү тус болох хүн. Миний араас Симотогийн хүмүүс дагаж байгаа. Тэгэхээр тэдний нүдэнд хүн хөлгийг өртөөж болохгүй. Хүн хөлгийг намайг хамгаалах зорилгоор явуулдгийг чинь Симото мэдвэл түүнийг барьж аваад эрүүднэ. Тэр ам ангайхгүй гэдэг нь илэрхий. Харин Симото түүнийг алчихаад юу ч гэж худлаа хэлж чадна шүү.

- Гэрэлээ минь амьдралын зовлон чи бид хоёрыг гэнэт учруулсан шигээ гэнэт хагацаах нь дээ. За юу ч гэсэн армийнхныг харзная. Болохгүй бол амиа бодно. Харин намайг америкийнхантай уулзаж байгааг эд мэдэхгүй тусмаа сайн юмсан. Тиймээс чи, английнхантай салшгүй холбоотой гэдгийг Симотоод ойлгуулах хэрэгтэй. Япон манжуурыг хятадаас салгаад төр эрхийг нь манжуурт өгвөл өөр хэрэг! Тозияа Тяньжин руу зүгээр яваагүй. Тэр манжийн сүүлчийн хааныг олж холбоо тогтоогоод байгаа юм. Япон манжуурт үнэхээр тусгаар тогтнол олгоод эзэн хааныг нь ширээнд залчихвал Нэгдсэн монгол улсыг байгуулж болно. Тиймээс би, Тозияагаар дамжуулж японы эзэн хаанд бараалхаж, тохиролцож болно. Ийм завшаан гарахгүй нь мэдэгдвэл шууд америк бараадна. Одоо Сайнжаргал, Сувдаа чи бид дөрөв нэг хүн шиг ажил төрлөө зохицуулах хэрэгтэй гэхэд Гэрэлээ,

- Цэен минь би ямар азаар чамтай учрав аа. Би үхсэн ч сэхсэн ч чиний дэргэд байж учраа олно гэж хэлэхэд нүдэнд нь нулимс цийлэгнэсэн агаад нимгэн уруул нь үл мэдэг өмөлзөнө.

Хаврын сүүл сарын эхээр японы армийн түрэмгий удирдагчид, Вакацукийн засгийн газрыг түлхэн унагахаар завдаж, Хар луу хэмээх байгууллага «Эх орончид» гэдэг нэрийн доор 10

мянган

цэргийг бэлтгэж, бослого гаргахаар зэхэж байсан нь сайд нарын танхимынханд илэрхий болов. Нууц ажиллагаа илрэхэд хүрсэн эгзгийг мэдсэн цэргийн яамны сайд Угаки, албан тушаалаасаа сайн дураар огцрох санал гаргасан явдлыг зарим хүмүүс «Хар луу» нийгэмлэгтэй холбоотой байсных гэж үздэг боллоо. Засгийн газрын эсрэг чиглэсэн армийн үйл ажиллагааг Вакацукигийн танхимд армийг төлөөлдөг хошууч генерал Кайсо ятган зогсоож, цэргийн 1931 оны зардлыг 50 сая иениэр нэмэгдүүлсэн нь засгийн газарт түр тэнцвэр олох завшаан бүрдүүлжээ. Японы армийн энэ бүтэмжгүй ажиллагаанд бухимдсан Цэен гүнтэн, сэтгэлээ сэргээхээр нэлээн сэргимдсэн аж. Гэтэл гүн гурав хоног шартаж хий огиулж, дотор гэдсээ амаараа гаргачих шахсанаас хойш элэг цөс нь өвдөөд ходоодонд нь нууц байсан өвчин нь илэрчээ. Цэен гүний өвчин гэнэт илэрсэн явдлыг Симото мэдэнгүүт Тозияад илтгэсний адилаар Мугдэн дэх цэргийн төлөөлөгчийн тэргүүн, удирдлагадаа илтгэжээ. Цэен гүнгийн бие чилээрхээд арав хонож байтал нэг өдөр Тяньжин дахь Тозияагийн утасны хонх жингэнэв.

- Байна уу, Тозияа сан уу гэх дууг сонсонгуут Тозияа жанжин штабын тагнуулын газрын орлогч нарын нэг, нэгэн генерал ярьж байгааг мэдэв.

- Тайса, Тозияа таны үгийг сонсож байна гэхэд,

- Тозияа сан, цэргийн яам болон жанжин штабын удирдлага гүнгийн талаар багагүй сонирхож байна. Талийгаач мэжи исин Иосихитоод Богд хаанаас айлтгасан айлтгалдаа таны яриад байдаг алтны талаар ганц ч үг дурсаагүй байна. Гэтэл түмэн лан алтны талаар илтгэсэн таны айлтгалд ихэнх хүмүүс эргэлзэж байна. Иймээс та түүний талаар бодох хэрэгтэй. Юуны өмнө Богдын алт хятадын ямар банкинд байгааг тогтоож, баталгаатай болгох хэрэгтэй. Нөгөө талаар та, түүнийг эзэн хааны санд хандивлах тухай айлтгалдаа цухас дурдсан учраас эзэн хааны зөвлөхүүд хаанд айлтгахаас цааргалж байна. Хаантанд хий хоосон юм дуулгаж болохгүй. Эцэст гэхэд Цэен гүнгийн бие чилээрхээд базаахгүй байгаа чимээтэй. Гүнгийн өвчин амь насанд нь хүрэхээр тийм эгзэгтэй бол Богдын алтны гэрээслэлийг авах хэрэгтэй. Та монголын асуудлаар олон жил ажиллаж байгаа. Гэтэл дорвитой алхам гаргаагүй явдлыг Вакацукигийн танхимынхан ажиглаад хэл ам таталж байна. Одоо мэнсэйто нам Вакацукийг дэмжиж ерөнхий болгосныг мартаж болохгүй гэж хатуухан сануулав. Тозияа генералын нухацтай үгэнд балмагдан, өөрийгөө аврах замаа сүүхээлэн бодож байхдаа "Эзэн хаанд бичсэн айлтгалдаа" осол гаргасныг мэдээд өөртөө уурлана.

- Гаккаа (ноён генералаа) Цэен гүнгийн биеийг сайжруулахад манай эмч нарыг албан ёсоор оролцуулан Токиогоос тусгай хэсэг зохион байгуулбал ямарсан бол? Симотогийн илтгэх хуудаснаас үзвэл гүнгийн бөөр, цөс нь муу төдийгүй ходоод нь хавдартай гэнэ.

- Манай эмч нарыг албан ёсоор оролцохыг жанжин штаб зөвшөөрөхгүй нь мэдээж. Үүнийг санаж явах хэрэгтэй гээд генерал утсаа тавьсан нь Тозияад ямар ч дэмжлэг үзүүлэхээс цааргалсныг гэрчилнэ. Тозияа удирдлагатайгаа чингэж ярьсны дараа бүр балмагдлаа.

...Одоо яах вэ? Бүр балрах зам руугаа орлоо. Вакацукигийн сайд нарын танхимынхан надтай дахин шөргөөлцөхөд хүрвэл би өнгөрөх нь тэр! Дөрвөн жилийн өмнө Вакацукийг ерөнхий

сайд болоход бас ийм хэл ам гарсан. Хэн нь ингэж оролдоод байдаг байна. За яахав яваандаа мэдэж болох байх. Харин одоо энэ урхинаас гарах нь чухал. Тэгэхгүй бол эзэн хааныг хуурах заль мэх гаргасан гэдэг шуугиан дэгдээвэл яаж ч болохгүй юм болно. Симотогийн гарыг харж Гэрэлээгээс хүүхэд төрөхийг хүлээж хугацаа алдлаа.

Тозияа хэдэн цагийн турш ингэж, бодоод ашигтай арга олж чадалгүй мухардав. Тэгээд түгшсэн сэтгэлээ тайвшруулахын тул Мугдэн руу залгуулж Симототой ярихаар шийдэв. Тозияа айсандаа хэтэрхий сандарч байгаагаа мэдлээ. Тэгээд өөртөө «Сандарч болохгүй» гэж сануултал Симотогийн дуу утасны чагнуурт хадлаа.

- Симото сан, гүнгийн бие ямар байна вэ? гэж асуухдаа яах гэж ингэж асууснаа ч анзаарсангүй.

- Тайса, доноо, биеийн байдал барагтай байгаа. Орноосоо босохгүй, тав хонож байна. Өчигдрөөс үе үе ухаан алдан, халуун нь буурахгүй зовоогоод байна. Бид төлөөлөгчийн газрын эмчээр үзүүлэх гэсэн боловч нэгд гүн өөрөө татгалзаад, нөгөө талаар төлөөлөгчдийн газрынхан дургүйцээд байна.

- Тэгээд ямар эмч үзэж байгаа хэрэг вэ?

- Мугдэнд байдаг нэг хорчин эмчээр үзүүлж байгаа.

- Эмчтэй нь уулзсан уу? Юу гэж байна.

- Урьдчилсан оношоор бол бөөр нь ууссан, ходоод хорт хавдартай байх гэсэн.

- Эмчийг судалж үзсэн үү?

- Бүх зүйлийг нь судалсан. Залуудаа Долнуурт лам байсан. Багаасаа нэгэн маарамбыг дагаж эмийн ургамал түүж эм найруулж сурсан байна. Арваад жилийн өмнө Бээжин Шанхайд суралцаж эмч болжээ. Ардын эмнэлгээр мэргэжсэн бололтой. Цэен өөрөө ардын эмнэлэг чухалчилж байгаа тул тэр эмчээр эмчлүүлэхэд Сайнжаргал ч дуртай байгаа. Тиймээс япон, хятад эмч нараар эмчлүүлэхээс татгалзаад байгаа юм.

- Симото, чи тэгээд яая гэж бодож байна. Удирдлагаас сая надтай ярилаа. Богдын алтны талаар баталгаа шаардаад амар заяа үзүүлэхгүй янзтай. Чи үүний учрыг ойлгож байна уу? Хугацаа унжруулсан явдлаас болж эзэн хаан, жанжин штабт худлаа илтгэл бичсэн хэрэгт чи унах уу, би унах уу гэдэг асуудал гарах нь. Би чамд итгээд өдий хүрсэн. Гэтэл чи ажил хэргийг сунжруулаад байна гэхийг ажвал нохой сүүлээ сүүл хонхорцгоо гэгч боллоо. Симото, юмыг муу талаас нь эхэлж тунгаадаг болохоор сэнсэй-багшийнхаа үгний цаад учрыг ухаарч, өөрийнхөө толгой дээр ял унахад хүрснийг ойлгоод,

- Тозияа сан, гүнгийн өвчнийг одоо далимдуулбал ямар вэ? гэхэд Тозияа шавийнхаа санааг ойлгоод,

- Гүнг нүд анихаас өмнө гэрээслэлийг яаж бичүүлж авах вэ гэдгийг нарийн боловсруулах

хэрэгтэй гэлээ.

- Гүнтэн өвчнөө эдгэхгүй гэдгийг төдийгүй амь насаа алдах нь гэдгийг мэдвэл нас барахын өмнө Сайнжаргалд гэрээслэлээ хэлэх нь зайлшгүй. Тэгвэл Богдын алтны учир амархан олдоно. Гэрээслэлийг бичихэд хөндлөнгийн итгэлтэй хүн хэрэгтэй. Тэр үед гүн танаар гэрч хийх байх.

- Симото ийм арга хэрэглэх юм бол эмч нар нь найдвартай хүн байх хэрэгтэй шүү.

- Тэр эмчийг судлахад ашиглаж болох нэг эгзэг олдоод байна. Хорчин эмч дөрвөн жилийн өмнө Доихарагийн (алс дорнодод алдаршсан японы тагнуул) нэг шавийг эмчилж байгаад осолдуулсан юм. Энэ хэргийг тэр үед Сойхара нягталжээ. Сойхара эмч Хайсангийн талаар хэд хэдэн эгзэг гаргасан боловч Жан Золингийнхон түүнийг хамгаалаад яаж ч чадаагүй. Энэ тухай Доихарагаас лавласан. Тэр үед Доихара, Жан Золингийн зөвлөхийн туслахаар ажиллаж байсан бөгөөд түүний туршуулын нэг нь Жан Золинд үг зөөдөг болсон учраас түүнийг тусгай даалгавраар устгуулсан гэнэ. Ингэхээр Хайсан эмчийг одоо ашиглаж болох далим гарч байна.

- Хээрийн цагдаагийн газрын Сойхара, тэр үед эмчийн хэргийг шалгасан байх нь!

- Тиймээ. Тэр үед Сойхара кэмпэйтэйн нууц албан тушаалтай байсан юм.

- Симото сан, тэгвэл Сойхарааг өөртөө авч ажиллуулж, гүнгийн эмчилгээний асуудлыг хариуцуулбал болох юм. Гэхдээ Сойхараад найдаад ажлаа цалгардуулж болохгүй. Чиний ажил хэрэг бүтэмжгүй байгаа. Тиймээс эзэн хааныг хуурч мэхэлсэн хэрэгт ороолдож мэдэх юм. Хянуур ажиллахгүй бол эзэн хааны армийн нууцыг хадгалах хуулийн дагуу өөртөө сеппуку үйлдэхээс сайхан зам байхгүй гэдгийг мэдэх хэрэгтэй гэжээ. Сеппуку бол нэг төрлийн харакири бөгөөд самурай нар эзэн хааны армид үнэнч байсны баталгаа болгож үйлддэг уламжлалтай байжээ.

Шөнө дүл өнгөрч байхад Мугдэн хотын баруун өмнөд хэсэгт байдаг бөглүү гудамжны нэгэн шавар байшингийн эзэн Хайсангийн өмнөд манжуурын төмөр замыг хамгаалдаг япон цэргийн эргүүлийнхэн орж ирээд түүнийг баривчилжээ. Чингээд хоёр цагийн дараа Мугдэнгийн «Мантэцу» хэмээх нийгэмлэгийн дэргэд маш нууц байгуулсан нууц албаныхан дээр авчирлаа. Симото зузаан хавтастай хэрэг уншиж байснаа,

- Хайсан сан, та ямар хэргээр хаана ирээд байна гэж бодож байна? гэв. Энэ нь үнэндээ төрийн эсрэг улс төрийн хүндхэн хэрэг үйлдсэн гэдэг сэтгэгдэл төрүүлэх гэсэн далайлгалт байлаа. Үүнийг мэдсэн эмч,

- Жаа жапан ноёд авчирсан болохоор өчүүхэн дорд би учрыг яаж мэдэх билээ хэмээн хятадаар айлдав.

- Хайсан сан та, японы нууц албаны нэгэн хүнийг өвчнөөр нь далимдуулж хор өгч цааш нь харуулсан байна. Бид үүнийг сонирхсон юм.

- Жан ноён түүнийг устгахыг биеэрээ уулзаж даалгасан юм.

- Үүнийг батлах баримт байхгүй шүү!

- Жаа тиймээ. Гэхдээ дээдсийн даалгаврыг би биелүүлэх ёстой. Дээдсийн биечлэн өгсөн үүргийг гүйцэтгэхдээ баталгаа гаргуулдаггүй. Нөгөө талаар тэр үед Кавасу эмч надад удирдамж өгсөн.

- Одоо Кавасу хаана байгаа вэ? Та хоёр уулздаг уу?

- Үгүй шүү. Тэр хүн Харбинаас ирээд ажил явдал төгссөний дараа буцаад явсан. Одоо Харбинд байгаа гэхэд Симото ширээн дээрээс цаас авч,

- Хайсан сан, таны үйлдсэн хэргийг Токиогоос сонирхож байна. Би таны үгэнд итгэнэ. Гэхдээ Токиод байгаа кэмпэтайн удирдлага үүнээс чинь илүү нотолгоо гаргаж баталбал би яаж ч чадахгүй гэхэд Хайсан гүнээ санаа алдаад сэтгэлдээ «Энэ чинь аймшигтай эгзэг дээ. Кэмпэтай энэ асуудлыг сонирхож байгаа бол би яаж ч чадахгүй нь илэрхий. Тэдний мөрдөлт, байцаалтаас хүн бүхэн айна. Тэгээд хар амиа бодоод зарим хүмүүс тэдний шаардлагын дагуу худал, хуурамч тодорхойлолт гаргахаас татгалздаггүй» гэж бодно.

- Симото сан би таны хэлснийг ойлгож байна. Гэхдээ одоо яая гэх вэ? Миний лай ланчиг тиймээс хойш таныг энэ хэрэгт хавчуулаад яахав. Намайг хамгаалах гэсний хэрэггүй гэж Хайсан гайхсан байдлаар хэлэхэд,

- Хайсан сан, та айж сүрдэх хэрэггүй. Харин кэмпэтайн шугамаар нэг юм шалгах ёстой. Нууц ажиллагаанд та оролцвол урьд хийсэн хэрэг явдлыг цайруулж болох боломж бий гэлээ. Хайсан, Симотогийн энэ үгийг сонсоод харц нь сэргэж,

- Би та нарын ажилд тусалж болно шүү. Намайг энэ гайтай асуудалд өртөөлгүй өнгөрөөж өгвөл болох нь тэр гэлээ.

- Хайсан сан та Цэен гүнг эмчилж байгаа. Тэгэхээр бид хэд хэдэн зүйлийг тохирох хэрэгтэй. Та гүнгийн биеийн байдлыг тун сайн мэднэ. Тиймээс Кавасу эмчийг, түүнтэй танилцуулж өгвөл болох нь тэр! гэхэд Хайсан эмч, Симотогийн болзлыг зөвшөөрч, японы цэргийн нууц хадгалах хуулийн баталгаанд гарын үсэг зуржээ.

Симото, Хайсанг гарсны дараа Харбин дахь японы цэргийн төлөөлөгчийн газар руу явуулах тусгай цахилгааныг төлөвлөв. Харин Хайсан гэртээ ирэнгүүт элдвийг эргэцүүлж «Японы цэргийнхний нууц ажиллагаанд оролцож байгаагаа Цэен гүнгийнхэнд мэдэгдэж болохгүй. Тэгэхээр Сайнжаргалын хөлд сууж, Кавасуг танилцуулаад ор сураггүй алга болох хэрэгтэй. Би өрсөхгүй бол японы нууц албаныхан яах ийхийн зуургүй намайг тонилгоно. Симото нууц баталгаанд гарын үсэг зуруулсан болохоор намайг дав дув устгахгүй. Энэ завшааныг ашиглахгүй бол дахиад ийм далим гарахгүй» гэж бодоод Цэен гүнгийн очлоо.

- Сайнжаргалаа, одоо аав чинь насгүй болжээ. Тэгэхээр үнэнийг чамаас нууж болохгүй. Бид хэн хэн маань монгол хүмүүс шүү дээ.

- Хайсан эмчээ тэгээд одоо яах вэ?

- Бөөрний хувьд гэвэл би эмчилж чадна. Харин ходоодны өвчнийг яах ч арга алга.

- Ер нь ходоодны хавдрыг яаж эмчилдэг юм бэ? Та сайн сайн эмч нарыг танина шүү дээ. Үнэ хөлсийг нь чамлахгүйгээр өгнө.

- Миний санаанд буухгүй юм. Харбинд Кавасу гэдэг нэг япон эмч бий. Гэхдээ гүнтэн түүнд итгэхгүй биз гэхэд Сайнжаргал,

- Ер нь аавтай ярьж үзье. Аваас үнэнийг нуух хэрэггүй гэлээ. Чингээд Хайсан, Сайнжаргал хоёр гүнгийн өрөөнд орлоо. Гэрэлээ, эмчийг үзэж байхад түүний хөдөлгөөн бүрийг нүд алдалгүй ажна.

- Цэен гуай, хал үзэж хашир суусан хүний нүднээс юу ч нууж болдоггүй гэдэг. Таны ходоодын амсар хавдаад нарийссан тул одоо эдгэнэ гэхэд хэцүү гэж хэлтэл Цэен,

- Нарийн өвчнийг эмчилчих эмч байдаг юм уу? гэж асуув.

- Мэдэхгүй юм. Харбинд нэг япон эмч бий. Тэр хүн нарийнаар өвдсөн хүнийг эмчилчихсэн юмдаг. Харбины оросууд их шүтдэг юм. Тэр хүнтэй уулзаж чадвал учиртай байх гэхэд гүн хартай нүдээр Хайсан руу сүрхий ширтэв. Цэен Хайсангаас орос эхтэй, япон эцэгтэй эмчийн сургийг дуулсны маргааш Гэрэлээ, Сайнжаргал хоёр Харбин руу ярилаа.

- Иван Степановичаа, аавын бие барагтай. Сүүлийн үед орноосоо босож чадахгүй болоод байна. Бөөр нь одоохондоо гайгүй байна. Гэтэл ходоод нь хорсоод хоол унднаас гарчихлаа. Танай тэнд Кавасу гэдэг нэг япон эмч байдаг сурагтай. Чи таних уу?

- Би муухан танина. Оросын дүрвэгсдийн товчооныхон их биширдэг юм. Цэен ахыг дургүйцэхгүй бол би ярилцаж болно байх.

- Тэр эмч аль зэрэг итгэлтэй вэ? Юу ч гэсэн аавыг үзүүлдэг юм билүү? Ер нь чи сайн судлаад боломжтой юм бол дагуулаад ирэхгүй юу гэж гуйхад Иван Степанович татгалзсангүй.

Иван Степанович, Сайнжаргал хоёрыг чингэж ярилцаж байхад Харбин, Мугдэн хоёрын аль аль нь тэдний яриаг тусгай шугамаар сонсож байв. Чингээд долоо хоногийн дараа Иван, Кавасуг дагуулж Мугдэнд ирлээ. Кавасу гүнгийн биеийг хэд хэдэн удаа үзээд,

- Өвчний хувьд гайгүй юм байна. Би эмчилж дөнгөх байх. Нэг их хүндрээгүй болохоор нааштай юм байна гэжээ. Кавасу, гүнг эмчилж эхэлсэн үед Сойхара, Кавасу эмчийн талаар хийсэн судалгаага танилцуулахаар Симотогийн өрөөнд орж ирлээ...

- Хито Кавасу, одоо гучин найман настай. Эцэг нь дөч шахам жилийн өмнө Харбинд ирсэн бөгөөд Дорнод хятадын төмөр замын нэг инженер оросын ганц охинтой ханилсан байна. Кавасу Харбины орос сургуульд суралцаж байгаад Токио дахь анагаах ухааны Кэйо хэмээх дээд сургуулийг төгсөөд буцаж иржээ. Кавасугийн эцэг Харбинд нас барсан учраас тэрээр Харбинд суурьшсан байв. Кэмпайтайн баримтаар бол тэрээр ажилд хичээнгүй, мэргэжилдээ сайн, эзэн хааны төлөө гэдэг үзэл бодолтой хүн. Харбинд байгуулсан Киовакай буюу

хятадуудын

нэрлэдгээр Сэхухэйка гэдэг итгэлтний нийгэмлэгийн ажилд идэвхтэй оролцдог гэнэ. Тиймээс ерөнхий сайд Танакагийн өргөмжилсөн сайдууд өндрөөр үнэлдэг байсан. Одоо манжуурт эзэн хааны дэглэмийг тогтоох орон нутгийн Сэхухэйка нийгэмлэгийн гишүүн юм гээд Доихарагийн нууц туршуулыг устгахад гүйцэтгэсэн үүргийн талаар танилцуулаад Кавасугийн нэг доголдолтой тал гэвэл эдийн сонирхолтой. Барьц хахуульд дуртай учраас Доихарагийн ажилтангууд болгоомжтой хандахыг зөвлөж байна гэхэд Симото хэсэгхэн зуур дуугүй сууснаа,

- Сойхара сан, цэргийн нууц хуулийн дагуу зохих баталгааг гаргуулж авбал зүгээр байх. Харбиныхны зөвлөснөөс үзвэл дорвитойхон айлгаж чадвал зүрх зориг муутай гэсэн юм. Ингэхээр эзэн хааны өмнө хүлээсэн самурайн ёсонд тулгаж, ёс суртахууны талаар сүрдүүлэг хэрэглэвэл айсандаа болоод амаа хавчаад явж чадах хүн гэсэн. Тиймээс Кавасутай тулж ажиллах хэрэгтэй.

- Симото сан, би энэ талаар бодож үзээд анхны уулзалтаар баталгаа гаргуулж авсан.

- Кавасу хаана байрласан бэ?

- Мүгдэнд байдаг нэг хөгшнийд байрлажээ. Тэр хөгшин эцгийн нь сайн нөхөр гэнэ. Харин одоо Хайсан эмчийн талаар бэлдсэн ажиллагааг эхлүүлэх үү? гэж лавлав.

- Цээн гүнг устгасны дараа Хайсан эмчийн учрыг олсон дээр! Тэгэхгүй бол гүнтэн сэжиг авчихна гэж хэлээд Сойхарагийн ажлын талаар удирдамж өглөө...

Харбинд ирсэн Кавасуг гүнгийнх гэртээ байлгах гэсэн атал эмч эцгийнхээ сайн танилын сэтгэлийг бодоод тэднийд байхаар болжээ. Кавасу өглөө гүнгийнхэнд ирээд оройхондоо хөгшнийд очно. Кавасуг Мүгдэнд ирээд хоёр долоо хоног болж байхад нэгэн орой буцаж иртэл хөгшнийд хоёр япон дарга хүлээж байлаа. Тэр хоёр Симото, Сойхара хоёр байжээ. Симото, Кавасутай уулзангуут нялуурч ая тал зассангүй. Хэзээ язааны таньдаг хүн шиг албан яриагаа эхэллээ.

- Кавасу сан эзэн хааны төрийн эрх ашиг, нэр төрийн үүднээс танд онцгой үүрэг хүлээлгэнэ. Таны гүйцэтгэх үүргийг биднээс өөр хүн мэдэх ёсгүй. Эзэн хааны кодо замналыг азид дэлгэрүүлэх ямагогийн эрх ашгийн үүднээс гүнг устгах ёстой юм. Гэхдээ шууд

амь насанд нь халдаж болохгүй. Юуны өмнө түүний өвчнийг хүндрүүлж, өвчний хүндрэлтээс шалтгаалж нас барлаа гэдэг ойлголт төрүүлэх нь чухал. Энэ бол тань шиг туршлагатай эмчид түвэг чирэгдэл багатай энгийн зүйл. Тиймээс та бусидоод үнэнч самурайн үүрэг гүйцэтгэх ёстой гэхэд Кавасу зүрх нь амаараа гарчих шахлаа.

- Кавасу сан, үүнээс хойш таны ажилд ахмад Сойхара удирдамж өгч байх болно гээд тэр хоёр явжээ. Кавасу тэднийг явсны дараа бүр балмагдав. Тэрээр гүнд амласнаа санаад «Яах гэж тэгж хэллээ. Эмчлэх боломжтой юм гэж хэлээгүй бол энэ даалгаврыг амархан биелүүлж болно. Гэтэл би гэж тэнэг амьтан амнаасаа болчихлоо. Ахмад тэр нэг өдөр намайг дуудаж,

цагдаагийн газрын шугамаар гадаадад байгаа япон иргэдийн адил эзэн хааны тангарагт үнэнч байна гэдэг баталгаа гаргуулж авсан учир ийм байж. Одоо тэгэхээр түүнийг зөрчиж болохгүй» гэж бодно. Кавасу ийнхүү элдвийг бодож сэтгэлээ түгшээсээр явтал долоо хоног өнгөрчээ. Гэтэл нэг орой Сойхара, Кавасутай уулзаад,

- Ишаа (эмчээ) та өөрийнхөө тангарагийн дагуу ажиллаж байна уу гэлээ.

- Сойхара сан, өвчнийг хороор хүндрүүлэх боломж гарахгүй байна. Сайнжаргал, Гэрэлээ хоёр өгсөн эм тариаг үргэлж шалгаж, хардаж сэрдээд байна. Нөгөө талаар гүн ч бас сэрэмжтэй байна. Ингэхээр тэдний сэжгийг арилтал жинхэнэ ёсоор нь эмчилж итгэл олох хэрэгтэй. Иймээс хугацаа нэлээн шаардагдана. Урьд өмнө уулгаж байсан эмийг солиход хаяг, өнгө, үнэрийг нь шалгадаг бололтой. Тиймээс уудаг эмтэй нь адил хор бэлдэх хэрэгтэй. Гэрэлээг байгаа цагт бидний ажил багагүй сунжирна шүү гэж Кавасу өөрийнхөө ажил төрлийн талаар учирлан тайлбарлав.

- Гэрэлээг гүнгээс холдуулж болно. Гэхдээ та өөрийнхөө ажлыг удаашруулбал ялтай шүү. Та тангараг өргөсөн самурай учраас эзэн хааны төлөө амь биеэ зориулах ёстой. Тиймээс манай армийн ажиллагаанд саад болсон бүхнийг самурайн ёсыг баримталж устгах хэрэгтэй. Энэ бол нүгэл биш! Та энэ бүхнийг бурхан тэнгэрийн зарлиг, эзэн хаан тэнногийн тааллаар хийж байгаа учраас танд гэм зэм байхгүй.

- Тай и (ахмад) Сойхара сан, арав хоногийн дотор би амжуулахыг бодъё. Гэхдээ Гэрэлээг холдуулах гэж яарсны хэрэггүй.

- Кавасу ишаа, эзэн хааны армийн бүх ажиллагаа манжуур руу чиглэж байгаа одоо үед наад хугацаа чинь удаан байна. Бид гүнг амьсгаа хураахаас өмнө түүний гэрээслэлийг бичиж авах ёстой. Гүн, удаан хугацаагаар амьд явахгүй гэдгээ мэдвэл гэрээслэлээ хэлнэ. Манай арми манжуурт орж ирэхээс өмнө тэр гэрээслэл бидэнд хэрэгтэй.

- Тай и, манай армийн цэрэг өнөө маргаашдаа манжуурт орж ирэхгүй. Манжуурын газрын зургийн судалгааг хийгээд удаагүй байна. Армийнхан газрын зураг дээр сургууль хийх хэрэгтэй. Тэгж байж жинхэнэ ажиллагаанд орно гэхэд Сойхара,

- Та энэ тухай яаж мэдсэн юм бэ? гэж шалгаав.

- Бээжингээс Мугдэнд ирсэн жуулчдын дотор цэргийн яамны жанжин штабын газрын зургийн хоёр хүнтэй би, Ямато буудалд дайралдсан юм. Би тэгэхэд Мугдэнгийн нэг эмчтэй уулзах гэж ирээд байлаа. Жуулчидтай хамт чиү са (дэд хурандаа) Исивари Канзитай явж байхад нь очиж уулзсан. Ингэхээр газрын зурагт шаардагдаж байгаа баримт бүрдүүлж яваа нь илэрхий байлаа. Одоо тэр зураг бэлэн болоогүй. Аягүй бол судалгааны ажил ч дуусаагүй байж мэднэ гээд цамцныхаа халааснаас тамхи гаргаж асаалаа. Энэ орой Кавасу гүнгийн дайлуулж нэлээн сэржимдсэн болохоор санаандаа орсон бүхнийг айлдах зүрх зоригтой болжээ.

- Жанжин штабын газрын зургийн удирдлагад ажилтай тэр хүн бол Бээжинд байсан манай цэргийн зохицуулах төлөөлөгчийн газрын нэг чиү жёо (хошууч генерал)-гийн хүү юм. Тэр

Бээжингийн их сургуулийн газар зүйн ангийг төгссөн газар зүйн зургийн мэргэжилтэй хүн. Эцэг нь багтраа өвчтэй. Манай талийгаач эцэгтэй сайн танил байсан хүн! Токиогоос Мугдэн, Харбингаар явсан тэр жуулчид энгийн хувцастай боловч ихэнх нь цэргийн мэргэжилтэнгүүд байсан юм гэлээ.

Кавасу, жуулчдыг төдий л их сонирхоогүй боловч Сойхарагийн саяын үгнээс сэжим авч манжуурт ирсэн жуулчдыг санангуут түүнийг армийнхан зохион байгуулсныг гадарлажээ. Харин

Сойхара бол Кавасугаас илүү сайн мэдэх болой. Японы цэргийн яамны сайд Угаки, Токиод үймээн дэгдэхээс өмнө тушаалаасаа сайн дураар огцроод Солонгост байгаа японы цэргийг удирдахаар явахын өмнөхөн Осака хотын ойролцоо байрласан 10 дугаар дивизээр дайрчээ. Энэ дивизийг манжуур руу чиглэсэн ажиллагаанд оролцуулахаар баталж, дивизийн дарга Сигэрү Хонзёо манжуур руу довтлох үед ёстой чухал чухал газруудыг эзлэх төлөвлөгөөний дагуу газрын зураг дээр тактикийн дасгал хийж, бэлтгэлээ хангаж байв. Жанжин штабаас Хонзёод өгсөн тэр газрын зургийг Манжуурт жуулчлах нэрийдлээр очсон дэд хурандаа Исивари Канзигийн хүмүүс хийсэн болой.

- Кавасу ишаа, би таны саналыг зөвшөөрнө. Тиймээс арав хоногийн дараа гүнгийн биед ямар нэг өөрчлөлт гарна гэж ойлгох нь зөв биз дээ. Би таны саналыг удирдлагад танилцуулна. Гэхдээ хугацааг яаж шийдэхийг тэндээс шийдэх тул би, танд урьдчилсан тойм хэлж байгаа юм гээд буцжээ. Сойхарааг явсны дараа Кавасу элдвийг бодлоо. Цэенгийн бие өдөр ирэх тусам сайжрах тийшээ орлоо. Тиймээс Кавасу, гүнд сэтгэл санааны дарамт үзүүлэхээр шийдэж, өвчин чинь хүндэрчихсэн учраас эмчилгээ авахгүй, түр зуур сайжирч байгаа гэдэг ойлголт төрүүлэхийг мэрийнэ. Цэен гүн, ямар нэг юманд сэтгэл нь зовоод өвчнөө үе үе асууж лавлахыг ажвал ер бусаар нас барахаас айж буй нь илэрхий байлаа. Тиймээс Кавасу сэтгэл санааны нь эмзгийг түгшээж ажиллах нь чухал гэдгийг мэдэж байлаа. Кавасу, шөнөжингөө бодолд дарагдаад Сойхараад амласан хугацаандаа амжуулахыг хэд хэдэн янзаар бодсон боловч бодож олсон аргуудынхаа алиныг хэрэглэхээ тогтоож чадсангүй. Тэгээд тухайн үед шийдэхээр зориглов. Кавасу, эзэн хааны арми манжуурт орж ирнэ гэдгийг мэдсэн боловч түүнд гүн ямар хамаатай болохыг бодоод олсонгүй. Тэгээд армийнхантай нууц холбоотой зүйлийг сонирхох хэрэггүй гэж бодно. Армийнхан хятад, манжуурын асуудлыг дайнаар шийдэхээр зэхэж байхад засгийн газар дипломат шугамаар дамжуулж хэлэлцээгээр зохицуулна гэсээр олон жил болсон атал амжилтанд хүрээгүй учраас засгийн газар, арми хоёр эхнэрээ булаалдсан харчуул шиг бие биенийхээ үйл ажиллагаанд дайсагнана. Тэгээд өдөр ирэх тусам армийнхан хүчээр давамгайлж байгаа болохоор Кавасу айна. Кавасу цаг үеийн уур амьсгалыг цэгнэж, түүний аяыг дагаж чаддаг болохоор Цэен гүнгийн өвчнийг сэдрээхийг хичээж өдөрт хоёр удаа үздэг болжээ. Гэвч эгзэгтэй цаг болоогүй байлаа.

Цэен биеэ сайн хоновол өглөөний цайны дараа ярьж хөөрөх дуртай учраас Кавасу өглөөний цайны дараа гүнгийн биеийг үзнэ. Харин бие нь барагтай бол толгой сэгсрээд хөмсөг зангидан сэрдэмтгий ажигч нүдээр Кавасуг хяламхийн ширтэж, сэтгэл санааг нэвт тольдох мэт ажна. Тиймээс Кавасу өглөөд Цэен, Гэрэлээ хоёртой мэндлэнгүүт царайны нь байдлыг ажаад биеийн нь байдал ямар байгааг мэднэ.

Кавасу гаднаас орж ирээд гүнгийн царайг ажиглангуут бие нь тааруухан хонож гэдгийг

мэдлээ. Түүнийг гаднаас орж ирэхэд хамгийн түрүүнд Сувдаа инээмсэглэн угтдаг билээ. Гэтэл энэ өдөр Сайнжаргал эмчийг угтахдаа давхраатай алаг нүдээ эрээлжлүүлэн харсан нь «Та яасан орой ирэв дээ» гэсэн шиг зэмлэнгүй байв.

Кавасу хана руу харж хэвтсэн Цэенгийн орны дэргэд суутал тэрээр эмч рүү эргэн хэвтэхдээ царайгаа үл мэдэг ярвайлгав. Тэгээд уртаар санаа алдаад амьсгалахдаа уруулаа тас зуусныг ажвал өвчиндөө тэсэж ядсан нь илтээ. Кавасу гүнгийн биеийг үзээд,

- Бөөр чинь бүр сайжирсан болохоор бие чинь гайгүй болжээ. Сайнжаргалаа, жаахан халуун ус аваад ирээч гэхэд Сайнжаргал өрөөнөөс гарлаа. Кавасу гүнгийн сэтгэлийг хямруулах эгзэг гарсныг ойлгоод,

- Цэен минь эмчийн хувьд чамтай ярих зүйл байна. Таны өвчин нарийн гэдэг нь гарцаагүй. Тэгэхдээ ганц дан өвчин биш. Ходоодны чинь хавдар нэмэгдсэн байна. Тэгэхээр ерийн хавдар биш. Магадгүй хортой хавдар байж болно. Түүнээс одоо ходоод чинь сайжрах болсон баймаар. Гэтэл сайжирч чадсангүй. Энэ бол хорт хавдар байгааг гэрчилж байгаа хэрэг! Хорт хавдрыг одоохондоо анагаах ухаан эмчилж дийлэхгүй байгаа юм гэж яриагаа зугуухан эхлэв.

- Кавасу ишаа, тэгвэл одоо эмчилгээгүй гэсэн хэрэг үү?

- Цэен минь эр хүн нэгийгээ хуурч болдоггүй юм. Үнэнийг хэлэхэд одоо өвчнийг чинь хүчтэй өвдсөн үед өвчин намдаах

эмчилгээ хийнэ үү гэхээс эдгээж дийлэхгүй. Одоо чинь өвчин бүхнийг анагааж чадахгүй байна шүү. Тэр тусмаа ходоодны хорт хавдрыг яаж ч чадахгүй байгаа гэж хэлэхдээ Цэенгийн сэтгэлийн эмзгийг хөдөлгөж чадна гэдэгтээ итгэнэ.

- Манайхан удмаараа нарийнтаж байгаа юм. Харин тэр хорт хавдраар чинь өвдөж байгаагүй гэхэд Кавасу,

- Хорт хавдар дотор эрхтэнд тарчихвал яах ч аргагүй. Чиний бөөр элгэнд чинь нөлөөлчихсөн байна. Сүсэгтэн хүн бол хойд насныхаа зам мөрийг боддог. Чи төрийн хар хүн болохоор одоо сэтгэлээ барих хэрэгтэй. Ганц охиноо зовоох хэрэггүй гэж хэлэх нь хэдийгээр өрөвчхөн сэтгэлийн илрэл боловч «Чи тэртэй тэргүй өнгөрсөн хүн. Хурдхан зоволгүй үхсэн дээр» гэж хэлэх шиг санагдах аж. Кавасуг явсны дараа Сайнжаргал Сувдаа хоёрыг орж ирэхэд гүн хана руугаа хараад хэвтэж байлаа. Цэен элдвийн бодолд дарагдсан болохоор Сайнжаргал, Сувдаа хоёрыг орж ирснийг мэдсэнгүй. Сайнжаргал эцгийнхээ дэргэд ирж суухад Цэен сая охин руугаа эргэн харлаа. Эцгийн нь царай цайгаад зовхи нь унжиж, харц нь өөрчлөгдсөнийг ажсан Сайнжаргал,

- Аав аа, таны бие яагаад байна вэ? Өчигдрөөс хойш царай чинь хачин болчихлоо. Дуу шуугүй болохоор чинь айх юм гэхэд,

- Аавын нь бие барагтай байна. Гэхдээ айх хэрэггүй. Би жаал зугаа юм бодлоо гэснээ Сайнжаргалын сэтгэлийг зовоохгүйг хичээж,

- Аав нь Наран улсын армийн тухай бодсон юм. Зовох хэрэггүй гээд өөрийнхөө үгийг итгүүлэх гэсэн шиг яриагаа үргэлжлүүлэв.

- Японы засгийн газрыг хүрээлсэн улс төрийн гурван нам, хоорондоо таарамж муутай, бие биендээ тэрслээд байдаг болжээ. Ингэхээр удахгүй цэргийн эргэлт гарч магадгүй юм. Японы бага дарга нарын үймээн идэвхжиж, манжуурыг хятадаас тусгаарлаж, биеэ даасан улс болгох гэсэн цэргийнхний шаардлагыг эзэн хаан дэмжээд байгаа. Ерөнхий сайд армийнхны сүрдүүлгээс айсандаа цэргийн төсвийг нэмсэн. Ингэхээр удахгүй японы цэргүүд манжуурт орж ирнэ.

- Аав аа, японы армийнхан манжуурыг хятадаас тусгай улс

болгож чадах уу? Энэ есөн жил япончууд хятадын улс төрийн хэрэгт оролцож, яс булаалдсан нохой шиг үр ашиггүй хэрэлдлээ. Тэгээд эзэн хааны замнал кодоог хятадад дэлгэрүүлж чадаагүй. Одоо манжуур гээд байна. Естой зангууны ноос түүгээд эсгий хийнэ гэгчийн үлгэр болж байна даа. Анхандаа Азийн ард түмнийг сэргээн соёлжуулна гэдэг уриа дэвшүүлсэн. Түүнийгээ хятадаас эхлэхээр шийдсэн. Одоо болохоор манжуурт дэлгэрүүлнэ гэдэг боллоо. Аав аа, хоёр туулай хөөсөн анчин хоосон үлддэг жамтай. Та ардын засгийг устгаад хуучин засаг төрөө тогтооно гээд хүний газар ингэж зовж явдаг эцэстээ юу үзэх бол доо. Одоо та чинь хөгшин хонины насгүй болоод байна.

- Сайнжаргалаа, ирэх жил японы сайд нарын танхим, армийн гарт орохгүй бол японыхон Манжуурт тусгаар улс байгуулж чадахгүй. Тэгэхээр бидэнд далайн чанадад гарах нь ашигтай. Миний бие сайжраадахвал учиртай.

- Аав аа та дэмий юмаар өөрийгөө шаналгаад байна. Би таны бодолд итгэхгүй. Анхандаа Богд хаант улсыг сэргээнэ гээд байсан. Дараа нь нэгдсэн монгол улс байгуулж ерөнхий сайд болох гэж зүтгэсэн. Сүүлдээ Дайчин вангийн хошуу, Буйр нуурт үйлдвэр байгуулж Хайлар-Буйрын хооронд төмөр зам тавиулж, Азийн Та Да пүүстэй хорших юм болсон. Одоо болохоор Америкийг бараадна гэдэг ч юу бол! Ер нь та, наад хоосон бодлоо орхиж, биеэ бодсон дээр шүү гээд Цэенгийн өрөөнөөс гарахад гүн дэргэдээ зогсож байсан Сувдаа руу эргэж хараад,

- Миний охин очиж эгчээ тайвшруул гээд хаалга руу толгой дохив.

Цэен Сувдааг гарсны дараа өрөөндөө ганцаараа үлдэхдээ «Тиймээ... Би ганцхан биеэ бодох хэрэгтэй. Одоо насгүй боллоо. Тэгэхээр ганц охиныхоо хувь заяаг боддог хэрэг. Арга ухаан, авхаалж самбаа сууж чадсан бол одоо хэнээс ч дооргүй амьдарч алт эрдэнэсээ арвижуулаад байж чадна. Ер нь бүсгүй хүн, улс төрийн бодлоготой зууралдахгүй байвал дээр! Бүтэхгүй юмны хойноос хөөцөлдөөд хар толгойгоо алдана. Ер нь ганц шулуун бодолтой байхыг ой тойнд нь ортол хэлж өгөх хэрэгтэй! Эртхэн нутаг орныг нь бараадуулах уу? Гэтэл энэ алтыг яах вэ?. Алт... алтаа хүний хоол болгож болохгүй. Охиныг минь очихоор алтыг

хурааж аваад, аягүй бол шоронд хийнэ. Тэгэхээр алтаа хүний хоол болгож болохгүй. Хүний нохой идэхээр өөрийн нохой идэг гэдэг үгтэй. Алттай байсан цагт миний охин газардахгүй» гэж бодоод орноосоо өндийж дэрэн доороо байдаг янжуураа тэмтэртэл тэр алга болжээ. Түүнийг Гэрэлээ хурааж аваад нуусан гэдгийг Цэен мэдэж байв.

...Манай удам төрийн төлөө зүтгэж яваад хүний нутагт ясаа тавьдаг тавилантай. Нэгэнтээ ардын засгийг устгаж чадахгүйгээс хойш охины хувь заяаг боддог хэрэг. Гэрэлээ зовлон үзсэн болохоор охинд минь тус болж чадна. Тиймээс охиндоо улс төрийн асуудалтай орооцолдож болохгүй гэдгийг нь сэнхрүүлж өгөх ёстой! Нэгэнт энэ алтны буяныг би даахгүй хойно үүнийг хувиргаж доллар болгох хэрэгтэй гэж бодож хэвтгэл гаднаас Гэрэлээ орж ирлээ.

Мугдэн хотын нэг онцлог бол өдрийн цагт гудамж, талбайгаар нь хүн хөлөг сүлжилдэн, шөнийн цагт толгой хоргодох юмгүй, нүцгэн гуйлгачингууд хүн хөлгийн холхиж байсан гудамж талбайг түр эзэгнэн, улигт шөнийн уртыг өнгөрөөхийн тулд хүйтэн чулуун дээр хэвтэж, сүүжээ холгосоор үүр хаяармагц тал тал тийшээгээ сарнидаг болой.

Ган хигээс бүхий өндөр дугуйтай тэргэнд зүтгэдэг адгуусны оронд өөрийгөө хөллөсөн хүн хөлөг, хавар намрын цас бороонд шавшуулж, Ляо мөрний жихүүн салхинд нүүр нүдгүй нүдүүлсээр хотын гудамжийг хэрэн гүйж, бор ходоодоо тэжээх сохор зоос олдог агаад хавар намрын элч муутай жихүүн жаврыг үл анзааран, ягаарч улайсан хөрстэй хөлийнхөө сайртай тавхайг чинэрч ягаартал шогшихдоо дааран чичрэхийг үл ойшооно. Тэд хайлган зуны халуун наранд гандан хөхөрч, харлаглаа зүтгэхдээ хөлсөндөө нэвт цохиулснаа сэврээх төдийхнөөр биеийн чилээг гаргаж, хатаж омголтсон уруулаа хэлээрээ долоосон болж амны цангааг гаргаж заншсан болой. Нарийхан ган хигээстэй суудлын

тэрэгний арлаас шөрмөслөг гарынхаа судсыг гүрийтэл атгасан өндөр нуруутай, гонзгой царайтай нэг залуу өргөн гудамж уруудан, шавар шавхай туучуулан гүйсээр гүнтний хэрмэн хашааны ногоон паалантай гоёмсог дээвэр бүхий даамангийн явган хаалганы дэргэд зогсохыг завдана. Хүн хөлөг, нүцгэн хөлийнхөө тавхайг жийсхийн гэдийж, ар нуруу руугаа түлхсэн тэрэгний хүчийг сааруулж, хурд хасан зогсохдоо тэрэгний арлаас зуурсан гарынхаа атгалтыг чангаруултал туранхай хатангир царайны шанаа, гүрээний судас бүдүүрэн чинэрэхийг ажваас аварга могойн соролтоос мултрахыг хичээсэн өчүүхэн амьтан эцсийнхээ хүчийг шавхан амь тэмцэлдэхийг санагдуулам ажээ.

Хүн хөлөглөсөн тэрэгний суудал дээр тухлан суусан Сойхара, тайрдас шиг намхан биетэй, бүдүүн эмч Кавасу хоёр зорьсон газраа ирснийг мэдээд тэрэгнээс буунгуут, нүүрээрээ чийхарсан хөлсөө арчаад, зогсож байгаа хүн хөлгийн алган дээр ганц зоос чулуудсан Сойхара, хэрмэн хашааны даамангийн явган хаалгаар орж усанд хаясан чулуу шиг алга болов. Улайрч ягаарсан алган дээрээ байгаа шаргал өнгөтэй зоос өнгө булаалдах мэт гялтганахыг харж, шүүрс залгисан хүн хөлөг, уур хилэн бадарсан нүдээр хашааны дааман хаалга руу ширтэхийг ажвал наран эздийн хайрласан сохор зоосыг үл тоосон түүний бие сэтгэлийн хорслыг ундруулсны тэмдэг болой...

Өндөрдүүхэн гоолиг биетэй, хорь гаруйхан насны махлаг цагаан царайндаа нэгэн үзэмж нэмсэн, тал дугуй хэлбэртэй өтгөн хөмсөгний доор гялалзсан, сэргэлэн бор нүдээрээ үргэлж инээмсэглэж явдаг Сувдаа байшингийнхаа хаалгыг нээж гийчдийг угтлаа. Сойхара эмч хоёрын хэн хэн нь ч Сувдааг үл тоомсорлон, шаргал өнгөтэй, царсан шалны хивс даган, луу ороосон сийлбэртэй, зандан хашлага бүхий шатны хивсэн дээгүүр хөнгөн алхсаар дээд давхарт гартал, тэднийг Сайнжаргал тосон угтлаа. Эрхэмсэг зантай Сойхара, эмч хоёр Сайнжаргалын бараанаар шатны гишгүүр дээр зогсон тэргүүн бөхийлгөн хүндэтгэхдээ шатны гишгүүр мөргөчих шахахыг харваас хөрөнгө чинээ харж бөхөлздөг зуйрган хорвоогийн

хөг аясыг дагаж сурсны тэмдэг болой.

Дунд зэргийн нуруутай гуч хэрийн насны, гурвалжин гонзгой

царайндаа зохисон хаш шиг өнгөтэй цав цагаан шүдний хоёр соёог алтаар бүрээд, хоёр нарийн хуруунд ягаан бадмаараг шигтгээтэй алтан бөгж зүүсэн бүсгүй инээмсэглэн зогсоно. Сойхрагийн ихэмсэг царай нүд ирмэхийн зуур хувиран, зусар бялдууч хөг аяс илэрснийг ажаад Сайнжаргалын сэтгэлд «Симотогийн сүүдэр ямар хэргээр аавтай уулзах гэж яваа бол» гэдэг бодол төрлөө.

Сойхара, жанжин штабаас тусгай даалгавар авсан хурандаа Тозияагийн итгэлтэй шавь Симотогийн үгийг бодсоор Сайнжаргалын дэргэд ирэнгүүт, нимгэн хөрстэй цагаавтар царайгаа мэлтийлгэн,

- Сайнжаргару сан, таны амрыг эрье гэж долигоносон янзтай мэндлэв.

- Сойхара сан, та манайд ирдэг мөн сайхан завшаанаа. Кавасу ишаа, та чинь Сойхара санг хаанаас олоод ирэв ээ? гэлээ.

- Сайнжаргару сан, энэ хүнийг олоход бэрх боловч гүнгийн нэрийг сонссон ямар ч хүн, өөрөө хүрээд ирдэг шүү гэж эмч учир байдлыг тайлбарлав. Сайнжаргал тэднийг ирсэнд билэгшээсэн янзтай инээмсэглэсээр,

- Тэгвэл та нар чинь аавын минь урилгаар заларч яваа хэрэг үү? гээд тэднийг зочдын өрөө рүү дагуулан,

- Хиаку сан ва, эрхэм зочид минь, ийшээ морилооч гээд Сайнжаргал том царсан хаалгыг нээж, найрсгаар хэлээд зочдыг өөрийнхөө түрүүнд оруулав.

Сойхара, гүнтэй уулзаж байсан агаад алтанд туйлсан гүн гэгддэг Цэенгийн босгыг алхаж үзээгүй болохоор зочдын өрөөний үүдээр алхангуут, уужим өрөөний ханын дагуух шилэн хоргонд буй хэн хүний сэтгэлийг булаасан уран сийлбэртэн мөнгөн аяганы дундах дөрвөн алтан аягыг хараад гайхан бишрэхийн эрхэнд хөтлөгдөн, сэтгэлд нь шохоорхлын дөл улалзахын шидийг ухаарлаа.

Сойхара, хивс дэвссэн диван дээр суунгуут, өрөөний голд шахам зассан дун цагаан гантиган хашлагатай, дөрвөлжин хэлбэртэй усан оргилуур дотор бүлтгэр нүдтэй янз бүрийн өнгөтэй тао хэмээх загаснууд цацган сүүл сэлүүрээ уран хөдөлгөн сэлэхийг шохоорхон ширтэнэ. Сайнжаргал ханын шүүгээнээс тамхины үнс хийдэг болор сав, америкийн «манчестер» хэмээх ховорхон үзэгддэг янжуур авчирч ширээн дээр тавиад,

- Сойхара сан, тамхи тат. Би та нарыг ирлээ гэж аавд дуулгаадахья. Өглөөнөөс хойш өвчиндөө эмзэглээд уур уцаартай байгаа гээд эцгийнхээ өрөө рүү эргэв. Сойхара, Кавасу хоёр Сайнжаргалыг хүлээж дуугүй суухдаа хааяа цагаан царсан хаалга руу ширтэнэ. Чингэж хэдэн мөч өнгөртөл хаалга алгуурхан нээгдэж Сайнжаргал гарч ирээд,

- Аав та хоёрыг өрөөндөө урьж байна гэлээ. Гүнтэн хар минчүү тэрлэг өмсөж, орон дээрээ суусан агаад хажуудаа зааны ясан сийлбэртэй таяг тавьсныг харвал тэрээр таяггүй явж чадахгүй болсныг гэрчилнэ. Цэен гүнгийн орны эсрэг талд хананд шахсан ширээн дээр чихэр жимс, сакэ тэргүүтнийг өрсөн байлаа. Тэрээр зочдоо хүндэтгэн суулгаад ойр зуурын юм лавлаж асууна. Чингэж эхэлсэн зочлолт нэлээн удаан үргэлжилж Цэен гүнгийн сэтгэлийг догдлуулсан яриа үргэлжилсээр байв. Цэенгийн дэргэд суусан Сайнжаргал зочдын ярианы дагуу хоосорсон хундагыг сакэгээр дүүргэж, далайн ногоогоор амталсан зууш тэргүүтэнд амтархсан хоёрын яриа улам ундарна.

- Сойхара сан, та хундагатайгаа бариач гэж хэлсэн Сайнжаргал өөртөө жимсний шүүс аягалав.

- Та бүхэн аавыг минь өвчнийг эдгээх талаар их санаа тавьж боломжтой бүхнийг хийсэн ачийг би хэзээ ч мартаггүй. Та бүхний хүсэл мөрөөдөл биелэх болтугай. Кампай гээд Сайнжаргал хундага өргөв. Цэен гүн биеэ муудангуут Тозияаг Тяньжингаас дуудуулья гэж боддог удаатай. Харин биеэ сайн байгаа үед Симототой уулзаж манжуурын талаар ярих дуртай. Тэгээд Кавасугаар Симотоог дуудуулдаг заншилтай. Симото хэд хоногийн өмнө Долнуур руу явсан учраас Сойхара морилон ирсэн аж. Симото, Долнуур руу явахдаа Сойхараад албан үүргийн дагуу удирдамж өгсөн болохоор гүнтэй уулзаж яриаг тогтоож, түүний санаа бодлыг тольдохыг хичээх ажээ. Тиймээс Сойхара өөрийнхөө яриагаар гүнгийн сэтгэлийн эмзэг бүхнийг хөндөхийг бодно.

- Цэен сан, монголоос хэд хэдэн хүн ирж банчин эрдэнэтэй холбоо тогтоохоор Долнуур руу явсан байна. Ер нь газар бүр улс төрийн уур амьсгал урьд урьдаасаа мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байна. Манай армийн хувьд гэвэл манжуурыг хятадаас тусгаарлах асуудлыг энэ онд багтааж шийдэх нь гарцаагүй болсон гэж ярьдаг боллоо гэж яриагаа эвтэйхэн ундруулна.

- Монголоос хятадад ирсэн хүний тоо багадаагүй. Тэдний зарим нь Жан Золинтой сүүж холбох гэж баахан

дүвчигнэсэн. Одоо зарим нь түүний хүү Жан Сюэляныг царайчилж байгаа сурагтай. Гэтэл Жан Сюэлян, монгол руу гар сунгах нь байтугай өөрийгөө яая гэж байна. Тэгээд аргаа барж мухардаад одоо Чан Кайшигийн уяаны нохой болчихоод японы армийг гоочлох далим хайгаад байна. Харин банчин эрдэнэ японы армийг түшвэл өөр хэрэг!

- Цэен сан та, тун голыг нь олоод хэлчихлээ. Монгол дахь улааны нөлөөг устгаад Богдын хойд дүрийг тодруулбал хаант улсаа сэргээгээд зогсохгүй улмаар Их Монгол гэдэг нэгдсэн улс ч байгуулж болно. Энэ бүхэнд манай арми тусалж чадна. Харин шар сахалтын (Семеновын) оролцоог бодож түүний хүчийг зузаатгах нь чухал. Хүрээнд оросууд их байдаг. Тэд бол сахалтын үгнээс зөрөхгүй, итгэлтэй хүмүүс. Тэгээд ч манай арми, манжуурыг тусгаар улс болгохын өмнө тэд багагүй юм хийж чадна. Ганцхан тэдний ажиллагааг олигтойхон дэмжих нь чухал гээд Сойхара, сакэ балгав.

- Шар сахалт хорлон сүйтгэх, бусниулан үймүүлэх ажлаас хэтрэхгүй байна. Эзэн хааны цэрэг манжуурт орж ирээгүй цагт тэд юу ч хийж чадахгүй. Би одоо манжуурт эзэн хааны цэргийг орж ирэх цагийг хүлээж байна. Тиймээс наран улсын армид саад болсон Жан Золинг цааш

харуулах «Хар төмөр» гэдэг ажиллагааг дэмжсэн Жан Золингийн учрыг олчихвол наран улсын армийг манжуурт ороод ирнэ гэж бодсон. Гэтэл одоо хүртэл сураг чимээгүй гэж гүн уцаарлангуй хэлэв. Сойхара, гүнг уурлуулж болохгүй гэдгийг мэдээд дээрээс өгсөн удирдамжийн дагуу зарим нууцыг цухуйлгаж, гүнгийн сэтгэлийг тайтгаруулахыг мэрийв.

- Ерөнхий сайд Вакацуки, одоо эзэн хааны замналыг Их газар тогтоох «мусуби авасу буюу нэгтгэх» ажиллагаанд шаардагдах ихээхэн хөрөнгийг батлуулсан нь багагүй найдлага төрүүлж байгаа юм.

- Сойхара сан, сангийн яамны сайд Иноуэ хойтон жил японы эдийн засагт төдийгүй улс төр, армид гарсан харанхуй ангальг битүүлчих хөрөнгө гаргахгүй бол яана? Одоо Иноуэ төсвөөс армид

нэмж өгчихөөд хөрөнгөтний намууд болон үйлдвэрийн эздийн шүдний чигчлүүр болж байна. Түүнийг Хар луу нийгэмлэгийнхэн өршөөхгүй. Тэгэхээр Вакацукигийн танхим хоёр үзүүртэй тэвнэнд шорлуулчих шахаад байгаа учраас Манжуурын асуудлыг шийдэж чадахгүй ацан шалаанд орчихоод байгаа.

- Цэен сан, би тан шиг холыг хардаг мэдлэгтэй хүн биш. Би ганцхан зүйлийг мэднэ. Энэ жил ямар ч гэсэн эзэн хааны арми манжуурт тусгаар тогтнол олгохоор шийднэ. Арми ч өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийнэ, би худлаа яриагүй. Тиймээс та миний үгэнд итгэх ёстой. Таны бичсэн айлтгалыг эзэн Хирохито тухайн үедээ сайшаасан. Тэгэхээр залуу эзэн хаан Хирохито, таны айлтгалыг анхааралдаа авна гэж Сойхарааг хэлэхэд Цэен,

- Наран улсын арми, монголд Богд хаант төрийг тогтоож улааныхныг дарвал би хөрөнгө хайрлахгүй. Энэ найман жил миний бодол бага зэрэг өөрчлөгдсөнийг армийнхан гадарлаж байгаа. Энэ бол надаас шалтгаалсан зүйл биш. Гуаньдунгийн цэрэг Ляодунгийн булангаас хөдөлж чадалгүй өдий хүргэсэнтэй холбоотой. Гэхдээ би анхныхаа бодлоос ухраагүй байна. Хэрвээ чиний ярьсан бүхнийг биелүүлж, бодит зүйл болж чадвал би оросын дүрвэгсдийн товчоог санхүүжүүлж чадна. Харин энэ асуудал урьдын адил зогсонги үргэлжилбэл цахилдаг үргэлж ногооноороо байдаггүй гэдгийг санаж байх хэрэгтэй гэв.

- Тиймээ тан шиг баян хүн америкийг бараадаад хэдэн үйлдвэрийг нэгтгэсэн саятан болох нь дээр. Харин монголчууд хүний толгой дээрх өвсийг харахаас өмнө өөрийнхөө цоорхой дотоожийг анхаардаг шүү дээ. Далайн чанадад гарч хатуу хоол хайснаас эндхийнхээ дэл сул зүйлийг хүлхвэл хамаагүй дээр! Далайн салхи хөдөлбөл ёроол руу нь живчихнэ. Үгүй дээ дээрэмчин гэдэг гайхлууд юмны үнэр авахдаа сайн. Тэгснээс Буйр нуурт загасны үйлдвэр байгуулж, Халхын голын савыг эзэмшвэл унац нь их шүү гэж гүнг худлаа ятгахдаа эчнээн дэх санаагаа мэдэгдэхгүйг хичээнэ.

Сойхара ингэж хэлээд сакэ балгахдаа Симотогийн хэлсэн үгийг саналаа. Тэрээр Долнуур явахын өмнө Сойхаратай уулзаж ярилцахдаа «Гүн Мугдэнд ирснээсээ хойш их гүрний банкныхантай ойртохыг эрмэлздэг болсон нь худалдаачдыг

түших санаатай байгаагийн шинж. Энэ явдал түүний сэтгэл шинэчлэгдсэний баталгаа. Тиймээс сэтгэлийн нь зөрчлийг барьж ярилцахдаа монгол хүн монгол нутгийнхаа баялгийг

эзэмших ёстой гэдэг сэтгэл төрүүлэх хэрэгтэй. Нөгөө талаар чи гүнтэй уулзах бүртээ оросын дүрвэгсдийн товчоонд хөрөнгө өгөх эсэхийг мэдэх нь чухал. Эцэст нь өөрийнх нь хадгаламж английн банкинд уу америкийн банкинд уу гэдгийг ажиглах хэрэгтэй» гэж билээ.

- Би саятан болоход нэлээн хэдэн жил хэрэгтэй. Та нар манжуурыг хятадаас тусгай улс болгох гэж цаг үрсэнтэй адил удаан үргэлжилж мэднэ. Гэтэл би чинь эмгэг өвчний харгайгаар хонины насгүй болоод байна. Наран улс манжуурыг хятадаас тусгаарлаж, дорнод хятадын төмөр замыг улаан оросоос салгачихвал би хөрөнгө нийлүүлж хорших санаатай байна гэж гүнг хэлэхэд Сойхара, гүнгийн амнаас дуулах ёстой үгээ сонссондоо олзуурхаж уулзалтыг «өндөрлөхөөр» шийдэж, эмчтэй тохирсон ёсоор нүдээ ирмэж дохио өглөө. Сойхара, гүнгийн сэтгэлийн бодол санааг мэдэж чадвал өвчнөө хүндэрсэн үед юу гэж гэрээслэхийг багцаалах боломжтой гэж үзнэ. Гүнгийн дотоод ертөнцийн зам мөрийг чингэж мэдэх аргыг Тозияа өөрийнхөө шавьд даатгасан атал хүний гараар могой барьж сурсан Симото, өөрийнхөө гүйцэтгэх үүргийг Сойхараад оноосон ажээ. Кавасу, Сойхарагийн хэрэг бүтсэнийг мэдэнгүүт,

- Ноёдоо, та хоёр хэтэрхий их ярилаа. Цэен минь одоо амарсан дээр. Ингэж их удаан ярьж болохгүй. Биеэ бодохгүй гам алдвал хэцүүднэ шүү гэхэд Сайнжаргал эцгийгээ амрахыг шаардлаа. Чингээд Кавасу, гүнгийн биеийг үзэхээр завдахад Сойхара гүнгийн өрөөнөөс гарч зочдын өрөөнөө орлоо. Сойхара, эмчийг хүлээж суухдаа «Гүнтэн, оросын дүрвэгсдийн товчоонд хөрөнгө өгөх найдвартай юм байна. Дорнод хятадын төмөр замыг Манжуурт салгаж өгвөл гүнтэн хувь нийлүүлэх нь гарцаагүй хэрэг! Ингэхээр энэ талаар гэрээслэл бүхий баталгаа гаргаж өгөх нь эргэлзээгүй. Энэ ярианд Сайнжаргал биеэрээ байсан нь олз боллоо. Тэгэхээр илтгэх хуудсаа дорвитойхон бичих хэрэгтэй» гэж бодно.

Кавасуг гүнгийн өрөөнөөс гарч ирэхэд Сойхара сэтгэлдээ

«Гүнгээс баталгаа гаруулж ав гэж надад тушаах юм бол би ч нүд ирмэхийн зуур гүйцэтгэж чадна. Тэгвэл надад шүү са, (хошууч) цол хайрлаж дэвшүүлнэ байх. Тэгэхээр илтгэх хуудсаа Симотоод биш харин Тозияагийн нэр дээр бичвэл болох нь тэр» гэдэг нэгэн үзүүргүй бодолд захирагдав.

Сойхара, хэрмэн хашааны хаалгаар гарангуут эсрэг талд зогсож байсан хүн хөлгийг хараад «Сайнжаргал дуудуулж бэлдсэн юм байх даа» гэж бодоод гараараа даллахад хүн хөлөг тэдний дэргэд хүрч ирлээ.

- Кавасу сан, одоо таны ажиллагаа эхлэх цаг болсон шүү гэхэд эмч, хүн хөлөгт суух зуураа,

- Би өөрийнхөө үүргийг ойлгоод ажлаа эхэлсэн. Хэд хоногийн дараа үр дүн нь гарна гэхэд Сойхара,

- Энэ бол миний өгсөн үүрэг биш, Ямагогийн хөвгүүд Зинмү бурхны зарлигаар эзэн хааны замналыг манжуур, монголд тогтоох хэрэг явдлыг түргэтгэх бусидо цэрэг эрсийн замналыг хурдавчлах хариуцлагаас үүссэн та бидний зорилго гэж самурайн ёсыг дурдлаа.

Төмөр цагаагчин хонин жилийн (1931 он) зуны эхэн сар өнгөрөөд Цэенгийн бие муудаж, заримдаа өвчнийхөө шаналгааг даалгүй үе үе ухаан алдана. Харин сүүлийн хоёр хоног ходоод

нь шархирахгүй амсхийсэн атал гүнгийн сэтгэлд олон зүйл хямарч түгшээнэ. Цэен үхэхээс айсангүй. Тэрээр Кавасу эмчтэй ярилцаж, өөрийнхөө өвчнийг эдгэхгүй гэдгийг сонсохоос өмнө тоймолж байсан. Харин Кавасугийн үгэнд итгэж «Энэ чинь үнэнийг нь хэлчихлээ» гэж бодсоноос хойш сэтгэлд үл мэдэгдэх нэгэн аймшиг эргэлдэнэ. Тэрээр алтандаа хоргодож, мухар сохор сүсэг бишрэлийн гайгаар өөрийгөө шаналгаж байгаагаа үл ухаарна. Цэен ерийн нэг, сүсэгтний ёсоор хойд насандаа тамд унахгүй, хүн төрөлдөө эргэж төрөхийг мэрийх тул мэргэч төлөгч хүмүүсээр хойд насныхаа зам мөрийг үзүүлсэн. Нэгэн үзмэрч хүн түүнийг «Цагаан хэл аманд өртсөн тул барцад ихтэй» гэж айлдсан болохоор түүнд эргэлзсэн гүн Гэрэлээг нэгэн мэргэч хятад руу явуулжээ. Гэрэлээ нөгөө өрөөнөөс орж ирэхэд Цэен,

- Гэрэлээ чи өнөө хүнтэйгээ уулзав уу? гэлээ.

- Уулзлаа. Бас тэгээд үзэмчний цагаан даяанч гэж алдаршсан нэг хүнтэй уулзлаа. Тэдний хэн хэн нь чамайг өнгөтэй үнэт эдлэлийн хорлол болсон учраас түүнийг зүс хувилгаж, чанарыг нь алдагдуулахгүй байвал дээр гэж байна.

- За тийм ч байхаа даа. Бие биенээ танихгүй гурван хүн ингэж адилхан айлддаг явдал жирийн тохиолдол биш. Гэрэлээ, Сайнжаргалтай ярьж, Богд гэгээний бүтээлийн сүм рүү хүн явуулж улаан сахиус хуруулж, аврал гүрэм хийлгэхийг бод! Ер нь богдын алтыг доллар болговол өнгө зүс хувиравч, чанар нь төдий их алдагдахгүй байх. Ер нь чи юу гэж бодож байна даа гэж асуугаад Гэрэлээгийн царай өөд ширтэнэ.

- Цэен минь чи, энэ алтыг монголчуудыг хүйс тэмтрэх, монгол орны баялгийг цөлмөх дайснуудын гарт өгч болохгүй. Ямар нэг аргаар монгол руу буцаачих! Тэгвэл энэ өвчин, хэл ам, атаа жөтөөнөөс сална. Тэгэхгүй бол амь насаа ч алдаж мэднэ. Бид амьдраад байх хөрөнгөтэй шүү дээ. Чи хуучин засаг төрийг сэргээнэ гэдэг чинь монгол орныг цөлмөж байсан манжуудын ноёрхлыг японыхоор солино гэсэн үг! Япон, Богд Чингэсийн үеийн нэгдсэн монгол улс байгуулна гэдэг нэрийдлээр ар өвөр монголыг хятадаас тусгаарлаад, өөрснөө дангаараа эзэгнэх гэсэн цэрэг, улс төрийн бодлого шүү гэж учирлан хэлэхэд Цэен,

- Гэрэлээ, Баатар ахтай үүнээс болж муудалцаж билээ. Ахыг өөдөлснөөс хойш янз янзаар бодож үзлээ. Би их нүгэлтэй хүн гэдгээ мэдэж байна. Тиймээс нутагтаа очих нүүргүй хүн! Харин Сайнжаргалын хувьд гэвэл түүний хувь заяаг би баллачихлаа. Сайнжаргалыг нутаг руу буцаах гээд хэрэггүй. Намайг ийм байдалтай байхад хүний нутагт хаяад явахгүй нь мэдээж. Ер нь хожим хойдын өдөр бие сайжрах аз дайрвал тэр хоёрыг буцааж явуулна. Харин чи минь яах билээ дээ.

- Чи бид хоёр бурхны ерөөлөөр учирсан болохоор хамт байх ёстой.

- Гэрэлээ чи, өөрийнхөө бодлоос айхгүй байна уу?

- Цэен минь одоо юунаас айх вэ? Айж яваад амьдралаа оронцоглосон. Одоо самурай нарын ясыг мэдсэнээс хойш айж үхэхээр, алалдаж байж үхсэн минь дээр шүү дээ гэж сэтгэл шулуудсан зоримог янзтай хэллээ.

Гэрэлээ өөрийнхөө эчнээний хорсол өшөө хонзонг ямар ч үед

самурай нараас авч чадах атал Цэенгийн амь насанд сэтгэл түгшээд, цагийн байдлыг хүлээнэ. Гэрэлээ өтөлж яваа насандаа заяасан хайр сэтгэлээ бодож Цэенд хоргодоогүй бол Симоно, Сойхара хоёрыг ямар ч нөхцөлд өөрийн гараар нударч чадах байлаа. Тиймээс Гэрэлээ «Нэг бол эд нар намайг, нэг бол би эднийг устгаж байж санаа амрах болно» гэж бодно. Цэен Гэрэлээ хоёрыг чингэж ярьж суутал гаднаас Сайнжаргал, Сувдаа хоёр орж ирлээ. Гэрэлээ тэдний ярианд саад болохгүйг хичээж гүнгийн өрөөнөөс гарав. Сайнжаргал хэсэг зуур дуугүй сууж байснаа эцгийнхээ царайг ажиглангуй харснаа, бие нь шаналгаагүй болохыг мэдээд,

- Аав аа япончууд яагаад Гуаньдунгийн арал дээр цэргээ байлгадаг юм бэ? гэж асуулаа. Сайнжаргал эцгийнхээ өвчнийг мартуулахын тулд заримдаа түүний ярих дуртай зүйлийг зориуд асуудаг байлаа. Цэен яриандаа болоод заримдаа өвчнөө мартдаг аж.

- Хаант Орос хятадтай байгуулсан гэрээний дагуу дорнод хятадын төмөр замыг тавьж дуустал Ляодунгийн өмнөд хэсэгт газар түрээслэж авсан юм. Тэгээд өөрсдийнхөө хилээс одоогийн Порт-Артур хүртэл төмөр зам тавиад Порт-Артурт хаант оросын хуурай болон усан замын цэргийг байрлуулж, цэргийн цайз бариулсан юм. Порт-Артур бол Гуаньдунгийн арал дээр байсан нэгэн жижиг сууринг оросууд цэргийн боомт хот болгоод арлынх нь нэрийг орос хэлний дуудлагын дагуу квантунгийн арал гэсэн. Оросууд квантуны арал дээр байгуулсан нэг хотоо Дальный гэдэг боловч одоо Дайлян гэхийн зэрэгцээ монголчуудын дунд Дайран гэж алдаршсан билээ. Япончууд хятадтай хийсэн дайны дараа Ляодун, Гуаньдунг сонирхож өөрийн эзэмшил болгох гэж оролдоод дийлээгүй, харин Тайваны арлыг өөртөө авсан. Тэгээд 1904 оны I сард японы арми, Порт-Артур руу гэнэдүүлэн дайрч эзэлсэн билээ. Ингээд Портсмутын хэлэлцээгээр япончууд Ляодунгийн хойгийг Гуаньдунгийн арлуудтай хамт эзэмших болж, Чаньчунгаас Порт-Артур хүртэлх төмөр замыг хамгаалах нэрийдлээр нэг км газарт 15 цэрэг хуваарилж нийтдээ 15 мянган цэргийг Гуаньдунгийн арал дээр байрлуулах болсон юм. Япончууд Гуаньдунгийн цэргийг ойрын ирээдүйд тусгай арми болгоно гэдэг. Харин манжуурт японы цэргийн тусламжтайгаар биеэ даасан улс байгуулбал Гуаньдун дахь цэрэг армийн хэмжээнд хүрэх нь гарцаагүй гээд гүн Сувдаад,

- Охин минь аавдаа жаахан бантан хийгээтэх. Өнөөдөр бие овоо болохоор хоол идмээр санагдаад байна гэхэд Сувдаа гүнгийн өрөөнөөс гарлаа. Цэен, Сувдааг явсны хойно дэрээ өндөрлүүлж хэвтсэний дараа,

- Сайнжаргалаа, чи өнөө зургийн учрыг Сувдаад хэлээгүй биз гэлээ.

- Хэлээгүй. Та эхийнх нь сургийг гартал хэлсний хэрэггүй гээ биз дээ.

- За тэгвэл болох нь тэр! Баатар ахын хоёр хүү Токиод сургуульд явсан гэнэ. Ах минь ард олны төлөө сэтгэл зовдог хүн. Түүнээс болж бид хоёр муудалцсан. Хасбаатар эцгийнхээ бодлыг ягштал барьдаг бололтой. Харин Хасчулуун нь удам угсаа гэдэг бололтой. Ер нь бодоод байхад ахын бодол зөв байжээ. Гэрэлээ ч энэ тухай надад яриад байдаг болчихлоо. Тэгээд намайг төөрч явсан хүн гэж зэмлэх янзтай. Би ч төөрч явсан нь үнэн. Тозияа, Кавасу хоёр намайг хорлочих хүн биш. Бие минь ингээд түр ч гэсэн сайжирдаг юм бол чамайг нутгийн зүг явуулна. Үнэхээр ард түмний засаг тогтсон юм бол эцгийн бурууг хүүхэд нь хүлээхгүй! Нөгөө талаар Сувдаагийн эхийн сураг гарсан. Дэжид Улаанбаатар хотод барьж байгаа үйлдвэрийн барилга дээр ажиллаж байгаа. Түүний тухай Иван Степанович, та хоёрт

ярьж өгнө байх. Шанхайд байгаа алтны учрыг хэрхэх тухай аав нь сүүлд хэлж өгнө. Тэр алтыг бид хэрэглэж болохгүй. Бурхнаас заяагаагүй юмыг эзэгнэх гэж оролдвол нүгэл болдог жамтай! Юмны бага нь амттай гэдэг. Богд монголын ард түмнийг мунхруулдаг байсан ч манай удамд муу юм хийгээгүй хүн! Энэ алт хэдийгээр Богдын өмч боловч цаад учраараа бол манай монголын хөрөнгө сан. Тиймээс аав нь чамтай ярих юм ихтэй. Японы сайд, цэргийн генералууд засаг төрийнхөө эрхийг булаалдаж байгаа юм чинь бусад оронд эрх чөлөө олгож, тусгай улс болоход нь тусална гэдэг голионы жогорхой! Ер нь япон, манжуурыг хятадаас тусгаарлаж биеэ даасан улс орон болгоно гэдэг ч худлаа. Тэгээд цэргийнхэн засгийн эрхийг аваагүй цагт Гуаньдунгийн түмэн цэрэг, хятадын шороон түмэн хүмүүсийн аяыг олж, эвдэрсэн төр улсыг нь төвшитгөнө гэдэг байхгүй хэрэг.

Эд нар ар өвөр монголыг нэгтгэн Богд Чингэсийн үеийн их улсыг байгуулах нэрийдлээр монгол орныг манжийн хаад шиг захирах бодолтой байх шиг байна. Тиймээс ч энэ хэдэн жил хоосон үгээр намайг тайвшруулж байсан юм. Япончууд Богдын алтанд шунаад байгаа явдал бол бидний гараар могой барьж, хаант оросын цагаач нарын хорлон сүйтгэх ажилд хэрэглэх гэсэн бодолтой нь холбоотой. Тиймээс энэ алтыг хүний хоол болгож болохгүй. Шанхайн банкныхан тэр алтыг ямар ч улсад шилжүүлэх үүрэг хүлээсэн. Тиймээс гэрээнд хүлээсэн үүргийн дагуу шилжүүлэх болно.

- Аав аа, та намайг нутаг буцаагаад өөрөө америк явах бодолтой байна уу? гэж Сайнжаргалыг асуухад эцэг нь дуугүй байснаа,

- Олон санаат оргож босож чаддаггүй гэдэг. Тиймээс одоо надад тэгнэ ингэнэ гэсэн бодол алга гэж хэлтэл гаднаас Сувдаа орж ирлээ. Тэрээр хятад гангар шаазантай бантан барьжээ.

Симото, Долнуурт баригдаад байгаа нэгэн монгол хүнтэй уулзаж Хүрээний байдлыг мэдэхээр яваад ес хонолоо. Энэ хугацаанд Сойхаратай утсаар ярьсангүй. Сойхара, гүнгийн биеийн байдалд өөрчлөлт гарч байгааг мэдэнгүүт Симотоог хурдан ирээсэй хэмээн сэтгэл яарна. Сойхара юунд ингэж яарч байгаагаа мэдэх тусам өдөр хоног өнгөрөхгүй юм шиг санагдах ажээ.

...Симото явахынхаа өмнө Сойхаратай ярихдаа «Намайг иртэл шинээр бэлдсэн хортой эм, тариаг хэрэглэж болохгүй. Тэр эм тарианууд гүнгийн хэрэглэж байгаа эм тариатай үнэр, өнгө, амтаараа адилхан боловч Гэрэлээ, Сайнжаргал хоёр сэжиглэж мэднэ. Тиймээс нарийн төлөвлөгөө гаргасны дараа хэрэглэнэ» гэж хориглосон билээ. Гэтэл гүнгийн биеийн байдлыг харвал эм тариаг хэрэглэх нөхцөл нь бүрэлдсэн байлаа. Гэтэл Симотоогоос ямар ч чимээгүй таг чиг болсон нь Сойхарагийн сэтгэлийг яаруулна. Тиймээс хортой эм тариа хэрэглэмээр санагдах ажээ.

Учир нь гүнгийн бие ойрын хэд хоног овоо байгаа болохоор Гэрэлээ, Сайнжаргал хоёр Кавасугийн эм тариаг хардаж сэрдэхээ больсон бололтой. Харин гүнгийн биеийг муудсан үед хэрэглэх гэвэл Сайнжаргал, Гэрэлээ хоёрт амархан сэжиглүүлэх боломжтой болой. Тэгээд Сойхара энэ бүхнийг эргэцүүлээд «Гүнгийн биеийн байдлыг ажвал хэд хоног өвчин нь шаналгаад дараа хэд хоногтоо эрүүл хүн шиг болчих юм. Кавасугийн аргыг олж байгаад хортой тариа хийлгэчихвэл гүнгийн бие муудсан ч гэсэн Гэрэлээ, Сайнжаргал хоёр нэг их хардахгүй. Тэгэхээр цаг алдаж болохгүй. Хэрвээ Симотоог ирэхээс өмнө энэ бүхнийг

амжуулаад гүнгийн гэрээслэлийг би бичээд авчихвал тайса доноо Тозияа сан намайг магтаж цолыг минь тэр дороо ахиулна. Харин Симотоог хүлээвэл би энэ завшаанаа алдах төдийгүй Симото миний гараар могой барьж завшина» гэж бодлоо. Сойхара энэ бүхнээ шийдэж чадаагүй тээнэгэлзэж яах учраа олохгүй байтал нэг өдөр Кавасу утасдаж,

- Гүнтэн, таныг завтай бол маргааш морилж ирээч гэж хэлүүллээ. Та очвол би таныг дайрч очоод авъя. Би одоо гүнгийнх рүү явах гэж байна гэлээ.

- Тэгье. Хоёулаа ханиндаа очъё. Намайг дайраад ир! Би хүлээж байя.

Кавасу, Сойхара хоёрыг гүнгийнд ирэхэд Сувдаа угтан авч дагуулсаар гүнгийн өрөөнд орж ирлээ. Цэен гүн дэрээ өндөрлүүлээд бараг суугаа шахам хэвтэнэ. Тэрээр гийчдээ суусны дараа ажил төрлийн талаар асуув.

- Ноён ахмад аа, Симото сан удах юм болов уу? Би Харбингаас Иваныг дуудуулмаар байна! Ойрдоо бие базаахгүй байдалтай.

- Цэен сан, тэр талаар сэтгэл зовох хэрэггүй. Би өнөөдөр оросын дүрвэгсдийн товчоонд мэдэгдээтэхье гээд Сойхара гүнгийн орны толгойд зогсох зуур ширээн дээрх эм, тариа руу нүдний булангаар санамсаргүй ширтлээ. Сойхара, гүнд амласан ёсоор Харбинтай холбоо барьж оросын дүрвэгсдийн товчоо руу ярьтал тэрээр оросын хил рүү ажлаар явсан байв. Сойхара энэ өдрөө гүнд бараалхаж чадсангүй. Тэгээд маргааш нь хортой тариа бэлдсэн газраа очиж эм тариаг аваад Кавасутай уулзав.

- Ишаа Кавасу сан, та гүнгийнх рүү хэзээ явах вэ?

- Одоо ингэсхийгээд явна. Өнөөдөр хоёр тариа хийх ёстой.

- Тэгвэл хоёулаа явах уу? Би Харбинтай ярьсан тухайгаа дуулгамаар байна гэхэд Кавасу,

- Тэгвэл одоо явъя гэлээ.

Сойхарааг ирсэн явдалд гүн баяртай байлаа. Учир нь Иваныг дуудуулсан гэдгийг мэдэж байлаа.

- Цэен сан, Иван Степанович, оросын хил рүү явсан байна. Ирэхээр нь наашаа шууд явуулна гэсэн гэхэд Цэен гүн баярласнаа илэрхийлээд,

- За та нар зочдын өрөө рүү ор. Тэнд ширээ засчихсан байгаа гэхэд эмч Кавасу, цагаа харснаа,

- Одоо нэг тариагаа хийчихье. Хоол ундны дараа нөгөөг нь хийнэ. Тэр хооронд та жаахан ч гэсэн амарч ав гээд эмийнхээ савнаас тариагаа гаргахад Гэрэлээ өнөө тариануудыг үзээд нэгийг нь задлангуутаа үнэрлэв. Тэгээд Кавасуд буцаан өгч тариаг хийлгэлээ. Энэ бүхнийг ажиж зогссон Сойхара, «Энэ новш чинь гүнгийн уяаны нохой болжээ. Энэ ч Сайнжаргалаас болгоомжилсондоо ингэж байгаа байх! Түүнээс энэ лүд аминаасаа уйдаагүй. Аминдаа хайртай шүү дээ. Ер нь ингэж хандах нь ч зөв байхаа даа. Учир нь Цэнд итгэгдэх хэрэгтэй шүү дээ» гэж бодов.

Цэенд тариа хийсний дараа Сойхара, Кавасу хоёр зочдын өрөөнд орлоо. Тансаг идээ зассан ширээ тэднийг угтлаа. Сайнжаргал, Сувдаа хоёр гийчнээ ширээнд уриад болор хундаганд сакэ дүүргээд,

- Кавасу сан, танд хатуу нь дээр биз гээд өөрсөндөө жимсний ундаа аягалав. Чингэж эхэлсэн хүндэтгэл нэлээн дорвитой үргэлжилж, Кавасу шотланд вискинд шунаж суутал Сайнжаргал эцгийнхээ өрөө рүү явж, Сувдаа гийчнээ зочилно. Сойхара янжуур асаах зуураа,

- Сувдаа сан, Гэрэлээ сан хаачсан бэ? Бидэнтэй сууж ганц хундага сакэ балгахгүй юм байх даа гэж жирийн байдлаар хэлэв

- Гэрэлээ ажаа гадагшаа юманд явсан, мөд ирэхгүй байх.

- Сайнжаргал сан одоо ирэх үү. Би ажил төрлийн талаар ярих гэсэн юм гэхэд Сувдаа,

- Адиагийн өрөөнд байгаа. Та тийшээ очиж уулзсан ч болно.

Тэгээд ч дараагийн тариа хийх болчихсон байна гэхэд Кавасу цагаа хараад суудлаасаа босов. Чухам энэхэн үед Сойхара, халааснаасаа алчуураа авч амаа арчих гэтэл түүний гарт хортой тариа өртөхийг мэдээд "Ер нь энэ завшааныг ашиглаж болох болов уу?" гэдэг бодол сэтгэлд нь буулаа. Тэр хоёрыг гүнгийн өрөөнд орж ирэхэд Сайнжаргал байхгүй байв. Гүн, орон дээрээ цаашаа хараад зүүрмэглэнэ. Харин зэргэлдээх өрөөний онгорхой хаалгаар утсаар ярьж байгаа Сайнжаргалын дуу тодоос тод сонсогдоно.

- Сойхара сан, хоёулаа Сайнжаргалыг жаахан хүлээе. Тэгээд ч гүнг тарихад арваад мөч дутуу байна гэхэд Сойхара,

- Кавасу сан, та Сайнжаргалыг дуудаад ир! Би өнөөдөр жаахан ажилтай эртхэн явахгүй бол болохгүй гэтэл Кавасу толгой дохиод өрөөнөөс гарав. Сойхара, халаасандаа байгаа хортой тариаг гаргаад гүнгэрвааны баруун хананд шахсан ширээн дээр байгаа эм тарианы дэргэд очингуут ширээн дээр бэлдчихсэн жинхэнэ тариаг авч халаасандаа хийгээд ав адилхан шилтэй төдийгүй өнгөөрөө үл ялгагдах хортой тариаг ширээн дээр тавилаа. Тэгээд эмчийг хүлээж зогсохдоо «Сайнжаргал орж ирээд энэ тариаг шалгах болов уу? Уг нь Гэрэлээ орж ирвэл шалгаж сүйд болохгүй. Кавасу түрүүчийн тариаг хийхдээ хоёр тариагаа Гэрэлээд өгсөн шүү дээ. Харин үнэр нь ондоо байж магадгүй. Тэгэхээр тамхи татчихвал зүгээр байж мэднэ» гэж бодоод халааснаасаа тамхиа гаргаж асаалаа. Энэхэн зуур Кавасу орж ирээд,

- Сайнжаргал сан одоохон орж ирнэ. Юу ч гэсэн түр хүлээе. Сойхара сан та, энд тамхи татаж болохгүй гэхэд Сойхара тамхиа унтраалаа. Тэгээд Кавасу, Сайнжаргалыг хүлээхээр хананд тулгаж тавьсан диван дээр суух гэтэл гаднаас Сувдаа орж ирээд,

- Эмчээ тариагаа бэлдсэн үү гэхэд Кавасу суудлаас босож,

- Одоохон гээд тариагаа бэлдэв.

Цэен түрүүчийнхээ тарианы үйлчилгээнд чилээрхэж бага зэрэг нойрсож байгаа болохоор

Сувдаа түүнийг болгоомжлон сэрээлээ. Тэгээд Кавасугийн дэргэд ирээд тариаг нь ажиглах төдий харж хэсэг зогсоход Сойхарагийн дотор палхийгээд «Энэ тариаг хийлгэхгүй гэвэл яана! Тэгвэл дахиад эдний босгыг алхах нь байтугай түүнээс илүү юм болно» гэж бодохоос нуруугаар

нь хүйтэн хөлс чийхрах шиг болно. Үнэндээ ингээд хэрэг буруудвал Тозияа, Симото хоёрын даалгавраар түүнийг хэнд ч мэдэгдэлгүйгээр устгах байлаа. Тэгээд Цэенгийн сэтгэлийг тайтгаруулж «Тэр чинь Жан Сюэляны гар хөлийн амьтан байсан байна» гээд ятгачих аж. Үүнийг Сойхара хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байгаа тул Симотогийн удирдамжгүйгээр толгойтойгоо ороолдсон хэрэг хийлээ гэдгээ ойлгоно. Сойхара чингэж бодож байтал Сувдаа,

- Кавасу сан, жаахан хүлээж бай. Одоо Сайнжаргал эгч орж ирнэ гэхэд Цэен, эмч өөдөө харан, ханцуйгаа шамлах зуур,

- Цаадах чинь тарианы зүүнээс айдаг ухаантай юм.

Тэгээд миний гарыг барихаасаа айгаад Сайнжаргалыг хүлээж байгаа нь тэр! гэхэд хөшөө шиг зогссон Сойхарагийн сэтгэлийг харанхуйлж байсан тээглээ арилах шиг болж санаа нь амарлаа. Тэгээд Кавасу тариагаа хийж дуустал, гүнтэн инээмсэглээд,

- Бие ч овоо болж байна шүү гэснээ,

- Эмчээ та хоёр жаахан суухгүй юу. Би бүр уйдаж гүйцлээ шүү гэхэд Сойхара,

- Цэен сан, яривал ч юм байна. Харин миний хувьд өнөөдөр боломжгүй болчихлоо. Цагийн дараа хуралтай. Би заавал суух ёстой. Харин Кавасу сан завтай биз дээ гэлээ. Чингээд эмч гүнгийн үлдэж, энэ тэрхнийг ярьсан болж цаг нөхцөөхдөө шотланд вискигээр ходоодоо эрхлүүлэх мэт зугуухан балгасаар нэлээн больжээ.

Кавасу маргааш өглөө ирж гүнг үзэхэд түүний бие барагтай байлаа.

- Би өнгөрдөг шөнө тун барагтай хонолоо. Ходоод халуу оргиод тасарчих гэж байгаа юм шиг амар заяа үзүүлсэнгүй. Яг өнөө өвддөгөөрөө өвдөх янзтай байна. Цэен гүн энэ өдрийн шөнө дүлээс хойш учир зүггүй халуурч өвчиндөө шаналж, үе үе дуу тавин ёолдог болов. Тэгээд хэд хоногийн дараа бүр муудлаа.

Цэенгийн бие ингэж муудсан нь тэдний гэрийнхнийг төдийгүй Симотоог багагүй түгшээлээ. Тэрээр Долнуур ороод арван гурав дахь хоногийн өглөө Мугдэнд иртэл галт тэрэгний буудал дээр Доихарагийн хоёр ажилтан угтаж мэдэгдэхдээ «Тяньжингаас яаралтай ярина гэсэн. Таныг Доихара сан хүлээж байгаа» гэж

билээ. Симото, Мугдэнгийн нууц тагнуулын удирдлагад чингэж сонирхогдсон нь сэжигтэй санагдана. Гэвч тэднийг дагаж явахгүй гэх толгой байсангүй. Тиймээс Доихарагийн өрөөг чиглэхдээ «Тяньжингаас Тозияа яривал Доихарагийн газраар дамжуулахгүй. Шууд төлөөлөгчийн газраар ярина. Мугдэн дэх кэмпэтайн бүрэн эрхийн төлөөлөгч Доихара намайг сонирхоно гэдэг зүгээр хэрэг биш» гэж бодож явтал өнөө хоёр хүн түүнийг тусгайлан

бэлдсэн өрөөнд авчирлаа. Симото тэр өрөөнд орж ирэхдээ «Эд нар чинь намайг баривчилж байнаа даа» гэж бодоод өрөөг ажвал нэгэн ширээн дээр хэд хэдэн утас тавьсныг хараад Токио руу ярьдаг шууд холбооны өрөө болохыг мэдээд сэтгэл нь уужирчээ. Гэтэл гаднаас орж ирсэн холбооны нэг дарга,

- Шиу са доноо (ноён хошуучаа), Токиогоос ярина гэсэн гэхэд Симото гайхсан нүдээр бага даргыг гөлөрч,

- Юу! Надтай Тяньжингаас ярих ёстой шүү гэлээ.

- Шиу са доноо эхлээд Токиотой дараа нь Тяньжинтай ярина гээд харилцуурыг авч хэдэн юм лавласнаа Симоотоод өглөө. Гэтэл утасны чагнуурт нэгэн генералын танил дуу гарсанд,

- Гаккаа (ноён генералаа) шиу са Симоото сонсож байна гэж илтгэв.

- Гүнгийн бие ямар байна гэж жанжин штабын тагнуулын газрын даргыг асуухад Симоото,

- Чиү жёо гаккаа (ноён дэслэгч генералаа), би дөнгөж сая Долнуураас ирээд байна. Гүнгийн тухайд одоохондоо мэдсэн юмгүй. Одоохон мэдээд танд илтгэе гэхэд,

- Шиу са Симоото сан, гүн хэзээ үхэх нь надад хамаагүй. Харин тэр алтны тухай гэрээслэлийг бичиж албаны баталгаатай болгох нь чухал. Тэгэхдээ гүнгийн өөрийн гараар бичсэн гэрээслэл авч чадах уу, үгүй юү гэдэг сонирхолтой байна. Үүнийг би албан ёсоор шаардаж байна гэдгийг санаж яваарай гэж ам ангайх завгүй бууж гарлаа. Симоото, хэр баргийн юманд самгардаж яваагүй. Гэтэл одоо өөрийнхөө бэлдсэн занганд хүзүүгээ шургуулсныг гадарлаад яах учраа мэдэхгүй хэсэг гайхлаа.

- Симоото, та чинь хахаж орхив уу? Яагаад дуугүй байна гэж генерал сөөнгө дуугаар загнах нь чагнуурт тод сонсогдоно.

- Гаккаа, би таны үгийг сайн сонсож байна.

- Гүнгийн гэрээсийг бичүүлсэн цагтаа илтгээрэй. Цэргийн яам оросын дүрвэгсдийн товчоог санхүүжүүлэхийн тулд нэг өдөрт тавин мянган доллар зарцуулж байна. Гэтэл Тозияа сан та хоёр Богдын алтыг ашиглах талаар ямар ч алхам хийхгүй байгаа явдал чинь зарим хүмүүсийг эргэлзэх байдалд хүргээд байна. Тиймээс одоо нэг тийш нь шийдэх хэрэгтэй гэхэд Симоото арай ядан,

- Мэдлээ. Эрхэм дээдсээ гэхэд цаадах нь утсаа тавьчихлаа. Симоотоог ярьж дууссаны дараа холбооны бага дарга,

- Шиу са доноо та, одоо Тяньжинтай яриарай гэлээ. Симоото духаараа чийхарсан хөлсөө арчаад харилцуурын чагнуурыг чихэндээ барьтал,

- Симоото сан наана чинь юу болоод байна вэ? Цэен гүнгийн бие тийм их муу байгаа юм уу? гэж байцаалаа.

- Сэнсэй Тозияа сан, би ердөө мэдэж амжаагүй байна.

- Симото, чи одоохон өөрийнхөө хоёрыг олж уулзаад гүнгийн очиж учрыг магадлах хэрэгтэй. Ер нь амьд байгаа юм уу, үгүй юм уу гэдэг асуудал гарч байна. Тэгээд надад мэдэгдээтэй гэж тушаалаа.

Симотоог өмнөд манжуурын төмөр замын нийгэмлэгийн дэргэд байдаг нууц тагнуулын газраас гарч иртэл хэрмэн хашааны үүдэн дээр Сойхара түүнийг хүлээж байлаа. Симото түүнийг харангуут алхаагаа түргэтгэн дэргэд нь ирээд,

- Та нар чинь ямар бантан хутгачихаад байна гэж бууж гарлаа.

- Гүнтэн таныг явсны дараа бие нь муудаад өөдөлсөнгүй. Одоо амьсгаа хураачих гээд байна гэхэд Симото, Сойхара руу хяламхийн хараад царай руу нь гөлөртөл тэрээр харцаа буруулж газар ширтэхэд Симотогийн сэтгэл сэрхийж «Энэ золиг хортой тариаг миний зөвшөөрөлгүй хэрэглэсэн байх нь. Тэгээд Сайнжаргал Токио руу мэдэгдсэн хэрэг. Энэ золиг Гэрэлээ, Сайнжаргал хоёрын зав чөлөөг яаж ашиглаа бол? Энэ тэдний хяналтыг тийм ч амархан давахгүй. Тэгээд Кавасутай тохиролцох ёстой. Кавасу тун хашир хүн тэгэхээр үүний үгийг дагаж, гэнэ алдлаа гэж үү?» хэмээн бодоод,

- Чи ойрдоо гүнгийнхээр очсон уу? гэж шалгаав.

- Үгүй ээ гэж хэсэгхэн түгдрээд, гүнтэн намайг дуудуулсан

учраас хоёр удаа очсон гээд ээрлээ. Симото тэндээсээ ажил дээрээ очилгүй шууд гүнгийн ирлээ. Түүнийг Сувдаа угтаж хаалгаар оруултал дээд давхраас Кавасу шатаар бууж яваа харагдлаа. Тэрээр Симотогийн дэргэд ирэнгүүт турь муутай дуугаар,

- Гүнтэн нэлээн хүндхэн байна гэхэд Сойхарагийн царайгаар ягаарсан туяа нүд ирмэхийн төдийхөнд зурсхийн цайрахыг ажсан Симото «Энэ хоёр санаа нийлсэн хэрэг үү? Арай тийм байх ёсгүй» гэж бодоод гүнгийн өрөө рүү алхахад Сойхара, Сувдаатай үлдэж, Кавасу Симотоог дагав.

Симотоог гүнгийн өрөөнд ороход битүү хивстэй өрөөний нэгэн хананд тулгасан хүрэн суман орон дээр хэвгэж буй гүн, нүдээ тас анин, хөмхийгөө зууж, өдөн дэрээ толгойгоороо шөргөн эмзэглэж, гиншихийг ажваас өвчнийхөө шаналгаанд тэсэж ядаж буйг гэрчилнэ. Тэрээр орныхоо хашлагыг тас атган, шүдээ хяхтнуулж байснаа хамрынхаа нүхийг том болгон амьсгаа аваад ёолж эхэлтэл хамрын үзүүр, духаар нь хөлс чийхарлаа. Кавасу сувилагч дуудаж,

- Хар тамхи бэлдээрэй гээд гараа угаалаа.

Симото гүнгийн царай хөхөрч өнгөгүй болсныг хараад «Энэ хүнээс ямар ч үг сонсож чадахаас өнгөрчээ» гэж бодов. Сувилагчийн бэлдсэн тариаг гүнгийн гарын булчинд хийтэл, гүнтэн сэтгэл шимшрүүлэм муухай дуугаар ёолж хэвтсэнээ алгуурхан намдсаар ёолохоо болив. Сайнжаргал, эцгийнхээ нүүрээр чийхарсан хөлсийг арчихад нулимсандаа улайж хавдсан нүдний харц уурлангуй сүртэй байхыг ажигласан Симото дуугүй зогсоно.

- Симото сан, одоо сэнсэй Тозияаг дуудсан дээр байх. Амьсгаа хураахаас нь өмнө уулзаг гэхэд хошууч,

- Би ингэсхийгээд утсаар ярина. Ер нь өөрөө ч ирэх байх. Би цэргийнхэнтэй ярьж өнөө шөнийн дотор ирүүлэхийг бодъё гэж амлав. Гүн намуухан гиншсээр сүүл сүүлдээ дуу нь сонсогдохоо болиод хар тамхиндаа мансууран хөдөлгөөнгүй боллоо.

- За одоо ийшээ орцгооё. Одоо хэдэн цаг тайван байх байгаа гэж Кавасуг хэлэхэд гүнгийн өрөөнд Гэрэлээ үлдээд бусад нь зэргэлдээх өрөөнд орцгоолоо.

- Сайнжаргал сан, сэтгэлээ барих хэрэгтэй. Ходоодны хавдар

гэдэг чинь хэртэй аргалагддаггүй зүйл шүү гэж сэтгэлийг засахыг хичээж хэлэхэд Сайнжаргал,

- Одоо яая гэх вэ? Нэгэнтээ юу ч тус болохгүйгээс хойш их шаналгахгүй байх нь чухал гэхэд Симото дотроо «Эд нар ч сэжиг аваагүй юм байна» гэж бодоод гүнгийнхээс гарахын өмнө Кавасугаас,

- Гүнтэн, Сойхарааг танаар дуудуулсан уу? гэлээ.

- Тиймээ. Иваныг Харбинаас дуудуулах гэсэн юм.

- Түүнээс хойш Сойхара эднийхээр хэд ирсэн бэ?

- Нэг удаа надтай хамт ирсэн. Тэгэхдээ Иваныг оросын хил рүү явсныг дуулгасан юмдаг.

- Хэзээ тэр вэ? Гүнгийн өвчнийг хүндрэхээс өмнө үү, хойно уу?

- Сойхарааг ирсний маргаашнаас гүнгийн бие хүндэрсэн юм гээд Кавасуг тэр өдөр болсон бүхнийг Симотоод ярилаа. Симото гүнгийнхээс гараад өрөөндөө ирлээ. Тэгээд Сойхарагаас юу ч шалгааж асуусангүй. Тэрээр хэсэгхэн бодол болон зогссоноо,

- Тай и, чи өнөө тариагаа надад өгчихөөрэй. Одоо түүний хэрэг байхгүй. Гүнтэн одоо наашаа харахгүй байх гэж тайван хэлэхэд Сойхара тариаг авчрахаар явлаа. Чингээд Симото тариаг бэлдсэн газар руу утсаар ярилаа.

- Чиүса (дэд хурандаа), танайхан хэдэн ширхэг тариа бэлдсэн

бэ?

- Тайса Симото сан, бид арвыг бэлдсэн. Гэхдээ танай Сойхара тавыг авсан шүү. Бусдыг нь та хэзээ авах вэ?

- Би түүнийг сүүлд авна. Танайх хадгалж байсан дээр биз гээд яриагаа дуусгав. Тэгээд Сойхарааг орж ирэхийг хүлээж байтал ахмад дөрвөн тариа барьсаар орж ирлээ. Симото түүнийг авангуутаа,

- Нэг тариаг нь яагаад миний зөвшөөрөлгүй хэрэглэсэн бэ? гэж сүртэй асуулал Сойхара гарах газаргүйгээ мэдээд бүх үнэнийг тоочив.

- Тай и, чиний энэ үйлсгүй явдлаас болоод жанжин штабын удирдлага, Доихарагийн шугамаар бүх зүйлийг мэдээд гүнгээс өөрөө бичсэн гэрээслэл нэхэж байна. Тэгэхээр одоо яая гэж бодож байна даа. Гүнгийн гараар гэрээслэл бичүүлэх нь байтугай

хэлүүлж чадахгүй болсон байна гэхэд Сойхара дуугүй зогсоно.

- Сойхара танд ганц зам үлдсэн. Тэгэхгүй бол Гэрэлээ, Сайнжаргал хоёр энэ бүхнийг ямар нэг аргаар мэдээд таныг устгах болно. Гэрэлээгийн нүд хурц, чиний нүүрний хувьсалтаар хэргийн эзнийг чамайг гэдгийг амархан мэднэ. Ингэхээр юуны өмнө Гэрэлээгээс амиа хамгаалахыг бодох хэрэгтэй. Бид таны амь насыг хариуцахгүй. Тийм ч гавьяа, зүтгэл танд байхгүй. Тиймээс нарийн арга бодох хэрэгтэй. Гэрэлээ амьд үлдвэл бидэнд ч халтай. Тиймээс та өөрийгөө цагаатгах ганц арга бол түүнийг хэнд ч мэдэгдэлгүйгээр тонилгох явдал! За мэдэгдлээ гэж үзэхэд янхны газар байхад нь залилуулсан хүмүүсийн өшөө хонзонд өртсөн гэдэг баримт гаргаж болно. Тэгэхгүй бол Сайнжаргал Гэрэлээгийн араас дуугүй өнгөрөхгүй гэдгийг санах ёстой. Хэрэв өөрийнхөө нүхийг сайн бэлдэхгүй бол Сайнжаргалыг хэн ч аргалж чадахгүй. Түүний гомдлын дагуу бид цөмөөрөө намагт живнэ гэдгийг ойлго гэхэд Сойхара,

- Шиү са доноо таны даалгаврыг ойлголоо гэж илтгэв. Симото, гүнгийнхээс ирээд Тяньжин руу ярихыг яарсангүй.

Тэрээр гүнгийн бие тун доордсоныг мэдээд жанжин штаб руу хэрхэн мэдэгдэхээ бодно. Тэрээр юмыг эргэцүүлэхдээ сайн юмыг түрүүлж боддоггүй зантай. Сайн сайхнаар зөгнөхийг хүсдэггүй. Харин өөртөө зайлшгүй тохиолдох муу бүхнийг хийсвэрлэн төсөөлж, эцсийнхээ шийдийг гаргадаг. Өөрөөр хэлбэл өөрийгөө сүйрүүлж болох бүх эгзгийг сэтгэн олоод түүнээс мултрах арга ухаанаа боловсруулдаг «тооцооны машин» гэсэн үг. Тэрээр генералд өөрөө илтгэх үү? Тозияагаар илтгүүлэх үү гэдгийг тунгаагаад эцэст нь сэнсэй багштныхаа хөлд суухаар шийдлээ. Тэгээд орой нь Кавасуг дуудаж уулзав.

- Цэен гүнг хэд хоног торгоох арга бий юү? Өвчнийх нь шаналгааг багасгаж чадвал гэрээслэлийг нь бичиж авах боломж гарч магадгүй. Тэгэхгүй бол та хоёрын хэн хэн маань кэмпэйтэйн өрөөнөөс мэнд гарч ирэхгүй шүү гэхэд Кавасу,

- Юу? гэж гайхан асуув.

- Сойхара тэр өдөр таны сиймхийг ашиглаад хортой тариа тариулчихсан байна. Үүнийг токиогийнхон мэдээд цаана чинь баллахын даваан дээр байгаа бололтой. Үүнээс мултрах ганц зам бол гүнгийн амнаас ганц хоёр үг дуулж, тэмдэглэж авах нь чухал!

- Ай мэдэхгүй. Тарианаас хордсон бол ярвигтай. Гэхдээ тарианы хор аль зэрэг хүчтэй вэ гэдгээс шалтгаална.

- Түүнийг цэргийн эмнэлгийн тусгай газар боловсруулсан хороор бэлдэж өгсөн юм.

- Тэгвэл дийлдэхгүй хүчтэй зүйл байна даа.

- Кавасу сан, хар тамхины жинхэнэ хандаар таривал яасан юм бэ?

- Тэгвэл ч нэг боломж гарч болно. Гэхдээ хар тамхины жинхэнэ хандаар бэлдсэн тариа олно гэдэг нь хялбаргүй. Гэхдээ та өөрийнхөө шугамаар олж өгвөл тэр чинь тус болж мэднэ гэхэд Симолагийн сэтгэлд «Хар тамхины хандыг цэргийн шугамаар олж болно. Тэгэхээр баримт бичигт нь Тозияагаар мутарлуулчихвал ямар ч зардалгүй олдоно. Харин золбоотойхон хөдөлбөл надад унацтай юм биш үү? Тариаг эмнэлгийн шугамаар олсон гэж Сайнжаргалд үнэмшүүлбэл таван мянган иень салгаж болно. Тэгэхдээ эмчийн гараар амархан салгах хэрэгтэй. Харин цэргийн шугамаар олсон гэдгийг Сайнжаргал мэдвэл тэр их иенийг төлөхгүй аргаа хийчихнэ» гэж бодлоо.

- Кавасу сан, хар тамхины хандыг олоход зардал ихтэй. Манай шугамаар ярих нь бүр ч ярвигтай. Бас тэгээд нууцтай холбоотой зүйл! Гэхдээ олохыг бодно. Харин та Сайнжаргалд хэлэхдээ эмнэлгийн шугамаар олсон гэдгийг итгүүлэх хэрэгтэй. Тэгээд үнэ хөлсийг нь аваад надад өгчихнө биз. Сайнжаргалд үүний учрыг мэдэгдвэл цэргийн нууц задруулсан хэрэгт унана. Тэгэхээр сэмхэн зохицуулах нь чухал гэхэд Кавасу,

- Тэгье гэж зөвшөөрлөө. Чингээд Симола, Кавасуг гүнгийнх рүү явуулж өөрөө Тяньжин руу ярихаар захиалга өгөөд хүлээж суухад Кавасу, Сайнжаргалтай ярилцаж байв.

- Кавасу сан, аавд хар тамхины ханд олж таривал зүгээр юм байна даа. Ядаж өвчиндөө шаналахгүй байх нь чухал гэхэд түрүүнээс хойш далим хүлээж байсан Кавасу,

- Уг нь олдвол хар тамхиар тарих нь зүгээр. Гэтэл хар тамхины жинхэнэ хандмалаар бэлдсэн тариа олно гэдэг бэрхтэй. Олдлоо гэхэд үнэ нь хадаж өгнө. Тэгэхдээ дамаас ар өврийн хаалгаар олдоно гэлээ.

- Олддог бол үнэ хамаагүй. Тэгэхдээ хүрэлцэхүйц хэмжээгээр олох нь чухал гэж гуйхад,

- Юу ч гэсэн сураглая. Арваад мянган иень байхад нэлээн юм олно шүү гэхдээ яагаад чингэж хэлснийхээ учрыг өөрөө ч ойлгосонгүй. Тэгээд сэтгэлдээ «Симола таван мянга гэсэн. Би чинь таван мянган иень олчихож байгаа юм биш үү. Сайнжаргал ямар бэлгүйдэх биш. Харин яаж арван мянга гэж хэлэв. Далдаас лав бурхан ятгасан байх. Зөв зүгээр байж байгаад таван мянган иень олчихдог байна шүү» гэж бодохдоо угийн шунаг сэтгэлийн увдист урхидуулснаа хэрхэн ойлгох билээ.

- Сувдаа, миний өрөөнөөс зуугаар толгойлсон нэг боодол иень аваад ир гээд нууц шүүгээнийхээ түлхүүрийг өглөө. Чингээд Сувдаа удаж төдөлгүй буцаж ирээд зуутын дэвсгэрээр толгойлж боосон иенийг Сайнжаргалд өгөхөд шинэ иений цаасны анхилам үнэр нэлээн зайтай сууж байгаа Кавасугийн хамрын нүхийг цоргиж ирвэгнүүлэх шиг санагдав. Кавасу Сайнжаргалын гараас хамрын хөндий ирвэгнүүлсэн сайхан үнэртэй цаасаар хийсэн иенийг алга тосон авахад гарын нь хуруунууд үл мэдэг салганан, амьдралдаа атгаж үзээгүй иений бараагаар Кавасугийн сэтгэл догдолж «Энэ чинь үнэн л байгаа даа. Зүүд баймааргүй юмсан» гэж бодов.

- Кавасу сан, дахиад хэрэгтэй бол хэлээрэй гэж Сайнжаргалыг хэлэхэд Кавасу,

- Энэ чинь болно, дахиад хэрэггүй гэгчхээд ховдог сэтгэлдээ «Дэндүү түргэн дуугарчихав уу даа» гэж бодоод харамсав.

Симото, Тяньжинтай ярьж гүнгийн биеийн байдлыг илтгэхдээ, Сойхарагийн гаргасан алдааны талаар цухуйлгасан боловч төдий их дэврүүлсэнгүй. Тэгээд Токиотой ярьсантай уялдуулж илтгэх хуудас бичиж мэдэгдэхийг асуухдаа,

- Тозияа сан, та гаккаад өөрийнхөө нэр дээр илтгэх үү? Эсвэл би эндээсээ шууд айлтгах уу гэхэд Тозияа,

- Токио руу илтгэх гэж яарсны хэрэггүй. Ер нь би өөрөө ярьсан дээр чи гүнтэй ярьж амжсан уу? гэлээ.

- Гүнтэн ярих чадалгүй байна.

- Чи чинь тэгээд юу ярьсан юм бэ? Чиний түрүүний яриагаар

бол үе үе ухаан алдаж байгаа юм шиг санагдсан. Гэтэл одоо болохоор бүр ухаан мэдрэлгүй юм шиг ярьж байдаг. Үг хэлж чадахгүй тийм доор орчихсон хэрэг үү? Тийм бол Токиогийн удирдлага чиний ажиллагаанд дургүйцдэг нь зөв. Үүнийг чинь би ч хамгаалж чадахгүй. Тэр тусмаа жанжин штаб, эзэн хааны зөвлөхүүдэд энэ тэр гэж хачирласан бол бүр нэмэргүй гэж мэдээрэй гэж уурсан бууж гарлаа.

- Уг нь Сайнжаргал биеийн нь байдлыг харж байж танд мэдэгдье гээд байсан юм. Түүнээс Сойхара бүр эрт мэдэгдье гэсэн чинь таныг хий сандаргаад яахав гэж Сайнжаргал хориглосон байна гэж санаандаа орж ирсэн үгээр буудаж гарлаа.

- Би одоо эндээс гарна. Намайг очтол бололцоотой бүхнийг хий!

- Тозияа сан, одоохондоо хар тамхины хандаар тарьж байгаа. Гэтэл тэр нь олдохгүй байна.

- Тусгай шугамаар наадахаа олж ав! Миний нэрийн өмнөөс Доихаратай ярь. Тэднийхэн амархан олно. Тэгээд холбогдох бичиг баримтыг нь миний нэр дээр хийж болно гэдгийг Доихараад хэл гэж тушаахад «Доихарагийнхантай яаж хэл амаа ололцоно доо» гэж бодож байсан Симотогийн сэтгэлийн нэг дарамт хөнгөрлөө.

Симото, чингэж Тозияатай ярилцаад Доихарагийнханд сэнсэйнхээ тушаалыг дамжуулахаар завдаж байтал штабын ерөнхий жижүүр утасдав

- Шиү са доноо, тантай уулзахаар эмч Кавасу ирээд байна гэж мэдэгдэхэд Симото дотроо «Эмч Сайнжаргалтай тохирч чадаж дээ» гэж бодоод өрөөнөөсөө хурдан гарлаа. Кавасу Симотоог үүдэн дээр тосон уулзаад баярласандаа нүдээрээ инээмсэглэн,

- Симото сан, Сайнжаргал яг таван мянгыг өгсөн шүү гээд халааснаасаа баахан иень гаргахад Симото зовсондоо,

- Та наадахаа далд хий! Энд эвгүй юм биш үү гэхэд эмч эргэн тойрноо ажиглаад харуулын цэргээс болгоомжлов. Симото төлөөлөгчийн газрын хашаанаас гараад нэлээн холдсоны дараа

- За нөгөөдөхөө гэж нэхэхэд баахан задгай зуутын иень гаргаад,

- Дахиад хэрэгтэй бол хэлээрэй гэсэн шүү гэж хэлээд үл мэдэг самгардлаа. Кавасу шүлсэндээ цацан ээрэхийг ажсан

Симото «Энэ золигийн дуу шуу тасалдаад ээрч муураад байх чинь. Юунаасаа ингэж байгаа юм бол! Тун их сандарч тэвдсэн янзтай. Тэгээд энэ иень задгай байдаг чинь тун сэжигтэй хэрэг! Сайнжаргал үүнийг задгай өглөө гэж үү? Мань хүн замаас нь хэд хэдийг чимхсэн хэрэг байх нь! Тэгээд түүнийгээ надаас нуух гэж будилж байгаа хэрэг. Аймхай амьтан далимдууллаа гэхэд мянган иень авч чадахгүй биз. Ийм доожоогүй амьтан хумсаа уртхан гаргачих учраа олохгүй» гэж бодоод дуугүй өнгөрөхөөр шийдэв. Симото тэр дороо өмнөд манжуурын нууц тагнуулынхан дээр очиж Доихаратай уулзаж, Тозияагийн хэлснийг дамжуулаад тэдний мэдэлд байдаг хураагдсан хар тамхины хандмалаар бэлдсэн тарианууд авч бичиг баримтуудыг бүрдүүлээд маргааш нь хар тамхины хандмалаар бэлдсэн тариагаа өгөхдөө «Ам шүд, андгай тангарагийг» нь бичүүлж авчээ. Чингээд Кавасу хар тамхиар бэлдсэн тариагаа Сайнжаргалд өгч ойрхон хугацаагаар гүнг тарьж эхлэв.

Симото оройхон хэрд гүнгийн дээр ирж Тозияаг Тяньжингаас гарсныг мэдэгдээд анир чимээгүй тайван нойрсож хар тамхинд мансуурсан гүнгийн өрөөнөөс Кавасутай хамт гарч ирэнгүүт,

- Өнөө шөнө гүнтэн сэрэх үү? гэж сэмхэн асуулаа.

- Сэрнэ. Ер нь тийм ч их хүчтэй хордоогүй бололтой. Одоо сэрвэл нэг хэсэгтээ ёолж шаналахгүй гэж эмчийг хэлэхэд Симото сэтгэлдээ сэм баярлав. Симото, эмч хоёрыг гүнгийн өрөөнөөс гарсны дараа гүнгийн дэргэд сууж байсан Гэрэлээ суудлаасаа өндийгөөд,

- Сайнжаргалаа, Сувдаа та хоёр аавынхаа дэргэдээс холдож болохгүй. Кавасугийн хөдөлгөөн бүрийг ажиг бай! Тариаг нь өөрийнхөө дэргэд бэлдүүлж шилийг нь хадгалж бай! Ёроолд нь үлдсэн шавхрууг асгаж, ширгээж болохгүй. Би оройхон ирнэ гэхэд Сайнжаргал,

- Гэрэлээ ажаа, та өөрөө хамт байсан дээр шүү дээ гэв.

- Би одоохон явж үүнийг шалгуулаадахья гээд Гэрэлээ нэгэн тарианы шил үзүүлэв.

- Наадах чинь юун шил вэ?

- Намайг байхгүй хойгуур аавд чинь хортой тариа хийж амжсан байна. Тэгэхдээ Кавасу өөрөө мэдэж хийсэн биш. Харин

санамсаргүй хийсэн бололтой. Миний бодол зөв бол энэ тариаг Сойхара тэр нэг өдөр ирэхдээ сольж амжсан хэрэг. Хэрвээ Кавасу учрыг нь мэдэж хортой тариа хийсэн бол шилийг нь үлдээх ёсгүй. Энэ шилийг ажвал аавд чинь хийдэг тарианы шилнээс ялгагдахгүй байна. Гэхдээ үнэр нь ондоо юм. Тарианы шилийг санамсаргүй тохиолдлоор нойтон хөвөнгөөр

тагласан нь түүний ёроолын шавхрууг хатаагаагүй байна. Тиймээс Тозияаг ирэхэд шалгуулчихсан байх хэрэгтэй гэхэд Сайнжаргал толгой дохин зөвшөөрөхдөө нүдэндээ өөрийн эрхгүй цийлэгнэсэн нулимсаа арчив.

Сайнжаргал эцгийнхээ өрөөнд Сувдааг үлдээгээд Гэрэлээг хашааны үүдэн дээр гаргаж өглөө. Гэрэлээг юманд явахад ингэж гаргаж өгдөггүй мөртлөө өнөөдөр хашааны үүд хүртэл дагасан учраа олсонгүй. Тэр хоёрыг хаалгаар гарч ирэхэд замын цаад талын модны дэргэд зогсож байсан хүн хөлөг дэргэд нь ирж зогслоо. Гэсэн ч Гэрэлээ суухыг яарсангүй. Сайнжаргал ч гэсэн түүний дэргэдээс салмааргүй санагдана. Гэрэлээ Сайнжаргалын хацраар урссан нулимсыг арчаад,

- Битгий уйл. Бид анхаарлаа сарниулснаас осолдлоо. Түүнээс өвчин нь ингэж хүндрэх ёсгүй байсан. Одоо сэтгэлээ чанга барих хэрэгтэй. Өөрийнхөө сул талыг эдэнд мэдэгдэж болохгүй гээд Гэрэлээ хүн хөлгийн тэрэг рүү алхав. Сайнжаргал хашааны үүдэн дээр зогсоод хүн хөлгийн бараа харагдахгүй болон болтол гадаа зогслоо. Сайнжаргал аавынхаа өрөө рүү явахдаа «Гэрэлээ эгчийг хэрэггүй явуулав уу даа. Түүнийг шалгасан шалгаагүй хоёр адилхан шүү дээ. Нэгэнтээ эд нар хорлоё гэж бодсон нь илэрхийгээс хойш...»

Сайнжаргал эцгийнхээ өрөөнд орж ирээд гиншин ёолох шаналгаагүй гүн нойрсож буй эцгийнхээ царайг хараад хэсэгхэн бодлогоширсноо,

- Сувдаа, чи одоохон Харбинтай холбоо барь. Иван Степановичийг олж яриад «Хурдан ир» гэж хэлээрэй. Хэрвээ Иван оросын хил дээрээс ирээгүй бол Оросын дүрвэгсдийн товчоотой ярьж аавыг муу байна гэж хэлээд яаралтай дуудаач гэж гуйгаарай гэхэд Сувдаа холбоо руу явахаар гэрээсээ гарлаа.

Цэен гүн, хар тамхины хандаар тариулаад хэдэн цаг мансуурч,

гүн нойронд дарагдаад сэрсэнгүй. Сайнжаргалын сэтгэл нэг талаар жаахан уужирсан боловч шөнө дүл өнгөрөөгөөд сэтгэл сэрхийлгэсэн бодолд автагдав. Шөнө дүл өнгөрөөгөөд Кавасу, гүнгийн хоёр булчинд хар тамхины хандаар бэлдсэн тариа хийлээ.

- Одоо өглөө болтол нэг их сандаргахгүй байх. Ингээд сувилагч ирнэ. Би өглөө эрт ирнэ гээд Кавасу явлаа. Чингээд Сувдаа, Сайнжаргал хоёр эцгийнхээ орны дэргэд сууж түүнийг ажиглаж байхад гэрийн нь үйлчлэгч нар үүдний өрөөнд бөөгнөрөн сэтгэл түгшин сууцгаана. Сувдаа Гэрэлээг үгүйлэхийн эрхээр хаалга үүд чахрах тоолонд суудлаасаа өндөсхийж «Одоо ирж байх шиг байна» гэж бодох боловч түүний горьдлого талаар өнгөрнө. Тэгээд аргаа барахдаа,

- Гэрэлээ ажаа яачихваа. Одоо ирэх болсон баймаарсан. Сайнжаргал эгчээ, танд юу гэж хэлээд явсан бэ гэж шалгаана. Сайнжаргал Сувдаагийн сэтгэлийг бодоод үнэн учрыг хэлэхээсээ зовно. Гэсэн ч түгшсэн сэтгэлийн харгайгаар,

- Гэрэлээ ажааг хэрэггүй явууллаа. Ийм гай тохиолдоно гэдгийг даанч мэдсэнгүй гэхэд Сувдаа сэжиг авч,

- Юу! Амьтан хүнд хорлуулчихсан юм биш биз гэж асуухдаа сэтгэлээ түгшээсэн далдын совинд автагдлаа.

- Мэдэхгүй, өдий хүртэл ирэхгүй байхыг бодоход нэг учир ургалаа. Гэхдээ өглөө болтол хүлээ. Одоо хаана гэж сураглах вэ? Бас тэрэгчин (хүн хөлөг) өнөөдөр үзэгдсэнгүй. Бодвол тэр хоёр хамт яваа байх гээд Сувдаа өөд харахад түүний нүдэнд нулимс цийлэгнэсэн байв. Сайнжаргал, Сувдаагийн нулимсыг хурууны өндгөөр арчаад аргадтал,

- Сайнжаргал эгчээ, хүний хараал зүхэлд өртчих шиг боллоо. Адиагийн бие бүр муудаад нэг л биш. Ядаж Гэрэлээ ажаа алга болчих шиг боллоо. Ер нь Гэрэлээ ажаад ямар нэг гай дайрсан юм шиг бодогдоод байх юм гэж гонгиноно.

- Одоо яая гэхэв. Хорвоогийн амьдрал ийм хатуу байдгаас хойш, яах ч арга байхгүй. Эрт орой хэзээ боловч ийм хагацал үзэх байсан. Харин одоо гутарч болохгүй. Харамсалтай нь гэвэл...

Сайнжаргал үгээ гүйцэд хэлж чадсангүй. Түүний уруул өмөлзөж, давхраатай нүдэнд нь нулимс гүйлгэнэсэн авч сэтгэлээ

барина.Сайнжаргал, Сувдааг ширтсээр,

- Ийм зураг тавилантайгаас хойш амьдралын зам мөрийг дагахаас өөр арга байхгүй гэхэд түүний царайны гуниг, уй гашуу агшны төдийд сарниад ерийн тайван болчихсоныг мэдсэн Сувдаа «Яасан их тэвчээр вэ? Би бол өдийд ухаан жолоогүй уйлаад яах ч учраа олохгүй байгаа даа. Гэтэл Сайнжаргал эгч, юм бүхнийг цэнэж тунгаагаад, тун хянуур хандах юм» гэж бодоод сэтгэлээ барихыг хичээнэ. Үүр хаяарч байхад Сайнжаргалын сэтгэл дэнсэллээ. Тэгээд дотроо «Гэрэлээ ажаа өдийд амьд яваа болов уу. Яах гэж явуулав даа» гэж бодохоос сэтгэл нь харанхуйлагдаад зүрх яг зогсчих шиг санагдавч өөртөө «Ийм л үед тайван байх ёстой. Ямар ч гэсэн сэтгэлээ барих хэрэгтэй» гэж сануулна.

Сайнжаргал, өглөө болмогц тэрэгчинтэй уулзаж учир байдлыг мэдэж болох авч сэтгэл нь дэнсэлсээр байлаа.Тэгээд тэссэнгүй Симо то руу утасдаж байдал төлөвийг мэдье гэж бодоод түүний гэр рүү утасдсан атал тэрээр утсаа авсангүй. Гэвч энэхэн үед Симо то гэр алба хоёрынхоо аль алин дээр байгаагүй. Түүнийг хаашаа явсныг хэн ч мэдээгүй болой. Сайнжаргал Симо тоог хайж ядаж байсан тэр үед тэрээр хотын захад байдаг хээрийн цагдаагийн газрын нэгэн хэсгийн байшингийн умгар өрөөнд Сойхаратай ярьж байв.

...Симо то өдөр гэр рүүгээ явах санаатай өрөөнөөсөө гарах гэж байтал түүний утас дуугарчээ. Тэрээр утсаа авгал Сойхарагийн дуу утасны чагнуурт хадав.

- Шиү са доноо, Гэрэлээ хотын захад байдаг нэг өвгөнийх рүү очих янзтай явж байна.

- Тай и, байдлыг нь сайн ажигла! Ер нь баривчилсан дээр. Тэгээд бидний ажиллагааг сэжиглэж үү гэдгийг мэдэх хэрэгтэй! Сайнжаргал, Сувдаа хоёрын аль аль нь ямар нэг сэжиг аваагүй нь батлагдвал шууд устга! Харин тэдний хэн нэг нь мэдэж байгаа бол хэрхэхээ бодох хэрэгтэй. Би наад цагдаагийн чинь хэсэг дээр очно гэлээ. Симо то хотын захад байдаг хэсэг дээр ирээд удаагүй байтал Сойхара хошуучтай холбоо барилаа.

- Шиү са доноо, гүнгийн хашааны үүд сахидаг өнөө хүн хөлөг чинь жирийн гуйлгачин байгаагүй байна.
- Тэгээд түүнийг барьж чадав уу?
- Уг нь амьдаар нь барих гэсэн юм л даа.
- Сойхара сан, юу болсныг нэгд нэгэнгүй илтгэ. Битгий ээрч муураад бай! гэж байдаг чадлаараа хашгичин омогдлоо.
- Шиү са доноо, Гэрэлээ хотын захад байдаг өнөө хөгшнийд очсон. Бид түүнийг хөгшнийхөөс баривчлаад гарч иртэл тэр тэрэгчин, Гэрэлээг харгалзаж явсан манай хоёр цагдааг нударчихаад бидэнд халдсан. Гэрэлээ тэр мөчийг ашиглан самбаачлан зугтсан боловч гудамжны нөгөө талд үлдсэн давхар харуулынханд баригдсан юм. Бид тэрэгчинг амьд барихын даваан дээр гай болж эцсийнхээ сумаар өөрийгөө тонилгочихлоо гэхэд Симото амандаа «Гэрэлээг амьд гарч чадлаа гэж үзээд өөрийгөө устгасан байх нь! Тэр шулам амьд мултарсан бол бүх хэрэг явдлыг Сайнжаргалд дуулгаад биднийг хийцлэх байж дээ. Харин Сойхара давхар харуул гаргасан нь аз болж» гэж шивнээд,
- Гэрэлээг яасан бэ? гэж лавлалаа.
- Урьдчилсан байцаалтаар хэд хэдэн зүйл тодруулаад байна. Бид тэрэгчний үхдэлийг үзүүлээд «Одоо энэ хэрэг явдлыг хэн ч мэдэхгүй болсон. Тэгэхээр чамайг бидний гарт байгаа гэдгийг мэдэх хүн байхгүй» гэсэн чинь Гэрэлээ «Сайнжаргал энэ бүхнийг мэдэж байгаа. Хэрвээ намайг маргааш өглөө гэхэд гэртээ очихгүй бол асуудлыг Токиод ч илтгэж магадгүй» гээд суллаж тавихыг шаардаж байна.
- Тай и, чи тэгээд ямар саналтай байна. Өглөө болохоор явуулчихъя гэж бодож байна уу? гэхэд Сойхара, хошуучийнхаа дууны өнгөнөөс айж,
- Шиү са доноо, одоо уучлал гуйгаад болсон хэрэг явдлыг аятайхан шиг цагаатгаад буцаахаас өөр зам алга. Гэхдээ өглөө болтол нэлээн хугацаа байна гэлээ.
- Чиний толгой гашилж гүйцжээ. Гэрт нь буцаана гэдэг чинь солиотой хүний бодол болохоос эрүүл саруул хүний санаанд орох зүйл биш!
- Гэрэлээг гэрт нь буцааж болно. Гэхдээ хэрэг явдлыг Сайнжаргалд ярьж чадахгүй болсон тийм нөхцөлд буцааж болно шүү дээ гэхэд Симото «Энэ чинь ухаалаг, овжин санаа байна» гэж бодоод,
- Тэгвэл мэдрэлийн эмнэлгийн мэргэжилтнүүдэд тусгай
- шугамаар үүрэг өгч, ам тангарагийг нь авах болж байна уу? Эсвэл чамд төлөвлөсөн юм байна уу? гэж асуулаа.
- Нэг арга байна. Мантэцу нийгэмлэгийн дэргэд шинээр байгуулаад байгаа өнөө Б—11 гэдэг сорин турших газар өгөөд, маргааш өглөө болтол ямар нэг арга хэмжээ авахуулж болно шүү

дээ.

- Би одоохон тэднийхэнтэй яриадахъя. Чи над руу дахиад утасдаарай. Эсвэл өөрөө хүрээд ирнэ биз. Тэгэхдээ нааш нь Гэрэлээг авчирсны хэрэггүй.

Симото, Сойхаратай ярьсны дараа өмнөд манжуурын төмөр замын нийгэмлэгийн захиргааны дэргэд нууцаар байгуулсан «Ус шинжилгээний хэсэг» хэмээх энгийн нэртэй газар руу ярилаа. Хэн хүний сэтгэлд аймшиг төрүүлмээргүй даруу хаягтай энэ газар Зөвлөлтийн алс дорнод, ар өвөр монгол, хятадын нутгаас авчирсан усны дээжийг шинжилж ямаршуухан нян үржиж болохыг судалж, улс гүрнийг устгах аюулт нянгаар бэлдсэн зэвсэг туршдаг билээ. Японы армийн бактерлогийн зэвсэг туршин судлах энэ газрыг армийн дээд зиндааныхан «Б—11» гэсэн нь чухамдаа «Армийн нян» гэсэн үгийн эхний үсгийг тооны хэлбэрт шилжүүлсэн ярианы этгээд дуудлага болой. Симото, Гэрэлээг тийш шилжүүлээд өглөө авахаар тохиролцоод Сойхараг «ус шинжилгээнийхэн» рүү явуулав. Чингээд Сойхаратай байн байн утсаар холбоо барьж, байдлыг сонсоод Сайнжаргалтай хэрхэн ярилцахаа бодно. Гэрэлээгийн эмчилгээ үл ялиг шалтгаанаар удааширсан боловч туршлагатай эмч нар, дөрвөн цагийн дараа Гэрэлээг шилжүүлж өгнө гэж амлав. Симото эмч нартай болзсон цагаа хүлээж ядан суутал утасны хонх жингэнэв. Тэрээр харилцуураа авч чагнатал Сайнжаргалын дуу чагнуурт цангинахыг сонсоод «Яах аргагүй сэжиг авсан байх нь. Гүнгийн бие муудсан бол Кавасу эмчтэй ярих ёстой. Үүрээр ингэж утасддаг сайн хэрэг биш шүү. Юу ч гэсэн ярианы байдлыг харъя» гэж бодлоо.

- Симото сан, Гэрэлээ ажаа урьд шөнө гэртээ ирсэнгүй. Уг нь нэгэн өвгөн эмчтэй уулзаж эм тан сураглахаар явсан юм. Гэтэл одоо хүртэл ирсэнгүй. Та сургийг нь гаргах талаар бодохгүй юу! Миний сэтгэл зовоод байна гэхэд Симото «Сайнжаргал бүх учрыг гадарласан байх нь. Энэ ч аргалж болохгүй хэрэг дэгдлээ шүү» гэж бодоод айх шиг болов.

- Сайнжаргару сан, би яасныг нь мэдээд утасдъя. Харин гурван цагийн дараа Тозияа сан ирнэ. Гүнгийн бие хэвэндээ байна уу? гэж болгоомжтой хэлэхийг хичээсэндээ үл ялиг ээрэв.

- Аав ч тарианы хүчинд одоохондоо шаналгаагүй байна. Үргэлж мансууралд байгаа болохоор бас айгаад байх юм. Одоо тариаг нь зогсоож мансуурлаас сэрээдэг юм билүү. Ядаж ганц аяга бүлээн юм амсаг гэж бодоод байна.

- Таны хэлдэг ч зөв байх шүү. Мансуурлаас сэрвэл бас санаа бодлоо ярьж хэлнэ. Өөрийн нь бодлыг сонссон дээр. Дандаа ингэж тариа хийгээд байх дээр үү гэдгийг лавла! Өвчний нь шаналгаа жаахан гайгүй бол хааяа хааяа завсарлаж байвал дээр шүү.

Симото хэдийгээр чингэж энэрэнгүй зөөлөн сэтгэлтэй тусч хүн шиг ярих авч түүний сэтгэлд өөр зүйл хадаастай. Тиймээс Сайнжаргалын ярианы өнгийг ажиж байхдаа «Сойхараад хэлсэн Гэрэлээгийн үг үнэн үү! Эсвэл ахмадын зүрхийг үгээр үхүүлэх гэсэн мэх үү! Гэрэлээ ахмадыг айлгаж, сүрдүүлэх аргаа хэнээр ч заалгуулалгүй хийж чадна. Гүнд хортой эм тариа хийж хүндрүүлсэн гэдгийг Сайнжаргал мэдсэн бол бидний хэнтэй ч ингэж ярихгүй. Тэгвэл хий сэжгээс цаашгүй хэрэг үү? Эсвэл эргэлзээд цэнэж байгаа хэрэг үү? Сайнжаргал юу юуны туханд хүрэлгүй сэрдэж сэжиглэх хүн биш. Тэгэхээр Сайнжаргал хортой эм, тариа хийж магадгүй гэдгээс болгоомжилж байгаа болохоор Гэрэлээг надаас сураглаж байгаа байна»

гэдэг бодол сэтгэлд нь буув.

Симото, Сайнжаргалтай ингэж ярихдаа Гэрэлээгийн сургийг цагийн дотор гаргаж өгнө гэж амлаад сэтгэл мэдрэлийн мэргэжилтэнгүүдтэй уулзахаар «Б—11» рүү явжээ. Тэгээд тэдэнтэй тохирсон хэд хэдэн боломж гаргаад гүнгийнх рүү зүглэлээ. Симото, Сайнжаргалд юу гэж хэлэхээ нарийн боловсруулсан ажээ.

Сувдаа Симотоог угтан, түүнийг дагуулж, зочдын өрөөнд орж ирэхэд Сайнжаргал, гантиг хашлагатай усанд эрх дураараа сэлж байгаа тао загасандаа хоол өгч, бодлогошрон сууна. Тэгээд Симотоог орж ирэнгүүт суудлаасаа босож угтан уулзаад,

- Симото сан, Гэрэлээ ажаагийн сургийг гаргав уу? гэж шалгаав.

- Сайнжаргару сан, жаахан эвгүй юм болсон байна гэхэд Сайнжаргал Симотогийн царай өөд ажиглангуй харахад түүний тунгалаг цайвар царайнаа уур омог илэрсэнгүй. Симото, Сайнжаргалыг үнэн баримтанд түшиглэсэн бол түүний царайнд атаа хорсол бүхий өширхөл илэрнэ гэж бодсон билээ.

- Юу? Тэгээд амьд уу? гэж харамссан дуугаар асуухад Симото,

- Гэрэлээ амьд байгаа. Гэрэлээгийн ажиллаж байсан газар (янхны газар) танилцсан хэдэн залуус, гудамжинд дайралдаад бие, цогцост нь халджээ. Шалиг самуун залуус, согтуу үедээ сайхан хүүхнийг хараад тэсдэггүй шүү дээ. Тэгээд улайм цайм барьж аваад гудамжны цэцэрлэг рүү чирсэн байна. Харин танай хашааны дэргэдээс салдаггүй тэрэгчин Гэрэлээг аврах гэж тэдэнтэй ана мана үзэлцээд хоёр залууг нь нударчихаад өөрөө нас баржээ. Тэднийг тэгж бужигнаж байх хойгуур бас хоёр гурван залуус Гэрэлээг нэг газар аваачсан байна. Сайнжаргал, Симотогийн үгийг сонсоод өөрийн эрхгүй уйллаа.

- Сайнжаргару сан, та тайвширч үз! Тэр залуусыг бүгдийг нь барьсан гэхэд Сайнжаргал,

- Ямар хатуу хорвоо вэ? Нэгийг нь өвчин тамлаж байхад нөгөө нь зэрлэг танхай залуусын гарт тамлагдаж байдаг. Яасан хатуу хорвоо вэ гээд эхэр татан уйлав. Чухам энэхэн үед зэргэлдээх өрөөнөөс Сувдаа орж ирлээ. Тэгээд хэдэн мөч өнгөрсний дараа Сайнжаргал,

- Сувдаа чи, аавын дэргэд оч доо. Одоо тариаг нь хийх болж байна. Би Симото сантай яримаар юм байна гэхэд Сувдаа өрөөнөөс гарлаа.

- Симото сан, Гэрэлээ ажааг яасан бэ? гэж асуусан Сайнжаргал нулимсаа барьж ядан өмөлзөв.

- Тэд нар Гэрэлээг хотын захад байдаг нэгэн эзгүй байшингийн ногооны зооринд оруулж хүчиндээд гашилж үнэр орчихсон торхтой ногоонд хийчихсэн байна. Гэсэн ч Гэрэлээгийн аз дайрч амьд гарсан. Харин энэ бүхэн Гэрэлээгийн сэтгэл санаанд их хүчтэй нөлөөлжээ. Үзэшгүй муухайгаар доромжлуулсандаа болоод галзуурчихсан байна. Одоо эмнэлэгт байгаа. Эмч нар үзэж бололцоотой бүхнийг хийнэ гэж амласан.

- Симо то сан, хоёулаа эмнэлэг рүү явья гээд Сайнжаргал хувцсаа сольж өмсөхөөр өрөөндөө орлоо.

Симото, зочдын өрөөнд ганцаараа үлдэж, цагаан гантиган хашлаган дахь усанд сэлж байгаа тао загасыг харж зогсохдоо «Сувдаа, Сайнжаргал хоёрын хэн хэн нь бидний ажиллагааг мэдээгүй юм байна. Гэрэлээ нэлээн юм мэдэж байгаа боловч эдний сэтгэлийг зовоохгүйн тул ганц ч үг цухуйлгаагүй бололтой» гэж бодов. Чингээд Сайнжаргал, Симототой хамт хотын сэтгэл мэдрэлийн эмнэлэг дээр ирлээ. Гэрэлээгийн сэтгэл санааг өөрчилж чадсан «Б—11»-гийнхан Симотогийн заавраар түүнийг хотын эмнэлэгт Сойхарагаар хүргүүлсэн ажээ.

Сойхара Гэрэлээг эмнэлэгт авчраад эмчийн өрөөнөөс гарч амжаагүй байхад орж ирсэн Сайнжаргалаас царай буруулж шал ширтэн зогссон Сойхарааг Симото нүдний булангаар ажна. Симото, Сойхарагийн болхи байдлыг харангуут дургүй нь хүрч, уурандаа толгойгоороо үүд рүү зангахад Сойхара даргынхаа дохиог ойлгоод тэднийг Гэрэлээгийн өрөөнд аваачив.

Давчуу жижигхэн өрөөний ханыг зөөлөвчилсөн эдээр доторлож, тохилог зассан, шалыг нь хүртэл зөөлөвчилсөн ажээ. Энэ нь Гэрэлээг хана, шал мөргөхөөс болгоомжилсон хэрэг. Шалан дээр суугаад хана түшсэн Гэрэлээ өрөөний хаалга руу гөлрөх боловч орж ирсэн хүмүүсийг харсан шинжгүй. Хүрэн үйтэн хуараар хийсэн дээлийнхээ энгэрийн дагуу хумсаараа хүүлж, цуулсан болохоор дээл нь тамтаггүй урагджээ. Гэрэлээгийн үс, толгой, нүүр царай, байдал төрхийг харахаас Сайнжаргалын нүд далдирч «Даанч яав даа. Би болгоомжгүй байснаас энэ хүн, дайснуудынхаа гарт тамлагдлаа» гэж бодохоос сэтгэл харуусна. Тэгээд биеэ барьж чадалгүй, Гэрэлээгийн дэргэд очиж, газар сөхрөн суугаад хоёр хацрыг нь ээлжлэн илж,

- Гэрэлээ ажаа минь, юу болов оо гэж уйлагнан асуухад Гэрэлээ хаалга руу гөлөрсөөр байлаа. Түүний уруул өмөлзөн, ямар нэг юм хэлэх авч дуу нь цээжний хөндийд хүржигнэхээс цаашгүй.

- Сайнжаргару сан, их айж, хэтэрхий гутарснаас болоод сонсгол, ярианы эрхтэнгүүд нь сааталд орсон гэнэ. Тэгээд зогсохгүй урьд өмнө тархиндаа гэмтэл олж байснаас шалтгаалж,

сэтгэлд хадгалагдсан ахуй амьдрал, атаа жөтөө, цөхрөл гутралын нөлөөгөөр сэтгэлийн эмзэг бүхэн өртөгдөж ийм байдалд хүрсэн гэж үзэх үндэслэлтэй юм гэж эмчийг хэлэхэд Сайнжаргал, эмчийн үгийг төдий л үнэмшсэнгүй. Сайнжаргал Гэрэлээгийн дэргэд суугаад хацрыг илж, хэсэгхэн бодолхийлснээ, шалнаас өндийгөөд,

- Эмчээ энэ эмэгтэйг одоо би аваад явна. Ийм хүн эмчилгээ авахгүй гэдэг нь илэрхий гэхэд эмч Симото руу хараад мөрөө хавчгануулав.

- Сайнжаргару сан, эндээ хэд хоновол яасан юм бэ? Их айж сандарснаас үүссэн саатлууд аажимдаа тайвшрах явцад сарнидаг гэдэг шүү дээ гэж Симотоог хэлэхэд Сайнжаргал,

- Гэрэлээ ажааг гэртээ аваачвал таны хэлснээр алгуурхан тайвширч саатлууд нь сарниад хуучин хэвэндээ орж магадгүй гэж бодож байна гэхэд Симото, эмч хоёрын аль аль нь юу ч хэлж чадсангүй.

Үд өнгөрөөгөөд Симото, Мугдэнгийн хойд хэсэгт байдаг цэргийн нисэх онгоцны буудал дээр ирлээ. Онгоцны буудал дээр шаргалдуу зэвхий хувцастай самурай нар холхилдон, хөл үймээн ихтэй байв. Мугдэнгийн цэргийн төлөөлөгчийн газраас нисэх онгоцны буудалд байдаг японы цэргийн нисэхийнхэнд «Тусгай онгоц» ирэх тухай мэдэгдсэн болохоор буудлын эргэн тойронд хамгаалалт гарсан ажээ.

Симото, ажил үүргийнхээ дагуу энгийн хувцастай байлаа. Тозияа, энгийн хувцас өмсдөг болохоор Симото, сэнсэй багштныхаа сэтгэлд тааруулсан хэрэг. Тэрээр онгоцны буудлын тусгай өрөөний цонхоор талбай руу ширтэн зогсоно. Симото ойрын хэд хоног шиг сэтгэлээ түгшээж байсангүй. Долнуураас ирсний дараа түүний сэтгэл үл мэдэгдэх нэг юманд түгшээд байдаг боллоо. Симото юунд ингэж түгшиж байгаагаа багцаалсан атал түүнээс хэрхэн сугарах вэ? гэдгээс сэтгэлээ шаналгана. Тэгээд Сойхарагийн болгоомжгүй явдлуудаас болж балрах вий гэхээс айна. Гэсэн ч Симото арга ухаан олодоно гэдэгт итгэнэ. Нэгэн япон дэслэгч гаднаас орж ирээд номхон зогсоод ёслолгуут,

- Шиү са доноо, онгоц буух гэж байна. Тозияа сан хамгийн түрүүнд бууна гэхэд Симото өрөөнөөс гарлаа.

Онгоц талбай дээр бууж тогтоосон газраа ирж зогсоод мотороо унтраалаа. Тэгээд сэнсний эргэлт зогссон хойно онгоцны хаалга нээгдэж, намхан биетэй, цулцгар царайндаа зохисон монцгор хамрын доор ургасан япон сахлаа нямбайлан зассан, эрхэмсэг байрын ахимаг насны нэгэн хүн бууж ирэхэд талбай дээр байсан япон дарга нар түүний бараанаар номхон зогсов. Энэ хүн бол Хохидо Тозияа байлаа. Тэрээр одоохондоо Тяньжин дахь консулын газар данстай бөгөөд тусгай даалгавраар тэндхийн тагнуулыг удирдаж, хотын танхай залуус, нууц нийгэмлэгтэй холбоо тогтоон ажиллаж өөрийнхөө ажил төрлийг явуулдаг. Тозияа хурандаа цолтой атал цэргийн хувцас өмсөж байхыг хэн ч хараагүй. Симото, онгоцноос бууж байгаа сэнсэй багштан Тозияаг угтан мэнд лавлалат тэрээр,

- Гүнгийн бие ямар байна? гэж асуулаа.

- Ер нь барагтайхан байгаа. Бараг амьсгаа хураачих гээд байна. Одоохондоо дээнгийн хандаар тарьж, өвчнийг нь намтган торгоож байгаа гэж Симоог хэлэхэд Тозияа,

- Хурдан очих хэрэгтэй гэж яарлаа. Чингээд сэнсэй, шавиа даган буудлын байшингийн гол хаалганд тулгах шахам зогсоосон машинд суугаад гүнгийнх рүү чиглэв.

- Симото сан, гүн ярьж чадах уу? гэж Тозияаг асуухад Симото,

- Ярих байхаа. Өчигдөр оройноос хойш мансуурлыг нь гаргах гэж оролдоод байгаа. Сайнжаргал ч гэсэн мансуурлаас сэрээе гээд байгаа. Би зөвхөн Кавасу эмчээс биеийн нь байдлыг лавладаг гэлээ.

Тозияа ийнхүү шавьтайгаа ярьсаар хөнгөн тэрэгний арын суудлын зөөлөн түшлэгийг налан суухдаа «Гүнгээс баталгаа гаргуулж чадахгүй бол Богдын алтыг Шанхай дахь америкийн банкинд уу, английнханд уу гэдгийг мэдэж чадахгүй болно. Харин нэг боломж бий. Гүнг нас

барсан тухай сонинуудад дорвитойхон шуугиан дэгдээвэл Шанхай дахь америкийн худалдааны танхимын тэргүүн Френчийн гар хөлийн хүмүүс өөрийнхөө банкны

ерөнхийлөгчийн даалгавраар Сайнжаргалтай холбоо тогтоохын тулд Мүгдэн рүү хүн явуулна байх! Мөн английнхан ч ялгаагүй. Тиймээс одоо Сайнжаргалын хөдөлгөөнийг анах хэрэгтэй» гэж бодож байтал хөнгөн тэрэг, хурдаа хассаар гүнгийн байшингийн хэрмэн хашааны даамангийн дэргэд зогсоход Тозияагийн саяын бодол сарнив.

Тозияаг хаалгаар орж ирэхийг харсан Сайнжаргал, түүнийг үүдний өрөөнд угтан уулзангуут ганц ч үг хэлж чадалгүй мэгшин уйллаа. Тозияа, самгардахын эрхээр Сайнжаргалыг тэвэрч,

- Охин минь битгий уйл. Ертөнц гэдэг чинь ийм хатуу хайрхан байгаа юм гэж хүрээний халх аялгуугаар хэлэв.

- Та яасан их удав аа? Би таныг ирээсэй гэж тэсэж ядаж байлаа гэж арай ядан хэлэхэд түүний хацрыг даган урсаж байгаа нулимсыг харсан Симото «Аа халаг! Ийм түргэн нүд аньчихдаг хэрэг үү?» гэж бодтол зүрх нь зогсчих шиг санагдав. Симото, зогсож буй газраасаа хөдөлж чадалгүй хөшөө шиг хөшчихсөн тэрхэн үед Сайнжаргал нулимсаа арчаад,

- Тозияа гуай ийшээ ор доо. Ингэсхийгээд тариаг нь хийнэ. Мансуурлаас нь сэрээх гэсэн чинь өвчиндөө шаналж, орь дуу тавиад байнагэхийгсонсоод Симотоөөрийнхөө чихэнд итгэсэнгүй. Тэгээд сэтгэлдээ «Нээрэн гэж үү? Гэрээслэлийг нь бичиж авах аз заяасан хэрэг үү» гэж өөртөө шивнэж байлаа. Симото, сэнсэй багшаа гадуур хувцсаа тайлж хөнгөлөхийг хараад өөртөө итгэж, гүнээ санаа алдаад, харанхуйлсан сэтгэлээ уужруулаад гүнгийн өрөө рүү чиглэсэн Тозияагийн араас гүйх шахам алхана. Тэднийг гүнгийн өрөөнд ортол Цэенгийн орны толгой дээр зогсож байсан Кавасу, ажигламтгай харцаар хурандаа өөд ширтээд,

- Ингэсхийгээд мансуурлаас сэрнэ. Түрүүчийгээ бодвол өвчин нь жаахан намдсан шинжтэй байна. Ер нь ходоодны хорт хавдар нэг хэсэгтээ тасралтгүй өвдөж байгаад жаахан амсхийдэг л дээ. Гэхдээ та нар гүнтэй ярьж болохгүй. Бие нь иймэрхүү янзаараа байвал маргаашнаас ярилцах бүрэн боломжтой болно гэж учир байдлыг тайлбарлав. Чингээд Тозияа, Симото хоёр эмчийн үгийг дагаж зочдын өрөөнд орлоо.

Тэд шөнө орой болтол гүнгийн биеийн байдлыг ярилцаж байгаад Тозияа гүнгийн хажуугийн өрөөнд ор дэр засуулаад

амрахаар хажуулж, Симото байшин руугаа гэлдэрлээ. Эмч Кавасу, Тозияад бараа болон гүнгийн үлдлээ. Сувдаа шөнө дүл өнгөртөл гүнгийн дэргэд сууж, Сайнжаргал Гэрэлээгийн өрөөнд түүний аяг даган сэтгэлийг нь тайвшруулахыг хичээхдээ учир байдлыг мэдэхийн тулд нялх хүүхдээс юм асууж байгаа юм шиг лавлан асууна. Гэтэл Гэрэлээ Сайнжаргалтай ярих ямар ч бололцоогүй болой. Тэрээр зөвхөн толгой дохин зөвшөөрөх буюу сэгсрэн татгалзах атал Сайнжаргалын асуусан бүхний эсрэг хандах бөгөөд цээжинд нь хий шуугихаас цаашгүй. Чингэж байтал Сувдаа орж ирээд баярласан нүдээр инээмсэглэн,

- Адиа ухаан орж сэрээд байна гэлээ.

- Гэрэлээ ажаа гурвуулаа аав дээр очъё. Аав ухаан ороод сэрчихсэн гэнэ гэхэд Гэрэлээ нүднийхээ зовхийг хөдөлгөлгүй гөлөрсөөр ямар нэг үг хэлэх гэсэн юм шиг цээжээ хүнгэнүүлнэ. Сайнжаргал, Сувдаа хоёр Гэрэлээг түшин хөтөлсөөр гүнгийн өрөөнд орж ирэхэд гүнгийн барааг харсан Гэрэлээ уруулаа жуумалзуулах төдий инээмсэглээд, уруул нь хэдэнтээ өмөлзөвч цээжний чанадад хүржигнэсэн дуу хүнгэнэхээс цаашгүй. Цэен, цонхийсон царайны ухархайнд шигдэн ширгэх шахсан нүдээр Гэрэлээг ширтэхэд нүдний аяганд нулимс гүйлэгнэн, хатаж омголтсон уруулаа хэдэнтээ хий өмөлзүүлээд,

- Миний дэргэд суугаач гэлээ. Сайнжаргал, Гэрэлээг хөтөлж эцгийнхээ орны дэргэд суулгатал Цэен, тамир муутай гараараа Гэрэлээгийн гарыг атган мэлмэрүүлэх авч Гэрэлээ тэр бүхнийг үл анзааран гүнгийн царай руу гөлөрнө. Эцгийнхээ мэлмэрүүлж байгааг харсан Сайнжаргал, Сувдаа хоёр өрөвдөхийн эрхээр тэсгэлгүй уйллаа. Гэтэл Цэен гүн нулимсаа арчиж сэтгэлээ тайвшруулаад,

- Та хоёр уйлсны хэрэггүй. Гэрэлээ ажаагаа асарч яваарай. Бидний төлөө гэж яваад хорлогдсон бололтой. Одоо та хоёр сандарч, айх хэрэггүй тун ухаантай хөдлөх хэрэгтэй. Иймээс уйлж унжилгүй аавынхаа үгийг сайн сонсож ав! Та хоёр нэг эхийн хүүхэд биш ч гэсэн зулай зулайгаа дарж төрсөн эгч дүүгээс илүү барилдлагатай хүмүүс шүү. Хэрэг явдал муугаар эргэж магадгүй. Юуны өмнө Шанхай дахь алтны талаар ямар ч сэжиг авахуулж болохгүй. Тэр тусмаа Иокогама гингоод байгаа зүйлийг өөр

банкинд шилжүүлж болохгүй. Тэгвэл япончууд хар авна.

Ааваасаа хойш энд удаж болохгүй. Энэ их хөрөнгө та хоёрын хэн хэнд халтай. Одоо Иваныг Харбингаас дуудуул гээд амарсхийснээ амьсгаагаа уртаар аваад Сувдаа өөд эгцлэн харав. Тэгээд хатсан уруулаа долоож дэвтээгээд,

- Сувдаа ээж чинь тун сайн яваа. Хаана байгааг эгч чинь мэднэ. Нутгаас ойрын үед нэг хүн ирэх ёстой. Тэр хүн намайг сураглаж ирэхдээ «Очирвааний тиг бүтээчих хүн энд байдаг уу?» гээд хариу хүлээнэ. Тэгэхээр нь «Ажаа гэгээний тиг мэддэг хүн бий» гээрэй. Тэр хүн, бурхны тигтэй зураг гаргаж үзүүлнэ байх. Тигийг сайн ажигла! Очирваань бурхны тигийн баруун нүдний тигийн гамбумыг (нүдний зовхины зураасны хэмжээ) татаагүй байгаа. Тэр хүнтэй уулзаж ярилцсаны дараа бурханч Бадрах гэдэг хүний сургийг гарга! Тэр хүн алтны талаар ямар нэг захиа ирүүлэх ёстой. Тэгээд Богдын алтыг халх руу буцаах талаар ярилцана биз. Би тэр хүнд захиа бичсэн. Тэр захиа нууцын шүүгээнд бий. Тэр алт бол бидний хөрөнгө биш. Түүнд шунаж болохгүй. Тэр бол монгол улсын хөрөнгө гэдгийг ойлгох хэрэгтэй. Тиймээс буцааж явуулах нь зүйтэй биз гээд гүн нүдээ аньж хэсэг хэвглээ. Цэенгийн аньсан зовхи алгуурхан хөдөлж, тогтуун харцаар Сайнжаргалыг ширтэн, дэрээ өндөрлөхийг хичээв.

Сайнжаргал эцгийнхээ цээжнээс өргөхөд Сувдаа дэрийг нь өндөрлөв.

- Аав аа та, жаахан бүлээн юм уухгүй юу гэж Сайнжаргалыг хэлэхэд,

- Харин ээ. Ер нь жаахан бантан оочилбол дээр байх. Миний бие сэрүү оргиод нэг л хөнгөн шингэн болчихсон байна гэлээ. Сувдаа гүнд бантан хийж ирэхээр өрөөнөөс гарахад Цэен,

- Хөөрхий энэ муу хүүхэн, ийм болчих гэж дээ. Хүний мөс сайтай хүн юмсан. Өнөө Симото, Сойхара хоёр алтны нууцыг мэдэж чадсангүй гэж ийм болгоо биз. Би эднээс урьтаж чадахаасаа өнгөрлөө. Ингэхээр Сайнжаргал минь тун болгоомжтой байгаарай. Ер нь Тозияа ч гэсэн тийм ч сайн хүн биш бололтой. Түүнийг дуудсан уу? гэв.

- Дуудсан. Өнөөдөр ирсэн, хажуугийн өрөөнд унтаж байгаа.

- За яахав. Унтаж байг! Аав нь охиндоо нэг юм өгчихье гээд хүзүүндээ зүүж явдаг сахиусаа авч, сахиусны оёоны заагаар нэгэн түлхүүр гаргаад Сайнжаргалд өгөхдөө,

- Аавынхаа нууц шүүгээний дээд талын шургуулгыг онгойлгоод үз! Манай байшингийн доод зооринд нэг муу авдар бий. Түүний цоожийг үүгээр онгойлгодог юм. Тэр авдар давхар ёроолтой юм шүү. Түүн дотор байгаа дархны багажуудыг аятайхан аваад давхар ёроолыг сөхөөрэй. Миний нууц шүүгээний дотор талын шургуулганы түлхүүр тэнд байгаа. Тэнд миний гэрээслэл бий. Захиа ч байгаа. Түүнийг сайн уншаарай. Шанхайн банктай харилцах нууц бичиг тэнд байгаа. Түүнийг Аюуш гүүшийн галиг үсгээр хятад хэл дээр бичсэн юм. Чи галигийг мэдэх хойно учир утгыг нь хэлүүлэлтгүй ойлгоно. Аав нь энэ хэдэн жил чамд япон, пийлэн хэл заалгуулсан хойно чи газардахгүй, хүний царай харахгүй байх. Хэлгүй хүн гэдэг чинь хүний нутагт сохортой адил байдаг юм гээд Сайнжаргалын дух руу унжсан үсийг алгаараа илж, хойшлуулаад духан дээр нь үнслээ.

Үүр цайх үед Сайнжаргал Кавасугийн өрөөнд орж сэрээгээд,

- Аав ухаан орсон. Та очооч гэхэд Кавасу хувцаслаад Тозияаг сэрээн гүнгийн өрөөнд орлоо. Тозияа гүнгийн өрөөнд оронгуут махны хурц үнэр үнэртэхийг ажиглан хамраа үл мэдэг сэртэгнүүлэн үнэрлэснээ, гүнгийн орны дэргэд ирж суухдаа, ширээн дээр байгаа аяга руу хяламхийн ажив.

- Цэенээ, бие бүр овоо шив дээ гэж сэтгэлийг нь тайвшруулаад гангар шаазангийн ёроолд үлдсэн цайны шавхрууг сэм хараад «Гүнтэн бантан хийлгэж идэж дээ. Тэгэхээр сая ухаан орж байгаа биш, нэлээн эрт ухаан орсон байх нь. Мансуурлаас сэрснийх нь дараа бантан хийж, идүүлсэн болохоор нэлээн удсан хэрэг» гэж бодлоо.

- За яахав дээ. Эмч нарын ачаар та нартайгаа хэдэн үг солих азтай юм байна.

- Цэенээ, Токио явж эмчлүүлэх үү дээ. Тэгвэл зохих ёсны арга хэмжээ авья гэж Тозияаг хэлэхэд, Цэен,

- Хэрэггүй биз дээ. Хүн мөнхрөх биш. Цаг нь болсон бол тэнд ч гэсэн ялгаагүй гэж хэлээд татгалзав.

- Цэенээ, чи өөрийнхөө хүссэнийг нүдээрээ үзэх ёстой. Одоо

манжуурыг шийдэхийн даваан дээр ирчихээд байна. Манжуурын хэрэг явдлыг цэгцлэнгүүт гадаад монголын асуудлыг шийдэхээр төлөвлөөд байгаа. Өөрөөр хэлбэл Манжуурыг бие даасан улс болгон эзэн хааныг ширээнд залангуут манай арми, оросын дүрвэгсдийн

товчооныхныг бэлтгэх юм. Тэгэхээр чиний хүссэн хүсэл биелэх цаг хугацаа ойртоод байна гэж хэлтэл Симо то гаднаас орж ирлээ.

- Японы сангийн яам Семеновынхныг 4 сая иениэр санхүүжүүлэхээр шийдсэн нь сайхан хэрэг. Би ч гэсэн 500 мянган иень өгөх санаатай байгаа. Харин ар халхын асуудлыг шийдэх явдал нэг л удаашралтай байна. Түүнийг түргэлэх талаар та бүхэн идэвх, санаачилга гаргана гэж найдаж өдий хүрлээ. Нөгөө талаар та бид хоёрт яримаар нэг юм байна. Та нар түр гарч байхгүй юу гэлээ. Чингээд өрөөнд байсан хүмүүс гарч тэр хоёр үлджээ.

- Тозияа сан би, танай армид гэрээслэл үлдээсэн. Нөгөө талаар Богдын алтны талаар хэдэн үг хэлье. Хүрээнээс Ойдов гэдэг хүн ирэх ёстой. Тэр хүн надаас «Хар тамхи сураглаж» асуух ёстой. Түүний хариуд «Алт ховордсон» гэх ёстой. Тэр хүн хариуд нь «Гүнгийн алтыг Иокогама гингоод шилжүүлбэл болно» гэж хэлнэ. Маргааш би охиндоо нэг бичиг ол гэж хэлээдэхье. Чи түүнийг уншиж үзээрэй. Одоо цаадуулаа дуудчих гэхэд Тозияа гүнгийн амнаас сайхан үг дуулсандаа баярлах авч түүнийг батлах албан ёсны баримтгүй байгаадаа сэтгэл зововч гүнгээс ямар нэг баталгаа бүхий бичиг авч чадна гэдэгт итгэнэ.

Гаднаас орж ирсэн хүмүүс нэг хэсэгтээ дуугүй бие биенээ харж зогсоцгоов. Тиймээс Симо то яриа өдөж, Долнуур явсан сониноосоо Цэенд дуулгахаар шийдэж,

- Цэен сан, би сая банчин эрдэнэтэй уулзаад ирлээ. Банчин богд ар халхын асуудлыг шийдэх хамгийн тохиромжтой үеийг 1932 он гэж байна. Ноднин, уржнан хоёр ардын засаг гэгч тэнгэр язгууртай хүмүүсийн хөрөнгийг хурааж, 5 сая төгрөгийн эд агуурсыг 56 мянган гуйлгачинд тараасан гэнэ. Тэгээд зогсоогүй сүм хийдийн лам нарыг хар болгожээ. Энэ бүхэнд дургүйцсэн лам нар, Банчин богдоос тусламж гуйж, манай армитай холбоо тогтоохыг дэмжиж өгөөч гэжээ. Банчин богд бослогыг «Мичин жилтэй хүнээр удирдуулах зарлиг буулгасан. Тэгээд Самбуу

гэдэг дүвчин хүнийг томилсон гэнэ. Энэ жил манай арми манжуурыг хятадаас тусгаарлана. Тэгэхээр банчин богд энэ бүхнийг тунгаагаад «Мичин жилийн зуны дунд сарын 15-наас оройтуулалгүйгээр бослогыг эхлэх хэрэгтэй» гэсэн байна гэхэд Цэен орноос өндийн дэрээ өөдлүүлэхийг хичээхэд Сайнжаргал Сувдаа хоёр эцэгтээ туслав. Гүнгийн өвчний шаналгаа түр намдсан болохоор тэрээр эмзэглэн яраглахгүй байгаа нь хүн бүрийн сэтгэлийг тайвшруулна.

- Энэ чинь сайхан мэдээ байна. Эр хар мичин жил (1932 он) мичин жилтэй дүвчин хүнээр бослого удирдуулна гэдэг чинь тун зөв. Жил нь орж яваа дүвчин хүн, сая төрсөн эм бар хоёр догшин бүрэлбаатай байдаг гэдэг. Дөнгөж төрсөн бар зулзагаа харамлахаар галзуу дүртэн болдог. Жил нь орж яваа дүвчин хүн, хувилгаан чадалтан болдог. Тийм үедээ далай дээр ойчсон өчүүхэн цогийг хэдэн далай дамнасан түймэр болгодог ид шидтэй байдаг гэж хэлэхэд угийн догшин, ширүүн харцтай гүнгийн нүд хар цагаанаараа эрээлжилж, сэтгэлийнхээ догдлолыг барьж чадахгүй байгааг гэрчилнэ. Гэсэн ч Цэен өөрийнхөө биеийг барьж сэтгэлээ тайвшруулж чаддаг болой.

- Тозияа сан, би их азтай алтан үеийг үзэж чадахгүй байж мэднэ. Тэгэхээр ганц охиноо хүний газар ганцаардуулж магадгүй. Чи бид хоёр сайнаар яривал садан төрлийн сүлбээтэй. Хэрвээ

хадан гэртээ харихад хүрвэл чи, ганц охинд минь эцэг болох хүний нэг шүү. Би охиндоо чиний тухай ярьж амжаагүй. Гэхдээ зах зухыг нь хэлсэн. Миний хүсэл мөрөөдөл талаар өнгөрч, ёстой «Их санасан газар есөн шөнө хоосон» гэдэг шиг зүүднээс цаашгүй боллоо. Өвчин хүнийг дөнгөдөг сүрхий гайхал шүү гэж хэлтэл түүний царайд ягаан туяа татсанаа хүзүү чих нь ягаараад явчихлаа. Цэен, сүүлчийнхээ үгийг шүд зуун хэлж амжсаныг ажваас түүний өвчний шаналгаа эхэлсний шинж болой. Цэен уруулаа тас зуугаад, хамраараа гиншиж байснаа дуу нь чангарсаар эрүү хамхилгүй ёолж, шүдээ тачигнатал хавирна. Кавасу энэ зуур хар тамхины хандмалаар бэлдсэн тариагаа хоёр булчинд нь ээлжлэн хийлээ. Чингээд хэдэн мөч өнгөрсний дараа Цэен гүн мансууралд умбан, ухаан балартсаар ёолон гиншихээ болив. Түүний царай өвчиндөө шаналж зовсныг илэрхийлэх гэсэн шиг цонхийх агаад хүйтэн

хөлс дух, хамрын самсаагаар чийхарчээ. Энэ өдрөөс хойш Цэен, орноосоо өндийсөнгүй. Өдөр өнгөрөх тусам муудсаар эм хонин жилийн (1931 оны) зуны эхэн сарын хуучаар насан өөд болов.

...Жанжин штабаас өгсөн үүргийн дагуу Цэен гүнгээс гэрээслэл гаргуулж авах хийгээд хятадад байгаа алтны баталгаа баримт олох ёстой Тозияа, гүнгийн амнаас олигтойхон үг дуулж чадаагүй болохоор Токиод хэрхэн илтгэхээ бодно.

Цэен гүнг нутаглуулснаас хойш Сайнжаргал сэтгэл санаагаа шаналган уй гашуунд нэрвэгдсээр сар гаруй болоход Тозияа түүний сэтгэлийн зовлонгоос хуваалцаж гэрт байлцлаа. Гэсэн ч Тозияа, Сайнжаргалаас эцгийнх нь талаар асууж лавлаж зүрхэлсэнгүй. Тэгээд нэгэн өдөр Симототой уулзаад,

- Токио руу илтгэх гэж яарсны хэрэггүй. Сайнжаргалын сэтгэлийг бодоод амыг нь харъя! Богдын алтны талаар Сайнжаргалаас ганц ч үг сонсоогүй цагт ямар ч алхам хийж болохгүй. Би өөрөө жанжин штабынхантай ярина. Тэр хүртэл хүлээж бай! гэж чандлан тушаалаа.

Тэгээд Сайнжаргалаас үг дуулах санаатай нэг өдөр,

- Би ингэхийгээд Тяньжин руу буцдаг юм билүү дээ гэлээ

- Тозияа гуай та хэзээ явах гэж байна даа. Эргэж ирэх үү? гэж асуусан Сайнжаргал, Тозияагийн хариуг хүлээлгүй яриагаа үргэлжлүүлж, таны ажил хэцүүдэж байгаа байх. Тозияа гуай, аав танд юу гэж ярьдаг байсан бэ? гэж асуулаа. Үнэндээ энэ тухай Тозияа тооцоолоогүй болохоор юу гэж хариулахаа мэдэхгүй хэсэгхэн зуур самгардсанаа,

- Уг нь ярьсан зүйл их. Наанадаж гэхэд чамайг Токио руу сургуульд явуульга гэж ярилцсан. Чи япон хэлэнд хэнээс ч илүү болчихлоо. Тэгээд хятадаар бичиж, ярьж чадна. Үгүйдээ орос, англи хүмүүстэй ойр зуурыг ярьчихна. Ингэхээр мэдлэг боловсролоо ахиулах хэрэгтэй. Тэгээд эцгийнхээ зүдэрч хураасан хөрөнгийг яаж арвижуулах учраа олно гэж аргацаан тайлбарлав.

- Харбин дахь оросын дүрвэгсдийн товчоонд гэрээсэлсэн хөрөнгийг шилжүүлэх үү. Ер нь түүгээр яах ёстой байсан юм бол?

- Одоо өөрөө мэд! Уг нь ар монголд гарах хөдөлгөөнийг зохион байгуулах хүмүүсийг бэлтгэхэд нэлээн хөрөнгө зарцуулах

ёстой байсан. Зэр зэвсэг худалдаж авах, түүнийг зөөж тээвэрлэх гээд зөндөө ажил бий. Энэ бүхэн мөнгөгүйгээр бүтэх биш дээ.

- Тозияа гуай аав, эзэн хааны армид нэлээн зүйл зориулна гэж байсан. Тэр ямар учиртай юм бэ? гэхэд Тозияагийн сэтгэл сэргэх шиг болов.

- Тэр үү? Аав чинь ардын засгийг устгаж, Богд хаант улсаа байгуулах асуудлыг эрхэлж байсан Богдын төлөөний хүн. Тиймээс Богдын алтыг, монгол руу чиглүүлсэн армийн ажиллагаанд зориулж цэрэг, зэвсгийн тусламж авахад хэрэглэх ёстой байсан юм. Харин одоогийн нөхцөл байдлын хувьд гэвэл чи, аавынхаа үзэл санааг үргэлжлүүлж болно. Арми яваандаа монголыг улааны нөлөөнөөс ангижруулна. Харин одоогийн тулгамдаж байгаа асуудлын нэг бол Ар монгол руу чиглэсэн зам харилцааны асуудал юм. Ардын засгийг устгаж, монголд хуучин засаг төрийг байгуулмагц гүнтэн Буйр, Халх голын сав газрыг хошуу нутгаа болгоод, үйлдвэр байгуулахын тулд Хайлараас төмөр зам тавина гэдэг байсан. Бодвол энэ бүхнийг байгуулахад алтаа зориулна гэж бодсон байх. Гүнтэн төмөр зам тавиулбал манай армийн цэргийн тээврийн тулгамдсан асуудлыг шийдэхэд тус болох юм. Энэ бүхнийг талийгаач тунгаачихсан хүн. Гэтэл гайны хар өвчин түүний хүсэл бодолд саад боллоо гэж гашуудан харамссан янзтай үглэнэ.

- Тозияа гуай, та ер нь дөчин ес хоногийг нь гүйцээгээд явбал яасан юм бэ? Тэгээд ч надад тантай ярьж зөвлөх юм байна. Наанадаж гэхэд гэгээн сүм, Долнуур хоёрын алинд нь буяны сүм бариулах ёстойг шийдэх хэрэгтэй. Гэтэл надад зөвлөж ярих хүн танаас өөр байх биш дээ.

- Харин ээ... гэснээ Тозияа, өөртөө олдсон завшааныг алдахад хүрэх алхам хийж байгаагаа мэдэнгүүт, тэгье дээ. Би шуурга уруудаж, салхинд туугдсан юм шиг яараад байх сүрхий ажил байхгүй гэж Сайнжаргалын санааг дагуулан яриагаа аятайхан өөрчлөв.

- Тозияа гуай, та үүнийг уншаач гээд Сайнжаргал муутуу цаасан дээр татсан улаан шугамын хоорондуур хар бэхээр тогтуухан гоёмсог бичсэн нэгэн бичгийг өглөө. Тозияа тэр бичгийг авч үзээд «Үүнийг гүнтэн өөрийнхөө гараар бичээгүй байна.

Бичгийн хэлбэрийг ажвал Сайнжаргалын бичиг шиг байна» гэж бодоод баярласан хүний шинж гаргаж,

- Сайнжаргалаа эцгийнхээ гэрээслэлийг юу гэж бодож байна даа гэж хаяа манасан байдалтай асуулаа.

- Би төрүүлсэн ганц охин нь шүү дээ. Тэгэхээр аавын минь гэрээслэл наддаа хууль гэж хэлэхэд хоолой нь зангирахыг Тозияа ажив.

- Сайнжаргал минь чамд баярлалаа. Чи аавынхаа зан чанарыг тэр чигээр нь хуулжээ. Хэрэв чи ахтай байсан бол ах чинь ингэж хэлэх байсан. Чи ёстой аавын хүү, охиныг орлож чадах юм байна гээд өнөө бичгийг дахин уншихдаа «Гүн охиндоо хэлж бичүүлсэн байх нээ» гэж бодно.

...Эрхэм Тозияа минь, манай удам угаасаа нарийнтаж өөдөлдөг. Тийм болохоор оюун ухаан саруул байгаа дээрээ чамд хэдэн зүйл захимаар байна. Хүн үрийнхээ биеийг төрүүлдэг болохоос сэтгэл санааг төрүүлдэггүй. Гэхдээ сэтгэл санааг нь багаас нь зөв удирдаж, залж чадвал сайн хүн болдог ёстой! Би охиноо хүн шиг хүн болгох гэж яаж зүдэрснийг чи мэднэ. Чиний тус хандив ч бий. Би охиноо хүний зэрэгт хүргэж чадсан болохоор миний бодлыг үргэлжлүүлж чадна. Харин чамтай мэнд уулзахгүй байх гэхээс айх юм. Чи охиныг минь Юки шигээ хүндэтгэн асарч яваарай. Чи намайг орлох эрх бүхий асарсан эцэг нь болж чадна гэдэгт итгэнэ. Та хоёр хөрөнгөөр дутахгүй. Бусдаас хэдэн хувь илүү амьдарч болно. Энэ бол миний өвөг дээдсийн буян. Тэр буяныг арвижуулах аргыг охинд минь хэлж, эцэг хүн шиг түшиж яваарай гэж чамаас гуйх гэсэн юм. Би ингэж гуйх эрхтэй гэдгийг чи андахгүй шүү дээ... »

Цэен гүнгийн захиаг уншиж байгаа Тозияаг нүдний булангаар ажиж суусан Сайнжаргал,

- Тозияа гуай, надад асууж лавламаар зүйл байна гэхэд тэрээр,

- Тэг тэг. Би мэдэх бүхнээ хэлж өгнө гэлээ.

- Эцэг минь тантай танилцаад олон жил болсон. Та хүрээнд юу хийж байсан юм бэ? гэхэд Тозияа юунаас эхлэхээ хэсэгхэн бодсоноо,

- Одоо надад чамаас нуух юм байхгүй. Хэрвээ чи, бид

хоёр талийгаачийн гэрээслэлийг биелүүлж чадвал халхын нэг сурвалжит хүний нэр төрийг өндөрт өргөж явах болно. Энэ бол чухал зүйл гээд Тозияа яриагаа эхэллээ.

...Намайг анх монголд очиход аав чинь манжийн амбан яаманд бичээч байсан юм. Тэгэхэд чи зургаан настай байлаа. Би монголын сэхээтнүүдэд тусалж, манжаас тусгаар улс болж Богд хаант улс байгуулах явдалд дэмжлэг үзүүлэх ёстой байсан. Би хүрээнд багашигхан пүүсний эзэн нэртэй амь зууж байв. Миний тэр пүүсний нэр хүнд өндөрсөх явдалд эцэг чинь их тус болсон. Богд хаант улсыг байгуулсны дараа эцэг чинь сангийн яаманд дээгүүр зиндааны алба хаадаг болов. Гэтэл Сюй Шүжан хүрээнд ирж олон сэхээтнүүдийг тонилголоо. Би эцгийг чинь тэдний мөрдөлт хавчилтаас зайлуулж хөдөө гаргасан. Тэгээд Богдыг суллаж хаан ширээнд дахин залахад эцгийн чинь гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлж, гадаад яамнаа том түшмэл болгосон. Гэсэн ч бидний зовлон үүгээр дууссангүй. Хүрээнд ардын засаг тогтож, намайг наашаагаа явахад эцэг чинь тэндээ үлдэв. Талийгаач намайг Мугдэнд ирснээс хойш нэлээн байж байгаад Богдын даалгавраар энд ирсэн юм гэж ярьсан Тозияа их зүйлийг дэгсдүүлж, давсалсныг Сайнжаргал хэрхэн мэдэх билээ.

- Тозияа гуай Юки гэж ямар хүн байсан бэ?

- Чи сургийг нь дуулсан байх. Ээжийн чинь төрсөн дүүг Должин гэдэг байсан. Бид хоёр амьдрах гэсэн боловч тийм тавилан заяасангүй. Должин нэг өдөр гандан эргээд буцаж явахдаа гамингуудад баригджээ. Тэгээд хэдэн цагийн дараа амь алдсан байсан. Би түүнийг Юки гэдэг байлаа. Энэ нэр бол эртний япон хэлний цасан охин гэсэн утгатай үг юм. Должин цас шиг цэвэрхэн царайтай болохоор би тэгж хүндэтгэдэг байлаа.

- Тозияа гуай миний ээж яаж нас барсныг та мэдэх үү гэж Сайнжаргалыг нухацтай асуух шиг болоход Тозияа хирдхийн цочив. Гэсэн ч сэтгэлийнхээ сандралыг мэдэгдэхгүйгээр өнгөрөөхийг хичээсэн Тозияа, Сайнжаргалын царайг ажвал жирийн ажээ. Тозияа энэ асуултаас булзаарч болохгүй гэдгийг сайн ойлгоод арга буюу,

- Мэдэлгүй яах вэ? гээд санаа алдлаа. Тэгээд яриагаа үргэлжлүүлэв.

- Бидний хэдэн хүмүүс гаминг устгах гэж байгаад сэжиглэгдсэн. Тэд биднийг олохын тулд эхлээд Должинг, дараа эцгийг чинь баривчлах гэж оролдсон болохоор Түнхэл рүү явуулаад чамайг нэг хамаатан дээр чинь хүргэж өгснийг чи мэднэ шүү дээ. Та хоёрыг гамингаас зугтаалгасан боловч Должинг гамингийн гараас зайлуулж чадаагүй юм. Түүнээс болж Должин амь эрсэдсэн. Талийгаачийг нутаглуулснаас хойш ээж чинь савхийвэл дүүгийнхээ оршуулган дээр оччихдог сон. Цагаан мичин жилийн зуны нэг бороотой өдөр ээж чинь дүүгийнхээ шарил дээр очоод буцахдаа гандан эргэх санаатай явж байхад нь цахилгаан цахилж бороо ширүүсчээ. Тэгэхэд ээж чинь хөл хүндтэй байсан. Нэг хүчтэй цахилгаанаас цочихдоо нойтон газар халтираад биеэ тэнцүүлж чадалгүй Тасган овооны зүүн хүр рүү унаад ухаангүй хэвтэж байхад нь нэг хүн олж авчирсан билээ. Ингээд дугуу төрснөөсөө болоод амь насаа алдсан юм. Тэр үед (1920 он) цаг хатуу байсан болохоор талийгаач та хоёрыг дуудуулж чадалгүй нутаглуулсан юм. Гамингууд алхах гишгэх бүхнийг цагдаад болж өгөхгүй болохоор бидний хэдэн хүн эхийг чинь бараг үүр шөнөөр нутаглуулсан. Түүнээс хойш таван сарын дараа чамайг авчирч, гамингаас нуух гэж их зүдэрч байсныг чи гадарлана гэж ярихдаа Тозияа тэртээд өнгөрсөн хэрэг явдлыг санахгүйгээр өнгөрч чадсангүй.

...Тозияа, Должинг гамингаар устгуулсны дараа Цэенг ятгаж Түнхэл рүү явуулаад гэрт нь очихдоо «Гамингууд Цэенг барих гэж хайгаад байна. Бас Должинг бариад явчихсан. Цэенг оргуулж амжсан. Сайнжаргалыг хүрээнээс даруйхан холдуул гэж хэлүүллээ» гэж ятгаж билээ. Тозияа Сайнжаргалыг Туулын гүний хүрээ явуулсны дараа Цэенгийн эхнэрийн алхаа гишгээ бүрийг нүд салгалгүй анаж байлаа. Тэгээд тэр нэг ширүүн бороотой өдөр замыг нь отоож байгаад айлгаж, Тасган овооны зүүн хүрийн нэгэн өндөр жалга руу түлхэж орхисон билээ...

Тозияа энэ бүхнийг бодоод хэсэгхэн зуур балмагдаж, дуугүй суусаар «Сайнжаргал яагаад үүнийг надаас асуусан бэ? Үнэн явдлыг мэдэх ёсгүй юмсан. Эхийг нь олж ирсэн тэр лам бол Хэнтийн Бэрэйбун хийдээс хүрээнд ирсэн хүн. Тэгээд Цэенгийн эхнэрийг нутаглуулсны маргааш нь хүрээ рүүгээ явсан. Үүнийг

Цэен ч мэдээгүй өдий хүрсэн» гэж бодно.

- Тозияа гуай, та яав аа! Бие чинь муу байна уу гэж Сайнжаргалын асуух дуунаар Тозияа сэтгэлээ түгшүүрт эзэмдүүлж, хэсэг зуур дуугүй сууснаа мэдээд,

- Сайнжаргал минь айх хэрэггүй. Миний зүрх мууджээ. Тэгээд сэтгэл санаа уймарсан үед зүрхээр хатгуулах гээд байдаг юм. Одоо жаахан гайгүй боллоо гэж өөрийгөө цагаатгаж чадлаа. Сайнжаргал Тозияагийн бүрсгэр царайг хараад «Хөөрхий энэ хөгшин аав, ээж хоёрт минь тун сайн байж дээ» гэж өрөвдсөн харцаар Тозияаг ширтэж буйг ажигласан өвгөн сэтгэл нь уужирчээ. Сайнжаргал, Тозияатай ингэж ярилцсаны дараа долоо хоноод Гэгээн сүм рүү явах боллоо. Чингээд Сайнжаргал, Тозияа хоёрыг үдэж өгөхөөр Симото төмөр замын буудал

дээр ирлээ. Симотоог харахаас нүд нь хорсон зэвүүрхсэн Сайнжаргал биеэ барьж, жирийн байдлаар дуугүй өнгөрлөө. Тозияа галт тэргэнд суухын өмнө Симотоод,

- Байхгүй хойгуур гэр орныг нь шиншилж болохгүй. Өөрийнхөө хүмүүсийн сүүдрийг ч энэ гудамжинд гаргаж болохгүй гэдгийг Доихара санд дамжуулаарай. Нөгөө талаар Сайнжаргал Гэрэлээг талийгаач ахынх руугаа явуулах гэж байгаа. Түүнийг нэг бол Сувдаа, эсвэл гэрийнх нь хүмүүс хүргэж өгөх байх. Тэгэхээр тэдний хойноос мөрдөж, цагдах хэрэггүй. Эцэст нь гэхэд одоо Сойхара бидэнд хэрэггүй. Түүнийг Мугдэнгээс холдуул гэж хатуухан тушаалаа. Тэд талийгаач гүнгийн гэрээслэлийн дагуу Очирвааний дуганг Гэгээн сүм дээр бариулж, гурван тохой бурхан бүтээлгэхээр шийджээ.

1921 онд японы сайд нарын танхимыг Сэйюкай намын Такахаси толгойлсноос хойш арван жилийн турш улс төрийн хүчнүүд ерөнхий сайдын түшлэгийг булаалдаж арав дахь ерөнхий сайдын нүүрийг үзэж байгаа боловч Вакацуки бас л дэн дунтай байлаа. Хар луу нийгэмлэгийн ятгалгаар цэргийн яамны сайдаас сайн дураар огцорсон генерал Угаки, манжуур явуулахаар бэлтгэж байгаа 10 дугаар дивизийн удирдагч дэслэгч генерал Хонзёотой уулзаж ярилцжээ.

- Хонзёо сан, Хятад японы найрамдалт холбоог бэхжүүлэх хийгээд азийн асуудлыг шийдэхэд чухал гүүр болсон Манжуурт Гуаньдунд байгаа манай цэрэг онцгой үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Та Гуаньдунгийн цэргийг орчин үеийн арми болгох талаар юу бодож байна даа гэж асуусан нь жирийн хэрэг биш байлаа. Тэрээр солонгос руу явах замдаа Осакаад байгаа Хонзёотой санаа бодлоо ярилцсан нь хунтайж Канин, хошууч генерал Кайсо хоёроос авсан тусгай даалгавар байв.

- Угаки сан, армийн удирдлага надад итгэж онцгой үүрэг өгвөл би, түүнийг хэрэгжүүлэх талаар бололцоотой бүхнийг хийнэ. Гуаньдун дахь манай цэргийг арми болгох гэвэл одоохондоо эрт байна. Манай дивиз удахгүй тийшээ явна. Тэгээд манжуурын ажиллагааг амжилтанд хүргэсэн цагт шинэ армийн тухай ярилцаж болох байх. Бид ганцхан манжуурыг биш цаашдаа улаан оросыг алс дорнод, ар монголын нутаг дэвсгэр дээр эзэн хааны дэглэмийг тогтоох ёстой тул Гуаньдунд арми байгуулах нь зайлшгүй асуудал!

- Хэрвээ Гуаньдунд шинэ арми байгуулбал та юу гэж нэрлэе гэж бодож байна даа?

- Гуаньдун бол Ляодунгийн өмнөд хэсэг төдийгүй зүүн умард хятадыг далайтай холбож байгаа цэрэг стратегийн чухал ач холбогдолтой газар. Тиймээс хаант орос, хятад хоёр Гуаньдунг манай хараанаас салгахыг мэрийсээр ирсэн уламжлалтай. Хятад руу чиглүүлсэн манай ажиллагааны дараа (1894—1895 оны япон хятадын дайн) хаант орос Гуаньдунг хятадуудад буцааж өгүүлэх гэж хөөцөлдсөний ачаар өөрийнхөө цэргийг тэнд байрлуулж амжсан юм. Бид генерал Ояамагийн ачаар (Япон-Оросын дайн) Гуаньдунг эргүүлж аваад өдий хүрлээ... Оросууд Гуаньдунг эзэгнэсэн байхдаа хятад дуудлагыг өөрийнхөө хэлээр хазгай дуудаж квантун гэж нэрлээд Курпаткин гэдэг генералаар толгойлуулсан хуурай болон усан замынхаа цэргийг суулгасан түүхтэй. Харин бид өөрийнхөө цэргийг армийн хэмжээнд хүргэвэл шинэ армийг Квантун буюу хязгаар боомтын цэрэг гэж нэрлэх нь зохимжтой.

- Хонзёо сан, шинэ армийг квантун гэж нэрлэвэл цэрэг зэвсэг, хүч чадлыг ямар хэмжээнд

хүргэх вэ?

- Кантуны армийн гол зорилго бол Улаан оросын нөлөөг алс дорнодоос зайлуулж улмаар Байгалаас Урал хүртэлх газрыг ар монголтой хамт эзэн хааны өлмийд сөгтгөх учраас 50 дивизээс наашгүй байх хэрэгтэй. Үүнээс 30 дивизийг Улаан оросын хил дагуу байрлуулна гэхэд Угаки сэтгэл хангалуун байлаа. Угаки, Осакагаас Солонгос руу хөдлөхийн өмнө хунтайж Канинд явуулах тусгай цахилгаанаа бичлээ.

«Токио. Маршал хун тайж, Канинд. Сигэрү Хонзёо өөрийнхөө үүрэг зорилгыг сайн ойлгосон хүн байна» гэж бичээд туслахаа дууджээ. Ерийн үгтэй энэ цахилгааны үг бүр нарийн утгатай. Угаки маршал Канин руу явуулсан энэ цахилгаанд «Хонзёо манжуур руу довтлох бэлтгэлээ бүрэн хангасан байна» гэжээ.

Манжуур руу довтлох үүрэг авсан Хонзёогийн аравдугаар дивиз бэлтгэлээ сайн базаасныг мэдсэн маршал уул ажиллагааны ач холбогдлыг эзэн хаан Хирохитогийн зөвлөхүүдийн сонорт хүргэж, өөрийнхөө биеэр тайлбарлаж өглөө. Үүнээс хойш хэд хоносны дараа эзэн хаанаас тусгай даалгавар авсан дэд хурандаа Тэйти Сузуки, Хонзёогийн штаб дээр гэнэт ирлээ.

- Хонзёо сан, манжуурыг эзлэх явдал бол эзэн хааны кодо зарчмыг азид дэлгэрүүлэх ажиллагааны эхлэл болох ёстой. Харин дэлхий дахиныг нэгэн дээвэр доор нэгтгэх ажиллагааг хятадаас эхлүүлэх нь дээр биш үү?

- Манжуур бол хятадын үйлдвэрлэж байгаа бүх нефтийн 93 хувь алтны 55 хувь, цувимлын 41 хувь, төмөр замын 37 хувь, гадаад худалдааны 40 шахам хувийг эзэлж байна. Ингэхээр эдийн засгийн одоогийн бэрхшээлээс гарья гэж бодвол зөвхөн манжуураас олсон баялгаар одоогийн сүйрлийг арилгаж болно. Түүгээр ч зогсохгүй алс дорнод, Байгалиас Урал хүртэлх нутаг руу ар монголын хилийн дагуух чиглэлээр цэргээ оруулах боломж нээгдэнэ. Нөгөө талаар зүүн сибирьт тогтоох эзэн хааны кодо зарчимд гадаад монгол их саад болоод байгаа. Тэр нь Сибирийг манай армиас хамгаалсан өргөн цайз болоод байна. Тэр цайзыг аваагүй цагт алс дорнод зүүн сибирь дэх улаан оросын ноёрхлыг устгаж чадахгүй гэлээ.

- Хонзёо сан, манжуурын талаар баримталж байгаа таны саяын байр суурийг эзэн хаан дэмжиж, сэтгэл хангалуун байна.

Тиймээс та, өөрийнхөө ажиллагаанд итгэж болно гэснээр Сузуки эзэн хаанаас авсан анхныхаа даалгаврыг биелүүлэв. Чингээд Сузуки Мугдэн руу явлаа. Тэрээр зүүн умард хятадад явуулж байгаа тагнуулын ажиллагааг удирддаг Доихаратай уулзаад манжуурт явуулах ёстой хорлон сүйтгэх тагнуулын үйл ажиллагаатай танилцлаа. Дорно дахинд алдаршсан энэ тагнуул Жан Золингийн япон зөвлөхийн туслахаар олон жил ажилласны ачаар хориод улсын хэл сурчээ. Тэрээр монгол хэлэнд муугүй. Харин харчин аялгуугаар ярих тул хос эгшгийг уртаар дуудна. Тэрээр морин жил (1918 он) Тагна урианхай, монгол, буриад, өвөр монголыг нэгтгэн Их Монгол улс гэгчийг байгуулах асуудлаар Даурт ирж, Нэйж гэгээнтэй сүүж холбож явсан билээ. Тэгээд хоёр жилийн дараа Борон Унгерний зөвлөхөөр ажилласан. Тэрээр 1921 онд Владивостокт японы оролцоотойгоор эргэлт гаргаж Зөвлөлт засгийг устгаад Меркуловын засгийн газрыг байгуулахад Итакийн хамт хүчин зүтгэжээ. Чингээд эзэн хааны

зөвшөөрлөөр хятадын армид алба хааж, хожим Жан Золингийн япон зөвлөх Нанаогийн шадар хиа (гарын туслах) болсноор зүүн умард хятад, алс дорнодод хийгээд монголын асуудлаар мэргэжжээ. Тэрээр Жан Золингийн сэтгэл санааг арван хуруу шигээ мэдэж байсан тул түүнийг их гүрнүүдтэй холбоо тогтоож японоос хөндийрөх гэж байгааг мэдэж баримт цуглуулсны дараа түүнийг богино хугацаанд устгах санал боловсруулсан эзэн болой. Доихара, Жан Золинг нас барсны дараа манжуурын талаар дагнан ажиллаж, тэгснээрээ Жан Золингийн хүү Жан Сюэляныг ятгаж түүнийг манжуурын эзэн болгоно гэдэг ойлголт төрүүлэхийг мэрийж байлаа. Харин Жан Сюэлян, эцгийгээ нас барсан явдлыг Чан Кайшигийн хүмүүсээс мэдсэний дараа японыг бараадахаа болиод Чан Кайшийг дагах болсон тул Доихара тэр хоёрын хооронд «яс хаях» арга бодож, манжуурт японы цэрэг улс төрийн ноёрхлыг тогтооход тус болох хүнийг судалж «Эзэн хаан» гэсэн ажиллагаа сэдээд Тозияаг Тяньжинд суулгасан энэхэн үед жанжин штабаас Жан Сюэляны засаг захиргааны эсрэг явуулах хорлон сүйтгэх ажиллагааны удирдамжийг Сузуки авчирсан байлаа.

- Доихара сан, манжуурт төвхнөхийг эрмэлзэж, улс төрийнхөө байр суурийг бэхжүүлээд байгаа Жан Сюэляны ноёрхлоос зүүн

умард хятадыг аврах ажиллагаанд танай тагнуулын байгууллагын ажлыг идэвхжүүлэх нь чухал байна. Энэ тухай наад удирдамжаасаа үзээрэй гээд битүүмжилсэн лацтай бичгийг Доихарад өглөө. Чингээд эзэн хааны бүрэн эрхт элч, Доихарагийн өрөөнөөс Гуаньдун, Солонгост байгаа цэргийн удирдлагатай утсаар ярьсны дараа Доихарад,

- Эзэн хаан тэнно Хирохито, манжуур дахь хээрийн цэргийн цагдаагийн газрын тайса (хурандаа) Хидэки Тозиог жанжин штабт цэрэг дайчлан зохион байгуулах газрын даргаар томилсон тул Токио руу яаралтай явуулах ёстойг мэдэгдэх үүргийг надад даалгасан юм гэж албан үүргийнхээ дагуу мэдэгдлээ.

Доихара, Мугдэн дэх тагнуулын ажлыг удирддаг боловч тусгай үүргээр ажиллаж буй Тозияагийн талаар Сузукийд хошуу хүргэхийг үл хичээнэ. Тэрээр Тозияагийн туслахуудын үйл ажиллагааг давхар хянадаг болохоор бүх ажиллагааг арван хуруу шигээ мэднэ. Тиймээс дэд хурандаа Сузукийг Мугдэнгээс Тяньжин руу яаран нисэхэд түүнийг даган онгоцны буудал дээр очиж гаргаж өглөө. Чухам энэ үед Доихара Гуаньдун дахь цэргийн штабын дарга Мияаги, Аравдугаар дивизийн командлагч Хонзёо, хурандаа Итагаки нарын боловсруулсан төлөвлөгөөг жанжин штаб баталсан болохыг мэджээ. Тиймээс Сузуки, манжуурын ажиллагааг далдлах нууц ажиллагааг туршлагатай Тозияагаар удирдуулахаар шийдэж Тяньжин руу явах гэж байгааг төвөггүй мэдэв. Тозияа, Жан Золинг устгах «Хар төмөр» хэмээх ажиллагааг далдлах мэхийг боловсруулахдаа гүнгийн охиныг овжин ашигласан нь жанжин штабт үнэлэгджээ. Тиймээс манжуурын ажиллагааг далдалсан уран мэх сэдсэн Тозияа, Доихаратай ярилгүйгээр өнгөрөхгүй нь мэдээж хэрэг. Дойхара, онгоцонд сууж буй Сузукигийн хойноос харж зогсохдоо, «Маргааш нөгөөдөр хоёрын нэгэнд Тозияа над руу утасдана даа» гэж бодож байлаа.

Доихара, дэд хурандааг явсны маргааш нь утасны хонх чагнаж суухдаа «Сайнжаргалыг тагнуулын байгууллагад татан оруулна гэдэг тун найдваргүй зүйл. Тун их азтай үлдсэн гэгддэг энэ эмэгтэй, японы тагнуулын байгууллагатай ороолдох үндэсгүй. Тэр эмэгтэй мөнгө, хөрөнгөөр гачигдахгүй болохоор Америк руу яваад хэдэн сарын дараа үйлдвэр банкны

эздийн хамгийн хүндтэй хүн

болчих эгзэгтэй. Тэгэхээр Сайнжаргалын сэтгэлд байгаа тогтвор муутай үндэсний үзлийг Тозияа гашилгавал тэр эмэгтэй миний бодсоноор Америк руу тонилчихно. Ингэхээр өнөө алтыг оросын дүрвэгсдийн товчоонд ашиглуулах гэсэн манайхны төлөвлөгөө нурж, энэ хэд шалдан үлдэнэ гэсэн үг» гэж бодож байсан тэр үед Тозияа Сузуки хоёр энэ тухай ярилцаж байлаа.

- Тозияа сан, Сайнжаргалд тавьж байгаа найдвараа хэр бүтэмжтэй гэж бодож байна даа. Тэр их алтыг Оросын дүрвэгсдийн товчооны үйл ажиллагаанд ашиглах нь чухал шүү гэж нухацтай асууж шалгаав.

- Чиү са Сузуки сан, Цэен гүн амьсгаа хураахын өмнө амласан нэг зүйл бол дүрвэгсдийн товчоонд багагүй хөрөнгө амласан. Энэ талаар эцэг нь охиндоо нэлээн юм ярьсан бололтой. Тиймээс гүнтэн хөрөнгөө армид гэрээслэн үлдээсэн гэрээслэл Сайнжаргалд бий гэдэг гарцаагүй хэрэг! Харин Сайнжаргал тэр хөрөнгийг олгох эсэхээ ямар нэг шалтгаанаар хүлээсхийж байна. Миний бодлоор бол Сайнжаргал, Буйр нуурт загасны үйлдвэр байгуулах гэсэн Азийн загасны пүүсний болзлыг сонирхож байгаа төдийгүй Халх голын савд жимсний тариалан байгуулах санаатай байна. Тиймээс энэ бүхэнд хамгийн чухлаар шаардагдаж байгаа зам харилцааны талаар зовж Харбиныхантай хоршиж Хайлараас Буйр хүртэл төмөр зам тавих санаатай байх шиг байна. Гэхдээ энэ талаар нарийн бодож боловсруулсан зүйл Сайнжаргалд байхгүй байгаа.

- Тэр шөнө гүнтэн та нарын хэнтэй нь ч Богдын алтны талаар ярьж чадаагүй гэдэг нь илэрхий. Тэгэхээр гэрээслэл бичих боломж гараагүй шүү дээ.

- Тэр шөнө гүнгийн өвчин үүрээр намдсан биш. Харин бүр шөнө дундаас хойш намдсан юм. Тэгэхдээ бүр эдгэсэн хүн шиг байсан бололтой. Үүнийг гүн самбаачлан ашигласан бололтой. Тэгээд охинтойгоо ярьж, зарим зүйлийг охиндоо хэлж бичүүлсэн байна. Тэр ч байтугай хоол хийлгэж идсэн байсан. Өглөө намайг гүнгийн өрөөнд ороход тэр өрөөнөөс хонины махны үнэр ханхалж, ширээн дээр байгаа аяганы амсраар шингэн бантан үлдэж хатсан ор мөр ив илхэн байсан.

- Тэгвэл гэрийн нь үйлчлэгч нараас мэдэж болох юм бишүү гэхэд,

- Тэр бол боломжгүй хэрэг. Сайнжаргалын гэрт байгаа хүмүүс бол эцгийн нь ах агсан Баатар гүнгийн ураг садангийн хүмүүс. Тэд улаан голоо тасарч байхад ч гэсэн дуугүй байж чадах хүмүүс. Тэгээд тийм тэнэг алхам хийвэл Сайнжаргал буруу тийшээ хандана. Аягүй бол Нью-Йорк, Лондон руу алтаа шилжүүлчихэж мэднэ. Тэр алтыг хятадаас гаргахгүй байх нь чухал. Харин надад нэг боломж бий. Энэ бүхнийг сайн зохицуулж чадвал Сайнжаргалын асарсан эцэг болох нөхцөл бүрдээд байна.

- Ухай, та яахаараа тэр сайхан хүүхний өргөсөн эцэг болдог байна гэж Сузуки хорхойтон асуулаа. Тозияа ханын шүүгээнээс нэгэн захидал гаргаж ирээд,

- Энэ бол гүнгийн захиа. Тэр өөрийн гараар бичээгүй ч гэсэн охиноороо бичүүлсэн нь

бичгийн хэлбэрээр мэдэгдэж байгаа юм. Энэ захиаг Сайнжаргал Гэгээн сүмд буяны сүм бариулахаар очсон хойноо бүр өгсөн юм. Та үүнийг уншаач гээд эх захиаг орчуулгын хамтаар Сузукид өглөө. Сузуки, гүнгийн захиаг анхааралтай уншаад,

- Би үүнийг уншиж сонирхлоо. Энэ захидлын талаар та өөрөө жанжин штабт танилцуулсан дээр биз. Харин би энэ тухай эзэн хааны сонорт заавал хүргэнэ гэж хэлэхэд Тозияа Сузукигийн цайвар царайг ширтэн «Энэ дэд хурандаа их мэдэлтэй болжээ. Тухайн үедээ Доихара ийм эрх эдэлж байсан. Энэ хүн Доихарагаас хэдэн хувь сүүхээтэй болохоор Чан Кайшигийн зөвлөхөөр хэдэн жил ажиллалаа. Ирээдүйд эзэн хааны дэргэд цэргийн зөвлөх болох зам мөрөө засаж байгаа энэ хүн, их азтай эр юм. Жанжин штабынхан Сузукигийн гурвалд их талтай байдаг. Шиү са (хошууч) Ермити Сузуки бол хятадын улс төр, эдийн засгийн байдал төлөвийг арван хуруу шигээ мэднэ.

Тэйти Сузуки бол Чан Кайшигийн бодол санааг гар хурууных нь хөдөлгөөнөөр мэддэг зөвлөх. Өөрөөр хэлбэл Чан Кайшигийн зан аашийн халууныг хэмжих хэмжүүр гэсэн үг. Адмирал Кантаро Сузуки бол хятадын усан боомтонд байгаа гадаадын усан онгоц, номхон далайгаар хэсүүчилж хятадын шар тэнгисийн эрэг хавийг шиншилдэг усан замынхан болон хятад руу орох усан замын бүх нүх сүвийг эрхтэн шигээ андахгүй болсон хүн.

Ингэхээр азийн усан зам, хуурай газрын илүү дутууг төдийгүй хятадын улс төрийн бодлогыг сургаар нь андахаа байсан эдгээр нэвгэрхий толинуудыг эзэн хаан өөрийнхөө нүд, чихнээс илүү эрхэмлэдэг нь аргагүй биз» гэж бодно.

- Би ч ажил төрлөө жанжин штабт ойлгуулж чадна. Харин эзэн хааны ордонд бараалхахгүй болохоор өөрийнхөө тухай хаантанд юу гэж ярих билээ гэж даруу зан гаргаж хэлтэл Сузуки,

- Таныг хятадын талаар төлөвлөсөн нууц ажиллагааны талаар төдийгүй манжуур, гадаад монголын талаар гүн мэдлэгтэй гэдгийг эзэн хаантан мэднэ. Тэгэхээр та айлтгалаа бичсэн дээр. Энэ тухай «Хар төмөр» ажиллагааг далдлахад сэдсэн, Сайнжаргалын ажиллагааны тухайд гэвэл тайса Комотогоос жанжин штабт бичсэн айлтгалд дорвитой баримт орсон байна билээ.

- Комото... Дайсаку Комото. Сонин юм. Бид хоёр тийм ч сүрхий танил биш гэж Тозияаг хэлэхэд Сузуки,

- Тайса доноо Комото сан, Сайнжаргалын талаар судлаад их магтсан төдийгүй төрөлхийн тагнуулч хүний авьяас байна гэж үзсэн байсан. Тэгэхээр та, армийн өмнө ямар үүрэгтэйгээ бодох хэрэгтэй. Та ганцхан алтны тухайд биш харин тагнуулч эмэгтэй бэлдэх болж байгаагаа бодох хэрэгтэй.

- Энэ чинь арай гоомой дүгнэлт байна. Сайнжаргалын авьяасын хувьд гэвэл хэл шинжлэл, түүхэнд гоц ойтой байж мэднэ. Харин уржнан тэр ажиллагаанд оролцуулсан явдал бол тохиолдлын төдий зүйл! гэхэд Сузуки ярианы сэдвийг өөрчилж, ажил хэргийнхээ дараагийн шатанд оров.

- Армийн дотор байгуулагдсан «Эзэн хааны бэлтгэл хүчний холбоо» «Сакурайка—интоор

нийгэмлэг», цэргийн удирдах ажилтныг хамарсан «Хокухонся—төрийн үндэс нийгэмлэг» зэрэг байгууллагууд Хятадын асуудалд бодитойгоор хандаж, их газрын дайныг өргөжүүлэхийг шаардаж байна. Иймд хятадын улс төрийн асуудлыг зохицуулах замаар «Хэй» хэмээх товлосон төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар эзэн хаан сонирхож байна. Энэ талаар алс дорнод, хятадын асуудлыг, эрхэлдэг «Эрдэм шинжилгээний» байгууллага саналаа илтгэсэн. Харин хятадыг эзлэх «Хэй» төлөвлөгөөний талаар та, ямаршуухан бодолтой байна даа?

- Хэлэхэд хэцүү байна. Хятадын улс төрийн маргааныг

зохицуулах зам гэдгийг засгийн газар сонгохдоо хэлэлцээний аргаар эвлэрүүлж, түүнийг эзэн хааны кодо зарчимд ашигтайгаар хэрэглэнэ гээд байгаа. Гэтэл цэрэг армийн зарим хүмүүс «Хэй» төлөвлөгөөг шууд эхлүүлнэ гэдэг. Миний хувьд гэвэл Манжуурыг аваагүй цагт Хэй төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй. Харин манжуурыг хятадаас салгах тухайд гэвэл надад өөрийн гэсэн бодол бий. Түүнийг эзэн хаан таалах эсэхийг би, яахан мэдэх вэ?

- Таны төлөвлөгөөг армийн удирдлага нэлээн үндэслэлтэй гэж үздэг бололтой. Ялангуяа одоо цэргийн яам, жанжин штабынхан манжуурын асуудлыг хэрхэх тухай шийдэх гэж байна. Тиймээс манжуурыг хятадаас салгаж, манжийн эзэн хаан агсан Пу Игийн талаар эзэн хаанд айлтгалаа бичих нь зүйтэй гэж зөвлөмөөр байна. Та үүний тулд л Тяньжинд сууж байгаа шүү дээ гэлээ.

Тозияа Токио явах гэж яараагүйн адилаар эзэн хаанд айлтгал бичих гэж яарсангүй. Учир нь Аравдугаар дивизийн онцгой ажиллагааны талаар Гуаньдунгийн цэргийн штабын дарга Мияаги, хурандаа Итагаки хоёр нарийн төлөвлөгөө зохиохдоо Тозияатай ярилцаж түүнийг эхлүүлэх далимыг тооцоолоод нэгдсэн төлөвлөгөө гаргаж Доихарагаар Токио руу явууллаа. Тэр төлөвлөгөөг жанжин штаб хянаж, «Хятадын асуудал эрхэлсэн» хэсгийнхэн шүүн тунгааж байгааг Тозияа мэдэж байв. Харин цэргийнхний энэ ажиллагаанд төрийнхөн буюу Вакацукигийн засгийн газрын гадаад яам, саад тотгор хийнэ гэдгийг Тозияа тооцоолж үзжээ. Тиймээс армийнхан «Мугдэнгийн зөрчил» гэж томьёолсон ажиллагааг гадаад яамны сайд Сидэхарагийн «нүд чих» болсон Мугдэн дэх элчин консулынхнаас нууж байлаа. Тозияа манжуур руу армийн оруулах төлөвлөгөөг далдалж, хэргийн эзнийг Жан Сюэляныханд оноохоор нарийн арга сэдчихээд байсан эгзэгтэй энэ үед цэргийн яамны сайдтай хэдэн удаа утсаар ярилцаад Токио руу яаран нислээ.

Тозияа, Токиод ирээд арван хоёр хонолоо. Найман сарын эхээрх халуун өдөр, цэргийн яамны сайдын өрөөнд японы арван

долоон дивизийн удирдах ажилтангууд цуглав. Тэд цөмөөрөө хятадад байгаа японы цэргийн командлагч нар байлаа. Цэргийн яамны сайд Минами, орлогч Кайсо нар «Манжуурын асуудлыг шийдвэрлэх хойшлуулшгүй зорилт»-ын талаар ярилцав. Сайд Минами үгийнхээ төгсгөлд,

- Бий болж байгаа нөхцөл байдал бол юуны өмнө биднээс цэргийн асар их мэдлэг, идэвхийг шаардаж байна. Бид эзэн хааны өмнө хүлээсэн ариун үүргэндээ хүрэх тангарагтаа үнэнч байхыг яматогийн хөвгүүдэд уриалж байна. Бидний эрхэм зорилго бол яматогийн хөвгүүдийн нандин чанар бусидо—цэрэг эрсийн замналаар замнаж, хятадын улс төрийн маргааныг

зохицуулж, манжуурт тусгаар тогтнол олгох замаар эзэн хааны кодо зарчимд хятадыгоруулжулмаар азийгцэцэгжүүлэн мандуулах алхмыгэхлэх ёстой. Тиймээс Сёвогийн (эзэн хаан Хирохитогийн хаанчлалын үе) өнөөгийн зорилго бол дэлхий дахиныг яматогийн хөвгүүдийн өрх гэрийн нэгэн дээвэрт нэгтгэж, ариун дагина Аматаэрасугийн удам тэнногийн (тэнгэрийн элчийн) үйлсийг хэрэгжүүлэх явдал мөн. Энэ бол бидний эрхэм үүрэг. Бид одоо манжуурыг хятадаас салгаж эзэн хааны эзэмшил болгох эрин үетэй золгоод байна. Энэ гайхамшигт үйл хэргийг та бүхэн эхлэх ёстой. Банзай... Банзай... Банзай гээд үгээ дуусгахад танхимд байсан бүх дарга нар босож нэгэн дуугаар «Хакко ити о—Бүх дэлхийг нэгэн дээвэрт нэгтгэе» гэж хашгирлаа.

Зөвлөгөөн тарсны дараа Минами, Тозияатай уулзахаар өрөөндөө орж иртэл түүний туслах сайддаа,

- Гаккаа, эзэн хааны зөвлөх Саёнзи сан таныг ордонд ирэхийг тушааж байна гэлээ.

- Тозияа сан, та цэргийн академи дээр очоод хүлээж бай. Би хаантны ордонд очоод тэндээсээ очно гээд өрөөнөөсөө гарлаа.

Тозияа, цэргийн яамны гол хаалгаар гарч ирээд суудлынхаа тэргэнд суусангүй. Харин жолоочтойгоо уулзангуут,

- Цэргийн академи дээр очоод хүлээж бай гээд явган гэлдэрлээ.

Тозияа, янжуураа баагиулсаар хөмсөг зангидан бодлогоширч гудамжаар хайхрамжгүй алхахдаа «Эзэн хааны зөвлөх зөнөг Саёнзи, юу гэж дуудсан бол! Ерөнхий сайд Вакацуки, үйлдвэрийн эзэд, хөрөнгөтний намуудаас айгаад, байр сууриа алдахгүйн тулд тэр зөнөгийг ятгасан байх. Тэгээд манжуурын ажиллагаанд саад хийхээр шийдсэн хэрэг» гэж амандаа үглэнэ.

Тозияа, «манжуурын асуудлыг шийдвэрлэх» төлөвлөгөөг хэрэгжүүлэх ач холбогдолтой өдөөн хатгалгыг «Мугдэнгийн зөрчил» гэж товлосон учир манжуурын ажиллагааг тэгж нэрлэсэн байлаа! Тэрээр жинхэнэ ажиллагааг далдлах арга залиа хоёр янзаар төлөвлөсөн. Тиймээс Токиогийн гудамжаар гэлдрэхдээ элдвийг бодно. Мугдэнгийн зөрчил ажиллагааг 9 сарын эхээр гэж товлосон. Мугдэнг японы цэрэг эзлэхээс өмнө Хонзёо, Порт-Артурт ирэнгүүт аравдугаар дивизийг хөдөлгөж, бусад холбогдох ажиллагааг удирдах ёстой. Энэ үед Солонгост байгаа цэргийг байлдааны бэлэн байдалд оруулна. Бүх ажиллагааг эхлэхээс өмнө жанжин штабын хоёрдугаар газрын дарга буюу тагнуулын газрын тэргүүн хошууч генерал Есизи Татэкава, Солонгост ирээд тэндээсээ Мугдэнд нууцаар ирэх ёстой. Үүнийг Итаки зохицуулна. Татэкава, Мугдэнд ирээд ажил хэрэгтэй танилцсаны дараа Мугдэнгийн баруун хойно байрлаж байгаа хятадын долдугаар бригад руу японы цэргийг довглуулах тушаал өгөх ёстой байв. Харин Доихара, өөрийнхөө хүмүүсийг зохион байгуулж, Мугдэнгийн ойролцоо төмөр замын даланг дэлбэлэх үүрэгтэй ажээ...

Тозияа, энэ бүхнийг эргэцүүлэхдээ «Мугдэнд очих галт тэргийг сүйрүүлэхгүй байх ёстой» гэсэн сайдын үгийг бодоод ажлаа хэрхэн зохицуулахаа бодно. Тэрээр галт тэргийг ямар ч гэмтэлгүйгээр Мугдэнд оруулах хоёр боломж бий. Гэвч энэ тухай сайддаа айлтгасангүй.

Хожим ямар нэг хэл ам дэгдвэл «Газар дээр нь тэгж шийдэхээс өөр арга байгаагүй» гэдгээр амыг нь таглах байлаа. Тозияа чингэж бодсоор яваад цэргийн академд ороод эртний танил хэдэн багш нартай уулзаж байтал сайд Минами иржээ. Тэгээд тусгайлан бэлдсэн өрөөнд Тозияатай уулзав.

- Тозияа сан, би хэнтэй уулзсан гэж санаж байна?

- Гаккаа, та эзэн хааны зөнөг зөвлөхтэй уулзсан биз дээ. Бидний ажиллагаанд ерөнхий сайд, тэр хоёроос өөр саад болох хүн байхгүй гэж Тозияа нэлээн дургүйцэн хэлэв.

- Соёнзи юу гэж хэлсэн гэж санана! Гуаньдунгийн цэргийн

ажиллагааг Мугдэнгээс гаргаж болохгүй. Чан-чунь, Гирин, Харбин, Цицикарь (Цэцэн хар) руу цэргийн нэг ч ангийг зүглүүлж болохгүй гэж айлдаж байна. Тэгээд их гүрнүүдтэй дипломат шугамаар ярилцаж тохироогүй цагт армийг ямар ч ажиллагаа хийж болохгүй гэж хориглолоо.

- Гаккаа, та тэгээд юу гэж хэлэв дээ. Бусидо зарчмаа мартаагүй бол сеппуку үйлдсэн дээр гэв үү? Тэр хөгшин зөнөг эзэн хааны төлөө алгын чинээ турсгаа тэнгэрт өргөж чадахгүй юм бол тэнд үхсэн үлийгээ хийж байгаа хэрэг вэ? Уржнан токиогийн бага хурал дээр Дайрангийн генерал Нобиеси Мүтогийн хэлсэн үгийг цаад зөнөг чинь мартжээ. Манжуур руу чиглүүлсэн армийн ажиллагаа бол эцсийн эцэст америк, англи хоёртой үзэлцэхэд хүргэнэ. Тиймээс их гүрнүүдтэй байлдахад бэлэн байх хэрэгтэй гэдгийг хоолтойгоо холиод идчихсэн байх нь. Тийм юмнуудыг яматогийн хөвгүүдийн замаас зайлуулж байх ёстой.

- Тозияа сан, ямар ч гэсэн товлосон ажиллагааг өөрчлөхгүй. Тэгээд ч зогсохгүй Чанчуныг эзлэх нь чухал. Хаантан, их гүрнүүдтэй түнжин муудахаас айсан сайд нарын саналыг дэмжихгүй. Би Гуаньдунгийн цэргийн бэлтгэлийг шалгасны дараа танд цахилгаан явуулна. Тэр цахилгаан ердөө «Маргааш, дорнодын нар улаан өнгөтэй мандана» гэсэн үгтэй байна. Үүнийг авангуут та, өөрийнхөө ажиллагааг эхлэх хэрэгтэй гэхэд Тозияа сандлынхаа түшлэгийг налан сууж, инээмсэглэхийг ажваас хотонд гэтсэн чоно, хонины бараанаар шүлсээ залгин архирахыг санагдуулам ажээ.

Тозияа, Токиогоос ирээд хэд хоносны дараа Тяньжин руу явахаар шийдсэнийг мэдсэн Сайнжаргал, түүнтэй уулзаж ярилцахдаа хэд хоног хүлээхийг аминчлан гуйжээ. Үнэндээ Сайнжаргалын санаа сэтгэл тавгүй. Эцэг нь өөдлөөд гурван сар өнгөрсөн атал сэтгэлдээ эцгээ үгүйлэн, эрүүл ахуй цагтаа, ярьж хэлж байсан үг, байр байдал, инээмсэглэлийг нь үргэлж бодно. Ялангуяа өглөө,

Хоёр. Өнчин хүнд эзэн мундахгүй

оройд цай хоолны үеэр илүү их санагдаж, хонины мах нимгэн хөшиглөөд, мөнгөн аягандаа цай хийж уух дуртайг санахаас нүдэнд үзэгдэх шиг болно. Тиймээс Сайнжаргал, хоолныхоо өрөөнд ганцаараа юмуу Сувдаатай байхаас зүрхшинэ. Харин Тозияатай хамт хоол цай идэж уух дуртай болохоор эцгийнхээ тухай бодох шаналгаанаас чөлөөлөгдөнө. Тэгээд нэгэн үе хүргэн гэгдэж явсныг нь бодоод «Эцгээс минь өөрцгүй хүн шүү» гэж боддог болсныг Тозияа ойлгоно.

Тозияа, Токиогоос ирэхдээ бараг олдохоо больсон ховор ном, японы эртний урлагийн нэг, хулсан дээр зурдаг хуйлмал зураг эмакимоногийн хэдэн сайхан хуулбар авчирч өгчээ. Сайнжаргал, Тозияаг ирсэн өдөр, эцгийнхээ өрөөг зайчлан суулгаад өөрөө хоол ундыг нь дөхүүлж өгдөг болсныг ажиглаад Тозияа сэтгэлдээ «Аргагүй дээ. Эцгийгээ үгүйлэхийн эрхээр намайг хэд хоног ч гэсэн дэргэдээ байлгахыг бодолгүй яахав» гэж бодов. Тэгээд Сайнжаргал сүүл сүүлдээ Сувдаагаар хоол цайгаа авчруулж өөрөө Тозияатай хамт нэг өрөөнд хооллож, ундалдаг болсонд хашир өвгөн сэтгэлдээ олзуурхна.

Хоолны ширээ засаж, далайн байцаа, амталж дарсан ногоо, битүү шарсан хонины мах, жимсний ундаа, сакэ тэргүүтнийг тавьсан ширээг засаж бэлэн болгосон Сувдаа, Сайнжаргалын өрөөнд орж ирээд,

- Эгч ээ, хоол бэлэн болсон шүү гэлээ.

- Тозияа гуайд хэлэв үү?

- Одоо хэлнэ. Том өрөөнд ном уншиж байгаа гэхэд Сайнжаргал, Сувдаа руу эргэн хараад,

- Чи өнөө бичгээ аваачаад хоолны ширээн дээр тавьчих. Тэгээд Тозияа гуайг хоолоо зооглохоор очингуут надад дуулгаарай гээд эцгийнхээ нууц шүүгээний түлхүүрийг өглөө. Сайнжаргал уншиж байсан «Никон сёки-японы түүхэн судар» хэмээх түүхийн хуудсанд нимгэн эвэр хавчуураа хийж тавиад хувцсаа солихоор унтлагынхаа өрөө рүү орлоо.

Сайнжаргал хувцсаа солиод хоолныхоо өрөөнд орохын өмнө, том царсан хаалгыг чимээ гаргалгүй зөөлөн онгойлгоод завсраар нь шагайвал, хэдэн мөчийн өмнө зориуд тавьсан өнөө бичгийг их анхааралтай уншиж байгаа Тозияагийн бодлогоширсон царай Сайнжаргалд тодхон харагдана.

Сайнжаргал гэнэт орж ирэхэд Тозияа хэсэгхэн самгардсанаа цагаатгахыг хичээж,

- Сайнжаргалаа чамайг хүлээж суухдаа үүнийг уншчихлаа. Чи намайг уншиг гэж тавиулсан биз дээ гэж аятайхан хэлэв.

- Тиймээ. Танд ямар санагдаж байна? гэж асуусан Сайнжаргал, нүдний булангаар Тозияаг сэм ширтэнэ. Чухам энэ үед Тозияа дотроо «Түрүүний захиаг гүн амьсгаа хураахын өмнө хэлж бичүүлсэн байсан. Энэ бол гүнгийн гараар бичигдсэн захиа байна. Түрүүний захианд миний оронд эцэг болох хүн шүү гэсэн байсан. Гэтэл одоогийн захианд Буйр, Халх голын талаар дурджээ» гэж бодсоор хэсэг зуур дуугүй байснаа,

- Талийгаачийн ухаантай эн зэрэгцэх хүн ховор! Би бол цэргийн алба олон жил хаасан, нэг мулгуу хүн шүү. Тэгэхээр миний ухаан, талийгаачийн ухааныг яаж гүйцэх вэ? Надад төрсөн сэтгэгдлийн хувьд гэвэл энэ захианд дурдсан бүхэнд яарах хэрэггүй. Юу ч гэсэн жаахан хүлээх хэрэгтэй! Манай цэрэг манжуурыг хятадаас тусгаарласан үед бол хоршсон нийгэмлэг байгуулж болно. Харин одоо хятадын бага зиндааны хүмүүстэй хувь нийлүүлж хорших явдал найдвартай биш. Цаг үе, улс төрийн хямрал, нэг төрийг нөгөөгөөр нь сольдог. Улаан хятадууд Мугдэн, Харбин хоёрт ноёрхчихвол яана. Өнөө хоршсон хөрөнгийг улсын болгоод зарлачихна. Эсвэл хураана. Монголд ардын засаг тогтонгуут яаж байлаа даа. Халхын ноёдын хөрөнгийг хураагаад гуйлгачингуудад тараачихсан шүү дээ. Тэгэхээр хятадуудтай хоршиж, хувь нийлүүлсэн пүүс байгуулна гэдэг чинь бодуштай зүйл!

- Буйр нуурт загасны үйлдвэр байгуулж болох талаар наад захианд дурдсан аавын саналыг та юу гэж бодож байна даа?

- Одоогоос долоон жилийн өмнө (1924 онд) Азийн Та да хэмээх загасны пүүс Харбины орос худалдаачидтай хоршиж Буйр нуурт загасны үйлдвэр байгуулахаар шийдээд монголын талд саналаа тавьсан юм. Гэтэл монголчууд Буйр нуураас олзворлосон бүх загасны ашгийн гуравны хоёр хувийг монголд өгвөл зөвшөөрнө гэсэн юм л даа. Тэгээд энэ болзлыг зөөллүүлэхийн тулд Та да пүүснийхэн талийгаачийг ятгасан боловч бүтээгүй

- Хэрвээ армийнхан манжуурыг хятадаас тусгаарлаад,

Монголд хуучин засаг төрийг тогтоочихвол Буйрын загасны үйлдвэр ашигтай юу?

- Ашигтайгаар барах уу? Урьдчилсан тооцоогоор бол Хайлар Ганжуур сүмийн хооронд төмөр зам тавиад түүнийгээ Буйр нууртай холбочихвол, түүнд зарцуулсан хөрөнгийг хэдэн жилийн дотор олчих байсан. Нөгөө талаар Халх голын савд жимс таривал өмнөд манжуураар дамжуулж умард хятадыг хангадаг бүх жимсийг эндээс хангах бололцоо гарч байгаа юм. Халхад хуучин засаг төрийг тогтоож чадахгүй юмаа гэхэд Тамсаг хүртэлх газар нутгийг Баргад нэгтгэх хэрэгтэй. Тэгвэл талийгаачийн гэрээслэлд дурдсан бүхнийг биелүүлж болно. Энэ бүхнийг талийгаач аав чинь тунгаачихсан хүн? Гэтэл улигт өвчин түүний хүсэл мөрөөдөлд саад боллоо гээд Тозияа харамссанаа илэрхийлэх гэсэн шиг санаа алдав.

Сайнжаргал, эцгээ нас барснаас хойш чингэж анх удаа эцгийнхээ гэрээслэлийг Тозияд үзүүлсэн болохоор тэрээр сэтгэлдээ «Одоо алтны тухай ярих байх» гэж сэтгэл яарна. Гэтэл Сайнжаргал тэр талаар ганц ч үг дурсаагүй болохоор Тозияа сакэ балгаж, ундаанаар даруулах зуур,

- Сайнжаргалаа, чи манай армийн ажиллагаанд оролцож байх хэрэгтэй. Маргааш манжуурт байгуулсан «Киова-кай-итгэлтний нийгэмлэгээс» болон «Сакуракай-интоор» ний-гэмлэгт хамаарагддаг хэдэн хүн надтай уулзахаар ирнэ. Магадгүй Доихара, Итаки хоёр ч ирж магадгүй гэлээ.

- Тэр итгэлтний нийгэмлэгийг эндхийнхэн сэхэхуэй гэдэг байхаа?

- Тиймээ эндхийнхэн хятадаар тэгж нэрлэдэг юм. Сайнжаргал, Тозияа хоёрыг чингэж

ярилцсаны маргааш нь Итагаки, Доихара хоёр гурван залуугийн хамт Сайнжаргалын ирлээ. Тэд нар тус тусынхаа нийгэмлэгийг төлөөлжээ. Итагаки, Доихара хоёр «Сакурайкай» нийгэмлэгийг төлөөлсөн байхад нөгөөдүүл нь манжуурт японы үзэл бодлыг дэлгэрүүлэх «Киовакай-итгэлтний» нийгэмлэгийг төлөөлсөн байв. Болор хундагатай сакэнээс шимж байсан Итагаки,

- Сайнжаргару сан, эд нар бол Харбинд гаргадаг «Харбины цаг» мөн «Дүрвэгсдийн дуу хоолой» сонингийн сурвалжлагч нар.

Тэгээд сониндоо монголын асуудалтай холбогдсон булан гаргах ажлаар энд ирээд байгаа юм гэж яриа өдлөө. Гэтэл Итагакийн дэргэд сууж байсан нэг залуу,

- Би танай өвөг дээдсийг Харбинд сонин гаргаж байсныг дуулсан. Тэгээд манай сонинд монголын талаар ажиллах байнгын хүн хэрэгтэй болоод тантай зөвлөхөөр ирлээ. Талийгаач эцэг чинь манай сонинд монголын тухай асуудал эрхэлсэн хавсралт сонин гаргая гэж байсан. Энэ талаар ямаршуухан бодолтой байна вэ?

- Тэр тухай талийгаач аав минь надтай ярьдаг байсан. Гэхдээ одоо надад тэр хавсралт сонин гаргахад оролцох бололцоо алга гэхэд Итагаки ярианд дэм үзүүлж,

- Тэр ч тийм байж болно шүү. Харин танаас гуйх нэг зүйл байна. Хэрвээ та Гириинд сонин гаргах бололцоогүй гэж үзээгүй бол манай хүмүүстэй очиж уулзвал яасан юм бэ? Манай нийгэмлэгийн эндхийн салбар өөрийнхөө томилолтоор явуулж болно шүү гэлээ.

- Би ойрын үед Харбин явж оросын дүрвэгсдийн товчооныхонтой уулзах санаатай байна. Уг нь Иваныг Дүрвэгсдийн дуу хоолой сонинд өөрийнхөө төлөөний хүнээр ажиллуулна гэж талийгаач минь ярьдаг байсан. Гэхдээ Иван ямар бодолтой байгааг би мэдэхгүй. Тэгэхдээ Гириин дайрч ирье. Тэр үед танайхан надтай уулзана биз.

- Хэрвээ та Гириингээр дайрвал манай энэ залуу угтаж уулзах болно гээд Доихара дэргэдээ байгаа нэгэн туранхай залууг зааж хэллээ. Ийнхүү манжуурыг арван хуруу шигээ мэддэг гурван хурандаа орой болтол Сайнжаргалтай ярилцахдаа японы цэрэг улс төрийн бодлогыг нуусангүй. Гириин рүү явах санааг Итагаки сэдэж, Доихара дэмжиж байгаа боловч энэ нь тэдний санаа биш гэдгийг Сайнжаргал мэдэж байв.

Гуаньдун дахь японы цэргийн штабын Итагаки, дорно дахинд алдаршсан тагнуул Доихара хоёрыг уулзаад явснаас хойш хэд хонож байтал нэгэн орой Тозияа Сайжаргалын өрөөнд орж ирлээ.

Сайнжаргал эцгээсээ хойш Тозияаг өргөсөн эцгээ гэж үзэх болсноор түүнийг Тяньжингаас нүүж ирэхийг гуйдаг боллоо.

Тэгээд Тозияа, өнчин бүсгүйн сэтгэлийг бодож, Тяньжин рүү явалгүй Мугдэнд ажиллахаар шийдсэн нь Сайнжаргалыг баярлуулна. Сайнжаргал Харбин руу явах ажилдаа яарсангүй. Тэрээр Тозияагийн авчирч өгсөн номуудыг шохоорхон уншиж, өдөр шөнийг өнгөрөөдөг байв. Сайнжаргал сүүлийн хэдэн өдөр «Гэмпэй сэйсуйки буюу Тайрагийн мөхөл ба Минамотогийн

мандалтын» тэмдэглэлтэй холбогдсон ном уншжээ. Сайнжаргал Никон сёки-японы түүхэн тэмдэглэл гэдгээс мянга гаруй жилийн тэртээх тэнно Зимугаас «Дэлхий дахиныг нэгэн дээвэрт багтаан захирья» гэсэн заалтыг «Хакка ити о» гэж хураангуйлсан дайчдын онолын үндэслэлийг олж мэдсэн шигээ нөгөө номноос нь япончуудын илд бишрэх хийгээд цэргийн холбоо эвсэл цэрэг эрсийн замнал Бусидо хэрхэн дэлгэрснийг мэдэж аваад Бусидо буюу цэрэг эрсийн замналд үнэнч самурай нар үнэнч зүтгэхийн баталгаа болгож гэдсээ хүүлдэг ёс «харакири» гэгчийг хууль болгон мөрддөг болсон хэрэг явдлыг олж мэдэв. Тиймээс бусидо ёсоор замнагчдыг самурай гэсэн нь угтаа эртний япон хэлний сабурай гэдэг угийн дуудлага сунжирч эдүгээтэй золгосон агаад хамгаалан зүтгэгч гэсэн үйл үгнээс гаралтай ажээ. Тиймээс анхны үед эзэндээ зүтгэгч, эзнээ хамгаалан зүтгэгч гэсэн утгатай байсан болой.

Японы армийнхан самурайн ёсыг сахин, дэлхий дахиныг японы улс төр цэргийн «дээвэр доор нэгтгэн» захирах зорилгоо манжуураас эхлэхийг эрхэмлэж байлаа. Тиймээс манжуур дахь хорлон сүйтгэх ажиллагааг киовакай буюу сэхэхуэй нийгэмлэгийнхэн голлодог ажээ. Чухам энэ нийгэмлэгийн харьяанд байдаг залуусыг турхирч сурсан Тозияа, Сайнжаргалын өрөөнд орж ирээд хэсэгхэн зогсохдоо «Гэмпэй сэйсуки» гэдэг ном уншиж байгааг ажиглаад,

- Сайнжаргал аа, яматогийн хөвгүүдийн (японы эртний дайнч овгийг ямато гэдэг) замналыг дэлгэрүүлсэн нь сонирхолтой байгаа биз гэж бахархсан янзтай хэлэв.

- Тозияа гуай, самурайн ёс бүр VII зуунд дэлгэрсэн гэхэд үнэмшмээргүй байна. Надад бол ердөө саяхан дэлгэрсэн юм шиг санагддаг. Тэгэхдээ сёвогийн эрин үед (Японы эзэн хаан мэйжи исин Иосихитогийн дараа хаан хүү Хирохито 1925 оноос залгамжилсан) дэлгэрсэн юм шиг санагдаад байна. Гэтэл олон зуун жилийн уламжлалтай ажээ гэж хэлээд Сайнжаргал суудлаасаа өндийлөө. Тозияа, янжуураа уугиулсаар түүний дэргэд ирж тухлан суугаад,

- Аа тийм, мартчих шахлаа. Чи маргааш Харбин руу явахгүй юу. Тэгэхгүй бол дэслэгч Комототой Гиринд уулзаж чадахгүй гэхэд Сайнжаргал жимсний ундаан аягалах зуураа,

- Дэслэгч Комото гэдэг чинь эртээр Доихарагийн дэргэд сууж байсан туранхай залуу юу? гэж асуулаа.

- Тиймээ, тэр чинь Гиринд очоод удахгүй юм байх. Аа тийм чамд би, учрыг нь гаргаж хэлэх гээд мартчих шахаж. Зөнөнө гэдэг ийм амархан байдаг юм байх даа. Бодож санаснаа үнэг шиг мартаад байдаг болчихож. Жан Сюэлянгийн хэдэн залуу дарга нар Мугдэнд байгаа манай эзэмшлийн цэрэг, цагдаа нарыг гоочлоод байгаа юм. Тэр хутган үймүүлэгчдийг Да Ботусан гэдэг нэг хожгор, хүрлэгэр хар юм толгойлж байгаа нь мэдэгдсэн л дээ. Тэгээд Гиригээс наашаа гарах сурагтай. Түүнийг аятайхан айлгачихвал хэлээ хазаад дуугүй яваад байж чадах золиг байгаа юм гэж ярихдаа Сайнжаргалын анхаарлыг татахгүйг хичээнэ. Тозияа, Да Ботусангийн тухай дэлгэрэнгүй ярихаас аль болохоор зайлсхийсэн тул Сайнжаргал уг мухарт нь хүрэхийг бодсонгүй.

Тозияа, Сайнжаргалтай орой болтол ярихдаа сакэ балгаж, япон хятадын харилцааны цаашдын хувь тавилан, Манжуурыг хятадаас салгахад гүйцэтгэх армийн үүрэг зэргийг хуучлав. Чингээд удаан суусандаа ядарсан Тозияа, өрөөндөө очиж хажуулахаар бослоо. Сайнжаргал Тозияагийн ярианаас ойлгосон нэг зүйл бол японы арми манжуурт хүч түрэн

орох болсон явдлыг гадарлав. Тиймээс Тозияа өдөөн хатгах далим хайж байгаа болой. Тозияа, Сайнжаргалын өрөөнөөс гарахдаа,

- Чи өнөө номонд оролцох хэвээрээ юү? гэж асуугаад түр саатасхийв.

- Азийг цэцэгжүүлэх аугаа үйлс гэдэг ном уу?

- Тиймээ. Тэр номын нэг бүлэг нь Манжуур монголын тусгаар тогтнол гэдэг нэртэй юм. Тэгээд монголын талаар чамайг бичээч гэж жанжин штабынхан хүссэн юм шүү.

- Би чадах юм болов уу? Гэхдээ чадах ядахаараа тус болохыг

хичээе. Харин их ном унших хэрэгтэй байх даа. Түүхийн баримтыг өргөн оруулж өгөх хэрэгтэй юм шиг санагдаад байна. Тэгэхгүй бол олигтой юм болохгүй байх гэхэд Тозияа толгой дохин зөвшөөрөөд өрөөнөөс гарлаа.

Сайнжаргал ширээн дээрх номоо янзлах зуур Тозияатай ярилцсанаа санаад «Жан Золинг устгах ажиллагаанд хурандаа Дайсаку Комото гэдэг хүн надад зааварласан. Одоо дэслэгч Сэмори Комото гэдэг хатсан борц шиг юм юу гэх гэж байгаа бол? Хурандаагийн удирдсан тэр ажиллагааг «Хар төмөр» гэж нэрлэсэн нь Зөвлөлтийн бөмбөгний хэлтэрхий олж ашигласантай холбоотой байсан. Тозияагийн яриагаар бол японы армийг манжуурт оруулах ажиллагааг «Мугдэнгийн зөрчил» гэсэн байх нь гэж өөрөөсөө санамсаргүй асуугаад хэд хоногийн өмнө болсон нэгэн хэрэг явдлыг санаав.

...Уржигдар Тозияа өрөөнөөс гаралгүй өдөржингөө хар архи балгаж гахайн шарсан мах, далайн байцаа, хайсугаар даруулж өнжсөн. Тэгэхдээ нэг удаа Сайнжаргалын өрөөнд орж ирээд гарахдаа амандаа «Мугдэнгийн зөрчил» гэж маани мэгзэм шиг уншиж байсан. Тозияа өчигдөр өрөөнөөсөө гараагүй. Сайнжаргал эртний япон хэлний тайлбар толиос үг түүж, худам бичгийн хадмал тайлбар хийж өнгөрөөлөө. Тэгээд Тозияагаас хэдэн үгний гарал, утгын холбогдлыг асуухаар өрөөнөөсөө гарч зочдын өрөөг дамжин, Тозияагийн өрөө рүү чиглэтэл Сувдаа харилцуур чагнаад буруу харан зогсож байв. Тэрээр утсаа тавиад эргэхдээ Сайнжаргалын бараанаар балмагдсандаа хацар нь ягаараад явчихсан билээ. Тэр утас нь Тозияагийн өрөөний утастай салаа болой. Сайнжаргал шал ширтэн зогсож буй Сувдаагийн дэргэд очоод,

- Юу ярьж байна гэж хайхрамжгүй асуулаа. Гуаньдунгаас хурандаа Итагаки ярьж байна. Цэргийн яамны сайд Минамигээс Тозияад цахилгаан явуулсан байна. Түүнийг мэдэнгүүт Тозияа уншаадах гэсэн юм. Цахилгаанд Тозияагийн биеийн байдлыг асуугаад эцэст нь энэ сарын арван найманд дорнодоос ягаахан өнгөтэй нар мандана гэж цаг агаарын бололтой мэдээ дамжуулсан байлаа.

- Сувдаа үүнээс хойш утас чагнаж болохгүй. Маргааш наад

утсаа зайлуулаарай гээд Сайнжаргал өрөөнөөс гарч билээ. Сайнжаргал цахилгаан утасны агуулгыг тунгаахдаа цэргийн яамны сайд цаг уурын мэдээ Тозияад дамжуулах ёсгүй. Тэгэхээр есөн сарын 18-нд японы цэрэг манжуур руу халдана гэсэн үг! гэж бодож билээ.

Япон, манжуур руу солонгост байгаа цэргээ илгээх тул Солонгосын Синьжугаас Аньдунгийн чиглэлээр орж ирвэл таван цагийн дотор Мугдэнд ирэх ёстой ажээ. Ийнхүү элдвийг эргэцүүлэн бодсон Сайнжаргал Харбинд ирээд Тозияагийн зөвлөснөөр Модрен буудалд буулаа. Чингээд маргааш нь Оросын дүрвэгсдийн товчоо, Харбин дахь цэргийн төлөөлөгчийн газраас хүмүүс ирж Сайнжаргалтай ажил төрлийн талаар ярилцлаа. Тэдний дотор дүрвэгсдийн дуу хоолойн сурвалжлагчаас гадна ахмад Мешанов, Сайнжаргалтай дотночилж ярилцана.

- Бид танай талийгаачтай сайн харилцаатай байсан. Тэгээд гүнтэн манай ажилд их элэгсэг ханддаг сан. Манай сонинд ар монголын асуудлаар хэдэн сайн өгүүлэл бичсэн. Би түүнийг эмхтгэл болгон хэвлэхээр бэлдээд байгаа гэхэд Сайнжаргал «Энэ хүн Итагакийн санааг надад сануулах гэсэн бололтой! Хөрөнгө хайж байгаа хэлбэр! Дүрвэгсдийн дуу хоолой сонины хавсралтыг надаар санхүүжүүлэх гэж байгаагийн баталгаа энэ дээ» гэж бодоод,

- Манжуур тусгаар улс болсон цагт би танай сонины ажилд хэрхэн оролцохоо шийднэ. Монголын сэхээтэн нарт зориулж сонин гаргана гэдэг тийм ч амархан асуудал биш! Тэгээд танай сонинд миний сэтгэлд таалагдах мэдлэгтэй хүн олох бөөн чирэгдэл болно биз гэлээ.

- Бид тийм хүн олно гэж бодож байгаа. Сонины газрын нөлөө бүхий хүнийг чингэж хэлэхэд Мешанов тэдний ярианд оролцож,

- Харбины сонингуудад нөлөөтэй байсан нэг хүний хүү энэ ажилд тохирно байх! Харин одоо Токиод байгаа учраас тантай танилцуулж амжсангүй. Та сургийг нь дуулсан байх. Нэрийг нь Хасчулуун гэдэг гэлээ.

- Би мэднэ. Хасчулуун бид хоёр ураг төрлийн барилдлагатай хүмүүс. Би аавынхаа ахын хүүхдүүдтэй дотносож яваагүй юм. Тэгээд ч ах нь бүтэлгүй хүн шүү дээ гэж Сайнжаргалыг дургүйцсэн янзтай хэлэхэд,

- Эх эцэг хүүхдүүдийнхээ биеийг төрүүлэхээс санаа бодлыг нь төрүүлдэггүй. Тиймээс нэг эхээс төрсөн хүүхдүүд үзэл бодол, улс төрийнхөө мэдлэгээр ондоо ондоо байдаг тохиолдол бий гэж Мешанов өөрийнхөө санааг илэн далангүй хэлэв.

- Би юу ч гэсэн Тозияа гуайтай ярилцана. Гэхдээ морины урд хөлийг бүдрэхээр нь хойд руу нь ташуурддагийг мартаж болохгүй. Дүү нь итгэлтэй боловч ах нь хэзээ нэг цагт дүүдээ нөлөөлөхгүй гэсэн баталгаа байхгүй. Үүнийг л ялгаж, салгадаг байх хэрэгтэй гэж Сайнжаргалыг хэлэхэд Мешанов, бүсгүйн дургүйг хүргэхгүйг эрхэмлэн яриагаа дуусгах нь зүйтэй гэж үзлээ. Мешанов, Сайнжаргалтай салах ёс гүйцэтгээд буудлын өрөөнөөс гарахын өмнө,

- Сайнжаргалаа, танай талийгаач эцгийн гэрээсэлсэн зүйлийг ойрын үед Харбин дахь японы банкны салбарт шилжүүлбэл Оросын дүрвэгсдийн товчоо тун их баярлах юм шүү гэхэд Сайнжаргал,

- Манжуурын нутаг дээр японы армийг бүрэн суурьшсан тэр цагт талийгаачийн гэрээсэлсэн хөрөнгийг Оросын дүрвэгсдийн товчоонд шилжүүлнэ гэхэд Мешанов инээмсэглээд,

- Хоёр хоногийн дараа байдал төлөв мэдэгдэх юм шив дээ гээд өрөөнөөс гарчээ.

Таргандуу махлаг царайндаа зохисон орог буурал битүү халимаг дэгжирхэж тавьсан Тозияа, есөн сарын арван зургааны үд өнгөрөөгөөд Мугдэн дэх японы эзэмшлийн цэргийн төлөөлөгчийн газар руу очихдоо явган явжээ. Давчуу нарийн гудамжаар тайван гэлдэрч яваа Тозияа, байшин, барилга бүхнийг ажиглан «Энэ хотын хувь тавилан нөгөөдөр өглөө гэхэд бүрэн шийдэгдсэн байна. Тэгээд эзэн хааны дэглэм манжуурт тогтох нь тэр дээ. Жилийн дараа гэхэд Өвөр монгол, умард хятад манай мэдэлд бүрэн орно. Хоёр жилийн дараа ар монголыг эзлэнгүүт алс дорнод, Байгалийг салгах «Оцу» төлөвлөгөөний дагуу манай аугаа их армийн ажиллагаа эхэлнэ» гэж бодсоор бардам алхана.

Тозияаг гаднаас орж ирэхэд түүнийг хүлээж байсан Симото, суудлаасаа өндийн босож сэнсэй-багштнаа хүндэтгэн угтаж,

- Тайса доноо, Порт-Артураас тантай ярья гэсэн.

Одоо ердөө мөчийн дараа утасдана байх гэлээ. Тозияаг ширээний дэргэд очтол утасны хонх жингэнэв. Тэрээр утсаа аваад, чагнавал холбооны хүүхнүүд,

- Байна уу?... Мугдэн байна уу гэх нь тод сонсогдлоо. Гэтэл удаж төдөлгүй бүдүүн баргил дуу чагнуурт паржигнаж,

- Байна уу? Тозияа сан байна уу? гэхэд Тозияа дуугаар нь дэслэгч генерал Сигэрү Хонзёо ярьж байгааг төвөггүй мэдлээ.

- Чиү жёо гаккаа Хонзёо сан, би байна. Та сайн явж ирэв үү? гэхэд Хонзёо хариу мэндлээд,

- Сайн явж өнөө өглөө энд ирлээ. Ах дүү нар мэнд хүргэж байна. Танайх руу явуулах бэлгийг бэлдчихсэн. Харин ах чинь захиа өгүүлснийг хүнээр явуулчихсан. Маргааш аваачиж өгөх байх гэснээр тэдний яриа дуусжээ. Тозияа генералтай утсаар ярьж байхдаа түүний хэлсэн үгийг Симотод хэлж бичүүлсэн билээ. Тусгай болзмол үг бүхий даалгавар хүлээн авсан Тозияа өнөө бичгээ ширтэн зогсохдоо,

- Хонзёо өнөө шөнө аравдугаар дивиз дээр иржээ. Жанжин штабын тагнуулын газрын дарга хошууч генерал Татэкава тусгай хэсгийнхээ хамт Солонгост ажиллаж байгаад наашаа гарсан байна. Мугдэнгийн ажиллагааг Татэкава удирдахаар шийджээ гээд ширээн дээрх шүдэнзээ авч Симотоод хэлж бичүүлсэн зүйлээ шатаалаа. Тэрээр цонхны дэргэд зогсож хэсэгхэн бодсоноо,

- Симото сан, Харбинаас ямаршуухан чимээ дуулдаж байна? гэж асуув.

- Ажил төлөвлөсөн ёсоор явж байна. Сайнжаргал Мешановтой уулзаж, Оросын дүрвэгсдийн товчоонд амласан гүнгийн гэрээслэлийг шилжүүлэхээр шийдсэн байна. Сониныхны, тавьсан болзлыг сонсоод Хасчулуунд итгэхгүй гэдгээ шууд хэлжээ. Тэгэхдээ Хасчулууныг ахтайгаа хэзээ нэг цагт холбоо тогтоож ажлыг нь унагана гэдгээс болгоомжилсон байна. Иван Степановичийг тусгай ажлаар Хайлар руу явуулчихсан тул Сайнжаргал түүнтэй уулзаж

амжаагүй байгаа гэж илтгэв.

- Гүнтэн нас барахын өмнө ахынхаа үр хүүхдийн талаар ярьсан байх нь. Тиймээс Баатар гүн агчийн хүүхдүүдээс Сайнжаргал болгоомжилсон хэрэг.

- Тийм ч байж болно. Гэхдээ Сайнжаргал, эцгийнхээ ахын

хүүхдүүдээс хөндий байсан хийгээд ер нь нүүр учирч яваагүй явдлыг үзвэл тэдний ураг төрлийн харьцаа, их хөндий байсан юм. Тэр байтугай нэг эх эцгийн хүүхдүүд бие биенээсээ хөндий өсөхөөрөө ах дүүгийнхээ барилдлагыг мартдаг удаа бий шүү. Тиймээс Сайнжаргал тэдний хэн хэнд итгэхгүй байдаг нь зөв хэрэг! гэхэд Тозияа, Симото руу сүрхий харав. Энэ бол сүүдэртээ итгэдэггүй Тозияагийн заяаны сэжигч, болгоомжлон сонжиж харддаг шинж болой.

- Баатар гүнгийн анхны амрагийн охины талаар юу бодож байна вэ?

- Бидэнд байгаа баримтаар бол тэр охиныг Харбины гудамжнаас Баатар олсон нь үнэн боловч хэнд өгч асруулж байсан нь мэдэгдээгүй. Дам сонсоход тэр охиныг эхтэй нь хамт ар монгол руу явуулсан байна. Гүнгийн эхнэр Улаанбаатарт барьж байгаа барилга дээр ажиллаж байгаа сураг гарсан болохоор саяын дам баримт үнэн гэж үзэх үндэстэй юм. Энэ талаар судлуулах ажил бэлдэж байгаа.

- Симото сан, ер нь энэ тухай хэрхэн ажиллах төлөвлөгөө боловсруулахдаа гүнгийн холбоочинтой уялдуулаарай. Нөгөө талаар дэслэгч Комотогийн үүргийг өөрчилсөн. Хар төмөр ажиллагаанд оролцсон тай са Камото Сайнжаргалд зааварласан юм. Тэгэхээр одоо чий и Комото Сайнжаргалын гүйцэтгэх үүрэгт оролцуулж болохгүй. Харин Доихарагийн төлөвлөсний дагуу төмөр зам дэлбэлэх ажилд оролцуулсан дээр. Бидний зорилго бол сүүлчийн вагоноос өөр ямар ч вагоныг дэлбэлж болохгүй гэдгийг бодох хэрэгтэй. Гирингээс тэр вагонд Сайнжаргалыг суулгаад аюулгүй байдлыг нь хангах нэг санаа сэдсэн. Тиймээс удирдамжаа Гирин рүү явуулна. Би Биньси рүү явж эрхэм дээдсийг угтана. Итагаки, генерал Татэкаватай ирэх ёстой. Ингэхээр эрхэм дээдсийг буудалд нууц буулгах ажлыг сайн зохион байгуулах хэрэгтэй. Татэкавааг буудалд буусан явдлыг хэн ч мэдэж болохгүй. Нөгөө талаар Татэкавааг Порт-Артуртай ярьсан үед холбоог сайн ажиглах хэрэгтэй. Тэдний яриаг холбооныхноос хэн сонссон бэ? гэдгийг мэдсэн байх хэрэгтэй гээд Тозияа өрөөнөөс гарлаа.

Тозияаг, Солонгосоос хятадын хил дээр ирээд Аньдун руу хөдөлчихөөд байгаа галт тэрэгт суусан тагнуулын газрын

дарга Татэкавааг угтахаар явсны дараа Доихара өөрийнхөө ажилтангуудыг цуглуулж удирдамж өглөө.

- Жанжин штабаас боловсруулсан Манжуурын асуудал ажиллагааг нууцлах "Мугдэнгийн зөрчил" ажиллагаанд та бүхнийг оролцуулахаар баталсан юм гээд Доихара өрөөнд байгаа таван хүнийг ажиглангуй харлаа. Тэгээд яриагаа үргэлжлүүлэн — Маргааш орой Тайлинд ирэх галт тэргэнд сууж яваа Сайнжаргалтай уулзах ёстой хүний ажиллагааг өөрчилсөн. Ингэхээр чий Комото төмөр зам дэлбэлэх асуудлыг гардан удирдах болно. Хамгийн гол

анхаарах зүйл бол сүүлчийн вагон зам төмрөөр явж өнгөрөх тэр хугацаатай дэлбэрэлтийг яг тохируулсан байх ёстой! Нөгөө талаар зам төмрийн тасархайг заавал авчирна. Энэ бол баримт болгох зүйл гэдгийг мартаж болохгүй. Мөн хятад цэргийн хувцастай таван үхдэл бэлдэх хэрэгтэй. Үүнийг томилогдсон хүмүүс явж улс төрийн хоригдлуудыг хорьдог хорих газраас олж, дэлбэрэлт болсон газар дээр аваачих болно гээд Доихара, өөрийнхөө яриаг дуусгаж, хүмүүсээ ажил төрөлд нь яаралтай оруулав. Чухам энэ үед Доихарагийн нэг шавь Гиригийн галт тэрэгний буудлын зоогийн газар Сайнжаргалтай уулзаж байлаа.

- Сайнжаргал сан, та вагонд суунгуутаа үйлчлэгч нартай уулзаж «Хүнгүй вагонд явах уйтгартай юм. Өөр вагонд суулгаж өгөөч гэж гуйгаарай! Тэгэхдээ өөр вагонд суух гэж улайрсны хэрэггүй. Тайлинд таныг нэг хүн угтана. Тэр хүн цаашаа хэрхэх тухайг чинь хэлж өгнө» гээд зоогийн газраас гарч оджээ.

Галт тэрэг хөдөлсний дараагаар Сайнжаргал буцалсан ус хийж авахаар халуун тогооны дэргэд зогсож байтал үйлчлэгч бүсгүй өөрийнхөө өрөөний хаалгаар цухуйснаа,

- Эгч ээ та, ус авах гэж байна уу? Жаахан хүлээх байх даа. Арай буцлаагүй байгаа. Би ингэсхийгээд таны өрөөнд оруулж өгье гээд халуун савыг нь авах гэлээ.

- Би эндээ хүлээе. Өрөөндөө ганцаараа уйдаад байх юм.

- Тэг дээ, манай вагон өнөөдөр явах ёсгүй байсан юм. Гэтэл Мугдэнгээс тусгай хүмүүс авч Гирин хүргэх ёстой боллоо.

- Тийм байхаа. Хүмүүст пиу худалдахгүй байсан юм. Би, цэргийн төлөөлөгчийн газрын нэг хүнийг гуйж байж ганц пиу авсан шүү гэж Сайнжаргалыг хэлэхэд үйлчлэгч бүсгүй,

- Та өөр вагонд суувал ярилцаж болно шүү... Харин үйлчлэгчид нь гар цайлгах байх шүү гэж учирлав.

- Тэгвэл сайн байна. Би гар татахгүй гэхэд үйлчлэгч өрөөнөөсөө гарав. Тэр үйлчлэгч, Сайнжаргалд хэлсэндээ хүрчээ. Тэрээр дөрөвдүгээр вагонд нэг сул суудал байгааг ярилцаж, Сайнжаргалыг суулгахаар тохирсон байлаа. Сайнжаргал эхэндээ хэсэгхэн зуур бантсанаа, үйлчлэгчийн аяг олж тааруулахаар шийдээд,

- Би та нарт түвэг тарьчихлаа. Ер нь ганцаараа явах нь амар юм шиг байна. Тэгээд ийм сайхан тусч хүүхнүүдийг гомдоогоод яах вэ? Тийм биз дээ гэж өөрийгөө цагаатгав. Чингээд Сайнжаргал үйлчлэгч нартай нийлж, дэвэн дэлхийн адал явдлыг уудлан, эмэгтэй хүний сониучхан зангаар далан хэл дэлгэж гарлаа. Сайнжаргал тэдэнтэй ярилцаж суухдаа «Энгийн хоёр бүсгүй эцсийн эцэст амиа алдахад хүрэх нь. Тиймээс Тайлинд угтах хүнтэй уулзсаны дараа хэрэг явдал тодорхой болох нь эргэлзээгүй. Ямар ч гэсэн энэ хоёр бүсгүйн амийг аврах хэрэгтэй» гэж бодож байлаа. Чингээд галт тэрэг нар шингэж байхад Тайлинд ирлээ. Үйлчлэгч буух дохио өгөхөөр зэхэж байхад Сайнжаргал галт тэрэгний буудал сонирхохоор вагоны үүдэн дээр очив. Галт тэрэг зогсож, Сайнжаргал вагоноос буутал энгийн хувцастай нэгэн япон залуу угтан уулзахыг ажваас зүс үзсэн залуу байлаа. Тэрээр Доихарагийн ажилтангууд гэдгийг Сайнжаргал мэдэж байжээ. Залуу Сайнжаргалтай уулзаад энгийн ярьж

байснаа алгын чинээ дөрвөлжин боодолтой хоёр зүйлийг өгөөд,

- Та энэ бэлгийг өрөөндөө оруулж суудал доогуураа тавиад цаг хагасын дараа галт тэрэгний зоогийн газар орох хэрэгтэй. Мугдэнгийн буудал дээр таныг Симото сан өөрөө угтана гэж учир байдлыг тайлбарлав. Сайнжаргал залуутай энэ тэрхнийг ярин тавцан дээгүүр хий холхихдоо өнөө бэлгээ гар цүнхэндээ хийгээд вагон руугаа эргэлээ. Чингээд вагондоо орж ирэнгүүт өнөө бэлгээ суудал доогуур хийгээд хэсэгхэн зуур элдвийг эргэцүүлэн бодлоо.

...Яагаад сүүлийн вагоныг дэлбэлэх болсон бэ? Хоосон вагон дэлбэлээд ямар ашиг гаргах вэ? Цаг хагасын дараа агаарт хийсэн одсон хоосон вагоны талаар япончууд ямар шуугиан дэгдээх гэж

байгаа бол? Энд л хамаг учир байна. Манжуурт японы армийг оруулахын тулд энэ дэлбэрэлт зайлшгүй хэрэгтэй болжээ. Тэгвэл үүнээс ямар эгзэг гарах вэ? Сүүлийн вагоныг дэлбэлбэл төмөр зам дэлбэрэхгүй. Төмөр зам бол японы хөрөнгө. Тэгэхээр өөрийнхөө хөрөнгийг дэлбэлье гэж хэн бодох вэ? Харин дэлбэлбэл яах вэ? Тэгвэл нэг эгзэг гарч болно. Хятадын цэрэг японы эзэмшлийн төмөр замыг дэлбэлж, хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан гэдэг шуугиан дэгдээж болно. Ингэвэл японы армийг манжуур руу оруулах шалтаг болно. Ингээд л япон өөрийнхөө хөрөнгө болон манжуурт байгаа иргэдийнхээ эрхийг хамгаалах зорилгоор армия оруулаа гээд зарлачихна. Ингэхийн тулд намайг ашиглаж байгаа нь нэг ёсондоо эцгийнхээ хүсэл мөрөөдлийг биелүүлэх гэсэн намайг өөрийнхөө бодолд тууштай эсэхийг шалгах гэсэн хэрэг! Харин дэлбэрэлтийн уршгийг япончууд нэг бол Жан Сюэляны цэрэг юм уу эсвэл хятадын партизан руу чихнэ. Мугдэнгийн ойролцоо Жан Сюэляны цэрэг хуарагнадаг. Тэгэхээр япончууд энэ хэргийг хятадууд гэдэг ерөнхий нэрээр шуугиан дэгдээх нь гарцаагүй.

Сайнжаргал ингэж бодсоор өрөөнөөсөө гарч үйлчлэгч нарын өрөөнд орлоо. Тэгээд уйдаж залхсан байдлаар үг яриа өдөж, амандаа халсан гурван хүүхэн яриа дэлгэсээр нэлээн хугацаа өнгөрөөлөө.

- Дэмий юм бурсаар байгаад цаг талийчихлаа. Хоёулаа хоолныхоо аяыг бодно байгаа гэж нэг үйлчлэгчийг хэлэхэд нөгөө нь,

- Тэгье дээ гэж уриалгахан хүлээн авлаа. Сайнжаргал өөртөө ашигтай далим гарсныг мэдэнгүүт,

- Би ч гэсэн өглөөнөөс хойш олигтой юм идсэнгүй. Галт тэрэгний зоогийн газар очье байз... Ер нь гурвуулаа хооллох уу? Би та хоёрыг надтай хамт оройн хоол идэхийг гуйя гэхэд үйлчлэгч нар татгалзсангүй. Галт тэрэгний зоогийн газар тэр гурвыг орж ирэхэд хүн цөөн, сэлүүхэн байлаа. Учир нь цагийн дараа галт тэрэг Мугдэнд очих ёстой.

Зоогийн газрын үйлчлэгч эмэгтэй, тэдний захиалгыг аваад эргэх зуур Сайнжаргал цагаа харвал галт тэрэгний сүүлчийн вагон дэлбэрэхэд ердөө арван таван мөч үлдээд байлаа. Чингээд

үйлчлэгч бүсгүй, захисан хоолыг авчирч ширээн дээр өрж байсан тэрхэн хоромд нүргээнтсэн

их чимээ гарч, галт тэрэгний вагонууд бие биенээ мөргөн, хүчтэй түлхэлтээс хүмүүс сандал дээрээс огло үсэрч, зарим нь газар ойчиж, зарим самбаатай нэг нь суудлаасаа босон зоогийн газрын хаалга руу хурдалж байгаа харагдав. Галт тэрэг нүргээнтсэн чимээгээр хурдаа хастал буун дуу тас нясхийн пижигнэх нь тэрээ. Тэгээд зоогийн газар байсан зорчигчид сандарч «Дээрэмчид...улааны дээрэмчид...улаан партизанууд... мухар толгойтнууд» гэж шуугьцгаатал хурдаа хасаад зогсох гэж байсан галт тэрэг цаашаа хурдлах нь тэрээ. Галт тэрэг хурдаа нэмэн Мугдэнгийн зүг хурдлахад буун дуу тэртээд чимээтэн тачигнасаар холдож байлаа.

Буун чимээгээр зоогийн газар байсан ихэнх хүмүүс вагон руугаа яаран явцгаажээ. Галт тэрэгний вагоны үйлчлэгч нар яаран сандран вагон руугаа явцгаахад Сайнжаргал тэднийг даган вагон вагон дамжсаар байлаа. Тэр гурав сүүлчээсээ гурав дахь вагонд орж иртэл хоёр үйлчлэгч, цувааны ахлагч гурав тэдний барааг хараад эг маг ээрлээ.

- Та нар чинь юу болчихоо вэ? Сая юун дэлбэрэлт болсон бэ? гэж сүүлчийн вагоны нэг үйлчлэгчийг асуухад цувааны ахлагчийн дүрэмт хувцас өмссөн нэг хятад,

- Сүйд болсон. Бид их азтай улсууд юм. Танай вагон дэлбэрч, тасраад үлдчихсэн. Тэгээд бид чинь та гурвыг осолдчихлоо гээд сандарч байлаа шүү гэж дуу алдав. Энэ үгийг сонсоод Сайнжаргал,

- Юу? Миний хамаг юм тэнд чинь байгаа юм гэж дуу алдав.

- За тайвширцгаа. Амьд үлдсэн хойно тэр юм ч яахав. Гарах ёстой гарлага гарч байгаа нь тэр! гэж галт тэрэгний цувааны ахлагчийг хэлэхэд Сайнжаргал сэтгэлдээ «Ямар ч гэсэн гэмгүй хоёр бүсгүйн амийг аварч амжлаа» гэж бодоод баярлаж байлаа. Галт тэрэгний цуваа сүйрэхэд хүрсэн байдлыг Мугдэнгээс холгүй байгаа зөрлөгийнхөн мэдээд Мугдэн руу мэдэгдсэн тул цувааг буудалд оруулсангүй. Тэгээд тусгай мухар зам дээр зогсоолоо. Зүсэн бүрийн хуйвалдаан, хэрэг явдал, үймээнийг хамгийн түрүүнд мэддэг цагдаагийнхан японы эзэн хааны хөрөнгийг хятадууд дэлбэлсэн явдлыг хамгийн түрүүнд Мугдэн дэх японы

ерөнхий консулд мэдэгдэв. Чингэснээс хойш Мугдэнгийн сонин сурвалжлагч нар мэдээд шөнийн 22 цаг гэхэд Мугдэнгийн буудал руу гүйцгээлээ. Гэвч Мугдэнгийн буудлыг хамгаалсан цагдаа нар тэднийг галт тэрэгнээс буусан хүмүүстэй уулзуулсангүй. Чухам энэ үед Симото, Сайнжаргалыг тосон авч дагуулсаар буудлын нэг тохилог өрөөнд хүлээж байгаа Тозияатай уулзуулав. Энэ хэрэг явдал дэгдсэнээс хойш хэдэн цагийн дараа Мугдэнгээс холгүй хээрийн сургууль хийж байгаа японы хоёр суман цэрэгт тусгай үүрэг оногджээ. Тэд өглөө 8 цаг 20 минут гэхэд Мугдэнгийн хээрийн цагдаа цэрэг болон хотын зүүн талд байгаа хятадын цэргүүдийн хуаран руу дайрах тушаал авчээ. Маргааш өглөөний есөн цаг гэхэд Мугдэнгийн зүүн хойно байгаа төмөр замын өртөө, онгоцны буудал руу японы армийн хоёр суман хүнд их буугаар гал нээжээ. Чингээд японы 500 цэрэг бүхий жижиг хэсэг 10 мянган цэрэгтэй хятадын хуаранг сандаргажээ. Чухам энэ үед японы засгийн газар «Хятадын төмөр замын хамгаалалтын цэрэг, цагдаа нар үймээн дэгдээж, японы эзэмшил төмөр замын даланг дэлбэлж ноцтой хохирол учруулсан учраас өөрийнхөө иргэд болон эд хөрөнгийг аюулгүй байлгах нөхцөлийг хангахын тулд японы арми зохистой арга хэмжээ бүхнийг авна» гэж мэдэгдлээ. Гэтэл үнэн хэрэг явдал өөр байсан төдийгүй нарийн зохион байгуулсан билээ.

...Ерөнхий сайдын зөвшөөрлөөр Асахи сонин, Цэргийн яамны сайд Минами хятадад байгаа 17 дивизийн дарга нарыг цуглуулж уулзсан уулзалтыг 8 сарын 21-ний өдрийн дугаарт нийтэллээ. Тэгэхдээ цэргийн яамны сайд «Цэргийнхэн, нийгмийн бодол санааг хүлээн авахгүй бөгөөд засгийн газрын эсрэг илэрхийгээр хандах болно» гэснийг дуулиан болгосон нь ерөнхий сайдыг айлгажээ. Эзэн хааны зөвлөх Саёнзи, Вакацукийг дуудаж уулзахдаа «Мугдэнгийн ойролцоо, эзэн хааны хөрөнгө болсон өмнөд манжуурын замд халдаж сүйтгэсэн тул тэр сүйрлээс аврахын тул армийнхан хязгаарлагдмал ажиллагаа явуулна» гэж мэдэгдсэн нь армийн ажиллагааг засгийн газар албан ёсоор зөвшөөрөх ёстой гэсэн битүү тулгалт байжээ. Тэр зөвлөх 9 сарын 14-нд Минамийг дуудаж уулзаад зөвлөхдөө «Гуаньдунгийн цэргийн ажиллагааг Мугдэнгээс өөр тийш чиглүүлж болохгүй»

гэж дахин сануулжээ. Сайд Минами, зөвлөхийн үгэнд эгдүүцсэнээ илэрхийлэхдээ «Манжуурт явуулж байгаа армийн ажиллагаа бол зөвхөн эзэн хааны хөрөнгө, ард иргэдийн амь насыг хамгаалж байгаа төдий зүйл биш. Манжуурт болон хятадад улаан оросын нөлөө коммунизмын үзэл санаа дэлгэрэх явдалтай тэмцэх хамгийн зохистой аргын нэг болж чадахад оршино. Тиймээс арми, өөрийнхөө ажиллагааг үргэлжлүүлнэ үү гэхээс ухардаг уламжлал байхгүй» гэж эсэргүүцжээ. Минами, эзэн хааны зөвлөхтэй ам мурийж, ордноос гарч ирэнгүүт Тозияа руу цахилгаан явуулжээ. Ингээд төлөвлөсөн ёсоор 9 сарын 18 нд шөнийн 22 цагт дэлбэрэлт болсон билээ. Энэ хэрэг явдлыг эхлэнгүүт Итагаки өөрийнхөө үүргийн дагуу Мугдэн хэмээх өртөөнөөс Порт-Артур руу утсаар Хонзёод илтгэхдээ «Юу л болох ёстой бүхэн ёсоороо боллоо.

Давшилт бол хамгаалалтын шилдэг хэлбэр шүү дээ» гэж илтгэсэн нь армийн ажиллагааг Чанчун, Харбин, Гирин руу чиглүүллээ гэсэн хэрэг байлаа. Хонзёо тэр дороо Солонгост байгаа Угакитэй утсаар ярьж, Солонгост байрласан нисэх онгоцуудыг Мугдэн руу хөдөлгөхийг тушаалаа. Хонзёо Мугдэн руу гарч дэлбэрэлт болсны маргааш өглөө нь ирээд хурандаа Хэсэбагийн бригадыг Чанчун руу хөдөлгөв. Энэ бүхнийг мэдсэн ерөнхий сайд хаантанд бараалхаад «Манжуурт дэгдээсэн армийнхны ажиллагааг зогсоож бүх цэргийг Гуаньдунгийн арал руу татах зарлиг соёрхоно уу» гэж гуйлаа. Гэтэл эзэн хаан Хирохито, түүний саналыг үл ойшоон буцаалаа. Чингээд их гүрнүүдийн өмнө хүлээсэн үүргээсээ эмээж цочсон Вакацуки, Минамийг дуудаж «Гуаньдунгийн цэргийг манжуураас гаргахыг үүрэг болгож жанжин штабт тушаал өгөхийг шаардлаа». Үүнийг сонссон цэргийн яамны сайд «Самурайн ёсонд эзэн хааны цэрэг очсон газраасаа буцаж ухарч байсан уламжлал байхгүй» гэж сүрдүүлжээ. Энэхүү учир холбогдлыг битүү мэдсэн сонин сурвалжлагч нар Тозияа, Доихара нартай уулзаж, дэлбэрэлтэнд өртсөн галт тэргэнд сууж явсан «Сайнжаргалтай уулзах хүсэлт» тавилаа. Тозияа үүнийг урьдчилан тооцоолсон болохоор Сайнжаргалтай уулзах гэсэн сонин сурвалжлагч нарт хориг саад тавьсангүй. Тиймээс Сайнжаргал Тозияагийн зөвлөсөн ёсоор

«Дэлбэрэлт болох үед зоогийн газар байсан болохоор чухам юу болж байгааг мэдээгүй. Ямар ч гэсэн хятадын цэргүүд зэвсэглэн халдсан гэдгийг л би мэдэж байна» гэж мэдэгдэв. Гадаадын сурвалжлагчид зөрөөтэй мэдээ дамжуулж түүнээс дам авсан сурвалжлагч нар бүр дампууруулжээ. Манжуурын хэрэг явдлыг цэргийн хүчирхийллээр шийдэж Мугдэнг эзлэн авангуут хотын захиргаа Доихарагийн гарт орлоо. Чингээд хэд хонож байтал цэргийн яамны сайдын туслах Тозияатай утсаар ярив.

- Тозияа сан, сайд нарын танхим армийн ажиллагаанд чөдөр болж, Харбин, Гирын рүү манай армийн цэргийг хөдөлгөж болохгүй гэж хориглосоор байна.

- Тэр аймхай сайдуудыг сайд нарын танхимаас зайлуулах хэрэгтэй. Их гүрнүүдийн нохой сүрдүүлгээс айж, ямагогийн хөвгүүдийн нэрийг бузарлаж байна. Тийм бялдууч нялуун зантай, туулай шиг аймхай улс төрийн янхнууд үхэх мөрөөрөө үхэцгээг. Гагцхүү ямагогийн хүүхдүүдийн замд гай бололгүй мөрөөрөө тонилцгоо гэж хэл! Армийн ажиллагааг үргэлжлүүлж манжуурыг авахгүй юм бол ямагогийн хүүхдүүд хэний төлөө амиа өргөх болж байна. Тэр мөртлөө үйлдвэрийн эзэд, сайд нарын нэр оронцоглосон хүний сүгнүүдийн нэр сүрийг бодож ухарна гэдэг бол тэнногийн зарлигт таарахгүй! гэж Тозияа хашгирч хэлээд сандал дээр суутал утасны чагнуур баахан паржигнаж байгаад дуугүй болчихлоо. Тозияа энэ бүхэнд уурласан уурандаа утас руу нулимаад ширээ рүүгээ чулуудав. Тозияа омгоо дарж ядан бухимдаж суутал утасны хонх дахин жингэнэлээ. Гэтэл утсыг Симото авч чихэндээ ойртуулснаа Тозияа руу сүрхий хараад

- Тозияа сан, гаккаа Минами сан ярья гэж байна гэлээ. Тозияа суудлаасаа өндийгөөд чагнуурт паржигнасан дууг сонсонгуут,

- Цаад маанагууд чинь юу гээд байгаа юм бэ? гэж асуухдаа цэргийн яамны сайдын амар мэндийг лавлахаа мартжээ.

- Тозияа сан, ерөнхий сайд олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу тэдний шаардлагыг харгалзан Гуаньдунгийн цэргийн ажиллагааг түр зогсооё гэж шийдсэн боловч эзэн хаан зөвшөөрсөнгүй. Тиймээс төлөвлөгөөний дагуу Хонзёод 10 дугаар дивиз, 29 дүгээр холимог бригадын ажиллагааг үргэлжлүүлэх тушаал өгсөн. Түүнээс гадна таны

бэлдсэн «Эзэн хаан» гэдэг ажиллагааг далдлах төлөвлөгөөг үзлээ. Түүнийг эхлүүлэх нь чухал байна? Уул ажиллагааг Доихара бие даан шийдэх тул та түүний ажиллагааг Тяньжин дахь урт чихтэй хүмүүсээс далдлах нь чухал байна. Ялангуяа манжийн эзэн хаан агсан Пу-Игийн талаар эвгүй үг яриа дэгдээж болохгүй. Тиймээс эзэн хаан, хатан хаан хоёрыг өөрийнх нь хүсэлтийг харгалзсан юм гэдэг сэтгэгдэл төрүүлэх боломжийг хангах хэрэгтэй. Энэ талаар жич удирдамжийг таны нэр дээр явуулна гэж амласан нь Тозияагийн бухимдсан сэтгэлийг уужруулав. Учир нь Тозияа японы цэрэг манжуурыг эзлэнгүүт манжийн төрийн сүүлчийн хаан агсан Пу И-ийг манжуурын хаан болгоно гэдэг сэтгэгдэл төрүүлэхийн тул Тяньжинд хэдэн жил ажилласан. Харин одоо түүний үр дүнг гаргах боломж нээгдэж байгаа тул Тозияа сайдын үгнээ баярлажээ. Тэгээд Тозияа Доихаратай ярихаар завдаж байтал гаднаас Мугдэн хот дахь цагдаагийн газрын орлогч Тозияагийн өрөөнд орж ирлээ.

- Тозияа сан, дэлбэрэлт болсон газраас авчирсан зүйлээр байгуулсан үзэсгэлэн бэлэн болсон. Тэр үзэсгэлэнг нээхэд зарим сонин сурвалжлагч нар Сайнжаргалтай уулзах санал гаргаж магадгүй юм. Тиймд Сайнжаргалаар сонин сурвалжлагч нарын зарим асуудалд хариу өгүүлэх нь бидэнд ашигтай. Галт тэрэгний сүйрлийн талаар зөрөөтэй баримтууд сонинд хэвлэгдэж байгаа тул одоо бид учир байдлыг тайлбарлах нь хэрэгтэй шүү дээ. Тиймээс энэ бүхэнд танаас удирдамж авмаар байна гэхэд Тозияа хэсэгхэн бодож зогссоноо,

- Та нар хятадын цэргийн үхдэлийг буюу шоронгоос авчирсан хоригдлуудын хүүрийг хятадын

цэргийн хувцсаар хувцаслаж будлиан дэгдээсэн. Уул нь тэр хүүрүүдийг хятадын төмөр зам хамгаалдаг цэргийн сапёрчдын хувцсаар хувцаслах ёстой байсан. Та нар төмөр замыг хятадын хээрийн цэргүүд хамгаалдаггүй гэдгийг яагаад мартсан хэрэг вэ? Нөгөө талаар сонин сурвалжлагч нарт үзүүлэхээр дахин шинэчилсэн үзэсгэлэнг чинь би өөрөө урьдаар үзсэн. Ер нь бүх зүйлийг бүтэлтэйхэн бэлдээгүй бол сайхан мэдээрэй гэж загнажээ.

Мугдэнгийн ойролцоо болсон дэлбэрэлтийн талаар бие биенээсээ их зөрүүтэй мэдээ сонингуудад хэвлэгдсэнд түүнийг

дахин сурвалжлах ажил нэмжээ. Сурвалжлагч нар японы цагдаагийн газрын бэлдсэн үзэсгэлэнг үзэж зургийг нь авахдаа дэлбэрэлт болсон газраас авчирсан зам төмрийн хэлтэрхийг их сонирхов. Тэр зам төмрийг жинхэнэ дэлбэрэлт болсон газраас авчраагүй гэдгийг гагцхүү дэслэгч Комото мэднэ. Комото, дэлбэрэлтийг яг тохируулсан боловч зам төмөрт ямар ч гэмтэл болоогүй учраас харанхуйд сандарч яваад төмөр замын зам төмрийг солиход үлдсэн зэвэрч хуучирсан зам төмрийн богино тайрдас олж, цагдаагийнханд атгуулсан ажээ. Гадаадын сонин сурвалжлагч нар шинэчлэн байгуулсан үзэсгэлэнг үзээд цагдаагийн газрын удирдах хүмүүсээс хэдэн зүйл сонирхон лавлажээ.

- Дэлбэрэлт болсон газраас авчирсан зам төмөр зэвэрчихсэн байна. Энэ зам төмөр ерөөсөө зэвтэй байсан хэрэг үү? Сая зэвэрчихсэн юм уу? гэж нэг сурвалжлагч шалгаав.

- Хуучин зэвтэй төмөр яалаа гэж байх вэ? Дэлбэрэлт болсон газраас манайхан авчирсан хойноо жаахан гамгүй хадгалсан болохоор зэврэхэд хүрсэн биз гэлээ. Чингээд сурвалжлагч нар Сайнжаргалтай уулзав. Тэр уулзалтанд Доихара, Тозияа хоёр хоёулаа байлцлаа. Асуулт бүхэн ерийн байдалтай өнгөрч байгаад Тозияа сэтгэл хангалуун болой. Уулзалт тарахын өмнөхөн өвөр монголын нэг сурвалжлагч,

- Сайнжаргал гуай та 1928 оны 6 сарын эхээр Бээжингээс Мугдэн руу явж байсан галт тэргэнд суусан байхаа? Тэгэхэд тэр галт тэрэг Мугдэнгийн ойролцоо дэлбэрч маршал Жан Золин нас барсан. Харин та өөр хотод буусан шүү дээ. Саяын галт тэрэг Гирингээс хөдлөхөд та сүүлчийн вагонд суусан байна. Эдгээр дэлбэрэлтүүд яагаад таны явалттай таардаг юм бэ? гэж асуулаа. Тозияа ийм асуулт гарна гэж тооцоогүй болохоор Сайнжаргалд өгсөн заавартаа энэ тухай дурсаагүй билээ. Энэ нь Тозияагийн алдас болжээ. Тозияа гайхсан харцаар Сайнжаргал руу сэм хартал тэрээр баясгалантай инээмсэглээд,

- Би монгол хүн. Манай ёсонд ийм тохиолдлыг мэнгэ голлож, ёр шүглэх гэдэг юм. Тийм болохоор намайг ёр даллаж байгаа хэрэг! Ийм үед жанрайсэгийн даллага авч, ёроо хөөлгөдөг ёстой. Та ингэж сануулаагүй бол би, даллага авахуулж, овоо тахиулалгүй явж байгаад халуун тамд унах байжээ. Таны сануулж хэлсэнд

их баярлалаа. Би даллага авахуулж, овоо тахиулна. Харин та заавал ирээрэй. Би танд тусгай урилга явуулна гэж даажигнасан нь сурвалжлагч нарын сэтгэлд таалагдаж, хөөр хөгжөөн боллоо. Харин Тозияа тэр сурвалжлагчийн хаягийг олох үүргийг цагдаагийн газрын орлогч даргад үүрэг болгосон төдийгүй бас Симоотоод санамж болгожээ. Чингээд хэд хоногийн дараа өвөр монгол сурвалжлагч санамсаргүй тохиолдлоор галт тэрэгний осолд өртсөн нь цагдаагийн газрын өвөрмөц онцлог хэвшмэл арга гэдгийг сурвалжлагч нар мэдэж байлаа.

Японы армийнхан манжуурт цэргийнхээ хүчийг оруулснаас хойш Чанчунь, Гирин хотуудыг эзлэв.

Энэ бүхний мөн чанарыг мэдсэн Сайнжаргал, японы армийн ажиллагаанд үл итгэхэд хүрсэн сэтгэлээ Сувдаад ярилаа.

- Сайнжаргал эгч ээ, японы арми, манжуур өвөр монголыг хятадаас тусгаарлаж, биеэ даасан улс болгоно гээд байдаг сан тэгвэл өнгөрөх нь шив дээ. Манжуурыг бүр хаантай болгоно гэдэг сэн гэхэд Сайнжаргал,

- Японы арми манжуурыг Жан Сюэляны гараас салгаж, эзэн хаантай болгох нь болгоно. Харин манжийн сүүлчийн эзэн хаан Пу И манжуурын хаан болоод хаан эзнийхээ эрхийг эдлэхгүй харин японы армийн удирдлагын дуу хоолойгоор улс орныг захирах байх. Ингэхээр хаан болгоно гэдэг нь ор нэрийн зүйл! Харин манай Халхыг ингэх үү, үгүй юу гэдэг сонирхолтой байна. Богд Чингэсийн үеийн улсыг сэргээн байгуулна гээд байгаа юм. Гэхдээ мэдэхгүй дээ. Харин ардын засгийг устгачихвал Буйр, Халхын голын сав газрыг эзэмшил болгож авбал надад ашигтай. Аав үүнийг чухалчилж байсан юм. Гэхдээ энэ бүхэнд итгэхэд хэцүү байна.

- Японыхон эхлээд манжуурыг дараа нь өвөр монголыг хятадаас салгана гэдэг улс. Тиймээс одоо Жиэхэ, цахарт суурьшсан Жан Сюэляныг умард хятадаас зайлуулахыг оролдож байна. Японы арми үүнийг хэрэгжүүлсний дараа ар монгол руу мөлхөх үү? Эсвэл Чан Кайшигийнхантай түнжин хагарах уу гэдэг сонин зүйл. Миний бодлоор бол эд эхлээд хятадын асуудал гэгчийг хэрэгжүүлэх байх.

- Харин ээ. Ер нь улс төрийн бодлого гэдэг ч хаашаа янзын

юм бэ? Нөхрөө голж гоодсон хүүхэн шиг урваж хөрвөөд зогсохгүй садар самуун эрчүүд шиг нэгээс нөгөө рүү үсчиж байх юм.

Сувдаа, эцгийнхээ хүсэл мөрөөдөл, гэрээслэлийг биелүүлэх гэж учраа ололгүй будилж байгаа Сайнжаргалын эчнээний бодлыг сонсоод өрөвдөж, ойрын үед сэтгэл санааныхаа шаналгаанаас цонхийж цайсан царайг ажиглаад «Дэмий юмаар сэтгэлээ зовоогоод байдаг болчихлоо. Тэгээд бүр сульдаж гүйцжээ» гэж бодоод,

- Сайнжаргал эгч ээ, би танд аяга шөл хийж өгье. Та тун ядарсан байна. Одоо жаахан амарч хэвтсэн дээр. Дандаа ном шагайж болохгүй шүү гээд өрөөнөөс нь гарлаа. Сувдаа гал зуухны өрөө рүү гэлдрэхдээ «Хөөрхий муу эгч минь одоо яана даа. Япончууд хэмжээгүй их хөрөнгөнд нь шунаад байдаг! Тэгээд хот эргэсэн чоно шиг тал талаас нь дайрах гээд мяраагаад байдаг. Эгч минь ёстой өлөн араатангуудын дунд орсон янзага шиг ганцаардлаа.

Одоо надаас өөр хэн ч үүнийг түшиж тулаад туслахгүй. Би эцгийнх нь хүчээр өдий хүрсэн. Тиймээс гэдэс өлсөн мөр улайхын зовлонг үзсэнгүй. Сайнжаргал эгчид надаас өөр итгэлтэй хүн байхгүй болохоор надад нууцынхаа түлхүүрийг өгдөг. Муу талийгаач бид хоёрт захихдаа «Нэг эхийн хүүхдүүд шиг бие биендээ түшигтэй яваарай гэсэн. Тэгэхээр Сайнжаргал эгчтэй ярилцаж ар монгол руу явах нь зүйтэй» гэж өөртөө сануулж байлаа.

Японы жанжин штабын боловсруулсан «Манжуурын асуудал» гэж товлосон цэргийн нууц ажиллагааг далдалж чадсан «Мугдэнгийн зөрчил» ажиллагааны талаар хэлэлцээд Тозияд шиү жёо хошууч генерал цол олгохоор эзэн хаанд айлтгасан боловч түр хойшлуулсан ажээ. Японы цэргийн яам зүүн умард хятадын гурван мужид явуулах армийн ажиллагаатай уялдуулж Гуаньдунгийн цэргийн хүчийг тав дахин нэмэгдүүлж 100 мянга гаруй цэрэгтэй болгоод Кантунгийн арми гэж нэрлээд

Гурав. Дасгахын учир, далд бодол

командлагчаар нь Сигэрү Хонзёог томилжээ. Тэгээд зогссонгүй Манжуурын эртний хот Чанчунгийн нэрийг өөрчилж японоос тогтоосон шинэ дэглэмийн дагуу Синьзин буюу шинэ хот гэж нэрлээд кантунгийн армийн штабыг Синьзинд байрлууллаа.

ЛяодунгийнхойгийнөмнөдхэсэгдэхГуньдунгийнаралдээрбайсан японы эзэмшлийн цэргийг өргөтгөж Зөвлөлтийн алс дорнод, Байгаль, баруун Сибирь хийгээд гадаад монгол руу чиглүүлсэн армийн ойрын ирээдүйн зорилготой уялдуулж байгуулсан шинэ арми Кантунг 1931 оны эцсээр эмхлэн байгуулсан тул олны дунд Квантуны арми гэж алдарших зам мөрөө зүүн умард хятадын Цицикарь (Цэцэн хар) Гирин хотуудаас эхлэв. Кантун арми анхандаа ердөө явган цэргийн 10 дугаар дивиз, солонгосоос татаж ирсэн 29 дүгээр холимог бригадаас бүрдсэн 20 гаруйхан явган цэрэгтэй байсан болой!

Жан Сюэлян, Цицикарь хотыг алдахгүйн тулд генерал Ма Жаншанд хэр чинээгээрээ тусалсан атал тэрээр японы цэрэгт хүч түрэгдэж, Хайлар руу ухарчээ. Жан Сюэлян, генералдаа туслахын тул нэг сая доллар гаргав. Гэтэл тэр хөрөнгийг нь манжуурт суурьшсан Мицуи гингогийн салбар банкнууд барьцаанд авсан төдийгүй Ма Жаншаныг Жан Сюэлянгаас хагацаж, японы талд ажиллахыг тулган шаарджээ. Хашир генерал японы энэ шаардлагыг нүүрэндээ зөвшөөрч хүлээн авснаар японы тал Мицуи гингогийн салбаруудад байсан хөрөнгийг Ма Жаншанд олгохыг зөвшөөрчээ. Харин Ма Жаншан, японы гараас тэр доллараа салгаж авсны дараа Жан Сюэляны зүг жолоо залжээ. Энэхэн үед Жан Сюэлянгийн байдалд гунигт явдлууд үргэлжилж, японы цэрэгт шахагдахад хүрсэн учраас Чан Кайшигээс тусламж гуйж, японы эсрэг нэгдэн тэмцэх санал тавилаа. Чингээд Жан Сюэлян, Чан Кайшид тусгай цахилгаан явуулав.

Нанжин. Чан Кайшид.

Японы цэргийг Бээжин Зиньжоугийн чиглэлд төмөр замын дагуу бут цохиж, умард хятадын төмөр замд ойртуулахгүйгээр Мугдэн рүү шахан хөөхийг чухалчилж онцгой арга хэмжээ авна уу... Жан Сюэлян. Зиньжоу хот. 1931 оны 11 сарын 5.

Чан Кайши, энэ цахилгааныг аваад японы армитай мэс зөрүүлэхгүйг хичээсэн төдийгүй улс төрийнхөө харилцааг

хурцатгахгүйн тулд бөөрөнхийлөхөөр шийджээ. Тэгээд Жан Сюэлян руу бие төлөөлөгч илгээхдээ «Хятадын засгийн газар японы түрэмгийллийг зогсоох талаар бололцоотой бүхнийг хийнэ. Юуны өмнө олон улсын Лиги байгууллагад хандаж, уриалга гаргах санал оруулсан. Түүний шийдийг хүлээе» гэж аятайхан аргалжээ. Чан Кайши, үүнийг цахилгаан мэдээгээр явуулж болох авч японы талд сэжиг авахуулбал эвгүй юм болно гэж үзээд бие, төлөөлөгч явуулсан болой. Гэсэн ч тэр захидлын агуулга Тозия болон Дойхарагийн шавь нарын гарт орсон байлаа. Чингээд Тозия Доихаратай ярилцсаны дараа кантуны армийн командлагчтай утсаар ярихдаа «Хонзёо сан, та хүчээ зузаатгаад умард хятад руу хөдлөх хэрэгтэй. Чан Кайши, Жан Золингийн хүүд ямар ч тусламж үзүүлэхгүйгээр шийдсэн байна» гэж айлджээ.

Кантунгийн армийн командлагч энэ мэдээг авсны дараа өвөр монголын томоохон хот Байчэн, Таонанг эзэлснээр Халуун рашаан, Ханширээ рүү чиглэж, Вангийн сүмийг эзэлжээ. Чингэснээрээ японы арми гадаад монголын хилд ойртож, ердөө найман бээрийн хэртэй газар байрлах болсон ажээ.

Кантунгийн армийн штаб Чанчуньд байрласны дараа Тозияа барга монголын асуудлаар судалгаа хийх ажилдаа орж түүнийг Симотоод хариуцуулснаар кантунгийн армийн штаб эчнээ бүртгүүлжээ. Харин Тозияа кантунгийн армийн тагнуулын хэлтсийн зөвлөхөөр ажиллаж, түүнийг ажил хэргийн холбогдлоор хошууч генерал болгов. Гэсэн ч Тозияа, генерал алдар цолоо хэрэглэсэнгүй энгийн хувцас өмссөөр байв. Чингээд Тозияа, өмнөд манжуурын төмөр замын нийгэмлэг «Мантэцу»-гийн дэргэд нууцаар ажилладаг Доихарагийнхантай холбоотой ажиллаж, Сайнжаргалын гэрт байдаг ажлын өрөөнд шууд утас тавиулжээ. Чингэснээр японы нийслэлээс кантунгийн арми руу чиглэсэн цэргийнхэн Мугдэнгээр дайрч Тозияатай уулзаж зөвлөгөө авдаг болсон нь нэг ёсондоо эрхэм сэнсэй-багштны мутраас адис авах заншил бүхий ёслол болон хувирчээ.

Тозияа, гүнтэнг өөд болсноос хойш жил гарангийн хугацаанд Сайнжаргалын гэрт ийнхүү эрх дархтай болсноор японы армийн дунд алдаршсан «Хокухонся-төрийн үндэс», «Сакурайка-интоор» болон манжуурт байгуулагдсан «Кио-вакай-итгэлтний холбоо»

гэдэг нийгэмлэгүүдээс хүмүүс ирдэг боллоо. Сайнжаргал, эцгийнхээ гэрээслэлийг даган Тозияаг «хүргэн ах» хэмээн хүндлэх тул Тозияагийн үйл ажиллагаанд үл дургүйцнэ. Нөгөө талаар Тозияа эцсийн эцэст Сайнжаргалын эцгийг орлох хүн гэдгийг Сайнжаргал хэнээс ч илүү ухаарна. Гүн өөдөлснөөс хойш гэрийн доторх ажил төрөл, аж ахуйг эрхлэх болсон Сувдаа «Тозияагийн хөл» үймээнд дургүйцэх атал сэтгэлийнхээ бодол санааг ил гаргадаггүй аж. Харин хааяа энэ бүхнийг Сайнжаргалд хэлж «Эд нар манайд дэндүү новшрох юм» гэж уцаарлахад Сайнжаргал өөдөөс нь «Хааяа яриаг нь сонсож байхгүй юу! Эдний энэ яриаг эндээс өөр газар хэн ч сонсохгүй. Тэгээд ч сонинд хэвлэгддэггүй нууц зүйл шүү дээ» гэж тохуурхан дүйвүүлнэ.

Намрын эхэн сарын шувтаргаарх нэгэн орой цай ууж суусан Тозияа, бодлогоширсон нүдээр Сайнжаргалыг ширтсээр,

- Сайнжаргалаа, би маргааш орой Тяньжин руу явах санаатай байна. Манайхан намайг гаргаж өгнө гэсэн. Чи юу гэж бодож байна охин минь гэв.

- Та Тяньжин руу явах тийм их хэрэгтэй юм уу?

- Үгүй ээ. Гэхдээ муу овоохойгоо очиж эргэе. Танайд тав тухтай байсаар байгаад овоохойгоо мартчих шахлаа. Одоо энд нэгэнт суурьшсанаас хойш очиж жаал зугаа юмаа авчирья. Би чамд номынхоо санг бэлэглэе гэж бодож байгаа. Чамд хэрэгтэй ном маш их бий.

- Тозияа гуай хичнээн хүн ирэх юм бэ?

- Итагаки Синьзингаас ирнэ. За тэгээд Доихара ирнэ дээ. Ер нь тав зургаан хүн ирэх биз гээд ярианы далимд хэтэвчээ халааснаасаа гаргатал Сайнжаргал, Тозияа гуай, та надад мөнгө өгөх

гэж байна уу? Бид хоёр чинь саараар яривал садангийн хүмүүс. Сайнаар яривал эцэг охины холбоотой шүү дээ гэхэд Тозияа,

- Охин минь муу аав чинь заримдаа мунгинаад байдаг болчихлоо. Зөнөж яваа нь тэр байх даа! гэж Сайнжаргалын сэтгэлийн эмзгийг хөндөж чадсандаа сэм баярлан мөнөөх «аав» гэдэг үгийг яриандаа хавчуулж амжина. Тэрээр сүүлийн нэг сар, яриандаа «охин минь» гэдэг үгийг зүүдэг болсон. Тозияа сэтгэлдээ бодож явсан зүйлээ Сайнжаргалын амнаас дуулсан болохоор ажил төрлөө хөөцөлдөх тухайгаа бодож өрөө рүүгээ эргэв. Харин Сайнжаргал маргааш нь Сувдааг дуудаад,

- Өнөө орой Тозияа сан, Тяньжин руу явах гэнэ. Арван хүнээр бодоод оройнхоо хоолыг бэлдүүлчихээрэй. Гаднаас тогооч хөлсөлсөн дээр биз. Гүнгийн охин ямаршуухан нүнжигтэйг бодох хэрэгтэй шүү гээд хүлээн авалтын талаар зөвлөв.

Сайнжаргал оройн хүлээн авалтанд ирэх япон дарга нарын дунд ихэмсэг, олигтойхон байх хэрэгтэй гэдгийг ойлгож байлаа. Тэгээд Мугдэнд нээгдсэн японы үсчний газрын хамгийн тэргүүн зиндааныханд тооцогддог нэгэн үсчинд очихоор гэрээсээ гарчээ.

Сайнжаргал үс засуулж байхдаа үсчингээс нэгэн санамсаргүй үг сонслоо. Үсчин Сайнжаргалын үсийг янзалж байхдаа,

- Окусан-хадагтай таны үс яваандаа амархан бууралтах юм байна. Ер нь сардаа нэг удаа будуулж байх хэрэгтэй. Тэгвэл тийм ч амархан бууралтахгүй. Манайд бууралталтыг удаашруулдаг зүйл бий гэлээ. Ингээд Сайнжаргал үсээ будуулж янзлуулаад үд өнгөрч байхад гэртээ орж иртэл утасны хонх жингэнэв. Сувдаа утсаа аваад,

- За одоохон гээд,

- Эгчээ, Тозияа гуай ярья гэж байна гэлээ. Сайнжаргалыг утсаар ярьж зогсоход Сувдаа гоёмсог засаад, аятайхан янзалсан үсийг таашаан ширтэхдээ «Хаана янзлуулсан юм бол? Маргааш очиж ингэж янзлуулъя» гэж бодлоо. Чухам энэ нь эмэгтэй хүний атаархамтгай сониуч зан болохыг хэр баргийн эмэгтэй хүн анзаардаггүйн адилаар Сувдаа өөрийнхөө атаархан бодсоны учрыг хэрхэн тунгаах билээ.

- Харин ээ, хамт явбал надад сайхан байна. Би Тяньжинд очиж үзээгүй шүү дээ. Тэгвэл би, юмаа янзлаад бэлдчих үү гэж лавлаад Сувдаа өөд харж инээмсэглэнэ. Сайнжаргал Тозияатай ярьж дуусаад,

- Сувдаа би, Тяньжин руу явахаар боллоо. Чи гэртээ үлдэнэ. Харбингаас Иван ярьж магадгүй. Тэгвэл Тяньжин дахь консулын газраар дамжуулж яриарай гэж хэлээрэй. Би ер нь 11 сарын хорьдоос нааш ирэхгүй гэлээ. Чингээд Сайнжаргал явахад бэлэн боллоо. Бас юмаа янзлаад Сувдаад захих ёстой зүйлээ хэлчихлээ. Ганцхан зочид ирэх л үлдээд байв. Гурван өрөөнд хүндэтгэлийн

ширээ засжээ. Оройн таван цагийн үед зочид ирцгээлээ. Хоёр зуу гаруй тавганд хийсэн тавин янзын хоол, зууштай өргөн ширээг тойрч суусан хүмүүсийн хоёр нь энгийн хувцастай ажээ.

Тэр хоёрын нэг нь Дайран симбун сонины газраас Мугдэнд ирсэн сурвалжлагч Тогава, нөгөө нь армийн штабаас ирсэн газрын зургийн мэргэжилтэн Ёоши хоёр байлаа. Тэр хоёроос бусад нь манжуурт байгуулсан Киокавай, сакурайка нийгэмлэгийнхэн ажээ. Бусдаасаа нэлээн ахиухан халсан намхан биетэй нэгэн ахмад гүвэр гүвэр ярих боловч дуу нь чангарсаар байв. Тэрээр суудлаасаа өндийж,

- Эрхэм ноёдоо... японы армийн гүйцэтгэж байгаа одоогийнх шиг тийм чухал үүргийг засаг захиргааны болон улс төрийн ямар ч байгууллага гүйцэтгэж байсан удаагүй. Тиймээс манжуурын засаг захиргааны байгууллагыг квантунгийн арми гартаа бүрэн авч хянах ёстой. Түүгээр ч зогсохгүй Вакацукигийн танхимыг тарааж армийн удирдлага засгийн эрхийг авах хэрэгтэй. Тиймээс арми засгийн эрхийг авахын төлөө банзай... банзай... банзай... Хакка ити о гэж хашгиртал архинд халсан дарга нар суудлаасаа босож «Хакка ити о» гэж хашгирлаа. Дарга нарыг хундага өргөж домогт зинмү хааны гэрээслэлийг уриа болгон дэмжсэний дараа нэгэн хошууч суудлаасаа босож,

- Тай и-гийн (ахмадын) хэлдэг түмэн зөв. Сайд нарын танхимынхан нөгөө Лиги Наци гэдэг олон улсын байгууллагаас хий айгаад байна. Бид манжуурыг бүрэн эзэлж кодо эзэн хааны замналаар бүрэн удирдахын тулд Лиги Нацитай уралцах хэрэгтэй! Ер нь их гүрнүүдийн нөлөөг Хятадаас төдийгүй номхон далайн арлын орнуудаас зайлуулах ёстой. Тэгэхгүй бол үйлдвэрийн эзэд, хөрөнгөтний намуудыг царайчилж байгаа Вакацуки, армийн ажиллагаанд саад болно уу гэхээс нэмэр болохгүй. Ерөнхий сайд, сайд нараасаа эмээж, сайд нар нь үйлдвэрийн эздээс хулчийж, үйлдвэрийн эзэд нь нүцгэн ажилчдаасаа айсаар байгаад зүрх нь шимширчих нь байна. Тэгэхээр тэд эзэн хааны армид чөдөр болно. Ингэхлээр арми бүхнийг өөрөө шийдэх ёстой. Банзай... Хакка ити о... Банзай тэнно гэж сүр бадруулан орилов.

Цэргийн дарга нарын яриа эд өрнөж байхад Сакурайка нийгэмлэгийнхэн сайд нарын танхимыг тараахын тул Вакацукийг

устгах санаа дэвшүүлж бусдаараа дэмжүүлэхийг тулгаж байхад Сайнжаргал, Сувдаа руу нүдээрээ ирмэж дохио өглөө. Үүнийг яриандаа халсан согтуу дарга нарын хэн нь ч ажигласангүй. Чингээд хэсэгхэн мөч өнгөртөл зочдын өрөөний хаалга нээгдэж, ягаан цэцэгтэй цагаан кимоно өмссөн гэйша зоогийн газрын дууч, бүжигч нар орж ирэхэд дарга нар тэдний зүг нүд бэлчээв. Гэйша нарын уяхан хоолой, хөгжмийн хөгөнд хувилж, уянга төгөлдөр аялгуунаа дарга нарын сэтгэл татагдан, уяхан хөдөлгөөнтэй бүжигчин хүүхнүүдийн туяхан биеийг ширтэн, нүд алдан алмайрчээ. Тэрхэн хоромд Тозия, Итагаки, Доихара гурав суудлаасаа өндиймөгц Сайнжаргал, зочдын өрөөний нөгөө талын хаалга руу гэлдэрлээ. Саяхан армийн хүч чадал, цэрэг эрсийн дайчин замнал, самурайн цог хийморь, эзэн хааны замнал кодоог дэлгэрүүлэх хийгээд ямато угсаатныг алдаршуулахаар «Банзай» хашгирч байсан дарга нар өрөөнөөс сэм гарсан хүмүүсийг үл анзааран, гагцхүү гэйшагийн зүг анхаарлаа чиглүүлсэн байлаа.

Синьзин дэх квантуны армийн (Зүүн умард хятадад байрлаж өөрийн ажиллагааг Зөвлөлт, Монгол руу чиглүүлж байсан квантунгийн арми гэгчийн олонд алдаршсан нэр нь квантун тул үүгээр нь нэрлэв) штабаас ирсэн Итагаки, уужим өрөөний зөөлөн түшлэгтэй сандлуудын нэг дээр суухын өмнө,

- Манжуурын засаг захиргааны талаар жанжин штаб сонирхож байна. Би «эзэн хаан» гэдэг ажиллагааны үр дүнг харах нь дээр гэж санал өгсөн гэхэд Тозияа,

- Жанжин штабынхан Токиогоос манжуурт шилжин суух гэсэн хүмүүсийн шаардлагаар тэгж байгаа юм. Энэ бол манжуурын нутагт эзэмшилтэй болох гэсэн хүмүүс засгийн газарт хатуухан шаардлага тавьж байгаагийн илрэл гэлээ.

- Тэгвэл жанжин штаб «эзэн хаан» ажиллагааг эхлүүлэх нь илэрхий болж байгаа хэрэг. Харин эзэн хааны халхавчинд биеэ оторлосон Саёнзи гэхчлэн армийн ажиллагаанд саад тотгор болсон юмнуудыг зайлуулах нь чухал гэж Доихараг хэлтэл Тозияа,

- Вакацукигийн танхим Чан Кайшигээс Лиги Наци хэмээх олон улсын байгууллагад явуулсан өргөх айлтгалын сургаар яахаа мэдэхгүй барьц алдаж байгаа юм. Тиймээс манай боловсруулсан «эзэн хаан» ажиллагааг нүүрэн дээрээ зөвшөөрөөд, харин

манжуурыг тусгай улс болгон зарлах явдалд болгоомжтой хандана гэдгээр халхавч хийж саад болоод байна гээд хэсэг бодсоноо яриагаа үргэлжлүүлж, Доихара сан Дайран руу ярьсан уу? гэж асуулаа.

- Ярьсан. Төлөвлөсөн ёсоор Тяньжин руу усан онгоц гарна. Нөгөөдөр гэхэд Дайрангаас гарах ёстой. Харин би таны ажиллагааг харж байж ажлаа зохицуулах ёстой болоод байна гээд Доихара цагаа харлаа.

- Доихара сан, та тэгвэл Тогавааг Дайран руу яаралтай явуулсан дээр. Миний бодлоор бол манжийн эзэн хаан агсан Пу И японы армийн тусламжтайгаар Сюань Тун (манжийн эзэнт төрийн сүүлчийн өргөмжлөл) төрийг сэргээхээр Дайранд ирсэн тухай тусгай өгүүллийг дохио өгмөгц хэвлүүлэх талаар Дайран симбун сонинтой зохицох ажлыг зохион байгуулах нь чухал гэхэд Доихара толгой дохин дуртай зөвшөөрлөө. Чингээд тэр гурав аминчлан ярих яриа дууссан тул гэйша нарын дууг сонсохоор зочдын өрөө рүү явцгаав.

Тяньжин хот. Солонгос японтой усан замаар холбосон энэ боомтыг XIII зууны үед Шар тэнгисийн хэсэг Бохайн тохойд байгуулжээ. Тозияа, Сайнжаргал хоёр 11 сарын 1-нд Тяньжинд ирлээ. Галт тэрэгний буудал дээр Тяньжинд байдаг японы консулынхан болон цэргийн төлөөлөгчдийн газрын нэгжээд ажилтан угтлаа. Тэгээд хотын төв хэсэгт байдаг төлөөлөгчийн газрын хамар хашаанд байдаг нэгэн байшинд ирлээ. Энэ бол Тозияагийн «овоохой» ажээ. Тозияагийн байшин арваад өрөөтэй бөгөөд эндээс Тяньжинд ажилладаг японы хорлон сүйтгэгчдийг удирддаг байв. Тозияагийн хамгийн том өрөөний нэг ханыг номын сан эзэлжээ. Тэр номын санд хан улсын түүхийн сурвалж бичиг, хятадын түүхчдийн бүтээлд орсон Монгол угсаатны түүхэнд холбогдолтой түүвэр зохиол ч бий. Нэг үгээр хэлэхэд азийн улс орны түүх, эдийн засаг, газар нутаг, цэргийн холбогдолтой бүх зохиолыг цуглуулжээ.

- За охин минь хар даа. Ямар байна. Би чамд бэлэглэх

гэсэн номын сангаа үзүүлэхээр энд дагуулж ирсэн юм. Энэ бол цөмөөрөө чиний ном болсон. Монголын засаг ноёдын гарал угсааны түүхээс авахуулаад эртний монголын өвөг дээдсийн

гарал угсаатай холбогдсон баримтуудыг эндээс үзэж болно. Тиймээс чиний бичих номонд маш чухал хэрэгтэй зүйл их бий. За ингээд энэ бүх ном энэ мөчөөс эхэлж чинийх болсон гээд тун аятайхан тохижуулсан номын шүүгээнүүдийг заалаа.

- Та ийм их номыг цөмийг нь уншчихсан хэрэг үү гэж асуусан Сайнжаргал сэтгэлдээ «Аргагүй дээ. Тагнуулч хүн сонирхсон газрынхаа хэл, түүх соёл, зан заншил, улс төр, эдийн засгийг арван хуруу шигээ мэдэх ёстой. Тэгэхээр энэ номыг унших нь албан ёсны үүрэг шүү дээ» гэж бодов.

- Ихэнхийг нь уншсан. Гэхдээ энэ арван жилд уншаагүй үлдээсэн ном бий шүү. За чи номоо сонирхож бай! Би төлөөлөгчийн газар руу яриадахья гээд өрөөнөөс гарлаа.

Сайнжаргал эмэгтэй хүний сониучхан зангаар номуудыг хайнга үзэж байснаа торгомсог даавуун гадартай, япон хиригана үсгээр «Хятадын алдагдсан нутаг ба маргаантай газар орны нууц» гэж бичсэн зузаан хавтсыг авч сонирхлоо.

...Жан Золингийнхон 1927 онд хятадын алдагдсан газар нутаг, маргаантай газар нутгийн талаар томоохон төлөвлөгөө боловсруулсан байна. Түүнд оруулсан баримт бичгийг эх зохиолуудтай тулган үзэхэд цөм зохиомол, хуурамч байлаа. Харин Жан Золингийн даалгавраар боловсруулсан энэ зохиомол баримтыг нарийвчлан ашиглаж чадвал эзэн хаан тэнногийн замналыг азид тогтооход хэрэг болж чадах зүйл гэж үзнэ. Энэ баримтын эмхтгэлийг Цагаан морь гэдэг хочтой залуугаас салгаж авлаа... гэж бичсэнийг уншаад Сайнжаргал хавтасны сүүлчийн хэдэн хуудсыг эргүүлж үзвэл хятадын түүхийн эх зохиолуудад орсон баримтыг хуулж хавсаргасан байлаа.

Тозияа, Сайнжаргал хоёрыг Тяньжинд ирснээс хойш нэг хоногийн дараа Доихара нисэх онгоцоор маш нууц байдалд ирлээ. Тэрээр төлөөлөгчийн газар ирэнгүүтээ Тозияатай уулзах ёстой. Тиймээс болзсон ёсыг баримтлан гэрт нь ирэхдээ Тозияатай байшингийн довжоон дээр тааралдлаа.

- Доихара сан, би мөд ирэхгүй. Та манайд намайг хүлээж

байгаарай. Сайнжаргал гэрт байгаа. Гэхдээ түүнд садаа болох хэрэггүй. Цаадах чинь ном сонирхож байгаа гэхэд Доихара,

- Тозияа сан, хоёулаа явах юм биш үү? гэж лавлав.

- Орой болж байна. Олуулаа явах дэмий. Нөгөө талаар чамайг Тяньжинд ирснийг хүн мэдэхгүй байх нь дээр! За тэгээд эндхийн шалдан банди (гудамжны дээрэмчин, хулгайч нар) сүрэглэж яваа хүмүүсийг нэг нүдээрээ үздэггүй юм гээд хашааны хаалга чиглэн алхахад Доихара түүний араас гөлөрсөөр хоцорлоо.

Намрын үдшийн бүрэнхий Тяньжин хотыг нөмрөөд, арваад алхмын цаадах юмс бараантан сүүтэгнэж буй энэхэн үед хашааны хаалгаар гарсан Тозияагийн бараа үзэгдэхээ больж, гагцхүү хөнгөн тэрэгний моторын дуу холдсоор байгаа нь сонсогдохтой үгүйтэй.

Тяньжин хотын баруун өмнөд хэсэгт байдаг, Вахэй голын зүүн эрэг бараадуулж барьсан нэгэн байшинд байрладаг зоогийн газрын үүдэнд ирсэн Тозияа, төлөөлөгчдийн газрын хоёр ажилтанг зоогийн газар руу оруулаад хэсэгхэн болсны дараа суудлын тэрэгнээс гарч зоогийн газар орлоо. Энэ зоогийн газарт Тяньжингийн «нусан журууд буюу дэггүйчүүд» цуглардаг учраас Тозияа түүнийг «Шалдан банди нарын ноохой» гэдэг. Хотын танхай залуусын орогнодог ноохойд орж ирсэн Тозияа хаалганы ойролцоо байгаа сул ширээний дэргэдэх сандал дээр суув. Гэтэл нэгэн хятад залуу Тозияа руу анхааралтай ширтэж байснаа ширээнийхээ араас босож дэргэд нь ирээд,

- Тозияа сан, та чинь Тяньжинд байгаа юм уу гэж ёжтой асуув.

- Чи намайг хаана байгаа гэж бодоо вэ? Эсвэл хайгаа юу?

- Хайгаагүй шүү. Таныг манжуурт, тэр тусмаа Чанчунь, Мугдэн хоёрын нэгэнд тоос манаруулж яваа байх гэж бодож байлаа. Танай арми тэнд хийцэлж байгаа гэх шив дээ. Тэгээд та одоо ямар албан тушаалтай болсон бэ? Тяньжинд бие хамгаалагчтай явдаг болсон байх чинь. Бодвол нэлээн дээгүүр зиндааны албан тушаалтай болоо биз дээ. Таны хамгаалагч нар нэлээн түрүүн орж ирээд биднийг анаад байгаа бололтой байсан гээд хаалганаас холгүй сууж байгаа хоёр хүн рүү толгой дохин хэллээ.

- Байма, улс төрийн асуудал сонирхоод хэрэггүй. Чи тэртэй

тэргүй ерөнхий сайд болж чадахгүй нь мэдээж! Тэгэхээр чамд, олигтойхон хөлстэй хөнгөн шиг ажил хэрэгтэй. Чамд гэж хэлэхэд явдал чирэгдэл багатай, хэл ам татлахгүй, ихээхэн унацтай ажил байна. Чи хийх үү?

- Хүн тонилгох юм бол толгойн чинээ алт өгсөн ч хийхгүй. Хойд насандаа тамд унаж тарчилна. Тэгж зовохоосоо айж байна.

- Тийм ажил биш. Нэг удам судартай хүнд захиа хүргэж өгөөд, амь насанд халгүйгээр жаахан айлгачих хэрэгтэй юм.

- Унац нь аль зэрэг юм бэ?

- Таван мянга.

- Тавхан мянга уу. Тозияа сан, та хашир хүн. Юмны ээдрээг надаас илүү мэднэ. Тэгээд ч үнэ цэнийг нь андахгүй. Наад яриа чинь согтуу хүн сормуусаа хараад баярлахтай адил юм биш үү?

- Таван мянган ногоон шүү.

- Ногооноор (доллар) ацаглах юм бол мянгыг дахиад нэмчих!

- Болно. Манжийн эзэнт гүрний хааны хүүг мэднэ биз дээ.

- Сюань Тун уу?

- За тийм дээ. Манжийн төрийн хаан ширээг залгамжлах ёстой тэр хаан хүүгийн дэргэдийн хүнд энэ захиаг өгөөд байрны нь гадаа хоёр гурван удаа гар бөмбөг дэлбэлчих. Тэгвэл болох нь тэр! Энэ захиаг уншиж болно гээд Тозияа, Байма буюу цагаан морь хочтой «Төмөр ба цус» хэмээх Хятадын нууц нийгэмлэгийн тэргүүнтэй шууд холбоотой залууд захиаг өглөө. Байма тэр захиаг аваад уншиж үзсэнээ, Тозияа руу хяламхийн харж,

- Та чинь бүр манай нийгэмлэгийг төлөөлж айлддаг төдийгүй айлган сүрдүүлэх арга хэрэглэн захиа бичдэг болоо юу? гэлээ.

- Битгий бухимд! Та нар бичиг цаасаар оролдож цаг гарздаад яах вэ. Тэгээд ч бичиг цаасны ажил бол та нарын мэргэжсэн ажил биш.

- Манжийн хаанаас хятадын ард түмний өшөөг авах ёстой манай нийгэмлэгийн нэрийн өмнөөс өгөх юм бол дахиад дөрвөн мянга нэм! Тэгэхгүй бол наадахаа аваад тонил! Би үүнийг уншаагүй. Та надтай дайралдаагүй гэж тохироод хал балгүй салцгаая гэж тунирхлаа.

- Болно. Би гар татахгүй. Эхний ээлжинд гурван мянгыг авч

бай гээд аравтын дэвсгэрээр толгойлсон гурван боодол доллар ширээн дээр тавилаа. Тяньжин дахь «Төмөр ба цус» гэдэг нууц байгууллагатай шууд холбоотой Байма бол хотын танхайчуудыг толгойлж тэр нийгэмлэгийн нэрийн өмнөөс өш хонзон авч, үймээн дэгдээж явдаг «алуурчид» болой.

Тозияа Тяньжинд хэдэн жил болохдоо зөвхөн Баймагаар дамжуулж "Төмөр ба цус" гэдэг нийгэмлэгийн толгойлогчтой харьцаа тогтоож эцсийнхээ зорилгонд хүрэхийг бодож байсан. Тиймээс Тяньжинд хоргодож байгаа Пу И хэмээгдэх Сюань Тунг төдийгүй түүний эхнэрийг айлгах замаар хотоос гаргаж манжуурт аваачаад манжуурын эзэн хаан болгож «Тоглоомын» засгийн газар байгуулах Доихарагийн ажлыг нууцлах арга хийх ёстой байсан. Байма долларыг авч үзсэнээ, Тозияа руу харцаа эгцлээд,

- Хэзээ дахиж уулзах вэ? гэлээ.

- Тэр бол та нарын ажиллагаанаас шалтгаална гээд Тозияа суудлаасаа өндийлөө. Тозияаг зоогийн газрын хаалгаар гаран гартал хойноос нь ширтэн зогссон Байма, зоогийн газрын архи дарсны лангууны дэргэд зогсож буй нэгэн залуугийн дэргэд очоод,

- Эрхэм сурвалжлагчаа! Хэрвээ танай сонины эзэн, мянган юань хаявал ойрын үед болох нэгэн дорвитой ажлын талаар тодорхой баримт хэлж өгч болно гэлээ.

- Тийм чухал сонин юм уу гэж сурвалжлагч хэнэггүй асуухад,

- Хэрвээ танай сонин тэр мэдээг нийтэлбэл сонингоо хэдэн саяар ч хэвлэлээ гэхэд дор нь борлуулж чадна. Манжийн эзэн хааныг ширээнд залж, Манжуурт шинэ засаг төр тогтох болоод байна. Түүгээр ч үл барам эзэн хааны нэр тодорхой болсон гэхэд өнөө сурвалжлагч,

- Нээрэн үү? гэж лавлав.

- Ийм үед тоглоом тохуу хийгээд яах вэ? Би тоглоом тохуунд дургүй гэдгийг чи мэднэ шүү дээ.

- Тэгвэл жаахан хүлээж бай! Би эрхлэгчтэйгээ яриадахья гээд зоогийн газрын эзний өрөө рүү гэлдэрлээ.

Түүнийг утсаар ярих гэж байгааг Байма ойлгож байлаа. Тозияагийн хэрэг амархан бүтсэн болохоор Доихара баяртай байв.

Манжийн сүүлчийн хааны хүүгээс өшөө авах ая олж ядаж байсан нийгэмлэг Пу И-гийн ойр дотны хүмүүстэй уулзаж Тозияагийн захиаг атгуулсан төдийгүй байрных нь ойролцоо гар бөмбөг дэлбэлж, дээрэм тонуул хийжээ. Пу И таван настай байхдаа манжийн төрийг залгамжилсан боловч төмөр цагаагчин гахай жил (1911 он) хятадад Синьхайн хувьсгал гэгч дэгдэж манжийн эзэнт хааны төрийг унагажээ. Чингээд удалгүй хятадын умардын цэргийн бүлэг (Бэйян) засгийн эрхэнд гарч Юань Шикай засгийн эрхийг авснаар Пу И Бээжинд толгой хоргодох газаргүй болсноор Японы элчингийн газарт ивээгдэж хэдэн жил амь зуусан билээ. Түүнээс хойш хорин жил өнгөрч жаал хүү эрийн цээнд хүрлээ.

Тозияагийн явуулгаар дэгдсэн заналхийллээс айсан Пу И-гийн дотно хүмүүс Доихаратай нууцаар уулзсаны дараа хэрэг явдал мандлаа. Пу И-гийн итгэлтэй хүмүүсийг Тозияа, Доихара хоёр нууцаар хүлээн авч уулзав. Хаантны шадар, тэр хоёртой хэдэн зүйл тохиролцсоны дараа,

- Залуу хааныг манжуурын хаан ширээнд залахыг гадарласан хүмүүс өш хонзон санаж заналхийлдэг боллоо. Тиймээс японы консулын газар урьд балчир байхад нь өөртөө аваачиж амь насыг нь хамгаалсан шигээ туслах болов уу гэж бодож байна гэхэд Тозияа,

- Нөгөөдөр өдрийн гурван цагт эзэн хааныг манайхан очиж авна. Эзэн хаантанг хэрхэн яаж хүлээж авахыг Доихара сан танд мэдэгдэнэ. Ингэхээр одоо очоод бүх юмыг нь бэлтгэ гээд гарын дийзтэй бичиг өглөө. Энэ бол Пу И-гийн амь насыг хамгаалахыг зөвшөөрсөн албан ёсны мэдэгдэл байлаа. Чингээд хаантны шадар хүн Доихаратай маргааш хэрхэн уулзахаа ярилцан тохироод буцав. Шадар хүнийг явсны дараа Тозияа,

- Доихара сан, аравны үдээс хойш татуурга усан онгоцыг бэлэн байлгах хэрэгтэй. Татуурга онгоцоор эзэн хааныг аваад Бохайн буланд байгаа «Имази Мару» гэдэг хөлөг онгоцон дээр аваачиж тэндээсээ Дайран руу яв! Эзэн хааныг Хонзёо сантай уулзуулаад Тогавагийн сурвалжлагыг хэвлүүлнэ биз. Би одоо явж Байматай уулзана гэтэл гаднаас Сайнжаргал орж ирлээ.

- Та хоёр хотын сонинд юу гэж бичсэнийг хараач гээд гартаа барьж байгаа сонингоо Тозияад өглөө.

- Юу гэж бичсэн байна. Сонин мэдээ гараа юу? гээд Тозияа Тяньжинд хэвлэдэг «Иши- Бао» сониныг эргүүлж тойруулж үзсэнээ Доихарагийн талаар бичсэнийг уншаад зузаан уруулаа хэдэнтээ өмөлзүүлснээ, сөрвөгөр сахлаа илэв.

- Муу новшийн бэлтрэг! Захианы агуулгыг худалдаж амжсан байна гэж үглээд утсаа авч

төлөөлөгчийн газар руу утасдаж,

- Бүрэн зэвсэгтэй арван хоёр цэрэг дөрвөн машин бэлд. Би одоо эндээс гарлаа гээд утсаа тавилаа. Тозияа Сайнжаргалын өгсөн сонинг халаасандаа хийгээд Доихара руу сүрхий харснаа,

- Намайг иртэл хаашаа ч гарч болохгүй гээд гэрээсээ гарлаа. Тозияа, хэдэн мөчийн дараа шалдан банди нарын «ноохойд»

орж иртэл хаалганы дэргэдэх ширээний хажуугийн сандал дээр сууж байсан Байма, Тозияагийн бараанаар инээмсэглэсээр угтав.

- Хөгшний мэндийг эрье. Ажил хэрэг чинь бүтэмжтэй болоо биз дээ. Бид нэлээн дорвитой хөдөлсөн. Тэгэхээр та амласнаа одоо өгнө байгаа гэж өр нэхлээ.

- Чи нууц ажиллагааг задруулсан байна. Чиний гараар «Иши Бао» сонины сурвалжлагч нар ажиллахдаа багагүй давсалжээ.

- Тозияа, сонингийнхон таны тухай биш, Японы тагнуулч Доихарагийн тухай бичсэн шүү дээ. Та бол Тяньжин дахь консулын ажилтан учраас Доихарагийн ажиллагаанд ямар ч хамаагүй.

- Байма, чи их андуурчээ. Намайг ший жёо (хошууч генерал) Тозияа гэдэг. Бүр тодруулж хэлбэл японы тагнуулын газрын зөвлөх гэж сүртэй хэлтэл Баймагийн царай ягаарч, хэсэгхэн дуугүй зогссоноо,

- Би таныг дипломат ажилтан гэж боддог юм. За яахав. Ингээд өнгөрье. Харин болзол ёсоор нөгөө хэдийгээ авчраа биз дээ гэлээ.

- Нууц ажиллагааг илчиллээ гэж шагнах болж байна уу? Нусгай минь авсныгаа буцааж өг! Ингэсэн чинь дээр гэдгийг сануулья.

- Тозияа сан, энэ чинь дэндэж байгаа юм биш үү? Ясаа хэмлэлцэх гээгүй юм бол хэн хэнийхээ муу муухайг төнхөх гээд яахав. Түүн дээрээ хүрвэл та бид хоёрын хэн хэн маань ч эндээс амьд гарахгүй. Би бол амьд явахыг хүсдэггүй хүн. Харин та амьд явбал наран улсын тэнногийн шагналаас авахуулаад хоргодох юм их бий. Над бол ердөө халз тулалдаанд ганц сумаар амиа солих нь ашигтай!

- Байма, чи ахаараа даажигнах гэж оролдоод хэрэггүй. Чи цагтаа ч үхэж чадахгүй хүн. Үхэхийг хүсдэг хүн бол өөрийнхөө гараар өөрийгөө тонилгодог юм. Чи өөрийгөө нудрахаас айж өдий хүрсэн гэдгийг хэнээс ч нууж чадахгүй. Би бол мэргэжлийн самуурай учраас эзэн хааны төлөө амиа өргөх цаг ирвэл харакири үйлдэхэд ч бэлэн байна гээд бээлийгээ ширээ рүү чулуудахад Байма дотроо «Энэ генерал чинь харакири үйлдэх гэж бээлийгээ ингэж чулуудмааргүй юм даа» гэж бодож байсан тэрхэн үед япон цэргүүд орж ирээд зоогийн газрын сэжиг бүхий хаалга, цонхны дэргэд зогсоод бугаа сумлаад барьчихсан байлаа.

Байма, гэнэ алдаж, хорлон сүйтгэх ажиллагаанд мэргэжсэн Тозияагийн урхинд орсноо

гадарлаад «Бээлий... Бээлий мөн нарийн зохион байгуулжээ. Гартаа барьж байсан энэ бээлийгээр дохио өгөх юм гэж даанч бодсонгүй. Ингэхээр манай согтуу толгойнууд одоо яаж ч хөдлөөд нэмэргүй» гэж бодов.

- Байма, одоо миний дүүгийн ухаанд овоо юм ороо биз! Харин нэмэн сануулахад миний ажиллагаанд саад болохгүйг хичээвэл аминд чинь өлзийтэй. Тиймээс Пу И-гийн байрны гадуур дахиж үзэгдэх хэрэггүй. Нөгөө талаар хотод дэгдээсэн дээрэм тонуулын ажиллагааг зогсоох хэрэгтэй! Үүнээс өөр сайхан зам та нарт байхгүй. Энэ болзлыг биелүүлбэл японы арми, хятадын улс төрийн асуудлыг зохицуулж, шинэ төр эмхлэн байгуулсан цагт та нарт буюу болно гээд Тозияа зоогийн газраас гарахад Байма түүний араас гөлөрсөөр хоцорчээ.

Доихара, Пу И хааныг хулгайлж Дайран руу аваачих нарийн арга боловсруулаад Тозияад танилцуулсан. Тозияа иймэрхүү юмны учрыг олж тунгааж сурсан болохоор түүнийг нууцлах хоёр хувилбар бэлдэв. Тэгээд хоёр дахь хувилбарыг хэрэглэвэл Сайнжаргалыг ашиглахаар Тяньжин руу дагуулж ирсэн. Энэ бол Пу И хааны хатан Сюэнь Тээг хаантай хамт Дайран руу аваачихад Сайнжаргалаар үйлчлүүлж ятгуулах байсан. Тозияагийн анхны ажиллагаа түвэггүй бүтлээ. Тозияа, хааны шадартай уулзаад маргааш өглөө нь эрт босож, цонхоо онгойлгоод, далайн зүгээс сэвэлзэж байгаа чийглэг мөртлөө жихүүн салхи амьсгалан хэсэг

зогслоо. Тэднийх өнгөрдөг шөнө бүгчим хоножээ. Тяньжингийн тэнгэр Тозияагийн сэтгэл шиг бүрхэг байлаа. Бүдүүн ширхэгтэй цас малгайлан хаялж, газар унангуугаа хайлж, гудамж, талбайг шавхайтуулна. Тозияа өглөөнийхөө цайг уугаад төлөөлөгчийн газар очлоо. Тэнд Доихаратай уулзаж цаашдынхаа ажил төрлийг ярилцлаа.

- Тозияа сан, хэрвээ хатан хаан Сюэнь Тэ, хаантантай явахгүй бол яана гэж Доихарааг асуухад Тозияа,

- Шадар хүний ярьж байгаагаар бол хатан хаантан явахгүй байж мэдэх юм. Тэгвэл өнөө Кавашима Ешика гэдэг эмэгтэйг ашиглах нь илүү биз. Сайнжаргалыг хатан хаантай танилцуулах болохоор түүнийг хулгайлах ажилд оролцуулж болохгүй. Ер нь Ешика бол хятадын зан заншлыг сайн мэдэх эмэгтэй гэж байна гэлээ.

- Тэгвэл та эндээ үлдэж таарах нь дээ.

- Тиймээ. Би энд хэд хоног байж байдлыг харна. Тэгээд Ешика хүүхний ажиллагааг хянана. Чи хатан хааныг татаж авах талаар Пу И-тай ярилцаж тохирох нь чухал. Юуны өмнө Дайранд очоод байдлыг ажигла! Бид хатан хааныг ятгаж дийлэхгүй бол Пу И-гийн гараар могой барина. Тэгэхдээ нэг зүйлийг гойд анхаарах хэрэгтэй. Хатан хаан, Пу И хаанд өөрийн гараар нэг цамц хийж өгсөн гэдэг. Та нар хаантай ярьж, тэр цамцан дээр өөрийн нь гараар захиа бичүүлж авчирч өгвөл, хатан хаантан нөхрийнхөө захиаг уншаад бидний үгэнд итгэж түүнийг айлган сүрдүүлэх аргаар Дайранд аваачаагүй гэдгийг батлах болно. Энэ асуудлыг нарийн бодож боловсруулах ёстой.

Тозияа, Доихара хоёр чингэж ярилцаад эзэн хааныг оргуулж Дайранд аваачих ажилдаа орлоо. Үд өнгөрөөд гурван цагт хэдэн мөч дутуу байхад суудлын дөрвөн тэрэг олон давхар байшингийн дэргэдүүр өнгөрөхдөө хурдаа хастал байшингийн булангаас гарч ирсэн зургаан

хүн суудлын тэргэнд хуваагдан суусныг хэн ч мэдсэнгүй. Тозияа «эзэн хаан» ажиллагааг өдрөөр хэрэгжүүлэх нь ямар ч сэжиггүй гэж тооцоолсон. Үнэхээр тийм байлаа. Суудлын гурван тэрэг хурдаа нэмэн Тяньжингийн усан буудал руу хурдлахад нэг тэргэнд сууж явсан хүмүүс гудамжны байдлыг ажсаар үлджээ. Суудлын тэрэгнүүд хэдэн мөчийн дараа

Тяньжингийн боомтон дээр ирэхэд японы цэргүүд боомтыг битүү хамгаалсан байв. Суудлын тэрэгнүүд зогсоол дээр байгаа нэгэн татуурга онгоц руу ойртоход тэрэгнээс буусан хэдэн хүн татуурга онгоцон дээр гарлаа. Доихара, сүүлчийн тэрэгнээс гарч ирээд Тозияатай уулзаж салах ёс гүйцэтгээд японы далбаа хийсгэсэн татуурга онгоцон дээр гарахад Тозияа халааснаасаа янжуур гаргаж асаагаад амандаа зуулаа.

Татуурга онгоц алгуурхан хөдөлж, хурдаа нэмсээр Бохайн буланг чиглэлээ. Японы татуурга онгоцонд суусан хэдэн хүний нэг нь манж дайчин улс гэгчийн сүүлчийн хаан Пу И байсныг буудлын ойролцоох онгоцныхон мэдсэнгүй өнгөрлөө. Харин хатан Сюань Тэ, гэртээ үлдсэнийг мэдсэн Тозияа, усан онгоцны зогсоол дээр үлдээд цайвар манан дунд орж бараа тасарсан татуурга онгоцны хойноос ширтэн зогсохдоо «Хатантан аргагүй яс зааж үлдлээ. Энэ бол манжуурын талаар явуулж байгаа манай бодлогод итгэхгүй байгаагийн шинж! Тиймээс Ешикагаар хатанг ятгуулж Дайранд аваачсаны дараа аажим замаар эгзгийг нь олж устгах хэрэгтэй. Ятгалганд орохгүй бол шууд устгахаас өөр замгүй. Залуу хааныг өөр сайхан хүүхний авхаалжаар урхидаж болно» гэж бодсоор янжуурын утааг алгуурхан сорж, ам хамраараа савсуулна.

1931 оны эцсээр японы арми, зүүн умард хятадын Хэй-Лунзян мужийн Цицикарь буюу нутгийн монголчуудын дунд Цэцэн хар гэж алдаршсан хотыг эзэлсэн нь японы сайд нарын танхим огцрох шалтгааны нэг боллоо. Шинэ ерөнхий сайдаар Ц. Инукай тохоогдож, цэргийн яамны сайдаар "Залуу дарга нарын нийгэмлэгийн" нэг удирдагч Араки томилогдлоо. Энэ бол арми дахь фашист нийгэмлэгүүдийн ажиллагааг идэвхжүүлж, сайд нарын танхимыг армийн талыг баримталсан хүмүүсээр дүүргэх аятай нөхцөл бүрдсэний баримт болжээ. Шинэ оны дараахан Итагаки Токио руу явах болсон нь эр хар мичин жил (1932 он) квантуны армийн ажиллагаа бүтэмжтэй байгаагийн илрэл боллоо. Тэрээр жанжин штаб төдийгүй сайд нарын танхимд квантуны

армийн ажиллагааг танилцуулах ажээ. Тиймээс манжуурт шинэ засаг захиргаа байгуулах гэсэн квантуны армийн саналыг толилуулах даалгавартай болой. Тиймээс Токио явахынхаа өмнө манжуур, монголын асуудлаар Тозияа, Доихара хоёртой уулзаж ярилцав.

- Манж Го улсыг байгуулах талаар бэлдсэн квантуны армийн саналыг сайд Араки дэмжих нь гарцаагүй хэрэг! Харин Инукайн танхим эсэргүүцэж магадгүй юм. Тиймээс тэдэнтэй зоригтойхон уралцах хэрэгтэй гэж Тозияаг хэлэхэд Доихара,

- Америкийн төрийн нарийн бичгийн дарга Стимсон, манай улс төрийн бодлогыг дэмжсэн царай гаргаж байгаа боловч өөр бодолтой байгаа. Гакка Татэкавагаас ирүүлсэн цахилгаанд «Америк улс, манжуурт тогтоох шинэ засаг төрийг зөвшөөрөхгүй гэдэг нь илэрхий боллоо» гэсэн байсан. Ингэхээр Итагаки сан, та үүнийг санаж явах нь чухал гэж зөвлөв.

- Итагаки сан, Азид яматогийн хөвгүүд байх ёстой юу? Славянууд ноёрхох ёстой юу гэдгийг

сайд нарын танхимд ойлгуулах хийгээд тэдний нүд чих болсон дипломатуудыг сэнхрүүлэх нь чухал! Манай армийн ажиллагааг хятад, манжуурт байгаа консулын ховч нар сайд нарын танхимд ховлоод, муулж байгаа юм. Тиймээс Мугдэн, Тяньжин хийгээд манжуур, хятадад байгаа дипломат ажилтангууд бидний мөрийг шиншилж, гадаад яаманд юу бичдэгийг нь мэдэх хэрэгтэй. Дипломатууд Пу И хааныг айлган сүрдүүлэх замаар манжуурт авчирсан гэдэг цуурхал тараасан.

Тэгээд ч зогсохгүй Тяньжингийн консул гадаад яамны сайд Сидэхараад цахилгаан явуулахдаа «Доихара квантуны армиас олгосон бүрэн эрхийнхээ дагуу туйлаад гадаад яамнаас өгсөн чиглэлийг ойшоосонгүй» гэж ховлосон байна.

Би ерөнхий сайдад бичсэн айлтгалдаа «Армийн зүгээс Пу И хааныг хэн ч ятгаагүй. Хаантан, манжуурыг хятадаас тусгаарласан армийн ажиллагааг дэмжсэн юм» гэж бичсэн.

Гэтэл Инукай миний бичсэн захидлыг хайхралгүй гадаад яамныхаа сайдын үгэнд бишрээд эзэн хаанд бараалхахдаа «Квантуны армийг манжуураас хэсэгчлэн гаргах» талаар шийдвэр гаргаж өгөхийг гуйсан байна. Харин миний бэлдсэн

өнөө Ёшика хатан хаан Сюнь Тээтэй сайн ажилласны үрээр хатан хаан манжуурт өөрийнхөө саналаар ирснийг сонин сурвалжлагч нарт албан ёсоор мэдэгдсэн учраас түүнийг мэдсэн тэнно Хирохито «Квантуны армийг манжуураас хэсэгчлэн гаргана гэдэг бол бүтэхгүй ажил» гэж татгалзсан учраас Инукай мухардсан бололтой гээд Тозияа хундагатай сакэг өргөлөө.

- Итагаки сан, та Манж Го улсыг байгуулах талаар шууд Аракийд танилцуулаад эзэн хаанд бараалхахыг бод! Тэгвэл бидний саналыг зөвшөөрнө гэж Доихара ярианд оролцов.

- Итагаки сан, Сакурайка интоор нийгэмлэгийн залуу дарга нарын бослого хэзээ хэзээгүй эхлэх гэж байгааг мэдээд сайд нарын танхим Хасимотоог баривчлуулсан. Гэхдээ түүнийг яллаж гавиагүй учраас одоо «Зинмү» гэдэг шинэ нийгэмлэг байгуулсан гэнэ билээ. Тиймээс Инукай, Манж Го улсыг байгуулах явдлыг эсэргүүцвэл, ялангуяа манай армийг манжуураас гаргах тухай үг дурдвал Хасимотоод мэдэгдээд түүнийг хөдөлгөх хэрэгтэй! гээд Тозияа нэгэн зурвас өглөө. Итагаки, Хасимотоод бичсэн захиаг авч Тозияагийн үгийг анхааралтай сонссон Итагакийг ажиглангуй ширтэж байснаа тэдний ярианд оролцож,

- Аав аа та Та Инукай саныг эзэн хааны зарлигийг дагахгүй гэж бодож байгаа юм уу? Тэр чинь амь насандаа халдана гэдгийг мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр...

- Охин минь монголын цэцэн үгэнд тэнэг хүн тэнгэрээс ах гэдэг. Инукайн чихэнд алт хийсэн ч сэгсэрч мэдэх хүн байгаа юм. Тиймээс эзэн хааны зарлигийг тоохгүй хэнэггүй царайлж мэдэх хүн шүү. За тэгээд ямато угсаатнууд эзэн хааны кодо замналыг дэлхий дахинд дэлгэрүүлэхийн тулд хийсэн улс төрийн ажиллагааг бусидогийн хуулинд гэмт хэрэг гэж үздэггүй юм гээд Тозияа хундагатай сэкэ балгаад хэсэг бодолхийлно. Тэгээд янжуураа асаагаад,

- Итагаки сан, Токиод очоод юу ч гэсэн байдлыг хар! Чухам хэн нь саад хийж байгааг тогтоох хэрэгтэй! Нөгөө талаар Инукайн танхимд их гүрнүүд ямаршуухан шахалт үзүүлж байгааг

мэдсэн дээр. Хэрвээ Инукайн засгийн газар, их гүрнүүдийн улс төрийн бодлогод хавчигдаж, тэдний өмнө хүлээсэн үүргийн дагуу яаж ч чадахгүй бол Шанхайд байгаа их гүрний нөлөө бүхий хүмүүсийг

айлгах хэрэгтэй юм. Тэгж чадвал Стимсон, өөрийнхөө хийсэн алдааг ойлгож, манай армийн талаар баримталж байгаа бодлогоо зөөллөнө. Тэдэнд чинь худалдаа, үйлдвэрийн эзэд шахалт үзүүлж чадна. Тэгэхээр Стимсон өөрийнхөө улс төрийн бодлогыг өөрчлөхөөс өөр замгүй гэдгийг ухаарна. Ер нь ажил төрлийн байдал ямаршуухан байгааг Токиогоос мэдэгдэж байвал зохино гэлээ.

Квантуны армийн штабын дарга Итагакийг 1932 оны эхээр Араки, их найрсгаар хүлээн авлаа. Тэгээд Хонзёо, Тозияя, Доихара нарын санаачилгаар боловсруулсан квантуны армийн төсөл, Манж Го улсыг байгуулах талаар сэдсэн асуудлыг сайд нарын танхимд биеэрээ танилцуулна гэж амлав. Араки өөрийнхөө хэлсэн үгэндээ хүрч, сайд нарын танхимд үг хэлэхдээ "Манай үндэстнийг дэлхий дахинаар хүндэтгэн, эзэн хаан тэнногийн өмнө хүлцэнгүй байх тийм эрин үеийг бид, армийн хүчээр авчрах хэрэгтэй. Бидний гол зорилго бол азийн улс орныг мөнхийн харанхуйд байгаа мэтээр үздэг европынхонд, азийг цэцэгжүүлэх ганц хүч нь яматогийн хөвгүүд гэдгийг ойлгуулах ёстой. Азийн ард түмэн бол мөнхийн харанхуй хоцрогдолд умбаж, түүнээс салахгүй мөнх төөрөгдлийн тив бол Ази бишээ. Тиймээс яматогийн хөвгүүд Азийн улс оронд сэргэн мандалтын гэрэл гэгээг тусгах ёстой. Энэ бол эзэн хааны зарчим кодоог азид дэлгэрүүлэх явдал мөн! Бид хятадын мэдэлд байсан Манжуурыг тусгаарлаад зогсоогүй одоо Манж Го гэдэг улсыг Нанжингийн засгийн газраас тусгайд нь бай-гуулах болно" гэж цог бадрангуй тунхаглав. Гэтэл засгийн газар Аракигийн саналыг түр хойшлуулахаар шийдсэнээр Пу И-ийг манжуурын эзэн хааны ширээнд залах явдал хойшлогдож, Манж Го улсын асуудлыг сайд нарын танхим дэмжсэнгүй. Үүнийг мэдсэн Итагаки тэр өдрөө Тозияятай утсаар ярилцаж хэдэн зүйл дээр санал тохирлоо.

- Итагаки сан, ер нь Шанхайн асуудлыг эхэлбэл зүгээр байх. Түүний дараагаар сайд нарын танхим ямар нэг юм ойлгох биз! Тэгээд ч их гүрнүүд, манай засгийн газар тавьж байгаа тулгалтаа зөөллөнө байх. Хэрвээ энэ бүхэн үр дүн багатай болбол Хасимотогийн ажиллагааг эхлүүлэх талаар тохиролцож болно гэхэд Итагаки, Тозияагийн саналыг зөвшөөрлөө.

Тозияя, Итагакитай ингэж ярьснаас хойш хоёр хоногийн дараа «Шанхайн лам» гэдэг нэгэн ажиллагааг сэдэж, сэтгэлдээ тунгаагаад, Сайнжаргалыг ашиглахаар шийдэж, нэгэн орой түүний өрөөнд орлоо. Сайнжаргал японы эртний урлагийн түүхэн тэмдэглэл уншиж байгааг ажигласан Тозияя, түүний дэргэд хэсэгхэн зогсоод,

- Охин минь юу л уншиж байна даа гэлээ.

- Укиёо гэдэг зургийн урлаг, түүхийг нь сонирхсон юм. Талийгаачийн танил нэг зураач дандаа бурхны амьдрал, эрлэг номон хаан, эрлэг тамын явдал, эгэл жирийн хүмүүсийн нэг өдрийн амьдрал ахуйг зурдаг байсан юм. Бурхны амьдрал ахуйг ингэж зурдаг зан үйл, японд бас дэлгэрсэн бололтой.

- Охин минь, чи зөв ойлгожээ. Бурхны амьдрал ахуйг дүрсэлдэг уран зургийн энэ хэлбэрийг японд XII зууны үед Иваса Матабай гэдэг хүн дэлгэрүүлж, укиёог үндэслэсэн юм. Тэр үед

ердөө ганц өнгөөр зурдаг байсан. Харин XVIII зууны үед Киёнобу гэдэг хүн, маажиндсан даавуун дээр олон өнгийн будгаар өнгө ялган зурдаг болцгоосон билээ. Шанхайд байдаг миний нэг танил, укиёогийн хуулбар зураг цуглуулдаг юм. Би удахгүй Шанхай явж магадгүй.

- Хэдийд явах вэ? Боллоцоо байвал намайг дагуулаад явахгүй юу. Би Шанхай үзмээр байна. Тэр далимандаа тэр хүнтэй танилцъя.

- Ажил төрлийн минь боллоцоо нэг л болж өгөхгүй байна. Ер нь чи, газар үзэнгүүтээ яваад ирсэн ч болно. Шанхайд очоод Танака гэдэг хүнтэй танилцаад цуглуулгыг нь сонирхоорой. Чамайг явбал би захиа бичиж өгнө гэхэд Сайнжаргал дургүйцсэнгүй. Тозияа, Сайнжаргалыг ийнхүү Шанхай явахыг чармайж байгаа зүтгэлийг ажиглаад «Аргагүй далим хайж байсан хүн байх нь» гэж бодлоо.

Тозияа, Шанхайд байгаа их гүрнүүдийн худалдаачдыг айлгаж чадвал японы армийн ажиллагааг эсэргүүцэж байгаа америкийн улс төрийн бодлогыг зөөллүүлнэ гэж үзэж байлаа. Тэгээд зогсохгүй бас Сайнжаргалыг Шанхай дахь америкийн банкныхантай холбоотой эсэхийг мэднэ гэж бодно.

Армийнхан Шанхайд байгаа өөрийнхөө тагнуулуудыг ажиллуулж дорвитойхон будлиан гаргаж чадвал түүнийг мэдсэн

Сайнжаргал америкийнхантай уулзах ёстой. Өөрөөр хэлбэл японы армийг Шанхайд оруулах боломж гаргаж чадвал Шанхайд байгаа үйлдвэрийн эзэд, гадаадын пүүсүүд дайн дажны хөлд хөрөнгөө сүйрүүлэхгүйн тулд засгийн газартаа японы армиас манжуурт явуулж байгаа бодлогыг илэрхий эсэргүүцэж байгаа явдалд саад болох нь илт байлаа. Чингэж тооцоолсон Тозияа, хоёр хоногийн дараа Сайнжаргалыг Шанхай руу явуулав. Түүнийг Шанхайд ирэхэд хотын Чапей хэсэгт суурьшсан японы орон нутгийн засаг захиргааны газрын нэг хүн, японы цэргийн төлөөлөгчийн газар хүргэж өглөө.

Сайнжаргал, хошууч Танакатай уулзаж ярилцахад Сигэто гэдэг хүн байлцав. Тэрээр Шанхайд суурьшсан японы орон нутгийн «Нэгдмэл зорилго» гэдэг байгууллагын ажилтан болой. Шанхай дахь тагнуулын удирдагч хошууч Танака, Тозияагийн битүүмжилсэн захиаг авч уншаад учрыг ойлгонгуут,

- Та манай газарт байрлана. Би хүн явуулаад байрыг чинь бэлдүүлчихье. Харин миний цуглуулсан укиёогийн хувьд гэвэл би бүгдийг нь дүүдээ бэлэглэчихсэн. Бүгдээрээ Токиод байгаа. Тэгэхээр би, укиёогийн цуглуулгаа танд сонирхуулж чадахгүй нь гэж учир байдлыг тайлбарлав. Тэрээр Тозияагийн захиаг уншаад Сигэтоод өглөө.

...Манжуурт явуулж байгаа манай армийн ажиллагаа төлөвлөсөн ёсоор явж байна. Их гүрнүүд Инукайн засгийн газарт хүчтэй шахалт үзүүлж, олон улсын байгууллагаас комисс зохион байгуулж, манжуурт ирүүлж бодит байдлыг шалгуулахаар шийдэх гэж байгаа учраас Манж Го улсыг хятадаас тусгайд нь байгуулж эзэн хаан Пу И-гийн хаан ширээ залгамжлах явдлыг засгийн газар зөвшөөрөхгүй байна. Энэ нь их гүрнүүд япон хятадын харилцааны асуудлыг тэнцвэртэй байлгахыг хичээж, улс төрийн зохицуулалт хийх гэж мэрийж байгаагаас шалтгаалсан юм. Иймээс их гүрнүүдийн анхаарлыг манжуураас зайлуулах ажиллагааг

Шанхайгаас эхлэх нь ашигтай. Шанхай дахь үйлдвэр банкныханд хүчтэйхэн шахалт үзүүлбэл тэд засгийн газрынхаа улс төрийн бодлогыг зөөлрүүлж чадах нь дамжиггүй. Ялангуяа манай армийн цэргийг Шанхайд оруулах бололцоо гаргаж чадвал тун сайн хэрэг! Үүнийг зохион байгуулаад мэдэгдэх

хэрэгтэй. Жич: Миний асарсан охиныг Шанхай хотод тухтай байлгаж, укиёогийнхоо цуглуулгыг үзүүлж, сонирхуулахыг хүсье...

Танака, Тозияагийн захиаг уншаад өчигдөр Мугдэнээс Доихара утасдаж тусгай даалгавар өгснийг саналаа. Шанхайд чингэж өдөөн хатгах ажиллагаа явуулахыг цэргийн яамны сайд зөвшөөрсөн гэдгийг Танака, Тозияагийн захианаас төдийгүй, Доихарагийн ярианаас багцаалаад өөрийнхөө нэр төрд нөлөө болохуйц хүмүүсийн санаачилсан энэ ажиллагаанд идэвхтэй оролцохыг өөрийн үүрэг гэж үзлээ.

- Гакка Тозияа сан, захиандаа хэд хэдэн зүйлийг анхааруулсан байна. Би таны хүссэн бүхнийг биелүүлж, тусалж чадна. Тиймээс та, надад өөрийнхөө саналыг аажуу уужуу хэлнэ биз. Харин таныг хэн гэж хүндэтгэж байх вэ? гэж Танакааг асуухад Сайнжаргал бодож санасан зүйлгүй шууд,

- Намайг Юки гэдэг юм гэчихлээ.

- Юки сан, та одоо байрандаа очиж амар даа. Аян замдаа ядраа байлгүй. Сигэто сан таныг байранд чинь хүргэж өгнө гэлээ.

Сайнжаргал, хотын байдалтай танилцаад сэтгэл шимширнэ. Тэрээр хэдэн үйлдвэрийн газраар ороод тэнд ажиллаж байгаа хүүхдүүдийг хараад сэтгэл эмтэрчээ. Насанд хүрээгүй, ямар ч хамгаалалтгүй жаалууд үүр шөнөөр ажилдаа ирж үдэш харанхуй болтол борви бохис хийлгүй ажиллана. Тэд ингэж ажиллаад ажлынхаа хөлсний тавны нэг хувийг авч, гол зогоох төдий амьдрах учраас ихэнх хүүхдүүд туранхай, царай зүсгүй болсныг харахаас нүд далдирмаар ажээ. Хятадын нутагт эзэмшил тогтоосон их гүрнүүдийн үйлдвэрийн эзэд үй олон хүүхдүүдийг хямд хөлсөөр ажиллуулж байгааг гадаадын зарим дэвшилт хэвлэлд «доллар, цент» үйлдвэрлэх арга гэж бичсэн нэгэн өгүүллийг уншсанаа Сайнжаргал санав.

Сайнжаргалыг ирэхээс нэг хоногийн өмнө Доихарагаас удирдамж авсан Танака өөрийн туслах Сигэтоод тусгай даалгавар өгч, алхаа гишгээ, уулзсан хүмүүс, очсон газрыг тогтоож нүдлэх үүргийг оноогоод Сайнжаргалаас нүд салгаж болохгүй гэж тушаажээ. Тиймээс Сайнжаргалд бараа болсон Сигэто, түүний аюулгүй байдлыг хангахын тулд консулын газрынхантай

тохиролцож, суудлын тэрэг хэрэглэх болов. Консулын газрынхан цэргийн төлөөлөгчийн газартай хэзээ хэзээнээсээ таардаггүй болохоор аар саар ажилд хэрэглэдэг муухан тэрэг өгчээ.

Сигэто, тусгай таних тэмдэг бүхий суудлыг тэрэгний жолоочийн хажууд сууж явах дуртай ажээ. Тэрээр чингэж явахдаа өөрийгөө консулын газрын ажилтан болчихсон мэтээр санана. Тиймээс гудамжинд харагдсан танилуудынхаа бараанаар тэргээ зогсоогоод танил залуусаа

дуудаж уулзахдаа энэ тэрхнийг албархуу байдлаар асуугаад «Юки сан, энэ залуу манай байгууллагын гишүүн» энэ тэр гэнэ. Чухам энэ нь сайхан хүүхэн дагуулж яваагаа харуулж гайхуулах гэсэн сэтгэлийн хөөрүү занг Сайнжаргалаас үл нууна. Ийнхүү дөрвөн өдөр хоттой танилцсан Сайнжаргал нэг өдөр хотын зүүн хэсэг буюу далайн эрэг рүү явж байхдаа Шанхай хотод байгуулсан японы эртний нитирэн шашны нэгэн сүмийг харжээ. Тэр сүмээс гурван залуу гарч ирэхийг харсан Сигэто, жолоочдоо,

- Энд зогсоорой. Би энэ гуравтай уулзах хэрэгтэй гээд суудлын тэрэг зогсонгуут өөрөө бууж тэднийг угтан уулзав. Сигэто, суудлын тэрэгнээс хэдэн алхам зайтай зогсож байгаа өнөө гурван залуутай уулзаж байхад Сайнжаргал залуусыг ажиг. Тэдний нэг нь дэндүү намхан болохоор модны тайрдас шиг харагдаж Сайнжаргалын инээдийг хүргэнэ.

- Сайнжаргал гуай, та үүнийг уншаач гэж жолооч англиар хэлээд нэгэн танилцуулах хуудас өглөө. Сайнжаргал өөрийг нь чингэж нэрээр нь дуудсан жолооч руу гайхан ширтсээр өнөө хуудсыг авч үзтэл хэдэн жилийн өмнө Шанхай дахь олон улсын банкны ерөнхийлөгчийн бие төлөөний хүнтэй уулзахад өгсөн эцгийн нь танилцуулах хуудас байлаа. Энэ хуудас ердөө хоёрхон ширхэг бөгөөд нэгийг нь Цэен гүн өөрөө авч хадгалж явдаг байлаа. Сайнжаргал банкны ерөнхийлөгчийн итгэмжилсэн хүмүүсийн нэг нь японы консулын газар тэрэг барьдгийг мэдээд болзмол дохиогоор,

- Дийзний (тамганы) үсэг их бүдэг байх нь ээ гэж асуутал жолооч,

- Наад дийзэнд чинь үсэг байхгүй. Түмэн наст гэдэг хээ байгаа юм гэж сөргүү үгээр хариу хэлээд албан ёсны ярианд орлоо.

- Сайнжаргалгуай, манай банкны ерөнхийлөгч таныг

Шанхайд ирсэн явдлыг сонирхож байна. Нөгөө талаар алтны хадгаламжийн тооцоог тохирсон ёсоор бүрэн эрхийн төлөөлөгч хэрэглэхгүйгээр хийж байх явдлыг үргэлжлүүлбэл таны алтыг ямар ч улс оронд шилжүүлэх эрх хэвээр үлдэх болно гэж хэлүүлсэн гэлээ.

- Японы цэргийн яамны зөвшөөрлөөр энд байгаа цэргийн газрын ажилтан Танака, ямар нэг өдөөн хатгалга үйлдэнэ. Тэгэхдээ японы цэргийг Шанхайд оруулах тийм далим гаргах ёстой. Харин алтны хувьд эцгийн минь байгуулсан бүх гэрээ хэлэлцээ хүчин төгөлдөр үргэлжлэх болно.

- Сайнжаргал гуай тантай уулзаж үнэн мөний сураг дуулсандаа их баярлалаа. Манай ерөнхийлөгчийн бие төлөөлөгч японы талтай ярилцаж, олон улсын банкны аюулгүй байдлыг хангаж чадна гэдэгт итгэж байна.

- Шанхайд гарах үймээнийг одоогоор энд хоёрхон хүн мэднэ. Тэгэхээр энэ талаар японы талд ямар ч сэжиг мэдэгдэж болохгүй. Үүнийг алттай холбогдсон нууцыг хадгалах үүднээс бодох ёстой асуудал. Алтны нууцыг задруулахгүй байх талаар танай банкны ерөнхийлөгч болон түүний итгэмжилсэн хүмүүс тодорхой үүрэг хүлээснийг бодно биз.

- Сайнжаргал гуай, энэ талаар санаа зовсны хэрэггүй. Бидэнд өөр замаар японыхонтой

харилцах боломж бий гэж жолоочийг хэлтэл Сигэто өнөө гурван залуугаас арайхийж салаад машин руугаа эргэлээ. Сигэто машины суудалд тухлан суух зуур,

- Энэ хэдэн маанагуудыг уржигдраас хойш хайгаад олоогүй юм гэж санамсаргүй хэлснээ цагаатгахын тулд хэдэн өдөр ажил тасалчихаад байгаа юм гэж нэмж хэллээ.

- Эд нар чинь танай төлөөлөгчдийн газар ажилладаг хэрэг үү?

- Үгүй ээ. Шанхайд байдаг манай Мицуи концерны харьяанд ажилладаг юм. Би эднийг нийгэмлэгийн зүгээс удирддаг юм байхгүй юу гэлээ.

Сайнжаргал Шанхайд байхдаа эцгийнхээ хойтын буяныг бодож японд дэлгэрсэн Буддын шашны нэг урсгал Нитирэн ёсны өнөө сүмд очлоо. Тэр урсгалыг анх 1253 онд Нитирэн Сёнин гэдэг хүн үндэслэсэн болохоор түүний нэрээр нэрлэжээ. Тэгээд сүмээс гарч

иртэл Танака, Сигэто хоёр гудамжинд хүлээж байлаа.

- Юки сан, та сүмд ирэхдээ бидэнд дуулгахгүй яагаа вэ? гэж Сигэто хэлэхдээ нэлээн сандарсан байлаа.

- Намайг энд яав л гэж дээ. Тэгээд би чинь хүүхэд биш. Та нарт ажил удаад яахав гэж бодоод хэлээгүй юм.

Тэднийг чингэж ярилцаж зогстол Нитирэн сүмийн тэргүүн лам хоёр шавийнхаа хамт гарч ирлээ. Тэд гудамж уруудан алхаж, Мёхо сүмийн нөгөө талын Иншань гэдэг мухар гудамжинд байдаг алчуурын үйлдвэрийг чиглэж явтал үйлдвэрийн хашаанаас гурван залуу гарч ирээд лам нарыг чиглэн алхав. Тэд хоёр хоногийн өмнө Мёхо сүмээс гарч ирж, Сигэтотой уулзсан гурван залуу байв. Харин энэ удаа тэд хятад маягаар хувцасласан байлаа. Сайнжаргал тайрдас шиг залууг таниад инээдээ барьж чадаагүй боловч лам нар руу анхаарлаа чиглүүлсэн Танака, Сигэто хоёр Сайнжаргалыг анзаарах сөхөө байсангүй. Харин алчуурын үйлдвэрийн хашааны нөгөө талаас гарч ирсэн хоёр хос түр саатан зогсохыг ажвал нэг нь хятад охин агаад нөгөө нь европ залуу байлаа. Чухам энэхэн үед Сигэто Танака хоёрын ажиж байсан залуус нөгөө гурван ламын дэргэдүүр өнгөрөхдөө лам нарыг тулган буудсан тул буун дуу гудамжинд хадлаа. Чухам үүнийг мэдсэн Сигэто, Танака хоёр бие бие рүүгээ гайхсан янзтай хартал энэхэн зуур сэхээ авсан Сигэто,

- Тэр танхай хятадуудыг хараач! Манай лам нарыг буудчихлаа гээд хятад хувцастай найзууд руугаа гүйлээ. Харин Танака, Сайнжаргал хоёр өнөө лам нарын дэргэд иртэл сүмийн тэргүүн хамба зүрхээрээ буудуулаад, хоёр шавь нь хүндхэн шархадсан байв. Ингэж буудахыг гурван шавьдаа хэд хоног зааварласныг Сайнжаргал мэдэхгүй боловч энэ бүхэн Танакагийн зохион байгуулсан өдөөн хатгалга гэдгийг ойлгож байлаа.

1932 оны I сарын 18 ны өдөр болсон энэ хэргийн маргааш нь японы тагнуулын газрын нууц туршуул Сигэто, Шанхай дахь япон иргэдийг турхирч «Нэгдмэл зорилго» гэдэг нийгэмлэгийн 32 гишүүнийг толгойлж, алчуурын үйлдвэр рүү зэвсэглэн халдав. Энэ үйлдвэрийн ажилчид Манжуур Зүүн умард хятадад японы цэрэг хүч түрэмгийлэн орсон явдлыг эсэргүүцэн хэд

хэдэн удаа цуглаан хийсэн ажээ. Сигэтогийн хүмүүс үйлдвэрт орж цехийн

ажилчид руу гал нээж, зарим тоног төхөөрөмжийг эвджээ. Чингээд хятадын цагдаагийн отряд хүрэлцэн ирж, тэдэнтэй буудалцсанаар Сигэтогийн хоёр залуу амиа алдаж, хэдэн залуус шархаджээ. Тэр оройгоо Танака, Шанхай дахь японы иргэдийг цуглуулж цуглаан хийгээд «Цуст хэрэг явдлыг» эсэргүүцэн, японы засгийн газарт «Япон иргэдийн амь насыг хамгаалах хээрийн цэрэг ирүүлэх» хүсэлт тавилаа. Чингээд энэ шаардлагаа Токио руу яаралтай явуулахыг Мицуи концерны удирдлагад тулгав. Танака өөрийнхөө ажиллагааг өргөжүүлэхийн тулд Шанхай хотын дарга У Тисинд эсэргүүцлийн бичиг гардуулж япон иргэдийн амь нас бүрэлгэсэн явдлыг хятадуудад тохлоо.

Чухам энэхэн үед японы армийн залуу дарга нар Токио дахь Мицуи нэгдлийн удирдлагад шаардлага тавьж, хөл үймээн дэгдээлээ. Үүнийг дэмжсэн цэргийн яамны «Хятадын асуудлыг судлах» хэсгийнхэн ерөнхий сайд Инукайд саналаа оруулсанд армийн залуу дарга нарын хөдөлгөөнөөс айсан Инукай, Мицуи нэгдлийн ерөнхийлөгч хунтайз Такумааг дуудаж, японы иргэдийн аюулгүй байдал, нэгдлийнхээ эрх ашгийн үүднээс Шанхай руу илгээх цэргийн тээврийн зардалд 22 сая иень (8 сая доллар) гаргахыг үүрэг болгов. Цэргийн яамны арга залиар ингэж бэлтгэсэн хуйвалдааныг гадарласан Такума татгалзах гэсэн боловч арга буюу зөвшөөрчээ. Чингээд адмирал Коити Сёзавагаар удирдуулсан байлдааны дөрвөн усан хөлөг онгоц I сарын 23-нд Шанхайн дэргэд ирсний маргааш нь байлдааны нисэх онгоц зөөгч хоёр усан хөлөг онгоц Хөх мөрний бэлчирт занга тавилаа. Японы энэ ажиллагааг эсэргүүцсэн цуглаан Шанхайд болж хятадын засгийн газарт японы түрэмгийлэгчдээс хотыг хамгаалах цэргийн хүч ирүүлэхийг шаардаж, Чан Кайшид илгээжээ.

Чан Кайшигийн даалгавраар Сунь Фо, Шанхай дахь японы эрх баригчидтай «Мөргөлдөөнийг тайван замаар зохицуулах» талаар ярилцаад үр дүнгүй болсон учраас гоминдааны 19 дүгээр дивизийг Шанхайн район руу хөдөлгөж, хүчээ нэмэгдүүлэх заавар өгчээ. Америкийн тагнуулын нууц туршуулууд үүнийг мэдэнгүүт зохих хүмүүст мэдэгдсэний дараа америкийн худалдааны танхимын нэгэн төлөөлөгч Танакатай уулзаж, гоминдааны 19 дүгээр дивизид өгсөн Сунь Фогийн зааврыг мэдэгдээд хэд хэдэн болзол тавилаа.

Танака, гоминдааны арми гал нээхэд бэлэн болсныг мэдэнгүүт адмирал Сёзаваад мэдэгдэж удирдамж авлаа.

- Танака сан, маргааш орой гэхэд Шанхайд байгаа япон иргэдийн гэр оронг нүүлгэх хэрэгтэй. Бид Чапэй руу гал нээнэ гэхэд Танака,

- Өөрийнхөө иргэдийн районыг тэгж сүйтгэж болохгүй шүү дээ гэв.

- Ингэснээрээ, хятадын цэргийн дайралтанд япон иргэдийн суурин сүйдсэн гэдэг шалтаг гаргах хэрэгтэй шүү гэж анхааруулав. Чингээд Танака 1 сарын 26 ны 22 цаг гэхэд япон иргэдийг Чапэйгээс зайлуулж амжлаа. Харин адмирал 23 цагт Шанхай дахь хятадын удирдлагад Японы эсрэг чиглэсэн цуглааныг зогсоож даруйхан бууж өгөхийг шаардлаа. Чингээд хагас цагийн дараа Чапэй руу гал нээлээ. Чингэж байлдааны ажиллагаа эхэлсний маргааш нь Сайнжаргал цэргийн тусгай шугамаар Мугдэн рүү нисэв.

Шанхай дахь мөргөлдөөн удаашрах төлөвтэй болсонд сайд нарын танхим дургүйцлээ. Тэгээд зогссонгүй их гүрнүүд Шанхайн асуудлаар яаралтай хэлэлцээ хийхийг японы засгийн газраас шаардах болсон нь сайд нарын танхимын үйл тамыг баржээ. Японы засгийн газар армийн ажиллагааг ширүүн шүүмжилж, олон улсын харилцаанд японы талаас хүлээсэн үүргийг бүдүүлгээр зөрчлөө гэж зэмлэж эхлэв. Энэ нь цэргийн «Залуу дарга» нарын холбооны дургүйцлийг буцалгалаа. Шанхайг эзлэх ажиллагаа удааширсан бурууг армийхан шүүмжилж, засгийн газар руу дайрахдаа сайд нарын танхимын хуучны үзэлтэн, ордныхны нөлөөгөөр эх орны аюулгүй байдлыг хамгаалахад цалгар ажиллагаа явууллаа гэж дүгнэсэн нь буруутангуудыг хашраах арга хэмжээ явуулах алхам боллоо.

Чингээд хоёр сарын 8-нд Токиогийн Хонго хэмээх бага сургуулийн цуглаан дээр Вакацукигийн засгийн газрын сангийн яамны сайд агсан японы цэргийн зардлыг багасгах санал дэвшүүлж байсан Иноуэ буудуулав. Түүнээс хойш хорь гаруй хоноод Мицуи банкны байшингийн дэргэд хунтайз Такума Дан

алагдлаа. Чингэж сайд нарын амь насанд халдах өшөө хонзон эхэлсэн явдлаас болгоомжилсон сайд нарын танхим Манж Го улсыг байгуулах шийдвэр гаргасан боловч эзэн хаан Пу И-ийг хаан ширээнд залах талаар тодорхой шийдгүй байлаа.

Сайд нарын танхим ийнхүү нүүрэндээ зөвшөөрөөд ачир дээрээ армийн ажиллагааны эсрэг байгааг мэдсэн залуу дарга нарын холбоо 5 сарын 15-нд үймээн дэгдээв. Чингээд ерөнхий сайд Инукайн орд руу халдаж, залуу дарга нарын холбооны нэг гишүүн Инукайг устгалаа. Тэгээд зогссонгүй хааны тамга хамгаалагч Макино, цагдаагийн газар Сэйюкай намын байр, Нихон гинго, Мицуибиси гинго зэрэг банк руу зэвсэгт халдлага хийлээ. Ийнхүү өшөө авах ажиллагааны нөлөөгөөр сайд нарын танхимыг тарааж, сайд нарын танхимыг шинээр байгуулах явдлыг Саёнзи удирдаж, ерөнхий сайдаар Солонгост японы цэргийг удирдаж байсан адмирал Макото Сайтоог сонгосныг эзэн хаан батлав. Шинэ ерөнхий сайд Манж Го улсын асуудлыг нарийвчлан судлаад, засгийн газрын албан ёсны шийд гаргаж, Манж Го улсыг японы сайд нарын танхим зөвшөөрснөө мэдэгдсэний дараа улсын засаг төрийг Пу И толгойлов.

Японы квантуны арми, өөрийн ажиллагааг манжуурт идэвхжүүлж, Харбиныг эзлэн авсны дараа өөрийнхөө цэргийг алс дорнодын Хабаровск Ханх нуур, Хасан нуурын ойролцоо байгуулах боломжтой болсон нь цэргийн яамны сайд Аракигийн санаачилга байлаа. Тэрээр Манж Го улсыг хүлээн зөвшөөрсөн сайд нарын танхимын хурал дээр хэлсэн үгэндээ «Манай түүхэн зорилтыг хэрэгжүүлэхэд хоёр их хүч хөндөлдөж байна. Энэ бол улаан орос төдийгүй улаан хятадууд болно. Бидний эсрэг дайсагнасан эдгээр хоёр хүч нь баруун европ болон америкийн төрийн зүтгэлтэнгүүдийн хувиа бодсон улс төрийн бодлого, хятадын үндэсний үзэлтэнгүүдийн хүчийг ашиглаж байна. Тиймээс азид эзэн хааны кодо замналыг дэлгэрүүлэх, манай улс төрийн бодлогыг гүнзгийрүүлэх хамгийн найдвартай түшиц, тулгуур газар бол Манжуур байх ёстой» гэж айлджээ.

Намрын эхэн сарын хуучдаарх нэгэн орой Доихара, хамрын шуухинаа туссан Тозияатай уулзахаар ирлээ.

-Тозияа сан, Аракигийн саналыг гадаад яам дэмжихчээн

аядаж, Чан Кайшигийн засгийн газар цахилгаан явуулсан байна. Тэр цахилгаанд «Манж Го улсын эсрэг тэмцэж байгаа Жан Сюэляны цэргийг хятадаас зайлуулах явдлыг эрхэм үүрэг болгосон квантуны армийн зорилгыг тайлбарлаад хятадын цагаан хэрмийн өмнө талаар цэрэг хөдөлгөж, хүч хавсрахыг хүссэн байна» Үүнтэй уялдуулж Сузуки, Чан Кайштай уулзаж ярилцахдаа «Япон хятадын ард түмэн ах дүүгийн харьцаатай байх нь чухал! Хэрвээ та бүхэн Жан Сюэляны эсрэг цэргээ хөдөлгөхгүй бол манай арми та нартай түнжин хагарахаас өөр замгүй» гэж айлдсан байна.

- Би энэ талаар Чан Кайшигийн зөвлөх Сузукитай ярих санаатай байсан юм. Тэр лүд ашгүй Токиогоос удирдамж аваад тэгж ярьж л дээ. Чан Кайши, Жан Золингийн хүү рүү халдахгүй байх. Харин аль аль талаа бодоод бөөрөнхийлөх бодолтой байгаа. Манай армийг Жэхэ, Цахар руу хөдлөхөд Жан Сюэлян хүчинд автагдаад ирэхээрээ Чан Кайшигаас тусламж гуйх нь зайлшгүй. Тэр үед Чан Кайши, одоогийнх шиг бөөрөнхийлсөн аргаараа хандвал бидэнд хэрэгтэй! Чан Кайшийг ийм аргаар Жан Сюэлянаас хөндийрүүлж чадвал манай арми, Жэхэ, Цахарыг нүд ирмэхийн зуургүй авна гэж Тозияаг хэлэхэд Доихара «Ийм сайхан зантай байхад нь өнөөхөө хэлье» гэж бодоод,

- Тозияа сан, монголоос хүн ирсэн байна гэхэд Тозияа,

- Бурхны тиг сурагласан хүн үү? гэж асуулаа.

- Үгүй ээ. Хүрээ хийдийн аврал гэдэг ажиллагааны холбоочин.

- Тэр яахав. Монголын лам нарын энэ удаагийг хөдөлгөөнийг толгойлуулахаар Бандит гэгээний хийдийн чойжин ламыг томилсон гэдэг. Тэгтэл тэр новш манайхны хударгаар орж хятадуудтай холбоо тогтоохыг хичээж байсан нь мэдэгдсэн. Хоёр туулай хөөсөн анчин хоосон үлддэг номтой! Тэгээд би, тэдний ажиллагаанд найдаагүй юм. Нөгөө талаар монголын асуудлаас өмнө манжуурын асуудлыг чухалчилж байсан шүү дээ. Харин ирэх жилээс дорвитой юм сэдэх хэрэгтэй байна. Би энэ талаар армийн удирдлагад санал оруулах бодолтой байгаа гэхэд Доихара эчнээндээ баяртай байв. Тэрээр монголд гарсан эсэргүү хөдөлгөөнд (1932 он) дэмжлэг үзүүлсэнгүй гэдэг асуудалд

ороогдож магадгүй хэмээн болгоомжилсон билээ. Доихарааг чингэж ярилцаад явсны нөгөөдөр орой нь Сувдаа гангар шаазанд шөл хийж барьсаар Сайнжаргалын өрөөнд орж ирлээ.

- Эгч ээ, би аяга хар шөл хийгээд ирлээ. Та өнөөдөр толгой өндийлгөсөнгүй цоохор цаас шагайлаа. Одоо жаахан амарч үз.

- Еэ яасан сайхан үнэртэй юм бэ? Чи наад ширээн дээр байгаа юмаа янзалчихаарай гээд Сайнжаргал бичгийн ширээний дэргэдээс холдож, явган ширээн дээр тавьсан шөлөө авч диван дээр суулаа.

- Сувдаа чи, наадахаа уншаарай. Манж Оросын гэрээнүүдийн хуулбар байгаа юм. Би наадахыг чинь Тозияа гуайн номын сангаас олж авсан. Тун сонин зүйл шүү. Чи унш гэлээ. Сувдаа тэр гэрээ бичгүүдийг сонирхон уншив.

Амар мөрний хавиар нутагладаг оросуудын орон нутгийн захиргааны төв рүү 1687 онд хоёр удаа довтолсонтой холбогдуулж гаргасан албан баримт, 1689 онд байгуулсан Нэрчүгийн гэрээ, 1858 онд дорнод Сибирийн амбан захирагч Мураваев, манж улсын төлөөлөгч Шань нарын байгуулсан Аргуны гэрээ бичгийн хуулбар байлаа.

- Эгч ээ та, энэ гэрээ бичгээр яах гэсэн юм бэ?

- Манж улс 240 жилийн өмнө Амар мөрний сав газрыг өөрийн нутаг болгох гэж зүтгээд эцэстээ наад гэрээгээр чинь Оросын унаган нутаг болгохыг хүлээн зөвшөөрсөн юм. Гэтэл Жан Золингийн үед Амарын сав газрыг «Хятадын алдагдсан нутаг» гэдэг хуурамч баримт бэлдсэн байна. Түүгээр ч барахгүй саяхан «Хятадын алдагдсан нутаг» гэдэгтэй холбогдуулж Хуан Циюн гэдэг хүн «Хятадын хил» гэдэг ном хэвлүүлэхдээ Жан Золингийн даалгавраар боловсруулсан хуурамч баримтуудыг албан ёсны зүйл болгож хэрэглээд зогссонгүй түүнийг батлах гэж оролджээ. Намайг Шанхайд очиход өнөө Танака, тэр номыг укиёо зургийнхаа оронд бэлэглэсэн юм. Тэр номонд Жан Золингийн даалгавраар боловсруулсан төлөвлөгөөнд оруулсан бүх нутгийг хятадын алдагдсан нутаг гэж зарлажээ. Японы арми, хятадын алдагдсан нутаг гэдэг хуурамч баримтанд орсон улс орныг байлдан дагуулж, эзэн хааны кодо замналд оруулах бодолтой байна. Энэ бүхнийг эргэцүүлэхэд надад хачин санагдах юм.

Сувдаа, Сайнжаргал хоёр ингэж ярьж суутал зэргэлдээх өрөөнөөс Тозияа орж ирлээ.

- Сувдаа наад бичиг цаасаа янзалчихаарай гэсэн Сайнжаргал Тозияа руу эргэж,

- Та наашаа суугаач гээд суудал тавьж өглөө. Тозияа, Сайнжаргалын дэргэд суухдаа гүнээ санаа алдсанаа,

- Сайнжаргалаа би, чамайг Юки гэж байя. Чи дургүйцэхгүй биз гэлээ. Сайнжаргал, Шанхайд болсон хэрэг явдлыг мэдсэн Тозияад,

- Би таныг хэлэхээс өмнө өөрийгөө ингэж нэрлэсэн юм. Танака, Сигэто хоёр миний нэрийг хэлэх гэж ээрч муураад байхаар тэгж нэрлэсэн юм. Ер нь талийгаач таныг ааваа гэж байгаарай гэсэн. Тэгэхээр би чинь таны эрхэмлэдэг Юки гэдэг нэрээр нэрлэж болно биз дээ. Одоо албан ёсоор болговол яасан юм бэ? Заримдаа ааваа гэхихээд зовох юм. Албан ёсоор болгоогүй болохоор нэг л эвгүй санагддаг. Намайг ааваа гэхээр танд бас тэгж бодогддог уу? гэж энгийн байдлаар асуулаа.

- Чамайг хааяа аав гэж хэлэхээр надад сайхан, бахархалтай юм шиг санагддаг. Харин чамайг гомдоочих вий гэхээс би айх юм.

Тозияа, сэтгэлийнхээ далдын бодолд хүрэх боломж ингэж олдоно гэж бодоогүй. Тэгээд Манжуур дахь Буддын синто бурхны хутаг олох ёсны нэгэн ширээт ламтай уулзахыг чухалчиллаа. Тозияа ширээт ламд бараалхаж,

- Би нэг халх бүсгүйг өргөж авах санаатай байна. Тэгэхдээ бүүр албаны ёс горимоор шүү дээ. Ингэхээр шашны зүгээс ёсолж төрөлж өгөхөд шашны ялгаа гарах уу ганц танаас лавлах гэсэн юм гэлээ.

- Сүсэг бишрэлийн хувьд буддын энэрэнгүй ёсонд харшлахгүй. Монголд дэлгэрсэн буддын энэрэнгүй ёс бол шарын шашны урсгалаар түгсэн ламрим хэмээх ёс билээ. Бурхны зам мөрийг олох энэрэнгүй ёс болсон синто бол нэг өвөрмөц ламрим юм. Манай суут ухаантнууд ламримыг (номхон хүлцэнгүйн үзэл) засан сайжруулсан онцлогтой. Тиймээс шашны зан үйлийн ёсоор бол зөрөө байхгүй. Харин монгол нэрийг нь синто ёсонд нийлэх нэрээр солих нь чухал.

- Би түүнийг Юки гэж нэрлэдэг юм.

- Ёстой санаанд оромгүй сайхан нэр байна. Их эртний нэр шүү гэснээр Тозияагийн санасан хэрэг түвэггүй бүтлээ. Чингээд арван тав хоногийн дараа Тозияа, Сайнжаргалыг асарсан охиноо болгох ёслолоо ширээт ламаар хүндтэй гүйцэтгүүлж, бурхны адистидлаар (ерөөлөөр) Юки нэрийг албан ёсоор Сайнжаргалд хайрлав. Ийнхүү эцгээ нас барснаас жил гарангийн дараа Сайнжаргал Тозияагийн охин боллоо.

Тозияа Сайнжаргалыг асарсан охиноо болгох ёслолыг дорвитой тэмдэглэсэн нь сэтгэлийн түгшүүрийг зайлуулжээ. Тэрээр жанжин штабаас өгсөн даалгавар ёсоор бол Богдын алтыг ямар банкинд байгааг, багтай мэдэж тэгснээрээ нэг бол эзэн хааны санд оруулах, нэг бол Оросын дүрвэгсдийн товчооны хорлон сүйтгэх ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломж сэдэх ёстой байсан. Гэвч Тозияа богдыг нас барснаас хойш алтыг арми, хаан хоёрын аль алинд өгөхгүйг бодох болсон. Үүнийг гадарласан хүмүүс түүнийг шүүмжилж, хяхаж хавчих болсон тул тэрээр дайснуудтайгаа түр эвлэрч өдий хүрч билээ. Тэгэхдээ олон юмнаас айж, сэтгэлээ түгшээж байлаа. Тэгээд өөрийгөө эвгүй байдлаас гаргахын тул Симото, Сойхара хоёрыг ашигласан нь зовлонг төдий л хөнгөлөөгүй ажээ. Тозияа Синто ёсны шашны сүсэгтэн болохоор далдын ид шидэнд бишрэмтгий. Чингэж сүсэглэн наманчлахын ачаар аар саар осол эндэгдлээс аврагддаг гэж боддог.

Тэрээр Юки хэмээх асарсан охинтой болсон явдлыг бурхны ерөөл хувь тавилан, ид шид далдаас тэтгэж миний үйл лайг минь цагаатгаж байна гэж бодно. Тозияа Сайнжаргалыг охиноо болгосны дараа богдын алтыг яаж өөрийнхөө өмч болгох, алтны талаар дэгдсэн шуугианыг хэрхэн дарах талаар бодох болсон. Тозияа чингэж эрт эдүгээг улируулан бодохдоо талийгаач гүнгийн хэлсэн үгийг хүртэл нэхэн санадаг. Тозияа нэг удаа гүнтэй архидахдаа гүнгийн амнаас маш их хөрөнгөний тухай сонссоноо саналаа. Энэ бол уржнангийн цаад жил болсон хэрэг болой. ...Цэен гүн сакэ балгаж, яриа дэлгэн, янжуураа уугиулахдаа,

- Тозияа чи, бид хоёрын байгуулах гэсэн өнөө Богд хаант улс, Их Монгол улс ч нохойн замаар орсон байхаа! Ингэж бүтэхгүй

юманд санаархсанд орвол өмнөд Манжуурын Мантэцу нэгдэлд хувь нийлүүлж хоршоод Азийн загасны пүүстэй нийлж, Буйрт загасны үйлдвэр байгуулж, газар түрээсэлж авах талаар ардын засагтай тохирох замаа боддог байж дээ.

- Цэен минь Буйр Хайларын хооронд төмөр зам тавих нь уу? Тэгвэл Мантэцу нийгэмлэгтэй хоршиж хувь нийлүүлнэ гэдэг чинь зөв шүү.

- Төмөр зам тавиулчихвал Та да пүүснийхнийг шомбодоод байж болно. Тэд чинь Буйраас

олсон загасаа илжиг тэргээр зөөхгүй нь мэдээж! Нөгөө талаар Хайлар, Харбин руу цувсан нутгийнхнаас нэлээн ашиг олно.

- Цэен минь Хаант орос өөрийнхөө хилээс Ляодунгийн өмнөд хэсэг Гуаньдунгийн арал дээрх Порт-Артур хүртэл 2000 км төмөр зам тавихдаа 375 сая алтан рублийн хөрөнгө зарсан юмдаг. Тэгэхээр Хайлар Буйр чиглэлд төмөр зам тавихад ихээхэн алт орно доо тэж Тозияаг хэлэхэд,

- Тэр ч яахав. Сайндаа 6 сая доллар орно биз. Үүний тэн хагасыг гаргана гэдэг энүүхэнд хэрэг гэжээ...

Тозияа тэр үед их согтуу байсан болохоор энэ үгний учрыг тунгаалгүй өнгөрсөн. Гэтэл энэ нь Богдын алтны хэмжээг барагцаалах баримт байжээ. Тэгээд Тозияа нэг өдөр Мантэцу нийгэмлэгийн нөлөө бүхий хүмүүстэй уулзаж, алтны ханшны талаар сураглав. Манжуур дахь төмөр замын Мугдэнгийн төлөөлөгч,

- Тоаияа сан, танд алтны одоогийн ханш хэрэгтэй юу? Эсвэл дорнод хятадын төмөр замыг байгуулах үеийн ханш хэрэгтэй юу? гэж магадлав.

- Би аль алиныг нь сонирхсон юм. Ер нь тэр үед нэг км зам ямаршуухан өртөгтэй байсныг доллар, иений харьцаагаар гаргавал бүр сайн шүү гэж Тозияаг хэлэхэд хижээлдүү насны халзан япон бичиг дансаа шүүж,

- Та жаахан хүлээх байх даа гээд хар суман сампингаа шаржигнуулж гарлаа. Тэр хүн хориод мөч болсны дараа нахиу хамар дээрээ тохсон нүдний шилээ аваад,

- Олон улсын банкны баталгаагаар бол хаант оросын нэг алтан рубль нэг грамм алтыг сая хуваасны 222168 микрон (0,222168)-

той тэнцэх юм. Өөрөөр хэлбэл 1 грамм алт нь 5 алтан рубльтэй тэнцэх болно. Энэ нь 38 рубль буюу 7 доллартай тэнцдэг байсан. Ингэхээр хичнээн сая доллар зарцуулсан нь илэрхий гэлээ.

Тозияа тэр оройжингоо бодол болов. Тэгээд Хайлараас Ганжуур сүм, Буйр нуурын эрэг дээрх Асар сүм хүртэл ердийн хөсгийн замаар 200 км байгааг мэдлээ.

...Мантэцу нэгдлийн гаргасан тооцоогоор бол 1 км төмөр зам тавихад 38 мянган долларын хөрөнгө шаардагдана. Тэгвэл Хайлараас Буйр хүртэл төмөр зам тавихад 8 сая гаруй доллар шаардагдах юм. Богдын алтыг долларт шилжүүлбэл 3 сая гаруй доллар болно. Харин дамын үнээр бол талийж өгнө. Ингэхээр талийгаач Харбин, Мугдэнд байгаа 4 сая иений хөрөнгөө нийлүүлээд 50 сая орчим иений хадгаламжтай байх нь... Төмөр зам... төмөр зам гэдэг чинь надад ашигтай юм биш үү! Юкийг ятгаж байгаад Мантэцу нэгдэлтэй хувь нийлүүлж хоршуулаад Буйр Хайларын замыг тавиулсны дараа түүнийг устгачихвал Юкигийн бүх хөрөнгө минийх болно. Манай арми, өвөр монголыг эзлээд ар монголыг улааны гар хөлөөс салгачихвал надад их аз дайрна. Тэгээд уржнангийнх шиг будилааныг дорнод хятадын төмөр зам дээр хийж, цувааг нь сүйтгээд байвал улаан орос Харбин дахь төмөр замын бүх хөрөнгөө Манжуурт худалдахаас өөр аргагүй болно. Ингэхээр Харбингаас Манжуур өртөө хүртэлх зам

японы мэдлийн төмөр зам болно гэсэн үг! Ингэж чадвал засгийн газар, зүүн умард хятадын төмөр замыг нэгтгэсэн том нэгдэл байгуулна. Тэр үед би тэр нэгдэлд хувь нийлүүлэх нэр хүндээ олчихсон байна. Ингэхээр надад их ирээдүй байна...

Тозияа чингэж олон удаа харьцуулан тунгаагаад цэргийн яам, жанжин штабын удирдлагын нэр дээр айлтгал бичихээр шийдлээ. Тозияа энэ айлтгалаараа армийн удирдлагад барагтай болсон нэр төрийнхөө сэжгийг нэгмөсөн цайруулах зорилготой. Түүний сэдсэн санаа талаар өнгөрөхгүй гэдгийг нарийн тооцоолжээ.

Тозияагийн айлтгалтай танилцсан армийн удирдлага түүнийг сайд нарын танхимд танилцуулаад эзэн хаанд уламжлуулж «Мандан буй наран» гэдэг одонгоор шагнуулах санал оруулжээ.

...Ямато үндэстний үнэнч хүү миний бие, тэнногийн зарлигийг дагаж халхын улс төрийн томоохон зүтгэлтний нэг Цэен гүн агсны охин Сайнжаргалыг эзэн хааны замналд (Кодоод) үнэнчээр сүсэглүүлэн, сёвогийн эрин үеийн наран улсын зорилгыг хэрэгжүүлэх үйлст бишрүүлэн дагуулав.

Ингэж чадсанаараа армийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлын нэг ар монголыг шийдэх үйлсэд Юки хэмээгдэх Сайнжаргалыг хүчин зүтгүүлэх бүрэн боломжтой боллоо гэдгийг сэтгэл баясгалантайгаар уламжлан толилуулъя. Талийгаачийн нэр дээр Богдын алт үлдсэн нь гарцаагүй бөгөөд сэрүүн тунгалаг байхдаа Мантэцу нэгдэлтэй хувь нийлүүлж, Хайлараас Буйр нуур хүртэл төмөр зам тавихад шаардагдах хөрөнгийг хоршино гэж гэрээсэлсэн юм.

Энэ тухай Юки надад саяхан мэдэгдлээ. Үүнийг армийн удирдлагын нэр дээр уламжилсан эзэн хааны армийн шиү жёо Хакидо Тозияа Сёвогийн 7-р он намрын сүүл сарын 20. Мүгдэн хот.

Тозияагийн илтгэлтэй танилцсан эзэн хааны зөвлөх цэргийн яамны удирдлагыг дуудаж уулзахдаа,

- Ноён сайдуудаа. Улаан оросын алс дорнодыг шийдэх асуудлыг яаралтай боловсруулах хэрэгтэй. Нөгөө талаар дорнод хятадын төмөр замын асуудлыг шийдмэгц ар монголын асуудал чухалчлагдана. Учир нь Харбинаас Улаан оросын хилийн үүд болсон Манжуур өртөө хүртэлх төмөр замыг Манжуурт хямд үнээр өгүүлчихвэл монгол руу чиглэсэн армийн тээврийн асуудал шийдэгдэнэ. Ялангуяа тэр үед гүнгийн охины гүйцэтгэх үүрэг багагүй байж магадгүй.

Монголын хил рүү чиглэсэн армийн ажиллагаанд шаардагдах төмөр замыг тавихад хамгийн наад захын асуудал түүнийг армийн зориулалттай биш, иргэний тээврийн зориулалттай төдийгүй ар монголын үндэсний хөрөнгөтний нэг болох хүний хувийн юм гэдэг сэтгэгдэл төрүүлбэл армийн ажиллагааг нууцалж чадах онцгой нөхцөл гарч болох юм. Тиймээс Тозияагийн айлтгал цаг үеэ олсон сүрхий ирээдүйтэй зүйл болжээ гэж хэлсэн нь бас учиртай ажээ. Үнэндээ эзэн хааны зөвлөх ингэж хэлэхгүй бол хэзээ нэг цагт армийнхны өшөө хонзонд өртөж, ордныхоо дэргэд буудуулна гэдгээ ойлгож байлаа.

Цэргийн яамны удирдлага, зөвлөхийн энэ үгийг сонсоод сэтгэл

хангалуун байлаа. Учир нь цэргийн яам, жанжин штаб Тозияагийн айлтгалыг хүлээн аваад тунгаан шүүхдээ ингэж тохиролцсон явдлыг зөвлөх мэдэж байлаа. Цэргийн яамны удирдлага энэ үүргийг хүлээж аваад жанжин штабын тагнуулын газарт тусгай үүрэг өгөхдөө «Юкийг самурайн үзэл санаагаар хүмүүжүүлэх арга боловсруулахыг» даалгажээ. Иймээс тагнуулын газрын удирдлага доорх цахилгааныг Мугдэн руу явуулав.

Мугдэн. Тозияад Юкийг Токио руу явуулах талаар санаачилга гаргах хэрэгтэй! Жанжин штабын хоёрдугаар удирдах газрын дарга Татэкава. Токио. Сёвогийн 7 дугаар он өвлийн эхэн сарын шинийн 5.

Тозияа энэ цахилгааныг хүлээн аваад «Юкийг Токиод очсоны дараагаар кэмпэйтэйн гараар хүмүүжүүлж, улмаар Богдын алтны нууцыг тайлах гэсэн хэрэг байх нь! Тэгвэл миний бодсон бодол эвгүй тийшээ эргэж мэднэ. Жанжин штаб миний айлтгалыг үзээд ингэж шийддэг мөн сониноо! Юу ч гэсэн зохих хүмүүстэй холбоо барьж байдлыг далдуур хянах хэрэгтэй. Хэрвээ надад ашигтай далим гарвал Сайнжаргалыг Токио руу явуулах нь зүйтэй» гэж боджээ.

Нэг. Үнэний мөр балрах ёсгүй

Давчуу өрөөний хананаас зайдуухан зассан урт ширээний дэргэд суусан хоёр хүн ажил төрлөө ярилцана. Тэдний аль аль нь энгийн хувцастай ажээ. Дотоодын хамгаалах газрын ажилтан Даваг, удирдлагаас өгсөн даалгаврыг биелүүлэхтэй холбогдсон зүйлийг нарийвчлан судалсны дараа өөрийнхөө төлөвлөгөөг даргадаа танилцуулсан ажээ.

Гуравдугаар бүлэг

Үл илрэх нууцын эзэд

- Японы засгийн газар армийнхны шахалтаар 1932 оны 9 сарын 15-нд Манж Го улсыг албан ёсоор зөвшөөрөөд Гуаньдун дахь цэргийн удирдлагад байсан генерал Мутоог Манж Го улсад суух элчин зөвлөхөөр томилсон юм. Манж Го улсын засгийг Пу И-гийн гарт захируулж байгаад 1934 оны 3 сарын 1 нд Пу И-ийг эзэн хааны ширээнд залж түүний хаанчлалын шинэ эрин үеийг Кандэ буюу Энх эрдэмт гэж цоллосон байна. Квантуны арми Манжуурыг ингэж эмхлэн тохинуулсны дараа Өвөр монголыг эзлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд орсон. Одоо Жэхэ, Долнуур хот японы цэргийн мэдэлд ороод байгаа. Түүгээр үл барам Жэхэ мужийн нөлөө бүхий хүмүүсийг Пу И хаан гэгчид бараалхуулж уулзуулах арга замыг квантуны арми зохион байгуулаад байгаа. Япончууд Жэхэ мужийг сайн дурын үндсэн дээр Манж Го улсад дагаар орохыг зөвлөж байгаа төдийгүй түүнийг яаран зарлуулах төлөвтэй байна. Энэ бол Өвөр монголыг түрэмгийлэх гэсэн ов мэх бөгөөд түүнийгээ Жэхэгийнхэнд хүчээр тулгаж байгаа хэрэг мөн.

Үүний ачаар японы арми Хэбэй муж, Бээжин Мугдэнгийн чиглэлийг өөртөө бүрэн хянаж байх боломж олох ёстой. Ер нь японыхон цэргээ цагаан хэрмийн дагуу байрлуулж байгаа явдал бол манайх руу чиглүүлсэн армийн ажиллагааг өргөн фронттой болгох гэсний нэг илрэл мөн! Нөгөө талаар хятадыг эзлэх Хэй гэдэг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд умард хятадад цэргээ оруулах боломжийг харгалзсан хэрэг. Армийн энэ төлөвлөгөөг биелүүлэхэд чөдөр болж байгаа нэг хүчин зүйл бол их гүрнүүдийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу нэр төрөө бодсон японы сайд нарын танхим, минсэйто буюу их гүрнүүдтэй түнжин хагарсан явдлаа хурцатгахгүйг хичээж байгаа хүчнийхэн, ардчилсан хүчийг нэгтгэсэн Сякай Тайсюто намтай хамтарч дайныг эрхэмлэх болсон Сэйюкай намыг эрс шүүмжилж байгаад оршиж байгаа юм. Бидний төсөөллөөр бол японы арми, Бээжин Тяньжингийн чиглэлээр Нанжин руу довтолж, түүнийг эзэлбэл японы армийг Бохайн булангаас төмөр замаар тээж, манай хил рүү ойртуулах зам нээгдэх ёстой. Ингэснээрээ алс дорнодоос баруун Сибирь, Байгаль руу чиглүүлсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд орж, юуны өмнө манай улс руу заналхийлэх болно. Өөрөөр хэлбэл

манай орныг эзлээд Зөвлөлтийн нутгийг Байгалиар таслан авч, дараа нь Сибирь Мансю гэдэг нэгдсэн улс байгуулж японы тоглоомын засгийн газар байгуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ёстой юм. Иймээс японы армийн нууц ажиллагааг илрүүлэхэд чиглэсэн «Рожуганукай» гэж товлосон ажиллагааг эхлүүлэх үндэслэл бүрдсэн гэж үзэж байна гээд Даваг өөрийнхөө илтгэлийг төгсгөв.

- Буянтыг барьж өгсөн Хаалганы жинчдийн даамалд холбогдсон асуудлыг бүрэн нягталсан уу?

- Жинчдийн даамал нас барсан нь нотлогдсон. Тэр жинчид манай хилээс гараад Аксахалынханд дээрэмдүүлсэн байна. Тэр үеэр даамал алагдсан.

- Жинчдээс Хаалганд буцаж очих хүн байхгүй гэж үү?

- Даамлаас бусад нь Ганьсугийн хүмүүс байсан. Даамал бол Бээжингийн нэгэн томоохон пүүсний эзний Хаалган дахь бие төлөөлөгч байсан. Тэгээд дөрвөн жилийн өмнөөс гүйлгээ муутай бараагаа Шиньжаан руу тээхдээ манай нутгаар дамжин гардаг байжээ. Энэ удаа даамал өөрөө жинчдийг толгойлсон нь Цонж, Бархулд салбар дэлгүүр нээх зорилготой байв.

- Гунгааг Ойдовдаржаалин хийдээр гаргах асуудлыг найдвартай гэж үзэх үндэслэл юунд байгаа юм бэ? Нөгөө талаар Гэгээн сүм, Вангийн сүмийн аль аль нь япон цэргийн хөл үймээнд үрэгдээд одоо тэнд бараг эзгүй шахам байна. Ингэхээр хүн цөөнтэй газар очсон Гунгаа амархан сэжиглэгдэх юм биш үү?

- Энэ талаар бодож үзсэн. Синьзин буюу Чанчунд гардаг "Мансю нити нити" буюу Манжуурын өдөр тутмын сонины сурвалжлагч Тогава, Хаалганд ажлаар очихдоо Буянтын сургийг гаргаад Сюйюань (Хөх хот) рүү очсон байна. Энэ бол Буянтын хамаатан садангаас амьд үлдсэн үү, үгүй юү гэдгийг шалгасан хэрэг. Тогава хувийн сонирхлын үүднээс Аксакалтай холбогдож, түүний үймээнийг цагаатгах нэгэн өгүүлэл бичихдээ хамаг хэргийг Буянт дээр тохоожээ. Буянт үүнийг мэдсэний дараа эртний өш хонзонтой Тогаваг олохын тулд Вангийн сүмээр дамжин Синьзин (Чанчун) очих нь дөт төдийгүй бас өөрт нь ашигтай юм. Тэрээр Токиод байхдаа кэмпэйтайд алба хааж байсан учраас японы тагнуулынхантай хэл амаа ололцох бүрэн боломжтой гээд «Рожуганукай» ажиллагааны талаар тодорхой ярилаа.

- Даваг аа, Буянтыг Токиод байхад тэндхийн сөрөг тагнуулынхан нэг сонин ажиглалт хийснийг «Рожусай» мэдэгдсэнийг санаж байна уу? Буянт япон хэлээр тун цэвэрхэн ярьдаг мөртлөө нэг үгэнд орсон хоёр "ра" үеийг дуудахдаа эцсийнх нь үсгийг ла гэж дууддаг гэнэ. Энэ талаар Гунгаа юу мэдэж байгаа вэ?

- Монгол хэл аялгуунд нэг үгэнд орсон хоёр р гийгүүлэгчийн эцсийн р гийгүүлэгчийг л гийгүүлэгчээр сольж хэлдэг онцлогийг мэддэг тул өөрийгөө монгол угсаатан гэдгээ харуулахыг хичээдэг байсны онцгой чанар юм.

- За би чиний илтгэлийг сонслоо. Юу ч гэсэн удирдлагад танилцуулна. Тиймээс Гунгаад «Рожусайн баримтыг» танилцуулах хэрэгтэй. Нөгөө талаар Буянттай хамт явсан хүмүүсийн хувьд дахин яаралтай шалга! Үүнээс гадна манай газрыг Дотоод яам болгон өргөтгөх талаар яригдаж байгаа. Тиймээс бид саналаа боловсруулах ёстой. Чи өөрийнхөө саналыг бичиж өгөөрэй. Тэгэхдээ ойрын үед шүү гэлээ. Даваг ажил төрлөө даргадаа танилцуулсны дараа өрөөндөө орж иртэл Гунгаа түүнийг хүлээж байлаа.

- Гунгаа чи, Буянттай ярилцаж тодруулах зүйлээ яаж байна.

- Нэлээн ярилцсан. Одоо хэд хэдэн зүйлийг дахин тодруулах санаатай байна. Тэгээд тантай нууц түлхүүр, түүнийг тайлах хувилбарын талаар ярилцана даа.

- Маргааш хоёулаа дэс дараалан ярья. Харин одоо яндан дуугарахаас өмнө комбинат руу явах хэрэгтэй. Чи өнөөдөр дүүтэйгээ уулзаж, тэднийд хэд хонох ёстой. Алба алба гэсээр байтал амины чинь ажил хэцүүдлээ. Муу дүү чинь бараг найман жил чиний барааг хараагүй. Их санасан байна билээ. Тэгэхээр өнөөдөр очиж сэтгэлийг нь амрааж үз гэхэд Гунгаа,

- Мэдлээ. Таны тушаалыг гүйцэтгэе гэж хошигнов.

Таван цагийн яндан дуугарахаас өмнө үйлдвэрийн комбинатын банзан хашааны том хаалганы дэргэд барьсан харуулын жижиг цагаан байшингийн ойролцоо өндөрдүү нуруутай, тунгалаг махлагдуу цагаан царайтай нэгэн залуу холхихыг ажваас бидний танил Гунгаа болой. Тэрээр баруун хязгаараас ирээд хэдэн сар болсны дараа үйлдвэрийн комбинатын гутлын үйлдвэрт ажилладаг дүү Чимгээтэйгээ уулзахаар хүлээж буй нь энэ ажээ.

Үйлдвэрийн комбинатын уужим хашааны дотор талд байгаа эгнээ дөрвөн байшингийн зүүн талд цэмбэний үйлдвэр, тэгээд гутлын үйлдвэрийн хоёр байшин, хамгийн баруун талд булгаарын заводын байшин байдаг аж.

Үйлдвэрийн хашааны гадна талд хэдэн алхмын зайтай барьсан хориод гэр байгаа нь ажилчдын сууц ажээ. Тэр гэрүүдээс гарсан ажилчид харуулын дан байшингийн дэргэдүүр гарч үйлдвэр рүү алхахыг харвал оройн ээлжийн ажилчид болой. Гэтэл удаж төдөлгүй, үйлдвэрүүдийн гол дунд мөртлөө нэлээн урд руу барьсан өндөр барилгын орой дээрх дөрвөн бүдүүн яндангийн хажууд байгаа жижигхэн нарийн яндангаас уур олгойдон хүнгэнэсэн дуу цуурайтлаа. Тэр яндангийн дуунаар үйлдвэрийн байшингаас гарч ирсэн хүмүүс харуулын хаалгаар гарч гэр гэрийн зүг алхална. Хүмүүсийн сүүл хэрд харуулын жижиг байшингийн эгц өмнөх намхан байшингаас гарч ирсэн хэсэг хүмүүсийн дунд яваа тавиад насны хижээл авгай, гуч орчим насны залуу бүсгүй хоёр энэ тэрхнийг ярин гэлдэрсээр харуулын хаалганы дэргэд ирлээ. Залуу бүсгүй харуулын хаалганы дэргэд зогсож байгаа цайвар одончуу дээлтэй Гунгааг ажиглан хараад зогтуссанаа алхаагаа түргэтгэн, гүйх шахам явахдаа «Ах минь... ах минь. Гунгаа ах» гэж амандаа үглэтэл давхраатай том нүдний аяганаа нулимс цийлэгнэв. Чимгээ ахынхаа дэргэд ирээд түүнийг хүүхэд шиг хүзүүдэн авснаа мэгшиж гарлаа.

- Чимгээ... миний дүү. Битгий уйл. Ах нь хүрээд ирлээ шүү дээ. Одоо уйлаад яах вэ? гээд өвлийн хүйтэн жаварт ягаарсан хоёр хацрыг нь ээлжлэн үнсэв. Чимгээ хэсэг мэгшиж байснаа,

- Цэрэндэжид ажаа, энэ хүн чинь миний яриад байдаг миний ах шүү дээ гэж үгээ эвлүүлж ядан хэллээ.

- Чимгээ минь уйлаад яах вэ? Одоо ахтайгаа уулзсанаас хойш болох нь тэр! гэхэд тэр авгайн хоолой үл мэдэг зангирлаа.

Цэрэндэжид гэдэг энэ авгай, хорин нэгэн жилийн тэртээ хүрээнд ирээд гандан зүүн хүрээнд аврал буулгуулж, буян үйлдэхдээ эх эцгээс заяасан нэрээ Цэрэндэжид гэж сольсон нь угтаа найман зүйлийн амгалан наст гэсэн түвд үгийн утгаар бэлэгшээсэн болой.

Тэрээр ганц охиноо нутагтаа үлдээгээд ирсэн болохоор эчнээндээ охиноо үгүүлэн санахын эрхээр сэтгэлийн шаналгаанд олон жил урхидуулсан ажээ. Цэрэндэжид амьдрал ахуйгаа эргэцүүлэх тусам ганц охиноо эцгийг нь бараадуулсан явдалдаа санаа сэтгэл уужирдаг. Гэсэн ч жинхэнэ ард түмэн, засаг төрөө барилцаж, аз жаргалтай амьдардаг зүй тогтлыг ухаарах тусам охиноо нутагтаа үлдээсэндээ харуусахын эрхээр өөрийгөө зэмлэдэг удаатай болой. Учир иймээс найман жил шахам уулзаагүй ах дүү хоёрыг харсан Цэрэндэжид уйлахгүй байж

чадсангүй. Тэр гурав ойр зуурын юм хамж шимж ярьсаар үйлдвэрийн банзан хашаанаас төдий холгүй байгаа давхар цагаан байшингуудыг зүглэв. Чимгээ нүүрэн талын байшингийн баруун булан тойронгуутаа,

- Эгч ээ, та манайд орохгүй юу гэхэд Цэрэндэжид,

- Эгч нь аяар орно гээд байшингийн баруун үзүүрийн хаалгаар оров. Гунгаа дүүгээ дагасаар ажилчдын сууцны давхар байшингийн дунд хаалгаар орж, налуу модон шатаар өгстөл будагны үнэр хамар өөд сэнгэнэхийг мэдээд «Энэ намар ашиглалтанд орсон юм байх даа» гэж бодов.

- Ахаа наад шатаараа болгоомжтой яваарай. Анхандаа жаахан аягүй байдаг юм. Гэхдээ яваандаа дасчихна. Хажуугийн хашлаганаас сайн барьж яв! Толгой чинь эргэж магадгүй шүү. Буухдаа тун болгоомжтой явж байгаарай гэж жижиг хүүхдэд зааж байгаа юм шиг хэлээд «Муу ах минь боловсон ёс мэдэх биш дээ. Баруун хязгаарт хил дээр олон жил болсон хүн! Толгой нь эргээд уначих вий дээ» гэж санана. Харин Гунгаад дүүгийн нь сануулга хачин сонин санагдаад,

- Хэе яасан өндөр хайрхан вэ? Манай тэндхийн Ишгэн толгой шиг гайгүй өндөр юм байна гэж хэлсэн учрыг Чимгээ хэрхэн ойлгох билээ.

Гунгаа найман жилийн өмнө эх орныхоо даалгавраар, гадаадад гарч, улс орныхоо тусгаар тогтнолын эсрэг чиглэсэн гоминдаан, японы хорлон сүйтгэх ажиллагааг илрүүлэхийн тулд Ганьсу, Шинжаан, Өрөмчөөр явж байжээ. Чингэж нам, ард түмнийхээ даалгаврыг нэр төртэй биелүүлж, японы болон гоминдааны хорлон сүйтгэх ажиллагааг илрүүлэх үйлст хүчин зүтгэн амь өрсөн тэмцэлд хатуужиж сурсан Гунгааг хэдэн сарын өмнө

«Төв» дуудсан билээ. Тэгээд түүнийг Зөвлөлтийн, алс дорнод болон монголын зүүн хязгаар руу чиглүүлсэн квантуны армийн түрэмгий ажиллагааг илрүүлэх ажилд тохоон томилохоор бэлдэж байгаа билээ. Гунгаа хэдэн сарын турш өөрийгөө бэлтгэж, манжуурын улс төрийн байдал, японы цэргийн түрэмгий ажиллагаатай холбогдсон баримтуудыг судлан, шинжилж байсан үед «Төв» дүүтэй нь уулзуулахаар шийдэв.

Орон сууцны барилгын дээд давхрын гурван хаалганы дунд хаалгаар орсон Гунгаа өрөөний байдлыг ажвал гал тогоо, ариун цэврийн өрөөний хоёр талд нэжгээд өрөөтэй тохилог сууц байлаа.

- За ямар байна даа. Догь байгаа биз. Боловсон сууц гэдэг чинь ийм байдаг юм гэж Чимгээ омоотон танилцуулахад Гунгаа өрөө рүү шагайгаад,

- Аа мөн сайхан сууцаа гэлээ.

- Ахаа та одоо баруун хязгаар явах уу?

- Үгүй.

- Ашгүй дээ. Яасан сайхан юм бэ? Би маргааш хаминдаатай уулзаад нэг диван авч цаад өрөөнд чинь тавьж өгнө, диван гэж зөөлөн сайхан өргөн ор бий. Энэ том өрөөнд байгаа шүүгээ, ширээ, сандал чинь цөм манай үйлдвэрээс өгсөн юм. Харин би, тэр диваныг нь аваагүй. Энэ цөмөөрөө үйлдвэрийн юм. Тэгээд зогсохгүй байшингаас мөнгө хөлс авдаггүй юм шүү. Манай байшингийн зүүн талд цай хоолны халуун ус буцалгадаг тусгай газар бий. Тэндээс халуун ус авчраад энэ цахилгаан зуухан дээр тавиад болчих нь тэр дээ. Би одоохон ирнэ гээд гал тогооныхоо өрөөнөөс нэгэн гуулин данх аваад гарлаа.

Гунгаа яг арван жилийн өмнө улсын анхдугаар их хуралд төлөөлөгчөөр суухдаа Нийслэл хотыг Улаанбаатар хот гэж нэрлэснийг саналаа. Хоёр жилийн дараа Гунгаа баруун хязгаар явахын өмнө хотоор явж билээ. Харин сая хотод буцаж ирээд хотоор явахад их өөрчлөгдсөн байлаа.

Хүрээ цамын талбай дээр бөмбөгөр хэлбэртэй ногоон барилга барьсан нь Цэнгэлдэх хүрээлэн ажээ. Түүний зүүн талд оюутны сургуулийн байшин хойд хэсэгт хэвлэх үйлдвэрийн гоёмсог барилга барьсан агаад Чойжин ламын Занхан сүмийн ард байсан

Шагдар гүний хашааны буурин дээр нэгэн шинэ байшин барьсанд хуучин өргөн чөлөөнд байсан Нардомынхан орцгоож «Ленин клуб» гэж нэрлэсэн байлаа. Түүний зүүгээр хотыг захирах яам, Үйлдвэрчний төв зөвлөлийн давхар байшин барьжээ. Сэцэн хааны хорооны ар тал Гоожингийн өндөр байшингийн баруун талд нэгэн байшин барьсан агаад зүүн талд засгийн газрын байшинг барьсан байв.

Гунгаагийн сэтгэлийг татсан нэг зүйл бол Туулын хойд эрэг, Гунгаадэжидийн сүмийн ар талд байгуулсан үйлдвэрийн комбинатын барилгууд билээ. Энэ комбинат ашиглалтанд ороод хэдэн сар болжээ. Гунгаа чингэж эрт өнгөрснийг бодож байтал гаднаас Чимгээ орж ирлээ.

Гунгаа хуучин засаг хошуугаараа бол Сэцэн хан аймгийн жонон вангийн нутгийн хүн. Эцэг нь хөвчийн жонон вангийн хошуу төдийгүй халхад алдартай мужаан шидэт Дархан номч Гүр гэгдэж явсан болой. Гунгааг хорьтой, Чимгээг арван зургаатай байхад эх нь таалал төгсчээ.

Гүр дархан Эрдэнэ зуугийн Ригсүмгомбын сүмийн мянган минтүб, Их хүрээний Шаравпилжээлин, Занхан сүмийг барихад оролцож, Богд хаанаас шидэт дархан, номч цол хүртжээ. Гүр дархан гадангийн дашчойпил дуганыг засах ажилд оролцож, хүрээнд ирэхдээ Гунгааг дагуулсан билээ. Тэгэхэд Гунгаа ердөө есөн настай байв. Гүр дархан Гунгааг богдод мөргүүлж, хүрээ жасаанд суудаг нэгэн танилынхаа тусламжтайгаар хүрээний манж, хятад бичгийн сургуульд оруулсан билээ.

Гунгаа сургуулиа төгсөөд амбан яамнаа тал бичээч (дагалдан) гурван жил хийгээд бичээч болсон. Энэ үед манж амбан хөөгдөөд байсан үе байлаа. Тэгээд Богд хаант улсын гадаад яамнаа эх зохиогч болжээ. Чингэтэл түүнийг түүх шастир зохиох ажилд тохоон томилов. Чухам энэ үед хэвлэх үйлдвэрт ажиллаж байхдаа сэцэн хаан аймгийн ёст бэйсийн хошууны Баатар (Сүхбаатар) гэгчтэй танилцжээ.

Тэгээд гаминг хүрээнд ирэнгүүт нутагтаа очиж амьдарсан байтал Хүрээнд ардын засаг тогтсоныг мэдээд хүрээнд ирж Сүхбаатартай уулзаад учир байдлыг мэдэнгүүт цэргийн

яамнаа ажиллав. Тэрээр монгол, хятад манж бичигтэй төдийгүй япон хэл гадарладаг болой. Чингээд дотоодыг хамгаалах газрыг байгуулахад тийшээ шилжсэн билээ.

Харин Чимгээ энэ хугацаанд намын төв сургуульд сурч төгсөөд нутагтаа очиж, эвлэлийн товчлох хороонд ажиллаж байгаад үйлдвэрийн комбинатын ажилчин бэлтгэх элсэлтээр хот ирж улмаар Зөвлөлтөд явж сургууль хийж ирээд эдүгээ эд шалгагчаар ажиллаж буй. Ах дүү хоёр тэр шөнөжингөө ярьсаар үүр цайхын өмнө унтжээ.

Тэгээд өглөө оройтож босоод, хэн хэнгүй сандарч ажил руугаа явцгаалаа. Үүнээс хойш Гунгаа хэд хоног манжуурт Рожусай гэдэг товлосон нэрээр ажиллаж буй нэгэн хүнээс ирүүлсэн баримттай танилцав. Гунгаа, улс эх орныхоо эсрэг чиглэсэн японы түрэмгийлэгчдийн болон гоминдааны хорлон сүйтгэгчдийн үйл ажиллагааг илрүүлэх зорилготой үл таних нөхрийнхөө явуулсан баримтыг үзээд түүний үйл ажиллагаанд биширлээ. Гунгаа хөндий иштэй тамхиа асаангуут өмнөө дэлгэсэн тусгай баримтын хавгаст материалыг уншаад өөртөө зайлшгүй хэрэгтэй зүйлийг сэтгэлдээ тэмдэглэн тогтооно.

"ДОХАГА"-д. Японоос цэргийн тусламж гуйхаар ирсэн шадар Дорж, Жан-Золингийнхонд баригджээ. Тозияа түүнийг суллуулахаар хөөцөлдөж байна. Хүрээнд байгаа төв нь Бат-Оршил хэмээх нэртэй аж. Рожусай. 1923. XII. I

"ДОХАГА"-д. Их хүрээний Готов, Харбин дахь цагаантны товчоогоор дамжуулан японоос тусламж гуйхаар иржээ. Харбин дахь японы цэргийн төлөөлөгчийн газрын тэргүүн генерал Хато, Готовыг сонирхож, хүрээнд гаргуулах бослогын төлөвлөгөөний дагуу ашиглахаар шийджээ. Рожусай. 1924 X. 15.

"ДОХАГА"-д. Харбины худалдаачин Боронцов, Азийн Та да хэмээх загасны пүүстэй хоршиж Буйрт загасны үйлдвэр байгуулах талаар нууц хэлэлцээ хийх зорилготой байна. Пүүсний эзэн Хан Инсү, монголыг японы арми эзэлсний дараа асуудлыг шийднэ гэдэг нэрийдлээр хойшлуулах янзтай. Цагаантнууд 1925 онд Монгол руу довтлох төлөвлөгөө зохиосон. Гэтэл японы цэргийн яам үүнийг хойшлуулсанд цагаантны дүрвэгсдийн товчоо дургүйцэж байна. Рожусай. 1925. IV. 19.

"ДОХАГА"-д. Доихарагийн санаачилгаар Банчин эрдэнийг

монголын хилийн ойролцоо суулгах асуудлыг квантуны арми чухалчилж байна. Тозияа Банчин эрдэнэтэй холбоотой байж, Санбэйс, Алтан-Очирт, Хамба, Егүзэрийн хийдийн лам нартай холбоотой байхыг чухалчилж байна. Рожусай. 1925. XII. 26.

"ДОХАГА"-д. Японы цэргийн яамны эрдэм шинжилгээний төвөөс алс дорнодын эдийн засгийн баялаг, нөөцийг судлахаар Сева хэмээх нийгэмлэг байгуулсан. Энэ нийгэмлэг азийн улсуудаас олох эдийн засгийн үр ашгийг тооцоолох бөгөөд тэгснээрээ квантуны армийн ирээдүйн зорилтыг тодорхойлох болно. Рожусай. 1926. VI. 15.

"ДОХАГА"-д. Танака, сайд нарын танхимыг толгойлсны дараа эзэн хааны кодо зарчмыг азид дэлгэрүүлэх төлөвлөгөөг боловсруулж хаанд барилаа. Энэ төлөвлөгөөгөөр Хятад, түвд, энэтхэг зэргийг оролцуулсан асар уудам нутагт японы эзэн хааны төлөвлөгөөгөөр эзэмшил

тогтоох ёстой. Үүнийг боловсруулахдаа 1905 оны Портсмутын хэлэлцээ, 1915 онд манжуурт тулгасан 21 зүйлийн шаардлага, 1919 онд боловсруулсан Нармай монгол улсыг байгуулах төлөвлөгөөг харгалзсан байна. Энэ төлөвлөгөөний гол зорилт бол Зүүн умард хятад, манжуур, алс дорнод, монголыг оролцуулан Мансю Сибири гэдэг нэгдсэн улс байгуулахад чиглэжээ. Рожусай. 1927. XI. 66.

"ДОХАГА"-д. Японы ноёрхлыг манжуурт тогтоох явдалд саад болж байгаа Жан Золиныг устгах төлөвлөгөөг Ермиги Сузуки боловсруулсан бөгөөд хурандаа Комото, Тозия нар удирдах юм. Нууц ажиллагааг Хар төмөр гэж товлосон бөгөөд ирэх 6 сарын эхээр хэрэгжүүлэх ёстой. Рожусай 1928. IV. 20.

"ДОХАГА"-д. Японы зөвлөхүүд Дайранд цугларч, Семеновынхонтой уулзаж СИБАИЛЕН гэдэг төлөвлөгөөтэй танилцлаа. Цагаантнууд Якутыг эзлээд, Лен мөрнөөр Байгаль руу нэвтэрч Сибирийн төмөр замыг таслан авсны дараагаар монгол руу довтлох төлөвлөгөө зохиов. Японы цэргийн мэргэжилтэнгүүд энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагааг хойшлуулсан явдлыг японы арми манжуур руу чиглүүлсэн ажиллагааг үр дүнд хүргэсний дараа хэрэгжүүлж магадгүй гэж үзэж байна. Рожусай. 1931. IV. 9.

Гунгаа «Рожусайн» баримттай танилцах тусам түүний гүн

мэдлэг, нарийн ажиллагаанд биширнэ. Рожусай, японы сайд нарын танхим, хөрөнгөтний намуудын зөрчил, цэргийн нууц нийгэмлэгүүдийн үйл ажиллагаа хаашаа эргэхийг арван хуруу шигээ мэддэг байв. Тиймээс Рожусайн баримтаас манжуурт байгаа квантуны армийнхан монгол руу ямар хорлон сүйтгэх ажиллагаа явуулж, ямар хүмүүс түүнийг удирддаг болохыг илрүүлсэн нь Рожуганукай ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхнийг тодорхойлох ажээ. Гунгаагийн анхаарлыг татаж их юм ойлгуулсан ба, римтан дотроос 3 сарын өмнө явуулсан баримт сонирхолтой байлаа.

«Квантуны армийн штабын дарга Итагаки, хээрийн цагдаагийн газрын дарга Тозио нараас жанжин штаб руу нууц материал илгээв. Үүний гол агуулга бол ирэх жил Халхын сүм орчмоор ямар нэгэн өдөөн хатгалга хийхээр төлөвлөсөнтэй холбоотой. Тэдний төлөвлөгөөгөөр бол Халхын сүм, Буйр, Тамсагийг Баргын найман хошууны нутаг гэдэг зохиомол баримтыг ашиглан, гүтгэлэг хийхэд чиглэсэн байна. Үүнтэй холбогдуулж, квантуны армийн удирдлага, Жан Золингийн үед боловсруулсан хуурамч баримт бүхий зүйлийг үндэс болгож, тусгайлсан хэсэг зохион байгуулах төлөвтэй байгаа юм. Энэ хэсэг монголын газар нутгийг гойд сонирхох зорилготой гэдэг нь батлагдсан. Рожусай. 1934 он V сарын 5.

Гунгаа Рожусайн баримтуудыг манжуурын цаг үеийн байдалтай холбон судалж, Чан Кайши болон Жан Сюэляны улс төрийн бодлоготой харьцуулж үзэв. Тэгээд Буянтын амьдрал ахуй, сүүлийн үеийн болон Токиод байхдаа гаргасан зан чанарын онцлогуудыг дахин нягталж үзлээ.

Буянт бол Суйюань (Хөх хот) хотын багашигхан худалдаачны гэр бүлд төрсөн эдүгээ гучин долоон настай, эхнэргүй хүн. Тэрээр Токиогийн их сургуулийн хуулийн ангид суралцаж байхдаа хотын цэнгээний газраар их сэлгүүцдэг байжээ. Энэ нь японы кэмпэтай буюу сөрөг тагнуулын газрын анхаарлыг татаж билээ. Тэгээд аажимдаа хүний ул шагайх, хошуу худалдах,

хорлон сүйтгэх, галдан шатаах, өндөр хөлсөөр хүний өш хонзонг авах ажилд түүнийг сургажээ. Буянтын эцэг, хүүгээ бүтэлгүй замаар орсныг мэдээд сэтгэл зовж, сүүлийн үед садар самуун хүүхнүүдийн «хормой сахих» дон шүглэсэн хүүдээ захиа бичсэн боловч янхан хүүхнүүдтэй сүүж холбосон хүү нь биеэ татаж авсангүй. Тэгээд танил нөхдийн тусламжтайгаар хүүгээ авчруулсан боловч замаа алдсан хүүд өөрчлөлт гарсангүй. Нас өндөр болсон эцэг, хүүгийнхээ байдалд сэтгэл шаналж, олсон цуглуулсан хэдийг нь хорзонд сэгсэрч, мод бариулахад хүрсэн явдалд харамссаар насан өөд болжээ. Харин Буянт японы цэрэг Жэхэ, Хэбэй мужид суурьших болсныг мэдээд эрийн жолоог манжуур руу залахаар шийдтэл сохор зоосгүй болсон байлаа. Чухам энэ үед Хаалганаас Цонж орохоор гарсан жинчдийн сургийг дуулангуут гурван нөхрийн хамт их замын дээрэмд гарав. Буянт, тэдний мөрөөр бэдэрч, монголын хилийн орчим буусан жинчдийг гүйцэн очиж даамалтай уулзлаа.

— Жинчин ахаас гуйх яльгүй зүйл байна. Би Шинжаан бараадах бодолтой явна. Гэтэл зам мэдэхгүй, бичиг баримтгүй болохоор мухардлаа. Та биднийг өөрийнхөө жинчний бүрэлдэхүүнд оруулж хил гаргаж өгөхгүй юу. Би Шинжааны хилд очингуут ацаг хөлсийг чинь өгнө. Одоо урьдчилгаанд үүнийг өгье гээд зуун янчаан гаргаж барьжээ. Жинчдийн даамал угийн хашир, юмны өөг үгний ээдрээнээс олж чаддаг болохоор Буянтын эчнээнийг үг яриагаар нь мэдээд,

- Ай даа хэцүү юм. Газар сайгүй дайн дажин дэгдээд, хүн амьтныг амар тайван ч байлгахгүй. Яасан хэцүү цаг үе вэ? Биднийг Шинжаан рүү гарахыг сонссон хэд хэдэн хүн дагуулж явахыг гуйж билээ. Би тээршаагаад ганцыг нь ч авч гараагүй юм. Одоо алийн болгон хүн гомдоох вэ? Ах нь аваад явья гэж зөвшөөрчээ. Чингээд жингийн даамал хил гарангуут монголын гаалийнхантай уулзаж, дагаж яваа хүмүүсийнхээ учир байдлыг хэлснийг Буянтын гурван найз гадарлажээ. Гэвч тэд энэ бүхнийг Буянтад хэлсэнгүй. Харин түүнийг архинд согтоож унагаад, өөрснөө оргохдоо монголын хилийнхэнтэй зам зуур тааралдаж, эсэргүүцсэнээр амь алджээ,

Буянт хар архинд согтож, халуун наранд цохиулсан болохоор нойрноосоо сэрээд гараа хөдөлгөхдөө гавлуулснаа мэдэв. Ингээд хилийнхэнд баригдаж, харин жинчингүүд Алшаагийн элсийг тойрч, монголын хилээр зам товчлон явж, монголын хилээс гараад Шинжаан руу орохдоо зам отоож байсан Аксакалынхантай дайралджээ.

Гунгаа, Буянтын мэдүүлгийг нарийвчлан судлаад шалгах зүйлээ нягталсны дараа түүнтэй дахин уулзлаа.

- Буянтаа таны үерхдэг хүмүүсийн талаар лавламаар зүйл байна. Би мэдэхгүйдээ асууж байгаа юм биш. Энэ бол таны хэргийг хөнгөлөхөд зохих ёсны нөлөө үзүүлэх зүйл. Тиймээс та үнэнээ хэлэх ёстой гэхэд,

- Би та бүхэнд үнэнээ ярина гэсэн болохоор миний үгэнд итгэх байх гэж бодож байна. Одоо надад нуух юм байхгүй гэж Буянт хэллээ.

- Таныг манай хилийнхэнд алагдсан тухай Тобава гэдэг хүн Мансю нити нити гэдэг сонинд бичсэн нэгэн өгүүлэлдээ дурджээ. Үүний учрыг та хэлж өгөх ёстой юм гээд Гунгаа сониноос авсан хайчилбараа Буянтад өглөө.

...Бээжин түншийн пүүсний Ляо Байны жинчдийг хүлээн авч өвөрмонгол Шинжаанд алдаршсан дээрэмчин Хар чоноос хамгаалах ёстой Аксакалынхан болсон газраа хүлээж байлаа. Гэтэл монголын хилийн зүгээс гэнэт буун чимээ гарчээ. Учир байдлыг тодруулахаар Аксакал тэр зүг рүү очив. Жинчидтэй хамт явсан Буянтын нөхөд Аксакалын бараанаар монголын хил рүү эргэж зугтахдаа зэвсэг хэрэглэсэн учраас монголын хилийнхэн түүнийг газар дээр нь нам буудсан байлаа....

Буянт үүнийг уншаад уруулаа хэмлэх нь түүний эчнээний хорсол оволзож байгааг гэрчилнэ.

- Энэ яахав. Амисээд нэр нүүр олох гэсэндээ бичсэн хэрэг. Хокухонся, төрийн үндэс нийгэмлэгийн муу бэлтрэг, хүний шаар гэж үглээд шүдээ заналтайгаар хяхтнуулав.

- Буянгаа, энэ өгүүллийг бичсэн хүн та хоёрын хооронд ямар нэг холбоо байгаа. Гэтэл тэр тухай мөрдөн байцаалтанд өгсөн мэдүүлэг, өөрийн чинь тодорхойлтонд байхгүй байна. Энэ бол таныг улс төрийн ямар ч зорилгогүйгээр манай хилд орж ирснийг батлах баримтын нэг болох юм гэхэд Буянт сонины өгүүллийг уншаад оволзсон уураа барьж, хэсэгхэн зуур эрүүгээ базалж байснаа,

- Өнгөрсөн хавар сакурайн интоорын баяраар Токиогоос нэг эмэгтэй захиа бичихдээ Тогавааг мансю нити нити сонинд ажиллаж байгааг мэдэгдсэн юм. Энэ бол жирийн нэг зүйл биш байлаа гээд Буянт ширээн дээрх тамхинаас авч асаагаад хэд хэд хүчтэй сорж угааг нь ам хамраараа савсуулан яриагаа үргэлжлүүлэн алгуурхан ярина.

...Арван жилийн тэртээ Токиогийн нэг том цэцэрлэгт сакурай интоор цэцэглэхийг үзэхээр очихдоо Амисэтэй танилцсан юм. Түүнээс хойш бид хоёр хааяа дайралддаг байсан. Сүүлдээ өдөр бүр уулздаг боллоо. Тэгээд оройн цагийг Токиогийн цэнгээний газар өнгөрөөж байв. Нэг орой бид хоёр нэг томоохон зоогийн газар сууж байтал намхандуу нуруутай малигар цагаан залуу орж ирээд Амисэтэй уулзаж сүйд боллоо. Тэр хүнийг ширээндээ урьтал Амисэ дургүйцээд «Чи миний найзтай танилцах уу?» гэж шазруухан хэлж билээ. Тогава надтай анх ингэж дайралдсан юм. Түүнээс хойш сар болоод бид хоёр уулзсан. Тэр үед Амисэ, Киото руу явчихсан байлаа...

Тогава, тэр уулзалтаас хойш Буянтын мөрийг шиншилж, хаана сурдаг, ямар хүмүүстэй үерхдэг, зан чанарын сул талыг хүртэл ажиглажээ. Тэгээд Амисээг Буянтаас холдуулахын тулд эцгийнхээ хамаарагддаг Хокухонся төрийн үндэс нийгэмлэгийн нууц ажиллагаанд оролцдог хэдэн залууст хахууль өгч гарыг нь цайлгаад Буянтыг зааж өгчээ.

Буянт нэгэн удаа зоогийн газар сууж байтал хэдэн залуус орж ирж түүний ширээнд суулаа. Тэд нар ерийн байдлаар танилцахдаа өөрсдийгөө цэргийн сургуулийн оюутнууд гэлээ. Түүнээс хойш Буянт тэдэнтэй үе үе дайралдаж, заримдаа токиогийн цэнгээний газраар ордог болов. Харин тэд Буянттай цэнгээний газар орохдоо сохор зоос төлүүлдэггүй байлаа. Нэг өдөр тэдний нэг нь Буянттай уулзаад "Буянгаа бидэнд хичээж тус болж үз! Бид өчигдөр жаахан наргиад нэг хүнтэй гар зөрүүлчихсэн чинь буруудаад байна. Цагдаагийн газар баригдаад таван мянган иений торгууль төлөхөөр болсон. Чи хүнээс зээлээд ч гэсэн өгөөч. Би ердөө гурав хоногийн дараа өгнө» гэж шалаад байхаар нь эцгийнхээ танил нэгэн худалдаачнаас зээлээд өгчээ. Тэр өдрөөс хойш тэдний хэн нь ч үзэгдсэнгүй арваад хонотол

цагдаагийн газраас Буянтыг дуудаж, шоронгийн оргодлуудыг мөнгөөр хангасан гэдэг ял тулгав...

- Би японы сөрөг тагнуулын газар кэмпэйтэйнхны гарт орсон юм. Тэгээд Аяанаосу гэдэг нэрээр кэмпэйтэйд мэдээ дамжуулдаг болсон. Аяанаосу гэдэг нэр бол аямори о наосу буюу алдаагаа засагч гэдэг үгнүүдийн эхний үеийг нийлүүлж хочилсон хэрэг юм. Надад өөр зам байгаагүй. Яагаад гэвэл гэмт хэрэгтнүүдийг оргуулсан учраас нэг бол шоронд орох, нэг бол тэдний даалгавраар ажиллаж, нөгөө залуусыг олж барих ёстой байсан. Би тэднийг олж барих гэсэн боловч чадаагүй юм. Харин кэмпэйтэйнхан оргодлуудыг олох нэрийн доор надаар өөр зүйл хийлгэж байлаа. Би гэмгүй хүмүүсийг гүтгэх, хутган үймүүлэх баримт цуглуулах, өш хонзонтой хүмүүсийн өшөө хонзонг ацаг хөлсөөр авах зэрэг муу муухай бүхнийг сурч эхэлсэн.

...Буянт «Аяанаосу-алдаагаа засагч» гэдэг нэрийн доор чингэж ажиллаж байхдаа, Тогаватай хэд уулзсан. Тогава Буянтын байдлыг, мэдэнгүүт Амисээд сээтэн хаях дуртай нэг хөгшин баянд Буянтын тухай дуулгажээ. Токиогийн томоохон баянд ордог тэр хөгшин Амисэтэй уулзаад Буянт ямар замаар орсныг ярьж, хэнтэй зуузай холбох болсныг дуулгажээ. Түүнээс хойш Тогава, Амисэгийн хойноос гүйж, чаргуулдах ажлаа хүчтэй болгож, Буянтад гомдон цөхөрсөн хүүхний сэтгэлийн шаналгааг ашиглан өөртөө татжээ. Чингээд Тогава, Амисэтэй суусны дараа түүнийг Токиогоос холдуулахгүй бол аюултай гэдгийг ойлгов. Тогаваад дайсагнах хүн цөөнгүй ажээ. Нэг талаас үйлдвэрийн хөгшин эзэн, шинээр бий болж байгаа цэргийн эвсэлд талтай тул тагнуулын газраар дамжуулан өш хонзонгоо авч болох ажээ. Нөгөө талаар Буянттай олон удаа дайралдвал Амисэтэй суусныг мэдмэгц нүд ирмэхийн зуур хорвоогоос Тогавааг танилгох байлаа. Иймээс Тогава, эхнэрээ ятгаж Осака хотод суухаар шийджээ.

Амьдрал ахуйн явцад Амисэ, нөхрийнхөө бузар булайг мэдээд Буянтыг сэтгэлдээ өрөвдөж, Тогаваад өширхөх болсныг тэрээр гадарласангүй. Амисэ амьдралын явцад тухайн үед ямар хуйвалдаан болж, Буянтыг ямар байдалд оруулсныг цэргийнхэнд нэр хүндтэй болсон хөгшин баяны холбоочингоос мэдээд Токио орж Буянтыг сураглалат тэрээр нутаг буцсан байлаа. Чингээд Амисэ өөртөө сайн байдаг хөгшний нууц хүмүүсээр дамжуулж Буянтыг сураглуулжээ.

Үйлдвэрийн эзэн хөгшин, Амисээг өөртөө татах эгзэг гарсанд олзуурхан түүний хүсэлтийг биелүүлэхийн тул Сюйюаньд байдаг танил худалдаачингаар дамжуулж Буянтын сургийг гаргажээ. Цэргийн үйлдвэрийн эзэн өөртөө орж ирсэн баримтуудыг хянан нягтлаад Амисээд ний нуугүй танилцуулахаар шийдэв. Учир нь Буянт нутагтаа очоод «хүний адаг» болсон болохоор энэ бүхнийг дуулсан Амисэ Буянтаас холдоно гэдэгт итгэж байлаа. Чингээд Буянтын талаар багагүй мэдээ цуглуулсан Амисэ, хөгшин эзэнтэй ойртож, түүнтэй хэдэн зүйлийн болзол тавьж, Сюйюань хот руу явж өөрийн нүдээр үзье гэж гуйжээ. Тэгээд Амисэ, Хөх хотод нууцаар ирж Буянтын ахуй байдлыг нүдээр үзээд явахдаа нэгэн захиа үлдээж, Тогавааг «Дайран симбун» сонинд ажиллахаар Гуаньдун руу явсныг мэдэгджээ. Ингээд Амисэ, Тогавагаас салж мөр мөрөө хөөсөн билээ. Буянт энэ бүхнийг Амисэгийн захианаас олж мэдсэн болохоор Гунгаад дэлгэрэнгүй ярьж өглөө. Тэрээр ингэж ярихдаа ширээн дээрх тамхинаас авч угсруулан татахдаа уур хилэн, атаа жөтөө, сэтгэлийн бухимдлыг

тайтгаруулахыг хичээж байлаа.

- Амисэ амьдралын гачаал зовлонгийн эрхээр үйлдвэрийн эзэнтэй суусан нь алсын бодолтой байсан бололтой. Түүний захиаг уншихад хэзээ нэг цагт өөрийнхөө амьдралыг тарамдуулж, бие сэтгэлийг нь бузар санаандаа ашигласан Тобавааг чадах гэсэн бодолтой байсан нь илэрхий байсан. Ноднин сакурайн баяраар надад бичсэн захиандаа Тобавааг Синьзинд сууж «Мансю нити нити» сонинд ажиллах болсныг надад мэдэгдсэн нь угтаа өшөө хонзонгоо аваарай гэсэн анхааруулга байсан юм гээд Буянт тамхиа хүчтэй сорж, утааг нь залгилаа. Гунгаа, Буянттай ийнхүү ярихдаа Токиогийн сөрөг тагнуулын газрын ямар ажилтантай үерхэж, үдэш оройн цагийг яаж өнгөрөөж байсныг магадалсан төдийгүй ямар багшаар жиүдиүцү, кэндо (кэнжиүцү сэлэм эзэмших ёс) заалгаж байсныг асуулаа.

- Тэр үед надад хоёр хүн жиүдиүцү, каратэ заадаг байсан. Үнэндээ түүнийг сурах сонирхол тэр үед надад байгаагүй болохоор кэмпэйтэйхан намайг аажимдаа зайлуулах юмуу, тонилгох янзтай болсныг мэдээд эцэг минь Токиогийн худалдаачдын дунд алдаршсан танилуудынхаа тусламжтайгаар эсэн мэнд салгаж авсан юм. Нутаг буцахынхаа өмнө Тобаваатай нэгэн зоогийн газар санамсаргүй дайралдсан. Тэгэхэд чамбайхан халчихсан явсан болохоор би уураа барьж чадалгүй цохиж унагачихаад цагдаагийн газар хүргэгдэж билээ.

...Буянт тэр оройг буудлын зоогийн газар өнгөрөөхдөө энэ буудалд хээл хахууль өгч Амисэтай хамт хоргодож байснаа бодож суутал Тобава гаднаас хэсэг залуустай орж ирлээ. Буянт, Тобавагийн барааг харангуут уур омог нь гэнэт бадарч, хамаг бие нь салганан чичирлээ. Буянт түүнийг харангуут нүд нь хорсох шиг санагдсан тул сэтгэлээ барьж чадалгүй ширээнээсээ босжээ. Тэгээд янжуураа зууж, хөмсгөө зангидсан харцаар Тобавааг ширтсээр түүний дэргэд очоод хүйтнээр инээмсэглээд,

- Тобава сан, чи бид хоёр энд уулздаг байжээ. Та бид хоёр анх энд танилцсан. Салахдаа бас эндээс тангараг тасрах ёстой байж гээд Тобавааг заамдан өөр рүүгээ таттал тэрээр суудлаасаа босож,

- Энэ чинь юу болж байнаа? Та минь ээ намайг үүнээс салгаад өгөөч гээд нөхөд рүүгээ харах тэрхэн үед Буянт зангидсан нударгаараа элгэнд хүчтэй буулгаж, ухаан балардан тонгойход нь хоёр гараа зангидан дагз руу нь буулгажээ. Чухам энэхэн үед Тобавагийн нөхөд Буянт руу дайрахад тэрээр кэмпэитайд сурсан эрдмээ ашиглан, каратэгийн оновчтой цохилт, хурдан хөдөлгөөнөөр замдаа тааралдсан бүхнийг «намалдаглаад» зоогийн газраас гартал цагдаагийнхантай улаан халз тулгарлаа. Буянтыг цагдаагийн газар авчиртал аз болж өөрийнхөө багштай дайралджээ. Багш нь зоогийн газар болсон явдлыг төдий их ойшоогоогүй учраас Буянтыг төлбөр ялбаргүй явуулсан болой.

Гунгаа ийнхүү Буянттай хэд хэдэн удаа уулзсаны дараа түүний зан чанараас түргэн уур, өширхдөг атаач чанар, өөрийгөө аврахын тулд юу ч хийж чаддаг шийдмэг атлаа бузар араншин, каратэ, жиүдиүцүгийн дадсан цохилт, барьц, булталтыг хүртэл нарийвчлан судлав. Чингээд бэлтгэл гүйцсэн тул Давагт ажил төрлөө илтгэлээ. Гунгааг хилийн чанадад явуулах ажлыг удирдаж байгаа Даваг, Буянтад холбогдох бүх баримтыг шалгасны дараа нэг зүйлд сэтгэл зовно. Японы цагдаагийн газар болон тагнуулынхан Буянтын нэрээр манжуурт очих ёстой Гунгааг баривчилсны дараа холбогдох зүйлийг өөрийн хэмжээнд тодруулаад Синьзин

дэх квантуны армийн тагнуулын удирдлагад явуулах нь гарцаагүй. Ялангуяа Тогавагийн өгүүлэл хуурамч болохыг мэдсэн тагнуулын газрынхан, Буянтын нэрээр очсон Гунгааг шалгасан баримтаа нотолгоотой болгохын тул Токиогоос Амисэ болон сөрөх тагнуулын газрын хоёр багшийг Синьзинд дуудаж ирүүлэх үү гэдэг асуудал Давагийг шаналгана. Тогава, Буянттай уулзаагүй арав гаруй жил болж байгаа болохоор түүний царайг танина гэдэг эргэлзээтэй. Тэр хоёр тоотойхон уулзсан болохоор Буянттай царай зүсээр ойролцоо, нуруу биеэр тун адилхан Гунгааг сэрдэх сэжиг гарахааргүй. Гарсан ч гэсэн сөрөг арга хэрэглэж болно. Харин Амисэтэй Буянтыг нүүрэлдүүлбэл яах ч аргагүй болно. Иймээс Даваг үүнийг нарийвчлан бодсоны дараа Гунгааг аврах хоёр хувилбар гаргалаа. Давагийн энэ хоёр арга нь «Рожуганукай» ажиллагааг хүндрүүлэх нь эргэлзээгүй. Гэхдээ тухайн нөхцөл байдал Гунгаад ашигтайгаар эргэвэл хоёр дахь аргыг хэрэглэхэд «Рожуганукай» ажиллагааг унагахгүй онцлогтой. Харин хэрэг явдал хэцүүгээр эргэвэл нэг дэх аргыг хэрэглэж, Рожуганукай ажиллагааг зогсоож Гунгааг аврах нь ашигтай. Даваг өөрийнхөө боловсруулсан хоёр аргыг хэрэглэх нөхцөлийн талаар Гунгаатай ярилцаж, нарийн ширийн зүйлийг нягтлан тухайн үед хэрхэн хэрэглэхийг Гунгаад зөвлөөд,

- Амисэ, токиогоос ирж нүүрэлдвэл нэгдэх аргыг хүч хэрэглэж, Рожусайн ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд Рожуганукайг нууцлах боломж гарах нөхцөлтэй. Хэрэв ийм байдалд өртөхгүй өнгөрвөл байдлыг сайн шалгаад, Харбинд суурьшиж мухлаг нээж ажиллах нь илүү тохиромжтой. Мухлаг нээсний дараа сэжиглэх гойд зүйлгүй болсон үед Харбины цаг сонинд нөгөө зарлалаа нийтлүүл. Чамтай даавууны наймаачин өөрөө очиж, уулзах ёстой. Рожуганукай ажиллагааг тэр хүн удирдана гээд нууц дохио, сорих түлхүүрийн дэс дарааллыг хэлж өгтөл Давагийн ширээн дээрх утасны хонх жингэнэж тэдний яриаг тасалдуулав.

Хоёр. Ацаг хөлсний үнэ цэнэ

Хөх гахай жил буюу 1935 он. Токиод байдаг гадаадынхан шинэ жилийг их нүргээнтэй өнгөрөөлөө. Шинэ жил өнгөрөөгөөд японы гадаад яам «Хиротогийн гурван зарчим» гэдэг асуудлыг боловсруулав. Энэ нь японоос хятадын улс төрийн харилцаанд тавих хяналтыг их гүрнүүдээр зөвшөөрүүлэх, Япон-Хятад-Манж го гурван улсын эвсэл байгуулах, Манжуурыг улаан хятадын нөлөөнөөс хамгаалах улс төрийн холбоо байгуулах эдгээр гурван асуудал байлаа.

Японы жанжин штаб, дорнод хятадын төмөр замыг худалдан авахыг Окадагийн танхимд тулгахдаа Зөвлөлтийн талаас тавьсан болзлыг үнэ буулган хямдруулах явцад 150 сая иень буюу 50 сая доллараар худалдан авахыг тулган шаардлаа. Чухам энэ үед японы тагнуулын байгууллага монголын нутгийн гүнд судалгаа хийх, хилийн дагуу засмал болон төмөр зам тавих асуудлыг нарийвчлан, цэргийн болон тагнуулын нисэх онгоцны буудал байгуулах газруудыг сонгох, монголын нутаг дэвсгэрийн байр зүйн, зураг боловсруулахад шаардлагатай баримтыг хэрхэн бүрдүүлэх талаар ярилцаж байлаа.

Юки, Тозияагийн ятгалга, эцгийнхээ гэрээслэлийг бодоод Токиод ирж, их сургуулийн дорно дахиныг судлах ангид орсноос хойш гурван жил болов. Харин сүүлийн хоёр жил Токиогийн кэмпэйтэйд ажилладаг, Тозияагийн танилуудтай танилцаж, хааяа тэндхийн сургуулиар очдог боллоо. Чухам чингэж кэмпэйтэйнхан Юкитэй холбоо тогтоосон нь Тозияагийн гаргасан уран арга болой. Тозияа, кэмпэйтэйнхантай холбоотой болсон Юкийд нэг өдөр захиа бичлээ. Тэрээр захиандаа «Охин минь би чамд багагүй сэтгэл зовох юм. Заримдаа ямаршуухан яваа бол гэж боддог. Чи түүхч болсны хэрэг байна уу даа! Миний бодлоор бол чи өөрийнхөө хөрөнгийг болон өөрийгөө элдэв оролдлогоос хамгаалдаг арга ухаан сурсан дээр! Чи надад хэдэн удаа биеэ хамгаалах эрдэм сурья гэж хэлсэн боловч Мугдэнд мэргэжлийн хүн ховор учраас чамд багш олж чадаагүй юм. Харин одоо каратэ

сурах боломж чамд бүрэн бий. Юки минь чамтай уулзахаар Акасай гэдэг эмэгтэй очиж магадгүй. Чи минь банкны талаар мэдлэгтэй байхын тулд сонирхсон зүйлээ нөхрөөс нь асууж лавлаж байгаарай. Түүний нөхөр Сайто гэдэг хүн Нихон гингоод ажилладаг юм...» гэсэн байлаа.

Тозияагийн захиаг авснаас хойш арваад хонож байтал насаар гучин хоёр гуравтай болов уу гэмээр тун царайлаг, бие нуруу тэгш, царай үзэсгэлэнтэй, гоолиг хүүхэн ирж Юкитэй танилцсан нь өнөө Акасай байлаа. Чингээд Юки, Акасайтай үерхэх болж, үдэш оройд Токио дахь цэргийн нийгэмлэгийн үдэшлэг уулзалт, цуглаан дээр очиж, заримдаа цэнгээний газраар орж, харин залхуурсан үедээ байрандаа шигдэж, японы эртний түүхийн зохиолууд уншиж, хятадын түүхэн судар шагайж нүдээ чилээнэ.

Юки, японы бичиг соёлын түүхийн харилцааны асуудлаар хоёр илтгэл бичих даалгавар багшаасаа авсан болохоор япон, хятад хэлний бичиг үсгийн харилцааны талаар судалгаа хийхдээ эртний япон хэлний үг зүй, хэл зүйн байгуулал нь худам монгол бичгийнхтэй тун ойролцоо байсан нь түүний сонирхлыг татлаа. Тэгээд япон бичиг үсгийн түүхийг мөшгив. Юки, сүүлийн хоёр жил японы хэл, түүхэнд холбогдолтой «Козики-эртний хэрэг явдлын

тэмдэглэл», Манъёсиу-түг түмэн баримтын эмхтгэл», «Фудоки-газар ус, зан заншлын тэмдэглэл», "Тайхэйки-аугаа ертөнцийн тухай тэмдэглэл» зэрэг номыг уншиж, их хотын нүргээнт үдшийг өнгөрөөсөн билээ.

Юки, сургуулийнхантайгаа үерхэхдээ дурамжхан. Энэ нь юуны өмнө түүний нас сүүдэр гуч гарч, элдэв шалдар булдарт сонирхолгүй байсантай холбоотой учраас буурь суусан «нээсан-эгч» болсонтой холбоотой байв. Тиймээс Акасай тэр хоёрын зиндаа нийлсэн болой. Юки, Акасайтай танилцсанаас хойш цэргийн яамтай холбоотой «Сакурайка-интоор», «Хокухонся-төрийн үндэс» гэдэг нийгэмлэгтэй холбоотой болоод зогссонгүй кэмпэйтэйн залуу дарга нартай үерхдэг боллоо. Тозияагийн түлхээсээр кэмпэйтэйн түр сургууль дээр хааяа очдог болсноор тэдний тусгай бүртгэлд оржээ. Кэмпэйтэйнхан Юкид талархуу байлаа. Ялангуяа «Хар төмөр», «Мугдэнгийн зөрчил», «Эзэн хаан», «Шанхайн лам» гэдэг нууц ажиллагаанд оролцсон явдлыг

өндрөөр үнэлж байв. Юки завтай үедээ Акасайтай хамт кэмпэйтэйн түр сургууль дээр очиж, тэндхийн хичээл сургуулийг сонирхох болсноор өөртөө багшлах хүн олжээ. Юки юуны өмнө зэвсэгтэй хүнээс өөрийгөө хамгаалах арга хийгээд урт саваа мод ашиглаж өөрийгөө элдэв мэснээс хамгаалдаг эр зоригийн ёс кэндо, яваа ашиглан оночтой цохилт хийх арга заалгасан төдийгүй самурайн тангараг өргөсөн хүмүүс харакири хэрхэн үйлддэг зэрэг цэргийн зан үйлийг заалгахад хүрчээ.

Юкигийн багш анхандаа тур сургуульд сурдаг хүмүүсийн бэлтгэлийн танхимд Юкийг оруулж бэлтгэл хийж байгааг сонирхуулдаг байснаа сүүл сүүлдээ Юкид тусгай кимоно өмсүүлж, жинхэнэ хичээлд оролцуулдаг болов. Чингээд каратэгийн алхалт, зогсолт, гарын зангидалтын сургууль заалгасан анхны өдрөөс хойш дорно дахины судлалаас алгуурхан холдож, тагнуулын байгууллагын мэргэжилтэнгүүдтэй тусгайлан хичээллэдэг болсонд их сургуулийн удирдлага дургүйцэх аргагүй дуугүй болжээ.

Аажимдаа Юки, Акасайтай хамт хичээллэх болж, буси ёсыг гүйцэтгэхэд өмсдөг нэгэн янзын хувцас хакама өмсөж, том сэлэм катана барьж, илдний сургууль кэндо ёсонд суралцах боллоо. Тэгээд түргэн хөдөлгөөн, нүдний харааны хурц эрэмгий харц, өчүүхэн хором ашиглаж чаддаг авхаалж самбаанд өөрийгөө дасгахдаа заримдаа канадо (кэндо хийхэд өмсдөг дуулган хувцас) өмсөж, нүүрэндээ канами хэмээх баг углан, модон сэлэм букито барьж, түүнийг хэрэглэх хөдөлгөөн заалгаж, басхүү хамгаалах дасгал хийнэ. Ингэж дэс дараатай хичээллэсний эцэст каратэгийн ёс, буюу нүцгэн гараараа өөрийгөө хамгаалах хөдөлгөөн, цохилт, үсрэлт, эргэлтүүдийг заалгаж, мавасигэри хэмээх онцгой хөдөлгөөний хялбарчилсан аргуудыг заалгав. Энэ нь Юкигийн хувьд жинхэнэ сургуулилтаас дутахгүй хүнд боловч чухамхүү каратэ, илд эзэмших явцад мэснээс өөрийгөө хамгаалдаг кэндо, жад эзэмших Созицү хийгээд нүдний хараа, биеийн хөдөлгөөний гайхамшгийг шалгадаг жиүдиүцү хэмээхийг дагнан мэргэжсэн хүмүүсийн заалгадаг дасгалуудаас нэлээн хөнгөн хэлбэр байлаа. Жиүдиүцү бол самурай нарын гардан байлдааны зориулалт бүхий хүний амийг бүрэлгэх зорилготой боловсруулсан тул түүнийг нийтийн бие тамирын хүртээл болгох гэсэн шударга жиүдиүцүчид 1806 онд жиүдо буюу арван мэх (арван уран мэх) хэмээх бие тамирын дэг горим, хөдөлгөөн, барьц, шидэлтүүдийн арга хэлбэрийг шинээр боловсруулсан ажээ. Ийнхүү цэргийн зориулалт бүхий зүйлийг сурсны адилаар самурай нарын

боловсруулсан харакиригийн (хара гэдэс, кири-огтлох, хүүлэх, хэрчих) өвөрмөц хэлбэр болсон зигай ёс буюу эмэгтэйчүүд хоолойгоо огтлох ёстой танилцав. Эмэгтэйчүүд ингэж хоолойгоо огтлохдоо кайкан хэмээх тусгай хутга хэрэглэдэг байлаа.

Юки энэ бүхний түүх, гарал үүсэл зэргийг сонирхон мэдсэний дараа харакири, зигай ёсыг эргэцүүлээд «Ёстой тэнэг хүний эрхэмлэдэг ёс байна" гэж бодлоо. Юки нэг өдөр кэмпэйтэйн сургуулийн бэлтгэлийн танхимаас гарч явахдаа Сойхаратай санамсаргүй дайралдлаа. Сойхара, Юкийг харангуутаа багагүй самгардаж, харц буруулсан билээ. Юки түүнийг харахаас сэтгэлд нь хүйт оргих шиг санагдаж, уур хилэн нь шар тос асгаж дүрэлзүүлсэн гал шиг дүрсхийн оволзсон атал тэрээр хөмхийгөө тас зуугаад биеэ барьжээ. Юки эцгээ нутаглуулсны дараа Симоно, Сойхара хоёрын холбоог түвэггүй мэдсэн. Сойхара, Симоногийн даалгавраар тэрэгчинг устгасан төдийгүй, Гэрэлээг галзууруулсан аргыг бодохоос нүд нь хорсох шиг болно. Юки хамаг учрыг нарийвчлан мэдсэний дараа Гэрэлээг гэртээ байлгаж байгаад талийгаач Баатарын нэгэн дотно хүнийг олж, учир байдлыг ярилцан тохирсны дараа маш нууц байдлаар Гэрэлээг гадаадад гаргаж эмлүүлэх болсныг Тозияа ч мэдээгүй өнгөрсөн билээ. Юки, Токиод ирсний дараа их гүрнүүдийн худалдааны танхимаар дамжуулж Гэрэлээгээс захиа авдаг байлаа. Гэрэлээг тарьсан хортой тарианаас үүссэн өвчнийг эмчлэх талаар эмч нар нөр хөдөлмөр зарж, өөрсөндөө мэдэгдээгүй хорыг илрүүлэх хэд хэдэн ашигтай туршлага хийсэн нь талаар өнгөрсөнгүй, харин эмч нарын олзтой нээлт болжээ.

Нэг өдөр Юки, Акасайгийн нөхөр Сайтотой уулзаж, банкны үйл ажиллагааны талаар сонирхохоор явж байхдаа замдаа түр сургуулиар дайрч, Акасайтай уулзахаар шийдэв. Гэтэл Акасай, түр сургууль дээр байсангүй.

Юки энэ далимд багштайгаа уулзтал тэрээр,

- Юки, сан, чиний сурсан эрдмийг шалгахаар болсон. Чи татгалзахгүй биз. Онолын дөрвөн сорилтонд дээгүүр үнэлэлт үзүүлсэн болохоор туршлагын шалгалт өгөх нь дээр шүү гэлээ. Юки, багш сэнсэйнхээ үгийг сонсоод «Зэвсэгтэй хүнээс өөрийгөө хамгаалах онол, дадлагыг минь удирддаг багш маань намайг шалгах даалгавар авсан юм байх даа» гэж бодсоор Сайтогийн иртэл Акасай түүнийг угтан, хаалгаа нээж өглөө.

- Юки сан, чи Сайтотой уулзаад ярилцаж бай! Цаадах чинь чамайг сураглаад байсан. Чамтай уулзах хэрэгтэй юм байх. Би хоолоо хийгээдэхье. Будаагаа агшаачихсан. Одоо удахгүй гэлээ.

Сайтогийнх тийм ч баян биш. Гэхдээ зиндааныхаа айлуудыг бодвол нэлээн чамбайхан айл байлаа. Тэрээр Токиогийн баруун хэсэгт найман өрөө байшин бариулсан нь японы эртний сууцны барилга синдэн зукуру-цэцэрлэгт сууцыг эрхэмлэсэн боловч арай европжуу маяг оруулснаараа өвөрмөц болжээ. Тэрээр гурван өрөөгөө япон маягаар засаад хашааны цэцэрлэг рүү шууд гардаг урт хонгилоор цэцэрлэгийн сүүдрэвчтэй холбосон нь сонин. Тэр гурван өрөөнд орсон хүн, ердөө япон заншлыг дагаж шаахайгаа үүдний өрөөнд тайлаад дотогшоо оймстойгоо орж, ямар ч тавилгагүй уужим өрөөний голд зассан явган ширээний ойролцоох ам дөрвөлжин олбог дээр хөлөө нугалан сөхрөх юм уу эсвэл завилж сууна. Харин цэцэрлэгт хашааны зүүн талаас орсон хүн, европ маягаар зассан тавилгатай тохилог өрөөнд орно. Тэгэхдээ нэг онцлог ёсыг дагана. Айлчин, гадуур хувцсаа тайлангуут үүдний хананд гаргасан олон нүдтэй шүүгээнд хийсэн цоо шинэ гоёмсог улавчнаас авч хөлдөө углаад дотогшоо ордог

болой.

Юки, цул алтан саатай улавч авч өмсөөд Сайтогийн өрөөнд орохдоо эвэртэй туулай үзсэн юм шиг мэл гайхав. Анх танилцахдаа Нихон гингогийн ажилтан гэсэн Сайто, японы армийн чиү са-дэд хурандаагийн таних тэмдэг бүхий цэргийн хувцас өмссөн байлаа.

Сайто, Юкигийн сэтгэлийн гайхшралыг мэдэнгүүт өөрийгөө цагаатгахыг мэрийн хичээж,

- Юки сан, намайг битгий гайх! Цэргийн ёсны "Дотоод дүрмийг бодоод танд өөрийгөө даруухан танилцуулсан бурууг хүлээж, уучлал гуймаар байна" гэлээ. Юки учир байдлыг мэдэнгүүт инээмсэглээд,

- За одоо яая гэхэв. Нэгэнтээ албан үүргээ гүйцэтгэж байгаа хүнийг зэмлэлтэй биш. Уг нь би тантай уулзъя гэж бодож ирсэн юм. Гэтэл байдал өөрчлөгдсөн тул би, айлчны үүрэг гүйцэтгэхээс биш дээ гэж тунирхсан янзтай хэллээ.

- Юки сан, юу ч гэсэн таны хүсэлтийг сонсьё. Одоо үдийн хоол болж байна. Тэгээд нэг их яарахгүй юм байгаа биз дээ. Би ч гэсэн уулзъя гэж бодож байсан юм гээд Сайто, Юкийг тохилог засалтай өрөөний нэг хананд тулгасан диван руу урилаа.

- Би ч онц гойд хэргээр ирээгүй. Тэгэхээр таны хэрэг учрыг сонсмоор байна. Тэгээд ч нэг их яараагүй байна. Би танай айлчин учраас гэрийн эзний хүсэлтийг сонсох ёстой шүү дээ.

- За тэгвэл ...Юки сан, би таны шалгалтыг удирдаж дүн тавих бүрэлдэхүүнд орсон. Тэгээд энэ талаар ярилцъя гэсэн юм.

- Сайто сан, тэгвэл одоо дүнгээ тавьчих. Чи чинь эхнэрийнхээ найзаас шалгалт авч үйл тамыг нь барахгүй биз дээ гэж Юкийг шалгаахад Сайто,

- Юки сан, би чамаас шалгалт авахгүй...

- Тэгэх л ёстой доо. Юуны тул найзууд билээ.

- Гэхдээ... таныг нэгэн буудлын гэйшагийн дүрд тоглуулахад туслах ёстой юм шүү.

- Сайто сан, би мөнгөөр гачигддаггүй шүү. Тэгэхээр би, гэйша болно гэдэг чинь юу гэсэн үг вэ? Энэ чинь доромжлол биш үү.

- Үгүй дээ. Юки сан, учрыг нь одоо танд яриадахья гэтэл нөгөө өрөөнөөс Акасай орж ирлээ. Тэгээд инээмсэглэсэн нүдээр Юкийд тал засаж нөхөр рүүгээ эрхлэнгүй хараад,

- Тийшээ орцгооё. Хоол бэлэн болсон гэхэд Сайто суудлаасаа босов.

Юки европ маягаар зассан зочны өрөөнд орж ирээд ажвал цагаан бүтээлгээр бүтээсэн ширээний голд цэцэг тавьж, шотланд виски, сакэ өрсөн байлаа. Акасай өдрийнхөө хоолыг тун нямбай бэлджээ. Чингээд битүү жигнэсэн мах, халимны тосонд агшаасан цагаан будаа, тахианы тунгалаг шөл, жигнэсэн далайн байцаа хэмээх гамбу тэргүүтнээр хооллож сакэ,

ундаагаар даруулан балгасаар нэлээн удаан зочлуулав.

Сайто, Юкигийн шалгалтын бүрэлдэхүүнд орсноо нэгд

нэгэнгүй ярив. Тэгээд ямар үүрэг гүйцэтгэхийг нь хэлж өглөө. Юки зочид буудлын зоогийн газрын гэйшагийн (дуучны) үүрэг гүйцэтгэхдээ нэгэн итали дуу дуулж, түүнийг сонирхсон хүмүүсийг урих буюу өөрөө уригдах ёстой байв. Тэгээд Акасай, шалгуулах гэж буй Юкид итали дуу, япон ардын эртний нэг дуу зааж өглөө. Энэ үдшээс хойш дөрөв хоног Юки тур сургуулийн бэлтгэлийн өрөөнд өнжлөө. Тэгэхдээ гар буу, хутга алдуулах арга, өөрийнхөө ойролцоох зүйлийг ашиглан, шидсэн хутга мэснээс хамгаалж зайлах, ашигтай үед чамархай, аймхай, суга, бөөр, харвинд цохилт хийх, алганы хажуу, тохойн цохилт, хурууны үеэр онож чичих зэргийг янз бүрийн байдалд сургуулилж, багалзуур шахалтаас бултах, үсдэлт тавиулах аргуудыг голчилж бэлтгэл дасгал хийлээ. Чингээд тав дахь хоногийн орой болзсон зочид буудалд заасан цагтаа очжээ. Тэрээр буудлын эзний туслахтай уулзаад,

- Намайг Юки гэдэг гээд томилолтын хуудсаа үзүүлтэл өнөө залуу, нүдээ том болгон гайхсанаа цагаатгахын тулд,

- Юки сан, таны ирэх цагийг мэдээгүй болохоор угтан авч чадсангүй. Та 51 дүгээр өрөөнд байрлана гээд Юкийг дагуулж өрөөнд нь оруулж өглөө. Тэгээд Юкигийн өрөөний түлхүүрийг ширээн дээр тавиад гарахдаа "Ёстой манай буудалд баймаар гэйша байна даа! Энэ хүүхэнд ятга хөгжим бэлдээрэй гэсэн" гэж бодлоо. Юки тохилог засалтай өрөөнд орж, орой болтол хүлээхдээ буудлын туслагчийн авчирч өгсөн ятга хөгжим дарж, хэд хоног сургууль хийсэн гарынхаа хөдөлгөөнийг засаж дууныхаа ая, хөгөнд тохируулахыг хичээв. Юки хүрээнд байхдаа ятга хөгжмөөр тоглож сурсан боловч сүүлийн жилүүдэд ятга бариагүй болохоор их төсөөрсөн байлаа. Чингэж өөрийгөө бэлдэж байтал цаг нэгэнт болж, Сайтогийн туслахууд Юкигийн өрөөнд орж ирлээ.

- Юки сан, танд амжилт хүсье. Усан цэргийн дарга нарыг орж ирсний дараа та, эхлээд «Улаан сарнай» гэдэг япон дуугаа дуулаарай. Харин «Загасчин бүсгүй» гэдэг дууг дуулахдаа усан цэргүүд рүү анхаарлаа хандуулж болохгүй. Урилга ирвэл болзсон ёсоор мэдэгдэнэ биз гэж зөвлөв.

Юки, үдшийн цэнгээний газар гэйшагийн үүрэг гүйцэтгэхээр орж ирэхэд хүмүүс Юки рүү анхаарлаа хандуулсангүй. Чингээд

хэдэн мөч өнгөртөл усан цэргийн хувцастай хэдэн дарга орж ирээд нэгэн ширээнээ суулаа. Тэднийг ажвал өндөрдүү гоолиг биетэй, хар үстэй тас хар хөмсөгтэй залуус байв. Юки тэдний гадаад байдлаар нь италийн усан цэргийн дарга нар гэдгийг багцаалжээ. Юки, цэнгээний газар байгаа Сайтогийн хүмүүсийн дохиогоор ажиллаж байгаа болохоор тэднийг суудлаа эзэлснээс хойш нэлээн хугацаа өнгөрөөгөөд ««Улаан сарнай» гэдэг дуугаа дуулав. Чингээд «Загасчин бүсгүй» гэдэг дууг итали хэлээр дуултал өнөө залуус суудлаасаа босож Юкигийн зүг алга ташин хүндэтгэж, дахин дуулахыг гуйлаа. Хэсэгхэн мөч өнгөрсний дараа Юки өрөөндөө ирээд ширээн дээрх ундаанаас аягалаад уух гэж байтал буудлын эзний туслах орж ирээд,

- Юки сан, таныг хажуугийн чинь өрөөнийхөн урьсан. Тэнд өнөө усан цэргийн дарга нар байгаа юм гэлээ. Юки урилгыг хүлээж аваад тэр өрөөнд очихдоо хөгжимчид дагуулсангүй. Харин ятгаа барьж оров. Юкийг орж ирэхэд өрөөнд байсан хоёр итали дарга, нэгэн итали бүсгүй Юкийг хүндэтгэн босож, түүнийг дайлж хүндэтгэв. Тэгтэл нэгэн өндөр нуруутай, туранхай гозгор залуу дарга,

- Та өнөө итали дуугаа дуулаач гэж япон, англи үгээр хольж хутган гуйлаа. Юки эхлээд япон заншлын дагуу «Улаан сарнайг» дуулж ятгаа дарна. Ятгын утсан дээр усны долгион шиг үелзэн хөдлөх нарийнхан хурууны уран хөдөлгөөний аясаар намуухан зөөлөн аялгуу хөгжмийн утаснаа эгшиглэн, энхрий ялдам хоолойгоор дууны үе, нугалааны донжийг тааруулан эвлэгхэн дуулж буй Юкигээс өнөө итали дарга нар нүд салгалгүй анхааралтай сонсоно. Юки япон дууны дараа өнөө итали дууг дуулав. Гэтэл өнөө өндөр туранхай залуу, гүн ухархайндаа шигдэх шахсан нүдээр Юкийг ширтэн, хөшөө шиг зогссон байлаа. Тэрээр дуу дуулж дууссаны дараа сакэ аягалж, Юкийд өгөөд өөрийнхөө дэргэд суухыг гуйлаа.

Чингэж эхэлсэн наргиан хэдэн мөч өнгөрч, итали залуугийн нэг нь үерхдэг хүүхнээ дагуулан өрөөнөөс гарлаа. Тэднийг гарсны дараа өндөр туранхай залуу, сакэ хундагалан Юкийд өгөөд бие сэтгэлийн эчнээнд бадарсан шунал тачаалын увдист хөтлөгдөн Юкийг оролдож эрээ цээргүй аашлав. Юки суудлаасаа өндийн

бостол өнөө итали залуу Юкийг хана руу шахан, хүч түрэн тэврэх гэтэл тэрхэн хоромд Юки хоёр гарын алганы хажуугаар бөөрөн тушаа газар хүчтэй цохилоо. Юкигийн огцом атлаа сулхан цохилтонд бөөр нь доргисон өнөө итали залуу, хоромхон зуур саатсан амьсгааны түгжрээг гаргахын тул уртаар амьсгаа авч биеэ тэнцүүлээд, эгшин зуур халааснаасаа бугаа авч газар хэвтэж байгаа ятгыг өшиглөн өөрөөсөө холдуулаад Юки рүү ойртов.

Чухам энэхэн үед Юки, өөрийн зогсолтонд тохируулан зай аваад огцомхон эргэхдээ баруун хөлийн тавхайн өшиглөлтийг залуугийн буутай гарт тохируулж, зүүн хөлийнхөө цохилтыг чамархайд тааруулжээ. Гэвч Юки зүүн хөлийн шагайн шидэлтийг хийгээгүй болохоор итали залуу газар унаад эгшин зуур босохдоо Юкигийн ятгыг гартаа барьсан байлаа. Юки үүнийг ажиглаад ятга барьсан залуугийн гарын тохойд өшиглөлтөө тааруулаад, хагас эргэх тэрхэн зуур баруун гарын алганы хажуугаар эрүүнд нь хүчтэй буулгалаа. Эрүүгээ хуга цохиулсан итали залуу, ухаан балардан зочид буудлын тохилог өрөөний голд дэвссэн араб хивсэн дээр нугдайн унасан тэрхэн эгшинд хажуугийн өрөөнд байсан Сайтогийн туслахууд орж ирцгээлээ.

Токиогийн буудлын гэйша руу бүдүүлгээр дайрч, япон зан заншлыг хүндэтгээгүй италийн усан цэргийн нэгэн дарга гэйшаад нудруулаад буудлын өрөөний хивсэн дээр унасан зургийг Токиогийн сонинууд гайхамшиг болгон нийтэлж, цуудам шуугиан дэгдээсний маргааш Юкигийн багш нар, өөрийнхөө шавьд дээд зэргийн дүн тавьж, шалгалтаа амжилттай өгсөн Юкийд талархал дэвшүүлэв.

Юки чингэж шалгалт өгснөөс хойш хэдэн сар болж байтал Токиогийн сонинд манжуур дахь квантуны арми, Баргын уугуул газар нутгийг «Улаан монголын» аюулаас хамгаалах зорилгоор Халхын сүмийг 1936 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр эзэлж авсан тухай мэдээлснийг олж уншсан Юкигийн сэтгэл сэрхийлээ. Чухам энэ үйл ажиллагааны шалтаг нь японд хэвлэсэн

нэгэн газрын зурагт Халхын сүмийг Баргын уугуул нутаг болгож зарласантай холбоотой байв. Юки, японы цэргүүд Халхын сүмийг эзэлсэн мэдээтэй танилцаад Манжуур руу буцахаар шийдлээ. Тэгээд нэгэн өдөр цэргийн яамны тагнуулын газрын даргын туслахуудын нэгтэй уулзаж,

- Би манжуур руу буцмаар байна. Нэгэнт Халхын сүмийг армийнхан авсан болохоор би, эцгийнхээ гэрээслэлийг биелүүлэх боломжтой болсон хэрэг. Тиймээс Мугдэн рүү буцах явдалд туслах арга хэмжээ авахыг эрхэм дээдэст айлтгаж өгөөч гэж гуйлаа.

- Юки, эрхэм дээдэс одоохондоо байхгүй. Каназава руу утсаар ярьж таны хүсэлтийг уламжилъя. Харин та, одоо явах ажлаа бэлтгэ! Генерал таны саналыг хүлээж авах байх гэж бодож байна. Тиймээс бэлэн байх хэрэгтэй. Би гаккатай утсаар ярьж зөвшөөрөл аваад түүний нэрийн өмнөөс цэргийн нисэхийнхэнд үүрэг өгнө. Бас тэгээд Мугдэн рүү ярьж, Тозияа санд дуулгана гэж амлав.

Юкийг Мугдэнд ирснээс хойш Токиогоос квантуны арми руу цувж байгаа цэргийн дарга нар Тозияагийн дараа бараалхах нь алба боллоо. Ялангуяа монголын хилийн ойролцоох цэргийн анги руу зүглэж байгаа дарга нар Тозияатай уулзаж зөвлөгөө авах нь нэг ёсондоо «адис» хүртэхтэй адил.

Юкийг ирсэнд хязгааргүй баярласан Тозияа Халхын сүмийг эзэлсэн явдалд билэгшээж эчнээндээ «Одоо яваандаа алтны нууцыг илрүүлж болно» гэж бодож байлаа. Ялангуяа японы засгийн газар улаан оросоос дорнод төмөр замыг хямдхан үнээр авсан нь алсдаа Юкийг Харбин, Синьзинд суулгах нөхцөлийг бүрдүүлэх алхам боллоо. Тиймээс дорнод төмөр замыг эрхлэх томоохон нийгэмлэг байгуулах нь зайлшгүй. Юкийг түүнд хувь нийлүүлэн хоршуулах талаар Тозияа санаа тавих цаг болсонд баярлана.

Сувдаа, Юкитэй уулзаж гэр орноо хэрхэн харж байсныг ярихдаа заримдаа Тозияатай ам мурийхад хүрдэг боловч хэлээ хазаад дуугүй өнгөрдөг байснаа дуулгав. Сувдаа өнгөрдөг зун Токиод очиж, Юкитэй хамт Нара орж 1325 жилийн тэртээ барьсан Хорюзи (Есолсон журам) гэдэг анхны сүмийг үзээд Киото хотод

хэд хонохдоо чулуун шалтай сүмүүдийг сонирхож, Никко дахь Тэнгоногийн гоёмсог сийлбэртэй сүмийг үзсэнээ үргэлж сэтгэлдээ боддог байсныгаа хуучилна.

Юки, нэгэн өдөр Сувдааг дуудаад эртний хятадын түүхчдийн бичсэн Хан шу, Цян Хан шу, Синь Тан шу, Зю Тан шу гэдэг сурвалж бичгийг өгч,

- Наад тэмдэг тавьсан зүйлүүдийг уншаад цөмийг нь орчуулчихаарай! Чи чинь хятад бичигтээ надаас арай илүү шүү дээ гэж хэлтэл Сувдаа,

- Би өвгөнд (Тозияад) цай оруулж өгөөд ирье гэлээ.

- Ямар хүн ирээ вэ?

- Токиогоос ирсэн бололтой нэг дарга Халхын сүмийн талаар ярилцаж байна билээ. Бараг

шивнэж ярих нь холгүй байна.

- Би очиж цай тавгийг нь янзалъя. Өглөөнөөс хойш цоохор цаас шагайгаад нүд чилчихлээ гэхэд Сувдаа,

- Эгчээ, та өнөө хятадын алдагдсан нутаг, маргаантай газрын тухай баримт шүүж байгаа юм уу? гэлээ.

- Тиймээ. Токиод байхад тагнуулын газрын даргын нэг туслах "Ямато үндэстэнгүүд баруун тийшээ Каспи, хойшоо мөсөн далай хүртэлх газар нутгийг өөрийн эзэмшил болгоно" гэж байсан юм. Манжийн хаанаас авахуулаад Жан Золинг хүртэлх үеийн хятадын улс төрийн бодлоготонгууд Күнзийн үзлээс сурвалжтай энэ сургаалыг баримталж газар нутгаа тэлэхийг эрхэмлэж байсан юм. Одоо хятадын энэ уламжлалыг японы армийнхан уламжилж аваад байгаа юм шиг санагддаг. Чан Кайши ч гэсэн ийм бодолтой байдаг гэсэн гээд Юки өрөөнөөс гарлаа.

Юки, архи дарс, чихэр жимс эгнүүлсэн тэргэн тавиураа түрсээр Тозияагийн өрөөнд ортол намхан нуруутай, цайвар улцан царайтай туранхай япон ахмад суудлаасаа өндийж Юкитэй мэндлэв. Тэрээр Юкийг, Тозияагийн асарсан охин гэдгийг хэзээ язааны анддаггүй бололтой. Тэгээд Тозияаг гараараа дохитол, өнөө ахмад суудалдаа суулаа.

- Ёоши сан, яриагаа үргэлжлүүл гэхэд өнөө ахмад яриагаа эхлэв.

- Халхын сүмийг Баргын нутгийн салшгүй хэсэг гэдгийг батлах газрын зургийн баталгааг гадаад яам шаардаад байна. Энэ талаар тодорхой баримт гаргахгүй бол Зөвлөлт болон Монголын засгийн газрын шаардлагад бодитой хариу өгөх асуудлыг хүндрүүлж, засгийн газрыг эвгүй байдалд хүргэж мэднэ гэж гадаад яам үзэж байгаа билээ. Нөгөө талаар монголын нутагт улаан оросын ганц ч цэрэг байхгүй гэдэг нь олон улсын хэмжээнд илэрхий болохоор Баргын нутгийг орос монголын улаантнууд түрэмгийлэх санаа гаргалаа гэдгийг нотлох баримт гадаад яаманд байхгүй болохоор квантуны арми, Баргын нутгийг хамгаалах зорилгоор Халхын Сүм рүү орсон гэж зөвгөх үндэслэл муутай байгаа хэмээн гадаад яам дурамжхан байгаа.

Ёошигийн үгийг сонсоод Тозияа дотроо баахан унтууцан сууснаа янжуураа асаах зуур хэд хүчтэй сороод,

- Миний ярьсан зүйлийг сайд нарын танхим, гадаад яамныханд дуулгаж болохгүй. Ганцхан цэргийн яамны сайд, жанжин штабын дарга нар л мэдэж байх ёстой тул чи сонсож ав! Монголын засгийн газраас Халхын сүмийн хэрэг явдалтай холбогдуулж хэлэлцээ хийхээр тавьсан саналыг засгийн газрын хэмжээнд биш, харин армийн удирдлага хүлээн авахдаа хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй.

Жан Золингийн даалгавраар зүүн умард хятадын цэргийн мэргэжилтэнгүүд «Хятадын алдагдсан газар» гэдэг нэрийн доор хуурамч баримт боловсруулсан байна. 1924 онд төлөвлөсөн тэр төлөвлөгөөнд манжийн хаанаас Баргын хошуу нутгийг тогтоосон нэг баримтыг хэн хэнгүй мэдэж байсан боловч ойшоолгүй өнгөрсөн. Үүнийг монголчууд мэдэж

байгаа гэдгийг мартаж болохгүй. Намайг хүрээнээс гарахад Богд надтай уулзаад Барга, монголын хилийг тогтоосон эртний газрын зураг үзүүлж байсан. Тэр бол бүр манжийн Амбагай цэцэн хааны (1626—1643) үед манж нар өвөр монголын ноёдыг эрхэндээ оруулаад ар монголоос түр тусгаарлахын тулд хил хязгаарыг тогтоож, газрын зураг хийлгэснийг батлах албан ёсны баримт байлаа.

Манжийн хаан Кан си буюу Энх-Амгалан (Сюань Е) өндөр гэгээн Занабазарт тал засаж, түүнийг нутаг руу нь буцаахдаа тэр зургийг өгсөн учраас Богдын ордонд одоо хүртэл хадгалагдаж байгаа хэрэг! Хэлэлцээний явцад энэ зураг, Амбагай цэцэн, хааны мутрын дийзтэй (тэмдэгтэй) албан ёсныхоо баримт бичигтэй гарч ирвэл Мин улсын үеэс одоо хүртэл хүлээн зөвшөөрсөөр ирсэн монголын хилийг Баргын нутагт оруулж хэвлүүлсэн жанжин штабын газрын зураг, хүчингүй болгох эгзэг бүрдүүлнэ. Ингэж өөрөө өөрсдийгөө хүний шившиг болгож болохгүй.

Тиймээс би, сайд нарын танхим болон гадаад яаманд ямар ч баримт гаргаж өгөхгүй. Засгийн газрынхны баримталж байгаа улс төрийн аймхай үхээнц бодлоготой эзэн хааны армийн чиг баримтлалыг хутгаж болохгүй. Самурайн ёсоор бол бусидогийн (цэрэг эрсийн замнал) замналаар замнасан арми, улсын эрхийг барих ёстой гэдгийг сайд нарын танхимд ойлгуулах хэрэгтэй. Тиймээс сайд нарын тэнхимд бид захирагдахгүй. Харин тэр мулгуу сайд нар эзэн хааны армид захирагдах ёстой гэдгийг хатуу сануулж, мөрдүүлэх цаг болсон. Тиймээс монголын засгийн газартай японы засгийн газар биш, армийнхан хэлэлцээ хийх ёстой, Квантуны армийн удирдлага, монголынхонтой хэлэлцээ хийх юм бол бид армийн төлөөлөгчийг монголд суулгах асуудлыг сөргүүлэн тавих талаар бодох ёстой. Тиймээс Еоши сан та, засгийн газрынханд биш, харин өөрийнхөө мэдлэг боловсролыг армид зориулах ёстой. Та чинь газрын зургийн мэргэжилтэн хүн! Харин эцгийнхээ буянаар засгийн газрынхантай холбоотой байгаагаа их юманд бодох хэрэггүй. Тэгсэнд орвол манжуурт ирж, мэргэжлийнхээ ажлыг хийвэл би таныг дэмжих болно. Тэгэхдээ бүүр монголын асуудлаар шүү. Тодорхой яривал Халх гол төдийгүй монголын нутгийн гүнд явуулах манай хүмүүсийн тусламжтайгаар байр зүйн зураг хийх ажлыг удирдвал зүгээр гэдгийг ойлгоорой гээд Тозияа урдаа байгаа хундагатай сакэг өргөж «Кампай» гэлээ.

Еоши, Тозияатай чингэж ярилцаж нэлээн оройхон хэрд явлаа. Харин Тозияа Еошитой багагүй сэржимдсэн болохоор үг яриа нь олширчээ,

- Аав аа та, хятадын алдагдсан газар нутгийн талаар ямар бодолтой байна даа гэж Юкийг асуухад Тозияа,

- Хятадын алдагдсан газар гэж үзэх алгын чинээ газар нутаг хаана ч байхгүй. Тэгэхээр чи өөрийнхөө бичих номонд энэ тухай оруулах талыг бодох хэрэгтэй. Гэхдээ юуны өмнө үнэн мөнийг мэдэх нь чухал. Хятадууд маш эртнээс нарийн арга

мэх зохиогоод түүнийгээ "Гурван зорилго" гэж нэрлэсэн гэдэг. Хятадын түүхчдийн боловсруулсан тэр гурван аргыг "Алдагдсан нутаг", "Маргаантай газар", "Илбэн тохинуулах эзэн" гэж салгаж нэрлэдэг гэдэг сэн.

Хятадын алдагдсан нутаг гэдэг бол маш нарийн боловсруулсан ов мэх юм шүү! Тэд айл

зэргэлдээх улс орны нутгийг өөрийнхөө унаган нутаг болгохын тулд их чармайлт тавьдаг. Тиймээс айл хөршийнхөө эртний хаадыг хятадын үлгэр домгийн хааны удам угсаанаас гаралтай болгож зориуд хуурамч домог зохиодог донтой. Өөрөөр хэлбэл айл зэргэлдээ улс орны хаадыг өөрийнхөө хааны үр сад гэдэг хуурамч үлгэр зохиож, түүхийн сурвалж бичгүүдэд хавчуулдаг авьяастай улс! Ингээд айл хөрш орноо муучилж, газар нутгийг нь эрт балар үед хятадын хаадын уугуул нутаг байж байгаад хожим цагийн эрхээр алдагдсан гэдэг шалтаг заадаг өвчтэй. Ингээд айл хөршөө «хятад болох замдаа ороод байгаа» улс гэж үздэг бодлогыг Күнзийн залгамж үеийнхний үзэл суртлын зэвсэг болгон уламжилж ирсэн хуучтай юм байхгүй юу! Үнэндээ энэ бол хөршөө хятадчлах замд оруулахын тулд хойч үедээ тунхагласан «Нууц гэрээслэл» байгаа юм. Ингэхээр хятадын «Алдагдсан нутаг» гэдэг маань уг чанартаа юу байх нь мэдэгдэж байгаа биз дээ.

Тозияа тамхиа сорж, сакэ балгаж, хааяа далайн ногоон зууш савхдаж яриагаа үргэлжлүүлэхдээ өврийнхөө тэмдэглэлийн жижиг дэвтэр гаргаж, хятадын сурвалж бичигт гуйвуулж оруулсан баримтыг зааж, хуудсыг нь дурдаж наг наг инээх нь өөрийнхөө яриаг үнэмшилтэй болгохыг баталсан хэрэг болой.

Харин "Хятадын маргаантай нутаг" гэдэг чинь сонин зүйл! Эрт балар үед хятадын цэрэг, хятад жуулчид хөлийнхөө мөр гарсан газар орныг хятадын нутаг болгохын тулд боловсруулсан цэрэг, улс төрийн бодлогоос үүссэн, үнэн бодит баримтуудыг гуйвуулсан, мухар тэнэг хэрэг. Хятадуудыг хуурамч баримт дурдаад байхаар нь зарим улс орон жинхэнэ түүхэн баримтыг гаргаж ирдэг удаатай. Тэгэхээр хятадууд түүхэн үнэнийг баллах аргагүй болохоор асуудлыг хойшлуулж, «маргаантай нутаг» гэдэг шалтаг заадаг. Тэгэхдээ зүгээр тийм шуугиан дэгдээдэг улсууд биш шүү. Айл хөршүүдийнхээ баримтыг хожим ямар нэг замаар устгах хулгайлах, үрэгдүүлэх хүртэлх хугацаанд «хэл ам» татлалгүй, дуугүй байж чаддаг гоц авьяастай гэлцдэг.

Гурав дахь чиглэл бол Күнзийн сургаалыг баримтлагч нараас гаргасан онол билээ. Тэгэхдээ Жунго гэдэг нэрээр түрүү барих дээрэнгүй үзлийн тусгал юм! Учир нь хятад бол дэлхийн бүх улсын төв дунд байдаг гэнэ. Тиймээс бусад улсын дотоод эрхийг барилцаж, тэдний улс төрийн маргаантай асуудлыг шийдэн өгч, зохицуулж байхын зэрэгцээ засаг төрийг нь удирдан жолоодож, илбэн тохинуулж өгөх ёстой гэнэ дээ. Тиймээс хятадын хаадууд «асрамжлан энэрэх, удирдан жолоодох, илбэн тохинуулах» гэдэг нэрийдлээр айл зэргэлдээх улс орны дотоод хэрэгт оролцож, тэр улсын төрийн эрхийг атган захирахын тулд гаргасан нарийн зальт арга билээ. Үүнийг Манжийн эзэнт гүрний үед их баримталж байсан. Би монголд байхдаа манжийн хааны сангаас хөрөнгө гаргаж бариулсан Ховдын Шар сүм, Амарбаясгалант, Дамбадаржаалин хийдийн гэрэлт хөшөөний бичгийг очиж уншсан. Тэгэхэд манжийн хааны зарлиг болгосон тэр бичигт «Хязгаар дахиныг тохинуулсан, хол дахиныг илбэн тохинуулсан» гэдэг хэллэгийг их хэрэглэсэн байсан. Үүнээс үзвэл дайчин улс гэдэг чинь үнэн чанартаа монголыг хоёр зуун жил хятадын хаадын сургаалаар дарлаж, улс төрийн эрхийг барьж байсан юм байна гэж боддог миний бодол баталгаатай зүйл гээд диван дээрээс бослоо.

Тозияаг унтахаар явсны дараа түүний яриаг тунгаан бодсон Юки, Токиогийн цуглаанууд дээр очиж байснаа саналаа. Хокухонся буюу төрийн үндэс нийгэмлэгийн нэг цуглаан дээр нэгэн

самурай хэлсэн үгэндээ «Энэтхэгээс Сибирь, Сахалингаас Каспи хүртэлх газар нутагт эзэн хаан тэнногийн дэглэмийг тогтоосны эцэст бүх дэлхийг японы өрх гэрт нэгтгэж яматогийн хөвгүүдийн өрх гэр болгох хэрэгтэй. Хакко ити о Банзай» гэж орилж байсныг санаад «Японы арми, хятадыг эзлэх гэдэг асуудал бол үнэн чанартаа Жан Золингийн боловсруулсан төлөвлөгөөнд тусгасан хятадын алдагдсан нутгийг хятадын нутагтай нь хамт эзэн хааныхаа өлмийд сөхрүүлэх гэсэн бодлого байж таарах нь ээ» гэж бодлоо.

Юки унтахынхаа өмнө Тозияагийн өрөөнд буцалсан халуун

ус, хятад ногоон цайны хандалсан ааг оруулж өгөхдөө,

- Аав аа манжийн хаан, Энэтхэгээс умард далай, Номхон далайгаас Хар далай хүртэлх газар орныг илбэн тохинуулж, түвшитгэсэн хязгаар болгоно гэдэг зарлиг гаргасан гэдэг. Тэгэхдээ бүр эртний нэг тулгар бичигт тэмдэглэснийг иш болгосон гэдэг. Тэгэхээр Жан Золин тэр сурвалж бичгийг эрхэмлэж байжээ гэж хэлэв.

- Би хэдэн жилийн өмнө нэг хүнтэй уулзаж, түүний зохиосон «Хятадын хил хязгаар» гэсэн номын талаар ярилцаж билээ. Тэр хүн өөрийнхөө номонд хятадын түүхийн сурвалж бичигт байсан бүх баримтыг ашигласан гэж ярих дуртай. Тэгэхээр би нэг удаа өөрийнхөө сайн мэддэг нэг зүйлийг ярьж, таны бичсэнээр бол одоогийн Памир, Иссикуль хавийн нутгийг хятадын нутаг болгосон байна. Харин таны иш татсан сурвалж бичигт дурдсан баримтыг шүүхэд Чигү (Иссикуль) хавь болон Давань орчмын нутагт хятадын амбан байгаагүй. Харин У дэ хааны цэрэг тэр нутгийг эзлэх гээд хиарч буцсан тухай тэмдэглэсэн байна шүү гэж хэлтэл нөгөөхийн маань царай хувьсхийгээд явчихлаа. Тэгээд надаас зовж, хуурамч баримт гаргаж зохиосондоо ичсэн бололтой «Чи ч мөн сүрхий самурай юм даа» гэлээ. Тэгэхээр нь «Сүрхий байхын тулд баримтуудыг шалгах ёстой биз дээ» гэтэл мань эр «Тозияа сан, хятад хүний шаахайны мөр гарсан газар бүхэн хятадын нутаг байх ёстой юм мэдэв үү?» гэдэг байна. Миний уур бадарч «Их Наран улсын нутагт олон мянган хужаа нарын мөр үлдсэн.

Тэгэхээр наран улсын нутаг бас хятадын нутаг болж байна уу» гэж ууртай асуухад мань эр «Хай Тозияа сан, тийм алдас яаж байх вэ? Наран улс бол эх тэнгэр Аматаэрасугаас, удамтай шүү дээ» гэж нялганаад «Энэ яриа та бид хоёрын хооронд үлдэж, өөр хүн мэдэхгүй байвал зүгээр юмсан» гээд гурван цэнгийнхээ алтан бөгжийг дэнчин тавьж билээ. Тэр хүн үнэн баримтыг гуйвуулж, хуурамч баримт боловсруулаад түүнийгээ үнэн болгохын тул хятадын түүхийн баримт гэж сүржигнэсэн юм байж.. Ингэхээр тэд бусдын газар нутгийн баялагт шунаж, дайн өдөөхийн тулд ийм хуурамч баримт боловсруулдаг байна шүү дээ. Тэгэхээр хятадын "алдагдсан нутаг" гэх алгын чинээ шороо дэлхийн аль ч улсад

байхгүй гээд Тозияа, гангар шаазантай цайгаа авч уулаа. Тозияа, цайгаа уух зуур Юкитэй энэ тэрхнийг ярьж байгаад унтахаар хажуулах үед Юки, өрөө рүүгээ явлаа.

Юки, өрөөндөө орж ирээд номын сангаас Ханшугийн ботиудыг (дугтуйтай түүх) авч Сувдаагийн орчуулгыг тулгаж, эхтэй нь харшуулаад тэмдэглэлээ авч өдрийнхөө харсан, үзсэн, дуулснаа тэмдэглэв.

...Японы цэргийн онцгой төлөөлөгчийн газрыг хятадад зохион байгуулсан аргандаа

түшиглэж, монгол тийм төлөөлөгчийн газрыг байгуулахын тул Халхын сүмийн асуудлаар хийх хэлэлцээг орон нутгийн цэргийн хэмжээнд хийлгэхийг оролдож байна. Японы талаас тавих саналын үндсэн хэсгүүд бол Улаанбаатар, Ховд зэрэг газар цэргийн төлөөлөгчийн газрыг байгуулж утсан харилцаатай байлгах, цэргийн төлөөлөгчид монголын нутгаар чөлөөтэй явж байх эрхээр хангуулах болзол тавих нь тагнуулын мэдээ баримт цуглуулах нөхцөлийг хашуулахад чиглэж байгаа аж...

Юкийг ийнхүү тэмдэглэлээ бичиж байтал Сувдаа орж ирлээ. Юки ширээний араас өндийж унтлагынхаа өрөө рүү явахын өмнө,

- Сувдаа наад ширээн дээрх бичиг цаас янзлаарай. Тэмдэглэлийн дэвтрийг нууцын шүүгээнд хийгээрэй гээд түлхүүрээ өгөөд өрөөнөөс гарлаа.

Юкийг Токиогоос ирсний дараа орой бүр япон, хятадын түүхийг уншиж тэмдэглэдэг болсон явдалд Сувдаа гайхсангүй. Юки, мэдэхгүй юмуу ойлгохгүй зүйлээ Тозияагаас асууж лавлахдаа хятад хар архи авчруулж, өргөсөн эцгээ хүндэтгэнэ. Тэгээд Юки эцэгтэйгээ ярьсан зүйл хийгээд Итагаки, Доихара нарын зөвлөснөөр бичих ёстой «Шинэ үеийн эзэнт Монгол» гэдэг номынхоо талаар ярьж, зөвлөгөө авсан тухайгаа тэмдэглэнэ. Харин Сувдаа орой бүр Юкигийн өрөөнд орж ирээд ширээн дээрхийг нь янзлаад, тэмдэглэлийн дэвтрийг нууц шүүгээнд нь хийж цоожлоод өглөө Юкийд түлхүүрээ өгдөг болжээ.

...Чуулалт, Хаалган хот. Толгой дээрээс нар шарж, улан доороос халуун элс төөнөсөн хотын бүгчим, хуурай тоосорхог агаар хамар хорсгон, цээжинд аргасан тоос амтагдана.

Тогава, хотын захад байдаг японы цэргийн төлөөлөгчийн газраас гарч хотын төвд байдаг буудал руу сажлав. Тогава, энэ өдөр америкийн консулын газрын нэгэн ажилтантай уулзаж, манжуур, өвөр монголын асуудлын талаар ярилцаж, өвөр монголчуудад олгох тусгаар тогтнолын талаар бодлоо солилцох ажээ. Буудлаас төдий холгүй байдаг нэгэн торгоны мухлагт америкийн консулын ажилтанг хүлээж байсан Тогава, торго сонирхож байтал болзоот хүн иржээ.

- Тогава сан, манжуурт тогтоосон дэглэмийг манай улс дипломат шугамаар эсэргүүцсэн. Ер нь завсрын улс байхыг зөвшөөрөхгүй. Тэр ч байтугай умард хятад, дорнод Хэбэй мужид тусгай засгийн газар байгуулж, тэргүүнээр нь Инь Жүгэнийг томилж, өвөр монголд Дэ вангаар толгойлуулсан засгийн газар байхыг ч эсэргүүцнэ. Би квантуны армийн төлөвлөгөөг танаас ч илүү мэдэж байгаа гээд өнөө хүн, Тогавааг ширтэх нь түүний эчнээний зорилгыг тольдох мэтээ.

- Манжуур, өвөр монголын ард түмэн, цаг үе, улс төрийн бодлогын ач холбогдлыг эрхэмлэхдээ модон морьт улсаас (Америк тивд байдаг эртний овог аймгууд мустанг хэмээх морийг эрхэмлэж, модоор хийсэн мустанг тахидаг байсан маш эртний уламжлалыг дайруулж нэрлэсэн хоч нэр) илүү юү гэхээс дутахгүй!

- Тогава сан, таны хуучин эхнэр, японы цэргийн томоохон үйлдвэрийн эзэнтэй суугаад алхаа гишгээг чинь отоож байгаа. Гэтэл таны эртний танил Буянт дагзанд чинь сум зоочих эгзэг хайж байсан. Ер нь энэ бүхнийг та мэдэхгүй байгаагийн адилаар манжуур, өвөр монголын

ард түмэн, японы армийн жинхэнэ бодлыг мэдэхгүй байгаа шүү!

Америкийн консулын газрын ажилтантай уулзсан Тогава, сэтгэлийнхээ эмзэг бодлоо төнхүүлээд, зүрх шимшрэхийн эрхэнд олон үг нуршилгүйгээр салахын түүс боллоо. Тогава, японы цэргийн төлөөлөгчийн газар ирээд тэндхийн нэгэн ажилтангаас Буянтын тухай сураглав.

- Тогава сан, Буянтын тухайд гэвэл монгол руу дээрэм хийх гэж яваад хилийнхэнд баригдаж нудруулсан сурагтай. Гэхдээ бид сураг дуулснаас цаашгүй. Харин Суююаньд байгаа манай хүмүүс энэ тухай тун сайн мэднэ. Хэрвээ танд шаардлагатай бол тийшээ явах нь дээр гэж зөвлөв.

Тогавагийн сэтгэл дэнсэлж, үе үе Токиод болсон явдлуудыг санах тусам зүрхээр нь хатгуулах шиг болно. Тэрээр буудлын цонхны дэргэд зогсож, шөнийн харанхуйг ширтэхдээ «Буянтын сургийг заавал гаргах хэрэгтэй. Тэгэхгүй бол тэр новш надаас өшөөгөө авна шүү. Ер нь америк ноёны хэлсэн үг жирийн зүйл биш! Тэд өөрсдийнхөө тагнуулаас тун тодорхой мэдээ авсан хэрэг! Үнэхээр алагдсан бол Манжуураас буцах хэрэггүй! Эндээ байх нь надад ашигтай. Тэгэхээр Суююань руу явж сургийг нь мухарлах ёстой» гэж өөртөө сануулав.

Тогава, Чуулалт Хаалганаас Суююань хотыг зорьж ирээд хотын нэг зочид буудалд буулаа. Тэрээр хоёр хоног хотоор сэлгүүцэж, японы төлөөлөгчийн газрын туршуулуудтай уулзаж, Буянтын халуун мөрийг мөшгиж байхад зочид буудлыг отсон хэдэн хасаг эрс, нэгэн шөнө түүнийг өрөөнд нь хүлээж байлаа. Тогава, Буянтыг үхсэн хийгээд түүний хамаатан садан танил талын хүмүүс Суююань (Хөх хот)-д байхгүй гэдгийг баттай тогтоогоод буудалдаа ирээд өрөөндөө ортол, унтлагын өрөөнөөс хоёр хүн гарч ирж халз уулзав.

Тогава, өндөр нуруутай, ширүүн харцтай, бүргэд шиг хянган хамартай, хууз хүнийг ажиглангуй хараад уруулынх нь сахал бууралтсан болохыг мэдээд «Шинжаан Ганьсуд алдаршсан дээрэмчин Аксакал гэдэг хочтой Илбирс шив дээ» гэж амандаа үглэв.

- Эрхэм ноён ахмад аа! Бээжин түншийн талаарх хэрэг явдлыг шиншлэхгүй байхыг танд зөвлөе! Харин бидэнд ашигтай алхам хийвэл таны утсан чинээн гол чинь бүтэн үлдэх болно. Миний саналыг харгалзахгүй бол миний нүд, чих, сүүл, сүүдрүүд Чанчун, Харбин, Мугдэнгийн аль ч гудамжнаас таныг олно гэдгийг бодоорой! Тиймээс танд дэнчин тавьж үүнийг өгье гэж хэлтэл хажууд нь зогсож байсан нэг эр боодол иень ширээ рүү чулуудлаа. Тогава ширээн дээрх иенийг хараад,

- Эрхэм Аксакал сан би танд юугаар туслах болж байна даа гэж асуув.

- Тогава сан, Буянт Бээжин түншийн жинг дээрэмдээд монголын хилийнхэнд мэдэгдэхэд хүрсэн тул тэдэнтэй мэс зөрүүлж дүвчигнээд амиа алдсан. Бээжин түншийн төлөөний хүн ч алагдсан. Тэгэхээр энэ тухай газар газрын сонинд мэдээлэх ёстой!

- Тэр болно. Харин би өөрөө тэр бүхэн хэрхэн болсныг дэс дараалан мэдэж байж бичих ёстой.

- Тогава сан, би таны хэвлүүлэх зүйлийг бэлдчихсэн. Та түүнийг бичих гэж цаг гарздахгүй гэж хэлээд өврөөсөө нэгэн бичиг гаргаж ширээн дээр тавилаа. Тэгээд Аксакал хүйтэн инээмсэглэн,

- Тогава сан, бодолтой хандаарай! Биднийг эрлэгийн элч ч хуурч чадахгүй шүү гээд цонхоор гараад алга болжээ.

Тогава тэр шөнө унтаж чадсангүй. Шөнжингөө ширээний дэргэд суугаад цонх руу гөлөрч үүр хаяарахаас өмнөхөн өөрийн эрхгүй зүүрмэглэв. Гэтэл Тогавагийн өрөөнд хятад хувцастай гурван залуу орж ирээд, түүний эрүүнд хутганы үзүүр тулган,

- Тогава сан, бид бол Буянтын найзууд. Тэгэхээр ямар зорилготой ирсэн нь танд илэрхий. Танд хоёр зам бий. Нэг бол нүглээ наманчилж, гэдсээ хүүлж үхэх хэрэгтэй. Ойлгов уу? гэтэл нэг залуу, хулсан хутга гаргаж ширээн дээр хаялаа.

- Үүнийг танай ёсонд харакири гэдэг биз дээ. Нөгөө зам бол Аксакалын өгсөн таван мянган иенийг өгөөд маргаашийн дотор Сюююаниас далд ор! Бид таныг алахыг хүсэхгүй байна. Учир нь Аксакалын гараас бид мултрахгүй. Тэгэхээр та, өөртөө харакири үйлдсэн дээр гэхэд Тогава, өнөө гайтай иенийг гаргаж өгөөд өөрийнхөө хэдийг дээрээс нь нэмэрлээд хоёр яс хагацахыг хичээв. Хятад залуусыг гарсан даруйд Тогавагийн зүрх, амаараа гарчих шахсаныг ойлгоод «Ай бурхан минь... Би юу гэж наашаа зүглэв вэ? Бурхан минь аавын хэлдэг үнэн боллоо шүү! Одоо эндээс хурдан зайлах хэрэгтэй. Ер нь Осака руу зайлъя» гэж бодсоор өөртөө үглэж захисаар өглөө болгов. Тогава өглөө төлөөлөгчийн газар очоод буцах тухайгаа мэдэгдээд хэдэн иень дараа тооцохоор зээлж аваад галт тэрэгний буудал руу явлаа. Гэтэл галт тэрэгний пиу худалддаг жижиг цонхны дэргэд зогсож байсан дөрвөн залуугийн нэг нь,

- Тогава сан, та Синьзинд очингуут өгүүллээ хэвлүүлэх хэрэгтэй. Харин одоо наад пиугаа над өгөөтөх гээд гараас нь угз татан авангуут өөр нэг пиу өгөөд царай руу нь сүрхий ширтэхийг ажваас «Наад пиугаа сольж маяглах хэрэггүй шүү» гэж анхааруулах шиг санагдав.

Тогава, буудлын байшингаас гарч галт тэрэгний вагон руу гэлдрэхдээ саяын залуусын царай, дууны өнгө, биеийн байдлыг эргэцүүлээд «халаасных нь» хэдийг цөлмөсөн залуус болохыг таниад «Аксакал над өгсөн хэдээ нарийн аргаар буцааж авчээ» гэж бодлоо. Тогава, Аксакалын хүмүүс дагаж явах болсныг мэдээд үхлийн ангал руу тулж очсоноо ухаарлаа... Тогава тэр ангалаас айж, уначихгүйг хичээн арагшаа ухрахыг бодно. Гэтэл түүний ар нуруунд бууны хүйтэн ам тулгасан ажээ. Тогава, үхлийн ангал ойртох тусам дуугарч ч чадахгүй болжээ. Тэгээд айхын эрхэнд амьсгаагаа арай ядан аваад эргэн тойрноо ажиг.

Тогава чингэж хар дарсан зүүднээс арайхийж сэрээд, өөрийгөө ажтал хөнжил даавууныхаа нэг үзүүрийг амандаа чихчихсэн зогсож байлаа. Нойрноосоо чингэж сэрсэн Тогава, өдөржингөө сэтгэлээ дэнсэлгэж тав тухгүй өнжлөө. Яагаад ингэж хар дарснаа мэдсэнгүй. Гэсэн ч ямар нэг гай дайрах совин татаад байх шиг санагдана. Уул хэрэг явдал болж өнгөрөөд жил гаруй болж байхад ингэж зүүдэлж байсан удаагүй. Тогавагийн эцэг зөнтэй хүн билээ. Тэгэхээр Тогава, өөртөө учрах аюулыг зөгнөн мэддэг эцгийнхээ зөн совинг дуурайсан бололтой. Эцэг нь Амисэ, Буянт хоёрын тухай хүнээс сонсоод нэг удаа «Хүү минь чи, эцсийн эцэст наад бөгснөөсөө болж өшөөтэй хүний мэсэнд амиа алдах байх даа» гэснийг одоо

бодохоос айна. Тогава, эрт өнгөрснийг сэргээн бодож өөрийгөө шаналгасаар үдийн хоол идэхээр «Мандаж буй Манжуур» гэдэг зоогийн газар руу гэлдэрлээ. Түүнийг зоогийн газар орж ирэхэд квантуны армийн тагнуулын газрын ажилтан хошууч Симото угтан уулзав.

Симото, Юкийг Токио руу явсны дараа квантуны армийн штабт ирж, монголын асуудал эрхлэх болж Синьзинд суурьшжээ.

- Тогава сан, та надтай хамт хооллохгүй юү? Бас яримаар юм байна.

Тогава түүний урилгыг хүлээн авч ширээний дэргэд суухдаа «Энэ золиг, юуны үнэрээр ингэж байгаа бол?» гэж бодоод болгоомжлов. Харин Симото, Тогавагийн орноос хоол захиалж сакэ авчрууллаа,

- Тогава сан та Буянтыг сайн танина байхаа гэж асуухад Тогава бүлх залгисан юм шиг хий бөлтөлзсөнөө «Тэгнээ тэр! Гайны Буянтын асуудлыг тагнуулынхан сонирхсон байх нь. Яагаад тэр вэ? Амисэгийн явуулга уу» гэж бодлоо.

- Эрхэм хошуучаа, таних нь танина шүү. Гэхдээ бурхан болчихсон хүн шүү дээ гэж хэлэхдээ биеэ барилаа.

- Тогава сан, би таны өгүүллэгийг уншсан. Таныг бичсэн гэхэд үнэмшмээргүй юм. Найруулга нь таныхаас ондоо юм байна билээ.

- Симото сан, үнэнийг хэлэхэд Буянтыг үхсэн гэдгийг би нүдээрээ үзээгүй. Гэхдээ надад мэдээлсэн тэр хүн бол их нэр сүртэй, найдвартай хүн шүү гэж хэлэхдээ «Симото бүх хэргийг мэдэж байгаа бололтой. Тиймээс юу ч нууж болохгүй» гэж өөртөө захиж байлаа.

Хошууч, хоолоо идсэний дараа ч Буянтын тухай дахин яриа дэлгэсэнгүй. Тэгэхдээ Тогавагаас нүд салгасангүй. Тогава хошуучийг нүдний булангаар ширтэн «Энэ новш, намайг нэлээн хоргоох нь дээ» гэж бодоод дуугүй байлаа. Гэтэл Симото зоогийн газраас гараад дуугүй явснаа,

- Хоёулаа штаб дээр очиж, манай өрөөнд Буянтын тухай ярилцъя гэхэд Тогавагийн зүрх зогсчих шиг болов.

Тогава хэрхэхээ мэдэхгүй, Симотоог даган квантуны армийн штаб руу гэлдрэхдээ «Армийн тагнуулын газар Буянтыг яагаад сонирхоод байна» гэж өөрөөсөө асуувч учрыг үл олно.

Симото, өрөөндөө орж ирээд Тогаваад сандал өгөөд,

- Тогава сан, та Буянтын талаар багагүй нүгэл үйлдсэн чинь илэрхий болсон. Тэгэхээр тун эвгүй байдалд орж магадгүй гэж хэлээд Токио дахь Хар луу нийгэмлэгийн удирдлагаас ирүүлсэн тодорхойлолтыг үзүүлэв. Генерал Тояамагийн гарын үсэгтэй бичигт Буянтын зан төрх, Токиод гүйцэтгэсэн үүрэг, хувийн сонирхол, авьяасын талаар яггүй тодорхойлсон төдийгүй

түүнийг Аяанаосу гэдэг нууц нэртэй байсныг бичжээ. Түүгээр зогссонгүй Буянтыг монголын

асуудал ажиллагаанд оролцуулах тухай өөрийнхөө саналыг кэмпэйтэйн нэрийн өмнөөс бичихдээ найдвартай гэдэг тодорхойлолт гаргажээ. Симо, сөрөг тагнуулын газраас ирсэн энэ тодорхойлолтыг Тогаваад үзүүлэх ёсгүй ажээ. Гэсэн ч үзүүлэх шалтаг бий. Тэр тодорхойлолтыг Симогийн дарга өгөхдөө «Миний мэдэж байгаагаар бол Буянт, Токиод байхдаа цэргийн нууц байгууллагынханд хүчин зүтгэж явсан хүн. Гэхдээ алдаа гаргаж байсан удаатай. Гэсэн ч тэр бол асуудлыг хүндрүүлэх шалтаг болохгүй. Харин Тогавагийн бичсэн зүйл бол цэвэр хувийн өшөө хонзонд тулгуурласан хэрэг» гэж сануулсан болохоор Симо, Буянтыг халхаас ирсний дараа нарсанд түгжээгүй билээ.

Буянтыг дөрвөн сарын турш ажигласан ажиглалт, Сююань, Токиогийн тодорхойлолтыг үзвэл түүнийг хардаж сэжиглээд байх гойд зүйл байсангүй. Симо, квантуны армийн тусгай төлөөлөгчөөр дамжуулж Өрөмч, Цонжоос авсан баримттай танилцаад Тогаватай уулзахаар шийдсэн. Тэр баримтанд бүх асуудлыг шийдэхэд хэрэгтэй зүйл багагүй байв.

...Аксакал хэмээгдэх Илбирс жинчдийг түйвээхдээ бидэнд мэдэгдээгүй. Бид ч жинчдийн талаар ямар нэг удирдамж өгөөгүй. Энэ хэргийг тэд өөрсдийн дураар үйлдсэн байна. Тиймээс буруугаа хүлээж тодорхойлолт гаргасан. Тэд өөрсдийнхөө энэ хэргийг сэжиггүй болгохын тулд Тогава санд таван мянган иень өгч, сонинд бичих зүйлийг зааварласан байна... гэжээ.

Тогава, хар луу нийгэмлэгийн удирдагч Тоямагийн захиаг уншихад Буянтын талаар ямар нэг гай дэгдэх нь илэрхий болсныг мэдээд Симогийн царай өөд гөлөрсөөр,

- Шиү са доноо, би тэгээд одоо яах вэ? гэж асуулаа. Тогава, генералын захиаг уншаад тоомсоргүй хандвал түүнд

Өрөмчийн тодорхойлолтыг үзүүлэх ёстой байсан Симо, Тогаваг ингэж асуусан болохоор «Гэмээ бүрэн ойлгосны шинж» гэж үзлээ.

- Мэдэхгүй. Хэрвээ Буянтын нэр төрийг хамгаалах асуудал өндийвөл таныг хариуцлагад татна. Эцэст нь хэлэхэд Амисэ, Буянтын нэр төрийг бодохоос биш таныг нохойн гөлөгний

чинээтэй тоохгүй. Амисэ, одоо ямар хүний эхнэр болсныг мартав! Тэр гоё сайхан хүүхэн, хөгшин зөнөгт сайхан биеэ зориулахдаа нэлээн тооцоотой гэдгийг санах хэрэгтэй. Тэгэхээр бидэн шиг муусайн нусан жур байтугай цаг нь ирвэл цэргийн яамны сайд, яаж ч чадахгүй үгийг нь дагана гэдгийг анхаарах ёстой гэж омогдонгуй хэллээ.

Тогава, Симогийн энэ үгийг, Чуулалт Хаалганы америкийн консулын өнөө ноёны үгтэй харшуулаад «Амисэгийн гараас амьд мултрахгүй» гэдгийг юунаас ч илүү ойлголоо. Тэгээд гэртээ орж ирснийхээ дараа орон дээрээ гэдрэгээ харан хэвтэж, эргэцүүлэн бодтол аймшигт явдал сэтгэлд дараалан орж, нүдэнд нь сүүтэгнэнэ. Тогава, энэ шөнө үүр цайтал нүд аньсангүй. Тэгээд өглөө эрт босож хувцаслаад Симототой уулзаж, Амисэгийн өш хонзонгоос хэрхэн мултрахаа зөвлөхөөр штаб руу гэлдэрлээ. Тэрээр квантуны армийн штабын хашаанд байдаг цайны газраар орж өглөөний цай ууж суутал хар өнгийн шинэ костюм өмсөж, цагаан цамц дээр эрвээхэй зангиа дэгжирхэж зүүсэн нэг хүн орж ирээд архи дарс, тамхи худалддаг лангууны дэргэд очив.

Тогава, түүнийг хайнга хараад «Энэ хүнийг хаана харлаа. Ингэж дэгжин хувцасласныг бодвол цэргийн тагнуулынхан байх. Тэгсэн байтлаа яасан танил царай вэ? Би чинь тагнуулын газрынхнаас Симоотоог танина» гэж бодсоор лангуу руу харахдаа өнөө залуугийн бараанаар хамаг биеэр нь хүйт оргиж, салганан чичирч байгааг мэдээд «Энэ чинь Буянт уу даа» гэж өөртөө шивнэн хэлээд эг маг ээрлээ. Нимгэн уруул дээрээ япон сахал дэгжирхэн тавьсан Буянтыг харж самгардсан Тогава, нүүрээрээ халуу дүүгэн буйг мэдээд цайны газраас хурдан гарахыг хичээж суудлаасаа босохдоо Буянтад хар авахуулахгүйг мэрийж, бараг мяраах шахан алхсаар цайны газраас гараад сая амьсгаагаа авч гүнээ санаа алдав. Тэгээд штабын байшин руу гэлдрэхдээ «Яах аргагүй Буянт мөн байна! Энэ арван жил нэлээн өөрчлөгджээ. Гэхдээ янз төрх нь хэвээрээ шүү. Үүнийг монголын хилийнхэнд алагдсан гэж Аксакалын ярьсан худлаа боллоо. Ингэхээр үүнийг Симоото мэдэж байгаа учраас намайг сонжсон хэрэг! Одоо яах вэ? Би гэдэг амьтан чинь хязгааргүй тэнэг юм. Хар луу нийгэмлэгийн удирдагч генерал Тояамагийн захианд Буянтыг монгол руу чиглүүлсэн армийн ажиллагаанд оруулж болно гэснийг уншсан мөртлөө яагаад Буянтыг санасангүй вэ? Ганцхан Амисэгийн гараас мултрахгүй нь гэж бодоод байсан шүү дээ. Мөн тэнэг ээ!» гэж бодсоор штаб руу орж ирээд Симоотогийн өрөө рүү хурдан алхаж яваагаа мэдэв. Симоото, Тогавааг орж ирэхэд ёс төдий мэндлээд, шууд яриандаа орж,

- Буянтын талаар хийсэн гүтгэлгийг хянах тухай заалт өгч байна! Тэгээд энэ асуудлаар хөндөгдөх гайтай зүйлээс гарах чиний ганц боломж бол Буянттай өөрөө уулзаж, уучлал гуйвал дээр байх. Ер нь Буянт таныг олж уулзахын тулд энд ирсэн гэдгийг санаарай! Тиймээс чи өөрөө түрүүлээд уулзвал аминд чинь өлзийтэй гэлээ.

- Би үүнийг мэдэж байна. Тэр ч байтугай...

- Тогава сан, та дайралдаа юу?

- Тэглээ. Өнөө өглөө... үгүй ээ... тун сая цайны газар санамсаргүй дайралдлаа.

- Буянт таныг зүгээр өнгөрөөлөө гэж үү?

- Намайг ажиглаагүй. Ер нь хараагүй.

- Тогава сан, тэгвэл та одоо Буянттай уулзаад зарим зүйлийг урьдчилж хэлээд тохиролцох хэрэгтэй. Тэгэхгүй бол таны амийг би атугай хээрийн цагдаагийн газар ч хариуцахгүй шүү! Буянт тантай тооцоо хийхийн тулд Амисэтэй холбоо барьж, хэл ам тохиролцвол хэн ч аргалж чадахгүй юм болно. Тэгэхээр та, улаан нүүрээрээ уулзсан дээр гэж зөвлөв. Симоото ингэж хэлээд Тогавагийн айсан царай өөд хараад "Энэ золиг үнэхээр Буянттай дайралдсан хэрэг үү? Буянт мангартаж, танилгүй өнгөрнө гэж баймааргүй юмсан. Тэгэхээр энд ямар нэгэн далдын учир байна! Хэрвээ Буянт, Тогаватай уулзвал Токиогоос явахын өмнөхөн уулзсан шигээ уураа барьж чадалгүй ганц дэлсээд унагана. Ингэхээр Тогавааг, Буянттай нүүрэлдүүлэх хэрэгтэй! Хэрвээ Буянтын нэрээр ирсэн монголын тагнуул бол Буянтыг таних нь байтугай өнөө цохилтыг ч мэдэхгүй байгаа. Тэгвэл миний сэжиг баримтаар нотлогдож чадна. Буянт ямар ч хүнийг ганц цохиод, дагз руу нь буулгадаг онцлог барилтай хүн дээ" гэж бодов.

- Симоото сан, надад одоо нуух юм алга. Та бүгдийг нь мэдэж байгаа. Би долоон голтой тэр

чонотой уулзахгүй. Харин сонинд бичсэн өгүүлэл...

- Тогава сан, тэгвэл Аксакал чиний бөгсөн дээр халуухан жин тавьчихаж дөнгөө шив дээ!
- Симото сан, та намайг энэ эвгүй байдлаас хэл амгүйхэн шиг мулталж өгөөч. Би таны ачийг мартахгүй гэж гал буурсан харцаар хошуучийг ширтэн уйлагнав.
- Таны алдар нэрийг хамгаалъя гэж бодъё. Гэтэл энэ чинь ямаршуухан адармаатай хэрэг вэ? гэдгийг та мэднэ биз дээ. Бүүр нарийн яривал хоолноосоо хагацаж, толгойгоороо тоглох адармаатай тоглоом шүү!
- Би ойлгож байна. Гэхдээ... гээд Тогава халааснаасаа тавьтын дэвсгэрээр толгойлсон боодол доллар гаргаж,
- Би үүнийг аав руугаа гуйвуулах гэж цуглуулсан юм. Одоо энэ надад хэрэггүй. Энэ чинь таван мянга шүү. Симото сан, та тоолсон ч болно гээд гараараа заалаа.
- Тогава сан, гэхдээ танаас ганц зүйлийг гуйя. Та миний дэргэд Буянттай уулзах ёстой! Танд ямар нэг гай учрахгүй гэдгийг амлаж болно. Ингэвэл таны алдар нэрийг баттай хамгаалж болно.
- За яая гэх вэ? Миний амь насанд хал балгүй юм бол би уулзъя гэж дурамжхан хэллээ.
- Маргааш өглөө та миний өрөөнд ирнэ. Таныг орж ирэхэд би, Буянттай ярьж байх байх. Та Буянтыг таниагүй юм шиг байгаарай. Тэгээд миний ширээнд дөхөнгүүт «Орой манайхаар очоорой» гэж хэлээд өрөөнөөс гарах хэрэгтэй. Ойлгов уу? Харин маш энгийн, тоомсоргүй байх тусмаа сайн шүү!
- Ойлголоо. Энэ чинь бол болмоор юм шиг санагдана. Харин цаадах чинь миний бараанаар бариад авбал яана. Тэр чинь улаан галзуу амьтан шүү гэж болгоомжлон хэлэхэд Симото,
- Токиогийн зоогийн газар болсон тэр явдал дахин давтагдахгүй. Ер нь тэр уулзалт таны зүрхэнд шар ус хуруулчихжээ дээ! гэж хэлээд Тоговагийн сэтгэлийг засав. Тогава, Симотогийн өрөөнөөс гарахдаа «Энэ хошууч тун нарийн судалжээ. Токиод болсон сүүлчийн уулзалтыг хүртэл мэдэж байна» гэж бодлоо.

Тогава гэртээ ирээд, үүдээ түгжиж аваад гурван шил архи уугаад ухаан балартав. Ингэхгүй бол Тоговагийн сэтгэлд өнгөрсөн бүхэн бодогдоод нүднээ үзэгдэн амар заяа үзүүлэхгүй байлаа. Тэрээр

өглөө болтол унтаад босохдоо согтуу нь гараагүй байлаа. Тэгээд Симотогийн өрөө рүү очих цаг болсон тул зүрхээ чангалахыг хичээж нэг шил сакэ балгаад дөрөө чангалав.

Тогавааг квантуны армийн штабт согтуу орж ирэхэд ерөнхий жижүүр, түүний толгойноос хөл хүртэл сүрхий харснаа харилцуураа авч, Симотогийн өрөө рүү гэлдэрч яваа Тоговагийн араас ширтэн ажиглаад,

- Шиү са дон оо (эрхэм хошуучаа?) Тогава сан их согтуу ирлээ. Гэсэн ч удирдамж ёсоор штаб руу орууллаа. Одоо таны өрөө рүү явж байна гэж илтгэв. Тогавааг Симотогийн өрөөнд ортол түүний туслах угтан уулзаад,

- Тогава сан, та шиү са доноогийн өрөөнд ороод тэнд байгаа хүнтэй мэндэлж ч болохгүй гэж сануултал Тогава,

-Би өөрөө мэднээ гээд Симотогийн үүдний бариулаас атгаад өөр рүүгээ татлаа. Хаалгаар гуйвж, дайвсаар орж ирсэн Тогавагийн гадаад байдлыг хараад Симотогийн уур гэнэт оволзов. Гэтэл Тогава дайвалзахгүйг хичээж, бие барин алхсаар Симотогийн дэргэд ирээд нэг нүдээ аньсхийн Буянтыг тоомсоргүй харж ярвайхыг ажваас баригдсан хүн гэж бодсон нь илэрхий байлаа. Чухам энэхэн үед янжуураа асааж байсан Симото «Энэ лүд чинь аймхай мөртлөө овжин золиг юм. Аятайхан арга олсон байна. Тэгээд яггүй жүжиглэж байхыг нь хараач» гэж бодоод сэтгэлийнхээ бухимдлыг барьж, тайвширлаа. Тогава харцаа тогтоож ядан харснаа,

- Симото сан, чи чинь хүн байцааж байгаа юм уу. За яахав би явлаа. Харин орой манайхаар очоодохоорой гээд үүд рүү эргэв. Тогава гуйвж дайвсаар хаалганы дэргэд очиход Буянт түүнийг ажиглаагүй царайлж суухыг мэдсэн Симото сэтгэлдээ «Энэ чинь Буянт биш болох нь! Буянтын нэрээр ирсэн монголын тагнуул болж таарлаа шүү» гэж бодоод суудлаасаа өндийтөл Буянт, хаалгаар гарах гэж байсан Тогавааг агшин зуур барьж аваад хорсолтойгоор,

- Тогава сан гэж хахир муухай дуугаар хашгиртал өнөөх нь согтуу нүдээ онийлгон гайхсан байдлаар Буянт руу харснаа,

- Эрхэм ээ яаж байна? Та надад юм хэлэв үү гэж хайхрамжгүй асуулаа.

- Аа мөн дөө. Намайг танихгүй хүн болж даажигнаж байна

уу? Би чамайг үхсэн байхад ясаар чинь танина гээд зүүн гараараа эрүүн доороос өлгөн, хүчтэй цохиод ухаан балартаж тэнцвэрээ алдан тонгойх тэрхэн эгшинд хоёр гарын зангидсан нударгаар ар дагз руу нь буулгав.

Симото энэ бүхнийг харж зогсохдоо Токиогоос ирсэн тодорхойлтонд зоогийн газар ингэж цохисныг гэрчилсэн хүмүүсийн мэдүүлэг хавсаргасныг санах. Симото, Буянтын дэргэд ирж, шалан дээр ухаангүй байгаа Тогава руу тонгойн харснаа,

- Буянтаа, та хэтрүүлчих шиг боллоо. Уг нь дагз руу нь цохих хэрэггүй байсан юм гэхэд Буянт,

- Би ямар ч юмыг дутуу хийх дургүй хүн шүү. Гэхдээ дутуудуулчихсан. Уг нь алах байсан юм гэж хэнэггүй хэлэв.

Симото энэ үгийг л Буянтын амнаас дуулах байсан. Учир нь Буянтыг Токиогийн цагдаагийн газрынхан яг л Симотогийн адилаар асуухад Буянт саяынх шигээ хариулсан болой.

Симото удирдамж ёсоор Буянтыг шалгасан эцсийн сорилтын дүнг даргадаа илтгэлээ.

- Тайса доноо (ноён хурандаа) Амисээг Чанчуньд ирүүлбэл яасан юм бэ? Бидний сэжгийг

тайлах эцсийн найдвар бол ганцхан Амисэ үлдлээ гэхэд Симо тоогийн илтгэлийг уншиж суусан хурандаа,

- Шиү са (хошуучаа) энэ талаар би бодож байна. Гэхдээ удирдлагаас зөвшөөрөл авах ёстой. Харин одоо Буянтын саналыг дэмжиж Харбин руу явуулсан дээр. Бид өөрийнхөө хэмжээнд сорьж үзлээ. Энд болсон бүх явдал Токиогийн тодорхойлолтонд орсон баримттай яг тулна гэдэг бол жинхэнэ нотолгоо. Буянтаас өөр хэн ч хийж чадахгүй зан араншингийн гойд онцлогийг ямар ч авьяастай тагнуулч давтах ёсгүй. Энэ бол түүнийг жинхэнэ Буянт гэдгийг баталж байна. Гэхдээ яах вэ? Ингэсхийгээд өөрт нь их сэжиг өгөлгүй орхих нь дээр. Харин Харбинд очсон хойно ажиглалтаа улам чангаруулах хэрэгтэй. Тиймээс цагдаагийн газар явуулах тодорхойлолтыг тун сэжиггүй, Буянтын хүслийн дагуу хийж өг! Чингээд цаашдаа Буянттай хэрхэн ажиллаж, ажиглах тухай нарийн төлөвлөгөө гаргаж танилцуулаарай гэлээ. Хошууч ч хурандаагийн энэ саналыг дуртай хүлээн авлаа. Буянт Синьзин буюу Чанчуньд хүргэгдэж ирснийхээ дараа Харбинд суурьшиж хувцас засварын газар нээх зөвшөөрөл гуйсан юм. Одоо түүний хүслийн дагуу Харбин руу явах бичиг баримтыг бэлдсэн Симо то, нэгэн өдөр Буянттай уулзаад,

- Буянт сан, монголын үйзэн бэйсийн нутагт байдаг тэргүүн буянт гэдэг нэг хийдийн өмнөх суварганд байдаг цул алтан очир алга болсон гэдэг. Одоогоос хоёр зуугаад жилийн өмнө Авгын нэгэн баян өөрийнхөө охиныг монголын удам судартай нэг хүнд хатан болгож өгсөн гэдэг. Тэр хатнаас төрсөн нэг хүүг Манжийн хаан алтан очиртын хувилгаан гэж өргөмжлөөд алтан очир хайрласан тухай албан баримт болох айлтгал, зарлиг Мугдэн дэх Манжийн хааны нууц сангаас олдсон. Та наашаа явахдаа Алтан-Очиртын хийдийг дайрсан шүү дээ. Таныг Вангийн сүм дээрээс баривчилж нэгжихэд нэг Алтан-Очир гарсныг манайхан дээд газрын шийдвэрээр танд буцааж өгсөн. Та түүнийгээ эндэхийн худалдаачдад дамласан байсан. Тэгэхээр энэ домог танд ямаршуухан санагдаж байна гэж Симо тоог ацаг хөлс нэхэж сурсан заншлаараа асуухад Буянт түүний эчнээний бодлыг мэдээд, хайхрамжгүй байдлаар,

- Симо то сан, та энэ тухай надтай анх уулзахдаа хэлсэн бол бидний ярианд ийм их ээдрээтэй чирэгдэл гарахгүй байсан юм. Тэгээд танай шалгалтын хугацааг тэсэж өнгөрүүлэхийн тулд Синьзинд хэдэн сар болохдоо халаасаа хоослох шахлаа. Гэхдээ их юмны шавхруу гэсэндээ жаахан юм үлдсэн шүү гээд Буянт халааснаасаа хоёр цэнгийн алтан бөгж гаргаад Симо тоод өгөхдөө,

- Симо то сан, танаас хамгийн сүүлд гуйх нэг зүйл байна. Би ер нь зөн билэгтээ биширч явдаг болохоор сэтгэлд орсон сэвээ арилгамаар байна. Тиймээс Буянт гэдэг нэрээ кэмпэйтайд байхдаа нэрлэж байсан Аяанаосу гэдэг нэрээр өөрчилмөөр санагдаад байна. Тэгэхдээ бүүр танай газрын зөвшөөрлөөр шүү гээд инээмсэглэхэд Симо то,

- Тэр бололгүй яахав. Би зохих ёсны албан хүмүүстэй ярилцаад хариу өгнө гэж амлалаа.

Гурав. Чоно үүрэндээ өлзийтэй

Буянт Харбинд ирэнгүүтээ Модрен буудалд гурван өрөө хөлсөлж авлаа. Тэгээд хотын цагдаагийн газар очиж бүртгүүлэхдээ Аяанаосу гэдэг нэрээр бүртгүүлэв. Харбины цагдаагийн газрын нэг дарга түүний нэрийг сольсон албан ёсны бичиг баримттай танилцаад,

- Аяанаосу сан, та жаахан хүлээхгүй юу гээд өрөөнөөсөө гарлаа. Тэгээд төдий удалгүй буцаж ирээд,

- Аяанаосу сан, таныг манай хэсгийн дарга уулзъя гэж байна гээд өрөөг нь зааж өглөө. Хижээл насны дэд хурандаа гийчнийхээ толгойноос хөл хүртэл ширтэн,

- Аяанаосу сан, ший са Симото сан, надтай утсаар ярьсан. Харин Тогава сан, гомдол мэдүүлээд байгаа сурагтай гэж хэлэхэд Аяанаосу,

- Чиү са доноо, тэгвэл би та бүхэнд багагүй чирэгдэл тарих байх даа. Би өөрөө эрхэм дээдэс Тояама санд илтгэхээс биш дээ. Генерал, Тогавагийн ааш занг андахгүй болохоор татаж авна биз гээд халааснаасаа «Челстр фильм» хэмээх америк янжуур гаргаж дэд хурандаатай тамхилав.

- Аяанаосу сан, Тогава ший саатай тохиролцож чадна. Тэгэхээр бид бие биенээ ойлгох хэрэгтэй биз дээ гэж хэлээд сэтгэлдээ «Ерөнхий сайд Окадагийн танхим улс төрийн хямралд ороод одоо сэйюкай нам, Хар луу нийгэмлэгийнхэн дэмжээд байгаа. Хэрвээ минсэйто нам парламентын сонгуульд ялагдаж, Араки сайд нарын танхимыг толгойлбол Тояамагийн удирддаг Хар луу нийгэмлэг, дурамжхан хүмүүсээ толгой дараалан дансалж нудрах болно. Аяанаосу гэдэг зохиомол нэртэй энэ лүдийг ирээдүйд монголын ажиллагаанд оролцуулбал Тояама үүнийг Доихара, Тозияа хоёрын нэгэнд шилжүүлнэ. Тиймээс энэ золигтой үг хэлээр шөргөөцөлдөөд яах вэ» гэж бодов.

- Чиү са доноо, таны санал надад аятайхан санагдаж байна. Харин надад яльгүй хүсэлт бий. Оросын дүрвэгсдийн товчооныхонтой танилцъя гэж бодож байгаа. Тэд европ хувцас сайн хийдэг хүүхнүүдийг андахгүй биз дээ. Энэ явдалд таныг тусалбал ачийг чинь мартажгүй хариулж чадна. Надад сайн

оёдолчид хялбархан олдохгүй. Тэгэхээр Оросын товчоогоор дамжуулж оёдолчин олбол зүгээр байх.

- Аяанаосу сан, тэр талаар тохирч бололгүй яах вэ. Харин танд зөвлөхөд Харбинд ари нарын хувцас захиалгын газар байгуулснаас харин ямато нарын хувцас захиалгын газар байгуулбал илүү хожоотой шүү.

- Их Наран улсын арми зүүн умард хятадад шинэ дэглэм тогтоосон ч гэсэн эндхийн сурвалжит хүн амын ихэнхийг ари нар эзэлдэг. Тэгэхээр олны аяыг дагах нь наймаачин хүнд ашигтай байдаг. Харин ямато үндэстэнгүүд манжуур, зүүн умард хятадад ирж суурьшвал өөр хэрэг. Хөрсийг нь бордоогүй газар ургац муутай байдаг шүү дээ.

- Аяанаосу та, ирээдүйгээ бодох хэрэгтэй. Засгийн газрын төлөвлөсөн ёсоор бол ойрын ирээдүйд манжуурын нутагт японы 40 мянган хүн ирж эзэмшил газартай болох бөгөөд нэг япон өрхөд олгох эзэмшил газрыг бид 4 га газраар төлөвлөж байгаа. Ер цаашдаа энэ таван жилд 1 сая япон хүмүүс зүүн умард хятадад ирж амьдрах ёстой. Ингэхээр та яматогийн үр ач нарын хувцасны сонгомол загварыг одооноос бэлдэж байх хэрэгтэй гэхэд Аяанаосу сэтгэлдээ «Энэ хөгшин армийн нууцын нэг болох хүн амын шилжилтийн талаар ёстой гэнэгүй ам алдав аа? Япончууд өөрийнхөө иргэдийг манжуур, зүүн умард хятадад авчирч үржил шимтэй газрыг нь булааж аваад нутгийн ард түмнийг хөөх юм гэсэн нь үнэн байх нь ээ» гэж бодлоо.

- Би юуны өмнө тэнхрэх хэрэгтэй. Тэгээд ирээдүйн хувьд гэвэл таны энэ сайхан саналыг мөрдлөг болгожгүй яахав. Харин таныг болгоовол бүгдээрээ Модрен зоогийн газар цуглаж ярилцвал ямар вэ? Тэгээд гэйша нарыг урьж болно гэхэд дэд хурандаа,

- Тэгье л дээ. Би дуртай байна гэлээ.

Буянт гэдэг нэрийг Аяанаосу гэдэг нэрээр сольсон Гунгаа төвийн төлөвлөсөн ёсоор квантуны армийн тагнуулын газрын анхны сорилтыг давж, Харбинд ирээд хэд хоносны дараа Модрен буудлын хоёрдугаар давхарт тусгай өрөө бэлдүүлж, Харбины нөлөөтэй хүмүүсийг цагдаагийн газрын нэгэн хэсгийн даргаар уриулав. Чингээд сарын дараа хуучин хувцас сэлбэн засах захиалгын газар нээж «Харбины цаг», «Дүрвэгсдийн дуу хоолой» сонинд зарлал бичлээ.

Юки, оройн хоолны дараа их өрөөнд орж, усан оргилуурын дэргэд сууж тао загаснуудыг хооллож байхдаа «Харбины цаг» сонины сүүлийн хуудаснаа бичсэн зарлалуудыг гарчиглана. Харин Тозияа, өөрийнхөө өрөөнөөс гарч ирээд өрөөний нэг хананы ширээн дээр байгаа утсаар ярина.

- Доихара сан, умард хятадад байгаа японы армийн удирдагч Умэзу, гоминдааны армийн жанжин штабын дарга Хэ Инь Цинь хоёрын хийж байгаа хэлэлцээ ирээдүйтэй байна. Ямар ч байсан Хэбэй мужийн талаар зөрөлдөөнгүйгээр манайд шилжүүлж өгөх нь бололтой. Тиймээс таван мужийн тэргүүн нарын зөвлөгөөнийг хийлгэж (Зүүн умард хятадын гурван муж Хэйлунзян, Гирин, Ляонин, Хэбэй, Өвөр монгол) Хэбэй Цахарын улс төрийн зөвлөлийг байгуулах асуудлыг бэлэн болгох нь чухал! Би өвөр монголын өөртөө засан тохинох эрхийн асуудлаар нэлээн юм бодож байгаа. Ер нь төрийн тэргүүнээр Дэ ванг (Дэмчигдонров) томилж, генерал Ли Шоусиныг цэргийн командлагч болгох нь зүйтэй байх. Халхын сүмийн асуудлаар гарсан шуугианы дагуу монголын тал, манай саналыг зөвшөөрөхгүй болохоор хилийн мөргөлдөөнийг даамжруулах арга зам хайх хэрэгтэй. Нөгөө талаар танайхны бэлдэж байгаа тагнуулын сургуульд монголын гүнд явуулах хүмүүсийг сонгон суралцуулах явдлыг түргэтгэх хэрэгтэй.

Харин сая монголын хилийнхэнд баригдсан хүмүүсийг эргүүлэн авч болохгүй. Харин түүний оронд «Тэдгээр хүмүүсийг армиас бэлдэж явуулаагүй бөгөөд монголын хуулийн дагуу арга хэмжээ авах ёстой гэж тулгах нь зүйтэй. Тэгэхдээ тэднийг өөрсдийн дур зоргоор хил нэвгэрсэн гэдэг шалтаг гаргах хэрэгтэй. Танай ус шинжилгээ гэдэг ажиллагаанд орсон өнөө дэслэгч Ясихато манай ажиллагааг баллах шахсан. Түүнийг эрлэгийн элчид тушаагаад өнөө барга залууг суллуулж, Халх голын сав газрын зураглал хийх ажилд газарчингаар оролцуулах ашигтай биз. Бид ямар ч байсан байр зүйн зургийн мэдээ баримт цуглуулах ёстой гэдгийг

мартаж болохгүй...

Тозияа Доихаратай ажил төрлөө ярилцаж дуусаад Юкигийн дэргэд ирж усан оргилуурын дотор төхөөрөмжилсөн цахилгаан

гэрэлд шумбан, сагсгар цацган сүүл, сэлүүрээрээ уран хөдөлгөөн гарган сэлж байгаа загасыг ажиглан, цагаан гантиган хашлагын дагуу тавьсан бонсай навчийг цэвэрлэж сууна. Чухам энэхэн үед хажуугийн өрөөнөөс орж ирсэн Сувдаа, тавиур тавьсан цайны хэрэгсэл, хятад ногоон цайны хандтай гүц аяга тэргүүтнийг явган ширээн дээр тавиад өрөөнөөс гарлаа. Тозияа хоолны дараа хятад ногоон цай уудаг заншлаар цайгаа аягалаад тагийг нь тавингуут,

- Улаан орос зүүн умард хятдын нутагт байдаг дорнод төмөр замыг бүх хөрөнгөтэй нь 170 сая иениэр худалдахаар шийдсэн байна. Дорнод төмөр замыг худалдаж авсны дараа зохион байгуулалтын талаар өөрчлөх ёстой. Тэгэхээр нь хувь нийлүүлж, шинэ нийгэмлэг байгуулах явдалд чи хөрөнгө тусалбал ямар вэ? гэж аятайхан асууна.

- Би өөр юм бодож байгаа. Хайлар, Харбины төмөр замыг өргөтгөх асуудал, Хайлар Ганжуур сүмийн хооронд төмөр зам тавих ажиллагаанд оролцож хувь нийлүүлбэл надад ашигтай. Нөгөө талаар Халуун Рашаан, Ирэши, Ханширээгийн төмөр замыг ашиглалтанд өгөх гээд байгаа шүү дээ гэж хэлэхэд Тозияа сэтгэлдээ «Энэ ч зөв замаараа явж байна. Тиймээс энэ саналаасаа гуйвж дайвахгүй хэрэг» гэж бодоод Юкигийн саналыг дэмжсэн царайгаар,

- Тэр нь ч дээр байх гэж зөвшөөрлөө. Үнэндээ дорнод төмөр замын нийгэмлэгийг байгуулбал түүнд хөрөнгө нийлүүлж хоршуулах санаа өгч алтны тухай сэжим гаргах гэсэн Тозияагийн энэ удаагийн бодол талаар өнгөрлөө.

- Ер нь ойрын үед Харбины Оросын дүрвэсгдийн товчооныхонтой уулзаж, тэндхийн төмөр замд ажиллаж байсан оросуудтай уулзах санаатай. Тэгээд Иван Степановичтой уулзаж яримаар юм байна гэхэд Тозияа, Юкигийн царайг ширтсээр «Ойрдоо Сафроновын хүүг яриад байдаг болж дээ. Өдий хүртэл ганц бие, зожиг өссөн, ихэмсэг зан араншинтай хүн эрчүүдэд дурламааргүй сан. Яагаад Сафроновын хүүг үгүйлээд байдаг болчихоо вэ? Эсвэл Хабрины төмөр замын хуучин захиргаанд ажиллаж байсан төмөр замын инженер зураг төслийнхөнтэй танилцах гэж байгаа юм болов уу?» гэж бодоод,

- Юки минь тэр чинь чухал хэргийн нэг. Ирэх онд армийнхан

сайд нарын танхимыг толгойлж чадвал үйлдвэрийн эздийг өөртөө татаж, монголын талаар онцгой ажиллагааны төлөвлөгөө зохионо. Тиймээс одооноос эхэлж, монголын Халхын сүмээс Тамсаг, Матадаас Егүзэрийн хийд, тэндээсээ Сулинхээрийн чиглэлд газар зүйн судалгаа хийх гэж байгаа юм. Энэ явдалтай уялдуулж, Панчэньд тагнуулын онгоцны буудал байгуулах билээ. Гэтэл Хаалган дахь америкийнхан манай ажиллагаанд саад хийж цуурхал тараагаад байна. Гэхдээ үүнээс айх юмгүй.

- Аав аа энэ чинь тэгээд өнөө Оцу гэдэг төлөвлөгөөний зохицуулалт уу? Эсвэл биеэ даасан ажиллагаа юм уу?

- Юки минь энэ бол Сэй буюу баруун гэсэн биеэ даасан тусгай ажиллагааг боловсруулаад байгаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл Синьзингээс баруун тийш Халх гол руу чиглүүлсэн ажиллагаа юм.

- Аав аа, та надтай хамт Харбин явах уу? Хоёулаа бол ч Оросын дүрвэгсдийн товчооныхонтой ярилцахад дэмтэй шүү дээ.

- Юки охин минь оросын товчооныхонд хэдэн юм өгөхийг бодоорой. Оросын дүрвэгсдийн товчоо, өнөө шинэ фашист холбооны дэргэд тусгай хүмүүсийг бэлтгэх түр сургууль байгуулах ёстой. Гэтэл хөрөнгөгүйдээд байгаа бололтой. Хэдэн юм чулуудчихвал цаадуул чинь өөрснөө гүйгээд чиний хэргийг бүтээчихнэ. Харин би, чамтай хамт явж чадахгүй. Доихара, бид хоёр Сөнөд хошуугаар орох ёстой гээд бонсайн дэргэдээс босож өрөө рүүгээ явлаа. Юки өөрийнхөө өрөөнд орж ирээд тэмдэглэлийнхээ дэвтрийг нууцын шүүгээнээс гаргаад, энэ өдрийнхөө онцлог зүйлийг тэмдэглэв.

...Сэцэн хан аймгийн Хурц вангийн хошууны Ойдовдаржаалин (Егүзэрийн хийд) хийдийн дархан цорж лам, Да хүрээний Ёнзон хамба нарын илгээсэн хүн Харбинд иржээ. Тэдэнтэй уулзах санаатай Тозияагийн төлөөний хүмүүс Өлзийт хийд, Сан бэйс Байшинтийн хийдээр байдаг ажээ...

Юки асарсан эцэгтэйгээ чингэж ярилцсанаас хойш долоо хоноод Сувдааг дагуулж, Харбин дахь оросын товчооноос зохион байгуулсан цагаачдын уулзалтанд оролцохоор Мугдэнгээс гарлаа. Тэгээд Харбинд ирээд Модрен буудалд буулаа.

- Эгч ээ оросын товчооноос Мешанов гэдэг хүн ирлээ гэхэд

Юки,

- Тэр торх шиг новш нойтон хамуу шиг салахгүй нь ээ. Чи Харбины салбар банкныхантай уулзаж хадгаламжийнхаа хүүний тооцоог хийгээд, нөгөө европ хувцасны захиалгын газраар ороод ир. Цагаачдын уулзалтанд европ хувцастай очсон дээр гэлээ.

Зуны тэргүүн сар өнгөрмөгц нарны илч нэмэгдэж, хүмүүс нимгэн хувцастай явдаг болжээ. Харбин хотын барилга европжсон болохоор гол гудамж нь дөрөв таван давхар байшин олонтой. Барилгуудын тагт дээр нэг наст ургамал тарьсан тул хотын гудамж үзэмжтэй болой.

Сувдаа, Харбинд байдаг америкийн банкны салбартай тооцоо хийгээд хүү мөнгөнөөсөө Харбинд хэрэглэх хэдэн юм авлаа. Тэгээд гудамжнаас хөлсний морь тэрэг олж суугаад хувцас захиалгын газар руу очив. Тэрээр гудамжны эхэнд барьсан байшингийн дэргэд буугаад «Аяанаосугийн хувцас захиалгын газар» гэсэн хаягтай байшингийн хаалгаар орлоо. Япон заншлаар хувцасласан Сувдааг гаднаас орж ирэх бараанаар хувцас захилгын газрын эзний туслах түүнийг тосон авч уулзав. Манжуурт япон үндэстнийг тэгж хүндлэх ёс тогтоосон болохоор нутгийн худалдаачид түүнийг эрхэмлэнэ.

- Окусан, та юу сонирхох вэ? гэж японоор асуухад Сувдаа,

- Аяанаосу сантай уулзах юмсан. Завтайсан болов уу? гэлээ.

- Эзэн зав муутай байгаа. Гэхдээ би дуулгая, таныг хэн гэж танилцуулах вэ? гэхэд Сувдаа өөрийнхөө нэрийн хуудсыг гаргаж өглөө.

- Сувдаа сан, та жаахан хүлээж байхгүй юү гээд өнөө залуу хажуугийн хаалга руу алхав. Тэгээд удсангүй өндөр нуруутай, туранхай биетэй цагаан хүний хамт гарч ирэхийг ажваас захиалгын газрын эзэн Аяанаосу мөн бололтой.

- Сувдаа сан, та надтай уулзах гээ юү гэж ордос аялгуугаар асуухад Сувдаа,

- Тиймээ, танайд иймэрхүү бөс бараа хэрэгтэй юү гэж хэлээд гар цүнхнээсээ ноосон даавууны цуглуулга бүхий жижиг хавгас гаргаж үзүүлэв. Аяанаосу нэрээр Харбинд төвхнөсөн Гунгаа даавууны цуглуулгын хавтсыг үзээд таних тэмдгээ олж харангуут даавууны худалдаачин гэж сэтгэлдээ бодоод баярлав.

Японы түрэмгийлэгчдээс Зөвлөлтийн алс дорнод, монголын зүүн хязгаар руу чиглүүлсэн улс төр, цэргийн түрэмгийлэл, хорлон сүйтгэх ажиллагааны нууцыг илрүүлэх ёстой «Рожуганукай» ажиллагаанд оролцох, хамтран зүтгэгч ирснийг мэдсэн Аяанаосу, өөрийгөө санхүүжүүлж, чухал баримтаар хангах ёстой хүн, эмэгтэй байсанд багагүй гайхжээ.

Аяанаосу, нууц түлхүүрийн дэс дарааллаар сорих түлхүүр хэрэглэж шалгаад даавууны өөдсийг сонирхож байгаад,

- Иймэрхүү даавуу хэрэгтэй юмсан гээд цайвар саарал өнгөтэй тагнайлдсан хээтэй даавууг заалаа.

- Аяанаосу сан, танд аль зэрэг хэрэгтэй вэ? гэж Сувдааг асуухад,

- Хоёр мянган мод гэж хэлэв.

- Аяанаосу сан, ердөө хоёр мянган мод уу? гэж Сувдааг хэлэхэд, Аяанаосу хажуугийн хаалга руу заагаад,

- Хоёулаа манай өрөөнд орж ярих уу даа гэлээ. Аяанаосу өөрийнхөө өрөөнд орж ирсний дараа үүдээ хаагаад наагуур нь хөшиг татангуут,

- Сайн байна уу? Би таныг ирнэ гэж санасангүй шүү гэхэд Сувдаа гар цүнхээ уудалж, зуутын дэвсгэрээр толгойлсон хоёр боодол доллар гаргаж,

- Үүнийг хэрэглэж бай. Мөнгөний хэрэгцээ гарвал барьцааны газраас зээлээд «Харбины цаг» сонинд сувдан эдлэл худалдаж авна гэдэг зарлал нийтлүүлээрэй. Таны ажил тэгээд ямаршуухан байна даа гээд өнөө доллараа өглөө.

- Одоохондоо зүгээр байна. Ер нь бэлгүйдээд барьц алдах шахлаа. Одоо энэ хорин мянган доллараар чинь их юм хийнэ. Хувцас захиалгын ажил барагтай. Орлого муутай байна гээд Аяанаосу ажил төрлөө ярилаа.

- Төвөөс холбоочин ирэхийг түр хойшлуулсан. Дохага-гийн (Дотоодыг хамгаалах газар) буухиа элч ирж тантай уулзана. Та удирдамж ёсоор Цицикарът очиж холбооны салбарт уулзах ёстой гээд уулзалтын болзоо, цаг, өдөр, нууц дохионы дарааллыг хэлж өглөө.

- Аяанаосу сан, Халхын сүмийн болон хилийн талаарх

асуудалд японы засгийн газар оролцохгүй байхыг хичээнэ. Тиймээс орон нутгийн цэргийн байгууллагын хэмжээнд тэр хэлэлцээг хийхээр шийдэж байгаа. Энэ нь монголын хилийг батлах албан ёсны баримт гарч ирэхээс болгоомжилсон хэрэг! Квантуны арми, Халхын сүмээс Егүзэр, Байшинтын чиглэлд газрын зургийн тодруулалт хийх гэж байгаа. Энэ ажиллагаанд зориулж Сөнөд хошууны нутаг Панчэньд тагнуулын нисэх онгоцны буудал байгуулахаар шийдсэн. Ер нь ойрын ирээдүйд монголын дорнод хэсгээр хилийн будлиан гаргах төлөвлөгөө зохиосон. Монголын хилээс 200 км байгаа Панчэньгийн онгоцны буудал бол алсдаа японы цэргийг Гуаньдунгаас Тяньжин руу татаж, тэндээсээ Бээжин рүү төдийгүй Бээжингээс Хаалганы чиглэлд тээвэрлэж байрлуулахтай холбоотой юм...

Сувдаа ийнхүү Аяанаосутай уулзаж ажил төрлөө ярилцаж, түүний сонирхож байгаа зүйлийг тодруулж өглөө. Чингээд Юкитэй болзсон цагтаа уулзахаар Аяанаосугийн захиалгын газраас гарч Модрен буудал руу чиглэв.

Аравдугаар жарны аравдугаар он, гал хулгана жилийн (1936 он) хаврын тэргүүн сарын хуучдаарх нэгэн өдөр Японы цэргийн дэслэгч цолтой, хорин тав зургаа орчим насны нэг дарга Аяанаосугийн захиалгын, газар орж ирээд Аяанаосуг сураглав. Үйлчлэгч үүргийнхээ дагуу хамгийн түрүүнд японы армийн цэрэг, дарга нарыг хүлээлгэлгүй үйлчлэх журмын дагуу түүний дэргэд ирж толгой бөхийлгөн зогстол өнөө дэслэгч,

- Аяанаосугийн өрөөг зааж өг гэж шаардлаа. Үйлчлэгч японы цэргийн дэслэгчийг дагуулсаар эзнийхээ өрөөнд орж ирэхэд өнөө дарга,

- Чамайг Аяанаосу гэдэг үү? гэж дээрэнгүй байдлаар асуув.

- Эрхэм дэслэгчээ, танд юу хэрэгтэй вэ? Би өөрөө Аяанаосу биеэрээ байна гэхэд өнөө дэслэгч,

- Би Токиогоос саяхан ирсэн. Нэг эмэгтэй танд захиа дамжуулж өгөхийг хүссэн юм гээд барьж явсан хавтаснаасаа битүүмжилсэн хувийн дийзтэй захиа гаргаж өглөө. Аяанаосу

ажлынхаа ширээний хажуугийн сандлыг өнөө дэслэгчид тавьж өгөөд,

- Ноён шүү и, та суугаач гээд захиаг задлахдаа «Симотогийн шалгалт дахиад эхэлж байгаа нь энэ байх даа. Ямар сэжиг гаргаад түүнийгээ шалгах гэж байгаа бол» гэж бодлоо. Аяанаосу захиаг задлангуут эцэст нь байгаа гарын үсгийг хараад Амисэгийн захиа гэдгийг ойлгов.

«...Аяанаосу сан, Тогава сан Синьзинд болсон явдлыг манай нөхөрт бичсэн байна. Би чиний сургийг дуулаад яагаад ч юм бэ сэтгэл зовоод болохгүй болохоор захиа бичлээ. Би чамтай танилцсанаас хойш ганцхан зүйлийг гүнээ ухамсарладаг. Би чамд хязгааргүй хайртай. Гэвч

тэр хайр чамайг төдийгүй намайг боомилж мэдэх хайр билээ. Тогава болон квантуны армийн тагнуулын газрын ажилтан Симото нар намайг Синьзинд хэрэг болгож ирэхийг хүсчээ. Би чамтай уулзахын тул Синьзин руу очмоор байна. Гэсэн ч би чиний өмнө түмэн буруутай болохоор царайг чинь яаж харах билээ. Би чамтай уулзаж болохгүй. Чиний царайг дахин харвал энэ ертөнцөд хоргодох сэтгэл надад төрөхгүй. Тиймээс айж байна. Тиймээ... айх сэтгэлийн угт ганцхан хүүгээ зовоож, элгийг нь хатаахгүй хүн болгох юмсан гэж бодохоос айж байна. Эмэгтэй хүн, сэтгэлийнхээ хамгийн гүн эмзгийг хөндсөн нууц увдистаа захирагдвал эр нөхөр, ганц хүүгээ ч мартаж, гагцхүү өөрийнхөө чин сэтгэлийн хайраа бодож, тэнэглээд нүгэлт хорвоогийн намагт шигддэг юм байна. Үүнийг мэдсээр байж би, чамтай очиж уулзана гэдэг бол аюултай. Тиймээс би, очихыг хүсэхгүй байх ёстой.

Чи үүнийг ойлгож байгаа шүү дээ. Би чиний сургийг гаргаж, чихэндээ сонсож явахын тулд энэ хөгшинтэй суусан. Гэтэл миний зовлонг бурхан хөнгөлж өгсөнгүй бүүр хүндрүүллээ. Би ганц сэтгэлээрээ зовдог байсан бол одоо бие, сэтгэлээрээ тамд ойчжээ. Ганц биеэрээ явсан бол чамтай хамт тамд очиж, хойд насандаа жаргал зовлонгоо хуваалцмаар байна. Гэтэл үхэж болохгүй. Чамтай ч уулзаж болохгүй. Чи ойлгож байна уу! Би үхэж болохгүй. Чамд хайртай Амисэ чинь, түмэн буруутай нүгэлт Амисэ...» Аяанаосу захиаг уншаад хоромхон хугацаанд зөв оновчтой шийд гаргах ёстойгоо ойлгов. Захианы үг бүрийг ажвал сэжиглэгдмээр

өө сэв байхгүй аж. Үүнээс үзвэл Симотогийн хүмүүс ийм захианд мэргэжсэн гэдэг нь илэрхий. Тиймээс Аяанаосуг Буянт мөн үү гэдгийг сорих ажлаа үргэлжлүүлэн байгаа нь илэрхий. Харин Амисэгийн хайр дурлалыг эргэцүүлбэл тэрээр Манжуурт ирэхээсээ татгалзаж байгаа нь Аяанаосуд өөр бодол төрүүлнэ. Нөгөө талаар энэ захиаг өгч явуулсан дэслэгчийн нэрийг Хасу Тоиши гэж бичихдээ нэрийн өмнөх галигийг нарийвчилбал эхний үе нь харь хэлний нэр болох нь илэрхий агаад тоиши, гэдэг нь эртний япон хэлний эрдэнийн чулуу гэсэн үгээс гаралтай байж мэдэх талтай. Чингэвэл Хасу Тоиши гэдэг нь Хасчулуу гэсэн монгол нэр бололтой.

Аяанаосу, Амисэгийн захиаг уншаад төдий их тоосон шинжгүй байхыг хичээгээд, захиаг ширээн дээр чулуудангуут,

- Эрхэмсэг ноёд надаар тоглоом хийж, даажигнасаар байгаа юм шив дээ. Эр хүний халуун өвөрт хэвтсэнээ хайр гэж боддог мөн энэрэнгүй сэтгэлээ гэж дургүйцсэн янзтай хэлснээ, эрхэм шиү и минь та, Токиод очвол тэр хөгшин, залуу хоёрт амьд арзайж, мэнд мэлтийж явна гэж хэлчихээрэй. Одоохондоо тэднээс гуйх юмгүй, бурхны ивээлээр овоо явж байна гэж дамжуулж үзээрэй гэж өвөр монголын ордос аялгуугаар хэлэхдээ тайжууд отгийнхны аялгууг дагаж хос эгшгийг урт эгшгээр сольж хэлэв. Аяанаосугийн үгэнд дургүй нь хүрч эгдүүцсэн Хасу Тоиши,

- Амисэ таныг чин сэтгэлээсээ хүндэтгэдэг юм шүү. Тэр чинь таны өмнө буруутай ч гэсэн хайр сэтгэлдээ буруугүй гэж шазруухан хэллээ. Аяанаосу дэслэгчийн үгийг сонсоод,

- Хасчулуун минь хоёулаа манайд очиж ярилцъя. Албаны өрөөнд ийм юм ярих дэмий байдаг гэж хэллээ. Аяанаосу гэртээ орж ирээд ханын шүүгээнээс архи гаргаж, гэрийнхээ үйлчлэгч нэгэн бүсгүйг дуудаж хоол бэлдэхийг тушаагаад,

- Эрхэм шүү и, та бид хоёр сайхан танилцлаа. Бид чинь элэг нэгтэй нутгийн хүмүүс шүү. Амисэгийн нөхөр таныг ингэж холбоо зөөдгийг мэдвэл та бид нүд ирмэхийн зуур тээрмэнд орсон будаа шиг яйчуулна даа гээд хундагатай архиа өргөв.

- Аяанаосу сан. Тийм эвгүй юм болохгүй. Амисэгийн нөхөр цэргийн яамны захиалгаар үйлдвэрээ цэргийн зэвсгийн үйлдвэр болгон шинэчлэх гээд толгой өндийлгөх завгүй байгаа. Тэгэхээр

эхнэрийнхээ хойноос шиншлэх завгүй гэсэн үг!

- Хасчулуун минь нөхөр нь шиншилдэггүй юм гэхэд нөхрийн нь нэр төрийг хамгаалах ёстой кэмпэйтэйнхан шиншилнэ шүү. Харин та Токиогийн сониноос яриач. Өнгөрсөн өвөл юу гэгч болов оо? Ёстой хорвоо хөрвөх гэдэг болсон сурагтай байсан.

- Хоёр сарын хоринд парламентын сонгууль болж, их гүрнүүдэд тал зассан нэр төрөө алдахгүйг хичээж, хятадтай дайн хийхээс айсан Минсэйто намынхан, ардчилсан хүчийг нэгтгэсэн Сякай тайсюто намтай хавсайдаад фашист төр тогтоож, дайн хийхийг эрхэмлэсэн Сэйюкай намыг түлхэх гээд чадаагүй юм. Сайд нарын танхимыг армийнханд шилжүүлэхийг шаардсан «залуу дарга» нар бослого гаргаад хэдэн хүний аминд хүрснээс цаашгүй.

Энэ үед Аяанаосугийн гэрийн үйлчлэгч бүсгүй орж ирээд халуун хоол унд авчирч ширээн дээр тавилаа. Хасу Тоиши хэмээгдэх Хасчулуун, халуун хоол, хятад архины аагинд ходоодоо эрхлүүлж яриа нь олширно.

- Бослогынхон засгийн газрыг эзлэнгүүт ерөнхий сайд Окадааг тонилгох гээд түүний туслах Дэнзо Мацуог устгажээ. Тэгээд ерөнхий сайд байсан Макото Сайтоог алчихсан юм. Харин эзэн хааны зөвлөх урт чихт Кантаро Сузуки, зөнөг Саёнзи, жанжин штабын Макино нар золоор амь мултарсан юм гээд ширээн дээрх хундагатай архиа хөнтөрчихлөө.

- Манай энд ерөнхий сайд Окадааг авсанд нуугдаж амь гарсан гэж цуурсан. Тэр үнэн үү? Токиод бас тэгж шуугиад байгаа юм. Ер нь ортой байх. Бослогынхон цэргийн яамны сайд Ёсузуки Кавасимагаас болгоомжлоогүй учраас тэр нь цэргийн Екосука баазаас их хүч татаж, дөрөв хоногийн дараа залуу дарга нарын үймээнийг дарсан Кавасима үүний дараа эзэн хаанд бараалхаж тэр үймээнийг зохион байгуулсан хүмүүсийн нэрийг тэнноод толилуулсан. Тэдний дотор Минами, Кайсо, Угаки, Араки, Мазакки, Хаяси, Абэ болон тагнуулын газрын дарга Татэкава зэрэг генералууд орсон байлаа. Кавасима, тэднийг албан тушаалаас нь зайлуулах шийд гаргахыг эзэн хаанаас гуйсан. Тэгэхэд нь эзэн хаан түүний саналд дургүйцээд хавьтуулаагүй гэдэг. Ингээд ерөнхий сайдаар орост элчин байж байгаад гадаад яамыг толгойлсон

Хиротоог болгосон. Удахгүй болох парламентын 69 дүгээр хурлаас цэргийн яамны төсвийг шинэчлэн батлах юм гэсэн.

- Хасу Тоиши сан, Хоки Хирото өөрийнхөө өнөө гурван зарчмыг одоо биелүүлэх бүрэн боломжтой болж дээ.

- Хятадаас америк зэрэг орнуудтай байгуулсан бүх гэрээг хүчингүй болгохыг эрхэмлэсэн Хиротогийн санаа биелэхгүй. Чан Кайшитэй хамтарч Хятад, Манж Го, Япон гурвын цэргийн эвсэл байгуулах гэдэг ч бүтэхгүй. За тэгээд японоос хятадад тогтоох гэсэн онцгой эрхийг их гүрнүүд яагаад ч зөвшөөрөхгүй. Ингэхээр алдар цуутай гурван зарчим хоосон зүйл болно.

- Хасу Тоиши минь тэгвэл Хиротогийн засгийн газар удахгүй юм шив дээ гэж хэлсэн Аяанаосу архи хундагалав.

- Тэгэлгүй яахав. Аягүй бол хагас жил бололгүй Хиротогийн засгийн газар огцорно гэхэд Аяанаосу японы улс төр, дипломат үйл ажиллагааг сайн мэддэг Хасу Тоишигийн боловсролыг гайхан хуурай үгээр магтав.

Аяанаосу, Хасу Тоиши хоёр ингэж танилцсанаас хойш сарын дараа шинэ танил нь Харбин дахь японы зөвлөхийн туслахын нэг болжээ. Тэгээд Хасу Тоиши өөрийнхөө танилуудыг нэг өдөр урьж, шинэ ажилд томилогдсон баярыг дорвитойхон тэмдэглэв. Хасу Тоиши, өөрийнхөө танилуудыг Харбинд суудаг холын хамаатан нэгэн хөгшин худалдаачныд урилаа.

Таван зуу гаруй тавагтай, зуу гаруй янзын хоол, зууш амттан тэргүүтнийг өрсөн ширээнээ хориод хүн сууцгаасан нь квантуны армийн албан хаагчид байлаа. Хятад ёсонд дайллага цайллаганд тавьсан тавагны тоогоор гэрийн эзний бэл бэнчинг үнэлдэг болохоор Хасу Тоиши удам угсааныхаа нэр төрийг армийнхны дунд алдахгүйг хичээснийг гэрчилнэ.

Ширээний тэргүүнд Харбин дахь японы зөвлөх генерал Хато заларч, Хасу Тоишигийн хүлээн авалтыг удирдана. Хасу Тоиши, Аяанаосуг хүлээн авалтандаа урьсан болохоор тэрээр эртний танил Симотогийн дэргэд суулаа. Аяанаосугийн зүүн гар талд Синьзинд шинээр ирсэн Ёоши сууж, түүний цаад талд нэг хошууч суужээ.

Симотогийн хажууд суусан энгийн хувцастай хүүхдэрхүү нэг эр, хошуучийн хундагыг өргөхөөс өмнө хоосолчихоод байхаар нь

Аяанаосу, Симотогийн хундагыг дүүргэнэ. Ийнхүү зочлолт цаг гаруй үргэлжилж байтал зочдын өрөөнд гэйша нар орж ирлээ. Чингээд дайлагынхан дууч, бүжигчдийн туяхан хөдөлгөөн, намуун хоолойгоор дуулах уянгын дууг сонсоцгоон шагшин магтана. Хасу Тоиши, өрөөний хананд шахсан урт диван дээр суусан Симото, Ёоши, өнөө залуу гурвын дэргэд очоод явган, ширээн дээрх архинаас хундагалаад Аяанаосуг дуудлаа. Тэгээд тэд тавуулаа хундага өргөөд Хасу Тоиши, өнөө залуугийн дэргэд сууж, Аяанаосу Симотогийн дэргэд суув.

- Эрхэм хошуучаа, өнгөрдөг долоо хоногийн ажиллагааг та юу гэж бодож байна. Миний бодлоор бол эгзгийг нь олоогүй юм шиг санагдсан. Бодоод үз! Ерэн машин цэрэг арван хоёр танк, их буу онгоцны дэмжлэгтэйгээр ердөө Тамсаг хүрээд ухарна гэж байх уу? гэж асуулаа.

- Хасу Тоиши сан, энэ бол таны хэлээд байгаа тэр эгзгийг нь олох ажиллагаа байгаа юм. Өөрөөр хэлбэл генералуудад хэрэгтэй зүйлийг хайсан.

- Манай генералууд байлдааны төлөвлөгөөг хийх гэж баримтууд хайж ядаж байхад Сталин, монголд амласан тусламжаа ирүүлчихвэл яана гэж бодож байгаа юм бол доо?

- Хасу Тоиши, тэгвэл бүр сайн шүү. Танай генерал Хатогийн асрамжинд байдаг Оросуудын боловсруулсан өнөө Сибирь, Лена, Байгалиар довтлох Сибайлен гэж нэрлэсэн ажиллагааг Оцу төлөвлөгөөний дагуу эхлүүлчихгүй юу гэж егөөтэй хэллээ.

- Эрхэм хошууч минь, улаан оросын гадаад яамны орлогч сайд, Москвад байгаа манай элчинд саяын ажиллагааны талаар эсэргүүцэл илэрхийлсэн байна гэхэд өнөө залуу Хасу Тоиши руу тонгойж,

- Та бид хоёр нэлээн халсан байна гэж анхааруулав. Чингээд Хасу Тоишигийн ирсэн гийчид өндөрлөх үед өнөө хошууч, Аяанаосугийн дэргэд ирээд сөөнгөтсөн хоолойгоор,

- Аяанаосу сан, танайх чинь цэргийн буудалд ойрхон байдаг гэл үү. Хоёулаа зам нийлэх үү дээ. Би овоо согтсон байна гэлээ.

Аяанаосу, Хайлар дахь... дивизийн морин цэргийн хорооны штабын дарга албатай хошуучтай нийлж, Харбин дахь цэргийн зочид буудал руу гэлдэрч явахдаа өөр хоорондоо юу ч ярьсангүй.

Харин хошууч ажил хэрэгч болохоор маргаашийнхаа ажлыг бодож, өөртөө үглэн сануулж «Маргааш чинь хамгийн түрүүнд Еоши сантай уулзах хэрэгтэй... Газрын зургийн энэ мэргэжилтэн жанжин штабт ажиллаж байсан мөртлөө манай энд саналаараа ирдэг сониноо! Маргааш толгой өвдөхгүй байгаасай. Сая америкаас авсан хоёр суудалтай дайрагч онгоц, бөмбөгдөгч онгоцноосоо манай дивизид өгнө гэдэг үнэн болов уу. Үүнийг Еоши сан мэдсэн байх. Эрх биш жанжин штабын ажилтан шүү дээ. Юмны зах зухыг андахгүй» гэж амандаа үглэнэ.

- Аяанаосу сан, та яагаад дуугүй явна вэ? Маргаашийнхаа ажлыг бодож байна уу? гэж асуулаа.

- Тэгэлгүй яахав. Наймаачин хүн гэдэг чинь яаж орлого олох вэ? гэдэг бодлоос хагацдаггүй юм гэхэд хошууч түүний үгийг зөвшөөрч,

- Тиймээ! Бид бол нутаг дэвсгэрээ өргөтгөж, баян чинээлэг болгохын тул дайн хийдэг. Худалдаачин хүн юмыг хямдхан үнээр аваад ахиухан үнээр зарахыг мэрийдэг болохоор нэг ёсны өвөрмөц дайн... Аяанаосу сан, та Хайларт очвол манайхаар заавал очоорой. Найтунд очоод шиү, са Мадака гэхэд заагаад өгөх хүн мундахгүй гэлээ.

Аяанаосу, хошуучийн яриаг далимдуулж шалгааж хоргоохыг бодсонгүй. Харин квантуны армийн нэгэн дивизийн морин хорооны штабын дарга, монголын хилийн дагуу байрлуулсан японы цэргийн талаар амандаа үглэхийг ажваас Буйр нуурын эрэг буюу Асар сүм дээр байрласан явган цэргийнхэнтэйгээ түнжин муутай болох нь илэрхий ажээ. Тэр хошууч өөрөө хор шартай болохоор бусад дарга нарынхаа ажлыг үгүйсгэж, өөрийнхөө хорооны амжилтыг алдар гавьяаны хэрэг болгох бодолтой учраас атаархамтгай ажээ.

- Аяанаосу сан, та эндээс буц. Маргааш чамтай уулзъя. Харин Харбин хотын хамгийн сайхан зоогийн газрыг зааж өгөхөө мартаж болохгүй шүү. Би чамайг урина гэж бардагнан хэлээд Аяанаосутай салах ёс гүйцэтгээд, гудамжны дунд хэрд байгаа зочид буудлын барилга руу

гэлдрэхийг ажвал цэргийн зочид буудлаар эргэлдэж, дарга нарын илүү дутууг бүртгэж байдаг хээрийн цагдаагийн газрын туршуулуудаас эмээсэн нь илт байлаа. Тиймээс буудал

хүрэхээс өмнө Аяанаосуугаас салах гэж бодсон нь илтээ.

Аяанаосу хувцас захиалгын салбар нээх асуудлаар Цицикарь орох зөвшөөрөл авахаар цагдаагийн газар руу явахдаа Хасу Тоиштой уулзахаар цэргийн зөвлөхийн газар руу очив. Аяанаосу хэмээгдэх Гунгаа төвөөс ирэх буухиа элчтэй уулзаж, Дохагад илгээх баримтуудыг дамжуулахын тул зам зуур тохиолдох шалгалтынханд үзүүлэх цэргийн газрын үнэмлэх олох хэрэгтэй байлаа. Цицикарь дахь хээрийн цагдаагийн газрын шалгалт хийдэг зохион байгуулалтын талаар багагүй судалгаа хийсэн Аяанаосу, Харбинд байдаг цэргийн зөвлөхийн газраас үнэмлэхтэй явбал илүү найдвартай гэдгийг Хасу Тоишигийн амнаас мэдсэн билээ. Тиймээс Хасу Тоиштой уулзаж, энэ талаар тохиролцохын тулд түүний үдийн хоолны цагийг дайруулж очих нь ашигтай байлаа. Зөвлөхийн газрын байшингийн голын хаалганаас гарч ирсэн Хасу Тоиши, Аяанаосуг хараад түүнийг угтан очиж,

- Чи чинь хаашаа алга болчихоо вэ? Би чамтай уулзах гэж үдээс өмнө хайгаад олсонгүй. Гэтэл сайн хүн санаагаараа гэгчээр ашгүй энд дайралддаг байна шүү гээд инээмсэглэв.

- Танай генералд бараалхъя. Уулзах хэрэг гараад гэж хэлээд «Хато хоёр хоногийн өмнө Хайлар руу явсан. Тэгэхээр ингэж хэлэх нь зүйтэй» гэж бодлоо.

- Гаккаа Хато сан байхгүй байгаа. Тав хоноод ирнэ. Та тийм их хэрэгтэй юм уу? гэж Хасу Тоиши асуулаа.

- Цицикарь явахын өмнө нэг бараалхаадахъя гэж бодсон юм. Одоо тэгвэл харьдаг юм билүү дээ. Хасу Тоиши сан, чи хаачих санаатай байна?

- Ходоодныхоо мухарт юм олж хийх санаатай явна.

- Тэгвэл хоёулаа үдийн хоолонд орёе.

- Тэгье. Тэгэхдээ энэ удаа би чамайг дайлна. Би чамайг хоолонд урих зав олддоггүй юм. Тэгсэн мөртлөө чамаар хэдэн ч удаа дайлуулав даа. Ингэхээр одоо миний ээлж болсон Докоэ юкимасука (хаашаа очих вэ?)

- Сибирь ресторанд очих уу даа.

Хасу Тоиши, Аяанаосугийн саналыг дагаж, даргынхаа жолоочийг дуудаж унаа залгаад хэдэн мөчийн дараа Харбины дүрвэгсдийн товчооныхон цугладаг Сибирь ресторанд ирлээ.

Рестораны гол танхимд зогсож байсан гоёмсог хувцастай метрдотель (зохион байгуулагч) тэр хоёрын бараанаар гүйх шахам алхаж, дэргэд нь ирээд хуурамчаар тал засан инээмсэглэж,

- Эрхэм ноёдоо тийшээ морилно уу гээд рестораны баруун хананд тусгайлан зассан ширээг зааж өглөө. Японы армиас манжуурт тогтоосон шинэ дэглэмийн нэг бол зоогийн газар орсон армийн албан хаагчдыг тусгай бэлдсэн ширээнд суулгах заншилтай тул наран эздийн өмнө

хүндэтгэн бөхөлзөх ёстой билээ. Тэр хоёрыг цав цагаан бүтээлэгтэй ширээний хажуу дахь зөөлөвтэй сандал дээр тухлан суутал тас хар хувцастай үйлчлэгч залуу ирж хоолны захиалга аваад явлаа. Аяанаосу хоол хүлээх зуураа халаасаа уудалж, Челстр фильд хэмээх янжуураа гаргаж Хасу Тоиштай тамхилахдаа,

- Би Цицикарь явах санаатай. Цагдаагийн газраас зөвшөөрөл авахаар ярилцсан гэж яриа дэлгэв.

- Хэзээ явах юм бэ? Уг нь манайхаас үнэмлэхтэй явбал зүгээр дээ.

- Маргааш явдаг юм билүү.

- Аяанаосу сан, тэгвэл маргааш өглөө надтай уулзаад үнэмлэх аваарай гэж хэлтэл үйлчлэгч залуу ирж, тавиур дээрх тансаг идээг ширээнээ өрөв.

Хасу Тоиши, анхны хундагыг Аяанаосугийн эрүүл мэндийн төлөө өргөснөөс хойш хятад архины аагт зүрх сэтгэлээ бүлээсгэсэн хоёр хорвоогийн эрээн барааныг уудлан ярьж, далан хэл дэлгэх нь тэрээ.

- Аяанаосу сан, Чан Кайши, Жан Сюэлян хоёрыг чи таарна гэж бодож байна уу? гэж Хасу Тоиши асуугаад царай өөд нь ширтэхдээ өрөөсөн нүдээ аньсан байлаа.

- Мэдэхгүй шүү. Арай л юу бол доо! Таардаг юмаа гэхэд их сонин юм болох байх гэж хэлээд Аяанаосу Тоиши өөд харах нь «Чи юу гэж бодож байна» гэх шигээ.

- Миний бодлоор бол тэр хоёр эвлэрэхгүй. Харин Мао, хятадын бүх хүчийг нэгтгэх замаар асуудал боловсруулаад тэр

хоёрын аль алинд явуулсан гэдэг. Үүнийг Симото сан мэдсэн байна билээ. Чан Кайши, эзэн хааны эсрэг чиглэсэн хуйвалдаанд шууд оролцохгүй байх. Түүнээс гадна Чан Кайши Жан Сюэляныг Маогийнхантай нууц холбоотой гэж хардаад байгаа. Тиймээс Чан Кайши тэр хоёрыг нууц хэлэлцээ хийж үү, үгүй юу? гэдгийг мэдээгүй цагт тууштай шийд гаргахгүй. Ер нь энэ гурван хүн, хятадад японы армийн нөлөөг дэлгэрүүлэхгүй гэдэг санал дээр тулгуурлаж тур зуурын нэгдмэл байдал бий болгож болно. Гэхдээ эцсийн эцэст энэ гурван хүн, хятадын эзэн хааны ширээг булаалдаж байгаа болохоор хэн авхаалжтай нь нөгөө хоёрыгоо устгаад өөрөө үлдэх ёстой.

Жан Сюэлян эцгийгээ япон армийнхны гарт өртөж амь насаа алдсан гэдгийг мэдсэн болохоор японы эсрэг тэмцэх нь зайлшгүй. Гэтэл Чан Кайши бол хятадын улаан намыг устгахыг эн тэргүүний зорилт болгодог хүн. Ингэхлээр эд нар нэгдэж чадах уу? Гэхдээ би, эдний нэг ч холион бантныг сонирхдоггүй юм. Надад үймээн самуунгүй бол болох нь тэр гэж хэлэхэд Хасу Тоиши сэтгэлдээ «Энэ ч яахав, худалдаачин хүний нүдээр харж байгаа хэрэг. Тэгэхээр Цицикарь шиг амар жимэр хот бараадаж ашиг хонжоо хайна гэдэг бол энэ хүний ясны бодол» гэж бодлоо.

- Хасу Тоиши сан, Цицикарьд японоос олон хүн ирж суурьших уу? Чи юу гэж бодож байна

даа?

- Аяанаосу сан, та ирээдүйгээ тун сайн олж харах юм. Ойрын жилүүдэд японоос 300мянганхүн ирж, манжуурт эзэмшилгаартай болж суурьших ёстой. Хэрэв аз дайрвал чи, Хабаровскт хувцас захиалгын салбар нээж болно. Чамд гэж хэлэхэд японы армийн удирдлага, Хабаровскийн хавиар цэргээ оруулах төлөвлөгөө зохиосон. Энэ жил Герман япон хоёрын хамтын ажиллагаа буюу Улаан оросыг хайчлах, японы цэргийг алс дорнодод оруулах талаар төлөвлөсөн ажиллагааг тохирохын тулд «гэрээ» байгуулж магадгүй. Японы арми «Оцу» буюу Байгаль хүртэлх төлөвлөгөөг, шинэчилж, 30 дивиз буюу 250 мянган цэргийг оросын хил рүү зүглүүлэх төлөвлөгөө хийж байгаа гээд хундагатай архиа авч хөнтөрлөө.

- Аяанаосу сан, би чамд багагүй өртэй болсон байх. Гэхдээ төлж дийлнэ. Харин чи одоо надад хэдэн юм зээлүүлэхгүй юу.

- Хасу Тоиши сан, чамд ногоон нь хэрэгтэй юү? гэж асуухад,

- Тэгэлгүй яах вэ? Иениэр юугаа хийх вэ? Би гадаад руу юм захих гэсэн юм гэж учирлан хэлэв.

Зоогийн газар чингэж эхэлсэн яриа үргэлжилж нар шингэхээс өмнө хоёр хашир тэр гэрийн зүг явахаар зоогийн газраас гарлаа. Тэгээд Харбины нэг гудамжнаас салахдаа маргааш орой уулзахаар тохирлоо. Тиймээс Аяанаосу, Хасу Тоишийг галт тэрэгний буудал дээр хүлээхээр боллоо.

Хасу Тоиши Аяанаосуг үдэж өгөхөөр цагтаа ирлээ. Тэрээр буудлын тавцан дээр зогсож байсан Аяанаосутай уулзангуут халааснаасаа хатуу хавгастай нэгэн үнэмлэх гаргаад,

- Наад үнэмлэх чинь зураггүй байсан ч болдог юм гэлээ. Манжуур дахь квантуны армийн тагнуулын газрын шугамаар

яваа тусгай хүмүүст өгдөг тэр үнэмлэхэнд генерал Хато гарын үсэг зурсныг үзвэл Хасу Тоиши үүнийг эрт бэлтгэсэн ажээ. Японы зөвлөхийн гарын үсгийн доохон талд «Зураггүй байхыг зөвшөөрнө» гэсэн бичигтэй үнэмлэхийг ажиглаж байсан Аяанаосу сэтгэлдээ «Үүнийг хэнд зориулж бэлтгэсэн юм бол! Генералыг Хайлар руу явахаас өмнө гарын үсэг зуруулж авсныг бодвол оросын дүрвэгсдийн товчооноос хүн явуулах гэсэн хэрэг. Түүнээс квантуны армийнханд бэлдсэн бол Хасу Тоиши надад өгч зүрхлэхгүй» гэж бодно. Чингэтэл галт тэрэг хөдлөх дохио өгсөн болохоор Аяанаосу вагон руугаа дөхлөө.

Харбинаасхөдөлсөн галт тэрэгцагийнхуваарьёсоорхурдалсаар Цицикарьд хожимдолгүй иржээ. Аяанаосу галт тэрэгнээс бугаад хотын төв зочид буудалд хүн хөлгөөр хүргүүлэв. Тэгээд Хасу Тоишигийн зааварласан ёсоор цагдаагийн газар очиж бүртгүүлэв. Тэндээсээ зочид буудалд ирээд гадагшаа гарсангүй. Тэгээд гурав хонохдоо худалдааны газар, оёдолчингуудаар хэсэж, ажил төрлийн холбогдолтой судалгаа хийхдээ өөрийнхөө араас тавьсан туршуулуудыг шалгав. Гэтэл ямар ч сэжиг гарсангүй. Чухам энэ бүхнийг эргэцүүлсэн Аяанаосу, Хасу Тоишигийн хэлсэн үгийг саналаа.

Тэрээр Аяанаосуд үнэмлэхээ өгөхдөө «Ийм үнэмлэхтэй хүн очсон газрынхаа япон цэргийн болон хээрийн цагдаагийн газар

цагийн дотор бүртгүүлдэг юм» гэснийг саналаа. Тэгээд буудлынхаа өрөөнүүдийг шалгаж, чемоданууддаа тавьсан тэмдгээ ажвал зочид буудлаар хөллөсөн цагдаагийн газрын туршуулууд түүний өрөөг нэгжээгүй нь илэрхий байлаа. Үүнийг ажвал цэргийн тагнуулын газрын шугамаар яваа хүмүүсийн араас шиншлэн мөрдөн хянаж болохгүйг цагдаагийн газрынхан туршуулууддаа дамжуулдаг болохыг мэдэв. Тиймээс тусгай үнэмлэхтэй хүмүүс цагийн дотор бүртгүүлдэг журамтай ажээ. Чингээд тав хоногийн дараа Аяанаосу Цицикарь дахь «Мансю дэн дэн буюу Манжуурын цахилгаан утасны» нэгдлийн нэгэн салбар дээр очлоо. Цахилгаан утсан шуудангийн энэ салбарт хүн цөөн ажээ. Гуч эргэм насны махлаг цагаан залуутай мэндэлсэн Аяанаосу нимгэн хавгас гаргаж нээнгүүтээ,

- Танайд захидалд наадаг ийм зурагт хуудас байна уу? гэж асуугаад үйлчлэгч залууд өнөө хавгсаа өглөө. Үйлчлэгч түүнийг авч шуудангийн зурагт хуудсуудыг хэсүүлэн харж байснаа,

- Танд ийм зурагт хуудас байвал манайд их хэмжээгээр хэрэгтэй гээд нэгэн зурагт хуудсыг заалаа. Аяанаосу Сувдаагийн хэлж өгсөн дохиог дэс дарааллын дагуу хэлээд сорих түлхүүрээр,

- Үнэ цэнгий нь тантай ярилцах уу гэлээ.

- Үгүй ээ. Манай салбарын эзэн өрөөндөө бий. Та орж уулз гэлээ.

Үйлчлэгч, Аяанаосуг дагуулсаар нэгэн өрөөнд орж иртэл хаалганы баруун талын ширээний дэргэд нэгэн хүн буруу хараад сууж байлаа. Тэр хүн хаалга чахрах чимээнээр суудлаасаа босож эргэн харахад Аяанаосугийн танил, төвийн буухиа элч зогсож байхыг мэдээд баярлав. Чухам энэ үед үйлчлэгч залуу,

- Та хоёр ажил төрлөө ярилц. Манайд чөлөөтэй байж болно. Би та хоёрт цай хоол бэлдээдэхье гээд өрөөнөөс гарлаа. Ингээд Аяанаосу хэмээгдэх Гунгаа төвийн буухиа элчтэй уулзаж Харбинд хэрхэн ирж тохижсон хийгээд ямар ямар шалгалтуудыг хэрхэн давснаа дэс дараалан ярилаа.

Аяанаосу, Сувдаагаас авсан мэдээнүүдийг дэс дараатай ярьж, монголын хилийн дагуу квантуны армиас явуулж байгаа цэргийн холбогдолтой үйл ажиллагаануудыг ярьсны адилаар японы

тагнуулын удирдлага Хүрээ хийдийн мяндагтай лам нартай хэрхэн холбоотой байгааг ярьж, тэднийг толгойлж байгаа лам нарын хаягийг хэлж өглөө.

- Японы армийн жанжин штаб, америкаас хөнгөн бөмбөгдөгч онгоц ЛБ—93, дайрагч И—96 маягийн онгоц худалдан авахаар тохирсон байна. Монголын хил рүү чиглүүлсэн ажиллагаанд эдгээр онгоцуудыг хэрэглэнэ. Японы хорь гаруй үйлдвэр цэргийн захиалга хүлээн авсан бөгөөд энэ онд (1936) янз бүрийн буу 25498, их буу 612, нисэх онгоц 1300, танк 360, их бага радио хэрэгслэл 800 гаруйг үйлдвэрлэх юм. Квантуны арми монголын хил рүү тавих зам

харилцааг чухалчилж байна. Тиймээс 1929 оноос Гирин мужийн Сыпингаас Таонань хүртэл тавьсан төмөр замыг үргэлжлүүлж байгаа юм. Японы арми 1933 оноос эхэлж энэ төмөр замыг үргэлжлүүлж Байчэн хүргээд тэндээсээ өвөр монголын жирмийн чуулганы Вангийн сүм хүргэсэн төдийгүй Солунь хүртэл тавьж ноднин ашиглалтанд оруулсан. Одоо квантуны арми тэр төмөр замыг цааш нь монголын хил рүү тавьж одоо Халуун Рашаан, Ириэши болон Ханширээ хүртэл тавьж энэ онд ашиглалтанд өгөх гэж яарч байна. Ханширээ бол манай хилээс ердөө 8 км зайтай байгаа хот юм.

Квантуны арми Зөвлөлтийн алс дорнод руу чиглүүлсэн Оцу гэдэг ажиллагааг хэрэгжүүлэх зорилт тавьж байгаа. Энэ ажиллагаанд 250 цэрэгтэй 30 дивиз төлөвлөсөн бөгөөд үүний 20 дивизийг Зөвлөлтийн хилийн дагуу байрлуулах юм. Оцу гэж товлосон ажиллагааны анхны ээлж нь Хабаровск, Ханх нуурын чиглэлээр Владивостокийг таслан авахад чиглэгдсэн байна. Алс дорнодод явуулах тагнуулын хорлон сүйтгэх ажиллагаанд оролцох хүмүүсийг «Сунгар—П» гэсэн төвд бэлтгэж байгаа юм. Хорлон сүйтгэх ажиллагаанд оролцох цагаантны оргодлуудыг толгойлдог Разаевский Харбинд Оросын дүрвэгсдийн товчоог түшиглэж «Оросын фашист холбоо» гэгчийг байгуулсан гэж хэлтэл хаалга тогших чимээ тэр хоёрын ярианд саад боллоо.

Дөрөвдүгээр бүлэг

Алдар нэр горилох ес

Нэг. Аз сорьсон тушаалтан

Амьд бурхан гэгдсэн тэнно Хирохитогийн хаанчлал, сёвогийн 12 дугаар он гарахад японы улс төрийн зөрчил, эдийн засгийн хямрал, эзэнт гүрнийг сүйрлийн босгонд сөхрүүлэв. Японы эзэн хааны мэдэлд азийн улсуудыг нэгтгэж, аугаа азийн цэцэглэлтийн үе гэгчийг хөгжүүлэхээр төлөвлөсөн төлөвлөгөөний умард, өмнөд гэдэг хувилбар төлөвлөгөөг японы цэргийнхэн зохиосон билээ. Тэр төлөвлөгөөгөөр Сибирийг таслан авах «Оцу» хятадыг хэсэгчлэн хуваах, шаталсан төлөвлөгөөний дагуу эзлэх «Хэй» гэж товлосон ажиллагааны үрээр азийг бүхэлд нь эзэмшил болгох ёстой байлаа. Жил гарангийн өмнө болсон будлианаар хэд хэдэн генералыг цааш харуулсан төлөвлөгөө гаргаж, эзэн хаанд танилцуулаад хэрэг буруудсан Кавасимагийн нэрийн жагсаалтанд орсон генералын нэг Хаяси, 1937 оны хоёр сарын сүүлчээр Хиротоогоос засгийн эрхийг хүлээн авлаа. Хаяси бол улс төрийн мэдлэгээр дульхан гэж хочлогддог. Тэрээр ерөнхий сайд болохын тулд цэргийн фашист бүлэглэлийн үймээнд оролцож дэвэргэхдээ авьяастай генерал гэгдэнэ.

Тозияа квантуны армийн штабын дарга Итагакигийн бичсэн «Ноппон рэнсё э но мити буюу японыг ялалтанд хүргэх зам» гэдэг ном уншиж суутал утасны хонх жингэнэв.

- Тозияа сан Синьзингээс ярьж байна. Итагаки сан маргааш ирэх болсон гэж цэргийн төлөөлөгчийн газраас Тозияд мэдэгдэв.

- Доихара санд энэ тухай дуулгах хэрэгтэй гээд утсаа тавьсан Тозияа Юкигийн өрөө руу гэлдрэхдээ Итагакийг жанжин штабт ажиллуулах гэсэн миний саналыг эзэн хаан болгоожээ. Итагаки тэнд очно гэдэг нэг алхам! Хэрвээ монголын асуудлыг дорвитой танилцуулах сурвалж үндэслэлийг сайн боловсруулж чадвал

Итагаки, цэргийн яамны сайд болно гэсэн үг. Тэгвэл миний санасан ёсоор болж шулуундаа орох нь тэр гэж бодлоо.

Тозияа Юкигийн өрөөнд орж ирээд бичгийн ширээний дэргэд очингуутаа янжуурынхаа утааг Юкигээс зайлуулах гэсэн шиг агаар өөд үлээгээд хэсэг дуугүй зогссоноо,

- Охин минь юу уншиж байна даа гэснээ уншиж байгаа ном руу нь өнгийснөө,

- Аа Итагакигийн бичсэн Синани тайсуру энзё то соко сай бацу кики Хятадад туслах хийгээд эзлэхэд учрах аюул гэдэг ном шив дээ. Чи үүнийг хаанаас аваа вэ? гэж асуулаа.

- Уржигдар хүн авчирч өгсөн юм. Ойрдоо номын худалдаанд Итагаки саны бичсэн хоёр ном гарсан гэсэн. Би олж авч чадаагүй юмсан. Өөрөөс нь гуйвал өгөх болов уу гэж асуултыг асуултаар хариулав.

- Итагаки сан, хятадын улс төрийн хямрал, ялангуяа гоминдааны удирдагчдын хоорондын

зөрчлийг нарийн судалсан хүн. Тэр чинь уг нь сүрхий авьяастай. Ялангуяа тагнуулын ажилд гоц эр! Тиймээс Чан Кайшигийн дэргэд хавчуулсан түүний туслахууд маш нууц баримтуудыг олж чаддаг юм. Ер нь Маогийн дэргэд шавь нараасаа хавчуулчихсан байхаасаа сийхгүй толгой гэж хэлснээ, аа тийм. Итагаки сан маргааш Синьзигээс ирнэ гэсэн. Миний тавьсан саналын дагуу түүнийг жанжин штабт ажиллуулах нь зайлшгүй юм. Тэгэхээр маргааш манайхаар орж ирнэ гэсэн үг. Тэр үед чи талархал дэвшүүлбэл цаадах чинь хоёр номоо бэлэглэх байх шүү. Тэр ч яахав. Итагакийг цэргийн яамны сайд болоод Тозиог квантуны армийн штабын дарга болгочихвол уу! Монголын асуудлыг дор нь шийдэж болно. Ер нь маргааш орой түүнийг гэртээ уривал яасан юм бэ? гэж аятайхан далим олж хэллээ.

Тозияа төлөөлөгчийн газрын жижүүртэй ярьсны дараа Итагакийг Токио руу явах гэж байгааг хүндэтгэн, үдэлтийн уулзалт зохион байгуулья гэж бодоод Юкийд дуулгах санаатай түүний өрөөнд орохдоо ийм сайхан эгзэг гарна гэж бодоогүй билээ.

- Тэгье. Би ч гэсэн тэгж бодож байна гэж Юкийг хэлэхэд Тозияа олзуурхан дотроо "Маргааш оройн уулзалт дээр дорнод

төмөр замын талаар сөхөх хэрэгтэй. Юки, Хайлар Манжуурын төмөр замыг өөрийн хувийн, хөрөнгө болгохыг мэрийж байгаа үед Халуун Рашаан, Ханширээ, Ирэшигийн төмөр замыг төдийгүй Хайлар Ханширээгийн дардан замыг хувийн хөрөнгө болгож болно гэдэг сэтгэгдэл одооноос төрүүлж байх хэрэгтэй. Тэгэхээр энэ бүхнийг Итагакигаар дэмжүүлсэн янзтай ярих нь ашигтай! Тэгэх юм бол Юки алтаа гаргаж худалдаж авах юм уу эсвэл хувийн пүүсүүдтэй хоршиж нийлэхийг хичээнэ. Гайгүй ээ, ганцхан тэвчээр хэрэгтэй! Армийнхны үзэж байгаагаар бол Монгол руу энэ хоёр жилдээ хүчээ чиглүүлэхгүй. Бэлтгэл ажил гүйцээгүй байна. Чухам энэ хугацаанд амжиж Юкийг ятгах хэрэгтэй. Харин хилийн будлианыг дорвитойхон дэгдээж, түүнийг байлдаан болгон хувиргах маш чухал зүйл шүү" гэж бодно. Хүний газар толгой хавчуулж, амьд явахын эрхийг даган, эцгийнхээ буяныг хүний хоол болгочихгүйг хичээх болсон Юки, инээсэн бүхнийг царайчлахад хүрдэг болсныг Тозияа ажиглаад «Алтны учрыг тайлах цаг ч ойртож байна даа» гэж бодоод эчнээндээ баярладаг болсон. Харин хүний газар ганцаардахын эрхээр сэтгэлээ шаналгаж яваа Юки, Тозияаг түшиж тулах хүнээ гэж үзэх тул түүний сэтгэлд далдлагдсан хар бараан санааг хэрхэн ухаарч, ялган салгах билээ.

Юки өрөөнөөсөө гараад Сувдаагийн өрөөнд орж гийчдийг дайлах, цайлах тухайгаа хэлээд дорвитойхон хөдлөхийг зөвлөв. Чингээд Юки сурсан заншлаараа үсчин рүү явжээ. Харин Тозияа Юкийг үсчин рүү явсан гэдгийг дуулаад «Үсээ будуулаад хоёр долоо хоноогүй мөртлөө бас үсээ будуулж янзлуулахаар явсан хэрэг үү! Сонин юм. Гангалж дэгжирхэх гэдэг бас нэг өвөрмөц онцлог шүү» гэж бодсоноос цаашгүй.

Квантуны армийн штабын дарга Итагакийг жанжин штабт дээгүүр зиндаанд очих болсныг гадарласан, ирээдүйг нь тоймлон зөгнөсөн хүмүүс Мугдэнд цугларлаа. Харбин хотын дүрвэгсдийн товчооноос хурандаа Иван Степанович, Хасу Тоиши, япон зөвлөх генерал Хато иржээ. Итагакийг гаргаж өгөхөөр квантуны армийн штабт монголын асуудлыг хариуцдаг хошууч Симото, газрын зургийн мэргэжилтэн Еоши, Хайлараас нутагтаа очих гэж яваа Мазаки, «Мансю нити нити» сонины сурвалжлагч Тогова нар энэ үдэш Тозияагийн ирж, Итагакийг үдэх ёслолд оролцлоо. Тэгээд зогссонгүй үдэлтийг хөөр хөгжөөнтэй болгохын

тулд хотын даргын туслах гэйша хүүхнүүдийг явуулсан байлаа.

Олон зуун тавагтай зууш хоол ярайсан, тансаг засалтай ширээний эхэнд юмин кимоно өмссөн Юки, европ маягаар хувцасласан Тозия, удам угсаагаараа самурайн ёсыг сахисан Итагаки гурав заларч, зочид гийчдийг тэргүүлэх ажээ. Албан тушаалын зэрэг дэвээр сууцгаасан зочдын ширээнээ шотланд хар архи, голланд жин, хятад маоту, япон сакэ гол мөрөн шиг элбэг дэлбэг болой. Итагакийн үдэлтэнд ирсэн хүмүүс бүгдээрээ цол хэргэм зүүсний адилаар оросын дүрвэгсдийн товчооны Иван Степанович шинээр дэвшсэн хурандаа нар хэргэмээ бүрэн эдэлсэн байв. Иван Степанович Хасу Тоиши хоёр зэрэгцэн суусан агаад Симото, Еоши, Тогава гурав бөөр бөөрөөрөө наалдаж ургасан саримс шиг ихэрлэн суужээ. Монголын асуудал эрхэлдэг энэ гурван хүнийг эрхэлж байгаа ажил төрөл нь нэг сүвэгчээр холбосон төдийгүй түүний үзүүрт өлгөж мэдэх эгзэгтэйг гурван хашир арван хуруу шигээ мэднэ. Гэхдээ энэ гурвын хэн хэн нь авхаалжтай учраас хэн нь илүү зальтайг ялгахад бэрх болой.

Япон дарга нар Итагакигээс далдирсан янзтай сууцгааж, эхний гурван хундагыг ёс төдий өргөөд дуугүй дүмбийж суугааг гадарласан Юки,

- Эрхэм хүндэт ноёдоо, эрхэм Итагаки сан, бид бүхэн санаа зорилго нэгтэй нэгдмэл нэгэн хүч билээ. Гэвч ажил төрлийн байдлаас шалтгаалаад ингэж тохитой уулзаж байсангүй. Тэгээд бидний хэрэг үйлс энэ хэдэн жил, амарч наргих зав чөлөө өгөөгүй шүү дээ! Өнөөдөр эрхэм Итагаки сан, урьдынхаа буян ерөөлөөр бид бүхнийг цуглуулж уулзууллаа. Иймээс хундагатай архиа тавьж, бие биенээ хараад байх хэрэггүй! Манайд архи уулаа гэж хэн ч зэмлэхгүй. Тэр тусмаа Итагаки сан, бүүр ч зэмлэхгүй гэдэгт итгэж байна. Нөгөө талаар ганц хоёр хундаганд согтоод хэл амаа долоолчих тийм хүмүүс бидний дунд алга! Бид чинь догширсон хашрууд шүү. Тийм биз дээ, Итагаки сан гэхэд Итагаки суудлаасаа бослоо.

- Ноёдоо. Юки саны сайхан сэтгэлийг гашилгах тийм эвгүй байдал гаргаж болохгүй. Тиймээс хундагандаа энэ ариун идээг

үлдээж болохгүй кампай гэхэд хүмүүс хундагаа авч өргөлөө. Итагакийг сууснаас хойш хөлсөөр үйлчилж байгаа үйлчлэгчид Сувдаагийн заавраар архи хундагалан, ширээний зуушийг сольж сэлбэнэ.

- Итагаки сан, хоёулаа миний өрөөнд орёе. Одоо гэйша нар орж ирнэ. Тэгэхээр хоёулаа энд гөлийж байхын хэрэггүй гэснээ түүний чихэнд "Нанжингийн тусгай төлөөлөгч Яньанд Маотай уулзахаар очсон байна" гэхэд Итагаки цочсон юм шиг сүрхий хараад санаа алдав. Чухам энэ үед Тозия суудлаасаа өндийхөд Итагаки түүний араас дагалаа. Тэр хоёрыг өрөөнөөс гарсны дараа Юки Сувдааг дуудаад архи дарс, чихэр жимс, зууш зэргийг бэлтгэхийг даалгаад генерал Хатогийн дэргэд очиж суулаа.

- Юки сан аав чинь хаачих нь вэ? гэхэд Юки,

- Аав Итагаки сантай ажил төрлөө ярихаар өрөөндөө орсон. Та тэр хоёр руу очих юм биш үү гэлээ

- Би жаахан азнаж байгаад очье. Харин чи өрөөг нь заагаад өгөөрэй гэхэд Юки инээмсэглээд,

- Тэгье л дээ. Хато сан, оросын дүрвэгсдийн товчоонд байгаа цагаач нар, дорнод төмөр замын талаар ямаршуухан бодолтой байна. Манжуурын төмөр замын нэгдсэн нийгэмлэг байгуулбал би хувь нийлүүлж хорших санаатай. Энэ чинь цаашдын миний хүсэл мөрөөдөлд нэлээн дөхөм болно. Тиймээс би, оросын цагаачдын мэргэжилтэнгүүдийг сонирхоод байгаа юм. Хайлар Манжуурын хооронд зам тавихад дорнод төмөр замын нийгэмлэгт хувь нийлүүлж хоршвол орос инженер нь илүү найдвартай байх гэж бодож байна гэлээ.

- Хэрвээ энэ жил (1937 он) алс дорнодыг эзэмшлээ болгож, Владивостокийг хялбархан салгачих боломжийг сайн судалж чадвал хойтон жил зам харилцааны асуудал чухалчлагдана. Ялангуяа умард солонгосоор улаан оростой хил нийлдэг Дунин, Тумын, Яньзи хотуудын төмөр замын асуудлыг шийдвэрлэх болно. Энэ талаар бид дорвитойхон ажил сэдээд байгаа. Ялангуяа зүүн Умард хятадын нутаг, солонгосын баруун хойгуур бугшран, улааны зулбасагуудыг номхотгож чадвал манай ажиллагаа хялбархан үр дүнд хүрнэ гэж архинд ам халсан Харбины япон зөвлөхийг хэлэхэд Юки, Хатогийн үгэнд гомдсон юм шиг,

- Тэгвэл миний бодож байгаа зүйл тийм ч амархан бүтэхгүй юм байна. Уг нь наран улсын цэрэг, монгол руу чиглэвэл миний бодол талаар өнгөрөхгүй юм гэлээ.

- Юки сан битгий гомд! Цаг нь ирэхээр нүд ирмэхийн зуур тэр нийгэмлэг чинь байгуулагдана. Японы томоохон үйлдвэрийн эздийн дам яриагаар бол "Зүүн умард, хятадын зам харилцааны асуудлыг эрхэлсэн улсын болон хувийн пүүсний нэгдэл" байгуулагдах юм гэсэн. Өөрөөр хэлбэл өмнөд манжуурын төмөр замын нэгдэл Мантэцу шиг нэгдэл байгуулах юм. Харин саад болоод байгаа гол зүйлийн нэг бол зам барилга, ашиглалтыг хамаарсан нэгдэл байгуулах уу? Ганцхан ашиглалт эрхэлсэн нэгдэл байгуулах уу гэдэг асуудлыг тууштай шийдэж чадахгүй байна. Юки сан, би үүнийг чамд итгэсэндээ хэлсэн юм шүү. Би бол асарсан эцгийн чинь төдийгүй талийгаачийн сайн танилын нэг. Нөгөө талаар би багагүй өртэй юмсан. Харин чи, эцгийнхээ буяныг бодоод надаас нэхэлгүй өдий хүрсэн явдал чинь намайг дандаа баярлуулдаг юм. Тэгээд ч чи, ийм ярианы зах сэжүүрийг ойлгох байх гэж бодоод цухуйлгасан. Түүнээс энэ чинь нууц шүү гэж хэлэхэд манжуурын төмөр замын хувийн болон улсын байгууллагыг нэгтгэж зохион байгуулалтыг өөрчлөх гэж байгаа армийнхны төлөвлөгөөний талаар хамаагүй ярьснаа цагаатгах далим хайж байгаа нь илэрлээ.

- Таны мутрын үсэгтэй бичиг надад бий. Гэхдээ та чинь бусдыгаа бодвол бага өртэй юм байна билээ. Нөгөө талаар таныг намайг залилчих хүн биш гэж боддог шүү гэж хэлээд Юки дотроо «Хато генерал Хашчулууныг дэргэдээ байлгадаг явдлыг хүмүүс нэг жигтэй гэдэг. Зүүн умард хятадын партизануудыг удирддаг ах Хасбаатарыг урхидах арга гэж хүмүүс ярилцдаг ортой байх. Тиймээс түүнийг барих дорвитой ажил сэдсэнээ цухуйлгасан хэрэг! Харин энэ генерал, эгчийн нь талаар мэддэг болов уу?» гэж бодлоо. Чухам энэ үед Сувдаа гаднаас орж ирээд нүдээ ирмэж «Юм бэлэн болгосноо» мэдэгдэв. Тиймээс Юки,

- Хато сан, та аавын өрөөнд очих уу? Энд зүгээр суугаад яахав дээ. Тэдэн дээр очвол дээр байх. Та энд ганцаараа уйдаж гүйцлээ гээд босов. Хато тохилог тавьцтай том өрөөнүүдийг дамжсаар нэгэн жижиг өрөөнд орж ирлээ. Ханын дагуух шилэн шүүгээний наагуур зассан ширээний дэргэд тухлан суусан Тозия, Итагаки нар генералын бараанаар талархан угтлаа.

Энэ зуур Сувдаа дөрвөн дугуйтай түрдэг, тавиураа түрсээр орж ирээд тансаг амттаныг ширээнээ өрөөд өрөөнөөс гарлаа. Сувдааг гарсны дараа гурван хашир яриандаа оров.

- Одоо хятадын асуудлыг найрамдлын замаар шийднэ гэдэг чинь худагт унасан мэлхийн бодлоос дээрдэхгүй, тэнэг зүйл! Тэгэхээр Хаясигийн улс төрийн бодлого бас газар авахгүй гэж Тозияа хэлээд суудлаасаа босож ханын шүүгээ рүү эргэв.

Юки болор хундаганд хийсэн сакэгээ Итагакид барихад тэрээр толгой бөхөлзүүлэн талархал дэвшүүлээд,

- Тозияа сан, би тантай санал нэг байна. Харин Чан Кайши, Маогийнхантай тохиролцдог юмаа гэж үзвэл Жан Сюэляныг яана гэж бодож байна вэ? гэж лавлан асуулаа. Гэтэл Хато тэсэлгүй ярианд оролцож,

- Манай хүмүүст мэдэгдсэн баримтаар бол Мао, зүүн умард хятадад байгаа Жан Сюэляны армийг улаан армитай нэгтгэж, нэгдсэн арми байгуулахын тулд түүнийг улаан намдаа элсүүлэхэд ч бэлэн байгаа гэж хэллээ.

- Тиймээ. Хато саны хэлсэн ортой шүү. Азийг цэцэглүүлэх ёстой манай армийн ажиллагаанд хорссон Мао, өөрөө азийг гартаа хийх ирээдүйн бодолдоо хүрэхийг хичээхдээ эхлээд биднийг хятадаас хөөн гаргахын тулд дайсагнасан хүчнүүдтэйгээ нэгдэж, нэгдсэн арми байгуулах санаа сэдээд байна. Энэ талаар би та нарт ноцтой баримт хэлж болно шүү гээд Тозияа номынхоо шүүгээнээс нэг хавгастай хэргийг авчирч ширээн дээр тавилаа. Энэ бол түүний шавь нараас ирүүлсэн «тагнуулын холбогдол» бүхий баримтууд билээ. Тэрээр шавь нарынхаа мэдээлсэн баримтыг үзээд,

- Чан Кайши саяхан Сиань рүү нисэхийн өмнө мэдэгдэл хийсэн. Тэр хэлсэн үгэндээ «Тэгш эрх, харилцан ажиллах санал гаргасан японы саналаас илүү аюултай зүйл бол улаан коммунистуудын (Маогийн) шаардлага» гэж мэдэгдсэн байна. Чан Кайши Сиань руу зүглэсэн гол зорилго бол Жан Сюэляныг улаан хятадуудын эсрэг хөдөлгөх бодолтой байсан.

- Тозияа сан, Чан Кайшийг Нанжингаас Сиань рүү гарсан чимээгээр тэндхийн залуучууд хөдөлгөөнөө хүчтэй болгосон байна. Үүнийг мэдсэн Чан Кайши, залуучуудын жагсаалыг тарааж, устгах тухай тусгай тушаал Жан Сюэлянд өгсөн гэдэг биз дээ гэж Хатоог асуутал,

- Тиймээ. Сианины залуучууд манжуурт тогтоосон дэглэмийг эсэргүүцэж жагсаал хийхдээ Жан Сюэляныг Маогийнхантай нэгдэх шаардлагыг тавьсан юм. Жан Сюэлян, манай эсрэг хятадын нэгдсэн арми гэгчийг байгуулах санаатай болохоор Чан Кайшигийн өгсөн тэр тусгай тушаалыг биелүүлээгүй. Чан Кайши, Сианины залуусын хөдөлгөөнийг улаан оросууд дэгдээсэн гэдэг цуурхал тараах хэрэггүй байсан юм. Тиймээс өнгөрсөн оны 12 сарын 14-нд нийтэлсэн улаан оросын эсэргүүцлийн үнэн баримтыг дэлхийн улс үндэстэнгүүд мэдэхгүйгээр өнгөрөх байсан үүнээс болж манай талд муу эгзэг бүрдээд байгаа. Үүнийг яах вэ гэдгийг бодох хэрэгтэй гэж Итагакийг хэлэхэд хүмүүс хэсэгхэн дуугүй болцгоов.

- Тэр цуурхлыг дэгдээхэд манай ажилтангууд жаахан яарч, Чан Кайшийг яаруулсан тал бий. Гэхдээ түүнийг, сайд нарын танхимд амархан тайлбарлаж болно. Харин нэг хэцүү юм байна.

Сианьд очсон Жоу Эньлайгийн ятгалганд Чан Кайши татагдвал нэгдсэн арми байгуулах асуудлыг зөвшөөрч мэдэх юм.

-Тозияа сан, тэгвэл үүнийг Чан Кайшигийн өөрийн нь алдаа гэж үзэх хэрэгтэй. Чан Кайши, Сианьд очихынхоо оронд Жан Сюэляны аяыг олоод Нанжинд дуудаж ирүүлсэн бол арай илүү ахицтай байсан шүү гээд Итагаки сакэ балгаад Тозияа өөд ширтэв.

- Чан Кайшийг Сианьд ирэхэд онгоцны буудал дээр хүндэтгэлийн харуул байтугай, гоминдааны тугийг ч босгоогүй байсан. Чан Кайши үүнээс сэжиг авч болгоомжлохын оронд дэндүү бардан, тэнэг зан гаргасан. Тэгээд зогссонгүй 12 сарын 8 нд Жан Сюэлян, Ян Хунчэнь хоёртой уулзсаны дараа дөрөв хоноод дахин уулзжээ. Энэ уулзалтаар Чан Кайши, Жан Сюэляны ширээн дээр байсан нэг бичгийг үзсэн байна. Тэр бичигт хятад дахь иргэний дайныг зогсоох, манай эзэн хааны «кодо» замналыг азид тогтоох явдлыг саатуулах, цаашдаа манай армийг хятадаас хөөн гаргахын тулд хятадын нэгдсэн арми байгуулах тухай санал боловсруулсан улаан хятадуудын төлөвлөгөөний тухай дурдсан байжээ. Түүгээр ч барахгүй Жан Сюэляны ширээн дээр Жоу Эньлайтай хийх хэлэлцээний төсөл байсныг хараад Чан Кайши уураа барьж чадалгүй сүржигнэж, түүнийг урвасан гэдэг ял тохоох гэтэл Жан Сюэлян түүнийг дор нь баривчилсан байна гээд Тозияа янжуураа асаалаа. Итагаки, Тозиягийн яриаг анхааралтай сонсож суугаа Хатоог ширтэн хэсэг дуугүй байснаа ярианд оролцож,

- Энэ бол Жоу Эньлайгийн найруулсан жүжиг гэж үзэх ёстой. Нэгдсэн арми байгуулах асуудлыг Чан Кайшигаар зөвшөөрүүлэхийн тул Жан Сюэляныг ашиглаж, түүнийг баривчлуулаад өөрснөө Жан Сюэлянтай тохирсон дүрээр Чан Кайшийг суллуулж, асуудлыг Чан Кайшид тулгаж, зөвшөөрүүлэх гэсэн барьцаалсан арга! Үүнийг мэдсэн жанжин штабынхан түүний ов мэхийг гоминдааныханд ойлгуулж тэдний хооронд хутгах, эсвэл Чан Кайшигийн хударгаар орохын тулд Умэзуг, манайхан Нанжин руу илгээж Ван Зиньтай уулзуулах арга хэмжээ авсан бололтой байна гэж хэллээ.

- Жоу Эньлай өөрийнхөө найруулсан жүжгийн гол дүрд тоглохдоо өөрийн биеэр Чан Кайшитай уулзаж, түүнийг Жан Сюэляны гараас суллуулна гэж амлаад хэд хэдэн сүрхий болзол тавьсан нь үнэн л дээ. Үүний дотроос миний мэдэж байгаа зүйл бол Чан Кайши, Маогийн боловсруулсан хятадын нэгдсэн арми байгуулах асуудлыг зөвшөөрсөн нөхцөлд Жан Сюэляныг Жоу Эньлай баривчилж, Чан Кайшид тушаах ёстой байсан байна. Жоу Эньлайн энэ ов мэхийг гадарласан Жан Сюэлян, Чан Кайшитай сэм уулзаж, хэд хэдэн зүйл дээр тохиролцсон юм. Чингээд Чан Кайши, хятадын нэгдсэн арми байгуулах асуудлыг түр зөвшөөрсөн царай гаргаж, Нанжин руу нисэхээр бэлтгэж байсан тэр үед Сианьд үлдэж болохгүй гэдгээ Жан Сюэлян ойлгожээ.

Тэгээд Чан Кайшитэй тохиролцсон болзлынхоо дагуу түүнтэй нийлж Нанжин руу явахаар нууцаар бэлтгэжээ. Үүнийг сэжиглэсэн Жоу Эньлай, тэр хоёрын хуйвалдааныг мэдэнгүүт Маогоос удирдамж авахаар шийдэж байсан тэр хооронд Чан Кайшигийн онгоц агаарт хөөрчихсөн байжээ. Чингээд Чан Кайши, Жан Сюэляныг дагуулж яваад Нанжинд буухын өмнөхөн түүнийг баривчлахаар шийдэхдээ сэтгэлийн гүнд «Энэ золигийг устгаж болохгүй. Тэгэхээр хятадын коммунистуудтай ямар гэрээ байгуулсныг хэлүүлэх хэрэгтэй.

Хэрвээ ямар ч гэрээ байгуулаагүй буюу байгуулсан ч албан ёсоор батлаагүй байвал үүнийг

хуйвалдаанд оролцсон хэргээр баривчилбал японыхон хэл ам татлаад байхгүй» гэж бодож явсан нь илэрхий. Тиймээс Нанжинд буухын өмнө Жан Сюэляныг баривчилж хорьсон байна. Ингээд Жан Сюэлян, хятадын хоёр хүчний удирдлагад төдийгүй манайд ч хэрэггүй болоод байна. Чан Кайши, Нанжинд ирсэн даруйдаа нэгдсэн арми байгуулах талаар өөрийнхөнтэйгөө ярьж тохироод Жоу Эньлайг Баоньд урьж уулзаад зарим зүйлийг урьдчилан тохирохоор шийдсэн байна. Үүний үндсэн дээр энэ оны (1937) эхээр хуралдсан Хятадын гоминдааны намын III бүгд хурал дээр хятадын нэгдсэн фронт байгуулж оролцохоор шийдсэн болохоор Мао, гоминдааны эсрэг хийж байгаа байлдааныг зогсоохоор шийдсэн. Иймээс одоо эзэн хааны армийн гол зорилго бол хятад руу чиглүүлсэн Хэй төлөвлөгөөний дагуу Бээжин, Тяньжины, асуудлыг мухарлаж, армийн ажиллагааг эхлүүлэх нь чухал! Ингэж чадвал Мао, Чан Кайши хоёрын хуйвалдаанд саад хийж болно. Бид армийн ажиллагааг эхлүүлснээрээ юуны өмнө Бээжин, Нанжин, Шанхай хотуудыг эзэлнэ гэж хэлээд Тозия, Итакийг ятгалаа.

Тозия ингэж ярихдаа нөгөө хавтсан дотроос авсан баримтаа гаргаж дурдаад ширээ рүү чулуудна. Түүний сэтгэлд уур хилэн бадарч, багтарсан үедээ барьж байгаа зүйлээ хаа харагдсан зүг рүүгээ чулууддаг зуршилтай. Тозиягийн шидсэн цаасыг бөөгнүүлж хавтсанд хийж буй Юки, бүсгүй хүний саваагүй зангаар тэр бичгүүдийг халти мөлт уншина. Тозиягийн шавь нарын тагнуулын мэдээнээс гадна басхүү «Тайюань жибао», «Наньзян жибао» сониноор дамжуулж зарласан мэдээнүүд байхыг ажиг.

Тозия яриагаа дуусгаад суудлаасаа босохдоо гартаа барьж байгаа хайчилбараа ширээ рүү чулуудсан боловч тэр нь хивсэн дээр унав. Юки түүнийг авч үзвэл «Наньзян жибао» сонины 1936 оны 12 сарын 25, 26-ны өдрийн дугаараас авсан хайчилбар байлаа. Тэр хайчилбарт Жан Сюэляныг баривчилсан тухай бичжээ.

Тозия ширээн дээрх сакэ авч балгаад, янжуураа хэд хэд угсруулан сороод сэтгэлийнхээ бухимдлыг тайвшруулав.

- Манай жанжин штаб "Аугаа их азийн цэцэгжүүлэлтийг төвхнүүлэх» ажиллагааны өмнөд, умардын хувилбар дээр хүчээ хувааж байгааг хянууштай зүйл. Ер нь өмнөдийн хувилбарыг буюу хятадыг эзлээд умардын ажиллагаа руу орвол үр дүнд хүрнэ. Умардын асуудлыг шийдэхэд юуны өмнө монголыг улааны нөлөөнөөс ангижруулах тусгай нэгдсэн улс байгуулах асуудлыг шийдсэн цагт умардын хувилбар хэрэгжих бүрэн боломжтой юм. Тиймээс ар монголын асуудлыг шийдэхэд зайлшгүй шаардагдах мэдээ баримт, газрын зургийн байр зүйн тодруулалт, армийн хүчийг байрлуулахтай холбогдсон зам тээврийн асуудлыг шийдэж, газрын зураг дээр, бэлтгэл хийх хэрэгтэй гээд Итаки, Хато хоёр руу ширтлээ.

- Итаки сан, таны хэлсэн үгийн хувьд гэвэл онолын болон бодит хандлагын тусгал гэж үзүүштэй санал байна. Одоо Сунгар II өртөөнд байрлуулсан тагнуулын үүрэг гүйцэтгэх тусгай бүлгийг ажилд оруулна. Тиймээс энэ бүлгийн орос туршуулуудыг Разаевскийн удирдлага зохион байгуулах ёстой. Тиймээс оросын фашист холбооны идэвхтэй гишүүдийг өргөн хамрах юм. Харин манай армийн жанжин штаб үүнийг хэрхэн санхүүжүүлэх вэ гэдэг асуудлыг шийдээгүй байна. Энэ нь уул ажиллагааг шуурхайлахад яльгүй саад болж байгаа юм гэж хэлсэн нь ар монголын нутаг, алс дорнодын газар орны байр зүйн зурагт холбогдох баримт цуглуулах чиглэлээр тусгай мэргэжлийн хүмүүс бэлдэх ажил удааширч байгааг цагаатгахыг оролдсон хэрэг байлаа.

- Хато сан, сунгарын бүлгийн ажиллагааг үзэл суртал, цэрэг байлдааны гэдэг хоёр чиглэлээр бэлтгэх ёстойг хүн бүхэн ойлгох хэрэгтэй. Ялангуяа үзэл суртлын чиглэлээр улаан орос болон монголд ажиллуулах хэсгийг удирдан толгойлох хүмүүсийг бэлтгэхдээ хутган үймүүлэх, самуун дэгдээхэд авьяас чадлаа ашиглаж чадах тийм хүмүүсийг олж бэлтгэх нь чухал. Хайларт байгуулсан салбар түр сургуулиас бусдыг онцгойлоод байх хэрэггүй. Харин Хайларын түр сургуульд авьяастай, монголыг сайн мэдэх хүмүүс ажиллуулах нь манай ажиллагааг түргэтгэх хүчин зүйл болно гээд Итагаки хундагатай архиа өргөөд,

- Эрхэм ноёдоо, но кэнко шукушитэ кампай иташимашо. Энэ хундагыг эрүүл мэндийн төлөө өргөө. Кампай гээд сакэгаа балгав.

- Тозияа сан би та бүхний саналыг цэргийн яам, жанжин штабт биеэрээ уламжилна. Ялангуяа монголын асуудлыг шийдвэрлэх хүчин зүйлийн нэг болж байгаа Бээжин Тяньжин, Бээжин-Хаалганы төмөр замын тээврийг манай армийн эзэмшил болгоогүй цагт эзэн хааны армийн хүчийг монгол руу чиглүүлэх нь бэрхшээлтэй асуудлын нэг юм.

Тиймээс өмнөдийн хувилбар дээр хүчээ төвлөрүүлж, Тяньжин-Бээжингийн хувь заяаг шийдэх нь монголын асуудлыг түргэтгэх хүчин зүйл болно гэдэг нь гарцаагүй хэрэг билээ гээд хундагаа өргөхөд Юки, Хато генералын хундаганд голланд жин дүүргэв. Генерал хатуу архинд дуртай гэдгийг мэддэг Юки, түүнийг чингэж онцгойлон дайлсан болой.

Хато генерал ярианыхаа сэдвийг алгуурхан өөрчилж, оросуудын товчоонд гэрээсэлсэн хөрөнгө рүү чиглүүлэв. Гэхдээ энэ бол Хатогийн, санаа бишээ. Үнэндээ Тозияа, Итагаки хоёрын алсын бодолтой туршилт байсныг Юки ойлгож байв. Японы жанжин штабын төлөвлөсөн «Оцу» гэдэг төлөвлөгөөний дагуу Хабаровск, Благовещенск, Ханх нуурын чиглэлээр Зөвлөлтийн алс дорнод руу хэд хэдэн удаа өнгөлзөөд салам цохиулсан нь квантуны армийн ажиллагааг монголын зүүн хязгаар руу чиглүүлэх явдлыг хойшлуулсан билээ. Өөрөөр хэлбэл Зөвлөлтийн алс дорнод руу өнгөлзсөн армийн ажиллагаа амжилтанд хүрээгүйн дээр Зөвлөлтийн засгийн газраас Монголын тусгаар тогтнолыг хамгаалах тухай шийдвэрийг албан ёсоор зарласан нь алс дорнодын хил дээр нэлээн цэргийнхээ толгойг залгисан японы жанжин штабынхны зүрхэнд хурсан шар усыг (аймшгийг) багагүй хөнджээ. Ийнхүү цэрэг зэвсгийн хүчээр алс дорнодын асуудлыг шийдэж чадахгүйгээ мэдсэн японы жанжин штаб, тагнуулын хорлон сүйтгэх хутган үймүүлэх ажиллагааг сонгон боловсруулж, түүндээ найдлага тавьж байлаа.

- Хато сан, би өөрийнхөө хөрөнгийг хорлон сүйтгэх ажиллагаанд биш харин эзэн хааны армийг Монгол руу чиглүүлэх асуудалд зориулмаар байна. Талийгаач минь ингэж гэрээсэлсэн юм. Ингэхээр талийгаачийн сэтгэлийн зорилгод хөрөнгөө зориулах ёстой гэдгийг та бүхэн мэднэ. Гэхдээ би, та бүхний саналыг бас харгалзана. Тэгээд ч би, цэргийн мэдлэг боловсролгүй болохоор учрыг салган ухаарахгүй байна гээд Юки суудлаасаа босоод,

- Итагаки сан, бүгдээрээ их өрөөнд орёе. Тэнд бас хүмүүс хүлээж байгаа шүү дээ гэж хэлээд зочдын өрөө рүү чиглэсэн нь асуудлыг аятайхан зайлуулж чадлаа.

Итагаки, их танхим руу дурамжхан сажилж, тэргүүн бөхийлгөн гэлдрэхдээ "Энэ сайхан

хүүхний эцэг олон сая долларын алт хадгалуулсан гэдэг. Үнэн ч байхаа. Эцэг нь амьд ахуйдаа хөрөнгө гаргаж өгье, ганцхан цэргээ хөдөлгөж, Богд хаант улсыг минь сэргээн тогтоож өгөөч гэж шаардаад байсан. Их хүрээнээс ирсэн нөлөө бүхий нэг хүн тэр жил надтай уулзахдаа Богд Цэен гүнд их итгэдэг гэлцдэг болохоор хаант улсын сан хөмрөгийг хариуцуулж байсан юм. Тиймээс наашаа ирэхдээ гар хоосон ирээгүй байх. Миний дуулснаар бол их алттай ирсэн байх ёстой гэж билээ. Гэтэл энэ их хөрөнгө Шанхай, Кантон болон хятадын томоохон банкнуудын алинд байгаа нь одоо хүртэл мэдэгдэггүй нь сонин шүү! Хэрвээ тэр алтыг хадгалж байгаа банкиг мэдэж чадвал түүнийг Юкигээс хялбархан салгачих хоёр арга бий! Нэг бол Юкийг цааш нь харуулаад хуурамч гэрээслэл бэлдэж болно. Эсвэл алтыг хадгалж байгаа хотыг цэргийн хүчээр эзлэх явцад тусгай хүмүүс бэлдэж банкиг дээрэмдүүлэх хэрэгтэй"

Юки, зочдын өрөөнд орж ирэнгүүтээ Сувдааг дуудаж, ширээний архи зуушийг сэлбүүлээд гэйша нарын дуу бүжгэнд уярсан Симотогийн дэргэд байгаа сул сандал дээр суулаа.

- Манай дарга нар өөдлөх дөхөж байна уу гэж Симотоог асуухад Юки, ширээн дээрх жинээс хундагалаад,

- Хөгшид маань аугаа их азийг цэцэглүүлэн мандуулах хувь заяаны тухай ярьж байгаа. Одоо ингэсхийгээд ороод ирнэ. Надад уйтгартай болохоор түрүүлээд гараад ирлээ. Ер нь ингэсхийгээд өндөрлөнө байгаа гэв

Симото, Юкигээс хундагатай архи аваад гэйша нарын зүг ширтэхдээ «Энэ баян эмэгтэй Тозияагийн гарт санамсаргүй орсон нь сониноо. Аргагүй туршлагатай тагнуулчийн мэхэнд лавхан орж дээ. Тозияа, энэ эмэгтэйг өөртөө татахдаа алагдсан эцгийнхээ нэр

төрийг бодсон сэтгэлийн эмзгийг аятайхан далимдуулсан шүү» гэж бодно.

Симото, Юкигийн цугласан хүмүүсийн ахуй амьдралыг арван хуруу шигээ мэднэ. Тэдний илүү дутууг толгой дараалан андахгүй учраас дээрэнгүй, бардам ихэмсэг байлаа. Гэсэн ч Симотоод айх аюул бий. Тэрээр Гэрэлээ хүн хөлөг хоёрыг Сойхарагаар устгуулсан явдлыг сэжиглэж болох эгзгийг эргэцүүлэн бодоод Юкигээс айна. Чухам тэр эгзгүүдийг учиглан тооцоолсон Тозияа, өөрийнхөө хоёр шавийн ажлыг өөрчилж, Сойхарааг Токио руу явуулж, Симотоог квантуны армийн тагнуулын газар монголын асуудал хариуцах мэргэжилтэн болгосон билээ.

Симото, хундагатай жин шимж суухдаа Хасу Тоишийг үе үе нүдний булангаар ширтээд «Тайжууд отгоос гаралтай энэ залуугийн өвөг дээдэс Чингэсийн шууд удмын хүмүүс гэдэг. Тиймээс Хасу Тоиши, гоминдааны талыг баримталдаг байх. Хато сан, ах Хасбаатарыг нь урхидахаар үүнийг дэргэдээ авсан. Аягүй бол хөгшин генерал бөгсөн дээрээ хүйтэн жин тавиулж мэдэх юм. Тэгвэл ор сураггүй алдана гэсэн үг! Зүүн умард хятадад бүгсэн улаан хятадууд оросын хилийн дагуу байрлачихаад алс дорнод чиглэсэн манай армийн ажиллагаанд саад хийх санаатай. Ялангуяа оросын товчооны нууц ажиллагаанууд улаан оросуудад амархан мэдэгдэж байна.

Тэгээд учир нь олдохгүй замаар сүйрчихдэг! Дүрвэгсдийн товчоогоор хийлгэх ажлыг Хато

удирддаг. Гэтэл Хасу Тоиши, генералын амнаас дуулсан бүхний сэжгийг гаргаад ах руугаа мэдэгддэг бол яана! Хасу Тоиши, ухаалаг болохоор өөрийгөө хамгаалах нүх сүвийг маш сайн бэлдсэн байсан. Ялангуяа Амисэтэй танилцаж, Тогава, Аяанаосу хоёрыг зөрчлийг далимдуулж, Аяанаосуд ойртоод байгаа нь ямар зорилготой вэ? Хэрвээ Аяанаосуг Монголын ажиллагаанд оролцуулах гэсэн манай санаачилгыг Тозияагаас мэдсэн Хато, ам мэдэн бурсан бол Хасу Тоиши түүнийг дуулсан байж таарна.

Тэгэхээр үүнийг хавханд борвидуулах урхи бэлдэх үү? Эцэстээ урхи маань хэрэггүй болчихвол яана. Амисэгийн чихэнд өчүүхэн сэжиг өртвөл Хасу Тоишийг хамгаална. Тэгээд нөхөртөө ховловол яана! Эзэн хааны ивээлд багтаж, цэргийн яам, кэмпэйтэйн удирдлагыг атгандаа оруулсан тэр хүн нүд ирмэхийн зуур намайг тонилгож чадна. Ийм алдаа хийж толгойгоо залгиулах хэрэгтэй ороолдох хэрэг надад байх ёсгүй. Харин Аяанаосуг, Хасу Тоишигийн эсрэг турхирч чадвал өөр хэрэг! Тийм үед Амисэ, Хасу Тоишийг хамгаалахгүй. Харин Юки, Хасу Тоишийд тийм ч сайнгүй. Учир нь Цэен гүн ахтайгаа үзэл бодлоор таардаггүй байсныг Юки гадарладаг. Тиймээс эцгийнхээ ахын хүүхдүүдээс хол явдаг бололтой. Тэр жил Харбины сониныхонтой ярьсан ярианд "Ахыгаа дагаад улаан болчихвол яана. Тэгвэл хөрөнгөний гарз болно» гэсэн байсан. Тиймээс одоо хүртэл дүрвэгсдийн дуу хоолой сонинд хавсралт гаргахаас татгалзаад сохор зоос гаргаагүй. Ингэхээр Юки, Хасу Тоишийг хамгаалахгүй нь илэрхий! Хэрвээ Хасу Тоиши улаан хятадуудтай холбоотой бол түүнийг нь би илрүүлж чадвал хурандаа цол аманд ороод ирнэ» гэж бодов.

Тозияа Юки хоёрын урилгаар тэднийд цугласан квантуны армийн болон оросын дүрвэгсдийн товчооны удирдах ажилтангууд шөнө дүл болгоод тарлаа. Тэд онгоцны буудал дээр уулзахаар тохиролцоод салсан ажээ. Юки гийчдээ үдэж өгөөд Тозияагийн хажуугийн өрөөнд орж ор дэрээ засаад, өөрийнхөө өрөөнд орохдоо Сувдаад,

- Иван Степанович аавын өрөөнд байгаа. Хажуугийн өрөөнд ор дэр засчихсан гэж хэлээрэй. Намайг сураглавал толгой нь өвдөөд хэвтгээд өгсөн гэнэ биз. Би жаахан юм хийнэ гээд бичгийнхээ ширээний хажуугийн хананд гаргасан нууцын шүүгээнээс тэмдэглэлийн дэвтрээ гаргаад сандалдаа тухлан суулаа.

1937 оны 4 сарын 3. Японы эзэн хааны цэрэг Ханх нуурын хавиар Зөвлөлтийн алс дорнод руу довтолсон боловч амжилт олоогүйн учир шалтгааныг магадалсан баримтыг үзвэл Оцу илэрсэнтэй уялдуулж байна. Симото үүнийг илэрсэн явдлыг Дүрвэгсдийн товчооны ажиллагаатай холбож байна. Оцу төлөвлөгөөг шинэчилж, юуны өмнө хилийн дагуух төмөр замыг өргөтгөх, шинэчлэх ажлыг эхлүүлэхээр яарч байна. Монгол руу чиглэсэн армийн ажиллагаанд чухалчлагдсан тээврийн асуудлыг шийдэх нэг боломжийг хятад руу чиглүүлсэн Хэй төлөвлөгөөг хэрэгжүүлэх явдал гэж үзэж байна. Тиймээс японы цэргийн яам хятад, монголын асуудлыг сайн мэддэг Итакийг татаж авахаар шийдсэн бөгөөд цэргийн яамны сайд Сугияамагийн оронд тавих найдлагатай хүн гэж үзэх боллоо.

Юки тэмдэглэлээ бичиж дуустал Сувдаа орж ирлээ.

- Цаад хоёр чинь унтсан уу гэж Юки ширээнээс босохдоо асуухад,

- Унтаагүй байна. Дүрвэгсдийн товчооны ажиллагаа бүтэмж муутай байгаа учир явдлыг шүүн

хэлэлцэж байна. Ялангуяа Ханх нуурын ажиллагаа нурсан явдлыг Хатогийн дэргэдийн хүмүүстэй холбож, түүнийг илрүүлэх талаар дүрвэгсдийн товчоо шинэ ажиллагаа сэдэж байгаа бололтой.

- Сувдаа наадуулаа янзлаарай. Би явж унтлаа гээд өрөөнөөс гарахдаа ширээний түлхүүрийг Сувдаад өглөө.

Сувдаа Юкийг гарсны дараа сандал дээр нь сууж тэмдэглэлийн дэвтрийг уншлаа. Энэ тэмдэглэл бол Юкигийн бичих номонд орох дуртгалын эмхтгэл ажээ. Юки номынхоо төлөвлөгөөг тэмдэглэлийнхээ дэвтэрт хавсаргасан байв. Энэ номыг бичихэд Тозияа, Доихара, Итагаки нар Юкийд зөвлөх ёстой. Номын нэрийг "Гадаад монголд хаант улсыг дахин тогтоосон нь" гэжээ. Тэр номыг цэргийн яамны захиалгаар бичиж байгаа болохоор цэргийн яамны сайд агсан Арааки номын төлөвлөгөөг баталсан байлаа.

...Хатотой нэлээн ярилаа. Тэрээр Хасу Тоишигийн удам угсааны холбоог сайн мэдээгүй байна. Ялангуяа Хасу Тоиши, Хасбаатар хоёрын эгчийн талаар сэжиг аваагүй байна. Хато дүүгийнх нь тусламжтайгаар Хасбаатарыг баривчлах санаатай бөгөөд дараа нь Хасчулууныг цагдаагийн газар шилжүүлэх ёстой аж. Энэ ажиллагаанд Тозияагийн зөвшөөрлөөр Иван Степановичийг тавих бодолтой байна. Хасчулууныг цагдаагийн газар ажиллуулсны дараа түүнийг улааныхны удирдах ажилтанг баривчилж, японыхонд шилжүүлдэг гэдэг гүтгэлэг дэгдээх ёстой байна. Чухам энэ ажиллагаанд үндэслэж, умард хятад дахь улааны удирдлагыг хагалан бутаргах санаа сэджээ. Генерал Хатогийн сэдсэн энэ ажиллагаа амжилтанд хүрвэл түүний хувилбарыг Зөвлөлтийн улаан арми, нам төрийн удирдагчдыг гүтгэн үймүүлэх шинэ ажиллагаа сэдэх ёстой болой. Тиймээс Харбин дахь оросын фашист холбооны удирдагч Разаевскийн мэдэлд хутган үймүүлэгчдийн түр сургууль байгуулахаар шийджээ.

Сувдаа Юкигийн өдрийн тэмдэглэлийг уншаад айх гайхахын эрхэнд автагдлаа. Тэр юм бүхнийг эргэцүүлбэл Баатар гүнгийн үрчлэгдсэн учраа сая мэдлээ. Ингээд эрт өнгөрснийг бодох тусам Хасбаатар, Хасчулуун хоёрын эгч гэдгээ ойлгоод сэтгэлийн шаналгаанд эзэмдүүлэв.

Сувдаа долоон настайдаа Харбинд болсон тэр нэг явдлыг эргэн саналаа. Тэр уулзалт хорин дөрвөн жилийн турш сэтгэлд нь хадгалагдан тэр хэвээрээ үлджээ. Сувдаа Цэен гүнгийн гар дээр ирснээсээ хойш Хасбаатар, Хасчулуун хоёрыг харалгүй арван дөрвөн жил болжээ. Тэгээд энэ үдэш Хасчулуунтайгаа дайралдсанаа бодоод «Их том болжээ. Намайг танихгүй байх нь аргагүй юм даа» гэж бодлоо. Сувдаа хоёр дүүтэй гэдгээ энэ үдэш мэдсэний адилаар тэр хоёрт учирч болох аюулыг ч энэ үдэш мэдээд балмагдав.

Сувдаа Юкигийн өрөөг түгжээд хэдэн мөч элдвийг бодож суусан боловч тэрээр дүүтэйгээ уулзаж, учир байдлыг тайлбарлаж болохгүй гэдгийг юунаас ч илүү ойлголоо.

Тэгээд баахан уйлж сэтгэлийнхээ тээглээг онгойлгоод, Юкигийн тэмдэглэлийн дэвтрийг нууц шүүгээнд хийгээд өрөөндөө орж хажуулсан боловч түүний нойр хүрсэнгүй. Ийнхүү хэрэг явдлыг эргэцүүлэх тусам хоёр дүүгийнхээ хувь заяанд учирч болох аюулыг зүрх сэтгэлээрээ мэдэрч ойлгох тусам харамсах сэтгэл төрнө. Ахуй амьдрал нэг эцгийн эгч дүү гурвыг нар, сар, од шиг эрс тэс ялгаатай болгожээ. Сувдаа үүр цайтал элдвийг бодон

Хасчулуунтай уулзаж учир байдлыг ойлгуулах далим хайсан авч ямар нэг эгзэг гаргаж болохгүй байлаа.

Итагакийг жанжин штабт очсоны дараа квантуны армийн хээрийн цагдаагийн дарга байсан хурандаа Тозио генерал болж, квантуны армийн штабын даргад дэвшив.

Хидэки Тозио, 1919 онд японы цэргийн академийг төгсөөд, Германд цэргийн атташегаар ажилласан билээ. Тэрээр 1928 онд квантуны армийн цэргийн цагдаагийн газрын тэргүүн болж алдар суугаа мандуулсан юм. Хидэки Тозиогийн эцсийн зорилго бол сайд нарын танхимыг гартаа авах эрмэлзлэлтэй. Тэрээр квантуны армийн штабын даргын тушаалыг хүлээн авангуут жанжин штабт илтгэх хуудас бичлээ.

Түүний илтгэлд «Аугаа их азийн цэцэглэлтийн цаашдын зорилготой уялдуулбал хятадын асуудлыг мухарлан шийдэх алхмыг түргэтгэх хамгийн сайн арга бол Нанжингийн засгийн газарт (Чан Кайшид) цохилт өгч, бидний араас аюул учруулж болох боломжийг арилгах явдал бөгөөд Сибирийн баялаг руу орох бидний замд саад болсон гадаад монголыг эзэн хааны мэдэлд оруулах манай зорилтыг хэрэгжүүлэх явдлыг түргэтгэхэд оршино» гэж айлджээ. Тозио, ингээд зогссонгүй Хаясигийн засгийн газрыг огцруулахыг хичээж, хан хүү Коноэгийг гарт засгийн газрыг шилжүүлэхийг шаардсан болой.

Сүүлийн арван жилийн турш японы засгийн газрын тэргүүнд тогтож чадаагүй ерөнхий сайдын нэг бол Хаяси боллоо. Тэрээр засгийн газрыг ердөө жаран зургаан хоног толгойлов. Харин түүний оронд 1937 оны 6 сарын 4 нд арав дахь ерөнхий сайдаар Коноэ дэвшлээ.

Коноэ, японы улс төрийн амьдрал, эдийн засгийн хямралыг зайлуулах замыг тодорхойлохдоо хятадад дайн зарлаж, умардын хувилбарын дагуу алс дорнод руу армия хөдөлгөх асуудлыг чухал гэж тунхаглав. Хан хүү Коноэ ерөнхий сайд болоод тав хоноод байхад түүний нагац ах хунтайз Хасимото, ерөнхий сайдын даалгавраар манжуур, солонгос, Гауньдунд байгаа армийн үйл ажиллагаатай танилцахаар хэсүүчлэв.

Синьзин дэх квантуны арми, штабын ёслолын танхимд хүлээн авалтын ширээ засаж, танхимын голд эзэн хааны хөргийг ёслол төгөлдөр залж, самурайн ёс бусидогийн дагуу дайныг бишрэн шүтэхийн билэгдэл болсон илдэт тахилга засжээ.

Өмнө зүг нарны илчинд боловсорсон жимсийг дарж нэрсэн дарс, архи, янз бүрийн жимс, зууш алагласан ширээний тэргүүнд хунтайз Хасимото сууж, түүний баруун гар талд нь Тозио заларч, зүүн гар талд нь саяхан арван нэгдүгээр армийн командлагч болсон Доихара суужээ. Тозия, квантуны армийн даргын баруун гар талд суусан агаад доохон талд цагаан саатай үнэт хоргойгоор хийсэн европ хувцас өмссөн Юки, дэрвэгэр захаа задгай тавьсан болохоор нарийн цагаахан хүзүүнд нь зүүсэн шижир алтан зүүлтний эрдэнийн чулуун шигтгээ уужим танхимын болор чимэгтэй чийдэнгийн туяанаас өнгө цацруулан гялтганаж, хүн хүний шохоорхолт харцыг булаах ажээ.

Ажил үүргийн хувьд энэ дайллаганд оролцсон хүмүүсийн хамгийн бага тушаалтай нь Симото байлаа. Тэрээр сурсан зангаараа хүн бүхнийг илүү дутууг сонжиж суухдаа «Юки сан аргагүй л алттай хүн юм даа. Амьдаараа алтанд умбаж, бадмааргаар баглуулна гэдэг энэ байх

даа. Хань нөхрийн халамж үзээгүй энэ хүүхэн, эр хүний дулаан өвөр, халамжтай халуун үгний ид шидийг амтархдаг болов уу» гэж бодоод эчнээнийг гижигдсэн нэгэн далд бодолд өөрийгөө тушаах авч бас зүрх шимширсэн бодолд автагдана. Тозио суудлаасаа өндийж, хан хүүгийн нагац Хасимотогийн эрүүл мэндийг ерөөж, албан тушаалыг хүндэтгэн зүйргэн үг урсгаж гарлаа.

- Эрхэм генерал дарга нараа. Хүндэт хатагтай зочид гийчдээ. Бид эзэн хааны замналыг азид тогтоож, славянуудаас өмнө яматогийн хөвгүүдийн сүр хүчийг азид алдаршуулах эрин үетэй золгоод байна. Энэ эрхэм үйлс хориод хоногийн дараа эхлэх болтугай.... Банзай гэхэд зочид дайллагын ширээний араас зэрэг

босож Банзай... Банзай... Банзай... гэж гурвантаа хашгирлаа...

- Эрхэм ноёдоо, азийг нэгтгэн төвхнүүлэх хамгийн их хариуцлага бидэнд оногдож байна. Умард зүгийн асуудал хариуцлага бидэнд оногдож байна. Умард зүгийн асуудал буюу Байгаль Сибирь, Алс дорнодыг улаан оросоос аврах, эзэн хаан тэнногийн дэглэмийг тогтоох, ямато үндэстний сүр хүчинд азийг төдийгүй дэлхийн улс түмнийг сөгтгөж, нэгэн дээвэр доор дагуулах үйл хэргийг азиас эхлэх ёстой юм. Тиймээс азийн төвд гадаад монгол гэдэг нэр байж болохгүй. Энэ зорилтыг хэрэгжүүлэх анхны алхам дорно зүгээс буюу Тяньжин Бээжингийн чиглэлээс гараагаа эхлэх ёстой. Ингэснээрээ бид, ертөнцийг эзэн хааны ивээлд багтааж, аугаа их, нэгэн өрх гэрийг тогтоох ёстой. Энэ бол ямато үндэстний өрх гэр байх ёстой. Энэ бол Хакку ити о мөн. Банзай. Тозиог үгээ хэлж дуусахад хүмүүс суудлаасаа босон цөмөөрөө «Хакку ити о-ертөнцийг нэгэн дээвэрт нэгтгэн захирья» гэж хашгирлаа.

Хан хүүгийн нагац, суудлаасаа алгуурхан өндийж хүмүүсийн зүг хайнгадуу харж хэсэгхэн дуугүй зогссоноо,

- Эрхэм ноёд оо. Яматогийн үнэнч хөвгүүд ээ. Эзэн хаан тэнногийн шинэ дэглэмийг хэрэгжүүлэх үйлс эхлэх нөхцөл төгс төгөлдөр бүрдсэнийг би нүдээр үзлээ. Би армийн цаашдын ажил хэрэгт зайлшгүй хэрэгтэй байгаа онцгой талуудыг мэдэж авлаа. Үүнийг ерөнхий сайдад биеэр танилцуулна. Одоо хөдлөх цаг нэгэнт болжээ. Бид Нанжингийн засгийн газрыг устгавал хятадыг нүд ирмэхийн зуур хэлэлцээгээр шийдэж чадна. Нанжингийн дэглэмийг устгаад хятадыг авсан цагт гадаад монгол, эзэн хааны замналыг хүлцэнгүйгээр дагах болно. Тийм зам аяндаа нээгдэнэ. Эзэн хааны армийг Сибирь Байгалийн цаана хүргэж чадах тэр замыг гадаад монголоос эхлэх ёстой. Гадаад монголыг авна гэдэг бол бид ёслолын хаалгыг нээнэ гэсэн хэрэг мөн. Банзай... Хакку ити о... Банзай.

Хасимотоог хүндэтгэсэн цайллага дээр ирсэн зочид, самурайн цэрэг эрсийн замнал Бусидогийн тангарагт үнэнч байхаа баталж байхад ганц хүн энэ урианд түрлэг үл нэмнэ. Энэ бол Юки байлаа. Юки ерөнхий сайд Коноэгийн нагацын илэн далангүй үгэнд эгдүүцсэнийг ажсан Тозио, Тозияа хоёр сэтгэлдээ «Үүнийг дайллаганд хэрэггүй урьж» гэж бодно. Хасимотогийн дайллага дээр «Монголын хаант улсын талаар» ганц ч үг дурсаагүй болохоор Юкигийн уур хүрэх нь зүйн хэрэг болой. Тиймээс Тозияа түүний сэтгэлийг тайтгаруулах тухай бодож байлаа.

Дайллага өндөрлөх дөхөж байхад Хасимото гэнэт алга болжээ. Гэтэл Симото, Тозияагийн

дэргэд ирээд чихэнд нь «Эрхэм дээдэс минь таныг Тозио сан уулзъя гэж байна. Хасимото сурагласан бололтой» гэхэд Тозияа толгой дохиод суудлаасаа өндийхдөө,

- Симото сан та Юкийд минь хань болж байгаач. Зарим хүмүүсийг Юкитэй танилцуулахыг бодоорой гээд Тозиогийн албан өрөө рүү гэлдэрчээ.

Симото, Юкитэй ярих арга ухаанаа олж ядан хэсэг балмагдсанаа,

- Юки сан, Хасимотогийн үг танд ямар санагдав даа гэж асуув.

- Би Хасимотогийн үгийн утгыг ойлгосонгүй. Гадаад монголын талаар буруу бодол баримталж байна. Наран улсын арми, гадаад монголд хаант засаг тогтоож өгөхөд туслах ёстой. Энэ хөгшин буруу ухаарч, өөр юмтай хольж хутгаад байх шиг байна. Харин Тозио сан, хан хүүгийн нагацын талд бөнжигнөж үгээ бөөрөнхийлсний учрыг би ойлгосонгүй. Харин эдний үгнээс миний ойлгосон нэг зүйл гэвэл Чан Кайшигийн гуйвамтгай байдлаас болоод гадаад Монголд наран улсын цэрэг тусламж үзүүлэх боломжгүй байсныг мэдлээ. Одоо квантуны арми асуудалд яаж хандахыг л харах хэрэгтэй болсон байна гэж бодлоо гэв.

- Тозио саны үг бол сайд нарын танхимыг арми руу хандуулах гэсэн бодлогын илрэл гэж бодож байна. Тэдэнд тал засахгүй бол сайд нарын танхим, армийг олигтойхон хөрөнгөжүүлэхгүй, гар татаад байх болно шүү. Тэгэхээр Юки сан минь Тозиогийн үгийг зөв ойлгох хэрэгтэй. Түүнээс гадна, гүйдэлгүй жингэр, гүйх нохойд саад болдог гэгчээр Чай Кайши, Жан Сюэлян хоёр манай армийн ажиллагаанд хичнээн саад болсныг та ойлгож байна. Одоо чинь гоминдаан, улаан хятад хоёр сүүж холбож, манай армийн эсрэг байлдах гээд байгаа учраас Чан Кайшигийн дотно хүн Жан Цюнгээр толгойлуулсан хүмүүс Яньанд очоод Маогийнхантай уулзаж, гурав хоногийн турш хэлэлцээ хийгээд байхад Тозио сан хятадын асуудлыг мухарлахыг бодолгүй яахав гэж Симото, Юкигийн бодлыг зөөлрүүлэхийг мэрийж үгээ бодож ярина.

- За яахав чиний хэлсэн үгэнд үнэний хувь байгаа байх гэж бодъё.

- Юки сан, та миний үгийг сайн ойлголоо. Одоо манай цэрэг Бээжингийн асуудлыг шийдчихвэл Долнуур, Хаалган, Датун, Баоту хотыг авахад хялбархан болно. Тэгэхээр Монголд хаант улс тогтоох зам шулуудна шүү.

- Сайхан бэлэг дэмбэрэлтэй ам байна. Би зургаан жил хүлээж байгаа болохоор заримдаа хүүхэд шиг цөхрөх юм. Тиймээс Симото сан, та миний сэтгэлийг зөвөөр ойлгоно биз. Яагаад ч юм бэ? Таны хэлсэн үг надад үнэн юм шиг санагддаг гээд уруулаа мушилзуулан инээмсэглэхэд Симото далим гарсанд баярлаж, ширээн дээрээс дарс авч Юкийд барилаа. Юки зөөлөн дарс шимж байхдаа нүдний булангаар Симотоог ширтэн "Энэ лүд надад наалдах гээд байгааг ажвал ямар нэг хэрэг гарч дээ. Харахаас л зэвүүн. Болдогсон бол Гэрэлээ эгч, аавынхаа өшөөг авах юмсан. Гэхдээ эдэнд сэтгэлийнхээ эчнээний бодлыг илэрхийлж болохгүй. Нэг гараа нөгөөгөөрөө барьж, хэлээ шүдээрээ хазаж явах хэрэгтэй. Аав минь хятадуудыг үздэггүй мөртлөө өөрийнхөө санааг нууж чаддаг байсан. Тэгэхээр эдний санааг нүүрэн дээрээ дэмжсэн дүр гаргах ёстой» гэж бодно.

- Юки сан, өчүүхэн мөхөс би, үнэн юманд дуртай. Тэгээд үнэнийг санамсаргүй ярьчихдаг юм. Таны ирээдүйн төлөө армийн удирдлага их анхаарал тавьдаг болохоор би ч гэсэн аминдаа баярлаж явдаг. Тэгэхдээ таныг ингэж баярлуулна гэж санаагүй

шүү.

- Симото сан та эхнэр авах уу? Ер нь ганц биеэрээ амьдралыг туулах уу гэж асуусандаа Юки санаа зовсон янзтай хацар нь ягаарсхийлээ. Юки ингэж асуусандаа ичсэн бололтой, яриагаа үргэлжлүүлж, Симото сан, та намайг ингэж асуусан явдалд битгий шоолоорой. Эмэгтэй хүн чинь иймэрхүү саваагүй юманд дуртай шүү. Та үүнийг юу андах вэ? гээд баруун гараараа Симотогийн гарын шуунаас атгаад уруулаараа инээмсэглэж нүдээрээ ирмэнэ.

- Ойлгож байна. Юки сан, амьдрал ахуй маань цэргийн хуаранд өнгөрсөн болохоор тохь тухтай амьдрах зав надад олдоогүй юм. За тэгээд олдохгүй байх! Заримдаа сэтгэлийн уйтгар, бухимдлаа ярьчихмаар хүнгүйдээ айх юм. Тэгээд янз бүрийн бодолд автагдаад эхнэртэй болдог юм билүү гэж боддог удаа бий шүү.

- Хэн ч гүй тэгж бодох юм. Ганцаараа амьдрах гэдэг чинь бөөн уйтгар! Ер нь янз бүрийн бодолд автагдаад ирэхээр ингэсээр яваад үр хүүхэдгүй насыг барвал яана. Энэ хөрөнгө маань хүний хоол болно гэж боддог удаа зөндөө байдаг.

- Юки сан, хүн насаа ахих тусам хань ижлийн тухай яах ийхийн зуургүй боддог бололтой. Би ч гэсэн ямаршуухан хүний үртэй учирдаг бол гэж боддог. Залуу насанд цэргийн хуаран сайхан санагдаад эхнэр авья гэж боддоггүй явлаа. Одоо нас ахиад ирэхээр цэргийн хуарангийн аялг даахгүй юм шиг санагддаг болж байна. За тэгээд зуугийн тал дөхлөө. Гэтэл би гэдэг амьтан хань ижилгүй явдаг. Та бол яахав, хөрөнгөтэй бэлтэй. Залуу зандангаараа байна. Ер нь эндээ гэхэд манайхан таныг Дүрвэгсдийн товчооны Ивантай суух байх гэгцгээдэг юм. Ялангуяа Итаки саныг үдэхээр ирээд танайд хориод хоноход лав нижгэр хурим болох байх гэдэг байсан шүү гээд Симото, Юкигийн царай өөд ширтэв.

- Симото сан, Иван бид хоёр амьдрал таарахгүй хүмүүс. За тэгээд тэр мангардуу хүн! Бид хоёр багаасаа үерхсэн болохоор би цаадахыг чинь андахгүй. Бүүр тэнэг амьтан шүү. Багадаа намайг яаж зоддог байсан гэж санана. Миний гээгнээс бариад хайр найргүй угзардаг сан. Тэгээд одоо хүртэл мартагддаггүй юм. Ер нь би, Иван Степановичтай суухгүй гэж боддог... Үгүй ингэхэд та бид хоёр чинь юунаас болоод ийм балай юм ярьж байна даа. Хэн хэн маань архинд халжээ дээ. Бид хоёр руу хүмүүс хараад байна. Одоо дэмий донгосохоо больё гэж Юкийг хэлэхэд Симото дуугүй боллоо. Энэхэн үед нөгөө өрөөнөөс Тозияг ирж явахыг харсан Юки, асарсан эцгээ тосон очлоо. Харин Симото талимаарсан нүдээр Юкигийн араас ширтэн «Энэ баян бүсгүй амьдын жаргалд уйдаж залхжээ. Эмсүүд нэг хэсэгтээ гоё сайхан залуус руу тэмүүлж, хоосон хүсэл мөрөөдөлдөө урхидуулж явахдаа найр цэнгэл хөөж, зуурдын сэтгэлийг үүрдийн юм шиг бодоод залуу сайхан үеэ өнгөрөөдөг.

Тэгээд эцэст нь хань ижилгүй үлдсэнээ ойлгонгуут амьдын жаргалд ташаарч явснаа санаад тэр зам мөрөө өөрийн эрхгүй жигшихэд хүрдэг билээ. Тэгээд зогсдоггүй, чингэж шалиглаж яваад залуу насаа гээснээ мэдэнгүүт бие сэтгэлээрээ гутардаг удаатай. Эмэгтэй хүн ийм үедээ гоё сайхан залуусыг харахаас нүд нь хорсож, энэ сайхан царайны цаана шулам шүглэж

байгаа шүү дээ гэж өөртөө анхааруулж болгоомжилдог гэнэ билээ. Тэгээд гоё сайхан залуустай наргиж, цэнгэж явахдаа яаж мэхлэгдсэндээ биеэ сул тавьж эдлүүлснээ бодохоор гол руу нь хүйт оргиж, зүрх нь шимшрэх шиг болдог гэсэн. Тийм үедээ хань ижлийн түшиг тулгуур, хайр халамжийн талаар ойлгоод эргэцүүлээд ирэхээр томоотой, тохь тухтай хөгшчүүлийг хайдаг замтай. Ингэхээр Юки ийм замаар орж залхсан хүүхэн байх нь. Ийм үедээ эмэгтэй хүн сэтгэлдээ дассан хөгшчүүлд илүү янаг, хайртай болдог гэсэн.

Юки чинь одоо гучин тав хүрч байгаа болохоор аргагүй хань ижлээ мөрөөддөг нас!» гэж бодохдоо ойворгон сэтгэлдээ далдын нэгэн бодол төрснөө ухаарлаа.

Хан хүүгийн нагацыг Токио руу буцсаны дараа Тозияа гүн бодолд орлоо. Тэрээр Синьзингээс ирсний дараа Тяньжин руу хоёр удаа ярьж, Доихаратай холбоо барилаа. Тэгээд Бээжинд байгаа «Холбоотны эзэмшлийн комиссын» дарга генерал Такэо Имаи руу тусгай цахилгаан явуулав. Юки асарсан эцгээ чингэж сандрангуй байхыг ер үзээгүй. Тозияа Хасимототой уулзсанаас хойш бүр адгуу болжээ. Чингээд л Тозияа, Хасимототой ам мурийснаа орой бүр боддог болсныг хэн яахан мэдэх вэ.

Тозияа дайлагын танхимаас гарч Тозиогийн тусгай өрөөнд ороход Хасимото хүйтэн царайгаар угтав.

- Тозияа сан би тантай ингэж уулзсаны хувьд хэдэн зүйлийг хэлэх гэсэн юм. Ерөнхий сайд ар монгол руу чиглэсэн ажиллагааны явц бүтэмж муутай байгаа явдалд эвлэрэнгүй хандаж болохгүй гэсэн. Ар монголд ажиллаж байгаа квантуны армийн тагнуулын хэлтэст данстай байдаг «тарган хулганууд» эзэн хааны сүр хүчинд сүйдтэй дэмжлэг үзүүлсэнгүй. Харин тэд чинь өөрснөө сүйрээд байгааг та мэдэж байна уу? Нөгөө талаар Егүзэрийн хийдийн «дархан цорж» Их хүрээний ёнзон хамба нарын ажиллагаа усанд хаясан чулуу шиг таг чиг болсон. Өлгий хийд Сан бэйсийн хүрээнийхэн цөмөөрөө годронгийн ямаа шиг хиарсан сурагтай байна. Гэтэл энэ бүхэн юутай холбоотой болохыг нягтлаагүйгээр барахгүй монголд байгаа армийн «нүд чих» цөмөөрөө «Монголын чекистүүдийн» гараар орсон мэдээ ерөнхий сайдад очсон байна. Гэтэл үүнийг мэдвэл зохих зарим хүмүүс одоо хүртэл сургийг нь дуулаагүй явна. Та үүнийг юу гэж бодож байна гэж шүүгч шиг сүрдүүлэхдээ Тозио руу ууртай нүдээр хяламхийн харлаа.

- Монголд байгаа хүрээ хийдийн лам нар манай тагнуулуудын удирдлагаар бослогонд бэлтгэж байсан нь үнэн боловч тэдний сүйрэх ажиллагаанд манайхан ямар ч буруугүй. Энэ бол Хайлар дахь цэргийнхэн болон дүрвэгсдийн товчооныхон болгоомжгүй хандлага гаргаж, газрын зургийн мэргэжилтэнгүүдийг монгол руу явуулах удирдамж өгөөгүй байхад өөрснөө дур зоргоороо хүмүүс бэлдэж явуулсантай холбоотой. Ялангуяа газрын зургийн тодруулалт хийх хэсэгтэй цагаантны дарга нараас явалцсан нь ажлыг хундрүүлээд зогсоогүй тэр нь баригдаад оргохдоо Баянтүмэнд байсан манай хүмүүстэй уулзах гэж байгаад сэжиглэгдсэн байна. Тэгээд дороо баригдаад өөрийнхөө мэдэж байсан бүх зүйлийг хэлж, өөрийнхөө амийг бодсон учраас Сан бэйсийн хүрээний лам нар баригдсан юм. Тэр лам нар дотор Егүзэрийн хийдийн дархан Цоржтой холбоотой хүн орсноос бослогын асуудал илэрсэн. Түүгээр барахгүй ёнзон хамбын холбоочин баригдсан байна. Ингээд хамаг ажил нурсан хэрэг.

- Тозияа сан тэгвэл та яагаад одоо хүртэл дуугүй байсан юм бэ?

- Би Цэен гүнгийн холбоочинг хүрээнээс ирэхийг хүлээсэн юм. Түүнийг Улаанбаатараас ирмэгц тэнд юу болсныг мэдэж байж илтгэе гэж бодсон юм. Нөгөө талаар гүнгийн холбоочныг Юки хүлээн авч уулзах учраас үүнийг хүн бүхэнд мэдэгдэх албагүй байсан.

- Тозияа сан, та иймэрхүү замаар Юкийг хамгаалж өдий хүрсэн. Гэтэл талийгаач эцгийн нь авчирсан Богдын алтны асуудал одоо хүртэл шийдэгдээгүй байна. Тэр ч байтугай армийн тагнуулын газар алтны хадгалагдаж байгаа банкнийг мэдэх гэж Шанхай, Бээжин, Тяньжин, Кантоноор сураг тавиад олигтой зүйл болоогүй.

- Хасимото сан, Богдын алтны тухайд гэвэл жанжин штабын сул амтангууд нууцыг нь задалсан учраас түүнийг хадгалж байгаа банк Цэен гүнтэй хийсэн гэрээнийхээ дагуу хадгалж нууцалж чадсан. Хэрвээ тэгж их сүр бадруулаагүй бол алтны нууц яваандаа илрэх байсан юм. Гэхдээ энэ найдвар тасраагүй байгаа. Тиймээс жанжин штабын сул амтай, задгай хүмүүсийг энэ ажиллагаанд оролцуулахыг эзэн хаанд үнэнч самурайн хувьд уучлахгүй гэж самурай бусидо ёсыг барьж ярьсан төдийгүй эзэн хааны нэр дээр гомдол мэдүүлнэ гэж дүвчигнэсэн тул Хасимото өөртөө хамаагүй зүйлд хошуу дүрэхэд хүрснээ ойлгоод дуугүй болжээ.

- Тозияа сан, ерөнхий сайд Коноэ, Хайлар, Харбины төмөр замыг өргөтгөж, ачаа тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэж байгаа. Тиймээс Юки та хоёрыг Токиод ирвэл ямар вэ гэж хэлүүлсэн юм. Тэгэхдээ Дорнод төмөр замын талаар хувийн пүүсүүд болон засгийн газрын хамтарсан байгууллага байгуулах шийд гарсны дараа бол бүүр зүгээр гэсэн юм. Жанжин штабаас боловсруулсан төлөвлөгөөтэй уялдуулж, Доихара «Хааны гүүр» гэдэг ажиллагаа сэдсэн байна. Тиймээс тэр тухай таныг Доихаратай харилцах байх гэж бодож байна гээд ярианыхаа өнгийг өөрчилж зөөллөнө. Тозияа армийн ажиллагааг Бээжин рүү чиглүүлсэн явдлыг Хасимотогийн ярианаас мэдээд Доихарааг хятад дахь арван нэгдүгээр дивизийн командлагч болгосон учрыг багцаалав. Энэ бол Бээжин рүү чиглэсэн ажиллагааг удирдуулах гэсэн хэрэг байлаа. Харин Тозияагийн сэтгэл зовоосон бодол бол «Хасимото токиод очоод ерөнхий сайдаар дамжуулж эзэн хаанд хов хүргүүлэх үү? Хааны зөвлөхүүд тэр ховыг хэрхэн хүлээж авах вэ?» гэдэгт санаа зовно...

- Аав аа та тэгээд Тяньжин руу явах болоо юу? Дэмий ингэж өөрийгөө зовоохын оронд дан өөрийнхөө ажлыг бодмоор юм даа. Таныг бухимдаад байхаар миний сэтгэл өвдчих шиг болох юм. Та ганцхан монголын асуудлыг хариуцах ёстой биз дээ гэлээ. Үнэндээ Юкигийн үг зөв байлаа. Гэтэл армийнхан түүнийг туршлагатай хүн гэж өргөмжилдөг болохоор нэг мэдэхэд Тозияа өөрөө бүх ажиллагаанд оролцчихдог ажээ. Нөгөө талаар Доихара Тозияагийн дэмжлэгийг авдаг болохоор түүнтэй гар нийлсэн ажилд дуртай болжээ. Харин энэ орой Тозияа, ажлаасаа ирсний дараа халуун усанд ороод хөнгөн шингэн байлаа. Тэрээр өнөө өглөө эзэн хааны зөвлөхтэй утсаар ярихдаа Хасимотогийн талаар чих тавьжээ. Хасимото, Синьзингээс буцаж очоод ерөнхий сайдад квантуны армийн талаар танилцуулахдаа Тозияагийн талаар муу үг цухуйлгасангүй. Тиймээс Тозияа энэ өдөр бүүр тайвширсан байлаа.

- Юки минь, би уурлахаа больсон. Харин баяртай байна. Ерөнхий сайд цэргийн яамны төсвийг нэмэгдүүлж, хятадад байгаа манай армийн хүчийг 500 мянгад хүргэхээр шийдсэн бололтой. Үүнтэй уялдуулж хятадад байгаа 17 дивизийн зохион байгуулалтыг өөрчилсөн байна. Аав нь маргааш Тяньжин рүү явна. Намайг байхгүй хойгуур Симото, Синьзингээс ирж магадгүй. Түүнийг хүлээлгэж байгаарай гэж хэлтэл Сувдаа орж ирлээ. Чингээд эцэг охин

хоёр оройн хоол зооглохоор өрөөнөөсөө гарлаа.

Юки хоолны дараа зочдын өрөөнд орж ирээд усан оргилуурт эрх дураараа умбаж байгаа тао загаснуудаа хооллов. Уужим өрөөний ханын дагуух шилэн шүүгээнд төхөөрөмжилсэн цахилгаан гэрлийг асаагаад ханын чийдэнгүүдийг унтраажээ. Тиймээс шилэн шүүгээнд байгаа алт, мөнгөн аяга, хаш чулуун гүц, хундага, аяга тавагнууд чамин өнгөөр гэрэлтэнэ. Юки, загасаа хооллож суухдаа хоолны үед ярьсан Тозияагийн яриаг санав. Тэгээд өрөөндөө орж тэмдэглэлийнхээ дэвтрийг авч ширээн дээр дэлгэв.

1937 оны 6 сарын 25. Хятадад байгаа японы армийн дивизийг шинэчлэн зохион байгуулахдаа А, Б гэж ангилжээ. А бүлгийн дивизийн бүрэлдэхүүнд 22,6 мянган цэрэг орсон бол Б бүлгийн дивиз нь 24, 5 мянган цэргийн бүрэлдэхүүнтэй аж. Дивиз бүр танкийн бригадтай бөгөөд 150 хөнгөн танк, 38 хүнд танкнаас бүрэлдэнэ. Мөн 50 нисэх бүхий тусгай отрядтай болно. Японы цэргийн зэвсгийн үйлдвэрүүд энэ онд төрөл бүрийн буу 42,7 мянга, пулемёт 2,3 мянга, янз бүрийн их буу 47,8 онгоц 2,5 мянгыг үйлдвэрлэх аж. Аав Тяньжин руу явж Доихаратай нийлж, генерал Кавабэтэй уулзах гэнэ. Түүний удирдсан явган цэргийн бригад 10 мянган цэрэгтэй, 30 их буутай, 28 танктай, 20 нисэх онгоцтой гэнэ. Тэд Бээжин Тяньжингийн төмөр замын дагуу байрласан аж. Генерал Кавабэ Бохайн эрэг хавийг хамгаалах, Дагу боомтыг хяналтандаа авч байх үүрэгтэй ажээ. Мөн Бээжингийн ойролцоох Юньдин голын гүүрийн хавьд японы цэргийн 8 дугаар суман хээрийн сургууль хийх ёстой гэнэ. Хээрийн сургууль... хээрийн сургууль...

Аав Хасимототой ам мурийсан нэг шалтаг бол Доихара тэр хоёрыг Бээжин рүү чиглэсэн армийн ажиллагааг далдлах "Эзэн хааны гүүр" гэдэг ажиллагаанд оролцохыг даалгажээ. Аав түүнийг зохион байгуулах төлөвлөгөөг хийлцээгүй болохоор оролцохгүйгээр шийдсэн боловч Доихарагийн саналыг дагалаа. Аав хүний төлөвлөсөн ажиллагаанд оролцох дургүй болохоор Бээжин рүү японы цэргийг оруулахаар төлөвлөсөн Хасимотогийн ажиллагаанаас хөндий байхыг бодсон аж. Гэтэл Хасимото, өвгөний дургүйг хүргэхгүйн тулд ерөнхий сайдад илүү дутуу хов жив шивнээгүй нь илэрхий тул түүний "сайн дур нь" хүрч, ажилд оролцохоор шийдсэн бололтой. Эзэн хааны гүүр гэдэг төлөвлөгөөгөөр японы арми Бээжинг эзэлсний дараа Их хэрмийн дагуу армия хөдөлгөж, Жанчхүүгийн чанадад квантуны арми, ажиллагаагаа эхлэх ёстой байлаа. Аав энэ бүхний учрыг надад цухуйлгаад номоо эхлэхийг даалгалаа. Номын эхний бүлгийг "Хан улсын түрэмгийллийн эсрэг тэмцсэн нүүдэлчид" гэдэг оршил бүлгээр эхлэх гэнэ. Тэгээд өөртөө байгаа баримтуудаа надад өглөө.

Тозияа Тяньжин руу явснаас хойш гурав хонож байтал нэгэн орой Симото Синьзингээс ирлээ. Юки, Симотоог ирсэн явдалд бэлэгшээсэн дүр гаргаж, хүндэтгэн дайлж ширээ засуулав.

- Симото сан, аав танд цахилгаан явуулаа юу?

- Тиймээ. Юу гээ вэ?

- Аав Тяньжин руу явахын өмнө чамайг ирнэ гэсэн юм. Тэгээд хүлээлгэж байгаарай гэж захисан. Ингэхээр аав өнөө шөнө ирэх хэрэг үү?

- Тэгж таарах байх. Намайг маргааш өглөө гэхэд бэлэн бай гэсэн байсан. Тэгэхээр таны

хэлдэг зөв байх гэхэд Юки голланд жин хундагалаад Симотоод барихдаа "Тюоку сесен рэйсю буюу Хятад дахь хэсэгчилсэн салбаруудын байлдааны үлгэр дуурайл" гэсэн эмхтгэлд японы цэргийн салбар ангиуд хэсэгчилсэн өдөөн хатгалгаас дайны байдалд шилжихэд шаардлагатай нөхцөлийг хэрхэн хангах тухай номлосныг саналаа.

Хасимото Синьзинд ирсэн явдал, монголын хил дээр дэгдээсэн хэсэгчилсэн өдөөн хатгах ажиллагааг байлдааны байдалд шилжүүлэх нөхцөлийн урьдчилал болж мэдэх ажээ. Чухам энэ учраас Харбин, Хайлар, Ганжуурын болон Бээжин-Хаалганы төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр байгуулах асуудлыг сонирхсон хэрэг аж.

Юки Хасимотогийн айлчлалыг эргэцүүлээд "Хасимото, Бээжин рүү чиглэсэн армийн ажиллагааг боловсруулсны адилаар монгол руу чиглэсэн өдөөн хатгалгыг төлөвлөх хүний нэг байвал яана. Квантуны арми Жанчхүү рүү чиглэсэн ажиллагаанд бэлтгэж байгаа нь энэ бүхний зангилаа" гэж бодлоо.

- Симото сан, цэргийн яам Хасимотогийн саналыг яах бол?

- Юки сан, та юу гэж бодож байна даа?

- Би цэргийн эрдэм мэдлэггүй хүн. Ганцхан доромжлогдсон нэр төр, удам угсаагаа боддог. Хасимото, цэргийн яамны орлогч Умэзу, жанжин штабын даргатны туслах Киёси хоёрт илгээсэн илтгэлдээ дорнод хятадын далайн эрэг хавь, тухайлбал Тяньжины чиглэлийг ашигтай гэж үзсэн бол надад ашиг гарахгүй. Одоо чинь Нанжин Бээжин хоёрыг Чан Кайшигаас салгахыг илүү эрхэмлэж байна. Тэгэхээр квантуны арми Хөх хот руу чиглэнэ гэсэн үг гээд Симотогийн царай руу эгцлэн ширтэх нь квантуны арми, ар монголын талаар цаашдаа ямар алхам хийхийг мэдэх гэсэн эрмэлзэл болохыг Симото түвэггүйхэн мэднэ. Үнэндээ ардын засгийг устгаж, хуучин засаг төрөө тогтоох гэсэн эцгийнхээ мөрөөдлийг сохроор дагасан эмэгтэйд үүнээс өөр юу бодогдох билээ.

- Юки сан, би таны саналыг дэмжиж байна. Гэхдээ та бид хоёрын санал бодлыг ерөнхий сайд Коноэ сонсохгүй шүү дээ. Ер нь Бээжинг эзлэн авах явдал хоёр талтай. Юуны өмнө Маогийнхантай нийлсэн Чан Кайшигийн дэглэмийг даруйхан устгах, нөгөө талаар Тяньжингаас Бээжин хүртэлх төмөр замыг авбал Гуаньдунгийн арал, Солонгосоос Бээжин рүү манай цэргийг татаж, тэндээсээ Хаалган руу татах зам харилцаа саадгүй болно. Өөрөөр хэлбэл манай армийн цэргийг Гуаньдунгийн өмнөд хэсгээс Мугдэн, Харбин, Хайларыг дайруулж монгол руу татсанаас Тяньжин Бээжингийн чиглэл нь илүү ойрхон юм. Ингээд манай арми гол хүчээ Дэ вангийн нутаг Сөнөд хошуунд байрлуулж төвхнүүлсний дараа монголын өмнөд хил рүү чиглэсэн ажиллагааг эхлэхэд бэлэн болно гэсэн үг. За тэгээд одоо чинь Хайлар Ханширээгийн дардан замыг сайжруулаад байна. Одоо Хайлар Ганжуур Буйр нуурын хойд эрэг дээрх Асар сүм хүртэл төмөр замтай болбол Монголын өмнөд хилээс зүүн хойд хилийн дагуу армийн цэргийг байрлуулах бүрэн боломжтой болно. Чухам энэ үед та, санасандаа хүрэх зам мөрөө шулуутгана биз дээ.

- Аа мэдэхгүй. Би сайхан үг сонсож, баярласандаа хөрөнгөө хий үрээд байх шиг байна. Ер нь нэг үгээр хэлэхэд цөхрөнгөө барж байна гээд хэсэгхэн бодлогоширтол Симото,

- Юки сан, бид чинь гараа хумхиад байгаагүй. Одоо цахарыг авчихлаа. Өнөө маргаашгүй манай арми Хятадын цагаан хэрмэнд орчихно. Ингээд өвөр монголыг хятадаас бүрэн чөлөөлчихвөл болох нь тэр. Тиймээс ерөнхий сайд Сөнөдийн Дэ ванг Токиод дуудаж уулзахаар болоод байгаа гэж аргадан хэллээ

- Аав ч бас тэгж ярьж байна билээ

- Энэ ч яах аргагүй үнэн шүү. Зүүн умард хятадад байгаа манай бүх цэргийг саяын зохион байгуулалтаар нэгдүгээр армийн бүрэлдэхүүнд оруулсан. Тэгээд фронт командлагчаар цэргийн яамны сайд байсан нөгөө Тэраутыг томилох болсон гээд Симото ширээн дээрх хундагатай жинээ аваад «Хөөрхий энэ эмэгтэй Халх голын сав газрыг өөрийн эзэмшил болгох хүсэлдээ захирагдаад галзуурах нь холгүй байна. Тэгээд манай армийг хаашаа чиглэх бол гэхээс сэтгэл нь түгшдэг бололтой. Сэтгэл санааны хямрал, хүсэл мөрөөдлийн бүтэлгүй санаархал өөр хоорондоо зөрчилдөөд Юкийг бачимдуулжээ. Ийм үед л аятайхан тал засах хэрэгтэй! Тэгэхээр энэ сайхан завшаан, боломжийг алдаж болохгүй. Юки надад элэгтэй хандаж магадгүй байна» гэж санаархана.

Симото ойрын сар гарангийн дотор эмэгтэй хүний дулаан өвөрт гал халуун сэтгэлээ урхидуулан нойрсоогүй болохоор сэтгэлийн чанадад ёроолгүй хүслийн оч улалзаж, бие сэтгэлийг шаналгахыг ухаарлаа. Симото яриандаа халж, үг хэл нь ороолдож байгаа боловч түүнийгээ үл ойлгоно. Гагцхүү сэтгэлийн далдад цогшсон увдист дөл хамаг биеийг төөнөн, зүрхийг нь лугшуулах тул үе үе суудлаа засах зуур Юки рүү ойртоно. Тэгээд ярианы далиманд Юкигийн өвдөг, гаранд алгаа хүргэж амжина. Чингэж өөртөө аятайхан далим гаргахыг хичээсэн Симото сэтгэлдээ «Өвгөнийг ирвэл яриагаа сунжруулаад шөнө дүл өнгөрөөчихвөл эднийд хонож болно. Тэгээд Юки рүү мөлхвөл энэ ч нэг их хажиглаад байхгүй нь бололтой. Ер нь Синьзинд болсон уулзалтаас хойш надад талтай болсон. Тэр уулзалт надад их хувь заяа хайрласан юм биш биз» гэж бодоод өөрийнхөө бодол төсөөллийг шалгахын

тулд,

- За даа, эртхэн явъя. Буудалд согтуу очвол бас хэл аманд ороолдож мэднэ. Би өвгөнтэй маргааш уулзъя гэхэд Юки,

- Симото сан, та дургүйцэхгүй бол манайд хоноод явна биз дээ. Ингэсхийгээд аав ирвэл та хоёр үүр цайтал ярих байлгүй. Та хоёр уулзахаараа хэзээ тэгж амархан салж байлаа. Наад зах нь хоёр цаг болдог шүү дээ гээд жин хундагалав. Симото өөрийнхөө бодолд хүрэх зам мөр нээгдэж байгааг мэдэнгүүт,

- Ийм сайхан хүүхний хүсэлтийг хүлээж авахгүй бол эр хүний аз харьж, заяа гомдох байгаа даа гэж хэлээд Юкийн мөрнөөс нэг гараараа тэвэрч өөрийнхөө цээж рүү ойртуулаад,

- Тийм биз дээ. Юки сан гэлээ.

- Симото сан, таны үг чинь салаа утгатай хачин үг байна. Би ойлгох янзгүй. Таныг дуурайгаад хоёр хундага тогтоочихсон чинь толгой дүйрээд нэг л биш байна гэлээ.

- Ойлгож ядаад байх юу байх вэ? Шууд утгаар нь ойлгочих. Тэгээд л болох нь тэр! Мэдэв үү, хонгор минь гээд Симото зүрх гарган духаа Юкигийн хацарт хүргэх гэтэл Юки суудлаасаа гэнэт босож,

- Симото сан, та намайг ямар хүн гэж санаа вэ? Арай.. гээд дараагийнхаа үгийг хэлж амжаагүй байтал хонх жингэнэх дуу дуулдлаа.

Юки хонхны дуунаар хаалга руугаа эргэхэд Симото «За хөгшин ирлээ. Аль зэрэг бүтэмжтэй яваа бол? Өнөө шөнө Юки рүү мөлхөх ч нохойн замаар орлоо шүү. Орж ирээд штаб руу явна гэвэл тэгээд өнгөрөх нь тэр! Үүнийг мэдсэн бол өчигдөр ирж байхгүй. Юки хэдийгээр ууртай ч гэсэн улаан халз уулзвал таггалзахгүй. Хүүхнүүд анхандаа тэгж байдаг зантай шүү дээ» гэж өөртөө хэлээд баахан харамслаа.

- Симото сан, аав ирэх шиг боллоо. Та наанаа сууж бай гээд Юки өрөөнөөс гарч урт хонгил руу эргэтэл Сувдаа Юкигээс түрүүлээд хаалгаа онгойлгож өгтөл нэгэн эмэгтэй орж ирлээ.

- Ноён Тозияа саных мөн үү гэж тэр эмэгтэйг асуухад Сувдаа,

- Хай содэсу (За тиймээ) гэлээ.

- Би Токиогоос ирлээ. Миний нэрийн хуудас энэ байна. Юки сантай уулзмаар байна гэхэд тэр эмэгтэйн дуу Юкийд нэг л танил санагдав. Юки, хэсэгхэн зогсож байхдаа «Энэ чинь хэн бэ? Акасай юу даа» гэж амандаа шивнэтэл Сувдаа өнөө эмэгтэйн нэрийн хуудсыг барьсаар Юкийд авчирч өглөө. Хатуувгар гялгар цаасан дээр япон, англиар гоёмсог бичсэн нэрийн хуудсыг нүд гүйлгэн уншсан Юки амандаа «Мөн байна. Акасай» гэж шивнээд үүдний өрөө рүү орлоо.

- Акасай.... энэ чинь юу вэ? Яасан сонин айлчин бэ? Ямар салхи нааш нь аваад ирэв дээ. Лав бурхны салхи байхаа.

- Юки минь албан ажил чи бид хоёрыг санамсаргүй танилцуулсан шигээ одоо бас санамсаргүй уулзууллаа гэж Акасайг хэлтэл нөгөө өрөөнөөс гарч ирсэн Симото, согтуу нүднийхээ харцыг тогтоож ядан, үл мэдэг дайвалзан алхсаар дэргэд нь ирлээ.

- Симото сан, миний найз бүсгүй Акасай. Та танилц гэхэд Симото сэтгэлдээ "Чиү жёо гаккаа" (эрхэм дээдэс дэслэгч генерал) Уэдагийн гарын туслахуудын нэг, нууцын эрхлэгч, эрхэмсэг окусан (хатагтай)

"Акасай... ховч өлөгчинтэй энд дайралддаг ч базаахгүй хэрэг дээ... Тэгэхдээ ийм байдалтай шүү. Би ёстой үйлтэй толгой ёо! Уэда энэ лүдийг дэргэдээ авч ажиллуулахаар шийдсэн. Тэгэхээр энэ лүд Токиогоос Синьзин руу явж байгаа хэрэг! Ингээд квантуны армийнхан кэмпэтайн ховчийн харцнаас мултрахгүй болж байгаа нь энэ дээ... Зарим дарга нар үүний сургийг дуулаад «Уэдагийн эчнээний гунигийг арилгадаг, нууц амраг сэтгэлийн зул нь ирэх нь гэж байсан. Ай ямаршуухан шулам болохыг бурхан ч мэдэхээргүй ээдрээтэй юм байгаа биз. Гай түйтгэр бүхэн надаас холуур явах болтугай» гэж бодоод сэтгэлдээ сэм залбирлаа. Юки эрхэм зочноо, зочдын өрөөнд уриад хүндэтгэн зочлох зуур,

- Акасай, өнөө шөнө манайд хоноод явна биз дээ. Хоёулаа шавиагаа ханатал ярина шүү гэхэд Симото дотроо «За байз гайны энэ өлөгчинг яая даа байз. Өнөө шөнө үүнийг аргалаад явуулчих далим олдохгүй байх даа» гэж бодно.

- Юки сан, би цагийн дараа явна. Тиймээс чамтай ханатлаа донгосож чадахгүй нь. Харин буцахдаа Мугдэнд хэд хононо. Тэгэхдээ тухтай хуучилья гэхэд Симотогийн сэтгэлийн нар гарч дотроо «Аа ашгүй бурхан минь. Энэ лүдийг явахгүй бол яана гэж бодохоос зүрх уушги амаараа гарчих шахлаа шүү. Цаг хагасын дараа би, бие сэтгэлийнхээ хүслийн далайд умбана. Харин хөгшин өнөө шөнө битгий ирээсэй» гэж бодов. Акасай, Юкитэй энэ тэрхнийг хуучилж сууснаа цагаа хараад,

- За одоо би явья даа. Ердөө хагас цагийн хугацаа үлдлээ. Онгоцны буудал хүртэл хориод мөч давхина. Ингэхээр хөдлөхгүй бол оройтох нь гэхэд Симото Акасайг үдэж өгөхөөр суудлаасаа өндийв.

Акасай барьж явсан гар цүнхээ уудалж нэгэн битүүмжилсэн бичиг гаргаж ирээд,

- Шиү са (хошуучаа) армийн командлал үүнийг танд өгүүлсэн юм гээд өнөө бичгээ Симотоод өглөө. Симото харцаа Акасай руу чиглүүлэн гайхан харснаа өнөө бичгийг задлан уншив.

...Хааны гүүр ажиллагаа эхлэх болсон тул та Акасайгийн хамт Бээжингийн ойролцоо байгаа цэргийн анги дээр бэлэн байх хэрэгтэй! Уэда. 1937. VII. 4...

Симото үүнийг уншсаны дараа уусан архи нь гарчих шиг боллоо. Акасай Симотоог Мугдэнгийн цэргийн төлөөлөгчийн газар хүлээж байгаад Юкийнд ирсэн билээ.

- Симото сан одоо хөдөлье. Та бид хоёрт цөөхөн мөч үлдлээ гэхэд Симото арга буюу ёсыг дагаж,

- Мэдлээ, гүйцэтгэе гээд үүдний өрөө рүү алхав.

Хоёр. Ховдог сэтгэл хүзүү ороодог

Симото, японы армийг Бээжин рүү оруулахаар төлөвлөсөн «Хааны гүүр» ажиллагаанд оролцоходоо Тозия, Доихарагийн даалгаврыг тун авхаалжтай биелүүлсэн. Гэтэл энэ ажиллагааг Акасайгийн гавьяа зүтгэл болгож армийн удирдлагад илтгэсэн явдлаас шалтгаалж Симотогийн эгдүү хүрсэн болой. Бээжинд японы армийг оруулах ажиллагааг далдалсан далимыг «Хааны гүүр» гэсэн нь жирийн хэрэг биш. Хубилай хаан эртний хятадын нийслэл Жүндү хотыг түйвээсний дараа орчин үеийн Бээжинг үндэслэхдээ Бээжингийн ойролцоо Юньдин гол дээр нэгэн гүүр бариулсан учраас Бээжинг эзлэх ажиллагааг билэгдэж шалтаг үүсгэх будлианыг «Хааны гүүр» гэсэн ажээ. Чухам тэр гүүрнээс зүүн тийш байдаг Наньпин хэмээх суурингийн ойролцоох Бээжин Мүгдэнгийн төмөр замын дагуу байрлуулсан япон цэргийн ангийн 8 дугаар суман, хээрийн сургууль хийхээр 7 сарын 8 нд хөдөлжээ.

Харин Акасай, тэр суманд алба хааж байгаа нөхрөө эргэхээр очсон хүүхнийг орлон жүжиглэх ёстой байлаа. Тэгтэл түүний нөхөр хээрийн сургуульд гарахаас өмнө ор сураггүй алга болсон тул Акасай, генерал Кавабэгийн нэр дээр гомдол гаргах үүрэг хүлээлээ. Симото уул гомдлыг нягтлан, шалгаж барагдуулахын тул гоминдааны 37 дугаар дивизийн удирдлагатай уулзаж, гоминдааныханд хулгайлагдсан гэж үзсэн япон цэргийн талаар ярилцаж, түүнийг эргүүлж өгөхийг шаардаад, гэм буруутай хүмүүст хариуцлага хүлээлгээд мэдэгдэхийг тулган шаардав. Тэгээд өнгөрсөнгүй 24 цагийн дотор хариу өгөхгүй бол японыхон өөрийнхөө цэргийг олж авахын тулд Наньпинд нэгжлэг хийнэ гэж сүрдүүлэв. Гоминдааны тал японы цэргийнхний шаардлагад хариу өгөхөөс зайлсхийхийг эрмэлзэж, хариу мэдэгдээгүй тул Симото, 8 дугаар сумангийн дарга шиү и (ахмад) Киеимизуд тусгай даалгавар өгч, Наньпин руу довглохыг үүрэг болголоо.

Бээжингийн босгонд болсон энэ будлианы маргааш нь «Холбоотны эзэмшлийн цэргийн комисс» гэдэг нэрийдлээр Бээжинд суудаг японы цэргийн генерал Такэо Имай, гоминдааны 29 дүгээр армийн удирдлагын ширүүн шаардлагад «Японы цэргийг хулгайлсан хүмүүсийг олж хариуцлагат татахаас зайлсхийж, тэдгээр бусниулагч нарыг нууж байгаа учраас Бээжин Тяньжингийн төмөр замын дагуу байгаа японы цэргийг Бээжин рүү оруулахаас өөр замгүй» гэж далайлгалаа.

Бээжинг хамгаалж байсан 29 дүгээр армийн 37 дугаар дивиз, японы шаардлагыг хүлээж аваагүй тэр үед ерөнхий сайд Коноэ, умард хятадад байгаа квантуны армийн хоёр бригад, Солонгост байгаа нэг дивизээс гадна, танкийн бригад, нисэх ангиудыг хөдөлгөхийг 7 сарын 10-ны орой зөвшөөрчээ. Ингээд ерөнхий сайд Коноэ, маргааш нь цэргийн яамны сайд Сугияаматай хамт Токиод суугаа гадаадын хэвлэлийн ажилтангуудыг хүлээн авч, японоос хятадад дайн зарласныг мэдэгдээд, таван яамны зөвлөгөөнөөр армийн хэрэгцээнд 5, 5 тэр бум иень нэмэн олгох болсноо битүү мэдэгдэв,

Тозия, Доихара хоёрын боловсруулсан «Хааны гүүр» гэдэг өдөөн хатгах ажиллагааны улмаас үүссэн мөргөлдөөн хорь хоног

үргэлжилсний дараа Бээжингийн хувь заяа шийдэгдэж японы цэргийн мэдэлд орлоо. Энэ явдлыг тохиолдуулж дээд командлал Акасайг хааны шагналд тодорхойлсноор Симото

сэтгэлдээ өш өвөрлөснийг хэн ч мэдсэнгүй. Тэрээр хэд хоног эмнэлэгт хэвтэхдээ «Цусаа асгаруулсан хүн ад болж, зусарч ховч эмийн аз болж» гэж боддог боллоо.

Бээжинг эзэлснээс хойш найман сарын дараа нэгэн өдөр Тозио гурван бригадаа удирдаж Долнуураас өмнө зүг Жанчхүүгийн хэсэг рүү довтолж, удаж төдөлгүй Хаалган хотыг эзлэв. Чухам энэ үед Наньпин суурингийн дэргэд болсон тулалдаанд шархадсан Симото, эмнэлгээс гараад ажлаа хийж байлаа. Тозио, Хаалганаас буцаж ирсний дараа Симотоог дуудаж уулзахдаа царай муутай байлаа.

- Шиү са (хошуучаа) танай Ёоши хаачсан бэ? гэж асуухад Симото,

- Эрхэм дээдсээ, Ёоши сан Харбин явсан. Тэндээсээ Хайлар ороод Баргын сүмээр дамжин Буйр нуурын баруугаар Булан дэрс, Ганц модтын овоогоор хил нэвгэрч, газрын зургийн баримт цуглуулах ёстой гэж илтгэв.

- Энэ талаар Тозия мэдсэн үү?

- Гаккаа өөрөө энэ ажлыг удирдаж байгаа.

- Би танай тэр Ёошигийн ажиллагаанд нэг л итгэхгүй байна. Монголын нутгийн байр зүйн зурагт шаардагдах баримт цуглуулж байна гэхээс цаашгүй байна. За энэ ч яахав сүүлдээ үр дүн гарах юм байгаа биз. Харин жанжин штабаас нэг сонин баримт ирсэн. Хатогийн туслахуудын нэг Хасу Тоиши, өнгөрдөг хавар алс дорнод руу чиглэсэн Оцу ажиллагааны нэг бүлэг ажиллагааг унагасан хүний нэг байж магадгүй сэжиг гарч байна. Ер нь Разаевскийн «Фашист холбооны» хүмүүсийг битүү шалгах хэрэгтэй болоод байна. Хасу Тоиши ахтайгаа холбоо барьсан сэжим цухуйсан. Жанжин штабаас ирсэн баримтаар бол түүний ах Хасбаатар гэгч, умард солонгосын хойгуур уулархаг газар бүгсэн мухар толгойтнуудтай (хувьсгалч нарыг засаг захиргаагүй хүмүүс гэдэг утгаар ингэж хочилдог аж) нийлсэн сурагтай. Тэд Тумыны төмөр замын асуудлыг хэрэгжүүлэхэд саад хийж магадгүй байна. Умард солонгос, улаан оросын хилийг бараадсан тэдгээр мухар

толгойтнуудыг устгах хэрэгтэй болоод байна. Тиймээс энэ хавгаст хэргийг уншиж танилцаарай. Ямар ажиллагаа боловсруулахаа өөрөө төлөвлөөд надад танилцуул! гээд Тозио ширээнээсээ нэгэн хавгастай хэрэг гаргаж өглөө.

Симото, Токиогоос авчруулсан тэр хэргийг хэд хоног уншиж, хэд хоног толгой өндийлгөх завгүй ажиллав. Симото, Хасу Тоишигийн хэрэгтэй танилцаад түүний ахуй амьдрал, гарал угсаа, ажил төрөл бүхнийг нэгд нэгэнгүй хянасан кэмпэйтэйн судалгаатай тулгаж үзлээ. Чингээд ах дүүсийн холбоог илрүүлэх сөрөг ажиллагаа сэдээд «Ах дүү» гэж төлөвлөв. Симотогийн төлөвлөгөөгөөр бол Хасу Тоиши, түүний хань хамсаатан болон манжуурын мухар толгойтнуудыг урхидах ёстой байлаа. Нөгөө талаар Аяанаосуг энэ ажиллагаанд оролцуулах талаар Симото олигтойхон санаа сэдэж чадвал "нэг сумаар хоёр туулай буудаж болох болой"

Тозио, Симотогийн төлөвлөсөн ажиллагаатай танилцаад Тозия, Доихара хоёрын аль алинд дуулгахгүйгээр шийдэж, армийн тагнуулын газарт мэдэгдэж, жанжин штабаас удирдамж

авлаа. Тэгээд зогссонгүй Симотогийн саналыг дэмжиж, Амисээг нөхрийн хамтаар Манжуурт ирүүлэх талаар санаачилга гаргахыг хүсчээ. Чингээд Симото, Тозиогийн зөвшөөрлөөр Харбинд очоод «Ах дүү» гэдэг ажиллагааг эхлэв.

Аяанаосу, Синьзингаас ирсэн Симотогийн сургийг дуулаад түүнтэй уулзахыг яарсангүй. Харин ямар хэргээр ирснийг нь мэдэхийг хичээж аяыг нь харна. Гэтэл нэг өдөр Симото тэднийд айлчлан иржээ.

- Аяанаосу сан, танаас гуйх яльгүй зүйл байна. Таныг дуртай туслах байх гэж найдаж байна. Та ойлгож байгаа биз гээд Симото хуурамчаар инээмсэглэв. Тэрээр сэжиглэсэн хүнээ сонжихдоо ингэж инээмсэглээд аждаг заншилтай агаад өөрийнхөө зан араншингийн энэ доголдлыг мэддэггүй болой.

- Хөх хот руу явуулах юм бол би дуртай зөвшөөрнө шүү гээд Аяанаосу сакэ хундагалав.

- Чи чинь өнөө хамаатан хүүхнээ сураглах гээ юү?

- Тиймээ. Симото сан, тэр чинь миний хамаатан хүүхэн биш. Өндгөн сүй тавьсан хүүхэн шүү. Чи чинь намайг асман юм гэж

бодоогүй биз! Одоохондоо заазлагдаагүй шүү. Гэхдээ хөгширч яваа болохоор хань ижилтэй болмоор бодогдоод байна. Алийн болгон хоног өнгөрөөсөн хүүхнүүдийн хормой сахих вэ? Тэгээд удам угсаагаа бодож, өндгөн сүй тавьсан хүүхнээ олж харъя. Боломж байвал нааш нь авчраад суусан ч болно шүү дээ. Нүглээ эртхэн цагаатгахгүй бол тамд очоод тарчилж магадгүй байх гэхээс айж байна.

- Аяанаосу сан, энэ удаа тийм томилолт гардуулах гээгүй юм. Харин хожим бол таны ажилд үг дуугүй тусална. Манай ажиллагаанд нэг сонин юм ургаад байна. Энэ талаар манай удирдлага надад найдлага тавьсан билээ. Харин би бол танд найдаж байна. Ноднин жил манай арми улаан оросын хил дээр багагүй хохирол үзсэн. Яагаав дээ Хабаровск, Ханх нуурын орчимд яггүй сүйрсэн. Үүний гогцоог та, олж мэдэх юм гэж бодож байна гээд Симото, Аяанаосу руу сүрхий харлаа. Энэ бол сэжигтэй хүмүүстэй шууд холбоотой баримтыг нь тулган байцааж сурсан Симотогийн онцлог зан чанар болой. Симото, Аяанаосугийн байр төрх, царайны хувьсал, үг ярианы самгардалт, уруулын хөдөлгөөнийг төдийгүй нүдний харцыг ширтэв.

- Симото сан, та кэмпэйтийгаас миний хувийн хэргийг авчруулаа юу? гэж тоомсоргүй асуугаад «Ноднин жил Зөвлөлтийн хил рүү чиглэсэн өдөөн хатгалгын талаар төлөвлөсөн төлөвлөгөөг Дохагагийн буухиа элчээр явуулсан. Тэр эдний гарт орох ёсгүй. Харин тэр нууцыг илрүүлсэн хүний нэгэнд намайг сэрдэж байгаа хэрэг үү? Тэгээд нууц задруулсан хүнийг надаар илрүүлэх ажиллагаа сэдэхдээ давхар мэх олж дээ. Ингэхээр одоо халз тоглох хувилбар олох хэрэгтэй» гэж бодлоо.

- Тиймээ. Хар луу нийгэмлэгийн хэд хэдэн ажиллагаанд идэвхтэй оролцоод өгсөн даалгаврыг нь ахархан хугацаанд биелүүлэхдээ онцгой идэвх гаргадгийг чинь кэмпэйтийн мэр-гэжилтэнгүүд тогтоосон байна. Тэгэхдээ, тэр ажиллагаа бүхэн тантай холбоотой байсан

гэдгийг би ойлгож байна. Харин таныг эзэн хааны шагналд тодорхойлсон явдал талаар өнгөрсөн хэрэг бол янхан хүүхнүүдтэй толгой холбосноос болжээ. Таныг янхан хүүхнүүдээс, салахгүй бас архинд толгойгоо мэдүүлсэн явдалд дургүйцсэн дарга нар саад тотгор хийсэн байдаг. Одоо бол таныг хэн ч гоочлохгүй байх.

- Симото сан, даалгавар биелүүлэх явдал надтай шууд холбоотой байгаагүй. Харин кэмпэйтэй сэжиг бүхий баримтаа нуулгүй өгдөг учраас би, сэжүүрийг нь амархан олдог байсан. Харин олдоогүй шагналын хувьд гэвэл таны амнаас одоо сонслоо. Нуугаад яах вэ? Тэр үед би шагнал горьддог байсан. Тэгээд өөрийнхөө горьдлогонд хүрч чадахгүй болохоор гомдсон сэтгэлээ гашуун ус, янхан хүүхнээр баярлуулдаг байсан юм. Одоо нас ахичихсан болохоор залуу үеийн сүр сүлд буугаад аз харьчихсан байх. Нөгөө талаар би мэргэжлийн тагнуулч биш. Гэхдээ хэр хэмжээнээс хэтрээгүй юм бол азаа үзээд алдъя. Гэхдээ эзэн хааны шагналд тодорхойлох хэрэггүй шүү. Надад ацаг хөлс нь дээр. Би одоохондоо алдагдалтай байгааг та бүхэн мэднэ.

- Аяанаосу сан, чи бид хоёр тохиролцвол ацаг хөлсөн дээр гар татахгүй. Гүйцэтгэх ажлын хувьд гэвэл ердөө ажиглалт. Ажиглалтаа баяжуулж баримт гаргах нь чухал.

- Симото сан, ажиглалт чинь бодитой зүйлд тулгуурласан юм уу, эсвэл төсөөлөл төдий сэжиг үү?

- Юу гэх вэ? Аль алиныг нь хосолсон. Ердөө нэг хүний тухай гэх үү дээ. Чи танина. Тэгэх тусмаа чиний дотны хүн гэхэд Аяанаосу,

- Хэн бэ? Миний намтар түүхийг мэддэг дотно танил гэвэл танаас өөр хүн байхгүй гэж егөхдөө «Миний Танил гэнээ. Хасу Тоишийг сэжиглэж байгаа хэрэг үү! Тэр залуу Амисэ бид хоёрын холбоог мэддэг гэдгийг эд нар шиншлээд «Чиний дотны танил» гэж онцолж байгаа хэрэг!» хэмээн бодоод Симотогийн үгийг хүлээв.

- Генерал Хатогийн туслахуудын нэг Хасу Тоиши гэж хэлэхэд Аяанаосу нүдээ том болгон Симотогийн царай өөд ширтэв.

- Аяанаосу сан, гайхах хэрэггүй. Түүний ах Хасбаатар гэдэг хүнийг бид анхааралдаа аваад байгаа! Тэр хүн манжуурын мухар толгойтнуудтай нийлж, тэднийг өөгшүүлээд байгааг Хато сан мэдээд дүүгээр нь ахыг нь урхидах санаатай. Гэтэл Хатогийн нууц мухар толгойтнуудад дамждаг учраас тэдний зарим ажиллагаа унасан байж болох талтай. Тиймээс та, Яньзи, Нинань, Аньху хотоор орж салбар нээнэ гэж хэлээд дэнчин тавьж болно.

Би дэнчингийн хөрөнгийг гаргана. Тэгж байтал тар нь танигдах байлгүй. Тиймээс одоогийнхоо холбоог гүнзгийрүүлж дотно үерхэх нь чухал.

Аяанаосу, армийн тагнуулын газрын ажилтны үгийг бодит байдалтай тулгаж, хэдэнтээ эргэцүүлээд «Яагаад умард солонгос, Зөвлөлтийн хил Хасан нуурын чиглэл дагуух хотыг сонирхдог билээ. Тэнд партизанууд бий. Тиймээс партизануудыг тэндээс зайлуулах гэсэн ажиллагаа юу? Эсвэл үнэхээр Хасу Тоишийг ахтайгаа холбоотой эсэхийг шалгах гэсэн хэрэг үү? Хасан нуур... Энэ чинь Владивостокоос холгүй байдаг... Тэгэхээр Солонгост байгаа японы армид саад болж байгаа партизан нарыг Хасу Тоишигийн тусламжтайгаар устгуулах гэсэн

арга уу. Үгүй юү гэдгийг мэдэх нь чухал. Тэгвэл эд нар Хасу Тоишийг ахтайгаа холбоотой эсэхийг мэдэх гэж намайг ашиглаж байгаа нь гарцаагүй. Ингэхээр Хасу Тоишийг Хатогийн өрөөний нууцыг гадагш нь дамжуулдаг тагнуул гэдэг гохонд оруулж таарна» гэж бодож суух хооронд болор хундагатай архины өнгийг сонирхсон дүр гаргана.

- Симото сан, Хасу Тоиши чинь Амисэтэй холбоотой. Ямар холбоотойг нь би мэдэж чадаагүй. Эцсийн эцэст Амисэ бидний ажиллагааг мэдээд Хасу Тоишийг аврахаар шийдвэл бидний ажиллагааны эсрэг, бид хоёрыг нугаслах шинэ арга замыг кэмпэйтэй боловсруулах нь зайлшгүй. Амисэ надад сайн байсан. Харин одоо Хасу Тоишид илүү сайн болсон нь илэрхий байна. Тэгэхээр нөхөр нь эхнэрээ хамгаалахын тулд эзэн хаан, ерөнхий сайд хоёрт алтан хошуу хүргэвэл та бид нүд ирмэхийн зуур үнсэн товрог болох нь тэр! Ингэхээр амь дүйсэн хэрэгт оролцох дургүй байна.

- Аяанаосу сан, энэ ч аюултай тоглоом л доо. За яахав, ажлын хүнд хүчрийг бодоод ацаг хөлс нэмье гэж Симото хэлэхдээ «Энэ золиг мөнгөний ханшийг нарийн тооцдог болжээ. Ацаг хөлс нэмэх аргаа олчихсон байна шүү» гэж бодлоо.

- Симото сан, ацаг хөлсийг та нэмээд байж чадна. Эцэстээ та өөрөө сугараад гарчихаж чадна. Тэгэхээр өнөө муу нэртэй, хойд захын хар овоохой болсон би чинь яах вэ?

- Аяанаосу сан, бидэнд нэг далим бий. Та Хасу Тоишитэй

уулзаж ярилцаад ирэхээр чинь ахтайгаа холбоотой болох нь илэрхий бол хоёулаа ярилцаж байж шийдье. Харин холбоогүй бол надад олигтойхон тодорхойлолт гаргаад өгчих! Би түүнийг шалгаад нотлогдвол хэнд ч мэдэгдэлгүйгээр энэ хэргийг хаагаад нууц архивт хийчихье.

- Энэ ч болдог арга. Тэгэхээр найр цэнгээний илүү дутууг яах вэ?

- Аяанаосу сан, эхний ээлжинд танд зургаан мянган иень өгье гэхэд Аяанаосу Симотогийн болзлыг хүлээн зөвшөөрлөө.

Аяанаосу зуны хувцасны загвар үзүүлэх уулзалт зохион байгуулах тухайгаа сонинуудад зарлуулав. Тэгээд шинэ хувцасны маяг үзүүлэх тэр өдөр Аяанаосугийн умгар танхим хүнээр дүүрч, Харбины сониныхон шавлаа. Энэ загвар үзүүлэлтэнд Хасу Тоиши ирлээ. Тэгээд тэр орой Аяанаосу багашигхан хүлээн авалт хийхдээ Хасу Тоишийг урьжээ. Хүлээн авалт тарсны дараа Аяанаосу Хасу Тоишитай уулзаад,

- Чи яараагүй бол жаахан дэмийрэхгүй юү гэхэд Хасу Тоиши татгалзсангүй. Чингээд тэр хоёр хорвоо ертөнцийн сонинь дэлгэн, оройг хамт өнгөрөөлөө.

- Хасу Тоиши өнөөдрийн хувцасны загвар үзүүлэх уулзалт ямар санагдав даа. Би ер нь амжилт олох болов уу гэж асуутал,

- Зүгээр боллоо. Чиний аз шовойж байгаа бололтой. Харбины хүүхнүүд энэ зун танайхаас салахгүй байх. Ялангуяа оросын цагаач хатагтай нарын сэтгэлийг европ хувцасны загвар

гигигдсэн бололтой гэж хуурай магтав.

- Би тэгэх ч байх гэж бодсон юм. Энэ чинь Мугдэн, Аньдун, Яньзи хотуудад салбар ажиллуулах ирээдүй нээгдэж байгаа хэрэг гэж хэлээд хундагатай цагаан архиа өргөөд, чи өнөө шөнө манайд хонохгүй юу? Чамтай яримаар юм байна гэхэд Хасу Тоиши дуртай зөвшөөрлөө. Тэгээд Аяанаосугийн царай өөд хайнга хараад сэтгэлдээ «Мань хүн, хүлээн авалтанд ирсэн хүүхнүүдээс үлдээж чадсан болов уу» гэж бодсоныг Аяанаосу хэрхэн мэдэх билээ. Аяанаосу Симотогийн ятгалгаар Хасу Тоишитэй чингэж шөнийг өнгөрөөхдөө өөрийнхөө ирээдүйн тухай яриа дэлгэж, хэдэн газар захиалгын салбар нээх гэсэн бодлоо цухуйлгаж зөвлөгөө өгөхийг гуйлаа.

- Зүүн өмнөд манжуур, умард солонгосын мухар толгойтнуудад тонуулчихгүй бол Дунин, Тумын хотод хувцас захиалгын салбар нээнэ гэдэг чинь зөв хэрэг шүү.

- Хасу Тоиши, тэр мухар толгойтнууд чинь Харбинд мундахгүй байгаа. Харин японы цэргийн хээрийн цагдаагийн газрын авралаар овоо өршөөлтэй байна. Тэднийх чинь бүтэн хагас дивиз гэдэг биз.

- Аяанаосу сан, Тозио албан тушаалд дэвшсэний адилаар түүний удирдаж байсан цагдаагийн газар одоо гурван дивиз цэрэгтэй болсон атлаа бас өргөжих сурагтай байгаа.

- Тэр чинь сайн хэрэг. Харин Симотогийн хардалт л мухар толгойтноос илүү ярвигтай байж магадгүй шүү

- Симото чинь нүдэндээ өртсөн хүн байтугай, зүүдэндээ орсон хулганыг сэрдэн мөрдөж мэдэх хүн. Нэг ёсны мэргэжлийн өвчтэй болчихсон юм. За тэгээд алт мөнгө, алдар нэрнээс армийн тагнуулын газрыг худалдаж чадах сүүхээтэй эр дээ гэж Хасу Тоишийг хэлэхэд Аяанаосу,

- Хасу Тоиши минь өвөр монголын өөртөө засан тогтнох эрхийн талаар юу гэж бодож байна даа гээд цагаан архи хундагалав.

- Японы арми, өвөр монголд автономит эрх олгоно гэдэг юу бол доо. Харин Дэ вангийн хөөрүү занг далимдуулж, өвөр монголыг бүхлээр нь японы эзэн хааны эзэмшил болгох гэсэн алсын санаа байж магадгүй. Тэгэхээр Дэмчигдонровыг (Дэ Ван) засгийн газрын нарийн бичгийн дарга болгосон нь зүгээр хэрэг биш байсан шүү дээ. Аягүй бол хойтон жил гэхэд Дэ вангийн засгийн газар байгуулахаар болно. Чи бид хоёр элэг нэгтэй монгол хүмүүс тэр тусмаа эзэн Чингэсийн удмынхан. Тэгэхээр өвөр монголыг японы эзэн хааны өлмийд сөхрүүлэхийг бодож байгаа ихэс дээдсийн бодлогыг сохроор дагаад хэрэг байна уу даа.

- Би ч улс төрийн талаар мэдлэгтэй биш. Надад бол ялгаа алга! Харин хувцас захиалгын маань газар орлоготой болбол болох нь тэр гэж хэлтэл Хасу Тоиши согтуу нүдээр ууртай ширтсэнээ,

- Чамд мөнгө байвал удам угсаа хамаагүй л дээ. Сүнсээ алдсан амьтан гэж амандаа шивнэсэн боловч Аяанаосуд тод сонсогдлоо.

- Түүн дээрээ хүрвэл... Би чинь хүнийхээ мөсийг хөлдөөчихсөн

эр биш! Ер нь чи надаас үнэхээр асууж байна уу? Эсвэл сонжиж байгаа хэрэг үү?

- Би үнэнээсээ асууж байна. Би чамтай тоглоогүй шүү.

- Хасу Тоиши минь тэгвэл миний үгийг сонс! Би самурай нарын гарын үзүүрийг харж, гол зогоож явсан боловч надад гялайсан юм байхгүй. Тэгэхээр өвөр монголд эрх чөлөө олгож хятадаас тусгаарлана гэдэг чинь наран эздийн үнэн царайг халхалсан хуурамч баг! Өөрөөр хэлбэл монгол манж угсаатныг гартаа атгаад над шиг өөрийн мэдэлгүй болгоно. Иймээс эрхгүй зарц болгох гэсэн санаагаа нуухын тулд хоосон амлалт гаргаж байгаа юм! Чи бодоод үз. Чи өөрөө японы армид алба хаагаад юу хожив доо! Өөрийгөө хардаж сэрдүүлэхийн тулд уу? гэтэл нөгөө өрөөнд хөлийн чимээ гарах нь тод сонсогдов.

- Хасу Тоиши минь чимээгүй. Манай зарц орж ирэх бололтой. Бодвол өнөө орой хөлсөөр ажиллуулсан тогооч нарын үнэ хөлсийг нэхэх гэж байгаа биз гээд суудлаас өндийхөд Хасу Тоиши, ширээн дээрх сакэтэй хундага руу гараа явуулав.

Хасу Тоиши, сүүлийн хэд хоног нэлээн зүйлийг эргэцүүллээ. Хато, өөрийнхөө штабаас алдагдсан нууцын эзнийг олохын тулд сүүдрээ хүртэл хардах болжээ. Тэгээд зогссонгүй Хасу Тоишийг зарим хуралд суухыг хориглов. Хасу Тоиши намрын эхэн сарын хуучдаарх нэгэн өдөр ажлаасаа тараад гэр рүүгээ сажилж явах зуураа дүрвэгсдийн товчооны хурандаа Сафроновтой дайралдлаа.

- Хасу Тоиши сан та, харьж явна уу гэхэд,

- Тэгье. Та харих гэж явна уу? гэлээ.

- Тиймээ. Харин та завгай бол манайхаар орохгүй юу гэхэд Хасу Тоиши хурандаагийн урилгыг дуртай зөвшөөрлөө. Баатар гүн, орос хэлэнд чамбайхан хүн байсан болохоор хоёр хүүгээ ойр зуурын ярианы хэлтэй болгожээ. Тиймээс Хасу Тоиши оросоор ярихдаа төдий түгдэрдэггүй боловч хамаа намбагүй ярих тул ойлгоход бэрхтэй.

Иван Степанович, Цэен гүнгийн тусламжаар Оросын дүрвэгсдийн товчоонд ажиллах болсноос хойш ахуй амьдрал, алдар нэр өөдрөг боллоо. Энэ бүхнийг ганцхан өдөр шийдсэн. Нэг удаа Разаевский Иван Степановичийг өрөөндөө дууджээ. Иван

Степанович түүний өрөөнд ороход нэгэн хошууч байсныг ажвал Сухаревын туслах байж билээ. Ингээд Иван Степанович битүү хардалтаас мултарч, урвагчийг устгасан нэр төртэй ажиллагааг зохих ёсоор үнэлээд хуучин цол хэргэмээс дээгүүр дэд хурандаа цол хайрлаж билээ. Цэен гүн, Иван Степановичийг илэрхий дэмжиж түүнийг нь Тозия турхирсан болохоор түүнийг атаман Семеновын штабт нэгэн хэсэг ажиллуулж Дайран, Порт-Артур, Токио хот зэрэг томоохон газраар хөллөх болжээ. Харин Харбинд оросын фашист холбоо байгуулсны дараа түүний тусгай курсын ахлах мэргэжилтэнгээр ажиллуулах болсон. Чингээд алс дорнод, монголын асуудлаар судалгаа хийх удирдах бүлэглэлд багтаж хурандаа цол дэвшив.

Иван Степанович гүнг нас барснаас хойш Юкитэй тухтай уулзаж чадаагүй. Итагакийг үдэж өгөх тэр үеэр Юкитэй уулзаж нарийн ширийн зүйлээ ярилцах гэтэл Семенов түүнийг дуудсан болохоор яаж ч чадалгүй Дайран явж билээ. Түүнээс хойш Иван Степанович Юкитэй уулзаж гавьсангүй өдий хүрсэн.

Сафронов хоёр өрөө сууцтай. Харбинд суурьшсан нутгийн оросуудын гэр бүлийн хүмүүсээс гэртээ хөлсөөр ажиллуулна. Хасу Тоиши, тэр хоёрыг гаднаас орж ирэхэд нэгэн залуу бүсгүй угтан авч хурандаагийн хувцсыг тайлуулж янзлав. Тэгээд хурандаа зочдын өрөөнд Хасу Тоишийг дагуулж ортол орос янзаар зассан оройн хоолны ширээ угтлаа.

- Хасу Тоиши сан, ширээнд ойртож суугаач. Би ажлаасаа ирэнгүүт оройнхоо хоолыг иддэг юм гээд ширээнд урилаа. Сафронов өндөр шилтэй орос цагаан архианаас хундагалаад,

- За хоолны өмнө нэг хундага тогтоочих. Тэгвэл идсэн хоол амттай, шингэц сайтай байдаг юм гээд өөрөө том аягаар дүүрэн хийсэн архиа нэгмөсөн хөнтөрчихөөд, давсалж дарсан өргөст хэмхнээс авч хамартаа ойртуулан үнэрлээд,

- Хасчулуун минь, би таныг жинхэнэ нэрээр чинь дуудахад дургүйцэхгүй биз. Би япончуудын сан (хүндэтгэсэн үг) иша (ноён) гэдэг үгийг нэрийн дараа заавал хэлдэг ёсонд дургүй. Энэ чинь дэндүү нялганасан зан чанарын илрэл шүү дээ гэлээ. Хурандаа Хасчулуунтай ойр зуурын юм ярьж сууснаа ярианыхаа сэдвийг зугуухан өөрчилж,

- Би чамаас ажил төрлийн чанартай хэдэн юм асуумаар байна. Чамд эвгүй санагдаж магадгүй. Тэгвэл уурласны хэрэггүй. Үүнийг би, чамд сануулж гуйх ёстой юм. Миний асуусан зүйлийг цөмийг нь хэлж өгвөл тун сайн. Энэ бол танилцсаны хувьд гуйж байгаа миний хүсэлт. Та эцгийгээ яаж өөдөлснийг мэдэх үү? гэж асуулаа.

- Намайг арван дөрвөн настай байхад өвчнөөр өөдөлсөн юм. Юу гэж хэмээн Хасчулууныг асуухад хурандаа «Тэгвэл 1925 онд нас барсан байна» гэж дотроо бодоод,

- Чи эцгээ өвчнөөр өөдөлсөн гэдэгт итгэдэг үү? гэлээ.

- Тиймээ. Итгэхээс өөр яах вэ?

- Манайд нэг туршуул байдаг юм. Тэр лүд Ханх нуурын ажиллагааг нэг том хүнээс дуулаад танай ах Хасбаатарт дамжуулсан байна. Энэ ч яахав. Харин тэр золиг Тозияагийн заавраар эцгийг чинь хорлосон гэж яриад байна.

- Тэр чинь юу гэсэн үг вэ?

- Хасчулуун минь ийм хүнийг хоёр туулай хөөсөн анчин гэдэг. Гэтэл.. манай тэр сайн эр, гурван туулай хөөснөөрөө бусдаасаа ялгаатай байгаа юм. Энэ ч бага хэрэг! Бас нэг сонин зангилаа гарч байна. Таны эгч гэдэг нэг эмэгтэйн сураг гараад байна. Манай туршуул тэр эмэгтэйн сургийг гаргаж чадах хүн! Гэвч энэ бол бидний сонирхох зүйл биш.

Би хэрэгтэй зүйлээ тэр лүдээр хэлүүлээд авсан. Тиймээс тэр туршуулыг чиний мэдэлд өгвөл

ямар вэ? Би түүний мэдүүлгийг удирдлагад танилцуулаагүй. Хэрэггүй биз гэж бодож байна. Та түүнийг надаас шилжүүлж аваад яахаа өөрөө шийднэ биз. Хэрвээ үүнийг зөвшөөрвөл нөгөөдөр тэр туршуулыг би өрөөндөө аваад ирье. Чи өөрөө яриад үз. Тэгээд шийднэ биз гэлээ.

Хасчулуун тэр орой Сафроновынхаас гараад холын хамаатан гэгддэг өнөө хөгшнийд очлоо. Өвгөн Хасчулууны яриаг сонсоод,

- Чамд нэг эгч бий. Түүний учрыг эх чинь сайн мэдэх ёстой. Эцгийг чинь нас барахын өмнө төрсөн дүү нь ирсэн. Чухам хаанаас ирснийг нь тэр үед сонирхоогүй юм. Бодвол ар монголоос ирсэн байх. Эцэг чинь халх хүн шүү дээ. Тэр хүнийг нэг царайлаг бүсгүй дагаж ирсэн юм. Тэр хүүхэн эхийг чинь хориод хоног сувилж байгаад ясыг нь барьсан юмдаг. Харин хожим эцгийн

чинь нэг сайн танил Самбуу гэдэг хүн надтай уулзаад ярихдаа тэр эмэгтэйг Хасбаатар та хоёрын эгч гэж билээ. Би тэр үед тэр тухай нэг их сонирхоогүй өнгөрсөн юм. Харин жилийн өмнө Хасбаатар түүнийг олохоор Мугдэн руу явахдаа манайд хэд хоноод явсан. Тэгэхдээ «Эгчийнхээ сургийг гаргана» гэж байсан. Харин чамд дуулгаагүй хэрэг үү. Ер нь Хасбаатар сайн мэдэх байх гэж ярив.

Хасу Тоиши хэмээгдэх Хасчулуун энэ бүхнийг өвгөнөөс сонсоод Сафроновтой тохирсон ёсоор ажил тарахаас өмнө түүний албан өрөөнд очиж «Хэрээ» хочтой нэгэн оростой уулзав. Намхан биетэй, шаргалдуу царайтай орос Хасу Тоишигийн бараанаар суудлаасаа босохдоо үл мэдэг ухарч зайлсхийхийг ажваас түүнээс сүрдсэн бололтой.

- Хасу Тоиши сан та суугаач гэж хэлээд Сафронов ширээн дээрээс нэгэн бичиг авч үзсэнээ,

- Чи Ханх нуурын ажиллагааг хэрхэн мэдсэн юм бэ? гэж асуулаа.

- Би тэр өдөр «Хөгшинтэй» уулзах ёстой байсан. Өөрөөр хэлбэл Хато сантай шүү дээ. Би Разаевскийн өгсөн даалгавар ёсоор генералтай уулзахаар өрөөнд нь очтол түүний туслах байхгүй байлаа. Харин генералын үүд онгорхой байсан болохоор Хасу Тоиши сантай ярьж байсан яриа надад тод сонсогдож байв. Би туслахын өрөөнд оронгуут генералд харагдахгүйн тулд ханын нэг талд зогсоод тэдний яриаг сонслоо. Тэгэхдээ генерал Оцу төлөвлөгөөний дагуу оросын хил рүү газрын зургийн мэргэжилтэн явуулах тухай ярьж байсан. Ингээд Хасу Тоишийг генералын өрөөнөөс гарч ирэхийн өмнө би, генералын туслахын өрөөнөөс гарч, бие засах газар руу очсон. Намайг буцаж ирэхэд генералын туслах ирчихсэн байлаа. Ингээд би, генералд Разаевскийн бичгийг өгсөн. Гэтэл генерал надад «Чи хэдэн хүнийг авч яваад Хабаровск, Ханх нуурын чиглэлээр хил давуулах хэрэгтэй» гэж үүрэг өгөөд буцаахдаа «Разаевский удирдамж өгнө» гэж билээ. Ингээд нөгөөдөр нь аяны замд гарсан. Би болзсон газартаа очтол японы цэргийн хэдэн дарга нар надтай уулзаж миний дагуулж явах хүмүүстэй танилцуулсан. Ингээд тэднийг оросын хил давуулж өгөөд буцаж ирэхдээ Ханхын тухай баримтуудыг Хасбаатарт өгсөн юм. Түүндээ орос дарга нарын хувцсаар хувцасласан хүмүүсийн гадаад байдал, тэдний уулзах газар, нууц нэр, сорилт үгийг хүртэл дурдсан гэлээ. Тэгээд хэсэг дуугүй сууснаа гүнээ санаа алдаад,

- Хасбаатар надтай хоёр удаа уулзсан юмдаг. Анхныхаа уулзалтаар эгчийнхээ сургийг гаргаж өгөхийг гуйсан.

Хасбаатартай уулздаг болсон тухайгаа би тэр үед Тозияад хэлээгүй. Тэгээд би, ахын чинь зааж өгсөн хаягаар Мугдэнд очихдоо Тозияатай гудамжинд халз тулгарлаа. Гэсэн ч би, Тозияагийн мөрдөлтөөс зайлж чадсан. Ер нь Тозияа тун аюултай хүн. Ёстой аймаар гээд үл мэдэг ээрлээ.

...Би Тозияагийн туршуулаар ажиллаж байсан тэр үед нэг өдөр намайг дуудаад баахан эм өгч танайх руу явуулсан. Би тэр үед тэр эмийг хортой гэж яаж мэдэх вэ? Эцгийг чинь нас барсны дараа эцгийн чинь дүү гэдэг хүн гомдол гаргаж «Хортой эм өгсөн байна» гэдэг сэжиг олжээ. Гэтэл Тозияа намайг ялд унагаад өөрийгөө аврахдаа өгч явуулсан эмийг сольсон байна гэдэг нотолгоо гаргаж намайг гүтгэлээ. Ингээд би мөрдөнд орсон юм. Гэтэл аз болж миний нэг танил цагдаа хэдэн хүмүүстэй хуйвалдан намайг орлуулав.

Би Харбинд ирээд Разаевскийн хүмүүстэй танилцсан. Нэг удаа Зөвлөлтийн нутагт оруулах тагнуулуудыг газарчилж хил давуулаад буцахдаа мухар толгойтнуудад баригдсан. Гэтэл аз болж Хасбаатартай дайралдаж энэ бүхнийг ярьсан.

Ингээд би, хээрийн цагдаагийн ажиллагааг мэдээд Хасбаатарын хүмүүст дамжуулдаг болсон. Ер нь гурван талд ажиллах нь тун ашигтай. Ялангуяа мухар толгойтнуудад баригдвал амиа алдана гэж айхгүй санаа амар байсан...

Сафронов, «хэрээ» хочит туршуулаа явуулсны дараа хэсэг дуугүй сууснаа, Хасу Тоишигийн дэргэд ирж суугаад,

- Би үүнийг чамд шилжүүлэе. Нөгөө талаар амьд явах хоногийн тоо гүйцсэн гэдгийг ойлгох хэрэгтэй. Бас Хато, Тозияа хоёрын нэрийг бодох хэрэгтэй. Тиймээс чи миний саналыг зөвшөөрөх байх гэж бодож байна гэлээ.

- Хурандаа та, мөрдөн байцаалтын баримтыг яая гэж бодож байна?

- Хасу Тоиши мэдүүлгийг танд шилжүүлнэ. Ер нь энэ бүхнийг

та бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй. Тэгэхээр хаана ямар ч баримт үлдэхгүй. Нөгөө талаар таны эгч хаана байгааг энэ хүн мэдэж байгаа. Тиймээс та эгч, ах хоёроо олох нь чухал. Тэгж чадвал таны гаргасан мөрөөр бид өөр шинэ «Хэрээ» бэлдэнэ гээд хурандаа Хасу Тоишигийн царай өөд харж, нүдээрээ инээмсэглэв.

Намрын эхэн сарын шинэдээр японы эзэн хаан «Шанхайн ажиллагааг» амжилтанд хүргэх зарлиг буулгаад энэ бүхний зангилаа дээр дэслэгч генерал Мацуйг тохоон томилжээ. Чингээд японы цэрэг Шанхай, Нанжингийн чиглэлээр өргөн фронт нээлээ.

Хятадын нутаг дээр явуулж байгаа японы армийн ажиллагаа бүтэмжтэй байсан боловч алс дорнод руу чиглүүлсэн ажиллагаа үл мэдэгдэх замаар сүйрэлд орж, түүнийг илрүүлэх тусгай үүрэг тагнуулын байгууллагын толгой дээр буулаа. Тиймээс квантуны армийн тагнуулын

газрын ажилтангууд бүтэн нойртой хонохоо больжээ.

Симото, Харбинд сар болохдоо нэлээн сэжим гаргаж, Оросын фашист холбоонд шургасан нэг урвагчийн сургийг Аяанаосугийн тусламжтайгаар илрүүлжээ. Чингээд «Хэрээ» хочтой газарчинг Синьзин руу нууцаар аваачих ажиллагаа бэлдлээ.

Аяанаосу ажил тарсны дараа гэртээ орж иртэл утасны хонх жингэнэн утглаа. Тэрээр чагнуураа авангуут,

- Байна уу? Хэн бэ? Би Аяанаосу байна гэлээ.

- Аяанаосу сан, чи завтай бол Модрен буудлын зоогийн газар хүрээд ирээч гэхэд Аяанаосу, Хасу Тоишигийн дууг танилаа. Тэрээр найзынхаа урилгыг хүлээн аваад зоогийн газар очлоо. Гэтэл Хасу Тоишигийн урилга санамсаргүй хэрэг биш байлаа, Симото, Ханх нуурын ажиллагааг мухар толгойтнуудад илчлэх аргаа олсон нөгөө «Хэрээ» хочтой туршуулыг өөрийн мэдэлд авах болсныг дуулгах гэсэн хэрэг байв. Аяанаосу, Хасу Тоишитай чингэж уулзаад орос цагаан архи тулган, ярьсаар нэлээн халж согтох тийшээ орлоо.

- Аяанаосу сан, Синьзингийн гооргор (Симото) та бид хоёрын улыг шагайж явдаг нь үнэн байна. Манай генерал Хато өнөөдөр Токиотой утсаар ярилаа. Эд нар, Амисээг Синьзинд урьж байна. Ер нь ямар нэг юм сэдсэн бололтой. Аягүй бол чамайг Амисэгийн толгойг эргүүлж, нөхрөөс нь хөндийрүүлэх гэсэн хэрэгт унагаад намайг та гурвын хооронд хутган үймүүлсэн гэж өөлөх шалтаг гаргах санаатай байх шиг байна. Тэгэхээр Симото, ерийн нэг юм санаачлаагүй хэрэг!

- Амисэ ирэг л дээ. Тэр үед би хоёр өөр тийшээ яваад өгөхгүй юү. Наанадаж гэхэд Тумын руу судалгаа хийх, салбар нээх ажлаар явчихаж болно. Тэр үед Симото юу гэж бурахыг нь харъя. Харин чи надад үнэмлэх бичиг олгох талаар Сафроновтой тохирох хэрэгтэй болно байх. Тиймээс одооноос нүхээ малтах хэрэгтэй болно.

- Тэр болно. Харин нөгөө «хэрээгийн» үнэрийг Симото гадарлаад надаас салгах гэж гүйгээд байна. Тэр туршуул нэг юмнаас айгаад эгчийн талаар дуугарч өгсөнгүй. Тэгээд ямар нэг баталгаа гаргуулж авах гээд байгаа бололтой.

- Тэр чинь хэцүү хэрэг байна даа. Чи ер нь яая гэж бодож байна?

- Аяанаосу сан, ёстой яахаа мэдэхгүй болчихлоо. Өчигдөр надтай нэг үл таних хүн ирж уулзлаа. Хатогийн штабт болж байгаа зүйлийг надаас илүү мэдэж байна. Нөгөө талаар ахаас захиа авчирчээ. Тэд «хэрээг» сонирхоод байгаа юм байна.

- Хасу Тоиши сан, чи бид хоёр ингэж нарийн ширийн юм ярих болсон болохоор миний саналыг сонсоно биз. Чи ер нь ахтайгаа нийлбэл яасан юм бэ? Би чиний ярьсныг хэд дахин тунгааж үзлээ. Чи Аракигийн үгийг санаж байгаа биз. Тэр чинь Уссурийг Манж Готой нэгтгэхийг улайрч байсан. Гэтэл Итагаки жанжин штабт очсоноос хойш Сибирь, Манж Го, Монголыг нэгтгээд Сибири Мансю го гэдэг улс байгуулах гэж мэрийгээд байна.

- Энэ бол надад тодорхой хэрэг.

- Тэгвэл чи, японы эзэнт улсын төлөө гэдэг чинь зөв хэрэг үү! Чи чинь удам угсаа дамжсан самурай биш. Тэгээд ч тэр самурайн бусидо ёс монгол хүнд ямар хамаатай юм бэ? Ер нь чи, явж явж над шиг өөрийн гэх санаа бодолгүй кэмпэйтэйн заавраар тархиа

гашилгасан мангуу амьтан болоод байна уу?

- Аяанаосу сан, сүүлийн үед ёстой маанагтаж гүйцлээ. Гэхдээ байдлыг харья гэж бодож байна.

- Хасу Тоиши, чи над шиг өнгөрсөн хүн биш. Одоо ахтайгаа уулзах нь чухал. Чи ахтайгаа таарахгүй гэж бодоод байна уу? Энд удах юм бол нэг өдөр гудамжны булангаас буудуулна. Тэгээд Симото сонинд «Мухар толгойтнууд ахын нь өшөөг дүүгээс нь авлаа» гээд зарлуулчихна. Японы тагнуулууд ийм арганд сурамгай шүү!

Аяанаосу, Хасу Тоишигийн бухимдлыг мэдэж байсан болохоор сэтгэлийг нь манантуулсан манангийн дунд үл мэдэг сүүтэгнэж байгаа хүсэл мөрөөдлийн илч, үнэнийг ухаарах гэсэн бодлыг нь царцаахыг хичээгээгүй билээ. Хасу Тоиши, Аяанаосутай чингэж ярилцсан тэр өдрөөс хойш ахтайгаа анх хэрхэн муудалцсанаа санана. Тэр хоёр Токиогийн их сургуульд байхдаа хоёулаа техникийн ухаан сонирхдог байсан. Гэтэл Хасу Тоиши, цэргийн сургуульд шилжсэн билээ. Чингэтэл Хасбаатар японы цэрэг манжуурт орж ирсний дараахан нутагтаа ирээд буцаагүй аж. Хасбаатар нэг удаа Хасчулуунтай цэц булаалдаж, манжуурт тогтсон дэглэмийг шүүн хэлэлцээд муудалцсан билээ. Хасчулуун тэр жилээ япон руу буцаад Хасбаатар намар очно гээд үлдсэн аж. Гэтэл хэдэн сарын дараа Хасбаатар ор сураггүй алга болсон байв. Түүнээс хойш таван жилийн нүүр шувтарч байгаа нь энэ билээ.

Нэгэн үдэш Хасу Тоиши гэртээ бодлогоширч суутал, шоронгийн ахлах харгалзагч утасдаад,

- Дээд газрын шийдвэрээр гурван хүн ирээд оросын дүрвэгсдийн товчооноос ирсэн өнөө орос хоригдлыг аваад явлаа гэж илтгэв.

- Та нар чинь хэний шийдвэрээр үхсэн үлийгээ хийж байгаа юм бэ? Тэр оростой холбогдсон асуудлыг надаас өөр хэн ч шийдэх ёсгүй гэдгийг та мэдэж байгаа шүү дээ.

- Хасу Тоиши сан, сая дээд газрын нөлөөтэй хүмүүс ирсэн. Тэгээд ч гаккаа Хато сан гарын үсэг хийж өгсөн байна.

- Ёстой хоолны сав, тэнэг малууд гэдэг чинь та нар байна даа. Тэгээд тэр золигийн оросыг хаашаа аваад явсныг мэдэж чадсан уу?

- Мэдэж чадаагүй. Шоронгийн тэргээр аваад явсан. Тэр тэрэгний хойноос суудлын хоёр тэрэг дагаж явсан. Энэ бүхнийг шоронгийн их хаалганы харуулууд үзсэн байна.

Хасу Тоиши утсаа тавиад генерал руугаа ярих гээд зүрхэлсэнгүй. Учир нь дөрөв хоногийн өмнө уулзахдаа «Оросын товчооны шоронгоос манайд нэг хүн шилжиж ирээ юу? Түүнийг

Симото сонирхоод байгаа юм. Хэл амгүйхэн шилжүүлсэн дээр! Тозияагийн дургүйг хүргэвэл эвгүй байдалд орох болно» гэж анхааруулсан билээ.

Хасу Тоиши энэ шөнө унтаж чадсангүй. Тэрээр үүрээр арайхийж дугхийтэл гэнэт утас хангинаад нойрноос нь сэрээлээ.

- Би Сафронов байна. Нөгөө оросыг Симото аваа шив дээ гэхэд Хасу Тоиши арга буюу,

- Тиймээ. Хато сан шийдвэр өгсөн байна. Харин одоо Симото, нэлээн юм яриулж аваад та бид хоёрыг гоочлох байх даа гэлээ.

- Хасу Тоиши, чи тэр талаар санаа зоволтгүй. Тэр «хэрээг» авч явсан хүмүүс Харбин Синьзиний засмал зам дээр сүйрсэн байна. Одоо мэдэгдэж байгаа баримтаар бол тун эгзэгтэй байгаа. Би сүйрэл болсон газар руу явах гэж байна. Сая Хато сантай уулзсан. Тэгээд чамд дуулга гэж байна. Чи бидэнтэй хамт сүйрэл болсон газар руу очсон дээр биз. Би чамайг дайраад очъё. Чи бэлдэж бай гээд Сафронов утсаа тавилаа.

Хасу Тоиши хувцаслах зуур Сафроновын ярьсан яриаг эргэцүүлээд "Энэ зориуд зохион байгуулсан хэрэг мөн үү? Тэгвэл энэ бүхэн Симотогийн гараар хийгдсэн зүйл! Эсвэл санамсаргүй тохиолдол уу? Хасбаатар ахын явуулсан тэр танихгүй хүнд тав хоногийн дараа хариу өгье гэсэн шүү дээ. Тэр хүн өнөөдөр ирэх ёстой. Гэтэл шар оросыг авч явсан хүмүүс сүйрэлд өртжээ. Энэ бас санамсаргүй хэрэг үү?" гэж бодлоо. Хасу Тоиши, Харбин Синьзингийн зам дээр болсон сүйрлийн голомтон дээр ирлээ.. Тэднийг суудлын тэрэгнээс буухад Симото, өөрийнхөө хүмүүсийн хамт үзлэг хийж байлаа. Сафронов тэрэгнээс буунгуутаа товчооны орчуулагчийг дагуулж Симото дээр очлоо.

- Симото сан, Хэрээг Синьзин руу явуулах асуудлыг Хато сан та хоёроос өөр хүн мэдсэн байсан уу? Үүнийг манай фашист холбооны удирдлага сонирхож байна. Учир нь Разаевский өнөөдөр

атаман Семеновтой утсаар ярих ёстой гэнэ.

- Мэдэхгүй юм байна. Ер нь өөр хүн мэдэх ёсгүй.

- Танай хүмүүсийг шоронд очсоныг шоронгийн ахлах хянагч ажигласан байсан. Тэр тусмаа хоёр суудлын тэргэнд ямаршуухан хүмүүс сууж явсныг гадарласан байна.

- Тэгвэл тэр лүдийн хоногийн тоо гүйцэж дээ. Тэр ахлагч, Хато генералд бурсан нь Хасу Тоишигийн чихийг дэлссэн байж таарна. За яахав. Гэхдээ олон хүнд бурж амжихгүй биз гээд өмднийхөө халааснаас цагаа гаргаж үзсэнээ, тэр лүд одоо хорвоогоос тонилчихсон байхаа даа гэхэд Сафронов, шоронгийн жижүүрийг устгах арга замаа олчихсоныг мэдлээ. Тэгээд хэсэгхэн дуугүй зогссоноо,

- Энэ хэрэг бол манжуурт эрх чөлөө олгосон манай армийн ажиллагааг муутган гүтгэгч нарын гараар үйлдэгдсэн байж магадгүй, санамсаргүй тохиолдол байж мэднэ. Тэгэхээр хэн хэнд маань балаггүй өнгөрвөл болоо юм биш үү гэж хэлээд Симото хэнэггүй царай гаргав.

- Манай туршуулын хүүрийг үзүүлээч гэж Сафроновыг шаардангуй асуухад Симо, уруулаа мушилзуулан муухан инээмсэглээд,

- Бид шинжлүүлэхээр явуулчихсан. Магадалгаа гаргах хэрэгтэй. Тэгэхгүй бол хожим хойно хэл ам татлаад байж магадгүй гэж тоомсоргүй янзтай хэллээ!

Симото, энэ өдрөөс хойш долоо хоноод Синьзин рүү урам муутай буцахдаа Тозияд энэ хэргийг дуулгахгүй гэж шийдлээ. Харин хожим асуувал «Санамсаргүй хэрэг» гэдэг баталгаа гаргахаар бэлдэв. Учир нь «Хэрээ хочтон»-гийн хүүрийг Хато нүдээр үзнэ гэсэн нь Тозиягаас болгоомжилсон хэрэг байв. Тиймээс Симото, зүрхшсээр байлаа. Хато, хаяагаа манахын тулд Симо, тогийн дэргэд квантуны армийн штабын дарга руу ярьж жанжин штабт явуулах цахилгааныг Симо, тогоор бичүүлжээ. Тэгээд Тозиятай утсаар ярихдаа «Танай тэр Хэрээ хочтой амьтан чинь их гарын бэлтрэг байжээ. Ялангуяа Ханх нуур руу чиглүүлсэн ажиллагааг мухар толгойтнуудад дамжуулснаа нуухын тулд Хасу Тоишигийн нэрийг барьсан төдийгүй над руу дайрч, гүтгэхийг оролджээ. Би энэ тухай жанжин штабт мэдэгдсэн.

Тэр хэрээ хочитыг чинь их юм гадарлаж байсныг дүрвэгсдийн товчооныхон магадлан тогтоосон байна. Түүгээр ч барахгүй өнөө «Нуурын чанадад» гэсэн ажиллагааг мэдсэн байж магадгүй сэжиг гарч байгаа! Тийм хүнийг мухар толгойтнуудад алдана гэдэг бол манай нууцыг долоо хоногийн дараа улаантнууд мэднэ гэсэн үг! Сүйрэл гарсан газраас олдсон үхдлийг нарийвчлан шинжлэхэд Хэрээ хочитын хүүр байхгүй байсныг тогтоосон гэж билээ. Үүнийг Симо, то мэдэнгүүт Синьзин руу хурдан явж, штабын дарга Тозиод өөрийгөө цагаатган тайлбарлахыг чухалчилсан аж.

Тозия, Ёошийг Синьзингээс яаралтай дуудсан тул тэрээр Мугдэнд шөнө өнгөрөөж ирлээ. Тэрээр зочид буудалд буунгуугаа үүргийнхээ дагуу цэргийн төлөөлөгчдийн газар руу утасдаж бүртгүүлэв. Тэгээд цүнхнээсээ сакэ гаргаж, хоёр хундага дугтраад хажуулахдаа Тозиягийн өглөө очихоор шийджээ Гэвч Ёошигийн нойр энэ шөнө хүрсэнгүй. Тэрээр шөнөжингөө хөнжилдөө хургахдаа «Битүү дуудлагын» учрыг олох гээд чадсангүй.

Мугдэнд өвлийн улирал дулаавтар ордог боловч улаан эм үхэр жилийн өвөл тун хатуу орж, Ляодунгийн булангаас далайн жихүүн салхи салхилсаар байлаа. Ёоши Хайлар дахь цэргийнхний даалгавраар монголын хил рүү яваад ар монгол дахь японы тагнуул туршуулын ажиллагаанд саад болоод азаар хэл амгүйхэн шиг мултарсан билээ. Энэ нь юуны өмнө халхын да вангийн хошуу нутагт байсан нэгэн туршуул «гохонд» оролгүй үлдсэн төдийгүй Буйр нуурын Булан дэрс, Адаг Дулаан, Баян Түмэн Өлзийт овооны хавиар нутагладаг нэг ламтай холбоо барьж чадсаны ачаар Буйр нуураас баруун урагшаа Эрс уул хүртэлх газар нутгийн эртний газрын зураг олж ирсэн явдлыг Тозия олзуурхаж түүнийг өршөөсөн явдлаас шалтгаалжээ. Чингээд таван үеийн өвөг дээдсийн нь байгуулсан гавьяаг бодож Ёошийг ял зэмлэлгүй өнгөрөөсөн.

Ёошигийн өвөг дээдэс самурайн ёсыг хатуу сахидаг, бусидоод үнэнч хүмүүс байсан. Сүүлийн хоёр үе нь самурайн ёсыг сахисангүй. Харин эзэн хааны төрд нэлээн хүндтэй хүмүүс байлаа. Ёоши японы эртний хот Никкогийн хүн. Тэрээр долоон настай байхдаа Тосегугийн сүмд өвөөтэйгөө хамт очжээ. Тэрээр сүмийн

суурин доороос гарч давхисан хулганыг чавхдаж, түүнийгээ мөч мөчөөр нь салгаад Тосегугийн довжоон дээр хаяжээ. Чухам энэ үед нитирон ёсны (Дайныг эрхэмлэгч шашны урсгал) нэг лам сүмээс гарч ирээд нөгөө хулганыг харангуут зогтусан зогсов. Гэтэл Еоши хүү, хулганы нэг мөчийг довжооны чулуун шалан дээрээс аваад «Лам гуай, энэ хулгана танай гоё сүмийн сууринаас хэмлээд нураах гэж байхад нь алсан юм. Тиймээс энэ хулганыг залхаах ёстой. Одоо хулганууд тэнногийн төлөө буян үйлдэж, сүмийн баганыг хэмлэхээ болино» гэж хэлжээ. Нитирон ёсны лам, Еоши хүүгийн авхаалж самбааг магтаж, жинхэнэ самурайн үр сад, бусидо ёсонд үнэнч хүний удам байна гэж тунхаглаад өвөөтэй нь уулзаж "Таны ач, танай удмыг залгамжлагч жинхэнэ самурай мөн» гэж зарлаад өнөө хулганы мөч бүрийг сүмийн үүдний багананд өлгөж, хорхой шавьжийг хайр найргүй нядлах сэтгэгдэл төрүүлэхийн тул гайхамшигтай уран сийлбэрүүдийг хулганы цусаар мялаахад Еоши хүү «Ёстой гайхамшиг? Кэкко» гэж баярлан хашгирахад лам түүнийг адислав. Ингээд жаал хүү бусидогийн ёсоор хүмүүжиж, нүдэндээ үзэгдсэн халуун голтой бүхнийг голыг тасалж, сэтгэлээ баясгаж явдаг болжээ. Тэрээр том болсон хойноо цэргийн сургуульд орж төгсөөд Солонгост хээрийн цагдаагийн газар ажиллаж, японы үйл ажиллагааг эсэргүүцсэн солонгосын мухар толгойтнуудыг залхаан хашрааж байлаа. Харин таван жилийн өмнө Токиогийн тусгай сургуульд орсон жилээ өвчин эмгэгт ээрэгдэж, нэгэн мэргэн ламаар хувь тавилангаа үзүүлж, хар багаасаа үйлдсэн нүглээ арилгахын тул их буян үйлдэж, мэргэжлээ сольсноор газрын зургийн мэргэжилтэн болж жанжин штабт ажиллах болсон. Тэгээд газрын зураг дээр улс төрийн болон цэргийн түрэмгийлэл үйлдэх арганд мэргэжсэнээр эртний хан улсын цэргийн ёсыг судлах болсон. Тэрээр айл зэргэлдээх улсаа хятадчлах, газар нутгийн түрэмгийлэл хийх хятадын уламжлалт ёсыг японы самурайн ёсонд хэрэглэх «онол туршлын асуудал» боловсруулаад газрын зургийн түрэмгийлэлд ашигладаг болжээ. Харин санамсаргүй нэгэн тохиолдлоор засгийн газрын эсрэг чиглэсэн улс төрийн хуйвалдаанд оролцсоны уршгаар цол хэргэм буугаад квантуны армид ирж ахмад цолтой болжээ. Тэрээр хурандаа цолтой байсан болой. Тиймээс квантуны армийн зарим дарга нар түүнээс болгоомжилж, түүнийг кэмпэйтэйн туршуул гэж сэм бодно.

Еоши, аливаа улсын газар нутгийн зургийг будлиантуулах, эх материалыг нь олж устгах, арганд багагүй туршлагажсан хүн. Тиймээс Буйраас Халх, Нөмрөгийн гол хүртэлх газар нутгийн зургийг олж ашиглахыг мэрийнэ. Гэтэл түүний ажил, монголын нутаг руу хөл тавихыг оролдсон анхны алхмаас буруутжээ.

Еоши өглөө эрт босоод Тозияагийнх руу алхав. Түүнийг хашааны хаалгаар ороход Сувдаа тосон авч угтлаа. Тэгээд Сувдааг даган байшинд орж ирэнгүүтээ Тозияагийн өрөө рүү гэлдрэв. Тозияа, өглөөний цайны дараа сайхан зантай байдаг болохоор Еоши тэднийд очих цагаа чингэж тохируулсан болой. Еошийг, Тозияагийн өрөөнд ороход генерал тун сайхан зангаар угтлаа.

- Еоши сан, наашаа суугаач гэж урьсан Тозияа, янжуураа асаагаад ширээн дээр дэлгэсэн нэгэн газрын зураг руу заалаа. Хөх, ногоон, хүрэн, шар будгаар өнгө ялгаж зурсан тэр зургийг ажвал Сэцэн хан аймгийн Хурц вангийн хошуу нутгийн зураг болохыг Еоши түвэггүй мэдэв.

- Еоши сан, манжийн хааны архивт ар өвөр монголын бүх хошуудын зураг байсан гэнэ. Гоминдааныхан түүнийг аваад алга болгосон боловч өвөр монголын хошуудтай хил залгадаг

монголын хошуудын зарим зураг үлдсэн бололтой. Тиймээс танд нэгэн тусгай даалгавар өгье гэж шийдсэн. Та юуны өмнө ар монголын Ачит ван, Илдэн вангийн нутаг хошууны зургийг олох хэрэгтэй! Энэ ажилд чинь туслах хүний талаар жич ярилцана. Таны гол анхаарах зүйл бол дээрх хошуудын зургаас гол мөрөн, булаг, шанд, нуур цөөрмийг төдийгүй гол гол уулын өндрийг тогтоож, байлдааны газрын зурагт оруулж өгөх явдал юм! Тэр тусмаа хилийн дагуух овоо тэмдгүүдийн байрлалын талаар гоц анхаарах хэрэгтэй. Мөн газар нутгийн нэрийг тодруулах ажил хийх болно. Үүнийг та хэдэн сарын дотор багтаавал өндөр шагнал оногдоно гэдгийг мартаж болохгүй.

- Эрхэм дээдсээ энэ зургийг хэдийд зурсан юм бэ? гээд маотуу цаасан дээр өнгө ялгаж зурсан зургийг заахад Тозияа,

- Богд хааныг анх ширээнд залснаас хойш долоон жилийн дараа хийсэн зураг байна. Хурц вангийн нутаг хошууг тогтоосон

анхны газрын зурагт хил хязгаарын овоонуудыг нарийн тусгасан байдаг гэнэ. Ер нь Да вангийн нутгийг Баргын нутаг гэж мэтгэх нь ашиггүй зүйл. Тиймээс Та, Да вангийн нутгийг анх хэний нутаг байсныг мэдэх гэж хөөцөлдсөний хэрэггүй! Харин тэр нутгийн гүнд байгаа чухал газруудын байр зүйн холбогдолтой зүйлийг сайн судлах хэрэгтэй. Шилийн голын чуулганы Үзэмчин ван Сономравдан, Баруун хуучид хошууны Сандагдорж, Зүүн хуучид хошууны ван Гүнчинванчигийн үед зурсан газрын зургуудыг Дэ вангийн хүмүүс олж өгнө гэсэн. Тэгэхээр та, тэр зургуудыг энэ зурагтай харьцуулж ялгааг нь тогтооно биз! Мөн монгол руу явуулах «Усны хайгуулын» хүмүүст шаардагдах газрын зургийг боловсруулах ёстой. Тиймээс хэд хичнээн хүн хүч шаардагдах ёстойг над танилцуулаарай гэснээ ярианы далим гаргаж, аа тийм. Симото та нар чинь хоорондоо ялих шалихгүй юмаар маргадаг гэнэ. Түүнийгээ зогсоож, тохиролцох талаар хэн хэн нь бодох хэрэгтэй! Та нарын хоорондын шальгүй атаа жөтөө ажил хэрэгт багагүй чирэгдэл тарина гэдгийг бодох хэрэгтэй!

- Тозияа сан, би Симотоод өөрийгөө цагаатгаад хэлчихэж болно. Харин тагнуулын газрын саваагүй, хэрэгт дуртай хүмүүс миний ажилд атаархаад байгаа юм гэж Еошийг хэлэхэд Тозияа эчнээндээ «Хөөрхий энэ зулбасга, хүзүүгээрээ ороосон боомоо мэдэхгүй харайлгаж явдаг. Гэтэл Симото, хийг нь тааруулаад цааш нь түлхчих санаатай! Аа хөөрхий эдний энэ алдар нэр хичээсэн атаа жөтөө юу? Ажилд мөн садаатай юм даа» гэж бодно.

Симото, Еошийг штабт ирж ажилласан өдрөөс түнжин хагарч, ул мөрийг нь шагайдаг болсон. Үүнийг мэдсэн Еоши, Симотогийн асуусан зүйлд хариулах дургүйгээ хүрвэл «Чухал хэрэгтэй бол Тозияагаас асуу» гэдэг болжээ. Еошигийн энэ егөөтэй даажигналт Симотогийн хорыг малтана. Тиймээс Симото, Еошигийн амжилтанд атаархаж, түүний ажил төрөлд саад хийж, хясах бодолтой. Гэсэн ч Симото, өөрийнхөө эчнээний бодолд үл хүрнэ.

Еоши, Тозияагийн зөвлөгөөнийг ажлын удирдамж болгодог болохоор энэ бүхнээс болгоомжилсон Симото өөрийнхөө атаархалт бодлын уршгаар сэтгэлдээ эгдүүцэх тусам Тозияагаас айгаад, Еошигийн ажилд саад хийж зүрхэлдэггүй ажээ.

Еошигийн үйл ажиллагаанд саад тотгор хийх алхам гаргавал Тозияа, Симотоог нүд ирмэхийн зуур баллаж чадах эрх мэдэлтэйг бодоод айна. Ер нь хөгшний дургүйг хүргэвэл Тозияа, эзэн

хааны нэрийн өмнөөс яах ийхийн зуургүй өөрийн нь гараар хэнийг ч устгуулж чадна. Тозияа дургүйгээ хүрсэн цагт Симото, Ёоши хоёрыг дуудаад «Эзэн хааны армийн нууцыг задруулахгүйн тулд та хоёр самурайн эрхэм тангарагийг дагаж өөрөө өөртөө харакири үйлдэх хэрэгтэй. Ингэвэл та хоёрын хэн хэн нь эзэн хааны армийн өмнө нэр хүндтэй байх болно» гэж тулгавал өнгөрөх нь тэрээ? Ингэхээр Ёоши, үхэхээс айдаг Симото хоёрын аль аль нь Тозияаг харахаараа «Эрлэгийн элчтэй» халз учирсан юм шиг санагддаг билээ.

Тозияа, энэ өдөр Ёошитай чингэж ярилцаад төлөөлөгчийн газар руу очихоор гэрээсээ гарахын өмнө,

- Ёоши сан, чи Юкитэй уулзаарай! Чамаас монголын зарим хошуудын засаг ноёдын гарал угсааг асуух байх. Чи чинь ар монголын ноёдын уг сурвалжийг нэлээн судалсан гэдэг биз дээ гээд өрөөнөөсөө гарахад Ёоши түүнийг сүүдэр шиг дагана. Тозияа, Ёоши хоёрыг дээд давхрын шатаар уруудаж явтал Юки зочдын өрөөнөөс гарч ирлээ. Тозияа, асарсан охиныхоо бараанаар шатан дээр зогсож, түүнийг хүлээсхийлээ. Тэгээд Юкийг дэргэдээ ирэхэд нь,

- Юки охин минь Ёоши сантай уулзаж, асуух юмаа ярилц! Наадах чинь Халхын ноёдын гарал угсааг таван хуруу шигээ мэднэ. Мэдэхгүй зүйлээ сайн асууж лавла гэлээ.

Ёоши, Юкитэй уулзангуут ёсыг даган түүнийг хүндэтгэн мэхэсхийж, тэргүүн бөхийлгөн мэндлэв. Тозияаг байшингаас гарсны дараа Юки, Ёошийг зочдын өрөөнд урилаа. Ёоши уужим өрөөнд орж ирэнгүүтээ тавьц тавилга өөрчлөгдсөнийг ажиглав. Цагаан гантиган хашлагатай усанд умбанхан шумбаж байгаа загасны хажууд зочдыг дайлах явган ширээг засаж, хананд тулгасан хар суман дивануудын байрыг өөрчилж, ширээнүүдийн дэргэд засжээ. Тэгээд эргэн тойронд нь одой мод бонсай эгнүүлэн тавьжээ.

- Ёоши сан та суугаач гэхэд диван дээр тухлан суусан Юкигийн дэргэд суув. Чухам энэхэн зуур Сувдаа архи дарс чихэр

жимс тэргүүтнийг авчирч ширээнээ өрөхийг ажваас түрүүнээс хойш бэлдсэн нь илэрхий. Сувдаа ширээнд таваг тавиад гарсны дараа Юки сакэ хундагалж, Ёошид барилаа.

Ёоши ёсыг даган хундагатай архийг тогтоогоод, хундагаа ширээн дээр тавьтал Юки дахин сакэ хундагалаад,

- Ёоши сан, та саяхан Буйр нуурын хавиар явсан гэл үү? гэж асуув.

- Буйраас холгүй байдаг Асар сүм ороод ирсэн.

- Та чинь Халхын Үнэн сүжигт илдэн вангийн удам судрын талаар аль зэрэг мэдэх вэ?

- Юки сан би танд өвөг дээдсийн нь намтрыг бичээд өгсөн ч болно. Тэгэхдээ бүр Чингэс богдын үеэс одоо хүртэлхийг судалснаа ч ярьж болно. Харин Даян сэцэн хаанаас хойшихыг бол одоо яриад өгсөн ч болно.

- Ёоши сан надад тийм эртнийх хэрэггүй. Ердөө сүүлийн үеийн Да вангийн тухай бол болох

нь тэр.

- Ар монголын захын Да ван гэж алдаршсан Доржпаламын тухайд гэвэл одоогийн Халхын гол, Буйр нуурыг хамарсан нутаг хошууг Бадруулалт төрийн 10 дугаар онд залгамжилж аваад хоёр жилийн дараа (1886 онд) засаг төрийн ажилд эндэгдэл гаргаад, хэргэм зэргээ хасуулсан юм. Харин Богд хааны зургадугаар онд гавьяа шагнал тэмдэглүүлж, нэлээн нэр төртэй болсон. Ардын засгийг Их хүрээнд ирсэн чимээг сонсоод сар хагас болсны дараа зам буруулж нутаг, хошуунаасаа гараад Хайлар, Харбинаар дамжин Бээжинд очоод баларсан хүн. Тэрээр хэдэн сар баян тарган бялхаж байхдаа Бээжингийн садар самуун хүүхнүүдтэй сүүж холбож, сүүлдээ гуйлгачин болж сүйрсэн гэдэг. Харин Ардын засаг, эзгүй үлдсэн нутаг хошуунд нь хамгийн түрүүнд төлөөний түшмэл илгээж, баахан бужигнуулсан гэж дуулддаг. Илдэн ван өөрийнхөө нутаг хошууны газрын зургийг Сүрийг Бадруулагч хийдийн (Тамсагийн хийд) нэг зураач ламаар зуруулсан юм. Гэтэл тэр газрын зургийг хэн авсан нь мэдэгдэлгүй алга болчихоод байгаа. Бид бас сургийг нь гаргаж чадаагүй байна.

- Еоши сан, та тэр газрын зургийг олбол хамгийн түрүүнд надад үзүүлэхийг бодоорой. Би Богд хаант улсыг дахин сэргээсэн тухай ном бичих ёстой. Түүндээ японы эзэн хааны армийн гүйцэтгэсэн үүргийн тухай оруулаад хэд хэдэн газрын зураг хэвлэх санаатай. Та миний энэ ажилд тусалбал би, таны ачийг хэзээ ч мартаггүй. Юу хүссэн есөн хүслийг чинь биелүүлнэ гээд шинийн сар шиг нарийхан хөмсгөө өргөж, давхраатай алаг нүдээрээ инээмсэглэн талархал дэвшүүлэв.

- Юки сан би, таны ажилд тусалж чадна. Эзэн хааны армид одоо азийг цэцэгжүүлэх их үйлсийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээд байна. Одоо манай арми, Нанжингаас Ухань, Тяньжингаас Сюананьны чиглэлд амжилттай давшаад байгаа. Юки сан та энэ тухай «Шанхай Дэйли» сонинд юу гэж бичсэнийг санаж байна уу?... Японы эзэн хааны зоригт цэргийн өнөөгийн зорилт бол хятадын армийн эсрэг чиглэсэн үйл ажиллагааг богино хугацаанд хэрэгжүүлэх явдал гэсэн. Манай армийн цэрэг Бохайн булангаас ар монголын хил хүртэл ямар ч саадгүй болсон. Одоо чинь манай арми, Тяньжингээс Бээжин, Бээжингээс Хаалган хүртэл ямар ч саадгүй цэрэг зэвсгээ тээвэрлэж чадах төдийгүй Синьзингээс Вангийн сүм, Вангийн сүмээс Ханширээ хүртэл төмөр замтай болчихоод байна. Тэгээд Хайлараас Амгалан, Ганжуур сүм, мөн Жанжин, Мөст сүм хүртэл дардан замтай. Ингэхээр армийн цэрэг зэвсгийг Монголын хил хүргэх зам харилцааны асуудлыг шийдээд байна. Одоо нутгийн гүнд нэвтэрч газрын зургийн тодруулалт хийх баримт цуглуулна.

- Еоши сан та яасан сайн хүн бэ? Би долоон жил хүлээсэн хүсэл мөрөөдлөө талаар өнгөрөх нь гэж бодоод цөхөрдөг байсан. Харин таны саяын үг намайг бүр баярлуулчихлаа.

- Юки сан би, бүр үнэнийг хэлж байгаа юм шүү. Ялангуяа Чан Кайши, манай армид бууж өгөх цаг нь ойртоод байгаа. Саяхан Германы элчин Траутманаар дамжуулж Гитлерт санал дэвшүүлсэн. Тэгэхдээ манайхаас хятадад тулгасан долоон зүйлийн шаардлагыг зөөлрүүлэх санаачилгыг гаргах санал тавихыг германаас гуйжээ. Токиод байгаа Германы элчин Дирксен, гадаад яамны сайд Хиротатай уулзаж, Чан Кайшигийн саналыг цухуйлгасан юм. Ингэхээр Чан Кайши, өөртөө боломжтой цагийг хүлээж байгаа хэрэг. Дорнод төмөр замыг нийгэмчлэх хувийн компаниудад улсын зүгээс хяналт тавих асуудлыг Токиод хэлэлцэх тухай яриа дэгдээд байна гээд Еоши хундагатай сакэгаа балгана.

Юки, Еошитай ярьж сууснаа суудлаасаа өндийж хананд тулгасан, шилэн хорготой шүүгээгээ онгойлгож, нэгэн жижиг хайрцагтай юм аваад Еошигийн дэргэд ирлээ. Тэгээд хайрцгийн тагийг нээтэл алтаар хийсэн оосортой энгэрийн алтан цаг байхыг хараад Еоши балмагдах шиг болов.

- Еоши сан, миний өчүүхэн бэлгийг хүлээн авч хайрла. Та миний бичих ёстой номонд шаардагдах баримт олж өгвөл би таны ачийг ямагт санаж явах болно гэхэд нүдний харц булаасан алтны өнгөнд сэтгэл зүрхээ эзэмдүүлсэн Еошигийн эчнээнд шуналын цог улалзах ажээ.

- Би таны ажилд туслалгүй яах вэ. Манай нэг туршуулыг ар монголоос ирэнгүүт тэр зургийг авчирч үзүүлнэ гэж хэлснээ ажил төрлийн нууц задгайруулснаа ухаарангуут, Юки сан та намайг өршөөгөөрэй. Та чинь цэргийн яамны захиалгаар ном бичиж байгаа болохоор бидний хооронд нууцлаад байх зүйлгүй биз дээ. Да ванг Хайларт ирэхэд нэг лам ирсэн. Түүнийг манайхан элсүүлээд хэдэн сарын дараа буцаасан. Харин уржнангийн цаад жил Адаг дулаанаар орохдоо тэр ламтай холбоо барьсан юм. Тэгээд түүгээр дамжуулж газрын зурагт шаардагдах зүйлийг олдог болсон. Да вангийн хошууны зургийг тэр хүн олох найдлагатай байгаа.

- Еоши сан, тэгвэл тэр газрын зургийг хамгийн түрүүнд надад үзүүлнэ гэдэгт итгэж болох нь шив дээ гэхэд Еоши жижгэвтэр цагаан шүдээ яралзуулан инээмсэглэж тал засна.

- Юки сан, үүнийг би танд амлаж чадна шүү гээд Еоши сэтгэлдээ «Энэ баян хүүхэн миний үгний алдааг ухаарч, нууцтай холбогдсон зүйлийг Тозияд ховлох сөхөөгүй шив дээ» гэж бодлоо. Еоши ингэж өөрийгөө цагаатгасан нь утсан чинээ улаан амиа, алт мөнгөний барьцанд алдахыг үл тоомсорлох бурангуй ёсны нэг өвөрмөц хөг аяс ажээ. Чингэж дорвитойхон барьцанд шунаж, амин хувь, албаны нууцыг үл ялган, ам мэдэн бурдаг ёс эцсийн эцэст хүзүү ороодог тавилантайг сакэнд халж, томоохон бэлэг авсан Еоши ухаарах сөхөө байсангүй.

Гурав. Үл ойлгогдох учрал

Сафронов ажилдаа эрт ирлээ. Тэрээр Харбин дахь «Оросын дүрвэгсдийн товчоо», «Оросын фашист холбоонд» харьяалагддаг хүмүүсийн улс төрийн үйл ажиллагааг хянах хэсгийг толгойлдог хүмүүсийн нэг билээ. Өөрөөр хэлбэл атаман Семеновын даалгавраар нууц байгуулсан тусгай хэсэгт ажилладаг. Тэрээр Харбин болон бусад хотуудын улс төрийн самуун дэгдээгчдийг мөрдөх туршуул, дүрвэсэн иргэдийн хэргийг эрхэлдэг болой.

Сафронов энэ өдөр «Цагаач» гэдэг хочтой туршуултай уулзах ёстой учраас өглөө эрт ирсэн. Харбин дахь сэжигтэн хүмүүсийн «илүү дутууг» бүртгэх ажилтай «Цагаач» болзсон цагтаа даргын өрөөнд орж ирлээ. Тэрээр хурандаатай уулзаад амар мэндийн зөрөө гаргангуут албан үүргийнхээ дагуу ажлаа илтгэлээ.

- Манжуурт байгаа японы банкны салбарт олон сая иень, долларын хөрөнгө хадгалуулсан Юкигийн төлөөний хүн, Сувдаа банкинд хадгалж байгаа хадгаламж, хүү мөнгөний тооцоо хийхээр ирэх бүрдээ 10—15 мянган иень авдаг байна. Миний хяналт хийж байгаа хугацаанд 45 мянган иень авсан. Тэр эмэгтэй Харбинд ирэх тоолондоо Аяанаосугийн захиалгын газраар ордог боловч ямар ч хувцас захиалж байгаагүй.

- Тэр эмэгтэйг Харбинд ирсэн өдөр, Аяанаосугийн захиалгын газраар орж гарч байсан цагийн бүртгэлийг хийсэн үү?

- Ноён хурандаа, энэ талаар бичсэн илтгэх хуудсаа аваад ирсэн гээд барьж явсан хавтсан дотроос нямбайлж бичсэн арваад хуудас бичиг гаргаж өглөө.

- Тэр эмэгтэйн талаар та, ямаршуухан сэжим гаргасан бэ?

- Ноён хурандаа, миний таамаглалаар бол Сувдаа, Аяанаосу хоёрын хооронд ямар нэг нарийн холбоо байгаа юм. Ер нь Сувдаагийн амьдрал ахуй зан чанарыг сонирхууштай санагдаад байна. Хүмүүсийн яриагаар бол Сувдаа Баатар гүн гэгчийн нууц амрагаас төрсөн бололтой. Тиймээс Цэен гүн ахынхаа нэр төрийг бодоод өөртөө авсан бололтой. Гэхдээ энэ талаар надад нарийн баталгаа байхгүй.

- Нотолгоо гаргахын тулд нарийн ажиглалт хийж болно.

- Иймээс та надад удирдамж өгвөл ямар вэ?

- Чи юу ярьж байгаагаа мэдэж байна уу? Энэ чинь цаашдаа Юкигийн нэр сүртэй холбоотой төдийгүй Тозияагийн ажил төрөл, армийн нэр хүндтэй холбоотой. Бид ийм ээдрээтэй юманд хошуугаа дүрэхэд учир бий. Нотолгоо гаргах гэж мэрийгээд өөрөө ороолдож мэднэ гэдгийг санах хэрэгтэй шүү! Тиймээс хөнгөн, гоомой хандаж болохгүй!

- Тиймээ би энэ талаар бодож үзсэн. Хасу Тоиши Аяанаосу хоёр найз нөхөд. Гэтэл Сувдаа дүүтэйгээ уулздаггүй, найзтай нь сэм уулздаг явдал миний сэжгийн нотолгооны гогцоо болж байгаа юм. Эдний удам судраас үзвэл өвөг дээдэс нь 40 шахам жилийн өмнө өвөр монголын хувьсгалт чанартай хөдөлгөөнд оролцож явсан байна. Тиймээс..

Сафронов суудлаасаа босоод «Цагаач» хочтой туршуулынхаа дэргэд суулаа.

...Би хорчин аймгуудын нөлөөтэй хүмүүсийн гэрийн үеийн угийн бичгийг шүүж үзсэн. Жирмийн чуулганы ван, тайж нар бол өөрсдийгөө Чингэсийн дүү Хавт Хасарын удам гэдэг. Баатар гүний «Хатан» бол Хасарын арван нэгдүгээр үеийн Хүй Мөнх Тасхарын удам судраас гаралтай байна. Өөрөөр хэлбэл дархан вангийн хошууныхан бол Тасхарын их хүү Бодидарагийн хүү Намсрайн удам юм. Баатар гүнгийн өвөг дээдэс Өндөр гэгээний үед түүнийг дагаж Халхад очсон шавь буюу одоогийн өвөр монголын Засагт вангийн удмын улсууд.

Сафронов хэсэгхэн зуур бодлогошрон суухдаа «Цэен гүнийг нас барсны дараа Жирмийн чуулганы Засагт ван, Дархан вангийн хошууны хэд хэдэн нөлөө бүхий сурвалжит хөгшид ирсэн явдал ийм нарийн холбоотой байжээ» гэж бодов.

- Ноён хурандаа, би олон баримтыг шалгаж үзсэн. Засагт вангийн хошуу нутагт анх хятадууд нутаглах болж, хятадын засаг захиргааны байгууллага (Сянь) байгуулах болсонд дургүйцсэн Самбуу гэдэг хүн, 1899 онд зэвсэг барин боссон байна. Үүний нөлөөгөөр Жирмийн чуулганыхан хятадын гүнээс нүүж ирж суурьшсан хятад цагаачдыг нутагтаа байлгахгүй гэж тэмцэх болжээ. Ялангуяа Баатар гүнгийн эхнэрийн ах нь 1905 онд

Жирмийн чуулганы Горлос хошуунд гарсан Тогтох тайжийн хөдөлгөөнийг дэмжиж, Дархан вангийн хошууны «Мухар толгойтнуудыг» удирдан боссон байна. Чухам энэ үед Баатар гүн, Харбинд ажиллаж байсан бөгөөд эхнэрийнхээ ахтай танилцаж үерхсэн юм. Түүгээр барахгүй Даагын хуа гэдэг газрыг хятадуудад эзэмшүүлэхээр өгсөн Дархан вангийн тухай хошин дуу гаргажээ. Чухам үүнийг мэдсэн Хасбаатар одоо мухар толгойтнуудтай нийлээд байгаа хэрэг. Ингэхээр Хатогийн штабын нууц Хасу Тоишигоор дамжин Аяанаосуд хүрч, тэндээсээ Сувдаагийн гараар орж Хасбаатарт хүрдэг байж болно.

Сафронов, «Цагаач» хочтой туршуулаа Аяанаосу, Хасу Тоиши хоёрын талаар нарийн судалгаа хийсэн явдалд гайхлаа. Үнэндээ өөрөө ч ийм судалгаа хийгээгүй билээ. Сафронов энэ бүхнийг эргэцүүлэн бодсоноо,

- Цагаач минь чи тун нарийн судалгаа хийжээ. Гэхдээ дэл сул зүйл багагүй байна. Юуны өмнө Хасбаатартай Сувдаа яаж уулздаг вэ? Холбоочин хэн бэ? гэдгийг тодруулаагүй цагт энэ талаар чи бид хоёроос өөр хэн ч мэдэж болохгүй! Надад төрсөн ойлголтоор бол чи, эдний холбоочныг тогтоох боломжтой юм шиг санагдаж байна. Харин энэ бүхнийг батлах нотолгоогоор дүлхан үед хамаагүй дуугарч болохгүй гэж хэлээд «Мань хүн хий сэжгээс цаашгүй юм» гэж бодлоо.

- Тэдний холбоочны талаар надад тодорхой баримт байхгүй. Гэхдээ сэжиг гаргах боломж бүрэн бий.

- За чи, энэ ажлаа үргэлжлүүл! Тэгэхдээ ямар ч эгзэгтэй үед, тэр байтугай зайлшгүй аюултай үе тохиолдлоо гэхэд Сувдаа, Аяанаосу хоёрыг бариулах алхам хийж болохгүй. Энэ бол маш нарийн зохион байгуулсан байх ёстой ажиллагаа. Тиймээс асуудлыг надаас өөр хэн ч мэдэж болохгүй гээд Сафронов шүүгээнээсээ аравтын дэвсгэрээр толгойлж боосон боодол иень

гаргаж өгөөд гарын үсгийг зуруулж авлаа.

Сафронов, цагаачтай уулзсанаас хойш бүх баримтаа нарийвчлан шалгаад сэтгэлд буумгүй нарийн сэжим оллоо.

Юки, эцгийнхээ хойдын буянд зориулж нэг сүм бариулсан. Түүнийг Жирмийн чуулганы Түшээт вангийн хошуу нутаг Соёлж уулын баруун өмнөхөн байдаг Булгийн сүм, Вангийн сүм хоёрыг

холбосон замын хойно байгуулсан. Түүнийг Гучит сүм гэдэг. Зуны улиралд зүүн Үзэмчин, Вангийн сүмийн гучин лам ирж тайлга хийдэг болохоор Гучит сүм гэжээ. Юки гахай жилийн намар (1935 он) Солунь Ханширээгийн төмөр замыг ашиглалтанд оруулсны дараа Гучит сүм рүү явахдаа Сувдааг дагуулж явсан байлаа. Гэтэл Сувдаа үл мэдэгдэх шалтгаанаар Вангийн сүм дээр үлджээ. Гэтэл тэр үед Тоор (Тоорой мод ургадаг учир ингэж нэрлэсэн гэдэг) гол дээрх төмөр замын гүүр дэлбэрч, Халуун Рашаан руу очих ёстой бэхлэлтийн барилгын ихээхэн материал сүйджээ. Хойтон жил нь тайлга хийлгэхээр Гучит сүм дээр ирэхдээ Хянганы нуруунд бүгсэн Жирмийн чуулган, Шилийн голын чуулганы мухар толгойтнуудад баригдсан атал сэтэрхий тэвнэ, сэмэрхий хадагны гарзгүй мултарчээ. Гэтэл түүнээс хойш дөрөв хоноод Ханширээгийн төмөр замын галт тэрэгний засварын газар, Хандгайт голын гүүр дэлбэрсэн. Эдгээр дэлбэрэлт болсон цаг үе, нөхцөл байдал нь Сувдаагийн «жуулчилсан» үетэй тохирч байлаа. Сафронов, ийм баримтуудыг харьцуулан нягталсны дараа Мугдэн рүү гарлаа. Сафронов, Мугдэнд ирэнгүүтээ Тозияатай уулзав.

- Тозияа сан, би нэг эвгүйхэн ажлаар тантай ярилцахаар ирлээ. Манай нэг туршуулын төсөөллөөр бол хэн хэн маань эвгүйхэн хавханд орж магадгүй байна. Сувдаа Тайлгын сүм рүү явахдаа мухар толгойтнуудад баригдаад ямар ч аюулгүй суллагдсан байна. Энэ бол сэжигтэй зүйл гэхэд,

- Иван Степанович минь, энэ бол дүү нь эгчээ алж зүрхлээгүйтэй холбоотой асуудал. Нөгөө талаар Солуньгаас Ханширээ рүү явж байсан цэргийн тээврийн галт тэрэг сүйрсэн судалгаанаас үзвэл Синьзингээс мухар толгойтнууд мэдээ авсан байсан. Ер нь ар монголын тагнуул, туршуулууд Хайлар, Харбинд байхгүй гэх нотолгоогүй. Тэгэхээр хамар доорхыгоо сайн судалж бай! Эцэст нь хэлэхэд Юкигийн нэр төртэй холбоотой ийм зүйлийг чи бид хоёрын хэн хэн нь цагаатгаж байх нь чухал! Тиймээс дэвэргэн хөөрүүлэх тийм боломж гаргаж болохгүй! гэж хэлэхийг сонсоод Сафронов сэтгэлдээ «Хөгшин генерал, ах дүүсийн талаар нарийн эгзэг олж дээ. Тэгээд Юкигийн байр байдлыг харж, гарцаагүй нотлох баримт гарч ирсэн үед Юкид зөв ойлгуулахын тул хамаг нууцыг түр далдлахаар шийджээ...Баттай нотолгоо

байхгүй үед Юки, Сувдааг хамгаална гэдгээс болгоомжилж дуугүй өнгөрөхөөр шийджээ» гэж бодоод дуугүй өнгөрөхөөр шийдлээ. Учир холбогдлын энэ зангилааг мэдсэн Сафронов, тэр өдрөө Юкитэй уулзаж, өөртөө хэрэгтэй зарим зүйлийг ярилцаад Харбин руу буцсан билээ. Харин түүнийг Мугдэнгээс явахын өмнө Юки түүнтэй уулзаж,

- Иван аа, чи ор сураггүй алга болчихдог шигээ хэл чимээгүй ирдэг сонин эрээ! Мугдэнд аль зэрэг удах вэ? Би чамтай уулзаж яримаар юм их байна. Ер нь тэгээд манайд хэд хонох юм

байгаа биз дээ? гэлээ.

- Юки минь би чамтай ярих юм их бий. Гэхдээ чи бид хоёр хөгшнөөс тусгай уулзах нь чухал. Ер нь хөгшний дэргэд чамтай нарийн ширийн юм ярьж болохгүй байна шүү дээ.

- За тэгвэл өнөө орой миний өрөөнд уулзаад шавиагаа ханатал ярья.

- Хөгшин муу юм бодох байлгүй дээ.

- Бодож л байг! Тэртэй тэргүй эд нар чинь чи бид хоёрыг сууж магадгүй гэж ярьдаг юм гээд инээмсэглэхэд Иван Степанович, Юкигийн үгнээс зөрсөнгүй...

Тозияа, оройн хоолны дараагаар Сафроновтой ярилцахдаа Аяанаосугийнд очдог Сувдаагийн талаар ямарчүгцухуйлгасангүй. Харин ярианы байдлаас үзвэл Тозияа, Аяанаосугийн зан чанар, мэдлэг боловсролд гүн дүгнэлт хийсэн нь илэрхий. Тозияа, үнэндээ кэмпэтайн баримтанд түшиглэж, Аяанаосугийн талаар бодохдоо «Уг нь тагнуулын боловсролгүй хүн! Гэхдээ муу юманд туршлагажсан эр.

Ер нь түүний захиалгын газрын орлогыг унагаагаад өр ширэнд оруулж чадвал уу? Гэр оронг нь галдан шатаагаад сэтгэл санааг, ахуй амьдралаар нь хавчаад өгвөл тагнуулын хорлон сүйтгэх, хутган үймүүлэх ажиллагаанд оролцож болно. Өрөнд баригдсан сохор зоосгүй хүн тагнуулын ажиллагаанд өөрийн эрхгүй татагдаж, ацаг хөлсөнд нь шунах болно. Чингэж чадвал Аяанаосуг Хайлар, Харбинд биш харин Асар, Мөст сүмд байгуулах хорлон сүйтгэгчдийн түр сургуульд өгч монголын ажиллагаанд бэлтгэх тагнуулуудтай ажиллуулж болно» гэж боддог ажээ. Тозияа, шөнө дүл өнгөртөл Сафроновтой ойр зуурын юм ярьж байгаад өрөөндөө >орж хажуулахаар явахад Иван Степанович, Юкитай хамт зочдын өрөөнөөс гарч билээ...

Сувдаа хонх жингэнэх чимээнээр дээд давхраасаа бууж байшингийн хаалгаар гарлаа. Хэрмэн хашааны даамангийн түгжээг тайлж явган хаалгаа онгойлгосон чинь нэгэн гуйлгачин зогсож байлаа.

Хир хөлсөнд дагтаршсан дээлийн зах, энгэрийн оёос ханзарч, ханцуй нь урагдаад салмарсан монгол дээлтэй дөч орчим насны туранхай монгол хүн, хатангир хөх нүүрнийхээ ухархайнд шигдсэн нүдээр Сувдааг ширтэх нь «Гол зогоох юм хайрла» гэж гуйх шиг санагдаад сэтгэлд нь өрөвдөх энэрэл төрнө. Гуйлгачин, нуухандаа дарагдаж улайсан зовхио үл хөдөлгөн хэсэгхэн зогсохдоо хэдэнтээ ээрээд,

- Очирвааний тиг бүтээчих хүн энд байдаг гэсэн үнэн үү? гэж хорчин аялгуугаар асуухад Сувдаа хэсэгхэн гайхаад «Юу?» гэж амандаа шивнээд өнөө гуйлгачин өөд сүрхий ширттэл тэрээр үгээ дахин хэлэв. Чухам энэхэн үед нэгэн бодол од харвахаас хурдан эгшинд Сувдаагийн санаанд буулаа. Талийгаач гүн, нас барахын өмнөхөн амжиж захисан үгийг Сувдаа саналаа.

Богд хаан, ардын засгийг устгахын тулд гадаадаас цэрэг зэвсгийн хүч гуйж, олон сая долларын алт, эрдэнэс нууцаар хятадад гаргаж, гадаадын банкинд хадгалуулсан нууц хэрэг

явдалд шууд оролцох эрх бүхий хүн ирснийг мэдсэн Сувдаа сорих түлхүүрийг саналаа.

- Ажаа гэгээний тигийг мэддэг хүн бий.

Сувдааг ингэж хэлтэл өнөө гуйлгачин, хирэнд дагтаршсан дээлийн өврөөс маотуу цаасан дээр зурсан Очирваань буюу Шагдар бурхны тигийг гаргаж өглөө. Улаан шунхаар тиг татсан цаасан дээр хар бэхээр зурсан Очирваань бурхны зургийг ажвал баруун нүдний тигийн гамбумыг (зовхины зураас) татаагүй байлаа. Сувдаа чингэж зургийг нарийвчлан ажсаны дараа өнөө хүнийг дагуулж байшиндаа орж ирээд, үүдний диван руу заагаад,

- Та эндээ жаахан хүлээж байхгүй юу. Та суугаач гэлээ.

- За яахав. Би зогсож байя гэхэд Сувдаа шатаар өөдөө гарч, Юкигийн өрөөнд орж ирээд юм бичиж байсан Юкигийн дэргэд очлоо.

- Сувдаа чи, нөгөөдөр Харбин руу явахад бэлтгээрэй. Харбины банкныхантай тооцоо хийгээд тэндээсээ Гучит сүм очиж тайлга хийлгээрэй. Тэгээд Вангийн сүмээр ороод Дарь эхийн мандал шиваа бүтээлгээд ир гэж хэлээд суудлаасаа босов.

- За мэдлээ. Юки эгчээ ар монголоос хүн ирсэн байна.

- Юун хүн билээ?

- Яагаа вэ? Талийгаач адиагийн хэлдэг нөгөө Очирвааний тиг сураглах ёстой хүн гэж Сувдааг хэлэхэд Юки,

- Очирвааний тиг авчирч уу? гэж лавлав.

- Авчирсан байна. Бүх юм талийгаач адиагийн хэлснээр байна гээд Сувдаа өнөө тигийг Юкийд өглөө. Юки бурхны тигийг үзэж байснаа,

- Аавд дуулгасан уу?

- Үгүй шүү. Дуулгах хэрэг байгаа юм уу?

- Дуулгачих. Талийгаачийн холбоочин хүрээнээс ирэх ёстой. Ирвэл хэл дуулгаарай гээд байсан юм. Харин Очирвааний тигийн талаар уг цухуйлгах хэрэггүй. Тэгээд ч энэ бурхны зургийг холбоочинд буцаагаад өгчих гэлээ. Сувдаа, Юкигийн өрөөнөөс гарч, Тозияагийн өрөөнд орлоо. Тозияа, Сувдааг ажиглангуй харснаа,

- Намайг төлөөлөгчийн газраас сураглаа юу? гэж асуув.

- Үгүй ээ. Тозияа сан, ар монголоос ирсэн бололтой нэг хүн талийгаачийн алдар нэрээр сураглаж байна гэхэд Тозияа суудлаасаа ухасхийн өндийснөө биеэ барьж хэсэгхэн зогссоноо,

- Ямаршуухан хүн байна гэлээ.

- Гуйлгачин байрын хүн байна. Их муухай хувцастай юм байна.

Тозияа тасалгаанаас гарч үүдний өрөөнд орж ирээд хаалганы баруун ханын дэргэд зогсож байгаа гуйлгачин руу сүрхий харснаа,

- Юу ч гэсэн би өөрөө уулзъя. Ийм амьтныг Юкитэй уулзуулаад яах вэ? гээд өөрийнхөө өрөө рүү дагуулан явав. Тозияа, өрөөндөө орж ирээд өнөө гуйлгачин руу эргэн хартал тэрээр сая ам нээж,

- Даеэний (хар тамхи) үнэ нэмэгдээд алтаар худалддаг болжээ гэв.

- Алт ховордсон болохоор одоо яая гэх вэ? гэж Тозияа Цэен гүнгийн хэлж өгсөн дохиог хэлтэл гуйлгачин,

- Гүнгийн алтыг японы банкуудад шилжүүлээд авбал хэрэг бүтэх юм биш гэж сорих түлхүүрээ хэлсэн тул Тозияа,

- За ашгүй. Та чинь хүрээд ирдэг. Халхаас гараад удаж байна уу? гэв.

- Тозияа сан, авсанд ороод буцаж амилахаас бусдыг үзлээ. Халхаас гараад бараг гурван сар гаруй болж байна гэхэд Тозияа,

- За тэр яахав. Юуны өмнө наад хувцсаа соль. Ус цасанд орж хирнээсээ салж үз! Тэгээд тухтай ярилцъя гээд ширээн дээрээс хонхоо авч тачигнуултал Сувдаа орж ирлээ.

- Сувдаа ноёнтонг усанд оруул. Төлөөлөгчийн газар руу ярьж, ноёнтны биед таарах хувцсыг миний нэрийн өмнөөс захиалаад, хорин мөчийн дотор авчирч өг! гэж хэлээрэй гэлээ. Чингээд Сувдаа, холбоочин хоёрыг гарсны дараа Тозияа, дээд давхрын өрөө рүү гэлдрэхдээ, Юкитэй ярих үгээ эргэцүүлэн бодно.

... Холбоочин ирэх нь ирлээ. Энэ хүнийг гүнгийн холбоочин гэдгийг Юкийд яаж итгүүлэх вэ? Үүнийг чинь Юкигийн бөөрөнд хавчуулах хэрэгтэй! Энэ хүн алтны талаар Юкитэй ярьж чадвал, алт ямар банкинд байгааг мэдэж чадна. Тэгвэл тэр банкныхныг сүрдүүлж, банкны нь ойролцоо хэдэн удаа хорлон сүйтгэх ажиллагаа өдөөчихвөл тэд айх нь зайлшгүй. Тэр үед Юкийг цааш нь харуулчихаад олигтойхон үнэмшигдэхээр баримт бэлдээд авчихвал учир бий! Банкныхан хуурамч баримт гэдгийг мэдээд алтыг өгөхгүй бол дахин сүрдүүлнэ. Бидний гараас амьд мултрахгүй гэдгээ мэдээд ирэхээрээ дахиж сүйд болохгүйгээр өгөөд хэл амгүйхэн шиг салъя гэж бодно. Харин Юкигийн хадгаламжийн нууц шифрийг яаж салгах вэ? Ер нь Сувдааг цааш нь харуулаад Богдын холбоочин гэдэг нэрээр ирсэн хүнийг Юкигийн туслах болгох хэрэгтэй! Сувдааг цааш харуулбал Сафроновыг ашиглах нь найдвартай. Тэгвэл Сувдааг Харбин явсан үед л ажлаа тохируулах хэрэгтэй гэж бодлоо.

Тозияа чингэж бодсоор Юкигийн өрөөнд орж ирснээ бараг

мэдсэнгүй. Юки, асарсан эцгийнхээ царайг хараад «Хөгшин юу гэж орж ирсэн бол? Нэг юм сэдэж дээ. Түүнээс миний өрөөнд зүгээр орж ирээгүй. Аавын минь холбоочинг турших гэж

бодоод надаас зөвшөөрөл гэж байгаа болов уу? Эсвэл өөр хэрэг гараа юу?» гэж бодлоо. Юки, Тозиягийн сэтгэлийн чанадад байгаа санааг мэдэхийн тулд өөрөөс нь урьтаж,

- Аав аа, Сувдаа бид хоёр нөгөөдөр Вангийн сүм рүү явна. Та бид хоёртой явахгүй юу. Тэндхийн лам нараар Дарь эхийн бүтээл хуруулъя. Би энэ жил жилээ угтаад өөдлөхгүй байна. Хойтон бол шар бар жил. Тэгэхээр гучин зургааны жил тун барцадтай орж мэднэ. Ер нь байн байн ханиагаад хамрын шуухинаа тусаад нэг л хачин. Цагаан хэл аманд өртөөд байх шиг байна. Тиймээс барцдаа арилгуулъя гэлээ. Тозияа, Юкигийн үгийг сонсоод хэсэгхэн бодохдоо «Нөгөөдөр...нөгөөдөр гэнээ. Тав хоногийн Дараа Мугдэнгээс Ханширээ рүү тусгай галт тэрэг гарна. Үүнийг манай төлөөлөгчдийн газраас гадна Симото л мэдэж байгаа. Өөр хэн ч мэдээгүй зүйл. Гэтэл Юки Вангийн сүм явна гэдэг сонинноо! Сафроновын гаргасан төсөөлөл ул мөртэй юу? Сувдаа энэ галт тэрэгний сураг чимээг сонссон үедээ Юкийг ятгаж чадна. Гэтэл Сувдаа үүнийг хэнээс мэддэг билээ?» гэж өөрөөсөө асууна.

- Юки минь дарь эхийн бүтээлийг Вангийн сүм орж бүтээлгэсний хэрэггүй. Мугдэнд бүтээлгэсэн ч болно.

- Хаанахын лам нараар бүтээлгэх вэ?

- Ар монголоос ирсэн ламаар бүтээлгэж болно.

- Юу? гэж Юкийг гайхан асуухад Тозияа,

- Ар монголоос талийгаачийн дотно танил нэг лам ирсэн.

- Өнөө таны асуугаад байдаг хүн үү?

- Тиймээ. Уг нь лам хүн гэдэг сэн.

- Аав аа тэгвэл би, Харбин руу очиж, банкны салбартай энэ жилийнхээ хүү мөнгөний тооцоо хийнэ. Тэгээд буцах замдаа Вангийн сүм дайрч, Дарь эх бүтээлгэе гэж бодсон юм. Ер нь тэр ламыг дагуулаад явья байз.

- Тэгвэл болох юм. Энэ талаар дараа тухтай ярья гэж хэлээд Тозияа дотроо «Эхлээд Харбин явна гэнээ. Энэ чинь надад ашигтай хэрэг. Сувдааг Харбин явуулаад Юкийг холбоочинтой хамт тайлгын сүм рүү явуулж болно. Тэгэхээр Сувдаагийн талаар

Сафроновтой урьтаж яриад бас давхар мэх хэрэглэх хэрэгтэй. Сувдааг одоо амжиж Юкигээс салгахгүй бол өөр далим гарахгүй шүү» гэж бодлоо.

Өдрийн хоолон дээр ар монголоос ирсэн холбоочин, Тозияа, Юки гурав хамт хооллолоо. Дунд зэргийн нуруутай, туранхайвгар биетэй холбоочин, хар өнгийн зангиа зүүж, европ хувцас өмсөөд цагаан цамцтай байгааг ажваас тун яггүй зохижээ. Гэсэн ч идэр ахуйдаа шашны ёс сахиж явсан лам, европ хувцсанд дасаагүй болохоор биеэ барьчихаад хачин хөөрхийлөлтэй харагдана. Харин дорно дахины ёс гадарладаг тэр хүн, зааны ясан савх барихдаа өвөрмөц сурмаг ажээ.

- Ар монголд ямаршуухан байна даа гэж Тозияаг асуухад,

- Хэцүүхэн байна. Улаанбаатарт оросоос байгуулж өгсөн үйлдвэрүүд шатсан. Жас жавын талаар бүр ярилтгүй. Цөмийг нь хаачихсан. Ихэс дээдэс, шавь нараа зэвсэглэн хөдөлгөх гэсэн боловч ямар ч амжилт ололгүй, өөрснөө өртлөө. Тэгээд амьд үлдсэн хэд нь Наран улсын сүлдэнд найдаж байна. Гэтэл зарим хүмүүс хувиа борлуулж, довоо шарлуулахаас цаашгүй болсон доо.

- Монголчууд манай армийн талаар ямаршуухан амтай байна гэж Тозияа зориуд асуулаа.

- Янз янз л ярьдаг бололтой. Улаан хулгана жил (1936 он) өвлийн сүүлчээр Булан дэрсэнд Гонгор гэдэг залуу, сүрхий эр зориг гаргасан юм гэж шуугиад байна. Хавар нь Адаг Дулаанд болсон явдал, энэ өвөл болсон онгоцны нислэг зэргийг их ярих юм. Тийм их хүчээр хөдөлсөн мөртлөө Тамсагбулагаас хэтэрч чадаагүй гэж зэмлэж байгаа хүн ч бий.

- Улаан оросууд монголд ирсэн үү?

- Одоохондоо мэдэгдэх юм алга. Ер нь 1921 онд гамин, бароноос чөлөөлсөн шигээ туслах юм гэж шуугьж байна. Нөгөө талаар улаан оросууд монголыг эзэлсэн гэж бичсэн Харбины сонин цуурхалд хүрээ хотынхон дургүй байдаг бололтой. Үнэндээ цөвүүн цаг гэдэг айхавтар сүйтгэлтэй, түйтгэрээр багагүй байдаг бололтой. Тэгээд ард олны ихэнх нь уур хилэнгээ барж явдаг болжээ. Би наашаа зүглэх гэж үйл тамаа барлаа. Уг нь Эрхэмсэг бэйсийн нутгаар дамжин зүүн Үзэмчин хошуугаар орж ирье гэж бодсон. Тэгсэн чинь болж өгсөнгүй. Тэгээд Хурц вангийн хошуу дайрч, Егүзэрийн хийд дээр байж байгаад ирлээ. Богдын шадар хүмүүс танд захиа явуулсан. Тэд ч гайхаш тасраад байгаа шүү дээ.

- Би таны авчирсан захиаг уншсан. Захианд дурдсан бүхнийг армийн удирдлагад мэдэгдэнэ гээд Тозияа яриагаа завсарлав. Тозияа, зочныхоо талаар Юкитэй ярих гэж байсан болохоор яриаг түр завсарласан. Хоолны дараагаар Тозияа, Юкитэй гийчнийхээ тухай ярилцлаа. Тиймээс хэлэх үг, ярих зүйлээ тун их цэгнэн бодож байв.

- Юки минь энэ хүнийг яах вэ? Ярианы өнгө овоо юм шиг байна. Миний охины ажилд дэм болж чадах уу?

- Талийгаач минь энэ хүний талаар нэлээн зүйл ярьсан. Энэ хүн багадаа лам явсан нь үнэн. Богдын түлхээсээр цагаан хаант оросын төмөр утасны хүмүүстэй нийлж нарийн мэргэжилтэй болсон гэдэг. Тэгээд Замын-Үүдийн төмөр утасны хороонд байж байгаад хожим Богдын дэргэд очсон юм гэдэг. Хаантан энэ хүнийг талийгаачтай танилцуулсан гэдэг. Богдын таалал төгссөнөөс хойш энэ хүн аавтай хоёр удаа ирж уулзсан гэдэг. Түүнээс хойш одоо бараг арван жил боллоо. Тэгэхээр бөөрнөөсөө ягаарчихсан байвал яана?

- Юки энэ талаар шалгаж үзье. Тэгэхдээ манайд байсан дээр биз. Чи гар хурууныхаа үзүүрт зарсан дүр гаргаж бай! Тэгээд ч хятад, монгол, манждаа зүгээр юм. Бас тэгээд япон хэл гадарладаг бололтой. Ингэхээр энэ хүн хэн болохыг шалгахад хялбархан шүү дээ. Өөрөөр хэлбэл өдөр бүр илүү дутууг нь ажиглаж, жирийн юмаар шалгаж болно. Тэгээд ч Сувдаагийн ажилд туслуулах нэрээр байлгавал сэжиггүй гэж хэлэхдээ «Холбоочинг Юки, хардаж байна.

Харин мань хүний ярианаас үзвэл монголд болсон цаг үеийн байдлаас зугтааж амиа хоохойлохоор наашаа ирсэн бололтой. Ингэхээр Юкийд дасгаж, ажил төрөлд нь туслуулах нэрээр байлгаж байх нь чухал! Хэрэгтэй үедээ үүнийг ашиглах нь хялбархан» гэж бодов.

- Аав аа та, өөрөө энэ хүнийг яахаа шийд. Би юу гэх вэ.

- За тэгвэл байдлыг нь харъя. Харин чи, Харбин руу хэзээ явах вэ? Нөгөөдөртөө явж амжих юм уу? гэлээ.

- Ер нь Сувдааг Харбин руу явуулж тооцоо хийлгүүлнэ. Тэндээсээ Вангийн сүм ороод тайлгын сүм рүү явна биз. Харин хоёулаа энэ хүнтэй хамт тайлгын сүм рүү явъя. Та зөвшөөрнө биз дээ.

- Тэгж болно. Харин чамд нэг сайхан мэдээ дуулгая. Ерөнхий сайд Коноэ ар, өвөр монголын нөлөө бүхий хүмүүсийг Токиод урьсан байна. Тэгээд армийн хүсэлтээр чамайг урьжээ гээд биеэсээ салгадаггүй хүрэн хавтсан дотроос Коноэгийн урилгыг гаргаж өглөө.

Ёоши, Юкийд хэлсэн амандаа хүрч, Халхын илдэн вангийн хошуу нутгийн зургийн жинхэнэ эхийг Юкийд авчирч өглөө. Юки ширээн дээр байгаа газрын зураг руу харж байснаа ханынхаа нууцын шүүгээнээс аравтын дэвсгэрээр толгойлсон боодол доллар гаргаж аваад Ёошид өгөхдөө,

- Ёоши сан, та ёстой эр хүн юмаа. Миний ажилд ингэж тусалсан явдалд их баярлалаа. Өөр сонин зүйл олбол үзүүлж байгаарай гэхэд Ёоши боодол долларыг алга тосон авахдаа «Энэ зургийг надад буцааж өгөхөөсөө өнгөрлөө шүү. Үүнийг мэдсэн бол хувилж авдаггүй мөн тэнэг ээ! Тозияа сан энэ бүхнийг мэдэхгүй өнгөрвөл болох нь тэр" гэж бодоод дотроо залбирчээ.

- Юки сан та энэ зургийг аль болох түргэн хугацаанд надад эргүүлж өгвөл сайн юмсан гэж арай ядан хэлтэл Юки,

- Ёоши сан, би номондоо энэ зургийг хэрэглэнэ. Тэгэхээр мэд өгч чадахгүй. Нөгөө талаар миний номыг хэвлэсний дараа ар монголын улаантнууд баримтыг минь үгүйсгэхийн тулд юу ч гэж магадгүй. Тэр үед би, жинхэнэ эхийг нь гаргаж баримт болговол дээр шүү дээ. Тэгэхээр энэ зургийг би танд мэд буцааж өгөх боломжгүй юм.

- Юки сан тэгвэл энэ нууц та бид хоёрын хооронд үлдсэн дээр юмсан. Энэ зургийн хувь хаана ч байхгүй. Би өөрөө ч хуулж аваагүй.

- Ёоши сан таны үнэнч чанар чинь надад их таалагдаж байна.

Би энэ тухай Тозияа санд ч цухуйлгахгүй гэдгийг амлаж чадна. Хэрвээ баримт дурдах тийм хэрэг гарвал тантай зөвлөж байж шийднэ гэж Юкийг хэлэхэд Ёошигийн сэтгэл сая уужирчээ. Ёоши ингэж Юкитэй уулзсаны дараа Тозияд бараалхав.

- Ёоши сан, чиний ажил юу болж байна?

- Буйр нуурын Асар сүмээс хүн ирсэн. Захын Да вангийн хошууны зургийг олоогүй байна. Ер нь тэр зургийг Сан бэйсийн хүрээний жасад хадгалж байгаад алдсан сурагтай байна. Дам сонссон баримтаар бол Цагааны оргодлууд арван хоёр онд (1922) шарилын сүмийн алтан суваргыг хулгай хийхдээ хамт аваад явсан бололтой. Түүгээр ч барахгүй цагаантнууд тэр зургийг аваад өөрийнхөө ажиллагаанд ашиглаж байсан сэжиг гарч байна.

Тозияа, Еошигийн үгийг сонсоод хэсэгхэн бодолхийлснээ,

- Еоши сан, чи одоохон оросын цэргийн нисэх онгоцны буудал руу оч! Тэндээсээ Харбин руу ниснэ. Сафроновт нэг бичиг хүргэж өгөөд тусгай даалгавар бүхий ажиллагаанд оролцоно. Тэгэхдээ зүгээр оролцохгүй. Юу хийснийг нь ширхэгчлэн ажиглаж, түүний талаар тодорхой илтгэл бичих ёстой. Таны гол үүрэг бол өөрийнхөө таньдаг нэг эмэгтэйг таалал төгсөж үү? Үгүй юү гэдгийг л мэдэж баталгаа гаргах ёстой юм гээд Тозияа нэгэн битүүмжилсэн бичиг гаргаж өглөө.

Еоши Тозияагийн тэргээр Мугдэнгийн зүүн хойхно байдаг цэргийн нисэх онгоцны буудал дээр хүрч ирээд зохих хүмүүстэй уулзсаны дараа тусгай бэлдсэн онгоцоор агаарт хөөрлөө. Тозияа, Еошигийн ажиллагааг өөрөө боловсруулаад түүнийг Буйр нуурын зүүн хойд эрэг дээр байгаа Асар сүмээс хүрч ирэхийг хүлээж байсан юм.

Еоши, Харбинд ирсний дараа Сафроновтой уулзаж амжсангүй. Тэрээр гурав хоногийн өмнө Хайлар явсан агаад өнөө шөнө ирэх ёстой ажээ. Еоши цэргийн буудалд буугаад Сафроновыг ирсэн дор нь мэдэгдэхийг хүсэн цэргийн төлөөлөгчийн газарт захилаа. Чингэтэл өглөө цэргийн төлөөлөгчийн газрын жижүүр утасдаж, Сафроновыг хагас цагийн өмнө ирснийг мэдэгдэв. Еоши алба цугласны дараа Сафроновын өрөөнд очлоо. Тэгээд Еоши, хурандаад Тозияагийн захиаг гардуулав.

... Сафронов сан, таны гаргасан сэжим бодитой бололтой. Сувдаа

энэ удаагийн ээлжит явалтаар Харбин орно. Энэ нь Мугдэнгээс Ханширээ орох ёстой цэргийн тээврийн галт тэрэгний явалттай таарч байна. Энэ галт тэрэг Ханширээд барилгын материал хүргэх ёстой. Тэр материалыг Монголын хилээс холгүй байгаа Жанжин сүм рүү татах ёстой. Тиймээс Сувдаагийн цаашдын ажиллагааг хянахгүйгээр учрыг нь олох нь чухал байна. Тэр хүний амьд явах хоногийн тоо гүйцсэн учраас Юкийд үнэмшүүлэх арга сэдэж олох нь чухал. Мугдэн дэх японы цэргийн зөвлөх онцгой эрх бүхий хошууч генерал Х.Тозияа. Үүнийг уншаад шатаа!

Сафронов Тозияагийн захиаг уншаад «Хөгшин генерал, Сувдааг устгах ажиллагааг манайхаар гүйцэтгүүлэхээр шийдсэн мөртлөө илтгэх хуудас бичихийг хоригложээ. Тиймээс Еошигоор бидний ажиллагааг хянуулахаар илгээсэн бололтой. Илтгэх хуудас бичихийг зөвшөөрөөгүй болохоор Юкигээс болгоомжилсон хэрэг! Тэгэхээр Сувдааг аюул, ослын замаар устгах явдлыг бидэнд сануулсан хэрэг!» гэж бодлоо. Сафронов захиаг уншсаны дараа туслахаа дуудаад,

- Цагаач туршуулыг яаралтай олж ир гэж тушаалаа. Чингээд Еоши, хурандаа хоёр энэ тэрхнийг ярьж суутал Сафроновын туслах орж ирээд, «Цагаач» хочтой туршуул ирснийг илтгэв.

Иван Степановичийн туслахыг гарсныдараа ганган хувцасласан нэгэн эрлийз байрын залуу, хурандаагийн өрөөнд орж ирээд Ёоши руу сүрхий ажиглангуй харлаа. Тэрээр хурандаатай мэндэлсний дараа албан үүргийнхээ дагуу илтгэж гарав.

- Өнгөрдөг шөнийн галт тэргээр Сувдаа Харбинд ирсэн байна! Тэгээд Модрен буудалд буусан. Одоо банкны салбарынхантай тооцоо хийхээр явсан.

- Сувдааг, нэг гэж товлосон газар очингуут нь надад яаралтай мэдэгд! Хяналтаа үргэлжлүүлж, цаг тутам утсаар мэдэгдэж бай гэж үүрэг өгсөн. Сафронов, туршуулаа гарсны дараа Сувдааг хэрхэх тухай Ёошитой ярилцахаар шийдэж байсан тэрхэн мөчид Сувдаа хадгаламжийн мөнгөний хүүнээс дүрвэгсдийн товчоонд гэрээсэлсэн хорин мянган иенийг шилжүүлэхээр банкинд зөвшөөрөл өгөөд Хатотой уулзахаар цэргийн төлөөлөгчийн газар руу явлаа.

Сувдааг өрөөндөө орж ирэнгүүт Хато найрсаар угтаж,

дүрвэгсдийн товчоонд шилжүүлсэн хөрөнгийг сонсоод баярлахын эрхэнд Сафронов руу утасдаж түүнийг дуудлаа. Чингээд генералын туслах халуун цай авчирч Сувдааг дайлж байтал Сафронов ирлээ.

- Сафронов сан, наашаа суугаач. Сувдаа сан талийгаачийн гэрээсэлсэн хөрөнгөнөөс хорин мянган иенийг танайд шилжүүлсэн гэнэ гэж хэлээд талархал дэвшүүлэхэд Сувдаа гар цүнхээ уудалж банкны хуудас гаргаж генералд гардуулан өгөөд,

- Юки сан, талийгаачийн хойтын буяныг бодож тайлгын сүм рүү явсан. Харин энэ хөрөнгийг та бүхэнд гардуулахыг надад даалгасан юм гэлээ.

- Юки саны, өгөөмөр сэтгэлийг хүндэтгэж маш их баярлаж байгаагаа Оросын дүрвэгсдийн товчооны өмнөөс илэрхийлж байгааг Юкид дамжуулахыг хүсье гэж Сафронов талархал дэвшүүлээд «Энэ хүүхний нас сүүдэр цагаар хэмжигдэж байгааг Ёоши бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй. Одоо Ёоши яаж устгахаа тооцоолж суугаа. Гэтэл энэ эмэгтэй ингэж явдаг. Юки, Сувдаад жигтэйхэн сайн. Сувдааг осолдвол тэр минь ганцаардана. Ай даа даалгавар...даалгавар гэдэг чинь яаж ч болохгүй хэцүү зүйл юм» гэж бодно.

- Сувдаа сан, та хэзээ буцах вэ? Буцахаасаа өмнө бидэнтэй уулзана биз дээ. Бид Юки санд өчүүхэн бэлэг барих санаатай байна.

- Ноён генералаа.. Би нөгөөдөр явна. Та бүхнээс Мөст орох зөвшөөрөл гуйх гэсэн юм. Манай эзэгтэй тэр сүмийн лам нараар дарь эхийн мандал шиваа бүтээлгэх санаатай байгаа юм.

Сафронов Сувдаагийн энэ үгийг сонсоод сэтгэлдээ «Мөст сүм... Монголын хилд хамгийн ойрхон байдаг хоёр сүм бол Жанжин, Мөст сүмүүд билээ. Японы армиас монгол руу чиглүүлсэн төлөвлөгөө ёсоор энэ хоёр сүмийг цэргийн хуаран болгохоор шийдсэн. Тиймээс цэргийн барилгын материалыг одоо тийш нь татаж байгаа» гэж бодлоо.

- Сувдаа, чамайг Мөст рүү явуулах тухай зохих хүмүүстэй ярилцаж зөвшөөрөл авч өгнө. Нөгөө талаар би, нөгөөдөр Хайлар явна. Тэгэхээр таныг аваад явсан ч болно гээд Хато, Сувдаа

хоёрын албаны яриа дуусав.

Сувдаа Хатогийн өрөөнөөс гараад буудалдаа иржээ. Тэгээд буудлын жижүүрээс түлхүүр авахдаа,

- Хорин нэгэн цагийн үед нэг хүн ирж сураглах байх. Тэгвэл утсаар хэлчихээрэй. Би оройн сүүдэр ший үзэх ёстой юм гэж захилаа. Сувдаа, өрөөндөө орж ирсний дараа Аяанаосугийнд очих цагаа хүлээлээ. Гэтэл Аяанаосутай уулзах цаг яагаа ч үгүй байлаа. Харин Сувдаа уулзах цагтаа яарч байлаа. Сувдаа, энэ уулзалтаас хойш Аяанаосутай биеэрээ уулзахгүй юм шиг санагдана. Үүнээс хойш Аяанаосу, төвийн удирдамжаар ирсэн холбоочинтой ажиллах ёстой.

Сувдаа, Аяанаосутай уулзах бүртээ сэтгэлд нь үл мэдэг нэгэн өдвөлт үүсч, түүний эчнээнийг дэнсэлгэдэг болсныг мэдэв. Яагаад ч юм бэ? Аяанаосуг үе үе санаж, заримдаа түүнийг зүүдэлдэг болсон. Тэгээд зогсохгүй зүс царайг нь харах юмсан гэж хүснэ. Ингээд түүний ярьж байсан үг, царай зүсийг сэтгэлдээ бодох дуртай болов. Ийнхүү өдөр хоног өнгөрөх тусам Аяанаосу сэтгэлд нь хоногшиж, үгүйлэх болсныг ухаарангуут бүсгүй хүнд хайр сэтгэл ингэж заяадаг юм болов уу гэж бодно. Гэсэн ч Сувдаа, Аяанаосутай тэр бүр уулзаж болохгүй. Сувдаа, Аяанаосугийн царайг харж сэтгэлээ баясгах, үг яриаг нь сонсож эчнээнийхээ хүслийг тольдон ухаарах эрмэлзлэл бүхэн цаг хугацаатай. Тиймээс нэг уулзалтаас нөгөө уулзалтыг хүртэл хуруу даран тоолдог удаатай. Заримдаа элдвийг бодоод атаархах сэтгэл төрдөг. Сувдаа заримдаа «Аяанаосуд дурласан хүүхэн байдаг болов уу? Тэгвэл Улаанбаатарт байгаа» гэж өөртөө анхааруулдаг аж. Ингээд Аяаносутай уулзах бүрдээ түүний яриаг ажиглахад хувийн яриа дэлгэх цаг хугацаа байдаггүй билээ. Энэ эгзэг Сувдааг залхаах шиг санагдана. Гэхдээ Сувдаа юуны өмнө ажил үүргийнхээ тухай боддог болохоор энэ бодлоо мартаж шаардлагатай гэдгийг юунаас ч илүү ухаардаг болой.

Сувдаа, байн байн цагаа хараад цонхны дэргэд зогсож гудамж ширтэхдээ Аяанаосуд дамжуулах баримтаа бодно.

...Өнөөдөр Аяанаосутай уулзаад ер нь жаахан ярья байз. Эхнэртэй эсэхийг нь мэдэх хэрэгтэй. Эхнэртэй хүнд дурлаж болохгүй. Харин яаж ярих вэ? Намайг шоолбол яана? Үгүй ээ. Би яагаад ингэж бодож байна! Муу ёр байгаа даа... Дахиж уулзахгүй

юм шиг заавал өнөөдөр ярих нь юу билээ. Ёстой муу ёр байгаа даа... Өнөөдөр ярихгүй бол надад өөр бололцоо гарна гэж үү? Би яагаад ингэж бодоод байна. Өглөө зүүн нүдний зовхи татаад байсан. Ер нь муу ёр байгаа даа. Муу юм битгий тохиолдоосой...

Сувдаа ингэж бодсоор зогсохдоо цагаа харахаа таг мартжээ. Чухам энэхэн үед цагийн зүү урагшилсаар Аяанаосутай уулзах болзоонд хориод мөч үлджээ. Гэсэн ч Сувдаагийн сэтгэлээс хорвоо дээр амьдарсан энэ хэдэн жилийн тохиолдол бүхэн салсангүй.

...Аяанаосу...Аяанаосу бид хоёр ямар учралаар уулзав аа. Ёстой гайхамшигтай учрал шүү. Жирийн энэ хүнд, хүн хүнээс илүү гойд юу байгаа юм бэ? Хүнтэй адилхан хүн шүү дээ. Гэтэл миний сэтгэлийг дэнсэлгээд байдаг. Гэтэл Аяанаосугаас илүү гоё сайхан залуу зөндөө бий. Тэд миний сэтгэлийг ингэж дэнсэлгэж байгаагүй. Яах вэ? Ийм үед эмэгтэй хүн яах ёстой юм бэ?...

Сувдаа ингэж өөрөө өөртэйгөө ярьж зогсохдоо хаалга цохиж буй чимээг бүдэг бадаг сонсоод цагаа харвал Аяанаосутай уулзах цаг болжээ. Буудлын жижүүр авгай орж ирээд,

- Сувдаа сан, таныг нэг тэрэгчин сураглаж ирлээ гэхэд Сувдаа,

- Одоохон. Би одоохон очно. Хүлээж бай гэж хэлээрэй гэлээ. Сувдаа ширээн дээрээс янжуураа авч, шаахайгаа углаад яаран

сандран гарснаа өөрийнхөө байдлыг мэдэнгүүт тайван байхыг хичээж биеэ барилаа. Тэгээд буудлын жижүүр авгайд түлхүүр үлдээхдээ,

- Намайг хүн сураглаагүй биз гэлээ.

- Нэг орос хүн утсаар асууж байсан. Таныг сүүдэр шийнд явах гэж байгааг хэлсэн гэхэд Сувдаа толгой дохиод буудлаас гарахдаа «Сафронов уулзах гэсэн юм байх даа. Маргааш тухтай уулзаж болох байгаа. Юки минь уулзаад ирээрэй гэсэн шүү дээ» гэж бодов. Сувдаа өдөр Хатогийн газраас ирэхдээ тэрэгчинтэй цаг тохирч, үнэ хөлсийг нь ахиухан төлсөн болохоор тэрэгчин цагтаа иржээ.

Сувдаа, тэрэгчинд очих газраа хэлээд тэрэгний арын суудалд тухлан суухдаа уртаар санаа алдаж сэтгэлээ тайвшруулаад Аяанаосуд дамжуулах баримтаа бодно. Харбин хотын шөнийн гудамжнаа өнгө бүрийн гэрлэн хаяг солонгорон гялалзаж, өдөржингөө хөлийнхөө улыг улайтал шогшсон хүн хөлгөөс гадна гадаадын худалдааны пүүсний харьяанд захирагддаг морин тэрэгчид өдрийн од шиг үзэгдэх аж. Харбины хөл үймээн татрах яагаа ч үгүй болохоор гудамж талбайд бужигнасан хүмүүс, хөл тавих зайгүй багширна.

Сувдаагийн суусан морин тэрэг Аяанаосугийн байшингийн дэргэд иртэл бас нэг морин тэрэг байшингийн үүднээс хөдөлж байлаа. Сувдаа тэрэгнээс буугаад байшин руу ороход Аяанаосугийн туслах залуу Сувдааг угтан уулзлаа.

- Аяанаосу сан гэртээ байна уу? Би эзэгтэйн захиалгыг авах гэсэн юм. Би өнөө шөнийн галт тэргээр буцах ёстой гэж учирлав.

- Та жаахан хүлээхгүй юү. Таныг хэн гэж танилцуулах вэ? гэхэд Сувдаа гар цүнхээ уудалснаа,

- Гирингээс яваа гэж хэлбэл өөрөө мэднэ. Би нэрийнхээ хуудсыг орхичихсон байна гэлээ. Захиалгын газрын залууг яваад удаагүй байтал Аяанаосу өрөөнд орж ирлээ. Түүний араас үйлчлэгч залуу дагажээ.

- Окусан (хатагтай) таны амрыг эрье. Таны захиалгыг мартаад явуулчих вий гэж бодоод буудал руу чинь утасдах гэж байсан юм. Таныг өнөө шөнө буцна гэдгийг мэдээд захиалгын газрыг хаалгүй хүлээсэн юм гээд үйлчлэгч залуу руу эргэж,

- Ажил төрлөө зохицуул даа гэхэд өнөө залуу өрөөнөөс гарлаа. Үйлчлэгчийг гарсны дараа Аяанаосу, Сувдааг зэргэлдээх өрөө рүү оруулж ажил төрлөө ярилцав.

- Ажил минь тун бүтэмжтэй. Төвөөс холбоочин ирсэн. Харбинд суурьших ёстой. Сарын

дараа болзоот газраа очиж уулзах болно. Квантуны арми, Халх голын сав нутгийг нарийвчлан судалж, байр зүйн зурагт шаардлагатай материал цуглуулах төлөвлөгөөтэй байна. Энэ ажлыг Еоши толгойлох төлөвтэй. Халх голын Номон Хан, Бүрд-Овооны чиглэлд байдаг Жанжин сүм, Мөст сүмүүдийг цэргийн хуаран болгох, ойр хавийн нь айлуудыг нүүлгэх тухай квантуны армийн тусгай шийдвэр гарсан. Квантуны армийн тагнуулынхан Халх голын хуучин нутаг хошууны зургийг «Элээ» гэдэг хочтой туршуулаар дамжуулж олсон байна. Тэр туршуул Тамсаг хавьд барагцаалбал Булан шавар гэдэг газраар нутагладаг сурагтай. Тэр туршуул хуучин Тамсагийн хийд дээр сууж байсан лам хүн юм. Тэр лам, Да ванг дагаж Баргад ирэхдээ японы тагнуулынхантай холбоо тогтоож, даалгавар аваад буцсан юм гээд Сувдаа зургаа нугалж эвхсэн газрын зураг гаргаж Аяанаосугийн ширээн дээр дэлгэв. Ногоон, хар, хөх, хүрэн будгаар өнгө ялган зурсан газар орны байдал, гол мөрөн, нуур тойром, хилийн овоонуудыг ажиглаж байсан Аяанаосу,

- Сэцэн хан аймгийн илдэн ван Доржпаламын хошууны зураг гэж уншаад зургийн зүүн захад бичсэн бичиг рүү харцаа шилжүүлж, Бадруулалт төрийн 33 дугаар он (1907) гэж уншаад Сувдаа руу баярлаж инээмсэглэсэн нүдээр ширтэнэ.

- Сувдаа энэ чинь маш чухал зураг байна. Би эндхийн хэдэн дарга нартай уулзаж ярилцахад армийнхан хойтон жилээс монголын асуудал руу орох нь илэрхий болсон. Багтай баримтаар бол армийнхан Халх, Хайлааст голын сав, Баян Цагааны нурууг анхааралдаа авсан нь эргэлзээгүй. Үүнийг Жанжин сүмийн асуудалтай уялдуулбал Номон Хан, Бүрд-Овооны чиглэлийг чухалчилж байгаа нь илэрхий байна. Энэ талаар чамд мэдэж сонссон юм бий юу?

- Японы армийн жанжин штаб, алс дорнод руу чиглүүлсэн «ОЦУ» гэдэг төлөвлөгөөний дагуу Солонгост байгаа дивизүүдийг Хасан нуурын чиглэлд хөдөлгөж магадгүй байгаа. Квантуны арми, Зөвлөлтийн алс дорнод руу хандуулсан ажиллагаандаа түшиглэж, Халх голын асуудлыг сонирхож байгаа. Тиймээс Хасан нуур, Халх голын ажиллагаа өөр хоорондоо ямар холбоотойг тодруулсан цагт армийн ажиллагаа Халх гол руу чиглэх цаг хугацааг нарийн тогтоох сэжим болж өгнө гэж үзэж байна. Иймээс та, өөрийнхөө шугамаар энэ бүхнийг шалгах нь чухал гэснээр Сувдаа, Аяанаосу хоёрын албаны яриа дууслаа. Сувдаа цагаа хараад хэдэн мөч үлдсэнийг мэдэнгүүт Аяанаосугийн дэргэд жаахан суумаар санагдаж, сэтгэл нь дэнсэлж байлаа. Сувдаа, Аяанаосугийнхаас гарангуут тэдний холбоо тасарна гэдгийг юунаас ч илүү ойлгож байв. Учир нь үүнээс хойш Аяанаосу, төвийн холбоочинтой ажиллах ёстой билээ.

- Сувдаа, би чамайг, нэг хүнтэй танилцуулах ёстой. Энэ бол төвөөс ирсэн даалгавар гэхэд Сувдаа толгой дохин зөвшөөрлөө.

Аяанаосу, энэ өдөр ер бусын баяр баясгалантай байлаа. Тэрээр энэ өдрөөс хойш Сувдаатай дахин уулзахгүй гэдгээ гадарлаагүй юм шиг санагдах учир Сувдаагийн сэтгэлд нэг л хачин, өрөвдөлтэй болой.

Сувдаа, Аяанаосуг дагаж хоёр давхар байшингийн нэгэн өрөөнд оронгуутаа европ хувцас өмссөн Хасу Тоишийг хараад зогтусан зогсонгуутаа Аяанаосу руу гайхсан нүдээр ширтэв. Сувдаа дүүтэйгээ чингэж уулзана гэж санасангүй. Сувдаа өмнөө зогсож байгаа дүүгээ хараад нүдэнд нь нулимс өөрийн эрхгүй цийлэгнэж буйг ойлгов. Хасу Тоиши Сувдаагийн нүдэнд

нулимс гүйлэгнэхийг ажаад суудлаасаа өндийнгүүт амандаа «Эгч минь» гэж шивнэв. Тэрээр эгч рүүгээ алхсан боловч хөл нь хөшчихсөн юм шиг санагдаад хөдөлж өгөхгүй байв. Чухам энэхэн үед өрөөнд нэгэн бага дарга орж ирлээ.

- Бага дэслэгчээ юу болоо вэ? гэж Хасу Тоишийг асуутал тэрээр,

- Сафроновын гурван хүн гудамжинд үзэгдээд цаг шахам болж байна. Би Сафроновын туслахтай утсаар ярьж сураглалат «Мүгдэнгээс ирсэн нэг япон ахмадтай хамт гарсан» гэж байна. Миний бодлоор бол тэр хоёр ингэххийгээд энд орж ирнэ. Сафроновын нэг туршуул Аяанаосу таныг ажиглаад байдаг болсон. Тэр туршуул гудамжинд байгаа. Ингэхээр Сафронов хэнийг сонирхож байгаа нь тодорхой гэлээ.

- За тэгвэл байдлаа өөрчлөхөөс дөө. Тэгээд Сафронов япон даргатайгаа ирвэл зочдын өрөөнд хүндэтгэн хүлээж авъя. Ер нь ийм юм болж магадгүй гэж бодож байсан юм. Ингэхээр бага дэслэгч та, энэ эмэгтэйтэй хамт нууц хаалгаар гарч буудалд хүргэж өг. Тэгэхдээ хэнд ч мэдэгдэж болохгүй. Манай доод зоорь нөгөө талынхаа байшинтай урт хонгилоор холбогддог юм. Та тэр хонгилоор яваад нэг хаалганд тулна. Түүнийг энэ түлхүүрээр онгойлгоорой гээд халааснаасаа хоёр түлхүүр гаргаж өгөв.

Сувдаа бага дэслэгч хоёрыг доод зоорь руу орсны дараахан хаалга цохих чимээ тодоос тод сонсогдлоо. Гэтэл Аяанаосугийн туслах зэргэлдээх өрөөнөөс орж ирлээ. Аяанаосу үйлчлэгчтэйгээ уулзангуут,

- Хаалга тайлж өгөөд гийчдийг зочдын өрөөнд оруулаарай.

Харин нөгөө хоёр хатагтай бий биз гэлээ.

- Аяанаосу сан, тэд таныг хаачсан юм бэ? Хүн урьчихаад алга болчихдог хэнэггүй хүн шүү гээд байсан. Би таныг гадагшаа гарсан одоохон ирнэ гэсэн. Одоо тэд хөзрөөр тоглож байгаа гэлээ.

- Бид хоёр тэдэн дээр очно. Гийчдийг тийш нь оруулаарай гээд Аяанаосу Хасу Тоишийг дагуулж зочдын өрөө рүү чиглэв.

Уужим өрөөний голд зассан ширээний хоёр талд бие биен рүүгээ харан суусан хоёр эмэгтэй хөзөр тоглож буйг харсан Хасу Тоиши, Модрен буудлын үйлчлэгч бүсгүйчүүд гэдгийг төвөггүй мэдлээ.

- Хүүхнүүд ээ, та хоёр их уйдав уу? Ингэж их хүлээлгэснийг минь уучлаарай. Гуйхад гомдож л болохгүй шүү, гээд Аяанаосу ширээн дээрээс сакэ авч хундагалав. Тэд эхнийхээ хундагыг дөнгөж өргөн байтал Сафронов, Ёоши хоёр орж ирлээ. Аяанаосу тэднийг баяр баясгалантай угтан авч,

- Сайн хүн санаагаараа гэж үнэн юм даа. Ноён хурандаа наашаа суу. Хувцсаа хөнгөл гэж хэлээд зориуд зогсохыг ажвал нэлээн халамцуу гэмээр харагдана.

- Аяанаосу сан, бид албаны хэргээр явж байгаа болохоор та бүхний ая тухыг алдуулчих шиг боллоо. Бид танай байшинд орсон нэг эмэгтэйг сонирхсон юм гэж Ёошиг хэлэхэд Модрен буудлын үйлчлэгчийн нэг нь,

- Та и Ёоши сан, та наашаа суугаач гэж урилгахан хэлэхийг ажвал ахмадыг сайн таньдаг бололтой.

- Тэгвэл та хоёрын хайж яваа тэр эмэгтэй манайд байхгүй юм шив дээ. Нууц юм биш бол хэнийг сонирхсон юм бэ? гэж Аяанаосу согтуу хүн шиг хэл амаа хазах шахан асуулаа.

- Мүгдэнгээс яваа Сувдаа гэдэг эмэгтэйг Хато сан сураглаад байгаа юм гэж Сафроновыг хэлэхэд Ёоши тэдний ярианд оролцож,

- Генерал маргааш өглөө Хайлар руу дагуулж явах тул Сувдаад хэл дуулга гэж тушаалаа. Дам сураг дуулбал морин тэргэнд суугаад танай байшинд ирсэн бололтой гэтэл Ёошигийн танил бүсгүй,

- Та и (ахмадаа) бид хоёр түрүүхэн морин тэргээр энд ирсэн шүү. Бүүр тодорхой хэлбэл энд орж ирээд хориод мөч болчихлоо гэж хэдийд ирснээ нотлон айлдлаа.

- За ноёд, хатагтай нараа. Биднийг уучлаарай гэхэд Аяанаосу,

- Учраа ололцсоноос хойш та хоёр дээшээ суу. Жаахан наргицгаая гээд ширээнд урилаа.

- Аяанаосу сан, бид ажилтай тул та бүхний наргианд оролцож чадахгүй нь гээд Сафронов өрөөнөөс гарахаар шийдэв. Ингэхээс өөр замгүй байлаа. Учир нь Хасу Тоишигийн дэргэд Аяанаосугийнд үзлэг хийх нь ёс зүйд таарахгүй. Түүгээр үл барам Хатогийн нэрийг барин санамсаргүй худлаа хэлсэндээ багагүй бантлаа. Учир нь генерал Хато, Хайлар Манжуур өртөөнд байгаа японы цэргийн төлөөлөгчдийн тэргүүн нартай уулзаж, ар монголын хил рүү явуулах өдөөн хатгалгын талаар ярилцах тул энгийн хүмүүсийн дэргэд албаны нууц дэлгэсэн хэрэгт ороолдож болох эгзэгтэй ажээ. Энэ хэргээс мултрахын тул Хатогийн аяыг олж ятгах хэрэгтэй гэдгийг Еоши, Сафронов хоёрын хэн хэн нь ойлгож байв. Тиймээс Сувдааг генералтай хамт Хайлар руу явуулаад тэндээс Мөст орох замыг юм уу эсвэл Халуун рашаан дайрч Вангийн сүм орох замыг отож, Тозияагийн даалгаврыг хэрэгжүүлэх нь тохиромжтой гэж үзлээ. Чингээд Еоши, генералтай уулзаж, Сувдааг дагуулж явахыг ятгахаар шийдэж үг бүрээ цэнэж үзлээ.

Аяанаосу, төвөөс өгсөн үүргийн дагуу эгч дүү хоёрыг уулзуулаад учир байдлыг зохих хэмжээнд нь тайлбарлаж өгөх ёстой байсан. Нэг эцгийн хүүхдүүд уулзсан боловч сэтгэл санааныхаа үгийг ярьж амжсангүй. Тиймээс Хасу Тоиши, шөнөжингөө амьдрал ахуйгаа бодож эгчийнхээ тухай Аяанаосугаас сонссоноо эргэцүүлнэ.

... Сафронов яагаад Сувдааг сонирхсон бэ? Энэ талаар Еоши зааварласан хэрэг үү? Тэгээд ч зогссонгүй. Еоши, Сафроновын хөдөлгөөн бүрийг хянаж, ажиглаж байгаа хэрэг. Ер нь Сафроновтой уулзаж ярилцъя. Хурандаа эгчийн сургийг эхэлж гаргасан хүн! Тиймээс түүнтэй уулзаж ярилцах нь чухал. Одоо утсаар ярих уу?

Болохгүй. Еоши Сафроновын ажиллагааг хянаж байгаа бол өдийд утасны яриа сонсох нүхээ бэлдчихсэн. Еоши ийм ажиллагаа боловсруулж чадсан бол бусдын яриа сонсох зөвшөөрөл авсан байх ёстой. Еошид утасны яриа сонсох зөвшөөрлийг хэн өгөх вэ? Хатогоос уу? Эсвэл Тозияагаас уу? Бүрэн эрхийнхээ дагуу ийм даалгаврыг Тозияа өгөх ёстой. Тэгвэл Сувдааг хянах ажлыг Тозияа, Еошид өгсөн байх ёстой! Эд яагаад Сувдааг хянах болсон бэ?...

Хасу Тоиши, ингэж өөрөөсөө асуусан боловч ямар ч хариу өгч чадсангүй. Тэгээд шөнөжингөө эргэцүүлж бодохдоо «Хэрээ» хочтой туршуултай ярилцсанаа санав.

...Цэен гүн... түүний охин Юки шүү дээ. Ингэхээр Юки бид нар төрөл садангууд гэдэг илэрхий. Тозияа бидний төрөл садангийн холбоог бүрмөсөн таслахаар шийдсэн хэрэг үү? Сувдаа энэ талаар Юкид дуулгасныг мэдсэн Тозияа, төрөл садангийнхаа талаар бүдэг бадаг ойлголттой байгаа Юкигээс Сувдааг холдуулахыг эрхэмлэсэн хэрэг үү? Тэгвэл Сувдааг устгах ганц арга бий. Юки төрөл садангийнхаа холбоог нарийн мэдвэл Тозияагийн цаашдын ажил төрөлд багагүй нөлөөтэй. Тиймээс Тозияа, энэ хоёрын холбоог таслах аргыг нарийн боловсруулсан байж таарна. Тозияа, Сувдааг устгаж чадвал түүний амь настай холбогдсон хэргийг Юкид энгийн зүйлээр тайлбарлаад цагаатгаж дөнгөнө шүү дээ...

Хасу Тоиши, шөнөжингөө ингэж бодоод өглөө эрт босонгуут Хато генералын туслахтай утсаар ярилаа.

- Хасу Тоиши сан, генерал цагийн дараа Хайлар руу ниснэ. Та гаргаж өгөх ёстой. Нөгөө талаар Модрен буудалд байгаа Сувдаа сан, генералыг дагаж явах ёстой. Ингэхээр та, тэр эмэгтэйг буудлаас авч, онгоцны буудал дээр очих нь дээр биз. Уг нь надад үүрэг өгсөн юм. Гэтэл би, генералын юмыг бэлдэх гэж бажгадаад байна. Тэгээд таныг Сувдаа руу явуулья гэж бодлоо. Та дургүйцэхгүй биз дээ.

- Сафронов, намайг сураглав уу? гэж Хасу Тоишийг асуутал,

- Үгүй шүү. Тэр чинь Ханширээ рүү явах гэж байгаа юм биш үү гэлээ.

- Олуулаа явах нь уу?

- Еошитой хоёулхнаа явах байх.

- Вангийн сүмээс Ханширээ хүртэлх төмөр замын асуудлаар хүмүүс явах ёстой. Тэгэхээр тэднийхэн явахаар болжээ дээ гэж Хасу Тоишийг хэлэхэд генералын туслах,

- Тийм байхаа. Синьзингээс тусгай галт тэрэг гарах ёстой. Тэгэхээр тэд явж таарна байх. Хамгаалалтын асуудал яригдаад байсан гэж учир явдлыг тайлбарлав.

- Би тэгээд генералтай уулзах уу? Шууд эндээсээ буудал руу очих уу?

- Хасу Тоиши сан, та буудал дээр очоод хүлээж бай! Би эндээс унаа явуулна. Та тэндээсээ Сувдааг аваад онгоцны буудал дээр очсон дээр. Би генералд энэ тухай илтгэчихье. Танд ердөө цагийн хугацаа үлдлээ шүү!

Хасу Тоиши, цагаа харвал өглөөний зургаан цаг болж байлаа. Чингээд тэр дороо хувцаслаад буудал руу очиж Сувдаатай уулзахыг яарав. Тэрээр буудалд ирэнгүүт Сувдаатай утсаар яриад буудлын үүдний өрөөнд хүлээж байгаагаа хэллээ. Хасу Тоиши, эгчээсээ хэдэн зүйл лавлахыг бодовч боломж муутай ажээ. Учир нь машин дотор Сувдаатай ярьж болохгүй. Тэгэхээр эгчтэйгээ ярих ганц боломж бол буудлын үүдний өрөөнд машин хүлээх хугацааг ашиглах ёстой аж. Хасу Тоиши, эгчтэйгээ өрөөнд нь ярьж болохгүй гэдгийг хэнээс ч илүү мэдэж байсан тул буудлын үүдний өрөөг сонгож авлаа. Тэгээд эгчийгээ хүлээж байх хооронд буудлын үүдний өрөөнд байгаа хүн бүхнийг ажиглав. Гол хаалганы дэргэд буудлын хаалгач өвгөн сууж, баруун талын ханын дагуу зассан ширээний зөөлөн сандлын нэг дээр суусан залуу эр сонин гарчиглаж байв. Хасу Тоиши, зүүн ханын дагуу зассан явган ширээний дэргэд байгаа зөөлөн суудалтай сандал дээр сууж эгчээ хүлээнэ. Чухам энэхэн мөчид Сувдаа буудлын гол шатаар бууж, дүүгийнхээ дэргэд ирэнгүүт,

- Хасчулуун минь... Дүү минь гэж шивнэх төдий хэлээд, сайн нойрсов уу? гэж асуугаад уруулаа тас жимийлээ.

- Сувдаа сан, та биеэ барь. Би таныг онгоцны буудал руу хүргэж өгнө гэхэд Сувдаа сая санаа авч,

- Хасу Тоиши сан, Хато сан таныг над руу явуулсан гэж сая утасдсан. Та ирээд их хүлээв үү? гэж чанга хэлтэл буудлын гол

хаалгаар Хатогийн жолооч орж ирж яваа харагдлаа.

- Би дөнгөж сая ирлээ. Жолооч хүрээд ирэх шиг боллоо. Та юмаа авчруулах уу? гэж Хасу Тоишийг хэлтэл Сувдаа,

- Хэрэггүй. Дээрээс үйлчлэгч нар авчирч яваа гэхэд сонин гарчиглаж суусан залуу суудлаасаа өндийж, Сувдаа руу чиглэхийг ажигласан Хасу Тоиши, түүнийг Сафроновын туршуул гэдгийг түвэггүй мэдэв. Тэрээр Сувдааг ажиглаж байсан ажээ. Сувдаагийн тээшийг үйлчлэгч нар авчирсан тул тэд буудлаас гарлаа. Гэтэл өнөө залуу, хаалгач өвгөн рүү тонгойж ямар нэг юм шивнэх шиг болоод цаашаа эргэхийг ажвал утсаар илтгэх гэж явсан бололтой. Харин хаалгач өвгөн, Хасу Тоиши, Сувдаа хоёрын сууж явах тэрэгний дугаарыг тогтоохыг хичээсэн юм шиг буудлаас гарч ирээд довжоон дээр зогсоно.

Хасу Тоиши, буудлаас гарч ирээд машинд суухдаа эгчтэйгээ хамт суусангүй. Харин жолоочийн дэргэд сууснаар Сувдаа дүүтэйгээ ярих боломжгүй болжээ. Сувдаа онгоцны буудал хүртэл нэлээд зүйлийг бодож амжлаа. Түүний гүйцэтгэх ёстой ажил бүтэмжтэй боловч Аяанаосуд сэтгэлийнхээ үгийг хэлж чадаагүй болохоор гонсгор атал сэтгэлд нь баяр баясал ээлжилнэ. Учир нь тэрээр хүсэн мөрөөдсөн дүүтэйгээ уулзсандаа баяртай. Сувдаа дүүтэйгээ шавиагаа ханатал ярьж чадаагүй ч гэсэн хацрыг нь үнсэх юмсан гэж бодно. Цэен гүн амьд ахуйдаа хол юманд явахдаа Юки, Сувдаа хоёрын хацрыг ээлжлэн үнсээд «За охидууд минь сайн сууж байгаарай. Аав нь ирэхээрээ нөгөө хацрыг чинь үнсэнэ» гэдэг сэн. Цэен гүнгийн энэ үгийг санасан Сувдаа «Одоо дүүгийнхээ баруун хацрыг үнсээд дараа уулзахдаа нөгөө хацрыг нь үнсэх юмсан. Тэгвэл муу дүү минь хичнээн их баярлах болоо» гэж бодно. Сувдаа дүүгийнхээ араас харж суухдаа «Дүү минь наашаа хардаггүй юм болов уу. Сая аавтай

тун адилхан харагдсан. Отгон хүүхэд аавтайгаа адилхан байдаг гэдэг сэн. Үнэн болов уу?» гэж бодно. Сувдаа чингэж бодохдоо эцгийнхээ царай зүсийг санаж, содон тэмдэг, мэнгийг нь үгүйлнэ. Сувдаагийн эцэг зүүн завьжиндаа жижиг хар мэнгэтэй ажээ.

Хасу Тоиши, зам ширтэж явснаа халааснаасаа тамхиа гаргаад шүдэнзээр асаах гэснээ, суудлын тэрэгний онгорхой цонхыг хаагаад,

- Сувдаа сан, тамхи татвал дургүйцэхгүй биз гэж асуугаад эгч рүүгээ эргэн харж инээмсэглэхэд зүүн хацарт нь гүн хонхорхой гарч, түүний голд тас хар мэнгэ байхыг ажиглаад Сувдаа дотроо «Яг аав биеэрээ мөн байна» гэж бодоод,

- Бололгүй яах вэ? гэлээ. Хасу Тоиши, зам ширтэн урагшаа харж суусан болохоор Сувдаа дүүгийнхээ царайг сайн харж чадалгүй явсаар онгоцны буудал хүрлээ. Чингээд Сувдаа Хатотой уулзаж, онгоцонд суугаад агаарт хөөрснөөс хойш хэдэн цагийн дараа Хайлараас зайдуухан байдаг Наньтунгийн онгоцны буудал дээр буулаа.

Хато, Хайларын удирдлагатай ярилцаад Сувдааг Ханширээ рүү хүргэх замдаа Мөстийн сүмээр дайрч, нутгийн лам нартай уулзах талаар тохиролцоод унаа гаргуулж өглөө. Чингээд Сувдаа Хайларт нэг хоноод маргааш өглөө нь Ханширээ рүү гарлаа. Харин Хайлар, Амгалангийн замаар Мөст сүм очиж болох авч тэр зам нэлээн муудсан ажээ. Хэдхэн жилийн өмнө японы армийнхан олзлогдсон хүмүүсийн хүчээр Хайлараас Ханширээ рүү дардан зам тавьсан болохоор тэр нь бартаагүй шулуун.

Сувдаа нар шингэх зүг зурагдсан дардан замыг ширтэн, хөнгөн тэрэгний арын суудал налан явахдаа дүүгийнхээ тухай бодлоо. Гэтэл түүний бодол өөрчлөгдөж, монголын хилийн ойролцоо нутагладаг барга айлуудыг нүүлгэж, зарим хошуудын сүмийг цэргийн хуаран болгож байгааг санангуут Мөст сүмийг «Яасан бол?» гэдэг бодол сэтгэлд төрнө. Сувдаа монголын хилийн ойролцоох сүм, хийдийг японы цэргийнхэн хэрхэн ашиглаж байгааг ажиглах үүрэгтэй ажээ. Тиймээс сэтгэлд нь ажил төрлийн асуудал хадаастай.

Өглөөний нарны элч нэмэгдэж, наранд халж улайдсан зам алсад зурайж, бүгчим халуун салхи Сувдаагийн нүүрийг шавхуурдана. Аустари Даймлер маягийн хөнгөн тэрэгний берзинтэн бүхээгийг буулгасан болохоор Имэн голын сэрүүн салхи сэвэлзэн сэтгэлд таатай. Жолооч, Имэн голын хойгуур зурагдсан дардан замыг дагасаар Хүйн голын гүүрээр гарангуут тэргээ зогсоолоо.

- Сувдаа сан, та бууж биеийнхээ чилээг гаргахгүй юу? Одоо дахиад гол тааралдахгүй шүү гээд жолооч машиныхаа усыг сэлбэв. Сувдааг тэрэгнээс буухад голын гүүрэн дээр байгаа цэргийн

хээрийн цагдаа нар гүүрийн хашлага түшин зогсож, Сувдааг ажиглана. Тэр гүүрээр гарсан тэрэг бүхнийг зогсоон шалгадаг атлаа Сувдаагийн сууж, яваа тэргийг зогсоож шалгаагүй болохоор удирдлагаасаа тусгай үүрэг авсан нь илэрхий болой. Жолооч машиндаа усаа сэлбээд паалантай түмпэнд ус хийгээд замынхаа тоосыг хөнгөлнө. Тэгээд цоо шинэ алчуур гаргаж усаар норгоод Сувдаад өгөхдөө,

- Сувдаа сан, та нүүрнийхээ тоосыг арчихгүй юу гэлээ. Сувдаа чийгтэй алчуураар нүүр гараа

арчаад,

- Жолоочоо наашаа суугаач. Хоёулаа жаахан юм идье гэхэд жолооч түүний дэргэд ирж суулаа. Тэгээд хээрийн аялалд зориулсан жижиг цагаан бүтээлэг дээр дэлгэсэн зуушийг харсан жолооч,

- Яасан догь вэ? Давсалсан гампу (далайн байцаа), бутаннику (гахайн мах) гэж дуу алдахад Сувдаа хээрийнхээ цүнхнээс сакэ гаргалаа. Үүнийг үзээд жолооч баярласан нүдээр Сувдаа руу хараад,

- Сувдаа сан, донна сакэ аримасука? (ямар сакэ вэ) гэж асуулаа. Чингэж үдийн хоолыг орлосон замын зуушаа дуусангуут тэд алсын замдаа хурдлав. Жолоочийг Исидо гэдэг. Тэрээр Хайлар дахь армийн төлөөлөгчийн газар тэрэг барьдаг аж.

Хүйн голоос өртөө шахам явсны дараа замаас гарч Мөст сүмийг зорилоо. Тэгээд нэлээн явж байснаа Исидо,

- Сувдаа сан, Мөст сүм тэр харагдаж байна гэлээ. Сувдаа суудлаасаа өндийж сүмийн зүг харлаа. Тэр жижиг сүмийг хааж, цэргийн хуаран болгосон эсэхийг Сувдаа мэдэх ёстой ажээ. Хийдийн жижиг хэрмэн хашаанд барилгын материал хурааж, бүтээсэн агаад цэргүүдээр мануулжээ.

- Исидо сан, энэ сүм дээр лам нар бий юү?

- Таван лам байх ёстой. Гэхдээ өчигдрөөс нүүсэн байх. Манай нэг жолооч наашаа барилгын материал зөөдөг юм. Өчигдөр уулзахад таван лам Халуун рашаан руу явсан гэж байсан.

- Энд сүм барих гэж барилгын материал авчирдаг юм уу?

- Цэргийн бэхлэлтийн барилгын материал татаж байгаа юм. Хойтон жилээс цэргийн барилга, бэхлэлтийн инженерийн ангиуд ирэх байх. Ер нь Синто ёсны сүм барих юм гэсэн. Энд чинь манай

тусгай арми ирж байрлах учраас сүм бариулна гэж манай дарга нар яриад байдаг болсон байна билээ.

- Армийнхан энэ эзгүй газар ирж хээрийн сургууль хийх юм уу. Ер нь хээрийн сургууль хийж баймаар цэлгэр газар байна шүү гэж Сувдааг хэнэггүй хэлэхэд Исидо,

- Ар монголыг улааны нөлөөнөөс тусгаарлаж, хуучин засаг төрийг нь сэргээх их ажлыг манай арми эхлэх ёстой юм гэнэлээ. Хойтон жилээс энд нэлээн юм болох байх шүү гэлээ.

Исидо, Мөст сүм очих зам дээр байсан хээрийн цагдаа нарт бүртгүүлээд цаашаа явсаар сүмийг нар бүтэн тойрлоо. Тэгээд нэг жижиг шавар байшингийн дэргэд ирж зогсоод,

- Эндхийн лам нар энэ байшинд амьдардаг байсан юмсан. Өчигдөр манай цэргүүд энд байрласан гэнэ. Би ийшээ ороод ирье. Миний хүргэн ахын дүү нь энд байгаа. Энд хүрснийх

нэг уулзчихаад явья гээд тэрэгнээсээ буулаа.

Сүмийн эргэн тойронд торон хашаа босгож дотор нь барилгын материал хураасан агаад армийн инженерийн албаны дүрэмт хувцас өмссөн бага дарга нар холхилдоно. Сувдаа торон хашаан дахь материалын байрлал, харуул манааны байрыг ой тойндоо бүртгэн тогтоож аваад сууж байтал Исидо хүрч ирлээ.

- Сувдаа сан, та уйдав уу. Таныг багагүй хүлээлгэчихлээ гэхэд,

- Энд монгол лам нар байхгүй болохоор дэмий наашаа зүглэж цаг гарзадлаа. Уг нь лам байвал нэг ерөөл авахуулаад адис хүртчихье гэж бодсон юм. Миний жил орж байгаа болохоор хол юманд явахаараа сэтгэлийнхээ сэвийг арилгуулахгүй бол санаа амардаггүй юм. Ер нь энд чинь том хот байгуулах янзтай байх чинь гэж Сувдаа ерийн байдлаар хэлэв.

- Хойтон жилээс хэд хэдэн дивиз энд ирвэл шинэ хот үүснэ гэсэн үг гээд Исидо цэргүүдийн дунд тархсан цуурхлын талаар цухуйлгалаа. Чингээд Исидо жолооныхоо ард сууж тэргээ асаалаа.

Квантуны арми, Халх гол руу цэргийн хүчээр довглох бэлтгэлээ хийж төмөр зам, засмал замын асуудлыг шийдвэрлэх бүх асуудлыг нууцалж байлаа. Гэсэн ч энэ бүхэн нь цэргүүдийн дунд илэрхий болж, байлдааны төлөвлөгөө боловсруулахад

шаардагдах судалгаа хийж байгааг цэргүүд мэддэг болсноор бодол төсөөллөө өөр хоорондоо ярих болсон. Исидо, Сувдаа хоёр ойр зуурыг хаман шимэн ярьсаар яваад Жанжин сүмийг дайрав. Тэнд цэргийн хуарангийн барилга байгууламж барьж эхэлснийг ажвал Исидогийн ярьдаг хэд хэдэн дивиз нь Жанжин сүм дээр байрлах нь дамжиггүй агаад Мөст сүм дээрх материалын бааз нь цэргийн бэхлэлт инженерийн барилга байгууламжийн зориулалттай болохыг Сувдаа түвэггүй мэджээ. Хөнгөн тэрэг Жанжин сүмээс цааш хурдалсаар засмал замдаа орж төдөлгүй Шугуйт голын эргээр гарч Хандгайтын давааг чиглэв. Дардан замын баруун гар талд цэлийсэн уужим хөндийд хоёр нуур мэлтийн харагдана. Тэр нуур, дардан замын хооронд японы цэргийн хуаран байрлажээ.

- Исидо сан, энд бас юун цэргүүд байгаа юм бэ? гэж Сувдааг асуухад,

- Цэргийн нисэх онгоцны хээрийн буудал байгуулах гэж байгаа цэргүүд байгаа юм гэлээ.

- Исидо сан, тэр харагдаж байгаа нуурыг ямар нуур гэдэг юм бэ? гэж Сувдааг эмэгтэй хүний сониучхан, шалгаамтгай байдлаар асуутал,

- Цаад талын том нуурыг Цагаан нуур гэдэг. Харин наад жижиг нуурыг Долт гэдэг юм гэж мэдэмхийрэн хариулав.

Сувдаа Хандгайтын давааг давснаас хойш Исидогоос элдэв шалдвын юм асуусангүй. Харин замынхаа явалтанд ядарч нозоорсондоо үл мэдэг зүүрмэглэсэн царай гаргаж, нүдээ дутуу анин элдвийг бодсоор Ханширээ хотод ирлээ.

Наган уулын бэлд байгаа энэ хотыг Ханчандмань, Хан-ширээ гэж нутгийнхан нэрлэхийн зэрэгцээ хятадууд Таосо гэж нэрлэдэг болой. Их Хянганы нурууны давчуу хавцлыг бараадуулж тавьсан төмөр замын энэ өртөө хотхонг Япончууд сонирхож Халуун рашаан хотоос төмөр зам тавьж 1935 онд ашиглалтанд оруулснаар нутгийн хятадууд бөөгнөрсөн жижиг тосгон төмөр замын өртөө хот болсон билээ. Наган уулын хөндийг уруудсан Хандгайт гол монголын хил хүрч, Нөмрөгийн голын Цагаан арал хавиар Халх голд цутгана. Хандгайт голын дагуу ногоо тарьсан агаад тэр ногооны захаас Монголын хил хүртэл зургаан бээрийн зайтай. Ногооны талбайгаас төдий холгүй монголын хилийн Хараат уул дүнхийнэ. Исидо, Ханширээгийн төмөр замын буудлын гадаа ирэнгүүт машинаа зогсоогоод

- Сувдаа сан, би зам явах пиу аваад ирэх үү? гэлээ.

- Зүгээр. Би өөрөө авна. Хоёулаа буудал руу оръё гээд Сувдаа машинаас буулаа. Хянганы сүрлэг нурууны өндөр уулс бүхий энэ хөндийд байгуулсан багахан хотын төмөр замыг уржнан ашиглалтанд оруулсан болохоор буудлын барилга нь тохилог болой. Сувдаа, Исидо хоёрыг буудалд орж ирэхэд хүн цөөн байлаа. Буудлын их танхимд байгаа хүмүүсийг ажвал ихэнх нь цэргийн хүмүүс ажээ.

Сувдаа галт тэргэнд суух пиу олгодог жижиг цонхны дэргэд очоод Ханширээгээс Вангийн сүм хүртэлх пиу авахдаа Хайларын цэргийн төлөөлөгчийн газраас хийж өгсөн бичгийг үзүүлтэл, хижээлдүү насны нэг хятад Сувдаа руу сүрхий хараад пиуг нь тэр дороо бичиж өглөө.

Сувдааг пиу авсны дараа Исидо, эртхэн зам дөхөхдөө,

- Сувдаа сан, таныг би гаргаж өгөх үү дээ гэхэд Сувдаа,

- Исидо, чи эртхэн зам дөхсөн дээр. Галт тэрэг мөд явахгүй бол оройтож орхино гээд Исидотой салах ёс гүйцэтгэлээ. Сувдаа, Исидоог явсны дараа буудлын гол танхимын хаалганаас холгүй байгаа нэгэн вандан сандал дээр суулаа. Буудалд цэргийн дарга нараас гадна төмөр замын ажилчид хөлхөнө. Японы хээрийн цагдаагийнхан буудалд орж ирээд зарим хүмүүсийн үнэмлэх бичгийг шалгах авч Сувдааг үл шалгахыг ажваас тэд зөвхөн цэргийнхнийг шалгах үүрэгтэй бололтой. Тэдний дэргэдүүр япон дарга нарын гар тээшийг зөөсөн үйлчлэгч нар холхилдон, зарим нь цонхны дэргэд хий зогсох тул энгэрийн нь тэмдэг тод харагдана. Тийм тэмдэгтэй хүмүүсээр япон дарга нар ачаа тээшээ зөөлгөх ёстой ажээ. Сувдаа авч явсан чемоданаа газар тавиад вандан сандлын түшлэг налан сууж байтал гар тээш зөөгч нэгэн залуу хүрч ирээд,

- Сувдаа сан, таны тээшийг вагонд оруулж өгөх үү? Галт тэрэг ингэсхийгээд хөдөлнө шүү гэж барга аялгуугаар хэлээд чемоданыг авахад,

- Хэрэггүй. Би өөрөө авч орно гэхэд өнөө залуу, шалан дээрээс хөндийрүүлсэн чемоданыг буцаан тавихдаа нэгэн зурвас

үлдээсэн нь чемодан Сувдаа хоёрын хооронд унав. Сувдаа залууг холдонгуут цүнхнээсээ алчуур гаргах зуур зам явах пиугаа унагаад авахдаа өнөө бичгийг авч алгандаа атгахдаа «Энэ

залуу яахаараа миний нэрийг мэддэг байна. Энд намайг таних хүн ганц ч байхгүй» гэж бодлоо.

Сувдааг буудалд орж ирээд хориод мөч болж байхад дунд зэргийн нуруутай туранхай шаргалдуу царайндаа зохисон ширвээ сахалтай эрлийз байрын залуу орж ирээд буудлын их танхимд байгаа хүмүүсийг толгой дараалан ажиглаад хаалганы дэргэд буй вандан сандал дээр суухыг ажвал тэрээр Сафроновын туршуул «Цагаач» хочит байлаа.

Сувдааг генералтай хамт явуулах талаар Сафронов, Еоши хоёр багагүй чармайлт гаргасны адилаар түүний халуун мөрийг мөшгих явдал бас багагүйхэн чирэгдэлтэй учирчээ. Сувдаа, Хато хоёрыг Хайлар руу явсны дараа Еоши, Тозияатай утсаар ярьж, болсон байдлыг илтгээд Харбингийн цэргийн нисэхийнхэнтэй яриулж тусгай онгоцоор Синьзин руу нисэж билээ. Тэр хоёр чингэж нисэхийн өмнө «Цагаачийг» Сувдаагийн араас явуулж, Хайларын хээрийн цагдаагийн тусгай газарт үүрэг өгүүлсэн аж. Цагаач Еошигийн даалгавраар Хайларт ирэнгүүтээ цагдаагийн газрын даргатай уулзаж, нэгэн бага даргыг бараа болгон олж Сувдаагийн араас хөдөлжээ. Харин Сафронов, Еоши хоёр Синьзингээс Халуун рашаан хотод ирээд Ханширээгийн цэргийн цагдаагийнхантай утсаар яриад «Цагаачийн» ажилд туслахыг үүрэг болгосны дараа утсаар мэдэгдэж байхыг даалгажээ. Цагаач Ханширээгээс Халуун рашаан хүртэлх зам зуур Сувдааг устгах ёстой бөгөөд хэрэг төвөг дэгдсэн үед «Цагаачийг» барихаар оролдсон аливаа ажиллагаанд саад хийхийг цагдаагийнханд үүрэг болгосон байлаа.

Цагаач хочит туршуул Сувдаагийн барааг олж харангуут царайгаа буруулахын тулд буруу харан суусан агаад Сувдааг буудлаас гарахыг хүлээж байлаа. Харин энэхэн үед «Цагаачтай» хамт ирсэн бага дарга, цагдаагийнхантай уулзаж, галт тэргэнд гарч болох хэрэг түвэг, үймээний талаар урьдчилан ярилцаж ажлаа хуваарилж байв.

Сувдаа хүмүүсийн байр байдлыг ажиглан суухдаа газраас авсан өнөө бичгээ алган доороо задлан уншаад гайхлаа.

...Сувдаад. Барга залуугийн заавраар ажлаа зохицуул. Рожусай...

Сувдаагаас өөр хэн ч мэдэх ёсгүй энэ нэрийг уншаад Сувдаа сэрхийн цочлоо. Тэгээд хянуур ажиллах ёстойгоо мэдэнгүүт өнөө бичгийн үгийн дэс дарааллыг шалгав. Рожусайн бичигт байгаа дараалсан гурван цэгийг харангуут Сувдаа барга залуугийн удирдамжаар дараагийнхаа ажлыг зохицуулах ёстойг ойлгов.

Галт тэрэг хөдлөх дохио өгсөн болохоор Сувдаа буудлаас гарлаа. Тэрээр яаруухан алхсаар вагонд ойртов. Тэгээд тэрэгний цувааны эхнээс хоёр дахь вагонд орж суусан тэрхэн үед «Цагаач» хочит гурав дахь вагон руу орлоо.

Галт тэрэг алгуурхан хөдөлж хурдаа нэмсээр Ханширээгээс холгүй байгаа Ирэси өртөөг чиглэн хурдалсаар цаг шахам болж байхад Халуун рашаан хотын галт тэрэгний буудлын ерөнхий жижүүр, Халуун рашаан хотын япон цэргийн хээрийн цагдаагийн газар руу утасдаж илтгэхдээ «Ханширээгээс гарсан галт тэрэг Халахэ голын тохой руу онхолдлоо» гэж мэдэгдлээ. Халуун рашаан хотын цагдаагийн газрын дарга энэ мэдээг дуулангуут хотын цэргийн буудалд буусан тусгай төлөөлөгч Сафронов, Ёоши хоёрын өрөөнд орж ирлээ. Ёоши,

цагдаагийн газрын даргын царайг ажиглангуутаа,

- Та и (ахмад аа) ямаршуухан мэдээтэй ирэв дээ гэж омогтой асуухад ахмад хэсэгхэн түгдэрснээ,

- Ханширээгээр гарсан галт тэрэг онхолдсон байна гээд халааснаасаа алчуур гаргаж духаараа чийхарсан хөлсөө арчаад эг маг ээрлээ. Ёоши, Сафронов руу сүрхий харснаа,

- Энэ юу болж байна. Цаад маанагууд чннь юу хийж байгаа нь энэ вэ? Тэд чинь ганцхан Сувдааг цааш харуулах ёстойгоос галт тэргийг онхолдуулах даалгаваргүй шүү дээ гэж хахир зэвүүн дуугаар хашгиран хэлэхэд Сафронов сандал дээрээсээ ухасхийн босож ширээн дээрх малгайгаа шүүрэн аваад өрөөнөөс гарлаа.

ХОЁРДУГААР БОТЬ

Нэгдүгээр бүлэг

Анхны сүйрэл

Нэг. Хаяагаа хадарсан муу санаа

Тозияа сан, галт тэрэгний талаар надад тодорхой илтгэх хэрэгтэй. Санасан төсөөлөл бүхэн баримтаар нотлогдсон байх ёстой гэдгийг анхаараарай! Армийн удирдах хүмүүсийн сонссон яриагаар бол эргэлзмээр зүйл их гарч байна. Энэ бүхнийг ул мөртэй шийдэхгүй бол та бид эвгүйхэн занганд орж мэднэ. Ер нь төмөр замын гэнэтийн сүйрэл үү? Эсвэл Хянганд бүгсэн нутгийн мухар толгойтнуудын гараар үйлдэгдсэн хорлон сүйтгэх ялт ажиллагаа юу гэдгийг тогтоох ёстой.

Галт тэрэгний сүйрэлд өртсөн манай дарга нарын эх эцэг, ах дүү нар газар дээр нь очиж санал гаргаж, сайд нарын танхимд асуудал болгосон байна. Тиймээс надад яг үнэн баримт хэрэгтэй! Тозияа сан... Та миний үгийг сонсож байна уу? Яагаад дуугүй болчихов оо?

Тозияа, жанжин штабын нөлөө бүхий удирдах ажилтантай утсаар ярихдаа Яматогийн хөвгүүдийн бусидо ёсонд үнэнч самурайн горим дэглэмийг сахиж, ганц үг дуугаралгүй чагнана. Харин хааяа «Мэдлээ... Эрхэм дээдсээ ойлголоо» гэхээс цаашгүй.

Тозияа утсаа тавихдаа гүнээ санаа алдаж, гэнэт түгшсэн сэтгэлээ тайвшруулахыг хичээн халааснаасаа янжуур гаргаж асаах зуураа "Энэ ч яггүй даалгавар байна даа. Ингэхээр одоо яах вэ? Ямар ч гэсэн илтгэл бичих ёстой. Харин армийн удирдлагын зөвшөөрөлгүйгээр Сувдааг мөрдөж эцэст нь хүүрийг нь олоогүй хэргээс яаж мултрах вэ? Хато... өгөр новшийн ятгалгаар түүний шавь нар жанжин штабт ховлосон байж таарна. Тэр лүд өөрийнхөө турсагыг аврахын тулд намайг урдаа барьж байгаа нь илэрхий! Ингэхгүй бол тэр хог Сувдаагийн асуудалд ороолдох ёстой. Хашир хөгшин гэсэндээ өөрийгөө аятайхан аварчихсан бололтой. Тэгэхлээр би одоо яах ёстой вэ?" гэж бодно.

Тозияа, хэл ам таталсан энэ хэргээс өөрийгөө сугалахын тулд болсон хэрэг явдалтай дахин танилцаж, сайн тунгаах шаардлагатай гэдгийг хэнээр ч хэлүүлэлтгүй ойлгоно. Учир иймээс сонссон, үзсэн, харсан бүхнийг нэгд нэгэнгүй эргэцүүлэн бодож ашигтай эгзэг бүрийг олж санах хэрэгтэй.

...Ёошигийн сэдсэн ажиллагаа тухайн үед санасан ёсоор бүтэмжтэй байсан. Гэтэл галт тэрэг Ханширээгээс хөдлөөд цаг шахам болсны дараа Сафронов тэр хоёрыг түгшээсэн мэдээ иржээ. Галт тэрэг Ханан гэдэг уулын ёроолоор урсдаг гол руу онхолдсон байлаа.

Ёоши, Сафронов хоёр тэр машинаар Ирэси рүү хөдөлж Хянгану нурууны сүрлэг уулсын бэлээр зурагсан дардан замаар хурдуулсан юм. Тэр хоёрыг галт тэрэг онхолдсон газар ирэхэд шөнө болчихсон байлаа. Харин Ханширээгээс ирсэн зохих албаны хүмүүс, сүйрлийн шалтгааныг шалгахад нөлөөлөх бүхнийг хийсэн байв. Ёоши, Сафронов хоёр тэдгээрийн хийсэн шалгалтанд өртөхөөргүй зүйлийг ажиглан сэтгэлдээ эргэцүүлэн бодож байжээ. Ёошигийн сэтгэлд Сувдаагийн үхдэлийг олж нүдээрээ үзэх ёстой байсны адилаар Сафронов,

«Цагаач» хочтой туршуулынхаа хүүрийг олж харах нь юу юунаас ч илүү чухал байсныг хэн яахан мэдэх билээ.

Тозияагаас тусгай даалгавар авсан хоёр хашир маргааш үүр хаяармагц галт тэрэг онхолдсон газар дахин очлоо. Тэд голын хоёр талын эрэг, арал тохой бүрийг нэгжиж, монголын хил хүртэл нягтлан шалгахдаа нэгэн жижиг арал дээр хаягдсан «Цагаачийн» үхдэл, Хайларын цагдаагийн газрын бага даргын хүүрийг олсон. Вагонд сууж явсан зарим дарга нарын хүүр олдсонгүй. Харбин, Хайлар, Синьзингээс очсон төмөр замын мэргэжилтэнгүүд галт тэрэг онхолдсон учир шалтгааныг хоёр хоногийн дараа тогтоон тодорхойлжээ.

Галт тэрэгний хурдыг хэтрүүлж, огцом эргэлттэй газар хурдаа хасаж амжаагүй болохоор галт тэрэгний дугуйны ховилгүй тал, огцом эргэлтийн хүчний нөлөөгөөр зам төмрөөсөө мултарсан аж. Нөгөө талаар замын дэр модны чигжээс гурван зуугаад алхам газар суларч, далангийн шороо суултанд орсноос олон дэр мод гулссан төдийгүй зарим дэр модны хадаасны толгой сугарсан байжээ.

Долоо хоногийн дараа гол руу живсэн вагоны сэгийг гаргахад вагонд няц даруулаад тэр гэх тэмдэггүй болсон үхдэл олноороо олджээ. Усанд олон хоног байсан үхдэлийг шинжин тодруулах ямар ч боломж байсангүй...

Тозияа бүхнийг хэдэнтээ тунгаан бодсоны дараа Ёошитой утсаар ярилаа.

- Ёоши сан, галт тэрэгний ослыг жанжин штабаас сонирхож, ер бусын зүйл гэж сэрдэж байна. Хайнга хандвал жанжин штабаас тусгай хүмүүс ирж магадгүй. Чи төмөр замын мэргэжилтнүүдийн гаргасан тодорхойлолтыг юу гэж үзэж байна?

- Гакка (эрхэм дээдсээ), Сафроновын хүмүүс болон Халуун рашаан, Ирэси дэх манай хүмүүсийн гаргасан тодорхойлолтоос үзвэл ноднин жилээс хойш орон нутгийн мухар толгойтнууд тэр хавиар эргэлдэхээ больсон нь нотлогдсон. Ингэхээр хорлон сүйтгэх ажиллагааны уршиг гэж үзэхэд эргэлзээтэй. Нөгөө талаар энэ асуудлыг мухар толгойтнуудтай холбовол ямаршуухан дүгнэлтэнд хүрэх вэ? гэдгийг бодох хэрэгтэй! Ялангуяа Их Хянганы нуруунд бүгсэн мухар толгойтны хорлон сүйтгэх ажиллагааг квантуны армийн сул талтай холбож болохыг санах хэрэгтэй.

Тэгэхээр энэ асуудлыг мухар толгойтны гараар үйлдэгдсэн гэвэл квантуны армийн нэр сүрэнд муугаар нөлөөлж, армийн хээрийн цагдаагийнхныг юу ч хийдэггүй гэсэн ойлголтонд хүргэнэ.

- Ёоши тэгвэл төмөр замынхны олхиогүй байдлаас болсон гэдгийг батлах ноцтой баримт чамд байна уу?

- Тийм баримт гаргаж болно. Ханширээгийн төмөр зам ашиглалтанд ороод гурван жил гаруйхан болж байгаа боловч энэ хугацаанд далан шороо, дэр модны чигжээсийг сайн сэлбэн засаж байсангүй. Сүйрэл гарсан газрын далангийн шороо голд хэтэрхий ойрхон учраас ноднингийн үерт нэлээн эвдэрч муудсаныг төмөр замынхан хайхраагүй байна.

Тозияа, Ёошитой ярилцсаны дараа Сафроновыг Харбинаас дуудахаар шийдлээ. Тэрээр Иван Степановичоос гурван зүйл тодруулахыг хичээжээ. Юуны өмнө "Цагаач" хочит Сувдаагийн талаар ямар баримт цуглуулсантай танилцаж, түүнийг өөртөө авахаар шийдэв. Нөгөө талаар Аяанасугийн талаар нарийн судалгаа гаргуулж "Ар монголын ажиллагаанд" ашиглах боломжтой эсэхийг туршин үзэхэд холбогдолтой тодорхойлолт гаргуулах нь чухал зүйлийн нэг байлаа. Эцэст нь Хасу Тоиши, Сувдаагийн талаар ямаршуухан сэтгэгдэлтэй байсныг тодруулж, түүний гаргасан бодол санаанд түшиглэж, армийн тагнуулын газрын баримтыг нарийвчлан тулгаж үзээд өөрийнхөө шийдийг гаргах ёстой байв.

Үнэндээ Сувдаагийн хүүр олдоогүй явдал Тозияагийн сэтгэлийг яггүй түгшээсэн. Тэрээр Сувдаагийн дээл хувцасны тасархайг олж хараагүй цагт түүнийг үхсэн гэдэгт итгэхгүй аж. Тозияа баримт мэдээгээ нарийвчлан тулгасны дараа өөртөө дүгнэлт хийж, "Би дэндүү хаширлаад ойр хавиа сэрдээд байна уу" гэж өөрөөсөө асуудаг болжээ. Тэрээр янжуураа уугиулж суухдаа энэ бүхнийг тунгаагаад «Сэрдэнэ гэдэг бол муу санаа биш. Энэ бол сэрэмжтэй байхад зайлшгүй шаардлагатай сэтгэхүйн дадал зуршил» гэж үзээд

өөрийнхөө бодлыг гүнзгийрүүлнэ. Тозияа өрөөндөө ганцаараа ийнхүү эрт эдүгээг харьцуулж сууснаа цэргийн төлөөлөгчдийн газар руу угасдаж Сафроновыг яаралтай дуудахыг үүрэг болгов. Чингээд үдийнхээ хоолыг зооглохоор хоолны өрөө рүү сажлав. Тозияа хоолны өрөөнд орж ирэнгүүтээ Юкийг орж ирээгүйг мэдэнгүүт «Өнөөдөр бас хоолондоо орж ирэхгүй нь дээ" гэж өөртөө анхааруулсан янзтай үглэв.

Сувдааг амь эрсэдсэний дараа Юки өдөржингөө бодлогоширч, өрөөнөөсөө толгойгоо цухуйлгадаггүй боллоо. Тозияа энэ бүхнийг ажаад Юкигийн сэтгэлийг тайвшруулахыг хичээхдээ төлөөлөгчийн газраас хэдэн бүсгүй авчирч гэрт нь үйлчлүүлсэн боловч тэдний хэн нь ч Юкигийн уй гашуудлыг тайтгаруулж чадсангүй. Харин Халхаас ирсэн бурханч гэгддэг Ойдов Юкигийн хоол цайг өрөөнд нь оруулж өгнө.

Чингээд гэр оронд нь урьдын баяр баясалгүй болж дүнсийнэ. Тозияа хоолны ширээний дэргэд зогсож байхдаа "Юки, Сувдааг амь эрсэдсэн гэдэгт итгэсэн. Харин одоо яаж Юкигийн сэтгэлийг тайвшруулах вэ? Ямар ч гэсэн Сувдааг орлож чадах эмэгтэй олж бөөрөнд нь хавчуулах хэрэгтэй! Юкийд ойр дотно байдаг эмэгтэй хүн чинь хэн байх билээ" гэж өөрөөсөө асуухдаа энэ хэдэн жил ямаршуухан алдаа гаргаснаа Тозияа ойлгов. Тэрээр Юкийг япон эмэгтэйчүүдтэй ойр дотно үерхэх явдалд санаачилга гаргалгүй хайнга ханджээ. Гэхдээ Тозияа бүр арга барагдаж мухардсангүй. Түүний сэтгэлд Акасай санагдлаа.

Тозияа хоолоо зооглолгүй хэдэн мөч ганцаараа сууснаа Юкитэй уулзахаар зориглон суудлаасаа өндийлөө. Тэрээр Юкигийн өрөөнд болгоомжилж гэтсэн байдалтай орж ирээд ширээнийхээ дэргэд суугаад ном уншиж буй Юкигийн дэргэд очлоо. Тэрээр Бээжингийн монгол хэвлэлийн хорооноос хэвлэсэн эртний хятадын нэгэн түүхийг уншиж монголын удам угсаатай холбогдох баримтыг хуулж байлаа.

- Юки минь чи, ингэж удаан сууж болохгүй. Иом уншиж хэтэрхий сууснаас болоод ядаргаанд орчихвол хэцүү шүү. Одоо биеэ бодох хэрэгтэй гэж сэтгэл зовсон янзтай хэлэхэд Юки,

- Би номоо бичиж эхлэх санаатай байна. Иадад монголын удам угсааны дээд өвгүүдийн

талаар багагүй баримт хуралдаад байна гэхэд Тозияа сэтгэлдээ «Сувдаагаас хойш Юки номынхоо талаар надтай ярилцахаа больсон. Харин өнөөдөр сэтгэл нь овоо тайван байгаа юм болов уу даа. Ийм үед боломжоо алдаж болохгүй. Юки эртний хятадын хан улсын түүхийг Сувдаагаар орчуулуулсан. Тэгэхээр хүннүгийн талаар багагүй баримттай болсон хэрэг. Тэгэхээр хүннүгийн талаар нэлээн ойлголттой болоод одоо талийгаач эцгийнхээ бодож байсан Их монгол улсын талаар сонирхож байгаа хэрэг!»

Юкигийн үндэсний энэ үзэл баримтлалыг улам гүнзгийрүүлэх хэрэгтэй. Тэгвэл Юки хүннүгийн талаар надаас зөвлөгөө авч бидний харьцаа урьд урьдаасаа илүү ойртож, Сувдааг үгүйлэхээ болино. Тиймээс Хүннүгийн гарал үүслийн талаар ярьж өгөх нь зүйтэй» гэж бодож байлаа. Тозияа, Юкигийн тайван, сэргэлэн царайг ажиглаад өөртөө олдсон завшааныг алдахгүйн тулд Хүннү гэдэг үгийн утгыг Юкийд таалагдах жинхэнэ үнэн холбогдлоор нь тайлбарлах нь зүйтэй гэж үзлээ.

- Монголчуудын эртний өвөг дээдэс хүчирхэг байсан учраас хан улсын улс төрийн түрэмгийллийг тухайн үедээ нугалж байсан юм. Нүүдэлчдийн тэр дайнч уламжлалыг Чингэс сэргээж, алдар нэрээ цуурайтуулахыг өөрийн зорилго болгож байсан байж магадгүй. Харин монголчууд одоо улс үндэстнээ нэгтгэх бүрэн боломжтой юм шүү. Өвөр монгол, манай армийн тусламжтайгаар хятадаас тусгаар улс боллоо. Ингэхээр монгол туургатныг нэгтгэхэд гадаадын тулах хүчин нь манай арми мөн бөгөөд дотоодын нь хүч бол үндэсний үзэл суртлаар зэвсэглэхэд чиглэж байгаа юм. Тиймээс номондоо хүннү нарын тухай дурдах хэрэгтэй.

- Надад энэ талаар бодсон юм байхгүй. Би чинь хүннүгийн талаар байтугай хүннү гэдэг үгийнхээ учрыг олохгүй байна. Харин та надад туслах юм бол өөр хэрэг.

- Би чамд дуртай тусална. Ялангуяа нүүдэлчдийн өвөг дээдсийг хятадын түүхчид яаж мушгиж, гуйвуулж, муучилж байсныг чи мэдэх ёстой юм шүү гээд Тозияа янжуураа асаалаа. Тэрээр ийм завшаан олсондоо баярлажээ. Баярлах ч ёстой ажээ. Тозияа, Сувдаагаас хойш Юкийн сэтгэл өөрчлөгдчих вий гэхээс айж, харьцаагаа сайжруулахыг мэрийж байсан. Тэр аз завшаан өнөөдөр заяажээ.

- Хүннү гэдэг үгийг хятадын дүрс бичлэгийн утга, хэлбэрт тулгуурлан тайлбарлаж болохгүй. Эртний хүннү хэлний дуудлагын онцлогийг харгалзаж, овжноор ашигласан хятадын түүхчид хэрцгий боол гэсэн дүрс үсгээр тэмдэглэхдээ хионну гэдэг дуудлагыг гуйвуулсан юм.

Тиймээс хятад дүрс бичгийг баримталж хүннү гэдэг үгийг тайлбарлаж болохгүй. Эртний хятадын түүхчид хятадаас бусад үндэстнийг соёл боловсролгүй бүдүүлэг, хамгийн хэрцгий хүмүүс буюу боолууд гэж үздэг байсныг нуух газаргүй. Хятадууд өөрсдийгөө бусад улс үндэстний манлай болгоод өөрсдөөсөө бусдыг басамжилдаг донтой. Ингэхээр хионну гэдэг нэр бол хүннү хэлний үгийн дуудлагыг гуйвуулж, хятад дүрс бичгийн хэрцгий боол гэсэн үг рүү дөхүүлж тэмдэглэснээрээ бүдүүлэг боол гэдэг ойлголт дэлгэрүүлэх далим гаргасан хэрэг. Харин үнэнийг мушгин гуйвуулсан энэ бүхнийг хүн яаж мэдэх вэ дээ. Харин чи бол үнэнийг мэдэж байх нь чухал. Миний нягталснаар бол хионну гэж тэмдэглэсэн тэр үг бол бидний хүмүүс гэсэн утгатай эртний монгол хэлний хион ману гэдэг үг байсныг хятадын түүхчид ма үеийг гэж хионну гэж тэмдэглэсэн хэрэг.

Ингэхээр бидний хүмүүс гэдэг үг нь нэг удам угсааны хүмүүс гэсэн утгатай болох нь илэрхий. Тиймээс монгол түүхч Саган Цэцэн хионну гэдэг үгийн дуудлага, утга учрын холбогдлыг сайн мэддэг учраас хион ману гэдэг үгийн утганд түшиглэж монголчуудын эртний өвгийг Бида улс гэсэн нь угтаа бидний улс гэсэн үг юм. Эхийн эрхэт ёсны үед овог аймгууд өөрсдийнхөө гарал угсааг ингэж хамаатуулдаг учраас өөрийн овог аймаг, хүний буюу харийн овог аймаг гэж ялгадаг байсан болохоор хүннү нар өөрсдийгөө нэг л овог аймгийн ах дүүс гэж үзэж байсан нь илэрхий гэж сэтгэлдээ бодож явдаг зүйлээ тайлбарлав. Тозияа чингэж өөрийнхөө бодлыг хэлсэн нь хоёр зорилготой. Японы тагнуулын газраас ардын засгийн эсрэг чиглүүлсэн үйл ажиллагаа явуулахдаа юуны өмнө монголын хар шар феодалуудын төрөл төрөгсөд, үр хүүхдэд уламжилж үлдсэн үндэсний үзлийг дэвэргэхэд чиглэж байв. Нөгөө талаар Тозияа, Цэен гүнгийн үндсэрхэх үзлийг дэвэргэж чадсан болохоор охиныг нь эцгийн нь үзлээр хүмүүжүүлэх ёстой гэдгийг өөрийн үүрэг гэж үзнэ. Тозияа чингэж чадвал Юкигийн хөрөнгийг өөрийн гарт хийж чадна.

Тиймээс Тозияа, Юкигийн амнаас үндсэрхэх үзэл санаа юмуу, үндэс угсаагаа эрхэмлэх сэжим бүхий үг цухалзвал түүнийг өлгөн авч дэмжин гүнзгийрүүлэхийг хичээдэг. Тиймээс Тозияа Сувдаагаас хойш өдий хүртэл дуугүй яваа Юкитэй харьцаагаа сайжруулахын тулд Хүннү гэдэг үгийн утгыг тайлбарлахдаа улс үндсээ гэдэг бодолд нь түшиглэсэн хэрэг билээ.

- Юки, би чамд сайхан мэдээ сонсоё. Чи лав баярлах, байх. Акасайг миний туслахаар ажиллуулахаар болсон. Би татгалзаагүй. Нөгөө талаар та хоёр уулзаагүй удлаа. Цаашдаа чамд түшиг тулгууртай шүү дээ. Ер нь чамд ямар санагдаж байна. Би бол ганцхан чиний саналыг харгалзах ёстой. Акасай гол төлөв манайд ажиллана. Тэгэхээр чиний сэтгэл санаанд тохирох хүн байх ёстой гэж аятайхан хэлэхдээ Юкийг ятгах хандлага гаргажээ.

- Та дандаа миний төлөө гэж явах юм даа. Та байгаагүй бол би ёстой амаараа газар үмхэх байсан байх. Би таны буяныг яаж хариулна даа гэж Юки баярлан хэлэхэд Тозияагийн сэтгэлд хэд хоног бөөгнөрсөн тээглээс хөнгөрчих шиг боллоо. Тозияа Юкигийн сэтгэлийг догдлуулж чадсандаа дотроо баярлана. Юки Сувдаагаас хойш хоёр сар гаруй хугацаа өнгөрөхөд дуугаа хураачихаад, бүрхсэн тэнгэр шиг царайгаа бүрсийлгэж байсныг нүдний харцаар мэдээд дотроо "Сувдааг хорлуулчихлаа гэж бодоод намайг хардаж байгаа хэрэг үү?" гэж санахаас айх шиг болдог байв.

- Юки минь... охин минь явж хоолоо идье. Чи бид хоёр амандаа халаад хоолоо мартчих шахлаа гээд Юкийн царай өөд ширтсээр инээмсэглэнэ.

Тозияа хоолны дараагаар цэргийн төлөөлөгчдийн газар руу яриад квантуны армийн удирдагч Уэдатай угсаар ярилаа. Тэрээр армийн удирдлагад хэд хэдэн зүйлийн талаар санал дэвшүүлээд удирдамж авахаар шийджээ.

- Гакка Уэда сан, надад нэг санал байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд таны туслалцаа надад хэрэгтэй боллоо. Би ч таныг тусална гэдэгт итгэж байна.

- Тозияа сан, та хэрэггүй зүйл гуйдаггүй шүү дээ. Тэгэхээр таны гуйлтыг заавал хэрэгжүүлэх ёстой болдог. Гэхдээ таны хүсэлт их ээдрээтэй эгзэгтэй гэдгийг ч мартаагүй байна. Харин ээдрээг нь тайлж, учрыг нь тайлбарлавал тусалж болно шүү.

- Гакка (эрхэм дээдсээ), танаас нуух ээдрээ байхгүй. Би Акасайг өөрийнхөө туслахаар авч ажиллуулах саналтай байна.

- Энэ чинь тун сонин санал байна. Гэхдээ юуны өмнө жанжин штабынхантай ярилцах хэрэгтэй болно байх.

Тэр чинь манай штабт ажилладаг боловч бид түүний ажил төрлийг удирддаггүй шүү дээ.

- Гакка, би армийн тагнуулын удирдлагатай ярилцсан. Акасайг Юкигийн дэргэд ажиллуулах гэсэн юм. Юки Сувдаагаас хойш ганцаардаад байна. Чухам ийм үед сэтгэл санаа нь өөрчлөгдөж их гүрнүүдийг бараадаж мэдэх эгзэг гарч болзошгүй. Тиймээс түүний санаа сэтгэлийг засаж чадах манай хүч орж ажиллуулах нь чухал биз дээ гэж Тозияа даруухан ярихад Уэда сэтгэлдээ "Сувдааг устгасан хэрэг явдал ийм учиртай байж дээ" гэж боджээ. Квантуны армийн удирдагч Тозияагийн үгнээс түүний санааг ойлгосон болохоор олон зүйл асууж шалгаасангүй.

- Гакка, та миний саналыг дэмжвэл Юки бид хоёр зургадугаар сарын сүүлчээр Токиод очно. Тиймээс Акасайг тэр үед Токио руу явуулбал тэнд танилцуулж уулзуулах аятайхан завшаан гарах юм.

- Тозияа сан, би таныг сайн ойлгосны хувьд хүсэлтийг чинь ёсоор болгоё. Хариу надад нэг хэлэх юм байна. Та Ёшийг жанжин штабын мэдэлд шилжүүлбэл яасан юм бэ? Тэнд их удахгүй.

- Уэда сан, энэ талаар холбогдох хүмүүс надтай ярьсан. Тэд нар нуурын чанадад буюу Хасан нуур гэдэг ажиллагаанд шаардлагатай байр зүйн зургийн тодруулалтын ажилд оролцуулах бололтой байсан. Түүнийг зөвшөөрнө. Бас бидэнд ч ашигтай байх. Яагаад гэвэл Халх голын байр зүйн зургийн материалыг цуглуулахад багагүй туршлагатай хүн хэрэгтэй биз дээ.

- Тозияа сан, таны энэ санаа надад таалагдаж байна. Хэрвээ генерал Суэтоко, Камейзогийн ажиллагаа Хасан нуурт бүтэмжтэй болох юм бол Халх голын ажиллагааг эхлүүлэх асуудал аяндаа түргэснэ гэснээр тэр хоёрын яриа яв цав тохирчээ.

Зуны эхэн сарын хуучдаарх нэгэн үдшийн бүрэнхийгээс шөнө дүл хүртэл Мугдэн дэх японы төлөөлөгчийн газрын хэд хэдэн цонх гэрэлтэй байлаа. Тозияа, Тяньжингаас ирснээсээ хойш төлөөлөгчийн газар бэлдүүлсэн албан тасалгаандаа чингэж ажиллаж байсангүй. Хэдхэн хормын өмнө оруулж ирсэн гоёмсог шаазан гүцтэй халуун цайнаас аягалсан Тозияа Иван Степановичид тал засаж,

- Иван минь халуун цай уу гээд түүний царай өөд ажиглангуй харахад Сафронов хятад шаазантай цайг эв хавгүй барьж оочлох зуур,

- Тозияа сан, Аяанаосугийн хувьд гэвэл манайхан нарийн судалгаа хийгээгүй. Харин манай нэг туршуул сонин санаа гаргасан юм. Гэхдээ түүнийг нотлох баримт байхгүй. Би тэр туршуулаас нухацтай юм гарч магадгүй гэж бодсон чинь талаар өнгөрлөө. Тэгэхээр тоймтой айлдчих юм даанч алга гэж хаяагаа манасан янзтай хэллээ.

- Танай тэр цагаач хочит чинь Сувдаа, Хасу Тоиши хоёрын холбоог сайн мэдэж байсан юм биш үү?

- Уг нь муугүй зүйл цуглуулсан гэж ярьдаг байсан. Гэхдээ та бид хоёрын мэдэж байснаас хэтэрч чадаагүй хүн. Иван минь чи, Цагаачийнхаа талаар цуглуулсан материалыг надад, үзүүлээч. Би уншаад өгье.

- Би түүний материалыг танд бүрмөсөн өгч болно шүү гэхэд Тозияа, Сафроновоос салгах гэсэн зүйлээ хялбархан авч чадах далим гаргасандаа сэтгэл хангалуун байв. Тиймээс дараагийнхаа бодолд хүргэхийн тулд Иван Степановичаас санамсаргүй байдлаар,

- Иван минь, Аяанаосугийн хувцас захиалгын газар аль зэрэг орлоготой вэ? Дам сураг дуулбал овоо хөрөнгөтэй бололтой гэж асуулаа,

- Одоо мэдэгдэж байгаагаар бол захиалагч нараас гучаад мянган иений урьдчилгаа авсан бөгөөд наяд мянган иений эд бараа байгаа юм.

Түүнээс гадна байшингийн эзэн Аяанаосуд хөлслүүлж байгаа арван таван өрөөний эд хогшлыг нийлүүлээд зуу гаран мянган иень гэж ярьдаг зуршилтай. Ингэхээр нийтдээ хоёр зуун тавиад мянган иений хөрөнгөн дээр туйлж байгаа эр байх шүү.

- Аяанаосу юм бүхнээ даатгуулсан юм болов уу? гэж Тозияаг асуухад Иван Степанович дотроо "Хөгшин генерал одоо Аяанаосугаар оролдох нь ээ" гэж бодлоо.

- Тийм их хөрөнгийг даатгуулахгүй тэнэг хүн байдаггүй байх шүү гэж хэлээд Иван Степанович эчнээндээ "Аяанаосугийн талаар Симото далдуур сураглаад байсан. Тэгэхээр энэ санаачилга бол Симото сэдэж, Тозияагаар дэмжүүлсэн хэрэг биз" гэж бодов.

- Иванаа хоёулаа нэг зүйлийг хамтран хийнэ. Чи түүнийг гардан гүйцэтгэх хүмүүсийг олж зохион байгуулах хэрэгтэй! Харин би түүнээс үүссэн хохирлыг даая.

- Аяанаосугийн хувцасны газрыг шатаалаа гэж үзэхэд байшинг нь яах вэ? гэдэг нэг асуудал бий гэж Сафроновыг хэлэхэд өөрийнх нь ярианы өнгөөр Тозияагийн бодлыг багцаалсан Иван Степановичийн хэрсүү ухааныг өвгөн сэтгэлдээ таашаана.

- Иван минь чи чинь ердөө аавыгаа өвчсөн хүн юмаа. Аав чинь хүний ярианы өнгөөр бодож, хүсэж байгаа зүйлийг андахгүй мэддэгсэн.

Тозияа, өөрийнхөө ажиллагаанд саад болсон генералуудын элдэв ажиллагааг сүйрэлд оруулахыг хичээж, тэдний нууцтай холбогдсон зүйлийг задруулахаас ч буцахгүй байв. Тозияа, Зөвлөлтийн алс дорнод руу чиглэсэн довтолгооны сүйрэлд орвол монгол руу чиглэсэн ажиллагааг эхлүүлэх хугацааг түргэтгэнэ гэж итгэжээ.

Энэ учраас улаан оросын тагнуулуудыг олж уулзаад Хасан нуурын ажиллагааг илчилж, төлөвлөгөөг нь авч өгөхөд ч бэлэн байлаа. Тозияа өөрийнхөө ажиллагаанд оросын дүрвэгсдийн товчоог ашиглахын тулд Сафроновтой чингэж ярилцахдаа ярианыхаа сэдвийг үл

ялиг хазайлгаснаа мэдээд ажил хэргийн талаар ярихаар шийдэв.

- Иван минь, би чамтай ажлаа тохирлоо. Юки бид хоёр удахгүй Токио явна. Тэр хойгуур Симото та хоёр Аяанаосугийн асуудлыг шийдэж мухарлах хэрэгтэй. Ялангуяа Аяанаосугийн хувцас захиалгын газрыг шатаасны дараа тэднийд хувцас захиалсан оросын товчоонд харьяалагддаг хатагтай нарын дунд дорвитойхон ажил зохиож хэл ам татлуулах нь чухал! Аяанаосу, тэр сүйрлээс хялбархан гарахын тулд Симототой хэл амаа ойлголцож чадна гэж Тозияаг хэлэхэд,

- Тозияа сан, би таны өгсөн даалгаврыг биелүүлэхийн тулд өөрөө гардан гүйцэтгэх болно. Харин оросын дүрвэгсдийн "Фашист холбоонд" зохих ёсны удирдамж өгвөл миний ажил саадгүй бүтнэ шүү дээ гэж Сафроновыг хэлэхэд Тозияа түүний саналыг үг дуугүй хүлээж авлаа.

- Иван минь, би Разаевскийнхантай ярьж, чиний ажилд туслах удирдамж өгнө. Харин одоо ажил төрлийнхөө яриаг больё. Чи Харбин руу буцах гэж яараагүй биз дээ. Юкигийн сэтгэл санаа Сувдаагаас хойш тааруухан байгаа. Тиймээс чи хэд хоногтоо энд байж цаадахынхаа сэтгэл санааг засахыг бод! Та хоёр багаасаа тоглож наадаж өссөн болохоор заримдаа чамайг үгүйдэг бололтой гэж хэлэхэд Сафронов, Тозияагийн зөвлөгөөнийг хүлээн авчээ.

1938 оны хавраас манжуур, солонгос дахь японы цэргийн штабын ажил ундарсны адилаар Хато генералд унтах зав олдолгүй уджээ.

Тэрээр Харбин дахь «Оросын фашист холбоо», "Оросын дүрвэгсдийн товчоо" зэрэг байгууллагын удирдлагыг удирдан залах «мэргэн зөвлөх» болсноос хойш Зөвлөлтийн алс дорнод руу хараагаа сунгасан японы армийн үйл ажиллагаанд багагүй хандив оруулсан.

Тэрээр Амар мөрөн, түүний сав дагуух Зөвлөлтийн хот суурин, үйлдвэр завод, гацаа тосгоныг галдан шатаах, орон нутгийн коммунистуудыг толгой дараалан устгах, Зөвлөлт засаг төрд дургүй хүмүүсийг олж, мөнгө хөрөнгөөр хангах замаар өөртөө татаж, хорлон сүйтгэх ажилд ашиглаж байсан.

Хато, энэ бүхнийг хийхдээ алс дорнод руу чиглэсэн 30 дивиз бүхий тавдугаар армийн тэргүүн Доихарагийн заавраар зохицуулж гүйцэтгэдэг. Тэгэхдээ хорлон сүйтгэгчдийг бэлдэх тусгай сургуулийг Хайларт байгуулжээ.

Тэр сургуулийн сонсогчид нь «Оросын дүрвэгсдийн товчооны» харьяанд байдаг хаант оросын армийн оргодол бага дарга нараас бүрдэхийн зэрэгцээ тэднийг газрын зургийн мэргэжилд сургадаг байлаа.

Эндхийн газрын зургийн мэргэжилтэнгүүд нь монголын Буйр нуур, Халх голын сав дагуух газар нутгийн зургийг бэлтгэхэд оролцох ёстой төдийгүй Зөвлөлтийн алс дорнодын газар нутгийн байр зүйн зургийг боловсруулахад шаардлагатай мэдээ баримтыг цуглуулах ёстой.

Хатогийн ажлын хоёр дахь чиглэл бол умард Солонгос, Зөвлөлтийн хилийн дагуух уул нуруудаар бүгсэн орон нутгийн мухар толгойтны үүр, ичээг илрүүлэхэд чиглэж байлаа.

Ялангуяа умард солонгосын хойгуур Чанбайшаны нуруугаар бүтсэн солонгос, хятадын мухар толгойтны үүрийг илрүүлж, тэдний дотор өөрийн хүмүүсийг шургалуулахыг чухалчилдаг. Хатогийн эчнээний энэ бодолд Хасу Тоиши онцгой үүрэгтэй болой.

Тэрээр эгчийнхээ сургийг гаргах эгзэг эрэлхийлдэг болсныг гадарласан генерал сэггэлдээ багагүй түгшиж байжээ. Хато, Хасу Тоишигийн эгчийг «эрлэг тамд илгээх» арга хайж байсан тэр үед генерал мухардмал байдлаас амжин гарах аз дайрлаа. Ирэсигийн ойролцоо онхолдсон галт тэрэгний сүйрлээс хойш Хатогийн сэтгэл уужирсан боловч Хасбаатарыг Хасу Тоишигоор урхидуулах гэсэн ажиллагаа бүтэмж муутай байв. Гэсэн ч хашир генерал, нарийн боловсруулсан арга олоод Сафроновыг өрөөндөө урьжээ.

Хато, Сафроновтой уулзсан даруйдаа энгийн яриа дэлгэж энэ тэрийг хамж шимсээр алгуурхан албан яриандаа орлоо.

- Ноён хурандаа, умард солонгост тусгай хэсэг явуулахаар болсон. Тэр хэсгийг та удирдаж явбал ямар вэ? Манай талаас Хасу Тоишийг томилох санаатай байгаа. Та хоёрын ганзага сүрхий нийлдэг биз дээ гэж Хато генерал үгээ цэнэж хэлэхийг ажигласан Сафронов, Мүгдэнд байхдаа Тозияатай ярьсан нэгэн яриаг санав.

Сафронов халааснаасаа янжуур гаргаж, генералаас зөвшөөрөл аваад тамхиа асаах зуур, «Хато, Тозияа хоёр яггүй зөрчилтэй байгаа юм байна. Аягүй бол Аянаосугийн гарыг мухарлаж хоослох гэсэн Тозияагийн бодлыг Хато мэдсэн байх нь ээ. Тэгвэл Хато, энэ нууцыг хэнээс мэдсэн байх вэ? Эд нар алдар тушаал булаалддаг болохоор нэг нууц нөгөөд дамждаг шүү дээ.

Тэгэхдээ Аянаосуг хоосруулах нууц ажиллагаанд намайг оролцоно гэдгийг хэнээс мэдсэн байх вэ? Хатоод Тозияагийн эчнээний бодлыг дамжуулж, шан хөлс авч мэдэх хүн чинь хэн байх билээ. Симото, Симото байж болох уу? Тэр золиг хэрээ хочтныг мухар толгойтнуудад алдчихаад түүнийгээ цайруулахын тулд Хато,

Тозияа хоёрын хооронд чулуу хаяж, хоёр генералыг яс булаалдсан нохой шиг хэрэлдүүлэхэд хүрсэн шүү дээ!» гэж бодно.

- Ноён генералаа, би бол тушаал биелүүлэх ёстой цэрэг хүн шүү дээ. Тиймээс эрхэм дээдсийн өгсөн үүргээс татгалзах эрх надад байхгүй гэж хэлэхэд Хато баярласан янзтай инээмсэглээд,

- Би чамд хэн ч мэдээгүй нэг нууц ажиллагааны талаар хэлж өгье. Энэ зуны сүүлчээр солонгост байгаа манай армийнхан улаан оросын алс дорнод руу "жигүүрээ" дэлгэх болно.

Тиймээс юуны өмнө Тумынган (ган-ка кан, гон-хон, кон гэдэг дагавар солонгосын газар нутгийн нэрэнд өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь гол мөрөн гэсэн утгатай) голын сав, алс дорнодын хил дагуух Чёрный уулын чанад Посьётын булангийн хойд нутгийн байр зүйн зургийг хийхэд шаардлагатай тодруулалтын ажилд явуулах онцгой даалгавар жанжин штабаас ирсэн. Солонгост байгаа манай армийн үйл ажиллагаа умард солонгосын Чосали, Хоньйри, Вонжайннигийн чиглэлд хандах учраас танай «харцагануудыг» улаан цэргийн хувцсаар хувцаслан Чёрный уулын хавиар нутгийн гүнд илгээх болно. Газрын зургийн тодруулалт хийх

хэсгийн ажиллагааг түргэтгэхийн тулд Далунлин, Наньгамын нуруунд байгаа мухар толгойтны ихээхэн хүчийг тэндээс холдуулах шаардлагатай болоод байна. Тэднийг оросын армийн хуучин зүтгэлтэнгүүд зайлуулах нь зохимжтой юм. Тэднийг зайлуулж чадвал Гирин-Харбины төмөр замын зангилаа болсон тэндхийн төмөр замаар армийн техник хүчийг оросын хил рүү татах боломжийг хангана. Хэрвээ та тэр ажиллагаанд оролцвол бид атаман Семеновт шууд танилцуулж таныг бусад ажлаас бүр мөсөн чөлөөлнө гэж хэллээ.

Хато, Хасу Тоишийг энэ ажиллагаанд оролцуулахдаа хоёр зүйлийг гоц анхаарчээ. Хатогийн тооцоолсноор бол Хасу Тоиши, Мулинвозилингийн нуруунд байрласан орон нутгийн партизаны хэсэгт байдаг ахтайгаа холбоо барьж ажлаа зохицуулна гэж боджээ. Хасу Тоиши, эгчтэйгээ уулзаж, ахынхаа сургийг гаргаж чадсан бол Зомутай, Силиньхэ, Гуйян, Суйфынхэ хотуудын ойролцоо ажиллахдаа ямар нэг сэжиг гаргах нь дамжиггүй.

Учир нь энэ хотуудад мухар толгойтны холбоочид цөөнгүй ажээ. Хасу Тоиши ахынхаа холбоочинтой уулзаж ахтайгаа учрах эгзэг гаргаж чадвал түүнд хэн ч саад хийж болохгүй гэдгийг Хато тусгай хэсгийн удирдлагад хатуу тушаажээ. Хэрвээ Хасу Тоиши, ахтайгаа уулзвал түүнийг нь далимдуулж ахыгаа барьж өгөх даалгаврыг Хасу Тоишид өгөх ёстой байлаа. Хасу Тоиши энэ болзлыг хүлээн аваад

түүнийг биелүүлэх явцдаа урван тэрслэх хандлага гаргавал Хасу Тоишийг дор нь устгах тусгай төлөвлөгөө боловсруулсан болой.

Хато, Хасу Тоишийг устгасны дараагаар Тозияагийн өргөсөн охины зарц Сувдаа армийн нууцыг Тозияагийн амнаас сонсоод Хасу Тоишид хэлж, мухар толгойтнуудад дамжуулдаг учраас улаан оросууд тэр мэдээг хүлээн аваад японы армийн ажиллагааны эсрэг урьдчилсан бэлтгэл хийдэг байсан нь Ханх нуурын ажиллагаагаар батлагдсан гэдэг дүгнэлт хийж жанжин штабт илтгэх байлаа.

Хато, энэ ажиллагаагаа амжилтанд хүргэж баримтаар нотолж чадвал хязгааргүй эрх дархтай Тозияагийн толгой дээр «цахиур» хагалж, түүний оронд өөрийгөө залрах ёстой гэж үзэх ажээ. Өөрөөр хэлбэл зүүн умард хятад, манжуур, зөвлөлт рүү хараагаа сунгасан эзэн хааны "нүд чих" болж чадвал армийн томчуулын зиндаанд орно гэдэгт итгэнэ.

Хоёр. Шулуудсан сэтгэл

Аяанаосу Харбинд суурьших ёстой холбоочинтойгоо уулзахаар болзоот газраараа товлосон өдрүүдэд хэд хэдэн удаа эргэсэн боловч хэнтэй ч уулзсангүй. Тэрээр чингэж холбоочингоо хүлээж ядаад удирдамж ёсоор Харбин дахь «Дүрвэгсдийн дуу хоолой» сонинд сарын өмнө захиалгаа өгсөн хүмүүсийн хувцсыг хийж амжаагүй учир энэ сар хувцасны захиалга авах явдлыг хойшлуулсан тухай зарлал нийтлүүлэв.

Энэ зарлалыг нийтэлсэн өдрөөс хойш долоо хоноод "Харбины цаг" сонинд хүрээнд байсан хаант оросын худалдаачдыг толгойлж байсан томоохон худалдаачин Харбин руу явсан тухай мэдээ хэвлэгджээ.

Аяанаосу энэ мэдээг уншаад сэтгэл уужирчээ. Үүнийг ДОХАГА-ийн удирдамжаар холбоочин хэвлүүлэх ёстой байв.

- Аяанаосу, "Харбины цаг" сонины сүүлчийн нүүрэнд байгаа мэдээг уншаад сонингоо ширээн дээр тавихдаа «Сувдаа маань Улаанбаатарт очиж ээжтэйгээ уулзжээ. Холбоочин уулзалтаа хойшлуулсан болохоор Сувдаагийн дамжуулсан баримтуудыг нотлох шинэ баримт олох хэрэгтэй.

Ялангуяа Зөвлөлтийн алс дорнод руу товлосон өдөөн хатгах ажиллагаанд армийнхан ямар хүч оролцуулж, хэзээ, хаагуур халдах өдөр сарыг мэдэх нь чухал! "Дайран симбун" сонинд атаманыг

Токиод айлчлах тухай зарласан. Тэгэхээр энэ бол Хасан нуур руу чиглэсэн ажиллагаанд хаант оросын цагаачдыг оролцуулах гэж байгаагийн илрэл. Ингэхээр Хато, энэ талаар нэлээн зүйл гадарлана шүү дээ» гэж бодлоо.

Аяанаосу сүүлийн нэг сард болсон японы армийн генералуудын хөдөлгөөн, манжуур солонгос дахь цэргийн хүчний шилжүүлэлт, сонины тоймчдын битүү ажиглалтын нууц сэжмүүдийг өөрийнхөө хийсвэрлэлтэй харьцуулан, бодит байдалд хэрхэн холбогдохыг тунгааж үзлээ. Аяанаосу чингэж бодсоны эцэст Хасу Тоишитой уулзахаар шийдэв.

Хасу Тоишитой ингэж уулзах нь нэг талаас Аяанаосугийн ажиллагаанд хор хүргэж мэдэх эгзэгтэй боловч нөгөө талаас амьдрал ахуйн үнэнийг ойлгож, эцгийнхээ өшөөг авахыг сэм хичээж буй Хасу Тоишигийн тархинд он жил хадгалагдсан төөрөгдөлд үнэний гэгээ тусгах алхам болох ёстой байлаа.

Чухам энэ алхмыг зөв сонгож чадвал Хасу Тоишийг Хасбаатартай холбоо бариулаад ахынхаа үйл ажиллагаанд тууштай туслах сэтгэгдэл төрүүлж, итгүүлэх боломжтой байв. Сувдаагийн талаар тодорхой зүйл мэдэж чадаагүй Хасу Тоишийд эгчийнх нь үйл ажиллагааг зөв ойлгуулж чадвал Аяанаосугийн цаашдын ажилд Хасу Тоиши их нөлөөтэй ажээ.

Аяанаосу цагаа харвал оройн 19 цаг болж байлаа. Гучин мөч хэрийтэй болоод Хасу Тоиши, Модрен буудлын зоогийн газар очиж оройнхоо хоолыг зооглох ёстой. Тиймээс Аяанаосу, Хасу Тоишитой уулзахын тулд түүнээс өмнө зоогийн газар очсон байх хэрэгтэй аж.

Аяанаосу хувцас захиалгын газрын албан өрөөнөөсөө гарч хувцсаа солиод буудлын зоогийн газар руу гэлдэрлээ. Тэрээр гол хаалгаар орохдоо хөлийн танхимд байгаа япон дарга нарын дунд Симото зогсож байхыг харлаа. Харин Симото, Аяанаосуг орж ирэхийг харсан боловч огцомхон зуур эргэж буруу харан зогсоод ханын толь руу ширтжээ. Тэрээр Аяанаосуг ханын толинд ажиглахыг хичээсэн нь хэн хүнд яахан ажиглагдах билээ. Харин Аяанаосу, Симотоог чиглэн алхахдаа "Квантуны армийн тагнуулынхан Харбинд ямар ажлаар ирээ юм бол? Эд нар шинэ хуйвалдаан сэдсэн хэрэг үү? Тиймээс Симото Харбинд гуяа хоосон ганзагалж ирээгүй нь магад! Тэгвэл ямар хэргээр вэ?"

Хасан нуур руу чиглэсэн ажиллагаанд квантуны арми, ямар үүрэгтэй вэ? Эсвэл өөр хэрэг гараа юу?" гэж өөрөөсөө асууж байв. Симото, өөр рүүгээ дөхөж яваа Аяанаосугийн бараанаар эргэн харахдаа хуурамчаар инээмсэглэн түүнийг тосон уулзав.

- Симото сан, та Харбинд ирсэн мөртлөө надтай уулздаггүй чинь юу болж байна. Би танаас өр нэхэхгүй шүү гээд Аяанаосу Симототой мэндлэв. Симото, Аяанаосутай мэндлээд "Энэ золиг чинь зээлүүлсэн хэдэн юмаа аятайхан нэхэж байх чинь! Худалдаачин хүний хүүхэд гэсэндээ овжин сүүхээтэй байх чинь" гэж бодоод.

- Аяанаосу сан, би дөнгөж ирээд зогсож байна гэж хэлтэл нөгөө талын өрөөнөөс Ёоши гарч ирлээ. Түүнийг буудлын үйлчлэгч нарын ахлагч эмэгтэй дагажээ. Тэр эмэгтэй Симотогийн амар мэндийг лавлаад,

- Симото сан, төлөөлөгчийн газар таныг ирнэ гэж хэлсэн боловч хэдийд ирэхийг мэдэгдээгүй. Тиймээс таныг угтаж чадаагүйд минь өршөөн соёрхоно уу. Таны өрөө бэлэн байгаа. Симото сан, дозо какэ кудасай (та ийшээ морилно уу) гэж японоор цэвэрхэн хэлээд тусгай зочид хүлээн авдаг өрөө рүү заалаа. Чухам энэхэн мөчийг ашигласан Аяанаосу,

- Симото сан, та татгалзахгүй бол оройн хоолонд урья гэхэд,

- Аяанаосу сан, би одоохондоо чадахгүй нь ээ гээд Симото инээмсэглэв.

- Симото сан, хэрвээ завдвал зоогийн газар ороорой. Би таныг хүлээж байна шүү гэхэд Симото толгой дохиод үйлчлэгчийн араас явлаа.

Зоогийн газар хүн ихтэй, Модрен буудлын эзэн сүүлийн хэдэн жил квантуны армийнханд зориулж зоогийн газрыг өөрчилсөн нь нэн зохимжтой. Тэгэхдээ армийн сүр хүчийг бадруулан тунхаглах гэсэн шиг самурайн ёсыг дагаж бусидо цэрэг эрсийн замналыг сахисан зургаар ханаа чимэглэсэн болой. Зоогийн гол танхимын хөгжимчдийн байрны ар хананд японы шашны синто (Бурхны хутаг олох) ёсны дайны тэнгэр хатиманааг зурж, хоёр талаар нь хирагана бичгээр «Юмина хатиман (хатиман тэнгэрт тангараглая)» гэж бичсэн уриа унжуулжээ. Дайны тэнгэр хатиман бурхны хөргийн наагуур эртний самурайн хакама гэдэг хувцсыг дуурайлгаж хийсэн богино ханцуйтай кимоно өмсөж, дэгжирхсэн кэйэнгэкичүүд (хөнгөн хөгжимчид) зээглэн зогсож, эрт эдүгээгийн япон ая хөгжимдөнө.

Аяанаосуг хоол захиалаад удаагүй байтал Хасу Тоиши гаднаас орж ирлээ. Аяанаосу энгэрийнхээ цагийг хараад, "Энэ яасан эрт хооллохоор ирж байна вэ?" гэж бодож суутал Хасу

Тоиши түүний дэргэд ирлээ.

Аяанаосу түүнийг урьж дэргэдээ суулгахад тэрээр үг яриа цөөтэй, царай бүрсгэрдүү агаад харц нь омголон байртай байхыг ажсан Аяанаосу сэтгэлдээ «Мань хүн Хатотой ам мурийгаа юу? Эсвэл эгчээ амь эрсэдсэн явдлыг дуулснаас хойш намайг хардаж байгаа хэрэг үү?» гэж бодсоор,

- Хасу Тоиши сан, та чинь ус балгачихсан юм шиг дуугүй болсон хэвээрээ шив дээ. Ядаж хоёулаа амар мэндийн зөрөөтэй байя л даа гээд инээхийг хичээж уруулаа мушилзуулах зуураа,

- Чамд хитсуй будоцу (хатуу архи) хундагалах уу? гэлээ.

- Хэрэггүй. Харин ака будоцу (улаан архи) захиалчих гээд Хасу Тоиши гүнээ санаа алдав.

- Хасу Тоиши сан, чи Симото, Ёоши хоёртой уулзав уу? Тэр хоёр Синьзингээс ирсэн байна.

- Тэр хоёр Синьзингээс ирээгүй. Өчигдөр шөнө Мугдэнгээс ирсэн. Төлөөлөгчийн газар, дүрвэгсдийн товчоонд лай (тусгай ажил) нэмчихээд түрүүхэн наашаа явсан юм.

- Юун их ажил гараа вэ?

- Яах юу байх вэ? Ханширээгийн сүйрлийг шалгасан баримтыг бүрхэг болсон гэж үзээд дахин шалгахаар ирж байгаа бололтой. Жанжин штабынхан Тозияаг чихдэж тэр хөгшин уурандаа энэ хэдээ багалзуурдах шахжээ. Зуд болохоор хуц ухна дээр унадаг гэгчээр Тозияа аргаа бараад өөрийнхөө урд хормой (Симото), урт хошуу (Ёоши) хоёроор Хатогийн үрчгэр арьсыг хуулуулах арга олсон бололтой.

Хато уурандаа биднийг хяргачих шахаад заримыг нь умард солонгос руу хөөж явуулах бололтой байна.

- Тэгвэл ч ярвигтай юм байна даа. Ёоши сурсан заншлаараа Тозияагийн урд хойно гүйж байгаа болохоор Ханширээгийн хэрэгт хэд хэдэн хүн өртөх нь зайлшгүй. За тэгээд Симото, тэдний ул мөрийг шиншлээд давсалчихаар өртсөн хүн бүхэн хоолноосоо сална гэсэн үг! гээд Аяанаосу хундагатай архиа балгачихаад уртаар амьсгаа авлаа.

- Би ч солонгос руу явж магадгүй байна. Иамайг Сафронов дагуулж явах бололтой.

- Чи тэгээд юу гэж бодож байна? гэж асуугаад Аяанаосу дотроо "Хасу Тоишийг солонгос руу явуулна гэдэг бол Хатогийн бодол! Одоо ахыг нь барих ажлаа эхэлж байгаа хэрэг! Эсвэл Хато, Хасу Тоишигийн дагз руу сум зоож, өөрөө хоёр яс хагацах гэсэн бодол! Сүүлийн үед Хасу Тоишигийн сэтгэл санаанд өөрчлөлт гарсныг ойлгоод Хато, амархан салахыг хичээх болжээ дээ. Хасу Тоиши, ахыгаа барьж өгөхгүй гэдэгт генерал итгэсэн хэрэг үү? Тэгэхээр генерал өөрөө өрсөж Хасу Тоишийг устгахгүй бол хожим хоолойгоо боомилуулсан гохонд орно" гэж болгоомжилсон байж таарна" гэж бодсоноо,

- Чи тэгээд явахаар шийдэж байна уу гэж асуулаа.

- Ямар ч байсан энэ удаа. Сафронов Ёоши хоёртой хамт явна.

- Симото, явахгүй юм уу?

- Мэдэхгүй. Ямар ч гэсэн Ёошийг явуулахаар сая шийдсэн. Симото энд үлдэж Ханширээгийн хэрэгт холбогдох баримтыг нягтлахын зэрэгцээ бас бус ажилтай бололтой. Сафроновыг солонгос руу явуулахгүй энэ тэр гээд Тозияатай утсаар яриад өөрөө энд үлдэхээр шийдсэн.

Сафроновын яриагаар бол Симото, Харбинд удах шинжтэй байна. Бодвол оросын товчоонд шургалсан итгэл муутай хүмүүсийн илүү дутууг бүртгэж шалгах бололтой гэж хэлтэл гаднаас Симото, Ёоши хоёр орж ирлээ. Хасу Тоиши, тэдний бараанаар ширээнд байсан галуун хүзүүтэй шилнээс цагаан архи хундагалаад гуд гуд балгахыг ажваас сэтгэлийнхээ бухимдлыг дарж ядаж байгаагийн шинж болой.

Тэр хоёр энгийн хувцас өмссөн болохоор хэн хэнд нь яггүй зохижээ. Симото урьд урьдаасаа хөгжөөнтэй, царай нь баяр баясгалантай ажээ. Тэрээр ойр зуурын яриа дэлгэж, Хасу Тоишитай ярихыг анхааралтай чагнаж суусан Аяанаосу, архи хундагалах зуураа "Симотогийн ааш зан гойд онцгой байх чинь. Юу л бол доо! Симото ерийн байдалд ийм зан ааштай байдаггүй. Өөрийн нь анхааралд өртсөн хүнтэй ярихдаа нүдээ жоотийлгоод ёжтой инээмсэглэдэг. Тэгээд яриандаа хэн хүнд ажиглагдмааргүй гэнэ алдуулсан үг хавчуулсан асуултаар үг алдуулж, мушгидаг авьяастай хүн! Ярианы нь өнгө Хасу Тоиши руу илэрхий чиглэсэн юм уу даа" гэж бодно.

- Хасу Тоиши сан, та чинь солонгос руу очиж гайхамшигтай үйл ажиллагаанд оролцох нь дээ. Атаархмаар юм. Та тэндээс ирэхдээ лав хоосон ирэхгүй байх. Аягүй бол энгэрээ цоолно шүү гээд Симото хундагаа авч өргөхдөө гурвалжин нүдээ онийлгон,

- Хасу Тоиши сан, Панлингийн төлөө... та бүхний амжилтын төлөө өргөө. Кампай гэлээ. Симотогийн ёжилсон энэ үгнээс «Панлингийн төлөө» гэдэг үг Аяанаосугийн анхаарлыг татлаа.

Зөвлөлтийн алс дорнодын хилийн дагуух Чёрный гэдэг уултай зах нийлдэг зүүн умард манжуурын Панлин нуруунд нутгийн мухар толгойтнууд байрладаг болохоор ноднингоос хойш солонгос, хятадын сонинуудад энэ ууланд болж байгаа хэрэг явдлын талаар багагүй дуулиан дэгдээж мухар толгойтнуудтай үзэлцсэн японы хээрийн цагдаа, манжуурын цэргийн гавьяаны талаар бие биенээсээ өрсөн бичдэг байсан.

Хасу Тоиши, Симотогийн үгний далд утгыг ойлгосон болохоор хариу үгээ чамбайхан бэлдээд,

- Панлингийн нуруунд толгойгоо гээчихгүй бол эзэн хааны өмнө хүлээсэн бусидо цэрэг эрсийн замналд үнэнчээр зүтгэх нь миний алдар гавьяаны хэрэг мөн! Банзай гээд хундагатай архиа өргөлөө.

- Та чинь самурайн ёсонд аргагүй биширсэн хүн байна. Тэгэлгүй яах вэ? Та чинь синкэн сёбу (кэндо буюу илдний замнал гэдэг ёсыг сурч сэлмээр цавчих сургуульд мэргэжсэн хүний

хэрэглэдэг сэлэм) барихаараа кэсагирийд (сэлмээр хүний мөрнөөс хүйс хүртэл цавчдаг ёсонд мэргэжихийг кэсагакэ гэдэг боловч хожим ингэж нэрлэдэг болсон) дадамгай гэдэг байх аа?

- За яахав дээ. Анх сингай (хулсан сэлэм) барьж сурсныг бодвол гайгүй шүү гэж Хасу Тоишийг хэлэхэд Ёоши тэдний ярианд оролцож,

- Хасу Тоиши сан, та дэндүү даруу байна. Кэндоод мэргэжсэн, синкэн сёбу ганц далайгаад кэсагири хийнэ гэдэг чинь гайхамшиг шүү гэлээ.

Симото, Ёошигийн амнаас аятайхан далим гарсныг ашиглаж,

- Хасу Тоиши саны даруу зан бол удамшсан онцлог! Зүүн умард хятадын мухар толгойтны дунд нэг сүрхий эр байдаг гэнэ.

Түүнийг жанжин болгох гэхэд их дургүйцсэн юм гэнэ билээ гэж үгээр дайруулав. Симотогийн үгийн далд утга Хасбаатар руу чиглэснийг ажигласан Аяанаосу "Миний бодсон зөв байх нь. Тэгэхээр Хасу Тоишийг Солонгос руу явуулна гэдэг бол сөрөг тагнуулынхны сэдсэн заль байх нь. Хасу Тоишийг Солонгос руу явуулах нэрийдлээр Зөвлөлтийн алс дорнодыг бараадсан партизаны мөрөөр нь шинж гэсэн мэх гэдэг ч гарцаагүй хэрэг" гэж бодов. Чухам энэхэн үед Ёоши өөр зүйл бодож сэтгэлээ түгшээнэ. Тэрээр Тумын хот ороод тэндээсээ умард Солонгос, Зөвлөлтийн алс дорнодын хилийн ойролцоо байгаа Монтакусан (Кохо) сууринд очих ёстой. Тэндээсээ улаан цэргийн хувцсаар хувцасласан дүрвэгсдийн товчооныхонтой нийлж, Зөвлөлтийн Красино суурингаас Хасан нуурын баруун өмнө хүртэлх газар нутгийн байр зүйн зургийг хийхэд хэрэглэх материал цуглуулах ёстой.

Японы армийн жанжин штаб Зөвлөлтийн алс дорнодын хилийн дагуух нутгийн байр зүйн зургийн материал цуглуулах хоёр хэсэг бэлджээ. Ёошигийн толгойлох хэсгээс гадна мөн хятадын Далунлингийн нуруугаар хил давах хэсгийг Новокиевка чиглэлээр оруулж, Красино тосгон хүртэлх нутгийг тодруулах ёстой. Тэднийг Сафронов удирдах ёстой аж. Ийнхүү дөрвөн хашрыг ярилцаж суутал үйлчлэгч ирж Симотоод нэгэн зурвас өглөө.

- Кэй ай суру миасама (эрхэм ноёд оо), намайг төлөөлөгчийн газраас дуудсан байна гэтэл Ёоши суудлаасаа өндийхийг завдав. Гэтэл Симото Ёоши руу эргэж, инээмсэглэхдээ нүдээрээ ирмээд,

- Ёоши сан, та их азтай хүн юмаа. Тэгэхээр, би, энэ наргианд оролцож чадахгүй нь гэх нь Ёошийд ажиглалтаа үргэлжлүүлэхийг сануулсан дохио байв. Симотоог явсны дараа өнөө гурав ярих юмаа барчихсан юм шиг хэсэг дуугүй суухдаа кэйэнгэки (хөнгөн хөгжим) хөгжимдөхийг сонсов. Ёоши Симотогийн далд үгийн утгыг ойлгосон болохоор чингэж дуугүй суухдаа Хасу Тоиши руу нүдний булангаар сэм ширтэнэ. Аяанаосу, чухам энэхэн үед өөрийнхөө мэдэх ёстой зүйлийг Ёошигоос лавлахыг мэрийж яриа хэрхэн өдөөхөө боловсруулна. Тэрээр хундагатай архи дүүргээд,

- Кэйай суру миасама (эрхэм ноёдоо) уйтгартай хөгжим сонсоод чих дөжирчихлөө. Тэгэхээр одоо өндөрлөх үү дээ гэтэл Ёоши,

- Аяанаосу сан, жаахан дэмийрье. Чи юундаа яарсан юм бэ? Ямар эхнэр хүүхэд татлаа түтлээ гэж байх биш. Ингэхийгээд Симото сан ч ирэх байх гэж шалгаалаа.

- Ёоши минь үнэнийг хэлэхэд би гэр рүүгээ очмоор байна. Нэг хүн ирэх ёстой юм гээд Аяанаосу үгээ зориуд таслав.

- Тэр яахав. Чи болсон хойно, хүүхэнтэй болоо биз. Ганц шөнө өвдгөө тэврээд унтчих. Өдөр алгасалгүй хүүхнүүдтэй шалиглана гэдэг бас залхуутай ажил шүү! Ганц шөнө хуурай хонож үз гээд наг наг хөхөрлөө.

- Ёоши минь би чинь хөгширч яваа хүн. Ганц шөнө ч гэсэн эмэгтэй хүний өвөрт дулаан унтъя.

- Аяанаосу сан, чи орос хүүхний өвөрт унтаж үзсэн үү?

- Үгүй шүү.

- За тэгвэл би, энэ намар чамд орос хүүхэн олж өгнө. Чи миний буянаар Владивостокийн шар үстэй охидыг өвөртөлж үз дээ. Харин одоо жаахан ууя. Би нөгөөдөр гэхэд Чанкуфынд очоод чичирч явах байх. Тэгэхээр чи өнөө шөнө чичирч хоно! Хоёулаа бие биенийхээ зовлонгоос хуваалцъя.

Аяанаосу, Чанкуфын гэдэг үгийг Дайран симбун сониноос олж мэдсэн. Энэ бол Хасан нуурын баруун талд байдаг Заозерная өндөрлөгийн нэр байлаа. Аяанаосу Ёошигийн амнаас хэрэгтэй зүйлээ олж сонсох эгзэг гарсныг ойлгоод

- За тэгвэл чиний төлөө ууя. Орос сиро будопу (цагаан архи) захиалах уу? гэж лавлав. Чингэж эхэлсэн наргиан зоогийн газрыг хаатал үргэлжилж, орос цагаан архиар ходоодоо эрхлүүлсэн Ёоши хөл дээрээ тогтож чадахгүй болжээ. Тэгээд халсан аман дээрээ дэвэн дэлхийн юмыг уудлан бурлаа.

Аяанаосу сан, чи надтай найзлах хэрэгтэй! Би одоохондоо ийм байдалтай яваа боловч эзэн хааны түшмэлүүд намайг мартаагүй. Армийнхан үүнийг мэддэг болохоор маш чухал ажилд намайг урдаа барьдаг юм.

Намайг эзэн хааны дээд одонгоор шагнуулах гэж тодорхойлсон гэнэ. Хэрвээ миний тодруулсан баримтанд түшиглэсэн газрын зураг хийвэл квантуны арми, ялангуяа Доихарагийн штабынхан түүн дээр тактикийн сургууль сайн хийж чадвал манай цэргүүд Новокиевка, Раздольный болон Хасан нуурын баруун өмнөх Подгорная хүртэлх газрыг яах ийхийн зуургүй эзэлж Владивосток манайх болно. Долоон сар гэхэд газар нутгийн байр зүйн зургийн тодруулалтыг хийж, бэлэн болгох үүрэг өгч байна.

Би түүнийг ердөө сарын дотор амжуулна. Харин жанжин штаб газрын зурган дээр олигтой ажиллах боломж олговол найман сар гэхэд жинхэнэ ажиллагаа эхэлж чадна. Тэр үед Хасу Тоиши, мухар толгойтнуудыг оросын хилээс хөөчихсөн байна гэж хэлээд хундагатай архиа авах гэснээ нудраад асгачихлаа.

- Өө тоогүй юм боллоо. Сайхан архийг ингэж болохгүй шүү! гээд алгаараа ширээний бүтээлгэн дээр тунасан архийг дарж шингээгээд алгаа долоонгуутаа,

- Архи бол бурхны хишиг. Тэгэхээр архийг асгаж болохгүй. Долоогоод ч гэсэн ходоодондоо хийчих хэрэгтэй гээд согтуу нүдээр Хасу Тоиши руу гөлөрнө.

- Хасу Тоиши сан, чи явж болохгүй. Симото... гэснээ уруулаа цорвойлгоод,

- Чимээгүй! Цаана чинь урт чихтэй, алтан хошуутай юмнууд бий шүү гээд нүдээ аньсхийлгэж дохио өглөө.

Хасу Тоиши гэртээ ирээд нойр нь хүрсэнгүй. Тэгээд оройн уулзалтыг янз янзаар бодож үзлээ. Яаж ч бодсон тэр уулзалт ерийн биш ажээ. Аяанаосу, Хасу Тоишигийн оройн хоолыг дайруулахдаа нэлээн зүйл бодсон нь илэрхий байлаа. Ханширээгийн сүйрлийн дараа Хато, Хасу Тоишийг Сафроновынхонд түр шилжүүлж, умард солонгост очих тусгай үүрэгтэй. Цагаантны бага дарга нарт зэвсэгтэй хүнээс өөрийгөө хамгаалах арга заах үүрэг хүлээлгэв. Чингээд тэрээр арван орост мод чулуу ашиглаж, өөрийгөө хамгаалах арга зааж, кэндогийн бухутогоор (кэндо хийхэд хэрэглэдэг урт мод) өөрийгөө хамгаалах сургууль заав. Хайлараас Хатогийн тушаалаар ирсэн оросууд бухутогоор шаламгай хичээллэж, бас цэргийн газрын нэг мэргэжилтэн жиүдиүцу (зэвсгээс хамгаалах ёс) заалаа.

Энгийн номхон амьдарч буй ураг төрлийнхөө хүмүүсийн амиар сэтгэлийнхээ хорслыг тайлж алан хядах, тонон дээрэмдэх үйл ажиллагаанд бие сэтгэлээ зориулсан цагаантнуудыг чингэж сургаж байгаа нь Хасу Тоишигийн зэвүүг хүргэнэ. Ер нь Хасу Тоиши эдний хэн нэг нь Хатогийн даалгавраар өөрийг нь устгана гэдгийг ойлгож байлаа. Самурай нар Хасу Тоишийг ашиглах гэсэн бодолдоо хүрээгүй болохоор Сувдаагийн бодь мөрийг Сафронов, Ёоши хоёроор хөтлүүлсэн агаад түүний эзэн нь Тозияагийн гараар хүмүүжсэн Симото, түүний «зарц» Аяанаосу хоёрын ажиллагаа гэдэг төсөөлөл Хасу Тоишигийн сэтгэлийг эзэмдэнэ.

...Аяанаосу... Аяанаосу. Яагаад намайг Сувдаа эгчтэй уулзуулахыг бодсон бэ? Тэгэхдээ эгчийг бүр Хасбаатар ахтай холбоотой юм шиг ойлголт төрүүлэхийг бодож байсан эгчтэй уулзаад ганц ч үг сольж чадаагүй байхад Сафронов, Ёоши хоёр орж ирсэн! Ингэж нарийн зохион байгуулахдаа өнөө «хэрээ» хочтыг надаас салгасан шигээ ажиллажээ. Ингэхээр Аяанаосу хэн бэ? Амисэгийн үгээр бол кэмпэятайд ашиглагдсан шударга шулуун сэтгэлтэй, гүдэсхэн хүн байх ёстой. Анх надтай уулзахдаа тийм сэтгэгдэл төрүүлсэн. Тэгээд намайг сэнхрүүлж загнаад "Буруу замаар" будаа тээж яваа илжиг шиг болжээ гэсэн.

Энэ бүхэн хуурамч зүйл байсан гэж үү! Аяанаосу, намайг ахтайгаа уулз гэж ятгасан нь миний янзыг сонжсон хэрэг үү? Ёстой кэмпэятайн бэлтрэг байна даа. Энэ лүд миний бодол санааг мэдэж, ах эгч хоёртой холбогдсон зүйлийг надаас тодруулаад дараа нь Хато, Тозияа хоёрт худалддаг байх нь. Тэгвэл хүний зовлонгоор жаргал хийж, доллар олдог байж таарна! Тун холын бодолтой байжээ. Би түүнийг нь мэдэлгүй тэнэгтэж, Аяанаосуг хамгаалах санаатай өөрийнхөө хүмүүсийг ажиллуулсан. Гэтэл би өөрөө өөрийгөө гарах замгүй намагт хийжээ. Ингэхээр одоо яах вэ? Аяанаосу, Сафронов хоёрыг өөрийн нь аргаар устгах хэрэгтэй. Солонгос руу явахаас хагас цагийн өмнө амжиж Аяанаосуг устгавал Сафроновыг Солонгост очсон хойно учрыг нь олж болно.

Тэгээд ахтай нийлэхээс өөр сайхан зам надад байхгүй! Энэ зөв үү? гэж Хасу Тоиши өөрөөсөө байнга асуудаг болов. Хасу Тоиши ингэж бодсоор үүр цайлгаад дүрвэгсдийн товчооны доод давхарт бэлдсэн бэлтгэлийн танхимд орж ирлээ. Өглөөний таван цагт бэлтгэлд гарах ёстой хүмүүс цөмөөрөө хувцаслаад Хасу Тоишийг хүлээж байлаа.

Хасу Тоиши кэндогийн дасгалд хэрэглэдэг бухуто мод барьчихаад кана мэнээ (нүүр хамгаалах баг) сугавчилсан шавь нар руугаа сүрхий ажиглангуй харснаа бэлтгэлийнхээ кимоно өмсөхөөр өрөө рүүгээ орлоо. Чингээд хэдэн мөчийн дараа уужим танхимд бэлтгэл эхлэх нь тэрээ. Модоор өөрийгөө хамгаалах ёс зааж байсан энэхэн үед Сафронов гаднаас орж ирэхийг ажигласан Хасу Тоиши бэлтгэлээ түр зогсоогоод дэргэд нь очтол Сафронов мэндлээд,

- Чамайг генерал дуудаж байна гэлээ. Чингэтэл Тоиши Сафроновын хажуугаар дуугүй алхсаар танхимаас гарахдаа «Гайгүй ээ. Та нараас урьтаад шил рүү чинь сум зоож дөнгөнө байлгүй» гэж амандаа үглэв. Хасу Тоиши Сафроновын барааг хараад нүд нь хорсож, уур хилэн нь бадарсан аж. Тэрээр өөрийнхөө өрөөнд орж ирэнгүүт утсаа авч генералын туслахтай яриад хэсэгхэн хүлээтэл харилцуурын чихэвчинд Хатогийн дуу паржигнан, ханиах нь тод сонсогдоно.

- Хасу Тоиши сан, өнөө орой Сафронов онгоцоор явна. Чи нөгөөдрийн галт тэргээр гарахаар бэлтгэ! Ажлын чинь удирдамжийг Тумынд очсон хойно өгнө гэхэд Хасу Тоиши ёс төдий «Мэдлээ... гүйцэтгэе» гэлээ. Хасу Тоиши, утсаа тавихдаа «Одоо Аяанаосутай тооцоо хийдэг цаг! Миний совин татаад байсан нь Хатогоос ийм үг дуулах байсан юм байж!» гэж бодоод түр сургуулийн захиралд илтгэж, явах бэлтгэлээ хийхээр шийдэв. Хасу Тоиши, үд өнгөрөөгөөд дүрвэгсдийн товчоон дээр очиж, онгоцны буудал руу явлаа.

Сафроновыг гаргаж өгөхөөр дүрвэгсдийн товчооноос хэд хэдэн удирдах ажилтан ирсэн агаад Хатогийн газраас ердөө Хасу Тоиши байлаа. Сафронов, онгоцонд суухын өмнө буудал дээр ирсэн хотын гал унтраах хэсгийн даргатай уулзаж ярилцаж байснаа онгоц руу эргэхдээ ямар нэг юм санасан юм шиг түр зогсоод,

- Гал гарсан газар очих гэж яарсны хэрэггүй. Ер нь галыг унтраахаасаа өмнө байшинг шатаах нь чухал. Энэ тухай Симото, та бүхэнд заавар өгнө гээд онгоцны шат өөд мацлаа. Тэгээд онгоцны хаалганы дэргэд түр саатан гараараа даллаж салах ёс гүйцэтгэхдээ,

- Хасу Тоиши сан, хойноос хурдан очоорой! Би Тумынд хүлээж байна шүү гэхэд Хасу Тоишийн уруул татвасхийж сэтгэлд зэвүүрхэл төрлөө.

- Хэзээ яв гэж тушаана. Тэр цагт очно доо гэж амандаа хүйтэн дуугаар хэлснийг Сафронов атугай дэргэд нь зогсож байсан хүмүүс ч дуулах янзгүй болой. Хасу Тоиши, Сафроновыг явснаас хойш хоёр хонохдоо өөрийн тунгаасан бодлыг хэрэгжүүлэх аргаа бодлоо. Тэрээр оройн галт тэргээр Тумын руу явахаасаа өмнө галт тэрэгний буудал дээр очихдоо цагаа зохицуулахаар нарийн зохион байгуулав. Тэгээд гэрээсээ гарахын өмнө Аяанаосу руу утасдлаа.

- Чи гэртээ олуулаа байна уу?

- Үгүй шүү. Ердөө туслахтайгаа хоёулаа байна. Тэгээд ч туслах маань одоо гэр рүүгээ явна.

- Би танайд очмоор байна. Тэгэхдээ ганцаараа биш. Гурвуулаа очно.

- Би цаад хоёрыг чинь таних юм уу?

- Үгүй биз дээ. Саяхан Харбинд ирсэн хүүхнүүд..

- Тэгвэл сайн хэрэг байна. Шинэ танилтай болно гэдэг чинь эр хүний жаргал шүү дээ.

- Чамайг Харбины хүүхнүүдээс уйдсан байх гэж бодоод...

- Хасу Тоиши сан, чи уг нь далдыг мэддэг хүнсэн дээ. Намайг юугаар дутдагийг мэдэх хойно! Чи одоохон хүрээд ир. Манай туслах сая гарлаа. Би та нарыг хүлээж байя гэхэд Хасу Тоиши утсаа тавиад гүнээ санаа алдав. Тэрээр Аяанаосугийнд очоод ердөө арван мөчийн дотор санаснаа амжуулаад гарах ёстой. Тэгээд үүдийг нь сайн цоожлоод галт тэрэг хөдлөхөөс өмнө буудал дээр очиж байдлыг ажиглах хэрэгтэй. Хасу Тоиши, гэрээсээ гарахын өмнө галт тэрэгний буудал руу юмыг нь хүргэж өгөх туслахтайгаа уулзаад,

- Галт тэрэг хөдлөхөд цаг гаруй хугацаа үлджээ. Тэгэхээр чи, юмаа аваад галт тэрэгний буудал дээр очингуутаа унаагаа над руу явуулаарай. Би төв шуудангийн хавьд жолоочийг хүлээж байх болно. Би одоохон нэг эмэгтэйтэй уулзаад ирье. Дарга нар намайг асуувал аятайхан шиг аргалаад хэлчихнэ биз. Чи намайг буудал дээр хүлээж байгаарай гээд гэрээсээ гарлаа.

Аяанаосугийнх төв шуудангаас холгүй байдаг болохоор Хасу Тоиши цагаа тааруулахын тулд тайван гэлдэрсээр Аяанаосугийн байшингийн дэргэд очиж хэсэгхэн зогсож гудамжийг ажиглаад хаалгыг нь тогшлоо. Аяанаосу хаалгаа онгойлгож өгөнгүүтээ инээмсэглэсээр,

- Чи чинь яагаад ганцаараа ирээ вэ? гэж асуулаа.

- Иөгөөдүүл ингэсхийгээд ирнэ гээд Хасу Тоиши, зочдын өрөөнд орохдоо гар бууныхаа гэрний товчийг тайлав. Аяанаосу нөгөө өрөөнөөс орж ирэнгүүт ханынхаа шүүгээ рүү эргэж, чи хувцсаа хөнгөлөөч. Хасу Тоиши чи хатуухан юм уух уу? гэлээ.

- Сакэ дээр биз дээ гэж Хасу Тоишийг хэлэхэд дууны өнгө хүйтэн, хөндий болохыг Аяанаосу түвэггүй мэдлээ.

Аяанаосу, шилтэй сакэ, хундага барьсаар Хасу Тоишигийн дэргэд суугаад сакэ хундагалахдаа,

- Сафронов сан солонгос руу явсан гэл үү? Харин чи хэзээ явах вэ? гэхэд Хасу Тоиши, Аяанаосуг ширтсээр "Иамайг явах өдрийг энэ мэдээгүй гэдэг ч юу бол доо. Яг мэдээгүй юм гэхэд тоймлож баймаар юм даа. Гэхдээ сонжилт байж ч магадгүй. Ханширээ рүү Сафронов Ёоши хоёрыг Сувдаагаас түрүүлж явсныг энэ мэдэж байсан. Түүн шигээ Сафроновын зорилгыг надаас ч илүү мэдэж байгаа биз" гэж бодлоо.

- Ханширээгийн сүйрлийн өмнө Сафронов, Ёоши хоёр тийшээ явсны адилаар одоо зуузай

холбоод Тумын руу явсан. Тэгэхээр одоо миний ээлж болсон юм байлгүй дээ гэж хэгжүүхэн янзтай хэлээд хундагатай сакэг авлаа.

Аяанаосу, энэ үгийг сонсоод ацан шалаанд орлоо. Тэрээр хундаганыхаа бөөрийг хурууныхаа өндгөөр үрж суухдаа «За энэ чинь эгзэгтэй хэрэг! Би одоо яах ёстой вэ? Амьдрал ахуйнхаа үнэнийг олж харсан Хасу Тоишийг аврахгүй бол залуу насаа хүний гарт алдана. Тэгээд зогсохгүй ахын нь амь насанд халтай. Гэтэл ийм асуудлыг би ганцаараа толгой даан шийдэж болохгүй.

Чухам одоо л Рожусайтай холбоо баримаар байдаг. Гэтэл холбоочин Харбинд ирээгүй шүү дээ» гэж бодно. Аяанаосу чингэж бодсоор хэсэг дуугүй байлаа. Тэрээр юуны өмнө Хасу Тоишийд Улаанбаатарт очиж ээжтэйгээ уулзсан Сувдаагийн тухай сонсгомоор санагдана. Ингэж хэлэх нь Аяанаосугийн эрх мэдэлд таарахгүй. Гэхдээ тухайн нөхцөл, зайлшгүй хэлэх байдалд хүргэвэл түүний учир холбогдлыг тайлбарлахаас өөр аргагүй гэдэг нь илэрхий.

- Аяанаосу сан, чи яагаад усанд хаячихсан чулуу шиг таг болчихоо вэ? Миний үгийг сонсоход зэвүүн байна уу? гэж асуух нь цаанаа зэвүүн аж. Аяанаосу сакэ хундагалаад хэсэг дуугүй суухдаа «Хасу Тоиши, яагаад ийм үг хэлэв?

Царай зүс, үг ярианы өнгө цаанаа өдсөн байдалтай мөртлөө хонзогносон шинжтэй» гэж бодов. Харин Хасу Тоиши, Аяанаосуг дуугүй дүмбэгэр байгааг хараад дургүй нь хүрч,

- Та нарын бодлоор бол манай удам, самурай нарын эм тан, мэс, сумны золионд сүйрэх ёстой байх нь ээ гэж багтарсан дуугаар хэлсэн Хасу Тоишийг ширтэж суусан Аяанаосу түүний уур омгийн учрыг сая ойлгов. Тэгээд Хасу Тоишийн үг яриа, харц, нүүр царайны өөрчлөлтөөр түүний бодлыг багцаална. Дуугүй суугаа Аяанаосуг хараад Хасу Тоиши уур омогтоо бүр шатаж, хорсохын эрхэнд,

- Чи ч монгол хүний мөсгүй эр юм даа! Самурайн гарын үзүүрт зарагдаж, амь тээж ядсан хорхой шиг арчаагүй амьтан болжээ. Ёстой кэмпэйтэйн тэжээсэн нохой! гэж хэлээд цагаа харвал Аяанаосугийнхаас гарах цаг дөхөж байлаа. Чингээд Хасу Тоиши өөртөө "Энэ новштой олон юм яриад яахав! Үнэнийг хэлэхээр өчих үггүй гөлөгнөж байгаа нь илт байна. Ийм амьтан хорвоод амьд явах ёсгүй. Одоо суудлаасаа босохдоо сэжиг авахуулахгүй байх нь чухал! Тиймээс яриагаа үргэлжлүүлсэн янз гаргаж өрөөнд нь холхихдоо бууныхаа дуу намсгагчийг бууны аманд шургуулангуугаа гохоо дарж амжих нь чухал! Энэ бузар золиг хорвоогоос тонилж байвал болох нь тэр! Энэ лүд Юкийг мэдэж байгаа. Хэн ч мэдээгүй бидний ураг төрлийн холбоог нуун далдлахын тулд Тозияагийн даалгавраар эгчийг минь устгасан нохойнуудын нэг нь энэ мөн!" гэж өөртөө шивнэн сануулна.

Хасу Тоишийг суудлаасаа өндийх тэрхэн эгшинд түүний ташаан дахь гар бууны гэр товчлогдоогүйг Аяанаосу ажиглав. Чухам энэхэн хоромд Аяанаосу, жиүдиүцү юмуу эсвэл каратэгийн сонгомол аргаар хөнгөн цохилт хийж өөрийгөө хамгаалах хэрэгтэй гэдгийг ойлгоод ямар ч нөхцөлд сонгомол хөдөлгөөн хэрэглэх зайгаа авахын тулд Хасу Тоишигоос тохой хэртэй холдох хэрэгтэй байв.

- Аяанаосу сан, чи миний ярьсныг Симото, Сафронов хоёрын аль алинд нь ховлоно гэж

бодож байна уу? Ингэхээр миний гараар та нарын хэн нь ч могой барьж чадахгүй гээд халааснаасаа дуу намсгагчаа аваад бууны аманд шургуулах тэрхэн эгшинд суудлаасаа самбаачлан өндийсөн Аяанаосу диваны өмнөх явган ширээг шүүрэн авч чулуудахдаа Хасу Тоишигийн буутай гарыг алдалгүй оножээ.

Хасу Тоиши буугаа алдангуут өөрөө эвгүй байдалд орж магадгүйг ойлгоод бүх биеэ суллан зогсолтоо өөрчилж, эгшин зуур алхалтаа тааруулж (каратэгийн ёсоор) хөдлөхдөө зүүн хөлийнхөө өсгийгөөр Аяанаосуг цохих эгшинд зүүн гарынхаа цохилтыг чамархайд буулгах ёстой байлаа. Каратэгийн хөдөлгөөнөөр алхалтаа тохируулсан Хасу Тоишигийн дайралтаас бултсан Аяанаосу буруу тал руугаа зайлахдаа зүүн гарын алгаар Хасу Тоишигийн хөлний өсгий рүү цохихдоо хагас алхам ухарсан нь Хасу Тоишигийн дараагийн хөдөлгөөнөөс хамгаалах боломж гарчээ.

Каратэгийн ёсоор бол Аяанаосу Хасу Тоишигийн зүүн хөлийн цохилтыг баруун гарын алганы хажуугаар цохин зайлуулаад тэрхэн хоромд баруун хөл дээрээ тогтож биеэрээ эргэхдээ зүүн хөлийн өсгийн цохилтыг Хасу Тоишигийн харвинд тохируулах ёстойгоос гадна зүүн гарын цохилтоо шанаанд тааруулах байсан.

Монгол бөхийн өсгийлдөх аргыг каратэгийн хөдөлгөөнд тохируулж сөрөг мэх боловсруулж өвөрмөц хувилбар боловсруулсан Аяанаосу Хасу Тоишигийн дараачийн хөдөлгөөнийг хийлгэхгүйн тулд хар тавхайнд алгаа тааруулж цохихдоо өөр рүүгээ сулхан татсан нь Хасу Тоишигийн хөдөлгөөний хэмийг алдагдуулж, шалнаас тохой хэртэй үсрээд өрөөний шалан дээр унажээ. Аяанаосу шалан дээр унасан Хасу Тоишигийн дэргэдээс бууг нь өшиглөж зайлуулаад,

- Хасу Тоиши сан, одоо миний үгийг тэвчээртэй сонс! Юуны өмнө Сувдаа амьд байгааг чамд дуулгах ёстой гэхэд Хасу Тоиши үг хэлж чадалгүй ээрч амаа ангайлгасаар Аяанаосугийн царай өөд гөлөрнө. Түүний нүд ер бусын аймшигтай болжээ.

Тумынган. Умард солонгост алдаршсан Пэктусон хэмээх галт уулын ойролцоогоос эх авсан энэ гол хятад солонгосын хилийг зааглан урссаар зүүн хойд хэсгээрээ Зөвлөлтийн алс дорнод, манжуур, солонгосын хилийн уулзвар бэлчир болдог ажээ. Тумынган Солонгос-Манжуурын хилийг заагладгийн адилаар Зөвлөлтийн алс дорнодын өмнөд хилийн Подгорная хэмээх суурины ойролцоо урсана. Тумынган буюу Тумынцян голын хоёр эргээр солонгос манжуурын хэд хэдэн тосгон бий. Түүний нэлээд томхон нь Хомуку /Сюйму/ билээ.

Энэ тосгон Хасан нуураас ердөө тав зургаахан бээрийн хэртэй зайдуу байдаг. Энэ суурин Зөвлөлтийн алс дорнодын хилийн Заозерная, Пулемётная горка, Безыменная өндөрлөгүүдэд маш ойрхон болой. Нөгөө талаар Тумын хотыг Чанчунь /Синьзин/ Гирин Харбинтай холбосон төмөр зам Тумынган голын хөвөөг даган үргэлжилж Солонгосын Оносон, Кевон, Сонион, Иасанифо, Иансеосандо суурин хүрэх ажээ. Эдгээр суурингууд Зөвлөлтийн алс дорнодын хилээс найман бээрийн зайтай оршино.

Зуны адаг сарын эхээр Хомуку сууринд хэдэн суудлын тэрэг иржээ. Манжуурын хилийг улааны нөлөөнөөс сахин хамгаалж буй японы цэргийнхэн тэдгээр гийчдийг хүлээн авах тусгай үүрэгтэй болохоор дүрвэгсдийн товчооны ажилтангуудыг Дигашели сууринд тохилог

суулгахаар бэлдсэн учраас хэдэн айлуудыг суурингаас зайлуулахдаа "Улаан оросууд удахгүй довтолж, сууринг эзлэх гэж буй тул та бүхнийг хамгаалах зорилгоор тусгай хэсэг ирсэн. Тиймээс тэднийг орон сууцаар хангах хийгээд та бүхнийг аюулгүй байлгах шаардлагаар суурингаас гаргах шаардлагатай байна. Тэгэхгүй бол улаан оросын цэргүүд тосгонд орж ирээд та нарын эхнэр охидыг хүчиндэж, хамаг олигтой юмыг чинь дээрэмдэх болно" гэж айлган сүрдүүлэх замаар ятгажээ. Дигашелид саяхан ирсэн армийн хо лбооны цэргийн нэг бага дарга, квантуны армийн тусгай даалгавраар ирсэн хэвлэл мэдээллийн ажилтан Тогава, газрын зургийн мэргэжилтэн Ёоши хоёрыг суурингийн нэлээн тохилог байшинд суулгахаар шийдэж, гэрийн эзэнтэй уулзав.

- Улаан оросууд өнөө маргаашгүй ихээхэн хүчээр танай тосгоныг эзлэх гэж байна. Тиймээс та нарыг ар тийш нь нүүлгэх болсон гэхэд япон бага дарга Кобоясигийн шаардлагыг үл зөвшөөрсөн гэрийн эзэн өвгөн,

- Манай өвөг дээдэс энэ сууринг анх байгуулсан учраас үхсэн ч эндээ үхнэ. Тосгоноос гарахгүй гэлээ. Харин Ёоши энэ бүхнийг мэдсэний дараа гэрийн эзэн өвгөнтэй уулзаж,

- Та эндээс нүүхгүй байж болно. Гэхдээ манай талаас тавьсан шаардлагыг биелүүлэх ёстой. Та энэ газар нутгийг болон Оросын Хасан нуурын орчмыг хэзээ хэзээнээсээ манжуурын нутаг байсан гэдгийг баталж өгөх хэрэгтэй! Үүнийг биелүүлбэл эндээс дүрвэх хэрэггүй. Харин эс биелүүлбэл манай цэргийн нууцыг хадгалах хуулийн дагуу таныг тусгай заасан нутагт шилжүүлэх болно гэж сүрдүүлжээ. Тэгээд холбооны бага дарга Ёоши, Тогава хоёрыг өөр байшинд байрлуулав.

- Ёоши сан, та Хасу Тоиши, Сафронов хоёрыг хүлээхээр шийдэв үү? Эсвэл ажлаа шууд эхлэхээр шийдэв үү? гэж Тогавааг асуухад Ёоши,

- Тэднийг хүлээнэ гэлээ.

Тогава энэ хэдэн жил Симотогийн буянаар айж эмээх зүрхшин шимшрэх аюулгүй овоо амьдарсан. Тэгээд эчнээний гүнд хурсан айдас хүйдэс арилж айх эмээхийн аюулыг мартаад Аяанаосу хэмээх Буянтын нэрийг санахаа больсон. Тогава, өвөр монголын зүүн хойд нутагт японы эзэн хааны армиас явуулж байгаа улс төр, «эрх чөлөөний» тухай сурталчлах албандаа чармайн зүтгэж хэдэн жилийн өмнөх нүглээ цагаатгаад зогссонгүй хошууч цол хүртжээ. Тогава ингэж дэвшсэн явдал бол Сөнөд хошууны ван Дэмчигдонров нэлээн дэмжлэг үзүүлсэнд оршино.

Тогава хоёр жилийн өмнө эмхлэн цэгцэлсэн өвөр монголын засгийн газрын дэргэд байдаг япон зөвлөхийн бөөрөнд хавчуулагджээ. Тэгээд өвөр монголын засгийн газар гэгчийг эмхлэх ажилд хүчин зүтгэсэн билээ. Тэрээр Да ванд дотно хандаж түүний холын хамаатан нэгэн бүсгүйтэй дэр нийлүүлсэн боловч албан үүргийнхээ дагуу нууцалж билээ. Харин сарын өмнө квантуны армийн жанжин Уэда дуудаж алс дорнодод болох "нэгэн гайхамшгийн" талаар Токио болон манжуурын бүх сонинд мэдээлэх үүрэг өгсөн. Ингээд анхны томилолтоор Хомуку сууринд ирж байгаа нь энэ ажээ.

- Сафронов тэр хоёр Хуньчунд очих ёстой. Тэгээд наашаа ирэх юм.

- Хуньчун... Хуньчун. Үүнийг чинь тун их сонссон юм байх чинь...

- Тогава сан, та чинь армийн томоохон сурвалжлагч байж Хуньчуныг мэдэхгүй байна уу даа гэхэд Тогава амандаа "Хуньчун... Хуньчун" гэж давтан үглэв.

- Тогава сан, та 1886 онд Орос Хятад хоёрын хооронд байгуулсан гэрээг мэдэх үү? гэж Ёошийг асуухад Хато генералын ярьж байсан зүйл сая Тогавагийн санаанд орлоо.

- Тийм... тийм. Орос хятадын гэрээг Хуньчунд хийсэн юм. Одоо саналаа.

- Та чинь ёстой сурвалжлагч хүн шиг сүрхий ойтой юм. Үгийн сэжим гарав уу үгүй бүгдийг нь санадаг байна шүү. Харин та нэг зүйлийг мартаж болохгүй. Орос хятадын тэр хэлэлцээгээр Хасан нуурыг Оросын газар нутгийн салшгүй хэсэг гэдгийг баталсан юм. Бидний зорилгод түр гэрээ хамаагүй зүйл! Тиймээс бид Хасан нуурыг цэргийн хүчээр эзэлж чадвал манай арми Посьётын булангаас Владивосток руу дайрч эзлээд алс дорнодод эзэн хааны сүр хүчийг мандуулна. Үүний дараагаар манай арми Сибирь, ар Монгол, манжуур, өвөр Монголыг нэгтгэж умард хятадыг хамарсан энэ уужим нутгийг Азийн сэргэн мандалтын голомт болгож ХХ зууны гайхамшиг болгох ёстой.

Тогава, Ёошигийн үгийг сонсоод Хатогийн биечлэн өгсөн даалгаврыг саналаа. Тогава нутгийн хүмүүсийн нэр барьж, Хасан нуурыг манжуурын нутаг байсан гэдэг хуурамч цуурхал тараахын зэрэгцээ Зөвлөлт засаг төрд дургүй хүмүүсийг олж, хээл хахууль өгөх замаар хуурамч баримт гаргуулаад Токиогийн сонинуудад илгээх ёстой. Энэ үүргийг Ёоши, Тогавагийн адил хүлээн авсан. Тогава, Ёоши хоёрыг Хомукуд байрласны маргааш хилийн цэргийн бага дарга, Дигашели суурингаас нүүгээгүй өнөө хөгшнийг уулзуулахаар авчирлаа. Тэгээд Тогава, Ёоши хоёр албан үүргийнхээ дагуу өвгөнтэй ярилцахад хилийн цэргийн орчуулагчаар хэлмэрчлүүлэв.

- Хөгшөөн та, энэ нутгийг аль зэрэг мэдэх вэ? гэж Тогавааг асуухад

- Энэ нутагт миний мэдэхгүй дов толгод гэж байхгүй. Тэгээд ч манай өвөг дээдэс энд шарилаа тавьсан юм.

- Танай өвөг дээдэс Хасан нуураар нутаглаж байсан биз дээ.

- Манайхан Хасан нуураар нутаглаж байгаагүй. Харин Тумынцян, Хасан нуурын энэ газар нутагт манай өвөг дээдсийг ирэхээс өмнө оросууд нутаглаж байсан гэдэг. Харин тавин хоёр жилийн өмнө хятадын хүсэлтээр оросууд одоогийн энэ газрыг нутгийнханд шилжүүлсэн гэж ярьдаг. Түүнээс Хасан нуурыг манайхны нутаг гэж ярьж байхыг би сонсоогүй. Тиймээс манай энд чинь Чёрная, Заяц гэдэг нуур, Богомольница гэдэг орос нэртэй газрууд олон байдаг юм. Ингэхээр Хасан нуур хэзээ хэзээнээсээ оросуудын нутаг гэхэд орчуулагч өвгөний үгийг арай ядан орчуулав. Учир нь хилийн цэргийн дарга түүнд өгсөн үүргэндээ «Өвгөний үгийг зөөллөж орчуулаарай. Хасан нуурыг оросуудын нутаг мөн ч гэсэн биш гэж орчуулах хэрэгтэй шүү» гэсэн. Гэвч орчуулагч тэгж зүрхэлсэнгүй. Тогава, өвгөний яриаг сонсоод эгдүүцсэндээ,

- Энэ хөгшин жаахан солиотой байх. Ийм хүн бидэнд хэрэггүй гэж хэлэхэд Ёоши өвгөний дэргэд ирээд,

- Зөнөг минь та миний хэлснийг мартаа юу? гэж сүртэй хашгачин асуухад өвгөн Ёошийн царай өөд гөлөрсөөр,

- Ноён даргаа, юуны өмнө танд худлаа хэлээд яах вэ? Нөгөө талаар Хасан нуурыг оросын нутаг гэдгийг батлах Хуньчунгийн гэрээ бий шүү дээ. Тэгэхээр үнэнийг гуйвуулж нүгэл үйлдээд яах вэ? Тамд очоод аяыг нь даахгүй шүү дээ гэлээ.

- Төрж өссөн нутгаа орост алдчихаад ингэж хэлдэг хүн байх уу? Ийм юмнуудыг үг үсэггүй устгаж байх хэрэгтэй гэж агсарлаа. Тогава, Хомуку Дигашели суурингаар явж, нүүж амжаагүй хэдэн хүмүүстэй уулзсан боловч түүний зорилго бүтэх царайгүй боллоо. Тогава, квантуны армийн удирдагч Уэдагийн үгийг саналаа. Тэрээр сарын өмнө армийн удирдах ажилтнуудад хийсэн яриандаа «Эзэн хааны арми манжуурыг тусгаар улс болгоод долоон жил болох гэж байна. Гэтэл манжуурын нутгийн салшгүй хэсэг болсон Хасан нуурыг манжуурт эргүүлж өгөөгүй оросууд өөрсдийн дураар эзэлсээр байна. Тиймээс эзэн хааны зарчмыг баримталж дайны замаар манжуурын алдагдсан нутгийг буцааж авах үйл хэргийг хэрэгжүүлэх нь бидний гол зорилт болж байна» гэж билээ. Штабынхан Тогаваад зөвлөгөө өгөхдөө «Хасан нуур манжуурын нутаг гэдгийг нутгийнхан андахгүй. Тэгэхээр захын хүн сонинд нийтлүүлэх зүйлийг хэлээд өгнө. Харин нэг эгзэг бий. Улаан оросын нөлөөнд автагдсан хүмүүс бол чамд тус болохгүй гэдгийг санах хэрэгтэй» гэж билээ. Тогава хориод хүнтэй уулзахад Хасан нуурыг өөрийнхөө өвөг дээдсийн тахилгатай эртний нутаг гэдгийг батлах хүн гарсангүй. Гэсэн ч Тогава армийнхны үгэнд итгэж «Улааны нөлөө их шингэсэн газар байна. Тиймээс хээл хахууль цутгахгүй бол хэрэг бүтэхгүй нь» гэж бодов. Үнэндээ ингэхгүй бол Тогава амьд явах хоногийн тоо богиносож мэдэх осолтой ажээ. Тэгэхдээ бүүр ялтан болж цаазлуулна гэдэг илэрхий. Армийн удирдлагаас авсан үүргээ самурайн ёсоор биелүүлэхгүй бол цаазлуулдаг хуультай. Залуугаараа цаазлуулна гэдэг бол шившигтэй. Аав нь түүнийг үхэж болохгүй гэсэн. Үхэхгүйн тулд авхаалж самбаа гаргах ёстой. Тэгэхдээ эр хүний арван гурван мэхээр амиа аврах хэрэгтэй байлаа. Тогава, худлаа ч гэсэн ямар нэг мэдээ Токио руу явуулах ёстой болжээ.

Токиогийн сонинуудад хуурамч баримт явуулахаас Тогава айсангүй. Учир нь энэ бүхэн армийн ашиг сонирхолтой нийлж байгаа болой. Худлаа мэдээ хэвлүүлсэн байхад армийнхан түүнийг хамгаална гэдэг илэрхий. Нөгөө талаар Тогавагийн сэтгэлийг тайвшруулсан нэг зүйл бол «Самурайн бусидо» ёсонд армийн үйл хэргийг цэвэр ариун байлгахын тулд гэм буруутай хүнийг алж болно гэж зөвшөөрдөг сургаал юм. Тиймээс Тогава хилийн цэргийн бага даргаар нутгийнхныг байцаалгаж, болохгүй бол тэднийг устгах сүрдүүлэг хэрэглэж, зарим хүмүүсийг тосгоныхны нүдэн дээр буудвал «айсан хүмүүс худлаа ч гэсэн баталгаа гаргаж өгнө» гэдэгт итгэнэ. Чингээд Хомуку Дигашели суурингаас нүүхгүй гэсэн хүмүүсийг баривчилж Ёошигийн сургаалаар «дэнчин» тавьж байцаасан боловч ямар ч амжилт олсонгүй.

- Шиү са доноо (эрхэм хошууч аа) эндхийн хөгшчүүл нэг хэвийн юм яриад байна. Тэдний хэн нь ч Хасан нуурыг манжуурын нутаг гэдэг баталгаа гаргах янзгүй нь гэж хилийн бага дарга илтгэв.

- Чи улааны үзэлтэй болсон хүмүүстэй эвлэрэнгүй харьцаж байна. Ацаг хөлс амла. Болохгүй бол яс маханд нь даатга! Тэгээд хэлэхгүй бол хэдэр зантай хүмүүсийг нь олны өмнө аваачиж хэлийг нь огтол! Мөчийг нь салга. Мэдэв үү! Чи эзэн хааны өмнө буруутай доод заяаны амьтдын амийг ч өршөөх ёсгүй гэдгээ мэдэж байгаа биз. Улааныхныг хайрлаад байвал, өөрийн чинь арьсыг хуулна гэдгийг мэдэж ав! Хасан нуур улаан оросын нутаг байлаа ч гэсэн түүнийг манжуурын нутаг болгох ёстой. Бидний цэрэг эрсийн замнал бусидоод ингэж сургадаг гэж байдаг хүчээрээ чарлан хэллээ. Ингээд Хомокуд арваад хонохдоо найман хүний амь насыг бүрэлгүүлжээ. Гэсэн ч Тогава Хасан нуурыг манжуурын нутаг гэдэг тодорхойлолтыг нутгийнхнаар гаргуулж чадсангүй. Харин түүнийг оросын нутаг гэдгийг нутгийн арваад хүн амь насаараа баталсныг мэдсэн Уэда, тусгай холбоогоор дамжуулж Тогаватай ярилаа.

- Шиү са Тогава, чи чинь элсэнд булсан яст мэлхийн өндөг шиг яагаад дуугүй суугаад байна. Долоо хоногийн өмнөөс Токио, Мүгдэн, Харбины сонинуудад таны баримтууд нийтлэгдэх ёстой гэж ширүүн шаардлаа.

- Гакка (эрхэм дээдсээ) хорин таван хүнтэй уулзлаа. Гэтэл тэдний хэн нь... гээд дараагийнхаа үгийг хэлж чадаагүй байтал,

- Би чамаас хэдэн хүний толгой «залгисан бэ?» гэж асуугаагүй. Ер нь нутгийн хүмүүстэй уулзах хэрэг чамд байгаагүй. Иөгөөдрийн дотор энэ мэтээр дуугүй суугаад байвал та өөртөө эртний самурайн ёсыг дагаж сеппукуд бэлдэх хэрэгтэй гэдгийг сануулъя. Бусидоод үнэнч цэрэг эр бол үүнийг надаар хэлүүлэлтгүй шүү гэж ширүүн тулгалаа.

Квантуны армийн удирдагчийн энэ үүргийг чагнаж, чагнуураа чихэндээ барьсаар хэсэг дуугүй зогсохдоо ар нуруугаараа хүйтэн хөлс чийхарсныг Тогава гадарлаад айж тэвдсэнээ мэдэв.

Одоо яанаа. Хасан нуурын хэргээр энд хэдэн хүний амь нас гарзасаныг гакка мэдсэн болохоор хатуу юм дуулна даа. Хилийнхэн эндхийн хүмүүсийн амь насанд хамаагүй халдлаа гэж дургүйцэж байсан. Тэгэхээр хилийнхэн, нутгийнхны аль аль нь дээш мэдээлсэн байж таарах нь. Ингэхээр одоо мэдээ бичих хэрэгтэй. Хурдан бичье гэж өөртөө сануулан хэлээд цаас үзэг нийлүүлсэн боловч хамаг бие нь салгалаад бичих тэнхээгүй болжээ. Чингээд өөрийнхөө улаан голоо аврахын тул санаанаасаа зохиосон хуурамч мэдээ сонинд илгээхээр сэтгэл шулуудаад өөрийгөө тайвшруулахын тул нүдээ аньж хэрхэн эхлэхээ бодохдоо "Ёоши хил дээрээс ирэх болоогүй юм байх даа" гэж өөрөөсөө асуугаад санаа алдав.

Гурав. Хүслээ биелүүлэхийн дон шүглэсэн нь

Ёоши, Зөвлөлтийн алс дорнодын хилийн өмнөд хэсгийн газар нутгийг тодруулахаар Орос, Солонгос, Манжуур гурван улсын хилийн зааг дээр ирээд хилийн чанадад илгээх оросын дүрвэгсдийн товчооноос бэлдсэн хүмүүст зохих ёсны заавар өгөөд байр зүйн тодруулалт хийх хэсгийг таван групп болгов.

- Та нар өдрийн цагт хуваарилсан газраа гуу жалганд өнжиж, үүрийн дөрвөн цагаас өглөөний найман цагийн хооронд ажлаа амжуулж, оройн цагийг сайн ашиглах хэрэгтэй. Юуны өмнө санах нэг зүйл бол ойролцоох гацаа тосгоноос настай хүмүүсийг сэм баривчилж газар нутгийн байдлыг тодруулж, нэрийг нь хэлүүлж зөв тэмдэглэж байх явдал! Эцэст нь хэлэхэд газар нутгийн тодруулалтанд ашигласан хүмүүсийг амьд үлдээж болохгүй. Тодруулалтын ажлыг гүйцэтгэх хоёр хэсэг Хасан нуурын зүүнтэйгээр газар орныг тодруулах бөгөөд тавдугаар хэсэг бол Хасан нуурын орчимд байгаа оросын цэргийн хүчийг мэдэх, тэдний зэвсэг, байрлалыг тогтоох болно.

Өнөө маргаашдаа та бүхэн амарч сэтгэлээ сэргээх хэрэгтэй. Гирингээс хүүхнүүд авчруулсан. Харин хэлэхэд гахай шиг ухаан жолоогүй «гударч» болохгүй. Нөгөөдөр орой гэхэд хүн бүхэн эрүүл байх ёстой! Хэрвээ архи ханхлуулсан байвал байлдааны цагийн хуулиар шийтгэнэ! гэж ажил төрлийнхөө яриаг дуусгав.

Ёоши, Хомукуд ирснээс хойш хоёр хоноод Хайларт оросын хорлон сүйтгэгч бэлддэг түр сургуулиас шилж авсан хүмүүстэйгээ ажиллаж, тэднийг улаан оросын дарга нарын хувцсаар хувцаслах, бичиг баримтыг нь шалгаж, сэжиг бүхий зүйл байгаа эсэхэд хяналт тавьж, магадлах зэргээр хилийн хэдэн дарга нартай нийлж ажилласан болохоор Тогаватай уулзаж чадаагүй. Тэрээр Нансеосандоо сууринд байгаа оросын цагаачидтай хэд хоног ажилласны дараа Тумын руу хөдлөв. Тэгээд маргааш өглөө гэхэд Хуньчунд ирлээ. Түүнийг Хуньчунд оросын дүрвэгсдийн товчооны Мешанов хүлээж байлаа. Мешанов, Ёошийг Манжуурт ирж суурьшсанаас хойш Сафроновын газар шилжин ажиллаж, газрын зургийн мэргэжилтнүүдтэй дөрөө нийлүүлсэн билээ. Мешанов, Ёошигоор хичээл заалгуулж, орон нутгийн онцлог газрыг ажиглах, нүдний баримжаагаар уул толгойн өндрийг ойр хавийн тодорхой юмтай холбон харьцуулах замаар тогтоох хийгээд гуу жалга, судгийн чиглэл байр байдлаар тэрхүү уул толгой, хөндийн байрлалыг тодорхойлох арга барилд нэлээн дадлагажжээ.

Ёоши, Мешановтой чингэж ажиллахдаа түүний ажилч, хичээнгүйг мэдээд дотроо олзуурхан магтаж байв. Чингээд Ёоши Сафроновтой ярилцаж түүнийг Хасан нуурын байр зүйн зургийг тодруулахад ашиглах зорилгоор хоёр хэсгийг удирдуулжээ. Түүний удирдсан хэсэг Чёрный нуруу Луна уулын чиглэлээр орж, хилийн чанадад ажиллах бөгөөд Мешановын ажлыг амжилтанд хүргэхийн тулд Далунлин нуруугаар үзэгдэх болсон орон нутгийн мухар толгойтнуудыг цэвэрлэж саадгүй болгох үүргийг Сафронов, Хасу Тоиши хоёрт өгчээ. Чингээд Сафронов, Хасу Тоиши хоёр өөрийнхөө хэсгийг квантуны армийн хээрийн цагдаагийн газрын гурван хороотой нэгтгээд Луна уулнаас Далунлингийн нуруу хүртэлх газрыг хяналтандаа авч, тэндхийг цэвэрлэх ажилдаа оржээ.

Сафронов, Хасу Тоиши хоёр Чёрный нурууны хавиар Посьётын буланг чиглэж гарах

Мешановын хэсгийг зохион байгуулаад хил давуулах ажилд ороод гурав хонолоо. Чухам энэ үед Ёоши иржээ.

- Ёоши сан, манай хэсгийг хил давуулах газрыг сонгох ажлаар явсан хурандаа, Хасу Тоиши хоёр бидэнтэй холбоо бариагүй байна. Надад таныг тосож авах үүрэг өгөөд газарчлахыг даалгасан гэж Мешановын илтгэхэд Ёоши дотроо "Бүтэлгүй новшнууд! Одоо хүртэл зугаа цэнгэл хөөцөлдөж байгаа хэрэг байх нь" гэж үглээд хилийн цэргийн удирдлагатай уулзахаар яаравчилж Хуньчунгаас Тайнен руу хөдлөв. Тайненд иртэл тэндхийн удирдах хүмүүс Панлингийн нуруу явчихсан байв. Чингээд оройхон хэрд ирсэн хилийнхэнтэй Ёоши уулзаж учир байдлыг лавлав.

- Ёоши сан, Сафронов удирдамж ёсоор Панлингийн нурууны зүүн хэсэгт очсон боловч мухар толгойтны томоохон хүчтэй тулгарсан байна. Цагийн өмнөх мэдээгээр бол Хуньчун голын зүүн эрэг, Чёрный нурууны баруун хэсэгт хориглолтын байдалтай байсан. Сая туслах хүч явуулсан гэж илтгэв. Ёоши чингэж хээрийн цагдаагийн болон хилийн цэргийн дарга нарын илтгэлийг сонсоод бухимдаж байсан тэрхэн үед Сафронов, Хасу Тоиши хоёр, Хуньчун, голын эргээс алс дорнодын хил Чёрный нурууны баруун хэсэгт хилд ойрхон байв. Тэд удирдамж ёсоор хилийн ойролцоо будлиан дэгдээж, тэр газраасаа нэлээн зайдуухан газраар нэгдүгээр хэсгийг хил давуулах ёстой. Гэвч Сафронов удирдамж ёсоор ажилласангүй. Зөвлөлтийн хилийн цэрэг хүч нэмэгдүүлсэн хамгаалалтаар Чёрный нурууны бүх нүх сүвийг хяналтандаа авсан аж. Иймээс Посьётын булан, Красно суурингийн чиглэлд гарах нэгдүгээр хэсэг саатаж байлаа. Панлингийн нуруунаас бууж ирсэн мухар толгойтнууд Сафроновынх руу дайрч голын баруун талд буцаж гарсан болохоор тэдний замыг хаасан мухар толгойтнууд голын эргийг хамгаалж байлаа. Тиймээс Сафронов нэмэгдэл хүч иртэл голын зүүн эрэг дээр мухар толгойтныг гаргахгүй барьж байх ёстой байв. Харин энэхэн үед Сафроновынхныг хамгаалах үүрэгтэй байсан хээрийн цагдаагийн хэдэн салаа цэргүүдээс тусгай үүрэг авсан гурван цэрэг, Хасу Тоишигийн хөдөлгөөн бүрийг анаж байв. Оройн нар хэвийж байхад мухар толгойтнуудаас нэг барга эр баригдлаа. Тэрээр өөрийн хүсэлтээр бууж өгснөөс гадна цэргийн удирдах хүмүүстэй уулзуулахыг шаардав.

Хээрийн цагдаагийн салааны дарга олзлогдсон хүний хүсэлтийн дагуу түүнийг тагнуулын хэсгийн удирдах хүмүүст тушаах ёстой аж. Чингээд нар шингэж байхад нутгийн тариачны ядуу тосгоны ахлагчийн байшинд байрласан Сафроновт, олзлогдсон хүнийг авчирч тушаажээ. Сафронов өрөөндөө Хасу Тоишитай хамт байсан болохоор олзлогдсон хүнтэй ярихаас төвөгшөөсөн байдалтай,

- Чи хэл мэддэгээрээ энэ баргатай ярь даа. Би эдний чинь яриаг ойлгодоггүй юм гэлээ. Хасу Тоиши цагаан ямбуу даавуугаар толгойгоо ороосон барга залууг ажиглан суухдаа "Ахын холбоочин байна. Энэ хүн Сафроновт сэжиглэгдсэн туршуулыг надаас нэхсэн, ахын захидлыг авчирч өгсөн шүү дээ. Намайг энд ирснийг яаж мэдээ юм бол! Намайг наашаа явсныг эдэнд мэдэгдэж чаддаг хүн хэн билээ. Аяанаосу сан байх ёстой. Тэгээд Сувдаагийн амийг бас Аяанаосу авруулсан хэрэг үү?" гэж бодлоо.

- Сафронов сан, та асуу, би орчуулж өгье гэж Хасу Тоишийг хэлэхэд хурандаа хэсэг дуугүй байснаа,

- Чи наадахтайгаа ярилц! Надад хүнтэй зууралдах зав алга. Би хүмүүстэй уулзаж маргаашийн ажил төрлөө тохиролцоно. Нөгөө талаар нэмэгдэл хүч ирэх ёстой. Түүнийг угтаж тосгоны зүүн байшингуудад байрлуулахыг бодъё гэж нууцлах ёстой зүйлээ илэн далангүй хэлээд гарлаа.

Хасбаатарын холбоочин Сафроновыг гарсны дараа хоромхон зуур дуугүй сууж чимээ чагнаж байснаа суудлаасаа босон хаалганд ойртон, нөгөө өрөөг холбосон хаалганы хавтсанд чихээ наалдуулах шахан хэсэг чагнаснаа Хасу Тоишигийн хажуугаар гарч цонх руу очсоноо холын бараа харагдах төдий байгаа харуй бүрийг ажигласнаа,

- Хасчулуун аа, бидэнд байгаа баттай баримтаар бол чамайг устгуулахаар тусгай хүмүүс бэлдсэн байна. Ах чинь голын баруун эрэг дээр чамайг хүлээж байгаа. Тиймээс одоо самбаачлах хэрэгтэй гэлээ.

- Эндээс тийм ч амархан мултрахгүй шүү. Хэрвээ намайг отоож байгаа бол тэд миний сүүдрийг ч алдахгүй хүмүүс байгаа.

- Манайхан гадаа хүлээж байгаа. Энэ цонхоор гарвал болох нь тэр! гээд цонх руу заалаа. Хасу Тоиши цонхонд ойртвол зэргэлдээх шавар байшингийн хоёр цонхоор дэнгийн гэрэл сүүмэлзэж байв. Энэ бол аюулгүйн дохио болохыг Хасу Тоиши гадарлаад энэ бүхнийг ахынхан нь нарийн зохион байгуулсныг мэдэв. Хасу Тоиши цаг гарздаж болохгүйг ухаарангуут хаалганыхаа дэргэд очиж, чимээ гаргалгүй онгойлговол зэргэлдээх өрөөнд хэн ч байсангүй. Тэгээд хаалгаа хаангуут дотор талаас нь сайн түгжээд цонх руу алхлаа.

Хасчулуун ахынхаа холбоочны тусламжтайгаар цонхоор сэм гарсан тэр үед Сафронов хээрийн цагдаагийн бага даргыг дуудаад,

- Манай байшингийн эргэн тойронд хүч нэмэгдүүлсэн харуул гарга гэтэл голын эргийн зүүнээс ачааны машины дуу хүнгэнэж, хааяа гэрэл сүүтэгнэхийг ажив. Чингээд Сафронов өөрийнхөө туслахуудыг дагуулан суурингаас гарч, холгүй байгаа замын уулзвар дээр очоод хориод цэргийг дагуулж замын уулзвараас холгүй байгаа бургас руу чиглэв. Сафронов бургасанд хориглосон байдалтай байж байтал суурингийн эгц өмнөөс машины дуу тодрон ойртохын зэрэгцээ голын баруун эргээс буун дуу хааяа сонсогдож байлаа. Чингээд удаж төдөлгүй гурван машин цэрэг хоёр их буутай ирсний зэрэгцээ Ёоши, Мешанов хоёр хөнгөн тэрэгнээс бууж ирлээ. Ёоши Сафроновтой уулзсаны дараа,

- Байдал ямар байна гэж лавлав,

- Үнэнийг хэлэхэд ширүүхэн байна. Чёрный нуруунд оросын хилийн нэмэгдэл хүч ирсэн учраас Мешановын хүмүүсийг явуулаагүй. Бодвол мухар толгойтнууд холбоо барьж хэл хүргүүлсэн бололтой. Харин өнөө оройноос хойш гал зогсмоор шинжтэй болж байна. Бодвол мухар толгойтнууд уул руу гарсан бололтой. Нэг хүн олзлогдсон. Түүнийг Хасу Тоиши байцааж байгаа гэж ажил хэргээ товч танилцуулав. Ёоши Сафроновтой уулзангуут хэрэгтэй зүйлээ мэдэж аваад хөнгөн тэргэндээ сууж, суурин руу хөдөллөө. Тэднийг Сафроновын байрласан байшингийн дэргэд харуулын ахлагч тосон уулзаж байдал тайван байгааг илтгэхэд хүмүүс байшингийн үүдний өрөөг дамжин том өрөөнд ордог хаалгыг түлхтэл дотор талаасаа

түгжээтэй байлаа.

- Сафронов сан, энэ чинь юу болж байна? гэж асуусан Ёоши хартай сэжигч нүдээр Сафронов өөд ууртай ширтэнэ. Сафронов хээрийн цагдаагийн бага дарга руу ширүүн харснаа,

- Харуул хамгаалалт чангалсан уу? Би чамд явахдаа үүрэг өгсөн биз дээ гэснээ хажуудаа байгаа цэрэг рүү эргэж,

- Иаад хаалгаа түргэн эвд! Цонхон талын харуулыг шалга гэж сүртэй хашгиран тушаахад Сафроновын хахир хатуу дуунаас айсан цагдаагийн хэсгийн ахлагч бутанд хярсан туулай шиг давхийн цочив.

Ёоши, Чёрный нурууны хавиар газрын зургийн тодруулах хэсгийг оруулах ямар ч боломжгүй байсныг мэдээд дөрөв хоноод буцлаа. Тэрээр Хасу Тоиши, олзлогдсон хүний хамтаар алга болсныг мэдэнгүүт энэ хэрэгт өөрийгөө барьж өгөхгүйн тулд эртхэнээс холдохыг мэрийжээ. Хасу Тоиши, ахтайгаа нарийн холбоотой байснаас Чёрный нурууны чанадад явуулах ажиллагаа уналтанд орсон болохоор зүрхээ дэлбэртэл бухимдсан Ёоши сэтгэлдээ "Энэ хэрэг миний толгойноос холуур зайлах болтугай! Харин Хасан нуур хавийн газрын зургийн тодруулалтыг яаравчлан дуусгах хэрэгтэй. Жанжин штабынхан газар дээр нь ирж байлдааны ажиллагааг, боловсруулахад хүрвэл би сүйрнэ.

Тиймээс Хасан нуурын газрын зургийн материалыг бэлэн болгочихвол Чёрный нурууны хэргийг Сафронов руу чихэж болно.

Сафронов, Сафронов сонин юм даа. Хаант оросын армийн үнэнч хурандаа... сонин хэрэг шүү! Сафроновын оролцсон ажиллагаа үл мэдэгдэх замаар ямар нэг юманд өртөөд байдаг. Ерийн санамсаргүй тохиолдол гэхэд хэцүү. Симото "хэрээ" хочтын мөрөөр орсон мөртлөө ор сураггүй алдсан гэдэг. Тэгээд хэргээс мултрахын тулд нарийн арга хэрэглэсэн гэж ярьцгаадаг. Сувдаа сүйрэлд өртсөн гэж үзэхэд бас ээдрээтэй! Одоо Хасу Тоиши алга болчихлоо. Энэ бүхэн Сафроновтой холбоотой юм биш үү? Эгч дүүсийн хэрэг илбийн аргаар хэнд ч мэдэгдэлгүй будилах хэрэг үү" гэж бодно. Ёошийн сэтгэлээс энэ бодол гарсангүй. Тэгээд сүүлийн хоёр, гурван хоногийн турш бодол боллоо.

...Сувдаа галт тэрэгний сүйрэлд амиа алдсан уу? Бас л Хасу Тоиши шиг алга болсон уу? Бид хүүрийг нь олоогүй. Харин Тозияагийн зөвшөөрлөөр акт тогтоосон. Нэг биш дээ...

Ёоши, Хомукуд бэлдсэн байшиндаа орж иртэл хээрийн цагдаагийн газрын бага дарга, хилийн хэсгийн бага дэслэгч хоёр түүнийг бараадан орж ирлээ. Тэгээд хилийн бага дэслэгч,

- Тай и (ахмад аа), оросын нутгаас хоёр хэсэг буцаж ирсэн гэхэд,

- Ажил хэрэг нь аль зэрэг бүтэмжтэй вэ? гэж магадлав.

- Оросын цэргийн хүчний талаар мэдээ цуглуулах ёстой хэсэг Подгорная хүрсэн бөгөөд энэ хавиар цэргийн ямар ч анги нэмэгдэл хүч байхгүй гэдэг нь тогтоогдсон байна. Новоселки чиглэлээр явуулсан хэсэг намаг уруудаж междорожная хүртэлх газрын байр зүйн тодруулалт

хийгээд иржээ. Тэд одоо таны шийдийг хүлээж байна.

- Тэд хаана байгаа вэ?

- Дигашели дахь байрандаа амарч байгаа. Харин нөгөө гурван хэсгээс чимээгүй байна. Маргааш үүрээр ирэх ёстой. Ёоши, хилийнхний илтгэлийг сонсоод Дигашели рүү гарлаа. Тэрээр өөрийнхөө «харцагануудтай» уулзаж тэдний ажилтай танилцав. Ёоши маргааш нь Хомукугаас гарч Заозерная гэдэг өндөрлөгийн ойролцоо хилийн зурвас дээр ирлээ. Шөнө бороо орж, үүрээр зогсолгүй шивэрсээр байв. Энэ нь хилийн цаанаас буцаж ирэх ёстой хэсгүүдэд тун тохиромжтой ажээ. Өглөөний зургаан цаг өнгөрч байхад Хомукутай холбосон утсан дээр Ёошийг дуудлаа. Хилийн харуулаас Хомукутай холбосон шууд холбоогоор хилийн даргын туслах ярьж байлаа.

- Яньгуалин сууринд гурав дахь хэсэг ирсэн. Безыменная өндөрлөгийн хойгуур Чёрная нуурын хавилцаа оросын хилийн гүнд буун дуу сонсогдож байна. Дөрөв дэх, тав дахь хэсэг хилээр гарч ирж чадахгүй байж магадгүй бололтой.

- Ямар ч байсан оросын хил рүү буудаж болохгүй. Та нар зэвсэг хөдөлгөвөл энэ ажиллагааг унагана. Тиймээс сэжиг төрүүлэхгүйн тулд мэдээгүй юм шиг байх хэрэгтэй!

- Тэд баригдвал хэд хоногийн дараа манайд эсэргүүцлийн бичиг гардуулаад зогсохгүй гэм буруутай хүмүүст арга хэмжээ авахыг шаардана. Тэр үед бид яах ёстой вэ?

- Тэд чинь оросууд! Тэгэхээр японы армид хамаагүй зүйл! Оросын дүрвэгсэд өөрсдийн дураар авирлаж, хилийн будлиан гаргасан учраас квантуны армид нялзахгүй зүйл гээд өөдөөс нь эсэргүүцэх хэрэгтэй. Мэдэв үү гээд Ёоши яриагаа үргэлжлүүлж,

- Би одоо очно. Гуравдугаар хэсгийнхэнд хоол унд архи дарс бэлд. Нөгөө хүүхнүүдээс Янгуаньминд аваачсан уу? гэлээ.

- Тай и бүх зүйлийг төлөвлөсөн ёсоор бэлтгэсэн. Оросууд одоо усанд орж байна.

Ёоши утсаар ярьсны дараа Заозерная өндөрлөг рүү дурандахад цагаан манангаас өөр юу ч дуранд өртсөнгүй. Ёоши хилийн зурвас дээрээс Хомукуд ирээд Янгуаньмин руу хөдлөх гэж байтал хилийн хэсгийн ахлагч орж ирээд,

- Тай и Ёоши сан, сая Солонгосоос ярилаа. Армийн штабаас хэсэг дарга нар Сонионд ирсэн байна. Таныг яаралтай очиж уулз гэж тушаалаа гэж дамжуулав. Ёоши Хомукугаас хөнгөн тэргээр гарч умард Солонгосын хил дээр байгаа Чюсандон, Насандоо сууринг дайрч, цагийн дараа Сонионд ирлээ. Суурингаас хоёр бээрийн газар Ёошийг хүлээж байсан япон цэргийн хэсэг хүмүүс түүнтэй уулзангуут, замчлан түрүүлсээр суурингийн төвд байгаа нэгэн давхар байшингийн гадаа ирлээ.

Байшингийн довжоон дээр байгаа япон дарга нарыг ажвал Солонгос дахь япон цэргийнхэн болох нь илэрхий аж. Нэгэн дэслэгч Ёошийг дагуулсаар дээд давхарт гарч уужим танхимд оруулбал нэгэн генерал хэд хэдэн дарга нар өрөөний голд тавьсан газрын зургийг үзэж

байлаа. Гэтэл өнөө генерал Ёошийг харангуут түүн рүү хандаж,

- Тай и (ахмад аа), наашаа ойртооч гээд ширээ рүү заав. Ёоши ширээнээ ойртон зогсохдоо газрын зураг руу нүдний булангаар ажвал зуун мянганы харьцаатай хятад зураг байлаа.

- Таны ажил аль зэрэг ахицтай байна гэж генералыг асуухад Ёоши,

- Гакка (эрхэм дээдсээ), газрын зургийн байр зүйн тодруулалт хийх ёстой зарим хэсэг хилийн цаанаас ирсэн. Одоо байгаа баттай баримтаар бол Хасан нуурын ойр орчимд улаан оросын цэргийн ямар ч анги байхгүй гэдэг нь баттай юм. Оросын нутгийн гүнд байр зүйн тодруулалтыг хийж амжсан боловч түүнийг нэгтгэн дүгнэж амжаагүй байна гэлээ.

- Оросын хилийн баруун хэсгээр ямаршуухан байна вэ?

- Чёрный нурууны хойгуур хийх ёстой судалгаа эхлээгүй байгаа. Энэ ажлыг Харбины дүрвэгсдийн товчооны хурандаа Сафронов удирдаж байгаа. Далунлин нуруунаас буусан мухар толгойтнууд Сафроновынханд багагүй чирэгдэл учруулсан юм гэж илтгэхэд генералын дэргэд зогсож байсан өндөр халзан хүн Ёошигийн илтгэлийг чих тавин анхааралтай сонсоно. Энгийн хувцастай халзан хүнийг ажваас армийн тагнуулын газрын ажилтан болох нь тодхон аж. Тиймээс Хасу Тоишигийн алга болсон явдлыг илтгэхээс Ёоши эмээжээ.

- Хилийн чанадад байгаа хэсгээ авах талаар юу бодож байна гэж генералыг асуухад Ёоши албан үүргийнхээ дагуу тэднийг аврах ямар ч үйл ажиллагаа хийж болохгүй гэж дээд газраас чиглэл өгсөн тул,

- Би арга хэмжээ авах бодолгүй байна. Ер нь оросын хил дээр манай армийн цэргүүд ямар ч будлиан гаргаж болохгүй. Цаг нь болохоор бид оросын хилийнхнийг нүд ирмэхийн зуур арчиж чадна.

- Тай и, та манай ажиллагааны талаар сайн ойлгоцтой юм байна. Таны мэдэлд мэргэжлийн хориод хүн өгнө. Хилийн цаанаас олсон баримтаа энэ зурагт байгаа зүйлтэй тулган зарим зүйлийг тухайлбал, хөх будгаар тэмдэглэсэн бүхнийг бүрэн тодруулсан байх хэрэгтэй!

Та ер нь оросын хилийн Безымянная, Заозерная, Пулемётная горка, Подгорная өндөрлөгийн талаар биднээс илүү мэдэх биз гэж хэлэхдээ хилийн өндөрлөгийн нэрийг оросоор түгдрэлгүй хэлэхийг ажваас орос хэлэнд яггүй болох нь илт байлаа.

Ёоши Солонгос дахь японы армийн арван есдүгээр дивизийн даргатай ингэж уулзаад Хомукутай холбоо барилаа. Хилийн чанадад үлдсэн хэсэг ирээгүйг мэдсэн Ёоши, Хомуку руу хөдлөхөөр шийдэж маргааш өглөө нь генералын туслахтай уулзав.

- Тай и, тантай ажиллах хүмүүсийг маргааш Хомуку руу явуулна. Харин та, зэрэгцээх өрөөнд нэг хүнтэй уулзаад яваарай. Өчигдрөөс хойш сураглаад байсан гэлээ. Ёоши генералын туслахын өрөөнөөс гарч, хажуугийн өрөөнд ортол өчигдрийн халзан хүн угтлаа. Тэрээр бас энгийн хувцастай байлаа.

- Би тантай уулзах гэж бодсон юм. Наашаа суугаач гэж уриалгахан боловч хүйтэн зэвүүн дуугаар хэлэв. Ёошийг урт ширээнд дөхөж суусны дараа халзан хүн,

- Та, Хасу Тоишийг оргосон явдлыг юу гэж бодож байна вэ? гэлээ.

- Би тэр тухай сайн мэдэхгүй. Тэгээд ч учир начрыг нь олоогүй юмыг генералд дуулгаад яахав гэж бодсон юм.

- Та Мешановыг аль зэрэг таних вэ?

- Тийм ч сайн танил биш. Би түүнд газрын зургийн хичээл зааж байсан болохоор багш шавийн... гээд дараагийнхаа үгийг хэлж амжаагүй байтал халзан хүн Ёошигоос,

- Мешанов тэр шөнө тантай хамт Сафронов дээр орсон биз дээ гэж ороож шалгаах янзтай мушгиж асууна.

- Тиймээ. Намайг угтаж, замчлах үүрэгтэй байсан юм.

- Сафроновыг та нартай уулзсан тэр үед Мешанов хаачсан бэ?

- Мэдэхгүй шүү. Сафроновтой намайг уулзаж байхад алга болсон байсан. Би түүнийг Сафроновын даалгавраар ийш тийшээ явж гэж бодсон юм. Харин маргааш өглөө нь Сафроновын өрөөнд дайралдсан.

- Хуньчунд байхдаа Мешанов ямар ямар хүнтэй уулзсан бэ?

- Сафронов руу явах гэж байхад нэг оростой уулзсан. Би түүнээс юун орос вэ? гэхэд «Хурандаа явуулсан байна. Би явах замаа заалгаж авлаа» гэж байсан шүү.

- Та нар замдаа мухар толгойтнуудтай дайралдалгүй Сафронов дээр очсон явдал ямар нэг сэжиг төрүүлэхгүй байна уу?

- Тэр үед надад юм бодогдоогүй. Харин одоо хачин санагдаж байна.

- Юу тэр вэ?

- Бид Сафроновтой, уулзаад тэдний байшингийн дэргэд ирэхэд Мешанов биднээс түрүүлж ирээд зогсож байсан. Тэгээд биднээс түрүүлж байшинд ороод Сафроновын үүдийг түгжээтэй байхад байшин өөд гарч цонхоор нь орсон хүн дээ. Тэгэхээр Хасу Тоишийг Мешанов барих боломжтой байсан юм шиг санагдаж байна.

- Та энэ тухай хэнд ч дуулгаж үл болно. Хато генералын штабаас зарим нууц алдагдаж байсан төдийгүй цагаачдын товчооны нууц гадагшаа тарж байсан. Гэтэл энэ бүхний эзэн зарим талаараа тодорч байгаа боловч тодруулж амжаагүй зүйл нэлээн бий. Нөгөөтэйгүүр таныг тагнуулын байгууллагад ажиллаж байсны хувьд урьдчилан дуулгах нь зүйтэй гэж үзэж байгаа юм гэхэд Ёоши халзан хүний үгийг хүлээн зөвшөөрлөө. Ёоши халзан хүний яриаг бодоод өөрийнхөө сэтгэгдлийг хэлье гэж бодсон боловч ул мөргүй болж мэдэх зүйлд хошуу дүрэх

хэрэггүй гэж үзлээ.

- Симото, Харбингаар юу байна гэж асуусан Тозияа тэргүүнээ өндийлгөж Симотогийн урт хүзүүг ажиглах гэсэн шиг сүрхий харлаа.

- Жанжин штабаас авсан үүргийн дагуу оросын товчооны бэлдсэн хүмүүсийг солонгос оросын хил рүү явуулсан. Тэднийг нэлээн гавьяа байгуулна гэж магтаж, чих тавьсан улсууд их байх шиг байна.

- Хасан нуур... Хасан нуур гээд хөлөө хугалчих гээд байх болж дээ. Жанжин штабын муусайн дарга нар, хүний бараанаар сүржигнэж давхиад, хий боргоодог ноход шиг гүйлдээд байдаг болж дээ. Тэд Хасан нуурыг аваад дараа нь алс дорнодыг улаан оросоос салгах гэнэ. Тэгж хоосон сүржигнэхийн оронд ар монголыг хэмлэвэл арай мөлжүүртэй зөөлөн хоол байсан юм.

- Таны санал нэлээн ул үндэстэй гэдэгт би итгэдэг гэхдээ ерөнхий сайдад энэ талаар би танилцуулалтай биш. Ядаж хурандаа цолтой бол илтгэх хуудас бичих санж гэсэн нь угтаа Тозияад илэрхийлсэн гомдол аж.

Тозияа, түүнийг гар хурууныхаа үзүүрт зарахын тулд жанжин штабыг татаж авна гэхэд өгөөгүй. Энэ ч далдын учиртай байсныг Симото ойлгоогүй өнгөрсөн. Тозияа Юкигийн алтны учрыг олж мэдсэний дараа Симотогийн сэтгэлийн бодлыг дагуулж Юкитэй "ойртуулах" бодолтой байв. Тэгээд цагаас нь өмнө тэднийг бие биенд нь дасгаж болохгүй гэж бодлоо. Симото, Юкийг өөртөө дасгах гэж савсганаж байгаад өөрөө түүний гарт орж, сэтгэлээрээ дасчихвал тэдний холбоо хожим бэхжиж, Тозияаг өөрийг нь боомилж мэдэх аж. Тиймээс Симитоог Юкигээс хөндий байлгахыг хичээнэ.

- Чи тэр талаар гонгиноод яах вэ? Тэсвэртэй хүлээж бай! Цаг нь ирэхээр хурандаа байтугай генерал цол өөрөө гүйгээд ирнэ. Гэхдээ одооноос зам мөрөө гаргах гэдэг чинь зөв! Чи Аяанаосугийн талаар жаахан авхаалжтайхан ажиллавал яасан юм бэ? Бид халхын гүнд ажиллуулах нутгийн хүмүүсийг сэнхрүүлж чадах ухуулга бэлдэх, монголын газрын зургийг боловсруулах, байр зүйн зургийн тодруулалт хийхэд шаардлагатай хүмүүсийг бэлтгэх зэрэг ажилд Аяанаосуг ашиглах талаар бодмоор байна.

- Аяанаосу, захиалгынхаа газрын орлогонд шунаад тийм ажил хийхгүй бол яах ч аргагүй шүү дээ.

- Түүний саналыг асуувал татгалзах нь аргагүй. Харин манай ажлын онцлог бол хүссэн ажлыг нь биш хүсээгүй ажлыг нь ямар ч хүнээр хийлгэж чаддаг байхад оршино.

Тэгэхээр Аяанаосугийн сэтгэл санаа, ахуй амьдралыг бид өөрснөө удирдах ёстой шүү дээ. Иаад захын арга гэхэд Аяанаосуг хөрөнгөнөөс нь салгах хэрэгтэй.

Шалдан үлдээд өр ширэнд баригдаад ирэхээрээ бидний гарт өөрөө ороод ирнэ. Ер нь галын осол гэдэг аятайхан арга хэрэглэвэл Аяанаосугийн захиалгын газрын онцлогтой яг таарна. Тэднийх чинь цогоор халаадаг индүү хэрэглэдэг гэсэн. Ингэхээр хүүхнүүдэд индүүгээ цогтой нь орхичих салан задгай хүүхнүүд байх ёстой биз дээ гэж аятайхан ятгав.

Тозияа энэ талаар Иван Степановичтай ярилцсан боловч тэрээр солонгос руу явах нэрийдлээр уул ажлаас аятайхан хөндийрөхдөө атаман Семеновын зааврыг ашиглачихсан болохоор Тозияа гар хоосон хоцорсон. Гэхдээ Тозияагийн өгсөн даалгавраас түвэгшээсэн.

Тэрээр Аяанаосугийн захиалгын газарт гал гарсан үед гал унтраагчдыг зохицуулах талаар тусгай үүрэг өгсөн нь Тозияад мэдэгдэж байлаа. Чингэхээр Тозияа үүний зангилаан дээр Симотоог тавьж Аяанаосуг түүний шавь болгохоор шийдлээ.

- Тозияа сан, бидний төлөвлөснөөр Халх гол руу довтлох юм бол Аяанаосугийн хэрэг гэж юу байх вэ?

- Симото сан, чи шатар тоглож сурах хэрэгтэй. Ялангуяа морины нүүдлийг сайн сур! Улааныхан шатарт дуртай. Тэгэхээр дайсныхаа дуртай тоглоомоор тоглож сурах хэрэгтэй. Тэр үед Аяанаосу бидэнд хэрэгтэй болно.

- Та тэгээд яаж гүйцэтгэхийг дээр гэж үзэж байна даа. Надад таны удирдамж хэрэгтэй шүү дээ.

- Юки бид хоёр Токио явна. Тэр үед амжуулах хэрэгтэй. Нөгөө талаар Аяанаосуг Буянт мөн бишийг тогтоох гэж Амисээг дуудуулъя гээд байсан. Харин тэгж сорихын хэрэггүй. Чи Буянтыг анх яаж дээрэм хийснийг мэдээгүй өнгөрсөн байна. Тэгэхээр энэ хэргийг унш. Би Токиогоос авчруулсан юм гээд ширээнээсээ нэгэн хавтаст хэрэг гаргаж өгөөд малигар царайгаа мэлэлзүүлэн инээмсэглэнэ.

...Японы нийгэм улс төр, эдийн засагт гарсан өөрчлөлт, сайд нарын танхимтай өрсөлдсөн цэргийнхний өрсөлдөөн, ерөнхий сайд, үйлдвэр банкны эзэд нарын аминд халдсан хэрэг бүхэн Токиогоос эхэлдэг.

"Бурангуй ёсны үзэл суртал, хэв ёсны энэ уламжлал Токиод архагшжээ. Токио хот өргөжин тэлэх тусам архагшсан өвчний битүү буглаа газар авч бугласаар байв. Хөрөнгө түшин хөдөлж, хүний сэтгэл санаа, ухаан оюуны хүч хөдөлмөрийг зоос болгодог тэрхүү талхи, эгэл жирийн хүмүүсийн яс маханд гүн шигдсэн хувалз шиг хөдөлмөрийг нь сорсоор гуйлгачлалын туйлд хүргэсэн зам мөртэй.

Энэ горим дэглэмээ дагаж, эдийн засгийн сүйрэлд орсон болохоор түүнээс гарах найдвартай замыг сонгохдоо өөр орны баялагт шунаж, түрэмгий дайны үйл ажиллагааг эрхэмлэн улайрна. Японы нийгэм эдийн засгийг сүйрэлд хүргэсэн хямралын анхны шарх Эдо хотод хөл тавьсан гадаадын худалдаачид 1543 онд үүсгэжээ. Он жилийн турш Эдо хотод бугласан тэр архагшсан өвчин 1859 оны 4 сард засгийн газрыг өөрчлөхөд хүрснээр юм бүхэн Токиод төвлөрчээ. Шинэ засгийн газрын шийдвэрээр Киотоод байсан ерөнхий сайдын харшийг Эдоод нүүлгэн суурьшуулснаар Эдо хотын нэрийг Токио буюу Дорнод хот гэдэг нэрээр өөрчилсөн болой. Эдо хотыг анх 1457 онд үндэслэсэн бөгөөд энэ нь Иедо буюу Далайд нэвтрэх цайз гэсэн утгатай үгнээс үүссэн.

Улс орноо сүйрлээс аврахаар төлөвлөгөө боловсруулсан самурай нар Токиогийн Ясакуно дуганы өмнөх талбай дээр цугларч синто (Бурхны хутаг олох) ёсны зан үйлийн дагуу

Хатимана бурханд тангараг өргөж өглөөний нарнаас шөнө дүл хүртэл Ясакуно дуганы өмнөх талбай дээрээс үл сална.

Долдугаар сарын нэгэн өглөө. Ясакуно сүмийн өмнөх талбай дээр японы цэргийн яам, жанжин штабын удирдах ажилтан цугларч, цэргүүд анги нэгдлээрээ жагссан байлаа. Сүмийн хоёр талд дугануудын довжоон дээр зогссон генералууд цэрэг хувцасны гадуур самурайн дуулга өмсөж, дуулганы хормойг даруулсан самурайн илд (катана) бүсэндээ зүүжээ. Дуганы үүдний довжоонд Хатимана (Дайны Бурхан) бурхны хөрөг өлгөж, эргэн тойронд нь хакама хэмээх эртний ёслолт хувцастай самурайн зургаар чимсэн байлаа.

Иамхан нуруутай, урт цагаан сахалтай, цайвар нүүрний яс нимгэн хөрс нь хонины сархинаг шиг үрчлээтсэн нэг лам, уншлага эхэлж, ёс гүйцэтгэхэд түүний өмнө эртний самурайн хувцсаар хувцаслаж, модон шаахай (асида цумагаки) углаад богино ханцуйтай хакамагаар гоёсон нэг самурай, ламын уншлагын дагуу хөдөлж цамнахдаа бусидо ёсны дагуу кэндо (илд эзэмших), кудио (нум сум эрхэмлэх), базиуцу (морь эзэмшин эрхэмлэх) ёстой холбогдсон уран хөдөлгөөн үйлдэнэ.

Юкигийн хажууд зогсож байсан Тозияа дэргэдээ байгаа нэг хүнээс,

- Камейзо сан, та чинь тун хүндэтгэлтэй үдүүлж байх шив дээ. Ёстой хийморь сэргэмээр баяр ёслол болж байна гэж ёжтой атаархуу хэллээ.

- Бид Хасан нуурын чанадад барих бэлэг сэлтээ чамбайхан бэлдсэн. Тэгэхээр хийморьтой байлгүй яахав. Та миний төлөвлөгөөтэй танилцаж болно шүү. Хоёулаа ерөнхий сайдын хүлээн авалтын дараа манайд уулзъя гэж тун баяр баясгалантай бардам урилаа. Орчин цагийн самурайн ёсыг дагаж цээжиндээ дуулга өмсөж, урт улаан цацаг дайто хэмээх ёслолын илдний ишний төгсгөлд чимсэн энэ хүнийг арван есдүгээр дивизийн удирдагч Суэто Камейзо гэдэг билээ.

Генерал Хасан нуурын чанадад чиглэсэн ажиллагааг шуурхайлж чадсанаараа Халх гол руу чиглэсэн ажиллагаанаас урьтаж амжсан билээ. Гэсэн ч Тозияа, түүний амжилтанд итгэсэнгүй. Чухам энэ нь хоёр генерал бие биендээ жөтөөрхсөн атаархлын илрэл байв.

Ясакуно дуганы талбай дээр жагссан цэргүүдийг адислах синто ёсны (Синто ёсонд самурайн үхлийг алдар гавьяа болгодог юм) ёслол дуусах шахжээ. Урт хар өмсгөл өмссөн цагаан толгойтой өнөө ламтан уншлагаа дуусаад баруун гартаа барьсан хатано илдээ дээр далайж, зүүн гартаа барьсан гуулин толио өндөрт өргөөд,

- Яматогийн цэрэг эрсээ Манжуурт эрх чөлөө олгож түүний газар нутгийн бүрэн бүтэн байлгах үйл хэргийн төлөө та бүхэн амиа хайрлаж болохгүй. Та нарыг аугаа их Хатимана тэнгэр тэтгэн харж байна. Та нарын үйлс ариун. Тиймээс үхлээс айж болохгүй. Үхэх гэдэг бол жинхэнэ самурайн эрхэм ёс мөн! Бид үхлийг эрхэмлэж, үхлээр дэлхий дахиныг эзэн хааны өлмийд сөхрүүлэх болно. Хакко ити о... Хакка ити о... Банзай... Банзай гэж сөөнгө хоолойгоо хягтнуулан орилоход талбай дээр жагссан цэргүүд Банзай гэж гурвантаа уухайлав.

Токиогийн Ясакуно буюу дайны тэнгэрийг тахих сүмд болсон ёслолын дараа талбай дээрх

цэргүүд үхэл рүү явцгааж, харин армийн томчуул ерөнхий сайдын ордон руу зүглэв. Тозияа ёслол дуусангуут Юкийг дагуулан ерөнхий сайд Канозэгийн ордны ёслолын танхимд очлоо.

Уужим танхимд цугласан ихэс дээдэс, үйлдвэр банкны эзэд, гадаадын тэргүүн нарын дунд Тозио, Итагаки, Доихара нар байлаа. Итагаки бол нуруугаар өндөрдүү том биетэй, тас хар хөмсөгнийхөө адил ширвээ сахалтай, дуу цөөнтэй, хянуур харцтай хүн билээ. Харин Тозио бол оройноосоо халзарч яваа бөөрөнхий том толгойтой агаад зузаан уруулынхаа дээр өтгөн хар сахалтай төдийгүй зүүн завьжиндаа том хар мэнгэтэй. Тэрээр нүднээсээ хар шил үл салгана.

Энэ хоёр хятадын улс төрийн амьдралыг төвшитгөх хувь тавилантай японы армийн их зорилгод саад хийж байсан улааны мухар толгойтон буюу засаг захиргаагүй хүмүүсийг «хүйс тэмтрэх» ажлыг манжуур, зүүн умард хятадад удирдаж байсан хоёр. Жилийн өмнөөс энэ хоёр японы армийг толгойлох болсноос хойш Итагаки цэргийн яамны сайдын тушаалд баттайхан сууж, ихээхэн үйлс бүтээнэ гэж үзэх хүмүүс цөөнгүй болсны адилаар түүний орлогч Тозиог ирээдүйд ерөнхий сайд болж мэдэх хүн гэж үздэг болжээ.

Энэ хоёр сайдын хэн хэн нь Тозияд талтай билээ. Тиймээс Юкийг хүндэтгэх нь албан ёсны үүрэг байлаа.

- Юки сан, та тэнгэрийн хааны дагина шиг байх чинь, танд цасан цагаан кимоно тун сайхан зохижээ гээд Тозио Юкийд тал засна. Харин Итагаки, нөгөө хоёроосоо өөр бодолтой болохоор илүү дотно хүндэтгэхийг мэрийх болой.

- Юки сан, та өчигдөр сайд нарын танхимын сайд, үйлдвэр банкны нөлөө бүхий хүмүүстэй уулзахдаа төрсөн сэтгэгдлийнхээ талаар яриач. Ер нь манай эндхийн хүмүүс ямаршуухан санагдав аа? гэж шалгаана.

- Итагаки сан, би Токиод амьдарч байсан болохоор гэртээ байгаа юм шиг санагдаж байна. Харин сайд нарын танхим дахь эдийн засгийн бодлоготнуудын хувьд гэвэл «Мангё» нийгэмлэгийн тэргүүн Гисикэ Айкавагийн санал надад их тааламжтай санагдлаа. Тэр хүн квантуны армийг танаас хойш толгойлох болсон Уэдагийн үйл ажиллагааг их дэмждэг итгэдэг хүн бололтой. Тэр хүний хэлсэн үг миний цээжинд тэр чигээрээ хадаатай байна.

Итагаки, Юкигийн үгийг сонсоод Айкавагийн үгийг саналаа. Тэрээр өчигдөр сайд нарын танхимын хурлын индэр дээрээс «Квантуны армийн удирдагч Уэда, манжуур дахь төмөрлөг, нефть, хийн үйлдвэрийг хүчтэй хөгжүүлэх нь манай хөрөнгө оруулалтыг арвижуулах ганц зам юм. Түүний зэрэгцээ Монгол, Сибирийг хэзээ ч мартаж болохгүй» гэж хэлснийг Итагаки нэхэн саналаа.

- Хойтон жил зүүн умард хятадад зам ашиглалт, төмөр замын нийгэмлэг байгуулахад хүрвэл та, ямаршуухан хэмжээгээр оролцох вэ?

- Итагаки сан, хэрвээ «Кабоку коцу буюу зам харилцаа төмөр замын нийгэмлэг» байгуулахад хүрвэл миний бие хувь нийлүүлж, Хайлар Манжуур, Ханширээ Манжуурыг холбосон төмөр зам тавих ажилд өөрийнхөө нэмэр хандивыг өгөх болно гэхэд Итагаки талархан инээмсэглэв.

Итагаки, Юкигээс үүнийг мэдэх гэж бодож байсан. Одоо санасандаа хүрсэн болохоор Юкийг "Кабоку коцу" нийгэмлэгт татан оруулах талаар санаачилга гаргах ёстойгоо ойлгов. Чухам ийм нөхцөлд Юки, хэнд ч мэдэгддэггүй өнөө алтныхаа нууцыг дэлгэнэ гэдэгт тэрээр итгэн, сэтгэлдээ сэм баярлана. Итагаки, Юки хоёрыг чингэж ярилцаж байхад Доихара, Тозия хоёр Камейзотой уулзаад Хасан нуурын талаар ярилцаж байлаа. Учир нь хятадад байгаа 14 дүгээр армийг удирдах болсон Доихарааг Зөвлөлтийн алс дорнод руу чиглүүлсэн японы армийн ажиллагаанд оролцуулах чигтэй болохоор Камейзогийн үйл ажиллагаа Доихараад сонирхогдох нь албан ёсны хэрэг байлаа.

Ерөнхий сайд Каноэ танхимд орж ирэх болсон тул зочид, гийчид танхимын ханын том хаалга руу анхаарлаа чиглүүлэв. Ерөнхий сайд Каноэ, их хэрэг явдлын өмнө армийн удирдлага болон өвөр монголын төрийн зүтгэлтэнтэй уулзахыг чухалчилсан болохоор Сөнөдийн Дэ ван хэмээгдэх Дэмчигдонров, хүмүүсийн анхаарлыг татаж байлаа.

Сөнөдийн ван Дэмчигдонровыг эзэн хаан хүлээн авч уулзсан болохоор ерөнхий сайд албан үүргийнхээ дагуу дуугүй өнгөрч болохгүй нь мэдээж. Тэр ч атугай эзэн хаан Хирохито, Дэмчигдонров хоёр бараг нэг онд төрсөн болохоор хаантан түүнийг эрхэмлэн хүндэтгэдэг болой. Өвөр монголын засгийн газар гэгчийг толгойлж буй Дэмчигдонров монгол туургатны ихэс дээдсийн залгамж ёсыг даган, хэргэм зэргийнхээ хүндэтгэлийн хувцас өмсчээ.

Дунд зэргийн биетэй, бөгтөрдүү нуруутай, таргалах янз суусан, махлаг байрын агаад биеэ тоосон бардам царайтай энэ хүн 1901 онд төрсөн. Тэрээр ерөнхий сайд Каноэтэй уулзангуут монгол ёсоо дагаж хадаг барин золгож буйг харсан Юки, түүний амьдрал ахуйг бодохгүйгээр өнгөрч чадсангүй. Түүний эцэг Сөнөдийн баруун хошууг захирч байсан билээ. Дэ ван долоон насандаа эцгийнхээ зэрэг хэргэмийг залгамжилж, улмаар Шилийн голын чуулган даргын орлогч хэмээх үүргийг гүйцэтгэх болсон аж.

Тэрээр өвөр монголын хошуудыг хятадаас тусгаарлах бодолтой байсан болохоор Доихара, түүнийг өөртөө татаж, эзэн хааны армитай бие, сэтгэлийг нь холбон өгсөн болой. Дэмчигдонров, 1933 онд Бат хаалганд болсон хурлаар өвөр монголын хошуудыг нэгтгэн хятадаас тусгаар улс болохыг сурвалжит ноёдод уриалжээ. Тиймээс Дайранд Миньжаны (монголын хязгаарын) засгийн газар гэгчийг байгуулж Дэ ванг дэвшүүлсэн. Цахарын Чансыр (Завсар) хотод болсон хурлаар Өвөр монголын олон хошуудын шинэ засгийн газар байгуулж, 1934 онд Дэ ванг нарийн бичгийн даргаар томилоод жилийн дараа орлогч дарга болгосон билээ. Чухам тэр үед Итагаки Дэ вантай уулзаж өвөр монголыг манж го улстай нэгтгэх асуудлыг сөхсөн юм. Харин ноднин Тозио цахарыг "чөлөөлөх" ажиллагааг удирдаж, квантуны армийн монголын хэсгийг Долнуур чиглэлд гаргахдаа Дэванг урьж нууцаар уулзсан юм. Чингээд японы арми, Дэ ванд тал засаж 500 мянган иений тусламж үзүүлж, үлэмж хэмжээний зэвсэг өгөөд морьт дивиз 10, их бууны хороо 14-ыг байгуулж өгсний гадна 90 пулемёт, таван мянган буу олгож өвөр монголын арми гэгчийг байгуулсан билээ.

Каноэ, Дэмчигдонровын бэлэг сэлтийг хүлээн аваад зочид гийчдээ дайллагын танхимд урьж, тэрхүү дайллага таван цаг үргэлжилсний дараа өндөрлөв. Дайллагын дараа Тозия Камейзотой тохиролцсон ёсоор уулзаж ажил байдалтай нь танилцлаа. Камейзо Хасан нуур руу чиглэсэн ажиллагааг хэрэгжинэ гэдэгт итгэдэг болохоор Тозияд үзүүлж гайхуулах сэтгэл төгөлдөр ажээ. Үнэндээ Камейзо тусгай даалгавар хүлээж, бүх бололцоогоор хангагдсан

Тозияагийн ажилд дотроо агаархдаг боловч түүнийгээ ил гаргахыг хүсдэггүй. Камейзо дайллаган дээр Итагаки, Тозио хоёртой нийлж багагүй сэржимдсэн болохоор чамбайхан согтжээ.

Тэрээр ажлынхаа өрөөнд байдаг нууцын шүүгээгээ уудалж, Хасан нуурын талаар хийсэн төлөвлөгөөнийхөө нооргийг үзүүлэв. Камейзо, Тозияа, Юки хоёрын тусламжтайгаар зургаа дэлгээд

- За ямар вэ? Ийм л байгаа юм даа гээд зураг руугаа заагаад өрөөнийхөө ханан шүүгээ рүү эргэж сакэ хундага авчирлаа. Тэрээр сакэ хундагалаад Тозияад барихдаа,

- Миний ажлыг амжилттай болохын төлөө, Кампай гээд хундагатай сакэгээ балгачихаад зургаа Тозияад тайлбарлаж өглөө.

- Би цэргийнхээ гол хүчийг оросын хилийн Нэргүй (Бе-зымянная), Нуурын чанадад (заозерная) руу чиглүүлэхдээ юуны өмнө их буугаа зөв байрлуулахыг голчилсон юм.

Тозияа, зургийг ажиглангуй ширтэхдээ Тумын голын эрэг дээр байдаг Хомуку, Нанчиепсандон, Чюүсандан Намунон, Мантокусан гэдэг сууринд байрлуулсан их бууны байрлалыг харуулсан таних тэмдгийг ажиглана. Камейзо цэргийнхээ бэлтгэл хүчийг төмөр замын Сонион өртөөнд төвлөрүүлсэн байлаа.

- Таны энэ ажиллагаанд атаман Семенов аль зэрэг үүрэгтэй вэ гэхэд Оросын цагаачдын хэсгийг алс дорнод руу оруулах гэсэн Хатогийн саналыг жанжин штаб хянасан. Тэгээд хошууч Ямасакийг Дайран руу илгээгээд атамантай уулзуулсан юм. Үүний дараа атаман Токиод ирж Аракитай уулзсан. Тэрээр манай армийг Посьётын булангаар цэргээ оруулсан үед өөрийнхөө хүмүүсийг хөдөлгөхөөр тохирсон. Тэгэхээр Семенов бидний амжилтыг хүлээж байгаа хэрэг! Нэг үгээр хэлбэл миний гараар могой барих санаатай байгаа эр дээ гэв.

- Камейзо сан, та тэгээд хэдийд эхлэх бодолтой байна даа?

- Чи миний занг мэдэхгүй биш. Хурдан бол надад сайн. Ямааны мах халуун дээрээ гэдэг биз дээ. Жанжин штаб эхлүүлэх шийдвэр өгвөл өнөө шөнө ч эхэлмээр байна. Манай тагнуулын мэдээгээр бол Хасан нуур, Красино, Зайсановкад улаан армийн ямар ч анги байхгүй байгаа. Ийм үед хилийн цэргийг яах ийхийн зуургүй хийцэлчихнэ. Гэтэл сайд нарын танхим ялангуяа гадаад яам манжуурын хэрэгт хошуу дүрсэн шигээ миний ажилд оролцох гээд байгаа юм. Харин чамд гэж хэлэхэд та нарыг «Мугдэнгийн зөрчил» ажиллагааг эхэлчихээд байхад гадаад яамны Мориса Мугдэн дэх элчинд очоод яалаа даа. Итагаки, тэр шөнө 10 цаг хагаст өөрөөр хэлбэл төмөр замыг дэлбэлчихээд байхад Морисааг Мугдэнгийн төлөөлөгчийн газар дуудаж авчраад «Энэ ажиллагаанд гадаад яамныхан оролцож болохгүй» гэдгийг мэдэгдсээр байхад та нарын нууцыг дор нь гадаад яам, ерөнхий сайд хоёрын нэр дээр мэдээлсэн байсан юм шүү.

- Би үүнийг мэднэ. Ер нь сайд нар аймхай улсууд. Тэгээд гадаад яамыг урдаа барьдаг муу зантай. Тэд Мугдэнгийн зөрчил ажиллагаанд нэлээн чирэгдэл учруулсан гэхдээ, бид түүнийг тооцоогүй гэж хэлэхдээ Тозияа, сайд нарын танхим, гадаад яамыг үзэн яддаг бодлоороо

Камейзотой тохирч байгаага мэдэв.

- Зүйтэй. Та нар тун зөв хөдөлсөн. Тэгээд квантуны арми амжилтанд хүрсэн шүү дээ. Би ч гэсэн сайд нарын гарыг харахгүй гэж шийдсэн. Ер нь гадаад яам, армийн ажиллагааг мөрддөг явдлыг эцэс болгох хэрэгтэй! Тэгэхгүй бол тэд чинь армийг төдийгүй эзэнт гүрнийг сүйрэлд хүргэх галзуунууд байгаа юм гэлээ.

Камейзо, Тозия хоёр амандаа халаад улс төрийн яриа руу халтирч яриа нь сунжирлаа. Энэ бүхэн нь Юкигийн дургүйг хүргэж уйтгарт оруулав. Тиймээс тэрээр буудал руугаа очиж Акасайтай уулзахаар шийдээд Тозияд хэрхэн хэлэх аргаа бодож суулаа.

Зуны дунд сарын шувтаргаар нэг өдөр Аяанаосу ажлаасаа эрт таржээ. Тэгээд байшиндаа орж ирээд сарынхаа орлого, зарлагыг нийлж, ашиг хонжооныхоо тооцоог гаргаж байтал гэрт нь хоол унд янзалж өгдөг нэг орос эмэгтэй орж ирээд дөрөв нугалсан жижиг зурвас өгөхдөө,

- Сая нэг танихгүй хүн таныг сураглаж ирлээ. Тэгээд энэ бичгийг оруулаад өгчих гэж гуйлаа гэлээ. Аяанаосу тэр бичгийг аваад,

- Тэр хүн чинь гадаа хүлээж байгаа юм уу? гэлээ.

- Тиймээ. Үүдэн дээр хүлээж байгаа. Таны өрөөний цонхоор харагдах байх шүү гэхэд Аяанаосу ширээний араас босож цонхныхоо дэргэд очоод гудамж руу харлаа. Гэтэл өнөө үл таних хүн гудамжинд харагдсангүй. Аяанаосугийн гэрийн үйлчлэгч цонх руу хараад саяхан гудамжинд байсан танихгүй хүн алга болсныг мэдээд дал мөрөө хавчисхийн гайхлаа.

- За яахав. Захиаг нь уншихаар тодорхой болох байлгүй гэж хэлэхэд үйлчлэгч эмэгтэй Аяанаосугийн өрөөнөөс гарлаа. Аяанаосу бичгийнхээ ширээний дэргэд суугаад өнөө бичгээ задалж үзээд гайхсандаа өнөө зурвасыг дахин уншлаа.

...Танайхыг ойрын үед шатаах нь ээ. Бичиг дансаа холдуулсан дээр... 7 сарын 20... Энэ бичгийг уншаад Аяанаосу өөрөөсөө «Энэ зурвасыг ямар хүн бичсэн бэ?» гэж асуулаа. Тэрээр ширээн дээрх янжуураасаа авч асаагаад хатагана үсгээр монгол хэл дээр бичсэн зурвасыг ажиглан суухдаа «Симото, Харбинд ирэх тоолондоо намайг сонжоод юу ч олдоггүй болохоор одоо цөхөрсөн баймаар! Гэхдээ шалгаж мэдэх л хүн! Харин ойрын үед гэж бичсэнийг үзвэл өнөө маргаашдаа шатаахгүй нь илэрхий.

Сар өдөр тодорхой байхыг ажвал шатаах өдрийг надад мэдэгдэх гэсэн хэрэг! Тэгэхээр үүнийг бичсэн хүн нууц ажилд тун туршлагажсан хүн байх нь» гэж бодлоо. Чингээд Аяанаосу өөрөөсөө "Ямар зорилгоор шатаах гэж байгаа хэрэг вэ? Хамаг юмаа шатаалгасан хүн сэтгэл санаа, ахуй байдлаараа ямар байх вэ? Энэ галдан шатаах ажиллагаа ямар хүмүүст ямар ашиг өгөх юм бол? Энэ зурвасыг надад туслах гэсэн хүн бичсэн үү? Эсвэл..." гэдэг олон асуулт гарлаа.

Чингээд Аяанаосу, дээрх зурваст үндэслэж зөв дүгнэлт гаргах ёстойгоо ухаарав. Аяанаосу дагзаараа сандлын түшлэг налж бодит байдлыг сэтгэхүйнхээ хийсвэрлэлтэй харьцуулж бодлоо.

...Симото сэтгэлийнхээ сэжгийг нотлох ганц зам бол Амиса байсан. Гэтэл Амисэгийн нөхрийн албан тушаалаас айгаад ямар ч алхам хийгээгүй. Тэгэхээр намайг хардсан сэтгэлээ мухарлахын тулд эцсийн арга олсон хэрэг үү? Симото миний байрыг шатаагаад ямар ашиг олох вэ? Энд нэг эгзэг байна! Буянт биш гэдгийг тогтоохын тулд түүний алдаа, эндэгдэл, хэвшсэн зан заншил, хүсэл бодлыг нь хүртэл шалгасан баримтанд түшиглэж намайг сорьсон. Тэгэхээр одоо юунд түшиглэж сорихоор шийдсэн хэрэг вэ? Буянтын ярьсан зүйлийг дахин тунгаах хэрэгтэй... Би хамаг юмаа шатаалгаад толгойныхоо үснээс их өрөнд унасан үед Симото өөрийнхөө бодлыг шалгах эгзэг гаргах нь уу?...

Аяанаосу шөнөжингөө элдвийг бодохдоо халуун байхуу ууж, янжуур татсан болохоор ходоод нь харлан хорсож, хар шүлс аяндаа ундарна. Тэрээр үүр хаяарахын хэрд хажуулсан боловч нойр хүрсэнгүй. Тэгээд босож гал тогоондоо орж ус буцалгаад энэтхэг байхууны ханд аягандаа хийгээд жаахан юм идэх гэтэл сэтгэлд нь «Энэ зурвасыг бичсэн хүн өөртөө ашиг хонжоо гаргахыг бодсон бол яах вэ? Тэгвэл намайг хорлох гэсэн энэ ажиллагааг яаж мэдсэн байж таарах вэ?» гэж өөрөөсөө асуув.

Аяанаосуг хорлох ажиллагааг квантуны армийн тагнуулын газраас зохион байгуулсан гэж үзвэл түүнийг давын өмнө мэдэх хүн бол Тозияа, Симото, Хато гурваас гадна оросын цагаачдын товчооны сөрөг тагнуулынхан мэдэх ёстой ажээ.

Аяанаосу шарсан мах идэж суухдаа «Симотогийн энэ ажиллагааг мэдсэн Сафронов, өөртөө ашиг хонжоо гаргахын тулд надад мэдэгдсэн хэрэг үү? Тэгвэл энэ хэргийн дараа надаас ацаг хөлс нэхнэ. Сафронов эгэл жирийн дүртэй атлаа квантуны армийн нууц ажиллагааг мэдээд гадагш дамжуулж түүнийхээ хөлсийг чамбайхан, авдаг бол яана?» гэдэг бодол түүнийг эзэмдэнэ.

Аяанаосу энэ шөнө ганц хором ч нүд анилгүй өнгөрөөгөөд өглөө ажил дээрээ ирлээ. Тэгээд үдээс өмнө өрөөндөө тооцоо хийж захиалга өгсөн хүмүүсээс авсан урьдчилгаанд 120 мянган иень авсныг тооцоолж гаргалаа. Түүнээс гадна далаад мянган иень бэлэн байлаа. Ингээд дүнг гаргавал захиалгын газрыг шатаасны дараа Аяанаосу 200 мянган иений өрөнд орох ёстой аж. Түүнээс гадна байшингаа хөлслүүлсэн өвгөн ямаршуухан өр нэхэхийг мэдэхэд бэрх. Энэ бүхнийг эргэцүүлээд өөр дээрээ бэлэн байгаа иенийг банкны салбарт хадгалуулах хэрэггүй гэж үзлээ.

Учир нь Симотогийн гараар энэ бүхэн хийгдэж байгаа бол тэрээр банкинд байгаа хадгаламжийн хэмжээг хэдийн мэдсэн байх ёстой. Аяанаосугийн сэтгэлийг түгшээсэн нэг зүйл бол ийм их хохирол үзсэний дараа манжуур, алс дорнод, монгол руу чиглэсэн японы армийн түрэмгий бодлогыг илрүүлж төвд мэдээлэх үүргээ хэрхэн гүйцэтгэх вэ? гэдэг асуудал байлаа. Тиймээс Аяанаосу, энэ галдан шатаах ажиллагааг Симото, армийн тагнуулын удирдах хүмүүсийн даалгавраар хийж байгаа юу? Эсвэл тохиолдлын чанартай юу? гэдгийг яг тогтоох хэрэгтэй гэдгийг ойлгов.

Хэрвээ армийн тагнуулын удирдлагаас чиглэл аваад хийж байгаа бол Аяанаосу түүнийг өөртөө ашиглах хувилбар гаргах ёстой. Тиймээс Аяанаосу өр ширэнд баригдсан хүний хувьд бүх юмыг өөрөө санаачлах ёстой. Ингэхээр Симотогийн ажиллагааг сөргөж ажиллах талаар бодох нь зайлшгүй! Чингээд Буянтад байж болох буюу урьд өмнө байсан ааш араншингийн

онцлогийг нэхэн санана. Буянт Токиод байхдаа кэмпэйтэйд ашиглагдсан нэг эгзэг бол эцгийнхээ танил худалдаачнаас мөнгө зээлж сүүлдээ тэр нь 20 мянган иень болсонтой холбоотой. Чухам энэ эгзэг түүнийг хов зөөж, хошуу худалдах хорлон сүйтгэх ажилд даврахад хүргэсэн төдийгүй багахан шиг худалдаачдыг айлган сүрдүүлэх дээрмийн аргад боловсорсон шүү дээ...

Аяанаосу энэ бүхнийг эргэцүүлээд хүнд байдалд орсон үедээ Буянтын хэрэглэдэг аргыг дэс дараалан хэрэглэж чадвал Симотогийн гарт лавхан орж, тэгснээрээ тэдний гар хөлийн зарц болж квантуны армийн тагнуулын байгууллагад итгэгдэж болох талтайг ойлгов. Чухам ийм замаар тагнуулын байгууллагад шургаж чадвал «Рожуганука» ажиллагааг амжилтанд хүргэх боломж гарах байлаа. Тиймээс Аяанаосу хоёр хувилбар арга бэлдэв. Түүний гол үүрэг бол Хайлар Харбинд байгаа хорлон сүйтгэгчдийн сургуульд зааварлагчаар очиж чадвал монгол руу очиж байгаа тагнуул хорлон сүйтгэгчдийг арван хуруу шигээ мэдэж чадах нөхцөлтэй.

Хагас сайн өдрийн шөнө дундаас хойш гарсан түймрийн аюул Аяанаосуг халуун нойрноос сэрээжээ. Аяанаосуг гал гарсан газар ирэхэд Симото ирчихсэн байлаа. Тэрээр Аяанаосугийн сандарч тэвдсэн байдлыг ажиглаад сэтгэл зовсон царай гаргаж,

- Аяанаосу сан, гал унтраагчид ирсэн болохоор их сандарсны хэрэггүй. Манайхан гарз хохиролгүй унтраачихна биз гэж хэлэх нь цаанаа доогтой байлаа. Гал гарсан явдалд сэтгэл нь ханасан Симотогийн гадаад байдлыг мэдсэн Аяанаосу «Энэ бүхнийг Симото өдөөсөн байх нь. Тэгэхээр намайг ингэж хорлох гэсэн ажиллагаа бол тагнуулын газрын тодорхой зорилготой зүйл. Одоо анхныхаа сэдсэн аргаар ажиллах нь чухал» гэж бодов.

- Симото сан, чи юу ярьж байна вэ? Их гарз хохиролгүй гэнэ шүү! Миний ажлын өрөөнд далан мянган иень сул байгаа. Тэгээд зогсохгүй 100 гаруй мянган иений хувцас бэлэн байгаа шүү дээ гээд нулимс цийлгэнэсэн нүдээр Симото өөд ширтэн ямар нэг юм амандаа гонгиноно. Аяанаосу галыг түргэн унтраах гэж яарч сандарсан хүний дүр гаргаж гүйвч, гал сөнөөгчид түүнийг унтраах биш харин улам бадруулах зорилготой байгааг гадарлаад мэдээгүй царай гаргаж хий бухимдаж гүйсээр байлаа. Чингэсээр байгаад үүр цайж, өглөө болсон хойно галаа унтраахчаан аядлаа. Аяанаосу хөө, үнс болсон царайгаа үрчийлгэн, харамсан шаналсан харцаар Симото өөд гөлрөн,

- Одоо яанаа. Хамгийн гол нь өрөөнөөсөө хэрэгтэй юмаа авч чадсангүй. Ингэж балрах гэж байх уу даа. Одоо энэ их өрийг би яаж дарна гэж халаглан үглэж, хараал зүхлээ барж байлаа.

- Ийм санамсаргүй тохиолдлыг одоо яая гэх вэ? Гэхдээ бид учир шалтгааныг тодруулна гэж хэлэхдээ дууны нь өнгө энэ бүхэнд бахархан, хөх инээдээ барьж ядаж буйг илэрхийлнэ. Аяанаосу гал унтарсны дараа ус, үнстэй холилдсон, дутуу шатсан хэдэн хуудас бичиг баримт олжээ. Тэгээд орой нь Симототой уулзав.

- Аяанаосу сан сэтгэл санаагаар унаад яах вэ? Амьд хүн аргатай гэдэг. Учир нь олдох байлгүй гэснээ ярианыхаа сэдвийг өөрчилж,

- Ер нь аль зэрэг сүйрэл гарсан бэ? гэж асуулаа.

- Лав хоёр зуун мянга хол давсан гэж хэлэхэд Симото сэтгэлдээ «Аяанаосу Харбины банкнаас хадгаламжаа авлаа гэхэд яггүй өртэй үлдэх юм байна. Түүн дээр байшингийн эзэн чамбайхан юм нэхнэ» гэж бодоод сэтгэл хангалуун байв.

- Тун их гарз байна даа гэж Симото сэтгэл харамссан янзтай хэлээд,

- Манайхан гал гарсан учир шалтгааныг тодруулсан байна. Танай захиалгын газрын хүүхнүүд цогтой индүүгээ ширээн дээр орхиж явснаас гал гарчээ. Энэ гал ширээний бүтээлэгнээс гарсан гэдэг нь бүрэн нотлогдсон гэхэд Аяанаосу түүний үгийг зөвшөөрч,

- Би ч гэсэн тэгж бодсон. Гал гарах өөр шалтгаан миний санаанд буухгүй байгаа юм гэлээ.

Аяанаосу, захиалгын урьдчилгаанд авсан мөнгөө хүмүүст нь буцааж өгөх тухай зарлал "Дүрвэгсдийн дуу хоолой" сонинд нийтлүүлэв. Тэгээд банкны салбарт байгаа хадгаламжаа авч, мөнгө зээлсэн хүмүүсээс өрөө авч захиалагчдын гомдлыг барагдуулав. Аяанаосуд тохиолдсон золгүй явдлыг мэдсэн чинээлэг хүмүүс урьдчилгаанд өгсөн мөнгөө авсангүй. Үүнийг Симото тооцоогүй болохоор сэтгэл хуйсгануур болой. Аяанаосу хамаг байдгаа шавхаж өрөө дараад сэтгэл уужрах тийшээ орсон боловч байшингийн эзэн түүнийг засуулсан хөрөнгөнд 100 мянган иень нэхлээ.

Симото энэ бүхнийг арван хуруу шигээ мэдэж байсан болохоор нэг өдөр Аяанаосуг дуудаж уулзав. Тэрээр Сяньзингаас ирэхээрээ Мугдэн, Харбингийн цэргийн төлөөлөгчдийн газар сууж ажлаа явуулдаг болой. Аяанаосуг цэргийн төлөөлөгчдийн газар очиход Симото нэгэн хүүхэнтэй уулзан ярилцаж байлаа. Аяанаосуг өрөөнд орж ирсний дараа Симото өнөө хүүхнийг өрөөнөөсөө гаргалаа. Түүнийг гарсны дараа Аяанаосу сэтгэлдээ «Энэ хүүхнийг хаана харлаа. Нэг их танил царай байх чинь» гэж бодлоо.

- Аяанаосу сан байшингийн эзэн цагаачдын товчооны нэр дээр гомдол гаргасныг манайд шилжүүлсэн байна. Би түүнийг өөртөө авсан гэж сайрхан мэдэгдэв.

- Тэр зөнөг орос, байшингийн үнийг өдөр шөнөгүй нэхээд байгаа юм. Би одоо өөрийнхөө арьсыг хуулж өгөхгүй бол өөр сохор зоосгүй болоод байна. Заримдаа чамаас гуймаар санагдах юм. Гэхдээ чамайг зовоогоод яахав гэж боддог.

- Аяанаосу сан, бололцоотой юм бол тусална. Чи гуйх юм байвал ичиж зоволгүй хэлээрэй гэж уриалгахан хэллээ.

- Одоо энэ өрнөөс салах ганц зам байна. Армийн штабт тусгай үүрэг гүйцэтгэх ажилд орвол найдвар бий. Гэтэл намайг итгэж авах уу?

- Уг нь зүгээр санаа байна. Би удирдах хүмүүстэй яриад үзье. Ер нь Хайлар дахь барга монголын яаманд мэргэжилтэнгээр ажиллавал зүгээр!

- Симото сан, би тийм ажил хийгээд өрнөөс амархан салахгүй. Тэгэхээр азаа турших хэрэгтэй. Ингэвэл яг тэр зөнөг оросын амнаас хоёр яс сална. Ер нь дээрэм хийхгүй бол өөр зам надад алга болоод байна шүү гэж хэлэхэд Симото дотроо «Энэ чинь яах аргагүй Буянтын

бодол доо. Ингэхээр Буянтын шинж цухуйж байна» гэж бодлоо.

- Би хэдэн хүнтэй яриад орхиё. Чи юу ч гэсэн хүлээж бай! гэж Симоотоог хэлтэл нөгөө өрөөнөөс нэг дэслэгч орж ирлээ. Тэрээр Аяанаосутай мэндлээд Симоотоод хэдэн баримт бичиг үзүүлэв.

- Дэслэгчээ та 06—09 тоот эмэгтэйг Хянган руу шилжүүл. Одоо бидэнд хэрэггүй гэхийг Аяанаосу сонсоод хэдэн мөчийн өмнө Симоотогийн өрөөнөөс гарсан хүүхнийг хаана харснаа саналаа.

...Жан Сюэляныг баригддаг жил Хасу Тоиши нэг өдөр Модрен буудлын зоогийн газарт Аяанаосутай сууж байхдаа гаднаас японы хурандаатай хамт орж ирсэн нэг хүүхнийг хараад «Чи энэ хоёрыг харж бай! Би гараад ирье» гэж билээ. Тэгээд хэдэн мөчийн дараа орж ирээд «Энэ эмэгтэйг Сафронов сонирхоод байгаа юм. Одоо ингэсхийгээд Сафронов орж ирнэ» гээд тэр хүүхнийг Аяанаосуд сонирхуулан ярьж билээ. Хасу Тоиши, Сафронов хоёрын сонирхож байсан хүүхнийг Симоото баривчилсныг Аяанаосу түвэггүй мэдлээ. Тэгээд нэгэн далд бодолд автагдаад Симоототой уулзахаар шийдэв.

Гал гарснаас хойш сар хагасын дараа байрны эзэн Аяанаосуг байрнаасаа хөөж, шатсан байшингийн хохирлыг мөнгөөр төлөхийг шаардав. Аяанаосу өвгөний өрийг төлчих боломж байсан боловч өөрийнхөө төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж хайж байв. Тэгээд өвгөнтэй аминчлан ярилцаж хэд хоног хүлээхийг дотночлон гуйжээ.

Аяанаосу монголд илгээж байгаа хорлон сүйтгэгчдийг илрүүлэх, тэдний ажиллагааг хэрхэн удирдаж, ямар зүйл голлон анхаарч байгаа армийн гол төлөвлөгөөг мэдэх боломж-той боловч Симоотоог тэр бүхэнд ашиглах байлаа. Тиймээс Аяанаосу Симоотогийн аясыг харзнасаар хүлээсхийнэ. Аяанаосу армийн тагнуулын газарт итгэгдэж чадвал монгол руу чиглэсэн бүх ажиллагааг цаг тухайд нь илрүүлж, түүнийг унагах боломжийг өөрийн удирдлагад олгох ёстой.

...Хэрвээ байрны хөгшин арав хоногийн дотор байшингийн өрийг нэхэж ирвэл дахин болзол тавих хэрэгтэй. Хэрвээ миний болзлыг хүлээж авахгүй бол өөр өгөхөөс өөр замгүй. Харин тэр олон мянган иенийг олсон явдлаа Симоотоод үнэмшүүлэх ёстой дээрмийн аргаа сайн боловсруулах шаардлагатай. Симоото дээрмийн мөрөөр шалгана. Тэр үед үнэмших үндэслэлийг бүрдүүлсэн байх ёстой ажээ.

Аяанаосу энэ хэд хоногт болсон бүхнийг чингэж эргэцүүлэн бодохдоо Симоототой ярьсан үгээ эргэцүүлнэ. Тэрээр «Дээрэм хийхгүй бол өөр зам байхгүй» гэдгийг Симоотоод хэлснээ санах. Энэ бол Симоотогийн хожмын сэжгийг зөвлөхийн тулд хэлсэн үг. Тэгэх тусмаа Симоото, янхны газрын 06—09 тоот хүүхнийг баривчилсан явдлыг Хасу Тоишигийн яриатай харьцуулаад янхны газрын хүүхэн, эзэн хоёрын хооронд байгаа нарийн холбоог тунгаагаад Аяанаосу өөрийнхөө аргыг боловсруулсан. Тэгээд Аяанаосу өөрийнхөө боломжийг шалгахын тулд нэг орой Сафроновын туслахтай уулзаж,

- Хурандаа ирэх болоогүй юу? гэж асуулаа.

- Мөд ирэхгүй гэж Сафроновын туслахыг хэлэхэд Аяанаосу түүнийг зоогийн газар урьж, уй гашуун зовлонгоос ганц орой хуваалцахыг хүсэв. Ингээд зоогийн газар очлоо.

- Сафроновын сонирхоод байсан янхны газрын 06—09 тоот хүүхэн Симотогийнхонд баригдсан байна гэж хэзээ язааны мэддэг хүн шиг ярив.

- Тэр чинь их гарын хүүхэн дээ! Японы тагнуулын газрын гурван туршуулыг тонилгоод бас манай нэг туршуулыг устгачихсан юм. Тэгээд Сафронов ул мөрийг нь гаргах гээд чадалгүй алдчихсан. Японы тагнуулын газрынхан түүнийг Жан Сюэляны даалгавраар ажиллаж байсан гэж үздэг боловч нотолж чадаагүй. Янхны газрын эзэн тэр хүүхнийг зөвхөн дээд тушаалын хүмүүстэй нийлүүлдэг байсан учраас япон дарга нар түүнийг «06—09» гэж товчлон нэрлэсэн гэдэг.

Миний бодлоор бол тэр хүүхэн Жан Сюэлянтай холбоогүй. Харин янхны газрын эзэн Жан Сюэляны даалгавраар япон дарга нарыг гартаа хийж, тэднийг айлган сүрдүүлэх замаар нууцыг нь мэдэж байсан бололтой. Аяанаосу Сафроновын туслахтай уулзаж өөрийнхөө төсөөллийг батлах эгзэг гаргасны дараа нууц янхны газрын эзнийг айлгах маш нарийн төлөвлөгөө боловсруулав. Чингээд нууц янхны газраар хоёр удаа очиж байр байдлыг ажиглалаа. Чухам энэ үед өвгөн орос байшингийнхаа өрийг нэхэж ирлээ.

- Хөгшин минь та маргааш өглөө бүх өрөө надаас аваарай. Одоо хэдэн иень дутуу байна. Тэгэхээр маргааш өглөө арван цагт ир гэхэд,

- Маргааш өгөх юм бол хүлээе. Дахиж хугацаа сунгахгүй шүү! Хотын дарга шатсан байшингаа хурдан засуулж, янзлуул гэж шаардаад байна гэж учирлав. Аяанаосу, өвгөнийг явсны дараа төлөвлөсөн ажилдаа орохоор бэлтгэлээ.

...Үүр цайхын өмнө янхны газрын эзэн нойрноосоо цочин сэртэл орны өмнө нэгэн хүн сууж байлаа. Тэр хүн гар буу барьсныг ажвал японы дарга нарын зүүдэг «намбу» буу байлаа. Тэр хүн өргөн хүрээтэй бүрх малгай духдуулан өмсөж, хамар амаа өргөн бараан даавуугаар тагласан болохоор таних аргагүй.

- Та миний үгийг анхааралтай сонс! Танай газрын 06—09 тоот эмэгтэй манайд бий. Түүний барьцааг бодож 10 мянган иень өгье. Юуны өмнө анхааруулах зүйл бий. Танай хүүхэн таны даалгавраар японы дарга нарын нууцыг хулгайлж танд дамжуулдаг байсан. Харин та үүнийг яадаг байсныг би мэднэ. Гэхдээ таны амнаас үнэнийг дуулах ёстой учраас таныг үнэнээ бичиж өгнө гэдэгт итгэж байна. Тиймээс энэ иениэр дэнчин тавьж байгаа юм гэж зуутын дэвсгэрээр толгойлсон боодол иень үзүүлнэ.

- Аа... аа... ноёнтон минь энэ чинь болмоор юм байна. Би таны санааг ойлголоо. Та тэр хүүхнийг надаас худалдаж аваад өөр ажилд хэрэглэхийн тулд хожмын нууцыг бодож надаар баталгаа гаргуулах гэж байгаа юм байна. Ийм замаар Тозио сан хээрийн цагдаагийн даргаар ажиллаж байхдаа надаас хоёр хүүхэн худалдаж авсан юм.

- Энэ бол тэрнээс арай өөр! Та Жан Сюэляны даалгавраар японы армийн хоёр туршуулыг тэр хүүхнээр устгуулсны адилаар Сафроновын нэг туршуулыг тэр замаараа тонилгуулсан.

Үүнийгээ үнэн гэдгийг л бичиж өгөх ёстой. Нөгөө талаар маргааш өглөө цагдаагийн газар очиж өргөдөл бичиж өг. Түүндээ үл таних хүн шөнө ирж, дөчин мянган иень дээрэмдсэн гэж бичнэ гэж Аяанаосуг хэлэхэд өнөө хүн,

- Яаж тэгж болох вэ? Тэгвэл таныг амархан барьчихна шүү дээ гэв.

- Тэр талаар санаа зовох хэрэггүй. Одоо танд дөчин мянган иень өгнө. Түүнийг та өөртөө байгаа дөчин мянган иениэр сольж өгөх хэрэгтэй. Харин цагдаагийн газар өгөх өргөдөлдөө алдагдсан мөнгө буюу надад өгсөн мөнгөнийхөө дугаарыг дэс дараалан бичсэн байх нь чухал!

Янхны газрын эзэн, шөнийн гийчний хачин гайхалтай дээрэмдэлтийн учир ухааныг үл олон, шаардсан бүхнийг хийж гүйцэтгэлээ. Тэгээд хожмын зовлонгоос өөрийгөө аврахын тулд баталгаа бичгээ өгөхдөө,

- Жан Сюэляны талаар та хаана ч ярихгүй байх баталгаа өгвөл бидний хэн хэнд маань сайн шүү дээ гэж царайчлав.

- Би үүнийг танаас 10 мянган иенээр худалдаж авсан. Нөгөө талаар 1 сарын 26-нд Жан Золингийн хүү Жан Сюэляныг баривчлаад, Жэзын, Хубэй, Хунань, Гунжоугийн шоронд хорьж байгаад 1946 онд Тайванд аваачиж хорьсон юм болохоор зовох хэрэггүй. Тэр хүн шоронгоос гарч ирэхээсээ өнгөрсөн.

Аяанаосу нууц янхны газрын эзэнтэй ингэж гарцаагүй барьцаа тавиад өглөө нь байшингийн эзэн орос хөгшнийд очлоо. Тэгээд жаран мянган иенийг нь өгөөд,

- Хөгшин минь та бид хоёрыг Симотогийнхон хөөрхөн дөнгөлөө. Ингээд хүний гарт өртөөд байх хэрэг үү? Та юу бодож байна даа гэв.

- Японы тагнуулын газрынхнаар оролдох хэрэггүй. Зүгээр мөрөөрөө явсан дээр. Манай байшинг шатаасан явдал жирийн хэрэг биш. Миний нэг хамаатан залуу 1917 онд Харбинд байсан Оросуудын большевикуудтай нийлж ажилладаг байсан. Тэгээд жил бололгүй амиа алдсан. Японыхон түүнийг одоо мэдэж байгаа болохоор бас нэг бодолтой байгаа биз. Тэгэхлээр над шиг хүн мөрөөрөө явсан дээр.

- За тэгвэл хамаг юм ойлгомжтой. Харин танаас нэг юм гуйя. Таныг дуудаад өрөө өгсөн үү? гэвэл ердөө дөчин мянган иень өгсөн, үлдсэнийг нь дараа өгье гэж хэлсэн гээд энэ боодолтой иенийг үзүүлээрэй. Өөр юм асуувал мэдэхгүй гэх нь дээр. Мэдэхгүй гэдэг чинь мянган үгний таглаа болж чадна гэхэд өвгөн,

- Үүнийг хэлж чадна шүү. Харин чи өөрөө болгоомжтой байгаарай! Цаад самурай нар чинь чамайг чадах гэж байгаа бололтой гэлээ. Энэ өдрөөс хойш долоо хоноод Аяанаосуг Симото дуудуулав.

- Аяанаосу минь Харбины нууц янхны газрын нэг эзэн гомдол гаргажээ. Тун ноцтой хэрэг гарах бололтой.

- За тэгээд яагаа вэ? гэж Аяанаосу хэнэггүй асуулаа.

- Чи түүний сүнсийг зайлтал айлгаад 40 мянган иенийг нь салгачихсан юм биз дээ.

- Симото сан, чи тэгээд юу гэж бодож байна гэж Аяанаосуг асуухад,

- Би бодоод байсан юм алга. Байрны эзэн мөнгөнийхөө хагасыг өгсөн гээд дөчин мянган иень үзүүлсэн. Тэр чинь янхны газрын эзний иень болох нь илэрхий байна билээ.

- Би тэртэй тэргүй дүүрсэн хүн! Чамайг тус болох болов уу? гэж найдсан. Гэтэл тэр хөгшин орос миний үйл тамыг барах гэсэн шиг өдөрт хэд нэхдэг гэж санана. Тэр золигийн хараал зүхлийг нэг өдөр ч гэсэн сонсохгүй байя гэж бодсон юм. Харин танайхан надад «кэмпэйтэйнхан» шиг итгэхгүй байгаа биз дээ. Тэгэхээр чамайг зовоогоод яахав гэж бодоод өөрийнхөө сурсан аргаар шийдсэн. Чи ч гэсэн намайг аргалах гэж армийнхны урд хойно гүйгээд бас зовлонтой байгаа биз гэж хэлэхэд байж ядсан уурандаа Аяанаосугийн хүзүү, нүүр нь ягаарчихсан байв.

Аяанаосу үнэхээр гайхаш тасарсан нь Симотод илэрхий байлаа. Хамаг юмаа шатаалгаад болоогүй байхад сэтгэл санаагаар унаад, хувцас хунараа индүүдэхээ больжээ. Аяанаосу индүүдээгүй хувцас атугай ганц үрчлээтэй хувцас мөрөндөө угладаггүй байсан. Гэтэл одоо царай зүс алдаад хийморьгүй болжээ. Аяанаосуг ийм байдалд хүргэсэн Симото сэтгэл хангалуун агаад эчнээндээ "Энэ золиг Токиод байхдаа гаргасан бүх чанараа илрүүлээ. Буянтын зан чанарыг төдийгүй түүний нарийн эндэгдлийг түүнээс өөр хэн ч илэрхийлж чадахгүй нь мэдээж. Тэгэхээр одоо үүнийг оролдоод яахав. Хэдэн жил сонжиход илүү дутуу зан араншин цөмөөрөө илэрлээ. Яг л өөрийнхөө бүх шинжийг гаргалаа. Миний арганд ямар ч хүн гэнэдэх ёстой. Гэтэл Аяанаосу гэнэдсэнгүй, Тозияа үүнийг сонирхоод байгаа. Одоо шалгасан сорилтынхоо бүх үр дүнг илтгээд барга монголын яамны дэргэд байдаг монголын хэсэгт шилжүүлэх саналаа дэвшүүлье" гэж бодлоо.

- Аяанаосу сан одоо битгий гутар! Тозияа санд чиний тухай танилцуулсан овоо үнэлж байна билээ. Чамайг аягүй бол чи и (бага дэслэгч) болгоод монголын хэсэгт ажиллуулж магадгүй шүү гээд талархсан янзтай инээмсэглэлээ.

Зуны дунд сарын хуучдаарх нэгэн үдэш Сонион дахь хоёр давхар байшинд японы армийн хэд хэдэн удирдах ажилтангууд цугласан байв.

Тэд Хасан нуур чиглүүлсэн «Чанкуфын нуурын чанадад» гэж товлосон ажиллагааны талаар ярилцана. Энэ бол Зөвлөлтийн хилийн Заозерная гэдэг өндөрлөгийн нэрээр нэрлэсэн ажиллагаа ажээ. Ёоши газрын зургийн мэргэжилтний хувьд хуралд оролцлоо. Тэрээр армийн ажиллагааг харуулсан таних тэмдэг бүхий газрын зургийг хараад сэтгэлдээ бахархана. Таних тэмдгүүдийг ажвал Безымянная гэдэг өндөрлөгөөс 3 бээр байдаг Тумын голын нөгөө эрэг дээрх Нанхосон уулын Шакал өндөрлөгийн зүүн хэсэг Чиоки нуурын хойгуур, Иенгон сууринд байлдааны ангиудыг байрлуулсан байлаа. Мөн Тумын голын дунд байгаа элсэн арал дээр цэргийн ангиуд байрлуулахаар заасныг ажвал бэлтгэл хүч болох нь илт. Заозерная өндөрлөгөөс таван бээрийн зайтай их бууны галууд байрлуулжээ. Арван есдүгээр дивизийн даргын туслах,

- Мадай дивизийн байлдааны аймгууд долоо хоногийн дараа Хомуку тосгонд ирнэ. Ингэхээр та өөрийнхөө оросуудын асуудлыг удирдамж ёсоор янзал! гэж Ёошид хэллээ. Ёоши үүнийг сонсоод цэргийн дүрмийн дагуу,

- Мэдлээ. Гүйцэтгэе гэж илтгэв. Дивизийн удирдах ажилтны нэг нь Хуньчунгаас ирсэн хилийн отрядын даргад,

- Манай цэргүүд байрлах ёстой Дегашили, Хомуку сууринд үлдсэн айлуудыг ойрын өдрүүдэд суурингаас бүр мөсөн гаргасан байх хэрэгтэй. Тэгэхдээ Ёошигийн ажиллагааны дараа нүүлгэх ажлаа эхэлбэл дээр биз гэхэд хилийн отрядын дарга,

- Тай са доноо (ноён хурандаа) манай нэг суманг удирдсан тай и (ахмад) Сойхарагийн хүмүүс Хомуку руу өглөө гарсан гэлээ.

- Ёоши сан, та өөрийнхөө ажлыг Сойхаратай ярилцаж тохирох хэрэгтэй. Суурингийн гөжүүд хөгшчүүлийг жаахан айлгачих нь зүйтэй. Зүрхийг нь шантраагаад өгөхөөр тэд аяндаа нүүцгээнэ гэж хэлээд ажлын удирдамж өглөө. Ёошийг Хомуку руу хөдлөх гэж байтал Хуньчунгийн хилийн отрядын дарга ирээд,

- Ёоши манай тай и Сойхараад энэ бичгийг өгчихөөрэй гээд нэгэн зурвас өглөө.

Ёоши зам зуураа Сойхарагийн тухай бодно. Түүний тухай Симото үе үе ярьдаг байв.

Ялангуяа Ёошигийн ажилд удирдамж өгөх тоолондоо «Та бид хоёр санаа бодлоо ярилцаж байх нь чухал. Би олон хүнтэй ажиллаж үзсэн. Харин надад дуулгалгүйгээр ямар ч зүйлийг дураараа хийсэн хүнд би дургүй. Надтай Сойхара гэдэг нэг ахмад ажилладаг байсан. Гэтэл Юкигийн эцэгт хортой тариа хийлгэчихээд өөрийгөө баллах шахсан. Харин Тозияа өрөвчхөн сэтгэлээр хандаж түүнийг солонгос руу явуулсан юм» гэж билээ. Ёоши чингэж бодсоор яваад Тумынган голын зах дээр иртэл цэргийн сапёрынхан гүүр тавих газраа сонгож байгаа бололтой, усны гүнийг хэмжиж байлаа. Тумынган гол гүнзгий болохоор гүүр тавиагүй учраас татуургат бирваазаар (перевоз) нааш цаашаа гардаг. Харин Хомуку, Дегашели сууринд очих японы цэрэг техникийг хөвүүрт гүүрээр гаргахын тул аятайхан боломжийн газар сонгож байгаа болой. Ёоши голын эрэг дээр ирээд нөгөө эргээс ирэх татуургыг хүлээж байтал Тогава, Сойхара хоёр Хомуку тосгонд уулзсаны баяр тэмдэглэж байжээ.....

- Эрхэм хошуучаа таны бичсэн өгүүллийг манай нийгмийн сониноос уншсан. Чи тэр өгүүллийг бичихийн өмнө надтай уулзсан бол тун сайн байсан юм.

- Ахмадаа миний өгүүлэл муу болж уу?

- Юу гэх юм бэ дээ. Муу биш. Гэхдээ улс төрийн агуулгаараа үлбэгэр болсон байна. Өнгөрсөн хавар улаан оросууд хилийн маргаантай асуудлыг найрамдлын замаар шийдье гэдэг санаа сэдсэн юм. Тэгээд зогссонгүй, Хуньчунгийн гэрээг хүртэл хэвлэсэн. Гэтэл энэ бүхнийг та анзаараагүй болохоор давслах чинь хэтэрчихсэн байна. Аягүй бол гадаад яамныхан хэл ам татлах байх даа. 1931 онд Мугдэнгийн ажиллагааг гадаад яамны даалгавраар тагнахаар ирсэн Морисима тэндхийн элчин Хаяаситай нийлээд гадаад яамны сайд Сидэхараад төдийгүй

ерөнхий сайд Вакацукийд квантуны армийн удирдлага өөрсдийн дур зоргоор хууль бус ажиллагаа үйлдэж байна гэж сүрхий «матсан» шүү. Цэргийн яамны сайд Минами квантуны армийг болон Доихара, Тозияа хоёрыг хамгаалаад сүртэй эсэргүүцсэн гэдэг. Тэгэхээр чамайг энд юу хийж явааг гадаад яаманд мэдэгдчих хүмүүс бий гэдгийг мартаж болохгүй. Ер нь манай цэргийн яам гадаад яамыг тагнаж, гадаад яамныхан цэргийнхнийг хаана юу хийж явааг анддаггүй болсон гэдгийг мартаж болохгүй.

- Ахмад аа, би гакка Уэдагийн даалгавраар түүнийг бичсэн юм. Тэгэхээр алзахгүй биз.

- Шиү са доноо (ноён хошууч аа), гакка их зальтай хүн. Хэрэг буруудвал бөгс руу чинь өшиглөнө үү гэхээс татаад авахгүй. Би ч гэсэн тухайн үедээ Тозияа, Симото хоёрт түлхүүлж явлаа. Харин солонгост ирснээс хойш жаргаж байна. За хоёулаа ингэж дэмийрээд яах вэ? Дегашили рүү очих уу?

- Сойхара минь тийшээ очиж олзлогдсон хүүхнүүдтэй нялуурсанд орвол голын урд сууринд очиж эгч дүү хоёрыг оролдсон дээр. Ядаж цэвэрхэн шүү. Олзлогдсон хүүхнүүдийг цэрэг даргагүй талхиж гүйцсэн болохоор ой гутмаар байдаг юм. Тэд чинь замбараагүй учраас ямар ч өвчинтэй байж мэднэ гэхэд Сойхара,

- За тэгвэл чиний яриад байгаа тэр хүүхнүүд рүү чинь очъё гээд суудлаасаа өндийтөл Ёоши орж ирлээ. Тогава Ёошигийн бараанаар дуу алдан уулзаад,

- Ёоши... чи яагаад алга болчихов оо? Би хуучин танилтайгаа дайралдаад баахан хуучлаад аяга тагш юм хувааж сууна.

Та хоёр танилц гээд хундага дүүргэв. Чухам энэ үед Сойхара, Ёошигийн, царайг сайн тогтоож авах гэсэн шиг ажиглахдаа «Эзэн хааны зөвлөхүүдэд талтай энэ хүн хурандаа цолтой байсан гэдэг. Харин одоо бол...» гэж бодтол Тогава хундагатай архиа өргөж,

- Та хоёрыг танилцсаны төлөө, кампай гэлээ. Тэд хундага тулгаад нүд ирмэхийн зуур хөнтөрлөө. Ёоши ширээн дээр хоосон хундагаа тавихдаа халааснаасаа нэгэн зурвас гаргаж Сойхараад өгөөд,

- Үүнийг танай хурандаа өгүүлсэн юм гэв. Сойхара өнөө бичгийг уншаад хэсэг дуугүй зогссоноо,

- Ёоши сан, таны шийдийг сонсъё гэлээ.

- Маргааш орой Дегашили дахь цагаачдыг болон олзлогдсон хүүхнүүдийг байшинтай нь шатаана. Энэ бол манай армийн нууц ажиллагааны учрыг сайн мэдэж байгаа болохоор армийн нууцыг хадгалахын тулд нэг ч гэрчийг үлдээж болохгүй. Нөгөө талаар энэ хэргийг орон нутгийн засаг захиргаагүй мухар толгойтны гараар үйлдэгдсэн гэдэг нотолгоо гаргахын тулд маргааш өглөөнөөс орой нар жаргах хүртэл гудамжинд эргүүл гаргаж, энгийн хувцастай дөрвөн хүнийг ажиглуулах хэрэгтэй. Гэхдээ тэднийг ямар ч нөхцөлд баривчилж болохгүй. Буудаж ч болохгүй гэдгийг эргүүлийн цэргүүдэд анхааруулсан байх ёстой! Харин харанхуй бүрийгээс хойш тэр хүмүүсийг танай эргүүлийн цэргүүдээс нэг ч хүн харсан байж болохгүй

гэж хатуу даалгалаа. Сойхара, Ёошигоос ийнхүү үл ойлгогдох үүрэг аваад гарсны дараа хил дээр холбооны шугам тавьж, Камейзогийн дивизийг холбоогоор хангах ёстой салааны бага дэслэгчийг Ёоши дуудаж уулзав.

- Чи өөрийнхөө салаанаас дөрвөн цэрэг гаргаж энгийн хувцсаар хувцаслаад маргааш өглөөнөөс бүрэнхий болтол суурингаар явуулах болно. Тэгэхдээ Дегашилийнхэнд үзэгдэхүйц газраар явуулах хэрэгтэй. Орой нар жаргаж бүрий болмогц, оросын цагаачдын байшингийн хажуугийн байшинд очуул! гэж үүрэг өглөө. Ёошигийн энэ заавраар маргааш үдээс өмнө Хомукугийн сууринд дөрвөн үл таних хүн үзэгдэж байгаад үдээс хойш, Дегашили руу явжээ. Тэр хүмүүс бүрий болохын үед газар нүхлээд орчихсон юм шиг алга боллоо. Гэвч эргүүлийнхэн тэр дөрвийг мөрдөн хөөх даалгаваргүй болохоор Хомукудаа үлдсэн.

Ёоши нар жаргах гэж байхад Дегашилид ирж, оросын цагаачдын оройн хоолыг шалгаж үзлээ. Тэгээд тогоочийг дуудан,

- Та нар өнөөдрийн хоолыг сайн хийжээ. Тиймээс манай харцагануудад хатуу нясуун юм өгөхийг бодохгүй юу гэлээ. Үнэндээ оросын цагаачид сүүлийн үед архидаж, замбараагүйтэх нь ихэссэн учир Ёоши тэдний наргиан цэнгээнийг хориглосон ажээ. Япон тогооч Ёошигийн зөвшөөрлөөр агуулахаас архи авчруулж, орос цагаачид даргынхаа санаачилгыг магтан баярлацгааж хундага өргөсөн бүхэн үг хэлнэ.

- Хаант оросын армийн эрхэм дайчид аа. Та бүхэн их наран улсын аугаа үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрийг оруулахын тулд авьяасаа зориулж, амь биеэ хайрлахгүй зүтгэлээ. Манай армийн удирдлага та нарын гавьяаг эрхэм атаман Семеновт илтгэж, шагнуулах санал оруулсан.

Тиймээс атаманы бие төлөөлөгч Харбинд ирчихээд байгаа. Тэр хүн та бүхэнтэй биеэрээ уулзах гэж дуудуулсан тул та бүхэн нөгөөдөр Харбин руу буцах болно. Ингэхээр та бүхний амжилтын төлөө энэ хундагыг өргөе. Кампай гэж Ёошийг хэлэхэд оросын цагаачид суудлаасаа босон нэгэн дуугаар «Ёоши сан, ура» гэж хашгирлаа.

- Ноёд оо, та бүхэн өнөө шөнө яаж ч болно. Сайн наргих хэрэгтэй. Харин тосгоныхны анхаарлыг татсан шуугиан дэгдээх хэрэггүй учраас хаалга цонхоо сайн битүүлэх хэрэгтэй. Манай армийн түрүүчийн анги өнөө шөнө сууринд орж ирнэ. Тэгэхээр илүү дутууг ажсан дарга нар та нарыг шиншлээд дээш нь мэдээлбэл та нарыг хамаагүй эрхлүүлээ гэж намайг жавгийдах болно. Тэгэхээр та нар миний нэр сүрийг бодох биз гэж Ёошийг хэлэхэд оросын цагаач нар хаалга цонхоо битүүлэв. Чингээд тэднийг халж «улаан зээрд» болчихоод байхад олзлогдсон хүүхнүүд орж ирлээ. Тэр хүүхнүүд багагүй сэржимдсэн ажээ.

Ёоши оросын цагаачдын наргианаас гараад зэргэлдээх байшинд орж ирэхэд бага дэслэгчийн бэлдсэн дөрвөн хүн түүнийг хүлээж байлаа. Чингээд шөнө дунд өнгөрч байхад оросын цагаачид олзлогдсон хүүхнүүд ухаангүй унасныг мэдэнгүүт Ёоши өнөө дөрвөө гаргаж, байшингийн хаалга цонхыг гаднаас нь бөхөлж түгжээд хуурай өвс овоолж, байшингийн дөрвөн талаас галдав.

Шөнийн харанхуйд гарсан галын дөл тэнгэр өөд олгойдон хавь ойрын газрыг өдөр шиг гэрэлтүүлэх авч сууринд үлдсэн хүмүүс байшингаасаа гарахаас эмээж зөвхөн цонхоор

байдлыг ажиж зогсоход согтуу хүмүүсийн орилоон, хашгираан, хараалын үгс бүдэг бадаг сонсогдохын хамт хааяа буун дуу цуурайтна.

Шөнөжин гарсан галыг өглөө унтарсан хойно суурингийнхан байшингаасаа гарч хашааны завсар заалхайгаар гал гарсан байшин руу ширтэж байтал япон цэргийнхэн ирж, суурингийнхныг хурдан нүүж ар тийшээ зайлахыг шаардлаа. Тэгээд хүмүүсийг суурингийн голд цуглуулж Ёоши яриа хийлээ.

- Японы эзэн хааны арми, манжуурт олгосон тусгаар тогтнолыг хамгаалах эрх ашгийн үүднээс Хасан нуурыг та бүхэнд эргүүлж олгохын тул ихээхэн санаачилга гаргаж байгааг та бүхэн мэдэж байгаа. Гэтэл орон нутгийн мухар толгойтнууд манай энэ ажиллагаанд хордохдоо элдэв хорлон сүйтгэх бузар ажиллагааг хийж байгаагийн нэг тод жишээг та нар нүдээрээ харлаа. Өчигдөр нутгийн засаг захиргаагүй дээрэмчид танай тосгонд орж ирсэн байна. Тэд дөрвүүлээ явжээ. Тэгээд манай армийн идэвхтэй туслагч, та бүхний тусгаар тогтнолыг хамгаалагч оросын үнэнч дарга нарын байшинг шатаасан байна.

Бид тэр дөрвөн хорлон сүйтгэгчийг барьсан. Тэдний мэдүүлж байгаагаар бол оросууд Хомуку, Дегашили суурин руу довтлохоор бэлдэж байгаа гэнэ. Үүнийг бид армийн удирдлагад мэдэгдсэн. Өнөө маргаашгүй манай цэргүүд та бүхний аюулгүй байдлыг хамгаалахаар ирэх гэж байна. Иймээс та бүхэн, амгалан тайван, аюулгүй байдлаа бодож тосгоноос хурдан нүүж ар талд очих ёстой гэж сэнхрүүлэн ухуулав. Чингээд хоёр цагийн дараа тосгоны хүмүүсийг бөөн бөөнөөр тууж, голын эрэг дээр авчраад бирвааз руу түлхэн гаргалаа.

Хүмүүс бирваазны талбай дээр багтахгүй болж, хөл тавих зайгүй шавлаа. Гэсэн ч японы армийн хээрийн цагдаагийн цэргүүд хүмүүсийг хамаа намбаагүй түлхэн бууны бөгсөөр нүдэж зодсоор татуурга дээр гаргана.

Хоёрдугаар бүлэг

Үхлийн салхи дэгдээгчид

Нэг. Сүйрлээс гарах замаа бэлдсэн нь

Хасан нуурт болсон сүйрлийн дараа японы армийн дарга нар дүнсгэр царайлж нэг хэсэгтээ алмайран бодлогоширчээ. Тиймээс Ёошийг Харбинд ирэхэд Хато генерал царай муутай угтлаа. Тэрээр Дегашилид амь үрэгдсэн оросын цагаач нарын асуудлыг хариуцаж байлаа.

Гэтэл Хасу Тоиши, ахтайгаа холбоо барьж генералын ар хударгаар оргож амжсан төдийгүй тэр хэрэгт сэрдэгдсэн Мешанов Харбин руу ирж явах замдаа техникийн ослоор диваажинд одлоо. Чингээд атаман Семеновт тал засаж байсан генерал, Харбин дахь «Оросын фашист холбоонд» ямаршуухан тайлбар өгөхөө бодон шаналав. Хато, ингэж сэтгэлээ шаналгасан болохоор Ёошигоос учир явдлыг ахин дахин лавлана. Тиймээс Ёоши нүдээрээ үзсэн бүгдийг генералд айлдах ёстой боллоо.

- Нэг бүдрэхээр долоо бүдэрнэ гэгчээр Камейзо тийм сайхан боломжийг алдаж гай тарих гэж дээ гэж үглээд өөрийнхөө ширээний дэргэд зогсож байснаа цонх руугаа очиж намрын эхэн сарын бүрхэг тэнгэртэй Харбины гудамж руу гөлөрлөө.

- Ер нь юу болсныг дэс дараалан яриадахаач гэж генералыг гайхаш тасарсан янзтай асуухад Ёоши,

- Гакка (эрхэм дээдсээ), Улаан оросууд 4 сарын 28-нд Известия гэдэг сонинд нийтэлсэн зүйлийг санаж байгаа биз дээ?

- За тийм. Орос японы маргааныг хэлэлцээний замаар зохицуулъя гэж санал дэвшүүлсэн юмдаг.

- Камейзо сан үүнийг зөвшөөрөөгүй. Тэгээд өөрийнхөө бүх ажиллагааг санаачилсан билээ.

- Би түүнийг мэдэж байна. Гадаад яам Москва дахь элчингийн хэргийг түр хамаарагч байсан Нисигээр дамжуулж Хасан нуураас оросын цэргүүдийг гаргахыг 6 сарын 15-нд мэдэгдсэн билээ.

- Ниси саны тэр мэдэгдлийн хариу болгож Улаан орос 1886 онд байгуулсан Хуньчунгийн гэрээний талаар Правдо сонины 18-ны дугаарт нийтэлсэн л дээ. Үүнийг Камейзо болон түүний саналыг дэмждэг хүмүүс, «Кокухонся-төрийн үндэс», «Сакурайка-интоор» болон «Хар луу» нийгэмлэгийнхний түлхээсээр хэдэн залуус Токио дахь улаан оросын элчингийн байшин руу дайрсан.

- Би тэр бүгдийг мэднэ. Тэр байтугай 6 сарын 20-нд Сигемицугийн тавьсан асуудлыг мэдэж байсан юм. Харин Жамейзо тийм сайхан завшаанаар Чанку фынд "Заозерная өндөрлөг" 15 мянган цэргээ гаргачихаад яахаараа хамаг ажлаа балладаг байна даа? гэдэг асуудал намайг зовоож байна.

- Эрхэм дээдсээ, генерал эхний үед цэргээ зөв байрлуулж чадсан. Ялангуяа их буугийн гал хамаг асуудлыг шийдэж, Безымянная, Заозерная өндөрлөгийг манайхан амархан авсан юм. Камейзогийн гол алдаа бол Хасан нуурын зүүн талаар улаан арми орж ирэхгүй гэж тооцоолсон юм. Учир нь Хасан нуурын зүүн тал намаг шавхай ихтэй, зам харгуйгүй болохоор бүхэл бүтэн хоёр дивизийг оруулж чадна гэж хэн хүний санаанд орох билээ. Гэтэл улаан оросууд тэр намаг дундуур цэргээ гаргаж Бүргэд орчмын газрыг хамгаалалтандаа авчихсан юм.

- Тэр намгийг тооцолгүй гэнэдэнэ гэдэг чинь яах аргагүй тэнэг хүний зан чанар! Тиймээс улаан оросууд Хасан нуурын баруун хойд хэсэгт хамаг цэрэг техникээ бөөгнүүлсэн гэдэг ойлголтыг Камейзоод төрүүлээд цохилтынхоо гол хүчийг Хасан нуурын зүүн талын намаг дундуур явуулж Камейзогийн хударгаар орсон байна.

- Эрхэм дээдсээ гэхдээ 8 сарын 2, 3-нд Камейзогийн бүх хүч оросын довтолгооныг бариагүй бол Дегашили аль эрт оросуудын гарт орох байсан.

- Тэр чинь Камейзогийн амиа хоохойлсон арга болохоос байлдааныг амжилтанд хүргэх арга биш. Энэ чинь Москвад байгаа Сигемицуйг гал зогсоох, үг дуугүй бууж өгөх санал дэвшүүлэхэд хүргэсэн юм. 8 сарын 4-нд тавьсан тэр асуудлыг оросууд мэдэхгүй гэж санаа юу? Та нар байлдааны галыг түр зогсоох нэрийдлээр хүчээ сэлбэх гэсэн бодолтой байсныг оросууд мэдэж байгаа учраас галаа түр зогсоохгүй гэсэн шүү дээ. Тэд чинь маанаг амьтад биш. Тиймээс Зөвлөлт засаг гэгчийг 21 жил хөл дээр нь зогсоож чадсан. Та нар юмыг бодитойгоор сэтгэж байх хэрэгтэй! Гал зогсоох нэрийдлээр эзэн хааны 15, 20 дивизийг Солонгосоос очихыг хүлээх гэсэн та нарын залиг Воршилов мэдээд Штерний гарт 39, 40 дүгээр дивиз, механикжсан бригадаа шилжүүлсэн байна.

- Эрхэм дээдсээ таны хэлдэг түмэн зөв. Үнэндээ Камейзоод эзэн хааны цэргийг удирдах мэдлэг чадвар дутсан юм.

- Цэргийн жанжин хүн гэдэг чинь ахар богино хугацаанд бага хүчээ зөв зохион байгуулж, бүх галаа нэгтгэж чаддаг байх хэрэгтэй! Улаан оросуудыг хар! 8 сарын 5 гэхэд бүх цэрэг зэвсэг техникээ зөв байрлуулаад 6-ны өглөөний мананг хүртэл ашиглаж чадсан байна. Тэр байтугай Камейзогийн бэлтгэл хүч хаана байрлаж байгааг сайн мэдэж байжээ. Улаан арми Камейзоог дийлэхгүйдээ ухарсан биш.

Гол хүчээ иртэл та нарын ар талд тагнуулаа хаячихаад ухаарсан дүрээр молигодсон байна. Тэгээд Оросын тагнуулууд Камейзогийн бэлтгэл хүч хаана байгааг мэдэж чадсан учраас оросын 130 бөмбөгдөгч, 70 дайрагч онгоц Элсэн арал дээр байсан бэлтгэл хүчийг элс шороотой нь хутгаад тэгшилчихсэн байна шүү дээ гэж сүртэй хашгирч хэлээд цонхныхоо дэргэдээс Ёошигийн хажууд ирж зогслоо.

- Ёоши сан, та Хасан нуурын байр зүйн зургийн ажлыг хугацаанд нь сайн хийсэн болохоор зохих үүргээ гүйцэтгэснийг хэлэх хэрэгтэй. Харин одоо таныг маш том ажил угтаж байна. Камейзо эзэн хааны армийн нэрийг Хасан нуурын байлдаанд гутаасан бол одоо бид түүнийг аврах их ажлыг дорвитой эхлэх ёстой. Энэ бол Монголыг эзлээд цаашдаа Байгаль Сибирыг эзэн хааны дэглэмийг тогтоох явдал юм. Тиймээс таныг Тозиягийн мэдэлд буцааж

ажиллуулахаар болсон. Та нөгөөдөр гэхэд Мугдэнд бэлэн байх ёстой гэлээ.

Уужим өрөөний дөрвөн ханын дагуу зассан урт, өргөн ширээний хоёр талаар суусан цэргийн дарга нар, утсаар ярьж буй ширвээ сахалтай, махлагдуу биетэй, бодлогоширсон царайтай Уэда руу ширтжээ. Уэда, утсаар ярьж байхдаа хааяа «мэдлээ... ойлголоо... за тэгье» гэхээс өөр юу ч хэлэхгүй, анхааралтай сонсоно.

Квантуны армийн удирдагчийн өрөөнд цугласан хүмүүс алдар цол, албан тушаалын эрэмбэ дэвээр сууцгаасныг ажвал ямар асуудал хэлэлцэх гэж байгаа нь тодорхой болой. Өргөн ширээг тойрч суусан хүмүүсийн өмнө цэвэрхэн цаас тавьсныг ажвал ярианд гарсан баримтыг тэмдэглэн өөрсдийнхөө саналыг түүнд тулгуурлаж бэлтгэхэд зориулсан ажээ. Тиймээс Уэдаг утсаар ярьж байхад зарим генералууд өөрийн ярих үгийн санааг тэр цаасан дээр тэмдэглэж суулаа.

Ширээний цонхон талын эхэнд хошууч генерал Тозияа сууж, түүний өмнөөс харж суусан хурандаагийн хажууд энгийн хувцастай намхан пагдгар биетэй хижээлдүү хүн суусан нь жанжин штабаас ирсэн төлөөлөгч байлаа. Энэ хүн Уэдагийн өрөөнд болох хурлын явцыг ажиж дээш нь илтгэх үүрэгтэй болой. Харин Тозияагийн дэргэд Харбингаас умард солонгосын хил хүрдэг төмөр замын

Пинфан өртөөнд нууц байгуулсан цэргийн эрдэм шинжилгээний газрын захирлын туслахуудын нэг суужээ. Тэр нууц байгууллага 1934 онд байгуулагдсан бөгөөд бактерлогийн дайны үйл ажиллагааг боловсруулдаг хэд хэдэн хэлтэстэй аж.

Тэр хэлтсийн нэр нь Харбинд «Усаар хангах, урьдчилан сэргийлэх газар» гэсэн нэрээр ажилладаг бөгөөд тэнд Зөвлөлт, Монгол, Манжуурын зарим нутгийн усны дээжийг шинжилж нян үржүүлэх ашигтай асуудлыг боловсруулдаг аж. Харин тахлын нян судалж үржүүлэх хэлтэс нь маш нууц байдаг. Тэнд өвөр монгол, манжуураас олзолсон хүмүүсийг авчирч туршина. Уэдагийн өрөөнд эдгээр хүмүүсээс гадна квантуны армийн хэд хэдэн дарга нар сууж байв. Тэдгээр генералуудын доохон талд суусан нэгэн хошууч, ахмад хоёрыг ажвал Халх голын сав газрын байр зүйн тодруулалтанд түшиглэж газрын зургийн товоймол загвар хийх мэргэжилтэнгүүдийн ажлыг удирдах ёстой хүмүүс байжээ.

Уэда утсаар ярьж дууссаны дараа ширээн дээр байгаа ширэн хавтаснаас хэдэн бичиг гаргаад нүдэндээ шилээ зүүнгүүт яриагаа эхлэв.

- Жанжин штабын дарга ярьж байна. Та бидэнд маш их итгэл найдвар хүлээлгэж байгаа төдийгүй Халх голын асуудлыг шийдэх төлөвлөгөөг яаралтай боловсруулахыг шаардаж байна. Бид юуны өмнө Хасан нуурт манай армийн нэрийг хөөдсөн Камейзогийн алдааг давтаж болохгүй. Нөгөөтэйгүүр Хасан нуурын ажиллагаа нурсан нь хятадыг манай мэдэлд олгох талаарх асуудлыг их гүрнүүдээр зөвшөөрүүлэх явдалд саад болсон. Энэ байдлаас ангижирч манай армийн ялагдашгүй хүчийг их гүрнүүдэд ойлгуулах, ялангуяа Сибирь, Алс дорнодыг эзэн хааны эзэмшил болгох хүчин чадал төгс төгөлдөр байгааг харуулах ёстой. Иймээс Халх голын асуудлын талаар энд ирсэн хүн бүхэн өөрийн саналаа миний ярьсан баримтанд түшиглэн хэлэх хэрэгтэй гээд цэргийн яам, жанжин штабын баримталж байгаа бодлогыг тайлбарлав.

- Эрхэм генералууд аа, хэдхэн сарын өмнө Герман, Австрийг эзэлсний адилаар одоо Чехословакийг нэг мөсөн шийдэхээр Мюнхенд хийсэн англи, франц, итали, германы хэлэлцээг үр дүнд хүргэх нь гарцаагүй болсон. Энэ нь бидэнд хятадыг бүрмөсөн эзлэх төдийгүй улаан оросын эсрэг хийх дайныг амжилтанд хүргэхийн тулд Германтай холбоо байгуулах алхмыг нээж өглөө. Ялангуяа Герман, Мюнхений хэлэлцээгээр Чехословакийн асар их хүчийг ганц сумны гарзгүйгээр авсны адилаар бид хятадыг тийм замаар авахын тулд

америк, английнхантай тохиролцох боломжийг бий болгох хэрэгтэй. Энэ явдал Халх голд байгуулах манай ялалтаас ихээхэн шалтгаалах юм. Иймд бид алдагдсан нэр төрөө аврахын тулд Халх голыг эзлэх ёстой. Уэдагийн дараа жанжин штабын төлөөлөгч босож ярилаа.

- Уэда сан, олон улсын улс төрийн уур амьсгалыг зөв дүгнэж ярилаа. Үүний зэрэгцээгээр бид улаан оросын армийн талаар бодох хэрэгтэй юм. Жанжин штаб улаан армийг дотроос нь задлах, удирдлагын ажиллагааг сарниулах талаар багагүй зүйлийг санаачилсан.

Үүнийг амжилтанд хүргэвэл Сталинаас монголд үзүүлэхээр амласан үүргийг сааруулж, монголын цэргийг яах ийхийн зуургуй устгаж амжилт гаргах нь гарцаагүй. Манай арми монголыг эзэн хааны эзэмшил нутаг болгож чадвал бас Чан Кайшигийн гараас хятадыг түвэггүй салгаж чадна.

Ялангуяа улаан оросоос монголд үзүүлэх цэргийн тусламжийг таслан зогсоож чадвал улаан Оросоос Хятадад үзүүлэх ёстой цэргийн тусламж бүтэхгүй гэдгийг Чан Кайшид ойлгуулж чадна. Ингэснээрээ хятадын нэгдсэн арми гэдгийг сарниулж чадна. Энэ бүхнийг амжилтанд хүргэх алхам бол Халх голыг эзлэх явдал юм.

Халх голыг эзэлснийг Чай Кайши сонсонгуут манай армийн сүр хүчинд итгэж Хятадын асуудлыг шийдвэрлэх хэлэлцээний ширээнд өөрснөө биднийг гуйж урих нь гарцаагүй билээ.

Жанжинштабынтөлөөлөгч,квантуныармийнудирдаххүмүүсийн сэтгэлд итгэл төрүүлэхийн тул жанжин штабт боловсруулсан хэд хэдэн нууц төлөвлөгөөний талаар ярилаа, Уэдагийн өрөөнд байсан дарга нар, төлөөлөгчийн яриаг анхааралтай сонсож зарим зүйлийг цэргийн томьёолсон тэмдэглэлээр бичиж авлаа.

- Жанжин штаб алс дорнод руу чиглүүлсэн ОЦУ төлөвлөгөөний шинэ хувилбарыг боловсруулсан. Ялангуяа Халх голд ялалт байгуулбал Доихарагийн удирдсан тавдугаар арми алс дорнод руу орж Байгалийн чанад дахь газар нутгийг эзлэн авах болно. Тиймээс Халх голд хийх ажиллагаанд 5 дугаар армийн бүрэлдэхүүнийг оролцуулах болно. Иймээс та бүхэн энэ талаар саналаа тодорхой ярилцаж шүүн тунгаах ёстой гэж үзэж байна.

Жанжин штабын төлөөлөгчийн сүүлчийн үг Тозиягийн сэтгэлд аятайхан сэтгэгдэл төрүүлэв. Тиймээс Тозия өөрийнхөө нэр төрийг үнэлүүлэх алхам хийх ёстойгоо ухаарлаа. Чингээд Тозия жанжин штабын төлөөлөгчийг суунгуут босож өөрийнхөө үүрэг зорилгын үүднээс саналаа хэлэв.

- Эрхэм дээдэс ээ, бид Азийг сэргээн шинэчлэх эзэн хааны замналыг хэрэгжүүлэх жинхэнэ бодит бололцооны босгонд тулаад байна. Тиймээс бид эзэн хаандаа үнэнч самурайн ёс

бусидоог баримтлах ёстой. Богд хаан энх тунх ахуйдаа эзэн хааны армиас тусламж гуйж олон сая иенэтэй тэнцэх ихээхэн хэмжээний алтыг Хятадад авчруулсан нь тодорхой болсон. Гэсэн ч энэ алт одоо хувь хүний хөрөнгө болчихоод байгаа. Гэхдээ Богд хаант улсыг сэргээн байгуулах буюу монгол туургатныг нэгтгэх үндэсний үзэлтэй хүний гарт энэ хөрөнгө байгаа нь бидэнд түүнийг ашиглах боломж олгож байгаа юм.

Тозияаг үг хэлсний дараа хэд хэдэн дарга нар түүнээс зарим зүйлийг тодруулж асуух зөвшөөрлийг Уэдагаас гуйлаа. Уэда генералуудын хүсэлтийг зөвшөөрлөө.

- Тозияа сан Халх гол руу чиглэсэн ажиллагааны нэг чухал зүйл бол армийн цэрэг зэвсэг, техникийн тээврийн асуудал юм. Бидний мэдэж байгаагаар бол Юкигийн талийгаач эцэг Хайлараас Буйр хүртэл төмөр зам тавиулах сонирхолтой байсан гэдэг. Та үүнийг юу гэж үзэж байна? гэж нэг генералыг асуухад Тозияа суудлаасаа өндийв.

- Бидэнд энэ талаар хоёр боломж бий. Нэгд Хайлараас Буйр нуур руу төмөр зам тавих асуудлыг нууцлах ёстой. Түүнийг нууцлахын тулд Юкигийн нэр төрийг ашиглаж болно. Өөрөөр хэлбэл Буйр нуур руу тавих төмөр замыг арми, цэрэг дайны зориулалтай тавиулж байна гэдэг шуугиан дэгдээлгүй харин Юки өөрийнхөө хөрөнгийг Манжуурын зам харилцааны нийгэмлэгтэй хөрөнгө хоршин хувь нийлүүлж иргэний зориулалтаар тавьж байгаа юм гэдэг сэтгэгдэл төрүүлбэл манай армийн ажиллагааг нууцалж чадна.

Нөгөө нэг боломж бол Юки эцгийнхээ гэрээслэлийг бодож төмөр замын нийгэмлэгүүдтэй хөрөнгө хоршиж Буйр-Хайларын төмөр зам тавих явдлыг эрхэмлэвэл хувийн пүүсүүдэд армиас олгох зардлыг Юкигээр гаргуулж болох юм. Тозияагийн дараагаар Харбины эрдэм шинжилгээний институтийн захирлын туслах ярилаа.

- Халх голын ажиллагааг амжилтанд хүргэх асуудлын нэг бол монголын нутагт нян тараах явдал билээ. Сайн шилж сонгосон боом, сүрьеэ, тахлын нян бол бидний хамгийн гарамгай зэвсэг мөн! Манай газар энэ хугацаанд тахлын нян үржүүлдэг дулаан төхөөрөмж бүхий савнаас 130 мянган нян, булчин задлах, уушигны сүрьеэ, гэдэсний хижиг, тахлын олон арван тонн нян бэлдсэн. Бид Халх голд хамгийн түрүүнд нян туршихад бэлэн байгаа бөгөөд ганцхан армийн

удирдлагаас шийдвэр хүлээж байна.

Нян боловсруулах 4 дүгээр хэлтэс, нянг хүнд турших 5 дугаар хэлтэстэй хамтран ажиллаж байгаа нь их амжилтанд хүрлээ. Ялангуяа бутрамтгай шаазан бэлдсэн явдал нянг ямар ч газар оронд тараах боломжийг бий болгож өглөө гээд тусгайлан бэлдсэн цагаан шаазан бортгонуудыг үзүүлж сонирхуулав.

Квантуны армийн удирдагчийн өрөөнд болсон хуралдаанд хятадад байлдаж байгаа хэд хэдэн дивизийн удирдагч оролцсон нь Халх голын байлдаанд тэдний хэнийг тавих вэ гэдэг асуудлыг шийдэхтэй холбоотой байлаа. Тэдгээр генералууд хятадад байлдаж байгаа хэд хэдэн дивизийг монгол руу татах нь зүйтэй гэж үзэв. Ингээд хүмүүсийн эцэст Уэда товч дүгнэлт хийлээ.

- Та бүхний үзэж байгаагаар бол Халх голд явуулах манай ажиллагаа их ирээдүйтэй гэдэг нь тодорхой байна. Тиймээс бид Халх голын ажиллагааг явуулах тохиромжтой газрыг шилж сонгох нь зайлшгүй боллоо. Халх гол бол Яматогийн хөвгүүдийн эр зоригийг төдийгүй манай шинэ зэвсгийн сүр хүчийг бадруулах ёслолын хаалга болох нь дамжиггүй. Тиймээс алс дорнод сибирьт эзэн хааны замналыг дэлгэрүүлэх ажиллагааг монголоос эхлэх болно, банзай... хакко ити о... банзай...

Уэдааг үг хэлж дууссаны дараа жанжин штабын төлөөлөгч босож,

- Энд ярьсан зүйлийг та бүхнээс өөр хэн ч мэдэх ёсгүй учраас штабын дарга нарыг энд уриагүй юм. Ингэхээр саяын яриаг тэмдэглэж товчилсон цаасаа надад хураалгах ёстой гэхэд хүмүүс тэмдэглэл бүхий цаасаа төлөөлөгчид өглөө.

Тозияа энэ бүхний учрыг гадарлаж байсан болохоор юу ч тэмдэглээгүй цаасан дээр гарын үсэг зурахдаа «Энэ золиг армийн тагнуулын газраас төдийгүй кэмпэйтэйгаас даалгавартай яваа лүд байж таарах нь » гэж бодлоо.

Уэда яриа дууссаны дараа хүмүүсээ тараалаа. Гэтэл жанжин штабын төлөөлөгч,

- Комацубара...Тозияа сан та хоёр түр хүлээгээч гэлээ. Хүмүүсийг гарсны дараа төлөөлөгч,

- Тозияа сан, Халх голын байр зүйн тодруулалтанд танай Ёошийг илгээх талаар та ямаршуухан бодолтой байна вэ? гэж шалгаав.

- Ёоши Хасан нуур явж нэлээн туршлагажсан хүн болохоор байр зүйн тодруулалтанд явуулахад болох юм шүү.

- Хасан нуурт очиж байр зүйн зургийн тодруулалт хийсний хувьд өөр хэрэг. Харин Халх голын байр зүйн тодруулалтыг сайн хийнэ гэдэг бол газрын зураг дээр хийх тактикийн сургуулийн бэлтгэлийг сайн хангах төдийгүй жинхэнэ ажиллагааг дорвитой бэлтгэхэд чухал зүйл болно. Түүнээс гадна Халх голын газар нутгийг харуулсан байр зүйн товгор загвар хийх нь чухал юм гэхэд Комацубара тэдний ярианд оролцож,

- Энэ чинь хамгийн зөв санал шүү гэж дэмжлээ.

- Би юу ч гэсэн өөрийнхөө хүмүүстэй ярилцъя. Тэгээд юуны өмнө Халх голын хаагуур байр зүйн тодруулалт хийх вэ гэдгийг тогтоох хэрэгтэй гэж Тозияаг хэлэхэд Уэда,

- Урьдчилсан байдлаас үзвэл Хайлааст голын хоёр талаар судалгаа хийх нь тохиромжтой. Бид Буйр нуур, Булан дэрс, Халхын сүмээр туршилт хийгээд олигтой амжилт олоогүй. Тэгэхээр бидэнд шинэ газар сонгох хэрэгтэй. Тэр тусмаа армийн ажиллагаанд ашигтай газрыг сонгох нь чухал! Бидний үзэж байгаагаар бол цэрэг, зэвсгийн тээвэрт хамгийн тохиромжтой газар бол Номон Хаан, Бүрд Овооны чиглэл юм. Синьзингаас Ханширээ хүртэл төмөр замтай. Бас дардан зам ч байгаа. Тэгээд ч инженерийн барилга байгууламжийн материалыг бэлтгэчихсэн. Хайлараас цэрэг, техникийн хүчийг дардан замаар татаж болно гэж хэлэхэд тэрээр сүүлийн хоёр жил энэ асуудлыг гардан удирдаж байгаа нь илэрхий болой.

Уэда үнэхээр сүүлийн жилүүдэд Сэцэн хан аймгийн Дэ ван агчийн нутаг хошууг их сонирхжээ. Тэр тусмаа Дэ вангийн нутаг хошууг Барга хошуудаас заагласан Номон Хан, Бүрд-Овоо гэдэг хоёр овоог онц сонирхсон. Тиймээс байлдааны урьдчилсан төлөвлөгөөг «Номон Хан зикэнэ Номон Ханы ажиллагаа» гэж товлосон болой. Тэгээд зогссонгүй «Байгалийн чанадад» гэсэн ажиллагаатай үүнийг уялдуулахдаа 5 дугаар армийн дарга Доихаратай ярилцаж тохирсон зүйл цөөнгүй. Чингээд цэргийн яаманд өөрийнхөө саналыг уламжилсан болохоор жанжин штабын төлөөлөгч ирж ажил байдалтай нь танилцаж байгаа нь энэ.

- Эрхэм дээдсээ, миний бодож байгаагаар бол Халх гол Хайлаастын хавь газар армийн ажиллагаанд бүх талаараа тохирно гэж үзэж байна. Тиймээс ойрын үед би тодорхой санал хэлж болох юм гэж Тозияг хэлэхэд төлөөлөгч ярианд оролцож,

- Таны саналыг би дэмжиж байна. Гэхдээ долоо хоногийн дотор тодорхой санал боловсруулсан байхыг мартаж болохгүй гээд «Байгалийн чанадад» гэдэг ажиллагааг нарийвчлан японы жанжин

штабт боловсруулсан «Найм дахь ажиллагаа» гэдэг төлөвлөгөөний үндсэн санааг тусгасан хоёр хувилбар бэлдэхийг зөвлөв. Уэда, Тозияг Мугдэн рүү явах өдөр түүнийг гаргаж өгөхөөр галт тэрэгний буудал дээр ирэхдээ "Жанжин штаб манай үндсэн төлөвлөгөөнд түшиглэж найм дахь ажиллагаа" гэж товлосон төлөвлөгөөний сонгомол хувилбарыг бэлдэхээр шийдсэн. Үүний А хувилбар нь далайн эрэг хавиар улаан оросыг бут ниргэх бөгөөд Б хувилбарт манай Байгалийн чанадад гэдэг ажиллагааг үндэс болгосон байна гэжээ. Тозияа Мугдэнд ирэх замдаа генералынхаа энэ үгийг эргэцүүлэв. Тэрээр бодсон зүйлээ амандаа үглэж өөртөө сануулдаг болжээ.

...Халх голын байр зүйн тодруулалтыг богино хугацаанд хийлгэх хэрэгтэй шүү. Тэгэхгүй бол өвөл болчихно.

Тэгэхээр хээрийн тодруулалтын ажлыг одоо эхлүүлнэ гэдэг эргэлзээтэй. Хавар болгоно гэвэл Халх голын ажиллагааг хойтон жилдээ эхэлж амжихгүй. Яах вэ? Ажил төрлийн байдлаар бол армийн штабтай хамтарч ажиллах нь надад зайлшгүй хэрэгтэй! Гэтэл би гэдэг хүн Мугдэнд байдаг. Ингэж хол байж болохгүй. Синьзинд ирвэл ганцаараа ирж болохгүй. Тэгэхээр Юкийг яаж ятгах вэ? Ганцхан далимаа зөв олох нь чухал! Нөгөө талаар Ёошитой сайн тохирох хэрэгтэй. Мань эр барга хошуудаас өөртөө ашиглаж болохуйц хүн олоогүй бол яана?

Тозияа Синьзингаас гарсан тухайгаа Юкийд мэдэгдээгүй болохоор цэргийн төлөөлөгчийн газрынхан галт тэрэгний буудал дээр түүнийг угтан авлаа.

Акасай Токиогоос ирснээс хойш Юкийд хань болж тэднийд амьдарч өдөржингөө Юкитэй дэмийрэх юм уу эсвэл хотын дэлгүүр хоршоо хэсэж бичиж байгаа номонд нь туслалцаж, орчуулга хийнэ.

...Акасай хорвоод хорин долоон жил амьдрахдаа Юкийнд байгаа шиг эрх дураараа байж үзээгүй. Токиогийн газар хөдлөлтөөр эх эцэг нь байшиндаа даруулж сүйрснээс хойш нагац ах дээрээ очжээ. Тэгэхэд Акасай ердөө арваад настай байсан. Газар хөдлөлтийн үеэр Токиогоос нэлээн зайдуу байдаг нагац ахындаа байсан болохоор эсэн мэнд үлдсэн. Гэтэл Акасайгийн

амьдралын уй гашуу үүгээр дууссангүй. Нагац ах Каязавагийн цагдаагийн газар, кэмпэйтэйд ажилладаг байсныг тэр үед Акасай хэрхэн мэдэх билээ. Гэтэл нагац нь армийн нууц алдсан хэрэгт унаж шоронд орсноор Акасайгийн амьдрал ахуй харанхуй ангал руу орчихсон юм шиг өөрчлөгджээ...

Тозияа өрөөндөө орж ирээд гадуур хувцсаа тайлж Акасайд өгөөд гэрийн хувцсаа өмсөх зуур,

- Акасай, Юки юу хийж байна. Намайг эзгүй хойгуур ямар хүмүүстэй уулзсан бэ? гэж хардамтгай байдлаар асууж шалгаана.

- Онц гойд юм болоогүй. Иван Степанович ирээд гурав хоноод явсан. Юки Иванд тун сайн байдаг юм байна.

- Тэд чинь тав зургаатайгаасаа үерхсэн юм. Юки уг нь Иваныг үздэггүй байсан. Цаадах нь багадаа дандаа шоглодог. байсан болохоор түүнийгээ бодоод өширхдөг байж билээ. Акасай минь Юки одоо чамд их дасчихсан байна. Одоо хаашаа ч явсан чамайг дагуулдаг болжээ. Тиймээс чухал үүрэг гүйцэтгэх болно. Ялангуяа хэнтэй уулзаж, юу ярьж байгааг нь сайн тогтоож авах хэрэгтэй. Түүнчлэн банкныхантай юу ярихыг нь сайн ажиж бай!

- Юки банкнаас өөрөө мөнгө авахаа байгаад удаж байгаа шүү дээ.

- Юу? Яагаад энэ тухай чи надад хэлээгүй өдий хүрсэн юм бэ?

- Мүгдэнгийн банк руу намайг явуулж мөнгө авдаг болсон. Тэгээд надад итгэмжлэх хийж өгсөн гэхэд Тозияа сэтгэлдээ баярлахдаа,

- Энэ бол чиний гүйцэтгэх тусгай ажиллагааны анхны гараа. За үүнээс хойш миний ажилд туслах хэрэггүй. Гэр ахуйн ажилд илүү их идэвх гаргах нь чухал! гэхэд Акасай,

- Шиү жёо (эрхэм дээдэс хошууч генералаа)... гэтэл Тозияа,

- Үүнээс хойш намайг алдар цолоор дуудаж болохгүй. Зүгээр нэрээр минь дуудаж бай! гэлээ. Акасай уг нь генералдаа өөр зүйл хэлэх гэж боджээ. Тэрээр Ойдовыг Харбин дахь японы банктэй харилцах итгэмжилсэн төлөөлөгч болгосныг илтгэх гэж бодсон. Гэтэл генерал түүнд үг хэлэх зав олгосонгүй. Тозияа бичгийнхээ ширээ рүү эргэхдээ Акасайгийн үгийг анхаарсангүй. Акасай сэтгэлдээ "Генерал өөрийнхөө санаанд хүрэхийн тулд самурайн ёс горимоо хайхрахаа байжээ. Хэрвээ Токиод ингэж нэрээр нь дуудсан бол намайг арав хоногоос доошгүй шоронд хийнэ. Тэгээд самурайн ёсыг хүндэтгэсэнгүй гэж олон мянган иениэр торгох байсан. Самурайн дээд тушаалын хүнийг доод гарлын хүмүүс нэрээр нь дуудах ёсгүй" гэж бодлоо.

Тозияа тэр дороо усанд орж, халуун хоол зооглоод сакэ балгаж сэтгэлээ чангалаад Юкитэй уулзаж ярилцахаар шийдэв. Тозияа уг нь Ойдовт их найдлага тавьж байсан. Харин Акасайгийн ажил төрлийн байдалд гарсан амжилтыг мэдэнгүүт Ойдов шиг хэрэггүй хүн байхгүйг ойлголоо. Тозияа Юкигийн өрөө рүү гэлдрэхдээ "Ойдовыг Юкигээс холдуулах хэрэгтэй. Одоо Акасайд бүрэн найдаж болно. Харин Ойдовыг ямар замаар аятайхан

холдуулах вэ?

Энэ бол тийм ч амархан биш! Нөгөө талаар Симоотоог Юки рүү одоо хандуулж болохгүй. Харин Сафроновыг хүргэн болговол уу, ашигтай шүү" гэж бодтол түүний сэтгэлд "Тэр золиг чинь болох болохгүй юманд өртөөд армийнханд эвгүй сэтгэгдэл төрүүлээд байгаа. Симоото хүртэл сайн юм ярихаасаа өмнө муулах дуртай болжээ. Ер нь байдлыг харах хэрэгтэй юм шүү" гэж өөртөө анхааруулна. Тозияа ингэж бодсоор Юкигийн өрөөний хаалганы дэргэд ирээд хэсэгхэн зогсож сэтгэлээ тайвширсан хойно Юкигийн өрөөнд орлоо.

- Аав аа, та чинь яасан хурдан ирээ вэ? Надад хэл дуулгалгүй ирдэг сонин хүн шүү. За тэгээд Синьзингаар сонин юутай вэ? Дам сураг дуулбал армийн том зиндааны хүмүүс цугларсан бололтой. Симоотогийн ярьж байгаагаар бол сонин хэрэг явдал гарах бололтой гэж сониучхан сэтгэлээр асууна.

- Манай арми монголыг улаантны гараас чөлөөлж, Богд хаант засаг төрийг сэргээн тогтоогоод улмаар Нэгдсэн Их Монгол Улс эмхлэн байгуулах талаар ярилцлаа.

Жанжин штаб Алс дорнод, Байгаль, Сибирьт эзэн хааны сэргэн мандуулалтын гал голомтыг бадраахын тулд «Найм дахь ажиллагаа» гэдэг шинэ төлөвлөгөө боловсруулаад квантуны армийн боловсруулсан «Байгалийн чанадад» гэдэг ажиллагаатай уялдуулан үзэхээр шийдэж байна. Чамд дуулгахад квантуны арми монгол руу чиглүүлсэн үйл ажиллагаагаа «Номон Хан зикэна буюу Номон Ханы ажиллагаа» гэж товлосон. Тэгээд Халх голын сав дагуух газар орны байдлыг тодорхойлох байр зүйн зургийн тодруулалт хийхээр болж энэ ажилд Ёоши, Аяанаосу хоёрыг оролцуулахаар шийдэж байна гэж хэлэхдээ монголд илгээх хорлон сүйтгэх тагнуулчдыг Хайларт бэлтгэж байгаа талаар үг цухуйлгасангүй.

- Ёоши бол газрын зургийн мэргэжилтэн хүн учраас Халх голын газар нутгийн байдал төлвийг тодруулах ажилд тохирно. Харин Аяанаосу гэдэг чинь хувцас захиалгын газрын гуйлгачин биз дээ. Түүний байшин савыг хорон санаатай хүмүүс шатаачихсан гэл үү дээ. Сонингууд янз янзын төсөөлөл гаргаж шуугиан дэгдээгээд түүнийг нь Симоото хачирлаж яриад байсан даг. Ер нь тэр шалдан гуйлгачин Халх голын газар орныг тодруулахад оролцоно гэдэг чинь эсгий хийх газар нохой хэрэггүй гэдэг шиг шал дэмий хэрэг байх даа.

- Чи тэр Аяанаосуг мэдэхгүй байх чинь зөв. Тэр чинь тун сэргэлэн бэлтрэг байгаа юм. Тэр чинь худалдаачингаас дээрэмчин болж чадна. Дээрэмчингээс мэргэжлийн тагнуулч болчихно. Ийм авхаалжтай хүн бүдэрсэн ч хөл дээрээ босоод ирдэг юм. Аяанаосугийн энэ авьяасыг кэмпэйтийхан их шагшдаг юм. Тэгэхээр түүний авхаалж самбааг арми ашиглах хэрэгтэй. Өнөө өглөө гуйлгачин байсан хүн орой гэхэд армийн бага дэслэгч болж болно шүү. Аяанаосугийн нэг онцлог бол цаг үеийнхээ тулгамдсан асуудлыг шийдэхдээ гоц ухаан зарцуулж сэтгэдэг хүн. Тиймээс түүний авьяасыг монголын гүнд илгээх боловсон хүчин бэлтгэхэд ашиглах ёстой юм гээд хуурамчаар инээмсэглэв.

- За тэр гуйлгачингийн ажил яах вэ? Харин Уэда саны төлөвлөсөн «Номон Хан зикэнэ» гэдэг ажиллагааг жанжин штаб баталчихвал миний нар гарах нь тэр!

- Юки минь, чи тэр төлөвлөгөөг нүдээрээ үзсэн ч болно шүү. Уэда сан үүнийг зөвшөөрнө

байх.

- Аав аа, тэгвэл та бид хоёр талийгаачийн гэрээслэлийг биелүүлэх нь тэр дээ. Үнэхээр тэр төлөвлөгөөг батлах юм бол би шинээр байгуулах гэж байгаа төмөр замын «Кобуку коцу» нийгэмлэгт хувь нийлүүлж хоршоод Хайлар-Манжуурын төмөр замыг байгуулах асуудлыг хөөцөлдөнө. Энэ хэрэг бүтэмжтэй болбол би Ойдовыг өөрийн бие төлөөлөгч болгож «Кобуку коцу» нийгэмлэгт суулгах болно.

- Харин ээ, Ойдов бол итгэлтэй хүн. Гэхдээ хэдэн зүйлийг тодруулах нь зүйтэй байх. Наанадаж гэхэд Ойдов Бадрахтай... гэтэл

Юки,

- Аав аа, Богдын алтны учрыг гадарлах хүний хувьд Ойдов энэ ажилд биечлэн оролцох ёстой хүний нэг! Хаант төрийг сэргээн тогтоох талаар Богд хаантан ихээхэн зүтгэл гаргасныг одоо мэдэх монгол хүн бол Ойдов шүү дээ. Тэгэхээр би Богд хааны алтыг зүгээр үрээгүй гэдгийг тэр хожим гэрчлэх хүний нэг болох ёстой юм. Тийм биз дээ гэлээ.

- Энэ ч яах аргагүй чиний боддог бодлын нэг. Энэ бол түмэн зөв! Харин ажил хэрэг нэгэнт шийдэгдэж байгаа хойно бид Мугдэнд байгаад байх хэрэггүй. Синьзинд очиж армийн ажиллагаанд биечлэн оролцох хэрэгтэй. Наанадаж гэхэд армийн архиваас номондоо орох материал олж үзэх хэрэгтэй. Зарим үед байлдааны талбай дээр очих хэрэг ч гарч болно гэхэд Юки, Тозиягийн саналыг дуртай зөвшөөрчээ. Тозия сэтгэлдээ товлосон нарийн бодолдоо хүрэх зам мөрөө зассан болохоор баяртай байлаа. Тэгээд оройн хоолны өмнө Хайлартай ярилаа.

Тозия сан, баргын хошуудаас хорлон сүйтгэх ажиллагаанд тохирох залуусыг олж элсүүлсэн. Тэднийг эхлээд Аяанаосутай бэлтгэл хийлгэж байгаа. Одоо хүйтэрч магадгүй байна. Тиймээс дараагийн долоо хоногоос байр зүйн зургийн материал цуглуулах хэсгийг хээрийн дадлагад гаргана. Нутгийн хөгшчүүлийн ярьж байгаагаар бол энэ намар эрт сэрүү унасан тул өвөл нь хатуухан орно гэж байна. Бар жил ихээхэн зудархуу байдаг юм байхаа. Тэгэхээр энэ өвөлдөө хээрийн тодруулалтын ажлаар цуглуулсан материалын суурин боловсруулалтыг хэрхэн хийх талаар хичээл заасан дээр гэж үзэж байна.

- Ёоши, чиний ажил дэндүү удаашралтай байна. Ажлаа түргэтгэхийг бод! Бид хаврыг хүлээхгүй, өвлийн улиралд байр зүйн тодруулалт хийнэ гэдэг бодолтой байх хэрэгтэй.

- Тозия сан, үнэхээр зуд болох юм бол яана? Хүйтэнд хээрийн ажил хийнэ гэдэг чинь бүтэмж муутай. Хасан нуурын газар нутгийн байр зүйн тодруулалтыг зун байсан учраас өглөөгүүр хийдэг байсан юм. Өвөл үүрээр гарч хийж болохгүй нь мэдээж шүү дээ.

- Ёоши, Халх голын газар нутгийн байр зүйн тодруулалтыг үүрээр хийхгүй. Харин тэнд өвөлжих явцад хийнэ гэдгийг мэдэж ав.

- Монголын хилийн цэргүүд бидэнд тийм боломж өгөхгүй шүү дээ!

Ямар ч гэсэн чи өөрийнхөө ажлын бэлтгэлийг ханга. Монголын хилийн тухайд гэвэл бидэнд яг таг боловсруулсан, төлөвлөгөө бий.

Тозияа, Ёоштой утсаар ярьсны дараа түүний үгийг эргэцүүлээд янжуураа асаах зуур "Зуд гэнэ үү" Шалтаг заахдаа аргаа олж чаддаг байна шүү.

Зуд... зуд, хэн ингэж донгосоо болоо? Үнэхээр зуд болбол бидэнд бүр ашигтай. Мичин жилийн (1932) зуднаар Баргынхан Шилийн голын нутагт орж өвөлжсөн. Зарим нь хойшоо оросын хил рүү дөхөж нутагласан шүү дээ" гэж бодоод амандаа «Зуд...зуд» гэж үглэнэ. Тозияа зудын талаар нэлээн нарийвчлан бодоод өөрийнхөө саналыг армийн удирдлагад илтгэхийн тул Синьзин руу залгуулав.

- Гакка Уэда сан, армийн тагнуулын газраар дамжуулж нэг зүйлийг мэдэх шаардлагатай байна. Та удирдамж өгөхгүй юү.

- Халх голын ажиллагаатай шууд холбоотой юм бол надаас удирдамж авалгүй шууд үүрэг өгч бай! Энэ тухай тусгай тушаал гаргаад анги салбарт явуулна. Харин үүрэг өгсөн бүхэндээ хяналт тавьж байх нь чухал гэдгийг мартаж болохгүй. Чи одоо юу сонирхоод байгаа юм.

- Эрхэм дээдэс ээ, улаан орос монголын хилийн хэлэлцээг сонирхсон юм. Ер нь хилийн дагуу нутагладаг хүмүүсийн талаар юу гэж тохиролцсон байгаа бол! Түүнийг мэдмээр байна.

- Тозияа сан, би одоо үүрэг өгчихье. Харин үүнээс хойш өөрөө үүрэг өгөөд үр дүнг нь надад илтгэж бай.

Тозияа албан үүргийнхээ дагуу Уэдатай чингэж ярилцсаны дараа армийн тагнуулын газрынхантай ярилаа.

- Орос монголын хилийн талаар байгуулсан гэрээнд нутгийн ардуудад ямар ямар тусламж, үзүүлэхээр тохиролцсоныг нөгөөдрийн дотор мэдээд илтгээрэй!

Нөгөө талаар цаг агаарын урьдчилсан мэдээг армийн шугамаар гаргаж үзүүлээрэй. Энэ талаар Токиотой давхар ярих хэрэгтэй гэж тушаахад тагнуулын хэлтсийн дарга даалгаврыг гүйцэтгээд илтгэнэ гэж амлалаа.Тэгээд амласан хугацаандаа Тозияа руу утасдав.

- Тозияа сан, орос монголын хооронд байгуулсан гэрээгээр бол хилийн дагуу нутагладаг ардууд эмчлүүлэх, бие биендээ айлчлах, худалдаа хийх, цаг зуурын байгалийн бэрхшээлээс шалтгаалж бие биенийхээ нутагт орохыг зөвшөөрсөн байна. Гэхдээ хэдэн онд ямар гэрээгээр үүнийг тохирсон нь мэдэгдээгүй байна. Тиймээс гурав хоногийн дараа баттай хариу хэлье. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр бол баргын нутагт энэ жил цас их орох төдийгүй хүйтний эрч эрс нэмэгдэх төлөвтэй байгааг тогтоосон байна. Тозияа тагнуулчдаас авсан баримтандаа хангалуухан байсан болохоор,

- Энэ баримт чинь болно. Дахин тодруулах хэрэггүй гээд тэр дороо Ёошийг яаралтай дуудуулах талаар Харбинтай ярилаа.

Ёоши, Хайлараас гараад хоёр хоногийн дараа онгоцоор Мугдэнд ирэв. Тэрээр Тозияатай уулзан уулзатлаа «Юу асууж шалгаах бол. Хээрийн судалгааг өвөл хийж дуусга гэвэл яана» гэж бодоод зүрхшээв. Тозияа, Ёошитой уулзаад ажил төрлийг нь асуусны дараа,

- Одоо очоод хээрийн ажилд хүмүүсээ бэлтгэ! Тэгэхдээ 12 сард хээрийн ажилд гарна гэдгийг хүмүүстээ ойлгуулсан байх хэрэгтэй! гэхэд Ёоши дотроо «Энэ хөгшин чинь юу солиороод байна вэ?» гэж бодоод гайхахдаа шалтаг заах ухаанаа олсонгүй. Гэтэл Тозияа янжуурынхаа утааг уугиулсаар,

- Хээрийн ажлыг хийхдээ нутгийн ардуудад түшиглэх болно. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр бол зуд болох нь илэрхий. Чиний ярьсан шиг толгой байтугай, хошуугаа ил гаргаж болохгүй тийм хүйтэн болох нь эргэлзээгүй. Бид нутгийн барга айлуудыг Хайларт голын хоёр талаар оруулаад Халх голын гүнд нутаглуулах болно. Та нар гадаа биш, харин барга айлуудын дулаан гэрийн тотгоор шагайгаад ажлаа амжуулна гэсэн үг гэхэд Ёоши сэтгэлдээ "Энэ ч болдог арга байна. Уг нь манай хөгшин ийм аргыг олохдоо мэргэжсэн хүн гэдэг оргүй хоосон зүйл биш байжээ. Жанжин штабт Тозияаг Доихарагийн ажиллагааг далдалсан, төөрөгдүүлсэн арга заль хэрэглэсэн явдлыг дарга нар өндрөөр үнэлдэг байсан" гэж бодоод сэтгэл хангалуун байлаа.

- Монголд орж нутаглах барга айлуудад манай хүмүүсийг дайж ажиллуулах юм бол хээрийн цагдаа цэргийн хувцсаар хувцаслах хэрэгтэй. Бид чинь зарим үед монголын хилийнхэнтэй шөргөөлцөх хэрэг гарна. Тиймээс зэвсэгтэй байх хэрэгтэй. Цагдаа цэргийн талаар гэвэл барга айлуудын аюулгүй байдлыг хамгаалсан гэдэг нэрээр хэрэг явдлын мөн чанарыг цагаатгаж болно шүү гэхэд Тозияа,

- Энэ талаар бид нарийн бодож боловсруулна. Ганцхан та нарыг ч барга айлуудтай явуулах юм биш бас энгийн малчин гэдэг нэрээр Аяанаосугийн шавь нарыг хамт явуулна. Тэд энгийн хувцастай байх нь дээр. Хилийнхэнтэй маргавал барга иргэд л маргаа биз. Тэгэхдээ хилийнхнийг ашиглаж, маргаан дэгдээж чаддаг авхаалжтай хүмүүсийг шилж авах нь дээр биз. Аяанаосугийнхан нударган зодоонд сайн хүмүүс. Гэхдээ бүр сайн бэлдэх хэрэгтэй гэлээ. Тозияа ийнхүү Ёошигийн ажилд удирдамж өгөөд Халх голын сав дагуух газар орны байр зүйн тодруулалтыг богино хугацаанд хийж дуусгахыг даалгахдаа Шилийн овооны худгаас Хулд уул хүртэлх газрыг сонгож авлаа. Тозияа, Ёошийг буцахаас өмнө квантуны армийн удирдлагатай ярьж, барга айлуудыг Халх, Хайлаастын чиглэлд нүүлгэх талаар тохиролцжээ.

- Тозияа сан, таны наад санал тун сонирхолтой үр дүнд хүргэх ажил хэрэгч зүйл байна. Бид Халх, Хайлааст гол руу нүүлгэх барга айлуудыг хуучин, шинэ барга хошуудаас бэлтгэх үүрэг өгнө. Тиймээс та, зохион байгуулалтын талаар нарийн бодож төлөвлөгөөгөө бэлдэх хэрэгтэй.

- Уэда сан, бас нэг зүйлийн талаар тусламж шаардагдах болоод байна. Би Синьзинд суурьшвал ажил төрөл ойр дөхөм юм. Нөгөө талаар Юки, Ханширээгийн төмөр замыг сонирхоод байна. Түүнийг өргөтгөж Жанжин сүм, Манжуур, Буйр нуур хүртэл тавих төмөр замд өөрийнхөө хөрөнгийг хувь нийлүүлж хорших санаатай байна. Тиймээс байр сууцны талаар ярилцаж нарийн зохион байгуулах хэрэгтэй байна гэхэд Уэда, Тозияагийн саналыг зөвшөөрөөд,

- Одоо Юкигийн талаар нэлээн нарийн юм бодох хэрэгтэй. Шинэ он гараад «Кобуко коцу буюу төмөр замын барилга байгууламж, ашиглалтыг хариуцах» нийгэмлэг байгуулах явдлыг сайд нарын танхимаар хэлэлцэх болсон. Одоо зарчмын хувьд тохиролцоод үндсэн хөрөнгийн хагасыг сайд нарын танхим гаргах бөгөөд үлдсэн хагасыг нь хувийн пүүсүүдийн хөрөнгө хоршуулах замаар санхүүжүүлэхээр болсон. Тэгэхээр үүнийг Юкийд зөв ойлгуулж тэр их алтыг нь ашиглах талаар бодох хэрэгтэй болоод байна гэлээ. Гакка Уэда сан, Юкигийн алтыг ашиглах нэг боломж бол та бүхний боловсруулсан «Номон Хан зикэна Номон ханы ажиллагаа» гэдэг төлөвлөгөөний талаар Юкийд ойлголт өгч төлөвлөгөөний бүдүүвч тоймыг танилцуулбал Юки, Хайлар Ганжуур болон Ханширээгийн төмөр замыг үргэлжлүүлэн өргөтгөх ажилд хөрөнгө хорших асуудлаа дор нь шийднэ гэхэд Уэда,

- Та үүргээ биелүүлэх сайн арга боловсруулсан болохоор би ч гэсэн таны ажиллагаанд туслах ёстой үүргээ биелүүлэх болно гэлээ.

Тозияа квантуны армийн даргын үгийг сонсоод баярлажээ. Тэрээр Тозияаг үүргээ биелүүлбэл дэслэгч генерал (чиу жёо) цол өгүүлэх асуудлыг дэмжих нь ярианаас нь илт байлаа. Тозияа дэслэгч генерал болбол армийн тагнуулын байгууллагыг толгойлох төдийгүй Сибирь, Манжуур, Монголыг нэгтгэж «Сибирь Мансю Мооко Го» гэдэг улсыг байгуулахаар төлөвлөж байгаа японы армийн жанжин штабын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Чухам энэ эгзэг түүнийг эзэн хааны ивээлд багтаах зам мөрийг нээж өгөх байлаа.

...Тозияа 30 настайдаа эзэн хаан Мэйжи исин Иосихитотой биечлэн уулзаж Нармай монгол улсыг эмхлэн байгуулах явдалд хүчин зүтгэх үүрэг авсан. Тэр өдөр хаан хүү Хирохито эцгийнхээ дэргэд сууж, эзэн хаантай ярилцаж байсан Тозияаг ажиглан инээмсэглэн талархаж байсан билээ. Тэгэхэд хаан хүү 16 настай байсан бололтой. Тозияа энэ бүхнээ эзэн хаан Хирохитоод өөрийн биеэр танилцуулж айлдвал болох нь тэр ээ. Тэр тусмаа Юкигээр төмөр зам тавиулж бүх хөрөнгийг нь «Кобуко коцу» нийгэмлэгт хоршиж нийлүүлсний дараа Юкийг устгаад түүний хөрөнгийг өвлөн залгамжилсан үед эзэн хаанд бараалхаж сэтгэлийн эчнээнд байгаа бүхнээ толилуулсан үед л тэнгэрээс од шүүрэх гайхамшиг болно гэж бодох ажээ.

Хоёр. Чонын бодол нохой арга

Буйр нуур. Монгол Баргын нутгийг зааглан хиллэсэн энэ нуурын баруун талаас Татуурга, Халх гол цутгана.

Баруун эргээр нь үргэлжилсэн элсэн толгод, нуур тойром элбэгтэй. Тэрхүү хорь гаруй нуураас хамгийн том нь Нарийн, Тахир, Хөх, Нүхт, Баян нуурууд билээ.

Эрт балар үед Халх голын саваар элбэг байсан булга, халиу энэ нууранд үр төлөө өсгөдөг байсныг тухайн үеийн хүмүүс ажиглаж чадсанаар булганы зулзагат нуур буюу Буйр нуур гэдэг болсон ажээ. Монголчууд булганы зулзагыг буйр гэдэг юм. Цагийн эрхээр Халх голын булга, халиу ховордож нуурын нэрийн учир холбогдол мартагдсаар хожим нуурын хэлбэрээр нэрлэсэн нэр болгон ярилцах явдал мэр сэр байх тул Бөөр нуур гэдэг удаатай.

Үнэндээ Буйр нуурын хэлбэр нь үхрийн бөөр шиг хэлбэртэйгээс гадна түүний баруун эргээр олон жижиг нуур бөөр шиг шавсныг ажигласан хожуу үеийн хүмүүс үхрийн бөөртэй дүйцүүлж тайлбарлах болсон болой. Буйр нуурын цаад эрэг нэгэн бээр хэртэй газраараа Баргын нутагт ордог бөгөөд дайчин улсын (манж) үеэс нутгийн баргууд энэ нуурын өгөөжөөр амьдрах болсон учраас нуураа тахих нэгэн сүм байгуулсныг Асар сүм гэдэг болой. Асар сүмээс баруун тийш найман бээрийн хэртэй газар нэгэн суурин бий.

Түүнийг Цагаан овооны суурин гэнэ. Японы квантуны арми, 1932 оноос Цагаан овооны суурин, Асар сүмийг сонирхох болсон нь нарийн учиртай. Тэнд монголын гүнд илгээх тагнуул, хорлон сүйтгэгч нарыг орогнуулахдаа чонын арга, нохойн замаар бэлтгэдэг байв. Манж-японы цэргийн удирдлага 1936 оны 12 сарын 12-ны өглөөний 8 цаг хагаст Цагаан овооны суурингаас 500 гаруй цэргийг Буйр нуурын хойхно байдаг Булан дэрс рүү илгээжээ. Гэвч тэд нар удаж төдөлгүй бут цохиулаад буцаж билээ.

1938 он. Арван зургадугаар жарны 15 дугаар он, шороон шар бар жилийн намрын сүүл сараас хойш хүйтний эрч нэмэгдэж, хэдэн өдөр орсон цас цавцайгаад хээр талын цас өглөөний наранд гялтганан, хэн хүний нүдийг гялбуулаад харах нөхцөлгүй ажээ. Өвлийн эхэн сарын шувтаргаар Цагаан овооны суурингаас төдий холгүй байдаг хэдэн шавар байшингууд шөнө дүл өнгөртөл гэрэлтэй байв. Энэ бол монголд илгээх хорлон сүйтгэгчдийг шалгах туршлагын газар билээ.

Босоо хүн адарт нь тулам намхан, уужим өрөөний хоёр хананд төмөр ор тулган тавьж, голын ширээн дээр үйлдвэрлэлийн аргаар хатаасан далайн байцааг дэвтээсэн зууш, гахайн утмал мах, сакэ тэргүүтнийг өрсөн ажээ. Ханын пийшингийн ам сахиж гал өрдөж суусан нэгэн япон цэрэг галын дэргэд ном унших агаад харин нөгөө хоёр нь элдвийг ярих зуур архидана. Тэр хоёрын нэг нь Аяанаосу агаад нөгөө нь саяхан Мүгдэнгээс ирсэн Ёоши хоёр байлаа. Пийшингийн ойролцоо сууж галын гэрэлд Синто шашны цэрэг эрийн хийморийн сан шившлэг уншин цээжилж буй цэрэг, тэр хоёрын яриаг анхаарсан шинжгүй. Тэр шившлэг, тарины дотор хүн алахыг буян болгож, самурайн ёсны дагуу эзэн хааны төлөө амиа өргөх хэргийг цэрэг эрийн эр зоригийн хатуужил болгон тунхагласан ажээ.

Самурай нар эзэн хааны төлөө бусад орны ард иргэдийг хайр найргүй хядаж, тэдний

эсэргүүцлийн өөдөөс аймшиггүй тэмцэж, алдар гавьяа байгуулах ёстой агаад ямар ч нөхцөлд бууж өгөх ёсгүй болой. Тиймээс хүч дийлдсэн үедээ самурай нар өөрсдийнхөө дайсанд эрсдээгүй гагцхүү тэдэнд тусалсан бурхны далдын хүчинд дийлэгдэн, хүч мөхөсдсөн гэж өөрийгөө цагаатгаж байх хуультай болой.

Чухам ийм үед самурай нар үхлээс айлгүй өөртөө сеппуку үйлдэх ажээ. Ийм үхлийг бахархан биширч, эзэн хааны төрд харшилсан тэрсүү номтныг хайр найргүй алах ёстой. Хичнээн хүн албал тэр нь тэр чигээрээ буян болно. Энэ буяныг Хатимана хэмээх дайны бурхан дэнслэн хэмжиж байдаг аж. Чингээд л самурки гэдэг үг эзэн хааныг амь биеэрээ хамгаалагч гэсэн уриалга болсон хэрэг. Дайн хийхгүй бол япон гүрэн тамын зовлонгоос үл сална. Яматогийн үр сад аз жаргалтай, арвин баян амьдрахын тулд дайн хийж, муу заяатны гарт орсон баялгийг булаан эзэлж байх ёстой! Тиймээс өглөө орой аль ч цаг мөчид самурай нар энэ сан, шившлэгийг уншиж байдаг. Харин ахлах дарга нар бол тэр шившлэгийг толгойдоо шингээчихсэн учраас унших ёсгүй болой.

Ёоши, Аяанаосу хоёр ажил төрлөө ярьсаар сүүлдээ амин хувийн ярианд орж, тэгснээ эр цэргийн баатарлаг үйлс, эмс охидын гоо үзэмжийг бахархан яриад эцэстээ дайны тухай ярина.

- Аяанаосу минь өнөөдөр сайн наргих хэрэгтэй. Удахгүй бидний ажил эхэлнэ. Тэгэхээр одоо л уух хэрэгтэй. Хэд хоногийн дараа Халхын голын эрэг хавьд оччихоод барга айлуудаар бууз хийлгээд идэж байх болно. Тэгэхдээ сайн идэх хэрэгтэй. Харин уухаа татна. Муусайн баргууд унтаж байхад яаж ч магадгүй. Аа, тийм чи надад монгол дээл хувцас яаж өмсөх тухай зааж өгөөрэй!

Бид монголын хил рүү орохдоо монгол дээл хувцастай явах болно. Орсон хойноо бол цагдаа цэргийн хувцас өмсөнө. Тэгэхдээ хээрийн цагдаа цэргийнх шүү. Бид чинь барга айлуудыг хамгаалж байгаа дүрээр явах нь манай ажилд хэрэгтэй. Харин чамд цагдаа цэргийн дарга хувцас аль зэрэг зохих бол? Ха ха гэж хөхөрнө.

- Ёоши сан, тэгээд бид чинь барга айлуудыг Халх гол руу нүүлгэх болж байна уу?

- Бид тэднийг монгол руу нүүлгэх гэж зовохгүй. Хайларын цэргийн тойргоос мянга шахам айлуудыг нүүлгэн авчирч яваа. Бид бол тэднийг Номон Хан, Бүрд-Овооны ойролцоох Авдар сууринд хүлээж байх ёстой. Харин чи өөрийнхөө шавь нараас хэдэн сайн залуу шилж аваарай.

Гэхдээ бас доожоо муутай ганц хоёр хүн хэрэгтэй шүү. Монголын хилийн цэргүүд биднийг хөөвөл эхлээд махан бодиор үзнэ. Тийм үед доожоо муутай цэргүүдийг тавьж нүдүүлчихээд түүгээр шалтаг болгож байгаад үзэж тарна даа гээд намбу гар буугаа заалаа.

Ёоши цагаан архи сакэ хоёр хольж уусан болохоор яггүй согтжээ. Тэрээр ходоодноосоо төөнөсөн архины ааг, өрөөнөөс шарсан пийшингийн халуунд шатах шахаж ам мэдэн бурна.

- Чиний нэг үүрэг бол монголын цэргийг барьж байцаах асуудал. Тэгэхдээ бид тэдний эгзгийг олж барина. Чи өөрийнхөө доожоо муутай цэргүүдтэй монголын хилийн цэрэгтэй

маргах арга зааж өг! Тэгээд хилийн цэргүүд гараа хөдөлгөв үү үгүй юу унаад босохгүй байх талаар заавар өг! Тэгэхээр нь бид манай барга нөхдийн эрх чөлөөнд бүдүүлгээр халдаж амь насыг нь бусниулахад хүрсэн гэдэг маргаан үүсгээд танай шилдэг эрчүүдийг оролцуулж монгол цэргүүдтэй нүдэлдүүлээд заримыг барьж барьцаална. Тэгэхдээ хилийн цэргийн даргыг барих нь чухал!

- Ёоши, бид өвлийн хүйтэнд газар орны байр зүйн тодруулалт хийж чадах уу? Тэгээд бас хүмүүсээ бэлдэж амжих юм уу?

- Тэр яахав. Би хүмүүсээ сонгоод хоёр долоо хоногт сургачихна. Тэгээд барга айлуудыг дамжаад хийчихнэ. Ер нь айлаар газрын байрлалыг багцаалах арга боловсруулаад авчихсан. Тиймээс хилийн дагуу буулгах айлуудыг хамаа намбаагүй буулгахгүй. Наанадаж гэхэд гол гол өндөрлөгүүдийг бараадуулж буулгана. Мянга гаруй өрхийг Хайлаастын хоёр талд буулгачихвал уу? Их юм бүтээнэ дээ.

Аяанаосу шөнө дүл өнгөртөл Ёошитой ярилцаад хажуулав. Гэтэл түүний нойр хулжжээ. Харин Ёоши архиндаа нам цохиулаад боссонгүй. Аяанаосу шөнөжингөө хөлбөрч хэвтэхэд өнөө цэрэг нүд аних завгүй гал түлж өрдөнө.

Номон Хан, Бүрд-Овооноос Халх, Хайлааст гол хүртэлх нутгийн байр зүйн тодруулалт хийхийн тулд барга айлуудыг ашиглахаар төлөвлөсөн нь гарцаагүй. Тэгэхээр энэ ажлыг саатуулах хэрэгтэй. Энэ тухай Рожусайд мэдэгдэх нь чухал! Яах вэ? Рожусай намайг холбоо барихыг хориглосон. Намайг армийнханд нэр хүнд олж, удирдах хүмүүстэй ойр холбоотой байхыг даалгасан шүү дээ гэж бодохдоо холбоочинтойгоо уулзсанаа саналаа.

...Аяанаосу, Симотогийн занганд орчихоод байсан тэр үед Харбины цаг сонинд Цицикарийн холбооны салбараас захидалд наадаг хуучны зурагт хуудас (марк) худалдаж авах тухай зарласныг олж уншив. Тэгээд Аяанаосу холбоочинтойгоо Харбинд уулзах газар, өдрөө тэр сониноос олж үзээд сэтгэлдээ баярласан. Тэрээр өөрийнхөө араас мөрдөж болох Симотогийн ая занг мэдэхээр албан газар дээр нь очтол тэрээр Мугдэн рүү явчихсан байв. Үүнийг мэдсэн Аяанаосу, Харбины цагаачдын товчооны харьяанд байдаг нэг багахан шиг угаалгын газрын эзэнтэй очиж уулзав. Тэгээд хэдэн иень зээлэв. Үнэндээ Аяанаосу юмгүйтээд очиж зээлсэн хэрэг биш. Тэрээр холбоочинтойгоо Модрен буудлын зоогийн газар уулзах учраас тэнд очихдоо урьдын адил баян чинээлэг байх ёстой байлаа. Нэг үгээр хэлэхэд Аяанаосу захиалгынхаа газрыг шатаалгасан ч хоосорсон шинжгүй байх ёстой аж. Харин Симотогийн нүд чих Аяанаосугийн араас шиншилсэн байвал мөнгө бэл залгаснаа тайлбарлах хэрэгтэй бөгөөд түүний ярьсны дагуу шалгана гэдэг нь илэрхий байв.

Аяанаосу зоогийн газар нэлээн сууж байдлыг ажвал Симотогийн нүд чих түүнийг ажих гэж хөөцөлдсөнгүй. Зоогийн газар, шавь нараас нь хүн үзэгдэхгүй байлаа. Аяанаосу зоогийн газар 23 цаг хүртэл суудаг заншлаараа сууж байгаад овоохой руугаа сажлахаар гартал хэсэг хүмүүс түүний дараагаар ширээнээсээ босов.

Аяанаосу гуйвахгүйг хичээсэн янзтай алхсаар гудамжинд гарч ирээд зоогийн газрын үүдэнд зогсож байгаа тэрэгчний дэргэд ирээд,

- Аа чи чинь өнөө Ли овогт шив дээ. Хөгшнийгөө овоохойд минь хүргээд өг. Би хөлсийг нь төлнө шүү. Хамаг юмаа шатаалгасан ч гэсэн модоо барьчихаагүй байна гэж хашгиран хэлээд тэрэгний суудал өөд авирахдаа согтсон хүн шиг халти мөлт гишгэнэ. Энэ бол хүнд сэжиг төрүүлэхгүйгээр жүжиглэж байгаа «алиалалт» ажээ. Аяанаосуг тэргэнд суух тэрхэн зуур зоогийн газраас гарч ирсэн өнөө хэсэг хүмүүсийн сүүлд байсан нэг хүн,

- Хүүш тэрэгчээн, жаахан хүлээж байгаач. Зам дөхөөдөхье гээд Аяанаосугийн дэргэд ирж суухад Аяанаосу согтуу нүдээр түүнийг ширтээд,

- Би хол явна шүү. Та хаачих гэж байна? гэлээ.

- Би холдохгүй, зэргэлдээх гудамж орно. Хөл минь оройноос хойш янгинаад байна. Жаахан архи уучихсан чинь хууч хөдөлж байгаа бололтой гэх нь эгэл жирийн нэг тохиолдлын чанартай болой. Тэрэгчинг хөдлөөд нэг гудамж тойроход өнөө хүн сая,

- Таны ажилд Рожусай талархаж байна гэлээ.

- Рожуганука төлөвлөсөн ёсоор явж байна гэж барга аялгуугаар хэлэхэд өнөө хүн сорих дохиогоор,

- За ямаршуухан аж төрж байна даа? гэлээ. Аяанаосу холбоочинтойгоо чингэж уулзаад баргаар ажил төрлөө ярилцав.

- Рожусай таны тухай тодорхой мэдэж байгаа. Таныг Хайларт барга монголын яамны харьяанд ажиллуулахаар Тозияа шийдсэн байна. Тусгай удирдамж өгтөл холбоо барихыг хориглосон. Тиймээс жирийн байдлаар амьдрах нь таны нэр хүндийг квантуны арми, дээд зиндааны дарга нар зөв ойлгох болно гэж Рожусай үзэж байгаа гээд Аяанаосугийн өвөр дээр гурван боодол иень тавиад нэг харанхуй гудамжны булан тойрох тэрхэн зуур тэрэгний явалтан дунд үсэрч буусан тэр холбоочин бол Ойдов байлаа.

Аяанаосу эрт өнгөрснийг чингэж бодсоор үүр цайлгахдаа өөрийнхөө өмнө ямаршуухан хариуцлага тулгарч байгааг ойлгох тусам ажлаа хэрхэн зохицуулахаа бодно.

...Рожусай ...Рожусай Квантуны армийн одоогийн энэ ажиллагааны талаар мэдэж байгаа болов уу? Мэдээгүй байх. Мэдэх нөхцөл ховор! Энэ ажиллагааг маш нарийн зохион байгуулсан болохоор тухайн үедээ надад ажиглагдаагүй өдий хүрсэн. Ингэхээр Рожусай үүнийг мэдэж амжаагүй. Тэгэхээр одоо өөрөө шийдэх хэрэг! Ямар ч гэсэн байр зүйн зурагт шаардагдах судалгааг хийлгэхгүй байх нь чухал! Яаж үүнийг саатуулах вэ?...

Аяанаосу чингэж өөрөөсөө асуух авч шийдэх арга замаа ухаарч ядна. Ямар ч гэсэн Ёошигийн болон хээрийн цагдаа хувцастай туслахуудын алдаа, эндэгдлийг ашиглаж, түүнийгээ сэжиггүй зохион байгуулах нь чухал гэдгийг ойлгож байлаа. Тагнуулч хүн өөрийнхөө ажиллагааг зохион байгуулахдаа дайсныхаа алдаа

эндэгдэл дээр тулгуурлаж, зөв ажиллах гарч болох бүх сэжгийг дайсныхаа гараар үйлдэгдсэн баримт болгож нотлох байдалд хүргэх нь өөр рүүгээ чиглэсэн ямар ч сэжгийг арилгаж чаддаг

зүй тогтолтой билээ. Тиймээс барга айлуудаар тарж байрлах ёстой Ёошигийн шавь нар тэдний ажиллагаанд туслалцаа үзүүлэхээс түвэгшээсэн барга хүмүүсийн дэмжлэгтэйгээр ажиллана гэж бодлоо. Аяанаосу чингэж өөрийнхөө сэтгэхүйн төсөөллийг бодит боломжтой харьцуулснаар зөв алхмаа хэрхэн эхлэх тухай бодлоо.

Монголчуудын эрхэмлэж ирсэн цаг улирлын тооллын уламжлалаар бол сар бүрийг 30 хоногоор тоолдог. Тэгээд 360 хоногоо ес есөөр хувааж дөчин ес болгодог заншилтай болой. Үүнээс шалтгаалж хүйтний улирлыг есөн ес буюу 81 хоногт багтаадаг юм. Намрын сүүл сарын шувтарга, зул сарын 25-нд нялх гурван ес эхэлнэ. Тэгээд дараагийн гурван есөд хүйтний эрч тачигнадаг учраас идэр гурван ес гэдэг.

Бар жилийн нялх гурван есийн төгсгөлөөр урьд үзэгдээгүй их цас унаж, хүйтний эрч нэмэгдээд намрын үнэгэн малгай нэвт сийгсэн жавар зулай хага ташин сэнгэнэнэ. Барга хошуудаас монголын хилийг заагласан зурвасын дагуу нутаглуулахаар нүүлгэсэн мянга гаруй айл Авдар нуурын суурин хавьд бөөгнөрчээ. Авдрын суурингийн айлуудаас өөр юу ч байдаггүй энэ газар хэд хоногийн өмнө ойр хавиас ирсэн барга айлуудаар дүүрч дагтаршиж зузаарсан цас ухаж хөлдүү газар дээр барьсан гэрийн эзэд, япон эздийн аяыг даган бор хоног өнгөрөөнө. Барга айлууд яахаа мэдэхгүй уймарч байсан энэхэн үед квантуны армийн штабаас ирсэн хэдэн дарга Авдар сууринд тухлав. Тэгээд тавин өрхийн тэргүүн нарыг цуглуулж тусгай заавар өглөө.

Хаврын гурингатсан тэмээ шиг хөх царайтай, эв хавгүй гооргор биетэй шүү са цолтой нэгэн дарга ярвагар бардам, дээрэнгүй байдлаар яриа хийхдээ,

- Энэ жил барга нутаг даяар цас их орж зарим газар хүйтний эрч зуугийн талаас өнгөрч байна. Тиймээс манай арми зудад тав тух алдсан та бүхнийг монгол нутагт оруулж нутаглуулах явдалд туслах үүрэг хүлээж авлаа. Ер нь Номон хан, Бүрд-Овоо, Хайлааст, Халхын гол бол эртнээс нааш баргын нутаг байсан. Иймээс манай арми барга ард түмэнд өвөг дээдэс, элэнц хуланцын нь нутгийг монголоос авч өгөх, ахуй амьдралыг тохижуулах шаардлагатай бүх арга хэмжээг авах болно.

- Та нар манай хуваарийн дагуу Хайлааст голын хоёр талаар нутаглах болно гэж нигүүлсэнгүй байдалтай ярив.

Симото ийнхүү үгээ хэлж дуустал хэд хоногийн өмнө ирж барга айлуудын талаар судалгаа хийсэн Ёоши айлуудын хуваарийг уншиж өглөө. Тэгээд үгийнхээ төгсгөлд,

- Хайлаастын баруун талаар нутаглах айлуудыг манай бага дэслэгч Аяанаосу удирдах тул тэнд нутаглах 500 айл өрх Аяанаосугийн зааварласан бүхнийг дагах болно. Одоо та бүхэн гэр гэртээ хариад нүүхэд бэлтгэх хэрэгтэй гэлээ.

Тавин өрхийн тэргүүлэгч нар дуугүй сууцгаан бие биен рүүгээ хулгай нүдээр ширтэх нь «Бидний хэн нь босож үг хэлэх вэ?» гэж асуух шигээ. Өрхийн тэргүүлэгч нарыг дуугүй суухыг ажигласан Ёоши, уурандаа шатаж дотроо «Эд нар чинь хэдэрлэх нь ээ. Тэгвэл сайнаа үзэхгүй шүү. Ёстой бууны ам нуруунд нь тулгаж байгаад нүүлгэнэ» гэж бодно. Гэтэл тавин гэрийн тэргүүлэгч нар дуугүй суусаар байлаа. Чингэж амандаа ус балгачихсан юм шиг дуугүй байсан

тэргүүлэгчдийн дотроос нэгэн хижээл хүн босож,

- Бид ихэс дээдсийн үгийг чих тавин сонслоо. Гэхдээ бидэнд айлтгах айлтгал байна. Түүнийг та бүхэн болгоох биз ээ гэж хэлтэл Ёоши,

- Бид хэлдгээ хэлсэн. Түүнээс та нарын саналыг асуух гэж энд цуглаагүй. Бид бол дэлхийн хүн төрөлхтний дээд ямоточууд! Та нар бол бурхны зарлигаар доод төрөлд заяасан өчүүхэн амьтангууд болохоор наран хүний үг бүхнийг ёсчлон дагах ёстой. Тиймээс одоо хурдан тарцгаа гэлээ.

- Наран дарга нараа. Үнэндээ бид чинь энүүхэндээ гэхэд болоод байна. Цас зудтай байгаа нь үнэн. Бидний зарим минь холоос нүүж ирсэн. Хөлдүү газар янзалж буугаад нэг муу тохижихчоо аядаж байна. Тэгэхээр одоо дахиад нүүнэ гэдэг чирэгдэлтэй. Нөгөө талаар сая ирж явах замдаа хөл гараа хөлдөөгөөд үхэх сэхэх нь мэдэгдэхгүй хүмүүс цөөнгүй бий. Тэгэхээр би тавин гэрийн даргын хувьд хүмүүсийг нүү гэж тушааж чадахгүй. Манай тавин айлд өнөө маргаашгүй төрөх гэж байгаа бүсгүйчүүд бий гэж хэлтэл,

- Чи дуугүйхэн шиг явж, хошуугаа тат. Хошуу чинь хэм хэмжээнээсээ илүү цухалзвал тайраад өгч болно. Миний үгийг санаж явбал аминд чинь өлзийтэй гэж Симото багтарч ядсан уурандаа хашгичин хэлэв. Гэтэл түүний хахир дуунаас айж, зүрх нь амаараа гарчих шахсан нэг тарган барга,

- Жа, бид та бүхний үгийг даганаа. Би өөрийнхөө тавинаа маргааш нүүлгэе. Та бүхэн манайхны зүтгэлийг бодож хоол ундны тусламж үзүүлбэл ямарсан бол. Хүмүүс олон хоногийн нүүдэл, хүйтэн шамарганд туйлдаж ядарсан. Тиймээс хүмүүст гачигдаж байгаа хоол хүнсний зүйлээр тусалбал үг дуугүй нүүнэ гэж хэлэхдээ ашиг хонжоо хайсан сэтгэлээ илэрхийлэв.

- Бид та нарыг монгол нутагт оруулж нутаглуулах ёстой. Түүнээс хүүхэд шиг эрхлүүлэх гэж ирээгүй! Та нарын хоолыг бид бэлдэх ёстой биш! Харин барга хошууд манай цэрэгт хамгийн сайн агт морьд, хонь, үхрээ өгөх ёстой гэж Симото омогдоход өнөө тарган барга суудалдаа буцаж суухыг ажваас өөрийгөө хэл аманд орчих бий хэмээн болгоомжилсон нь илт байлаа. Гэтэл олны дундаас түрүүчийн хижээл хүн босож,

- Бид хүслээ айлтгаж байна шүү дээ гэж шаардангуй хэлэв.

- Хүсэл гэнэ үү. Чиний хүслийг эрлэгийн элч хөтөлж байгаа бололтой гээд Ёоши гар буугаа сугалах гэхэд Аяанаосу түүний гарыг барьж хориглон болиулав.

- Чи суу. Ах захтайхан ярьж сур! Бид та нарыг хаалттай газар удаан байлгах ёсгүй. Уг нь та нарыг цэргийн холбогдол бүхий хаалттай газар орж нутагласан явдалд шийтгэх ёстой. Гэвч бид их энэрэнгүй улс болохоор тийм хатуу арга хэмжээ авахгүй гэж Симото албан үүргэнд тулгаж хэллээ.

- Бид өөрийн дураар нүүж ирээгүй. Тэгэхээр буруу газар буулгасан хүмүүст хариуцлагыг хүлээлгэх ёстой гэж өнөө хижээл хүн өөрийнхөө бодлыг хамгаалахыг бодлоо. Энэ хүнийг

Сэтэв гэдэг. Тэрээр хуучин барга хошууны хүн. Хошуундаа чамбайхан хөрөнгөтэй, товхийсэн малтай байжээ. Гэтэл японы арми барга хошуудад ирснээс хойш алба татвар, тонуул дээрэмд малаа алдаж, гар хоосрох шахсан. Барга хошуу олон түмэн малтай баялаг хошуу байлаа. Гэтэл сүүлийн хэдэн жил бараг хоосорчээ. Зудад малаа алдаагүй малчид энэ бүхэнд харамсаж, «Зуу гаруй түмэн малаа зудад алдаагүй барга олон хө,

Зуун түмэн малыг зуурдын самурай залгилаа хө» гэж дуулдаг болсон. Симото, Сэтэвийн энэ үгэнд эгдүүцээд дотроо шатах шахан,

- Тэр тухай жич ярина. Гэхдээ манай армийн шийдийг гуйвуулж, энгийн хүмүүсийн толгойг улааны хороор угаж, мунхруулбал зүгээр өнгөрөөхгүй. Нөгөө талаар та бүхэн армийн нууцтай холбогдсон зүйлийг мэдсэн болохоор түү-нийг монголын нутагт очсон хойноо ямар ч хүнд тараахгүй гэдгээ баталж манайхаас тараасан бичигт гарын үсэг зурах буюу хурууныхаа хээг дарах болно. Энэ бичгийг одоо манай орчуулагч уншиж өгнө гэлээ. Япон хэлмэрч Симотоогоос бичгийг авч уншиж өглөө. Тавин гэрийн тэргүүлэгч нар нэг хэсэг дуугүй суутал бүдүүн барга босож Симотогийн дэргэд очоод,

- Жа би, энэ бичигт хурууныхаа хээг дарна гэлээ. Үүнийг ажиглаж суусан Сэтэв, уур хилэн бадарсан дуугаар,

- Би наад бичигт чинь хурууныхаа хээг дарахгүй. Авдар нуураас Мөст сүм хүртэлх газрыг хаалттай гэдгийг сая сонслоо. Ер нь танай цагдаа цэргүүд буу, шийдэм барьж, чичиж, нүдэж байгаад энд авчирсан. Гэтэл тэр цагдаа цэргүүд үзэгдэхээ болиод удаж байна. Квантуны арми манай ард түмэнд эрх чөлөө олгож хятадаас тусгаарлана гэсэн болохоос эд хөрөнгийг минь тоноод эрүү шүүлт тулгана гэж зарлаагүй гэхэд умгар байшинд байсан хүмүүс ам амандаа шуугилдаж эсэргүүцлээ.

Тэдний дотроос гурван хүн бусдаасаа илүү хэдэрлэж хэрэлдээд зогссонгүй Симотоог үгээр дайруулав. Симото энэ бүхнийг ажиглан тэсэж зогсохдоо арваад ахлагч нар тэр гурван хүний үгийг дэмжин японы армийн үйл ажиллагааг шүүмжлэхийг ажиглан нүдэлж авлаа. Хүмүүсийн эсэргүүцэл ширүүссэн тул,

- Хэдэр зантай энэ хүмүүсийг цөмийг баривчил гэхэд Симотогийн хахир дуугаар гаднаас цагдаа нар орж ирлээ. Ёоши Симотогийн даалгавраар арван ахлагч нарыг баривчлав. Тэр арван ахлагчийн дотор сүүлд тавин гэрийн ахлагч болсон хэрүүл шуугианыг өдөөсөн өнөө гурван хүн орлоо. Тэднийг Хайларын барга монголын яамнаас гаргасан шийдвэрийн дагуу ахлагч болгосон болохоор хүмүүс зэвүүцдэг байсан. Гэтэл тэр гурав энэ өдөр хурал дээр Симотоог илэрхий эсэргүүцэн үгээр дайрсан явдалд Симото өршөөлгүй баривчлав. Ийнхүү баригдсан хүмүүсийн тавыг маргааш нь авдар суурингийн ахлагчийн байшингийн өмнөх жижиг талбай дээр авчрахад нөгөө гурван ахлагч оролцсон байлаа.

Тэгээд тэр тавыг цасан дээр сөхрүүлэн суулгаад тэдний ард сэлэм барьсан таван цагдаа цэрэг зогсоолоо. Чингээд Симото, японы армийн дайны хуулинд заасан ёсоор тэднийг цаазлах тушаал уншихдаа баруун гараа дээр өргөж байснаа тушаалынхаа эцсийн үгийг хэлэнгүүт дээр өргөсөн гараа буулгатал таван самурай далайсан сэлмээ буулгах нь тэрээ.

Барга малчид энэ бүхэнд дургүйцэн эсэргүүцсэн боловч япон цэргүүд хүмүүсийг айлгаж толгой дээгүүр нь хий буудсан тул хүмүүс яаж ч чадсангүй. Энэ хэрэг явдлын дараа өрхийн ахлагч нар өнөө бичигт хурууныхаа хээг арга буюу даржээ. Чингээд тэр өдрийнхөө оройноос нүүхээр бэлтгэж, цагдаа цэргүүд айл бүрээр тарж, хоёр хоёроороо барга айлуудад суух боллоо.

Аяанаосу, Жанжин сүм рүү буцах гэж байсан Симоотой уулзаж, ажил төрлийн удирдамж аваад өнөө тарган баргыг дагуулж тэдний тавинд ирлээ. Сэтэвийг Симото баривчилсан болохоор түүний тавинг бүдүүн баргын тавинд харьяалуулжээ. Аяанаосу, тавин айлынхны нөлөө бүхий хүмүүс цугларсан гэрт очиход бүдүүн барга түүнийг бараадлаа. Цугларсан хүмүүсийн уй гашуун зовлонд хэлмэгдсэн царайг харахад сэтгэлийн өшөө хорсолд захирагдан тэргүүн бөхийлгөсөн агаад хааяа хяламхийсэн харцаар япон цагдаа нарыг хяламхийн, ширэв татан харж хөмхийгөө тас зуусныг ажваас уур хилэнгээ барьж ядсаныг гэрчилнэ. Бүдүүн барга Аяанаосуд эвгүй юм бодогдуулахгүйг хичээжээ.

- Манайхан маргааш цөмөөрөө нүүхээр болсон шүү гэж нялуун дуугаар хэлээд хүмүүс рүү эргэн харж,

- Манай өрх айлууд маргаашнаас эхлээд нүүж Хайлааст голын баруугаар нутаглах болно. Биднийг тэнд очсоны дараа монголын хилийн цэргүүд хөөвөл хүн бүхэн гачигдал зовлонгоо тоочих хэрэгтэй. Тэд манайхны амь нас, эрх чөлөөнд халдахад хүрвэл наран цагдаа цэргүүд биднийг хамгаалах болно. Тиймээс монголын хилийн цэргээс айж болохгүй. Харин бидэнд зүй бус авир зан гаргавал тийм хүмүүсийг барьж цагдаа нарт тушаах хэрэгтэй. Монголын хилийн цэрэг, дарга нарыг ингэж барьсан хүнд 100 иень шагнана.

Та нар ойлгож байна уу 100 иень гэдгийг... гэхэд гэрийн хойд талаар сууж байсан хэсэг хүмүүсийн дотроос нэг эмэгтэй «Чи өөрөө барьж өгөөд тэр иенээ авахгүй юу. Бидэнд тэр чинь хэрэггүй шүү» гэж хэлэв.

Аяанаосу, ийнхүү эсэргүүцэн ам амандаа шивнэлдэж байгаа хүмүүсийн зүг ажиглангуй хартал тэр эмэгтэйн хоёр талд суусан хоёр залуу гараас нь барьж зуурсан тул түүнийг босгосонгүй. Бүсгүйн гараас зуурч суусан хоёр залуу, Аяанаосугийн харцнаас далдирч тэргүүн бөхийлгөн суух атал харин нөгөө бүсгүй нулимсандаа улайж хавдсан нүдээр Аяанаосуг хорсолтой ширтэн, уур хилэнгээ барьж ядна. Энэ бүхнийг ажигласан ахлагчийн яс хавталзаж, Аяанаосуд тал засахдаа,

- Манайхан Наран улсын армийн үйл ажиллагааг чин сэтгэлээсээ бишрэн талархдаг юм гэж японоор халти мөлт хэллээ.

- Тэр эмэгтэйг хэн гэдэг вэ? гэж Аяанаосуг асуухад ахлагч;

- Өнөө хэдэр зантай хөгшин Сэтэвийн ганц охин чинь шүү дээ. Нэрийг нь Солонгоо гэдэг юм. Баруун талд сууж байгаа залуу бол хамаатан Бат гэдэг нь. Эд нарыг гэрээр нь шоронд хийхгүй бол бидний ажилд лай чирнэ шүү. Наашаа явахгүй гэж хичнээн баашилсан гэж сананаа. Эдний тавинг авчрахын тулд энэ хүүхний амийг өршөөсөн юм. Одоо бол эднийг царайчлаад байхгүй болсон гэж шивнэн хэлэв.

- Энэ хүүхэн нөхөртэй юу?

- Үгүй шүү. Үгүй ч гэж дээ. Нөхөр нь мухар толгойтнуудтай нийлээд алга болчихсон юм. Харин өнөө цаазлуулдаг таван хүний нэг, намхан хөх хүнийг санаж байна уу. Тэр бол удам судраараа мухар толгойтнуудтай холбоотой байсан хүн. Түүний хүү Сүндэв гэдэг залуу бий. Түүнтэй суух юм гэж ярилцдаг. Тэр нь суунги доголон амьтан юмдаг.

- Солонгоогийн хамаатан залуу юу хийдэг юм бэ?

- Бат угийн өвчтэй хүн. Эцэг нь ярихдаа эхийгээ нас барснаас хойш маанаг болчихсон юм гэдэг гэхдээ Батаа муу юманд тун авхаалжтай хүн дээ. Эцгээсээ хойш Сэтэвийнд ирсэн юм. Миний бодлоор бол эцэг нь амьд байхдаа хүүгийнхээ хэрсүү ухааныг ойлгоод хүний анхаарлаас холдуулахын тулд тэгж цуурхал тараасан байх.

- Тэгвэл эднийх чинь хүн цөөнтэй байх нь ээ. Би эднийд сууна. Тэгээд тэдний талаар дараа надад тодорхой ярьж өгөөрэй гэж Аяанаосуг хэлэхэд ахлагч зүрхээ хагартал айлаа. Аяанаосу, Сэтэвийн гэрт сууна гэсэн нь түүний сэтгэлийг түгшээжээ. Тиймээс ахлагч Солонгоогийн зан аашийг зөөллөх хэрэгтэй боллоо. Ахлагч өөртөө байсан тавин иенээ гаргаж үзсэнээ «Үүнийг өгөөд Солонгоог аргадвал яадаг бол! Тэгэхгүй бол Солонгоо, Бат хоёр дэслэгчийг цааш нь харуулчих улсууд. Тэгэхээр энэ хоёрыг аргалахгүй бол би нүд ирмэхийн зуур хэрэгт унана шүү» гэж бодно. Ахлагч Солонгоотой уулзаж,

- Танайд япон дэслэгч сууна. Тэгэхээр чамд анхааруулах зүйл байна. Чи цаад Батыгаа сайн харж байхыг бод. Уурандаа дэслэгчийн амь насанд халдвал энэ олон айл өрх хэцүү байдалд орно шүү. Тэгэхээр айл хөршөө бодох хэрэгтэй гэж ятгав. Ахлагчийн энэ үг Солонгоод нэгэн бодол төрүүлснийг тэрээр яахан мэдэх билээ. Ахлагч явахынхаа өмнө Солонгоод тал засаж,

- Ноён дэслэгч өнөө маргаашийн нэгэнд ирэх байх. Тиймээс манайхаас очиж мах ав. Би бас гурил өгнө. Түүгээр сайхан бууз хийж өгөөрэй. Аа тийм мартчих шахаж. Ноён дэслэгч танайд тохитой байх ёстой. Одоохондоо би чамд тавин иень өгнө. Энэ бол ноён дэслэгчийг тухтай байлгаж, амттай хоол унд хийсний хөлс юм. Аа, бас чи уур омгийг нь хүргэж болохгүй шүү. Чи энэ барга ах дүүсээ бодох хэрэгтэй гээд тавин иенээ гаргаж өгөхдөө «Дэслэгчийн амь нас бүтэн, хэрэг төвөг дэгдэхгүй бол энэ ч яахав» гэж бодлоо.

Солонгоо, ахлагчийг дагаж гэрт нь очоод жиш гурил, сонгино, хонины, хөлдүү гуя авчирлаа. Тэгээд Батаад учир явдлын зах зухыг дуулгаж,

- Батаа чи, дуугүйхэн шиг байгаарай. Хэрвээ аавыг Халх гол руу нүүхээс өмнө суллахгүй бол бага дэслэгчийг монголд очсон хойноо учрыг нь олно. Амьд хүн аргатай гэдэг. Энэ бага дэслэгчийг барьж монголын хилийнхэнд тушаагаад тэдний хамгаалалтанд орох хэрэгтэй. Тэгэхгүй бол чи бид хоёрыг устгах болно гэж хэлэхэд Батаа, Солонгоогийн үгийг сонсоод хэсэг дуугүй байснаа,

- Таны хэлдэг юу бол доо. Нөгөө талаар хар амиа боддог чинь зөв үү. Япон бага дэслэгчийг монголын хилийн цэрэгт барьж өглөө гэхэд бусад айлуудын зовлон нэмэгдэнэ үү гэхээс хасагдахгүй. Япон даргыг байтугай японы нэг цэргийн аминд халдвал зуун барга хүнийг

цаазална гэдэг биз дээ. Тэгэхээр нэг даргын төлөө зуун хүний амийг гарздаад яахав. Үүнийг бодох хэрэгтэй гэлээ.

- Тэгээд одоо яах вэ? Хүний гарт эрх мэдэлгүй дарлуулж үхсэнд орвол тэмцэж байж үхсэн дээр гэж талийгаач аав минь хэлдэг байсан. Ажаа (Бат, Сэтэвийг ингэж авгайлдаг аж) бас л тэгж захидаг шүү дээ.

- Эд нар монголд биднийг оруулдаг жирийн хэрэг биш. Хайлар, Харбины төмөр замыг өргөтгөх ажил ноднин эхэлсэн. Хайлар, Ханширээгийн дардан замыг ирэх жилээс өргөтгөх юм гэж дуулдсан. Ингэхээр хойтон хавар юмуу зунаас Номон Хан, Бүрд-Овооны дэргэд ямар нэг юм болох янзтай. Тиймээс биднийг монгол руу оруулах гээд байдаг чинь хилийн маргаан дэгдээх гэсэн санааны илрэл! Тиймээс энэ бүхнийг монголын хилийнхэнд аятайхан дуулгах аргыг сэдэх нь чухал!

- Батаа тэгвэл ёстой алаан хядаан болох юм биш үү?

- Монгол цэргүүд юу юуны туханд хүрэлгүй эдэн шиг зэвсэг хөдөлгөхгүй. Харин биднийг монгол нутгаас гаргах шаардлага тавина. Тэр үед бид монголын хилийнхний адилаар цагдаа цэрэгт шаардлага тавих хэрэгтэй.

- Батаа энэ чинь нэмэргүй. Аягүй бол байлдаан гарч мэднэ.

- Байлдаан болох тусмаа бидэнд ашигтай. Монголчууд энгийн барга айлууд руу зэвсэг шагайхгүй. Харин япон цэргүүдтэй үзэж тарна.

- Хэрвээ япончууд бидэнд зэвсэг өгөөд монголын хилийнхэнтэй байлд гэвэл яах вэ?

- Тэгвэл бидэнд бүр сайн болно. Гэхдээ Япончууд бидэнд зэвсэг өгөхгүй. Зэвсэг өгвөл өөрсдийн нь эсрэг байлдана гэдгийг сайн мэдэж байгаа. Тэгэхээр аргагүйн эрхэнд хилээс гарах болно.

- Яагаад тэр вэ?

- Япон цэргүүд өвлийн хүйтэнд байлдаж чадахгүй. Нөгөө талаар эд чинь байлдах ёстой жинхэнэ армийн цэрэг биш! Харин үймээн дэгдээгчид бололтой. Нөгөө нэг зорилго бол газар нутгийг тагнах үүрэгтэй мэт. Ингэхээр хилийн цэрэгт түрэгдэж ухрах нь зайлшгүй. Бид эдний мөргөлдөөнд ашиггүй болохоор биднийг тараахаас өөр зам байхгүй шүү дээ. Тиймээс цагийн аяыг хүлээх хэрэгтэй.

- Манайд байхаар шийдсэн бага дэслэгч биднийг зодож жанчих зэргээр хэрцгий авирлавал яах вэ? гэж Солонгоог асуухад Бат,

- Байдлыг харж байж болно. Хэрэв амь насанд халдах үүрэг тулгарвал өрсөхөөс өөр зам байхгүй. Тиймээс хоёр балиусаа ирлээд биенээсээ салгаж болохгүй гэлээ. Солонгоо, Бат хоёр ийнхүү ярилцаад хөлдүү махаа татаж бууз хийхээр зэхээд япон даргыг хүлээлээ. Өвлийн богино өдрийн цагаан гэгээ тасарч байхад ахлагч, нэгэн цагдаа цэргийн хамт ирж амтлан

бэлдсэн буузыг жигнүүлж, сакэ хуваан сэржимдээд шөнө дүл хүртэл наргижээ.

Аяанаосу, даарснаас болоод хоолой нь эвгүйрхжээ. Тиймээс бүдүүн баргыг хоёр тавьтгай нь Халх гол руу нүүлгээд Солонгоогийн зэрэг хоёр айлыг үлдээжээ. Барга айлуудыг Халх гол руу нүүлгэснээс хойш Бат, Солонгоо хоёр гэрээсээ гарсангүй. Бат амьдралын уй гашуун зовлон, шоронд байгаа нагац Сэтэвийг бодсоор байгаад гөлийжээ. Аяанаосугийн хоолой гайгүй болсон болохоор хоёр хоносны дараа Сэтэвийнд очлоо.

Гэр нь хүн байтугай мал тогтох аргагүй хүйтэн агаад Бат, Солонгоо хоёр сэгсүүргэн дээлээр хөлөө хучаад бодлогошрон сууна. Аяанаосуг гэрт ороход тэд суудлаасаа өндийсөнгүй. Япон дарга нарын барааг харсан хэн боловч ухасхийн босож, тэргүүн бөхийлгөн зогсоод, япон дарга нарын юу тушаасныг үг дуугүй гүйцэтгэх ёстой. Энэ ёс горимыг зөрчсөн хүнийг таван иениэр торгох буюу жавгийдан гэсгээнэ.

Бат, Аяанаосуг орж ирснийг мэдээгүй юм шиг суухдаа гэрийн тооно өөд гөлийжээ. Харин Солонгоо, Аяанаосугийн царай руу догшин харцтай нүдээр ширтэхдээ «Яасан ч яахав» гэсэн байдалтай.

Аяанаосу, ямотогийн хөвгүүдээс доод угсаатантай харьцах ёсыг баримталж «Намбу» буугаа гэрнээс нь авахаар завдахдаа,

- Та нар чинь амьд байна уу? Эсвэл суугаагаараа хөлдчихсөн амьтад уу! Босоцгоо. Наран улсын армийн дайчин эрийн өмнө та нар яаж байгаа чинь энэ вэ? гэж хятадаар хэлтэл Бат тооно ширтэн гөлийсөн нүдээр Солонгоо руу харах нь "Болгоомжтой бай! Энэ золигийн самурай бүдүүлэг харьцвал устгана шүү!" гэсэн шиг сэргэмжилсэн байдалтай. Солонгоо хэд хоног уйлсандаа улайж хавдсан нүдээ хар цагаанаар эргэлдүүлэн Аяанаосуг ширтэж буй тэрхэн үед Аяанаосу барьж явсан цэргийн хээрийн цүнхээ гэрийн хаяанд тавихаар тонгойтол Батаа суудлаасаа ухасхийн өндийж Аяанаосу руу дайрлаа.

Аяанаосу, тэр хоёрын царайны байдлаар өөртөө ямаршуухан аюул заналхийлж байгааг гадарласан болохоор том балиус барьсан Батаагийн балиустай гарын далайлтаас огцом зайлахдаа баруун гарын алганы ирмэгээр Батаагийн хутгатай гарын шууг тосгуулан цохих тэрхэн эгшинд зүүн гарын сулхан цохилтоор аюулхайд нь буулгажээ. Нүд ирмэхийн төдийхөнд болсон энэ хэрэг явдлыг ажигласан Солонгоо гэрийн хойроос өндийнгүүтээ хутгаа далайхыг ажигласан Аяанаосу, тулганы дэргэд байсан аргалын хоосон хайрцгийг шүүрэн авч урдаа барьтал, Солонгоогийн шидсэн хутга аргалын хайрцагт үзүүрээрээ зоогдохыг ажваас олон сар хутга шидэх сургууль дасгал хийсэн нь илхэн болой.

Аяанаосу аргалын хайрцагт зоогдсон хутгыг аваад Солонгоо руу эргэтэл тэрээр баруун гартаа багашигхан балиус барьчихаад шазуураа тас зуун зогсохыг ажвал амьсгалах тоолонд нь хамрын самсаа гүрэлзэн, багтарсан уур хорслоо барьж ядах тул цээж нь дэлбэрчихээс наагуур түнхэлзэх ажээ. Аяанаосу урагшаа ганц алхам ч гишгэж болохгүй гэдгийг мэдээд гэрийн эсгий үүдний дэргэд ухаангүй хэвтэж байгаа Батаагийн дээрээс өнгийн хараад,

- Солонгоо намайг хороосон ч гэсэн та нарын өшөө хорсол барагдахгүй. Батаа хэд хоног аяганы амсар зуугаагүй болохоор ганц ёвролт даасангүй. Энэ цүнхэнд идэх юм бий. Аяга шөл

хийж өг. Үүнээс хойш юманд бодолтой ухаантай хандаж сур! Би маргааш танайд ирж суух болно.

Тэгэхээр гэр орноо эзэн хүн шиг өөд татчихсан байвал дээр шүү гэж хятадаар хэлээд гэрээс гарлаа.

Аяанаосуг гэрээс гарсны дараа Солонгоо яахаа мэдсэнгүй. Тэгээд учир зүггүй уйлахдаа «Ёстой туулай шиг амьтан гэж намайг хэлнэ дээ. Дайсныхаа уран үгэнд хууртагдаад үлдэх гэж байх уу?» гэж өөртөө үглэн гиншиж суутал Батаа ухаан орж өндийнгүүтээ эргэн тойрноо сүрхий ажиглаад Аяанаосуг алга болсныг мэдэнгүүт эгшний төдийд ухасхийн гэрээс гарснаа удаж төдөлгүй орж ирээд балиусаа тулга руу чулуудав.

- Бид хоёр мөн таарсан амьтад юм даа. Иймдээ бид самурайн гарын шүүс болж байгаа юм. Чи яагаад түүнийг амьд явуулчихав? гэж Солонгоо руу омогдов.

- Чи бид хоёр байтугай бидэн шиг арван хүн байгаад ч нэмэргүй.

- Тэгээд одоо самурайн гарт сүйрэх хэрэг үү? Одоо ингээд цагдаа нар ирнэ. Ядаж ганц самурайг тонилгож чадахгүйгээр амиа алдах болж байна гэж орилон хэлэхэд Солонгоо,

- Цагдаа нар ч ирэхгүй байхаа. Тэгээд ч чи бид хоёрыг алахгүй биз гэж итгэл муутай хэлэв.

- Алахгүй гэнэ шүү. Мунхагийн дотор цайлган гэгчээр мөн найдах хүнээ олж найдав аа.

- Энэ бага дэслэгч бидний мэддэг самурай нараас арай ондоо юм шиг байна, Чи бид хоёрт хоол ундны юм авчирчээ гээд Солонгоо гэрийн хаяа руу толгойгоороо заалаа.

Бат гэрийн хаяанд, түшүүлээд тавьчихсан япон цэргийн хээрийн цүнхийг харангуут түүнийг уудалж дотроос нь хөлдүү мах, сонгино, гоймон, жиш гурил гаргаж дэргэдээ тавингуут гайхсан нүдээр Солонгоо өөд ширтэнэ. Сэтэвийнх дөрвөн жил гоймон гурилын бараа хараагүй болохоор Бат сэтгэлдээ баярласан атлаа эчнээндээ оволзсон өшөө хорсолдоо захирагдана.

- Энэ юм хортой бол яана. Тэр жил малчдад хортой гурил, мах өгснөөс олон хүн хордож үхсэн гэдэг. Тэгэхээр энэ цөмөөрөө хортой байж таарна гэж Батааг хэлэхэд Солонгоо,

- Одоо тэгээд яах вэ? гэж асуулаа.

- Ахлагч Хайлаастаас ирж, үлдсэн айлуудаа нүүлгэнэ гэсэн. Тэгэхээр самурайн өгсөн мах гурилаар хоол хийгээд өгчихье. Ахлагч амьд явсан цагт манайхан амар заяа үзэхгүй.

- Хордоод үхчихвэл бид хоёрыг бариад шоронд хийнэ шүү дээ.

- Энэ юм хортой бол идсэн дороо үхэхгүй. Харин аажимдаа хор нөлөөлөх нь гарцаагүй. Япончууд ийм арганд мэргэжсэн хүмүүс. Тэр жил олон хүн үхэхэд халдварт өвчин гарсан байна гэдгээр шалтаг заагаад өнгөрчихсэн гэдэг.

Бат Солонгоо хоёр чингэж ярилцаад гэр орноо янзлахчаан аядав. Солонгоо өшөө хорслоо хичнээн баривч сэтгэлд нь бөөгнөрсөн харуусал түүнийг захирах болой. Тиймээс эчнээндээ «Ингэж амьд явахаар үхэх юмсан. Үхэхдээ самурай нараас ганцыг ч гэсэн хороох юмсан» гэж бодно. Чингэж бодсоор үдэш хүргэтэл Авдар нуурын суурингаас хоёр хятад илжиг тэргэнд түлээ ачиж ирээд Сэтэвийн гадаа буулгаж өгөхөд «Наран ноёнтон танайд ирж хононо гэсэн. Гэрээ сайн дулаацуулаарай» гэх нь цаанаа ёжтой ажээ. Гэтэл од мичид тэнгэрт түгсэн хойно ахлагч, бас нэг цагдаа цэрэгтэй хамт ирлээ. Бат, Солонгоо хоёр хоол унд янзалж, жиш гурилтай мянтууз хийж ахлагч, цагдаа хоёрыг дайлав.

- Солонгоо чи, ноён дэслэгчийн уурыг хүргэж болохгүй шүү. Тэр дэслэгч та нарыг "Улаантай холбоотой юу? Эцэг нь гэжүүд хүн байна гээд байсан. Тэгэхээр дотроо нэг бодолтой байх шүү. Танайхыг нэг жижиг манхан бараадуулж буулгана. Монголын хилийнхэнтэй тун ойрхон. Монгол хилчид ирж та нарыг хөөх байх. Тэгэхэд нь нүүж болохгүй.

Зудад ядарч зүдэрснээ айлтгаад монгол нутагт өвөлжүүлэхийг гуйгаад байгаарай. Учир зовлонгоо ойлгуулбал та нарыг хилчид хөөхгүй биз. Харин Батаад учир байдлыг сайн таниулж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол наад мангарын чинь галзуу хөдөлбөл биднийг хөөдөж мэднэ" гэж болгоомжилсон янзтай захилаа. Харин Батаа тэр хоёрын үгийг сонсоогүй юм шиг сууж, хайлаас хугалж тулгандаа хийж гал өрдөх агаад ахлагч нарийнхан урт хэрчсэн мянтууз савхдаж, амтархан зооглоно. Ахлагчийг чингэж наргиж байсан тэр үед Аяанаосу, Ёоши хоёр Авдар нуурын суурингийн ахлагчийнд сакэ балгаж ажил төрлөө ярилцаж байлаа.

- Аяанаосу сан, барга айлуудыг тун аятайхан байрлуулсан. Хилийнхэн анхандаа хөөсөн боловч ядарч туйлдсан барга айлуудын хөл гараа хөлдөөж үхлүүт байгаа хүмүүсийг хараад өрөвдсөн бололтой. Тэд лав хүч хэрэглэхгүй. Би өнөө шөнө буцаад маргааш Хайлаастын зүүн талаас ажлаа эхэлнэ. Чи маргааш бүдүүн ахлагчтай нийлж үлдсэн айлуудыг нүүлгэж Хайлаастын баруун талаар нутаглуулах хэрэгтэй.

Ахлагч газарчилж буух газар чинь аваачна. Хилчид хөөвөл ганц ч айлыг нүүлгэж болохгүй. Ер нь жаахан далим гарвал айлууд нүүчих янзтай байгаа. Тиймээс тун болгоомжтой байгаарай. Би дөрөв хоноод очно. Хоёулаа Хайлаастын мухар манханд уулзана. Түүнийг ахлагч сайн мэднэ. Чи дөрөв хоногийн дараа үдээс хойш 16 цагийн үед тэнд хүлээж байгаарай.

- Ахлагч бид хоёр очих хэрэг үү?

- Хилийнхэн барга айлуудыг тун сайн ажиглаж байгаа. Тиймээс олуулаа явж болохгүй. Өчүүхэн төдий сэжиг авбал барга айлуудыг хөөх янзтай байгаа. Бид гурвуулхнаа очно.

- Ёоши, сан шиү са доноо Симоото, яагаад Сэтэвийг цаазлаагүй юм бэ? Би бол дор нь устгах байсан.

- Сэтэвтэй үлдсэн гурван хүнийг цаазалж болохгүй. Тэгвэл барга айлууд цөмөөрөө босож мэднэ. Харин цаазлуулсан тэр таван хүний гурав нь хожим барга айлуудтай нийлсэн хоригдлууд байгаа юм.

- Юу яахаараа тавин гэрийн ахлагч нар хоригдлууд байдаг билээ. Эсвэл зохион байгуулсан

тусгай ажиллагаа юм уу?

- Яг тийм. Баргуудын ярьдгаар тэр гурав бол урвагчид юм. Симо, уран арга хэрэглэж тэр гурвыг молигодоод устгачихсан билээ. Тэгээд тэдний хэн хэн нь Симогийн арга ухааныг мэдээгүй гээд сакэ балгасаар учир явдлыг ярилаа.

...Симо, урвагч нарыг ашиглахдаа үнэмшихээр ам өгч ятгаж чадсан. Тэрээр нутгийн гүнээс нүүж ирсэн барга айлуудын ахлагч нартай анх уулзахдаа сэжиг бүхий гурван хүнийг баривчлаад тэдний оронд тэр гурван урвагчийг ахлагч болгосон юм. Түүнийхээ ачаар барга айлуудыг тагнаж, улаантантай холбоотой байсан хэд хэдэн мухар толгойтнуудыг илрүүлэн барьсан. Тэгээд Авдар сууринд ирснийхээ дараа тэр нэг өдөр барга хүмүүсийг цуглуулах ажлыг зохион байгуулсан билээ. Цуглаан дээр Симо гурван урвагчийг өөрийнхөө эсрэг үг хэлэх арга ухаан зааж өгч тусгайлан бэлдсэн юм.

Тэднийг тэгж хэлүүлэх ажил зохион байгуулснаараа барга нарын дунд үлдсэн улааны шавь нарыг илрүүлж баривчлаад өнөө гурван урвагчаа Симо устгуулсан. Гэтэл тэр гурван урвагч толгой дээрээ далайсан сэлмийг буун буутал Симогийн үгэнд итгэсээр байсан. Симо барга айлуудтай уулзахын өмнө тэр гуравт зөвлөхдөө «Та нар бидэнд хамгийн аюултай хүмүүсийг илрүүлж өгсөн. Харин одоо хамгийн сүүлд гуйх нэг зүйл байна. Барга айлуудад улаантны гар хөлийн хүмүүс байна. Тэднийг илрүүлж өгсний дараа тэднийг цаазлахад та гурвыг авч явна. Тэгээд улаантнуудыг цаазалсан хойно та гурвыг цаазлахаа хойшлуулж, хүндрүүлэх ял хэлэлцэнэ гэдэг нэрийдлээр аргална. Ингэвэл та нарыг сэжиглэж байсан баргуудын сэжгийг цагаатгаж чадах төдийгүй та гуравт итгэх итгэл төрөх болно.

Ингээд та нарыг үнэнч улс байж гэж бодох нь гарцаагүй. Үүнийг та нараас гуйх гэсэн юм. Тэгэхээр та нар өөрсдийнхөө дураар шийд. Та нарыг зөвшөөрөхгүй бол албадахгүй. Та нар хийх ёстой зүйлээ хийсэн» гэж билээ. Гэтэл тэр гурван урвагч өөрсдийнхөө нэрийг цагаатгаж өгөх нь гэж баярлаад Симогийн болзлыг зөвшөөрөөд толгойгоо авахуулсан юм.

Ёоши ингэж Аяанаосутай нэлээн сэржимдээд шөнө дүл хүргээд багаж хэрэгслэлээ ачаад Халх гол руу хөдлөв. Аяанаосу Ёошийг явсны дараа түүний ярьсныг эргэцүүлэн бодлоо.

...Одоо яах вэ? Ёошийг тонилгож чадвал Халх голын газар нутгийн байр зүйн тодруулалтыг зогсоож чадна. Дөрөв хоног.

Аяанаосу чингэж өөрөөсөө хэдэнтээ асуувч тоймтой шийд гаргаж чадсангүй. Чингээд маргааш өглөө нь бүдүүн ахлагчаар газарчлуулж үлдсэн айлуудыг нүүлгэв. Хайлааст голоос нэлээн баруун тийшээ байгаа нэг жижиг манхны өвөрт Сэтэвийнхийг буулгав. Тэднийх найман гэрээр хотлон буулаа. Айл бүрт хоёр цагдаа цэрэг суусан учраас айлууд цагдаа нарыг хоймроо залж өөрсдөө гэрийн хаяагаар бөөгнөрч, толгой хоргодно. Бат айлуудаас гурван эр авчирч дагтаршсан цас арилгаж сүрэл дэвсээд гэрээ барилаа. Тэднийд бага дэслэгч байрлах учраас гэрээ тохижуулах хэрэгтэй боллоо. Ахлагч айлуудаас илүү дутуу ширдэг, дэвсгэр цуглуулж, сүрэл дээр хоёр давхар дэвссэн болохоор бусад айлуудаас илүү дулаан аж. Аяанаосу Симогийн өгсөн удирдамжаар таван айлд өөрийнхөө шавь нарыг байрлуулсан бөгөөд тэд хилийнхэнтэй будлиан маргаан гаргах үүрэгтэй.

Бат, Солонгоо хоёр гэрээ тохижуулж ядаж байхад ахлагч тэр хоёрыг хий шахаж шаардаж, толгой түрүүгүй загнасаар орой болгоод тэднийд хонохоор шийдэв. Аяанаосу, бүдүүн ахлагчийг явуулж зэрэгцээх саахалтаас хэд хэдэн цагдаа дуудуулж, хилийнхний байдал төлөвтэй танилцаж цагдаа нараа сакэгээр дайллаа.

- Та нарыг ирэхээс өмнө өнөөдөр өглөө хилийн цэргүүд ирж биднийг дахин хөөсөн. Тэгээд дарга нараасаа уулзуул гэж байна билээ. Хилийн цэрэг хойд талын манхны цаад талын өндөрлөгт байрласан бололтой. Маргааш ирж магадгүй. Тэгвэл нэг даргыг нь баривчилж болно шүү. Тэр хүн бидэнд сүрхий хатуу шаардлага тавиад байгаа юм гэж нэг цагдаа хэлэв.

- Бид юуны өмнө Ёошигийн ажлыг бодох ёстой. Тиймээс ямар ч зааваргүйгээр хилийнхэнтэй шөргөөлцөлдөж болохгүй. Харин Ёоши ажлаа бүтээчихсэн нөхцөлд бид хилийнхэнтэй нялганахгүй.

- Аяанаосу сан, би ч тэгж бодоод тэсээд байгаа шүү. Гэхдээ тэднийг сорьж үзсэн. Бодвол хил дээр маргаан дэгдээж болохгүй гэж заавар авсан бололтой. Ер нь зэвсэгт мөргөлдөөн гаргахгүйг хичээж байгаа бололтой байна билээ.

Аяанаосу цагдаа нартай чингэж ярилцаад сакэ балгахдаа хундаганы амсарт уруул хүргэхээс цаашилсангүй. Тэрээр хоолойн өвчнөөр шалтаг зааж, бүдүүн ахлагчийн шахалтаас аятайхан сугарна. Чингээд шөнө дүл болгоод наргиан өндөрлөв. Аяанаосу хөл дээрээ тогтож чадахаа байсан цагдаа нарыг ажиглангуй сууснаа,

- Батаа эдний байдаг гэрийн барга нарыг дуудаж хүргээд өгчихийг бод! Тэгэхдээ илүү дутуу нэмэр хандив хачирлах хэрэггүй. Ер нь Солонгоо та хоёрт сануулахад одоо өшөө хонзонгоо авах гэж улайрсны хэрэггүй. Энэ талаар барга айлуудад учир байдлыг ойлгуулахыг бод! Харин миний тухай тэдэнд ганц ч үг цухуйлгаж болохгүй гэж барга аялгуугаар хэлэхэд Бат, Солонгоо хоёр бие бие рүүгээ гайхан харахыг ажваас тэдний хэн хэнд нь «Энэ чинь барга хүн байсан хэрэг үү» гэдэг бодол төрж, царайд нь баярын мишээл зурсхийн илэрсэн байлаа.

Үүрээр ганц хоёр хаялж байсан цас үд өнгөрөөгөөд малгайлан орлоо. Аяанаосу өдрийнхөө хоолыг зооглоод өөрийнхөө дэргэд байдаг цагдаа цэргээ дагуулан явган гэлдэрч хот айлын хойхно байдаг манхан дээр гарлаа

Аяанаосу манхан толгой дээр зогсож хилийн зүг дурандахад алс тэртээд цайрагнасан цагаан мананд умбасан Халх голын бургас бүдэг бадаг сүүмэлзэхийг ажваас сэтгэлд таатай, нүднээ дулаан дотно харагдах ажээ.

Буянтын хоч, нэрээр манжуурт хэдэн жил суухдаа сэтгэл санааны тэвчээр, хэр хэмжээнээсээ хэтэрсэн сорилт, хардалт, мөшгөлт, шалгалтуудыг давж, квантуны армийн тагнуулын удирдлагад тал нүүр олсон Гунгаа өсөж төрсөн нутгийнхаа барааг ингэж харна гэж бодоогүй.

Нүд алдам тэртээд үргэлжилсэн, цавцайсан цагаан цас, тунгалаг хөх тэнгэрийн өнгөөр гялтганасан Халх голын мөсөн гялбаа, цасан талд бараантсан бургас, хайлаасыг харахад сэтгэлийн угт баяр баяслын оч цогших атал эх орон ард түмэндээ учирч болох аюулыг санахаас сэтгэлийн баяр баясал харууслаар солигдон «Яах вэ? Ёошигийн үйл ажиллагааг яаж

саагуулах вэ?» гэдэг бодол сэтгэл оюуныг эзэмдэнэ.

Ингэж орсон цас маргааш хоногтоо зогсоно. Аягүй бол шуурч мэднэ. Шуурга... шуурга! Миний бодол зөв үү? Ямар нэг сэжиг гаргахгүйгээр хөдөлж чадвал миний бодсон зүйл хамгийн боломжтой арга! Тиймээс маргааш Бат, Солонгоо хоёрт учир байдлыг хэлэх хэрэгтэй! Ямар ч гэсэн маргааш айлуудаар хайлаас, бургас түүлгэх шалтаг гаргая. Маргааш надад үүнийг ашиглах далим гарах ёстой. Маргааш...маргааш Ёоши ирнэ.

Аяанаосу өөртөө байгаа боломжийг сайн эргэцүүлсний эцэст Ёошийг баривчилж хилийнхэнд тушаахаар шийдэв. Аяанаосу Халх голын зүг дурандаж зогсохдоо чингэж бодоод манхан дээрээс буухдаа «Хилийнхэн өнөөдөр ирээд нүү гэж шаардвал яах вэ? Хилийн харуулын ахлагчтай уулзах боломж надад олдох уу? Эсвэл хэлэлцээ хийе гэдэг нэрийдлээр уулзах уу? Ингэж болохгүй. Миний үүргэнд харш зүйл! Симотогийн удирдамжгүйгээр хилийнхэнтэй уулзвал сэжиглэгдэх болно. Тэгэхээр Ёошийг хилийнхэнд тушаах арга байхгүй» гэж бодно.

Аяанаосуг ирэхэд Бат гэрийнхээ гадаа хайлаас хугалж байлаа. Хорь гарч яваа залуугийн цайвар царай, хацар нь даарсандаа үл ялиг ягаарсан агаад сэтгэлийн хорслоо илтгэсэн ширүүн харцаар Аяанаосуг нэвт ширтэнэ. Бат насаар бага боловч санасан бодолдоо хүрч чаддаг, гүжирмэг зантай төдийгүй харийн түрэмгийлэгчдийг үнэн голоосоо үзэн ядна. Тиймээс Сэтэв, Батаагийн энэ шулуун шударга зан араншинг япончуудаас нуухын тулд «сэтгэл санааны доголдолтой» гэдэг аян шалтаг гаргаж цагдаа нарын анхаарлыг сарниулсан ажээ. Бат, Аяанаосугийн бараанаар хугалж овоолсон хайлаасаа бөөнөөр тэврэх гэж оролдсоноо болиод хайлаас руугаа хэдэнтээ өшиглөснөө,

- Ноён даргаа та үүнийг бөөнөөр нь тэврээд явж чадах уу гээд инээмсэглэхэд цагдаа цэрэг Бат руу хараад,

- Аргагүй согогтой эр шүү. Ийм их хайлаасыг яаж тэвэрч багтаана гэж бодоо болоо гэж гайхан хэлэхэд Аяанаосу,

- Чи наад хайлааснаасаа хугалалц! Түлээ нэлээн бэлдэж авахгүй бол наад мангар чинь өнөө шөнө чи бид хоёрыг осгоож мэднэ шүү гээд гэрт орлоо.

Задгай тулгандгалөрдөж суусан Солонгоо, Аяанаосуг ажиглангүй ширтэхэд Аяанаосу юу ч хэлэлгүй алхсаар хоймор зассан орныхоо өмнө очоод халааснаасаа янжуураа гаргаад дууссаныг мэдэнгүүт хээрийнхээ цүнхийг уудалж янжуур авангуут,

- Солонгоо ахлагч саахалтаас ирсэн үү? гэж хятадаар асуув.

- Тэр новш яалаа гэж ирэх вэ? Аягүй бол архиа гүзээлж, авгай хүүхдийн хормой татаж яваа биз. Хэрэв эрүүл байгаа бол гэр рүүгээ гүйчихээ биз. Тэднийд байгаа хоёр цагдаа ахлагчийг байхгүй хойгуур эхнэрийг нь оролдоод байдаг гэсэн. Тэр ч байтугай ахлагчийг согтоож унагаад эхнэрийг нь хүчиндсэн гэнэ.

- Чи чинь хэнтэй харьцаж байгаагаа мэдэж байна уу. Иймэрхүү байдлаар харьцвал эцэг чинь

сайнаа үзэхгүй.

- Биднийг аятайхан харьцлаа гээд аавыг минь суллахгүй нь магад.

- Би эцгийг чинь яах ч үгүй. Харин саяын үгийг ахлагч сонсвол Симотоод нэлээн давслаад алтан хошуу хүргэчихэж дөнгөнө байх шүү. Ахлагч намайг тэр нэг өдөр танай тавин дээр ирж та нартай уулзахад эцгийг чинь улаантантай шууд холбоотой гэж мэдэгдсэн. Тэгээд зогсоогүй. Та нарыг бүгдийг устгах хэрэгтэй гэсэн юм шүү дээ гэж Аяанаосуг хэлэхэд Солонгоо амандаа «Тэр чинь олон удаа ховлож чадахгүй. Одоо хоногийн тоо нь гүйцэж байгаа» гэж үглэхдээ Аяанаосуг сонсог гэсэн шиг чанга хэллээ.

- Солонгоо ахлагчийн амь насанд халдаж болохгүй гэж та нарт хэлсэн байх аа.

- Ноён дэслэгчээ тэгвэл та, ахлагчаа юу гэж муулаад байгаа юм бэ? Та бидний гараар ахлагчийг тонилгуулахын тулд тал засаж байгаа шүү дээ. Бид үүнийг чинь ойлгож байгаа. Ер нь та хаашаа янзын бодолтой хүн бэ? Нялуунаас шулуун гэгчээр одоо хэлчихсэн дээр байх! Бидний янзыг үзэж байгаа бол түүнийгээ хэлчих! Та Бат бид хоёрын санааг бүрэн ойлгож байгаа. Тэгэхээр та биднийг өчиггүй устгах эрхтэй. Харин жүжиглэх хэрэггүй.

- Би та хоёрыг сонжсон нь үнэн.

- Тэгээд устгахгүй юугаа хүлээсэн юм бэ? Бидний зовлонгоор жаргал хийх гэж бодоо юу? Тиймээс миний бие сэтгэлийг бузарлах гэсэн хүсэлдээ хүрэхийн тулд Бат бид хоёрыг янз янзаар зусардаж байгаа биз. Би тэр ахлагчийн эхнэр шиг элэг бариулахгүй гэдгийг мэдэж ав!

- Би чиний наад хэлж байгаа санааг одоо хүртэл сэтгэлдээ бодоогүй юм. Нөгөө талаар хүний зовлонгоор хүн жаргал хийдэггүй юм. Эцэст нь хэлэхэд та хоёр Сүндэвтэй нийлж өшөө авна гэдэг бол тэнэг бодол! Сүндэвийн эцэг удам угсаагаараа гоминдааны эсрэг тэмцэж явсан улаантан. Тиймээс ахлагч шиг хэнд ч хэрэггүй хүнийг хий устгавал өөрсдийнхөө амийг хий гарздана.

- Ноён дэслэгчээ таны бодлоор бол яах ёстой юм бэ? Нэгэнтээ улаан цагаан дээрээ хүрснийх шулуухан ярья.

- Солонгоо надаас олон зүйл асууж шалгаахгүй бол арга зааж өгч болно. Тиймээс хэн хэн маань шударга болзол тавих ёстой болно.

- Хэрэг бишдвэл өөрийгөө барьж өгөх нь гэж айгаад болзол тавимаар байна уу? Бид таныг хэрэгт түлхэхгүй. Тиймээс танаас юу ч шалгаалахгүй. Хэрэгтэй гэж үзсэн үедээ таныг устгах болно. Өөрөөр хэлбэл амийг амиараа солих болно гэдгийг хатуу ойлгох ёстой!

- Солонгоо чиний наад болзол хатуухан болзол байна. Гэхдээ яая гэхэв. Тэгэхээр эхэлсэн зүйлээ үр дүнтэй дуусгах нь чухал. Би танай ахлагчтай ам мурийж яваагүй болохоор бидний дунд өшөө хонзон байхгүй. Гэхдээ энэ хүн амьд явбал та нарыг зовлонгоос салгахгүй гэдэг нь ойлгомжтой. Харин та нар ахлагчийг хилийнхэнд барьж өгвөл манай дарга нар сэжиглэхгүй байх боломжтой шүү.

- Та чинь биднийг толгой дараалан устгах аргаа олоо шив дээ. Би таны санааг бүрэн ойлголоо. Ахлагчийг хилийнхэнд барьж өгнө гэдэг чинь биднийг улаантантай холбоотой гэдгийг батлах гэсэн таны санаа мөн биз дээ.

- Надад тийм бодол байхгүй. Нөгөө талаар сэжиглэгдэхгүй аргыг би та хоёрт зааж өгсөн. Тиймээс та нар ганц ахлагчийг биш. Бас нэг хүнийг хамт барьж хилийнхэнд тушаах болно.

- Манайханд ахлагчаас өөр барих хүн байхгүй гэдгийг та мэдэж байгаа.

- Хоёр дахь хүнийг барга айлуудаас барихгүй. Манай дэд хурандааг ахлагчтай хамт барьж хилийнхэнд өгөх ёстой гэхэд Солонгоо гайхсандаа Аяанаосу руу гөлөрсөөр,

- Юу гэж асуулаа.

- Маргааш үд өнгөрөөгөөд Ёоши Хайлаастын зүүн талаас ирнэ.

- Тэр чинь хурандаа цолтой юм уу?

- Тиймээ Хасан нуурын орчмын газар нутгийн байр зүйн тодруулалтыг сайн хийсэн учраас дэд хурандаа болсон юм. Энэ хүн цэргийн хувцас өмсдөггүй боловч гэмт хэрэг дэгдээж явдаг хүн. Тиймээс монголын хилчдэд тун чухал хэрэгтэй гэж Аяанаосуг хэлэхэд Солонгоо итгэж ядсан мөртлөө баярласан сэтгэлээ үл нуусан харцаар Аяанаосуг ширтэнэ. Аяанаосу Солонгоо хоёрыг ийнхүү ярилцаж байтал хугалж жижиглэсэн хайлаас тэвэрсэн Бат гаднаас орж ирлээ. Батыг орж ирснээс хойш нэлээн хэдэн мөч өнгөрсний дараа Аяанаосу,

- Ахлагчийг хаана байгаа газраас нь дуудаж ир! Танай айлууд түлээ түүх ёстой. Гэтэл өнөөдөр ахлагч бас хөдлөх шинжгүй боллоо. Энэ янзаараа бол маргааш гэхэд бас хөдлөхгүй байж чадах хүн байна гэхэд Бат, Солонгоо руу нүдний булангаар харлаа. Солонгоо Батаад явж болно гэсэн дохиог нүдээрээ ирмэж өгсний дараа Бат гэрээс гарлаа. Түүнийг цагдаа дагаж явлаа.

Бат тэр нэг өдөр ахлагчийг хорлохоор хортой хоол хийж өгөхдөө баяртай байж билээ. Гэтэл түүний бодол талаар өнгөрчээ. Чингээд ахлагчийг тарган махтай мянтуузаар дайлснаа бодоод уур нь хүрдэг болжээ. Бат ахлагчийг харангуут нүүр царай нь хачин аймшигтай өөрчлөгддөг. Батааг дагасан цагдаа ахлагчийнд ирээд эртний танил хоёр цагдаатай уулзав. Тэд ахлагчийн эхнэрээр хоол хийлгээд сакэ балгаж байв.

- Батаа, Солонгоо юу хийж байна. Дэслэгчтэй сайхан наргиж байгаа биз дээ гээд ха ха хөхөрлөө. Ахлагчийн энэ үгийг сонсоод Батаагийн хамаг бие арзасхийх шиг болсон боловч тэрээр хязгааргүй оволзсон уураа барьж хөмхийгөө зууж өөрийгөө тайвшруулаад,

- Ноён дэслэгч таныг хурдан ир гэсэн шүү гэхэд цагдаа,

- Одоо хурдан явах хэрэгтэй гэж японоор шаардлаа. Ахлагчийнх тулгаа улайдтал гал түлсэн болохоор түүний цайвар царай ягаараад, хөлс урсаж, байж тэсэхийн аргагүй халууцсан нь илтээ. Ахлагч амандаа үл мэдэгдэх юм үглэсээр суудлаасаа өндийж бүсээ бүсэлж байхдаа

«За дэслэгч түлээ түүсэнгүй гэж омогдох байх даа. Гэхдээ маргааш түлээнд явуулах хүмүүсийн хуваарь хийчихсэн болохоор арай гайгүй байх» гэж амандаа үглэнэ. Чухам энэхэн үед гэрийн зүүн хаяанд сууж байсан эхнэр нь өвөр дээрээ сууж байсан хоёр хүүгээ босгоод ахлагчийн дэргэд очиж,

- Энэ хоёр чамтай явахгүй юм уу гээд гэртээ байдаг цагдаа руу толгой дохин заалаа.

- Яалаа гэж явах вэ? Чи ч гэсэн дуртай байгаа биз дээ гэхэд эхнэр нь нулимс цийлгэнэсэн нүдээр эр нөхрөө гөлөрсөөр,

- Яалаа гэж дээ. Эд чинь бугаа аманд тулгаж байгаад...гээд дараагийнхаа үгийг хэлж чадалгүй нулимсаа арчив.

- За одоо яах вэ? Амьд явбал тэр чинь энүүхэнд хэрэг!

- Тэгээд би эдэнд доромжлуулж биеэ бузарлуулж байх хэрэг үү? Чи намайг боддоггүй юм гэхэд хоёр хүүгээ бодооч. Эд нар чинь хүүгийн чинь дэргэд харуулж байгаад тэгдэг шүү дээ гээд уйлагнав.

- Чиний бөгсийг эднээс харамлаад сайнаа үзэхгүй. Миний амины гарз болно. Би амьд явахыг хүсч байна. Чиний орноос би үхэхгүй шүү гээд гэрийнхээ үүд рүү эргэхэд эхнэр нь хар цагаанаараа эргэлдсэн нүдээр хорсолтой хараад хөмхийгөө зууснаа «Хүний үнэргүй нохой! Самурай нарын шиврийг долоочих шахсан чи, эднийхээ гарт үхэх вий. Би тэгж үхэхийг чинь үздэггүй юм гэхэд японы гарт яаж үхэхийг чинь амьтан ах дүүс үзэх байлгүй» гэж үглэх нь Батаад тод сонсогдлоо.

Бат ахлагч цагдаа хоёрыг дагасаар гэр рүүгээ гэлдрэхдээ ахлагчийн эхнэрийн үгийг сонсоод «Өнөө дэслэгч Солонгоог бас ингэж зовоодог болов уу? Арай гайгүй болов уу? Яагаад энэ дэслэгч бусад самурай нараас ондоо юм бэ? Ямар нэг учир байна» гэж бодсоор явтал гэрийнхээ гадаа ирснээ мэдсэнгүй.

Бат морьдоо шон дээр уяд гэртээ орж ирэхэд Аяанаосу хээрийн ширээнийхээ ард суугаад ямар нэг юм бичиж байлаа. Ахлагч дэслэгчийн ширээний өмнө сөхрөөд өврөөсөө нэгэн бичиг гаргаад,

- Ноён даргаа, маргааш өглөө бүх айлуудыг түлээнд явуулна. Би айлуудын хуваарийг гаргачихсан гэж хятадаар тайлбарлаад бичгээ өглөө. Аяанаосу ахлагчийн бичгийг авч үзээд,

- Чи өөрөө аль хэсгийг удирдаж явах юм бэ? гэлээ.

- Та юу гэж айлдана түүнийг би дагах ёстой шүү дээ.

- Тэгвэл маргааш өглөө шийдье. Харин та манайд хоноод өглөө саналаа хэлнэ биз гэхэд ахлагч,

- Би танай хот айлуудаар хоноод өглөө таныг дуудангуут давхиад ирнэ гэхэд Аяанаосу түүний саналыг зөвшөөрлөө.

Өдөржингөө малгайлан орсон цас маргааш үүрээр зогсож, тэнгэр цэлмэж тогтуухан өдөр эхлэв. Саяхан орсон цас эргэн тойронд нэлмийн цайрагнаад өвлийн цонхигор наранд гялтганан цавцайна. Ахлагч Сэтэвийн хотод хоноод өглөө эртлэн босож, барга айлуудаас хайлаас түүх хүн хүч, унаа унаш хуваарилаад, айлуудыг хөдөлгөх гэж гүйсээр байгаад гэртээ харьж чадсангүй. Ийнхүү хайлаасанд явсан хүмүүс үд өнгөрөөгөөд үхэр тэргэнд хайлаас ачиж байтал тэнгэрийн алсын хаяа бударч, удаж төдөлгүй хуйсагнасаар цасан шуурга тавьж эхлэв. Аяанаосу, Батааг түүсэн хайлаасаа ачаад хөдлөх гэж байхад Солонгоотой уулзаж урьдчилан тохирсноор ажлаа зохицуулахыг сануулаад Батааг дуудаж,

- Наадуулаа явуулчих! Солонгоо та хоёр надтай явна гэхэд Бат яндан хээр мориндоо дөрөөлөв. Тэр гурав Хайлааст голыг хэсэгхэн бургасанд орж иртэл шуурга ширүүсэх янзтай боллоо.

- Солонгоо Бат та хоёр эндээ үлдээд хүлээж бай! Би ахлагчтай хамт ирнэ. Тэд энүүхэнд хайлаас түүж байх ёстой. Айлчид маань олуулаа ирвэл барааны газраас мэдэгдэлгүй дагаарай гэж хэлэхэд Бат, Солонгоо руу сүрхий харлаа. Бат учир үл олдох битүү үгэнд гайхсан болохоор Солонгоо түүний царайг ширтэн зогсохдоо,

- Би чамд аяар учрыг нь хэлж өгье гээд Хайлааст гол руу эргэхэд Бат түүний хойноос дагалаа. Аяанаосу, Солонгоо Бат хоёроос холдон салхи уруудан шогшуулсаар ахлагчийн хэсэг дээр ирлээ. Ахлагч Аяанаосуг тосон уулзаад,

- Ноён дэслэгчээ, мөн сүрхий салхи аа. Бид ямар ч гэсэн шуурганаас өмнө амжаад түүсэн хайлаасаа аччихлаа гэхэд Аяанаосу,

- Ахлагчаа наадуулаа ачаалж хөдөлгөөд Батаагийн хэсэг дээр очоорой. Би чамайг тэнд хүлээж байя гээд цагдаа цэргүүдтэй уулзаж баргуудаас болгоомжтой байхыг сануулав. Аяанаосу нэгэн жижиг манхны араар тойрч эргэнгүүт ахлагчийг амдан тослоо. Чингээд арав гаруй мөч өнгөрч байтал цасаар будран манарсан шуурганд нэгэн бараан дүрс тодрон ойртож буйг мэдээд Аяанаосу түүнийг угтан очлоо.

- Ноён дэслэгчээ, та төөрчихөө юү гэж ахлагч Аяанаосуг танингуут асуулаа. Нүүрээ ороолтоор таглан боосон ахлагчийн дэргэд ирсэн Аяанаосу энгэрийнхээ цасыг гөвөх зуур,

- Ахлагчаа, шуурга ширүүсээд замынхаа баримжааг алдчихлаа. Тэгээд таныг олох гэж будилж явна гэлээ.

- Энэ манхны цаад руу Сэтэвийн хот бий гэхэд Аяанаосу,

- Ахлагчаа, та бид хоёр Ёоши саныг тосож уулзана. Өнөө мухар манхан хаана байна вэ? Түүний ойролцоо хүлээж байх ёстой юм гэлээ. Одоо цагаан гэгээ тасрах дөхөж байна шүү. Харанхуй болчихвол хоёулаа төөрөөд амиа алдана.

- Бид хоёр үдээс хойш 16 цагт уулзах ёстой. Одоо арван таван цаг хагас болж байна гэхэд ахлагч амандаа ямар нэг юм бувтнаад өнөө Мухар манхан руугаа чиглэв. Ахлагчийг энэ манхны дэргэд буух гэхэд Ёоши зөвшөөрөөгүй ажээ. Явган шуурга үе үе ширүүсэж, дагтаршиж гүйцээгүй цас салхины аясаар шороо шиг хуйлран босож, цагаан манан

тагуулсаар эгшний төдийд эрчлэн тэнгэр өөд олгойдон, сэтгэл сэртхийлгэм шуугин исгэрч, тэнгэр газрыг холбон шуурна. Аяанаосу ахлагчтай хамт Мухар манхан гэж урьдчилан багцаалсан жижиг толгодын дэргэд ирж Хайлаастын зүг ширтэнэ. Хайлаастын цаад эрэгт цасан шуурга будран манантаад сэтгэл сэрхийлгэм шуугин исгэрэхээс өөр чимээ ер дуулдах аргагүй агаад торойх ч бараагүй ажээ. Өвлийн ахархан өдөр дуусч, үдшийн бүрий эхлэх дөхжээ.

- Ноён дэслэгчээ, бид хоёр зөрчихсөн байхаа. Ямар ч бараа харагдахгүй байна шүү дээ.

- Одоо ингэсхийгээд гараад ирэх байхаа гэж Аяанаосуг хэлтэл Хайлаастын цаад эргээс хоёр хүн ирж яваа нь шуурганд бараантан сүүтэгнэнэ. Аяанаосу мориноосоо буухаар завдахад ахлагч, түүнийг тосон буулгахаар мориноосоо үсрэн буулаа.

- Ахлагчаа өнөөдүүл маань ирж явах шиг байна гэж Аяанаосуг хэлтэл ахлагч голын цаад эргийн хайлаас руу хараад,

- Нээрэн тийм байна. Хоёулаа яваа юм уу даа гэх тэрхэн зуур Аяанаосу ахлагчийн түүшинд хүчтэй буулгах нь тэрээ. Чухамхүү үүнийг ажиглаж байсан Бат, Солонгоо хоёр зэргэлдээх хонхроос гарч ирээд ахлагчийг ягштал баглаад хонхор руу чирч аваачаад Бат буцаж ирлээ. Бат, Аяанаосу хоёр Ёошийг тосон зогсоход тэрээр дэргэд нь ирээд мориныхоо амыг татахад Бат түүнийг тосон буулгахаар хажууд нь очив. Ёоши мориноосоо буугаад цулбуураа Батаад өгөөд Аяанаосугийн хажууд очлоо. Тэгээд мэнд амраа лавлаж байх тэрхэн зуур Бат Ёошитой хамт ирсэн цэргийн дэргэд зогсоод Аяанаосугийн дохиог хүлээж байв. Тэр зуур Аяанаосугийн баруун гар гялсхийх шиг болж Ёоши чухам юу болж байгааг ухаарах сөхөөгүй газар писхийн уналаа. Чухам энэ үед Бат, өнөө цэргийг эмээл дээрээс нь татан унагав. Тэр цэрэг газраас өндийнгүүтээ гайхсан нүдээр Аяанаосуг харж, алмайрч буй тэрхэн зуур Аяанаосу түүнийг дэлсэн унагав.

- Батаа наадуулаа баглачих гээд халааснаасаа нарийн хялгасан дээс гаргаж өглөө. Ёоши ухаан орсон боловч юу болж буйг мэдэх сөхөө байсангүй. Аяанаосу дөрөв нугалсан хялгасан дээс гаргаж түүний гарыг ягштал хүлээд нэгэн бичиг гаргаж, энгэрийн нь халаасанд хийгээд «За ингээд болох нь тэр» гэж өөртөө сануулан хэлэхэд Ёоши хяламхийсэн муухай харцаар Аяанаосуг хорсолтой ширтээд амандаа ямар нэг юм үглэнэ.

Хилийнхэн Ёошийг баривчилсны дараа түүний энгэрээс Аяанаосугийн бичгийг олж аваад удирдлагадаа мэдэгдэх ёстой. Чингээд хэдэн цагийн дараа хил дээр гарсан хэргийн талаар төвд мэдэгдэх ажээ. Ингээд төв Аяанаосугийн бичгийг задлан шинжлээд өгүүлбэрт орсон үгийн дэс дараа бичлэгийн хэлбэрээр нь Аяанаосу хэмээх Гунгаагийн бичгийн учрыг түвэггүй гадарлах боломжтой. Чингэж Ёошийг баривчилсны дараа хэд хоноод төвөөс албаны хүмүүс ирж уулзаад түүний баригдсан явдалд Аяанаосу холбогдолгүй болохыг нотолсон баталгаа гаргах сөрөг ажиллагаа зохион байгуулах ёстой байлаа.

Аяанаосу баривчлагдсан гурваа тус бүрийнх нь морины эмээл дээр түрүүлэг нь харуулж хэвгүүлэн баглаад Бат, Солонгоо хоёрт хөтлүүлэн хилийн харуулын байрны наад манхан руу явуулахдаа өөрөө дөхүүлж өглөө.

Цасан шуурга ширүүсэн бударч, нүүр нүдгүй шавхуурдах тул хоёр гурван алхмын цаад юмс цагаан мананд цайрагнаад үл харагдах ажээ. Аяанаосу газрын баримжааг ажиглан Хайлааст голын хэсэг бургаснаас зайдуухан байдаг нэг манхны ойролцоо ирэнгүүт мориныхоо амыг татасхийн зогсоогоод Солонгоог дуудлаа.

- Солонгоо, энэ толгойн цаад өндөрлөгт хилийн цэргүүд байгаа. Та хоёр энэ гурвыг аваачаад тэдний ойролцоо орхичихоод ир! Би энд хүлээж байя гэлээ. Бат, Солонгоо хоёр, гурван бээр хэртээ холдоход Аяанаосу тэднийг барааны зайтай дагана.

Тэр хоёр цасанд дарагдсан жижиг толгойн дэргэд мориноосоо бугаад баривчлагдсан хүмүүсийн хүлгийг чангалаад тэдний морьдыг тушлаа. Бат, Солонгоо хоёрыг эргэж ирэхэд Аяанаосу болзсон газраа зогсоод дурандаж байв. Шуурга намдаж тэнгэр цэлмэх янз орсон болохоор цагаан гэгээ тасарч байгаа ч гэсэн барааны газрын юмс танигдах ажээ. Цасан толгойн баруун талаас морьтой хоёр хүн гарч ирээд Бат, Солонгоо хоёрын үлдээсэн морьдын зүг шогшуулж байгаа харагдлаа.

Ийнхүү олзлогдсон гурвыг хилийн цэргүүд аваад явахыг ажиглан зогсож байсан гурав хот айлын зүг бөг бөг шогшуулахдаа болсон байдлыг баяр бахархал болгон хөөрнө. Тэд хот айлд ирэхдээ бие биенээсээ цуварч очлоо. Гэсэн ч энэ бүхнийг хот айлынхан анзаарсангүй. Тэд ирээд ахлагчийг ч сурагласангүй. Харин маргааш өглөө нар дээр хөөрчихсөн байхад нэг цагдаа ахлагчийн хот айлуудаас яаруу сандруу ирж Аяанаосутай уулзлаа.

- Ноён дэслэгчээ ахлагчийн авгай манай хоёр цагдаа цэргийг алчихсан гэж арай ядан хэлэхэд Аяанаосу суудлаасаа босоод,

- Юу гэж гайхан асуулаа.

- Тэр авгай хоёр хүүгийнхээ амыг бариад дараа нь өөрийгөө алчихсан байна. Тэгэхдээ хоолойгоо тас огтолжээ гэж хэлэхэд Аяанаосу хувцаслаад гэрээс гарлаа.

Аяанаосу ахлагчийн хотод ирэхэд цагдаа цэргүүд ахлагчийн гэрийн гадаа бөөгнөрсөн агаад барга айлуудаас хэнийг ч гаргахгүйн тул гэрүүдийн үүдэнд нэжгээд цагдаа зогсоосон байлаа. Аяанаосу ахлагчийн гэрт орж ирээд үүдний баруун хаяанд зогсож байдлыг ажиглав.

Аяанаосу гэрт болсон байдлыг ажиглан гэмт хэрэг хэрхэн үүссэнийг тодорхойлж, дэргэдээ байсан цагдаа цэрэгт хэлж бичүүллээ.

Аяанаосу гэрийн хоймрын ширээний дэргэд хэвтэж байгаа таван хоосон шил, мах ногоо тэргүүтнийг харж зогсохдоо ингэж уусан хойно мал шиг ухаан алдалгүй яахав. Үүнийг нь ахлагчийн хүүхэн ашиглаад өшөө хорслоороо амь насанд нь халдаж бүрэлгээд зогссонгүй амьд үлдэж болохгүй гэдгээ сайн ойлгож дээ гэж бодлоо. Аяанаосу, гэрийн зүүн хаяанд байгаа орны урдуур ундуй сундуй хэвтэж буй хоёр цагдаагийн үхдэлийг ажиглан зогсохдоо халааснаасаа цаас авч хэдэн үг татлан бичээд битүүмжлэн наагаад,

- Үүнийг аваад Авдар нуурын сууринд оч. Тэндхийн ахлагчийн гэрт Симото байгаа. Түүнд өгөөд ир гээд дэргэдээ байгаа нэг цагдаад өглөө.

Аяанаосу, бүдүүн ахлагчийн тавинд суулгасан цагдаа нарыг цуглуулж яриа хийгээд барга айлуудаас ямар ч хүн гаргаж болохгүй гэж чандлан тушаагаад ахлагчийн гэрийн үүдэнд манаа гаргалаа. Тэгээд бас нэг цагдаа цэргийг дуудаад,

- Сэтэвийн хотонд байгаа ахлагчийг олоод ир! Зам зуураа ямар ч үг цухуйлгаж болохгүй гэж тушаалаа. Аяанаосу чингэж зохион байгуулахдаа Симотогийн сэжиглэж болох бүхнийг өө сэвгүй тохируулахыг хичээнэ. Чингээд үд өнгөрснөөс хойш Симото өөрийнхөө дагуулуудын хамт ирлээ. Симото ахлагчийн гэрт орж ирээд гэрийн баруун хаяанд зогсож байхдаа япон цагдаануудын үхдэлийг хараад зэвүүрхсэн янзтай ярвайна. Үнэхээр Симотогийн голоор хүйт оргиж, сэтгэлд нь «Эм хүний сэтгэл шулуудахаар юу ч хийж чаддаг гэдэг үнэн юм байна даа. Хоёрын хоёр эр хүн, нэг муу эмийн гарт үрэгддэг байна шүү» гэж бодоод сэтгэл нь арзасхийх шиг боллоо.

Симото ингэж зэвүүрхсэн нэг шалтгаан бол Ёошигийн хойноос сэтгэл зовсны уршиг байлаа. Ёоши өчигдөр Симототой радио холбоо барихдаа «Би одоо Аяанаосугийн хот айлууд руу очиж ажлаа зохион байгуулна. Хайлаастын зүүн хэсгийн газар нутгийн байр зүйн тодруулалтын ажил бүтэмжтэй явж байна. Тиймээс одоо дэслэгчийн шавь нарын ажлыг тохируулах хэрэгтэй. Хилийн цэргээс баривчилж тактикийн ач холбогдолтой өндөрлөгүүдийн нэрийг тодруулж хуучин зургийн нэртэй харьцуулаад танд мэдэгдэнэ» гэж билээ. Гэтэл Аяанаосугийн хот айлд Ёоши ирээгүй болохоор Симотогийн зүрх шимширчээ.

Симото гэрээс гарч ирээд ахлагчийн хот айлуудын байр байдлыг

ажвал айлуудаас ганц ч хүн цухуйсангүй бололтой. Хот айлын цөөн тооны мал цан хүүрэгт хучуулан түнтийгээд хэвтэртээ шуухинана. Хот айлууд өвс тэжээл тарчигхан болохоор хөхөө өвлийн нүүдэлд эцсэн мал тарга хүчээ бараад хэвтрээсээ өндийх чадалгүй болсон мэт. Симото хотонд байгаа бээцийсэн малыг хараад өөрөө амь голтой үлдсэн юм шиг санагдаж «Армийн удирдлагад юу гэж илтгэнэ» гэж бодохоос сэтгэл нь харанхуйлаад, цавцайсан цагаан цасан дунд зогсож байгаа биш харин үхлийн харанхуй ангальн ирмэг дээр зогсож байгаа юм шиг санагдана.

Симото өөрийнхөө сэтгэлийн түгшүүрийг тайвшруулахыг хичээхдээ нүдээ аньж, толгойгоо сэгсэрснээ мэдээд Аяанаосуд эвгүй сэтгэл төрүүлэхгүйн тулд,

- Чи Ёошитой уулзсан уу гэж бодлогоширч, гайхаш тасарсан байдалтай асуухыг ажигласан Аяанаосу дотроо "Симото, Ёошийг сураггүй болсныг гадарлажээ. Ингэхээр өчигдөр энд ирнэ гэдгийг мэдэж байсан байх нь" гэж бодоод,

- Бараг тав хоногийн өмнө Авдар сууринд уулзсан. Би шөнө өөрөө гаргаж өгсөн гэж түгдрэлгүй хэлэв.

- Ёоши, танайханд хэзээ ирнэ гэсэн бэ? Энд ирснийх уулзаад явъя.

- Надад тоймтой юм хэлээгүй. Ер нь ажлаа гүйцээгээд ирнэ байх гэж бодож байна гэхэд Симото сэтгэлдээ "Ёоши ирэх хугацаагаа хэлээгүй болохоор ажлынхаа хуваарийн нууцыг алдаагүй хэрэг! Тэгэхээр Ёошийг өчигдөр энд ирэх ёстойг хэн ч урьдчилж мэдээгүй байна.

Харин ахлагч яагаад алга болов? Энэ тохиолдол уу? Эсвэл нарийн зохион байгуулсан урван тэрслэх ажиллагаа юу" гэж бодлоо.

- Аяанаосу сан. Өчигдөр ахлагч ямар ямар хүмүүстэй явсан бэ?

- Өөрийнхөө хот айлын гурван хэсэгтэй явсан шүү.

- Та нар хаанаас түлээ түүсэн бэ?

- Хайлаастын наад манхнаас түлээ түүх хуваарийг ахлагч гаргасан юм. Бид хуваарь ёсоор нь ажилласан гээд энгэрийнхээ халааснаас ахлагчийн бичсэн бичгийг гаргаж өглөө. Симо то түүнийг хэрсүүхэн үзээд,

- Энэ хуваарьт ахлагч өөрөө ямар хэсэгт ажиллахаа бичээгүй юмаа?

- Би наадахыг чинь үзээд «Чи аль хэсэгт явах юм бэ?» гэж лавлахад «Би өөрийнхөө хэсгийг авч явъя» гэсэн юм. Симо то энэ өдөр ахлагчийн хот айлын хөгшчүүлтэй уулзаж, ахлагчийн талаар сураглав. Гэтэл тэдний дотроос ахлагчаа хайчсаныг ажигласан хүн байсангүй. Харин нэг хөгшин Симо тоод санамсаргүй нэг зүйлийг ярилаа.

- Би хайлаасаа үхэр тэргэнд ачаад хөдлөх гэж байтал ахлагч маань миний үхэр тэрэгний дэргэд ирээд «Та түрүүлээд явж бай!» гэлээ. Би гэрээ эртхэн бараадах нь гэж бодоод хөдөлтөл нэг хүн ирж ахлагчтай уулзлаа.

- Ямар хүн байсныг ажигласан уу?

- Юун ажиглах манатай. Шуурга нүүр нүдгүй балбаж байсан үе. Би ч ноён дэслэгчийг байх гэж бодсон.

- Хувцас нь ямаршуухан байсныг санаж байна уу?

- Монгол дээлтэй хүн байсан шиг санагдаж байна. Лав цэргийн хувцасгүй байсан. Би гэр рүүгээ явж байхдаа «Ноён дэслэгч монгол дээл өмсдөг байхдаа» гэж бодсон юм. Би шуурга уруудаж явсан болохоор шуурганы сөрөг яаж харах билээ. Өчигдрийн шуурга ямар байсан гэж санана! гэж өвгөн үглэв.

Симо то, ахлагчийн хот айлуудад тарж суусан цагдаа нартай уулзаж, тодруулах зүйлээ нягталж гүйцээд Аяанаосугийн байдаг хот айлууд руу хөдлөхөөр завдаж байхдаа,

- Аяанаосу сан, ахлагчийн гэрийг өнөө шөнө шатаалгачихсан дээр. Барга айлууд энэ бузар хэргийг мэдвэл цагдаа нарыг хорлохыг бодох нь зайлшгүй. Харин шатаачихвал өөр хэрэг. Задгай галд архи уусан согтуу хүмүүс осолдсон байна гээд акт тогтоочихвол сэжиггүй өнгөрнө.

Харин барга айлуудад тулганд шөнө гал түлэхдээ сонор сэрэмжтэй байх талаар тусгай заавар өгөх нь чухал гээд Симо то машиндаа суухдаа,

- Чи надтай хамт явна биз дээ гэлээ. Аяанаосу, унаж явдаг тарган хээр морио цагдаа цэрэгт өгөөд суудлын тэрэг рүү эргэхэд эмээлийн нь ганзаганд байгаа том цүнхийг сэжиглэн харж байсан Симото эчнээндээ «Энэ цүнхэнд дээл байгаа юм болов уу?» гэж бодоод,

- Аяанаосу сан, хөл хучих үстэй дээл байна уу? Миний тэргэнд яггүй хүйтэн байна шүү гэлээ.

- Би хүйтнийг тоодоггүй хүн шүү. Тэгээд ч монгол дээл хувцас өмсөлгүй олон жил болчихлоо. Дээл өмсөхөөр тал талаараа сийгээд байх шиг санагддаг. Ер нь энэ маань хамаагүй дээр гэж дарга хувцас руугаа заалаа.

- Шуурганд наадах чинь бие халхалж чадаж байгаа юмуу даа. Би чинь үстэй дээлийг илүү дулаан гэж боддог гэж Симотоог хэлэхэд гутлынхаа цасыг арилгаж байсан Аяанаосу суудлын тэргэнд суулаа. Чухам энэ үед Симото дэргэдээ сууж байсан туслах руугаа нүдээр ирмэж дохио өгөхөд хошуучийнхаа санааг ойлгосон туслах суудлын тэрэгнээс гарлаа.

Токиогийн "Тоёото"-гийн үйлдвэр хөдөлгүүр хийдэг боловч энэ жил анх удаа машин үйлдвэрлэжээ. Тэгээд армийнханд хэдэн суудлын тэрэг ирсний нэгийг Уэда тагнуулын хэлтэст олгосон. Тэгээд түүнийг Симото эзэгнэж байгаа нь энэ. Симото Жанжин сүмээс ирсэн болохоор нэг ачааны машин цэргээр хамгаалуулсан болой. Нөгөө талаар тэр ачааны машин суудлын тэрэгний өмнө явж зам гаргах үүрэгтэй. Аяанаосуг суудлын тэргэнд суусны дараа ачааны машин түрүүлж хөдлөв. Симотогийн тэргийг хөдлөх гэж байхад нэгэн цагдаа үстэй дээл авчирч өглөө. Чингээд Аяанаосу, Симотогийн хөлийг үстэй дээлээр хучаад Сэтэвийн хот руу хөдлөв, Симото хөлөө хучуулж, тухлан сууснаас хойш ганц ч үг дуугаралгүй элдвийг бодон тэрэгний цонх руу ширтэнэ.

...Ёоши яагаад алга болов? Бас тэр ахлагч сураггүй болдог. Тэр лүд Ёошийг барьж хилийнхэнд тушаасан хэрэг үү, сонин юм. Аяанаосу, ахлагч хоёр хуйвалдсан юм болов уу? Дэслэгч ахлагчтай ганзага нийлүүлэх хүн биш! Тэгээд ч Ёошигийн ирэх өдрийг мэдээгүй. Тэгэхээр үүнийг санаатай зохион байгуулсан хэрэг гэж үзэх үндэсгүй. Яах вэ? Энэ бүхний учрыг нарийн тунгааж олохгүй бол Уэдагийн гараас мултрахгүй.

Тэгээд ч Тозияа намайг хамгаалахгүй байж мэдэх хүн. Жанжин штаб шинэ оны эхээр Халх голын сав газрын байр зүйн тодруулалтыг дуусгасан байх хэрэгтэй гэж тушаасан. Хугацаандаа дуусгахгүй бол хариуцлага хүлээлгэнэ гэж хангинаад байгаа. Одоо Ёошийг сураггүй алдсан болохоор бүүр толгойгүй гэсэн үг! Яах вэ?...

Симото чингэж бодсоор яваад Батаагийн хот айлд ирж Аяанаосугийн байгаа гэрт бууж, Бат Солонгоо хоёрыг өөр айл руу явуулав. Тэгээд хэдэн цагдаатай уулзаж түлээ хэрхэн түүснийг асууж тодруулав. Гэсэн ч Симотогийн сэжгийг батлах баримт гарсангүй. Симотогийн туслах Аяанаосугийн эмээлийн ганзаганд байсан цүнхийг шалгаад дотроос нь чанасан мах, дарсан ногоо, архи олжээ. Симото Батын байдаг цагдаатай уулзаж ярилцахдаа,

- Аяанаосу өчигдөр ямар хувцастай явсан бэ? гэж асуухад,

- Ноён дэслэгч дүрэмт хувцаснаасаа өөр хувцас өмсдөггүй хүн гэж нотлов. Гэтэл бас хоёр

цагдаа түүний үгийг баталлаа. Симото газар нутгийн байр зүйн тодруулалт хийж байгаа хэсэг дээр гарсан хэргийг судалж гурав хонолоо. Симото энэ хэд хоногт Монголын хилийнхнээс ямаршуухан дуулиан дэгдээх бол гэж бодоод сэтгэл тавгүй. Симото байдлыг эргэцүүлэн тунгааж, ямар нэг сэжигтэй баримт олохгүй болохоор муу санаандаа Аяанаосуг сэрдэнэ. Хэрвээ Аяанаосугаас өөр хүн энэ хэсгийг удирдаж байгаад ийм хэрэг гаргасан бол Симоги ингэж сэрдэхгүй байсан. Тиймээс Симото сэтгэлдээ «Би үүний жинхэнэ тарыг таньж чадалгүй өнгөрсөн юм биш биз.

Харбин, Синьзин хил дээрх ажиллагаанууд яагаад бүтэлгүй тийшээ эргээд байна вэ? Энэ бүхэнд Аяанаосу ямар нэг битүү замаар дам холбогдоод байгаа юм шиг санагдаад байдаг сонин оо. Ёошийг энэ золиг хилийнхэнд барьж өгөх ажил зохион байгуулсан бол монголынхон тагнуулаа сэжиглүүлэхгүйн тулд дуугүй өнгөрнө. Ёошгийн талаар ямар нэг сэжиг авахуулахгүй, эсэргүүцэл илэрхийлэхгүй битүү өнгөрвөл битүү хэргүүдийн учгийг олох сэжим гарч мэднэ шүү. Аяанаосугтай энэ хэрэг огт холбоогүй бол монголын хилийнхэн үүний өмнө баригдсан хүмүүсийг буцаан өгдөг шигээ өгнө. Хэрвээ барга айлуудын ахлагч урваж манай ажиллагааны нууцыг задалсан бол хилийнхэн барга айлуудыг нүүлгэх шаардлага тавина» гэж үзлээ. Симото өөрийнхөө бодлыг чингэж тунгаагаад тав хонож байтал нэг өглөө цагдаа цэрэг Симолагийн гэрт орж ирээд,

- Шиү са доноо (Ноён хошууч аа), монголын хилийн цэргүүд ирж явна гэж илтгэлээ. Энэ үг Симолагийн зүрхийг зүүгээр шивэх боллоо.

- Дэслэгчээ, таны шавь нар монголын хилийн цэргүүдтэй тун эелдэг харьцдаг юм байна. Ер нь юу хийх гэж энд ирсэн юм бэ? гэж омогдоход,

- Шиү са доноо, та хувцсаа солих хэрэгтэй. Хилийнхний дэргэд армийн ахлах даргын хувцастай байж болохгүй. Квантуны армийн ахлах дарга нар барга айлуудаар сууж, тагнуулын ажиллагаа явуулж байна гэдэг яриа дэгдэнэ. Ийм эгзэг гаргаж болохгүй гэж штабаас тушаасан. Нөгөө талаар Ёошигийн ажил дуусаагүй болохоор хилийн цэргээс барьж, барьцаалах гэдэг осолтой. Бид хилийн цэргийг барьж Ёошигийн ажилд хэрэгтэй газар нутгийн нэрийг хэлүүлж авах ёстой. Гэтэл ажил маань дөнгөж эхэлж байна.

Нөгөө талаар хилийн цэргийг барилаа гэхэд удааж болохгүй. Тэгвэл барга айлуудыг зуднаар ирсэн гэж үзэхгүй. Армийн түлхээсээр тагнуулын зорилгоор орж ирсэн гэж үзэх болно. Тэгээд энэ асуудлыг засгийн газартаа уламжилбал тэд эсэргүүцлийн нот бичиж Манж го болон манай засгийн газарт гардуулбал сайд нарын танхимынхан бидний ажиллагааг мушгин гуйвуулж шуугиан дэгдээх болно гэж ажил үүргээ сайн мэддэг тагнуулч хүн шиг илтгэв.

Аяанаосу шавь нараасаа арваад хүнтэй ирж барга хувцсаар хувцаслаад айлуудаар суулгасан. Тэд дэслэгчийн заавраар хилийн цэргүүдтэй үг сөргөж, хэрүүл үүсгэх бөгөөд маргалдааны явцад нударган зодоон үүсгэж, хилийн дарга, цэргээс баривчлах буюу зэвсэгт мөргөлдөөн гаргах эгзэг бүрдүүлэх ёстой. Симото, дэслэгчийн үгийг сонсоод цаг үеийнхээ байдлыг сайн мэдэж, өөрийнхөө ажилд гярхай ханддаг, овжин ухаалаг зангий нь хэзээ хэзээнээс мэдэх тул энэ удаа түүний зөвлөснийг хүлээн авч монгол дээл өмсөхөөр шийдлээ. Аяанаосу орны дээд талын шүүгээн дээрээс цүнхээ авч уудлаад сэгсүүргэн дотортой хүрэн одончуу дээл гаргаж Симолагид өгөхөд «Энэ дээлийг мань эр өчигдөр өмссөнийг хэн ч мэдээгүй өнгөрчээ.

Түүнээс монгол дээлээр энэ яах вэ? Ёстой гэнэ алдана гэдэг ч боллоо доо» гэж бодоод сэтгэлдээ баярлангуй байлаа.

- Дэслэгчээ, энэ дээл чамд аль зэрэг зохидог вэ? Ер нь сайхан дээл байна шүү гэж Симото үгээ цэнэж хэлтэл Аяанаосу,

- Ёоши сан надад хийлгэж өгсөн юм. Би мөрөндөө углаж үзээгүй шүү гэхэд Симото сэгсүүргэн дээлийг нь авч үзлээ.

- Нээрээн тийм байна. Анхны нь нугалаанд сэв ороогүй байна гэж хэлэхдээ өөрөө гэнэ алдан Аяанаосуг хардан сэрдэж байгаага илчилж орхисноо гадарлав.

- Аяанаосу сан, чи хилийнхнийг авч уулз! Чамайг цагдаа хувцастай болохоор сэжиглэхгүй байх. Юуны өмнө тэдний үг яриаг сонсох нь чухал гэж зааварлалаа. Аяанаосу монголын хилийнхнийг албан ёсоор хүлээн авч, харин Симото болон түүний туслахыг монгол дээлээр хувцаслаж, өргөн бүс бүслүүлэв. Хилийнхэн арван гурвуулаа ирлээ. Хилийн цэргийн ахлагч, орчуулагч хоёроос бусад нь цэргүүд ажээ. Хилийн харуулын ахлагч Аяанаосутай уулзангуут,

- Барга айлуудын ахлагч, мөн цагдаагийн ахлах дарга нартай уулзмаар байна гэхэд Аяанаосу, хилийн цэргийн ахлагч, орчуулагч хоёрыг гэрт урилаа. Тэднийг гэрт ороход Симото түүний туслах, Бат, Солонгоо нар бараа боллоо.

- Тав хоногийн өмнө квантуны армийн дарга Ёоши, Хируса, барга айлын нэг ахлагч нарын гурван хүн манай хилийн гүнд орж ирсэн юм. Ёоши, Хируса хоёр бол манай улсын эсрэг тагнуулын ажиллагаа хийж байсан байна. Тиймээс барга айлууд хорин дөрвөн цагийн дотор нүүж гарах ёстойг албан ёсоор мэдэгдье гэхэд Аяанаосу,

- Манайханд тийм нэртэй хүмүүс байхгүй. Нөгөө талаар барга айлууд зуданд эрсдэж танай нутагт өвөлжихөөр орж ирсэн нь үнэн. Харин улс төрийн ямар ч бодлого өвөрлөөгүй. Эд нар чинь айл зэргэлдээх ураг удмынхаа ёс төрийг хүндэлдэг энгийн хүмүүс шүү дээ.

- Ноён дэслэгчээ, ямар ч баталгаагүй ийм үгээр мэлзэх хэрэггүй. Тэгээд ч ёс зүйд таарахгүй.

- Энд ямар нэг санамсаргүй эндүүрэл болсон байна. Түүнийг барга айлуудын зовлон зүдгүүрээс ялган салгаж ойлгох нь чухал. Одоо айлуудыг нүүлгэнэ гэдэг тун хүнд асуудал. Тиймээс барга айлуудад хэн хэн маань энэрэнгүй үзлийн үүднээс хандах ёстой. Харин бидний хувьд гэвэл бид айлуудын аюулгүй байдлыг хамгаалж тайван байлгах үүрэгтэй. Тэгэхээр олон хүмүүсийн санаа сэтгэлийг харгалзах болно. Эд нар нүүхгүй гэвэл бид тулган шаардах эрхгүй. Тиймээс айлуудын саналыг асуу гэж Аяанаосуг хэлэхэд Симото дотроо «Энэ золиг ийм овжин эр шүү. Ер нь яггүй дипломат хүн шиг урсгаж байна» гэж бодлоо. Гэсэн ч Симото Ёошигийн нэрийг сонсоод бараг ухаан балартсангүй. Тэгээд нөгөө өвгөний үгийг санаад «Ёоши Хируса хоёр монгол дээлтэй явсан хэрэг байх нь» гэж бодлоо.

- Ноён дэслэгчээ, бид барга айлуудыг хамгаалах нэрээр цагдаа цэргүүд хилийн дотор орж ирсэн гэж үзэхгүй. Квантуны армийн тагнуулын газрын даалгавартай хорлон сүйтгэгчид гэж үзэх болно. Үүнийгээ бид баталж чадна. Нэг баримт дурдахад Ёоши бол дэд хурандаа цолтой,

урьд өмнө японы армийн жанжин штабт ажиллаж байсан. Олон жилийн өмнөөс монголын газар нутгийн байр зүйн холбогдолтой материал судалж байгаагаар хүлээсэн. Мөн ноднин жил Хасан нуурын орчим газар орны байр зүйн зургийг хийх ажилд оролцож байсан нь илэрхий болсон. Мөн гурван жилийн өмнө Тамсаг булаг гэдэг газар түүний даалгавраар ажиллаж байсан нэг туршуул баригдсан. Энэ хүн бол захын Дэ вангийн хошуунаас оргож Дэ вантай хамт Хайларт очиж тэндхийн хүмүүсийн даалгавраар буцаж ирсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн.

- Үүнийг бид мэдэхгүй! Нөгөө талаар баригдсан хүмүүстэй бид уулзах ёстой. Түүний дараа армийн удирдлагад энэ эндүүрлийн талаар илтгэх болно.

- Баригдсан хүмүүстэй уулзах асуудлыг бид мэдэхгүй. Тэд тагнуулын ажиллагаа явуулах удирдамжийг квантуны армийн удирдах ажилтан Уэда, Тозияа, Симото гэдэг хүмүүсээс авч ажиллаж байсан нь баталгаатай зүйл шүү. Эцэст нь хэлэхэд бид танайхаас Буянт гэдэг хүнийг манайд тушаахыг шаардаж байна.

- Манайд тийм нэртэй хүн байхгүй. Нөгөө талаар бидэнд зуднаас нүүж ирсэн барга айлуудын нэрийн жагсаалтыг гаргасан. Түүнд Буянт гэдэг хүний нэр байхгүй. Та нар нэрсийн жагсаалттай танилцаж болно.

- Ноён дэслэгчээ, Буянт гэдэг тэр хүн хэдэн жилийн өмнө оргосон дээрэмчин бөгөөд одоо квантуны армийн тагнуулын газарт Аяанаосу гэдэг нэрээр ажиллаж байгаа төдийгүй одоо ч та нарын дунд ажиллаж байгааг Ёоши бүрэн баталж чадна гэхэд Симото хилийн цэргийн ахлагчийн үгийг сонсоод бараг багтарч үхсэнгүй. Тэрээр бүх зүйлээ балрах зам руугаа орсныг мэдээд «Ёоши муу урвагчийг хараач! Өөрийнхөө турсагыг аврахын тулд армийн нууцыг цөмийг нь тоочдог байна шүү! Түүнийг өөрийнхөө гараар устгах юмсан» гэж бодоод уурандаа байж ядаж байлаа. Харин Аяанаосу хэмээгдэгч Гунгаа, хилийн цэргийн ахлагчийн үгийг сонсоод сэтгэлдээ баяртай байлаа. Түүний бичсэн захиа төвийн удирдлагад хүрсэн учраас төв Гунгаагийн цаашдын ажиллагааг сэжиглүүлэхгүйн тулд Симотогийн сэтгэлд үлдэж болох сэжгийг чингэж арилгах ёстой байсан билээ. Симото, энэ бүхнийг сонсоод уураа барьж ядаад,

- Та бүхний шаардлагыг ноён дэслэгч дээд газраа уламжилна байх. Харин таны яриад байгаа тэр дэд хурандаа гэдэг чинь ямар хувцастай юм бэ? гэж асуусан нь сэтгэлийнхээ сэвийг шалгасан эцсийн горьдлого болохыг Аяанаосугаас үл нууна. Симотогийн энэ хачин асуултанд гайхсан хилийн цэргийн ахлагч,

- Дэд хурандаа цагдаагийн газрын хувцастай байсан. Харин Хируса барга айлуудын ахлагч хоёр дээлтэй юм байна билээ. Харин та нарт тэдний хувцас тийм их хэрэгтэй зүйл биш байхаа гэлээ.

- Бид таны ярьсан зүйлийг дээд удирдлагадаа илтгэхэд ямар хувцас хунартай, ямаршуухан хүмүүс будлиан гаргасныг тодорхойлох ёстой юм шүү. Бид таны шаардлагын хариуг хорин дөрвөн цагийн дотор өгч чадахгүй. Харин дөчин найман цагийн дараа өгөхийг бодъё гэж арга учраа тайлбарлах гэсэн шиг хэлэв.

Симото, хилийнхнийг явсны дараа Ёошийг монголын хилийн цэрэгт алдсан хариуцлагаас

мултрах эгзэг байгааг самбаачлан ухаараад Жанжин сүм рүү явахаар зэхэв. Симото задгай тулганд түлсэн галын дөл ширтэн суухдаа, хилийн харуулын ахлагчийн үгийг бодсоор "Хируса, барга айлын ахлагчтай ирж уулзсан байх нь. Ёоши болгоомжтой ажиллахын тулд түлээ ачиж байсан хүмүүс рүү Хирусааг явуулсан нь гарцаагүй хэрэг. Жанжин сүмд очоод байдлыг Уэдаад илтгэх үү? Тозияад дуулгах уу, аль нь дээр вэ" гэж өөрөөсөө асууна. Квантуны армийн командлагчид илтгэж чадвал Симото, хоолойгоороо боомилсон боомийг сулруулах талтай боловч түүнд итгэж ядна. Тиймээс Тозияад илтгэх нь илүү ашигтай байлаа. Тозияа, юу юуны туханд хүрэлгүйгээр Аяанаосуг шууд зэмлэхгүй! Тэгээд ч Тозияа өөрийнхөө толгойгоор шийдсэн зүйлээ хамгаалж чаддаг хүн. Тиймээс Аяанаосуг ямар ч нөхцөлд хамгаалж чадах болой. Тэгэхээр Аяанаосуг Тозияатай урьтаж яриулах нь зүйтэй гэж бодож байлаа.

- Аяанаосу сан, одоо хоёулаа Жанжин сүм орж байдлыг дарга нарт илтгэх үү дээ. Барга айлуудыг нүүлгэх асуудал бол чи бид хоёрын толгойноос давсан зуйл. Нөгөө талаар тэр муу урвагч Ёошигийн байдлыг яаж ойлгуулах вэ гэдгийг хоёулаа ян тан тохирох хэрэгтэй! Зөрүү гажуу юм яривал Уэдагийн дургүйг хүргэчихэж мэднэ гэж Симотоог хэлэхэд Аяанаосу,

- Тэгье. Би Хайлаастанд явуулсан байр зүйн тодруулалтын ажил буруудсан явдалд бид огт хамаагүй гэдгийг ямар ч нөхцөлд хамгаалах хэрэгтэй. Харин миний тухай хилийнхэн сураг гаргасан явдал надад эвгүй байна. Болдог бол тэр муу Ёошийг чинь өөрийнхөө гараар багалзуурдах юмсан. Ганц байцаалтанд армийн нууцыг дэлгэдэг байна шүү! Энэ бол ёстой гэмт хэрэг гэлээ.

- Би энэ бүхэнд эргэлзээд байна. Ёоши бүх зүйлийг ярьсан гэдэг тодорхой боллоо. Удам судраараа самурайн ёсыг сахисан Ёоши урваад армийн нууцыг дэлгэсэн гэхэд удирдлага яагаад ч үнэмшихгүй. Үнэмшинэ гэдэг итгэл надад ер төрөхгүй байна. Харин Ёоши тагнуулч хүний хэрсүү ухаан хэрэглэсэн бол яана! Чиний тухай ганцхан Ёоши мэднэ. Тэгэхээр Ёоши, үнэнээ хэлсэн нь төгс баталгаатай зүйл! Яагаад ингэж хэрэг улайсан бэ гэдэг тун эргэлзээтэй байна.

Симото, Аяанаосутай хэрэг явдлаа тохиролцсон нь хошуучийн сэтгэлд таатай ажээ. Тэрээр чингэж амиа хоохойлох арга замаа бэлдсэндээ баяртай байлаа. Өвлийн ахархан өдөр дуусаж, үдшийн бүрэнхий Жанжин сүмийг бүрхжээ. Арваад алхмын цаад юмс үл танигдах аж. Оройн жавар орж хүйтэн салхи тачигнан, малгайныхаа чихийг хулгавчлалгүйгээр явж болохгүй ажээ. Жанжин сүм дээр квантуны армийн инженер, сапёрынхан суурьшаад хэдэн жил болсон тул яггүй тохижсон болой.

Сүмийн жижиг барилгуудаас зайдуухан хэдэн намхан байшин эгнүүлэн барьсан агаад онцгойдуухан байгаа нэг намхан байшинд алба ажлаар яваа хүмүүс буудаг аж. Симото тоёото тэргэнд урт гооргор биеэ хэд нугалан суусан болохоор тэрэгнээс буунгуугаа хамаг мөчөө тэнийлгэн суниаж, биеийнхээ чилээг гаргана. Симото, намхан байшингийн хаалгаар сэрвээгээ бөхийлгөн орж, Синьзин руу ярьдаг холбооны тусгай өрөө рүү алхав. Түүнийг өрөөнд орж ирэхэд холбооны салбарын дарга, суудлаасаа босож,

- Шиү са доноо, та Синьзин руу ярих уу? гэж асуулаа.

- Штабтай яриад Тозияа сан хаана байгааг мэдээд яриулаадах гэж захирангуй тушаав. Чингээд

арваад мөчийн дараа Тозияатай ярилаа.

- Эрхэм дээдсээ, Хайлаастанд жаахан эвгүй юм болсон гэхдээ энэ талаар чиү и (бага дэслэгч) Аяанаосу тун тодорхой мэдэж байгаа гэж Симото Тозияагийн шалгаалтаас аятайхан зайлаад,

- Гакка, та дэслэгчтэй ярих уу гэж өөрөөсөө зайлуулаад Аяанаосуд харилцуураа шилжүүлэв.

Тэр хоёр замдаа нэлээд ядарсан болохоор Аяанаосу гаднаас орж ирээд хөшсөн биеэ амраахыг бодсон тул Тозияатай ярих учраа олж чадалгүй хэсэг түгдэрлээ.

- Гакка Тозияа сан, Ёоши хилийнхэнд яаж баригдсан нь тодорхойгүй. Хилийнхний албан ёсны эсэргүүцлээс үзэхэд Ёоши, Халх голын сав газрын байр зүйн тодруулалтын ажлыг армийн штабын даалгавраар хийж байгаагаа хүлээсэн байна. Түүнээс гадна Хасан нуурт ажиллах байснаа хүлээн зөвшөөрчээ.

- Та нарын наад нохой залиг хэн үнэмших болж байна. Би байтугай Ёошид өш хонзонтой хүн ч та нарын наад үгийг сонсохгүй. Наад үг чинь үнэн бол жанжин штабынханд толгойгоо хяргуулна гэж мэдээрэй! гэхэд Аяанаосу Симото руу сүрхий харснаа «Балрах нь байна даа» гэсэн шиг толгойгоо сэгсэрч мэдэгдээд,

- Гакка, Хайлаастын барга айлуудыг хорин дөрвөн цагийн дотор нүүлгэхийг шаардсан гэхэд Тозияа,

- Наад бантангаа та нар хариуцаарай, асуудал тийм хүнд байдалд орсон юм бол барга айлуудыг Авдар нуурын суурин руу тат! Уйланхай дээр улцан нэмэр гэгчээр дахиж хэл ам таталсны хэрэггүй. Асуудалд цаг алдаж хандсанаас шалтгаалж Ар монголын засгийн газраас эсэргүүцэл бүхий нот гаргавал та хоёрын арьсыг амьдаар чинь хуулна шүү гэж зандарлаа.

Гурав.Эцсийн горьдлого

Квантуны армийн удирдагч Уэдагийн өрөөнд өглөөнөөс хойш хэд хэдэн дарга орж ирсэн боловч генералтай уулзаж чадсангүй. Уэда өчигдөр орой Токиотой ярьсны дараа штабын дарга тагнуулын газрын тоотой хэдийг толгой дараалан дуудаж, Хайлаастанд дэгдсэн хэрэг явдлыг нягтлах удирдамж өгч Токио руу хэрхэн илтгэхээ бодно. Тэрээр сэтгэлдээ элдвийг бодож хий хоосон шаналж байгаагаа мэдээд өнөө өглөө Тозияаг дуудуулжээ.

- Тозияа сан, монголын хилийнхний гаргаж байгаа баталгаанд та итгэж байна уу? гэж асуугаад Уэда санаа алдав.

- Итгэхээс өөр замгүй.

- Тэгээд Ёоши урвасан хэрэг үү? Энэ бүхэнд жанжин штабынхан итгэхгүй. Нөгөө талаар Симото армийн удирдлагын шийдвэргүйгээр барга айлуудыг Хайлаастаас нүүлгэсэн байна гэж аргаа барсан янзтай хэлээд үзэгнийхээ бөгсөөр ширээгээ тогшино.

- Аяанаосугийн талаар монголын хилийнхэн ноцтой баримт гаргасан байна. Энэ баримтыг ганцхан Ёошигоос хилийнхэн мэдэж чадна. Тэр ч байтугай Да вангийн хошууны зургийг бидэнд олж өгөх ёстой байсан туршуулын талаар хилийнхэн мэдэгдэлдээ тодорхой дурдсан байна. Миний бодлоор бол барга айлын тавин гэрийн ахлагч эхнэр хоёр энэ бүхнийг нарийн зохион байгуулсан хэрэг! Манайхны тодруулснаар бол цагдаа нар барга айлын ахлагчийн эхнэрийг олон удаа хүчинджээ. Тиймээс цагдаа нараас өшөөгөө авахаар нөхөртэйгөө тохиролцсон нь илэрхий. Ахлагч эхнэр хүүхдүүдээ амь эрсдэнэ гэдгийг урьдчилан тооцоолсон болохоор шуурганаар санамсаргүй дайралдсан Ёошийг барьж өгөөд өөрийнхөө амийг аврахаар шийдсэн гэж үзэх үндэстэй. Хэрэв Ёоши тэгж дайралдаагүй бол Аяанаосуг барьж тушаах байсан.

- Ёошийг барьж өгсөн нь надад ойлгомжтой. Харин Ёоши яагаад хэрэг улайсан бэ гэдэг гайхалтай. Үнэхээр урвасан хэрэг үү. Үүнийг батлах хэрэгтэй шүү!

- Гакка Уэда сан, миний бодлоор бол энэ бүхэн эргэлзээтэй. Яг урвасан гэж үзэж болохгүй. Тагнуулч хүн өөрийнхөө төдийгүй өрөөл бусдыг илрүүлэх явцад итгэгдэж чадвал сөрөг ажиллагаа хийж болох боломжтой болдог. Чухам ийм үед Ёоши, Аяанаосугийн нэрийг барьж, үнэнээ хэлэх нь өөрийгөө итгүүлэх хамгийн найдвартай арга мөн! гэж Тозияа итгэлтэй хэллээ. Үнэндээ энэ үгийг Аяанаосу, Симото хоёр сэдэж Тозияад итгүүлж чадсан хэрэг болой. Харин Тозияа энэ үгэнд итгээгүй боловч дэмжихээс өөр зам байхгүй гэдгийг ойлгожээ. Симото, Аяанаосу хоёрын ажиллагааг буруутгавал Тозияа өөрөө занганд орчих эгзэгтэй. Учир нь Симото, Аяанаосу хоёрыг өөрийн шавь гэдэг. Иймээс муу шавь бэлтгэсэн багш (сэнсэй) өөрөө энэ хэрэгтэй ороолдох нь маргаангүй.

- Тозияа, та Жанжин сүм орж учир байдлыг газар дээр нь өөрийн биеэр шалгаад жанжин штабт илтгэх нь чухал. Би таны саналыг дэмжинэ гэхэд Тозияа сэтгэлдээ баярлаж "Ямар ч байсан миний бодсон анхны алхам бүтэмжтэй боллоо. Ингэвэл бид гурвын хэн нь ч хэрэгт өртөхгүй. Яг Сувдааг сураггүй болгосон явдлыг цагаатгаж чадсан шиг хэл амгүй өнгөрөх далим гарна. Ямар ч гэсэн Ёошийг урвасан гэдэг явдлыг цайруулах нь чухал. Тэгж чадсан

цагт аяндаа арга нь олдono" гэж бодохдоо Сувдааг осолдсон хэргийг гарцаагүй болгож баталснаа саналаа.

...Жанжин штаб Сувдаагийн хэргийг дахин шалгах даалгавар өгсөн болохоор Тозияа нарийн ухаан сэдэхдээ Юкийг ашигласан билээ. Юки, Сувдааг сураггүй болсны дараа нэг удаа Тозияатай номын тухай ярьж суухдаа «Бэргэний дүүгээс (Баатар гүнгийн эхнэр) захиа ирсэн. Сувдаагийн хойдын буянд зориулж Могойн сүмд өргөл өргөж, талийгаачийн осолдсон газар дээр очиж тайлга хийсэн гэнэ. Өглөг тараасан юм байх. Гэтэл нэг хүн ирж талийгаачийн авч явсан цүнхийг авчирч өгөхдөө «Сүйрэл болсон газраас олсон юм» гэжээ.

Тэгээд учир явдлыг асуусан гэнэ. Гэхдээ надад тэр тухайгаа бичээгүй байна. Харин цүнхийг нь явуулна гэж хэлж билээ. Тозияа тэр дороо Жирмийн чуулганы Тунляо (Баянтал) хотод байдаг японы тагнуулын төлөөлөгч, цагдаагийн газар руу бие хүн явуулж шалгуулжээ. Гэтэл Баатар гүнгийн эхнэрийн дүү Түмэд хошуу явчихсан байлаа. Харин Баатар гүнгийн авгай дүүгээ Халуун Рашаан руу явахад нь Сувдаагийн тухай хэлсэн болохоор дүү нь тайлга хийлгэхээр Ирэси орж, хүн хартай уулзсан гэдэг дам сурагтай ирсэн шавиасаа баталгаа авсан Тозияа, Юкийг ятгаж өнөө цүнхийг авчруулжээ. Тэгээд Сувдаагийн цүнх юмтайгаа олдсон тул тэрээр нас барсан нь баталгаатай боллоо гэсэн цахилгаан жанжин штаб руу явуулаад уул хэргийг зогсоон хааж, судлан шинжлэх ажлаа дуусгасан билээ.

Тозияа, Уэдагийн өрөөнөөс гараад гэртээ ирлээ. Тэрээр энэ зуур Сувдаагийн тухай бодлоо. Яагаад ингэж бодсоныхоо учрыг ч олсонгүй. Ердөө санаандгүй байхад сэтгэлд нь эргэлдээд салж өгсөнгүй.

...Баатар гүнгийн эхнэр дүүтэй юм болов уу? Эсвэл хамаатан садангийн нь хүн юм болов уу.

Тозияа ингэж өөрөөсөө асууснаа гэнэтхэн талийгаач Цэен гүнгийн яриаг саналаа.

Баатар гүнгийн эхнэр дүүгүй, ганц ахтай шүү дээ гэж Тозияа өөртөө хэлээд ямаршуухан алдаа гаргаснаа ойлгов. Гэтэл энэ асуудлыг одоо өндийлгөвөл тэрээр өөрөө балрах аж. Хэрэв үүнийг сэргээвэл жанжин штабынхан Тозияад молигодүүлснаа мэдээд «Эзэн хааны армийн нууцыг хадгалах үүднээс түүнийг үхэх хэрэгтэй» гээд когай (эртний самурай нар өөртөө хийдэг харикиригийн нэг хэлбэр сеппуку үйлдэхэд хэрэглэдэг нэг зүйлийн хутга) өгөх нь зайлшгүй. Ингэхээр энэ тухай бодох ч хэрэггүй болой.

...Юки Синьзинд ирснийхээ дараа номоо бичих гэж улайраад толгой өндийлгөх сөхөөгүй суужээ. Акасай түүний дэргэдээс үл сална. Тэгээд Тозияагийн даалгавраар Юкитэй харьцахдаа Тозияагийн мэдэх гэсэн зүйлийг яриандаа хавчуулж санамсаргүй байдлаар асууна. Юки яриандаа болоод тэр үү өөрийнхөө санаа бодлыг Акасайгаас үл нууна. Харин Акасай Юкигээс дуулсан зүйлээ Тозияад орой бүр айлдана,

Тозияаг гаднаас орж ирэхэд Акасай байхгүй байлаа. Тэр хоёр хааяа гадагшаа хамт гарахдаа штабын архиваар ордог. Тозияа өрөөндөө орж ирээд хувцсаа хөнгөлөөд штаб руу ярьж Юкийг сураглав. Юки Акасай хоёр архивт сууж байгаа аж. Юки тэндээс номондоо орох зарим баримтыг олж уншдаг болой. Харин архивынхан нууцтай холбогдсон нэр барьж зарим материалаа үл өгнө. Үүнд нь Юки уцаарлаж уурлах нь цөөнгүй. Гэсэн ч Тозияа тухайн үед

Юкигийн аргыг аятайхан олдог аж. Тозияа утсаар штаб руу ярьж архивт сууж байгаа Юки Акасай хоёрыг мөд ирэхгүйг мэдээд өрөөнөөсөө гарлаа. Тэрээр арваад өрөө бүхий байшингийн өрөө бүрийг нягтлан үзвэл Юкигийн гэрийн үйлчлэгч, тайчууд отгийн эр эм зургаан хүн гэр оронг янзлаад гал тогооны өрөөнд цугларч хоол ундаа янзалж байлаа. Тозияа гал тогооны өрөөнөөс гарч өрөө рүүгээ гэлдрэхдээ Юкигийн өрөөний үүдэнд очоод чимээ чагнан хэсэг зогсов.

Тэгээд халааснаасаа түлхүүр гаргаж авангуут хаалгыг нь онгойлгож орлоо. Тэрээр хаалгаа дотор талаас нь түгжээд хэсэгхэн зуур зогслоо. Юкийг зах зээл, архив руу явах тоолонд Тозияа түүний өрөөнд орж, судалгаа хийдэг аж. Юки Синьзинд ирээд өөрийнхөө өрөөг Мугдэнд байсан шигээ тохижуулжээ. Тозияа хулгана гэтсэн муур шиг хөнгөн алхсаар Юкигийн ширээний дэргэд очлоо. Ширээн дээр олон юм дэлгээстэй. Бичиж байгаад дутуу орхисон цаасны дэргэд нэг захиа байна. Тозияа нэгэн номын хуудсан дотроос хавчуулгаатай байсан ясан хавчуурыг авч өнөө захиаг хавчуурын үзүүрээр эргүүлж үзлээ. Захианы дор нэг дугтуй байна. Ажвал Харбинаас ирсэн болой.

Тозияа Ойдовоос захиа ирснийг мэдээд эхнээс нь авахуулж уншив. Захианд гойд зүйл байсангүй. Харбин дахь төмөр замын нийгэмлэгт Юкигийн бие төлөөлөгчөөр суудаг Ойдов банкны хадгаламжийн жилийн тооцоо хийсэн тухай бичээд Хайлар, Манжуурын төмөр замын зураг төслийн талаар хэд хэдэн хүнтэй уулзсан авч хайгуул судалгааны ажиллагаа бүтэмжгүй байгааг дурджээ. Захианы төгсгөлд төмөр замын нийгэмлэгийн удирдлагатай уулзсан тухайгаа бичжээ.

...Кобуко коцу нийгэмлэгийг байгуулах тухай асуудлыг японы засгийн газраас зөвшөөрсөн боловч албан ёсны шийдээ гаргаагүй байна. Урьдчилсан төлөвлөгөөгөөр бол энэ нийгэмлэг манжуур, өвөр монголоос баригдсан 15 мянган хоригдлыг Хянганы шоронгоос авч ажиллуулах бололтой байна. Нийгэмлэг эдгээр хоригдлыг Хайлар Харбин, Синьзин Ханширээгийн төмөр замын өргөтгөлд ашиглах ёстой юм. Харин бид иймэрхүү хүчийг авч ашиглавал зардал хэмнэгдэх нь гарцаагүй.

Тозияа захидлыг уншсаны дараа хуучин янзаар нь тавиад хананд гүн суулгасан ган дотортой нууц шүүгээний дэргэд очиж ажиглаж байснаа халааснаас хэсэг түлхүүр гаргаад нимгэн резинэн бээлий гартаа хийгээд нууц шүүгээг болгоомжлон онгойлгов. Тэгээд дотор талын хамгийн дээд талын шургуулгыг онгойлгоод ажигч гярхай нүдээр ширтэнэ.

Тозияа, Синьзинд ирсний дараа энэ шүүгээг онгойлгодог болсон. Юки шүүгээгээ тусгай захиалж хийлгэсэн боловч Тозияа түүний түлхүүрийг хийлгэж амжсан болой. Юки Синьзинд ирээд өрөөгөө тохижуулсны дараа Тозияагийн хамт Бүрэнгийн сүм рүү явж эцгийнхээ тайлгыг хийлгэж байсан тэр үед квантуны армийн мэргэжилтэнгүүд авьяасаа сорьж Юкигийн нууцын шүүгээг янзалж амжсан байлаа. Тэгээд Юкийг тайлгын сүмээс ирсний дараа Тозияа шавь нараасаа хоёр хэсэг түлхүүр авч нэг хэсгийг Акасайд өгснөөр Юкийг эзгүй хойгуур нууцын шүүгээг онгойлгож үздэг болжээ.

Тозияа энэ шүүгээнд юу байгааг арван хуруу шигээ мэднэ. Тэр тусмаа шүүгээнд байгаа үнэт эрдэнийн чимэгтэй бөгж зүүлтийг ямар янзтай тавьсныг төдийгүй хэзээ аваад хэдийд буцааж тавьсныг үл андана. Тиймээс Тозияа сурсан заншлаараа шүүгээ рүү гөлрөн зогсохдоо "Юки

бадмаараг шигтгээтэй алтан бөгжөө зүүхээ больжээ. Харин сувдан даруулга зүүх дуртай болсон байна. Дөрвөн өдөр дараалан зүүлээ. Харин бүх бичиг баримт нь тавьсан янзаараа байна. Нэмэгдсэн хасагдсан зүйл алга. Алтны нь хадгаламжтай холбогдсон баримтууд яагаад энэ шүүгээнд байдаггүй юм бол? Юки алтныхаа хадгаламжийн баримтыг хаана хадгалсан байж таарах вэ? Эндээс өөр газар байх ёсгүй дээ. Гэтэл энэнээс өөр нууц шүүгээ, шургуулга байхгүй. Яагаад энд байдаггүй байна" Тозияа энэ шүүгээг онгойлгох тоолондоо өөрөөсөө ингэж асуудаг болсон.

Тозияа нууц шүүгээг хааж цоожлоод сурсан заншлаараа санаа алдлаа. Тэгээд өрөөнөөс гарч өөрийнхөө өрөөнд орж ирээд элдвийг бодохдоо Жанжин сүм дээр очоод юунаас эхэлж шалгахаа бодно. Түүнтэй хамт армийн тагнуулын газрын орлогч дарга нарын нэг нь явах болжээ. Оройн хоол бэлэн болчихсон байхад Юки Акасай хоёр ирлээ. Юки хоолны ширээнд суунгуутаа,

- Аав аа, архивынхан надад юм үзүүлэхээсээ цааргалаад байдаг болчихлоо. Та Уэда сантай ярилцаач гэхэд Тозияа,

- Би ярилцъя л даа. Харин чамд гэхэд архивынхны гарыг цайлгавал тэд чинь юмаа харамлахгүй байх шүү. За тэгээд зөвшөөрөл энэ тэр гэж дүвчигнэхгүй гэж зөвлөв. Тозияа ингэж хэлсэн нь санамсаргүй хэрэг бишээ. Юки, заримдаа «Тантай яримаар юм бий» гэдэг болохоор Тозияа сэтгэлдээ «Алтныхаа талаар ярих юм болов уу» гэж бодоод яриагаа «алт руу» чиглүүлэхийг эрхэмлэдэг удаатай. Энэ удаа ч гэсэн сэтгэлдээ хэвшсэн зангаараа хээл хахуулийн талаар ярьчихсан байлаа.

- Уг нь удирдлагын зөвшөөрлийг авчихвал ёс зүйд нийлэмжтэй юм. Кэмпэйтийн төлөөлөгч заримдаа архивын материалтай танилцсан хүний уншсан зүйлийг авч сонирхдог гэнэ. Тэгээд хэний зөвшөөрлөөр үзэж байгаа юм бэ? гэж шалгаадаг бололтой.

- Тэр ч тийм л дээ. Олигтойхон барьц авсан хүн тэмдэглэсэн зүйлүүдийг кэмпэйтийнханд байтугай эзэн хааныг ч нэхсэн өгөхгүй аргалж ч чадна. Ялангуяа алт гэдэг чинь хүний сэтгэл санааг өөрчилдөг зүйл. Нэг жижигхэн бөгж өгчихсөн байхад юу үзэх гэснээ үзнэ шүү дээ. Чамд бол цэн алт гэдэг чинь юу ч биш шүү дээ гээд ширээн дээрээс янжуураа авч асаалаа. Тозияа хоолны дараа заавал тамхи татдаг заншилтай Юки, Тозияатай чингэж ярилцахдаа түүний эчнээний санааг гадарлаад «Аав ярианы далим гарвал алт ярьдаг болоо шив дээ» гэж бодоод,

- Аав аа, тоос шороотой цаас үзэхийн тулд алтаар дэнчин тавина гэдэг чинь дэмий хэрэг гэж уцаарлав.

- Юки минь зарим бичиг цаас алтнаас үнэтэй байдаг юмшүү.

Квантуны армийнхан цаг нь ирвэл цоохор цаасаа алтаар байтугай иениэр борлуулж чадалгүй шатаана. Харин алтыг тэгж болохгүй. Юки минь чи өөрөө мэд! Алтаар биш гэхэд ногоон (доллар) өгсөн ч болно. Ер нь тус болсон хүний гарыг цайлгадаг ёс бол биднээс өмнө тогтоод өгдөг авдаг болсон юм. Тиймээс одоо чинь нэг юманд тус болбол заавал хариуг нь хардаг болсон цаг үе шүү. Одоо чинь хөрөнгө мөнгөний төлөө алалддаг цаг. Бодоод үз дээ.

Сайд нарын танхим армийн төсвийг хэрэгцээний хэмжээгээр баталж өгөхгүй янз янзаар садаа болсоор байна. Халх голын ажиллагаа ч гэсэн үүнтэй холбоотой учраас өдий хүртэл сунжруулсан гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ гэж Тозияа Юкигийн санааг дагуулж хэллээ. Өөрөөр хэлбэл Юкийд «Алтаа гаргах талаар санаачилга сэдээгүй учраас армийн тусламж авч чадаагүй» гэсэн сэтгэгдэл төрүүлэхийг эрмэлзэнэ.

- Аа мэдэхгүй. Халх голын хувьд өөр шалтгаан байсан байх. Хэдэн жилийн өмнө армид тулгамдаж байсан асуудал бол цэрэг зэвсэг, техникийн тээврийн асуудал байсан. Харин цөөхөн жилийн дотор овоо их юм амжууллаа. Бодоод үз л дээ. Жан Золингийн үед Таонингаас Хуйюаньзин хүртэл тавьсан төмөр замыг ашиглалтанд оруулах гэж яаж хөглөж байлаа. Алгын чинээ төмөр замыг хэдэн жил тавив даа. Гэтэл армийнхан Таонингаас Солунь, Халуун рашаан, Ирэси, Ханширээ хүртэлх замыг яах ийхийн зуургүй тавьчихсан шүү дээ.

- Чиний боддог зөв л дөө. Одоо ч гэсэн тээврийн асуудал хүндрэлтэй байгаа. Ялангуяа Хайлараас Халх гол руу чиглэсэн төмөр замын асуудал тун хүндрэлтэй байгаа гэж хэлэхдээ Ойдовын захианд бичсэнийг санаж байлаа.

- Ганжуур сүмийн хавьд байгаа их элс, элсэрхэг хөрсний шинжилгээний дүн одоо хүртэл гараагүй болохоор төмөр замын зураг төслийн ажил сааталтай байгаа. Түүнийг шийдэж чадах юм бол би ч гэсэн томоохон юм бодож байгаа. Би хавар тийшээгээ юмуу эсвэл зун тийшээ Шанхай руу явна. Тэгэхдээ тантай хамт явна шүү. Шанхайн банкныхантай тооцоо хийнэ. Одоо алтны хадгаламжийн хугацаа дуусах гэж байгаа гэж хэлэхэд Тозияа гайхсандаа «Яагаад ингэж хэлэв. Гэнэ алдав уу. Ер нь, итгээд хэлэв үү? Юкигийн алт Шанхайд гэдэг нь тодорхой боллоо. Тэгэхээр одоо яах вэ? Дахиад жаахан хүлээдэг хэрэг! Алдыг аваад дэлмэн дээр нь гэдэг үг бий» гэж бодоод гэнэт догдолсон сэтгэлээ барихыг хичээлээ.

Тозияа энэ шөнө тухтай унтаж чадсангүй. Хайлаастан гарсан хэргээс Симотоог яаж салгах вэ? гэж бодож байхад нөгөө талаас Шанхайд байгаа алтыг яах вэ? гэж бодно. Ингээд сэтгэл нь хоёрдоод яах ч учраа үл олно.

Одоо Шанхай руу бие хүн явуулбал дээр үү. Америкийн банкны гарт орсон бол тийм амархан авч чадахгүй. Уран л арга хэрэгтэй. Юуны өмнө Юкитэй хийсэн гэрээний болзлыг мэдэх нь чухал. Ялангуяа алтыг өвлөх талаар хэрхэн тохирсныг мэдээгүй цагт Юкийг устгаж болохгүй.

Тозияа энэ хоёр бодлынхоо алиныг чухалчлахаа тогтон шийдэж чадалгүй хэвгэртээ хөлбөрсөөр үүр цайлгалаа. Тэгээд үд хүргээд Жанжин сүм явахаас өөр аргагүй боллоо. Тэгээд оройн галт тэргэнд сууж Ханширээгийн чиглэлд гарлаа. Тэрээр вагондоо хоёулаа суусан бөгөөд харин түүнийг бараадаж яваа хэдэн дарга нар өөр вагонд суужээ. Тозияа ажил төрлийн талаар армийн тагнуулын газрын орлогч даргатай ярих зүйл нэлээн байсан атал дуугүй явлаа. Ийнхүү ус балгачихсан юм шиг явсаар маргааш нь 10 цагийн хэрд Вангийн сүм дээр ирлээ. Жирмийн чуулганы төв гэж алдаршсан Вангийн сүмд галт тэргийг ирэхэд тэндхийн цэргийн төлөөлөгч буудал дээр ирж Тозияаг хүндэтгэн угтлаа. Төлөөлөгчийн газрынхан Хайлаастан болсон хэрэг явдлын талаар нэмэн тодруулсан зүйлээ Тозияд танилцууллаа.

- Бид монголын хилийнхний тавьсан шаардлагатай танилцаад барга айлуудыг ямар ч нөхцөлд нүүлгэж болохгүй гэдгийг Симотоод зөвлөсөн. Гэтэл бидний санамжийг хайхарсангүй. Тэгээд зогсоогүй монголын хилийнхэнтэй үзэлцэх бололцоо гарсаар байтал гараа хумхиад өнгөрсөн байна. Тиймээс барга айлуудыг нүүлгэсэн явдал бол гэмт хэрэг! Бид барга айлуудыг дахиад монголын хил рүү нүүлгэхээр бие төлөөлөгч явуулсан. Гэтэл монголын хилийн цэргүүд Номон Хан, Бүрд-Овооны орчим газрыг хамгаалаад улаан хөлтэй амьтан ч гишгүүлэхгүй болсон байна. Иймд армийн удирдлагаас өгсөн үүргийг хөсөрдүүлсэн хүмүүсийг хариуцлагад татах ёстой гэж үзэж байгаа юм гэж хатуу шаардлага тавилаа.

- Барга айлуудыг монголын хилээс гаргаад хаана буулгасан байна?

- Тэднийг Авдар нуурын суурины орчим газар нутаглуулсан гэж цагдаагийн газрын дарга үүргийнхээ дагуу илтгэв. Тэгээд цагдаагийн дарга яриагаа үргэлжлүүлэн,

- Гакка, Барга айлууд монголын хилээс нүүж эхэлсэн тэр өдрөөс хойш гурав хоног цасан шуурга тавьсан. Ихэнх айлууд малаа шуурга уруудуулан алдсан төдийгүй зарим хүмүүс төөрч осолдсон. Өнгөрдөг шөнийн мэдээгээр бол шуурганд төөрч үхсэн таван хүний хүүрийг олоод байна. Одоо арваад хүн яасан нь мэдэгдэхгүй байгаа төдийгүй айлуудын мал ихээхэн тоогоор өлбөрч байгаа тул айлууд хүнд байдалд орсон.

Тозияа, Вангийн сүмийнхэнтэй чингэж ярилцахдаа зарим зүйлийг сэтгэлдээ тэмдэглэн тогтоогоод Ханширээ рүү хөдлөв. Галт тэрэг Солуньгаас цаашлах тусам Их Хянганы өндөр сүрлэг уулс бүхий хөндийг уруудан урссан Тоор (Туур) голын хөвөөгөөр тахиралдсан төмөр зам голыг хөндлөн гулд сүлжсээр цаашлах тусам нарийн хавцал руу орж үргэлжилсээр Халуун рашаан хүрнэ. Оройн сэрүүн салхи сэвэлзэн цагаан гэгээ тасрах үед Халуун рашаанд ирлээ. Халуун рашаанаас Ханширээ хүртэл далаад бээр болохоор хоёр цагийн дараа Ханширээд хүрэх ажээ.

Тозияа цагаа хартал 18 цаг болжээ. Тэрээр цонхоор ширтэн янжуураа уугиулах агаад Ирэсигээс галт тэрэг хөдөлсний дараа цонхны цаана үргэлжилсэн харанхуй руу гөлөрч суухдаа Сувдаагийн тухай санамсаргүй бодлоо. Тэгээд Сафронов, Ёоши хоёрыг саналаа. Өвлийн дунд сарын хорин тавны тэргэл сарны цайвар гэгээнд Халх голын мөс цайрагнан түүний эргээр хөвөрсөн төмөр замын дагуу дардан зам зурайна. Энэ дардан зам Ханширээ хүрч цаашаа Хайлаар хүрдэг билээ. Дардан зам Ханан уулын урд тал Буван уулын хормой ороон Хандгайтын даваа чиглэхдээ төмөр зам хөндлөн гарчээ. Сар саруулд төмөр замын гарц Тозияд тодоос тод харагдана. Чингээд тэртээд өнгөрсөн нэг бодол сэтгэлд орон гаран эргэлдэх тэрхэн зуур Тозияа, амандаа «Энэ гарцнаас таван бээр яваад галт тэрэгний сүйрэл болсон өнөө мөрөгцөглөсөн тохой хүрнэ» гэж үглэнэ. Тозияа янжуураа уугиулан цонх руу шагайн харснаа,

- Тай са (хурандаа), тэр жил энд галт тэрэгний сүйрэл болсныг та сонссон уу гэж асуулаа.

- Шиү, жёо гакка (Ноён генералаа), би тэр үед энд байсан шүү дээ.

- Тэгвэл та Сувдаагийн сүйрснийг мэдэх юм шив дээ.

- Мэдэлгүй яах вэ? Тэгэхэд би судалгааны ажилд оролцсон юм. Та тэгэхэд энд ирсэн шүү дээ.

Сувдаагийн садангийн нэг хүн хожим энд ирж Ирэси,

Ханширээгийнхэнд өглөг өргөж, тайлга хийснийг та мэдэх үү?

- Гакка, миний мэдэхэд тийм тайлга энд болоогүй. Би энд тагнуулын хэсэг удирдаж байсан болохоор ажил төрлийн үүргээр эндхийн бүх юмыг гадарлана. Тиймээс штабт очин очтолоо эндхийг хариуцаж байсан. Харин Сувдаагийн садан төрлийн хүн энд ирж тайлга хийлгэснийг дуулаагүй. Ер нь ирээгүй гэдгийг баталж чадна. Яагаад вэ? гэвэл энд хувийн ажил төрлөөр ирж байсан өвөр монголчуудыг бид халуун мөрөөр нь мөшгөдөг байсан юм.

- Тай са, Сувдаагийн цүнхтэй юмыг эндээс олсон нэг хүн, түүнийг нь ураг төрлийн нь хүнд өгсөн гэдэг юм. Та үүнийг мэдэх

үү?

- Галт тэргэнд сууж яваад сүйрсэн хүмүүст холбогдох зүйлийг тодруулах ажлыг бид удирдаж байсан. Ер нь Сувдаагийн юм гэх даавууны тасархай ч эндээс олдоогүй шүү гэхэд Тозияа сэтгэлдээ «Сонин юм! Нээрэн энэ чинь эндхийн мухар толгойтнуудыг илрүүлэх монголын хилд манай тагнуулыг оруулах ажлыг удирдаж байсан. Тэгээд эдний шугамаар амь үрэгдсэн хүмүүст холбогдох баримтуудыг шалгах үүргийг удирдлагаас өгсөн.

Хэн тэр цүнхийг Юкийд өгч толгойг нь эргүүлсэн бол.Юки яагаад энэ бүхнийг надад хэлсэн бэ? Санаанаасаа боловсруулсан зүйл баймааргүй юм. Тэгэхээр хэн нэг хүн үүнийг сэдэж Юкийг мунхруулсан хэрэг! Энд ямар нэг зангилаа байна. Цүнх... цүнх! Сувдаа галт тэрэгний сүйрэлд өртөлгүй амьд үлдсэн бол яана? Тиймээс өөрийгөө сүйрсэн гэдгийг батлахын тулд цүнхээ зориуд явуулсан байж болно. Ай бурхан минь энэ чинь юү гэсэн үг вэ? Сувдааг хорлох ажиллагааг Юки, Сафроновоос дуулсан байвал яана...Би ингэж гэнэ алдах гэж!» гэж бодно. Тозияа Хан ширээ хүртлээ хурандаатай юм ярьсангүй. Гагцхүү түүний сэтгэлд Сувдаа бодогдоно. Гэвч Тозияа Сафроновыг хардах бодолдоо эргэлзэнэ. Ингэх үндэслэл байлаа. Сувдааг хорлуулсан ажиллагааг Юки мэдэж байсан бол Тозияатай дахин эвлэрэхгүй байсан ажээ.

Ханширээгээс гарсан ачааны гурван тэрэгний араас дөрвөн суудлын тэрэг дагажээ. Тэр тэрэгнүүд Хандгайтын даваан дээр бүгдээрээ зогслоо. Суудлын тэрэгнээс буусан япон дарга нар Тозияаг тойрон зогсож, нэлмийн цайрагнасан цасанд дарагдаж мэлийсэн цагаан талыг ширтэн зогсоход зарим нь тэнгэрийн хаяатай нийлсэн цэнхэр манан шиг гэгээнээ сүүмэлзэн буй хилийн зүг дурандана.

Тозияа Хандгайтын нурууны зүүн шувтарган хэсэг намхавтар уулсын нэг хөндийг дагуулан дурандаж зогсохдоо жар шахам бээрийн тэртээ цагаан цасанд дарагдсан талд гялтганан цайрагнасан хоёр гялаан юмыг дурандан ажиглахдаа «Авдар нуурын мөс шив дээ» гэж дотроо бодно.Тозияа арван зургаан жилийн өмнө монголоос буцахдаа Халх голоор гарч Жанжин сүм дээр ирснээ санав. Тозияа, Долоон нуурын ойролцоо харлан бараантаж байгаа бараан юмыг харснаа тэр зүг гараараа зааж,

- Замын зүүнтээ бараантаж байгаа тэр суурин урьд өмнө энд байгаагүй юмсан гэлээ.

- Гакка, тэр бол онгоцны хээрийн буудал хойтон хавраас тагнуулын нислэгт ашиглах юм. Одоо цэргийн хуарангуудын барилгыг барьж дуусаад байгаа гэж илтгэлээ. Тозияа тагнуулын газрын орлогч даргын яриаг сонсоод даваан дээр зогсож эргэн тойрныг ажигласнаа суудлын тэрэг рүү эргэлээ. Чингээд ачааны машинуудын гаргасан мөрөөр суудлын тэрэгнүүд цуварч, хурдалсаар Шоугуйт (Шугуйт) голын гүүрээр гараад зүүн тийшээ эргэж дардан замаа даган Жанжин сүмийг чиглэв. Жанжин сүм эндээс гучин бээр ажээ. Өвлийн цонхигор нар тэнгэрийг голлон үд болж байхад ирсэн Тозияа Симототой уулзаад байдал төлвийг яриулаад,

- Баргынхны байдал төлөв ямар байна вэ? гэлээ.

- Айлуудыг таны тушаалаар нааш нь татаж авчирсан. Хэдий тийм боловч байдал эвгүй байна. Баргуудын мал Халх голын хавьд дасахгүй өлдөж осгоод байна. Цаг агаарын энэ байдал хүмүүсийн сэтгэл санаанд нөлөөлж боломж гарвал монголын хилийнхэнтэй нийлчих гээд байна. Ялангуяа тавин гэрийн ахлагч Ёошийг барьж хилийнхэнд тушаасан хийгээд ахлагчийн гэр бүл манай хоёр цагдааг тонилгосон явдлыг мэдсэнээс хойш баргууд монголын талд урвачих гээд байдаг болсон гэхэд Тозияа Симотогийн талаар ярьсан «Халуун рашааны төлөөлөгч, Вангийн сүмийнхний» үгийг саналаа.

Тэгээд дотроо «Эд нар Симотоог хавчиж байгаа юм байна. Ноднин Уэдаад Симотоог ховлохдоо миний нэрийг барьж хотоос хот тэнэсэн юу ч хийдэггүй, зугаалж наргиж явдаг хүн гэсэн байсан. Сая тэр санаагаа гаргасан. Тиймээс гэмт хэрэгт татаж хариуцлага хүлээлгэхийг мэрийгээд байгаа хэрэг. Үүнээс өмнө эд нар Симотоог илэрхий муулж чаддаггүй байсан. Түүнийг цол ахиулах тухай тодорхойлолтонд тагнуулын газрын дарга гарын үсэг зурсан мөртлөө Уэдаад амаар танилцуулахдаа «Тозияа саны саналыг бодож дэмжлээ» гэж хэлсэн байсан. Энэ бүхнээс үзвэл эд өөр хоорондоо яггүй өшөөтэй хүмүүс байна.

Тагнуулын газрын даргыг өөрийнх нь аргаар өөрийг нь дөнгөчих сүйхээ Симотоод бий. Тиймээс Симотоод бололцоо олгох хэрэгтэй. Надтай болон шавь нараар минь оролдож болохгүй гэдгийг штабынхны зүрхэнд ортол ойлгуулах хэрэгтэй. Барга айлуудыг нүүлгэхийг намайг тушаасан гэдгийг мэдэж байгаа мөртлөө дан ганц Симотогийн буруу болгохыг хичээгээд байгаа нь илэрхий. Тэгэхээр эднийг өөрсдийг нь хашраах нь чухал» гэж бодлоо.

Тозияа, Симототой уулзаж байдал төлвийг мэдсэний дараа Аяанаосутай уулзав. Тэрээр Аяанаосутай нүүр учирч байгаагүй боловч сургаар нь танина. Ноднин Токиод очихдоо «Хар луу» хэмээх нууц байгууллагын тэргүүнтэй уулзахад тэрээр Аяанаосуг тэнгэрт тулгал магтаад «Архинд толгойгоо мэдүүлчихгүй бол тун авхаалжтай хүн» гэж билээ. Тозияа дэслэгчийн гадаад байдлыг хөлөөс нь толгой хүртэл ажиглаад «Аргагүй золбоотой сайхан эр юм» гэж бодоод,

- Дэслэгчээ наашаа суу гээд давчуу өрөөний голд зассан ширээний хажуугийн сандал руу заагаад яриагаа үргэлжлүүлэн,

- Урвагч нарын талаар юу бодож байна даа гэж ерөнхийлөн асуулаа. Юмыг бодож тунгааж сураагүй хүн бол үүнд ганцхан үгээр хариулах ёстой аж.

Гэтэл Аяанаосу хэсэгхэн бодох зуур Тозия түүнийг ажиглан суухдаа «Өөрийг нь монголын талд илчилсэн Ёошид аль хэр өширхөх бол.Одоо мэдэгдэнэ дээ. Ер нь бие биенийхээ алдааг далимдуулж өширхөн хонзогнодог зан бол манай армийн дарга нарын ганц өв дөө! Үүнийг ашиглаж чадсан хүн тушаал дэвшиж чадна. Өөрийгөө ч хамгаалж дөнгөнө. Муу хэлүүлсэн нь муу хэлснийгээ дөнгөхийн тулд дээгүүр тушаалын хүмүүсийн ар өврөөр гүйж муулаад, тал засан зусардана. Дөнгүүлсэн нь хариугаа авахын тулд цагдаагийн туршуул, хөлсний алан хядагч нарт мөнгө цутгаж, удам судраар нь хүйс тэмтрэхийг улайна. Аяанаосу үүнийг хослуулж чадах хүний нэг. Харин Ёоши Аяанаосугийн гарт амиа алдахгүй, харин улааныхны гарт өртөх тавилантай байж» гэж бодно.

- Ахлагчийн хувьд гэвэл түүнийг өчиггүй цаазлах хэрэгтэй. Харин Ёошигийн хувьд бодох хэрэгтэй юм. Ёоши бол жанжин штабт итгэлтэй хүн. Тиймээс армийн нууцыг илчилсэнд орвол миний нууцыг илчлэх нь улаантантай тоглох тоглоомыг сэдэх боломж олгосон байж болох талтай. Ийм аргыг тагнуулын туршлагатай Ёоши шиг хүмүүс эзэмшсэн байдаг. Үе удмаараа самурайн бусидо ёсыг сахисан Ёоши армийн нууцыг тийм ч амархан алдах ёсгүй. Би Ёошигийн оронд байсан бол ийм замыг сонгож авах байсан. Өөр ашигтай сэжим гарахгүй гэж Аяанаосуг хэлэхэд Тозия гайхлаа. Тэрээр ийм үг Аяанаосугаас сонсоно гэж бодоогүй. Энэ бол өөрийнхөө амийг тэнгэрт өргөдөг, бусидо ёсыг мах цусандаа шингээсэн жинхэнэ самурай, эзэн хааны үнэнч боолын үг байх ёстой ажээ. Аяанаосу самурайн ёсыг ингэж эрхэмлэдэг гэдгийг Тозия зүүдлээ ч үгүй билээ. Тозия, Аяанаосугийн царайг ширтэн «Тояамагийн үг, тэгж их магтдаг учир ийм ул мөртэй байж дээ» гэж бодохдоо Хар луу нийгэмлэгийн удирдагч Тояаматай ярьснаа санах.

- Чиү са Симото сан, армийн удирдлагын шийдийг харгалзалгүй барга айлуудыг Хайлаастаас нүүлгэсэн байна. Армийн зорилгыг барга айлуудад ойлгуулах талаар гараа хумхиж байжээ. Иймээс Симото саныг хариуцлагад татахыг зарим удирдах ажилтангууд шаардаад байгаа юм гээд Тозия Аяанаосу руу харцаа эгцлэв.

- Миний бодлоор бол Симото, өөрийнхөө дур зоргоор нүүлгээгүй байх. Ямар нэг удирдамж авсан байх ёстой. Симото тийм гоомой ажил хийх хүн биш! Хэрвээ Симото армийн удирдлагаас ямар нэг удирдамж аваагүй гэж үзвэл барга айлуудыг нүүлгэхээс өөр зам байгаагүй. Монголын хилийнхний шаардлагыг хүлээж авахгүй бол зэвсэгт мөргөлдөөн гарах ёстой байсан. Ингэвэл барга айлууд хамгийн түрүүнд сүйрнэ. Харин манай цэргүүд хэдэн гуйлгачин баргууд тэр тусмаа буян заяагүй хоосон хүмүүсийн төлөө амиа зориулж, тэднийг хамгаална гэдэг бол самурайн ёсонд харштай. Доод хүмүүсийн төлөө амиа тэнгэрт өргөнө гэдэг чинь муусайн баргуудыг эзэн хаан Хирохитогоос дээгүүр үнэлсэн хэрэг. Самурай нар бол зөвхөн эзэн хааны сайн сайхны төлөө амиа өргөх ёстой гэхэд Тозия сэтгэлдээ «Тояама үүнийг самурайн үзэл санаагаар хүмүүжүүлж чадсан байна» гэж бодлоо.

- Ёоши танай хэсгийн ажиллагааны талаар ямар үүрэг өгсөн бэ?

- Бид Ёошигийн ажилд хэрэгцээтэй хүмүүсийг монголын хилчдээс баривчлах ёстойгоос гадна монголын цэргийн анги, зэвсэгт хүчний байрлал, хамгаалалт, ар талын системийг хэлүүлж авах ёстой байсан. Гэхдээ Ёоши энэ талаар тухайн үед удирдамж өгнө гэсэн юм. Тиймээс манай хэсгийн ажиллагаа Симотоод шууд хамаагүй юм гэж Симотоог хариуцлагаас хөндийрүүлэв. Тозия, Хайлаастын зүүн талд байгаа барга айлуудаас нэг ахмадыг дуудуулж

уулзлаа.

- Ёоши Хайлаастын зүүн талд хийсэн байр зүйнхээ тодруулалтын материалыг өөрөө аваад явсан юм. Тиймээс хээрийн зураг хадгалдаг нууцын авдарт эх материал үлдээгүй гэж ярианыхаа төгсгөлд ахмад ховлох байдалтай ярилаа. Тозияа энэ үгийг сонсоод ахмадаас юу ч асуух хэрэггүй гэж үзлээ. Тозияа, Хайлаастанд болсон хэрэг явдлыг судлаад, тагнуулын газрын орлогчийн саналыг асуулаа. Тэрээр удирдлагатай ярих яриагаа яггүй бодож боловсруулсан болохоор Симото, Аяанаосу хоёрын талаар хэн хэнд нь тал засахыг хичээхдээ Тозияагийн амыг хүлээсхийж байгаа нь илт аж.

- Гакка, Симотогийн хувьд хариуцлага алдсан гэж үзэхэд хэцүү байна. Нарийвчлан ухвал юм гарч болох бололтой.

- Халуун Рашаан, Вангийн сүмийнхний үг ор үндэсгүй зүйл биш. Гэхдээ бас ч баталгаатай зүйл биш гэхэд Тозияа, хурандаагийн бөөрөнхийлсөн үгэнд дургүйцэж,

- Ноён хурандаа минь, хүний толгой эргүүлчихээр будлиан гарч шалиагүй байна. Нөгөө талаар барга айлуудын талаар бол би өөрөө нүүлгэх удирдамж өгсөн юм гэж ууртай хэлээд хяламхийсэн харцаар ширвэсхийн харсанд хурандаа сулхан дуугаар,

- Гакка, барга айлуудыг та нүүлгэх шийд өгсөн юм бол энд яриад байх юм алга. Гэхдээ манай дарга, Симотоод тийм ч сайн биш. Би бол тантай санал нэгтэй байна. Харин удирдлага маань юу гэх юм бол гэж учирлав.

- Тэгвэл танай дарга ямар удирдамж өгсөн юм бэ?

- Симото саныг олигтойхон муулчих хүмүүсийн тодорхойлолт, баталгааг сонирхоод байх шиг байсан. Түүнээс надад тэг ингэ гэж онцгойлон даалгасан зүйл байхгүй шүү.

- Чи тэгвэл Симотогийн талаар тусгайд нь тодорхойлолт бичээд олдсон аахар шаахар зүйлээ даргадаа өгөх хэрэг үү?

- Та гарын үсэг өгөөд надаас авчихвал болно шүү дээ. Та чинь манай хэлтсийн ерөнхий зөвлөх учраас надаас тэр зүйлийг авах эрх бүхий хүний нэг. Нөгөө талаар та миний зүтгэлийг бодох биз. Энэ бүхнийг танд л гэж хэлж байгаа юм. Би өөрөө Симотоод муугүй. Ганцхан манай дарга нарын мэдэл их, тэгээд дураараа болохоор над шиг будааны хүүхэд яах вэ дээ. Тушаал бол тушаал гэхэд Тозияа эчнээндээ «Энэ золиг бас эрх тушаал горилдог новш байх нь. Тэгээд эгзгийг нь тааруулж сурсан золиг байна. Симотогийн талаар цуглуулсан материалаа надад өгөхдөө ацаг хөлсийг нь нэхдэг байна шүү» гэж бодоод,

- Тайса (хурандаа), чи юмыг овоо уран сэтгэдэг, хэрсүү ухаантай хүн юм. Симотогийн талаар овжин санаа гаргасан чинь сайн хэрэг. Харин таны надад өгөх гээд байгаа зүйл чинь ажил хэрэгт тийм их холбогдолтой юм уу даа гэлээ.

- Гакка, би ч ажил хэргийн талаар нэлээн юм сэтгэе гэж боддог юм. Даанч манай дарга дэндүү идэвхгүй хүн болохоор ажлын арга барилаар зөрөлдөх юм их гардаг. Ер нь хурц

сэтгэдэг хүнд манай дарга дургүй. Тийм зүйлийг занганд оруулчихдаг гэмтэй сэтгэлгээ гэж айгаад миний ажлыг дэмждэггүй юм. Үүнийг Уэда сан мэдэхгүй болохоор намайг тань шиг үнэлэхгүй байх. Харин сонорт нь хүргэж чадвал өөрөөр хандах нь эргэлзээгүй хэрэг! гэхэд Тозияа дооглонгуй байдлаар,

- Би таныг армийн удирдлагад танилцуулъя. Та чинь армийн сайд болж мэдмээр хурц хүн байна гэхэд хурандаагийн нүүр, чих нь улайлаа. Тэрээр Тозияаг цаашлуулж байна гэдгийг мэдээд дотроо «Энэ хөгшинд хэрэггүй юм ярьчихлаа. Одоо очоод л хусуулна даа» гэж бодоод зүрх нь зогсчих шиг болжээ.

Тозияа, Авдар нуураас явахын өмнө тусгай холбоогоор армийн удирдагчтай цаг гаруй ярилаа. Тэрээр Хайлаастын асуудлын талаар ярилцахдаа жанжин штабт илтгэх хуудсыг өөрөө бичихээр шийдэж, мөн байр зүйн тодруулалтын ажлыг түр зогсоож өөр шинэ хэсэг зохион байгуулах санал боловсруулснаа тайлбарлав. Чингээд Тозияа Синьзин руу буцахын өмнө Симотоог дуудаж уулзаад,

- Тагнуулын газрын дарга, орлогч хоёр чиний талаар сайн хэлэхээсээ муу хэлэх нь илүү юм байна, Чи энэ талаар өөрөө юм бодох биз! Харин чиү и Аяанаосу, чамайг тун сайн хамгаалж байна. Ер нь итгэж болох хүн гэдэг нь илэрхий боллоо гэж хэлжээ.

Эзэнт гүрний армийн нэр хүндэд хар толбо суулгасан Хасан нуурын дуулианд зэвүүрхсэн эзэн хаан Хирохито, засгийн газар, жанжин штабын хэдийг яггүй баалсны адилаар Халх голын ажиллагаанд чөдөр болох шахсан квантуны армийн удирдлагын зарим хүмүүсийг чамбайхан зэмлэхдээ тагнуулын хэлтсийн удирдлагыг нэр цохон заажээ.

Уэда, ширвээ сахлаа сөрвөлзүүлэн уурлаж, тагнуулын хэлтсийн хэдийг толгой дараалан загнаад гагцхүү Тозияагийн шавь нарт муу үг хэлэлгүй өнгөрлөө. Уэда жанжин штабын даргад зэмлүүлсэндээ уурлаж, цагдаагийн газрынхныг зүгээр өнгөрөөсөнгүй. Тэгээд эвгүй байдлаас гарах хийгээд «Номон Хан зикэна» ажиллагааг эхлүүлэхэд холбогдолтой урьдчилсан ажиллагааны нэг Халх голын сав газрын байр зүйн тодруулалтыг үргэлжлүүлэхийн тулд санаачилга гаргасан Тозияагийн төлөвлөгөөтэй танилцаад сэтгэл нь жаахан уужирчээ. Тозияагийн төлөвлөгөөг жанжин штаб ч дэмжжээ. Тэрээр хил дээр зэвсэгт мөргөлдөөн гаргах замаар хилийн гүнд цөмөрч, тодорхой газруудыг онцолж, судалгаа хийж дуустал хилийнхэнтэй хориглон байлдах ажиллагаа боловсруулсан ажээ. Үнэндээ энэ санааг Симото гаргасан болохоор түүнийг нэг шат дэвшүүлж Аяанаосуд ахмад цол хайрлав.

Симото, шинэ цол хэргэм авсны дараа Жанжин сүмээс яваад долоо хонох гэж байхад газрын зургийн шинэ хэсэг Халх гол руу гарлаа. Харин Аяанаосуг монголын хил дээр ажиллуулах нь зохисгүй гэж үзээд шинэ ажилд томилон Харбин руу явуулав. Аяанаосуг хил дээр ажиллах тусгай хэсэгт оруулбал хилийнхэн нэхэмжлэх эгзгийг хянан үзсэн Симото, түүнийг Харбины төлөөлөгчийн газар байдаг армийн тагнуулын хэсэгт ажиллуулах санал оруулсан агаад Тозияа түүнд тусгай даалгавар өгчээ. Тэрээр Хянганаас найдвартай хоригдол олж, хоригдлуудын дунд ажиллуулахын зэрэгцээ эрүүгийн хэрэгтэнтэй тусгайлан ажиллах ёстой байв.

Аяанаосу, Харбинд ирээд цэргийн зочид буудалд байрлав. Түүнийг Харбинд ирсний

нөгөөдөр Хато дуудаж уулзлаа. Хато, Аяанаосуд тун дурамжхан боловч Тозияатай харьцаагаа дахин хурцатгаж болохгүй гэдгийг юунаас ч илүү ойлгоод Аяанаосуг нүүрэн дээрээ хүндэтгэх дүр гаргахаар шийдсэн болой. Хато, Сувдаагийн асуудлаас болж Тозияатай ам мурийсан удаатай. Хато Аяанаосуг янзгүй царайгаар угтахдаа сэтгэлдээ «Энэ лүд ямаршуухан амьтан бол доо. Хасу Тоиши юмуу Оросын цагаачдын товчооны өнөө Мешанов шиг амьтан бол яана. Армийн тагнуулын газрын судалгаагаар бол ажилд тэнцэх хүн. Гэхдээ энэ сайхан царайны цаана ямар шулам шүглэснийг бурхан ч мэдэхгүй. Тоиши удам угсаа үзэл бодлоороо цэвэр ариун, тэнгэр язгууртай байсан атлаа биеэрээ чөтгөр байсан. Энэ муусайн өвөр монголууд уу! Арьсыг нь амьдаар нь хуулж байвал таарах новшнууд! За яахав. Тозияа үүнийг өргөж дэмжээд байгаа юм. Тэгээд ч Симолагийн гарт гайгүй талхлуулсан болохоор учиртай байх. Гэхдээ царай өгч болохгүй хүн!

Хожим миний толгойг цусдаж мэднэ. Ер нь миний дэргэд Тозияа урт хошуу урд хормойгоо хавчуулж чадлаа шүү» гэж бодно.

- Та и (ахмадаа), таныг чухал ажилд томилсон явдалд сэтгэл тааламжтай байна. Та ажлаа нэр төртэй биелүүлж чадна гэдэгт итгэж байна. Жанжин штабаас өгсөн удирдамж ёсоор та, Харбин Хайларын төмөр замын өргөтгөлд ажиллах хоригдлуудыг судлах ёстой. Тэдний дотроос эрүүгийн хэрэгтнүүдийг олж өөрийнхөө шавь болгох хэрэгтэй. Тэгээд хоригдлуудын дотор ажиллуулж тэдний дунд байгаа мухар толгойтнуудыг илрүүлж «Ус шинжилгээний газарт» шилжүүлэх ажил эрхэлнэ. Нөгөө талаар дээрэм, танхай балмад ажилд авьяастай хэрэгтнүүдийг түүж олоод тэднийг толгойлж байсан одоогоор баригдаагүй үлдсэн удирдагчдыг олж танилцах болно. Таны ажилд оросын цагаачдын товчооны Сафронов харилцаатай ажиллах ёстой гэж хэлээд Аяанаосугийн царай өөд гөлөрлөө.

- Гакка, энэ талаар Тозияа надад удирдамж өгсөн тул та бүхний итгэлийг хөсөрдүүлэхгүй гэж самурайн ёсыг барьж илтгэхэд Хато,

- За тэгвэл өнөө маргаашдаа амарч бай. Ажлын өрөө тасалгааг чинь бэлдүүлсний дараа дуудна гэхэд Аяанаосу генералын өрөөнөөс гарлаа.

Өвлийн сүүл сарын дундуур Харбинд гэнэт дулаарсан болохоор ээвэр газрын цас хайлж, шөнө зайрмагтсан гялаан дээр халтирахаас болгоомжилсон хүмүүс бээцэгнэн алхах сонин. Аяанаосу, генералын өрөөнөөс гараад гудамж уруудан гэлдрэхдээ халтирахгүйг хичээж удаан алхсаар Харбины "Модрен" буудлын зоогийн газар руу чиглэв. Биржийн гудамж урьдын адил хөл үймээн ихтэй.

Аяанаосуг "Модрен" буудлын зоогийн газрын гол хаалгаар орохыг харсан буудлын зохицуулагч түүний бараанаар суудлаасаа ухасхийн босож хүндэтгээд тэргүүн бөхийлгөн өнгөрөөнө. Тэгээд араас нь гайхан алмайрсан нүдээр ширтэн үлдэхдээ «Энэ ахмад чинь өнөө захиалгын газрын эзэн шив дээ. Хэдийдээ японы армийн ахмад болчихдог байнаа. Саяхан хамаг байдгаа шатаалгаад гуйлгачин болчих шахаад явж байгаагүй билүү?» гэж бодлоо. Аяанаосуг зоогийн газар орж ирэхэд дүрвэгсдийн товчооны хэдэн дарга толгой дохин мэндлээд бас л гайхсан нүдээр бие биен рүүгээ гөлөрнө. Аяанаосу, япон цэргийн дарга нарт зориулан зассан тусгай кабин руу ороод цагаа харвал хэдэн мөчийн дараа Сафронов орж ирэх ёстой байлаа. Тэрээр өдрийнхөө хоолыг зоогийн газар өнгөрөөхдөө тогтмол цагт ирдэг

болой. Тиймээс Аяанаосу, түүнийг энд тосон уулзахаар шийдсэн билээ.

Чингээд төдий удаагүй байтал зоогийн газрын хаалгаар дунд зэргийн нуруутай дөч эргэм насны нэг монгол хүн Сафроновтой орж ирэхийг ажигласан Аяанаосу «Хурандаатай яваа европ хувцастай энэ хүн яах аргагүй халх хүн юмаа» гэж бодлоо. Энгийн хувцас өмссөн Сафронов гаднаас орж ирэнгүүт хэсэгхэн зогсож зоогийн газар байгаа хүмүүсийг ажиглахдаа хамгийн түрүүнд японы армийн дарга нарт зориулсан кабинд байгаа хүмүүсийн зүг анхаарлаа хандуулжээ. Иван, хананд тулгасан сандлын түшлэг налан суусан Аяанаосуг бараагаар нь таниад өнөө монгол хүний чихэнд хэдэн юм шивнээд шууд Аяанаосуг чиглэн алхаж дэргэд нь ирэнгүүт,

- Аяанаосу чи чинь газрын хаанаас гараад ирэв? Чамд чинь дарга хувцас тун аятайхан зохидог юм байна шүү гэж дуу алдан уулзав. Тэгээд Иван Степанович хамт яваа монгол хүнээ танилцуулж,

- Аяанаосу, чи энэ хүнтэй танилц! Юки саны бие төлөөлөгч Ойдов гэхэд Аяанаосу суудлаасаа босож тэргүүн бөхийлгөн ёслоод,

- Эрхэм дээдэс Тозияа саны асарсан бүсгүй Юкигийн бие төлөөлөгч эрхэм тантай танилцсандаа таатай байна гэж хэлэхдээ сэтгэлдээ баярлан инээмсэглэснийг хэн яахан мэдэх билээ. Аяанаосу, тэр нэг өдөр холбоочинтой уулзахдаа харанхуй шөнө царай зүсийг тоймлон тогтоосон төдийгүй дууг нь сэтгэлдээ тогтоосон ажээ. Тэгээд биеийн байдал хөдөлгөөнөөр нь холбоочноо таниад сэтгэл догдолсон ажээ.

Аяанаосу шинэ танил буюу холбоочинтойгоо Харбин дахь ажил төрлийг нь асуун лавлаж, ойр зуурын яриа үүсгэж, үдийн хоолыг зугаатай өнгөрөөлөө. Тэр гурвын хэн хэн нь үдээс хойш төдий их ажилгүй болохоор зочлолт удаан үргэлжилжээ.

- Ойдов сан, танай эзэгтэй шинээр байгуулж буй төмөр замын нэгдэлд хувь нийлүүлэх юм гэж шуугиад байна. Та нар Хайлар Харбины төмөр замын өргөтгөлд хувь нийлүүлэх үү? Эсвэл Хайлар-Манжуурын хооронд тавих шинэ төмөр замд хөрөнгө хорших уу гэж хятадаар асуулаа.

- Манай эзэгтэй Хайлар-Манжуурын чиглэлд тавих шинэ төмөр замын зураг төслийг сонирхож байгаа юм.

- За тэгээд ажил чинь бүтэмжтэй биз дээ. Ирэх хавраас төмөр замын ажлыг эхлүүлж чадах уу?

- Одоохондоо бүтэмж муутай байгаа. Хөрсний шинжилгээний баримтаар бол Үзүүр ус гэдэг газар намаг шавар ихтэй. За тэгээд тэр хавийн хужир марз шинжилгээнийхний махыг идэж байгаа юм. Нөгөө талаар Ганжуур сүмийн хавь газар их элстэй. Ойдовыг дараагийнхаа үгийг хэлэхээс өмнө Аяанаосу түүний яриаг таслан,

- Тэр элсийг нутгийнхан Манжуурын цөл гэдэг юм.

- Цөлсөөд байх тийм их юм биш. Гэхдээ төмөр зам тавихад ярвиг учруулах нь мэдээж гэлээ.
- Аяанаосу чи чинь Буйр нуурын эрэг дээрх Асар сүмд байж байгаад ирээ юу? гэж Аяанаосуг хоргоолоо.
- Иван Степанович минь тэр талаар сүүлд тухтай ярья. Харин та бид хоёр чинь өнгөрсөн зунаас хойш уулзаагүй шүү дээ. Харин Хасан нуурт очоод ямаршуухан явав даа гэж асуулаа.
- Маргааш манайд очоорой. Тэгээд хоёулаа шавиагаа ханатал бурья. Одоо өндөрлөсөн дээр гэхэд Аяанаосу түүний үгийг дуртай зөвшөөрлөө. Тэрээр Ойдовтой хамт харихаар явахад Аяанаосу цэргийн буудал руу сажлав. Чингээд маргааш нь үд өнгөрөөгөөд Сафроновынд очлоо. Аяанаосуг үүдний өрөөнд угтан авсан гэрийн үйлчлэгч эмэгтэй танимхайран угтаж,
- Ноёнтон зочны өрөөнд хүлээж байгаа гээд өнөө эмэгтэй гал тогооны өрөө рүү эргэлээ. Аяанаосуг зочдын өрөөний хаалгаар ортол Иван Степанович ширээнийхээ хажуугийн сандлаас босон мэндэлж уулзсанаас хойш тэр хоёр нар жаргатал хөөрлөө.
- Аяанаосу, чи чинь өнөө зангаараа шив дээ. Надтай архидахдаа болгоомжлох хэрэггүй. Чи элэг цөс муу гээд байдаг мөртлөө эмчид очдоггүй хүн. Үүнийг чинь би мэдэж байгаа. За тэгээд гаднаас чинь харахад шалиг завхай юм шиг мөртлөө танайд очсон хүүхнүүдийн яриагаар бол та чинь Хянганы нуруу шиг сайхан эр мөртлөө залуу хүний оронцог, манин эр гэх нь олонтаа байдаг. Чи чинь хүүхнүүдийг гэртээ аваачиж архидуулдаг мөртлөө тэдний хорхойг хүргээд хавьтаж ойртолгүй явуулчихдаг байсныг би мэднэ. Гэхдээ би чамайг тагнаж улыг чинь шагайх гэж хөөцөлдөж байгаагүй юм. Зүгээр тохиолдлын төдий мэдсэн.
- Сафронов, Чи Ёошитай хамт тэр нэг орой манайд очихдоо Сувдааг дуудах хэргээр очсон юм уу? Эсвэл өөр зорилготой байсан уу? гэхэд Степанович морин шилтэй архинаас шилэн аяганд дүүргээд ганц амьсгаагаар уунгуутаа ширээн дээрх тавагнаас давсалсан өргөст хэмх авч монцгор үзүүртэй хамрын нүхэнд ойртуулж үнэрлэснээ амьсгаагаа уртаар аваад,
- Тэгэхэд Ёоши бид хоёр Сувдааг барьж устгах ёстой байсан юм. Харин одоо Сувдаа хаана байгаа вэ? гээд Сафронов архинаас аягалав.
- Мэдэхгүй. Харин танаас сонин юм дууллаа. Та яагаад үүнийг Хатоод дуулгаагүй юм бэ?
- Сувдаа одоо Улаанбаатарт байгаа гэдгийг та мэдэж байгаа шүү дээ. Гэхдээ энэ бүхнийг японы дарга нарын хэн ч мэдээгүй байгаа. Сувдаа Мугдэнгээс ирэх бүртээ тантай уулздаг байсан.

Тэгээд банкнаас мөнгө аваад танайд очдог байсан. Би үүнийг мэддэг боловч хэнд ч хэлээгүй юм. За тэгээд ч миний зорилго тэднийхээс өөр. Яг та нарынх шиг. Танд Сувдаа хайртай. Сувдаад Юки ч хайртай. Би Юкийд сайн. Ингэхээр та нар чөтгөр шуламтай нөхөрлөсөн байлаа ч гэсэн би тэр чөтгөртэй чинь нийлэх ёстой.

Ингэхээр би мэдсэн бүхнээ тагнуулын газар, кэмпэйтийханд дуулгах хэрэггүй байгаа биз дээ.

- Манай байшинг шатаах тухай үл мэдэгдэх хүн надад зурвас өгч явуулсан байсан. Түүнийг та бичсэн хэрэг үү?

- За тэгсэн гэж бодъё.

- Хасу Тоиши Мешанов хоёрт тохиолдсон явдал бас таны гараар үйлдэгдсэн байх нь ээ?

- Би Мешановыг устгаагүй. Ердөө санамсаргүй явдлаар болсон юм. Ёоши Мешановыг барьж Хатоод тушаах ажлыг нууцаар зохион байгуулсан байсан. Тухайн үед би үүнийг мэдээгүй. Гэтэл тэр замдаа архидаад уулын замаар явж байхдаа согтуугийн гайгаар замын хашлага мөргөж хясаа руу онхолдсон байсан. Энэ бүхний гайг надад тохоох гэж үзсэн. Харин Хасу Тоишигийн хувьд бол Юкигийн ураг садангийн хүмүүсийг хорлох санаа байгаагүй юм.

- Сафронов сан, Хасан нуурт явуулсан японы армийн ажиллагааг та, юу гэж үздэг вэ?

- Японы арми, Хасан нуурын паянгаар Зөвлөлтийн эсрэг дангаараа тэмцээд дийлэхгүй гэдгээ бүрэн ойлгосон. Тиймээс одоо Герман, Италийн фашистуудтай нийлэх зам мөрөө бэлдээд байгаа. Тиймээс герман улаан орос руу довтлох цагийг хүлээж байгаа юм. Эд чинь коммунизмын нөлөөг дэлхийд дэлгэрүүлэхгүйн төлөө саналаа нэгтгээд байгаа. Гэтэл Гитлер ганцхан коммунизмын нөлөөг арилгахад биш, харин дэлхий дахиныг өөрийн мэдэлд захирах гэсэн бодлоо нуухаа больсон. Япон үүнийг мэдэж байгаа учраас зөвхөн Зөвлөлтийн эсрэг нэгдсэн хүчээр дайръя гэдэг санал тавиад байгаа. Япон, Герман, Италийнхан Зөвлөлтийн эсрэг хамтран тэмцлээ гэхэд устгаж дийлэхгүй. Үүний учрыг тэд тамтагтаа тулсан сүйрэл үзэж байж ойлгоно. Түүнээс одоо ойлгохгүй. Би Харбинд ирснийхээ дараа гуйлгачин болоод хог түүхэд хүрнэ гэж бодоогүй. Гэтэл энд ирээд гурван сарын дараа хог дээр гарсан. За тэгээд төмөр замын ачаа зөөж, буулгаж үзлээ. Өдөр шөнөгүй мөрөө сэтэртэл ачаа үүрээд нэг сайн цадчих хоолны мөнгө олоогүй. Харин Цэен гүн, Юки хоёр байгаагүй бол би Харбины хог дээрээс лааз түүж үнэр орчихсон шавхруу долоох байсан. Оросын цагаачдын товчоо ачаа зөөж амь зогоодог оросуудыг нэг нүдээрээ хардаггүй мөртлөө Цэен гүнг Харбинд ирж намайг сурагласан чимээгээр намайг сайд болгочихсон юм шиг хайж гүйгээд, зусардаж зулгуйдагдаа миний улыг долоох нь холгүй байсан. Хөрөнгө мөнгөнд тулгуурласан зан чанар гэдэг ийм байдаг хойно доо. Ингэхээр би Цэен гүнгийн ах дүү төрөл садан, төрсөн охиных нь төлөө амиа зориулсан ч багадна уу гэхээс ихдэхгүй. Гүнтэн амьд ахуйдаа надад захихдаа «Сайнжаргалыг амь шигээ хайрлаж яваарай. Хүний нутагт Сувдаа та гурав ах дүү шиг явах тавилантай улсууд шүү» гэсэн юм. Цэен гүн алсын хараатай болохоор намайг өндөр тушаалд дэвшүүлж чадсан. За ингээд бодоод үз дээ. Миний оронд чи байсан бол яах байсан бэ?

Иван Степанович ингэж ярьж суухдаа хятад янжуур уугиулж, морин шилтэй архиа ганцаараа хөнтөрч орхисон боловч ухаан алдталаа согтсонгүй. Харин нэг сайхан улаан зээрд болтлоо халжээ. Сафронов, Харбинд ирснийхээ дараа «Яах гэж цагаантантай нийллээ» гэж гутардаг байлаа. Тэгээд Унгернтэй уулзаж түүний даалгаврыг биелүүлэх гэж улайрч явснаа бодохоор өөрийгөө буудчихмаар үе олон удаа таарчээ.

Өвгөн Сафронов нэг өдөр хүүтэйгээ уулзаад "Борон Унгерн чамайг штабтаа ажиллуулахаар урьсан байна. Нөгөө улс төрийн хэрэгтнийг мөрдөн илрүүлэх товчоог удирддаг Спайло, надтай уулзаад чиний боловсролыг асууж байна. Би Цэен гүнгээр монгол бичиг заалгаж

сурсныг чинь хэлсэн. Олзуурхан баярлаж байгаа гэж яана! Чамайг штабтаа авч монголын хошуудаас хоол хүнс, агт морьд дайчлах асуудлыг эрхлүүлэх гэнэ. Хэрвээ тэгдэг юм бол бидэнд ашигтай. Барон Унгерны хөл үймээнийг ашиглаж чадвал баахан малтай болж мэднэ шүү. Эд чинь монголын хошуудад цэргийн алба гувчуур оноосон бичгээ чамаар хийлгэх нь зайлшгүй. Миний хүү монгол хэл, бичиг сурсныхаа ачийг одоо гаргадаг цаг" гэж ятгаж билээ. Ингээд Иван Степанович цагаантантай ганзага нийлүүлэн зуузай холбосон билээ. Сүүлийн хэдэн жил Сафроновын сэтгэлд Цэен гүнгийн хэлсэн үг юу юунаас илүү бодогдоно. Тэгээд ураг төрөл, ах дүүсийн эсрэг чиглэсэн цагдаагийн газрын болон тагнуулын газрын ажиллагааг мэдээд Юки, Сувдаа, Хасу Тоиши гурвыг хамгаалахыг өөрийн эрхэм үүрэг гэж үзэх болсон юм. Сафронов хоосон шилээ сэгсэрч үзсэнээ тагнайгаа хүчтэй ташиж шогшроод,

- Энэ чинь дүүрэн байсан биш билүү. Яасан амархан дуусчихав аа. Надя аа... Наденька гэж хэд хашхиртал зэргэлдээх өрөөнөөс гэрийн үйлчлэгч эмэгтэй орж ирлээ.

- Надя, Миний хонгорхон Наденька минь цаанаасаа нэг шил юм аваад ир гэхэд Надежда Михайловна толгой дохиод өрөөнөөс гарлаа.

- Би энэ хүүхнийг хүндэтгэдэг юм. Эцэг нь дорнод хятадын төмөр замын газар гэж байхад тэнд ажилладаг большевик хүн байсан. Харбинд 1917онд Зөвлөлт засаг тогтооход оролцож, томоохон тушаалтай явсан гэдэг. Харбины Зөвлөлт засгийг устгахад эцгийг нь цаазалсан юм.

Тэр үед найман настай байсан Надяг төмөр замын нэг орос ажилчин авч өсгөсөн гэнэ. Намайг шинэ албан тушаалд дэвшиж, оросын цагаачдын товчоонд ажиллах болсон тэр үед манай гэрийн үйлчлэгч болсон юм. Тун сайхан хүүхэн. Би Юкид хайртай болохоор анхандаа тоодоггүй байлаа.

Цэен гүнгийн гэрээсийг биелүүлэх ёстой болохоор би хүнийхээ мөсийг бодоод Сайнжаргалд сэтгэлээ хэлж чадаагүй юм. Би оргодол ч гэсэн хүн чанараа алдаагүй хүн шүү дээ.

Ингээд Сафронов дараагийнхаа үгийг хэлж амжаагүй байтал нөгөө өрөөнөөс Надежда Михайловна морин шилний дундуур архи барьсаар орж ирээд ширээн дээр тавихдаа,

- Иван Степанович аа, одоо үүнээс илүү юм өгөхгүй шүү гэхэд Сафронов инээмсэглээд,

- Надя минь. Наденька минь. Би чинь ямар дандаа гудраад байдаг биш. Өнөөдөр Аяанаосутай дайралдсаны баярыг тэмдэглэх ёстой. Би сэтгэлийнхээ хамаг юмыг уудалмаар байна. Ингэвэл миний сэтгэл онгойдгийг чи мэднэ шүү дээ. Аяанаосу бол самурай биш. Энэ чинь жинхэнэ монгол хүн! Наденька минь муу юм битгий бодоорой гэлээ.

Надежда Михайловнааг гарсны дараа Иван Степанович хэсэг дуугүй сууснаа яриагаа үргэлжлүүлж,

- Аяанаосу сан, ер нь би чамайг Буянт гэж байя. Энэ япон нэрнээс бүүр залхаж гүйцлээ. Хажууд нь нэг нэр хэлээд сан, ши гэж илүү нялуун үг зүүхийг яанаа. Шал залхуутай юм. За би баахан бурчихлаа, Одоо чи жаахан яриач. Халх голд яаж манаруулж явснаа яриач. Дам сураг дуулбал тун паянтай явсан чимээтэй. Армийн штабынхан манай товчооны танилдаа

цуурсныг дам сонсвол нэг барга залуу Ёошийг салам жанчаад монголын хилийнхэнд тушаачихсан ч гэх шиг. Бараг үлгэр шиг юм жиг жуг гэлцээд байна. Үнэн үү? Тэр лүд тэгж үхэх ёстой байж дээ. Хасан нуурын ойролцоо Дигашели гэдэг сууринд манай хэдэн маанагуудыг байшинтай нь шатаачихсан новш доо. Тийм үхээр хүний муугаар үхэж байвал таарна гэж хорсолтой хэллээ.

Аяанаосу, Иван Степановичийн чин сэтгэлийн үгийг чагнаж суухдаа амьдралын үнэн мөнийг ойлгож, хар цагааныг ялгаж чаддаг болсон Сафроновт сэтгэлээсээ баярлана. Манжуур, өвөр монгол, хятадад явуулж байгаа японы армийн үйл ажиллагааг үзэн ядах сэтгэл төрсөн Сафроновын яриа чухамхүү сэтгэлийнхээ бухимдлыг тайлах төдий зүйл биш тэдэнтэй тэмцэх сэтгэлийн илрэл байлаа. Тэрээр алс дорнод монгол руу чиглэсэн квантуны армийн ажиллагаанд дургүй нь хүрээд өчүүхэн төдий цог ойртуулбал дэлбэ буудах гэж байгаа торхтой дарь шиг сэтгэлийнхээ хорслыг барьж ядна,

- Ёошигийн хувьд гэвэл тийм явдал тохиолдсон. Халх голын газар нутгийн байр зүйн зургийн судалгааг хийж чадаагүй явдалд жанжин штабынхан их дургүй байгаа.

- Токиогоос ирсэн газрын зургийн мэргэжилтэнгүүд манай товчооноос арваад хүн авсан. Тэднийг улаан армийн дарга хувцсаар хувцаслаж ашиглах юм гэнэ. Гэхдээ тийм ч их олзтой буцаж ирэхгүй байх. Квантуны армийн удирдлага Халх голын байлдааны ажиллагааг Комацубарагаар удирдуулж магадгүй. Тэгээд зогсохгүй, аягүй бол Доихарагийн удирдаж байгаа тавдугаар армийг оролцуулж мэдэх юм. Гэхдээ эд яаж ч бэлдсэн зорьсондоо хүрэхгүй. Энэ бол илэрхий гээд Сафронов шилэн аягатай архиа ус шиг залгилна. Иван Степанович Харбинд ирээд эхний хэдэн сар архийг ус цас шиг хэрэглэсэн болохоор түүнийг нь гадарладаг хүмүүс «Судсаар нь цус биш, архи гүйдэг болохоор зуун лүү архи уусан ч шургаж унахгүй хүн» гэдэг удаатай.

Иван Степанович, энэ үдшийг Аяанаосутай өнгөрөөхдөө эчнээнийхээ дарамтыг уудалж, сэтгэлээ уужруулахдаа бараг зургаан шил архи уусан атал царайгаар нь хөлс дааварлаад, жаахан ягаарснаас цаашгүй.

- Токиогоос ирсэн газрын зургийн мэргэжилтэнгүүд байр зүйн зургийг ахархан хугацаанд бэлэн болгоно гэдэг ч юу л бол доо. Одоо монголын хилийнхэн Номон Хан, Бүрд гэдэг хоёр жижиг овооноос цааш хүн байтугай, туурайт мал, тураг шувуу оруулахгүй. Тэгэхээр энэ хавар байр зүйн зураг бэлэн болгоод түүн дээр байлдааны сургууль хийгээд энэ зун Халх гол руу довтолно гэдэг ч гонжийн жоо биз дээ.

- Иван минь, япончууд цагаа тулбал байр зүйн зураггүй дайрч мэднэ шүү. Тэд самурайн ёс суртахуунаар цэргээ хүмүүжүүлсэн тул цэргүүд нь ялалт байгуулах, эзэн хааны төлөө амиа өргөх хоёрыг алдар гавьяа гэж үздэг. Тэд чинь ганцхан байлдахын тулд төрсөн хүн алах хүслэндээ автагдсан яргачингууд шүү дээ. Ингэж улайрсан гайхлууд хүний нутгийн хөрс хатуу гэдгийг ойлгохгүй. Тэгээд ч дарга нар нь хүний нутгийн шороо руу улаан нүүрээрээ шургаж үхсэн цэргийнхээ хүүрийг хожим өөрснөө зөөнө гэдгээ мэдээгүй яваа. Ганцхан ялна, дийлнэ, бурхны илгээсэн үхлийн салхийг өөрсдөдөө тусална гэдэг бодолтой болохоор Хатиманэ бурхандаа залбирч, өөрсдийнхөө толгойг хаана гээхээ гадарлаагүй байгаа гэж Аяанаосуг хэлэхэд Сафронов, түүний үгийг тоосон шинжгүй архиа балгасаар байлаа.

- Аяанаосу минь, чиний наад үг ортой байж мэднэ. Ойрын үед квантуны армийн штаб дээр Доихара ирж магадгүй байна. Манайхны яриагаар бол түүнийг «Номон Хан зикэна» ажиллагааг жанжин штабаас бэлдсэн тусгай нууц явуулгатай уялдуулах талаар армийн удирдлагатай тохиролцох талаар ярилцана гэж шуугиад байна. Зөвлөлтийн алс дорнод руу чиглэсэн ажиллагааг жанжин штаб «Найм дахь ажиллагаа» гэж товлосныг Разаевский мэджээ. Доихарагийн тавдугаар арми, энэ ажиллагааны дагуу байрлаж бэлтгэл хийж байгаа болохоор түүнийг Синьзингээс шууд Токио руу явна гэж төсөөлж байгаа хүн цөөнгүй гэхэд Аяанаосу,

- Квантуны арми биеэ эрчилж байгаа могой шиг бэлтгэлээ хийгээд байна. Ялангуяа японы цэргүүд саяхан хятадын Ханькоу, Кантон хотыг эзэлсэн нь квантуны армийн дарга нарыг хөөргөчихлөө. Тэгээд ч гадаадын улс төрийн тоймчид ялангуяа их гүрнүүдийн нөлөө бүхий хүмүүс «Японы эсрэг хийж байгаа хятадуудын байлдаан төгсгөлийн шат руугаа орж, японы талаас тавьсан болзлын дагуу гоминдааны арми бууж өгөх нь гарцаагүй боллоо» гэж шуугиан дэгдээчихлээ. Гоминдаан японд бууж өгвөл японы арми, хятадад байгаа бүх хүчээ Зөвлөлт, Монголын хил рүү илгээнэ. Тэр тусмаа хятад, өвөр монгол японы мэдэлд орчихоор цэргийн асар их хүчтэй болно гэсэн үг! Ийм үед герман, италийн фашистууд японтой сүлбэлдэж гурвал байгуулах нь эргэлзээгүй. Ингэвэл алс дорнод, монголын хилийн дагуу дайны голомт бий болно гэхэд Сафронов Аяанаосугийн үгэнд дургүйцсэн янзтай ярвайна.

- Буянтаа, чи намайг сорьсны хэрэггүй! Би монголд төрсөн орос сэтгэлтэй хүн. Герман, Итали, Япон гурав цэргийн эвсэл байгуулж мэднэ. Гэхдээ эдний хэн нь ч оросын ард түмний жинхэнэ сэтгэл санааг мэдээгүй. Орос хүн гэдэг чинь эх нутгаа амиараа хамгаалж чаддаг учраас Батын довтолгоонд ч, Наполеоны дайралтанд ч, интервенцийн бүслэлтэнд ч газар нутгаа алдаагүй юм. Үүний учрыг ойлгож мэдээгүй маанагууд өөрсдийгөө авслах авсны ам руу дөхөж байгаагаа мэдэхгүй байна гэж хашгиртал нөгөө өрөөнөөс Надежда

Михайловна орж ирлээ. Тэрээр Сафронов руу гайхсан харцаар ширтэж,

- Иван Степановичаа, таныг Разаевский сураглаж байна. Юу гэх вэ? гэхэд Сафронов,

- Тэр муу новш надаар яах гээ болоо гээд суудлаасаа өндийгөөд шилэн аягатай архиа авч ганцхан амьсгаагаар балгачихлаа.

- Иван Степанович минь та Разаевскийд надтай уулзаад ажил төрлөө ярьж байна гээд хэлчихсэн дээр гэхэд Сафронов толгой дохин зөвшөөрөөд Надежда Михайловна руу эргэж,

- Надя минь, чи миний орноос яриад квантуны армийн тусгай төлөөлөгч, ахмад Аяанаосутай уулзаж байна гээд хэлчих гээд сандалдаа буцаж суулаа.

Ерөнхий сайд Коноэ, өөрийнхөө суудлыг Хиранумаад өгч, өөрөө түүний хуучин ажлыг хүлээн авч, ерөнхий сайдын нууц зөвлөлийн дарга боллоо. Ингээд Хиранума өөрийнхөө засгийн газрын улс төрийн гадаад бодлогоо тодорхойлсон үгэндээ «Хятадын талаар баримталж байгаа бодлогондоо Коноэгийн гурван зарчмыг баримтлах болно» гэж тунхаглав. Тэгээд тэрээр Азид тогтоох эзэн хааны шинэ дэглэмийн талаар үг хэлэхдээ «Гадаад монголын асуудлыг төгс шийдэж, Алс дорнодоос улаан оросын нөлөөг зайлуулж, тэнгэрийн

илч тэнногийн шинэ дэглэмийг Азид тогтоож цэцэгжүүлнэ» гэж зарлалаа. Хиранумагийн энэ үг нэмэгдэхүүний байрыг сольсноос нийлбэрийн чанар хувирахгүй гэдэг онолын үндэслэлтэй ихэрлэжээ. Коноэгийн гурван зарчим гэдэг бол юуны өмнө их гүрнүүдтэй байгуулсан хятадын бүх гэрээг цуцлах явцад зөвхөн Япон-Хятадын найрамдлын гэрээ гэгчийг тогтоох хийгээд хятадад тогтоох японы улс төр, эдийн засгийн онцгой эрхийг олон улсын хэмжээнд зөвшөөрүүлээд эцэст нь Япон, Манж го Хятад гурвын хооронд цэргийн холбоо байгуулж номхон далайн нутаг оронд дэгдээсэн хэсэгчилсэн дайныг үргэлжлүүлэх замаар тэдгээр орныг эзэлж эзэн хааны эзэмшил болгоход чиглэж байлаа.

Японы жанжин штаб, гадаад монгол руу чиглүүлсэн ажиллагааг яаравчилж, шинэ оны эхний улиралд байлдааны төлөвлөгөөг боловсруулж танилцуулах нууц даалгавар квантуны армид өгчээ. Аяанаосу, Сафроновын ярианаас үүнийг гадарлангуут ажилдаа оржээ. Аяанаосуг ажилдаа орсны маргааш Хато түүнийг дуудлаа.

- Би маргааш Синьзин руу явна. Намайг ирэхэд Харбины шоронд байгаа эрүүгийн хэрэгтэн болон улс төрийн хоригдлуудын хэрэгтэй танилцаад судалгаа гаргасан байх хэрэгтэй. Ялангуяа

халх хэл мэддэг бичиг үсэгтэй хүмүүсийг гоц анхаарах хэрэгтэй. Ажлынхаа явцыг миний туслахад танилцуулж зохих ёсны туслалцаа авч ажиллана биз. Цагдаагийн газрын дарга шоронгоор орж, хүмүүс шилж олох явдалд туслах үүрэг авсан. Миний туслахаас тусгай үнэмлэх аваарай гээд ажил төрлийн заавар өглөө.

Аяанаосу, генералаас даалгавар аваад, өрөөндөө орж ирсний дараа «Хато ямар хэргээр Синьзин руу явах болов оо? Сафроновын хэлдэг өнөө ерөнхий төлөвлөгөөний талаар уу? Хоригдлуудын дотроос халх хэлээр сайн ярьдаг хүмүүс ол гэдэг бол хорлон сүйтгэгчдийг гүн ар талд хаях гэсэн санааны илрэл! Тозияа намайг явахын өмнө хэлсэн үгэндээ Халх голын ажиллагаа амжилтанд хүрэнгүүт монголын гүнд хорлон сүйтгэх хэсэг илгээнэ гэж байсан. Тэгэхээр тэр хэсгийг бэлдэх ажлыг эндээс эхлэх гэж байгаа байх нь» гэж бодлоо.

Аяанаосу бүх баримтуудыг харьцуулаад монголын гүнд илгээх хэсгийн дотор өөрийнхөө даалгавраар ажиллах итгэлтэй хүн олохыг ойлгож байлаа. Тэгээд Хатоог явсны маргааш хорих газар руу ярьж, хоригдлуудын хувийн хэрэгтэй танилцахаар шийдэв. Хорихын дарга ахмад Мураяама гэдэг халзан толгойтой даргатай очиж уулзлаа. Аяанаосу цэргийн тагнуулын газар, кэмпэйтэйн тусгай албаны хүмүүст олгодог үнэмлэхээ Мураяамаад үзүүлэхэд тэрээр албан үүргийн дагуу,

- Аяанаосу сан, улс төрийн хоригдлуудын дотроос бид армийн тагнуулын газрын даалгавраар хэдэн хүн шилээд байгаа. Хувийн хэрэг, хэрэгтний зан төрхийн товчлох хуудас (карт) энэ дээ гээд ханын шүүгээ рүү заалаа.

- Би урьдаар эрүүгийн хэрэгтний талаар сонирхоно,

Улс төрийн хэрэгтэнтэй сүүлд танилцъя. Эрүүгийн хэрэгтний дотор аль зэрэг олон толгойлогч байгаа вэ?

- Би толгойлогчдыг барьж шийтгэж байсныг мэдэхгүй. Тэд чинь ихэнх тохиолдолд баригддаггүй. Баригдлаа гэхэд барьцаар суллагддаг. Харин тэдний гар хөлийн хүмүүс бол манайд олон бий.

- Тэгвэл сайн хэрэг. Би тийм хүмүүстэй өөрөө уулзъя гэхэд шоронгийн дарга хоригдлуудыг дуудаж ирүүлэв.

Аяанаосу хэдэн хоригдолтой уулзаж жаал зугаа зүйл асуусан боловч тэдний хэн нь ч Аяанаосутай ярьсангүй. Тэгээд үдээс хойш арван нэг дэх хоригдлыг авчирлаа. Өндөр, туранхай биетэй гуч нэлээн гарсан, эрмэгдүү, гэжүүд байрын өвөр монгол эр орж ирээд Аяанаосугийн хөлөөс толгой хүртэл хэрсүүлэн ажиглаад, үл тоомсорлосон янзтай инээмсэглэв. Аяанаосу энэ хоригдлыг гарын уртай болохыг хувийн хэргийн товчлох хуудаснаас мэджээ. Аяанаосу түүний дэргэд ирээд хувны үнэр сэнгэнэхийг мэдээд «Мань хүн хуваар хутганы иш хийж байгаад иржээ дээ» гэж бодоод,

- Халаасан хуваар амьтны дүрс хийж чадах уу? гэж асуув. Хоригдол Аяанаосу руу сүрхий ширтсэнээ дуугарсангүй.

- Халаасан хуваар хутганы иш олныг хийгээ юу? гэж Аяанаосуг асуухад өнөө хоригдол тоомсоргүй байдлаар,

- Та яаж мэдээ вэ? Арай далдыг мэддэг далай ламтан биш биз гэж хятадаар муухан хэллээ.

- Мэдэж бололгүй дээ. Харин надад олигтойхон туслах хэрэгтэй байна. Болж өгвөл нарсанд биш наранд байгаа хүмүүсээс олбол зүгээр юмсан. Тэгээд сураг гаргахаар та нартай уулзъя гэж бодлоо. Та тийм хүмүүсийг мэдэх үү?

- Армийн тагнуулын газар тийм хүмүүсээр яах нь вэ? гэхэд Аяанаосу эчнээндээ «Энэ хоригдол намайг армийн тагнуулын газрын ажилтан гэдгийг гадарлажээ» гэж бодоод,

- Заавал армийн тагнуулын газар тийм хүмүүсийг сонирхдоггүй шүү дээ?

- Та энгийн хувцастай боловч цэргийн хүн гэдэг чинь цээж, толгой, алхаа гишгээнээс чинь илэрхий байна. Нөгөө талаар кэмпэйтийнхан өөрсдийнхөө туршуулыг хоригдлууд дотроос хайдаггүй юм.

- Надад бол кэмпэйтийн бүртгэлд орсон тийм хүмүүс хэрэггүй. Нэр алдар нь цуурайтсан хүмүүс бол хүний анхаарлыг их татдаг биз дээ.

- Тэгвэл та шинэ хувилгаан тодруулах нь уу? гэхэд Аяанаосу кэмпэйтийнханд нүдлэгдээгүй, эрүүгийн гэмт хэрэгтний толгойлогчдыг «шинэ хувилгаан» гэж хочилдог болохыг төвөггүй мэдлээ.

- Та миний бодлыг сайн гадарлажээ.

- Тэгвэл ацаг хөлсийг нь ярилцах уу даа.

- Одоо ярихгүй. Таны тодруулсан шинэ хувилгааныг шалгасны дараа ярилцъя. Тэгвэл үнэ хүрнэ шүү дээ.

- Таны хайж яваа хувилгааныг би тодруулж чадахгүй «даваа» байна. Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр гэдэг биз. Би уушиганд дуртай хүн шүү гээд дахиж дуугарсангүй. Аяанаосу, хоригдлын энэ үгнээс хамаг учрыг мэдлээ. Хато, Тозияа хоёр хоригдлуудаас эрүүгийн хэрэгтний толгойлогчдын хаягийг хайсан нь сохор зоос гарздахгүй гэж бодсоныг гэрчилнэ. Харин тэд яагаад заавал эрүүгийн хэрэгтний толгойлогчдыг сонирхсон учрыг Аяанаосу олсонгүй. Тэгээд нэг өдөр гоминдааны удирдлагын даалгавраар Харбинд ажилладаг өнөө нууц янхны газрын толгойлогчийг олж уулзах нь чухал гэж үзлээ. Аяанаосу, эрүүгийн хэрэгтний нэр алдаршаагүй толгойлогчдыг олохдоо хоригдлуудыг биш харин янхны газрын хүүхнүүд, түүний эзэн зам мөрийг нь гаргана гэдгийг ойлгов. Тэгээд нэг орой нууц янхны газрын цэнгээний өрөөнд орлоо. Тэрээр энгийн хувцастай очсон болохоор түүнийг сонирхсон хүмүүс байсангүй. Аяанаосу үдшийн цэнгээний газраас гараад шууд эзний нь өрөөнд очлоо.

Махлаг цагаан хятад, Аяанаосуг танингуут хөл алдан угтаж, өрөөндөө хоол унд бэлдүүлж япон дарга нарт үйлчилдэг хүүхнүүдийнхээ дээжийг авчирлаа. Аяанаосу, янхны газрын тэргүүнтэй аминчлан ярих хэрэгтэй болохоор тэр учраа сэм шивнэв.

- Бололгүй яахав. Хоёулаа ярьж бололгүй яахав гээд янхны газрын тэргүүн гараа зангахад үйлчлэгч хүүхэн өрөөнөөс гарлаа.

- Би Харбин дахь их гарын панзчдын дотроос золбоотойхон хоёр гурван хүн хайсан юм. Тийм хүмүүсийг чи мэднэ. Танай сайхан хүүхнүүд тэдэнтэй холбоотой байдаг гэж янхны газрын нууц ажиллагааг анддаггүй хүн шиг хэллээ.

- Их гарын панзчингуудыг (хулгайч дээрэмчдийн толгойлогч) цагдаагийн газар андахгүй. Тэдэнтэй холбоотой байна гэдэг чинь кэмпэйтэйнхны занганд орно гэсэн үг. Би түүнээс айдаг болохоор тийм хүмүүсийг бараг танихгүй.

- Жоу Яован сан, та тэдний шоожү(банди) нарыг танина гэдэг чинь надад тодорхой хэрэг! Тэгэхээр дүлгэнэх хэрэггүй гэхэд нууц янхны газрын тэргүүн хэсэгхэн бодсоноо,

- За яахав. Таньсан хүн байна. Би сураглахыг бодъё гэхэд Аяанаосу гурав хоноод ирж уулзахаар болзоод явлаа. Тэгээд Жоу Яовантай уулзахаар болзсон өдрөө ирэхдээ Аяанаосу, дүрэмт хувцастайгаа ирсэнд Жоу Яован сүнсээ зайлтал айжээ. Жоу Яован, Аяанаосуг армийн тагнуулын газрын ахмад болохыг ойлгонгуут түүнийг залилж болохгүй гэдгээ ухаарлаа. Тиймээс тушаасан бүхнийг биелүүлэх нь зайлшгүй хэрэг.

Жоу Яован Аяанаосуг мэндлэн угтаад «За энэ ахмадын гараас амьд салахгүй хэрэг боллоо. Энэ чинь тэр жил 06—09 гэдэг хүүхнээр түрүү барьсан нь жирийн хэрэг биш байж. Одоо хүлцэнгүй байх нь чухал» гэж бодоод,

- Ноён ахмадаа, би бүгдийг нь бэлдчихсэн. Энэ нэрийн жагсаалт нь гээд дөрөв нугалсан цаас энгэрийнхээ халааснаас гаргаж өглөө. Аяанаосу түүнийг нь авч нүд гүйлгэн уншиж

зогсохдоо,

- Энд байгаа хаягийг танаас өөр ямар ямар хүн мэдэх вэ? гэж асуутал Жоу Яован хэсэгхэн бодсоноо,

- Бараг мэдэх хүн байхгүй. Нэг хүн байж магадгүй. Тэр хүн одоо шоронд байгаа. Уг нь Балиус хочтой юмдаг. Одоо шоронд ямар хочтойг нь мэдэж чадаагүй. Нэг хүн түүнийг над руу Балиус гэдэг хочоор явуулаад надаас мөнгө зээлдэг байсан юм. Тэр хүн эдний хаягийг цөмийг нь мэддэг байсан гэж итгэл муутайхан хэлэв.

- Балиусыг явуулдаг хүний нэрийг хэн гэдэг вэ? гэж Аяанаосуг асуухад Жоу Яован хэлэх ёсгүй нэр хэлчихсэнээ мэдээд ухаан алдах шахлаа,

- Ноён ахмад аа, тэр хүний нэрээр та яах нь вэ? Танд огт хэрэггүй хүн! Зүгээр нэг хулгай....За тэгээд ч... ер нь л...

Жоу Яован үнэхээр хэлэх ёсгүй нэрийг санамсаргүй хэлчихсэн нь илэрхий болохоор Аяанаосу энэ эгзгийг зүгээр өнгөрүүлж болохгүй гэдгийг ойлгоод,

- Бид юм бүхнийг мэдэж байх ёстой! Хэн юмаа нууна түүнийг японы эзэн хааны армийн тагнуулын газар мэдэж байх ёстой. Мэдэж байгаа зүйлээ хэлэхээс зайлсхийсэн хүнийг бид өршөөхгүй. Тэр тусмаа бидний сонирхож байгаа зүйлийг нуусан хүнийг байлдааны цагийн хуулиар шийтгэнэ гэхэд Жоу Яован хэлэхээс өөр замгүй гэдгээ мэдэрлээ.

Түүнийг хар чоно гэж хочилдог юм гэж хэлээд үл мэдэг ээрэхэд Аяанаосу өөрөөсөө «Жоу Яован энэ нэрийг хэлэхдээ яасан их айдаг байна» гэж шивнэн асуулаа.

- Хар чонын гадаад байдал, нүүр царайны төрхийг хэл!

- Тэр чинь нүүр царайгаа дандаа хувиргаж явдаг юм. Нуруугаар гэвэл өндөр, өргөн цээжтэй, туранхайвгар биетэй, хижээлдүүхэн хүн бий. Гоц тэмдэг гэвэл зүүн чихнийхээ хэнгэрэг дотор улаан мэнгэтэй.

- Энэ хаягнуудыг миний гарт орсон гэдгийг хулгайч нарын хэн нь ч мэдэх ёсгүй. Энэ хаяг миний гараас хүнд шилжихгүй учраас та хий айсны хэрэггүй. Баталгаа нь гэвэл энэ гээд нэгэн бичиг өглөө. Энэ бол Аяанаосу үүний өмнө дөчин мянган иень солиулж авахдаа гаргуулсан Жоу Яованы баталгаа байлаа. Үүнийг Аяанаосугийн гараас салгаж авсан Жоу Яован сэтгэлдээ «Одоо 06—09 гэдэг янханд холбогдох зүйл баримтгүй боллоо» гэж бодоод дотроо баярлана.

- Ноён ахмад аа, хэрэв хэрэгцээ тохиолдвол би танд тусалж болно шүү гэж Жоу Яованыг хэлэхэд Аяанаосу,

- Би танд энэ бичгийг эхээр нь өгсөн боловч үүний гэрэл зургийн хувь үлдсэн гэдгийг мартаж болохгүй гээд өрөөнөөс гарлаа.

Аяанаосу, Жоу Яованы өгсөн хаягийг нарийн судлаад хулгайч нарын талаар тавих хяналтын

төлөвлөгөө гаргаад Мураяаматай очиж уулзав. Тэрээр ахмадын шаардлагын дагуу «Өнөө зөрүүд хоригдол буюу дархан» хочтой хоригдлыг дуудуулав. Аяанаосу дархан хочтын хувийн хэргийг үзэж байснаа,

- Танай дархан буюу катанакази чинь шоронд юу хийдэг юм бэ? гэж сонирхлоо.

- Голдуу хутга хийдэг юм. Хуучин бол мөнгөний авдрын түлхүүр хийдэг байсан гэлцдэг. Хянганы шоронгоос энд шилжиж ирснээс хойш дандаа хутга хийдэг болсон. Заримдаа дарга нарын захиалгаар когай (самурай нар байлдаанд зүүдэг хутга. Эрт үед самурай нар дайсныхаа толгойг когайгаар огтолж, ишнээс зүүж бүсэндээ хавчуулдаг байжээ) хийдэг юм. Тун гойд хийхийг нь яана гээч.

- Мураяама сан, танай тэр катанаки (дархан) хочит чинь өөр хочтой байсан уу?

- Үгүй шүү. Ердөө ганц хочтой. Бусад нь хоёр гурван хочтой байдаг. Хумс гэдэг хочтой нэг хоригдол гууль, давс гэдэг хочтой. Анхандаа бусад хоригдлынхоо талаар манайд ховлодог болохоор гууль гэсэн юм. Уг нь давс гэдэг хочтой байж л дээ. Сонссон зүйлээ даваадуулж буудахдаа сайн болохоор тэгж нэрлэсэн гэдэг. Сүүлийн үед нөхдийнхөө аар саар юмыг хулгайлчихаад байхаар нь хумс гэсэн. Харин дархан бол илүү дутуу зангүй. За тэгээд бусад хоригдлууд түүнийг хочлохоос айдаг гэдэг. Яагаад тэгж айдгийг хэн ч мэддэггүй юмдаг.

Аяанаосу Мураяама хоёрыг чингэж ярьж суутал дархан хочтыг авчирлаа. Түүнийг хоолонд орж байхад нь авчирчээ. Харгалзагч орж ирэнгүүт дархан хочтын талаар Мураяамаад товч илтгэж гурав хоног хоолоо идсэнгүй гэж илтгэхэд Мураяама түүнийг нь тоосонгүй.

- Дархан минь яагаад хоолоо идэхгүй байгаа юм бэ? гэж Аяанаосу энгийн байдлаар асуутал Мураяама түүний оронд,

- Наадах чинь тусгай ходоодтой юм. Хэрэг гарвал ганц дусал усаар хоол хийнэ гэж солиорохыг нь яана. Түүнийгээ батлахын тулд өдөрт хоёрхон аяга ус уугаад хэд хоног хоолгүй байдаг эр дээ.

Хянганы шоронд байхдаа их ид шид үзүүлдэг байсан гэдэг. Нэг удаа наадах чинь арав хоног худлаа үхэж үзсэн гэдэг. Тэгээд аваачаад хаях гэж байтал босоод ирсэн гэдэг гэж тайлбарлан ярилаа.

- Яагаад энэ тухай хувийн хэрэгт тэмдэглээгүй юм бэ?

- Наадахын чинь хувийн хэрэг алдагдаад байдаг юм. Бид Хянганы хорихоос хувийн хэргийн хуулбарыг нэхсэн. Одоохондоо ирээгүй байна. Аяанаосу, орж ирснээсээ хойш дуугүй зогсож байгаа дархан хочтын дэргэд ирээд,

- Наад сандал дээрээ суу гэж ойрхон байгаа сандал руу заалаа.

- Ноён ахмадаа, би суух дургүй хүн.

- Тэгвэл хэдэн цаг зогсож чадах вэ?

- Ноён ахмад аа, та хэдэн цаг сууж чадна, би тэр хүртэл чинь зогсож чадна. Тэгэхдээ ганц хөл дээрээ ингээд шүү гээд баруун хөлийнхөө өвдгийг нугалсхийн зогсож, нөгөө хөлөө нугалаад баруун хөлийнхөө гуян дээр ачаад хоёр гараа залбирах гэсэн шиг алга хавсран наманчлан барьснаа эгшний төдийд буулгаад ганц хөл дээрээ зогсохыг ажвал ёгоч хүн болох нь мэдэгдэнэ. Аяанаосу хэмээгдэх Гунгаа, найман жилийн өмнө тусгай ажлаар умард түвдийн хойд хэсэг Синьжааны өмнөд нуруу буюу Улугмузтаг нурууны өмнөд бэлд байдаг нэгэн хийдэд очихдоо ёгоч өвгөнтэй уулзсанаа саналаа. Тэгээд хожим Буянтын хэрэгтэй танилцаж байхдаа Гандан хийдийн нэгэн ламтай уулзаж японд дэлгэрсэн буддын шашны урсгал Синто ёсны шашны ёс горимын талаар тайлбарлуулахдаа хүрээнд барласан мянган бурхны тигийг сонирхож билээ. Тэр тигний дотор Хажид хэмээх бурхны баранд ийнхүү ганц хөл дээрээ зогссон бурхны олон хэлбэр зурсныг үзсэнээ санах.

- Дархан минь та, багадаа хаанахын хийдэд шавилж байсан бэ? гэж Аяанаосуг хэнэггүй асуухад,

- Долнуурын сүмд шавилж байсан гэлээ.

- Бурхны шавь яахаараа дээрэмчин хулгайч болдог байна. Тэгэхдээ банкны мөнгөний авдрын түлхүүрийг хийж сурсан хулгайч шүү?

- Ноён ахмад аа, та их юм сонирхож байгаа юм байна. Би энэ тухай танд тайлбарлахгүй гэдгийг мэдсээр байж цагаа хий гарздах гэсэн солиотой хүн шиг ингэж асуудаг чинь инээдэмтэй байна.

- Тэгвэл та яагаад ганц хочтой байдаг юм бэ? Хоригдлууд хоёр гурван хочтой шүү дээ?

- Хэрэв танд хэрэгтэй бол намайг тэвнэ гэж хочилж болно шүү гэхэд Аяанаосу дархан хочтой хоригдлыг ажиглан дуугүй эогсохдоо Гандангийн ламтай ярьснаа саналаа.

...Манай монголд дэлгэрсэн шарын шашин бол онцлог ёготой юм. Ёгочид дүвчингүүд ид шидтэй. Улайдсан хусуур долоож, хурц үзүүртэй тэвнээр нүүр завьжаа нэвт сүлбэхэд цус гардаггүй юм. Ялангуяа энэтхэг жагараар явсан бадарчингууд бол «Хатха ёго» сурчихаад үхээд хэд хоногийн дараа босоод ирдэг юм. Биеийнхээ цусыг нэг эрхтэн рүүгээ шахаж цусгүй болсон эрхтнээ тэвнээр сүлбэхэд хүмүүс их гайхдаг. Тэгээд хэд хоног ч явж чадна. Тиймээс ламын ёсонд хоол цай идэж уусны дараа лам хүн модон аягаа (тагшаа) чулуун дээр нэг үрээд авах ёстой гэж номлодог юм. Ингэхэд тагш нь амсраараа элэгдэж багасаад хожим олон жилийн дараа хэдэн дусал ус багтах хэмжээтэй болдог гэсэн. Тэр үед лам хүн хэдэн дусал усаа ууж, өөр хоол унд хэрэглэхгүй явж чаддаг болдог гэсэн.

Аяанаосу, дархан хочтын гадаад байдлыг хараад бага залуудаа өвөр монголчуудын дунд нэрд гарсан ёгоч хүний шавь байсныг төвөггүй мэдлээ. Тэгээд ганц хөл дээрээ зогсож буй дархан хочтын дэргэд ирж зогсохдоо зүүн чихний дотор талд хуруу дарам хэмжээтэй улаан мэнгэ байгааг ажиглаад Жоу Яованы хэлсэн үгийг санаад "Энэ чинь Хар чоно шив дээ. Тэгвэл Балиус нь хэн байх вэ?" гэж бодлоо.

- Таныг тэвнэ гэж хочилдгоос гадна бас өөр хочоор хочилдог шүү дээ. Хэрэв санахгүй бол

хэлээд өгч болно шүү гэж Аяанаосуг хэлэхэд,

- Эзэн нь өөрөө мэдэхгүй хоч байна гэдэг чинь та бүхний хайрласан хоч байж таарна даа гэж санамсаргүй байдалтай сөргөв.

- Үгүй шүү, таныг Балиус гэж хочилдог байсан. Тэгж хочилдог байсан хүний нэрийг надаар хэлүүлээд яахав гэхэд дархан хочит өрөөсөн хөлөө буулгаад хоёр хөл дээрээ зогсохдоо гайхсан гярхай ажигч нүдээр Аяанаосуг нэвт шувт ширтэнэ.

- Гайхах хэрэггүй. Таныг самурайн когай хийдэг болохоор чинь дархан гэж хочилдог болсон байна гэж Аяанаосуг түмэд аялгуугаар хэлэхэд дархан хочит хоригдол бүр гайхан ширтсээр байв. Хар чоно хэмээгч түмэд хүн билээ.

Гуравдугаар бүлэг

Сэтгэл шимшрүүлсэн жавар

Нэг. Цасан дээр үлдсэн мөр

1939 оны 1 сар. Сарын шувтаргаар монголын хил дээрээс ирсэн Симоно Синьзин руу явахын өмнө Аяанаосутай уулзлаа. Тэр хоёр хуучин найзын ёсыг баримталж "Модрен" буудлын зоогийн газар очлоо. Симотогийн царай бүрсгэр, сэтгэл тогтворгүй учраас үе үе санаа алдаж өөрийгөө тайвшруулна. Тэрээр ярих юмаа олж ядсандаа,

- Аяанаосу минь ажил төрлийн талаар ямар байна даа гэж асуулаа.

- Чиү са доноо (Ноён дэд хурандаа) минь.

- Чи намайг тэгж албархуу байдлаар хүндэтгэсний хэрэггүй. Ердөө үерхдэг янзаараа бай! Хоёулаа жаахан дэмийрье. Би эндээсээ гараад өнөө Жоу овогтны янхны газар очно гээд ширээн дээрх сакэтэй хундагаа авлаа. Симотогийн ажил хэрэг бүтэмж муутай болохоор тэр уухыг чухалчилж байгааг Аяанаосу гадарлав. Тэрээр уймарсан сэтгэлээ ингэж тайвшруулдаг зантай.

- Аяанаосу минь Юкигийн төлөөний түшмэд өнөө Ойдов энд бий юү?

- Бий шүү. Бид хоёр хааяа дайралддаг юм.

- Уг нь би чамайг танилцуулья гэж бодсон. Гэтэл чи танилцаж амжаа юү?

- Сафронов бид хоёрыг танилцуулсан юм.

- Тэгнээ тэр. Сафронов Юкийг өөртөө татахын тулд хөлөө хугалж мэдэх хүн дээ. Даанч цаадах нь тоодоггүй юм. Харин надад Тозияа сан хориг тавиагүй бол би түүнийг дэгээдчих байсан. За тэгэхдээ Юки удаан амьд явахгүй хүн гэхэд Аяанаосу,

- Уушиг муутай юм уу гэж асуулаа. Симоно, Аяанаосугийн энэ үгийг сонсоод «Тозияа түүнийг устгуулах юм» гэж хэлэх гэснээ болиод,

- Магадгүй уушиг... уушиг гэснээ хундагатай архиа балгаад,

- Уушиг гэснээс чи чинь наад элэг цөсөө эмчлүүлж байна уу, наадахаа эртхэн янзлуулж нэг эр хүн шиг болооч. Чамтай ийм газар ирэхээр урам хугарах юм гэж гоморхлоо.

- Тэгж байгаад эмчлүүлнэ. Одоо чинь ажил ундраад эмч домч гэж гүйх сөхөө алга байна шүү. Намайг энд хоригдлуудтай хормойгоо чирч ядаж байхад та нар чинь байр зүйн тодруулалтаа гүйцээчихээ биз дээ? гэж лавлан асуулаа.

- За яахав дээ. Оргүйд орвол охинтой болсон. Гэхдээ Токиогоос ирсэн мэргэжилтэнгүүд

сэтгэл дундуурхан байгаа бололтой. Монголын хил дээр нэмэгдэл хүч ирсэн болохоор Номон Хан, Бүрд-Овооноос цааш алхуулахгүй байна.

Шинэ оны эхээр баргын 100 гаруй морин цэрэг хилээр амжилттай гараад Хайлааст уруудаж явтал гэнэт урдаас минь гал нээлээ. Хилийн харуулын цэргүүд бидэнд мэдэгдэлгүй ар хударгаар минь ороод буцах замыг минь хаачихсан болохоор галын цагирагт орчихлоо. Тэгээд барга цэргүүдээр дайралт хийж бүслэлтийг сэтэлж, газрын зургийнхныг эсэн мэнд авч гарлаа. Нэг сарын аравнаас хойш хэсэгчилсэн цөөн хүний бүрэлдэхүүнтэй хил гарч ажлаа үргэлжлүүлэх арга боловсруулав. Ингээд өдөр бүр хилийнхэнтэй үзэлцэж, ширүүн галын дунд амиа алдах шахан явж байж жаал зугаа юм цуглуулсан. Хоёр сарын найманд нуурын хэсгээр шинэ ажиллагаа зохион байгуулаад барга цэргийнхээ баргийг алдсан. Тэгэхээр нь зургаа хоногийн дараа ихээхэн хүч хуримтлуулаад даагаа нэхэхээр Талын манхны чиглэлд гарлаа гээд Симото хундагатай сакэгээ балгаад хэсэгхэн зуур бодолхийсэн янзтай дуугүй суухдаа үе үе санаа алдав.

...Тэр өглөө цас орлоо. Симото агаарын байдлыг ажиглаад үүр шөнөөр 200 гаруй морин цэрэг, 150 явган цэргийн бүрэлдэхүүнтэй хөдөлж, Номон Хан, Бүрд-Овоонд хүрлээ. Чингээд таван цэргээ толгойн сэргийлэхэд гаргаад хил давуулав. Хилийн харуулынхан өчигдөр шөнө цасан оромжиндоо хоносон болохоор тэдний хувцас цан хүүрэгт цохиулж цав цагаан болсон тул толгойн сэргийлэхийнхэн хилийн цэргүүдийг анзааралгүй дэргэдүүр нь өнгөрч орхижээ. Тэд хилээр эсэн мэнд гарлаа гэж бодож явтал өөдөөс нь ширүүн гал нээжээ. Тэднээс үлдсэн ганц барга цэрэг ирж байдлыг Симотоод илтгэлээ.

- Аль зэрэг их хүч байна? гэж Симотоог асуухад өнөө барга,

- Ноён дэд хурандаа минь маш их хүч байгаа бололтой. Лав хороо цэрэг байгаа. Сум нь бороо шиг шаагьж байсан гэж сүр бадруулан айлдав. Симото барга цэргийн үгнээс баахан сүрдсэн боловч сэтгэлдээ «Энэ золиг айсандаа болоод худлаа хэлж байна» гэж бодоод тагнуул гаргалаа. Чингээд Симото баргын морин цэргийг хоёр хэсэг болгож, толгойг бүслүүлээд, дөрвөн бээр хэртэй газар машинаа зогсоож явган цэргүүдийг давшилтанд оруулав.

Давшиж байгаа цэргүүдийн араас Симото дурандаж зогсохдоо «Түрүүчийн цэрэг манхны оройд ойртлоо шүү. Ашгүй энд хилийн цэргүүд байхгүй байжээ. Түүнээс өдийд гал нээх болсон» гэж бодтол гэнэт пулемёт тачигнаж, япон цэргүүд сандралд орж эмх замбараагаа алдав. Энэ бүхнийг харж байсан Симото «Үйлсгүй золигнуудыг хараач, ухарч байна» гэж хараал зүхэл тавиад баргын морин цэрэгт дайрах дохио өглөө.

Симото, энэ манхныцаад талд газрын зургийн мэргэжилтэнгүүдээ гаргах ёстой учир ингэхээс өөр зам байсангүй. Гэтэл гэнэт хүчтэй дэлбэрэх чимээ агаарт хадаж, морьдын янцгаах чимээ, гол нь тасран амь тавьж байгаа цэргийн муухай зэвүүн хашгиралт Симотогийн чихнээ өртөн, бөөн цас агаарт цацагдан цагаан талд япон, барга цэргийн хүүр хар тарлантана. Симото цэргүүдийн зүг дурандаж «Энэ их буугаар галлаж байна уу даа?» гэж бодтол бүслэлтээ хумьж байсан морин цэрэг тал тал тийшээ бутарч, дэлбэрэлтийн чимээнээс үргэсэн морьдынхоо амыг дийлээгүй барга цэргүүд толгой хандсан зүг рүүгээ зугтааж байлаа. Симото хилийн харуулын цэргүүд их буугүй болохыг мэдээд «Үхээрийн баргуудыг хараач! Өнөө винтовын бөмбөг гэдгээс айж ухаан алдчих шахаж байгааг хараач!»

гэж цухалдан хэлээд өөрөөсөө холгүй хонхорт байгаа хуягт руу очиж,

- Одоохон очиж өөрийнхөө үхсэн цэргүүдийн хүүрийг олж ир! Монголын хилийн дотор япон хүний үхдэл байж болохгүй гэж чандлан тушаалаа.

Хуягт алгуурхан хөдөлж, цасанд дарагдсан манхны бэлээр явж, үхсэн япон цэргүүдийн хүүрийг цуглуулсаар нэгэн гангархуу судагт тулаад буцлаа. Үнэндээ тэр судгийн цаана гарсан бол хэсэг гранат боож барьсан хилийн цэрэгтэй учрах байжээ. Хуягтын жолооч ойр хавиасаа япон цэргийнхээ хүүрийг түүж хуягтаа дүүргээд эргэхэд Симото машиндаа суугаад Номон Хан, Бүрд хэмээх хоёр жижиг овооны зүг хурдалж хилээс гарлаа. Симото, Авдар сууринд ирэхэд баргын морин цэргээс ганц ч хүн буцаж ирээгүйг мэдээд тэд оргосныг ойлгов. Тэгээд баргын морин цэргийн дарга хошуучийг дуудан ирүүлж баахан загнаад, «Наадахаа таван зуу банзад» гэж тушаалаа. Японы армийн дарга нар өвөр монголд хэрэглэдэг эрүү шүүлтийг байлдааны цагийн хуулийн дагуу хэрэглэдэг төдийгүй ноцтой хэрэг үйлдсэн хүмүүсийг дор нь бууддаг байлаа.

- Аяанаосу сан, би энэ бүхнийг бодоод өөрийгөө буруугүй гэж үзэж байна. Энэ ажиллагааг Тозияа санаачилж, Уэда дэмжсэн болохоор учиртай. Ер нь байр зүйн материал цуглуулна гэдэг тийм ч амархан ажил биш гэдгийг Токиогийнхон ойлгосон. Тэгэхээр байр зүйн тодруулалтын ажлыг унагасан явдалд би буруугүй юмдаг.

Аяанаосу хэмээгдэх Гунгаа Симотогийн яриаг анхааралтай сонсож суухдаа Сафроновын ярьсныг санаж «Хүний нутгийн хөрс хатуу» гэдгийг үзэж дээ хэмээн бодоод сэтгэлдээ баяртай байлаа. Халх голын сав газрын байр зүйн тодруулалт хийх даалгавартай Токиогийн мэргэжилтэнгүүд ганзага хоосон буцсаны дараа Симото Харбинд хэд хоноод Синьзин руу явахад Аяанаосу гаргаж өглөө. Тэгээд галт тэрэгний буудлаас төлөөлөгчийн газар руу очиж Хатогийн туслахтай уулзав.

- Гакка, Синьзингээс ирэх болоогүй юү? гэхэд генералын туслах,

- Ирэх болоогүй. Танд хэлүүлэх юм байвал надад хэлчих. Би өнөөдөр утсаар ярина гэхэд Аяанаосу,

- Хоригдлуудын хувийн хэргийг судалж дууссан. Зарим нэг хүний талаар тодруулахын тулд кэмпэтайгийн шугамаар цугласан материалыг архиваас үзмээр байна гэхэд генералын туслах,

- Тухайлбал ямар хүнийг сонирхоо вэ? гэж асуулаа.

- Би хоригдлуудын дотроос Балиус, Хар чоно гэдэг хоёр хүнийг сонирхсон юм. Балиус нь шоронгоос олдсон. Тэр хүн Хар чонотой ямар нэг хэмжээгээр холбоотой байсан бололтой.

- Хар чоно... Хар чоно! Энэ чинь банк ухахдаа мэргэжсэн хүн байсан юм. Тэр жил Тяньжингийн англи банкныхан Жан Сюэлянгийнхнээс нэхээд байсан юмдаг. Жан Сюэляныг баригдсанаас хойш сураг нь гарахаа больсон гэж ярилцдаг. Зарим хүмүүс түүнийг үхсэн гэж үздэг юм.

Би эрхэм дээдэст илтгэж зөвшөөрөл авч өгье. Харин та, оросын цагаачдын товчооны Сафроновоос асуугаад үз дээ. Тэдний туршуулууд сургийг нь гаргаж мэдэх юм шүү гэлээ.

Аяанаосу генералын туслахын зөвлөсөн ёсоор Сафроновтой уулзахаар шийдэж ажил дээр нь очлоо. Сафронов, Аяанаосугийн хэрэг зорилгыг сонсоод,

- Хар чоныг барина гэдэг бүтэмжгүй асуудал. Барилаа гэж санахад кэмпэйтэйн удирдлагаас сулла гэсэн тушаал ирнэ дээ. Миний хувьд гэвэл түүний сургийг дуулснаас цаашгүй. Миний мэдэж байгаагаар бол английнхан түүнийг хайж байгаад больсон юмдаг. Манайхны нэг туршуул английн банкныхантай холбоотой байсан юм. Тэр Тяньжин дахь английн банкны нэг хүнээс хар чоныг Токиогийн кэмпэйтэйнхан сэмхэн аваачсан байна гэдгийг мэдсэн юмдаг. Би үүнийг үнэмшээгүй юм. Манай нэг туршуул Хянганы шоронд байж байхдаа Хар чонын сургийг гаргасан байсан. Түүнтэй уулзахаар хүн явуулсан чинь өнөөх маань хоригдлуудад зодуулаад хутгалуулчихсан. Ингээд сургийг нь гаргаж чадалгүй мухардсан юмдаг. Уг нь Разаевский түүнийг их сонирхдог байсан юм. Ойрын хэдэн жил Разаевский (Харбин дахь цагаантны оргодлуудын байгуулсан Оросын Фашист холбооны удирдагч) сураглахаа больчихсон байна. Хар чоно амьд байвал шоронд байж мэдэх юм. Чи өөрөө Хар чоныг сонирхоо юу? Эсвэл Хато даалгавар өгөө юу? гэлээ.

- Би өөрөө сонирхсон юм. Харин танайхаас Номон Хан, Бүрд-Овоо руу явсан газрын зургийн мэргэжилтэнгүүдэд тусалсан хэдээс ямар сонин дуулдаж байна даа?

- Тэдний энэ удаагийн ажил бүтээгүй. Тэгээд өөр арга олсон бололтой.

- Чи яаж мэдээ вэ? гэж Аяанаосуг асуухад Сафронов,

- Разаевский өнөө өглөө намайг дуудаад гарын ур дүйтэй, газрын зургийн томьёолсон тэмдэг мэддэг авхаалжтай хүмүүсийг ол гэж тушааж байна. Бодвол хуучин зургуудыг судалж, газрын зургийн загвар хийлгэх гээд гарын ур сайтай хүмүүсийг хайж байх шиг байна. Тэгэхдээ уран барималч хүн байвал сайн гэснийг яана. Гэтэл Харбингаас тийм оргодол олно гэдэг чинь шуудайтай цагаан будаан дотроос арвай олохоос доор бололтой гэлээ.

- Сафронов минь би чамд Харбинд байгаа зарим баригдаагүй хүмүүсийн хаягийг өгье. Чи үүнийг өөрийнхөө шугамаар шалгаад үнэн эсэхийг тогтоогоод над хэлээдэхээрэй гээд Жоу Яовангийн өгсөн хаягийг өгөв.

Аяанаосу энэ хаягийг дархан хочтой хоригдолд үзүүлэхэд тэрээр тоосонгүй. Жоу Яованы өгсөн хаяг үнэн бол дархан түүнийг уншаад айх юмуу сандрах байлаа. Гэтэл тэрээр ямар ч сэжиг гаргасангүй. Ингэхээр Жоу Яованы өгсөн хаяг хуурамч болох нь илэрхий. Нөгөө талаар Жоу Яован хуурамч хаяг өгснөө далдлахын тулд Аяанаосугийн шалгаж байгаа хүмүүсийн араас мөрдөж, тэднийг устгавал уул хаягийг хуурамч гэдгийг хэн ч баталж чадахгүй ажээ. Тиймээс Аяанаосу уул хаягийг Сафроновын хүмүүсээр шалгуулбал

Жоу Яованы хүмүүс түүнийг анхааралгүй өнгөрөх байжээ. Тиймээс Аяанаосу, Сафроновтой хэдэн зүйлийг ярилцаж тохирлоо. Үүнээс хойш дөрөв хонож байтал Харбины цаг сонинд эртний шаазан эдлэлийн цуглуулга худалдаж авах зарлал гарчээ. Тэр зарлалд Баасан гаригийн

15-17 цагт шаазан ваар худалдах хүсэлтэй хүмүүсийг хүлээн авах тухай бичсэнийг уншаад Аяанаосу холбоочноо Харбинд ирж уулзах болсныг мэдлээ. Чингээд хоёр хоноод Харбины төв цэцэрлэгт очлоо. Цэцэрлэгийн зүүн хойд булангийн сандал дээр суусан Ойдовын дэргэд Аяанаосу очиж суухдаа хэдэн жилийн өмнө энэ сандал дээр нэгэн эмгэн суугаад хувийн гар үйлдвэрт хийсэн жижиг шаазан тоглоом зардаг байсныг саналаа. Тиймээс Ойдов, Аяанаосутай уулзах албан ёсны уулзалтын нэг газрыг энд сонгон авсан байлаа.

Билгийн тооллын шар бар жил шувтрах дөхөж байлаа. Өвлийн сүүл сарын хуучдаар Шилийн голын чуулганы нэгэн томоохон лам, манжийн эзэнт гүрний сүүлчийн хаан агсан Пу Игийн лагшинг айлтган бараалхахаар Синьзин хотноо ирлээ. Квантуны армийн штаб тэр ламын хүсэлтийг хүлээн авч хянасны дараа Пу Итэй уулзуулахаар болжээ. Пу И гурван настайдаа (1909) манжийн хаан ширээг залгамжилсан. Гэтэл таван настайд нь Синкайн хувьсгал гарч түүнийг хаан ширээнээс огцруулжээ. Тэгээд хятадын засгийн газартай тохиролцсон ёсоор Бээжинд амьдрах болов. Гэтэл 1924 онд хятадын засгийн газрыг толгойлох болсон Фын Юйсян, Пу Иг хавчин эзэн хааны ордноос зайлахыг шаарджээ. Залуу хаан хятадын заналхийллээс зайлж амь тээхийн эрхэнд Бээжин дэх японы элчин сайдын яаманд хүсэлтээ уламжлав. Тэгээд элчингийн байранд хагас жил хоргодсоны дараа Тяньжин руу амь зулбан очиж хоргодох болсон. Тэр үеэс эхлэн Тозия, Доихара хоёр японы жанжин штабын даалгавраар Пу Игийн дэргэдийн хүмүүсийг хянаж алхаа гишгээг нь ажих болсон. Чингээд японы армийн гурван хашир Тозия, Итагаки, Доихара нар түүнийг анасаар 1932 он хүргэсэн билээ. Харин Пу И манжуурын хаан болсон тэр өдрөөс өнөө хүртэл квантуны армийн генерал Ёсиокава сүүдэр шиг дагадаг болсон. Ламтны барьц өргөлөө өргөсний дараа Ёсиокавагийн туслахууд ламтанг ордноос хөөж шахан гаргажээ. Тэр орой Тозия, Юки хоёр ламтанд бараалхахаар зочид буудалд очлоо.

- Гэгээн багштан минь, миний өчүүхэн бие, Их монгол улсыг байгуулахын тулд юуны өмнө гадаад монголын улаантны нөлөөг арилгаж, шашин төрийг хослон баригч наран гэрэлт Богд гэгээний есдүгээр дүрийг тодруулан хаан ширээнд залах хүсэл,сүсгээрээ эцгийнхээ гэрээслэлийг биелүүлэх санаатай бие, сэтгэлээ зориулж яваа минь энэ билээ. Сүүлийн жилүүдэд миний лагшин муудаж, ханиад томуунд ээрэгдэж, үйлс минь нэг л бүтэмжгүй байна. Би бар жилтэй хүн, жил минь хатуу ордог болохоор жилээ угтах юм уу, дагаж өвчин зовлонд ээрэгддэг ёртой.Иймээс миний лай ланчгийг үзэж гай түйтгэрээс салгаж өгөхийг аминчлан гуйя гэж Юки алд хадаг барин мөргөв. Ламтан эрхи татаж, гурав гурваар тоолж үзсэнээ, өврөөсөө бяцхан судар гаргаж үзсэний дараа зааны ясан шоо шившин орхилоо.

- Усан бар жил, эхийн хэвлийн харанхуйгаас могой цагт гарч нарт хорвоогийн гэгээг харж амжилгүй лусын хорлолд өртсөн байна. Тиймээс шар бар жилтэйгээ харшлаад ирэхээрээ тун их гай түйтгэртэй юм байна даа гэж айлтгахдаа «Энэ хүүхний талийгаач эцгийг тун их алттай гэж Жирмийн чуулганы ихэс дээдэс хүндэтгэн шагшдаг байсан. Тэгэхээр тэр алтыг гай зэтгэр болгож айлдвал миний үгэнд итгэж сүсэглэх байх» гэж бодоод,

- Үгээгүй дордсоос аваад ихэс дээдсийн хараал шүглэсэн шар өнгөтэй үнэт эдлэлийн гай чамайг ороожээ. Луу жилийн зуны эхэн сараас өмнө түүнийгээ анх авсан газарт нь хүргэж өгвөл гай зэтгэр чинь арилах юм байна. Тэгэхээр одоо буяны зам бодож аврал гүрэм буулгуулсан дээр гэж айлдав.

- Гэгээн багштан минь тэр лай ланчгаас салгах аврал гүрмийг та айлдаж хайрлавал яахсан бол гэж Юкийг гуйхад ламтан,

- Хойтон жилийн намрын дунд сарын эхээр Гэгээн сүмд бараалхаж Гомбогүрийн бүтээл хуруулбал чиний цаашдын үйлст ачтай. Ер нь Абтай сайн хаан Гомбогүрийг анх залж монголд шашныг үндэслэсэн болохоор тэр уламжлалыг дагавал чиний үйлс чинь бүтнэ. Харин давын өмнө эх болсон зургаан зүйлийн хамаг амьтны тусын тулд ядуус, дээдэс, хүүхэд, нохойноос авахуулаад шавж хорхойг ч баярлуулах хэрэгтэй гэж айлтгахад Тозиягийн сэтгэлд нэгэн бодол төржээ.

Тозия, Халх гол, Хайлаастаар барга айл оруулах замаар байр зүйн судалгаа хийх гээд хамаг ажлыг унагасан. Тэгээд энэ хариуцлагаас мултрахын тулд Шилийн худгийн овооноос Хулд уул хүртэлх газар нутгийн байр зүйн судалгааг хийхдээ хилийн мөргөлдөөнийг ашиглах арга сэдээд Симотоогоор удирдуулсан бөгөөд монголын хил рүү 25 удаа халдлага хийгээд ямар ч амжилт олсонгүй. Ингэж үр дүнгүй болсон ажиллагааны хариуцлагаас Симотоог мултлахын тулд барга цэргийн урвалт, аймхай хулчгарт тулгуурласан

Тозия, армийнхны амыг аятайхан тагласан билээ. Гэсэн ч жанжин штабын төлөөлөгч нар хил дээр очиж үзэх хийгээд «Номон Хан зикэна» төлөвлөгөөг хэлэлцэх асуудлаар удахгүй Синьзинд ирэх ажээ. Урьдчилсан төлөвлөгөөгөөр бол тэд 2 дугаар сарын 21-нд ирэх бөгөөд хоёр хоног нууц төлөвлөгөөг хэлэлцэх ёстой байлаа. Гэтэл билгийн улирлын тооллоор бол 2 дугаар сарын 25-нд бар жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгэн ажээ. Монголын цагаан сараар Тозия, жанжин штабын төлөөлөгч нарыг дайлж, гарыг нь цайлгавал түүний талаар жанжин штабт илтгэх илтгэлийг зөөлрүүлэх талтай. Чингэж чадвал Симотоог цагаатгах «далим» гаргаж, хилийн чанадад хийсэн ажиллагаанд холбогдох алдаа, доголдлыг жанжин штабын удирдлагад танилцуулахгүй өнгөрч болох болой. Иймээс Тозия ламын хэлсэн ёсоор «Ихэс дээдэс, ядуусыг баярлуулах» дайллага хийлгэхийн тул Юкийг ятгаж, зөвшөөрүүлэх хэрэгтэй аж. Тозия өөрийнхөө энэ бодолд хүрэхийн тул нэгэн үдэш сурсан заншлаараа Юкигийн өрөөнд орлоо. Юки ч Тозиягийн санааг гадарладаг болохоор түүний үгийг сонсохоор шийдэж дуугүй сууна.

- Юки минь, чи ер нь их ядарчээ дээ. Бие чинь барагтай байна уу? гэснээ,

- Өнөөдөр чинь хуучин тооллоор бол хэдний өдөр вэ? гэлээ.

- Өвлийн сүүл сарын 20 биз дээ гэхэд Тозия,

- Хорин... гээд амандаа шивнэхдээ;

- Одоо ес хоног үлдэж байгаа юмаа гэж хэлсэн нь Юкийд тод сонсогдов.

- Ааваа та юу гээд байна? Надад юм хэлэв үү?

- Одоо чинь ес хоноод цагаан сар болох юм байна. Ламтангийн үг санаанд ороод. Ер нь цагаан сар хийвэл зүгээр юм биш үү? Чи чинь жилээ угтаад байх шиг байна. Тиймээс цагаан сар хийж, жил зүгээ үзүүлсэн дээр. Бас тэгээд ихэс, ядууст өглөг өгсөн дээр биз дээ гэж

аятайхан аргадангуй хэлж ятгалаа.

- Аав аа та яасан сайн юм бэ? Дандаа миний төлөө санаагаа зовоож явах юм. Би талийгаачаас хойш цагаан сар хийсэнгүй. Ер нь цагаан сар хийж сан тавиулж, даллага ч авуулъя. Одоо ес хоногт хамаг юмаа бэлдэж амжина шүү дээ. Харин армийн штабынхнаас хэн хэнийг урих вэ? гэв.

- Би нэрийг нь гаргая. Жанжин штабаас Синьзинд хүмүүс ирнэ. Тэднийг ч гэсэн урьсан дээр. Тэд нар Халх голын байлдааны төлөвлөгөөг хэлэлцэх юм. Би чамд хэлэх гээд мартчихсан байна. Халх голд явуулах ажиллагааг Уэдагийн саналаар «Номони Хан зикэн на боппацу буюу Номон Ханы ажиллагааны эхлэл» гэж урьдчилан нэрлэсэн. Үүнийг ердөө хэдхэн тооны хүмүүс мэдэж байгаа гэж сайрхан хэлэхдээ хэдэн хүний хэмжээнд мэдэгдэж байгаа нууцаа хэлэхээс ч буцсангүй.

- Ааваа тэгвэл жанжин штабынханд цагаан сарын бэлэг бэлдэх хэрэгтэй. Тэгэхдээ нүүр улайлгахгүй дорвитойхон бэлэг барих юмсан гэхэд Тозияа Юкигийн саналыг дагуулж,

- Одоо чинь алтан цаг үнэтэй бэлэг шүү дээ. Харбины герман худалдаачидтай ярилцаж, швейцараас алтан цаг авчруулж амжих байх шүү гэхэд Тозияагийн саналыг зөвшөөрсөн Юки,

- Тэгье. Та герман худалдаачидтай ярилцаарай гэлээ.

Тозияа юм бүхнийг нарийвчлан боддог болохоор түүнийхээ үр дүнг заавал гаргадаг. Тиймээс цагаан сарыг яаравчлан бэлдүүлсэн нь талаар өнгөрсөнгүй. 1939 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Пүрэв гариг. Хүйтний эрч буураад Синьзин хотын өндөр барилгын эзвэр газрын цас хайлж, тарлангав. Квантуны армийн штабын хашаанд өглөөнөөс хойш олон машин ёслолын жагсаалд оролцох гэж байгаа юм шиг эгнэсэн байлаа. Армийн удирдагчийн өрөөнд өвөр монголд байгаа тусгай дивизийн дарга нар, Долнуур, Жэхэ (Чандэ), Хаалган, Харбин, Мугдэнгээс ирсэн генералууд цуглажээ. Цонхны дагуу зассан урт ширээг тойрч суусан тэдгээрийг квантуны армийн удирдагч Уэда толгойлж, түүний баруун гар талд тавдугаар армийн дарга Доихара, Тозияа, манжуурын эзэн хаан Пу Игийн зөвлөх Ёсиокава, Хато, Комацубара нар заларчээ. Урт ширээний өмнө томсгосон масштабтай газрын зураг өлгөсөн агаад тэр зураг нь Буйр нуураас Эрс уул хүртэлх газар нутгийг хамаарчээ. Газрын зураг дээр Шилийн худгийн овооноос Хулд уул хүртэлх газрыг дөрвөлжлөн онцолсон байлаа.

Тэр зургийн баруун талд Баянтүмэн хавийн газрын зургийг өлгөсөн агаад түүний баруун булан дээр хирагана үсгээр "Чикчирак" гэж бичсэнийг ажвал "Эзэнгүй нутаг" гэсэн үгнээс гаралтай хураангуйлсан үг байлаа. Энэ зургийг 1923 онд жанжин штабынхан боловсруулсан бөгөөд Монголын зүүн хязгаарын Гурван Баян уулын ойр хавийг тэмдэглэж түүгээр цагаантангуудын томоохон хэсгийг оруулсны дараа японы армийг монгол илгээхэд зориулсан ажиллагааны зураг байлаа. Энэ зургийн доохон талд нэгэн зурмал газрын зураг өлгөснийг ажвал Сэцэн хан аймгийн захын Да вангийн хошуу нутгийн зураг болой. Үүнийг Пу Игийн зөвлөхийн тусламжтайгаар Манжийн хааны архиваас олжээ. Газрын зургуудын доохон талд уртаараа таван метр, өргөнөөрөө гурван метр хэмжээтэй модон хашлага бүхий товоймол загвар дэлгэн тавьсан нь газрын зурагт түшиглэж хийсэн макет байлаа. Байр зүйн зураг, түүний товоймол загварын талаар жанжин штабын нэгэн дэд хурандаа тайлбарлан ярьж,

тодруулалтын ажлын дүнг илтгэв.

- Эрхэм дээдэс ээ, газрын зургийн байр зүйн тодруулалтыг хийхдээ газар дээр явуулсан хэсгийн материал, 1923 онд боловсруулсан «Гурван Баян» гэдэг төлөвлөгөөний зураг, Манжийн хааны архиваас авсан Дэ вангийн газрын зурмал зураг, 1932 онд Шанхайд хэвлэсэн Хуа Циюньи гэдэг хүний «Хятадын хил» гэдэг сурвалжуудыг ашигласан юм. Бидний судалгаанаас үзвэл Шилийн овооны баруун талаас Хулд уул хүртэлх газар нутгийг армийн ажиллагаанд хамгийн тохиромжтой гэж үзэж байна.

Энэ нутгийг захын Дэ вангийн зурагт тэмдэглэхдээ Шилийн худгийн овоог 19 дүгээр овоо гэж тэмдэглэсэн бөгөөд 20 дугаар овоо нь Номон Хан, Бүрд гэдэг овоо, 21 дүгээр нь Хулд уулын овоо, 22 дугаар нь Эрс уулын овоо болно. Энэ зурагт одоогийн Хайлааст голыг Хулстай гол гэж тэмдэглэжээ. Уэда, дэд хурандаагийн яриаг сонсож сууснаа,

- Чиү са, Монголын хилийн овоо гэж үзэж байгаа бол энэ чинь бидэнд хэрэггүй зүйл. Бид чинь энэ газар оронг Баргын нутаг гэж батлах ёстой шүү гэж анхааруулав.

- Гакка, энэ зургийг Бадруулалт төрийн 33 дугаар онд (1907) хийсэн болохоор бид газар нутгийн нэрийг ашигласан юм. Бидэнд армийн ажиллагаанд онц хэрэгцээтэй өндөрлөгүүдийн нэрийг газар дээр нь тодруулах боломж байгаагүй гэж тайлбарлав. Дэд хурандаа яриагаа буруу эхэлснээ мэдээд "Илүү дутуу юм бурахаа больё" гэж бодоод Хайлааст, Халх гол хавийн газрыг Шанхайн зураг дээр тулгуурлан тайлбарлахыг чухалчлав.

- Халх гол бол манай армийн ажиллагаанд ашигтай усан хаалт болох нь дамжиггүй. Ялангуяа энэ хэсгээрээ 50-130 метр өргөн, зарим газраа 3 метр гүн, гарамгүй, ширүүн урсгалтай. Голын ёроол ихээхэн хайргатай. Голын хөндий дагуу намаг шавар ихтэй. Хамар даваанаас, Баян Цагааны нуруу хүртэл огцом өндөр гангатай болохоор тактикийн хувьд манай талд ашигтай.

Голын наад тал тухайлбал хил талын өндөрлөгүүдээс ч Баян Цагааны нуруу хүртэлх газрууд ил харагддаг төдийгүй эдгээр өндөрлөгүүдийн хооронд гүн хонхор, хотгор ихтэй учраас манай танк, хуягт, машин техникүүдийн хөдөлгөөнийг улааны талаас халхалж чадна. Халх голд цутгаж байгаа Хайлааст гол монголын цэргийн хүчийг хоёр хэсэгт хувааж хүчний байрлалыг эвгүй байдалд оруулж чадах тул байлдааны ажиллагаанд манай талыг тохиромжтой нөхцөлөөр хангаж байгаа хэрэг! Голын тахиралдсан тохой, хотгор гүдгэр газрууд нь манай армийн хүчийг байрлуулахад тун тохиромжтой. Бидний сонгож авсан энэ хэсэг бол армийн хүчийг шилжүүлэх, зэвсэг техникийн тээвэрт онцгой ач холбогдолтой гэж үзэж байна.

Нэгд бид энэ газрыг армийн ажиллагаанд сонгож авсан явдал бол юуны өмнө Хайларын төмөр замд түшиглэв. Хайлараас Жанжин сүм хүртэл дардан замтай төдийгүй Ханширээ хүртэл төмөр замтай юм. Иймээс армийн хүчийг товлосон газар шилжүүлэх зам харилцааны талаар бүрэн хангамжтай гэж үзэж болно. Ялангуяа Хайлараас Ганжуур хүртэлх 150 км төмөр замыг юм уу эсвэл Ханширээгээс Жанжин сүм хүртэл 100 орчим км төмөр замыг хоригдлын хүчээр хавраас эхэлж тавиулбал зам харилцааны асуудлыг бүрэн төгс шийднэ.

Хоёрт: Монголын тал энэ чиглэлд төмөр замгүй. Ар талаасаа 800 орчим км алслагдсан учраас ар талын хангамжийн хувьд барьц алдах нь эргэлзээгүй гэж дэд хурандаа Халх голын хавь газар явуулах байлдааны ажиллагаанд ашиглах байр зүйн зураг, армийн цэрэг зэвсгийг товоймол загвар, сургууль хийлгэх ач холбогдлын талаар дэлгэрэнгүй ярилаа. Дэд хурандаагийн ярианаас лавлаж асуусан генералуудын дотроос Комацубара түүний хэл амыг сугалчих шахлаа.

- Чиү са, манай армийг монголын хилийн дотор байрлуулахад ашигтай газар олон бий гэж байна. Тухайлбал ямар ямар өндөрлөгийг ашиглавал цэрэг, зэвсгийг шилжүүлэхэд ашигтай вэ?

- Бид газрын зурагт орсон чухал өндөрлөгийн нэрийг тодруулах боломжоор тун бага байсан. Тиймээс чухал чухал өндөрлөгүүдийг товлосон нэрээр нэрлэсэн. Жишээ нь Фуй (Хуруу өндөрлөг) гэж энэ өндөрлөгийг нэрлэсэн гээд газрын зураг заангуут яриагаа үргэлжлүүлэн,

- Энэ өндөрлөгөөс баруун тийш, Хайлаастын солгой талд байгаа энэ өндөрлөг хүртэл асар уужим хонхор газар бий. Түүнийг ашиглавал танк, хуягт, машин, ер нь цэргийн тээврийг нууцалсан харилцах суваг болгож болно. Өөрөөр хэлбэл Фуй өндөрлөгөөс бидний урьдчилан товлож нэрлэсэн Такасай (Өндөрлөг) хүртэлх энэ

хонхрыг танк, хуягт машин явахад зориулсан газар доор байгуулсан цооног нүх (тунель) шиг ашиглаж болно гэхэд Комацубарагийн дэргэд сууж байсан хорин гуравдугаар дивизийн штабын дарга,

- Таны ярьснаар бол бид Фуй өндөрлөгийг ашиглаж ар талаа бэхжүүлэх зорилгоор газар доор тусгай байгууламж байгуулж болох юм гэж ойлгож болох юм шив дээ гэж асуулаа.

- Та миний яриаг маш зөв ойлгосон байна. Бид Фуй өндөрлөгт инженерийн томоохон байгууламж байгуулж газар доор хүнс болон зэвсгийн агуулах, цэвэр усны нөөц, эмнэлэг, агт морьдын байр байгуулах боломжтой юм гэхэд дарга нар дэд хурандаагаас асуух зүйлээ мухарлав. Цуглааны эцэст Уэда суудлаасаа босоод,

- Өнөөдөр зөвхөн Халх голын газар нутгийн байр зүйн тодруулалтын ажлын үр дүнг ярилцаж байгаа юм. Саяын баримтан дээр түшиглэж Халх голд хийх ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулаад гурав хоногийн дараа надад бичгээр өгөх хэрэгтэй! Харин одоо та бүхний сонорт аятай мэдээ дуулгая. Тозияа саны ачлалт охин цагаан сар тэмдэглэж байгаа тул та бүхнийг урьжээ. Иймээс маргааш Тозияа саныд очих нь байна гээд өөрийнхөө дэргэд сууж байгаа жанжин штабын төлөөлөгчөөс,

- Танд хэлэх юм бий юү? гэж лавлав.

- Цуглааны дараа Доихара, Комацубара, Тозияа гурвыг үлдээчих гэхэд Уэда, гурван генералыг үлдэхийг дуулгатал цугласан хүмүүс Уэдагийн өрөөнөөс гарлаа. Гэтэл жанжин штабын төлөөлөгч,

- Халх голын ажиллагаанд Комацубарагийн дивизийг бэлтгэхээр санал оруулсан. Чиү

жѐогийн (дэслэгч генералын) дивиз байлдааны бэлтгэл сайтай байгаа гэж үзэж байна. Тиймээс чий жѐо Комацубара сан цэргийн зэвсэгт хүчний талаар нарийн судалгаа гаргаж цэргийн яаманд тавих саналаа бэлдэх хэрэгтэй.

Байлдааны төлөвлөгөөнд тусгасан ёсоор тавдугаар армийн (Доихарагийн) техникийн ангиудыг оролцуулна гэдгийг бодох хэрэгтэй!. Тиймээс газрын зургийн байр зүйн тодруулалтанд түшиглэж хийсэн загвар товоймол макет дээр байлдааны ангиудыг тун сайн сургуулилуулах нь чухал! Нөгөө нэг асуудал бол монголын гүнд ажиллах ёстой тусгай даалгавартай хүмүүсийг сайн бэлтгээд удирдлагад тацилцуулах, тэдний гүйцэтгэх үүргийн талаар Тозияа сан илтгэл бэлдэх шаардлагатай гэж үзэж байна.

Эцэст нь хэлэхэд Халх гол руу чиглэсэн ажиллагааг маш сайн нууцлах ёстой учраас Хайлар Манжуур болон Ханширээгийн төмөр замыг шинээр тавих ажлыг цэрэг байлдааны зориулалттай гэдгийг нууцалж барга болон гадаадын сонин сурвалжлагч нарт аятайхан сэтгэгдэл төрүүлэх ажиллагаа зохион байгуулах нь чухал. Үүнийг Тозияа сан удирдах нь зохимжтой гэж үзэж байна. Бидний үзэж байгаагаар бол төмөр замыг монголын хил рүү ойртуулж тавих гэж байгаа явдлыг зөвхөн орон нутгийн ард түмний амьдралын шаардлага хэрэгцээнээс үүссэн гэдэг сэтгэгдлийг бүх хүнд төрүүлэх ёстой. Ингэж чадвал бид монголын тагнуулуудаас болон улаан армийн удирдлагаас Халх гол руу чиглүүлсэн ажиллагааг бүрэн нууцалж чадна. Тиймээс Тозияа саны саналыг ойрын үед штабын удирдлага бүрэлдэхүүнээрээ сонсож зохих зөвлөгөө өгөх нь зүйтэй гэж үзэж байна гэлээ. Жанжин штабын төлөөлөгчийн дараагаар Тозияа,

- Сайд нарын зөвлөл «Кобуко коцу» гэдэг төмөр замын нийгэмлэг байгуулах шийдвэрийг зарчмын хувьд зөвшөөрсөн боловч албан ёсны болгоогүй байна. Иймээс жанжин штаб энэ нийгэмлэгийг ажилдаа орох асуудлыг түргэлүүлбэл миний асарсан охин, тэр нийгэмлэгт хувь нийлүүлж хоршихоор шийдсэн. Юкийг тэр нийгэмлэгийн хувь нийлүүлсэн гишүүн болговол Хайлараас Манжуур, Ханширээгээс Жанжин сүм хүртэл тавих төмөр замыг иргэний зориулалттай гэдгийг нутгийнхан болон гадаадынханд итгүүлж чадах ажиллагааг бүрэн зохион байгуулж болно.

Ер нь эрхэм дээдэс маргааш Юкитэй уулзахдаа Халх гол Буйр руу чиглэсэн төмөр замыг японы арми биш монголын үндэсний үзэлтэй сэхээтэн, язгууртны гараар байгуулах ёстой гэдгийг ойлгуулж дэмжихийн зэрэгцээ богдын алтыг хэрэглэх нь манай армийн ажиллагаанд дэмжлэг болно гэсэн сэтгэгдэл төрүүлэх болов уу гэж бодож байна гэж санал гаргалаа.

Зочдын өрөөний ханын дагуу II маягийн хэлбэртэй зассан ширээн дээр ул боов тэвхийтэл өрсөн арван таваг идээ, чихэр, жимс засаад хэд хэдэн ууц тавьсны зэрэгцээ далайн ногоо, хүйтэн зууш тэргүүтнийг алаглуулан засжээ. Таваг дүүрэн овоолсон бууз барьсан үйлчлэгч нар квантуны армийн дарга нарт таваглаж, архинд халсан хүмүүс бууз сонирхоно. Ширээний голд Уэда, Доихара, Комацубара нар тэргүүлж, Сафронов, Симото, Тогава, Ойдов, Ёсиокава нар зэрэгцэн суусан байлаа.

Дэнхгэр толгойдоо зохиогүй дэлдэн чихтэй, унжуу хамартай Доихара бусдаас чанга тас тас хөхөрч, Хато Комацубара хоёртой ярилцаж голланд жин балгах агаад Симото, Сафронов хоёр аминчлан шивнэлдэнэ. Харин язартлаа таргалсан Тогава, Халх гол, Номон Хан, Бүрд-

Овоогоор явснаа сайрхан эд бах болгож Ойдовт сонирхуулна.

Үд хүргэж эхэлсэн найрынханд Синьзин хотын захиргааны дэргэд байгуулсан «Киокавакай буюу үнэн итгэлтний» нийгэмлэг гэж алдаршсан байгууллагын харьяаны зоогийн газраас ирүүлсэн дуучин, бүжигчин нар ихэсийг зугаацуулан дуулж бүжиглэнэ. Зочдын ширээний ард биеэ хөштөл суусан зарим хүмүүс ширээний араас босож, ханын дагуух зөөлөн түшлэгтэй диван дээр сууж өмнөх явган ширээн дээр тавьсан архи дарснаас болор хундаганд хийж бие биенийхээ эрүүл мэндийн төлөө хундага өргөнө.

Гэйша нараас төдий холгүй байгаа нэгэн диван дээр Тогава, Ойдов хоёр суусан агаад Тогавагийн яриаг Ойдов амтархсан янзтай чагнана. Харин Ойдовын баруун гар талд суусан Хато, уянгалсан намуун хоолойгоор дуулж байгаа гэйша нарыг хайнгадуухан харж байснаа,

- Тозияа сан, танай ахмад Аяанаосу чинь овоо золбоотой сэргэлэн залуу байна. Хянганаас ирсэн хоригдлуудын дотроос өнөө Хар чонын сургийг гаргасан байна гэж бахархсан янзтай хэлэв.

- Түүнийг чинь Итагаки, Тозио, Доихара гурав хөөцөлдөөд байснаа ор сураггүй алдсан юм. Их ухаалаг залуу гэсэн шүү гэхэд Хато,

- Хар чоно чинь Жан Золингийн баруун гар гэж нэг хэсэгтээ мандаа биз дээ гэхэд Тозияа эрт өнгөрсөн нэгэн явдлыг санажээ.

...Хар чоно гэж алдаршсан тэр түмэд залууг хунхууз ашигладаг байжээ. Ялангуяа Манжуур өртөөнөөс Харбин руу чиглэсэн дорнод хятадын төмөр замаар явж байгаа галт тэрэг төдийгүй Харбинд байгаа оросын худалдаачдын үйл тамыг бардаг байжээ.

- Хато сан, та тэр Хар чоно гэдэгтэй нүүр учирч явсан уу? гэж Тозияа сонирхон асуухад Хато инээмсэглээд,

- Доихара уулзаж байсан гэдэг юм гэхэд Пу Игийн зөвлөхтэй ярьж суусан Доихарааг Тозияа дуудлаа. Тэрээр нэлээн халсан болохоор малигар цагаан царайгаа минчийлгээд инээж хөхрөөд сайхан зантай байлаа.

- Доихара сан, наашаа суугаач. Хато таны сураглаад олдоггүй танилын чинь сургийг гаргачихаад байна гэхэд Доихарагийн дэлдэн чих, чимээ авсан боохойны чих шиг сэрвэсхийн соотгонох адил хөдлөв.

- Юу? Та хоёр чинь ямар үхсэн үлийгээ өндийлгөөд байна вэ? гэж асуугаад согтуу нүдээр хоёр генералыг ээлжлэн ширтэнэ.

- Хар чоно амьд мэнд байгаа сурагтай байна гэж Тозияаг хэлэхэд,

- Магадгүй юм. Жан Золинг тонилсны дараа түүний хүүтэй дөрөө нийлүүлээд баахан шуугиан дэгдээгээд Жан Сюэляныг баригдсаны дараа гэнэт алга болсон юмдаг.

Манайхны олж мэдсэнээр бол Чуулалт хаалган дахь америкийн нэг пүүсний мөнгөний

авдрыг хоослоод алга болсон. Одоо нэлээн хэдэн жил болчихлоо. Амьд байдаг юмаа гэхэд дөч гарсан хүн байх ёстой гэхэд Тозияа Доихарагаас,

- Ер нь гадаад байдлаараа ямаршуухан хүн бэ? гэж шалгаалаа.

- Би Хар чонотой хоёр удаа дайралдсан юмдаг. Эхний удаа Жан Золинг оршуулах үед Хар чоно ирж Жан Сюэлянтай уулзаад явсан. Тэгэхэд залуухан, өндөр нуруутай, туранхайвтар, ширүүн харцтай, сүртэй эр харагдсан. Хоёр дахь уулзалт нь санамсаргүй болсон юм. 1935 оны 11 сард Тяньжинд хятадын таван мужийн төлөөдөгчидтэй уулзаж хурал хийлгэхээр очихдоо Хар чонотой дайралдсан юм.

- Чи чинь тэгэхэд умард хятадад тогтоох автономитын эрхийн талаар Нанжины төлөөлөгчидтэй уулзахаар яваа биз дээ.

- Тиймээ. Умард хятад манай цэргийн командлагч Тадагаас болоод тэр уулзалтыг тасалдуулж оронд нь би арга хэмжээ авахуулах шахсан. Тэр уулзалт тасарсан нэг шалтгаан бол Хар чонотой холбоотой байсан юм. Намайг Тяньжинд очиход английн банкны нэг салбарыг Хар чоно ухаад баригдчихсан байлаа. Гэтэл нэг өдөр Тада надтай ирж уулзаад «Хар чонын бие төлөөний хүн ирж уулзаад явлаа. Баригдсан хүмүүсийн амь насыг аюулгүй байлгах хийгээд суллах талаар тусалбал умард хятадын таван мужийн төлөөлөгчдийг ятгаж чадна» гэж амлаад байна гэлээ. Би тэр болзолд эргэлзсэн юм. Тэгээд Тяньжингийн шоронд очиж ямар ямар хүмүүс баригдсаныг ажтал баригдсан таван хүний нэг нь Хар чоно өөрөө байлаа. Английнхан Хар чоныг барьснаа мэдэлгүй маанагтаж байхад түүний шавиуд Тадатай холбоо тогтоож амжсан шалтгааныг мэдлээ. Хар чоно тэгэхэд гучин долоотой байсан юм. Жан Золинг оршуулах үед ирж байснаасаа их өөрчлөгдсөн байв. Ер нь зэрмэгхэн харсан хүнд танигдахааргүй өөрчлөгджээ. Би түүнийг зүүн чихний хэнгэрэгт байгаа улаан мэнгээр нь таньсан юм. Ингээд би Хар чоныг суллуулах талаар жанжин штабт танилцуулж удирдамж аваад суллуулсан юм. Хар чоно суллагдангуугаа Жан Золингийн өшөөг авахаар шийдэж, Бээжинд очиж умард хятадын таван мужийн төлөөлөгчидтэй уулзахдаа "Умард хятадад автономии байгуулах талаар японыхонтой тохиролцвол та нарыг хүйс тэмтэрнэ гэж мэдээрэй" гэж сүрдүүлжээ. Ингээд Хар чоно миний араар молигодчихоод алга болчихсон эр дээ.

- Доихара сан, тэр чинь түмэд хүн гэлүү?

- Уг гарлаараа цахар хүн байх ёстой. Эндээс тийшээ нүүсэн цахруудын удам судрын хүн. Цагтаа лам байсан. Их элдэвгэй, дүвчин лам байсан гэдэг. Та нар яаж сургийг нь гаргаа вэ?

- Ахмад Аяанаосу сургийг нь гаргасан бололтой байна.

- Аа мэдэхгүй. Би амьд яваа гэдэгт эргэлзэж байна. Хэрэв амьд голтой юм явдаг бол Хянганы шоронгийн хоригдлуудын дунд байж магадгүй. Хар чоно их зальтай хүн. Манай армийг Өвөр монголд суурьшсан болохоор Хар чоно өөрийгөө ил байж болохгүй гэж үзээд шоронгоос гар, хөлөөр удирдаж байж мэдэх юм. Түүнээс ил явахгүй гэхэд Тозияа сэтгэлдээ «Хар чоно... Хар чоно.Надад маш хэрэгтэй хүний нэг. Аяанаосу, үнэхээр түүний сургийг гаргаж чадсан болов уу? Тэгвэл өөрийн биеэр уулзаж Шанхай руу явуулаад Юкигийн хадгаламжийн талаар баримт олуулаад Юкийг Хар чоноор устгуулна. Шанхайн банкнаас алтыг нь авах дээрмийн ажил

зохион байгуулж болно!» гэж бодоод Аяанаосуг дуудаж заавар өгье гэж шийдэв. Хашир гурвыг чингэж ярьж суухад Тогава амандаа халж «Цасан дээрх мөр» гэсэн сайхан найруулал бичсэнээ ярьж суулаа.

- Энэ бол 2 дугаарын 17-нд болсон явдал. Цасаар шуурч байсан тэр өдөр монголын хоёр хороо цэрэгтэй манайхан ана мана үзэлцсэн юм. Монголынхон их буу, танктай байсныг яана. Гэсэн ч манай цэргүүд баатарлагаар тулалдаж монголын цэргийг сүйрүүлсэн дээ. Ингээд цасан дээр монгол цэргүүд хүүрээ үлдээгээд буцах нь тэр гээд Симото руу нүдний булангаар сэм ширтэнэ.

Тогава, Симотоог Синьзин руу явсан хойгуур Номон Хан, Бүрд-Овоо руу очжээ. Тэгээд Симотогийн удирдсан ажиллагаа бүтэлгүй болсныг дуулаад хэсэг бодлогоширчээ. Тэрээр болсон явдлыг үнэнээр нь бичиж болохгүй гэдгийг Хасан нуурын туршлагаас ойлгосон. Тэгэхээр армийн алдар нэртэй холбогдсон зүйлийг зөвтгөсөн, ялж дийлсэн байдлаар бичихэд яаж ч худлаа хэлсэн байлаа гэхэд хариуцлага хүлээхгүй гэдгээ ойлгоно. Харин болсон байдлыг үнэнээр нь бичвэл армийн нууцыг задруулсан хэрэгт өртөж болох байлаа. Иймээс Тогава, тэр өдрийн тулалдаанд японы цэрэг сүйрээд цасан дээр хүүрээ үлдээгээд цөөн тооны японууд хил даван гарч ирснийг монголын цэрэг ялагдсан мэтээр бичих нь дээр байжээ.

Орой болж найр өндөрлөх гэж байсан тэр үед жанжин штабын онц бүрэн эрхт төлөөлөгч Юкигийн зочлолтонд баярласнаа илэрхийлж,

- Юки сан, одоо их хэрэг явдал эхлэх гэж байна. Та үүнийг юу гэж үзэж байна даа гэж ярианы далим гаргаж асуулаа.

- Эрхэм дээдэс минь, Доихара сан, алс дорнод руу чиглэсэн ажиллагааны талаар надад дуулгасан. Харин Халх гол руу чиглэсэн ажиллагааны талаар надад одоохондоо юу ч мэдэгдээгүй байна. Их гүрнүүдийн сонин сурвалжлагчдын бичиж байгаагаар бол Гадаад монголын цэргүүд Баргын нутаг руу дайрч, японы цэргүүд Баргын хилийг хамгаалж байгаа бололтой. Ер нь гурван жилийн өмнө ийм мэдээ үе үе сонинд гарах болсноос хойш одоо хүртэл нэг хэвийн юм бичээд байхаар огт сонирхолгүй болчихоод байна. Би анхны мэдээ уншаад овоо дорвитой юм болох нь гэж бодоод Токиогоос сургуулиа хаяад ирж билээ. Тэгээд одоо болтол тэглээ ингэлээ гэсэн мэдээ сонсоод ингэж л байдаг юм шүү дээ гэж бодогдохоос цаашгүй болжээ. Уг нь би Буйр нуурт загасны үйлдвэр байгуулж, Халх голд эдлэн газартай болох нь гэж бодоод баярлаж байсан нь цөөнгүй! Одоо энэ бүхнийг бодохоор надад хүүхдийн бодол шиг санагддаг. Улаан орос японы шахалтаар дорнод төмөр замыг Манж го улсад 140 сая иениэр худалдаад нийт зардал нь 170 сая иень болсон. Гэтэл японы засгийн газар энэ сайхан далимыг ашиглаж дорнод төмөр замыг ашиглах талаар аж үйлдвэрийн томоохон эзэдтэй хувь нийлүүлсэн төмөр замын том нэгдэл байгуулах тухай бараг дөрвөн жил ярьж байна. Хэрвээ энэ оны хоёрдугаар улиралд японы засгийн газар улсын болон хувийн пүүсний эзэдтэй хоршсон төмөр замын нийгэмлэг байгуулбал би өөрийнхөө хөрөнгийг хоршиж Хайлараас монгол руу чиглэсэн төмөр зам байгуулахад хөрөнгө хорших санаатай байна. Гэтэл би чинь хувийн, томоохон пүүсүүд хоршоод ашиг хонжоогоо яаж хуваадгийг мэдэхгүй хийсэж яваа хүн. Ингээд бодохоор сураагүй тоглоомонд шунаад яахав гэж боддог удаа бий. Аягүй бол эцгийнхээ буяныг шавар шороотой холиод алсдаа хоосроход хүрч мэднэ. Гуйлгачин болчихвол хэн надтай учрах билээ дээ.

- Юки сан би таны санааг ойлгож байна. Монгол руу чиглэсэн төмөр зам тавина гэдэг үнэхээр бэрхшээлтэй асуудал юм. Арми иймэрхүү асуудалтай оролдох хэрэггүй биз. Учир нь гадаад монголынхон японы арми монголын хил рүү цэрэг стратегийн ач холбогдолтой төмөр зам тавьж байна гээд монгол руу цэргийн түрэмгийлэл үйлдэхийн тулд зам харилцааг чухалчилж байна гээд цуурчихна. Харин та энэ бүхнийг өөрөө санаачилбал гадаадынхан илүү дутуу юм сонжихдоо учрыг нь ойлгоод иргэний зориулалттай төмөр зам тавьж байна гэдгийг үнэн мөнөөр нь ойлгох болно. Харин манай арми таны энэ санаачилгыг дам, тойруу замаар дэмжиж бололцоотой бүхнээр тусалж болох юм шүү гэж жанжин штабын бүрэн эрхт төлөөлөгч квантуны армийн удирдлагатай тохирсон ярианыхаа дагуу Юкийг аятайхан ятгав.

- Эрхэм дээдсээ, би төмөр зам тавихад хөрөнгө хоршино гэдэг бол квантуны армийн ажиллагаатай салшгүй холбоотой юм. Учир нь монголыг улааны нөлөөнөөс ангижруулах талаар квантуны арми, ямар нэг алхам хийхгүй бол би Буйр нуурт загасны үйлдвэр байгуулж, Халх голын савд жимсний тариалан эрхэлж чадахгүй болно. Ингэвэл Хайлараас Буйр нуур Ханширээгээс Халх гол хүртэл тавих төмөр зам надад ямар ч ашиггүй болох шүү дээ.

- Энэ тухайд гэвэл Уэда сан танд баярлууштай юм хэлэх байх. Ойрын үед генерал Халх гол руу чиглэсэн ажиллагааны төлөвлөгөөг хийгээд жанжин штабаар батлуулах байх. Тэгэхээр та олон юманд эргэлзсэний хэрэггүй төмөр зам тавиулах талаар бодсон дээр! гэж хэлээд сэтгэлдээ «Өмнөд манжуурын төмөр замын нийгэмлэгийг анх байгуулахдаа Токиогийн Ясуда гэдэг томоохон пүүсийг засгийн газрын хөрөнгөтэй хоршиж Мантэцу гэж нэрлэсэн. Одоо дорнод төмөр замын нийгэмлэгийг байгуулахад улсаас хөрөнгө гаргаж, хувийн пүүсүүдтэй хоршин Кабуко коцу гэдэг нийгэмлэг байгуулахаар ян тан тохирчихсон. Энэ тухай албан ёсны шийд гарсан үед Юкийг бид ятгах хэрэггүй юм байна. Юкийг Кабуко коцу нийгэмлэгт оролцуулж чадвал Монгол руу чиглэсэн төмөр замыг армийн санаачилгаар байгуулаагүй гэдэг сэтгэгдэл төрүүлэх бүрэн бололцоотой юм байна» гэж бодож байлаа.

Гийчид өндөрлөх болсон тул Юки монгол ёсыг дагаж зочдодоо алтан цаг бэлэглэсэнд армийн удирдах нөхөд сэтгэл хангалуун төдийгүй Юкийг барагдашгүй их алттай гэж цуурхдаг цуурхлыг үнэмшжээ. Жанжин штабын төлөөлөгч Токио явахын өмнө Тозияатай биечлэн уулзаж,

- Би Токиотой ярьсан. Таны гаргасан саналыг жанжин штаб сайшааж байна. Юкийг Хайлараас монголын хил рүү чиглэсэн төмөр зам тавиулах ажилд оролцуулах явдлыг армийн удирдлагаас дэмжихдээ «Армийн ажиллагааг нууцалж чадах бүрэн үндэстэй санаачилга» гэж үзсэн шүү. Одоо та Юкитэй энэ талаар биечлэн ажиллах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Монголын хил рүү тавьж байгаа төмөр замыг Халх гол руу чиглэсэн армийн ажиллагаатай огт холбоогүй зөвхөн иргэний болон аж үйлдвэрийн зориулалт бүхий орон нутгийн шаардлагаар тавьж байгаа юм гэдэг шуугиан дэгдээх явдлыг хүчтэй болгох хэрэгтэй гэлээ. Жанжин штабын төлөөлөгчийг явсны маргааш нь Тозияа, Уэдатай уулзаж Юкийн талаар ярилцаж байхдаа Халх голын ажиллагааг хэдийд эхлэх боломжтойг асуулаа.

- Бидний төлөвлөснөөр бол 5 дугаар сар гэхэд ажиллагааг эхэлнэ. Тиймээс Юкийг сайн ятгаж чадвал шинэ байгуулах нийгэмлэгт хоршуулж чадна. Бид Юкийг хөрөнгө хоршуулах явдлыг чухалчлаагүй. Хавраас 50 мянган хоригдол Харбин, Хянганы шоронгоос авч төмөр замын ажлыг эхлүүлнэ. Үүнийг Юкигийн нэрээр далдлах нь чухал. Түүнээс гадна тантай ярих нэг

юм байна. Кэмпэйтийхан танай Симоотоог сонирхоод байна. Энэ сайн ёр биш гэдгийг та бодох хэрэгтэй гэлээ.

Тозияа, Мугдэнд байхдаа дан армийн тагнуулын ажиллагааг төдийгүй манжуурт байгаа кэмпэйтийн төлөөлөгч нартай холбоотой байсан. Гэтэл Синьзинд шилжиж ирснээр кэмпэйтийнхантай ажиллах ажиллагаа аажимдаа хөндийрч холдсон нь кэмпэйтийн зарим хүмүүс армийн тагнуулын зарим дарга нартай нийлж Симоотоог гадуурхан хавчдаг болсныг мэдсэн Тозияа, Уэдатай ярилцаж тохирсны дагуу түүнийг Доихарагийн армийн тагнуулын газар дэвшүүлэн орлогч болгов. Ингэхгүй бол Симоото, кэмпэйтийнханд хавчигдаад ирэхээрээ хар амиа бодож тэдний ятгалгаар юу ч хийж чадах байлаа. Харин Доихаратай кэмпэйтийн төлөөлөгч нар холбоотой төдийгүй ихэнх нь түүний шавь болохоор Доихарагаас эмээгээд Симоотоогоор оролдохгүй гэдэг нь илэрхий. Оролдсон ч гэсэн Доихара, Тозияаг хамгаалж Симоотоог өмөөрөх нь зайлшгүй ажээ. Үүнийг таван хуруу шигээ мэдэж байсан Уэда, Тозияад сануулсан агаад түүний саналыг дэмжиж Симоотоог Доихарагийннд шилжүүлэх аж. Тэгээд нэг өдөр Тозияа Симоотоог дуудаж уулзаад,

- Би чамайг өөр ажилд томилохоор санал оруулсныг Уэда зөвшөөрсөн. Чи тавдугаар армийн тагнуулын газрын орлогчоор дэвшиж ажиллана. Доихарагийн зарим дивизүүд Халх голын ажиллагаанд оролцох тул тэндхийн газар нутгийг сайн мэддэг хүн хэрэгтэй байгаа. Нөгөө талаар чамд нэг зүйлийг давхар хариуцуулна. Доихарагийн ажиллагаа оросын цагаачдын товчоотой салшгүй холбоотой. Тиймээс Сафроновыг нарийн ажиглах хэрэгтэй. Ер нь Сувдаагийн талаар миний санаанд ороогүй шинэ баримт гарч магадгүй байгаа. Мешановын үхсэн явдал, Хасу Тоишигийн оргосон хэрэг тун ээдрээтэй байна. Чи хэрээ хочтыг яаж мухар толгойтонд алдлаа. Түүнийг Сафронов, Хасу Тоишид шилжүүлсэн тэр өдөр нэг үл таних хүн ирж Хасу Тоиши, Сафронов хоёрын аль алинтай нь уулзсан нь одоо мэдэгдэж байна. Сафронов Хуньчун голын ойролцоох сууринд хориглож байхад тэр үл мэдэгдэх хүн дахин үзэгдсэнийг Мешанов мэдсэн байна. Харин Мешанов Юкигээс айгаад энэ бүхнийг илчилж чадалгүй зөвхөн нэг найздаа хэлсэн төдийгөөр өнгөрснийг Сафронов мэдээд түүнийг машины осолд орох нөхцлийг бүрдүүлсэн байна

Одоо бүхнийг нэгтгээд дүгнээд үз! Бүх явдлыг Сафронов далдуур зохион байгуулж байсан эгзэг гарч байгаа биз дээ. Түүнээс гадна Сафроновын байгаа гэрийн үйлчлэгч эмэгтэйн эцэг улаан большевикуудтай холбоотой байсан. Гэтэл Сафронов түүнийг өөрийнхөө дэргэд авч далдуур нөхцсөн дүр гаргаж байна. Угтаа тулбал Сафронов ах дүү хоёр (Баатар, Цэен) хэрхэн нас барсныг мэдэж байгаа. Гэсэн ч одоохондоо Юкид хэлж амжаагүй байгаа. Иймээс үүнийг нягтлаад хэрхэх ёстойг шийдэх нь чухал! гэлээ.

Хоёр. Хар чоно, шинэ үүрэг

Хато, Харбинд буцаж ирсний дараа Тозияагийн даалгавраар Аяанаосугийн ажилтай танилцав.

- Ахмад аа, Хар чоныг Тозияа сэнсэй (Багш) сонирхож байна. Бидэнд мэдэгдэж байгаа баримтаар Хар чоно амьд гэдэг нь эргэлзээтэй байна. Доихарагийн бодлоор бол Балиус хочтыг сайн судлах нь чухал гэдэг нь илэрхий! Хар чоно амьд бол Тозияад чухал хэрэгтэй гэж байна.

- Эрхэм дээдсээ, өвөр монголын хоригдлуудын талаар гэтэл Хато, Аяанаосугийн санааг ойлгоод,

- Хоригдлуудын дотроос хамгийн түрүүнд авхаалжтай хүмүүсийг олох нь чухал. Тэд хоригдлуудын дотор байгаа мухар толгойтнуудыг илчилж өгнө. Мухар толгойтнуудыг бид армийн эрдэм шинжилгээний газар (Бактерлогийн байлдааны 731 дүгээр отряд) шилжүүлэх ёстой. Тийм хүмүүсийг олж өөрийнхөө талд элсүүлэх нь чухал гэж зааварлав.

Аяанаосу, Хатогийн өрөөнөөс гарч ирээд түүний хэлсэн үг бүрийг эргэцүүлэн бодоод «Тозияад тун хэрэгтэй хүн гэнээ. Хар чоно яахаараа ийм хэрэгтэй болов? Тозияа, Хар чоныг улс төр, цэргийн хорлон сүйтгэх ажиллагаанд ашиглаж болохгүй гэдгийг мэднэ. Ялангуяа Доихарааг молигодсон явдлыг сонссон бол дахин хуурч болно гэдгээс болгоомжлох ёстой. Харин Тозияа түүнийг хувийн өшөө, хонзон атаа жөтөөнд ашиглаж болох юм. Тэгвэл хар чоныг хөлсний яргачин болгоно гэсэн үг!» гэж өөртөө сануулан хэлэв.

Аяанаосу энэ өдөр хорих газар руу очиж дархан хочиттой уулзах гэсэн боловч Энэтхэгийн ёгын түүхэнд холбогдолтой хэдэн номыг уншиж дуусгахыг мэрийнэ. Тэгээд буудалд иртэл үйлчлэгч авгай,

- Аяаняосу сан, орой Симото сан ирнэ гэсэн шүү гэж сануулав. Аяанаосу өдрийнхөө хоолыг зоогийн газар өнгөрөөгөөд өрөөндөө орж ирэнгүүт ёгын номыг гарчиглаж унших зуур сонирхсон зүйлээ хайна. Гэтэл нэгэн сонин баримт Аяанаосугийн анхаарлыг татлаа.

...Ёгочин Харидаза гэдэг хүн 1837 онд нас барахад тусгайлан оршуулаад хэд хэдэн харуул гаргаж мануулжээ. Үнэндээ энэ бол ер бишийн туршилт байлаа. Харидазааг авсанд хийхдээ түүний сахлыг хусжээ. Тэгээд 40 хоносны дараа авсыг онгойлгоход түүний сахал самбаа урьдынх шигээ ургачихсан байв. Ингээд Харидазааг үхээгүй гэдгийг мэдээд түүний шавь нарын нэгийг авчирч сэхээхийг даалгав. Харидаза хэдэн мөчийн дараа сэрмэгц туршилтыг удирдсан Моррей, Мак Грегор гэдэг хоёр эмч тодорхойлолт гаргаж, гарын үсэг зурахдаа «Харидаза, өөрийнхөө хэлээр дууныхаа сүвийг тагладаг онцгой аргатай байсныг тогтоов» гэсэн байлаа.

Аяанаосу ёгын тухай уншиж зарим зүйлийг сэтгэлдээ тогтоох гэж чамбайхан хүч идэвх гаргасан болохоор нэлээн ядарчээ. Тэгээд орон дээрээ хэвтэж Симотоог хүлээсэн боловч оройнхоо хоолонд орохоор шийдэж зоогийн газар руу орлоо. Аяанаосуг хоолоо захиад удаагүй байтал Симото орж ирлээ. Чингээд бие биентэйгээ уулзахыг хичээсэн хоёр учирч,

уулзсаны баяр тэмдэглэх нь тэрээ.

- Ахмадаа ажил чинь ямаршуухан байна даа гэж Симотоог асуухад,

- Юуг нь ч мэдэхгүй баахан хоригдолтой зууралдаж байна. За тэгээд Хар чоно гэдэг сүрхий гайхлын сураг гаргах гэж үйл тамаа эдэлж гүйцлээ. Зарим хүн амьд гэж баталж байхад зарим нь үхсэн гэж мэтгээд толгой эргүүлж, холион бантан болгочихоод гэлээ.

- Би цаадахын чинь сургийг дуулсан. Юкигийн дайллага дээр Доихара, Хато, Тозияа гурав хоорондоо яриад байсан. Миний ойлгосноор бол сэнсэй (Багш Тозияа) томоохон юманд ашиглаж магадгүй байсан шүү.

- Эрүүгийн гэмт хэрэгтнүүд тагнуулын ажилд дасахгүй. Тэгээд ч найдваргүй. Дураа хүрвэл өөрийгөө худалдаад амиа аварч магадгүй. Ингэхээр эрүүгийн хэрэгтэнг тагнуулын ажилд ашиглана гэдэг чинь нууцаа алдана.

- Тозияа эднийг тагнуулын ажилд хэрэглэхгүй. Сэнсэй (багш) тагнуулын ажиллагааг далдлахын тулд давхар мэх хийх гэж байгаа байлгүй. Наад зах нь Халх голын цэргүүдтэй ёс суртахуун, үзэл суртлын дайн хийж ялах хэрэгтэй. Ингэхийн тулд ухуулах хуудас, мөнгө төгрөг, нүцгэн хүүхний зурагтай чамин хийцтэй хөзөр, янжуур, архи гээд зүйл зүйлийн юмыг хаях хэрэгтэй. Үүнийг дээрэмчин, хулгайч нараар хийлгэвэл хожим армийн нэр хүндэд харшлахгүй. Тэд баригддаг юм гэхэд хилийн хулгайч (контрбанд нар)гээд тодорхойлчихно. Ингэхээр хоригдлууд бэлдэнэ гэдэг чинь давхар мэх хийнэ гэсэн үг!

- Би үүнийг ойлгож байна л даа. Харин Хар чоныг олох гэж цаг гарздаад яах вэ? Саяын ажилд Хар чоноос өөр хүнийг хэрэглэж болно. Гэтэл заавал Хар чонын сургийг гаргаж тогтоо гэж шаардаад байх юм. Би ч амар заяа үзэхээсээ өнгөрсөн байхаа.

- Аяанаосу минь наадахыг чинь сэнсэй өөрөө мэдэж байгаа биз. Ер нь айж суухын хэрэггүй. Олбол олоод, олдохгүй бол үнэнийг нь танилцуулаад байж бай! Өөр яахав дээ.

- Би ч тэгж бодож байна. Энэ ч яахав. Харин чи шинэ ажилд дэвшээ юу?

- Тэгсэн шүү. Миний эцсийн зорилго бол Халх голд тагнуулын хэсэг удирдаж гавьяа байгуулах явдал. Армийн тагнуулын газар, кэмпэйтэйн төлөөлөгч гэдэг чинь нэг хэвийн ажилтай байдаг. Байлдааны тагнуул гэдэг чинь үзэгдэхүйц үр дүнтэй. Штабт арваад жил болоход энгэрээ цоолж үзсэнгүй. Байлдаан бол газар дээрээ энгэрээ цоолно. Доихарагийн армиас Халх голд очно. Болж өгвөл түүнийг толгойлох санаатай.

- Одоо хүртэл байлдааны ерөнхий төлөвлөгөө гараагүй юм чинь ирэх зунаас Халх голын ажиллагаа эхлэх болов уу даа?

- Эхэлж ядаад байх юу байна. Манай арми шалгарсан цэргүүдтэй. Харин хятадууд шороо шиг болохоороо манай армийн ажиллагаанд тэсээд байгаа юм. Монгол бол хүн ам цөөнтэй. Байлдааны туршлага муутай. Цэргүүд нь бууны дуу сонсвол бут үсэрч, маани мэгзмээ уншаад сөхөрчихдөг амьтад! За тэгээд улаан оросын гар хараад байгаа. Доихара, алс дорнодод фронт

нээчихвэл улаан орос монголоос цэргээ татна. Тэд чинь хоёр газар яаж байлдах билээ дээ. Халх голын ажиллагаанд манай хоёр гурван дивиз байхад эд бадьг нь хөтөлчихнө. Ингээд монголд цэргийн түшиц газар байгуулсны дараа Улаан орос руу номхон далайн эргээс Монголын Алтай хүртэлх газраар өргөн фронт нээвэл шинэ зургадугаар армийг байгуулах нь зайлшгүй. Ер нь жанжин штаб тав, зургадугаар армийн хүчээр улааныг нугаслана гэж тооцоолж байгаа юм.

- Одоо хоёулаа өндөрлөө. Цэргийн буудлынхан чинь кэмпэйтэйн төлөөлөгч нарт хошуу худалдаж сурсан улсууд шүү гэхэд Симото,

- Аяанаосу минь би чамаас хэдэн юм зээлье гэж бодоод уулзах гэсэн юм. Чи гар татахгүй биз дээ.

- Цөөхөн юм бол бололгүй яахав. Их бол дийлэхгүй шүү гэхэд Симото,

- Чи над шиг архи, хүүхэн хоёрт мөнгөө үрэх биш. Намайг бодвол бэлтэй хүн. Надад мянган иень зээлчих гэлээ.

- За тэгвэл дээшээ манай өрөөнд орьё гэхэд Симото, Аяанаосугийн араас дагалаа. Тэрээр Аяанаосутай ярьж суухдаа овоохон балгажээ.

Харбин хотын хаврын эхэн сарын үдэш жавар нь буурсан салхи сэвэлзэн сэрүү оргиулна. Хотын гангачуул үдшийн бүрэнхий эхэлмэгц зоогийн газар бараадан, шөнө дүл хүргэх тул оройд зоогийн газар, цэнгээний газруудад суудал үл олдоно. Харин японы армийн дарга нар хэдийд ч очсон дархан эрхтэй. Симото Аяанаосугаас мянган иень аваад өрөөнөөс гарахын өмнө хэсэгхэн бодолхийлсэн нүдээр Аяанаосу руу харснаа,

- Хар чоныг олохыг бод! Сэнсэй багш түүнийг Юкитэй ажиллуулах гэж байгаа юм. Түүнийг олбол чамайг сэнсэй «шиу са» (хошууч) болгоно шүү гээд өрөөнөөс гарлаа.

Аяанаосу өрөөнийхөө цонхны дэргэд зогсож, Харбины шөнийг ажиглаж байхдаа «Симотогийн хэлдэг саяын үг үнэн үү? Хар чоныг алан хядах ажилд ашиглана гэж миний бодсон зөв үү. Тэгвэл Хар чоноор Юкийг устгуулахын тулд надаар олуулахыг чухалчилсан байх нь» гэж бодлоо. Аяанаосу ийнхүү байдлыг эргэцүүлэн бодож «Рожусайд» дамжуулах баримтуудаа үгүүлэн бодсоор холбоочинтойгоо болзсон ёсоор Модрен буудал руу очихоор өрөөнөөсөө гарлаа.

Аяанаосуг зоогийн газар орж ирэхэд зохион байгуулагч нь угтан авч тусгай бэлдсэн кабинд оруулаад ширээний чийдэнг асааж гол танхим руу харсан хэсгийн хөшгийг татав. Аяанаосу, хоол захиалсны дараа тусгай кабинд ганцаараа үлдэж, хөшигний заагаар зоогийн газрын гол танхим руу харлаа. Аяанаосу танхимд янз бүрийн туршуул байхгүй нөхцөлд энэ кабинаас гучин таван минутын дараа гарах ёстой. Харин цагдаагийн газрын туршуул танхимд байгаа бол дөчин минутын дараа гарах ёстой байлаа. Аяанаосу хооллох зуур танхимд ямар ч туршуул байхгүйг мэдээд цагтаа кабинаас гарахад хөгжимчдийн ойролцоох ширээнд гурван залуутай сууж байсан Ойдов, Аяанаосугийн араас гарлаа. Аяанаосуг хувцсаа өмсөж байхад Ойдов дэргэд нь ирэхэд,

- Та харих нь уу? гэж Аяанаосу асуулаа.

- Тэгье. Та явах гэж байгаа бол зам нийлүүлэх үү дээ.

Тэр хоёр зоогийн газраас гарч Биржийн гудамж уруудан гэлдэрч энэ тэрийг ярилцахыг ажваас ямар нэг сэжиглэмээр зүйлгүй энгийн болой.

Ойдов гудамжны байдлыг сэм ажигласны дараа,

- Төвтэй холбоо барьсан. Ёоши өөрийнхөө ажиллагааг Симото руу чихэж байгаа гэнэ. Таныг шинэ ажилд орж, цол дэвшсэн явдалд төв талархал хүргэж байна. Халх голын ажиллагааны ерөнхий төлөвлөгөөтэй холбогдсон баримтыг ойрын үед олохыг «Рожуганукай» бүлэгт даалгасан гэв.

- Ойдов минь одоо тун болгоомжтой ажиллах хэрэгтэй. Японы тагнуулын газар Германаас тусгай зориулалтын «Симес» гэдэг пеленгац авсан. Төвтэй барих радио холбоог хотоос гадагш гарч хийх нь чухал! Ер нь Харбин-Хайлар, Харбин-Синьзины галт тэрэгний явалттай тохируулах нь бидэнд ашигтай.

- Намайг төмөр замын нийгэмлэгийн дэргэд байгуулсан холбооны түр сургуулийн өвөр монголчуудад цагаар багшлуулахаар урьсан. Тэгэхээр холбооны түр сургуулийн туршлагын цагийг төвтэй холбоо барих цагтай тохируулах боломжтой юм.

- Энэ талаар сайн бодож боловсруулах хэрэгтэй! Халх голын ажиллагааны урьдчилсан төлөвлөгөөг «Номон Хан зикэн на боппоцу» гэж нэрлэснийг Симото мэдсэн байна. Ер нь ерөнхий төлөвлөгөөтэй дөрвөн сард жанжин штаб танилцах ёстой гэнэ. Тозияа өвөр монголд Хар чоно гэж алдаршсан дээрэмчинг сонирхож олох тухай тусгай заавар надад өгсөн. Тиймээс Хар чонод холбогдох баримтыг Рожусайгаас лавлах нь чухал! Японы цэргийн яамны энэ оны төсвийг долоон тэр бум 32 сая иениэр баталсан байна. Нөгөө талаар Буйр нуур болон монголын хил рүү чиглэсэн төмөр замыг тавих ажлыг арми нууцлах тухай зааврыг холбогдох хүмүүст өгсөн. Харин чи надтай уулзах явдлыг хязгаарлах хэрэгтэй. Онц шаардлагатай үе гарвал бичгээр мэдээ дамжуулах хувилбаруудыг хэрэглэнэ.

Ойдов, Аяанаосутай уулзсанаас хойш долоон цагийн дараа Харбины тэнгэрт «Дамжаалин... Дамжаалин» гэсэн дуудлага богино долгионоор тархах нь тэрээ. Энэ бол Оршуун голын баруун эрэг, Хөндлөн голын хойхно байдаг Халхын сүм гэж алдаршсан хийдийн түвдээр нэрлэсэн номын нэр ажээ. Ойдов төвтэй холбоо барихдаа чингэж дууддаг болой.

Аяанаосуг өглөө ажилдаа аажуухан иртэл түүнийг Хато дуудсан байлаа. Аяанаосу даалгаврынхаа дэвтрийг барьсаар генералын өрөөнд ортол Хато цонхны дэргэд зогсож байснаа,

- Ахмадаа, чи өнөө Балиус хочтой хоригдолтой ойрдоо уулзав уу? Түүний хочийг юу юу гэдэг билээ гэхэд Аяанаосу дархан хочтын хочийг дэс дараалан хэлж өглөө.

- Өөр ямаршуухан хүмүүстэй уулзав даа?

- Ойр зуурын хэрэгтний хувийн хэрэгтэй танилцахад «эрдэмтэн» гэж хочилсон нэг хоригдолтой уулзсан.

- Сонин юм. Эрүүгийн гэмт хэрэгтэн «Эрдэмтэн» гэдэг хочтой байдаг?

- Тэр залуу хуучин монгол бичиг, хятад бичигт сайн гэнэ. Тэгээд хүний гарын үсгийг нэг удаа хараад яг дуурайлган зурдаг гоц авьяастай болохоор хоригдлууд тэгж хочилсон байна гэж хэлэхэд,

- Ахмадаа, чи ажил төрөлдөө сайн, идэвхтэй хүн байна. Армийн командлалд халхаар цэвэрхэн ярьдаг, хуучин монгол бичиг мэддэг хүн их хэрэгтэй гэсэн. Нөгөө талаар ингэсхийгээд Доихара сан чамтай утсаар ярина гэлээ.

Чингээд хэдхэн мөч өнгөртөл генералын ширээн дээр байгаа олон утасны нэгний хонх хангинаж генерал утсаа авлаа.

- Доихара сан, би ахмадыг дуудаад авчирчихсан. Та өөрөө ярь гээд Аяанаосуд утсаа өглөө.

- Ахмад аа, Хар чоно амьд байгаа нь үнэн байна.

Уржнан Хянганаас 2 мянган хоригдол Харбинд шилжүүлэхэд тэдний дотор Хар чоно оргосон нь эргэлзээгүй боллоо. Хянганд хоригдлуудын дунд алдаршсан нэр нь Балиус гэнэ. Би өөрийнхөө шугамаар хоригдлуудын хоч нэрийг судлахад балиус, заазуур, хутга, тонгорог гэсэн хочтой хоригдол дайралдсангүй. Ингэхээр хочоо сольсон байна. Нөгөө талаар Хянганаас авчирсан хоригдлуудаас энэ хугацаанд ганц ч хүн оргоогүй тул Хар чоно Харбинд байгаа гэдэг үнэн хэрэг. Иймээс Хар чоныг олох хэрэгтэй! Түүнийг олоход амархан, зүүн чихэн дотроо хуруу дарам улаан мэнгэтэй. Тиймээс хоригдлуудад эрүүл мэндийн үзлэг хийхийг би эндээс даалгана. Хар чоныг олонгуут Тозияад мэдэгдэж удирдамж ав! гэлээ. Доихарагийн яриа Аяанаосуг сэтгэлийн тэнцвэргүй байдалд оруулах шахлаа.

Тиймээс генералын өрөөнөөс шууд утсаар нь шоронгийн дарга руу ярилаа.

- Хоригдлуудыг эрүүл мэндийн үзлэгт оруулах тушаал авсан уу? гэхэд

- Сая авлаа. Маргааш өглөө үзлэгт оруулна. Тэгэхдээ таныг заавал байлцуулах чиглэл өгсөн шүү гэхэд Аяанаосугийн сэтгэл онгойлоо. Аяанаосуг байхгүй хойгуур эмчийн үзлэг хийвэл Хар чоныг хүний гарт алдаж болох талтай тул Аяанаосугийн, сэтгэл дэнсэлжээ. Аяанаосу генералын өрөөнөөс гараад өөрөө өрсөхөөр шийдээд Ойдовтой уулзахаар төмөр замын холбооны түр сургууль руу явлаа. Аяанаосу Ойдовтой уулзаж Рожусайгаас өгсөн удирдамжийг сонсоод ажлаа зохицуулахаар шийджээ. Аяанаосу төмөр замын удирдах газрын байшинд байдаг түр сургууль дээр очихдоо удирдах газрын даргатай уулзахаар шийдэв. Түүнийг удирдах газар ороход цонхоороо харсан Ойдов коридорт дайралджээ. Аяанаосу удирдах газрын даргатай уулзаж, төмөр замын ажилд ашигладаг хоригдлуудын талаар хэдэн юм лавлаад гарч ирэхэд даргын туслахын өрөөнд хүлээж байсан Ойдов түүнийг угтан уулзаж,

- Ноён ахмадаа, манай эзэгтэй Юки сан тантай уулзаж төмөр зам тавих ажилд оролцох

хоригдлуудын талаар ярилцаарай гэсэн юм. Та надтай уулзах завтайсан болов уу гэлээ.

- Би ажил руугаа явж байна. Төмөр зам тавих хоригдлуудын талаар та нартай уулзаж тохиролцох зүйл бий. Тиймээс та надтай хамт манай ажил дээр очиж ярилцвал дээр гэхэд Ойдов Аяанаосуг дагалаа.

Ойдов, Харбин дахь японы цэргийн төлөөлөгчийн газар руу явж байхдаа Рожусайгаас авсан баримтаа Аяанаосуд хэлж өглөө.

- Хар чонын жинхэнэ нэрийг Буд гэдэг. Уг гарлаараа бол Жирмийн чуулганы Сүрэгчин хошууны малчин ядуу ардын гэрт төржээ. Таван настайдаа Ордосын нэгэн хувилгаан ламын шавь болж түмэд хошуунд очсон байна. Түүнийг хорьтой байхад гэгээн багш нь Харбин руу явуулжээ. Буд, Харбинд ирж багшийнхаа дүүтэй уулзахад тэр нь дорнод хятадын төмөр замын засварын газрын дугуйны цехийн нэгэн орос сургагчийн шавь болоод вагоны дугуй зорж засдаг суурь машин дээр ажилладаг ажилчин болсон байв. Буд багшийнхаа дүүг ятгаж Ордос руу авч явах гэсэн боловч тэр нь зөвшөөрөөгүй байна. Ингэтэл долоо хоногийн дараа багшийн нь дүүг гудамжинд алчихсан байсныг Буд олж нутаглуулаад буцах гэтэл түүнийг гоминдааныхан барьжээ. Буд хоригдон мөрдөгдөж байхдаа багшийнхаа дүүг Харбинд байсан улаан большевикуудтай нийлж байсныг мэджээ. Гэтэл тэр нь долоо хоногийн өмнө нэгэн хувьсгалчийг оргуулах гэж байгаад амь эрсэдсэн байжээ. Үүнийг мэдсэний дараа Буд сурсан авьяасаа гаргаж худлаа үхсэн байна.

Гэтэл түүнийг нийтийн нүхэнд хаях гэж байтал ухаан оржээ. Үүнийг цагдаагийн газар Жан Золинд биечлэн танилцуулсан учраас түүний ид шидийг мэдсэн Жан Золин өөрийнхөө дэргэд авч нүднээсээ илүү хайрлах болж, хоёр жилийн дараа дээрмийн хэсэг удирдуулсан байна. Буд, Жан Золинг хорлогдсон учрыг мэдэнгүүт японы армийнхныг үзэн ядах болжээ. Чингээд Жан Сюэлянта ярилцаад эцгийнх нь өшөөг авахаар зэхэж байсан тэр үед Жан Сюэлян, Чан Кайштай ганзага нийлүүлсэн учир Буд түүнээс нэг хэсэгтээ хөндийрсөн байна. Тэгээд Шинжаан, Ганьсуд алдаршсан Аксахалтай холбоо тогтоож бие даан амьдарсан байна.

Тэгээд умард хятадаар үзэгддэг японы дарга нарыг гоочилдог болсон тэр үед Тогава түүний гарт өртжээ. Буд Аксахалын даалгавраар тэр нэг шөнө зочид буудалд орж, Тогавагаас Аксахалын өгсөн мөнгийг өөрийн нь хэдтэй салгаад алга болсон юм. Харин Тогава, Хар чоно гэж алдаршсан Будтай чингэж дайралдсанаа одоо хүртэл мэдээгүй юм. Ингээд Хар чоно Доихарааг залилсан бөгөөд умард хятадын таван мужийн төлөөлөгчдийг айлгаад зугтсан тул японы тагнуулууд түүнийг бэдрэх болсон байна.

Хар чоно үүнийг мэдээд Жан Сюэлянтай холбоо тогтоох гэтэл тэр нь баригдсан байжээ. Буд өөрийн хойноос хүчтэй мөрдөж байгааг мэдэнгүүт дээрмийнхээ хэсгийг тараагаад өөрөө Жанчхүүд очиж нэгэн хулгайн хэргээр шийтгэгдэж шоронд орсноор өөрийгөө японы тагнуулын мөрдөлтөөс аварч чадсан байна.

Мураяама дээрээс өгсөн чиглэлийн дагуу бүх хоригдолд эмчийн үзлэг хийлгээд Аяанаосугийн даалгасан ёсоор шоронд байгаа мухар толгойтон түүний гар хөлийн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргажээ. Аяанаосу нэрсийн жагсаалттай танилцаж суугаад,

- Мухар толгойтнуудын талаар надад мэдээлэл бичиж байх хоригдлуудын нэрийг хочтой нь мэдэх үү? гэхэд Мураяама,
- Танд мэдээлэгч нарын дотроос доголон, гахай, бух, хатангир, улцан, унжуу гэдэг хочтонгууд илүү сонирхогдох байх гэж бодож байна.
- Танай мэдээлэгч нар яагаад ийм хачин этгээд хочтой юм бэ?
- Энэ бол нийтэд дэлгэрсэн хоч биш. Зөвхөн танд мэдээлэл өгч байх хоч юм. Манай мэдээлэл дамжуулдаг хоригдлууд ийм хочтой байдаг юм.
- Тэгвэл надад бас нийтэд алдаршсан хоч нь хэрэгтэй.
- За тэгвэл доголонг хувин, гахайг идэмхий, бухыг муна, хатангирыг гурай, улцанг уйланхай, унжууг залхуу гэдэг юм.
- Дархан хочит чинь мухар толгойтнуудтай аль зэрэг харилцаатай вэ? Энэ тухай ямар нэг мэдээлэл бий юү?
- Энэ талаар ямар ч мэдээлэл байхгүй. Ер нь дархныг ийм тийм гэж мэдээлдэггүй юм.
- Яагаад тэр вэ?
- Дархан манай дарга нарт когай хийж өгдөг болохоор ховлоно гэж айдаг байх. Тиймээс мухар толгойтнууд дархнаас хөндий байдаг бололтой.
- Хоригдлуудтай уулзах тусгай өрөө бэлдсэн үү?
- Ахмад аа, өрөө бэлэн шүү. Одоо үзсэн ч болно гэхэд Аяанаосу,
- Та саяынхаа нэрлэсэн мэдээлэгч нарын нэр, хочийг албан ёсны хуудсан дээр бичээд цагийн дараа надад оруулж өг! Би хоригдлуудтай уулзана гэхэд Мураяама Аяанаосугийн ажлын өрөөнд зориулж бэлдсэн өрөөнд очлоо. Мөрдөн байцаалтын багаж, төхөөрөмж бүхий тасалгаа бэлдсэнийг ажвал басхүү хоригдлуудтай ярих яриаг сонсоход зориулсан далд төхөөрөмж тавьсан нь илт байлаа. Ялангуяа хоригдлуудтай ярих яриаг сонсохын тулд сандал, ширээг өрөөний цонхны ойр зассан байлаа.
- Мураяама, та чинь армийн тагнуулын газрын ажиллагааг барагтайхан үнэлдэг юмаа даа. Над эрүү шүүлт явуулах, айлган сүрдүүлэх, тамлан тарчлаахад зориулсан байр хэрэггүй. Бид бол хүний сэтгэхүйн уран аргыг гол болгодог! Тэр тусмаа уян хатан харилцааг хослуулдаг гэдгийг мэддэггүй хэрэг үү? Та энэ дүүжилж байцаах хэрэгслэл, давстай усаар бургуйдах төхөөрөмж, шүд түүх, завьж сунгах, зовхи тэвхдэх багажаа зайлуул! Тэгээд ч энэ багажийг цааш нь харуулах хүмүүст хэрэглэдэг болохоос эзэн хааны төлөө амиа өргөх сэтгэл санаагаар хүмүүжүүлэх хүмүүст хэрэглэдэг зүйл биш. Эсвэл та хоригдлуудын сэтгэл санаанд өөр бодол төрүүлж армийн ажиллагааг унагах хүсэлтэй хүн юм уу? гэж зандрахад Мураяама сүнсээ зайлтал айлаа.

- Ахмад аа, би эд нарыг хатуу гараар хүмүүжүүлэх юм болов уу гэж бодоод тэр шүү дээ. Гэхдээ тохилог өрөө бэлдье гээд духаараа чийхарсан хөлсөө арчихад Аяанаосу,
- Надад тусгай байр хэрэггүй. Ердөө энгийн байр үзүүл гэж тушаав. Чингээд шоронгийн нэг байрыг сонгож аваад хоол унд, зууш, сакэ авчруулж зөөлөвчтэй сандал тавиулж, ширээг нь цагаан даавуугаар бүтээлгэв. Чингээд дархан хочит хоригдлыг авчирлаа.
- Тэвнэ минь суу гээд Аяанаосу зөөлөвчтэй сандал руу заалаа.
- Ноён ахмадаа би ийм сайхан сандал дээр суувал унтчих байх. Танай гурван дарга урьд шөнө намайг унтуулсангүй гэхэд Мураяама түүнээс урьтаж учир байдлыг Аяанаосуд тайлбарлахдаа,
- Өчигдөр таван когай хийлгэх гээд шөнөжингөө ажиллуулсан юм гэлээ.
- Мураяама сан, та одоо явж болно. Хэрэг гарвал би таныг дуудна гэхэд Мураяама дурамжхан гарлаа. Тэрээр хоригдолтой ярих яриаг чагнах төхөөрөмжгүй газар байцааж байгаа болохоор өөрөө дэргэд нь байж тэдний яриаг чагнах гэж бодсон атал түүний бодол талаар өнгөрлөө.
- Тэвнэ минь суу. Харин унтахгүй байхыг бодоорой! Одоо юм ид, сакэ балга! Тэгээд ярилцъя гэхэд дархан хочит зөөлөн сандал дээр сууж, зууш идэж хоёр хундага сакэ балгасны дараа Аяанаосу руу харж сууснаа алгуурхан зовхио буулгаад унтаад өглөө. Тэрээр үл мэдэг амьсгалж байснаа алгуурхандаа амьсгалах нь больж, хамрын хөндий, цээжний цаана ямар ч дуу чимээгүй боллоо. Аяанаосу Хар чонын баруун гарын судсыг барьж үзээд,
- Тэвнэ минь, битгий баашил! Чи хэлээрээ хоолойгоо таглаад хэрэггүй. Энэ чинь өөрийгөө надаас нууж байгаа хэрэг биш. Харин хэн болохоо надад баталж байгаа юм. Хар чоно бос бос. Ярих юм байна гэхэд тэвнэ хочит, зовхио алгуурхан нээж, хэлээ хэвийн байдалд оруулаад амьсгалж эхлэнгүүт гайхсан харцаар Аяанаосуг ширтэнэ. Аяанаосу тэвнэ хочтын судсыг барьж байснаа,
- За одоо судасны чинь цохилт хэвийн байдалд орлоо гэхэд,
- Ахмад аа, та намайг эмчийн үзлэгт орж байхад чихний эмчид үзүүлээгүй өнгөрсөн. Та намайг юунд ашиглахын тулд ийм арга хэрэглэсэн юм бэ?
- Та миний асуусан бүхнийг чин үнэнээсээ хариулбал уулзалтыг өөр тохитой газар үргэлжлүүлье.
- Та миний яриаг тэмдэглүүлэхгүй байх шаардлагатай юм уу? Түүнээс эндхийнхэн чинь хэнтэй юу ярьсныг тэмдэглэж авдаг туршлагатай улс шүү дээ.
- Би армийн тагнуулын ажилтан. Түүнээс кэмпэйтэйнх биш!
- Тэд нарт тийм их ялгаа байдаг юм уу?
- Хүн бүхэн адилгүй, хүлэг бүхэн жороогүй гэдэг биз дээ.

- За тэгвэл миний хариултыг чин үнэнээсээ хэлж байна гэдэгт итгэж болно гэж бодоод асуух зүйлээ асуу даа.

Аяанаосу, олон хочтой Хар чоно буюу Будтай ингэж тохироод Мураяамааг дуудуулж уулзаад,

- Дархан хочтыг усанд оруулж, сайхан хувцаслаад цагийн дараа Модрен буудлын зоогийн газар хүргэн өг! Би тэнд хүлээж байх болно гээд Аяанаосу өрөөнөөс гарлаа.

Чингээд цагийн дараа тас хар өнгөтэй европ хувцас өмсөж, цагаан цамцан дээр эрвээхэй зангиа зүүсэн өндөрдүү биетэй, гуалиг нуруутай нэгэн ганган хүнийг дагуулсан Мураяама зоогийн газар орж ирээд тусгай бэлдсэн суудалд суусан Аяанаосугийн дэргэд түүнийг хүргэж өгөөд зоогийн газраас гарлаа.

- Хар чоно минь одоо хоёулаа хэдэн зүйлийг урьдчилан тохиръё. Нэгд би таныг хочоор чинь нэрлэхгүй. Ердөө Буд гэе. Хоёрт хоёулаа хятадаар ярихгүй. Харчин, сахар, түмэд аялгуугаар юмуу халхаар ч ярьсан болно гэхэд эх эцгээсээ хайрласан багынхаа нэрийг мартаж шахсан Хар чоно хэмээгдэгч гайхсан ажигламтгай харцаар Аяанаосуг харж байснаа,

- Тяньжинд Доихаратай уулзахдаа миний хочноос цаашгүй гэдгийг мэдээд залилах аргаа олсон юм. Харин та, миний багын нэрийг хүртэл мэдэж байгаа болохоор надтай уулзах гэж овоо хэдэн жил махраа шив дээ гэв.

- Буд аа, би чиний адал явдалд холбогдох баримтыг ердөө сарын дотор багтааж судалсан юм гэж сахар аялгуугаар хэлэхэд Буд гайхсан янзаар,

- Ноён ахмад аа, та чинь халх хүн юмаа даа. Аль хошууны хүн бэ? гэлээ.

- Буд аа та хашир хүн гэхэд арай бүдүүлэг таамаг гаргаж байна. Би халх хүн биш. Уг гарлаа хөөвөл хөх нуураар нутагтай, ясаа хөөвөл сахар хүн дээ.

- Тэгвэл та чинь Хөх нуурт очсон сахарын Лигдэн хааны дөрвөн еншөөбуугаас гаралтай болох нь. Еншөөбуугийн дөрвөн аймаг хожим Халхын Цогт хун тайжийн хүү Арслан тайжийн харьяанд явсан болохоор би таныг халх гэсэн маань талаар хэрэг биш байх нь.

- Буд аа та, Ордосын их гэгээний шавь байсан болохоор «дэвтэр жамца буюу Хөх нуурын түүх» гэдэг зохиолыг сайн судалжээ дээ.

- Тиймээ. Би тухайн үедээ Их зуу, Ордосоор явж байсан. Багаасаа түмэдийн Рибугэжэй хийдэд шавилж байсан нь үнэн шүү.

- Би үүнийг мэднэ. Харин чиний хийсэн когай хутгыг самурай нар тун их эрхэмлэдэг гэсэн. Чи үүнийгээ юу гэж боддог вэ?

- Би эдний мөрдөлтөөс мултарч шоронд орсон боловч самурай нар миний гарт амь насаа алдаж яваа гэж боддог юм даа.

- Миний бодлоор бол та их эндүүрч дээ. Самурай нар чиний хийсэн когайгаар өвөр

монголчуудын толгойг хяргаж, бүсэндээ зүүхдээ когайгаар тээглүүр болгож хэрэглэдэг бол яана? Ер нь когай бол дайсан гэж үзсэн хүнийхээ толгойг хяргахад хэрэглэдэг тэдний өвөг самурай нарын балиус шүү дээ гэхэд Буд хундагатай сакэгээ ширээн дээр, тавиад Аяанаосу руу сүрхий харлаа.

- Буд аа, гайхах хэрэггүй. Чи самурай нарт гэдсээ хүүлэх мэс бэлдлээ гэж бодож байна уу? Самурай нар когайгаар харакири хийдэггүй юм!

Буд, Аяанаосугийн үгийг сонсоод ичих шиг боллоо. Тэрээр огт өөр юм бодож явсан. Гянданд байхдаа нэгэн өвгөн хятад дархныг дагаж дарх сурах гэж үйл тамаа барж билээ. Тэр үед Буд сэтгэлдээ «Миний хийсэн мэсэнд муусайн самурай нар амиа алдах болно» гэж бодож билээ. Гэтэл Будын хийсэн мэсээр самурай нар өөрийгөө биш гэмгүй хүмүүсийн толгойг хяргаж байсан гэж санахаас сэтгэл нь харанхуйлан, нүдэнд нь толгойгүй бие, биегүй толгой харагдах шиг болов.

Буд, Хянганы шоронгоос Харбинд шилжиж ирэхдээ битүү машинаар ирсэн. Нэг удаа японы дайн самуунд өртөгдсөн нэг жижиг тосгоны чандрууны дэргэд машинаа зогсоосон самурай нар хоригдлуудад товойх ханагүй болсон тосгоны чандрууг харуулж, нэг хонхорт овоолсон олон хүний толгойны дэргэдүүр явуулахдаа хоригдлуудыг зогсоож «Бие засах хүн байна уу» гэж билээ. Хоригдлуудыг тэр толгойнууд дээр бие засуулах гэж байгааг мэдээд ганц ч хүн цуваанаас гарсангүй. Гэтэл япон цагдаа нар хоригдлуудыг хүчээр бие засуулахын тул зодож нүдэж овоолсон толгойнуудын дэргэд аваачихад хоригдлуудын дунд байсан «мухар толгойтнууд» япон цагдаа нар руу дайрч тэндээ буудуулав. Цагдаа нар хоригдлуудыг алдахаас айгаад тэр дороо машинд чихээд хөдөлж билээ,

Буд энэ бүхнийг санахаас сууж байх газаргүй юм шиг санагдаад «Миний хийсэн когайгаар хичнээн хүний толгой огтлоо бол» гэж бодохоос тэсэж байж ядсан хорсолдоо захирагдана.

- Буд аа, та энэ бүхнийг тунгааж чадах хүн! Тиймээс нэг зүйлийг сануулах хэрэгтэй боллоо. Одоо япончууд таны гараар гэмт хэрэг үйлдүүлэх гэж байгаа. Тиймээс тэр нууцыг та илрүүлэх хэрэгтэй байна!

- Ноён ахмад аа, намайг муу юм бүхнийг хийж чадна гэж бодоо юу?

- Бузар юмыг ариун болгодог зан чанар бол самурайн ёс. Харин муу үйлсийг сайн үйлсээр солих нь шударга хүний эрхэм зорилго!

- Хэний төлөө тэр вэ? Самурайн эрх ашигт уу? Одоо тэгэхгүй шүү, би арчаагүй байдлаар амиа хоохойлж явсан. Одоо тэмцэж байж нэгийгээ үзнэ.

- Буд аа, чи өнөр олны ашиг тусын тулд олдсон завшааныг ашиглах болно.

- Би ямар хэрэгт оролцохоо мэдэхгүй байж, түүнийг өнөр олны тусын тулд хийж байгаа гэж яаж итгэх болж байна.

- Тэр тухайд би танд заавар өгнө. Өөрөөр хэлбэл квантуны армийн нэг удирдах хүний

сонирхож байгаа хэн ч үл мэдэх тэр хэргийг илчлэх ёстой!

- Бид японы генералуудыг ганц нэгээр хороогоод энэ ажиллагааг зогсооно гэж бодож байгаа бол тэрүүн шиг эндүүрэл байхгүй.

- Та квантуны армийн генералуудыг ганц нэгээр нь хороохгүй. Харин таныг ашиглах гэж байгаа тэр зүйлийг мэдэх нь надад чухал!

- Тэгвэл энэ чинь ард олны тусын төлөө биш, чи зөвхөн өөрийнхөө өшөөг авахын тулд намайг турхирч байгаа хэрэг байх шив дээ. Би одоо тийм ажлаар хөөцөлдөхгүй.

- Гэхдээ та шоронд байгаа хүмүүсийг бослогонд бэлтгэнэ гэдэг амаргүй ажил! Одоо таныг олохын тулд квантуны арми, кэмпэйтэйн төлөөлөгчийн туршуулууд шоронд олширч байгаа. Тэдний нэрсийн жагсаалт энэ дээ гээд Аяанаосу хэдэн цагийн өмнө Мураяамагийн бэлдэж өгсөн нууц туршуул, мэдээлэгч нарын нэрсийн жагсаалтыг Будаг үзүүлэв.

- Буд аа, тэд Хар чоно гэдэг нэрийг дуулбал тэр тусмаа чамайг гэж мэдвэл эд нар яана гэж бодож байна. Тиймээс мэдээлэгч нар чиний сургийг гаргаж амжаагүй энэ нөхцөлд Хар чоно гэдэг нэрээрээ гарч ирвэл чамд илүү ашигтай. Тэгээд шоронгийнхон дотор зохион байгуулсан ажлаа гаднаас удирдахад чамд хэн ч саад хийхгүй. Нөгөө талаар шоронгийн мэдээлэгч нараас ангид байна гэдэг чинь ажил хэрэгт сайн нөлөөтэй. Хэрвээ Тозияагийн мэдэлд очсоныг мэдээлэгч нар мэдвэл чиний хойноос шиншлэх зориг гаргахгүй. Эцэст нь хэлэхэд Харбинд японы армийн үйл ажиллагааг эсэргүүцсэн нууц байгууллага байгуулагдсан. Чи тэднээс салангид ажиллаж болохгүй.

Миний хэлснийг зөвшөөрвөл би таны ажилд тусалж байх болно.

Буд, Аяанаосугийн энэ үгэнд эргэлзлээ. Тэрээр юм бүхнийг эргэцүүлэн бодсон боловч японы армийн тагнуулын газрын ажилтан, тэр тусмаа Харбины хоригдлын дунд тусгай ажил зохион байгуулах асуудлыг хариуцсан хачин гайхмаар этгээд нэртэй ахмадын үгэнд итгэхээс зүрхшинэ. Гэхдээ сэтгэлд нь «Энэ ахмад намайг Харбинд гарах гээд байгаа нууц бослогонд ашиглах юм уу? Яагаад японы нэртэй, зартай тагнуул гэгддэг Тозияагийн үйл ажиллагааг сонирхож байгаа юм бэ? Тозияа бол гадаад монголын эсрэг чиглэсэн ажиллагааг удирддаг хүн гэгддэг. Тэгэхээр энэ хүн тагнуул хэрэг үү?» гэж бодно.

- Ноён ахмадаа, би таны хэлснийг бодох хэрэгтэй. Тэгээд хэд хоногийн дараа хариуг нь өгье.

- Буд аа, одоо хариуг нь авах шаардлагатай.

- Би таны тавьсан саналыг хүлээн авалгүй шууд армийн удирдлагад мэдээлэх хэрэгтэй гэж бодож байна.

- Танд тийм хүний нүнжиггүй сэтгэл байхгүй гэдэгт би итгэж байна. Миний саналыг зөвшөөрөхгүй байхад танд ямар ч муу юм болохгүй. Хар чоно шоронгийн хоригдлуудын дунд байхгүй байна гэдэг баталгаа бичээд армийн удирдлагад явуулчихна. Гэхдээ армийн удирдлага миний энэ бичгээр таныг сурвалжлах ажлаа зогсоохгүй, харин чамайг хайх миний

ажлыг зогсоох нь гарцаагүй. Ингээд өөр замаар таныг хайж олох болно.

- Би таны саналыг хүлээж авбал Хар чоно гэдэг нэрээр дахин тодрох болж байна. Хэрвээ таны саналыг зөвшөөрөхгүй бол та намайг оролдохгүй орхих боловч би мэдээлэгч нарын өрсөлдөөний явцад амиа алдах болж байдаг. Би Хар чоно гэдэг нэрээр дахин тодрохыг хүсэхгүй. Энэ чинь миний амьдралыг балласан юм.

- Би түүнийг мэднэ. Жан Золин чамайг ашиглах болсны дараа Улаан Оросын хилээс гарсан олон улсын худалдааны бараатай галт тэрэгний цувааг дээрэмдэж сүйтгээд «Хар чонон сүрэг» тонолоо гэдэг цуурхал дэгдээдэг байсан. Тэр үед Манжуурын толгодоор морин дэл дээр хийсэж явсан чамайг Жан Золин «Хар чоно» гэдэг нэрээр их дэвэргэж чамд нууц даалгавар өгч байсан.

Хар чоно гэдэг нэр бол тэжээмэл жингэр, зэрлэгшээд чонон сүрэгтэй нийлж гөлөглөсөн гөлөг бусдаасаа том биетэй, чадал тэнхээ ихтэй болохоор тийм бэлтрэгийг өвөр монголчууд хар чоно гэдэгтэй холбоотой. Үнэндээ таны алдар нэр хар чонон замаар тодорсон. Тиймээс квантуны армийн удирдагчдын сэнсэй (багш) Тозияа таны сургийг гаргах гээд байгаа юм. Би маргааш таныг олох ажиллагааны үр дүнг илтгэх ёстой гэхэд Буд,

- Хэрэв тантай ажиллахгүй бол та Хар чоноыг илчлэхгүй гэсэн амандаа хүрэх үү? гэж лавлав.

- Би худлаа хэлэхийг хүсдэггүй.

- Ноён ахмадаа таны амласан зүйл ямар ч баталгаагүй шүү дээ.

- Будаа, би үүнийг баталгаатай гэж үзэж байна. Чихний эмчид та үзүүлсэн бол эмч нар таныг тэр дороо Доихара руу мэдэгдэх байсан. Одоо Хар чоно хоригдлуудын дотор байхгүй гэдэг баталгаанд эмч нар гарын үсэг зурчихаад байна. Нөгөө талаар таны чихний хулхинд байгаа улаан мэнгийг одоо олон хүн мэдээд байгаа. Аягүй бол шоронгийн мэдээлэгч нарт энэ талаар үүрэг өгөгдсөн байгаа.

- Ноён ахмадаа, та бид хоёр чин сэтгэлээсээ ярьж байгаа боловч Хар чоно дахин тодорсны дараа юутай учрах гэж байгааг ярилцсангүй шүү.

- За, тэгвэл би чамайг миний саналыг хүлээж авсан гэж үзэж болох нь. Чамайг Хар чоно гэдэг нэрээр тодруулсны дараа шууд Синьзин руу авч явна. Тэнд чамайг жинхэнэ мэргэжлийн хүмүүс шалгана. Чи тэр бүх шалгалтыг давж гарах нь чухал! Шалгалт миний тооцоолсноор хоёр гурван сар үргэлжилж мэдэх эгзэгтэй. Ганцхан чиний тэвчээр мэдэх хэрэг. Шалгалт давсны дараа Тозияа таныг биеэрээ хүлээн авна. Тэгээд жинхэнэ гүйцэтгэх ёстой ажлын чинь талаар үүрэг өгч зааварлах болно. Тэр үед би тантай холбоо барина гэж бодож байна. Тэгээд та бид хоёрын цаашдын ажиллагаа бүр ард түмний үйл хэрэгт зориулагдах болно.

- Тийм үед би чамтай яаж холбоо барих вэ?

- Мансю нити нити сонинд «герман угсааны нохой» худалдаж авах зарлал нийтлүүлээрэй. Би өөрөө очиж уулзана. Харин зарлал нийтлүүлэхийн өмнө сайн угсааны нохой олох сураг

гаргаж байх хэрэгтэй. Сайн угсааны нохойны тухай бичсэн. ном олж цуглуулах хэрэгтэй. Тэгээд нохойны талаар багагүй мэргэжсэн байх нь чухал. Чиний зарлалыг тагнуулын газрынхан сонирхох нь зайлшгүй. Тэгвэл тэдэнд «Буунаас нохой илүү итгэлтэй хамгаалагч» гээд хачирлачихаж болно шүү дээ. Ер нь квантуны армийн ажиллагаанд оролцох болсон өдрөөс хойш таны дайсан олширно гэдэг сэтгэгдлийг удирдлагад төрүүлсэн байх нь чухал!

- Аяанаосу сан, та бид хоёр нэлээн ярилаа. Японы армийн үйл ажиллагааг үзэн яддаг миний үзэл баримтлалыг та чин үнэнээр ойлгож байгаа явдал надад сайхан сэтгэгдэл төрүүллээ. Тиймээс та Хар чоныг хорлохын тулд биш, харин зорьсон зорилгоо биелүүлж, өөрийнхөө нүглийг цагаатгах боломж олгож байгаа явдалд би үнэнч байх болно. Тиймээс Хар чоныг олсон тухайгаа удирдлагадаа мэдэгдэхийг зөвшөөрнө гэхэд түрүүнээс хойш барьж суусан хундагатай сакэгаа өргөсөн Аяанаосу инээмсэглээд толгой дохин нүдээ аньсхийх нь сэтгэгдээ баяр баясгалантай байгаагийн илрэл болой.

* * *

Синьзинд хавар эрт эхэллээ. Монгол зурхайн ёсоор хаврын эхэн сарын арван есөнд чийг усны амьсгал эхлэх ёстой.Ердөө цас мөс эмзэгхэн газраараа хайлна гэсэн үг. Чийг усны амьсгал эхлэхээс өмнө Синьзин хот цасгүй боллоо. Хотын гангачуул нимгэн хувцас өмсөж, гудамж талбайн ээвэр газрыг барин явдаг болцгоожээ. Хотод хавар эхэлсний шинж ийнхүү гоц мэдэгдсэн атал квантуны армийн штабынхан жанжин штабаас ирэх шийдвэрийг чих тавин хүлээж, өрөөнөөсөө ганц ч алхам холдож чадахгүй болохоор хаврын урь хэрхэн эхэлснийг мэдэх ухаангүй болой.

Квантуны армийн мэргэжилтэнгүүдийн боловсруулсан «Номон хан зикэн но боппоцу буюу Номон Ханы ажиллагааны эхлэл» гэж томъёолсон төлөвлөгөөг авч явсан Доихара, цэргийн яаманд танилцуулсны дараа сайд Итагаки, ерөнхий сайд Хиранумаад толилуулсны эцэс эзэн хаан Хирохитогийн сонорт хүргэжээ. Чингэвч Халх голын чиглэл буюу Шилийн худгийн Овооноос Хулд уулын чиглэлд Номон Хан, Бүрд-Овооны орчмоор эхлүүлэх квантуны армийн ажиллагааг Комацубараагаар удирдуулах нууц тушаалд гарын үсэг хараахан зураагүй байв. Төлөвлөгөөг армийн жанжин штаб алс дорнод руу чиглүүлсэн «Найм дахь ажиллагаа» гэж товлосон төлөвлөгөөтэй уялдуулан хянасны дараа квантуны армийн боловсруулсан "Номон Хан зикэн но боппоцу" гэдэг нэрийг өөрчилснийг ганцхан Доихара мэдэж байв. Шинэчлэн товлосон тэр төлөвлөгөөгөөр Монголын хилийн цэргийг тав хоногийн дотор устгаад Баянцагааны нуруунд японы армийн фронтын удирдлагыг байрлуулах ёстой байлаа. Тэгээд армийн ар талыг Хайлаастын баруун зүүн талд бэхжүүлэх инженерийн барилга байгууламж барихаар тусгай хороодыг зохион байгуулжээ. Гэвч энэ бүхнийг квантуны армийн удирдлага мэдээгүй болохоор чих тавин «Ямар шийд ирэх бол?» гэж сэтгэлээ дэнсэлгэнэ.

Тозияа жанжин штабын шийдийг хүлээхээр шийдээд Юкигийн чихэнд олигтой мэдээ дуулгалгүй амаа жимийсээр байлаа. Харин түүний сэтгэлд олон жил бодож, тэвчээртэй хүлээсэн бодолдоо хүрэх цагийг мэдрэх тусам яарах бодол төрнө. Гэвч Тозияа сэтгэлийн догдлолоо барьж «Халх голын ажиллагааг эхлэнгүүт Юкийг устгана. Тэр хооронд Юкигийн аргыг олж Хайлар Манжуур юм уу? Эсвэл Ханширээ, Жанжин сүмийн төмөр замыг тавих ажилд хөрөнгийг нь хоршуулаад, алтны банкны баталгаа, гэрээслэл зэргийг мэдэж амжина. Тиймээс Хар чонын ажиллагааг түргэтгэх хэрэгтэй. Ингэхээр Хар чоныг шалгах дараагийн

ажиллагааг эхлүүлье» гэж бодно. Тозияа цонхныхоо дэргэд очоод унтарсан янжуураа асаах зуур «Халхын голын ажиллагааг эхлэхийн өмнө төлөвлөгөөтэй Юкийг танилцуулахыг чухалчлах хэрэгтэй.

Жанжин штабаас баталсан төлөвлөгөөг Юки үзвэл төмөр замын ажилд оролцох явдлаа түргэтгэж шуурхайлах болно» гэж бодсоор утсаа авч тагнуулын хэлтэс рүү ярилаа.

- Гакка, Хар чоно-1 ажиллагааг туршсан. Бүх ажил төлөвлөсөн ёсоор болсон. Одоо Хар чоно-2 ажиллагааг бэлдэж байна гэлээ.

- Та нар Хар чоныг хаана байрлуулсан бэ?

- Цэргийн буудалд байгаа. Одоогийн ажиллагааг Ямато гудамжинд явуулахаар төлөвлөсөн юм.

- Яагаад заавал Ямато гудамжийг сонгож авсан хэрэг вэ?

- Гакка, Хар чоно «герман угсааны» нохой сураглаад байгаа юм. Нөгөө талаар германы хоёр пүүс энэ гудамжинд байдаг. Нөгөө талаар английн пүүс энэ гудамжинд бий шүү дээ. Тэр пүүсийн эзэн бол Тяньжингийн банкны эзний холын хамаатан юм. Ингэхээр Хар чоно-1 ажиллагааны агуулгатай уялдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл манай ажиллагааны дараа ямато гудамжинд байгаа английн пүүснийхэн рүү ажиллагааны нууцыг түлхэж болно шүү дээ.

- Та нарын наад ажиллагаа чинь дэндүү зохиомол юм шиг санагдаад байна. Хар чоно бол ёстой хар чоноос ч илүү хашир хүн шүү. Тиймээс Харбингаас Синьзин руу ирэх замд галт тэрэгний зоогийн газар туршсан ажиллагааг чинь урьдчилан сэжиг аваад танай гурван хүнийг нударчихсан гэдгийг ойлгож байгаа биз гэхэд тагнуулын газрын дарга дотроо «Тозияа, бидний ажиллагааг тусгай замаар давхар хянаж байгаа байх нь ээ» гэж бодоод айлаа.

- Гакка, тийм бүтэлгүй явдал болох нь болсон. Гэхдээ энэ алдаа дахин давтагдахгүй гэдгийг амлаж чадна гэлээ.

Хар чоно хэмээгдэх Буд анхны шалгалтыг давсны дараа хоёр дахь сорилт хэзээ, хаана болох бол гэдгийг бодож болгоомжилж байлаа. Түүний бодлоор бол зочид буудлын архичин дарга нараас болж үүсэх болов уу гэж бодно. Учир нь Синьзин дахь япон дарга нар онцгой эрх дархаа яг эдэлдэг болохоор армийн тогтоосон ёсыг хүндэтгээгүй нутгийн хүмүүсийг бараг дор нь буудахаас буцахгүй болой. Тэрээр буудалд байхдаа их болгоомжилдогийн адилаар гадуур явахдаа өөрийнхөө араас дагаж буй сүүл сүүдрийг хянаж байлаа. Тэрээр Синьзин хоттой танилцаж пүүсүүд хэсэхдээ сайн угсааны герман нохой бэдэрч байлаа. Тэгээд нэг өдөр Ямато хэмээх гудамжинд байдаг германы хоёр пүүсээр орохоор шийдлээ. Хар чоныг английн пүүсний хажуугаар өнгөртөл хоёр согтуу хүн түүнийг тосон уулзаад шүдэнз асуулаа. Байдлыг ажвал европжуу царайтай авч хятад хувцсаар хувцасласан ажээ.

- Би тамхи татдаггүй гэж Будыг хэлтэл өндөр нуруутай булиадуу байрын нэг нь амандаа зуусан тамхиныхаа ишийг тас хазаад нулимснаа,

- Би чамд заагаад өгөх үү дээ гээд аман дахь тамхиа авч Будын аманд зуулгах гэж оролдов. Гэтэл нөгөөх нь Будын баруун гарыг ар нуруунд эргүүлэн бариад,

- Аргаар хэлээд болдоггүй юм бол ингээд татуулна даа гэхэд нөгөөх нь тамхиа Будын аманд хийх гэж хүчлэв.

Буд, Жан Золингийн мэргэжилтэнгүүд болон япон сургагч нараар жиүдиүцү заалгасан болохоор иймэрхүү тоглоомыг үл тооно. Харин өөртөө ашигтай мөчийг хүлээж хүлцэнгүй зогсоно. Буд гарыг нь ар нуруунд зөрүүлэн барьсан бүдүүн эрийн хүчийг дагуулж эргэхдээ зүүн гарын тохойгоор аймхайд нь хүчтэй буулган өвортөл өнөө бүдүүн эр элгээ барин тонгойж цэхэлзсээр доошоо суусхийгээд газар нугдасхийгээд уначихлаа. Чухам энэхэн үед нөгөө нь Буд руу дайрахад, далайсан гарыг нь тосон барингуутаа нуруугаараа бөхийтөл өнөө эр хамаг хүчээрээ Будын дээгүүр тэгнэгдэн тогтосхийхэд Буд түүнийг нуруун дээрээ өргөсөн тэр чигээр нь хажуугийнхаа байшингийн шилэн цонх руу чулуудчихлаа. Гэтэл гудамжны нөгөө талд явсан хоёр хүний нэг нь газраас өндийсөн бүдүүн эрийг буудчихлаа. Чингэтэл гудамжинд байсан япон цагдаа нар тэднийг дор нь баривчилж, цагдаагийн хэсэг дээр авчирлаа. Будыг цагдаагийн жижүүрийн өрөөнд орж иртэл гаднаас нэгэн япон хурандаа орж ирээд Будыг суллуулаад аваад гартал цагдаагийн хэлтсийн үүдэн дээр суудлын тэрэг хүлээж байв.

- Хар чоно оо, та үүнээс хойш гудамжаар явахдаа болгоомжтой байх хэрэгтэй. Саяын согтуу хүмүүс ямар хүн байсан гэж санана. Тэр цонх руу чулууддаг чинь 1935 онд Тяньжинд байсан английн консулын газрын орчуулагчдын нэг. Одоо энд английн худалдааны нийгэмлэгийн газар ажилладаг юм. Тэгээд таныг Синьзинд ирсэн явдлыг мэдээд өшөөгөө авахаар шийдсэн байна. Манайд байгаа мэдээгээр бол танд өширхөн хонзогнох явдал үүгээр зогсохгүй. Гудамжны нөгөө талаас буудсан хүмүүс бол английн пүүсний гар хөлийн хүмүүс байгаа юм. Тэднийхэн таныг устгах гээд өөрсдийнхөө хүнийг нударчихлаа гэж өнөө хурандаа болсон хэрэг явдлын учрыг тайлбарлав. Хар чоно, хурандаагийн үгийг эргэцүүлэн тунгаавал энэ бүхэн зохион байгуулсан туршилт байлаа. Түүнээс уул хэрэг гараад хагас цаг болоогүй байхад энэ бүхнийг тогтоож чадахгүй нь илэрхий ажээ. Гудамжинд болсон хэргээс хойш цагийн дараа тагнуулын газрын дарга Тозияад болсон байдлыг илтгэв.

- Тозияа сан, Хар чоно биднээс герман угсааны нохой олж өгөхийг хүсэлт болгож байна. Гудамжинд болсон хэргээс болгоомжилж өөрийгөө хамгаалах нохойтой болох санаатай юм байна. Одоо Хар чоно-3 ажиллагааг эхлүүлэх удирдамж өгөхөөр бэлтгэж байна гэхэд Тозияа,

- Одоо турших хэрэггүй. Та нарын туршилт надад хачин санагдаад байна. Олон туршилт хүнийг жигшээчихэж мэднэ. Хар чоныг аахар шаахар юмаар өөлөх хэрэггүй. Юу ч гэсэн хэд хоногтоо тэр нохойгоо хайгаад тэнэж яваг! Гадуур явахад нь хориг саад тавьж болохгүй. Харин хяналтаа чангатга! Хэд хоногийн дараа би чамтай уулзаж цаашдаа хэрхэхийг хэлнэ гээд утсаа тавилаа.

Тозияа энэ өдөр орой болтол өрөөндөө сууж Хар чоныг туршсан бүх ажиллагааны мэдээ баримтыг тулган үзээд Юкитэй уулзахаар шийдлээ. Тэгээд өрөөнөөсөө гарч сэмхэн алхсаар Юкигийн өрөөний үүдэнд очтол түүний ард ямар нэг чимээ гарах шиг болов. Тозияа хэрсүүлэн ажигласан боловч ямар ч сэжиг алга. Тэгээд хэсэгхэн зогсохдоо «Миний араас

Юкигийн гэрийн үйлчлэгч нар сэм хянадаг юм болов уу? Би яагаад энэ бүхнийг мэдсэнгүй вэ? Хүний хөлийн чимээ яах аргагүй гарсан даа» гэж бодоод Юкигийн өрөөнд орлоо. Номоо бичиж суусан Юки, Тозияагийн бараанаар суудал дээрээ эргэн Тозияа руу хараад,

- Ааваа та, хүрээнээс манжийн амбан хэрхэн хөөгдсөнийг мэдэх үү? гэж асуулаа.

- Би хүмүүсээс сонссоноос цаашгүй. Тэр үед Хүрээнд байсан

нэг хятад энд байдаг юм. Түүнтэй уулзаж яривал сонин юм сонсоно шүү гээд Тозияа ярианы далим гаргаж,

- Юки минь Акасай хаачаа вэ? гэлээ.

- Өрөөндөө Банди, Тогтох хоёртой хятадын хувьсгалын тухай (1911 онд гаргасан хятадын хөрөнгөтний хувьсгал Учаны бослогоор эхэлсэн Хятадын хуучин он тоололд тэр жилийг синьхай гэдэг байжээ) орчуулга хийж байгаа юмсан. Та юм орчуулуулах гээ юү?

- Үгүй ээ. Акасайг Токиогоос дуудуулсан байна. Холын нэг хамаатан нь нас бараад Акасайд хөрөнгөө гэрээсэлжээ. Тэгээд түүнийг өвлүүлэхээр Акасайг армийн удирдлагаар дамжуулж дуудуулсан байна. Явуулахгүй бол болохгүй байх гэхэд Юки төдий их сонирхож шалгаасангүй. Юки, Акасайг явуулахгүй энэ тэр гэж хориг саад тавиагүй болохоор Тозияа сэтгэлдээ баяртай. Тозияа ширээн дээр дэлгэсэн ном руу шагайн, хэсэг дуугүй байснаа Юкигийн өрөөнөөс гарч Акасайн өрөөнд очлоо. Тозияаг орж ирэхэд Тогтох, Банди, Акасай гурав ёсыг даган хүндэтгэж суудлаасаа бослоо. Тэгээд Тозияаг Акасайтай ярихад нь саад болохгүйг хичээсэн Тогтох, Банди хоёр өрөөнөөс гарлаа. Акасай японы гэр ахуйн уламжлалт ёсыг даган тэргүүн бөхийлгөн зогсоход Тозияа хаалга руу эргэн харснаа «Энэ хоёр золиг намайг тагнадаг юм уу даа. Арай тэгмээргүй юм. Цэен гүн ахынхаасаа дагуулж ирсэн тэр өдрөөс хашаа хороо цэвэрлэж, хар бор ажилд зүтгэж өдий хүрэхдээ миний царай руу эгцэлж харахаасаа эмээдэг тэр л зангаараа байдаг аймхай амьтад намайг арай тагнамааргүй юмаа» гэж бодоод,

- Акасай та нар аль зэрэг удаан суув? гэж асуулаа.

- Бид бараг гурван цаг өрөөнөөсөө гарсангүй шүү гэхэд Тозияа сэтгэлдээ «Миний муу санаа яагаад муу юм зөгнөөд байна? Дэндүү хаширлаад байгаа юм байх даа» гэж бодоод,

Акасай, чи Шанхай руу явахаар бэлтгээрэй. Тэндхийн консулын газар үйлчлэгчээр ажиллах болно. Чамайг очсоны дараа нэг өвөр монгол хүн бүртгүүлэхээр очно. Тэр үед консулынхан чамд яаж ажиллахыг чинь хэлж өгнө.

Тэр хүн Эрхэмбаяр гэдэг нэрээр очих юм. Чи түүний үйл ажиллагаа, алхаа гишгээ бүрийг хэмжих болно. Ялангуяа хэнтэй уулзаж, хаана очиж, юуны талаар ярилцаж, юу сонирхож байгааг нь өдөр алгасалгүй тэмдэглээд тэмдэглэлээ консулын шугамаар явуулж бай! Тэр консулын газраар ажил төрөл хөөцөлдөж очих байх. Тэгэхэд нь үзэгдэж харагдсаны хэрэггүй. Ер нь удирдамж өгтөл хөндийхөн яваарай. Би чамайг Токио руу явуулах болсон гэж Юкийд хэлсэн. Тэгэхээр чи Юкийд хамаатныхаа гэрээсэлсэн өвийг авч эзэмших эрх бүхий цорын

ганц хүн гэдгээ хэлнэ биз гэв.

Тозияа Акасайгийн өрөөнөөс гарч өрөөндөө орж ирээд хажуулснаас хойш өглөө болтол таг унтжээ. Тэгээд өглөөний цай хоолоо идээд ажил руугаа гэлдэрлээ. Тозияаг гарснаас хойш хориод мөч өнгөрсний дараа Акасай Юкигийн өрөөнд орлоо. Юки, Акасайгийн бараанаар суудлаасаа босож,

- Тозияа сан чамтай өчигдөр орой уулзав уу? гэлээ.

- Уулзсан. Намайг Шанхай яв гэж байна гэхэд Юки,

- Мөн дөө. Өчигдөр надад хэлэхдээ Токиогоос дуудлаа гэж байсан гэв.

- Тозияа нэг юм хэлээд огт өөр зүйлийг хийдэг хүн. Үхээгүй хүнийг үхсэн болгож, үүсээгүй юмыг бий болгож чаддаг зайтай. Би Шанхайд очоод Токиогоос нутаг руугаа явж байгаа нэг өвөр монгол хүний ажил төрлийг хянах юм байх. Ялангуяа Шанхайн банкныхантай ямар холбоотойг нь мэдэж мэдээлж байх гэнэ. Тэр хүнийг Эрхэмбаяр гэдэг бололтой.

- Тэр хүнийг чи таних хэрэг үү?

- Үгүй. Шанхайд очсон хойно консулынхан тэр хүний царайг надад зааж өгөх бололтой. Ер нь би тэр хүнийг Токиогоос Шанхайд очиж байгаа гэдэгт итгэхгүй байна. Харин Синьзинээс тийшээ очиж байгаа хүн байх гэж бодож байна. Миний бодол зөв бол Тозияа, намайг галт тэргэнд суухаас өмнө тэр хүнтэй нүүр учруулах байх. Тозияа юмыг ингэж эсрэгээр нь зохион байгуулдаг сурамгай хүн.

- Чи тэгээд хэзээ явах юм бэ?

- Нөгөөдөр явах бололтой. Өнөөдрөөс эхэлж бэлтгэ гэсэн.

- Чи тэгээд явья гэж бодож байна уу?

- Би Тозияагийн өөдөөс үг хэлэх эрхгүй шүү дээ. Түүний юу хий гэснийг гүйцэтгэх ёстой. Харин та намайг явуулахгүй гэвэл таны саналыг Тозияа хууль шиг дагана. Тиймээс Тозияа тийм боломж гаргахгүйн тулд хамаатны нь хүн нас барсан гэж хэлсэн хэрэг. Ийм үг сонссон хэн ч яаж ч татгалзахгүй гэдгийг Тозияа сайн мэднэ.

- Акасай, чи өөрийнхөө мэдсэн бүхнийг Тозияад яагаад илтгэдэггүй юм бэ? Наанадаж гэхэд чи миний нууцын шүүгээний түлхүүрийг миний ширээн дээрээс хэд хэдэн удаа авсан мөртлөө надад буцааж өгсөн шүү дээ.

- Та тэр түлхүүрээ мартчихдаг удаа бий. Гэхдээ тэр түлхүүрийн чинь ижил түлхүүр Тозияа бид хоёрын хэн хэнд нь байдаг юм. Тэгэхээр таны мартсан түлхүүрийг авах хэрэггүй гээд халааснаасаа

Юкигийн нууцын түлхүүрийг дуурайлгаж хийсэн түлхүүр гаргаж тавилаа.

- Тозияа миний нууцын шүүгээг уудалдаг уу?

- Чамайг байхгүй хойгуур уудалдаг. Гэхдээ алтны баталгаа, банктай харилцах нууц томьёоллын талаар мэдэж чадаагүй юм.

- Чи түүнийг мэдсэн үү?

- Тиймээ. Таны банктай харилцах нууц томьёоллыг чинь талийгаач эцгийн чинь бадмаараг шигтгээтэй алтан бөгжний шигтгээний таван доор байдаг шүү дээ гэлээ.

- Тэр бөгжийг Тозияа сан зүүдгийг чи мэдэх үү?

- Мэднэ. Та Итагакийг Токио руу явах үед тэр алтан бөгжийг Тозияад өгч зүүлгэсэн байсан. Тэгэхдээ та банктай харилцах нууц томьёоллоо авчихдаг байсан байна.

Тозияа түүнийг зүүх тоолондоо тусгай хүмүүсээр үзүүлдэг боловч юу ч байхгүй гэдгийг мэдээд тоохоо больжээ. Хамгийн сүүлд саяны цагаан сараар Тозияад зүүлгэсэн биз дээ гээд Юкигийн нууцыг хэрхэн мэдсэнээ ярилаа.

...Тозияа. Акасайг Юкигийн дэргэд ажиллуулсны дараа хэдэн сар болоод тайлгын сүм рүү явсан ажээ. Тэгэхэд Тозияа, Акасайд түлхүүр өгөөд,

- Биднийг явсны дараа Юкигийн шүүгээг уудалж, эцгийнх нь алттай холбогдох бүх баримт, алтны талаар банктай харилцдаг нууц томьёолол, эцгийнх нь гэрээслэл зэргийг олж, гэрэл зургийг нь аваарай гээд тагнуулынханд зориулж үйлдвэрлэдэг жижиг аппарат өгчээ. Юкигийн гэрийн үйлчлэгч нарт мэдэгдэхгүйн тул Акасай Юкигийн өрөөнд өдрөөр орж нууцыг нь үздэг байлаа. Акасай үнэт эрдэнэсийн шигтгээтэй алтан бөгж, зүүлт, гоёл чимэглэл бүхнийг ширхэг дараалан үзсэн боловч хэрэгцээтэй зүйлээ олоогүй юм. Харин эмэгтэй хүний сониучхан зангаар алтан бөгж, ээмгийг зүүж сонирхдог байлаа. Нэг удаа талийгаач эцгийнх нь бөгжийг эрхий хуруундаа хийтэл тэр нь эрхий хуруунаас нь гарч өгсөнгүй. Хуруу нь хөөчихжээ. Тэгээд эрхий хуруугаа норгоод ноцолдож байтал том бадмаараг шигтгээ таваараа салж нээгдэв. Гэтэл шигтгээний тав сууринаас нэгэн жижиг бичиг ойчлоо. Акасай түүнийг задалж үзсэн боловч юу ч уншиж чадахгүйгээ ойлголоо. Акасай бөгжөө хуруунаас арайхийж гаргаад өнөө бичгийг буцааж хийгээд хуучин янзаар нь тавилаа. Акасай, энэ бүхнийг Тозияад хэлэхийг бодсонгүй. Харин сэтгэлд нь японы сөрөг тагнуулын газар орж бузар ажиллагаанд оролцох болсон нь санагдлаа. Акасайгийн сэтгэлд хоногшсон аймшгууд нүднээ үзэгдэх шиг болж сэтгэлийг нь шаналгана. Акасай энэ бодлоосоо салахыг хичээж «Юки надад ямар гэм хийсэн биш дээ. Би эднийд ирснээсээ хойш кэмпэйтийн дарга нарын гарын чилээг гаргах аюулаас (зодуураас) түр ч гэсэн мултарсан. Тэд намайг өгсөн даалгавар биелүүлсэнгүй гэж зодож нүдээд шоронд хийдэг байлаа. Шоронгийн согтуу хуягууд хүчиндэж тамладаг байсан» гэж бодохоос сууж байх газраа олсонгүй.

Акасай бурханд сүсэгтэй болохоор кэмпэйтийнхны гараас мултрахыг хүсэхдээ мэргэлүүлж үзжээ. Мэргэчид хөөрхий бүсгүйн зовлонг гадарлаад «Чи зовлонгоос сална. Гэхдээ тэр үед мэдэхгүй өнгөрвөл тамд очно» гэжээ. Акасай Юкитэй Токиод танилцсанаасаа хойш «Нөгөө аз жаргал авчрах үеэ» мэдэлгүй өнгөрөөчих бий гэж боддог болсон. Тэгээд Юкийнд ирснээс

хойш «Энэ бүсгүй намайг зовлонгоос салгах замыг минь зааж өгөх хүн шүү» гэж бодоод өөрийнхөө бодолд итгэдэг болжээ. Тэгээд өөрийнхөө мэдсэн бүхнийг Тозияагаас нуухдаа «Юкигийн зовлонгоор би жаргал хийгээд сайнаа үзэхгүй» гэж бодно. Акасай Юкигийн зан чанарыг ойлгох тусам түүний тэвчээр, ухаалаг байдал, амьдралтай харьцдаг чанар, алдаа ослоо харж чаддаг авхаалжийг ажаад улам зориг орж, сэтгэл шулуудсан билээ. Гэвч өөрийнхөө сэтгэлийн цаана байгаа бүхнийг Юкийд гаргаж чадалгүй өдий хүрсэн.

- Акасай, бөгжний хувьд гэвэл миний эцэгт тийм хоёр бөгж байдаг юм. Тозияад зүүлгэдэг бөгж бол чиний үзсэн бөгжийн өрөөсөн. Харин чамд олж үзүүлэхээр бэлдсэн тэр бөгж бол хуурамч зүйл. Жинхэнэ нууц томъёотой бөгжийг хожим чамд үзүүлнэ.

Энэ хугацаанд болсон зүйлийг би бүгдийг мэднэ. Чамд том итгэл хүлээлгэе гэж бодож байгаа. Чи Шанхай явах хэрэгтэй. Тиймээс ч би Тозияад чамайг явуулахгүй энэ тэр гээгүй юм. Чи Шанхайд очоод нэг эмэгтэйтэй уулзаарай. Тэр хүн чиний аюулгүй байдлыг хангах болно. Тэр эмэгтэйг Гэрлээ гэдэг юм. Би аавын жинхэнэ бөгжийг өгч явуулна. Түүнийг үзээд тэр эмэгтэй намайг явуулсан гэдэгт итгэх болно.

Тэгээд ч Гэрлээтэй тун холбоотой ажиллах хэрэгтэй болох байх. Тэр эмэгтэй чиний гүйцэтгэх ажлыг газар дээрээ шийднэ гээд номынхоо сан руу эргэж нэгэн зузаан ном авч номын хуудсуудыг эргүүлснээ нэгэн хуудсыг ураад цаанаас нь төдий гүн биш ухаж тохируулсан нүхэнд шигтгэсэн бадмаараг шигтгээтэй алтан бөгж гаргаж үзүүлээ. Тэр бөгжийг өөрийн нь хэмжээний хэртэй хуудсуудыг нийлүүлж наасан хуудасны голд суулгажээ.

Тозияа, Акасайтай тохиролцсоны маргааш квантуны армийн штаб дээр аваачиж ажил төрлийн заавар өглөө.

- Юки чамайг Токио явна гэдэгт итгэж байгаа. Чи өнөө орой Юкитэй уулзаад маргааш өдрийн онгоцоор явах болсноо хэлээрэй. Энэ онгоцны пиу чинь. Өглөө Юки чамайг онгоцны буудал дээр хүргэж өгнө байх. Чи татгалзах хэрэггүй. Тэгээд миний машинаар явцгаана биз. Онгоц агаарт хөөрөөд арван таван мөчийн дараа эргэж бууна.

Манайхан чамайг буудал дээрээс энд авчирна. Тэгээд оройн галт тэргээр Дайран руу гарна. Дайрангаас усан онгоцоор Шанхай руу очно гэж зааварлав. Чингээд маргааш өглөө нь бүх юм Тозияагийн төлөвлөсөн ёсоор боллоо. Акасай онгоцноос буугаад квантуны армийн штаб дээр ирлээ. Тэгээд орой болтол тэнд байлаа. Чингэтэл Дайран-Синьзингийн галт тэрэг хөдлөхөөс 20 мөчийн өмнө нэг ахмад орж ирээд,

- Акасай, та одоо эндээс гараад хоёрдугаар давхрын шатны дэргэд байгаа баганы хажууд очиж зогсоод доошоо харах хэрэгтэй. Тэнд хоёр хүн ярьж байгаа түүний нэгийг сайн нүдэлж авах хэрэгтэй гэлээ. Акасай, хоёрдугаар давхрын шатны дэргэд очтол шатны бариулын эргэдэг доголын зайгаар доод давхарт баганы дэргэд зогсож байгаа хоёр хүн сайн харагдаж байв. Өндөрдүү нуруутай, гоолиг биетэй, дөч эргэм насны нэг өвөр монгол хүн Тозияатай ярилцан зогсохыг ажваас өнөө Эрхэмбаяр гэдэг хүн нь бололтой. Акасай тэр хүнийг ажиглан харж зогстол нөгөө ахмад түүний дэргэд ирээд,

- Сайн ажиглаж ав! Шанхайд та энэ хүний үйл ажиллагааг хянах болно гэж хэллээ. Тозияатай

уулзан ярьж байгаа тэр хүнийг Акасай Эрхэмбаяр гэдгийг мэдэх авч түүний жинхэнэ нэрийг
Буд гэдгийг яахан мэдэх аж.

Гурав. Сафронов сэтгэл шуударлаа

Хаврын сүүл сарын шинийн таванд ичсэн амьтан ичээнээсээ гарч ханш нээжээ. Зуны улирал өгөөжтэй сайхан болох ая орж, цаг агаарын аясаар газрын өнгө өөрчлөгдөн хувирахын адилаар армийнхны боловсруулсан төлөвлөгөөний дагуу японы засгийн газар улс төр, цэргийнхээ бодлогыг өөрчилдөг уламжлалтай болой.

1939 оны эхний улирал дуусаж байхад японы сайд нарын танхим, хятадын эзлэгдсэн газар нутаг дээр явуулах улс төр эдийн засгийн ач холбогдолтой олон зуун зарлиг, тушаал, тогтоол гаргалаа. Японы засгийн газар сүүлийн хоёр жил хятадын хөрөнгөтнүүдтэй холбоо тогтоож чадсаны ачаар Япон-Хятадын хамтарсан 13 том компанийг төв хятадын нутагт байгуулж чадсаны ачаар ихээхэн ашиг олох бололцоо нээгджээ. Тэгээд ч зогссонгүй Шанхайг эзэлж, Ван Зиньвэй тэргүүтэй засгийн газар гэгчийг ёс бусаар байгуулж, японы засгийн газраас «Гадаадын капиталын мөлжлөгөөс чөлөөлөгдсөн хятадын үндэсний сэргэн мандалт» гэдэг нэрийн дор өөрийн концернүүдийг байгуулж түүний нөлөөг идэвхжүүлэв. 1937 оны 11 дүгээр сарын 12-нд Шанхайн хувь заяа японы гарт орсноос хойш Шанхайн районыг сэргээн шинэчилж хөгжүүлэх япон хятадын хамтын нийгэмлэг байгуулав. Чингээд шинэ байгуулсан засгийн газар дайны хөлд сүйрсэн Шанхайн цэргийн зориулалттай үйлдвэр, усан онгоцны засвар, зогсоол, төмөр зам, олон улсын цахилгаан харилцааны шугамыг сэргээх явдлыг чухалчилж япон-хятадын хамтын ажиллагааны нийгэмлэгт 20 сая иений хөрөнгө олгожээ. Японы засгийн газраас хятадын эзлэгдсэн газар нутагт явуулсан нэг шинэчлэлт бол доллар фунт стерлинг, марк, франкаар худалдаа хийх явдлыг албан ёсоор зогсоож ноднингоос эхлэн шинээр баталсан юань (японы засгийн газраас баталж гаргасан), иень хоёроор худалдаа хийж байхыг зарлиг болгожээ. Чингээд зогссонгүй Шанхайд байгаа 50 гаруй үйлдвэрийг «Японы армийн» өмч болгон зарлав. Харин Манжуур болон Өвөр Монголд дэлгэрсэн японы үйл ажиллагааны явцад 1938 онд 4 тэр бум иений ашиг олсны зэрэгцээ өмнөд манжуурын төмөр замаас олсон ашиг нь 722 сая иень байжээ. Гэтэл Манжуурын үндэсний компаниуд ердөө 316 сая иень хэртэй ашиг олсон аж.

Японы засгийн газар улс орноо эдийн засгийн сүйрлээс аврах арга замаа бусад орны эдийн засгийн баялгийг цөлмөх хэмээх хэлбэржсэн загвараа урьтал болгосны адилаар дорнод Хятадын төмөр замын ашиглалт зам барилгын ажлыг эрхэлсэн «Кобуко коцу» гэдэг нэгдлийг 1939 оны 4 сард байгуулах шийд гаргалаа. Энэ нийгэмлэг Хянгань шоронгоос 16 мянган хоригдол авч ажиллуулахаар шийджээ. Армийн удирдлага Хайлар Манжуур, Ханширээ Жанжин сүмийн хооронд төмөр зам тавихаар шийдвэр гаргасан боловч «Кобуко коцу» нэгдэлд хөрөнгө хоршсон хувийн пүүснүүдийн хооронд яггүй зөрчил гарчээ. Гэсэн ч армийн удирдлага үүнийг зохицуулж чадна гэж үзээд нэг метр замд 10 хоригдол гурван ээлжээр ажиллуулахаар тооцоолж 160 км төмөр замыг асар богино хугацаанд тавина гэж шийджээ. Гэвч үүнийг Уэдагаас өөр хэн ч мэдсэнгүй. Уэда өглөө ажилдаа ирж өрөөндөө оронгуут Тозияаг дуудуулав. Тозияа юм бүхнээс болгоомжилж сурсан зангаар «Армийн командлагч юу болоод намайг дуудав? Хэрвээ хоригдлуудын талаар асуувал тэднийг монголын хил дээр хаях ухуулах хуудас бичих, хэвлэх, тараах ажилд сургаж байгааг хэлнэ. Харин Хар чонын талаар асуувал юу гэх вэ? Үүнийг Уэда сан мэдэх ёсгүй юмсан» гэж бодсоор өрөөнд нь орлоо.

Уэда нимгэн уруул дээрээ ургасан ширвээ хар сахлаа хөдөлгөн инээмсэглэсээр угтахыг ажвал

тэрээр тун сайхан ааштай байгаа нь илт ээ.

- Тозияа сан, наашаа суугаач гээд Уэда ширээн дээрх янжуураас авав. Тэгээд янжуураа асааж тавтай нь аргагүй сорж, амаараа утааг нь алгуур үлээж гаргахдаа яриагаа эхлэв.

- Засгийн газар шинэ нэгдэл байгуулах шийд гаргасан. Ингэхээр энэ тухай Юки санд дуулгах хэрэгтэй. Нөгөө талаар танай ахмад Аяанаосугийн хоригдлуудыг сонгох ажлыг шуурхайлах хэрэгтэй.

- Хоригдлуудын судалгаа дууссан. Одоо тэдний дундаас хорлон сүйтгэх ажиллагаа, хутган үймүүлэх, монголын үндэсний үзэлт сэхээтэнтэй ажиллах хүмүүсийг сонгож тусгайлан хичээллүүлсэн. Халх голын районыг эзлэнгүүт нутгийн хятадуудыг тийш нь нүүлгэн суулгах асуудлыг боловсруулж байгаа. Ер нь гурван хэсэг хүмүүсийг Халх гол руу нүүлгэнэ.

- Тозияа сан таны ажил надад тун тааламжтай байна. Жанжин штаб Токиогоос зүүн умард хятадад шилжүүлэн суулгах иргэдэд хамгийн үржил сайтай газар эдлэнг олгох хэрэгтэй гэсэн. Тэгэхээр Хянганы болон баргын сайн хөрстэй газрыг эзэлсэн хятадуудыг монгол руу нүүлгэж, тэдний эдлэн газрыг Токиогоос ирэх иргэдэд шилжүүлэх нь чухал. Харин Юкигийн талаар ямар нэг идэвхтэй ажил сэдэх хэрэгтэй. Кобуко коцу нийгэмлэгт хоршсон хувийн пүүснүүд Хайлар Манжуур, Ханширээ Жанжин сүм рүү чиглэсэн төмөр замыг тавих ажилд чирэгдэл тарьж магадгүй байна. Тэд юуны өмнө төмөр зам тавьсны дараа хүн ам цөөнтэй, үйлдвэрийн томоохон район байхгүй энэ газраас ашгаа олж чадахгүй гэж цааргалаад байгаа бололтой. Тэгэхээр бидэнд Юкигийн идэвх, санаачилга тун их хэрэгтэй болох нь.

- Эрхэм дээдсээ бид үйл ажиллагаагаа Халх голоор хязгаарлахгүй. Тэгэхээр Халх голын чанадад явуулах ажиллагаанд Юкийг ашиглаж болох юм.

- Тозияа сан, би таны саналыг хамгийн түрүүнд дэмжинэ.

Тавдугаар армийн ажиллагааг идэвхжүүлж Цицикарь, Нуньзингийн төмөр замын өргөтгөлийг таван сар гэхэд дуусгасан байх талаар Доихараад тусгай даалгавар өгсөн байна. Энэ чинь манай ажиллагаатай зэрэгцэж байгаа юм. Би Комацубарааг дуудсан. Түүний штабыг Хайларт байрлуулна. Фронтын командлалын байрыг Жанжин сүмд төвлөрүүлж, хилийн цэргүүдийн дунд тараах болон орон нутгийн гүнд хаях ухуулах хуудас цэргүүдийн сонирхлыг татах зүйлийг бэлтгэх ажлыг эхлүүлбэ. Бид тавдугаар сарын эхний хагаст өөрийнхөө ажиллагааг эхэлнэ гэж бодож байна. Жанжин штаб тэгж батлах байх. Харин үүнийг чи бид хоёроос өөр хүн мэдэхгүй байгаа шүү гэлээ. Тозияа Уэдагийн өрөөнөөс гарч ирээд тагнуулын газрын даргыг дуудлаа. Тэгээд ажил төрлийн талаар асууж танилцаад,

- Харбинаас Аяанаосуг яаралтай дууд! Нөгөө талаар Халх голыг эзлэнгүүт эзэлсэн нутаг дээр шилжүүлэн нутаглуулах хятадуудыг аль аль газраас татах асуудлыг цагдаагийн газартай болон холбогдох газруудтай ярилцаж бэлэн болго! Мөн Ханширээ, Ирэси, Халуун Рашаан руу явуулах хүмүүсийг Аяанаосутай ярилцаж тохир! Харин та нарт сануулахад энэ онд Токиогоос 640-700 мянган иргэд ирж манжуурын янз бүрийн районд үржил шимтэй газар авч эзэмших тул тийм хэмжээний хятадуудыг монгол руу шилжүүлэн нүүлгэнэ гэдгийг мартаж болохгүй. Монголын эзлэгдсэн газраас хүн бүрт 4--5 га газар олгоно гэдгийг хятадуудад ойлгуулах

хэрэгтэй. Нөгөө талаар Жанжин сүм дээр байгуулах хэвлэлийн газар юу болсон бэ? гэж асуулаа.

- Монгол бичгийн үсгийн хэв, суурь машинуудыг бэлдчихсэн. Энэ долоо хоногт Жанжин сүм рүү явуулна. Харин ухуулах хуудас бичих, хэвлэх, тараах асуудлыг тантай ярилцаж шийдмээр зүйл нэлээд байна. Хэвлэлийн асуудлыг шийтгэх са Тогава удирдах ёстой. Харин орчуулагчдын асуудал хүнд байна.

- Орчуулагч нарын хувьд гэвэл танай хэлтсийн орчуулагч нарыг эхний үед ашиглана. Монголын хил нутгийн гүнд хаях ухуулах хуудсын агуулгыг таван чиглэлээр бэлдэх нь чухал. Нэг: Улаан оросууд монголын нутагт дураараа орж, улаан монголчуудтай нийлэн шашин шүтлэг, зан заншлыг сүйтгэж байгааг тодорхойлж, монгол түмнийг улааны эсрэг босгохыг ухуулан таниулах. Хоёр: Монголын шашин төрийг хосолсон хаант улсыг сэргээн байгуулж, улааны нөлөөнөөс ангижруулах явдлыг японы арми өөрийн эрхэм үүрэг гэж үзэж байгааг ойлгуулах. Гурав: Улаан оросоос амласан тусламжинд итгэж болохгүй. Монголын гадаад хүч бол зөвхөн Их Наран улс гэдгийг чухалчлах ёстой. Нөгөө хоёр сэдвийг эдийн засгийн асуудлаар боловсруулах нь чухал гэж Тозияа ажлын удирдамж өглөө.

- Гакка, Юки саныг манай энэ ажилд оролцуулбал ямар вэ? Бидэнд монголоор сайн бичиж найруулдаг хүн хэрэгтэй шүү дээ.

- Энэ чинь бүтэхгүй. Харин Сафроновыг ажиллуулах талаар Хатотой ярилцах нь арай дээр. Тэр чинь Цэен гүнгээр бичиг заалгасан хүн. Барон Унгерн, монголын хошуу ноёдод илгээх бичгээ Сафроновоор бичүүлдэг байсан гэдэг. Гэхдээ нэг эгзэг бий гэснээ «Тэр эгзгийг давхар шалгаж болно» гэж өөртөө сануулан шивнэв.

Тозияа Сафроновын талаар гаргасан сэжгээ Симотоогоор шалгуулахад бас сэжигтэй юм олдсонгүй. Симото Харбинд Сафроновтой уулзахдаа Благовещенскт байдаг дүрвэгсдийн товчооны туршуулуудынхаягийгавчээ. Тэгээдтүүний мөрөөр тусгайланбэлдсэн «золионы» хүмүүс явуулж шалгахад Сафроновын туршуулууд үнэнч хэвээрээ байлаа. Симотогийн золионы хүмүүс гэдэг нь туршуулуудыг шалгаад буцаж ирэхдээ хилийнхэнд өртөхөд гарзгүй хүмүүс юм. Тэд шалгасан мэдээгээ тусгай шугамаар Симотогийнхонд дамжуулдаг болохоор тийм хүмүүсийг Симото дахин ашиглах хэрэггүй гэж үздэг байв. Сафроновын хүмүүс урвасан бол очсон хүмүүсийг барьж өгнө гэж Симото тооцоолж байсан. Хэрэв Симотогийн золионы хүмүүсийг Сафроновын туршуулууд улааныханд барьж өгсөн бол Симото, Сафроновын хамаг хэргийг уудалж тулгах байсан. Гэтэл түүний төлөвлөсөн бүхэн талаар өнгөрлөө.

Тозияа, Симотогийн илтгэх хуудаснаас энэ бүхнийг мэдээд «Сафронов, Хатогийн ажигласнаар үл бүтэх хүн бол Халх голын ажиллагааны явцад түүний гууль цухуйна. Ер нь Сувдаагийн юмыг дамжуулсан хүний дүрд шавь нараасаа орлуулан тоглуулж шалгасан ч болох юм» гэж бодож байв.

- Хурандаа та, Тогавааг Жанжин сүм рүү явуулж ажлаа эхлүүлэхийг бод. Ухуулах хуудас хэвлүүлэх, эх бэлдэх хүмүүсийг тусгай шугамаар Жанжин сүм рүү явуулна гээд хурандааг гарсны дараа Харбин руу залгуулж Хатотой утсаар ярилаа.

- Хато сан, Сафронов ямаршуухан байна? Та өөрийнхөө төсөөллийг баримттай болгож чадав уу?

- Тэр талаар олигтой юм алга. Харин Разаевский Сафроновтой холбогдсон асуудлыг сонсоод эсэргүүцсэн төдийгүй агаман Семеновт танилцуулж гомдол гаргасан учраас агаман жанжин штаб, цэргийн яаманд тунирхсан байна. Харин Мешановыг өөрийнхөө шунаг сэтгэлийнхээ ашгийг бодож нууц баримт худалдаж байсан гэдэг баримт гаргаж болох боловч одоо тэр асуудлыг сөхөөд хэрэггүй юм шиг байна. Энэ ч яахав. Түүнээс илүү ноцтой юмтай учраад байна. Өчигдөр Харбин Синьзиний галт тэрэгний явалттай тохируулж нэг жижиг өртөөнөөс үл мэдэгдэх долгион баригдсан юм. Мөн үүний өмнө Харбинаас барьж авсан нэг долгионтой харьцуулсан мэргэжилтэнгүүд энэ хоёр мэдээг нэг хүн дамжуулсан гэж үзэж байна. Гэсэн ч түүний агуулгыг тайлж чадаагүй.

- Хато сан, түрүүчийн нэвтрүүлгийн газрыг тогтоосон уу?

- Тогтоох нь тогтоосон. Гэхдээ яг хаанаас гэдэг нь илрээгүй. Илрүүлдгийн даваан дээр нэвтрүүлэг дууссан. Урьдчилсан тоймоор бол Харбины цэргийн хуарангийн хавиас дамжуулсан байж болох юм.

- Цэргийн хуарангаас гэдэг чинь эндүүрэл биш биз?

- Би ч гэсэн тэгж бодож байна. Тэгэхдээ тэр хуаранд цэргийн холбооны хэрэгслэл байхгүй гэдгийг нэвтрүүлэг дамжуулсан хүн сайн мэддэг нь илэрхий байна.

- Хато сан, хоёулаа наад нэвтрүүлэгчийн талаар хамтран ажиллавал зүгээр юм биш үү? Нөгөө талаар Сафроновын талаарх асуудлыг танайх зогсоогоод харин манайд шилжүүлчих. Би түүнийг чинь Халх голд аваачаад туршаад үзье. Харин манай ахмадыг Синьзин руу явуулчихаарай.

- Тозияа сан, ахмад Аяанаосу миний өрөөнд байна. Та ярих уу?

- За тэгье. Утсаа өгчих гэхэд Хато утсаа Аяанаосуд шилжүүлээд «Тозияатай ярь» гэх нь чагнуурт тод сонсогдов.

- Та и, хоригдлуудаас хичнээн хүн бэлдсэн бэ?

- Монгол хэл бичиг овоо мэддэг хорин хүн бэлдсэн. Тэд үсэг өрөх сургууль хийж байгаа. Харин халхаар цэвэрхэн ярина гэдэг чинь санашгүй хэрэг байна. Тэднийг Халх аялгуугаар ярьж сургана гэвэл гурван жил ч багадах байх.

- Та и, чи өнөө маргаашийн галт тэргээр наашаа гар!

Энд чиний хэрэг гараад байна гэхэд Аяанаосу даргынхаа тушаалыг хүлээн авлаа. Аяанаосу генералын өрөөнөөс гараад Синьзин руу явах галт тэрэгний пиу авахаар шийдэж галт тэрэгний буудал руу явав.

...Тозияа яагаад Сафроновын талаар Хатогоос сураглав аа? Түүнийг хил дээр ажиллуулах

нэрийдлээр дахин шалгах нь уу? Тозияя, ухуулах хуудас бэлдэхийн тулд тусгай хүмүүс бэлдүүлсэн. Тэгвэл Сафроновыг хянагчаар ажиллуулаад уу?

Аяанаосу, сэтгэлийнхээ хийсвэрлэлийг бодит байдалтай тулган эргэцүүлж үзвэл Сафронов эвгүй «хавханд» орох нь илэрхий байлаа. Тиймээс Аяанаосу энэ бүхнийг Сафроновт урьдчилан дуулгах нь дээр гэж үзээд галт тэрэгний пиу аваад дүрвэгсдийн товчоон дээр очиж Сафроновтой уулзахыг эрхэмлэв.

- Аяанаосу сан, чи миний өрөөнд орж бай! Намайг Разаевский дуудаад байна. Би оччихоод ирье гэж өрөөнөөсөө гарч ирсэн Сафронов, туслахынхаа өрөөнд уулзсан Аяанаосуд хэлээд өрөөнөөс гарлаа. Аяанаосу туслахтай нь энэ тэрхнийг ярьж суухдаа «Хато, Сафроновын талаар Разаевскийтэй ярьж дээ. Ингэхээр Сафронов, квантуны армийн штабын мэдэлд очно» гэж бодож байтал Сафронов гаднаас орж ирлээ. Түүний царай түрүүчийнхээсээ бүрсгэр болжээ.

- Сафронов, ажил чинь аль зэрэг байна вэ?

- Яахав. Санасныг бодвол овоо явж байна. Танай Симото, дарга нарын даалгавраар намайг гоочлоод байдаг бололтой. Благовешенскт байдаг миний гурван хүнийг туршсаны адилаар арваад хоногийн өмнө Хабаровскт байгаа хүмүүсийг туршжээ.

- Тэгээд илүү дутуу юм олоо юу?

- Үгүй. Эд нар ийм ухаан гаргаж байхад цаадуул нь арай давуу арга сийлэх байлгүй,

- Сафронов минь би өнөө орой Синьзин руу явна. Тэнд удаж магадгүй бололтой.

- Танай өвгөн сонин хүн дээ. Юм бүхнийг нууцлах санаатай. Тэгсэн мөртлөө өөрөө түүнийг илчлээд явна. Тэр чинь хүнд ямар үүрэг өгөх гэж байгаагаа урьдчилж хэлдэггүй. Гэхдээ шууд цагийг нь тулгаад ингэ тэг гэж зааварлана. Энэ чинь хүнийг эвгүй байдалд оруулдаг боловч Тозияагийн занг мэддэг хүн бол үүнээс сэжиг аваад бүх юмаа зохицуулчихна. Гэсэн ч танай өвгөн энэ алдаагаа мэддэггүй, өөр хүнийг хардах санаатай. Өөрөөр хэлбэл нууцаа өөрөө алдаж байна гэж бодолгүй гэмгүй хүмүүсийг хардах дон шүглэжээ.

- За тэгвэл чи, Тозияаг сайн мэддэг юм байна. Чамайг өөр ажилд тавьж магадгүй. Гэхдээ түүгээр далимдуулж, туршина гэдгийг мартаж болохгүй. Үүнийг чамд хэлэх гэсэн юм гэхэд Сафронов,

- Шинэ ажлын талаар сая Разаевский надад дуулгалаа гэлээ.

Аяанаосу Синьзинд ирээд долоо хонолоо. Тозияа тагнуулын хэлтсийн гурван орчуулагч, Тогава нарыг өөрийнхөө өрөөнд суулгажээ. Тогава, монголын хилийн харуул, нутгийн гүнд хаях ухуулах хуудсын эхийг зохионо. Түүнийг орчуулагч нар орчуулж, Аяанаосу хянасны дараа Тозияа уншаад хэвлэх зөвшөөрөл олгож, гарын үсэг зурна. Тозияа өөрийнхөө дэргэд ажиллуулж байгаа хүмүүсийн харьцааг сайн мэдэх тул Тогава, Аяанаосу хоёрыг нүүр нүүрээр нь уулзуулсангүй. Аяанаосуг тагнуулын хэлтсийн даргын өрөөнд суулгажээ. Ингээд хэд

хоносны дараа Тозияа Аяанаосуг уудаж,

- Харбинаас Жанжин сүмд хэвлэлийн мэргэжилтэй хүмүүс очсон. Тэнд хэвлэж байгаа зүйлийг Сафронов хянаж байх болно. Чи ухуулах хуудсыг тараах хүмүүстэй ажиллана. Гэхдээ Сафроновын хянасан зүйлийг давхар үзэж байх хэрэгтэй. Чиний шавь нарыг тагнуулын хэлтсийн мэдэлд өгсөн. Тэдний гүйцэтгэх ажлыг газар дээр нь шийднэ гээд ажлын удирдамж өгөв.

Тозияа, ингэж ажил төрлөө Аяанаосутай тохирсны дараа тагнуулын хэлтсийн даргыг дуудлаа.

- Аяанаосугийн шавь нараас хорин хүн танайд өгнө. Тэднийг Ханширээ, Халуун Рашаан, Ирэси, Баргын нутгаар ажиллуулах болно. Тэд Халх голыг эзэлсний дараа манжуураас монгол руу нүүлгэн шилжүүлэх хятадуудтай ажиллах болно. Нөгөө талаар Сафронов Жанжин сүм дээр ажиллах тул Хатогийн газраас ирсэн материалын дагуу хянаж, түүний ажиллагааг шалгах хэрэгтэй. Гэхдээ Сафроновыг барих, хийж байгаа ажилд нь саад болох ямар нэг хандлага гаргаж болохгүй. Ердөө түүний бүх үйл ажиллагааг мэдээгүй юм шиг байх нь чухал. Миний зөвшөөрөлгүйгээр Сафроновтой танай ажилтангууд уулзаж болохгүй гэж чандлан тушаалаа.

Тозияа, чингэж ажил төрлөө хуваарилаад гэртээ ирэхдээ Ойдовтой ярих яриагаа бодно. Тэрээр Харбинаас өчигдөр иржээ. Чингээд Тозияа, Ойдовтой хамт оройн хоол зооглов.

- Ойдов оо, Харбиныхан манай армийн ажиллагаанд ямаршуухан хандаж байна даа гэж асуухад Ойдов,

- Овоо сайн амтай байна. Харин Оросын дүрвэгсдийн товчоо өнөө фашист холбооныхон жаахан тааруухан юм уу даа. Тэд квантуны армид эрхлээд сурчихсан болохоор тэдэнтэй барьцаж атаархсан хүмүүс, цагаан гахай гэдэг юм. Ялангуяа Сунгар өртөөнд тусгай сургууль хийж байгаа цагаантнуудыг нутгийнхан их зүхдэг. Тэд чинь согтохоороо тэндхийнхээ ойр хавийг сүйтгэж, түйвээдэг юм байх.

- Тэд удахгүй Харбинаас монгол руу явна. Тэгэхдээ амьд буцаж ирэхгүй «золионы» хүмүүс! Тэгэхээр дүрсгүйтэж байг! Одоо чинь улааны гал голомтыг сэгсрэх цаг ойртоод байна шүү. Гитлер европын орнуудыг дайны тогоонд хийгээд чанаж эхэлмэгц английн ерөнхий сайд Невиль Чемберлен Мюнхений гэрээнд гарын үсэг зурж, германууд Чехословакийг авчихсаны дараа Рузвельт, Гитлерийг долигонохдоо «маргаантай асуудлаа найрамдлын» замаар шийдэх санал тавиад байна. Энэ чинь «хятадуудын илбэн тохинуулах аргыг» америк маягаар боловсруулсан шинэ хувилбар шүү дээ. Харин Гитлер бол манай армийг царайчилж, улаан оросын эсрэг хамтран хөдлөх болзол тавиад байгаа. Тэгэхдээ өрнөдийн орнуудын эсрэг биднийг турхирах санаатай. Бид өрнөдийн орнуудын эсрэг хөдлөхгүй. Ганцхан улаан оросын эсрэг бол хамтарч болох юм. Тиймээс манай арми монголын асуудлыг шийдэж өргөн фронт нээх боломжтой болоод байна. Тэгэхээр богдын албан ёсны төлөөлөгчийн хувиар та, Юкитэй ярилцаж алтны асуудлыг шийдэх ёстой. Одоо бүх юм хаяанд тулчихаад байна шүү дээ гэж ятгалаа.

- Би энэ талаар Юкитэй ярьж үзсэн. Тэр чинь миний сайн муу үгийг сонсолгүй өнгөрсөн.

Харин саяхан нэг удаа ярьтал Халх голоос Улаанбаатар хүртэл нэлээн зай бий. Гэтэл Наран улсын арми, Тамсагаас цааш гарах уу? гэдэг асуудал шийдэгдээгүй байна. Богд хааны гэрээслэл бол Монголын хаант төрийг сэргээхэд чиглэсэн шүү. Түүнээс алгын чинээ газарт алтаа зориулаагүй юм гэж байна. Юмны эзэн сумны занги Юки болохоор би яах вэ? Гэхдээ дахиж ярина. Харин Халх голын ажиллагаатай холбож яривал зүгээр байх гээд Тозияа хундаганд сакэ дүүргээд яриагаа үргэлжлүүлэв.

- Хайлараас монгол руу чиглэсэн төмөр замыг Токиогийн томоохон пүүснүүд сонирхоод байна. Тэд монголын шорооны ширхэг бүрийг алт болгож чадах хүмүүс юм. Харин арми пүүснүүдийн хүсэлтийг харгалзаад Юкийг дэмжих нь зүйтэй гэж үзсэн юм. Учир нь Буйр нуур, Халх голыг үндэсний баячуул эзэмшиж, тэнд төмөр зам тавиулах юм бол манай армийн нэр хүндэд сайнаар нөлөөлж, монголд хаант төрийг сэргээн тогтоох явдалд манай арми их үүрэгтэй гэдэгт монголчууд итгэнэ. Тэгэхээр Хайлар, Ханширээгийн төмөр замыг байгуулах ажилд Юки оролцох нь ашигтай гэлээ.

Ойдов Тозияатай чингэж ярилцахдаа түүний ярианы өнгөнөөс Буйр нуур, Халх гол руу чиглэсэн армийн тээврийн зориулалтай төмөр замыг тавих явдалд Юкийг оролцуулах нэг шаардлага бол армийн ажиллагааг нууцлах гэсэн хэрэг гэдгийг ойлгов. Чингээд өөрийнхөө саналыг «Рожусайд» илтгэлээ. Рожусай энэ бүхнийг армийн ажиллагаа бодит байдал, мэдээ баримтын зөрөөтэй талыг тулган дүгнээд «Рожуганука» ажиллагааны хоёр дахь ажиллагааг зогсоохоор шийдэж саналаа төвд илгээв. Чингэтэл хориод хоноод төвийн буухиа элч, Харбинд ирж, Ойдовтой уулзав.

- Төвөөс Хайлар, Буйр нуур болон монголын хил рүү чиглэсэн төмөр замын ажиллагааг унагах асуудлыг чухалчлах хэрэгтэй гэсэн. Рожуганукай ажиллагааны хоёр дахь ажиллагаа буюу Богдын алтыг буцаах асуудлыг зогсоохгүй бөгөөд Халх голын ажиллагааны явцад үүргээ гүйцэтгэхийг төв «Рожусайн» бүлэгт даалгасан гэлээ. Төвийн буухиаэлч, Ойдовтой ингэж ажил төрлийн талаар ярилцахдаа Шанхайд байгаа алтыг авчрах талаар төвийн удирдамжийг тайлбарлаад «Буцах хаяг-1», «Буцах хаяг-11» гэж товлосон удирдамжийг хэрэглэх боломжийн талаар зөвлөв.

Ойдов эдүгээ дөчин нэгэн настай. Уг гарлаараа Сэцэн хан аймгийн Жонон вангийн хошууны хүн. Долоон настайдаа Бэрээвэн номон ханы хийд дээр шавилан суужээ. Тэгээд арван зургаан насандаа Богдын ордонд ирж Цагаан дарь эх буюу Богдын хатны дэргэд толгой хоргоджээ. Ойдовын эх Жонон вантай нууц сүлбээтэй байсан болохоор Бэрээвэн хийдийн майдраар танилцсан Дондогдуламыг Жонон вангийн аягачин болгожээ. Түүнээс хойш хэдэн жил болоод Жонон ван Амарбаясгалант хийд дээр заларч их өргөл хуруулахдаа Дондогдуламыг бараа болгон авч явжээ. Ингээд Дондогдулам Жонон вангийн ивээлээр Богдод таалагджээ. Чингээд нэгэн шөнө Ойдовын ээж Дондогдуламыг Богдтой танилцуулан Түнлха сүмд оруулан өгч, Богдын сэтгэлд таалуулснаар Дондогдулам гэгээнтний нууц амраг болжээ. Богдыг монголын хаан эзний ширээнд залсны дараа Дондогдуламыг Дарь эх хэмээн алдаршуулж хатан хаан болгожээ. Чингээд Дондогдулам, Ойдовын эхийг Жонон вангийн хошуунаас авчруулж дэргэдээ бараа болгосон болой. Гэтэл Ойдовын эх өвчин эмгэг архагжсанаас өөд болоход Дондогдулам Ойдовыг Богдын ордонд авчруулжээ. Харин хаантан Бадрахыг гадаадаас ирсний дараа Бадрах, Ойдов хоёрыг Хужирбулангийн орос дарга нарт

шавь болгоод төмөр утасны нууц ажилд сургасан ажээ. Хаантан гамингийн жил Бадрах, Ойдов хоёрыг гамингийн гарт өртөхөөс болгоомжлон Замын-Үүдийн утасны хороонд ажиллуулахаар нууцгайлан явуулсан юм. Тэгээд барон Унгернийг хүрээнд ирсний дараа тэр хоёрыг татаж авчээ. Харин Богдын дэргэдийн хүмүүс Ойдовыг гадуурхан түүнийг Цагаан дарь эхтэй уулзуулсангүй. Ойдов энэ бүхэнд бухимдаж нэгэн удаа Дайзийгийн хуучин гуанзанд очихдоо хэдэн залуустай нийлж архидаж байгаад Цэен гүнтэй санамсаргүй дайралдаж орох оронгүй болсноо хэлжээ. Цэен гүн, Ойдовыг нэгэн танил айлдаа суулгаад хожим Богдод бараалхахдаа учрыг хэлжээ. Чингээд Богд цагийн байдлыг ажиж түүнийг Бадрахтай уулзуулан хамт ажиллуулах болсон аж. Богдыг нас барсны дараа ялгуусан лам Дондогдуламд тал засаж ихээхэн хөрөнгө тасалж өгөх гэж зүтгээд бүтээгүй аж. Хатан хаантан хувьд оногдох хөрөнгөө аваад хүрээнээс гарахад ялгуусан лам хатны араас очиж толгой холбожээ. Үүнийг мэдсэн Бадрах Ойдов хоёр ламхай улаан голыг самнахаар нууц тохиролцоод Туулын гүний хүрээ рүү явах гэж байтал нэгэн өдөр Хатанбаатар вантан, Бадрахыг дуудуулжээ. Бадрах, Хатанбаатартай уулзаад хоногийн дараа Ойдовтой уулзлаа. Тэгээд «буруу замаар будаа тээж» явсныгаа эргэцүүлэн хоёулаа амьдрал ахуйн талаар нэлээн ярилцав.

- Ойдовоо, би цэргийн яаманд ажиллахаар Хатанбаатарт ам тангараг өгсөн. Хатанбаатар вантан чамайг асууж сураглаад ирж уулз гэж хэлүүлсэн. Чи ер нь очиж уулзсан дээр! Чи бид хоёрыг улаан армийн харилцан нэвтрэлцэх хороо (Холбооны хороо) гэгчид ажиллуулах бололтой! Хоёулаа очье. Ер нь чи бид хоёр Богдын төлөө зүтгэж өдий хүрлээ. Одоо монгол ард түмнийхээ төлөө зүтгэх үүрэг үлдээд байна гэхэд Ойдов түүний үгийг дагаж Хатанбаатар сайдад бараалхжээ.

Тозияа, Ойдовтой уулзаж Юкигийн санааг урьдчилан мэдээд нэг орой Юкитэй уулзаж энэ тэрийг ярьж байтал,

- Ааваа, жанжин штаб Халх голын ажиллагааны төлөвлөгөөг батлаа юу? Уэда сан надад тийм үг цухуйлгаж байна билээ гэлээ.

- Тэр тухай шийдчихсэн байна. Комацубарагийн 23 дугаар дивиз гол үүрэг гүйцэтгэх ёстой болж байх шиг байна. Доихарагийн армиас мотобуудлагын бригад шилжиж ирэх сурагтай. Чи дараагийн долоо хоног гэхэд голыг нь бүрэн мэдэх байхаа. Би Хайлар, Хайлааст руу явж магадгүй. Харин чи өөрийнхөө ажлыг юу болгож байна даа?

- Би ч шийдсэн. Харбин руу Ойдовыг явуулж хөрөнгө нийлүүлэх талаар ярилцана. Харин миний бодлоор бол Ханширээгээс Жанжин сүм, тэндээс Халхын гол, Баянцагаан руу тавих замын талаар судалгаа хийлгэе гэж бодож байна гэхэд Тозияа хөлд орж байгаа хүүхэд шиг баярлажээ.

- Тэгвэл чи зургийнхаа захиалгыг эртхэн өг! Ер нь Уэда сантай уулзаж ярилцсан дээр. Би чамайг уулзуулж өгье гэхэд Юки,

- Тэгвэл хоёулаа маргааш Уэда сантай уулзах уу гэлээ.

- Тэгье. Маргааш чи нэг завандаа штаб дээр яваад оч. Би чамайг хүлээж байя.

Тозияа Юкийг Квантуны армийн удирдагчтай уулзахын өмнө Уэдатай уулзаж, ярих зүйлээ тохирчихоод хүлээж байтал Юки иржээ. Юкийг Уэдагийн өрөөнд орж ирэхэд тэрээр сайхан дөлгөөн зантай угтаж, Ханширээгийн төмөр замын талаар сайхан санаачилга гаргасан танд баяр талархлаа хүргэе. 1935 онд Ханширээгийн төмөр замыг ашиглалтанд оруулсны дараа энэ тухай ярилцаж, уул нүхлэх хонгилын талаар санал хуваагдаад асуудлыг шийдэж чадаагүй юм. Энэ талаар холбогдох зураг төсөл архивт байгаа. Түүнийг авч үзэж болно. Тэгэхдээ газар дээр нь очиж, мэргэжилтэнгүүдтэй ярилцах нь ашигтай шүү гэлээ.

- Эрхэм дээдсээ, миний саналыг дэмжсэн явдалд би ч гэсэн баяртай байна. Одоо би номоо дуусгах гэж шамдаж байгаа болохоор тэр бүр Ханширээ, Халуун Рашаан, Амгалан, Жанжин сүм, Ганжуур, Хайлараар яваад байж чадахгүй. Харин би өөрийн төлөөний хүн, Ойдовыг газар дээр очуулж танилцуулах талаар бодъё. Энэ тухайд танаас зөвшөөрөл авах ёстой биз дээ гэхэд Уэда, Тозияа руу сэм ажиглан хартал тэрээр нүдээ ирмэж дохио өгсөн тул Уэда,

- Бололгүй яахав. Би өөрийнхөө гарын үсэгтэй тусгай үнэмлэх олгоно гэж амлав.

Оросын фашист холбооны дарга Разаевский Сафроновыг дууджээ. Разаевский Сафроновыг квантуны армид ажиллуулах тухай өөрт нь хэлсэн боловч асуудлыг хойшлуулсаар байжээ. Гэтэл өнөөдөр дээрээс шийд авчээ.

Сафронов, Разаевскийн өрөөнд орон ортлоо «Симото, намайг шалгах гэж улайраад байнаа даа» гэж бодлоо. Сафроновыг орж ирэхэд Разаевский бүрсгэр царайгаар угтсан тул олигтой юм дуулахгүй гэдэг нь илт байлаа. Разаевский хоёр хөлөө алцайн зогсож, нуруугаа ардаа үүрснийг ажваас Герингийн зан, төрхийг санагдуулна. Тэрээр оросын дурвэгсдийн фашист холбоог толгойлж байгаа болохоор зан аашаараа Гитлерийг хэдийн дуурайх дуртай.

- Иван Степанович минь, Аяанаосу монголын хил дээрээс сая ирсэн гэнэ. Тэгээд тантай уулзах юм байх. Уэда таныг өөрийнхөө штабт авч ажиллуулах талаар маш дээгүүр ярьсан байна гэхэд Сафронов «Би учрыг ойлгож байна» гэж хэлэх гэснээ болиод хоолой дээрээ гараад ирсэн үгээ арай ядан тогтоов.

- Таныг очуулахгүй бол эд чинь санхүүгийн талаар биднийг боож хаах гээд байна. Таны ажил амьдрал ахуйн нөхцлийг дээд зэргээр хангана гэж Уэда өөрөө амлаж байна. Ингэхээр та тэднийд очсон дээр! Харин танаас нэг зүйлийг үүргийнхээ дагуу асуумаар байна. Та тэр Надежда Михайловнатай янаг амраг шиг байдаг гэнэ. Та суух гэж байгаа юмуу. Би таныг нэр алдраа бодоод тийм улааны сүгнүүдийн сүүдэртэй ойртохгүй гэж бодож байна. Гэтэл Хато үүнийг чинь дөвийлгөөд байна гэхэд

- Би түүний намтар түүхийг сая л мэдлээ шүү дээ гэж Сафронов учирлан тайлбарлав.

Сафронов, Разаевскийтэй уулзсаны дараа өөртөө төдийгүй Надежда Михайловнагийн амь насанд заналхийлсэн эгзэг гарсныг ойлгов. Чингээд хэрхэх тухайгаа хэдэнтээ бодоод зочид буудал руу очиж Аяанаосутай уулзахаар шийдлээ. Сафронов буудалд ирж Аяанаосутай уулзаж бүх болсон зүйлийг хэллээ.

- Бүгдийг янз янзаар бодож үзлээ. Би ч яахав өөрийнхөө амийг хоохойлох боломжтой. Намайг

Синьзин руу явсны дараа Надежда Симотогийн туршуулуудын гарт өртөх нь гарцаагүй. Энэ бүхнийг Тозияа хийж байгаа юм. Намайг Юкигээс холдуулж бид хоёрыг эвдрэлцүүлэхийн тулд миний нэр хүндийг муутгах, Юкийд муугаар ойлгуулахын тулд ингэж байна. Гэхдээ надад нэг боломж бий. Түүнийг зохион байгуулж чадвал Надежда Михайловнагийн амийг аварч болно гээд өөрийнхөө бодсоныг нэгд нэгэнгүй ярьж тайлбарлав.

- Благовешенск руу явуулсан миний гурван туршуул амьдралын утга учрыг ойлгосон тул тэнд очингуугаа өөрсдийгөө илчилсэн байсан. Тиймээс Зөвлөлтийн зохих байгууллага Харбинтай тэдний холбоог таслахгүйн тулд зарим мэдээгээр хангадаг байлаа. Тиймээс Симотогийн туршуулууд тэднийг хуучнаараа хэвийн ажиллаж байна гэдгийг батлах зарим баримтыг Зөвлөлтийн байгууллагын даалгавраар өгч явуулсан байсан. Ингэснээрээ намайг Симотогийн хавханд орох аюулаас аварсан юм.

- Сафронов аа, чиний тухай Зөвлөлтийн байгууллагууд мэдэж байгаа юу? Тийм бол одоо Зөвлөлтийн талтай холбоо барих хэрэгтэй шүү.

- Намайг Зөвлөлтийн талаас зөв ойлгосон байна билээ. Гэхдээ хүн өөрийн нэг тодорхой зорилготой байх ёстой. Түүндээ хүрэхийн тулд заавал өөрийн биеэр гүйцэтгэх үүрэгтэй байх хэрэгтэй. Би тэр үүргээ гүйцэтгээгүй байна. Харин Надёжда Михайловна бол тэр үүргээ гүйцэтгэсэн учраас Зөвлөлтөд очих нүүртэй. Түүний байгуулсан гавьяаг тодорхойлох шударга хүн ч бий. Надежда

Михайловнаг аврах нэг боломжийн хувьд гэвэл дүрвэгсдийн товчооноос явуулсан нэг туршуул Хабаровскт баригдаад байгаа. Түүнийг ашиглаж чадвал Надежда Михайловнагийн асуудлыг шийдэж чадна.

Аяанаосу, Тозияагийн өгсөн даалгаврын дагуу Сафроновыг Синьзин руу явуулаад өөрөө Харбинд үлдлээ. Тэгээд Тозияад өөрийнхөө боловсруулсан төлөвлөгөөг танилцуулав.

- Эрхэм дээдсээ, Сафроновын нэг шавь болох Сиймхий хочтой туршуул Зөвлөлтийн талд урвасан байсныг мэдэх хүн хилийн контрбандын хэргээр сая шийтгэгдсэн байна. Тэр Сафроновын сайн шавиудын нэгийг өөрийнхөө сайн дураар урвасан төдийгүй тэгж урвахыг Сафронов зааж өгсөн гэж байсныг сонсож иржээ.

Наадах чинь надад хэрэгтэй юм байна. Чи үүнийг баримтаар нотолж чадах уу? Тэгвэл сайн хэрэг шүү!

- Үгүй. Баримтаар тогтоох нь жаахан ярвигтай юм шиг байна.

- Түвэгшээх хэрэггүй. Тэр урвасан туршуул Сафроновоос ямар даалгавар заавар авч улаан оросын талд орсныг тогтоох хэрэгтэй. Үүнийг 15 хоногийн дотор багтаж тогтоохыг бод! Би чиний ажиллагаатай холбогдсон удирдамжийг Хатоод өгч, онцгой эрхээр хангахыг даалгана гэлээ.

Аяанаосу, шөнөжингөө өөрийнхөө гаргасан төлөвлөгөөг бодож, тунгаагаад маргааш нь Тозияатай ярилцав. Тозияа, Аяанаосугийн боловсруулсан ажиллагааг дэмжиж,

- Би наад ажиллагааг чинь зөвшөөрнө. Харин тэр хоригдлын өчгийг сайн тунгаах хэрэгтэй! Ялангуяа орос руу явуулах хоёр хүнийхээ талаар оросын товчоо болон Хатогийнхонд мэдэгдэж болохгүй. Тэгвэл тэд чинь чиний ажилд саад болж мэднэ. Чиний ярьсан наад гурван хувилбар арганаас тэр хоригдлоо эмэгтэй хүнтэй хамт явуулна гэдэг чинь зүйтэй ажил хэрэгч хувилбар байна.

- Би ч гэсэн үүнийг дээр гэж бодож байна. Ер нь эмэгтэй хүн архиар дайлж сээтэгнээд байвал олон сар эмэгтэй хүний бараа хараагүй хоригдол хүүхний өврөөс зугтааж чадахгүй нь мэдээж. Нөгөө талаар тэр хоригдол мөнгө, архи хоёрт толгойгоо ч өгч мэдэх орос байгаа юм.

- Аяанаосу чи, цагдаагийнхантай уулзаж орон нутгийн үнэмлэх бичгээр тэднийгээ хангаарай. Би одоо цагдаагийн газар руу ярьж онцгой удирдамж өгье гээд багш шавийн яриа завсарлав. Аяанаосу тэр дороо Мураяаматай утсаар яриад,

- Хулгайн хэргээр хил давж шийтгэгдсэн өнөө оросыг би авна гэхэд,

- Урт хошуутыг уу? Сиймхийг үү? гэж лавлав.

- Сиймхийг гэхэд Мураяама тэр дороо Сиймхийг дуудуулахаар амлав.

- Ахмадаа, Сиймхий улс төрийн хоригдлуудын дунд тун сайн ажилладаг юм. Түүний тусламжтайгаар бид хоригдлуудын дундаас улааны үзэлтэй хүмүүсийг олж эрдэм шинжилгээний газрын дөрөвдүгээр хэлтэс рүү явуулдаг юм. Тэднийг тэнд туршдаг шүү дээ. Би дахиад Сиймхий шиг хүн бэлдэнэ гэдэг чинь тун их хөдөлмөр зарцуулна гэсэн үг. Ер нь өөр хүн авахгүй юу гэж гуйлаа.

- Та нар аль зэрэг сайн хүн бэлдсэнийг шалгаж үзэж байж болно. Сорилтын дараа та дахиж яриарай гэхэд Мураяама арга буюу зөвшөөрлөө. Аяанаосу, энэ хоригдлын талаар анх Будаас дуулжээ. Сиймхийг Мураяама, Аяанаосуд өгсөн нэрийн жагсаалтанд оруулаагүй байлаа. Хянган дахь улс төрийн хоригдлуудын дотроос Харбинд байсан большевикуудтай шууд холбоотой удирдах ажил хийж байсан хүмүүс баригддаг болсныг гадарлаад Хар чоныг тохоож, түүнийг устгахаар төлөвлөсөн хувьсгалч үзэлтэй хүмүүс Хар чоныг устгахын даваан дээр хамаг учрыг мэджээ. Тэгээд Сиймхийг устгах гэж байтал түүнийг Харбины шоронд шилжүүлсэн аж. Хар чоно, Аяанаосутай уулзаад «Би хов зөөдөг хүн биш! Тийм хүн олох гэвэл Сиймхий гэж хочтой нэг дориун эр бий» гэж билээ. Энэ нь Хар чоно, Сиймхийг Аяанаосугаар устгуулах гэсэн эгзэг байлаа. Сиймхий, хоригдлуудын дунд ярьдаг дэл сул ярианаас авахуулаад хувьсгалчдын нарийн ширийн зүйлийг хүртэл сиймхийг нь олоод мэдчихдэг учраас тэгж нэрлэсэн болой. Аяанаосу, Сафроновтой тохиролцсон ёсоор Сиймхийг Харбины хувьсгалт нууц байгууллагын зохих хүмүүст шилжүүлэх ёстой тул Сафроновын өгсөн хаягаар нэгэн хөгшнийд очиж уулзав. Тэгээд Сиймхийг тэдэнд авчирч өгөх өдрөө тогтлоо. Ингээд Сиймхийг тушаасны маргааш Аяанаосу галт тэрэгний буудал дээр очлоо. Аяанаосуг галт тэрэгний буудал дээр ирснээс хойш арваад мөч болоод Надежда Михайловна нэгэн орос хүний хамт ирээд галт тэрэгний тавцан дээр зогсож байгаа вагон руу явж байгааг олж харлаа. Түүнийг дагаж яваа хүнийг большевик Крутов гэдэг боловч эдүгээ Корпухин гэдэг нэрээр яваа ажээ. Надежда Михайловна түүний гэр бүлийн хүн гэдэг үнэмлэхтэй. Крутов бол 1917 оны большевик бөгөөд Харбинд нууц ажил удирдаж байгаад

баригдаж шийтгүүлсэн юм. Харин сарын өмнө Хянганы шоронгоос оргосон болой. Чингээд Сафроновын төлөөний хүн, Аяанаосуд учир байдлыг цухуйлгаж Надежда Михайловнагийн хамт Зөвлөлт рүү явуулахаар тохирчээ. Надежда вагон руу орж явахдаа Аяанаосугийн барааг олж харсан бөгөөд вагонд орсон хойноо цонхны дэргэд суугаад Аяанаосу руу харж байлаа. Чингээд удаж төдөлгүй галт тэрэг хөдлөв. Тэр хоёр, төмөр замын Манжуур өртөөгөөр дамжин хил гарах бөгөөд Даур орох хувийн хэргээр яваа нутгийн худалдаачид гэсэн үнэмлэхтэй боловч тэрхүү үнэмлэх бичиг, квантуны цэргийн хээрийн цагдаагийн ерөнхий газрын тусгай тэмдэгтэй аж. Тийм үнэмлэхтэй хүмүүсийг сэрдэж хардсан ч гэсэн тэднийг баривчлах, юмыг нь нэгжих, ямар нэг аргаар саатуулах эрх, орон нутгийн цагдаагийн газар, японы тагнуулын нууц албаныханд байхгүй.

Надежда Михайловна, Крутов хоёрыг яваад арав хоносны дараа нэгэн орой Аяанаосу, төмөр замын ажилчдын хэсэгт суудаг Сафроновын төлөөний хүнийд очлоо.

- Хилийн цаанаас хүн ирсэн. Надя тэр хоёрыг хилийнхэн сэжиглэсэн боловч үнэмлэхийг нь үзээд явуулсан байна. Энэ тухайд танд яаралтай мэдэгд гэсэн. Гэвч би тантай уулзаж чадахгүй болохоор ирэхийг чинь хүлээж байв гээд гутлынхаа өсгийг сугалан гаргаж нэгэн бичиг авч өглөө. Аяанаосу тэр бичгийг анхааралтай уншаад маргааш өглөө нь цагдаагийн газрынхаас хилийн Манжуур өртөөнөөс ямар нэг чимээ ирсэн эсэхийг лавлан асуулаа. Гэвч хилийнхнээс ямар ч мэдээ байсангүй. Тэгээд Аяанаосу Манжуур өртөөнд байдаг цэргийн тагнуулынхантай утсаар ярьж лавлахад онцгой зүйл мэдэгдсэнгүй. Харин тэд Аяанаосуд «Тусгай үнэмлэхтэй хоёр хүн оросын хил рүү орсноос хойш оросын талаас ямар нэг асуудал тавиагүй» гэж мэдэгдлээ. Энэ бүхэн Аяанаосуд сэжигтэй санагдсан тул тэрээр Харбины кэмпэйтэйн тусгай хэргийн төлөөлөгчтэй ярьж асуухад Манжуур өртөөнөөс ямар нэг сэжиг бүхий асуудалтай холбогдсон мэдээ ирээгүй гэж хэлэв. Чингээд Аяанаосу Синьзин руу залгуулж Тозияатай ярихдаа,

- Сиймхий хочит орос хүүхний хамт Манжуур өртөөгөөр хил давсан бөгөөд очих ёстой газраа хүрсэн байна гэж илтгэв.

- Аяанаосу, чиний нууцыг Хато мэдсэн байна. Корнухин гэдэг нэрээр хил гарсан Сиймхийг сэжиглээд тусгай үнэмлэхтэй болохоор явуулжээ. Хато надаас, асуухаар нь би зөвшөөрсөн юм гэж хэлсэн шүү гэхэд хилийн тагнуулынхан болон кэмпэйтэйн тусгай хэргийн төлөвлөгч нар энэ тухай зөвхөн Дээд удирдлагад мэдэгддэг дүрэмтэй болохоор Аяанаосуд илтгээгүй болохыг төвөггүй ойлголоо.

Тозияа Аяанаосутай ярихдаа явсан хүмүүсийн ирэх хугацааг асуугаад,

- Аяанаосу, чи наад ажлаа Хатоод танилцуулаад өөрийнхөө оронд ажиллах хүнд бүх зүйлийг тайлбарлаж өгөөд Жанжин сүм рүү оч! Харин хүмүүсийн буцаж ирэх газрын талаар хэлэхдээ Манжуур өртөөгөөр буцаж ирэх ёстой гээд аргалчихаарай. Тэд тэр чигээрээ чулуу хөөж байг гэхэд Аяанаосу сэтгэлдээ «Хөгшин тэднийг Хабаровскийн чиглэлээр буцаж ирнэ гэж танилцуулсан миний үгэнд итгэжээ. Ёстой хөгшин маань чулуу хөөгөөд үлдлээ дээ» гэж бодоод дотроо баярлажээ. Аяанаосугийн төлөвлөсөн ёсоор бол Надежда Михайловна, Даураас Хабаровскт ирэхдээ Аяанаосугийн зааварласнаар хил дээр байгаа японы тагнуулын төлөөлөгчийн гарт тусгай шугамаар хуурамч мэдээ атгуулах ёстой. Тэр мэдээнд Корпухин

гэдэг нэрээр тусгай үүрэг гүйцэтгээд буцсан сиймхий хэмээх хочит туршуул оросын хилээр гарахдаа сэжиглэгдээд хилийнхэнтэй буудалцсан төдийгүй өөрөө хүндээр шархдаад баригдсан байна гэх ёстой.

Аяанаосу Тозияатай чингэж ярилцаад төмөр замын холбооны түр сургууль руу очоод Ойдовтой уулзаж Жанжин сүм явах болсон тухайгаа мэдэгдэв.

- Ойдов оо, одоо чи надтай уулзах гэвэл Хайларт очих болох нь. Гэвч Рожусайгаас хэрхэн холбоо барих тухай заавар авна биз гэхэд Ойдов,

- Гол нь Хайларт очиж уулзаж байя. Надад тийм боломж бий. Манай эзэгтэй, Уэдагийн гарын үсэгтэй үнэмлэх авч өгсөн. Би Ханширээ, Жанжин сүм, Халх голын чиглэлд очиж төмөр зам тавих хэсгийнхэнтэй судалгаа хийх юм гэнэ билээ. Харин өчигдөр төвгэй холбоо барьсан. Халх голоор японы арми довтлохоор төлөвлөсөн төлөвлөгөө, эхлэх хугацаа, цохилтын гол чиглэлийг богино хугацаанд мэдэх хэрэгтэй гэсэн. Рожусайд танилцуулахад «Рожуганукай» ажиллагаанд эхний ээлжийг хэрэгжүүлэх ёстой гэж мэдэгд гэсэн.

- Юки сан чамд маш чухал үнэмлэх олж өгсөн байна. Тиймээс үүнийг ашиглах болно. Барилдааны төлөвлөгөөг олох нэг боломж бол Тозияа, Уэда хоёр төдийгүй штабын нөлөө бүхий хүмүүсийг хянах явдал. Нөгөө нэг зам бол Хайларт байгаа фронтын штаб юм. Миний саналыг Рожусайд танилцуулж өгсөн удирдамжийг надад мэдэгдээрэй. Би ямар ч гэсэн Сафроновтой нийлж ярилцаад ямар боломж байгааг дараагийн уулзалтанд хэлнэ.

Аяанаосу, Ойдовтой чингэж тохиролцоод найман цагийн дараа Харбинаас Хайлар руу хөдөлжээ.

Акасай Шанхай руу яваад хэд хонолоо. Тозияа энэ хугацаанд Хар чонотой холбогдсон зүйлийг кэмпэйтэй болон цэргийн тагнуулын газраас цуглуулаад зогссонгүй бас Чан Кайшигийн тагнуулын газраас зарим баримтыг авахуулсны дараа мэл гайхжээ. Ёгочин, дээрэмчин, сайн жиүдиүцүчин өөрийнхөө амийг аврахын тул хэдэн жил шоронд байсан нь гайхалтай. Тэрээр дээрэмчдийг шоронгоос удирдаж, умард хятад, манжуур, өвөр монголыг түйвээж байсан бол Тозияа гайхахгүй байсан. Тозияа, Хар чоныг дуудуулчихсан болохоор түүнтэй ярих зүйлээ бодно. Чингэж яриагаа хэрхэн эхлэхийг бодож суутал Хар чоныг авчирлаа.

- Ажил хэргийн байдлаас болоод чиний нэрийг өөрчлөх хэрэгтэй боллоо. Чи зөвшөөрнө биз дээ гэхэд Хар чоно толгой дохино. Тозияа, Хар чонын царай өөд эгцлэн харж хөмсөг зангидан ууртай юм шиг дүр гаргаж зогсохдоо «Яасан хэнэггүй эр вэ? Аяанаосу үүнийг хэнэггүй байрын шинжтэй, гүжирмэг зантай, сэтгэлийн тэвчээр сайтай, итгэсэн зүйлдээ үнэн зүтгэлтэй хүн гэсэн. Харин муу зангийн талаар тодорхойлохдоо зөрүүд, гэжимтгий, бардам бөгөөд тун хянуур, хүний янз үзэх дуртай, алдаа эндэгдлээ нүүр царайндаа илчилдэггүй, хүний үгний өөгөөр санааг нь багцаалж тоглоом тохуу хийх дуртай гэсэн шүү» гэж бодно.

Хар чоныг сорьсон шалгалтын үр дүн Тозияагийн сэтгэлийн далдад хуримталсан бодлыг зөөллөж чадаагүй. Харин Аяанаосугийн тодорхойлолтонд «Англи, хятад хүнийг нэг нүдээрээ

харахгүй үзэн яддаг бөгөөд яриандаа үргэлж зүхэж, харааж байдаг» гэсэн нь Тозияд итгэл төрүүлэх сэжим болжээ.

- Миний бодлоор бол чи өөртөө нэр өгөх хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхдээ сайхан нэр бодож олох хэрэгтэй!

- Миний жинхэнэ нэрийг Буд гэдэг. Тэгэхээр эцэг эхээсээ өгсөн нэрээр нэрлэсэн дээр байх.

- Чиний жинхэнэ нэрийг Англи, Хятадынхан сайн мэднэ. Тэгэхээр хар чоно амьд байна гээд бөөн шуугиан дэгдээнэ. Чамайг амьд байгааг мэдвэл тэд чинь юу ч хийж мэднэ. Тэгж шуугиан дэгдээх хэрэггүй. Хар чоныг шоронд үхсэн гэдэг нотолгоог бэлдчихсэн. Сонинд тусгай шугамаар нийтэлнэ. Харин чи чинь Хянганы шоронд байхдаа хэд хэдэн мухар толгойтонтой холбоотой байсан гэдэг байх аа гэж Тозия лавлах гэсэн зүйлээ аятайхан хавчуулж асуулаа.

- Шоронгийнхон өөрийгөө илчлэхгүйн тулд дээрэмчид, хулгайч нартай холбоотой хүмүүсээс холхон байя гэж бодоод өөрийгөө мухар толгойтны нэг гэдэг сэжиг төрүүлэх гэж тэгж байсан юм. Намайг Хар чоно гэж мэдвэл дээрэмчид, хулгайч нар намайг удирдагчаа болгож шоронгоос удирдуулах бүрэн боломжтой байсан. Шоронгийнхон ашиг хонжоогоо бодоод надад бүх бололцоо олгох байсан нь маргаангүй.

- Би бол тан шиг тийм арга хэрэглэхгүй. Шууд өөрийгөө илчлэх байсан. Тэгвэл шоронгийнхон чиний гар хөлийн үзүүрт үг дуугүй захирагдана шүү дээ.

- Ашиг хонжоонд шунасан хүн, хүнд нөхөр болдоггүй юм. Миний итгэлтэй хүмүүсийн дотор намайг барьж өгөхөөр дэнчин тавьсан хүмүүс байсан. Үүнээс болоод би дээрэмчдээ тараагаад хоёр яс хагацсан юм шүү гэхэд Тозия сэтгэлдээ «Энэ лүд ийм хашир эр үү? Ер нь чин үнэнээ ярьж байна уу? Ярианд нь сэжиг байхгүй боловч сэтгэлийн нь цаана ямар нэг юм нуугдаж байж мэдэх юм» гэж сурсан заншлаараа хардана. Ингэж бодох нь Тозияд аятайхан байдаг. Сэтгэлээ чингэж түгшээж, хэд дахин урвуулан хөрвүүлж бодвол алдаа гардаггүй. Тиймээс юмыг чингэж ухаж төнхөж, хардаж сэрдэж бодох нь Тозиягийн сүүлийн үеийн нэг онцлог ажээ.

- Би чиний бодлыг мэдэж байна гээд харцаа Хар чоно руу эгцэлснээ,

- Үнэхээр урвагч нар байсан бол тэднээс салдаг чинь түмэн зөв. Чингэхэд чамд Буд гэдэг нэр хэрэггүй. Харин Эрхэмбаяр гэвэл зүгээр, түгээмэл нэр шүү дээ гэж уруулаа мушилзуулан инээмсэглэв.

Тозия, Акасайд даалгавар өгөхдөө түүний ажиглах хүний нэрийг чингэж хэлсэн болохоор ингэж нэрлэх ёстой байсан.

- Чи хэд хоногоос далайн эрэг хавийн нэг хот руу явна. Тэнд очихдоо Токиогоос нутаг руугаа очиж яваа худалдаачин Эрхэмбаяр гэдэг нэрээр манай консулын газар бүртгүүлэх болно. Одоохондоо хотыг чинь шийдээгүй. Тэнд очоод эхний үед их гүрний худалдаачидтай танилц! Ялангуяа очсон газрынхаа америкийн худалдааны танхимын дээгүүр зиндааны хүмүүс,

банкны нөлөө бүхий хүмүүсийн найз нөхөд, үр хүүхэдтэй нь ойр дотно байх нь чухал! Таныг хөзрийн мөрийнд сайн гэдэг байхаа гэж хэлээд Тозия, Тяньжин дахь Чан Кайшигийн туршуулын мэдээнд «Хар чоно мөрий алддаггүй хэрсүү хүн» гэж тодорхойлсныг саналаа. Тозия, цонхоор гудамж харж зогссоноо Хар чонын дэргэд ирээд,

- Энэ өдрөөс эхэлж Эрхэмбаяр гэдэг нэрэндээ дасах хэрэгтэй. Томилсон газар очсоны дараа чиний гүйцэтгэх ажлын талаар тодорхой чиглэл өгнө. Харин сайн угсааны нохой олж авах гэдэг чинь зөв! Тэгэхээр ганцхан өөрийгөө хамгаалахад биш өөрийнхөө үүргийг гүйцэтгэхэд туслах нөхөр болгож сургах нь чухал. Нохойг хулгай хийлгэхэд сургаж болохгүй нь мэдээж юм. Тэгэхээр их гүрний тагнуулуудыг олж ашиглахад хэрэг болно. Ялангуяа бичиг баримтыг хулгайн замаар олохыг хичээдэг тагнуулуудыг олж болно шүү гэж зөвлөв.

- Миний сэтгэлд таалагдах нохой олдохгүй байна. Юу ч гэсэн зарлуулаад үздэг юм билүү. Тэгээд болохгүй бол та бүхний тусламжийг авна. Та нар тусална гэдэгт би итгэж байна шүү гээд халааснаасаа сонинд хэвлүүлэхээр бэлдсэн зарлалаа гаргаж үзүүлэв. Тозия түүнийг уншаад,

- Өөрөө мэд, сонинд зарлуулах эсэх нь таны дурын хэрэг гэлээ.

Синьзин хотод хэвлэдэг Манжуурын өдөр тутмын «Мансю нити нити» сонинд сайн үүлдрийн нохой худалдаж авах зарлал гарснаас хойш дөрөв хоноод байхад Аяанаосу Синьзинд ирлээ. Тэрээр Харбин дахь ажил хэргийн талаар Тозияд биечлэн танилцуулж, Жанжин сүмд ажиллах ажлын талаар ярих зүйл мундсангүй.

- Аяанаосу минь чи нөгөөдөр гэхэд Ханширээ рүү гарсан байх хэрэгтэй. Харин Хар чоныг би, өөр ажилд томилсон. Тэр одоохондоо бэлтгэл хийж байгаа. Чи тун чухал хүн олсон байна. Чи Хар чоныг явахаасаа өмнө уулзаж ажил үүргээ сайн гүйцэтгээрэй гэж хэлнэ биз! Анх таньж олсон хүн нь чи болохоор бас арай өөр хандаж, захисан үгийг чинь санаж явна биз! Миний бодлоор бол шинэ ажилдаа тийм ч дуртай биш шиг санагдаад байна. Гэсэн ч эчнээнийхээ бодол, хүсэл мөрөөдлийг нүүр царай, үг яриандаа илрүүлдэггүй, баяр баясал, атаа жөтөөгөө сэтгэлдээ барьж чаддаг хүн байна. Харин надад найдаж байгаа нэг зүйл бол Хар чоно чиний ятгалганд орсон явдал. Тиймээс чи уулзах нь чухал!

Аяанаосу квантуны армийн тагнуулын газрын тусгай сургуулийн бэлтгэлийн танхимд очлоо. Уужим танхимд цагаан кимоно өмсөж, толгойгоо хар бөсөөр боосон найман хүн каратэгийн бэлтгэл хийж байлаа. Эрхэмбаяр хэмээгдэх Буд алд хагас хэртэй өндөрт тэлж татсан утсан дээгүүр харайж, цаана нь байгаа хавтгай банзыг хөл гарынхаа цохилтоор зад цохих дасгал хийж байв. Ийм цохилтыг мавасигари гэдэг. Энэ нь угтаа мавари буранко буюу үсрэлттэй гишгэлт гэдэг үг, сигару хэмээх хамгаалалт гэсэн үгнээс үүссэн үсрэлтэндээ хамгаалж, цохих гэсэн утгатай ажээ. Эрхэмбаяр мавасигаригийн энгийн дасгал хийж байлаа.

Намхан нуруутай нэг залуугийн дараа Эрхэмбаяр гүйлтэн дундаа харайхдаа баруун хөлөө агийн зүүн хөлөө тийрэн жийх зуур баруун гарын зангидсан нударгаар дүүжлээстэй байгаа цунгийн банзыг цуу цохихдоо өлмийгөөрөө газардан буухад Аяанаосу түүний дэргэд очлоо. Тэгээд бэлтгэл удирдаж байгаа бага даргад Аяанаосу учир байдлыг хэлсний дараа,

- Эрхэмбаяр аа, хоёулаа танхимаас гаръя гэлээ. Уужим танхимд бэлтгэл хийж байгаа хүмүүсийн чих дөжрүүлсэн хашгиралтаас түвэгшээсэн Аяанаосу танхимаас гарлаа. Каратэгийн цохилтын хурд нь эзэн хүний дууны хурдаас хоцрох ёсгүй болохоор хүмүүс цохилт хийхийн өмнө байдаг чадлаараа чарлаж заншсан болохоор танхимд цуурайтсан дуу чимээнд энгийн хүн тэсэхийн аргагүй. Аяанаосу бэлтгэлийн танхимын үүдний өрөөний нэг сандал дээр суух зуураа янжуураа асаатал Эрхэмбаяр гарч ирлээ. Бэлтгэлдээ халууцсан Эрхэмбаярын нүүр ягаарч, хөлс дааварласан ажээ.

- Эрхэмбаяраа шинэ ажил, шинэ нэрэндээ аль зэрэг дасаж байна гэж яриагаа эхэлсэн Аяанаосу түүнээс сонирхсон бүхнээ лавлана.

- Танай хөгшин хаширлаад ямар хэргээр хаашаа явуулах гэж байгаагаа хэлэхгүй байна. Ярианы байдлыг ажвал Тяньжин руу явуулах бололтой.

- Чи тэгээд тэр нууц томилолтын талаар юу гэж бодож байна.

- Миний бодлоор бол их гүрний болон олон улсын банкны үйл ажиллагааг хянах бололтой. Гэхдээ ингэх гэж байгаа гэдэг нотолгоо миний гар дээр байхгүй.

- Чиний төсөөлөл зөв байх гэж Аяанаосуг хэлэхэд Эрхэмбаяр,

- Тозияагийн яриагаар бол японы засгийн газрыг үйлдвэр, банкны эзэд санхүүжүүлдэг бөгөөд тэд нар цэрэг дайны зардалд хөрөнгө хандивлахаасаа цааргалдаг бололтой. Ингээд японы армийн хөрөнгө нь армийн цэрэг дайны мэргэжилтэн генералуудын сэтгэлд чамлагдаад байдаг учраас тагнуулын үйл ажиллагаанд олгосон хөрөнгөндөө эд нар бухимддаг юм байна. Тиймээс Тозияа өөр замаар нэмэгдэл хөрөнгө олж авахын тулд Тяньжинд байгаа гоминдааны 50 сая долларын хадгаламжийг сонирхдог бололтой. Түүнийг айлган сүрдүүлэх замаар өөрийнхөө гарт хийх гэж байгаа юм шиг байна. Гэхдээ ийм сэтгэгдэл надад төрүүлээд өөр юм хийлгэхээсээ сийхгүй хөгшин бололтой.

- Эрхэмбаяраа, чи Тозияагийн санааг зөв ойлгосон байна. Цаад хөгшин чинь чамайг Тяньжин руу явуулахгүй. Шанхай руу явуулах байх. Би Жанжин сүм рүү нөгөөдөр явна. Тэгэхээр чамтай дахин уулзаж чадахгүй. Шанхайд очсоны дараа энэ хаягаар нэг эмэгтэйтэй уулзаарай. Тэр эмэгтэй чиний ажилд тус болно гээд халааснаасаа нэгэн зураг гаргаж үзүүлээд,

- Сайн нүдэлж ав! гээд түүнтэй уулзах нууц түлхүүрийг хэлж өглөө.

Аяанаосу, Хар чоныг Синьзин руу явуулсан хийгээд Тозияа түүнийг өөрийнхөө мэдэлд авсан учир холбогдлыг Рожусайд мэдэгджээ. Гэтэл Харбинаас Синьзин руу гарахын өмнө Ойдов ирж, Аяанаосутай уулзаад Рожусайн даалгаврыг дамжуулж, өөрийнхөө төлөөний хүмүүстэй уулзуулж ажиллуулахыг зөвшөөрсөн байлаа. Аяанаосу, Эрхэмбаяртай чингэж уулзаад явснаас хойш долоо хоноод Эрхэмбаяр алсын замд гарчээ. Тэрээр Синьзингийн галт тэргээр Мугдэнг дайрч, Гуаньдунгийн хойгийн зүүн өмнөд хэсэг Льюшунькоугийн булан дахь хятадын шар тэнгисийн эрэг дээр байгуулсан Льюшунь хотод ирлээ. Энэ хотын олонд алдаршсан нэр нь Порт-Артур гэдэг.

XX зууны эхнээс японы цэрэг Гуаньдунгийн хойг дээр суурьшсанаас хойш өмнөд манжуурын төмөр замын аюулгүй байдлыг эрхэлдэг цэрэг, зүүн азийн өмнөд хэсэг, Шар тэнгисийг холбосон энэ газар бэхэлсэн цайзтай болж бэхэжсэн болой. Гуаньдунгийн хойг дээр байдаг хоёр томоохон хот Порт-Артур, Дайран хоёр японы цэргийн эзэмшил болж, түүнээс хойш квантуны армийн түүх судар эхэлсэн ажээ.

Эрхэмбаяр, Порт-Артурын буудал дээр буутал японы цэргийн байнгын төлөөлөгчийн газраас ирсэн хоёр хүн түүнийг угтан авч, зочид буудалд аваачаад тохилог байрлуулав. Тэр хоёр хүн хэдэн жилийн өмнө Хар чоно гэж алдаршсан энэ хүнийг Доихарагийн даалгавраар барих гэж үйл тамаа үзэж байсан билээ. Гэтэл хожим хойчийн өдөр тусгай шугамаар түүнийг хүндэтгэн хүлээж авна гэж хэн хэний нь ч санаанд ороогүй. Чингээд хоёр хонож байтал японы жанжин штабаас тусгай төлөөлөгч Дайранд ирж, Эрхэмбаяртай биечлэн уулзаад Токио дахь нэгэн пүүсийн эзний бие төлөөлөгч, худалдаачин Эрхэмбаяр гэсэн үнэмлэх бичиг гардуулжээ. Эрхэмбаяр, Порт-Артурт дөрөв хоноод нэгэн орой усан онгоцонд суухын өмнө япон зөвлөхүүдтэй салах ёс гүйцэтгэтэл хоёр хоног өөрт нь ажил төрлийн холбогдолтой зүйлийг хэлж өгсөн дарга, Эрхэмбаярын зан араншингийн зарим гол зүйлийг хэлж өгөөд,

- Таныг Шанхайд байгаа манай хүмүүс угтаж авна гэхэд Эрхэмбаяр чухам ямар хот руу явж байгаагаа сая мэджээ.

Эрхэмбаярыг Шанхайд ирсний дараа консулын газар очиж бүртгүүлэхэд нэгэн халзан япон түүнийг хүлээн авч ярилцахдаа,

- Та энд Токиод байгаа өөрийнхөө эзний харьяаллын нэг байшинд сууна. Шанхайд байх хугацаандаа Нанжин-лу гэдэг гудамжинд байгаа гадаадын ихэсийн цэнгээний газраар орж, мөрийтэй тоглоомчидтой нийлэх хэрэгтэй. Алдах хожихоо та өөрөө мэдэх учраас энэ талаар зөвлөхийн ч хэрэггүй. Таны ажлын хэрэгцээнд таван мянган доллартай тэнцэх хэмжээний бэл эндээс олгоно. Гэхдээ та доллараар тоглохыг чухалчилж болохгүй. Манай улс хятадын зах зээл дээрээс долларыг шахан гаргах асуудлыг чухалчилж байгаа учраас шинээр гаргасан юань юмуу иень гаргаж тоглох хэрэгтэй гээд Эрхэмбаярт нэг боодол доллар, таван боодол юань өглөө.

- Би эндхийн америк худалдаачдын дунд бишрэгдсэн хүмүүсийн хаяг ажил төрлийн болон ахуй амьдралтай холбогдсон алдаа эндэгдэл, эгзэгтэй бүхнийг мэдэх хэрэгтэй. Тийм баримтыг арван хуруу шигээ мэдэж байвал миний ажилд тус болох хүмүүсийг түвэггүй урхидаж болно гэхэд,

- Үүнийг ажлын чинь явцад чамд хэлж өгч байх болно. Харин америкийн худалдааны танхимын ерөнхий захирлын сайн танилуудын нэг Гарриман гэдэг хүний эгзгийг олбол нэлээн юм мэдэж болно Угаасаа их юм үзсэн хашир хүн болохоор түүний амнаас хэр баргийн үг дуулж чадахгүй. Харин мөрийтэй тоглоомонд их шуналтай тоглодог, их хортой хүн. Их алдвал түүнийгээ эргүүлж авахын тулд шийдсэн мэх хийхээс буцахгүй толгой! Тиймээс түүнийг ажиглаж байх нь чухал.

Эрхэмбаяр Шанхайд ирээд долоо хоног хоттой танилцаж, гурван удаа Нанжинлу гудамжинд байдаг ихэсийн цэнгээний газраар орж, нэг удаа тоглохдоо алдсан ч үгүй, хожсон ч үгүй

гарчээ. Тэгээд байшиндаа ирэхэд түүний гэрийн үйлчлэгч хоол цайгаа бэлдчихсэн байлаа. Энэ эмэгтэйг консулын газраас ирүүлсэн нь Шанхайд бөөгнөрсөн япончуудын суудаг Чампай районыхон агаад Шанхайн тагнуулуудыг удирддаг өнөө Сигэтогийн туршуулууд болой.

Эрхэмбаяр оройн хоолныхоо дараа Хуанку мөрний зүүн хойд эргийн дагуу байрласан олон улсын эзэмшлийн хэсгийг Шанхай хоттой холбосон Гарден гүүрэн дээр зогсож цагаантны оргодол, их гүрнүүдийн худалдаачид, олон улсын тагнуул шургалсан энэ хотын Эргийн Банд гэж алдаршсан урт гудамжийг харж зогсох дуртай. Энэ гүүрэн дээрээс хятадын баялгийг тонон цөлмөсөн гадаадынхны усан онгоцнууд дааж ядсан, ачаатай далай руу зүглэхийг ажваас малын цусанд ханасан хувалз шиг санагдана. Францын үйлдвэрүүдийн нэгдлийн хэсгийг харж зогсоход хятад орноос бүрэн тусгаарлагдсан Шанхайнхны болон тэдний баялгийг эзэмшсэн гадаадынхны нүүр царайг гүүрэн дээрээс тольдож болох ажээ.

Эрхэмбаяр нохойныхоо уяаг сулруулан гэлдэрсээр эргийн Бандыг хөндлөн гарч, Нанжинлу гудамж руу явав.

Тэрээр гэртээ очиж нохойгоо орхиод Эдурад-Ш гудамжинд байдаг «Фантазио» хэмээх цэнгээний газар очдог заншилтай. Эрхэмбаярыг мөрийтэй хөзөрчдийн танхимд орж ирэхэд хэн ч түүнийг анхаарсангүй. Нэгэн том ширээнд суусан дөрвөн хүн покер тоглож түүний дэргэд олон хүн цуглажээ. Цагаантны ахлах дарга нарын өмсдөг мөрдөсгүй цэмцгэр хувцастай хоёр хүн бэлээ дуусаад босоход Гарриман инээмсэглэсээр,

- Суух хүн байна уу? гээд навчаар ороосон Гавай янжуур асаатал нэгэн үйлчлэгч мөнгөн тавиур дээр дөрвөн хундагатай архи авчирч Гарриманд барилаа. Тэрээр хожигдсон хүмүүсээ ингэж хүндэтгэдэг нь угтаа доромжлол байлаа. Тэд шотланд виски балгасны дараа тарган махлагдуу орос ширээнд суухад Эрхэмбаяр тэдний нэгийг орлов.

Ингээд дөрвүүлээ «франц покер» тоглолоо. Гарриман эхний гурван тоглолтонд хожлоо. Харин Эрхэмбаяр модоо солингуут мөрийгөө нэмээд тоглолтоос гардаг байв. Үүнийг ажигласан Гарриман сэтгэлдээ, «Энэ эр чинь овоо тоглож мэдэх хүн үү дээ! Миний тоглолтын янзыг ажиглахын тулд гурван удаа бага мөрий зүгээр хаядаг байна. Өнөөдөр энэ эрийн халаасыг хоосолж байж сална даа» гэж бодно. Эрхэмбаяр дараачийн хоёр тоглолтонд хожсон боловч тоглоомчдын хэлээр «Чихэндээ тулж, хор малтсан мөрий» авч чадсангүй. Харин Гарриманы мод барагтай болохоор тоглолгүй ажисхийхээр шийджээ. Ингээд гурав дахь тоглолтонд Эрхэмбаяр, Гарриман хоёр үлдлээ. Тэрээр хөзрөөсөө ганцыг солиод ширээн дээр уруу нь харуулж тавиад Гарриманы янзыг үзэх гэсэн шиг мянгыг амлав. Гарриман өнөөдрийн тоглолтонд чамбайхан хожсон болохоор Эрхэмбаярын амласныг бүтэн хагас нугалж амлалаа. Гэтэл Эрхэмбаяр ширээн дээрх бүх бэлийг амласан нь хүмүүст гайхал төрүүлэв. Эрхэмбаярыг мөрийгөө чингэж, ахиулаад үл мэдэг инээмсэглэхэд Гарриман «Ганц мод татаад нэг өнгийн дараалсан тав болмооргүй юм. Миний мод ч яахав. Зүгээр мод. Гурван тамга хоёр ижил. Ийм модтой хүн бууж өгөөд яахав? Дараалсан тав байвал цэцэг гэж байж болох уу? Үгүй шүү! Надад хоёр боол нь байна. Би түрүүн бундангийн арав, дөрвөлжингийн боол үхүүлсэн. Ингэхээр дараалсан тав байх ёсгүй. Мань хүн гурван ноён, хоёр ижилтэй байх нь! Би ийм юмыг алдаж болохгүй ямар ч нөхцөлд би хожно. Бундангийн дараалсан тав байвал яана. Би чинь арав, ес хоёрын алиныг хаялаа... Энэ золиг бундантай байж таарлаа шүү. Болих уу? Ингэж болохгүй. Нэр хор байна ахиулдаг хэрэг» гэж бодоод мөрийгөө нэмлээ. Гэтэл

Эрхэмбаяр мөрийгөө дөрөвний нэгээр ахиулав. Гарриман Эрхэмбаярын гарт дараалсан таван бундан орж гэдгийг мэдсэн боловч сэтгэлийг нь ямар нэг юм далдаас өөгшүүлж байлаа. Тэр бол Гарриманы совин ажээ. Тэрээр совиндоо итгэдэг болохоор тэсэлгүй мөрийгөө нэмлээ. Мөрий 70 мянгад хүрчээ. Хүмүүс 70 мянган долларын сургаар дуу алдлаа. Эрхэмбаяр мөрийг аравны нэгээр нэмлээ. Гарриман, Эрхэмбаярын царайг харвал түүний царай үл мэдэг яагаарчээ. Гарриман дотроо «Мань эр намайг чулуу хөөлгөж байжээ. Мод нь дараалсан тав байсан бол царай нь улайх ёсгүй. Мөрийгөө алдахыг мэдээд сэтгэл нь түгшсэн хэрэг! Одоо нэмээд байдаг цаг!» гэж бодоод,

- Мөрийг тавны нэгээр нэмлээ. Тэгээд зогссонгүй Эрхэмбаярын модыг үзье гэж нэхлээ. Хожно гэж баттай итгэсэн хүн ингэхээс өөр яах вэ. Покерт ингэж мод үздэг хүн ховор. Учир нь мөрийгөө алдаж байгаа хүн ийм саналыг хүлээн аваад модоо дэлгэдэг бөгөөд нэрэлхсэн хүн бол шууд модоо үзүүлэлгүй бууж өгдөг. Гарцаагүй хожигдсоноо илчлэх гэсэн шиг Эрхэмбаярын царай час улайгаад духаар нь хөлс чийхарсан байлаа. Тэрээр дуугүй бодол болон суухад ширээ тойрсон үзэгчид «Гарриман энэ залууг ганц чадлаа. Одоо яаж модоо дэлгэх вэ дээ» гэж бодлоо. Эрхэмбаяр ширээн дээр доош нь харуулж тавьсан модоо авахад түүний хуруунууд салгалан чичрэхийг харсан Гарриман,

- Залуу минь модоо үзүүлэхгүй байж болно гээд ширээн дээрх хожлоо өөр рүүгээ дөхүүлэхэд Эрхэмбаяр хөзрөө ширээн дээр дэлгэтэл тэр хоёрын ширээг тойрч цугласан хүмүүс цөмөөрөө дуу алдан шуугилаа. Эрхэмбаярын мод дараалсан таван бундан байлаа.

Дөрөвдүгээр бүлэг

Хар санаа, цагаан сэтгэл

Нэг. Үүр шөнөөр дэгдсэн хэрэг

Утасны хонх жингэнэх чимээгээр нойрноосоо цочиж сэрсэн Уэда, орныхоо толгойд байдаг шөнийнхөө гэрлийг асаагаад дэрэн доороосоо энгэрийн цаг гаргаж харвал 02 цаг болох гэж байлаа. Уэда утсаа авангуут, орон дээрээ сандайлаад жанжин штабаас ярьж гэсэн юм байх даа гэж бодоод чихэндээ чагнуураа ойртуултал,

- Эрхэм дээдсээ, Токиогоос буухиа элч ирлээ. Танайх руу явуулах уу? гэж штабын жижүүр илтгэхэд Уэда,

- Одоохон гэж хэлээд утсаа тавингуутаа утасны дэргэд байдаг жижиг цагаан товрууг дартал хажуугийн өрөөнөөс өндөр гоолиг биетэй залуухан хүүхэн орж ирээд хаалганы дэргэд зогсов. Энэ хүүхнийг Уэда, холынхоо нэг хамаатан болох хүнээр олуулж дэргэдээ авчирсан агаад гар хурууны үзүүрт зарахын зэрэгцээ өврөө дулаацуулж шөнө бор хоног өнгөрөөдөг болой.

- Сэйёоко, штабаас хүн ирнэ. Миний ажлын өрөөнд оруулаарай. Бас унаа дуудчихаарай гэж аргадангуй зөөлөн хэлээд хувцаслав. Уэда, хувцаслаад халуун усныхаа өрөөнд орлоо. Цагаан паалантай түмпэнд халуун бүлээн ус дүүргээд хажууд нь гялтгар ууттай алчуур нандигнан тавьжээ. Уэда, алчуураа уутнаас бүлээн усанд хийгээд мушгиж, усыг нь шавхарсны дараа нүүрээ дарж хэсэгхэн байзнаснаа алчуураа түмпэнтэй ус руу чулуудаад өрөөнөөс гарлаа. Тэрээр өдөрт хоёр удаа усанд ордог болохоор бие нь нялх хүүхдийн бие шиг булбарай, хөвөн шиг зөөлөн учраас алчуураар нүүрээ шударч арчих дургүй. Уэда гэртээ зассан албаны өрөөнд орж ирэхэд өндөрдүү туранхай ахмад түүний бараанаар номхон зогсож,

- Эрхэм дээдсээ, Итагаки сан үүнийг гардуулж өгөхийг надад даалгасан юм гээд цэргийн яамны сайдын нууцалсан тэмдэг бүхий нэг бичиг гаргаж өглөө. Уэда түүнийг аваад ширээнээсээ жижиг хатуу цаас гаргаж дээр нь нууцын тэмдэг дараад буухиа элчид өглөө. Энэ бол маш нууц бичиг хүлээн авсны баталгаа агаад түүнийг Итагаки хүлээн авсны дараа бичгийн нууц задраагүй гэдэгт итгэх ёстой. Уэда, буухиа элчийг өрөөнөөсөө гарсны дараа бичгийг задалж үзээд ширээн дээрх утсаа авч туслахтайгаа ярилаа.

- Шиү са (хошуучаа), одоохон штабын дарга болон байлдаан, тагнуулын газрын дарга нарыг миний өрөөнд ирүүл! Чи өөрөө төмөр замынхантай ярилцаад миний вагоныг бэлтгүүл! Ханширээгээс Хайлар руу машинаар явах учраас урьдчилсан арга хэмжээ ав! Ханширээд очоод цагдаагийн газрын дарга, кэмпэйтийн төлөөлөгчтэй уулзана. Тэндээсээ жанжин сүм рүү очно. Тозияа тэнд Сафронов, Аяанаосу хоёртой уулзах ёстой. Тэднийг бэлэн байлгах нь чухал! Нөгөө талаар биднийг хаашаа явж байгааг хэн ч мэдэх ёсгүй. Мөн Жанжин сүм, Хайларт очиход тэндхийнхэн урьдчилан мэдсэн байж болохгүй гэдгийг анхаараарай.

Уэда туслахдаа чингэж тушаасны дараа цаг болоод бүх хүмүүс генералын өрөөнд цуглав.

Тозияа, Уэдааг чингэж дуудуулсан хийгээд өрөөнд байгаа хүмүүсийн албан тушаалаар «Номон хан зикэн но боппоцу» ажиллагааг эхлүүлэх шийд дээрээс ирж гэдгийг багцаалав. Уэда дарга нарыг нойрноос сэрээсэндээ уучлал гуйгаад,

- Жанжин штабаас манай ажиллагааг зөвшөөрсөн. Та бүхэн хагас цагийн дараа Хайлар руу явах тул авч явах зүйлээ бэлэн болго! гээд холбогдох хүмүүст биечилж даалгавар өгөөд тараалаа. Тэрээр Халх голын ажиллагааны нууцыг далдлахын тул чингэж «түргэн жагсаал» зарласан болохоор Тозияаг ч гэр рүү нь явуулах ёсгүй ажээ. Уэда нууцын шүүгээнээс хэрэгтэй гэсэн бичиг баримтаа аваад,

- Тозияа сан, Жанжин сүмд өгөх өнөө товхимлоо бэлэн болгосон уу гэв.

- Штабын жижүүр дээр байгаа. Одоо гарахдаа аваад явъя. Чингэж шөнө дүлээр цугласан квантуны армийн удирдах хүмүүс

Синьзиний галт тэрэгний буудал дээр ирж тусгай вагонд сууснаас хойш хорин дөрвөн цагийн дараа Ханширээд ирлээ. Уэда, Ханширээд очихын өмнө Халуун рашаан, Ирэсигийн цагдаагийн газрын дарга нартай уулзахдаа дэргэдээсээ Тозияаг салгаагүйн адилаар Ханширээгийнхэнтэй уулзахдаа түүнийг дэргэдээ байлгалаа.

- Гакка, Мөст сүмд байгаа тусгай хэсгээс манайд хорин хүн ирсэн. Тэд орон нутгийн «Киокавакай» нийгэмлэгийнхэнтэй хамтарч монголын нутаг Халх голын бэлчир, Нөмрөгийн гол, Цагаан арлаар Монгол руу оруулах хүмүүстэй ажиллаж байгаа. Одоогоор Халх голын сав дагуу эзэмшил газартай болох гэсэн 400 өрх айлын бүртгэлийг гаргаад байна гэхэд Тозияа дотроо «Аяанаосугийн бэлдсэн хүмүүс, нутгийнхныг эзэмшил газартай болгоно гэж итгүүлж чаджээ. Энэ бол нэг амжилт. Харин өөр дорвитойхон арга сэдэх хэрэгтэй. Халх гол руу нүүх айлтай хамт нэлээн тагнуулыг монгол руу илгээж болно» гэж бодлоо. Уэда, Ханширээд цаг болоод тусгай хамгаалалтын таван машин бүхий цэргээр хамгаалуулан Жанжин сүм рүү гарлаа. Уэдааг үд өнгөрөөж Жанжин сүм дээр ирэхэд тэднийг ирнэ гэдгийг хэн ч мэдээгүй байлаа. Уэда, хилийн гарнизонхонтой ажил төрлийн талаар өнгөцхөн танилцаж, ярилцсан нь хилийнхэнд ямар хэргээр яваа нууцаа мэдэгдэлгүй өнгөрчээ. Тиймээс тэд Хайлартай холбоо барьж мэдэгдэхийг бодсонгүй. Харин Тозияа Аяанаосутай уулзаад удаан ярилцав.

- Чиний явуулсан «Сиймхий» үүргээ гүйцэтгээд хилээр гарч яваад хилийнхэнд сэжиглэгдэж баригдсан байна. Тэгэхдээ гурав шархаджээ. Харин хамт явсан орос эхнэрийн талаар хэл сураггүй. Хил дээрээс мэдэгдсэн манайхны мэдээнд Сиймхийг хил давахын даваан дээр бариад явахыг харсан хүмүүс тодорхойлтондоо оросын хилийнхэн эмнэлгийн дамнуур дээр нэг хүн дамнаж явсан гэжээ. Үүнээс үзвэл тэр эмэгтэй хилийнхний суманд өртсөн бололтой. Сафроновын туршуулууд урваагүй. Харин болгоомжгүй байдлаас сэжиглэгдээд хилийн хулгайн хэргээр шийтгэгдсэн байна. Ингэхээр Сафроновын талаар гаргасан чиний санаачилга барагтайхан үр дүнтэй боллоо. Энэ удаа чиний ажил урагш муутай ч гэсэн сэтгэл санаагаар унах хэрэггүй. Харин бодолтой яв! Сафронов энд ирээд ямар нэг сэжиг гаргаагүй болохоор Разаевский руу нь явуулчихъя. Үнэхээр улаантантай холбоотой бол Монголын хил дээр болж байгаа ажиллагааны талаар дуугүй байхгүй. Тэгэхээр хаанахын ямар сонин энэ тухай шуугиан дэгдээх нь вэ? гэдгийг ажиглана. Ер нь Монгол, Оросын хэн түрүүлж Манж го болон манай засгийн газарт эсэргүүцэл илэрхийлэх вэ? гэдгийг хүлээе. Энэ бүхний эзэн Сафронов

байх ёстой. Халх голын ажиллагааны талаар одоо Сафроновоос өөр гадны хүн мэдээгүй байгаа гэхэд Аяанаосу сэнсэйнхээ овжин ухаан, түргэн сэтгэдэг онцлогийг биширсэн царайгаар,

- Эрхэм дээдсээ энэ яах аргагүй нарийн арга байна. Сафроновыг хэн болохыг таны энэ арга илчилнэ гэлээ.

- Энэ ч яахав. Танайханд зориулж тусгай бэлдсэн товхимол авчирсан түүнийг авч тараалгаарай гээд Тозияа, Уэдааг бараадан Хайлар руу хөдлөв. Сиймхий хочтыг орлосон Корпухин, Надежда Михайловна хоёр ямар ч сэжиггүй Хабаровскт очсон энэ ажиллагаа цагаантны болон японы тагнуул, туршуулуудад мэдэгдээгүйг Тозияагийн амнаас сонссон Аяанаосу Тозияаг явсан хойно сэтгэлдээ баяртай байлаа. Харин Тозияа, генералын бараа болсоор Наньтун хүрэнгүүт хамгаалалтын цэрэг хуягтгүйгээр цаашаа Хайлар руу явж, хэдхэн мөчийн дараа Хайлар дахь Барга Монголын хэрэг эрхлэх яам хэмээх нэрийн доор байдаг японы цэргийн штабын модон байшингийн дэргэд иржээ.

Хайлар хот. Баргын хошуу нутагт хятадууд суурьших болсноос хойш эдүгээ хоёр зуун таван жил болжээ. Хянганы нуруунаас эх авсан Имэн гол, Хайларт цутгадаг бэлчирт тариалан тарих болсноор хятадууд 1734 онд шавар сууц барьж суурьшсанаар Хайлар хотын үндэс тавигджээ. Тэр шавар байшин бүхий сууринг Наньтун гэдэг байлаа. Дорнод хятадын төмөр замыг тавих явцад Наньтунгаас хэдэн бээр зайтай Хайлар голд цутгадаг Имэн голын зүүн тохойд төмөр замын нэгэн өртөө байгуулагдаж, Наньтунгийн хятад иргэд Имэн голын баруун эргээс төмөр замын сууринд ирж худалдаа арилжаа хийх, төмөр замын ажилд оролцдог болсноор шинэ хуучин хоёр суурин аажимдаа нийлж эдүгээгийн Хайлар хот болсон.

Төмөр замын Хайлар өртөө, дан тоосгон барилгатай. Наньтунг бодвол гудамж нь шулуун уужим агаад нэг маягийн тоосгон дан барилга өнгө үзэмжтэй болой. Хайларт голдуу төмөр замын ажилчид сууна. Харин Наньтунд гар урчууд бөөгнөрсөн агаад нарийн тахир гудамж бүхий намхан шавар байшингуудыг бөөр бөөрийг нь наалдуулан шахаж барьсан болохоор зөгийн үүр шиг санагдана. Энд модон эдлэл хийдэг мужааны пүүс, мухлаг олонтой. Хянганы нуруунд бэлдсэн модыг Имэн голоор саллан урсгаж Наньтунд авчирдаг. Чингээд Хайлараас галт тэргэнд ачаад зүүн умард Хятад Манжуур руу зөөнө.

Хаврын сүүл сарын хуучдаар Хайларын гудамж талбай цасгүй болоод зогссонгүй гол гудамжинд тарьсан бургас, улиас нахиагаа дэлгэн ногоорлоо. Хаврын цонхигор нарны илч өдөр өдөрт нэмэгдэж, хотынхон нимгэн хувцсандаа орж, зуны хувцастай япон дарга нар Хайларын гудамжнаа хөлхөлдөх нь олширчээ. Төмөр замын нэг маягийн тоосгон барилгуудаас нэлээн зайтай байгаа Барга монголын хэрэг эрхлэх яамны хорин жан модон байшинг цагаан шохойгоор будсан тул нутгийнхан "Наран эздийн цагаан" гэдэг билээ.

Уэда, оройн найман цагт дивизийн удирдлагыг Комацубарагийн өрөөнд цуглуулав. Мөн цуглаанд байлдааны туршлагатай Кобояси, Ясую, Ямагата зэрэг генералууд оролцсоны зэрэгцээ тагнуулын хэсгийн дарга дэд хурандаа Азума суулцлаа. Дэслэгч генерал Комацубара, армийн удирдлагыг хэл чимээгүй ирсэнд нэлээн эмээж, эвгүйрхэж байсан боловч сэтгэлдээ «Номон Ханы ажиллагааг» эхлүүлэхээр ирлээ гэдгийг багцаалжээ. Чингээд Уэда, Номон Хан руу явуулах тэргүүн ангиудын бэлтгэлийг ерөнхий төлөвлөгөөтэй

уялдуулсан өөрийнхөө төлөвлөгөөний дагуу танилцав.

- Манай гол хүчийг очтол Халх Голын зүүн талаас баргын 500 морин цэрэг бүхий хэсэг, мөн 250 хүн бүхий тусгай отрядыг Халх голын чиглэлээр оруулна. Жинхэнэ байлдааны ангиуд буюу баргын морьт хороод 64 дүгээр хороог Ямагатогийн нэгдсэн отрядтай нийлүүлж ширүүн довтолгоогоор Халх голын цаад тал Баянцагааны нурууг эзэлнэ. Иймээс монголын хилийн дагуу уртаараа 80 км, өргөнөөрөө 30км газар байлдааны ажиллагааг явуулах учраас 1000 гаруй морин цэрэг, 1500 явган цэргийн 64 дүгээр хороо, ахмад Кабаногийн моторжуулсан тусгай отрядыг байлдааны талбайд татах болно гэж Комацубара тайлбарлав.

- Чиү жёо (дэслэгч генералаа), монголын цэргийн талаар ямаршуухан судалгаа хийсэн бэ?

- Гакка Уэда сан, бид дөрвөн удаа монголын хилчдийн дунд ухуулах хуудас тараахын тулд хилийн цаана тодорхой газруудыг сонгон авч Аяанаосугийн хүмүүсийг явуулсан. Тэд үүргээ гүйцэтгэж чадсан. Мөн монголын хилчдийн сонирхлыг татахын тулд арван мянган төгрөг, хоол хүнсний зүйл болон тусгайлан бэлдсэн зураг, хэзрүүдийг хаясан. Ийм үүрэг гүйцэтгэх гурван хэсэг явуулсны ихэнх нь буцаж ирсэн. Тиймээс монголын цэрэг манай талд орох эгзгийг хүлээж байгаа. Одоо хил дээр байгаа монголын хүчний хувьд гэвэл дөрвөн суман цэрэг хилийн харуулынханд хүч хавсран хориглолтын байдалтай байна. Иймээс манай их хүч, тэднийг яах ийхийн зуургүй устгаж чадна. Энэ бол юуны өмнө оросын хүч Халх голоос хол алслагдсан учир давын өмнө хүрч ирж тусалж чадахгүйтэй холбоотой. Нөгөө талаар манай нисэгчид тэдний гол хүчийг зам зуур нь устгах бүрэн боломжтой гэхэд Уэда, өөрийнхөө дэргэд байгаа тагнуулын газрын дарга руу харж,

- Манайд байгаа мэдээтэй дүйж байна уу? гэлээ.

- Эрхэм дээдсээ, Комацубара сан, яриагаа сунжруулахгүйн тулд зарим зүйлийг товчилсон байх. Хил дээр хориглож байгаа монголын хүч, тусгай хуягт дивизонтой. Гэхдээ энэ бол Комацубарагийн саяын тодорхойлсон хүчний дэргэд юу ч биш! Манай цэргүүд манжуур, хятадад байлдаж шалгарсан дайчид шүү дээ гэж тал засаж тайлбарлав. Уэда, Комацубарагийн ярианы дараа товч дүгнэлт хийж,

- Та бүхэн амжилтанд хүрнэ гэдэгт итгэж байна. Та нарын гаргасан тэр мөрөөр эзэн хааны 5, 6 дугаар армийн хүч замнаж, ялалтаа бэхжүүлэх юм. Бид монголоос алс дорнод, Байгалийн цаана

эзэн хааны дэглэмийг тогтоох ёстой. Тиймээс танай дивизийн цэргүүд эзэн хааны сүр хүчийг мандуулах жинхэнэ самурайн бусидо ёсоор аймшиггүй замнах ёстой. Банзай! гэж уриалснаар үгээ дуусгалаа. Комацубарагийн дивизийн дарга нар Уэдагийн ярианаас Халх голын ажиллагааг эхлэх гэж байгааг мэдсэн боловч чухам хэдийд эхлүүлэх гэж байгаа талаар командлагч ам ангайсангүй. Үүнээс шалтгаалж ахлах дарга нарын сэтгэлд «Уэда, байлдааны бэлтгэлийг зүгээр шалгаж яваа юм байна. Түүнээс жанжин штабаас удирдамж ирээгүй хэрэг» гэж боджээ. Уэда яриагаа дууссан учир дивизийн хороодын дарга нар Комацубарагийн өрөөнөөс гарсны дараа цүнхнээсээ байлдааны зураг гаргаж ширээн дээр дэлгэлээ.

- Комацубара сан, монголын нутагт явуулах байлдааны шаталсан ерөнхий төлөвлөгөөг

баталсан. Манай ажиллагааг гурван том хэсэгт хуваасан байна. Өөрөөр хэлбэл эхний довтолгоогор Халх гол, Баянтүмэнийг дараагийн довтолгоогоор Баянтүмэнээс Хэнтийг, эцсийн шат нь Улаанбаатарыг эзэлснээр монголын асуудлыг шийдвэрлэх болно. Жанжин штабаас эхний хоёр ажиллагааны үр дүнд монголын асуудлыг шийдвэрлэх даалгавар өгсөн. Номон Хан зикэн но боппоцу буюу Номон Ханы ажиллагааны эхлэл гэж товлосон манай довтолгооны нэрийг жанжин штабаас алс дорнод, Байгаль руу чиглүүлсэн «Найм дахь ажиллагаа» ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж «Косэйтоку» гэж товлосон байна. Бид гурав хоногийн дотор гол хүчээ Баян Цагаанд гаргасан байх ёстой. Баян Цагааныг эзэлж, монгол оросын хүчийг Тамсагаас Халх гол хүрэх хооронд зам зуурт бут цохивол монголчууд сүйрлээс айгаад асуудлыг хэлэлцээний замаар шийдэх санал тавих нь гарцаагүй. Ингэхээр халх голыг эзлэх эрхэм үүрэг танд оногдож байна. Ганц ч хүний хохиролгүйгээр Халх голыг авбал манай 5,6 дугаар армийн 35 дивизийг Улаан орос руу хөдөлгөх бүх бололцоо нээгдэх болно гэж тайлбарлав.

Уэда, квантуны армийн төлөвлөгөөг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж «Косэйтоку» гэж товлон нэрлэсэн нэрийн учрыг зөвхөн фронт удирдах тэр хүнд хэлэх үүрэгтэй болохоор санамсаргүй үг алдах вий гэхээс айна. Уэда Хайлараас Харбин руу онгоцоор явахын өмнө Комацубараад,

- Байлдааны бэлтгэлийг долоо хоногт багтааж бэлтгээд надад илтгээрэй гэж хэлээд явахдаа «Косэйтоку» ажиллагааг эхлэх өдрийн талаар ганц ч үг цухайлгасангүй. Харин Комацубара, армийн командлагчийг явсны дараа өөрийнхөө генерал, хороодын дарга нарыг өрөөндөө цуглуулав. Комацубарагийн яриа олон цаг сунжирч

генералуудыг залхаасангүй. Тэрээр газрын зураг дээр зааж, яриагаа эхлэв.

- Койси, Ясуко, Ямагата та гурав байлдааны ажиллагааг зураг дээр тэмдэглэж ав! Өнөө шөнө явган цэргийн 64 дүгээр хороо, моторжуулсан бүх отрядыг хээрийн сургуульд гаргах нэрийдлээр, хөдөлгөнө. Энэ ажиллагааг урьдчилж танилцуулж болохгүй. Газар дээрээ жинхэнэ даалгавар өгөгдөх болно. Тиймээс та гурав Жанжин сүм рүү явах бэлтгэлээ хийх хэрэгтэй гэхэд гурван генерал Комацубарагийн өрөөнөөс гарлаа. Энэ гурав хятадад байлдаж байсан японы цэргийг удирдаж байсан байлдааны их туршлагатай болохоор зүүн өмнөд хятадын байлдаанаас татаж авчирсан болой.

Хаврын сүүл сарын хуучдаарх нэг шөнө Хайлар хотод байрладаг квантуны армийн 20, 23 дугаар дивизийн хороод түргэн жагсаалын дохиогоор босож, хээрийн сургуульд гарлаа. Японы хорооны цэргүүд машинд сууж, хээрийн замд гарсан болохоор цэргүүд маш хол явна гэдгээ ойлгож байлаа. Цувааны эхэнд тусгай хамгаалалтын хуягт тэрэгнүүд түрүүлж, түүний хойноос хэдэн суудлын тэрэг хөвөрчээ. Эхний суудлын тэргэнд дэд хурандаа Азума, дэслэгч генерал Кобояси хоёр суужээ. Кобояси үүр цайтал суудлын тэрэгний түшлэгийг налж, зүүрмэглэн явахад Азума байлдааны ажиллагааны талаар бодож явна.

Тэнгэрийн алсын хаяанаа нүүгэлтсэн үүрийн цайвар гэгээ улам тодорч таван цаг гэхэд өглөө болчихлоо. Цэргийн цуваа Имэн голын эрэг дээр буй Имэн сууринд ойртож зогсоход Кобояси нойрноос сэржээ. Цэргүүд бууж биеийн чилээ гарган, түр амсхийгээд машиндаа сууцгаахад машинууд хөдөлж, нүд алдам цэлийсэн талд зурагтай дардан замаар усны урсгал шиг

хөвөрнө. Машины дугуйнаас боссон тоос Имэн голын хөндийд хөшиглөн манарч, машин дээр суусан цэргүүдийн хамар хорсгож, хоолой ирвэгнүүлж, цээжинд хуурай тоос аргаад ядаргаатай.

Нар жаргах гэж байхад цэргүүд Жанжин сүм дээр ирлээ. Цэргүүдийг усанд оруулж хооллосны дараа Жанжин сүмийн гол дуганы өмнөх талбай дээр жагсаалаа. Сүмийн эргэн тойронд бамбар асааж барьсан цэргүүд эгнэн зогсжээ. Сүмийн гол хаалганы довжоон дээр хивс дэвссэн агаад сүмийн үүднээ цагаан даавуун дээр хар өнгөөр зурсан лууны хөрөг, Хатимана бурхны зураг өлгөсөн ажээ. Тэр луу биеэ тав нугалан эвхрүүлээд толгойгоо өргөн цогнойж, хар цагаанаараа эргэлдсэн нүдээр цэргүүдийн дээрээс өнгийн ширтсэн нь сүртэй. Сүмийн үүдний довжоон дээр гурван генерал, бас бус дарга нар зогссон агаад тэдний өмнө дунд зэргийн нуруутай туранхай биендээ томдсон, хэлхгэр тас хар өнгийн катагина (ёслолын хувцас) өмссөн нэгэн лам баруун гартаа самурайн илд, зүүн гартаа ятано хагами (утгаараа шидэт толь гэсэн уг) барьжээ. Самурайн ёсонд илд, эрдэнэ, ятано хагами гурвыг цэрэг эрсийн сүнс, сүлд гэж үздэг болой. Ялангуяа ятано хагами хэмээх шидэт толийг аянгын эзэн тэнгэр Сувано өөрийн төрсөн дүү, нарны охин тэнгэр Амагэрасуд өгч, өөрийн ач Ниниганно Микотоод хайр хишгээ хүртээн хөрст дэлхийд буулгахдаа шидэт толио уламжлуулан хадгалуулсан гэдэг домогтой. Түүнээс хойш самурай нар ятано хагамийг сахиус болгон зүүдэг болсон болой.

Жанжин сүм дээр байгаа Синто ёсны тэр ламыг ажвал хоёр ёрдгор модонд бэхэлсэн Модон ул бүхий шаахай буюу гэта хэмээх модон шаахай нүцгэн хөлдөө углан, катанина өмссөнийг бодоход эртний самурайн ёсоор хувцасласан ажээ. Энэ ламыг Сайто гэдэг. Харанхуйг гэрэлтүүлсэн олон зуун бамбарын гэрэлд Сайтогийн тосолсон улаан ягаан нүүр гялалзан хэлж байгаа үгийнхээ аясаар нүүр царай, ам хамраа татвалзуулан, нүдээ эрээлжлүүлэхийг ажваас онгод нь орсон догшин дүртэй агаад зурмал луугийн аймшигт төрх сэтгэлд бууна. Сайто цэргүүдийн эр зоригийг бадруулах, бусидо ёсонд бишрүүлэхийн тулд Хатимана бурхны нэрийг барин догшин дүрээр үг айлдах ёстой болохоор халуун ууранд өөрийгөө утаж, дотор биеэ хатуухан нанчдаар халаасан болохоор улаан өнгөтэй будаг шингээсэн тосоор будсан нүүр царай, бамбарын гэрэлд улам тод, догшин дүртэй харагдаж байлаа.

Сүмийн өмнөх талбай дээр эгнээ эгнээгээр нь хайрцагласан юм шиг тэг дөрвөлжин жагссан цэргүүдийн хойгуур зогссон хэсэг дарга нарын дунд зогсож байсан Аяанаосу, дэргэдээ байсан Сафроновоос,

- Чи тэр ламыг таних уу? Энэ хүн угаасаа лам хүн биш бололтой. Харин үе залгамжилсан самурай баймаар санагдана гэхэд Сафронов,

- Яаж байна? гэж лавлав.

- Үг ярих нь лам хүний сэтгэл санаа, үзэл бодлын илрэл биш харин самурайн сэтгэхүйн илрэл бололтой.

- Чи үнэн дүрээр нь олж харжээ. Энэ хүн угаасаа ийм хүн биш. Токиогийн кэмпэйтайд алба хааж байсан хурандаа цолтой явсан хүн гэнэ билээ.

- Сафронов чи яаж мэдсэн юм бэ?

- Юки энэ хүний тухай бараг домог шиг юм ярьдаг юм. Юкийг Токиод байхад нэг удаа кэмпэйтэйн даалгавраар гэйшагийн үүрэг гүйцэтгэж шалгалт өгөхөд энэ Сайто зөвлөгчөөр ажилласан гэдэг.

- Юкийг яагаад шалгах болсон юм болоо?

- Нэгд Юки кэмпэйтэйн багш нараас сурсан зүйлээ шалгуулах ёстой байж. Хоёрт. Энэ бүхэн италийн улс төрийн бодлоготой япончууд өрсөлдөх болсонтой холбоотой байж. Япон улс 1919 онд германы мэдэлд байсан Маршалл, Мариан, Киралины арлуудыг аятайхан салгаж чадсан тэр үеэсээ азийн газар нутагт төдийгүй Европыг эзэмших зорилго тавьж байжээ. Тэгээд бага азийг эзэмших санаатай байсан япон, Африкийн зарим хэсэгт ноёрхлоо тогтоосон Италийн ирээдүйн төлөвлөгөөг мэдээд тэднийхний цэргийн албаныхныг гүтгэж, гоочлох болсон хэрэг. Тэгээд Токиод ирсэн Италийн усан цэргийн дарга нарын нэр төрийг гутаах ажиллагаа сэддэг байсан аж. Түүндээ нэг удаа Юкийг ашигласан аж. Тэгэхэд Сайто, Акасайгийн нөхөр болж жүжиглэсэн юм гэдэг шүү. Юки Акасайтай үерхдэг боловч нөхрийг нь таньдаггүй байж. Гэтэл кэмпэйтэйнхан Тозиягийн даалгавраар Юкийг өөрийнхөнтэйгөө ажиллуулахын тулд өөрийнхөө туршуул Акасайг Сайтогийн эхнэр болгож Юкийг молигодсон гэдэг юм.

- Тэгвэл тун сүрхий чоно байх нь ээ. Цаанаа ондоо байсан юм. Үг хэл нь хүртэл илэрхий дайнч самурайн үг бололтой.

- Аяанаосу сан, энэ чинь их том хүн болох гэж байгаад сүйрсэн эр! Чи 1936 оны 2 сарын 26-нд болсон залуу дарга нарын үймээнийг мэднэ биз. Тэд засгийн газрын гишүүдийг устгах ажиллагаа бэлдсэн. Тэгэхэд Сайто сангийн яамны сайд, цэргийн сургуулийн захирал, эзэн хааны хамгаалалтын дарга Сузуки, жанжин штабын дарга Макино, ерөнхий сайд Окада нарыг устгах ажилд нууцаар оролцож байжээ. Эднийг цэргийн яамны сайд Есизуки Кавасима баривчилж шоронд хорьчихсон байхад эзэн хаан суллуулсан гэдэг. Тэр үед баригдсан найман генералуудын дотроос Араки, Хаяси, Абэ гурвыг ерөнхий сайд болох ирээдүйтэй гэж үздэг байсан. Хаяси ерөнхий сайд болоод огцорсон Сайто, тэр үед Хар луу нийгэмлэгийнхэнтэй нууц холбоотой байсны ачаар зүгээр өнгөрсөн боловч цаашдаа явцгүй гэдгээ мэдээд лам болсон гэдэг. Ер нь японы генералууд өтлөх, алдаа эндэгдэлд орохоороо лам болдог, сайд нар нь пүүсний эзэд болдог уламжлалтай юм.

Аяанаосу, Сафроновын яриаг чагнан зогсохдоо харанхуйг гэрэлтүүлсэн бамбарын гэрэлд Сайтогийн улаан ягаан царайг ажиглана. Тэрээр байдаг чадлаараа хоолойгоо шахан их дуугаар хашгирч ярих тул улайж ягаарсан царай бамбарын гэрэлд бүүр ч сүртэй агаад шарын шашны бурхны догшин улаан сахиус Жамсран бурхныг санагдуулам ажээ.

- Яматогийн үнэнч хөвгүүд ээ! Дэлхий дахинд зовлонгийн үр ургалаа. Тэр үрийг улаан оросууд тарьсан юм. Тэр халдвар гадаад монголд дэлгэрээд харин одоо манжуурын умард хэсэг, барга монголын нутгаар тэдний хий сүнс тарж магадгүй байна. Энэ бол манай эзэн хааны замналд саад болох гал усны аюул мөн! Тиймээс самурайн хөвгүүд эзэн хаан төрд аюул учруулах улаан орос, улаан монголоос улс орноо хамгаалах ёстой. Бурхны ёсыг огоорсон

гадаад монгол азийн хөрсөн дээр байх ёсгүй! Та нар энэ насны үйл лайгаар доод муу заяанд төрсөн учраас одоо ядуу зүдүү амьдарч байна. Ийм амьдралтай хүмүүсийг жаргуулахын тулд та нар самурайн эр зоригоор гадаад монголыг устгаж, тэдний газар нутгийг өөрийн болгож авахын тулд амиа өргөх цаг ирнэ. Та нарыг байлдаж ялах эсвэл амиа бурхан тэнгэрт өргөх хоёр аугаа их үйл хэрэг угтаж байна. Манай эзэн хааны цэрэг ялагдах ёсгүй. Тэд хөл тавьсан газраасаа ухрах ёсгүй. Та нар байлдаанд хүчинд автагдан эрсдэж болно. Тийм хүн бол бурхан тэнгэрийг хилэгнүүлсэн нүгэлтэй учраас бурхны салхи, үхлийн салхи аугаа их камиказегийн шийтгэлийг хүлээж байгаа нь тэр! Түүнээс улааны хүчинд ялагдаж байгаа хэрэг биш. Ингэж эрсэдсэн самурай бол улаан монголын цэрэгт амьдаар олзлогдохгүйн тулд эртний самурайн уламжлалаар өөрөө өөртөө сеппуку үйлдэх ёстой! Ингэж үхсэн хүн өөрийнхөө нүгэлт амьдралыг эцэслэж диваажинд төрөх болно. Ийм үхэл та нарт хойд насны аз жаргалыг авчирч өгнө. Тиймээс үхлээс айж болохгүй! Самурайн ёсонд үхлээс айж байсан уламжлал байхгүй. Тиймээс ч хөл тавьсан газраасаа хойш ухарч болохгүй тэндээ үхэх ёстой. Үхлээр эзэн хааны дэглэмийг дэлхийд дэлгэрүүлнэ. Банзай... Юмия хатимана (Дайны тэнгэр тангараглая!) Хатимана гомия (Бидний эр чадлыг Хатимана үзэг) Банзай! гэж хоолойгоо сөөтөл хашгирлаа. Синто шашны гэгээн лам Сайто, үгээ хэлж дуусаад цэргүүдийн зүг мутраараа дохин адислаж дууссаны дараа Кобояси цэргүүдийн өмнө гарч үг хэллээ.

- Яматогийн цэрэг эрсээ, одоо бидний дайчин замналын өлмийд гадаад монголын цэргүүд сөхрөх болно. Тэд байлдаан гэдгийг мэддэггүй учраас буун дуу сонсонгуут сүнс нь зайлж, үнхэлцэг нь хагарчихдаг аймхай амьтад.

Та нар эхний дайралтаар гадаад монголын цэргүүдийг өөрийнхөө өлмийд сөхрүүлнэ гэдэгт итгэж байна. Гадаад монголын цэргүүдийг өршөөж болохгүй. Тэд улааны номлолд оюун ухаанаа гашилгасан учраас хэнд ч хэрэггүй амьтад болно. Тийм хүмүүсийн зүрхийг сугалж, халуун элсэнд булж нарны элчээр борцлох хэрэгтэй. Тэгсэн цагт Азийн эзэн, манай ямато үндэстний үйл хэрэгт хэн ч саад болж чадахгүй. Гадаад монгол бол азийн хөрсөн дээр байх хувь тавилангүй, бурхны хараал зүхлээр сөнөх ёстой улсууд юм. Тэд Чингэс хаан, Хубилайн үеэс манай ямато үндэстнийг устгах гэснээс бурхны хараал эдэлж байгаа улс юм. Тиймээс гадаад монголын хүн бүрийг устгаж, когайн ишинд тэдний толгойг өлгөх хэрэгтэй! Банзай... Банзай гэж хашгирлаа. Кобоясийг үг хэлсний дараа нэг цэрэг үг хэлэхээр сүмийн довжоо руу алхав.

- Би хэд хоногийн өмнө энэ номыг уншлаа гээд жижиг ном барьсан гараа дээр өргөж,

- Энэ номонд 1274 оны намар Хубилай солонгосоос 33 мянган цэрэг хөдөлгөж, Цусиму, Ики арлууд руу довголсон байна. Гэвч манай сёгун Хозёо Такимунэгийн хүчийг дийлээгүй юм. Тэгээд манай ямато үндэстнийг устгах гэсэн Хубилай 1281 оны 7 сарын 23-нд дахин манай нутаг руу дайрсан байна. Манай цэрэгт Аматаэрасуэ бурхан өөрийн элч үхлийн салхи камиказег илгээж Хубилайн цэргийг 8 сарын 13-нд далайд живүүлжээ. Цэргүүд ээ...Яматогийн хөвгүүдээ...Бид наймдугаар сарын 13-нд монголын баруун хилд байхын төлөө амь хайргүй байлдъя! Би урьд үеийнхээ элэнц хуланцын гайгаар ядуу амьдралд төрсөн. Одоо аав ээж дүү минь өлбөрч үхэхээс наагуур байна. Би бурхнаас заяасан энэ аз завшааныг ашиглаж, дайчин байлдаж, монголын нутагт өөрийн эзэмшил газартай болохыг өөрийн эрхэм зорилго болгоно. Цэргүүд ээ! Бид цөмөөрөө ядуу гэрээс гаралтай шүү дээ. Тиймээс монголын

цэргийг ялж, монголд эзэмшил газартай болохын төлөө байлдах хэрэгтэй! Өөрийн эдлэн газартай болохын төлөө амиа өргөсөн ч багадахгүй. Банзай.Хатичана юмияа... Банзай! гэв

Кобояси, дэргэдээ байгаа ахмад Кабаногийн хажууд зогсож байгаа дэд хурандаа Азумагаас,

- Чиү са, энэ цэрэг чинь аль хороо сумангийн цэрэг вэ? гэлээ.

- Гакка Кобояси, энэ чинь явган цэргийн хорооны I дүгээр сумангийн дарга чиү и (ахмад) Аюумугийн цэрэг Арадаки...

- Тэр барьж байгаа ном нь юуны ном бэ? Та нар бэлдсэн юм уу?

- Уэда саныг ирэхэд Тозияа сэнсэй манайханд өгсөн юм. Одоо олон хувь байгаа. Сэнсэй Тозияа өөрөө эртний судраас түүвэрлэж бэлдсэн гэнэ билээ. Ер нь манай цэргийн зориг хийморь сэтгэл санааг сэргээх ном шүү гэж магттал цэргүүд Банзай гэж хашгирах чимээ тэдний ярианд саад боллоо.

Синто ёсны шашны нэрээр амь хоохойлж яваа Сайто, самурайн үзэл сэтгэхүйг цэрэг бүрийн цохилох зүрх, лугших судсаар гүйж байгаа цусанд шингээхийн тул Хатимана буюу дайны бурхны нэрийг барьж адислахыг ариун үүргээ гэж үзнэ. Сайтогийн адислал шөнө дүл хүртэл үргэлжилж цэргүүд хоолойгоо сөөтөл Банзай... Хакку ити о буюу дэлхийг японы өрх гэрийн дээвэр доор нэгтгэе гэсэн уриа хашгирлаа.

Сафронов, Аяанаосу хоёр сүмийн баруун өмнө барьсан дарга нарын нэгдсэн байранд орж ирээд үүр цайтал нүд аньсангүй. Хил дээр болж буй хэрэг явдлыг олон талаас нь дүгнэн ярилцав.

- Иван Степанович аа, Тозияа таныг гоочлохоо болихоор шийдсэн. Таныг Харбин руу буцаа гэсэн шүү.

- Зөнөж яваа энэ генерал надаар бүр тоглож гүйцлээ. Бөмбөг шиг дуртай зүг рүүгээ өшиглөж байх санаатай. За яахав. Цаг нь ирвэл би ч гэсэн аргаа бодно. Гайгүй ээ.

- Би Тозияагийн нэг бодлыг ойлгохгүй байна. Миний бодлоор бол Хар чоно та хоёрыг нэг тэвний үзүүрээр сүвэгчлээд холбочихсон юм шиг санагдах юм. Хар чоно Шанхайд энгийн худалдаачны дүрээр очоод банкныхантай сүүж холбох гээд байгаа, Акасай элчингийн хашаанаас ажиглаад өглөө үдэшгүй анаж байдаг болсон. Гэтэл чамайг улааны туршуул гэдгийг тогтоохын тулд үйл тамаа эдэлж байна. Эцсийн эцэст Тозияа та нарыг яах гэж байгаа бол?

- Аяанаосу энэ талаар бодсон чиний бодол зөв! Биднийг зангилсан тэр зангилаа бол Халх голын ажиллагааны дараа илэрхий болно. Өөрөөр хэлбэл Юкигийн алтыг Тозияа өөрийнхөө мэдэлд авсны дараа биднийг цөмийг устгана. Тэр байтугай чамайг ч устгана. Ингэхээр бид цөмөөрөө нэг тэвнэнд сүвлэгдээд байгаа юм.

- Иван Степановичаа, та үүнийг Юкийд хэлсэн үү?

- Үгүй. Юки японы армийн ажиллагааг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Юки, тийм ч амархан хүн биш. Тиймээс квантуны армийнхан яаж ч чадалгүй өдий хүрсэн.

- Сафронов, та Халх голын ажиллагааны талаар "Дүрвэгсдийн дуу хоолой" сонинд бичих үү? Энэ талаар одоохондоо танаас өөр орос хүн мэдэхгүй.

- Аяанаосу минь, Халх гол руу чиглэсэн армийн ажиллагааг би байтугай монголчууд мэдэж байгаа. Хэд хоногийн дараа эхлэх гэж байгаа энэ дуулианыг Харбиныхан мэдээгүй нь үнэн. Ямар нэг сонинд энэ тухай бичвэл Тозияагийн сэжиг овоохон баримттай болж баярлуулах болно. Тэр чинь хаанахын сонинд энэ тухай бичих нь вэ? гэж анаад нүд нь ширгэж, чих нь сэртэлзэж байгаа. Одоохондоо би, Тозияагийн аманд ороод яах вэ? Тэгэхээр дуугүй явсан дээр!

- Сафронов би ч гэсэн тэгж бодож байгаа юм. Харин танд хилийн цаанаас ирсэн нэг захиаг өгөх гээд завдсангүй өдий хүрлээ. Намайг удаачихсан явдалд уучилна биз. Би наашаа явахын өмнө танай өвгөнтэй уулзсан юм гээд Аяанаосу халаасаа уудалж өнөө захиаг гаргаж өглөө.

Үнэндээ Аяанаосу Тозияагийн санааг мэдэж чадсан тэр үед л Сафроновт өгнө гэж бодсон юм. Энэ бол Зөвлөлтийн зохих байгууллагаас Сафроновтой холбоо тогтоож бие хүн явуулахаар шийдсэн тухай мэдэгдсэн бичиг байжээ. Сафронов бичгийг авч уншаад уруулаа мушилзуулан инээмсэглэхэд түүний царайд баяр баясал зурвасласан байлаа.

Тэгээд хэсэг дуугүй суухдаа «Надад итгэж байна шүү» гэж үглэв.

- Иван Степанович аа, та тэгээд хэзээ Харбин явах вэ? гэж лавлахад,

- Өнөөдөр ч гэсэн буцмаар байна. Өвгөнтэй хурдан уулзмаар байна гэв.

Та маргааш нөгөөдөр хоёр амжиж орчуулагч нарт ажлаа хүлээлгэж өг. Би ч гэсэн нөгөөдөр явна. Татгалзахгүй бол хоёулаа Синьзин руу явъя. Синьзингаас би таныг гаргаж өгнө.

- Аяанаосу минь чи тушаал дэвшиж байгаа юм уу?

- Халх голыг эзлэх асуудалтай холбогдуулж намайг армийн тагнуулын штабт ажиллуулахаар болсон бололтой.

- Тэгвэл бүр сайн шүү! гээд баярлан инээв. Тэрээр амьдралдаа ганц удаа баярласан гэж ярьдаг. Цэен Харбинд ирж түүнийг гуйлгачингаас цагаантны ахлах офицер болгоход үхээд босоод ирсэн юм шиг санагдажээ. Гэтэл Аяанаосугаас захиа аваад дахин төрсөн юм шиг болоод магнай нь тэнийв. Тэрээр сүүлийн хэдэн жил сэтгэлдээ бодож явсан хувь заяандаа хүрэх найдвар олсондоо хөлд орсон хүүхэд шиг баярлана.

Тавдугаар сарын эхний долоо хоногийн Бямба гаригт Ясуко Авдар нуурт ирж цэрэг дарга нартай уулзлаа. Гэтэл гурав хоноод байтал лхагва гаригийн өглөө холбооны хэсгийн дарга орж ирээд нэгэн цахилгаан өглөө. Тусгай томьёоллоор бичсэн цахилгааныг авсан Ясуко, тусгай мэргэжилтэнгүүдийн тайлсан хавсралтыг үзвэл «Номон Хан зикэно. Госэйко о

иноримаеу буюу Номон Ханы ажиллагаа. Танд амжилт хүсье» гэсэн байлаа. Тэгээд цахилгааны эцэст «Моку ёо би» гэжээ. Ясуко хаалтанд онцолсон энэ үгийг үзээд «Пүрэв» гаригт ажиллагааг эхлэхийг мэдээд хороодын дарга нарыг дуудлаа.

Тавдугаар сарын 11-ний Пүрэв гаригт Комацубарагийн тушаалаар Халх голын ажиллагаа эхэллээ. Төлөвлөгөө ёсоор бол 64 дүгээр хороо, Баргын 7, 8 дугаар хороо Номон Ханы чиглэлд, Талын манхан, Хайлаастын баруун тал Бойтог, Тавиурт манхныг эзлээд Элсэн уул, Дүйнхор овоо (Шарын шашны өвөрмөц горимын дагуу Халх голын энэ овоог тахихад Дүйнхор хурснаас номын ёсоор ингэж нэрлэснийг ихэнх ном зохиолд Дунгар гэж ташаа тэмдэглэсэн байдаг), Нурын уулын хавь газрыг эзлээд ар талаа бэхжүүлэх ёстой болой. Гэтэл юм бүхэн төлөвлөсөн ёсоор болсонгүй. Хоёр өдөр хилийн харуулын цэрэг, хүч нэмэгдүүлсэн сумангийнхантай байлдсан Ясукогийнхон амжилт олсонгүй. Тиймээс хилийн цаад руу шинэ хүч илгээхээр шийдсэн Ясуко, цэргүүдийн эр зоригийг бадруулахын тулд өөрөө байлдааны талбар руу явахын өмнө цэргүүддээ сургамжаа өглөө.

- Яматочууд аа! Та нар өнөөдөр эзэн хааны дэглэмийг Азид дэлгэрүүлэх аугаа их үйлсийн төлөө амь хайргүй байлдаж байгаа цэрэг эрсийн ёсоор Халх голд өнөөдөр очно. Тэнд түрүүчийн ангиуд баатарлаг гавьяа байгуулж байна. Та нар тэдний үйлсийг батжуулахын тулд эр зоригоо шавхах ёстой. Та нар бусидоод үнэнч цэрэг эрсийн ёсоор хөл тавьсан газраасаа ухрахгүй байлдах ёстой. Үүнийг дайны тэнгэр, сүр жавхланта Хатимана бурхан та нарт даалгаж байна. Та нар маргааш гэхэд Баян Цагааны нуруунд гарсан байх аугаа их хувь тавилантай яматогийн хөвгүүд мөн. Банзай гэж уриаллаа.

Ням гариг. Үүрийн гэгээ Авдар нуурын зүүнээс мэлтийж, холын бараа танигдах төдий байхад суурингийн зүүгээр зурайсан замаар Баргын морин цэргийн хорооныхон цувж түүний араас арав гаруй машин цэрэг хөдлөв. Ясуко, суудлын тэрэгний арын суудалд тухлан сууж, үүрийн гэгээнд бараантаж буй их цувааг харж явахад түүнтэй зэрэгцэн суугаа дэд хурандаа Фузива, байлдааны газрын зураг дээр тэмдэглэсэн зүйлээ сэтгэлдээ бодно. Харин жолоочийн дэргэд суусан Ёнуванита зам ширтэн дуугүй суухдаа «Хангай нуурын баруугаар ороод Хайлааст голын зүүн салаанд байгаа штабын байранд очоод байлдааны ажиллагааг ярилцъя. Ер нь Хайлаастын баруун талд байгаа Хар Эрэгт Бойтог, Тавиурт манхан, Эмээлт манхны чиглэлд Кисуру, Фумито хоёрыг баргын хорооныхонтой оруулбал уу?» гэж бодно. Харин Ясуко «Хайлаастын зүүн тал Элгэн Цагаан нуур, Талын манхан, Өндөр Улааны чиглэлд нэгдүгээр хороо 64 дүгээр хорооны хэдэн батальоныг оруулбал маргааш гэхэд Дүйнхор толгойд штабын байраа нүүлгэх хэрэгтэй болно» гэж бодно. Ийнхүү бодож явсаар Хайлаастын зүүн салаанд байгуулсан штабын байранд ирлээ. Энэ штабыг Номон Хан, Бүрд-Овооноос зүүн тийш ердөө хагас бээр хэртэй газар байрлуулсан байлаа. Штабын байрыг элсэрхэг газар ухаж, төө хагас хэртэй бүдүүн гуалингуудыг углуургадан зааж бэхэлж барьсан бөгөөд монголын хил рүү чиглүүлсэн яндан дуранг голлуулжээ. Штабын газар байрны зүүн хананд холбооны хэрэгсэл байрлуулсан агаад хоёр цэрэг хажуугийн ширээнд суужээ. Штабын газар байр таван өрөөнөөс бүрдэх агаад өрөө бүрийн ханыг бүдүүн гуалингаар хийгээд хаалганы яс модонд шаргал саарал өнгөтэй цэмбэ унжуулан халхалжээ. Ясукоог гаднаас орж ирэхэд хилийн наймдугаар отрядын нэг дарга генералыг угтаж хилийн чанадад болсон үйл явдлыг танилцуулав.

- Өчигдөр манай морин цэрэг хилийн цаана байлдаж харанхуй болгоод командын шийдвэрээр буцаж ирсэн. Монголын хил дээр хэдхэн сумангаас өөр цэрэг байхгүй байна гэж илтгэхэд Ясуко царайгаа барайлган, уруулаараа хүйтэн инээмсэглээд,

- Шиү са, танай баргын цэргүүд ухарч шившгээ тарьсан юм биш биз? гэхэд хилийн отрядын даргын нуруугаар хүйт оргих шиг санагдлаа. Үнэндээ өчигдөр, уржигдар хоёр Бойтог манханд монголын хилийн харуулын цэргүүдийг бүсэлсэн боловч яаж ч чадалгүй хүйс тэмтрүүлэх шахаад буцаж хил гарч ирсэн билээ. Үүнийг Ясуко сайн мэдэж байгаа тул хилийн отрядын даргад орох гарах газаргүй болжээ. Ясуко, хилийн отрядын даргын илтгэлийг сонссон болоод штабын байрны голд тавьсан ширээний дэргэд очиход Фузива газрын зураг гаргаж дэлгэв.

- Шиү са (хошуучаа) та нар оросын цэргийн талаар ямар мэдээтэй байна? Та нарын хударгаар тэд чинь хил дээр ирчихсэн юм биш биз? гэж Ясукоог шаардангуй асуухад,

- Гакка (генералаа), Хайлаастан гарсан манай тагнуулын хэсэг сая ирсэн. Тэнд оросын ямар ч хүч ирээгүй байна гэж итгэлтэй илтгэв.

- Чиү са (дэд хуранда) Фузива, та ямар саналтай байна гэхэд,

- Бүх хүчээ хоёр хэсэг болгоод эхний хэсэг Талын манхан Элгэн Цагаан нуурын чиглэлээр Такайса (Нэргүй өндөрлөг буюу Ремизовын өндөрлөг) өндөрлөг рүү оруулахын зэрэгцээ баргын морин хороог Бойтог, Тавиур манхны чиглэлээр Дүйнхор овоо руу оруулах нь ашигтай. Өнөө шөнө гэхэд Хайлаастын зүүн баруун талд хүчээ бөөгнүүлээд даваа гаригийн өглөө Баян Цагаан руу бүх хүчээрээ дайрах нь найдвартай болно гэхэд Ясукогийн харц зөөлөрч, царайнд нь инээмсэглэл тодорлоо. Ясуко өөрөө энэ саналыг боловсруулсан болохоор штабын дарга түүний төлөвлөгөөг засан залруулах гэж зөрж мэтгэх хэрэггүй гэж боджээ. Ясуко бугуйнхаа цагийг хараад,

- Үүрийн таван цагт эхэлнэ гэж хэлээд сэтгэлдээ «1939 оны тавдугаар сарын 15-ны даваа гариг. Өглөөний долоон цаг гэхэд эзэн хааны төлөө гэсэн миний хувь заяа шийдэгдэнэ. Өнөөдөр хишиг өдөр! Хатимана бурханд тахилга өргөдөг өдөр! Ёстой есөн хүсэл биелэхийг зөгнөсөн ерөөл төгөлдөр өдөр» гэж бодоод,

- Довголгоо эхлэхийг би зөвшөөрнө гэлээ. Чингээд Ясукогийн тушаалыг хил дээр бөөгнөрсөн ангиудын штабын дарга нарт дамжуулав.

...Хайлааст голын баруун этгээд Бойтог, Давхар, Тавиурт манхны чиглэлд гарсан 600 морьт цэрэг, 13 машин явган цэрэг дэд хурандаа Ёкуванитагийн удирдлагаар байлдааны ажиллагаанд орлоо. Тэд хилээс дотогш 3 бээр хэртэй газар ирээд Хайлаастын Хар эргээс баруун тийш үргэлжилсэн хонхордуу газар машинуудаа зогсоож цэргээ буулгаад давшилтанд орлоо.

Ёкуванита, дурангаараа Бойтог, Тавиурт манхан руу дурандаж элсэн хонхрыг бүрхэн давшиж яваа цэргүүдийн араас ажиглана.

- Монголын хилийн харуулууд ойртон байж магадгүй. Тэр харагдаж байгаа манхан руу

тагнуул явуулж ажиглалт хийлгэдэг байж дээ гэж хэлтэл Барга цэргийн хошууч, Ёкуванитагийн дэргэд зогсож байснаа,

- Манайхан сайхан давшиж байна гээд явган цэргүүд рүү заалаа. Чухам энэхэн үед Аюумагийн давшиж байгаа сумангийн нэг цэрэг «Уржигдар Талын манхны тэндээс амьд гарсан. Одоо эндээс амьд мултрах болов уу» гэж бодож байжээ. Үнэндээ ахмад Аюумагийнхан ингэж давшиж яваагаа азгүй явдал гэж бодож байлаа.

Аюумагийн салаа хамгийн түрүүнд Тавиурт манханд ойртлоо. Манхны ойролцоох судаг даган явж байгаа Аюумагийн хойноос явган хорооныхон давшиж, баргын морин цэргүүд дайралтанд бэлтгэж байжээ. Аюумагийнхан Манхны оройд 300-гаад алхам ойртлоо. Гэтэл манхны цаанаас шоволзох бараа ч гарсангүй. Чингээд дахин зуугаад алхам ойртоход гэнэт пулемётын гал тургиж гарлаа.

Ахмад дурангаа урдаа барьсаар харахад хилийн цэргийн гурван пулемёт японы цэргийг урагшаа давшуулахгүй шүршинэ. Пулемётын суманд өртөж, амь тавьж байгаа цэргийн хахир дуу тэртээгээс тод сонсогдож, Аюумагийн чихэнд зүрх шимшрүүлэм хадаад замхрахад дараагийн хахир муухай дуу залгаж, Аюумагийн нуруугаар хүйт оргих шиг болно. Японы цэргүүд хилийн харуулынхны байрыг мэдсэн болохоор алсуур бүсэлж эхлэв. Тэгээд үдийн халуун нар эгц дээрээс шарж байхад бүслэлтийг хумьж эхлэв. Аюума элсэн манхан руу дурандаад,

- Эд нар пулемётын галын цэгийг сайн сонгосон болохоор манийгаа нэг ч алхам ахиулалгүй бариад байх царайтай байх чинь. Дэслэгчээ, майханд байгаа монгол цэргүүдийг амьдаар нь барих нь чухал. Оройхон тийш эдний сум дуусна. Тэр үед үү гээд Аюума бүсэн дэх төмөр саваа авч архинаасаа балгав. Тэрээр согтуу байх нь хэрэгтэй гэж үзжээ. Учир нь гай болоод шархадвал согтуу хүн шархаа мэдэхгүй. Тэгээд ч зориг зүрх чангарна. Аюумагийн цэргүүд Манхан руу улам ойртож бүслэлтийн цагираг улам хумхигдсаар байсан тэрхэн үед газар доргиулсан бөөн дэлбэрэлт болж, япон цэргүүдийн ёолон хашгирч байгаа зэвүүн дуу дэлбэрэлтийн чимээнээс тод сонсогдов. Аюума савтай архиа цөмийг нь хөнтөрчихсөн болохоор чухам юу болж байгааг төдий сайн мэдсэнгүй. Үнэндээ бүслэгдсэн хилийн харуулынхан япон цэргүүд рүү нэг зэрэг гранат шидэж тэр сиймхийгээр мориндоо мордоод бүслэлтийг сэтлээд гарчихсаныг Аюума ухаарах сөгөө байсангүй. Гэхдээ тэрээр юм тоймлох сэхээтэй байлаа. Тиймээс нуувчаас өндийхдөө «Мөн зальтай гайхлууд аа! Есүүлхнээ байж манай цэргийг пулемётын галаар шүршээд ойртуулсангүй шүү. Бүслээд эд бадьг нь хөтөлдгийн даваан дээр гранат шидэж, түүний сиймхийгээр бүслэлтээс гарчихдаг байна шүү» гэж өөртөө шивнэсээр өндөрлөг дээр бөөгнөрсөн цэргүүд дээр иртэл хоёр монгол хилчин шархадсан хэвтэж байлаа. Япон цэргүүд түүн рүү улайран дайртал Аюума,

- Байз хүлээж бай! Би өөрийнхөө гараар тонилгоно гээд шархадсан хоёр цэрэг рүү алхав.

Цус нэлийн шингэсэн элс рүү нүүрээрээ гударч ойчсон нэг цэрэг өндийх гэж оролдсон боловч япон цэргүүд хоёр гарын булчинг сэт жадалсан болохоор цээжээ даалгүй халуун элс рүү гудран унав. Гэтэл хажууд нь хэвтэж байсан монгол хилчин хөмхийгөө зуун өндийж, цусанд будагдсан час улаан нүүрнийхээ хоёр нүдийг хар цагаанаараа эрээлжлүүлэн гөлөрсөөр Аюумагийн өөдөөс алхахад "Энэ чинь юу вэ? Өнөө бууны дуу сонсохоороо зүрх нь

дэлбэрдэг монгол цэрэг үү? Тийм байх ёсгүй" гэж бодохдоо нүүрээ алгаараа даран нүдээ тас аньснаа мэдсэнгүй. Гэтэл хажууд нь зогсож байсан цэрэг буудах чимээгээр зовхио нээвэл монгол хилчин халуун элсэн дээр өвдгөөрөө сөхрөн унаснаа биеэ даалгүй писхийн ойчих чимээнээр Аюума хиртхийн цочив. Аюума энэ бүхнээс айсандаа «Яасан аймаар юм бэ? Монгол цэрэг бүхэн ийм бол яана! Манай дарга нар бидний толгойг эргүүлж худлаа хэлжээ» гэж өөртөө сануулаад орчноо харвал согтуу цэргүүд нь өнөө хоёр цэргийн хүүрийг тал талаас нь жадлан буудаж байлаа.

Оройн нар Хандгайтын нурууны цаад руу тонгойж байхад япон цэргүүд Бойтог, Тавиурт манхнаас зайдуухан байгаа нэг манхан руу шилжин байраа өөрчилсөн долоон хилчин рүү давшлаа. Аюума нар жаргахаас өмнөхөн эв эрүүл болжээ. Түүний архи гарчихсан болохоор өдрийн наранд халчихсан толгой нь тугалга цутгачихсан юм шиг даагдахааргүй болж, тархинд нь ямар нэг юм гүйх тул тэрээр нүдээ анина. Гэтэл өдрийн монгол цэрэг нүдэнд нь харагдах тул нүдээ анихаас айна. Чингээд Аюума элдвийг бодож «Монголын хилийн харуулынхан арвуулаа байсан. Гэтэл есүүлээ байдаг. Хоёр нь бүслэлт сэтлэх үеэр шархтаад бүслэлтээс гарч амжилгүй үхсэн. Эд одоо долуулаа. Нэг цэрэг хаачсан юм бол? Холбоо барихаар ар тал руугаа явсан хэрэг үү? Тэгвэл энэ хэд гол хүчээ иртэл биднийг молигодож дөнгөсөн байж таарна. Тэгвэл монголын цэргүүд бидний ар хударгаар орж ирээд бүсэлчихсэн байвал яана! Тэгээд бүслэлтээ мэдэгдэлгүй хумьж байгаа хэрэг» гэж бодоод сүнс нь зайлчих шахлаа. Тэрээр синто ёсны мөргөлтэй учраас зөнд итгэдэг болой. Аюумагийн бодлоор бол Ёкуванитагийн цэрэг бүрэн бүслэгдсэн ажээ.

Шинэ манханд шилжиж байрласан хилийн харуулын цэрэг хүчтэй галаараа японы цэргийн болон баргуудын анхаарлыг өөрсөн дээрээ татжээ. Тэгээд галынхаа цэгийг сайн хуваарилсан болохоор япон, баргын цэргүүдийг урагш ахиулахгүй барьсаар байлаа. Япон баргын цэргүүдийн бүх анхаарал хилийн харуулын цэргүүдийг устгах гэж улайрсан болохоор Аюума шиг эргэцүүлэн бодох сөгөөгүй. Үнэндээ байлдаж байгаа цэргүүд урдах цэргүүдийг устгахыг бодохоос ар талдаа юу болж байгааг бодох ч аргагүй!

Ёкуванита, хилийн цэргүүдийг нар шингэхээс өмнө бөөн хүчээр устгахын тул баргын морин цэргийг давшилтанд оруулах гэж шийдээд тушаал өгтөл тэдний арын манхнаас болон баруун, зүүн талаас пулемётын үргэлжилсэн гал шүршиж гарлаа. Ёкуванита эгшний төдий байдлыг ажиглаад монгол хилийн харуулын гол хүчинд бүслэгдсэнээ мэдээд машиндаа орж суунгуут жолоочдоо,

- Хил рүү хурдан ухар! Хурдан... цагаан гэгээ тасрах нь байна шүү. Ямар ч байсан замаа алдаж болохгүй. Монголын хилийн цэргийн гол хүч ирсэн байна гэж цухалдан хэллээ. Дэд хурандаагийн тушаалаар машинаа асаасан жолооч жолоогоо залж зам ширтсээр хурдаа нэмсээр хурдлахад буун дуу холдсоор байлаа. Тэнгэрийн алсын хаяанд нүүгэлтсэн цагаан гэгээ тасарч, үдшийн бүрэнхийд зам нь харагдахгүй болсонд жолооч арга буюу гэрлээ асаахдаа эсэн мэнд гарч, Хайлаастын зүүн салааны адагт ирснээ мэдээд сэтгэлдээ баярлан "За штаб дээр амар мэнд ирэх нь ирлээ. Манай цэргүүд одоо бүслэлтээс амьд гарахаасаа өнгөрсөн" гэж бодож байхад Хайлаастын зүүн салааны гарам ширтсэн дэд хурандаа Ёкуванита сэтгэлдээ элдвийг бодож өөрийгөө цагаатгахыг бодно.

...Монголын хилийн харуулынхан биднийг дөнгөлөв. Тэд гол хүчээ бидний зүүгээр

Хайлаастыг бараадуулж явуулсан болохоор ямар ч сэжиг авахуулалгүйгээр бүсэлж амжсан байна. Өнөө бардам Аюума, өдийд байхгүй болсон. Тэндээ салаа өндөрлөг өөд дайрах үед хилчид гранат шидсэн... Одоо харин гаккаад (генералд) юу гэж хэлэх вэ? Бид монголын хороо цэрэгт бүслэгдээд байхад баргын морин хороо биднийг бүслэлтэнд үлдээгээд зугтсан учир арга буюу бүслэлтийг сэтэлж гарцгаасан гэж хэлдэг хэрэг! Тэгэхгүй бол толгойгүй шүү.

Ёкуванита чингэж бодсоор яваад Хайлаастын зүүн салааны гармаар гарч штабын байрны гадаа ирснээ мэдсэнгүй. Гэтэл жолооч нь,

- Эрхэм дээдэс ирлээ гэхэд Ёкуванита машинаас ухасхийн гарч байлдаан хэрхэнийг өөрийнхөө боловсруулж, найруулсан ёсоор илтгэв. Ясуко, дэд хурандаагийн илтгэлийг сонсоод баргын хорооны дарга хурандаа Бүгээ рүү эргэж,

- Ноён хурандаа, танай баргууд ар монголын цэргүүдэд тал засаж урваснаас эзэн хааны цэргүүд бүслэгдсэн байна. Үүний хариуцлагыг чи хүлээх болно. Та өөрийнхөө барга цэргүүдийг манай эзэн хааны төлөө зүтгэх сэтгэл санаагаар хүмүүжүүлж чадаагүй байна гэж хэлээд гартаа барьж байсан ширэн шаахайгаар (эрүү шүүлтэнд хэрэглэдэг нэгэн зүйлийн цохиур) хурандаагийн хоёр хацарт буулгаж шавхуурдахад харанхуйг цочоосон тас няс хийх чимээ тодоос тод сонсогдоно. Хурандаа Бүгээ нүдээ аньсан болохоор байдаг чадлаараа хоёр хацар руу нь буулгаж байгаа генералын шавхуурдалтанд хацар нь мэдээ алдсаныг гадарлав. Хурандаа шавхуурдалт зогссоныг мэдээд нүдээ сая нээвэл генерал Ясукогийн нүд харанхуйн дунд чонын нүд шиг хачин том, улаан харагджээ. Ясуко баргын морин хороодыг хараан зүхсээр штабын байр руу эргэхэд Бүгээ шаахайн шавхуурдалтанд хэгз цохиулсан хацрынхаа цусыг алгаараа арчин цусаа тогтоохыг хичээсээр харанхуйд үлджээ. Энэ хэрэг явдлаас хойш хэд хоносны дараа хорин гуравдугаар дивизийн штаб дээр хэд хэдэн хороодын дарга нарыг генерал Комацубара цуглуулжээ.

Номон Ханы ажиллагаанд оролцож удирдсан генералууд арван тав хоногт ямар ч амжилт гаргаагүй тул Комацубара тэднийг хэдэн цаг номхон зогсоож толгой тархигүй загналаа. Комацубара тас хар хилэн шиг сахлаа сөрвөлзүүлэн, хөмсгөө зангидан, хяламхийсэн муухай харцаар Кобояси, Ясуко, Ямагата гурав руу ууртай цоргин ширтэж байснаа ширээн дээр дэлгэсэн газрын зураг руу эргээд,

- Та нар наашаа ойртоцгоо гэхэд генералын туслах ахмад даргынхаа хажууд ирж зогсоод нэгэн жижиг дэвтэр гаргаж дээд талын булан дээр 1938 оны тавдугаар сарын 21-ний өдөр 16 цаг гэж бичээд Комацубарагийн хэлж ярих үгийг хүлээнэ.

- Гадаад монголын цэргийг устгаж, Халх голыг Барга хошуунд нэгтгэх анхны зорилтыг биелүүлэх ёстой та нар өнгөрсөн хугацаанд армийн нэр төрийг гутаахад хүргэсэн. Зүй ёс нь та нарыг байлдааны тушаал гүйцэтгээгүй, самурайн уламжлалт ёсыг огоорсон хэрэгт татаж, хээрийн шүүхээр оруулалгүй шууд газар дээр чинь буудах ёстой! Гэвч Баргын морин хороод та нарын ажиллагаанд бүрэн дэмжлэг үзүүлээгүй урвасан байдлыг харгалзан, энэ эндэгдлээ засах бололцоо олгоё! Хэрвээ байлдааны тушаал дахин биелүүлэхгүй бол та нар эртний самурайн улалжлалт ёсыг сахиж байлдааны талбай дээр өөртөө сеппуку (хари-кирагийн нэг төрөл) үйлдээрэй! гээд генерал уур уцаараа дарж, өөрийгөө тайвшруулахын тул хэсэг дуугүй зогссоноо, яриагаа үргэлжлүүлж,

- Явган цэргийн 64 дүгээр хорооны бүх ангийг Ямагатагийн удирдлаганд нэгтгэнэ. Баргын 7, 8 дугаар морьт хороо, 12 дугаар морьт хорооны зарим суман, ахмад Кабаногийн моторжуулсан хэсгийг мөн нэгтгээд Талын нуурын чиглэлээр монголын хилийг гарч, Ооны манхны орчмоор монгол цэргийн хориглолтын ар талаас бүсэлж устгах хэрэгтэй. Цэргийн эр зоригийг өрнүүлэхийн тулд гурван лааз спирт олгож, байлдаанд онц гавьяа байгуулсан цэргүүдийг хар тамхиар шагнаж, тусгай заавраар чөлөө олгож, Жанжин сүм дээр аваачсан олзлогдсон хүүхнүүдтэй наргиж цэнгэхийг зөвшөөрнө. Байлдааны бэлэн байдлыг шалгаад лхагва гаригт надад илтгэ! Давшилтыг хэзээ эхлэхийг жич мэдэгдэнэ. Энэ ажиллагааны нууцыг хадгалахын тулд давшилтын талаар бага дарга нарт мэдэгдэхийг хориглоно гэхэд Комацубарагийн туслах генералынхаа үгийг тусгайлан тэмдэглэж авахыг ажваас тэрээр тушаал бэлтгэх нь илэрхий байлаа.

Хоёр. Сүйрлийг цагаатгаж болно

Цагийн үрийг дагаж Халх голын хөндий тэр аяараа ногоорч, Хайлааст голын дагуу ургасан хайлаас бургасны нахиа дэлгэрээд нов ногоон өнгө газар дэлхийг бүрхэн голын хөндийд чийглэг сэрүүн салхи сэвэлзэнэ. Жил бүр голын хөндий бургасаар жиргэдэг шувууны уяхан жиргээ дуулдахаа больсноос хойш эл хуль оргиод, усны урсгал шаагин хоржигнох чимээ нэг янзын уйтгар гуниг төрүүлэх шиг санагдана. Халх голын хөндийд буун дуу тачигнаж, онгоцноос хаясан бөмбөгний хахир шунгиналт, чих дүлийрч, тархи задрам дэлбэрэлтээс үргэсэн шувууд аль зүг нисэн одсоныг хэн яахан мэдэх билээ. Халх голын цаад эргийн дагуух элсэн толгод, манхнаар хориглож байгаа монгол цэргүүд хилийн зүг нүд анилгүй ширтэн хэвтэхдээ аль зүгээс дайсан ирэхийг сонор сэрэмжтэй ажиглаж байхад Халх гол аль талаас шувууд ирэхийг хүлээн гиюүрсэн юм шиг уйтгартай мэлтэгнэнэ.

Халх гол руу довтолсон япон цэргүүд хилийн цаад руу ухран гарсан боловч өдөр бүр хилийн цэргүүд рүү дайрах агаад шинэ довтолгоонд бэлтгэж, Жанжин сүмийн гол дуганы үүдэн дээр өлгөсөн луу шиг хүчээ бөөгнүүлж байлаа. Авдар нуурын суурингаас арван хэдэн машин гарч, Хайлааст голын зүүн салаа, Номон Хан, Бүрд-Овооны баруун өмнө байгуулсан штабын байрыг чиглэн хурдлахад замын тоос тэнгэр өөд хуйлран манарсаар алсад замхрахыг ажваас үүлэн лууны бие салхины аясаар сэмрэн сарних лугаа адил аа.

Квантуны армийн 23 дугаар дивизийн явган цэргийн хорооны дарга нарыг штабын байранд дэд хурандаа Фузива, Ёкуванита, Азума нар угтав.

Дэслэгч генерал Ямагататай хамт өндөр гооргор нуруутай, гурингатсан тэмээ шиг хөхөвтөр царайтай нэгэн хурандаа ирснийг ажиглавал Азумаад танил юм шиг санагдана. Гэвч тэрээр хаана, хэрхэн уулзсанаа үл санана. Ямагата штабын газар байранд орж ирээд гадуур хувцсаа тайлсан даруйдаа вандан ширээний дэргэд очиж зогсоход удирдах ажилтангууд генералыг тойрч номхон зогсоно.

- Гакка Комацубара сан, бидний ажиллагаатай танилцаад онцгой найдвар тавьж байна. Ойрын үед тухайлбал ням гариг гэхэд Халх голын цаад хэсэгт монголын цэргийг бүслэн цохиж, Баян Цагааны нурууг эзлэх бэлтгэлийг хангасан байх тушаал өгсөн. Иймээс эрхэм дээдсийн тушаалыг хэрхэн биелүүлэх талаар саналаа ярилцана. Та бүхний саналд түшиглэж ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан шинэ давшилтын төлөвлөгөөг боловсруулна гээд Халх голын наад хэсгийг хэрхэн эзлэх тухай ярилаа. Ямагатагийн яриаг дууссаны дараа Азума, үүргийнхээ дагуу ярих боллоо. Тэрээр байлдааны тагнуулын отрядыг удирдаж байгаа болохоор гадаад монголын цэргийн байрлал, хүчний талаар танилцуулах ёстой ажээ.

- Халх гол ихээхэн үертэй байгаа боловч уржигдраас эхэлж 6 дугаар дивизийнхэн гол гатлах гэж оролдсоор байна. Түрүүчийн сумангууд Талын манхан хавьд ирсэн. Одоогоор манай хоёр хороо хориглон байлдаж, монголчуудад ихээхэн хохирол учруулж байгаа. Манай отрядын хэдэн суман Хайлааст манхан, Элст манханд байгаа. Иймээс манай цэргийн хоёр хороог зэвсэг, техникийн хүчээр сэлбэж, 6 дугаар дивизийн тэргүүн ангийг бүслэн устгаж, хилээс Халх гол хүртэлх газрыг бүрэн эзэлж, Халх голын наад хэсэгт ар талаа бэхжүүлэх нь ашигтай. Бид нөгөөдөр гэхэд довтолгооноо амжилтанд хүргэхгүй бол 6 дугаар дивизийн бүрэлдэхүүн

голын наад талд гарч ирээд байрлалаа бэхжүүлж амжина. Иймээс бид хамаг хүчээрээ даруй довтолж өрсөх нь чухал!

Ямагатагийн хийлгэсэн энэ хурал гурван цаг үргэлжилж, бүх дарга нар өөрийнхөө саналыг дэлгэрэнгүй ярилаа. Тэгээд «бүслэн цохих» саналыг бүрэн дэмжив. Ямагата, дарга нарын саналыг нэгтгэн дүгнэж яриад шинэ довтолгоог хэрхэн хэрэгжүүлэх талаар зураг дээр зааж ярихыг ажвал Комацубарагаас тодорхой чиглэл авсан нь илт байлаа.

- Ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан шинэ довтолгоог Хайлаастын зүүн талаас Шилийн худгийн овооны баруугаар 64 дүгээр хороог оруулж, Хайлааст манхнаас Такайса өндөрлөгийн чиглэлд байрлах

хэрэгтэй. Харин 12 дугаар морьт хороо нэмэгдэл хүч болж хавсарна. Хайлааст голын баруун чиглэлээр манай морин цэргийн 8 дугаар хороо, баргын морин цэргийн 1,7 дугаар хороодын тэргүүн хэсэг, мөн моторжуулсан суман оролцохын зэрэгцээ Хайларт байгаа нисэх онгоцны 12 дугаар отрядаас дайрагч, бөмбөгдөгч онгоцууд ирж Долоон нуурын буудалд байрлаж манай ажиллагаанд оролцоно гэж довтолгооны цэрэг зэвсэг, хүчний талаар тодорхой ярихыганхааралтай сонсож суусан Азума сэтгэлдээ «Довтолгооныг амжилтанд хүргэх гэвэл ийм л хүч гаргах ёстой доо. Тэгэхээр 3000 орчим цэрэг, 18 их буу, 75 пулемёт, 10 хуягт, 30 онгоц оролцоно гэсэн үг!» гэж бодлоо. Азума ингэж бодоод өврийнхөө дэвтэр дээр тэмдэглэсэн хороо ангиудын цэрэг зэвсэг техникийн хүчийг байлдааны үеийн шинэчилсэн орон тоонд тулгуурлан тооцоолж, морин цэрэг 900, явган цэрэг 1800 гэж бичээд онцгой тэмдэг тавилаа. Ямагата ярианыхаа эцэст,

- Та бүхэнд чиү жёо Доихарагийн армийн (5 дугаар арми. Энэ арми нь 30 дивизтэй бөгөөд түүний 20 дивиз нь алс дорнодын хилийн дагуу байрлаад тусгай тушаал хүлээж байгаа) тагнуулын хэлтсийн дарга Симото саныг танилцуулъя гэхэд Азума, өнөө хөх царайтыг хаана үзсэнээ сая санажээ. Азума сар гаруйгийн өмнө Хайларт ирэхдээ, Харбин дахь японы цэргийн төлөөлөгчийн газраар дайралдаж Комацубаратай уулзаж байсан Симотоог танилаа. Комацубара Симотоог магтаж тэр үед «Монголын асуудалд мэргэжсэн, Халх голын сав газрыг арван хуруу шигээ мэддэг шилдэг туршлагатай тагнуул» гэж байсныг санасан Азума «Энэ эр... халууны тэмээ шиг хөх амьтан миний дарга болдог байж дээ. 23 дугаар дивизийн тагнуулын хэлтсийн ажилд туслах тусгай зөвлөх ирнэ гээд байсан. Тэгэхээр тэр зөвлөх энэ болж таарлаа» гэж агаархуу бодлоо.

- Халх гол руу довтлох манай шинэ төлөвлөгөөний дагуу тавдугаар армийн техникийн ангиуд тусална. Түүнээс гадна Халх голын дов толгодыг сайн мэддэг хүн манай ажиллагаанд оролцож байгаа нь бидэнд тун завшаантай хэрэг. Манай шинэ довтолгооны хүчийг улааныхтай харьцуулбал одоогоор бид явган цэргээр 2,5 дахин, морьт цэрэг 3,5 дахин, танк эсэргүүцэх буугаар 1,8 дахин, пулемётоор 1,8 дахин их байгаа гэж үзэж байна. Гэхдээ бид Халх голын цаад талын Баян Цагааны нуруунд улаан оросын ямар хүч байгааг мэдэж чадаагүй байна. Тиймээс Азума сан, танай тагнуулын отряд Хайлааст голын бэлчрээр очиж, Баян Цагааны нуруунд улаан оросын хүч ирсэн эсэхийг тогтоохын зэрэгцээ Талын манхан хийгээд Ооны манхан болон "Талын нуур"-ын чиглэлд ямаршуухан хүч байгааг мэдэж нөгөөдөр орой гэхэд надад илтгэх хэрэгтэй гэж хатуухан тушаахад Азума, хээрийн штабаас гарч өөрийнхөө тагнуулчид дээр ирлээ. Тэрээр тагнуулчдаа гурван хэсэг болгон, ажлын

удирдамж өглөө.

- Нэгдүгээр хэсэг, чиү и (дэслэгч) Тагама удирдан хил давж, Халх голын эрэг хавьд ямаршуухан хүч байгааг мэдээд тагтаагаар холбоо барина. Хоёрдугаар хэсэг Хайлаастын баруун талаар хил давж Элсэн уулын зүүн талаар байгаа хүчийг мэдэж амьд хэл барьж ирэх болно. Гуравдугаар хэсгийг Иосито удирдана. Та нар Хайлааст голыг уруудан Халх гол Хайлаастын бэлчирт хүрээд Баян Цагааны нуруунд оросын цэргүүд ирсэн эсэхийг мэдээд, орос цэрэг ирсэн бол байрлалын тойм хийж ирнэ. Мэдээгээ тагтаагаар явуулаад Такайса өндөрлөгт байгаа өөрийн хүчтэй нийлээд утсаар байдлыг дэлгэрэнгүй илтгээрэй гэж тушаав.

Тавдугаар сарын 25-ны Пүрэв гариг. Квантуны армийн 23 дугаар дивизийн тэргүүн ангиуд Халх гол руу цөмөрч дайн эхэлснээс хойш хоёр долоо хонолоо. Монголын зургадугаар дивизийн хоёр хорооны дөрвөн суман, хилийн отрядынхантай нийлж, дээд удирдлагын өгсөн үүргийн дагуу гол хүчээ иртэл японы цэргийн хүчийг Халх голын цаад эрэг дээр барьж байх үүргээ нэр төртэй гүйцэтгэж, самурай нарыг Баян Цагааны нуруу руу алхуулсангүй. Гэвч япончууд давуу хүчээ ашиглан Халх голын цаад талд байгаа зарим газрыг хориглон хамгаалсаар байлаа.

Иоситогийн хэсэг Номон Хан, Бүрд-Овооны чиглэл, Хайлаастын зүүн талаар голоо уруудан явсаар шөнө дунд өнгөрч байхад Такайса өндөрлөгийн чиглэлд ирж амарлаа. Иоситогийн хэсэг наймуулаа. Тэдний ихэнх нь шинэ цэргүүд байлаа. Иосито Халх голд ирснээс хойш арван удаа тагнуулд явахдаа хоёр удаа бүслэгдэж азаар амьд мэнд мултарсан. Энэ хугацаанд тэрээр арван таван цэргээ алджээ. Тэгээд зогссонгүй хэд хоногийн өмнө тагнуулд явж бүслэгдээд амь алдахын даваан дээр долоон самурайн буянаар өөрийгөө аварсан билээ. Тэрээр өчигдөр бэлтгэлээс ирсэн таван цэргийг нэмж авчээ. Иосито, таван цэргээ харахаас дургүй нь хүрч «Ийм доожоогүй амьтад яаж тагнуул хийнэ дээ» гэж унтууцан бухимдана. Гэвч Иоситогийн энэ бодсон бодол алдас байжээ.

Тагнуулын хэсэг нар битүү байхад Халх гол, Хайлаастын бэлчирт иржээ. Өглөөний манан голын хөндийг бүрхэн, улаанаараа эргэлдсэн Халх гол шуугин хүрхэрч урсах сонин. Баян Цагааны нуруу руу дурандсан авч юу ч үл харагдах агаад ямар ч анир чимээгүй нам гүм ажээ. Халх голын зүүнээс өглөөний сэрүүн чийглэг салхи сэнгэнэж, Иоситогийн нүүр рүү сэрүү татуулан сэтгэлд тааламжтай. Мөч хором өнгөрөх тусам өглөөний цагаан гэгээ улам тодорч зүүнээсээ асар том улаан нар мэлтийн өөдөлж, өглөөний өтгөн мананд умбасан Баян Цагааны нуруу нам гүм бараантан сүүтгэнээд голын хөндий дагуу нил ногоон хивс дэлгэсэн мэт ногоорон цэнхэртээд өглөөний манан дунд сэтгэл татахуйц сонин харагдана.

- Баян Цагааны нуруунд торойх ч бараа алга. Тэгэхээр улаан цэргийн хүч ирээгүй нь илэрхий. Халх гол ч ёстой хөөсөөрөө цахран орсон буур шиг сүртэй байх шив дээ. Монгол буур гэдэг аймаар амьтан орооныхоо үед толгой түрүүгээ хөөсөөр будаад сүртэй байдаг юм гэсэн. Бодвол хөөсөөрөө тургин хүрхэрсэн Халх гол шиг байдаг байх. За одоо буцъя. Такасай өндөрлөгт манай сумангууд байгаа. Тэнд очиж амраад шөнө ирж маргааш үүр цайтал байдлыг ажиглая гэж хэлээд морьд дээрээ ирж, эмээл олмоо чангалаад дөрөөлөв. Иоситогийн хэсэг Халх голыг хэсэгхэн уруудаж голын бургаснаас гарч Хайлааст манхан руу эргэтэл манхны зүүн талаас морьтой монгол цэргүүд гарч ирээд нэгэн ганга даган Иоситогийн хэсгийг амдах янзтай явааг харсан нэг шинэ цэрэг,

- Чиү и, зүүн талаас монгол цэргүүд гарч ирлээ. Биднийг ажигласан бололтой амдлаа. Одоо тэр ганганы цаагуур орчихлоо. Бид зугтахгүй бол амьд гарахгүй шүү. Бараг гурван тасаг цэрэг байх шиг байна гэхэд Иосито, шинэ цэргийн заасан зүг дурандлаа. Түүний үг үнэн ажээ. Иосито байдлыг ажвал голоо даган бургасан дундуур явж монгол цэргийн хударгаар ороод араар нь тойронгуутаа Хайлааст манхан руу морьдын хурдаар зүтгэвэл амьд гарч Такасай өндөрлөгт хүрэх байлаа. Иймээс Иосито голын бургасыг даган нэлээн яваад Такасай өндөрлөгийн эгц ар тушаа хойноосоо цуварсан элсэн толгодыг ажиглан дурандвал тэр хавьд бүртийх ч бараагүй аж. Иосито дурангаа нүдэндээ барьсаар «Монгол цэргүүдийн хударгаар орж дөнгөлөө. Тэд биднийг хараагүй учраас өнгөрөөд явчихлаа. Одоо морьдынхоо хурдаар тэр харагдаж байгаа ганга руу орчихвол цуварсан гурван толгодын цаад талаар ороож өгсөөд Такасай өндөрлөг дээрх цэргүүд дээр очиж болно. Бидний араас нэхэж хөөлөө ч гэсэн эд нар гүйцэхээсээ өнгөрсөн юмдаг» гэж бодоод,

- За одоо морьдынхоо хар хурдаар тэр харагдаж байгаа ганга руу орвол болох нь тэр гээд хэсгээ удирдан бургаснаас гарангуутаа өөрөө цэргүүдийнхээ ард үлдлээ. Иосито, бургаснаас гарч зүрхэлсэнгүй. Тэрээр сүсэгтэй болохоор «хүний сэтгэлд мөнх» байдаг совиндоо захирагдсан төдийгүй японы армийн бага, ахлах дарга нарын дунд хэвшсэн дадал зуршлын дагуу үлджээ. Япон бага дарга нар цэргээ уриалан түрүүлэх дүр үзүүлээд өөрснөө хойно нь хоцордог номтой. Энэ бол дүрмэнд заагаагүй боловч дарга нарын дунд хэвшээд удаж байгаа зүйл. Иоситогийн нүдний доод зовхи жирвэс жирвэсхийнэ. Тэрээр цэргүүдээ ганга хүрсэн хойно бургаснаас гарахаар шийджээ. Тэгэхгүй бол Такасай өндөрлөгийн зүүнээс зугуухан үргэлжилсэн ганга руу мөрөгцөглөсөн намхан эрэг бүхий элсэн довцог сэжигтэй санагдаж, цаана нь юу байгаа бол гэхээс ар нуруугаар нь хүйт оргино.

Бургаснаас гарсан цэргүүд ганга руу орох үед Иосито тэдний араас очих гээд бургаснаас гарахын даваан дээр гэнэт пулемётын богино ээлж тачигнаж гарлаа. Иосито, мориныхоо амыг татан зогсоход ганганы цаанаас цуурайтсан уриан дуу өглөөний агаарт хадаж, морьдын төвөргөөн тодоос тод сонсогдов..

...Биднийг ёстой хийцэллээ шүү. Ихэнх цэргээ бидний дэргэдүүр амдуулсан янзтай өнгөрөөж бидний санааг төөрүүлж, зам хааж отсон цэргүүд рүүгээ явах нөхцөлийг бүрдүүлээд ар хударгаараа оруулдаг байна шүү. Тактикийн ийм уран арга хэрэглэнэ гэж хэн санах. вэ? Гэхдээ миний зөн мэдэж байсан учраас амьд үлдлээ... Иосито, ингэж бодоод бүсэн дэх хавчиг савтай архиа гаргаж ухаан жолоогүй балгаад Халх голын бургас руу орж жаахан өгсөв. Гэтэл Хайлааст голын цаад руу Такасай өндөрлөгийн хавьд пулемёт их бууны нүргэлэх чимээ сонсогдсонд «манай хэсгийн хэдээс амьд гарсан хүн байгаа болов уу?» гэж бодтол зүрх нь зогсчих шиг боллоо. Иосито морин дээрээсээ бууж нэгэн хонхорт морио хэвгүүлээд дээрээс нь бургасны мөчир овоолж далдлаад нэлээн зайдуу газар нүх ухааж дотор нь оронгуут дээрээсээ мөчрөөр даллан битүүлээд өврөөсөө цаас гаргаж хэдэн үг бичнэ.

...Би Халх голын бэлчирт байна. Бид гурван суман цэрэгт бүслэгдээд байна. Такайса өндөрлөгт бас байлдаан болж, их буу нүргээнтэж байв. Халх гол, Баян Цагаанд оросын ямар ч хүч алга, гэж бичээд богцноосоо тагтаа гаргаж нарийхан хуйлсан бичгээ хөлийн нь бөгжинд шургуулав.

- За ингээд болох нь тэр! гэж Иосито, өөртөө хэлээд төмөр савгай архианаасаа хэдэнтээ

балгаад тагтаагаа өөд нь нисгэлээ. Халх голын өглөөний тэнгэрт хөөрсөн тагтаа, Хайлаастын зүүгээр ороож чигээ олоод нисэн одох тэрхэн үед Иосито архинаасаа хэд балгаад «Эндээ сууж орой болгох хэрэгтэй!» гэж өөртөө сануулан үглэнэ. Иосито архиа шавхаад мөн өчигдөр орой шагналд авсан зуу гаруй граммын багтаамжтай жижиг лаазанд хийж тусгайлан бэлдсэн спиртээсээ жаахан жаахан балгана. Ийнхүү архи, спиртэнд цохиулсан Иосито ухсан нүхэндээ нам унасан тэр үед Хайлаастын зүүн салаанд байгаа штабын тагнуулын байранд Иоситогийн хөөргөсөн тагтаа иржээ. Ямагата, Азумагийн авчирсан мэдээнүүдийг уншаад,

- Тагамагийн хэсгийн мэдээг өгөөч гэлээ. Тэрээр Хайлаастын зүүн хэсэгт гарсан тагнуулын мэдээг харьцуулж үзээд,

- Ёкуванита, тагнуулын мэдээгээр бол Талын манханд монголын цөөхөн цэрэг байгаа юм байна. Халх голоор гарсан цөөн тооны цэрэг Элгэн, Цагаан нуураас Талын манхны чиглэлд хориглон хамгаалж байгаа нь илэрхий. Монголын цэргийн удирдлага Халх голын үер татартал гол хүчээ гаргаж чадахгүй, одоо байгаа хүчээрээ хориглон хамгаалах нь илэрхий боллоо. Тиймээс та, Талын манхан, Өндөр Улаан уулын чиглэлд 12 дугаар морьт хороо, хуягт дивизон, 64 дүгээр хорооны дөрвөн суманг авч Такасай өндөрлөгт байгаа манай цэргүүдтэй нийлээд Баян Цагаан руу хөдлөх нөхцөлийг хангахын тулд Халх голын наад талд байгаа монголын цэргийг бүслэн устгана. Иймээс өнөө шөнө гэхэд Яньху (Цоохор морьт) нуурын чиглэлээр хил дээр хүчээ бөөгнөрүүлээд бэлэн байх хэрэгтэй! Би тантай холбоо барьж жич шийд өгнө! Фузива сан, та өөрийнхөө морьт хороог авч Хайлаастын баруун талд байгаа цэргүүдтэй нийлж манайд ашигтай толгодыг эзлэн авч хилийн цэргүүдийг устгах хэрэгтэй! Ялангуяа Тавиурт, Бойтог манхныг анхаарлаас гаргаж болохгүй! Харин Азума сан, танай тагнуулын хэсэг Ёкуванитагийнхантай Талын манхны чиглэлд гарна гээд байлдааны тушаалыг тайлбарлаад тараалаа.

Ямагатагаас тушаал авсан дарга нар ангиа үдээс хойш хил рүү хөдөлгөж, бямба гаригийн шөнө тусгай шийдвэрээр хил давлаа. Ёкуванита, хоёр салаа хаалтанд гаргаж, Номон Хан Бүрд-Овооны чиглэлээр хил давжээ. Сар саруулхан шөнийн сүүн гэгээ мэлтийн ойр тойрны бараа тод харагдах ажээ. Хоёр хоногийн өмнө дув дугуй байсан сар зүүн талаасаа эмтэрсэн юм шиг таллагджээ. Ёкуванита, цэргээ талын манхны чиглэлд гаргахдаа дэслэгч Фумитогийн салааг хаалтанд гаргажээ. Фумито салаагаа машинд суулгаад Талын манхан руу хурдалсаар манхны баруун урд руу үргэлжилсэн хонхорт машинаа зогсоож хоноглохоор шийдлээ. Тэгээд машин дээрээсээ миномётоо буулгажээ. Чингээд харуул хамгаалалт гаргаж цэргээ амраагаад маргааш нь үүрийн үнэгэн харанхуйгаар Талын манхны өмнө талын элсэн толгодоор хүрээлэгдсэн уужим хонхрын дагуу давшив.

Фумито дурангаа нүдэндээ барьж, элсэн толгодын зүг зовхи хөдөлгөлгүй ширтэхэд Талын манханд монгол цэргүүд байх царайгүй. Явган цэргүүд өндөр ургасан өвсөн дундуур эгнээгээрээ ханаран алхсаар алсад үргэлжилсэн намхан толгой руу ойртоно. Өглөөний гэгээнд шаргал цайвар өнгөөр цайрагнасан элсэн толгод анир чимээгүй манхайн зэрэглэнэ.

Элсэн толгодын зүг дурандаж байгаа дэслэгч Фумито «Энэ элсэн толгодод монгол цэрэг байхгүй бол мөн сайхан аа. Ойр хавьдаа голлох өндөр энэ шүү дээ! Энэ өндөрлөг дээрээс хааш хаашаа 30 бээр газрыг алган дээрээ тавьсан юм шиг хянаж болно» гэж бодож байтал элсэн толгойд ойртсон япон цэргүүд рүү хөнгөн пулемётын гал нээлээ. Япон цэргүүд

өндөрлөгийн зүг гал нээж давшилтаа үргэлжлүүлэхэд Фумито дурангаараа элсэн толгой руу харвал хэсэг монгол цэрэг толгойн ар руу ухарч, морьтойгоо давхилдана. Тэд талыг бүрхэн давшиж яваа япон цэргүүдээс сүрдсэн нь илт байлаа. Монгол цэргүүд хойно хойноосоо цуван морьдын хурдаар зугтаж байгааг харсан Фумито «Ёстой бууны дуу сонсохоороо сүр сүлдгүй болчихдог бололтой» гэж бодлоо. Пулемётын дуу аль хэдийн зогсож, давшиж байгаа цэргүүд явуут дундаа архиа балгаж янжуур татаж байгааг ажвал пулемётчин бас зугтсан нь илт ээ. Омог сүртэй цэргүүдийнхээ барааг харж байсан Фумито манхны оройд ойртож байгаа цэргүүд дээрээ очихоор ачааны машинд суунгуугаа, жолоочдоо,

- Монголын цэргүүд зугтаж орхилоо. Одоо өндөрлөг рүү очъё гэхэд жолооч нь баяр баясгалантай инээгээд,

- Манай мэргэн буудагчид пулемётчинг нь устгачихсан болохоор арга байж уу. Зугтахаас өөр яах вэ? Хүн аминдаа хайртай шүү дээ. Тэгээд ч манайхны мөндөр шиг суманд амьтай амьтан үлдэхгүй байсан нь илт харагдаж байсан гээд машинаа асааж хөдлөхөд Фумито дурангаа урдуураа унжуулан цонхоор цээжээ гарган, хурдаа нэмсэн жолооч эртний нэг дуу аялан жолоогоо зална. Фумито дурангаа авч манхны зүг харвал эхний цэргүүд манханд ойртоход 100 алхам газар үлджээ.

- За ингээд ганц ч хүний гарзгүйгээр энэ манхныг эзэлдэг байж гэж Фумитоог хэлтэл гэнэт пулемётын дуу чихэнд сонсогдож, машины урд талын шил харжигнан бутарч, жолооч нь жолоо руугаа бөхийн унахыг хараад Фумито машинаас үсрэн газар буухдаа хөлөө шагайгаар нь мулт гишгэснээ мэдсэнгүй. Фумито цээжээ өндийлгөн өндөрлөг рүү давшсан япон цэргүүдийн зүг дурандвал цэргүүд нь пулемётын цагирган галд орсон нь илт байлаа. Тэрээр дурангаа чанга барин дурандахад гурван пулемётын шуурган гал японы цэргүүдийг толгой дараалан унагаж байгааг ажвал өвс хадаж байгаа юм шиг. Нэг пулемёт хойноос урагшаа, нөгөө нь урдаасаа хойшоо гурав дахь нь тэр хоёр руу чиглэсэн галыг устгаж байлаа. Энэ бүхнийг ажигласан Фумито, «Энэ гурван пулемёт манайхныг баллах нь ээ. Эдний сум чинь ёстой үхлийн гал камиказе шиг бууж байна. Эд чинь цэргээ ухраасан дүр үзүүлж толгой давуулж давхиулаад биднийг мэхэлчихсэн байна. Эд нарт ийм муухай заль яаж заяадаг байнаа. Манай салаа лав өнгөрлөө. Ингэхээр салаагүй болсон дарга амьд үлдэх ёсгүй. Одоо Ёкуванита намайг өчиггүй буудна. Хүний гарт үхэх хэрэг үү?» гэж бодтол хажууд нь хэвтэж байсан нэг цэрэг хахир муухай дуугаар орилон баруун гараа барьсаар босон харайсан боловч хэд үсрээд газар уналаа.

Тэр цэрэг шархадсандаа айж босоод амиа алджээ. Пулемётын сум аадар бороо шиг шаагьж, газрын хөрс буцалж байгаа юм шиг санагдахын зэрэгцээ амь гол нь тасарч байгаа цэргүүдийн сэтгэл шимшрүүлсэн муухай дуу, ёолон хараах зүхлийн бузар үг, пулемётын зогсоо зайгүй тачигнах чимээн дундаас тод сонсогдоход Фумитогийн сэтгэлд «Яанаа одоо ингээд үхчихнэ үү?» гэдэг бодол төрж, эчнээд айдас хурна. Гэтэл хаанаас ч юм бэ үл мэдэгдэх газраас их буу нүргэлж, манхны зүг давшин байлдаж байгаа цэргүүд дээр их бууны сум дараалан тусаж, газар доргин, дарь хүхрийн эхүүн үнэр ханхалж, газар тэнгэрийг холбосон шороо тоос харанхуйлаад сэтгэлд аймшиг төрүүлнэ,

...Одоо буцаж очиж болохгүй! Бас амьд олзлогдож болохгүй. Улааны гарт үхсэнд орвол өөрийнхөө гараар өөртөө сеппуку үйлдсэн дээр гэж бодтол хамаг биеийн хөлс чийхарч,

нулимс нүдэнд нь цийлэгнээд ирлээ.

...Салаагаа алдсан дарга хүн өөртөө ганц сум үлдээх ёстой. Тэгэхээр одоо гээд гар буу руугаа хартал сэтгэл шимшрээд зүрх хүрсэнгүй. Фумито бүснээсээ когайгаа сугалаад хурц үзүүрээр нь гэдэс рүүгээ хэдэнтээ бүлээд эргүүлэхдээ «Юмия Хатимана... бакани баканий (ямар аймаар юм бэ?)... Бакана ханаси (ямар тэнэг юм бэ?) гэж хахир дуугаар чарлан хоолойгоо хяхтнуулсаар хэдэн мөч өнгөрсний дараа таг дуугүй боллоо.

5 сарын 28-ны өглөөний 05 цаг. Ням гариг. Комацубарагийн удирдамжаар Халх гол руу гурван чиглэлээр дайрахын өмнө японы онгоцнууд товлосон газруудыг бөмбөгдлөө. Фумитогийн салаа монголын цэргүүдэд цохигдон Ёкуванитагийн цэргүүд эвгүйхэн байдалд орж байсан тэрхэн үед Ёкуванита, их бууны батарейнханд тушаал өгснөөр 10 их буу монголын цэргүүд рүү сөгөө авах боломжгүй галлалаа. Их бууны сумны зэвүүн шунгиналт сэтгэл шимшрүүлэм агаад газар тусаж байгаа сумны дэлбэрэлтийг харахад галт уул оргилж байгаа юм шиг бөөн шороо тоос тэнгэр өөд олгойдон шороон хөшиг харанхуйлан татаад нүд ирмэхийн төдийхөнд газарт нэлмийн бууж хонхор газрыг тэгшилнэ. Сум туссан газар галт уулын тогоо шиг гүн цооног нүх харлан үлдэж, цайвар утаа тэр нүхээс суунаглан дарь хүхрийн эхүүн үнэр агаарт сэнгэнэж, газрын хөрсөн дээрх ноднин жилийн хуурай өвс шатаж, галын элч зулай нүүр рүү тургин халуун оргиулахын зэрэгцээ илч нь нэмэгдэж буй нарны халуун шатаад амьсгалах нөхцөлгүй.

Япон цэргүүд монгол цэргүүдийн хориглосон элсэн толгод дээр туссан их бууны сумны тэсрэлтээр тэнгэр өөд цацагдсан газрын хөрсийг хараад нуувчаасаа өндийцгөөн бие биен рүүгээ зааж «Мөн баллаж байнаа. Ийм галын дараа юу үлдэх вэ дээ» гэж хөөрцөглөнө. Харин тэд өөрсдийнх нь дэргэд их бууны сум тусах тэр үед яахаа сэтгэлдээ ч тоймлоогүй болой.

Ёкуванита, дурангаа нүдэндээ ойртуулж буцлан оргилж байгаа галт уул шиг элс, шороо өөдөө цацаж, манхны оройгоос цайвар утаа савсан суунаглаж замхрахыг хараад «Унтарч байгаа галт уул шиг сүртэй байх чинь!» гэж бодно. Чухам энэхэн үед түүний дэргэд зогсож байсан нэгэн дэслэгч хил рүү дурандаж байснаа,

- Тай са доноо (ноён хурандаа) нэмэгдэл хүч ирлээ гэхэд тэрээр эргэн харвал хэдэн зуугаад алхмын тэртээ хонхроос гурван машин цэрэг ирж яваа харагдав.

Цагаан тоос татуулан хурдалж яваа машинууд Ёкуванитагаас гурван зуугаад метр зайтай зогсох тэрхэн үед их бууны сум агаарт шунгинан исгэрсээр өнөө гурван машин дээр дараа дараагаар буух нь тэрээ. Онь холбон буудсан монголын их буучдын сум дараалан дэлбэрэх тэр чимээ чих дүлийрүүлэн хадах хоромхонд машин дээрх цэрэг агаарт цацагдан бутарч, хүний сэг, төмрийн үлдэгдэл шороотой холилдон, газар нэлмийн унана. Их бууны дараалсан дэлбэрэлтэнд Ёкуванитагийн хөлийн улан доороос хүчтэй түлхэх доргилтонд хурандаагийн дотор гэдэс, цээжний хөндийн эрхтэн амаараа гарчих шахан зүрх нь тасраад уначих шиг боллоо. Ёкуванитагийн дотор харанхуйлж чих нь дөжрөн шуугих учраас тэрээр яахаа үл ухааран хий мэгдэж байсан тэр үед их бууны гал сая зогслоо. Их бууны суманд өртсөн японы салаа цэрэг машинаасаа бууж чадалгүй чингэж сүйрэхийг харсан Ёкуванита агаараас унаж байгаа цэргийнхээ хүүр машины тамтгийг хараад балмагдсанаа сая ойлгоод дурангаа авч гурван машин зогсож байсан зүг рүү дурандаад айсандаа ухаан алдах шахлаа.

Саяхан ирж зогссон гурван машин цэргүүдийн хоёр нь агаарт хийсээд үлдсэн ганц машин дээр хүүр болсон цэргүүдийн цус, машины төмөр хашлагын зай завсраар ус шиг олгойдон гоожихыг хараад сэтгэл нь тэр гэх тэмдэггүй эмтэрч харуусна. Ёкуванита ийм юм анх үзэж байгаа болохоор штабт олон жил алба хаасан хурандаа нүдээ тас анилаа.

Их бууны гал зогссоны дараа саяхан утаа савсаж байсан өнөө толгодын зүүнээс хуягтууд гарч ирлээ. Хуягтууд хурдаа нэмэн пулемётнуудаас нь сум азарган бороо шиг шүршиж, хонхор хотгор газар хэвтэн байлдаж байсан японууд босон харайж суманд өртөөд зогссонгүй Ёкуванитагийн зүүгээр хориглон байлдаж байсан цэргүүд арваад хуягтын суманд «хярамцаг» боллоо. Хурандаагийн сэтгэлд аймшиг хурж, хажуу тийшээ харвал тэрээр ойр орчимдоо ганцаараа үлджээ. Түүний дэргэд байсан хоёр бага дарга үхсэн ажээ. Харин хурандааг бурхан тэнгэр далдаас тэтгэсэн болохоор азаар амьд үлдсэн бололтой.

- Одоо эндээс хөдөлж болохгүй. Өндийвөл зогсоо зайгүй галлаж байгаа хуягтын пулемётын суманд өртөнө гэж өөртөө сануулна. Ёкуванита, чингэж бодсоор Азумагийн хэсэг рүү харлаа. Гэтэл толгойн баруун талаар гарч ирсэн хуягтууд Азумагийн хэсэг дээр сумны мөндөр буулгаж байлаа.

Талын манханд ийнхүү сүйрэлд орсон Ёкуванита байлдааны талбайгаас амьд гарахыг хичээж хил рүү мөлхөхийг бодож байсан тэр үед Азума, их бууны суманд онгилогдсон нэг нүхэнд гурвуулаа байлаа. Тэд нүхнээс гарч, өөрсдийг нь чиглэн ирж яваа хуягтаас зам буруулан нэг хонхор руу мөлхөн очтол тэдний хажууд хуягт пулемётын сум мөндөр шиг под под тусаж шороо бужигнуултал Иосито,

- Тай са доноо, биднийг харчихсан бололтой. Одоохон эндээс холдье гээд өнөө хонхроос гарч хил рүү ухаан жолоогүй ухран мөлхөв.

- Чиү и Тагама, тэр үхээрийг одоохон устга! Бид хоёрыг дайсны дунд хаяад өөрөө амьд гарах юм гэнэ дээ гэхэд Тагама, намбу буугаараа буудаж устгаад Азума руу эргэхэд тэрээр түүнийг буудаад,

- Энэ хоёроос хоёр яс салахгүй бол алтан хошуу хүргэнэ. Цэргүүдээ зохион байгуулж чадалгүй ялагдсан гэдэг яланд намайг түлхээд өөрсдөө үлдэхдээ сийхгүй толгойнуудыг ингэж л устгах хэрэгтэй гэж шивнээд ойр тойрноо ажихад Тагама хонхрын ёроолд нугдайн унасан байлаа.

Азума, Тагамааг буудаад байлдааны талбай руу хартал нэг «Эмбехов» хэмээх машин японы хүүрэн дундуур явж байгаа харагдлаа. Гэтэл ойролцоох хонхроос ухасхийсэн самурай гар бөмбөг шидээд өөрөө саван унахыг ажвал буудуулсан бололтой. Гар бөмбөгөнд өртөн шатаж буй машины дэргэдээс хоёр гурван хүн цэргүүдтэй буудалцаж буйг ажигласан Азума тэдэн рүү зүрхэлж буудсангүй.

...Би эндээс буудаж болохгүй. Тэгвэл байраа мэдэгдчихнэ. Манай цэргүүд цөөн үлджээ. Яагаад тэр вэ? Өнөө байлдаж үзээгүй монголчууд чинь эзэн хааны зоригт самурай нарыг ингээд махан овоо болгочихдог хэрэг үү? Ёстой гайхмаар юм...

Азума, чингэж үглээд савтай архиа хэд балгав. Гэтэл гэнэт «Ура» дуун хадлаа. Тэр дуунаар өнөө машинаас холгүй байсан хонхроос хэд хэдэн цэрэг босож гараа өргөж байгааг хараад Азума сандарлаа. Түүний өөдөөс нэгэн хуягт ирж яваа харагдах агаад пулемётын нь амнууд онгойж харлаад Азума руу чиглэсэн юм шиг санагдсанд тэрээр суманд онгилогдсон нүхний ёроол руу нугдайн суухдаа «Ай Хатимана минь» гэж аяархан шивнэв. Их бууны суманд онгилогдсон толгодын шороо тэнгэр газрыг нийлүүлэн бүрхэж, их бууны суманд «сүйрч байсан» монгол цэргүүдийг хараад баярлахдаа айхаа мартсан үед, омог бардам байсан Азума чингэж тэвдэнэ гэдгийг ухаараа ч үгүй. Гэтэл монголчуудын их бууны суманд Ёкуванитагийнхан сүйрч, пулемётын сум, хуягтын довтолгоонд хиарсан цэргүүдээ нүдээр харсан Азумагийн учир утгыг сая гадарлав. Үхчих вий гэдэг бодол яах ийхийн зуургүй толгойд нь бууж, хайран амиа ингээд алдах уу гэдэг бодол сэтгэлд харван орж ирэхэд л айдас хүрдэг ажээ.

Азума айж балмагдсандаа болоод хичнээн хугацаагаар нүхний ёроолд хэвтсэнээ мэдсэнгүй. Нэг мэдэхэд буун дуу намдчихсан байлаа. Азума айж гайхсан нүдээр орчноо ажиглан нүхнээс өндийхдөө энд тэндгүй ундуй сундуй хэвтэж байгаа хүүрэн дунд ганцаараа үлдсэнээ мэдэв. Мэлийсэн уужим талыг өглөөхөн бүрхээд хар шоргоолж шиг оволзож байсан цэргүүд цөмөөрөө хүүр болжээ. Азума шөнө болгож байж хил рүү дөхөхөөс гэж бодсон атал бас айдас хүрнэ. Энэ удаа тэрээр үхнэ гэж айсангүй. Азума, синто ёсны шашинд бишрэмтгий болохоор энэ олон цэргийн сүнс шөнө өндийнө гэхээс айж байлаа. Чухам энэхэн үед ард нь хөлийн чимээ гарах шиг санагдсанд давхийн цочихдоо гэдрэгээ харвал намхан бор залуу Азума руу бар шиг үсрэн дүүлэх нь тэрээ. Бужгардуу халимагтай залуу эр Азумааг барьж авангуугаа бөх хүн шиг нэг хөлөөрөө баруун хөлийг нь ороогоод хамаг байдаг чадлаараа гэдрэг нь дарлаа. Азума газар ойчихгүйн тулд махлаг цулцгар гараараа өнөө залуугийн халимгаас зуурч гэдрэг нь угзарлаа. Гэтэл монгол залуу тоосон шинжгүй. Чухам энэ үед Азума залуугийн улаан нүүрэнд буулгав. Чингэтэл буун дуу Азумагийн чихэнд сонсогдож, хамаг биеийн нь чадал шавхран сулраад явчихыг гадарлаад «Үхэх гэдэг чинь ийм амархан хэрэг үү» гэж амандаа шивнэн байдаг чадлаараа орилоод амьсгаа тасарлаа.

...Азума чингэж нас барахаас хоёр хоногийн өмнө Иоситотой Хайлааст голын бэлчирт тааралдаад Ямагататай холбоо барьж «Халх Хайлаастын бэлчирт ганц ч цэрэг алга» гэж илтгэж билээ. Чингээд Халх голоор гарч ирж магадгүй орос, монгол цэргүүдийг амдуулан хэдэн суман цэрэг явуулсан юм. Чухам тэр өдрийн үдээс хойш улаан армийн танкийн 11 дүгээр бригадын сапёрын хоёр суман Халх голд цутгадаг Хайлаастын бэлчир хавьд гүүр тавьж өнжсөнийг Азумагийнхан анзаараагүй юм. Шөнө Хайлаастын бургасанд нуугдаж хоносон япон цэргүүд үүрээр хоёр голын бэлчир рүү хөдөлсөн билээ. Тэднийг Хайлаастын адагт ойртож байтал Долоон нуур дахь японы нисэх онгоцны буудлаас хөөрсөн онгоцнууд Халх голыг уруудан нисэж ирээд гүүр тавьж байсан улаан цэрэг рүү бөмбөгджээ. Голын бэлчирт хаясан бөмбөг усанд тусахад Халх гол тэнгэр өөд оргилон голын бургас үндсээрээ суга үсрэн дээр гэгч нь шидэгдээд навч нахиагаа бут гөвсөн мөчирний үйрмэг бороо шиг шаагин бууж байлаа. Голын эрэг дагуу бөмбөгдсөн онгоцны дараагаар Хайлаастын зүүн эргээс японы пулемёт зогсоо зайгүй шүршиж, суман мөндөр буулгав.

Ахмад Кабано, эрэг дээрээс дурандаж байтал нэг шар толгойтой орос баруун гар талдаа байсан японы пулемётчинг устгаад (гар бөмбөгөөр) өндийх тэрхэн зуур нөгөө талаас боссон

нэг самурай түүн рүү дайрахыг харсан Кабано «Ингэж л байлдах ёстой доо» гэж хэлээд дурангаа нүднээсээ салгаад хартал өнөө орос япон цэргийг жадлан устгаад ойрхон байгаа цэрэг рүү буугаа шагайж байлаа.

...Энэ чинь хүн биш ёстой биелсэн чөтгөр байна даа. Манай хоёр цэргийг яах ийхийн зуургүй устгачихлаа. Ганц орос гурван цэргийг устгаад байвал... Үгүй ээ... Ингэх ёсгүй.

Кабано ингэж үглэтэл түүний дэргэд байсан мэргэн буудагч,

- Тай и ши (ноён ахмад аа)одоо ухрах хэрэгтэй! Эд чинь улаан галзуу амьтад байна. Цаанаас чинь монгол цэргүүд гараад ирлээ гээд гараас нь угзарлаа. Чухам энэхэн үед монгол цэргүүд ура хашгиран давшилтанд орлоо. Хөнгөн пулемёт барьсан нэг монгол цэрэг ойр хавийнхаа япончуудыг шүршин устгах агаад толгойгоо боосон боолт нь цусандаа нэвтэрч, шингэн ягаан цус хацрыг нь даган урсах атал тоосон шинжгүй. Тэрээр шархандаа галзуурсан бух шиг урагшаа зүтгэсээр өнөө оросын дэргэд иртэл цаадах нь түүнийг тэврэн авлаа. Кабано хонхорт хэвтээд чингэж дурандаж байхдаа «Одоо энд удаж болохгүй» гэж шивнээд хажуугийнхаа хонхор руу мөлхөв. Монгол цэргүүд шөнө тавьсан гүүрээр гарч ирсэн нь илт ээ.

Эзэн хааны төлөө амиа өргөх юм уу эсвэл ялалт байгуулж монголд эзэмшил газартай болж амьдралын жаргалыг эдлэхийг хичээсэн самурай нар зогссон газраасаа ухрах янзгүй байлдсаар амиа алдана. Нэг самурай хөлөө тас буудуулсан атал үхсэн самурайн хүүрийг түшин сууж монгол орос цэрэгтэй буудалцана. Тэрээр цээжээрээ шархадсан атал «Банзай...тэнно банзай» гэж муухай дуугаар хашгираад хажуу тийшээ унав.

Өглөөнөөс хойш чингэж байлдсан Кабаногийн тусгай отряд, 64 дүгээр явган хороо Хайлаастын зүүн талд байгаа Такасай өндөрлөг рүү арга буюу ухарлаа. Гэтэл Такасайд байсан японы цэрэг өнгөрсөн шөнө монгол цэрэгт цохигдоод ухарсан болохоор замдаа монгол цэргийн томоохон хүчтэй тулгарч байлдсан болой. Оройн нар жаргах гэж байхад Кабано болон 64 дүгээр хорооныхон Такасай өндөрлөгийг дахин бүсэллээ. Өндөрлөг дээр цөөн тооны хүн үлдсэн нь илэрхий байлаа.. Гэсэн ч хүнд пулемётын дуу үл тасарна. Довтолгооны сиймхий харан ухарч гарсан Кабано, мэргэн буудагчаа дуудаад,

- Тэр хүнд пулемётчинг устга гэхэд мэргэн буудагч Кабаногийн дэргэдээс мөлхөн холдлоо. Тэрээр пулемётчингийн баруун талд гарч хажуу талаас нь буудаж устгасан учир японы давшилтыг саатуулж байсан хүнд пулемётын дуу зогсов. Кабано дурангаа энгэр рүүгээ унжуулан судгаас гараад «Банзай» гэж хашгиртал цэргүүд нь давшилтанд орлоо. Гэтэл өнөө хүнд пулемёт дахин шүршиж гарлаа. Кабано үсэрч харайсаар нэг судагт ороод амьсгаагаа жаахан дараад өнөө хүнд пулемётын зүг дурандтал цамцныхаа баруун ханцуй, энгэр хэсгийг ураад мөрөө боочихсон дарга бололтой нэгэн орос, өнөө хүнд пулемётоор шүршиж байлаа. Кабано дурангаа барьсаар «Мэргэн буудагч яав аа. Алуулчихсан юм байх даа» гэж амандаа шивнээд дурангийнхаа харааг тааруултал савхин хувцастай дарга бололтой нэг монгол хүн, өнөө орос дээр ирж пулемётыг нь аваад хэдэн юм хэлж гараараа зангатал өнөө орос холгүй байгаа морио авчраад өнөө монголдоо өгөх гэж оролдож байгаа нь дуранд тод харагдана. Чухам энэхэн үед япон цэргүүд «Банзай» хашгиран өндөрлөг рүү дайрч эхлэхэд өнөө пулемёт дахин тачигнасангүй. Кабано судгаас гарч урагшаа гүйлээ. Япон цэргүүд манханг бүсэлж, их буу миномётоор зогсоо зайгүй галлалаа. Монголын цэргүүд хүчтэй галын сиймхийг олж

ухарсан болохоор япончууд эзгүй өндөрлөг рүү сумаа гарзаджээ. Кабано өндөрлөг дээр гарвал өнөө монгол орос хоёрыг хайсан боловч олсонгүй. Гэхдээ манхны зүүн талаас шинэхэн савхин дээл өмссөн, тас хар савхин гутал нь элс шороотой, цусанд будагдсан гуч орчим насны нэг хүнийг барьж, Кабаноод авчирч тушаалаа.

Өлөн бүргэдийн нүд шиг хорсолтой гялалзсан гурвалжин нүдний хурц харцаар Кабаноог нэвт ширтсэн монгол эр, амандаа улаан өнгийн алчуур зуусныг ажвал хэгз цохиулсан уруулынхаа цусыг тогтоох гэсэн бололтой. Тэр алчуур цусандаа нэвтрээд өнгө ялгагдахгүй болжээ.

- Ноён ахмад аа, энэ залуу, орос даргаа оргуулаад өөрөө хэдэн хүмүүстэй үлдэж манай олон цэргийг устгалаа гэхэд монгол эр зүүн шанаагаараа урссан цусыг тоосон шинжгүй зогсохыг хараад Кабаногийн уур шатлаа. Тэрээр намбу бугаа сугалаад,

- Танай орос дарга хаачсан бэ? гэж асуулаа. Кабано орчуулагчгүй яваа болохоор шархадсан монголтой хэл нэвтрэлцэхгүй гэдэг илэрхий аж. Кабано монгол эрийн гадаад байдлыг харахад бардам, эрэмгий шазруун болохыг ажиглаад уур омог нь бадарч, хорсохын эрхээр тархийг нь шүргүүлэн буудаж зоригийг нь мохоохыг хичээв. Шархадсан эр алчуураа алдахгүй гэсэн юм шиг тас зуусан тэр чигээрээ үл хайхран зогсоход Кабаногийн уур бүүр шатаж дахин буудлаа. Кабано яаж буудсанаа ч мэдсэнгүй. Харин монгол залуу биеийнхээ тэнцвэрийг алдаж, газар унахгүйг хичээсэндээ биеэ барьсан боловч алгуурхан ойчсоноо дахин босож ирээд хэсэг зогсож биеэ тэнцүүлснээ Кабано руу ямар нэг юм хэлэх шиг болж дайрах гэтэл хажууд нь зогсож байсан нэг цэрэг түүнийг буудлаа.

Өглөөнөөс шөнө дүл хүртэл үргэлжилсэн байлдаанд япон цэргүүд их сульдсан ажээ. Нэргүй өндөрлөгт (Такасай)байрлаж байсан монгол цэргийн штабыг эзэлсэн япон цэрэг хориглолтонд орж харуул хамгаалалт гаргаж байсан тэрхэн үед Кабаногийн туслах гаднаас орж ирлээ.

- Та и Кабано сан, оросын нэг тагнуулыг барилаа гэхэд гаднаас орж ирсэн Фумива байлдааны явцтай танилцаад,

- Та и, чи өөрөө очиж тэр оростой ярилц. Халх голын гармаар орос, монголын ихээхэн хүч гарч ирсэн байна. Олзлогдсон тагнуулыг байцааж тодруулах нь чухал! Манай орчуулагчийг аваад яв. Одоохон очихгүй бол цэргүүд мөч мөчөөр нь таслаад хаячихна шүү гэж тушаалаа.

Кабано тэр дороо туслахаа дагуулан манхны зүүн талын нэг ганганд иртэл дөрвөн машины гэрэл асаачихсан салаа цэрэг өнөө оросыг «талхалж» байлаа.Цэргүүд цөмөөрөө согтуу болохоор баригдсан орос цэргийг үг хэлэх тэнхээгүй болгожээ.

- Цэргүүдээ наад оросоо амь голтой дээр нь мөчийг нь тэлээд машинаас уячих гэж нэг согтуу цэрэг санал гаргаад машиныхаа ар руу очив. Гэтэл нэг цэрэг өнөө орос руу ойртон очоод түүнийг барьж авгал өнөө орос яах ийхийн зуургүй согтуу цэргийг өшиглөн унагалаа.

- Яасан их шартай, зоригтой эр вэ? Наадахынхаа цээжин дээр өнөө таван хошууг сийлээч! Тэгвэл ёстой цусандаа будагдсан цусан таван хошуу болно доо гэж бас нэг цэрэг хашгирлаа. Гэтэл өшиглүүлсэн цэрэг газраас өндийгөөд гараа ардаа хүлүүлсэн орос цэргийн цээж рүү

когайгаа дүрлээ. Орос цэрэг тэнцвэрээ алдаж дайвснаа биеэ тэнцүүлж зогсоод шазуураа зуув. Гэтэл гурван согтуу самурай түүнийг барьж авч газар унагаад өөд нь харуултал хоёр самурай барьж байсан когайгаа хоёр хөлийн булчинд дүрж газартай хадав. Тэгээд тэд цээжийг нь дартал түрүүн өшиглүүлсэн самурай когайгаа барьсаар дэргэд нь ирж, цээжин дээр нь сандайлж суугаад таван хошуу сийлэв. Хутган когайн ирээр зурагдсан мөрөөр цус шүүрч цээж нь улаан нэлий болоход самурай нар бахаа ханатал инээнэ. Кабано, орос цэргээс ямар ч өчиг авч чадахгүй гэдгээ мэдээд нэг самурайгаас когайг нь аваад,

- Та нар хойшоо бол! Одоо наадахын чинь толгойг улаан болгоно гээд ханцуйгаа шамлан дэргэд нь иртэл гэнэт гар бөмбөг дэлбэрч япон цэргүүд чухам юу болсныг ухаарч амжилгүй амиа алдав.

Улаан цэргийн тагнуулыг бариад тамлаж байсан салаа цэргүүдийн дунд тэсэрсэн, баглаж боосон дөрвөн гар бөмбөгний чимээ шөнийн харанхуйг цочоож, нижигнээд намдсан хойно Нэргүй өндөрлөгийн зүүн ганганд самурай нарын орилон ёолох, хараан гинших дуу үргэлжилнэ. Дөрвөн машины ард суугаад хар тамхи татаж байсан нэг самурай,

- Оросын цэргүүд гэж хашгирсаар Нэргүй өндөрлөг рүү гүйхэд шөнийн харанхуйд сонсогдсон морин төвөргөөн алсад замхарлаа. Үл мэдэгдэх морьтон манхны баруун тал руу давхисаар харанхуйд бараагүй болов.

...Өдрийн тулалдаанд Азумагийн 24 цэргийг буулгаж авсан монгол цэргүүд үлдсэн хэсэгтэйгээ нийлж, бүслэлтийг сэтлэн гарах шийдвэр авсан бөгөөд Нэргүй өндөрлөгийн орчим японы томоохон хүчтэй халз тулалдсан билээ. Японы олзлогдсон цэргүүд өөрийнхөө их буунууд зогсоо зайгүй буудаж байгааг мэдэнгүүт монголын цэрэгт саад хийхийг хичээнэ. Олзлогдсон самурайн дунд Жанжин сүмийн үүдэн дээр тангараг өргөж байсан Арадаки олзлогдсон болой. Элсэн ганга налж хэвтсэн Арадаки, олзлогдсон цэргүүд рүү харж хэвтсэнээ,

- Ганц ч цэрэг, монголын цэргүүдийг дагаж болохгүй! Манайхан ойрхон байна. Эдний ихэнх нь шархдаад хүмүүсээ машинд ачсан төдийгүй танк эсэргүүцэх бууны нь сум дууссан учир моринд хөллөсөн байна. Машины тэвшинд хэдэн пулемёт ачжээ. Иймээс эднийг энд хоргоож өөрийнхөө ангиудыг хүлээнэ. Манайхан одоо ингэсхийгээд давшилтанд орно. Одоо их бууны гал зогсох дөхөж байгаа гэж хэлэхэд цэргүүд Арадаки руу хяламхийсэн харцаар ширтэнэ. Монгол цэргүүд ухрахаар хөдлөхөд нэг цэрэг олзлогдсон цэргүүдийн өмнө ирээд «Бос... Үг дуугүй яв!» гэж байгаа бололтой бугаараа дохино. Арадаки монгол цэргийн үгийг тоосон шинжгүй хэвтэнэ. Гэтэл монгол цэрэг ирээд түүнийг бос гэж байгаа бололтой гараараа зангана.

- Та биднийг аваад явна гэж бодож байна уу? Манайхан одоохон ирнэ. Тэгээд бид та нарыг туух болно доо гээд элс рүү нулимав. Гэтэл өнөө цэрэг бугаа сумлахад Арадаки хэдэрлэв. Гэтэл нэг япон цэрэг,

- Бид нэгэнтээ бууж өгснөөс хойш эдний шаардлагыг дагах ёстой! Бид буцаж очсон ч амиа алдана. Бусидо ёсыг зөрчсөн биднийг очингуут үг өчиггүй буудна. Харин монголчууд баригдсан цэргийг олон улсын гэрээний дагуу олзлогдсон цэрэг гэж үзээд алдаггүй гэсэн.

Тэр үнэн байх. Биднийг алах байсан бол өдөр турш ингэж тууж явахгүй байсан гэхэд Арадаки өнөө япон цэрэг рүү дайрч, түүнийг өшиглөөд,

- Эдний гарт үхсэнээс өөртөө сеппуку үйлдсэн нь нэр төртэй гэтэл,

- Тэгвэл чи, өдөр бууж өгөхийн оронд тархи руугаа сум зоож байхгүй яасан юм бэ? гэж бас нэг цэрэг хэлэв.

Монгол цэрэг Арадакийн мөр рүү зөөлөн түлхэж «Яв!» гэж дохио өгтөл тэрээр өнөө цэрэг рүү дайрч, мөргөн унагаад хажууд нь байсан цэрэг рүү дайртал нэгэн бага дарга түүнийг буудлаа.

Арадаки ингэж хэдэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш. Тэрээр өдрийн тулалдаанд хажуугийнхаа хонхорт байсан тасаг цэрэг дээр их бууны сум тусаж олон цэрэг шороотой холилдон тэнгэрт цацагдахыг хараад сүнс нь зайлчих шахжээ. Тэгээд архиа дууссаныг мэдэнгүүт хоргодож байсан нүхнээс гараад үхсэн цэргүүдийн бүснээс савтай архийг нь авах гэж явсан хойгуур өнөө нүхэнд үлдсэн долоон цэрэг дээр их бууны сум тусжээ. Арадаки үүнийг мэдээд хажуухан талдаа их бууны сум тусах тэрхэн чөлөөнд нэгэн нүх рүү орж хэвтгэл дээрээс хүнд юм хөвсийн буулаа. Арадаки босоод харсан чинь япон цэргийн тал бие түүн дээр унасан төдийгүй толгой нь заадсаараа салах гэж байгаа юм шиг янгинаж, чих нь шуугьж дөжирчихсэн байлаа. Арадаки цэргийн тал биенээс айсандаа муухай хашгираад босон харайж нүхнээс гартал, өмнө нь буу барьсан монгол цэрэг зогсож байлаа. Арадаки, их бууны сум хажууд нь дэлбэрсэн болохоор түүний дэлбэрэлт, доргилт, дээрээсээ буусан шороо, үхдэлээс айгаад маанагтаж орхисон болохоор айсандаа биеэ хурааж нүхэнд нэлээн удаан сууснаа мэдээгүй ажээ. Гэтэл энэ хооронд их бууны гал зогсож монгол цэргүүд давшилтанд орсон байжээ. Арадаки намхан биетэй хүрэн бор царайтай, бужгардуу халимаг нь малгайн доороос цухуйсан нэг залуу, бас өндөр туранхай биетэй, гонзгой царайндаа зохисон хөнхөрдүү царай ухархайндаа шигдсэн хурц нүдтэй, бужгар залуугаасаа гурав дөрөв ах болов уу гэмээр хорин зургаа орчим насны залууд баригджээ.

Арадаки ингэж баригдсанаасаа хойш элдвийг бодлоо. Монгол цэргүүд ухарч явахдаа олзлогдсон цэргээр их бууны дугуйг түрүүлж элснээс гаргалаа. Арадаки энэ бүхэнд унтууцан, өөртөө сеппуку үйлдэх нь дээр гэж бодох атал тийм боломжгүй ажээ. Арадакигийн амьд явах хугацаа дуусжээ. Нээрэн зайлшгүй үхэх хэрэгтэй байлаа. Тиймээс тэмцэж байгаад үхсэн гэж үзэх далим олбол тэрээр алдар нэрээ Токиогийн Ясакуни дуганы хананд мөнхлүүлэх ажээ. Арадаки монгол цэрэгт зүгээр олзлогдож болохгүй гэж бодохын зэрэгцээ буцаж очиж болохгүй гэж бодно. Тиймээс монгол цэргийн уур уцаарыг хүргэвэл түүнийг буудах нь зайлшгүй ажээ. Арадаки ингэж монгол цэрэгт буудуулж үхвэл хожим түүний хүүрийг олно гэдэг гарцаагүй. Тэр тусмаа хүлээтэй хүүр олсон дарга нар түүнийг баатарлагаар тэмцэж байгаад амиа эзэн хааны төлөө өргөсөн гэж тодорхойлоод Ясакуни сүмд нэрийг нь алдаршуулах байлаа. Сүйрлээ ийм замаар цагаатгадаг ёс бол ганцхан Арадакигийн заль биш. Олон дарга нар ингэж өөрийнхөө бурууг цагаатгаж армид үнэнч хүн байсан гэдэг үнэлэлт авдаг болохоор Арадаки тэр л зан заншлыг дагасан хэрэг гэж бодно. Чингээд бусидо ёсоор үхсэн баатарлаг эр болохын тулд чингэж авирласан.

Монгол цэргүүд цаашаа хөдлөөд шөнө болсон хойно ойр тойрныхоо байдлыг мэдэхээр

тагнуул гаргасан байлаа. Тэгээд тагнуулуудаа ирэхийг хүлээж хэсэгхэн түр буудалласныг олзлогдсон цэргүүд андсангүй. Шөнийн тагнуулаас буцаж ирсэн нэг тагнуул, Нэргүй өндөрлөгт болсон хэрэг явдлыг даргадаа илтгээд,

- Хайлаастын дагуу японы цэргүүд алга байна. Хайлаастыг уруудан Дүйнхор овооны араар гарч болох юм гэлээ. Чингээд монгол цэргүүд хөдөлж Хайлаастыг уруудан Дүйнхор овооны араар гарч ирээд Элсэн уулын баруугаар Дүйнхорын манхан, Дүйнхорын тохойгоор япон цэрэг байгаа эсэхийг мэдэхээр тагнуул явуулав. Баригдсан япон цэргүүд их бууны дэргэд сууцгааж байтал нэгэн монгол цэрэг хоол унд авчирч өгөхөд нь дотроо баярлацгаан сарны саруулд идэж байтал нэг монгол дарга тэдэн дээр ирлээ. Чухам энэхэн үед тагнуулд явсан нэг цэрэг ирж,

- Энүүхэнд орос цэргийн анги байна гэж илтгэхэд өнөө дарга,

- Хоёулаа явъя. Надад заагаад өг гээд япон цэргийн дэргэдээс холдсоор бараа нь тасарлаа.

Гурав. Буцалсан элс, улайдмал тэнгэр

Халх голд ялгуусан амжилт гаргахаар Ямагатагийн мэдэлд томоохон хүч хуралдуулсан боловч японы гавшгай хороонууд тэр чигээрээ сүйрээд, самурайн ёсыг чанд сахисан дарга нар байлдааны талбайд сеппуку үйлдэж, үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн буюу хөл тавьсан газраасаа ухраагүй самурай нарын нэрсийн жагсаалтыг гаргаж Ясакуни сүмд мөнхлүүлэхээр армийн дээд удирдлагад Комацубара танилцуулжээ.

Самурайн нэрийг ингэж алдаршуулдаг ёс японы хөрөнгөтний хувьсгал гэгчийн явцад тогтжээ. Цэрэг феодалын байгууллын засгийн газрын нөлөө буурч 1867 оны намар гэхэд эсэргүү хүчнийг толгойлж байсан сёгун Кэйкийг цэрэг феодалын байгууллын засгийн газраас зайлуулах тунхагт 15 настай эзэн хаан Муцухитогоор гарын үсэг зуруулжээ. Чингээд японд феодалуудыг эсэргүүцсэн хөрөнгөтний хувьсгал ялж (1867—1868 он), эзэн хаан Муцухитогийн хаанчлалыг Мэйжи буюу соён гэгээрүүлэгч хэмээн цоллож түүнээс хойш японы нийгэм эдийн засаг, соёл, улс төрийн байгууллыг өөрчилсөн учраас Мэйжи исин буюу соён гэгээрүүлэх шинэчлэлт гэх болсон. Чухам энэ үед феодал, хөрөнгөтний тэмцэлдсэн дажингийн явцад амь үрэгдсэн самурай нарын нэрийг мөнхжүүлэх болжээ. Чингээд Токиод эзэн хааны зарчмыг дэлгэрүүлэх үйлсэд амиа өргөсөн самурай нарыг Ясакуни болон Мэйжийн сүмд нэрийг нь мөнхлөн алдаршуулдаг болжээ.

Комацубарагийн цэргийг Халх голд ялагдсан явдлыг квантуны армийн штаб дээр хэлэлцээд даагаа нэхэх шинэ хувилбар бэлдэж байсан тэр үед гадаадын сонин сурвалжлагчид тавдугаар сард болсон японы цэргийн сүйрлийг «Морин дээрх камиказе буюу морин дээрх үхэл» гэж хочилжээ. Японы армийн генералууд үүнийг овжноор ашиглан Ямагатагийн нэгдэл ялагдсан явдлыг тайлбарлахдаа эзэн хааны армийн цэргүүд «Монгол Зөвлөлтийн» цэрэгт ялагдаагүй гагцхүү үхлийн тэнгэр камиказегийн хүчинд эрсэдсэн гэдэг дүгнэлт гаргаад «Косэйтоку» төлөвлөгөөний хоёр дахь хувилбар «Баян Цагаан сукуйдасу буюу Баян Цагааны аврал» гэдэг ажиллагаанд бэлтгэлээ. Үнэндээ ялагдлаа цагаатгахын тулд жанжин штаб ийм сүртэй төлөвлөгөө үзүүлж түр зуур ч гэсэн сэтгэлээ амраахыг бодсон квантуны армийн энэ «мэхийг» мэдэх хүн цөөн байжээ. Шинэ ажиллагаатай уялдуулж дивизийн бүрэлдэхүүнийг үл ялиг өөрчилсний адилаар хэвлэлийн товчооны орон тоог нэмэгдүүлж тусгай сурвалжлагч нар гаргаж байлдааны шугам руу явуулахдаа Тобавагаар удирдуулж албан үүргийнх нь дагуу түүнийг дэд хурандаа болгожээ. Харин цагийн байдлыг харгалзан Симотоог Комацубарагийн дивизийн тагнуулын удирдлаганд тавьсан төдийгүй Комацубарагийн ажиллагааг хянах үүрэг нууцаар өгсөн ажээ.

Квантуны арми чингэж шинэ довтолгоонд бэлтгэхдээ Халх гол, Буйр нуурт томоохон ажиллагаа явуулж Монгол болон Улаан армийн ар талд цохилт өгөхийн тулд нисэхийн тусгай дивиз байгуулж дэслэгч генерал Моригигаар толгойлуулсан төдийгүй генерал Гигааг удирдлаганд нь оролцууллаа. Армийн удирдлага «Баян Цагааны аврал» ажиллагааг төлөвлөж байхдаа агаарын томоохон тулалдаан зохион байгуулах, армийн ажиллагааг идэвхжүүлэхийн тулд зургаадугаар сарын 20-нд 1532 тоот тушаал гаргаж Комацубараад илгээв. Комацубара уул тушаалыг авангуут нисэх дивизийн дарга дэслэгч генерал Мориги, тагнуулын хэлтсийн дарга Симото хоёрыг дуудлаа. Командлагч тэр хоёрыг орж ирэхэд сандал руу уриад,

- Армийн удирдлагаас шинэ тушаал ирсэн. Шинэ ажиллагааг амжилтанд хүргэх бүх бололцоог тооцоолж үзсэн армийн удирдлага манайд долдугаар дивизийг өгч мөн танкийн 3, 4 дүгээр хороог бидэнд шилжүүлсэн гэхэд Симото дотроо «Тэгвэл Комацубара чинь 38 мянган цэрэг, 160 пулемёт, хүнд их буу 186, танк эсэргүүцэх буу 124, танк, 135, хуягт 10-тай болно гэсэн үг» гэж бодож суулаа.

- Жиү жёо Мори́ги сан, бид шинэ ажиллагааг амжилтанд хүргэх нэг зам бол улаан оросын болон монголын цэргийн гүн ар талд байгаа хүчийг устгаж хохирол үзүүлэх явдал. Тиймээс Тамсаг булаг, Баянтүмэн, Баян Бүрд нуурт байгаа улаан цэрэг, монголын нисэх хүчийг юуны түрүүнд устгасан байх ёстой гэхэд Симото тэдний ярианд оролцож,

- Манайд байгаа мэдээгээр бол Баянтүмэнд улаан оросын И— 15, И—16 гэдэг дайрагч онгоц бүхий хороо буудалласан. Мөн СБ гэдэг бөмбөгдөгч онгоц бүхий хороо ирсэн байна. Эднийг газар дээр нь устгах ёстой юм шүү гэж тагнуулын мэдээнд түшиглэж ярилаа. Чингээд Мори́ги командлагчийн тушаалыг хүлээн авч Халх голын дагуу бөмбөгдөх газрыг газрын зураг дээр тэмдэглэж аваад явлаа. Мори́гийг гарсны дараа Симото,

- Гакка, манай тагнуулын мэдээгээр бол Хужир Цагаан нуураас Гөлөгт манхан Фуйтакаса (Хуруу өндөрлөг) хийгээд Зэгст нуурт монголын томоохон хүч байна. Талын манхан, Такаса́й (Нэргүй өндөрлөг буюу Ремизовын өндөрлөг)-д улаан орос монголын багашигхан хүч байгаа төдийгүй Хайлаастын баруун бие Элсэн уул, Ногоон толгодод эчнээ хүч хориглож байна. Өнгөрсөн дуулианаас үзвэл (5 сарын 28, 29-ний өдрийн ялагдал) оросууд хээрийн их буугаар төдийгүй хуягт тэргээр манайхныг хийцлэх шахсан. Тиймээс дээрх газар байгаа хүчийг Мори́гийн харцагануудаар бөмбөгдүүлэх нь манай шинэ ажиллагааг амжилтанд хүргэх замыг нээнэ.

- Симото сан, энэ талаар би нэлээн юм бодож байгаа одоо Халх голд байгаа дайсны хүчийг үзвэл оросын 149 дүгээр буудлагын хороо, танкийн хоёр батальон, монголын хуягт дивизонууд, хоёр морин хорооноос гадна 8 дугаар дивизийн хэд хэдэн хороо байгаа юм. Харин Мори́гийн харцаганууд Тамсагаас Халх гол хүртэлх цагаан талд улаан армийн ангиудыг устгачихвал Баян Цагааныг яах ийхийн зуургүй авч болно гээд хэсэг бодолхийлснээ,

- Маргааш өглөө Кобояси, Ясуко хоёрыг Жанжин сүм дээрээс дууд гэж тушаалаа.

...Дэслэгч генерал Мори́ги, Комацубарагийн өрөөнөөс гараад туслахдаа «Тусгай тушаал бэлдэж маргааш Долоон нуурт байгаа Гигаад явуул» гэж тушаал буулгажээ. Чингээд маргааш нь Долоон нуурт байсан генерал командлагчийнхаа тушаалыг аваад тусгай төлөвлөгөө зохиолоо. Удирдлагаас өгсөн удирдамжийн дагуу төлөвлөгөө хийж шөнөжингөө нойргүй суусан Гигагийн хүмүүс үүрээр жаахан дугхийж нүднийхээ хорыг гаргалаа. Үд өнгөрч байтал Мори́гийн бэлтгэлээс гарсан шинэ отряд Долоон нуурын буудал дээр ирлээ. Тэднийг хурандаа Каворо ахалсан байлаа. Эд нар хятадад байлдаж байгаад Цицикарьт ирсэн ажээ.

- Тай са, танайд тагнуулын онгоц хэд байна? гэхэд Каворо,

- Бид В-97 онгоц арван хоёртой гэлээ.

- Нисэгчид аль зэрэг туршлагатай вэ?

- Бид ихэвчлэн хятадын уулархаг газар байлдаж, газрын зураг авч байсан удаатай.

- Тэгвэл танайханчинь тагнуулын нислэгхийхдээ туршлагажсан нисэгчид байна. Энэ чинь бүүр сайн. Харин бөмбөгдөгч онгоц хэр зэрэг вэ?

- Манайх голдуу хөнгөн бөмбөгдөгч онгоцтой, сөнөөгч И—96, И—97 онгоцтой юм шүү дээ.

Гига, Моригийн тушаалд дурдсан тусгай нисэх отрядыг хүлээн аваад нисэгчдийн хувийн хэрэгтэй нэг бүрчлэн танилцсаны дараа тагнуулын арван хоёр нисэгчдийг өөртөө үлдээгээд бусдыг нь Иранга нуурын буудалд өгч отрядын даргаар хурандаа Кавороог томилов. Нисэгчидтэй чингэж уулзсан Гига, төлөвлөсөн ёсоор Жанжин сүм дээр очиж Моригийд нисэх бүрэлдэхүүнийг танилцуулав.

- Гига сан, танай ажиллагаа гурван шаттай байх ёстой. Юуны өмнө Халх голд байгаа дайсны их бууны галын цэг хориглолтыг устгах, хоёрт Буйр нуурын район, эцэст нь Баянтүмэн, Тамсагийн район дахь ар талын хүчийг устгах ёстой! Энэ удирдамжийн дагуу өнөө шөнө Кобояси очиж таны төлөвлөгөөтэй танилцана гэснээр тэдний яриа дуусжээ.

Шөнө дүл өнгөрч байхад генерал Кобояси, Долоон нуурт ирж Гигатай ярилцаж түүний ажиллагааг өөрийнхөө төлөвлөгөөтэй уялдуулахыг ажвал өнөө Баян Цагааны аврал ажиллагааг удирдахаар ирсэн нь илэрхий бөгөөд ойрын үед эхлэх нь илэрхий байлаа. Чингээд товлосон өдрөө Гигагийн харцаганууд агаарт хөөрлөө. Японы 120 онгоц Хан-Өндөрийг чиглэн нисээд Зөвлөлтийн 90 онгоцтой Халх голын тэнгэрт тулалдсан энэ тулалдаан хоёр цаг хагас үргэлжилж Гигагийн харцагануудаас 31 онгоц буудалдаа эргэж ирсэнгүй. Энэ өдөр Гига сэтгэл тавгүй өнжиж «Яасан муу ёрын өдөр вэ? Олон онгоцоо алддаг. Мөн тоогүй еэ» гэж бодоод ширээн дээрх хуанли руугаа харвал 6 сарын 22-ны өдөр, пүрэв гариг байлаа. Халх голын дайныг пүрэв гаригт эхэлсэн. Түүнээс хойш 8 дахь пүрэв гариг нь энэ болой. Гига үүнийг мэдэнгүүт тун их сэжиглэжээ. Тавин зургаан хоногийн өмнө японы үлэмж цэрэг монголын хил даваад хилийн харуулын цөөн цэрэгт хийцлүүлснийг бодохоос сэтгэл нь сэрхийж, зэвүүн бодол төрнө. Гига өөрийгөө тайвшруулахыг хичээсэн боловч яаж ч чадсангүй. Чингээд төлөвлөгөө ёсоор Гига, өөрийнхөө харцагуудыг Буйр нуурын чиглэлд гаргаад бас ашиг олсонгүй. Ийнхүү гурван удаагийн агаарын тулалдаанд 60 шахам онгоцоо алдсан Гига уур омогтоо шатаж байсан тэр үед 90 онгоцоор зохион байгуулсан бөмбөгдөлтийг Тамсаг булаг, Баянтүмэний чиглэлд гаргалаа.

Зургадугаар сарын сүүлчээр Тогава нисэх хороон дээр ирлээ. Тэгээд Гигагийн ажилтай танилцахад тэрээр сүүлийн зургаа хоногт 70 гаруй онгоцоо алдсан байлаа. Гэсэн ч Гига Тогаваад байдлыг аятайхан зөв талаас нь танилцуулаад Мориги руу байдлыг илтгэжээ. Харин дэслэгч генерал Гигагийн илтгэлийг «яльгүй давслаад» Комацубараад илтгэхдээ,

- Эрхэм дээдсээ таны өгсөн даалгавар ёсоор манай агаарын дайчид оросын болон монголын хамгаалалтыг бөмбөгдөж, хээрийн нисэх буудлыг устгаж, 25 онгоцыг сөнөөлөө гэж илтгэлээ.

Комацубара, Моригийн илтгэлийг сонссоны дараа Симотоог дуудаж тагнуулын баримтуудтай

танилцлаа. Чингээд 6 дугаар сарын 30-ны орой генералуудаа цуглуулж шинэ ажиллагааны талаар ярилаа.

- Бидэнд «Баян Цагаан сукуйдасу» ажиллагааг эхлэх шийдвэр өглөө. Тиймээс тав хоногийн дотор Халхын цаана байгаа хүчийг устгаад Баян Цагааныг эзэлсэн байх ёстой! Иймээс манай ажиллагааг удирдуулахаар армийн удирдлагын шийдвэрээр дэслэгч генерал Кобояси, Ясуко хоёрыг томилсон. Тиймээс зураг дээрээс болон миний ярианаас холбогдох зүйлийг сайн тэмдэглэж авах хэрэгтэй. Ер армийн штабаас бидний боловсруулсан ажиллагааг бараг өөрчлөөгүй учраас та нар ерөнхий байдлыг мэдэж байгаа. Монголын цэрэг болон улаан оросын хүчинг устгах ажиллагааны гол цохилтыг Кобояси хийх болно. Тиймээс манай цохилтын гол хүч юуны өмнө манай давшилт дайсны баруун хажуугаас эхлэх ёстой. Ингэхдээ Халх голын зүүн эргийн дагуу өмнө зүг рүү дайсныг цохиж, монгол оросын хүчийг баруун эргээс нь таслан зайлуулах ёстой юм. Харин Ясуко, монгол оросын цэргийн баруун хажуугаас довтлохдоо Кобоясигийн хүчийг сэм давшин Халх голын эрэгт хүрч хүчээ бөөгнүүлэн голоор гаргах нөхцөлийг бүрдүүлэхдээ дайсны цэргийн анхаарлыг өөр дээрээ төвлөрүүлэх болно. Тэгээд манай цэргийг Баян Цагаанд гарангуут дайсны цэргийг хажуугаас нь тойрон бүсэлж Кобоясигийн гол хүчтэй хавчин устгах ёстой. Иймээс Кобояси, 71, 72, 26 дугаар явган хороог удирдаж Яньху нуураас Зэгст, Хан Өндөрийн чиглэлд давшиж, Их Бурхантын орчмоор гол гарч Баян Цагаанд хүчээ задлах ёстой. Ясуко, 64, 26 дугаар хороог 3, 4 дүгээр танкийн хороог удирдаж дайсны хүчийг устгах болно. Тиймээс Ясуко, өөрийнхөө хүчийг Талын манхан, Такасай өндөрлөгөөр давшуулж Баян Цагаанд хүрэх болно. Асуух лавлах зүйлээ одоо сайн ярилцах хэрэгтэй. Довтолгооныг амжилтанд хүргэхийн тулд 7 сарын 2-ны шөнийн 21 цагаас Номон Ханы чиглэлээр их буугийн гал нээж дараа нь Хайлаастын хойд эргээр танкийн шөнийн дайралт хийнэ гээд довтолгооны үүрэг зорилгын талаар удирдамж өгөөд тушаал гаргалаа.

...7 сарын 1.Бямба гариг. Синто хэмээх бурхны бодь мөрийн хутгийг олох ёсонд дайныг эрхэмлэхдээ Ням гаригийг самурайн мөргөлийн өдөр болгожээ. Тиймээс Баян цагаан руу явах цэргүүдэд бурхны адис хүртээхээр ширээт лам Сайто, Айдар сууринд иржээ.

Цэргийн хээрийн жодгорууд мэлтийсэн талаар цоохортож хайрцаглаад зөгийн үүр шиг харагдана.Дайны үеийн орон тоогоор бэлдсэн хоёр дивиз буюу 50 мянган цэрэг энэ талд ярайн жагссаныг харахад сүртэй. Цэргүүдийн дунд зассан индэр дээр Сайто гарч самурайн ёсыг номлон,

- Дайн бол бүтээн байгуулалтын эцэг, соёл цэцэглэлтийн эх мөн! Та нар өөрсдийнхөө амьдралыг элбэг дэлбэг болгож, өөрийн гэсэн газар нутагтай, эдлэнтэй болохын тулд дайн хийх ёстой. Дайнд нэг бол ялах ёстой нэг бол үхэх ёстой! Үхэхээс айж болохгүй, үхэл гэдэг бол энэ насны жаргалыг бурхны хувь тавилангаар хойд нас диваажинд очиж эдлэхийн мөрийг тавьж байгаа. Дайнд үхсэн дайчин эрийн нэрийг Мэйжи хааны сүмд мөнхжүүлж, монголын эзэлсэн газар нутгаас ноогдох ёстой дөрвөн га газрыг ах дүү, амраг саданд нь гэрээслэл ёсоор олгоно. Тиймээс ялалт байгуулахын төлөө, үхэхийн төлөө Хатимана бурханд мөргө! Хатимана бурхан чамд ирээдүйн чинь зам мөрийг дайны талбайд ямар байхыг чинь заан гийгүүлэх болно! Ямагогийн хөвгүүдийн бодь мөрийн хутгийг олох зам бол дайнд баатарлагаар байлдаж үхэх зам мөн! Итаоку гэсукай... сая сая хүний үхлээр цэрэг эрсийн

гавьяаг мөнхөлье! гэж үгээ дуусгаад адислав.

Сайтогийн дараагаар уламжлал ёсоор нэг бага дарга үг хэллээ.

- Ямато үндэстний нэр төрийг өндөрт өргөх цэрэг эрсээ! Бид аугаа их үндэстний ирээдүйн аз жаргалыг дайны яруу алдраар олж авах ёстой! Тиймээс энэ насаа аугаа ялалтын талбай дээр тушааж амьдаараа жаргал эдлэх үү? Амиа өргөж хойд насандаа жаргал эдлэх үү? гэдгийг Хатимана бурхны оноосон хувь тавилангийн төлөө зориулж шийдүүлье! Итиоку гэсукай... Сая сая цэрэг эрсийн амиар самурайн алдар гавьяаг босгоё гэж хэлээд Банзай. Банзай... Банзай гэж уриалав. Энэ хүнийг ахмад Такеру гэдэг бөгөөд тэрээр явган цэргийн их бууны батарей удирддаг болой. Такеругийн дараа түүний найз Хито үг хэллээ. Тэрээр самурайн цэрэг эрсийн ёсоор ялалт байгуулахаа баталж, гишгэсэн газраасаа нэг алхам ухрахгүйн тулд өөртөө сеппуку үйлдэж эзэн хааны үйл хэргийн төлөө үнэнч тэмцсэн зоригоо харуулна гэж тангараглав.

Самурайн энэ ёсыг японы цэргүүдэд уламжлуулж, байлдааны талбай болон гэр орондоо ёслол төгөлдөр биелүүлж байхыг анх 1868 онд генерал Ноги гэгч тогтоож өөртөө сеппуку үйлдсэнээр мэйжи исин хаан Муцухито (1852—1912) түүний нэрийг алдаршуулан самурай нарын үнэнч зүтгэлийн баталгаа болгон уламжлах ёсыг тогтоож, тийм самурай нарын нэрийг Мэйлси, Ясакуни сүмд мөнхөлж байх зарлиг буулгажээ. Чингээд японы эзэнт гүрний 122 дахь хаан Муцухитогийн дараа ширээ залгасан хүү Иосихито (1879—1926 он) энэ уламжлалыг үргэлжлүүлсэн агаад түүний хүү эдүгээгийн эзэн хаан Хирохитогийн үед Халх голын дайны талбай дээр үргэлжлүүлэхийг синто ёсны ширээт лам төдийгүй армийн генералууд ч эрхэм зорилгоо болгож байлаа. Тангараг өргөсний дараа Баян Цагааны авралын зам мөрийг гаргах ёстой 100 танк монголын хил рүү хурдалж, Кобоясигийн гурван хороо, Ясукогийн хоёр хороо болон түүнд хүчин хавсрах морьт хороод хөдөлгөв.

Долдугаар сарын хоёрны Ням гариг. Кобоясигийн гурван хороо, инженерийн хороо болон их буугийнхан битүү машинаар хилийн зурвас дээр ирээд дайрахад тэнд байсан монголын нэг суман Кобоясигийн дайчдыг улаан галаар угтан саатууллаа. Ингээд үд өнгөрөөгөөд японы танкууд оройн сэрүү орохыг хүлээж байсан юм шиг өдрийн халуун наранд улайдсан элсэн толгодын дундуур ханаран гарч ирлээ. Кобояси, Ясукотой холбоо барьж монгол-оросын цэргүүдийн хориглолтыг яаж сэтлэхээ тохиролцоод нар уулын цаад руу гудайж үдшийн бүрий орсон 21 цагт их бууны галаар хориглолтын бүх шугам руу гал нээж устгах тушаал өглөө. Чингээд зогссонгүй их бууны галын дараагаар танкийн ган урсгал галт уулын халуун хайлмаг алгуурхан урсаж байгаа юм шиг элсэн толгодын дундуур сүлжин давшилтанд орлоо. Зэгст нуурт байсан монголын суман цэргийг Кобоясигийн хоёр хороо мөр даран хөөсөөр Их Бурхантын тохой руу түрнэ. Чингээд даваа гаригийн өглөөний 03 цагийн үед Кобоясигийн хорооны түрүүчийн хэсэг Халх голын эрэгт тулж ирээд инженерийн хороо гол дээр хөвүүрэн гүүр тавьж байсан тэр үед Хайлаастын зүүн хойгуур орж ирсэн Ясукогийн танкнуудын ихэнх жагсаалаас гарч, Хайлаастын баруун тал Элст өндөрлөгөөс Нэргүй өндөрлөгийн араар Их Бурхантын тохой хүртэлх хэсэгт улаан армийн буудлагын 14, 9 дүгээр хороо, 9 дүгээр мото хуягт бригад, 6 дугаар дивизийн хороод японы явган цэргийн таван хороо, танкийн 2 хороо, инженерийн хороо, их бууныхан, баргын Хянганы морин дивизтэй шөнөжингөө тулалдаж хонолоо. 7 сарын 3-ны өглөө японы 71, 72 дугаар хорооны сумангууд монголын ухарсан

цэргийг хөөсөөр Их Бурхантын тохойд хүрлээ. Ганц суман цэрэгтэй чингэж хөөцөлдсөн японы хоёр хорооны таван сумангийн нэг нь Хитогийн суман байлаа. Тэрээр Зэгст нуурт байсан монгол сумангийнхныг Халх голоор гаргалгүй устгахаар улайрч байсан тэр үед монголын цэргүүд японы таван сумангийн дээд талаас түймэр тавилаа. Салхины аясаар хуйлран дүрэлзсэн түймрийг дурандаж байсан Хито,

- Чөтгөр шиг овжин амьтад юм даа. Зүүнээсээ салхилж байгааг ашиглаж бидний дээд талаас түймэр тавьдаг байна шүү. Ноднин жилийн ургасан энэ их хуурай өвсний өндрийг яана. Ер нь эднийг энд хаяхгүй бол Зэгст нуур, Гөлөгт манханд манайхны байдгийг хядсан юм шиг юм болно. Одоо эртхэн гарам дээр очье! Ямар ч гэсэн энэ талаас л холдье гэж бодоод Халх голын гарам дээр тавьсан хөвдөг гүүрийн зүг ухрах тушаал өглөө. Кобоясигийн удирдлаганд байсан 71, 72, 26 дугаар явган хороо, инженерийн хороо, их бууныхныг Халх голоор гарах үед Хито, Мицудо хоёр их бууны нэг батарейн дарга ахмад Такерутай танилцав. Тэд нэг нутгийнхан ажээ. Гэвч хэн хэн нь олигтой хуучилж чадсангүй. Шөнийн харанхуйг ашиглан Халх голоор гаргасан бөгөөд хамгийн сүүлд өглөө 6 цагийн үед хорооныхон гарч байгаа болохоор ярих нь байтугай түр зогсох зав байсангүй. Японы цэргүүд Баян Цагааны нуруунд гарангуут хамгаалалтын хоёр шугам, танк эсэргүүцэх их буунуудыг яаралтай байрлуулах даалгавартай байлаа.

... Кобояси нар битүү байхад Халх голын нөгөө эрэгт гараад бургасанд босгосон хээрийн штабын жодгорт орж ирэхэд хороодын дарга нар төдийгүй инженерийн хороо, холбооны дарга нар цугласан байлаа. Тэнгэрийн алсын хаяанаа манхайн цайсан бүүдгэр гэгээ жодгорын үүдээр тусах авч дотор талыг үл гэрэлтүүлнэ. Харин гадуураа шилэн бүрхүүлтэй дэнгийн сүүмгэр гэрэлд дарга нарын царай бүдэг бадаг танигдах ажээ.

- Баян Цагааны нуруунд түрүүлэн гарч, байрласан ангиудад утсан холбоо тавьсан, холбооны сумангийн даргыг илтгэхэд Кобояси, Долдугаар дивизийн 26 дугаар хорооны тэргүүн ангитай яриулаадах гэлээ. Хээрийн штабт цугласан дарга нарын дунд 26 дугаар хорооны дарга байсангүй. Японы явган цэргийн 26 дугаар хороо Их Бурхант, Балгасны чиглэлд байлдаж байгаа болохоор Баян Цагааны нуруунд гарсан 71, 72 дугаар хороодын зүүн талаас монголын зургаа дугаар дивизийнхэн довтолж болох учраас Кобоясигийн сэтгэл түгшиж байлаа.

- Баян Цагааны зүүн хэсэгт байгаа монголын хороог таслан бүсэлж устгах хэрэгтэй! Танайд нэмэгдэл хүч өгч, их буу, онгоцоор дэмжинэ. Миний тушаалыг ойлгов уу? гэж асуугаад утсаа тавиад дэргэдээ зогсож байгаа дарга нар руу эргэлээ.

- Маш хурдан хугацаанд Баян Цагаанд командын байрыг байгуул. Хориглолтын шугамыг маш нарийн зохион байгуулж, юуны өмнө танк эсэргүүцэх их бууны галыг уутан хэлбэртэй байгуулж, шуудууг тал хэлбэртэй ухаж, хамгаалалт хийх хэрэгтэй. Их буунууд 180 градус эргэж чадахаар байгуулсан байх хэрэгтэй. Гакка Комацубара үдээс хойш Хайлараас гарна. Тиймээс эрхэм дээдсийг ирэхийн өмнө Баян-Цагаанд байгаа улаан орос монголын цэргийг устгасан байх хэрэгтэй гэж зарлиг буулгалаа.

...Өглөөний тэргэл наран Шилийн худгийн овооны цаанаас өндийж байхад Халх голын тэнгэрт японы онгоцууд хүнгэнэлдэн гарч иржээ. Тунамал хөх тэнгэрт зайгүй барайсан олон онгоц Баян Цагааны нуруу Халх голын хөндийгөөр олон тооны бөмбөг мулталсан болохоор

чих дөжрүүлсэн хахир зэвүүн шунгиналт, тархи доргиосон хүчтэй дэлбэрэлт, газрын хөрсийг тэр аяар нь тэнгэр өөд цацан өглөөний нарыг халхалсан битүү шороон харанхуй толгой дээрээс нөмрөөд дарь хүхрийн гашуун хар утаа өглөөний цэнгэг агаарыг өөрчлөөд амьсгалах аргагүй болгов.

Баян Цагааны зүүн талын нэг ганганд байгаа япон цэргүүд өөрсдийнхөө бөмбөгдөгч онгоцноос унаж байгаа бөмбөгний шунгинахыг ажиглан, өлийн хараад шагшин магтаж бие биен рүүгээ зааж, элсэн ганганаас өндөс өндөсхийнэ.

- Чиү и Хито манай онгоцнуудыг хараач! Ёстой нэг болгож байна даа. Ийм бөмбөгдөлтийн дараа юу үлдэх вэ? Эдний дунд миний ах яваа гэж Такеруг хэлэхэд дэлбэрэлтийн чимээнээс халширч, хоёр чихээ хуруугаараа тагласан Хито, түүнийг юу ярьж байгааг сонссонгүй. Бөмбөгний дэлбэрэлт, шунгинан исгэрч байгаа чимээнд хичнээн чанга ярьсан ч дуулахгүй аж. Такеругийн уруулын хөдөлгөөнөөр ямар нэг юм хэлж байгааг гадарласан Хито, толгой сэгсэрснээ,

- Чи юу гээд байна вэ? гэж байдаг чадлаараа орилон асуусан атал нэгэн цэрэг ирж, Такеруд бичиг өгөхөд тэрээр буучийнхаа батарейг урагшлуулан галын байр эзлэхээр явлаа. Бөмбөгдөлтийн дараагаар японы их буунууд гал нээлээ. Ийнхүү их бууны дараагаар явган цэрэг давшилтанд орох байлаа. Их бууны галын дараа японы цэрэг Их бурхантын тохойг нөмрөн давшиж эхэлтэл улаан оросын их буунууд нижигнэж японы цэргийн ханарсан эгнээний дунд их бууны сум тусаж самурай нар газрын хөрстэй агаарт цацагдан давшилтын ханарсан эгнээний дунд ойн зурвас шиг зам гарлаа. Өглөөнөөс хойш их бурхантын тохойноос мултарч чадаагүй 72 дугаар хорооны хэдэн суман, 26 дугаар хорооныхон, монгол цэргийн галанд хоригдон ийнхүү байлдаж байсан тэрхэн үед Хитогийн салааны өмнөөс нэгэн хуягт гарч ирлээ. Хито хуягтыг хараад «Их бууны галын дараа дайснуудын давшилт эхэллээ» гэж бодтол явган болон морин цэргийн бараа харагдсангүй. Тиймээс Хито амандаа «Монгол цэргүүд гол хүчнээсээ тасарч холбоогүй болчихоод хуягт явуулж холбоо барих гэж байгаа юм байна» гэж бодоод хоёр тасгийн даргыг дуудаж,

- Тэр хуягтыг харж байна уу? Түүнийг устгаад хуягтынхныг амьдаар барих хэрэгтэй гэж даалгалаа. Хитогийн хоёр тасаг цэрэг газрын ашигтай талыг барин явсаар өнөө хуягтын эгц өмнө очлоо. Чухам энэхэн үед нэг япон цэрэг хуягтынханд мэдэгдэлгүй мөлхөж хажуу талд нь гараад өөрийнхөө дэргэдүүр өнгөрөх гэж байгаа хуягт руу ойртонгуут гранатаа шидэж амжив. Чингээд хуягт тэр дороо зогсож, Хитогийн хоёр салаа цэргүүд хуягт руу дайртал пулемётоор шүршиж гарлаа. Ийнхүү байлдсаар хагас цаг хэртэй болтол хуягтынхаа пулемётыг сугалаад барьчихсан монгол цэрэг хуягтаас үсрэн гарч ирэнгүүт Хитогийн тасаг цэргүүд рүү ширүүн гал нээж ухарснаа ар талдаа гарсан япон цэргүүдийг мэдсэн бололтой буцаж хуягт руугаа ухарсаар хуягтын дэргэд очингуутаа газар уналаа. Чингэж пулемётын гал зогссон тэр үед Хитогийн хоёр тасаг цэргээс үлдсэн зургаан цэрэг өнөө монгол цэрэг рүү бардам байдалтай ойртохыг ажвал түүнийг үхсэн гэдэгт итгэсэн нь илтээ. Гэтэл хоромхон зуур өнөө монгол цэрэг газраас өндийнгүүтээ япон цэргүүд рүү пулемётоороо галласаар хуягт руугаа орчихлоо. Хито энэ бүхнийг дурангаар харж байхдаа «Яасан долоон голтой амьтан бэ? Худлаа үхсэн хүн болж унаад манай хэдийн анхаарлыг сарниулаад устгачихдаг байна шүү» гэж бодоод бас нэг тасаг цэргээ хуягт руу явуулав. Хитогийн тасаг цэрэг хуягтыг

бүслэн мөлхсөөр ойртон очиход монгол цэрэг пулемётоороо шүршсэнгүй. Түүний сум дууссан гэдэг нь илт байлаа. Хитогийн цэргүүд болгоомжилсоор хуягтын дэргэд очиж хаалгыг нь онгойлгох гэтэл дотор талаас нь түгжсэн байлаа. Тиймээс япон цэргүүд хуягтын тал талаас шатдаг шингэнтэй шил шидэж шатаалаа. Хуягтаас бөөн хар угаа суунаглан тэнгэр өөд олгойдон дүрэлзэх авч шатаж байгаа хуягтаас өнөө монгол цэрэг гарч ирсэнгүй...

... Кобояси үүрээр 26 дугаар хороотой холбоо бариад дахиж ярьж чадалгүй өглөөний 9 цаг хүргэлээ. Тэнд утсан холбоо тавих гэж очсон салааг монгол цэргүүд устгажээ. Кобояси холбооны сумангийн даргыг толгой түрүүгүй загнаж «есөн цаг хагас гэхэд холбоотой болго!» гэж тушаагаад зогссонгүй «Байлдааны тушаал биелүүлэхгүй бол миний нүдэнд дахин үзэгдэх хэрэггүй. Бусидоод үнэнч юм бол өөртөө сепуку үйлдсэн чинь дээр. Энэ бол чиний нэр төрд өлзийтэй» гээд барьж байгаа зүйлээ уурандаа харагдсан зүг рүүгээ чулуудна. Чингээд цаг хагасын дараа өглөөний арван цаг өнгөрч байхад холбооны сумангийн дарга хээрийн штабын жодгорт орж ирээд Кобоясид,

- Эрхэм дээдсээ хуучин сүмийн орчим байгаа 26 дугаар хорооныхонтой холбоо барьсан. Одоо та ярьж болно шүү гэж хэлээд майханд байгаа холбооны хэрэгслэлийн дэргэд сууж байсан цэргийг босгоод өөрөө хороотой холбоо барьж Кобоясийг яриулав.

- Тай са, та байдлаа илтгээрэй. Яагаад Их Бурхант, хуучин сүмээс дайснуудыг арилгаж чадахгүй байна гэхэд хурандаагийн сөөнгөтсөн дуу харилцуурын чагнуурт паржигнаж,

- Их Бурхантын тохойд байгаа монгол цэргийг бүслээд устгадгийн даваан дээр баахан танкууд гараад ирлээ. Одоо бид танк эсэргүүцэх их буугаар давшилтыг торгоож байна гэх нь тод сонсогдов.

- Аль зэрэг олон танк вэ? Хаанаасаа гараад ирдэг танк вэ? гэж асуусан Кобояси сэтгэлдээ «Улаан оросын гол хүч, Баян Цагаанд хүрээд иржээ» гэж бодоод үл мэдэг сандарч байгаагаа мэдэв.

- Олон танк байна. Одоохондоо тоог нь авч чадаагүй. Бид оросын 10 танкийг шатааж устгасан. Гэтэл цаанаасаа хайлж байгаа ган шиг урсан гарч ирээд байна. Яг одоо гэвэл 10 гаруй танк бидний өмнөх гангыг даваад Халх гол руу мөрөгцөглөсөн жалга руу ороод ирлээ. Бидний буцах замыг хаах янзтай байна гэж хэлээд хэдэн юм хэлсэн нь генералд дуулдсангүй харин их бууны сумны дэлбэрэлт чагнуурт хадаад хурандаагийн дуу тасарлаа...

Кобояси, харилцуураа тавиад хэсэг дуугүй байснаа сая ухаан орсон юм шиг хөмсгөө зангидсаар,

- Намайг 71, 72 дугаар хороотой яриулаадах гэж тушаалаа. Холбооны сумангийн ахмад Кобоясигаас сүнсээ зайлтал айсандаа болоод тэргүүн шугамд байгаа хороотой яаж холбоо барьснаа мэдсэнгүй. Чихэнд нь нэг хүний дуу гарангуут Кобоясид харилцуураа өглөө.

- Чиү са, байдлаа илтгээрэй гэхэд дэд хурандаа,

- Байдал нэлээн хүнд байна. Тагнуулын мэдээгээр бол улаан оросын танкийн бригад

монголын 6 дивизийн хамтарсан хүч, их буу, мото буудлагын хороо манай баруун хажуугаас буюу 26 дугаар хороог бүсэлсэн байдалтай голын тохой руу шахаад Баян Цагааны нурууны зүг 72, 71 дүгээр хороо руу чиглэсэн байна.

- Аль зэрэг олон танктай юм бэ?

- Ён жү (дөч) гаруй танк одоо манай хориглолт руу довтолж байна.

- Танкнаас хориглох саад сувгаа татаж амжсан уу?

- Бүх зүйлийг тушаасан ёсоор бэлэн болгож амжсан. Бид танк эсэргүүцэх галын цэгийг зохион байгуулахдаа өвөрмөц арга хэрэглэсэн. Их бууны байрлалыг хоёр хажуугийн голын гэж хуваарилсан. Оросын танк голын их буунуудын гал руу дайрах ёстой бөгөөд манай хоёр хажуугийн их буунуудыг ажиглахгүйгээр байрлуулсан учраас оросын танкуудыг хажуугийн их буунууд устгах юм. Ийм ууган галаар байлдахгүй бол бид Баян Цагааныг алдаж магадгүй гэхэд Кобояси, хэнэггүй ярьж байгаа дэд хурандааг аман дотроо харааснаа,

- Битгий муу юм зөгнөөд бай! Юуны чинь Баян Цагааныг алдах энэ тэр гэж солиороод байна вэ? Одоо өөрийнхөө тэргүүний суман, салаа, тасгуудын цэргийг зөв зохион байгуулах хэрэгтэй. Тэгвэл таны толгойд муу юм зөгнөсөн бодол орж ирэхгүй. Юуны өмнө одоо «тайсинтай буюу үхэл таригч» хэсгийг зохион байгуул! Самурайн зорилгонд амьдаараа ялалт байгуулж чадахгүй бол амиа өргөж ялалт байгуулах ёстой гэдгийг та мэдэж байна уу? Тиймээс оросын танкийг зэвсгээр устгаж дийлэхгүй бол хүнээр устга! Тиймээс шатах шингэн бүхий лонх, мина, гар, бөмбөг өгч хүмүүсээ оросын танк руу мөлхүүл! Нэг цэрэг амиараа нэг танкийг устгах ёстой! Хоёр танк устгаад амьд үлдсэн хүнд монголын эзлэгдсэн газар нутгаас хамгийн үржил сайтай 10 га газар эзэмшил болгон өгч, эзэн хааны «Улаан наран» одонгоор шагнана гэж амла! Хоёр танк устгаад амиа өргөсөн цэргийн хөшөөг Мэйжи хааны сүмийн хашаанд хүрлээр цутгаж босгоно гэдгийг ухааруулж өг! Баян Цагааны нуруунд оросын ганц ч танк бүтэн үлдэж болохгүй. Мэдэв үү гэж хашгиран тушаагаад утсаа тавилаа.

Кобояси өдөр турш сэтгэлээ дэнсэлгээд үдийнхээ хоолыг зооглосонгүй. Харин хоосон ходоодон дээрээ цагаан архи хэдэн хундага ууснаар өл залгасан болжээ. Тэгээд үдээс хойш 15 цаг өнгөрөөд Баян Цагааны зүүн жигүүр болох Хайлааст, Халх голын бэлчир хавьд байрласан 71 дүгээр хороо руу ярилаа. Гэтэл хорооны дарга хурандаа,

- Манай энд байдал улам хүнд болж байна. Оросын танкийн хоёр батальон монголын цэргийн нэг морьт хороо, оросын явган цэргийн хороо, мото хуягтынхан довтолгооноо эхэлсэн гэхэд Кобояси юу ч хэлж чадалгүй хэсэг ээрэхдээ «Монгол, улаан оросын гол хүч Баян цагаанд бүрэн иржээ» гэж өөртөө сануулан шивнэж байлаа.

... 72 дугаар хорооны дарга дэд хурандаа, генералтайгаа яриад хэдэн сумангийн дарга нарт утсаар даалгавар дамжуулжээ. Тэр даалгаврыг Хито, Мицудо хоёр ч авлаа. Үнэндээ Хитогийн салаанаас ердөө тасаг цэрэг үлджээ. Харин Мицудагийнх овоо бүрэн шүү байлаа. Хито өөрийнхөө тасаг цэргийг цуглуулаад,

- Оросын танкийн томоохон хүч бидний давшилтыг саатуулж байна. Тиймээс тэр танкийг

Баян Цагааны нуруунд сэг болгох ёстой. Тиймээс бид салаанаасаа эзэн хааны нэр төр, аугаа ямато үндэстний алдар гавьяаг өндөрт мандуулсан тасгуудынхаа адил «тайсинтай» нарыг салаанаасаа төрүүлэх ёстой. Оросын танк, монголын хуягтыг мина, гранат, шатах бодистой шингэнээр устгана. Хүн бүхэнд эдгээр зэвсгээс нэг нэгийг өгнө. Хэрэв түүгээрээ гурван танк устгаад амьд үлдвэл монгол, манжуурын нутгаас үржил сайтай 50 га газрыг эзэмшил болгон шагнана. Бас зээн хааны найман зэргийн одонгоор шагнана гэж санаандаа орсныг ярив. Хито ингэж ярих нь өөрт нь ашигтай ажээ. Учир нь салаагүй болсон бага дарга өөртөө сеппуку үйлдэх ёстой! Эсвэл цаазлуулах ёстой байлаа. Тиймээс Хито, салаа цэргээ алдсан явдлыг «тайсинтайн» баатарлаг гавьяагаар далдлан цагаатгаж чадвал харин өөрөө амьд үлдэх төдийгүй шагнуулж ч болох талтай билээ.

- Та нар ямар нэг тохиолдлоор танк устгаж чадахгүй бол байлдааны талбай дээр сеппуку үйлдэж нүглээ наманчлах болно. Ганц минатай үлдвэл түүнийгээ тэвэрч танкин доор орох ёстой! гээд тасаг цэрэгтээ мина гранат, шилтэй шатах шингэн өгөөд танк руу давшуулаад өөрөө араас нь дурандлаа.

Баян Цагааны хөрс танкийн гинжинд онгилогдон, их буу, бөмбөгний суманд цоо өрөмдүүлсэн гүн хонхор, сархинаг шиг цоохортон, элсэн гүдгэр хотгорууд сэмж шиг болжээ. Их буу, бөмбөгний галд хуйхлагдсан газрын хөрснөөс гал дүрэлзэн, зуны аагим халуун дээр галын халуун нэмэгдээд улайдмал агаар хамаг биеийг төөнөж, шатаж байгаа хүний үхдэл, танкийн сэгнээс бензин, тосны үнэр ханхалж амьсгалах тоолонд цээжнээ эхүүн үнэр амтагдан дотор эвгүйрхэнэ. Ядаж тал талд их бууны сумны дэлбэрэлт хүнгэнэж, газар доороос доргин чичирхийлэх нь нэмэгдээд хүн бүхний чих дөжирч, толгой нь заадсаараа салах гэж байгаа юм шиг ангас ангасхийх бүр их бууны сум энд тэнд дэлбэрэх вий гэхээс айдас хурна. Хато, нуувчийн хана түшин ирж яваа танкны зүг мөлхөж байгаа тасаг цэргүүдийн араас дурандаж байхдаа явган цэрэггүй танкнуудыг хараад мэл гайхжээ. Японы их буучид оросын танктай ана мана үзэлцэж буй энэ хүнд үеийг тайсинтайчууд нэг талаас нь хөнгөлж байлаа. Оросын танкийн их буу, хуягтын пулемётын сум тэргүүн шугамд байгаа японы цэргийг нуувчаас өндийлгөх янзгүй. Их бууны сумнууд тэргүүн шугам дээр төдийгүй дараагийн шугам дээр тусна. Танкны их бууны сум Хитогийн байгаа нуувчийн хойно урд тусах бүр тэрээр нуувчийн ёроол руу нугдайн сууна. Гурван бээр хэртэй өргөн эгнээгээр орж ирсэн олон танкны түрүүнд цойлон гарсан долоон танк, 72 дугаар хорооны их буугийн хоёр батарейг чиглэн хурдаа нэмэх ажээ. Хамгийн түрүүнд хурдалж яваа танкны эгц өмнөөс мөлхөж нэг нүхэнд хоргодсон цэрэг өмнөөсөө ирж яваа танк руу босон гранатаа шидсэн боловч давуулчихлаа. Тэгээд мина тэврээд хажуу талаас нь танк руу дайрч доор нь орлоо. Танкны гинж гэдсээ хүүлүүлсэн юм шиг хөвөрлөө.

Тэр танкны зүүн гар талд хурдалж явсан танкны хажуугаас бас нэг цэрэг гарч ирээд өөрийнхөө хажуугаар өнгөрсөн танкийн араас шатах шингэнтэй лонхоо шидэхэд бөөн гал дүрэлзэн, өтгөн хар утаа савсуулан танк хурдалсаар байхад өнөө цэрэг араас нь гүйж гар бөмбөг шидэх гэтэл тэнэмэл суманд өртөн унатал цэнэглэсэн гранат дэлбэрлээ. Шатан дүрэлзсэн улаан галтай танк тэр чигээрээ хурдаа нэмэн хурдалсаар хамгийн ойр байгаа их бууны нэг батарей руу дайрахад их буучид буугаа сумлаж амжилгүй зугтаж, танкийн гинжинд яйчуулсан их бууны сэгнээс зайдуу зогссон шатаж байгаа танкнаас пулемёт тачигнаж зугтаж байгаа их буучдыг устгалаа. Тэгээд хэдэн мөч өнгөртөл шатаж байгаа танкны хуягт цамхгийн

нээлт онгойж танкчид гарч ирэхэд тэдний ар нуруунаас гал дүрэлзэж байгаа харагдлаа. Оросууд шатаж байгаа танкнаасаа буунгуут газар өнхөрч галаа унтраагаад их бууны суманд сэндийлэгдсэн нэгэн хонхорт ороод бараа нь харагдахгүй боллоо.

Хитогийн зүүн гар талаас орж ирсэн танкны түрүүхэнд хурдалж байгаа нэг танкны өмнөх нүхнээс нэг цэрэг өндийж бөөгнүүлж барьсан гранатаа шидээд өөрөө шархадлаа. Гэтэл түүний араас гарч ирсэн танк руу их бууны батарейнхан хараа тааруулан буудтал танкны хуягт цамхаг суга үсэрч газар унаад хоцроход хуягт цамхаггүй танк хурдаа нэмсээр хориглолтын тэргүүн шугаманд байсан нэгэн салаа руу цөмрөхөд цэргүүд нуувчаас огло үсрэн гарч зугтаад танкны пулемётын суманд хяргуулав. Харин хуяггүй болсон танк өргөн ухсан нүх рүү толгойгоороо гударч, танкнаас гарч ирсэн оросууд япон цэргүүдтэй буудалцаж байгаад амь үрэгдлээ.

Хито энэ бүхнийг дурангаараа ажиглаж байгаад өнөө гинжээ цувуулж зогссон танк руу дурандав. Танкны баруун дугуйны хавьд нэг юм хөдлөх шиг болоход Хито дурангаа тогтоож сайн харвал танкны доод талын нээвчээр хоёр хүн орж байгаа харагдлаа.

- Мөн сүрхий гайхлууд аа. Энэхэн зуур танкныхаа гинжийг хийгээд амждаг байна шүү. Яахаараа ийм сүүхээтэй байдаг золигнууд вэ? гэж бодтол өнөө танк тэр дороо хөдөлж эгц өмнөө байсан нэг батарей руу их буугаараа буудтал түүний сум их буучдын сумны хайрцагнууд дээр тусаж нэг батарей тэр чигээрээ нүд ирмэхийн зуур агаарт хийслээ. Их буучид тэр танкийг устлаа гэж бодоод, анхаарлаа хөндийрүүлсэн нь гай болжээ. Оросын тэр танк зогсонгуутаа их буугаараа буудаагүй нь японы их буучдыг ингэж итгүүлэх мэх болсон болой.

Хито энэ бүхнийг ажиглан гайхахдаа «Оросууд ингэж байлдвал бид маргааш, нөгөөдөр гэхэд эндээ авслагдах юм байна! Гэхдээ бид чинь аугаа их ямато үндэстний яруу алдрын төлөө амиа өргөж, эзэн хааны дэглэмийг Азид тогтоохын тулд биеэ зориулж байгаа алдар гавьяатан шүү дээ. Гэтэл энэ оросууд хэний төлөө хайран амиа алдаж байгаагаа ухаардаггүй тэнэг улсаа! Очиж очиж монголчуудын төлөө амиа бусниулжявдаг сонин хэрэг ээ! Бурхны зарлигаар бол монголчууд газрын хөрснөөс арчигдах ёстой, нүгэлтэй өчүүхэн амьтад! Гэтэл хувь заяагүй ийм улсуудын төлөө оросууд амиа гарздаж явдаг мөн үйлийн үртэй тавилан аа! Тэгэхдээ тэнгэрээс заяатай Азийг төдийгүй бүх дэлхийн хүмүүсийг захирах хувь тавилантай биднийг устгаад энэ өчүүхэн доод заяатай монголчуудыг амьд үлдээхийг боддог хачин юм шүү» гэж бодоходоо улс үндэстний эрх чөлөө тусгаар тогтнолыг нүднийхээ цөцгийнөөс илүү эрхэмлэдэг Зөвлөлтийн ард түмний чин ариун сэтгэлийг самурайн ёс горим, үзэл санааг мах цусандаа шингээсэн Хито ойлгон ухаарахгүйгээ хэзээ ч мэдэхгүй! Самурайн бурангуй ёс суртахуунд хордоод, сэтгэл санаагаа манантуулсан энэ хүнд хэн нэг хүн учир явдлыг тайлбарлалаа гэж үзэхэд чихэндээ алт хийснийг анзааралгүй толгойгоо сэгсэрч унагасан илжигний үлгэр лүгээ адил болно бизээ.

Хито чингэж бодсоор өмнөөсөө ханаран ирж яваа танктай амь өрсөлдөн тулалдаж байгаа Такеругийн их буучид руу дурандлаа. Баян Цагааны нуруунд гарч ирсэн японыхон танкны довтолгооноос хамгаалж хоёр давхар хамгаалалт хийсэн бөгөөд хамгаалалтын шугаманд 150 их буу байрлуулж их буучдад найдвар тавьж байлаа. Гэтэл эхний шугамыг сэтэлсэн танкнууд хоёр дахь шугаман дээр байгаа Такеругийн батарей руу чиглээд галзуу амьтад шиг тулалдаж

гарлаа. Үдийн халуун нар толгой дээрээс төөнөж, эмх замбараагүй шидсэн шатах бодистой лонхны галанд өртсөн Баян Цагааны онгилогдсон хөрс түлэгдэн шатаж, элс буцалгам халуун нөмөрч, хамар хоолой хорсгосон хар утаа Халх голын хөндийг даган суунаглах нь Баян Цагааны нуруунаас тод харагдана.

Такеру, хятадад болж байгаа баатарлаг гавьяаг Токиогийн сониноос уншаад эр зориг нь бадарч билээ. Тэгээд дайнд явбал алдар гавьяа байгуулж нэр сүрээ мандуулахын зэрэгцээ аль ашигтай нутгаас эзэмшил газар авч өөрийн гэсэн газартай болно гэж бодсон. Гэтэл манжуурт ирээд хэдэн сар болохдоо «Би хожимджээ. Алдар гавьяа байгуулах түүхэн үйл явдал дуусчихсан энэ газар би яах гэж ирлээ» гэж бодоод гутрангуй явсан. Гэтэл Халх гол түүний сэтгэлийг баясгажээ. Тэрээр энд ирээд алдар гавьяа байгуулбал монголын газар нутгаас хамгийн сайн үржил шимтэй газар авч эзэмшлээ болгоно гэж бодоод Токио дахь эцгийнхээ жижиг үйлдвэрийг түшиглэн азид алдаршсан тоосго, ваарны үйлдвэр байгуулж монголын олзлогдсон хүмүүсийн хөлс хүчээр баяжна гэж тооцоолсон болой. Тэгээд Баян Цагааны тулалдаанд оролцох болсондоо баярлаж байсан.

Тэгээд японы тэргүүн хороо Баян Цагааны нуруунд сэмхэн гарч байрласныг мэдээд Такеру сэтгэлдээ «Одоо миний ирээдүйн хувь заяаны зам мөр нээгдлээ» гэж бодож байлаа. Гэтэл өглөөний 10 цагаас хойш орос монголын танк хуягтууд хамгаалалтын тэргүүн шугамыг уулгалан дайрч сэтлээд хоёр дахь шугам руу ороход «Энэ махан поолуунууд яаж байлдаж байна аа. Ингэж байлдвал эзэн хааны нэр төр, ямато үндэстний аугаа алдрыг баллана шүү. Би эхний шугаманд байсан болоосой. Тэгсэн бол оросын танкнуудыг алд газар ч алхуулахгүй байсан» гэж бодсон билээ.

Явган цэрэггүй давшилтанд орсон оросын танкнууд өөрийнхөө их буу, пулемётын галыг чадамгай хослуулан байлдаад эзэн хааны армийн их буучдын тэргүүн шугамыг газрын хөрснөөс арчаад хаячихлаа. Өдрийн 16 цаг гэхэд Баян Цагаанд байсан японы их буучид сүйрэлд орж, танкинд бяц дайруулсан их бууны сэг ёрдойж, энд тэндгүй самурайн үхдэл нэлмийн, үхсэн цэрэг, их бууны тамтгаас хар утаа суунаглахыг хараад алмайрч байсан Такеру «Бид ингээд энэ элсэн ууланд булуулах хэрэг үү?» хэмээн өөрөөсөө асуутал өөдөөс нь гурван танк гарч ирлээ. Гэтэл хажууд нь байсан дэслэгч,

- Сум сум гэж хашгирлаа. Танкууд хэтэрхий ойртсон болохоор танкны их бууны онгойсон амыг харсан цэргүүд тал тал тийшээгээ зугтлаа.

- Та нар чинь яаж байна аа. Галлаач, зогс зогс... буудлаа шүү гэж Такеруг хашхиртал өнөө танк бүр ойртоод ирлээ. Такеру их буу руугаа эргэхдээ хараал зүхэл болсоор их бууны гал цохигчийн сууринаас татгал их бууг сумлаагүй орхисон байлаа. Такеру үглэсээр хайрцагтай сум руугаа ухасхийтэл өөрийнх нь их буун дээр танкны их бууны сум туслаа. Такеругийн чих хүнгэнээд тархи нь гавлаасаа салаад уначих шиг болж, нүд нь харанхуйлж байгааг гадарлаад ухаан алдлаа.

Байж ядам халуун нүүрнээс нь цоргиж байгааг Такеру гадарлаад нэг хэсэгтээ газар хэвтээд биеэ чагналаа. Эргэн тойронд ямар ч анир чимээгүй болжээ. Байлдаан зогссон нь илт ээ. Такеру олзлогдоогүйг бодоход өөрийнхөн нь ялаад тэрээр ар талд үлдсэн бололтой. Такеру алгуурхан өндийгөөд эргэн тойрноо харвал хүүр сэгэн дунд ганцаараа үлджээ. Тэгээд хар

тугалга цутгачихсан юм шиг хүндрэн янгинаж байгаа толгойгоо арай ядан дааж босоод ажвал тэнгэрийн хаяанаа хөшиглөн тогтсон шороо тоос, хар утаа манарсаар байгаа агаад энд тэндгүй газрын хөрс тэнгэр өөд олгойдон нөмөрч байгааг хараад байлдаан зогсоогүйг мэдлээ. Гэтэл их бууны сумны дэлбэрэлт Такеруд үл сонсогдоно. Тэрээр босоод их буу руугаа эргэхдээ нэгэн зөөлөн юман дээр гишгэснээ мэдээд доошоо хартал батарейных нь нэгэн бага дарга амаа ангайлган шүдээ ярзайлгаад үхсэн байлаа. Такеру тасгийнхаа нэгэн даргын хүүрэн дээр гишгэснээ мэдээд айлаа. Давхийн цочоод,

- Ай Хатимана минь гэж хашхиртал түүний дуу чихэнд нь сонсогдсонгүй. Тэрээр харсаар нэгэн хатуу юманд тулангуутаа айж цочин огло харайлаа. Тэгээд эргэн хартал танкны их бууны суманд өртсөн өөрийнх нь их буу байлаа. Такеру их бууныхаа дэргэд ирээд түүний төмөр хаалтанд гараа хүргэсэн чинь улайдсан төмөр гарыг нь хайрлаа. Тэрээр түлэгдсэн хуруунуудаа амандаа хийж аргацаагаад их бууныхаа төмөр рүү харвал нэг хэсгээрээ зад цохиулаад сэтэрсэн төдийгүй тэр сэтэрхий дээр сумны халуун илчинд хайлаад царцаж тогтсон бөнжгөр хайлшийг харвал нүдний зовхинд торж ядан тогтсон нулимсны дусал шиг санагдав.

- Төмөр бас уйлдаг юм байна шүү гэж хэлсэн Такеру их буунаасаа холдтол бас нэгэн цэргийнхээ толгой дээр гишгэчихээд бүүр сандарч "Энэ чинь бага дэслэгч Масури шив дээ. Ямар аймаар юм бэ. Энэ дайн байлдаан чинь ямар аймаар хайрхан бэ, ай Хатимана минь " гэж үглэтэл нүднээ нулимс бүрхээд ирлээ. Такеру өөрийн эрхгүй уйлахдаа хараал тавитал тэр нь өөрт нь сонсогдсонгүй. Харин цээжний хөндий, сэтгэлд нь түүний хэлсэн үг дуудах шиг болсонд " Миний чих... чих минь ...би чихгүй болжээ, хатимана минь намайг юунд эрхтэнгүй болгоно вэ. Би бурханд гэм хийгээгүй шүү дээ" гэж хашхирсаар газар сөхрөн халуун нар, дайны галд улайдсан элс самардан нүүр рүүгээ цацан орилж суухдаа галзуурснаа яахан мэдэх билээ.

Оройн нар жаргах гэж байхад Гига, Долт (Долоон) нуураас дуудагдаж ирээд Комацубарагийн өмнө номхон зогсож байлаа.

- Гига сан, манай цэргүүд Баян цагаанд гараад улаантай гайхамшигтай тэмцэж байна. Тэдэнд тусламж үзүүлэхийн тулд Ясукогийн хэсгийг урагш нь давшуулах хэрэгтэй. Тиймээс танай харцаганууд Ясукогийн замаар байгаа монгол орос цэргийг цэвэрлэж өгөх нь чухал гэлээ. Гига, Комацубарагийн тушаалыг аваад ихээхэн зүйл амлав.

- Гига сан, би маргааш Баян Цагаанд очиж байлдааны явцтай биеэрээ танилцах болно. Намайг тэнд байгааг танай нисэгчид мэдэж байх ёстой. Яг энд байх болно гээд газрын зураг зааж байрлалаа хэллээ. Тэгээд яриагаа үргэлжлүүлэн,

- Нөгөө талаар танайхан 6 сарын 22-ноос хойш, 90 онгоц алдсан байна. Армийн удирдлага ялангуяа гакка Уэда сан өчигдөр надтай утсаар ярихдаа үүнийг сануулга болгож байна. Тиймээс агаарын ялагдлын талаар ямар нэг юм бодож цагаатгах алхам хийх ёстой. Ингэхээр 7 сарын 4-ний өглөө ямар нэг амжилт гаргахгүй бол энэ хэрэг юугаар төгсөнө гэж бодож байна! Танайхны алдааг цагаатгах нэг арга зам бол «камиказе токкотайн» хэсгийг зохион байгуулах хэрэгтэй. Нэг нисэгч оросын нэг онгоцыг заавал сөнөөх ёстой. Болохгүй бол өөрийнхөө онгоцоор мөргөж устгах хэрэгтэй. Энэ бол бусидогийн тангарагаас үүсэн гарсан

зүйл гэдгийг мартаж болохгүй. Явган цэргийн хороод «тайсинтайн» хэсэг зохион байгуулж оросын танк, монголын хуягтуудыг Баян Цагаанд булшилсан байна. Тэгэхээр танай харцаганууд тэр замаар замнах ёстой. Тэгж чадвал та нар нүглээ арилгаж чадна гэхэд Гига,

- Гакка бид, камиказегийн хэсэг байгуулаад танд илтгэнэ. Урьд гаргасан алдаа дахин давтагдахгүй гэж амлаад өрөөнөөс гарахад генерал Симоотоог дуудуулав.

Симото, хоёр дивизийн тагнуулын хэсгийг толгойлсноос хойш хийморьтой байлаа. Тэрээр байлдааны талбай дахь хороо, батальонуудын тагнуулынхантай байнгын холбоотой ажиллаж, орос-монголын цэргийн байрлал, хүн хүчний талаар маш сайн мэдэж байсан нь Комацубарагийн сэтгэлд таалагджээ. Гэсэн ч Симото Комацубарагийн чихийг халууцуулахгүйн тулд болсон бүхнийг түүнд айлддаггүй болой. Симоотогийн ажлыг командлагч ийнхүү мэдээгүйн харгайгаар тэрнийг ажил хэрэгч гэж ойлгож байлаа. Симоотоог орж ирэхэд Комацубара байлдааны зураг ширтэн, зураг дээр байлдааны хүчийг шилжүүлэн давшилтын чиглэлийг сонгож байлаа.

- Тай са, надтай хамт Баян Цагаан руу явна. Нөгөө талаар армийн штабаас ирсэн Аяанаосуг авч явна. Та хоёр чинь хэзээний танил байхаа гэхэд Симото толгой дохисноос цаашгүй. Комацубара Симоотогийн бүрсгэр царай, сээрээрээ эв хавгүй бөгтийсөн гооргор бие, урьд урьдаасаа илүү бөгтийж, тэргүүн гудайлгасныг ажигласангүй.

Баян Цагааны нуруунд байгаа дөрвөн хороо оросын танкинд талхлуулсан төдийгүй их буучид нь бараг сүйрснийг Симото хоёр цагийн өмнө мэдсэн. Гэсэн ч түүний талаар Комацубараад илтгэж зүрхэлсэнгүй. Тэгээд толгойгоо унжуулсаар даргынхаа өрөөнөөс гарахад ширээн дээрх зураг ширтэж зогсоод бодлогоширсон Комацубара Симоотогийн урамгүй явааг ажиглалгүй гаргажээ. ...Гига, Жанжин сүмээс холгүй байдаг Иринга нуурын хавь дахь хээрийн буудал дээр ирээд хурандаа Коворотой уулзлаа.

- Маргааш танай бөмбөгдөгч, дайрагч онгоцууд Талын манхан, Такасай өндөрлөг, Фуйтакасагийн чиглэлд байгаа улаантны хүчийг тагнан мэдээд Баян Цагааны нуруу орж орос монголын цэргийн дээрээс бөмбөг хаяж устгана. Ингэвэл манай долоон хороо Баян Цагаанд том ялалт байгуулах юм гээд газрын зураг, зааж үүрэг өглөө. Гига явахын өмнө Коворогийн ажиллагаанд дахин удирдамж өгөөд,

- Баян Цагаанаас буцахдаа Халх голын нөгөө эрэгт байгаа монгол оросын үлдэгдэл хүчийг бөмбөгдөж устгана. Армийн удирдлагаас баахан хүмүүс Хайларт ирсэн байна. Тэдний дотроос хэвлэл мэдээллийн хэсгийг ахалж яваа Тогава та нартай ниснэ. Тиймээс байлдааны ажиллагааг идэвхжүүлэхийн тулд өөрсдийнхөө нисэгчдийн дотор «камиказегийн» хэсэг байгуулах хэрэгтэй гээд Комацубарагаас биечилж өгсөн үүргийн талаар ярьж өглөө. Тэгээд Гига, маргааш онгоцуудыг агаарт хөөргөх цагийн талаар Коворотой ярьж тохироод Долт нуур руу гарлаа.

Гигааг явсны дараа Коворо, өөрийнхөө хэсгийнхэнтэй уулзаж байлдааны ажиллагаа, түүний бэлтгэлийн тухай ярилцаад дээрээс өгсөн чиглэлийн дагуу «камиказе токкатайчүүдийг» эмхлэн зохион байгуулах талаар зааварлав. Коворо, нисэгчдийн дунд «үхэл таригч» хэсгийг байгуулахдаа өөртөө оногдсон онцгой эрхийн дагуу Жанжин сүм дээр авчирсан өвөр

монголын олзлогдсон хүүхэн төдийгүй манжуур, хятадаас авчирсан хүүхнүүдийн сорыг ялгаж, «үхэл рүү морилогч» нисэгчдийн бие сэтгэлийн хэрэгцээнд зориулав. Үхлээр гавьяа байгуулах тавилантай нисэгчид тэр хүүхнүүдийг зодож нүдэх, уур омгоо тайлахын тулд буудах, хутгалах зэргээр тамлаж болохын зэрэгцээ сэтгэлийнхээ шуналыг тайлахад хэрэглэх ажээ. Чингэж онцгой эрх эдэлсэн нисэгчид шөнөжингөө наргиад өглөө түргэн жагсаалын дохиогоор босохдоо согтуу шахам байлаа. Тийм нисэгчдийг онгоцны механикууд суулгаж, бэхэлгээг нь янзалж өгчээ.

Өглөөний 6 цагт Жанжин сүмээс ниссэн гуч гаруй онгоцны түрүүнд ямар ч эмх замбараагүй нисэж яваа арван таван онгоц монголын хилийг давахад түүний араас бусад онгоцууд эгнээгээрээ ниснэ. Тогава шөнө дунд өнгөрөөж Хайлараас ирээд Коворотой уулзангуут түүний онгоцонд сууж нисэхээр тохиролцоод амарчээ. Тэгээд өглөө Коворогийн жолоодсон СБ—97 маягийн онгоцонд суулаа. Нов ногоон өнгөөр эмжигдсэн Халх гол тэртээ доор туузран цэнхэртэх, агаад өмнөд этгээдээр нь үргэлжилсэн элсэн толгод цэлгэр хөндийн өглөөний наранд шаргалтан, их бууны сум, бөмбөгөнд сэгчүүлсэн хонхор нүхнүүд онгойн харлаад дотроос нь угаа савсан сархинаг шиг цоохортон бараантахын зэрэгцээ Баян Цагааны нуруу, Халх голын дагуух газарт их бууны сум дэлбэрч, газраас цацагдсан шороо, хөрсөн хэсэг агаарт нэлмийн сааралтаад алгуурхан замхран буухыг ажваас сэтгэлд зэвүүн хүйтэн ажээ.

Тогава, онгоцны бүхээгээр газар руу ширтэхэд Баян Цагааны орой хавтгайран хотгор гүдгэр, ганга жалгаар нь хүний хүүр, жагсаалаас гарсан танк, хуягт, их бууны тамтаг, морьдыг сэг зай завсаргүй хөглөрч, их бууны сум, бөмбөгөнд цоо өрөмдүүлсэн газрын том том нүхэн цооногон амсрууд газар хөдлөлтөөс тогтсон юм шиг онгойж харлах нь сэтгэлд нэг янзын аймшиг төрүүлэм агаад «Энэ их хүүрийг» гэж бодсон хэн хүнд зүрх шимшрүүлэм болой.

- Тогава анхааралтай байгаарай гэж хэлсэн хурандаагийн дуу чихэвчинд сонсогдоход доошоо харж явсан Тогавагийн сэтгэлд хиртхийсэн аймшиг төрсөн тэрхэн үед «Юу болоо юм бол» гэж гайхсаар урагшаа харвал оросын онгоцууд тэнгэрийг бүрхсэн юм шиг эгц урдаас нь ирж явааг хараад сэтгэлд нь «Яанаа. Халх голын шумуул шиг яасан олон юм бэ?» гэж бодтол дотор нь «Хэрэггүй л эдэнтэй хамт нислээ. Ингээд үхчихвэл яанаа» гэж бодно. Хурандаа оросын онгоцыг ажиглан явснаа тэднээс таван зуугаад метрийн зайтай эгц дээшээ хөөрч үүл рүү ортол Тогавагийн дотор гэдэс тэр чигээрээ амаараа гарчих шиг боллоо. Хурандааг ингэж маневрлахад японы хоёр сөнөөгч онгоц хурандаагийн онгоцыг хамгаалан эгц дээшээ даган хөөрлөө.

- Анхаар... анхаар! Миний тушаалыг 16-18, 22-34 сонсож бай! Та хоёр руу хоёр онгоц чиглэлээ... анхаар! гэж хурандааг хэлэхэд Тогава, энэ тооны учрыг төвөггүй мэдлээ. Энэ нь камиказегийн бүлэгт орсон нисэгчдийн нэрийн эхний үеүдийг тоогоор орлуулсан хэрэг байлаа. Энэ тухай хурандаа урьд шөнө камиказегийн бүлэг зохион байгуулсан тухай Тогаваад хэлэхдээ тайлбарлаж билээ. Тогава энэ үгийг сонсоод камиказегийн бүлэг рүү харах гэтэл хурандаагийн онгоц үүлний цаад руу орлоо...

Хурандаагийн тушаалыг хүлээж авсан хоёр нисэгч, эгц урдаасаа гарч ирсэн сөнөөгч онгоц руу хоёр зэрэг халз дайрлаа. Гэтэл оросын нисэгчид эгц доошоо уналт хийсэн болохоор камиказечууд оросын онгоцыг мөргөж чадсангүй, харин өөрснөө зөрөөд өнгөртөл тэдний хажуугаар оросын хоёр онгоц сүүл даран хөөж дайрахдаа 300 метрээс пулемётын галаар

шүршиж гарлаа. Японы нэг онгоц тэр чигээрээ хурдаа нэмэн зайлж гарсан боловч нөгөө нь хар утаан сүүл татуулсаар доошилж, эгшний төдийд газар унатал бөөн гал утаа хоёр тэнгэр өөд тургилаа. Ингэж үрэгдсэн нисэгчийг Котама гэх агаад нөгөө зайлж одсон нисэгчийг Исизава гэдэг ажээ.

Исизава, оросын онгоцны ард гарангуут алсуур эргээд байлдааны хэсэг рүү дайрлаа. Агаарт мөргөлдсөн онгоцноос бөөн гал утаа цацарсаар газар руу унах агаад энд тэндгүй гал бутарсан агаарт онгоцны пулемётын сум хэржээ. Японы онгоц, оросын онгоцнуудтай өндөр булаалдан эгц дээшээ хөөрөхөд оросууд доороос нь элдэн дайрахдаа пулемётоор зогсоо зайгүй шүршинэ. Исизава, эгц өөдөөсөө гарч ирсэн оросын дайрагч онгоц руу пулемётоор галлатал оросын онгоц хар утаа савсуулсаар эгц өөдөө хөөрөхөд Исизава, зүүн талынхаа онгоц руу дайрахын тул өндөр авч дээшээ хөөрөхдөө «Иш энэ оросыг! Эртхэн газар бууж амиа аврахыг бодолгүй эгц дээшээ зүтгэдэг мөн хачин эр ээ!» гэж бодоод оросын онгоц руу дайрахыг завдлаа. Исизава агаарт хөөрсөн хийн бөмбөлгийг эгц дээрээс нь дайрч буудаж сурсан болохоор энэ аргандаа туршлагажжээ. Ер нь японы нисэгчид өндрөөс эгц доошоо дайрах явцдаа гал нээж сурсан болохоор түүндээ гаршсан юм.

Исизава өндрөө аваад доошоо дайрах гэтэл түүний дээрээс утаа савсуулсан түрүүний онгоц маш хурдтай унаж байгаа харагдав. Чухам энэхэн эгшинд орос нисэгч, унаж яваа онгоцоороо хоёр гурав эргэтэл хүчтэй салхинд цохигдсон гал унтарч, цайвар утаа онгоцноос суунаглахыг хараад Исизава гайхлаа. Нислэгийн ийм уран чадвар эзэмшинэ гэдэг хосгүй юм шиг санагдсан Исизава «Энэ чинь устаагүй юмаа» гэж өөртөө хэлээд жолоогоо чанга атгатал өөдөөс нь оросын нэг онгоц гарч ирлээ. Исизава мултрах аргагүйгээ мэдээд «Хатимана минь» гэж үглээд тэр чигээрээ өнөө онгоцыг халз мөргөлөө. Чингэж мөргөлдсөн хоёр онгоц агаарт бутарч, бензины сав нь зад үсэрсэн болохоор онгоцонд авалцсан галын дөл агаарт цацагдсан бензинд авалцан бөөн дөл агаарыг бүрхэн галт луу эвхрэн мушилзаж байгаа юм шиг хуйларсан галанд тэдний ойр явсан японы хоёр онгоц өртөж бөөн гал газар руу уналаа.

Агаарын тулалдаан эхлээд хориод мөч болоход тэнгэр тэр аяараа улайдаж онгоцны дотор талд халуу дүүгэн дулааны заалт 45 градусын зураасан дээр тогтож ядан чичирхийлж байгааг харсан Тогава, амьсгаа давхцаад бүтэж үхэх нь үү гэж бодтол агаарт мөргөлдсөн хоёрын улаан галын дөл мушгиран дүрэлзэхийг хараад «Ингээд л амиа алддаг байж» гэж бодоод газар руу харахдаа «Хаана унах бол» гэдэг бодол сэтгэлд нь харвасанд Тогава нүдээ аних гэтэл нулимс цийлэгнээд явчихлаа.

Агаарынтулалдааньявцыг ажиглан хоёр онгоцоор хамгаалуулсан Коворо хэрэг бишдэж байгааг мэдэнгүүт Жанжин сүмийн зүг жолоо заллаа. Энэ тулалдаанд Коворо нэг зүйлийг ухаандаа тогтоож авлаа. Оросын нисэгчид уран жолоодлогоороо туршлагажсан төдийгүй хувийн нислэг хийдэггүй болохоор бие биенээ хамгаалсан эгнээ рүү «камиказе» нар дайрахаас халширчээ. Камиказе нар оросын онгоцыг эгц мөргөхөөс өмнө хажуугийн онгоцны дайралтанд өөрсдөө ямар ч амжилтгүй сүйрч байлаа. Мөн зарим нь урдаасаа дайрсан японы нисэгчдэд зай тавин эгнээгээ задалмагц хажуугийн онгоц нь «камиказе» руу гал нээж устгаж байлаа. Нислэгийн ийм сахилга батыг чанад барьж, уран жолоодлого эзэмшинэ гэдэг ерийн хэрэг биш бөгөөд тийм нисэгчдийн гараас амьд мултарна гэдэг бол ёстой Хатимана бурхны далдын ид шидийн аврал байж болох юм гэдэг сэтгэгдэл Ковороод төржээ.

Хурандаа Коворо Жанжин сүмийн ойролцоох хээрийн буудалд буухдаа генерал Гигаад хэлэх үгээ бодож амжсан байлаа. Харин Тогава газар эсэн мэнд буусандаа дотроо залбирах авч нэрэлхсэндээ айснаа ор тас нуухыг хичээхийн эрхээр,

- Оросууд ч тун адармаатай гайхлууд юм даа. Манайхны дайралтыг тэсэх гэж их хичээлээ шүү гэж хэнэггүй хэлэхэд Коворогийн сэтгэлд тээглэж байсан дарамт аль хэдийн хөнгөрчээ.

Армийн хэвлэлийн бүрэн эрхт сурвалжлагч агаарын сүйрлийг нүдээрээ үзэж, сэтгэлээрээ мэдэрсэн атал түүнийг удирдлагад жинхэнэ бодит байдлаар танилцуулахгүй нь илт байлаа.

- Тогава сан, та байлдааны явц дахь ээдрээтэй асуудлыг тун нарийн ойлгодог, жинхэнэ сурвалжлагч хүн байна.

Би, бидний амьдралын утгыг ойлгодог ийм хүнийг өндрөөр үнэлдэг. Та бид хоёрын санаа явцав нийлж байна шүү. Би гаккаад байлдааны явцын талаар илтгэе. Та ч гэсэн дуугүй байхгүй биз дээ. Ялангуяа өнөөдрийн тулалдаанд манайхан дайсны олон онгоцыг сүйрүүллээ гэж хэлээд Тогавагаас салав.

Тогава, Жанжин сүм дэх нисэх отрядын штабт буцаж ирээд элдвийг бодож, дэнсэлсэн сэтгэлээ тайвшруулахыг мэрийж янжуураа асаан уугиулж гарлаа.

... Одоо чинь яах билээ. Тай са Коворо, Гигаад саяын тулалдааныг чин үнэнээр нь илтгэхгүй! Миний хэлсэн үгэнд түшиглэн худлаа бурна. Эзэн хааны армийг ялагдаж байна гэж ямар ч тэнэг хүн хэлж зүрхлэхгүй. Тэгвэл толгойгүй болно гэсэн үг! Би ч гэсэн аятайхан өгүүлэл бичье. Харин юу гэж нэрлэх вэ? Ер нь шатаж байгаа тэнгэр гээ. Онгоцны дотор талд тийм их халуун байсан юм чинь агаарт бол бараг 100 градус хүрээ байлгүй дээ...

Тогава хашир сууж халуун чулуу тэвэрч явсан хүн, армийн нэр сүрийг урдаа бариад ямар ч хариуцлагаас мултарч чадна. Хэрэв үнэнийг нуугаад мэхэлсэн байна гэж хэн нэг хүн хэлбэл түүнийг дөнгөхийн тулд «Улааны үзэл санааг дэмжиж, армийн нэр төр рүү дайрч байгаа урвагч» гэж зүтгээд өнөөхөө нугаслачихна. Тиймээс квантуны армийн нисэх хүчнийхэнд нислэгийн уран чадвар, туршлага, зориг хатуужил, сэтгэхүйн тэвчээр маш их дутагдаж байгаа төдийгүй онгоцоор маневрлах, байлдааны сахилга батаар оросын нисэгчээс маш дутуу байгааг нуун далдлах нь түүний эрхэм зорилго байлаа.

...Манай хоолны савнууд даанч хоцрогдсон байна. Ялангуяа сэтгэл санаагаар амархан унаж, жирийн тэнцвэргүй мөчийг гарцаагүй мөхөлд учирсан аймшиг болгон ойлгодог сэтгэхүйн хэвшмэл зан чанартай болжээ. Тиймээс байлдааны сахилга батыг зөрчиж, хувийн нислэг дураараа хийж, ашигтай маневрлах бололцоогоо алдаж байгаа юм. Нислэгийн уран чадварыг олон хэлбэрээр эзэмшээгүй, залуу нисэгчээр нөхөн сэлбэлт хийжээ. Тэгээд олон жил хэвшсэн улиг домог болсон өнөө сонгомол арга гэдэг нэрээр халхалсан нислэгийн босоо, шулуун чиглэлийг эрхэмлэн байлддаг болохоор нислэгийн чадвар нь хоцрогджээ. Гэтэл оросуудыг хар даа! Ямар ч чиглэлд байраа өөрчилж, хажуу, налуу, хэвтээ, босоо, шулуун чиглэлд дуртай үедээ онгоцоо 360 градус эргүүлж чаддаг болохоор чөлөөт уналт эгц шумбалт, огцом дайралтыг манай нисэгчдийн байлдааны аргын эсрэг сайн эзэмшиж чаддаг байна. Гэхдээ над шиг будааны хүн ийм юман дээр цэцэрхээд хэрэггүй! Амаа жимийгээд мэдсэн ч

мэдээгүй юм шиг дүмбийж явдаг хэрэг. Тогава ингэж элдвийг эргэцүүлэхдээ Баян Цагааны тэнгэрт болсон байлдааныг санатал сэтгэлийн угт ямар нэг аймшиг хураад нүдэнд нь агаарт дүрэлзэн оволзож байсан өнөө сүрт галын хуйларсан дөл харагдах шиг болсонд зэвүүрхсэндээ «Тийм юмны дундаас амьд гардаг мөн аз шүү» гэж шивнэж суухад Комацубарагийн тушаалаар хөдөлсөн хэсэг цуваа Жанжин сүмээс монголын хил рүү чиглэсэн байлаа.

Дөрвөн машин цэрэг, хоёр танкаар хамгаалуулсан гурван суудлын тэрэг Жанжин сүмээс зүүн тийш зурагсан замаар Овоо уулын хойгуур гарч, Хөгийн нуурын дэргэд байгаа Анцагай сууринг чиглэв. Тэд тэндээсээ Яньху (Цоохор морьт) нуурын чиглэлээр монголын хилийг давж, Зэгст нуураас Баян Цагаан руу хурдлав. Баян Цагаан эндээс шулуун замаараа 30 бээр ажээ.

Симото энэ замыг сонгон авч, генералын аюулгүй байдлыг хангажээ. Гурван жижиг тэрэгний түрүүчийн тэргэнд сууж явсан Аяанаосу,

- Симото, жанжин штаб армийн ажиллагаанд дурамжхан байгаа бололтой. Ер нь олигтой амжилт гаргахгүй нь гэдэг яриа их дэлгэрчээ. Зарим дарга нарын илүү дутууг нягтлах нууц шийдвэр, кэмпэйтэйн төлөөлөгчдөд ирсэн чимээтэй гэхэд Симото хэсэг дуугүй явснаа,

- Жанжин штабынхан, хүний ул шагайхаас өөр юу хийж байлаа. Чи Сафроновыг яаж гоочилдгийг мэднэ шүү дээ. Хато генералын холын садангийн нэг залуу жанжин штабын тагнуулын газар байдаг. Хато, садангийнхаа залууд дэл сул юм бичиж явуулдаг болохоор дараа нь манай тагнуулын газар янз бүрийн хов жив ирдэг. Тэгээд манайхан, штабын дээд удирдлагын шийд гэж дуулахаараа хий айгаад сүнс зайлчихдаг болохоор харыг цагаан болгож, цагааныг хар болгож байсан ч дуугүй байдаг шүү дээ. Зарим дарга нар нь дээд газрын нэр барьж бие биенийхээ өөг төнхөхийн тулд ашиглаж, давслаад худлаа танилцуулчихна.. Тэгээд тэр дарга ингэ гэсэн.. Энэ дарга тэг гэсэн гээд нэрийг нь бариад юу бодсон санасныгаа хийж, далимдуулж амждаг!, Хүн гүтгэсэн ч тэдний дур. Гүтгүүлсэн хүн өнөө чиглэл өгсөн гэдэг даргатай нь уулзаад асуух биш дээ. Очоод уулзъя ч гэсэн нөгөөдүүл нь туслахтай нь яриад тийм хүн ирвэл битгий уулзуулаарай гээд захичихна. Намайг Доихарагийн штабт байхад бас Сафроновын туршуулыг шалга, ингэ тэг гээд байдаг байсан. Хэн ингэж будлиулж байгааг би мэддэг боловч өнөө тэг ингэ гэсэн даргатай нь уулзаад та ийм удирдамж, чиг өгсөн үү гэж асуултай нь биш дээ. Гэтэл Сафроновын туршуулууд шиг хэрэгтэй хүмүүсийг оросын нутагт бэлтгэж явуулдаг ажлыг түүн шиг зохион байгуулдаг хүн хэн байна даа. Гэтэл Хатогийн хамаатан, тэр генерал тэг гэсэн, энэ дарга ингэ гэсэн гээд бидэнд тушаал дамжуулаад сууж байдаг. Гэтэл үнэхээр тэр генерал, дарга нар тийм тушаал өгсөн эсэхийг бид мэдэхгүй шүү дээ гэж учирлан тайлбарлав.

- Симото, чи Халх голд амжилт олж чадна гэж бодож байна уу? Баян Цагаанд оросын алдартай дарга нарын нэг Жукова (япон хэлэнд дан В авиа байдаггүй учраас бичигт ВА үе тэмдэглэдэг) гэдэг хүн ирчихээд байгаа юм байна.

- Жукова бол маш хянуур, алсын бодолтой, хашир төдийгүй юмны нарийн учрыг сайн мэддэг хүн! Тиймээс 1937 онд манай жанжин штабаас оросын цэргийн дарга нар нам төрийн удирдлагын бүрэлдэхүүнийг задлан сарниулах талаар явуулсан гүтгэлэгт өртөөгүй хүн.

Манайхны боловсруулсан гүтгэлгийн нөлөөгөөр улаан ороост багагүй будлиан дэгдсэн гэдэг. Тэгэхэд Жукова, Белорусын нэг морин корпусын дарга байсан. Тэр цэргийн дарга нарыг хилс хэрэгт зүй бусаар холбогдуулж байна гэж Сталинд захиа бичсэн гэдэг. Тэгээд Жуковагийн зөв болж шувтарсан гэнэ билээ. Ийм яггүй хүн оросын цэргийг удирдаж байгаа болохоор чиний хэлдгээр манайхан амжилтанд хүрэхгүй байж мэдэх юм. Хэрвээ Комацубара сан, Баян Цагааныг эзэлсэн ажиллагаагаа цааш нь үргэлжлүүлж чадахгүй бол эцсийн горьдлого таслах шинэ ажиллагааг бэлдэх нь гарцаагүй.

Тэр бүтэлгүй болбол одоогийн удирдлагын ихэнх нь өөртөө сеппуку үйлдэхгүй бол цэвэр нэртэй үлдэхгүй. Миний хувьд гэвэл цагийн байдлыг харж байж болно.

- Симото, уржнангийн ажиллагаа тийм сүртэй юм болсон уу?

- Тэр ажиллагаагаар юу болсныг мэдэхгүй л дээ. За тэгээд тийм ажиллагаа боловсруулсан юм бол ерөнхий сайдын ширээг булаалдаж байсан Хирото, Хаяси, Коноэ гурвын амнаас юу болсныг дуулах байх. За тэгээд тийм ажиллагаа боловсруулсан юм бол арваад жилдээ нийтэд мэдэгдэхгүй л дээ гэж хэлсэн Симото энэ мөчөөс хоёр жилийн дараа буюу 1941 онд Цузи Масанобу гэдэг хүн «Номонхан зикэн но боппацу буюу Номонханы үйл хэргийн эхлэл» гэдэг номонд дурдаж Чанчунд хэвлүүлнэ гэдгийг яахан мэдэх билээ.

Аяанаосу, квантуны армийн штабын монголын асуудлыг эрхэлдэг тусгай газрын ажилтан төдийгүй өвөр монголд явуулж байгаа тагнуулын ажиллагааг удирддаг хэлтэст ажиллах болсноос хойш гадаад монголын асуудалтай дам холбогдох болжээ. Аяанаосу, зургаан сарын сүүлчээр Уэдагийн тушаалын дагуу Халх голд явуулах Комацубарагийн ажиллагаанд штабаас тавих тусгай хянах хэсэгт оролцох болсон. Тэгээд хэд хоногийн өмнө эхлүүлсэн ажиллагааг ажиглах комиссын бүрэлдэхүүнд багтжээ.

Жанжин сүм дээр ирсэн штабын комиссынхан Комацубарагаас сайхан мэдээ дуулаад газар дээр нь очиж үзэхээр Жанжин сүмээс гарсан нь энэ билээ. Симото, Аяанаосутай ярилцаж явахдаа «Эд нарыг Халх голоор гаргана гэдэг хэцүү дээ. Өнөө өглөө хийсэн манайхны довголгоо амжилтанд хүрсэн бол эднийг Халх голын цаана гаргаж болно. Тэгэхдээ Таг нуур, Шал толгойн чиглэлээр тохойн зүүн талаар гол гаргасан дээр. Хэрэв Оонын хавь газраар Баян Цагааны эгц урдаас гаргачихвал хожим ухрах хэрэг гарвал Оонын манхан гай болж мэднэ» гэж бодно.

- Симото, Халх голын ажиллагааг алс дорнод руу чиглүүлсэн Доихарагийн армийн ажиллагаатай зэрэгцүүлсэн бол илүү найдвартай байсан юм биш үү гэж Аяанаосуг асуухад Симото хэсэг бодсоноо санаа алдав.

Долоо хоногийн өмнө Ойдов, Аяанаосутай уулзахдаа төвийн даалгаврыг дамжуулсан байлаа. Төв квантуны армийн цаашдын ажиллагаанаас намар, өвлийн улиралд тавьж байгаа төлөвлөгөөт зорилтыг сонирхсон. Тиймээс Комацубарагийн сэтгэлийн эчнээний бодол санааг Симолагийн амнаас сонсож, штабын ажиллагаатай уялдуулж тоймлох ашигтай байлаа.

- Аяанаосу сан, би чам шиг ингэж бодож байсан. Харин Комацубара, өөрийнхөө төлөвлөсөн

төлөвлөгөөний дагуу хөдөлж азаа үзэх гээд байгаа юм. Тэгээд ч армийн удирдлага энэ саналыг нь дэмжээд байгаа. Хэрвээ Баян Цагааныг аваад цааших ажилдаа төлөвлөгөөний дагуу орвол юуны өмнө Харширээгээс нааш нь төмөр зам тавиулж ар талын бат баазтай болоод цаашаа монголын гүн рүү давших бодолтой байгаа. Тиймээс энэ намар Тозиягийн ажиллагааг шуурхайлна. Гэтэл Баян Цагаан гээд ямар нэг юм бодсон бололтой өөр зүйлээр дүйвүүлж өнгөрлөө.

Квантуны армийн төлөөлөгчдийг Халх голын гарман дээр ирэхэд Кобояси өөрийнхөө штабын дарга нартай ирж генералаа угтлаа. Суудлын тэрэгнүүд Халх гол дээр тавьсан хөвдөг гүүрээр гарч бургасанд барьсан жодгорт ирлээ. Комацубарааг дагалдан яваа хүмүүсийн хамт хээрийн штабт ороход дивизийн тагнуулын тусгай төлөөлөгч Симототой уулзаж Баян Цагааны байдлыг сэм танилцуулж амжлаа. Харин Кобоясигийн цагаан царай ягаарч чихээ хүртэл улайгаад «шаварт унасан шарын эзэн» гэгчээр Баян Цагааны байдлыг генералдаа танилцууллаа.

- Гакка, одоогоор байдал хүнд болоод байна. Улаан оросууд бүх хүчээ татаж энд авчраад байна. Одоогийн байдлаар бол манай зүүн талд монголын цэргийн нэр хороо танкийн болон хуягтын довтолгооныг их буугийн галын дэмжлэгтэй хийж Халх гол руу биднийг шахах төлөвтэй байна. Бидний эгц өмнөөс мотобуудлагын нэг хороо, хуягт бригадын дэмжлэгээр давшиж, баруун гар талаас монголын морьт хороо, танкийн хоёр батальон довтолж байна. Эдний гол зорилго бол биднийг Халх гол руу хумин шахаж устгах зорилготой юм. Тиймээс Баян Цагаанд байгаа дөрвөн хороог Халх голын цаад эргийн дагуу байрлуулж хориглох нь бидэнд ашигтай гэж илтгээд генералынхаа царай руу эгцэлж харалгүй хээрийн ширээн дээр байгаа газрын зураг руу гөлөрнө.

- Өглөөний нислэгийн дэмжлэг ямар үр дүн өгсөн бэ? гэж Комацубарааг ууртай асуухад Кобояси арга буюу,

- Оросуудын онгоц угтан байлдаж илт давамгайлсан. Түүнээс болоод манай онгоцнууд оновчтой газрыг бөмбөгдөж чадаагүй гэж арай ядан хэлэв.

Комацубара, Баян Цагаанд болсон явдлыг мэдэнгүүт Кобояси руу хяламхийсэн догшин харцаар цоргим ширтэж байснаа Ясуко руу залгуулав.

- Ясуко, чиний танкнууд яасан бэ? Газар нүхлээд элсэнд шургачихаагүй бол нааш нь хурдан хөдлөг! Чиний бүтэлгүй ажиллагаа оросуудыг өөгшүүлж байна. Танкаа нааш хурдан явуул!

- Гакка, манай танкнууд байлдааны талбай дээр оросуудтай тулалдаж байна. Бид Хайлаастын манхан, Такайса өндөрлөгийг өнөө шөнө эзлээд өглөө гэхэд Баян Цагаанд очсон байна гэж илтгэлээ.

- Тэгвэл, бэлтгэлээс дөчин танк гаргаж нааш нь хурдан явуул. Чи өнөө шөнө наад оросуудаа устгаад Баян Цагаанд ирэхгүй бол миний царай харахгүй гэж мэдээрэй гэж загнахад Ясуко,

- Эрхэм дээдсээ тушаалыг ёсоор биелүүлнэ гэлээ. Баян Цагааны байдлыг сайжруулах талаар Комацубарагийн туслахууд нэлээн санаачилга гаргасан боловч ямар ч үр дүн өгсөнгүй.

Оросууд хүчээ нэгтгэн шинэ хүчээр дахин довтоллоо. Оройн гэгээ тасарч, алсын бараа танигдах төдий байхад Комацубара, дагуулуудынхаа хамт галын шугам дээр ирлээ. Комацубара, байлдаанд өртсөн танк хуягтын сэг тамтаг, үхсэн морьд, цэргийнхээ хүүрэн дундуур явж байлаа. Улаан орос довтолгооноо түр зогсоосон болохоор хааяа тээр тэртээ их бууны лүн лүнхийх чимээ сонсогдож, пулемётын богино ээлж тачигнах хааяа сонсогдох нь дөрвөн шөнө өдрийн турш байлдсан хоёр талын цэрэг нэлээн сульдсаныг гэрчлэх мэт ээ. Комацубара цэргүүдийнхээ бүрсгэр урамгүй царай, гутарч гуньсан байдал, байлдаанд залхан халширсан шинж, их бууны сум, бөмбөгдөлтөнд маанагтан гөлийсөн төрхийг хараад Баян Цагааныг удаан барьж чадахгүй гэдгийг хэнээр ч хэлүүлэлтгүй ойлголоо. Зуны сүүл сарын шинийн сарны сар саруулд нижигнэсэн их бууны гал хориод мөч үргэлжилж их бууны суманд өртсөн бүхнээс гал гарч сарны цайвар гэгээнд танк их бууны сэг ёрдойгоод энд тэнд шатаж буй даавуу, тос бензин, хүн морьдын хүүрний нялуун үнэр, дарь хүхрийн эхүүн үнэртэй холилдон цээж давчдуулан ой гутаана. Их бууны гал зогссоны дараа танкны харжигнасан чимээ Баян Цагааны тэнгэрт цуурайтан оросын шинэ довтолгоо эхлэхэд Кобоясигийн дэргэд зогсож байсан штабын дарга,

- Эрхэм дээдсээ, маш яаралтай голын нөгөө эрэгт гарах хэрэгтэй! Оросуудын шөнийн довтолгоо эхэллээ. Оросуудын зүүн жигүүрээс хүчтэй довтолж баруун жигүүр нь их бууны галаар манай хориглолтын баруун хэсгийг... гээд дараагийнхаа үгийг хэлж чадалгүй мөрөө хавчисхийн хөдөлгөлөө. Комацубара, өөрийнхөө баруун жигүүрийн хэсэг буюу 71 дүгээр хорооны штабын газар нүхэн байрнаас гарах гэтэл их бууны сум штабын нүхэн байрнаас зайдуухан тусаж, газар доргин хана туурга яйжигнаасхийхэд ширээн дээр байсан дэн газар уналаа. Комацубарааг штабын газар байрнаас гарч ирэхэд штабын байранд нэлээн ойролцоо дахин их бууны сум тусаж дэлбэрэх чимээнээр харилцах шуудуунд байсан дарга нар цөмөөрөө газар хэвглээ. Комацубара, газар элэгдэн хэвтсэн дарга нарыг хараад «Аргагүй л бууны дуу сонсоогүй штабынхан мөн дөө» гэж дотроо бодоод сумны дэлбэрэлтээс агаарт цацагдсан хэсэг шороо генералын төмөр дуулган малгай, цээжний хамгаалалт канадо дээр унахад түүнийгээ гөвөх зуур өөрөөсөө холгүй зогсож байгаа Аяанаосу руу хараад дэргэд нь ирж, цээжний дуулган дээр унасан элсийг гараараа сэгсэрч унагаад инээмсэглэв.

Бусидогийн тангараг ёсоор бол Аяанаосу биш, харин газар элэгдэн унасан самурай нар Аяанаосу шиг номхон зогсож байх дэгтэй. Гэтэл тэд амиа хоохойлохыг эрхэмлэснийг хараад уур омог нь бадарсан Комацубара өөрийнхөө дэргэд номхон зогсож байгаа харь хүний зүтгэл идэвхийг үнэлэхгүйгээр өнгөрч болохгүй нь мэдээж билээ. Тэнгэрийн элч хэмээгддэг тэнноод тангараг өргөсөн рёмин буюу тэнгэр угсаат хүмүүсийн оронд, монгол угсаатны хүү Аяанаосу самурайн ёсыг сахиж чадсан нь Комацубарагийн сэтгэлд үл таалагдах авч арга буюу түүний хувцсан дээр буусан элсийг арилгаж ёс алдсандаа генерал өөртөө унтууцан уурлаж байлаа. Комацубара, яагаад Аяанаосугийн канадо дээр байгаа элсийг тэгж арчиж унагаснаа өөрөө ч мэдээгүй билээ.

Канадо бол японы армийн удирдах хүмүүсийн байлдаанд өмсдөг цээжний дуулга юм. Тэр дуулганы мөрөн тал нь өргөн бөгөөд дотор талдаа ган, хулсаар давхарласан хамгаалалттай. Түүнийг бүрсэн даавуу нь дарга нарын хувцасны өнгөтэй адилдуу аж. Цээжин талыг нь нимгэн ган хуудас, хулсан савхаар хуяглахдаа эртний самурай нарын өмсдөг ёрон хэмээх дуулган хувцасны ко гэдгийг дуурайлган орчин үеийн байдалд тохируулжээ. Цээжиндээ

өмсдөг канадо дуулганы хормой нь хуцны хөг шиг мухар агаад цайвар эмжээрээр захалж дээгүүр нь бүс бүсэлсэн боловч хормой нь дундад зууны самурайн дуулганы хуяг ко гэдгийн хормой хэсэг кусазуригийн адил дөрвөн талдаа оноотой ажээ. Цээжний дуулганы ар хэсгийг до гэнэ. Канадогийн урд цээжин хэсэг ар нурууны хамгаалалттай холбосон хэсгийг бат сайн хийдэг уламжлалтай. Энэ бол кэсагири буюу хүний мөрнөөс хүйс хүртэл тас цавчих сургууль хийсэн, морин цэргийн байлдааны сэлэм синкэн сёбугийн ирнээс хамгаалахад зориулжээ.

Комацубара, Аяанаосугийн цээжний дуулга руу гөлөрч зогсохдоо сэтгэлийн бухимдлыг түр тайвшруулаад,

- Шиү са Аяанаосу сан, наадуулаа босгоод миний хойноос очоорой гэсэн Комацубара, канадогийн бүснээс уяатай япон сэлэмний (нихон то) ишин дээр баруун гарын алгаар дарж бөхийсөөр хурдан алхалж Баян Цагааны бэлд байгаа тэрэг рүүгээ зүглэв. Газар хэвтсэн дарга нар босож тоос шороогоо гөвөлгүй генералынхаа араас гүйхэд Симото Аяанаосугийн дэргэд үлдээд,

- Шиү са, та чинь яахаараа ийм овсгоотой байдаг байнаа. Саяын их бууны сумны дэлбэрэлтэнд цочоогүй юм шиг үлдсэн чинь гаккагийн сэтгэлд тун их таалагджээ. Гакка чамайг генерал ч болгож мэднэ шүү. Цаадах чинь зоригтой хүнийг их үнэлдэг юм гэхэд Аяанаосу,

- Симото минь, сая чинь хаа хамаагүй хол туссан их бууны сумны доргилт боллоо шүү дээ гэхэд Симотогийн царай үл мэдэг улайв. Үнэндээ хоосон буунаас хорин хүн айна гэгчээр дэндүү арчаагүй байдал гаргаснаа ойлгосон Симото, Комацубарагийн хойноос алхав.

Шөнийн сарны гэрэлд гурван тэрэг Халх голыг өгсөж уруудан давхина. Тэд голоор гарах гарам, гүүрээ хайж яваа ажээ. Эхний тэргэнд армийн штабаас яваа хэсгийг ахалсан хошууч генерал Сурику гэгч Комацубаратай зэрэгцэн суусны зэрэгцээ Уэдагийн туслахын нэг Сурикугийн баруун талд суужээ. Харин урд талын суудалд Комацубарагийн туслах жолоочтой зэрэгцэн суусан болой. Хошууч генерал Сурику бол бэхлэлтийн инженер төдийгүй архитектор хүн ажээ. Тэрээр Халх гол хүртэлх газар дээр томоохон бэхлэлт байгуулах ажлыг удирдахаар ирсэн ажээ.

- Шиү жёо миний бодож байгаагаар бол манай төлөвлөсөн бэхлэлтүүд маш найдвартай юм. Ийм бэхлэлтийг юуны өмнө Фуйтакаса (Хуруу өндөрлөг) Такасай өндөрлөгт (Нэргүй өндөрлөг буюу, Ремизовын өндөрлөг) байгуулах маш чухал төдийгүй газрын байдлын хувьд ч тун тохиромжтой юм байна. Энэ хоёр өндөрлөгийн хооронд ихээхэн хэмжээний хотгор бий болохоор цэргийн бүх төрлийн тээврийн хөдөлгөөнийг дайснаас далдалж чадах тул газар доогуур харилцах суваг болгон ашиглах хэрэгтэй. Түүгээр барахгүй дээрх хоёр өндөрлөгт газар доогуур бэхлэлтийн байгууламж барих болно. Үүнд тэр барилга байгууламж нь хүнсний агуулах, зэвсгийн агуулах, хүн эмнэлэг, морьдын тэжээлийн байр, машин засварын газар, цэвэр усны нөөцийн хэсэг, бөмбөгдөлтөөс хоргодох цэргийн байр зэрэг зүйлээс бүрдэнэ. Нөгөө талаар энэ газар чинь хойд хэсгээрээ Халх гол болон элсэн манхнаар хашигдаад баруун талаараа Хайлааст голд шахагдсан болохоор эдгээр нь манай бэхлэлтэнд ашигтай усан хаалт болж байгаа юм гэж тайлбарлахад Комацубара генералаас,

- Ийм маягийн бэхлэлтийг байгуулахад аль зэрэг хүн, хүч хэрэгтэй вэ? гэж асуулаа.

- Нэг бэхлэлтийг арван тав хоногт байгуулах хүн хүч, материалын бэлтгэлийг бүрэн хангасан. Тэгэхдээ өдөр шөнийн гурван ээлжээр шүү гэхэд Комацубара сэтгэлдээ «Инженерийн гурван хороог ажиллуулахаар тооцоолсон байна» гэж бодлоо.

- Отани сан, бид чинь голоор гарах болоогүй юу гэж Комацубарааг асуухад өвөр дээрээ газрын зураг дэлгээд шагайж явсан туслах нь,

- Гакка, бид гарам гүүрээ олохгүй төөрчихлөө. Энэ хавьд байх ёстой юмсан гэхэд Комацубара дургүй нь хүрсэн янзтай,

- Чи өөрийнхөө зураг дээр тэмдэглээгүй юм уу гээд байлдааны зурагтай цүнхээ өглөө.

Шөнийн сүүн цагаан гэгээ хийгээд Баян Цагаанаас буудсан гэрэлт сумны туяанд голын усны мэлтэгнэсэн мандал гялтганан мяралзах агаад хааяа их бууны сум голд тусахад бөөн усан хуй тэнгэр өөд цацрахыг ажвал гадаад далайн догшин шуургыг санагдуулам сүртэй зэвүүн болой. Байлдаан дотроос хамгийн аймшигтай нь шөнийн байлдаан билээ. Гэрэлт сумнууд харанхуйд сүлжилдэн, аалзны тор шиг хэрэхийг харахад сэтгэлийн угт «Энэ золбин сум хэдийд миний хаана тусах бол» гэдэг аймшигт бодол хэн хүний дотор тусна. Тэгж бодсон хүн, юу юуны туханд хүрэлгүй эчнээний аймшигт захирагдан биеэ чагнах нь сэтгэлд айдас хүйдэс хурсныг илэрхийлнэ. Хүний сэтгэлийн өвөрмөц энэ зүй тогтлыг сэтгэл зүрхээрээ мэдэрсэн Комацубара, үе үе өөрийнхөө гар хөлийг ажиглаад нэрэлхүү зангаар биеэ барина. Гэвч хааяа зэвүүрхэх бүртээ,

- Болгоомжтой яваарай! Их сандарч болохгүй шүү гэж жолоочдоо захих нь өөрийнхөө айсныг нуух гэсэн оролдлого байлаа.

Комацубарагийн жолооч гүүр хайж замаа ширтэж явсан энэхэн үед тэдний арын суудлын тэргэнд сууж яваа Симото, Аяанаосу хоёр байлдааны цаашдын хувь заяаг шүүн ярилцана.

- Симото, Баян Цагааны сүйрлийг чи эрт мэдсэн үү? гэж Аяанаосуг асуухад Симото,

- Жанжин сүмээс гарахаас таван цагийн өмнө гадарласан юм. Довтолгооныг Комацубара оройтуулсан болохоор бидэнд ямар ч ашиг гарсангүй. Ядаж тав хоногийн өмнө эхэлсэн бол учиртай байсан. Нөгөө талаар 6 дугаар сарын 27-нд Тамсаг, Баянтүмэнийг ямар ч зорилгогүй ашиггүй бөмбөгдсөн явдал Жуковаад довтолгооны төлөвлөгөөг сэжиглэх баримжаа олгосон, Жукова шиг тийм хашир хүн үл ялиг сэжиг төрүүлэх эгзэг гаргавал асар богино хугацаанд сөрөг довтолгоо боловсруулж, хүчээ хуваарилж чадна гэдгийг Комацубара тоосонгүй. Ер нь манайхан орос, монголын цэргийн хүчийг хэтэрхий дорой гэж ойлгодог нь бидний хамгийн том алдаа! Энэ хоёр сард үзсэн миний нэг шарх бол элэг эмтэлж, сэтгэл сэвтүүлсэн шарх юм. Тэр шарх надад дайсныхаа давуу талыг олж харж, мэдэж чаддаг байгаагүйгээс болж үлдсэн юм гээд санаа алдав.

- Симото, чи сэтгэлийнхээ тэр шархны талаар гаккаад дурссан уу?

- Дуулгаад яах юм бэ? Гакка самурайн бусидо, цэрэг эрсийн замналыг биширдэг болохоор өөрийнхөө цэргийг хэзээ ч ялагдашгүй гэж үздэг юм чинь миний үгийг дуулбал хээрийн шүүхэд шилжүүлнэ шүү дээ. Түүнээс бидний алдаа юунд байна вэ? гэдгийг тунгаах чадвар манайхны хэнд нь ч байхгүй шүү дээ! Алдааг нь олж хэлсэн хүнд өширхөж, далим гаргаж амьдралаас хагацуулдаг ёс бидний дунд ноёрхоод одоо дийлдэхээ байсан.

- Тэгвэл энэ байлдаанд бид ялагдаж таарах нь ээ гэж Аяанаосуг асуухад Симото хэсэг бодсоноо,

- Эцсийн дүнг гаргах цаг болоогүй байна. Комацубара армийн нэрт инженерийн боловсруулсан зураг төслөөр Халх голын наад талд томоохон бэхлэлтүүдийг энэ намар бариулж амжвал асуудал өөрөөр эргэнэ. Тэр бэхлэлт бол тун нарийн хийгдсэн зүйл байна билээ. Бүх юмыг газар доогуур байрлуулсан учраас бид Халх голд өвөлжөөд хавар хүртэл бэлтгэлээ сайн базааж авсан ч болохоор юмдаг. За тэгээд «Баян Цагааны авралаас» гадна «Косэйтоку» гэж маш том төлөвлөгөө бий шүү дээ. Энэ чинь гурван шаттай бэлдсэн төлөвлөгөөний эцсийн цохилтын төлөвлөгөө байгаа юм гэхэд Аяанаосу, халааснаасаа архи гаргаж балгаад,

- Чи балгах уу гэхэд Симото Аяанаосугаас архийг нь аваад,

- Цөмийг нь уучихвал дургүйцэхгүй биз гэхэд Аяанаосу толгой дохиод,

- Надад өшөө бий шүү гээд цүнх рүүгээ заалаа. Симото, жаахан халчихаараа эчнээнийхээ бодлыг ам мэдэн ярьдаг зантай болохоор Аяанаосуд «Косэйтокугийн» талаар мэдэх бүхнээ ярих нь гарцаагүй билээ. Квантуны армийн намрын ажиллагаа нь Хайлаастын хоёр талд байгаа түшиц газраа хамгаалан томоохон бэхлэлт байгуулахад чиглэсэн боловч намар ямар нэг шинэ довтолгоо хийхгүйгээр бэхлэлтүүдээ хамгаалан, хориглон байлдаж өвөлжих үү? Эсвэл шинэ довтолгоо сэдэх үү гэдэг нь Аяанаосуд мэдэгдээгүй байсан. Гэтэл Симото, халсан амандаа «Косэйтокугийн» тухай ярьсан нь Аяанаосугийн анхаарлыг татав. Учир нь хоёр долоо хоногийн өмнө армийн штабын даргын туслах Аяанаосутай уулзаад Халх голын ажиллагаанд бэлдсэн тагнуулын ажлын талаар асуугаад зарим нууц баримтуудыг авахдаа «Шинэ арми байгуулж магадгүй» гэж учир холбогдлыг нь цухас сонсгож билээ. Аяанаосу Симотогийн амнаас «Косэйтоку» буюу ерөнхий цохилтын төлөвлөгөөний талаар сонсоод сэтгэлдээ «Шинэ арми... Косэйтоку хоёр холбоотой юу? Өвөр монголд Дэ вангийн цэргийг өөртөө багтаасан 4 дүгээр арми гэгч монголын өмнөд хилийн дагуу байрлаад байгаа... Алс дорнод руу чиглэсэн Оцу төлөвлөгөөний дагуу 5 дугаар армийг байгуулсан! Тэгвэл Косэйтоку төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд шинэ арми байгуулах нь... шинэ арми нь 6 дугаар арми байх хэрэг үү?... Квантуны арми одоо 350 мянган цэрэгтэйгээс гадна солонгост байгаа 60 мянган цэрэг квантуны армийн бүрэлдэхүүнд ордог учраас үнэн чанартаа 410 мянган цэрэгтэй. Шинэ армийг байгуулбал 500 мянган цэрэгтэй болох нь» гэж бодлоо.

Симото амандаа халаад Аяанаосуд санаандаа орсон бүхнийг ярьж байтал жолооч Халх гол дээр тавьсан хөвдөг гүүрээр гарлаа. Харин Симото,

- Гүүр гарангуутаа зогсоорой. Би тэндхийн дарга нартай уулзана гээд Аяанаосугийн чихэнд «Гакка, гүүрийг дэлбэлээрэй гэж тушаасан» гэж шивнэн хэлээд суудлын тэрэгнээс буулаа,

Тавдугаар бүлэг

Косэйтокугийн мөхөл

Нэг. Яарвал сүйрдэг

Квантуны армийн нисэх хүчин Халх голын Хөх-Өндөрийн дэргэд 120 онгоцоор дайралт хийгээд олон онгоцоо алдаж сүйрсний маргааш Шанхай дахь Ван Зиньвэй гэгчийн засгийн газар японы дэмжлэгтэйгээр үйлдвэр санхүүгийн банк байгуулж, 37 сая иений хөрөнгөтэйгөөр ажилдаа орлоо.

Шанхайгаас гадаадын үйлдвэр худалдааны нөлөөг шахан зайлуулахын тулд японы засгийн газраас Шанхай болон фронтын ойролцоо хотуудад стратегийн холбогдолтой бараа худалдаалахыг зогсоож гагцхүү Шанхай дахь японы цэргийн гарнизоны зөвшөөрлөөр зарим зүйлийг худалдаалахыг зөвшөөрдөг боллоо. Ингэснээрээ японыхон хятад дахь гадаадын үйлдвэр, худалдааны эздийг хавчин боож, хяхсан учраас арга барагдсан үйлдвэр худалдааны 21 байгууллага, хувийн худалдааны 81 пүүсүүд Ван Зиньвэйн тоглоомын засгийн газраас байгуулсан үйлдвэр худалдааны зөвлөл гэгчид харьяалагдах боллоо.

Японы засгийн газар, хятадын төв хэсгээс гадаадын худалдаа үйлдвэрийнхнийг шахан гаргах гэсэн энэ арга хэмжээнд их гүрнийхэн дургүйцжээ. Тиймээс Шанхай дахь америкийн худалдааны танхимаас хятад японы аж үйлдвэр, худалдааны банкны үйл ажиллагаанд зохих хэмжээний хориг саад хийхийг өөрсдийн эрхэм үүрэг гэж үзжээ.

Шанхайн үдэш далайн тэнгэрийн хаяанаас эхэлдэг заншлаараа эхлээд алгуурхандаа цагаан гэгээ тасарч, үдшийн бүрэнхий болж, Гарден гүүрэн дээр зогсож Шанхайг харж байсан нэгэн эр, соотон чихтэй герман угсааны нохойгоо хөтөлсөөр Нанжинлу гудамж руу гэлдэрлээ.. Энэ хүн Шанхайд ирээд нэлээд удаж байгаа атал Эдуард-III гудамжинд байдаг цэнгээний газраар хөлхөлддөг ихэс дээдсийн дунд нэр нь төдий их алдаршаагүй байлаа. Энэ бол бидний танил Эрхэмбаяр хэмээгдэх Буд болой.

Эрхэмбаяр, сэнсэй Тозияагийн өгсөн даалгавар ёсоор Шанхайд байдаг гадаадын их гүрний банкны дээд зиндааны хүмүүст талтай болохыг мэрийсээр орой бүр цэнгээний газрын хөзөрчдийн танхимд өнжих авч төдий их тоглодоггүй болой. Хөзөрчдийн яриагаар бол тэрээр «тоглох цагаа олж мөрий тавьдаг» хашруудын нэг болжээ.

Уужим танхимын баруун хойд талын өргөн ширээг эзэлсэн покерчид гаднаас орж ирсэн Эрхэмбаярын зүг нүд бэлчээн ажиглаад «Энэ түмэд залуу хэний халаасыг хоослох гэж яваа бол?» хэмээн бодоцгооно. Гарриман, Эрхэмбаярын бараанаар тоглож байсан ширээнээсээ босож, мөрийгөө хойшлуулаад дэргэд нь ирж инээмсэглэсээр,

- Покерийн ноёнтон, өнөөдөр азаа үзэх үү? гэхэд Эрхэмбаяр,

- Ноён Гарриман, та тун гялалзуур байна. Онгод чинь орсон өдөр бололтой! Тэгэхээр би халаасаа хоосолж энэ олон хүний нүдэн дээр нүцгэрнэ гэсэн үг гээд уруулаа үл мэдэг

хөдөлгөж инээмсэглэв.

- Та чинь хүний халаас хоослохдоо бирд шиг мөртлөө халаасаа хоослуулахдаа харуусаад байдаг, үнэг шиг хүн юмаа. Эр хүнд чинь алдсан нэг өдөр байхад авдаг нэг өдөр байдаг юм. Би танд тэгж их алдахдаа харамсаагүй юм шүү гэлээ. Гарриман тэр өдөр Эрхэмбаяраас сохор зоос хожилгүй нүцгэлүүлсэндээ болоод нойргүй хонодог болсон. Тэгээд түүнээс даагаа нэхэхийн тулд гурван хүн олж «хавсайдахаар» тохирсон боловч нэг аятайхан эгзэг гаралгүй өдий хүрсэн аж.

- За яая гэхэв. Би таны авьяасыг биширдэг хүний хувьд нэг суучихья гээд ширээний дэргэд ирэхэд хоёр орос хүлээж ядсан байдалтай байв.

- Гарриман, та бүр тоглох хүмүүсээ олчихоо шив дээ. Энэ чинь дэндүү шударга биш хэрэг шүү гэснээ,

- За, за би наргианд дуртай болохоор та хэдийг арай даваадуулж орхилоо. Ноён Гарриман, энэ зэргийн тоглоомыг даана биз дээ гээд Эрхэмбаяр зөөлөн түшлэгтэй сандалд суулаа. Чухам энэхэн үед танхимын үйлчлэгч ирж, тэдний ширээн дээр болор хундагатай архи тавиад холдлоо.

Эхний хэдэн тоглолт хүний сэтгэл зүрхийг догдлуулсан тоглолт болсонгүй. Ширээн дээрх мөрий ердөө тав зургаан мянгаас хэтэрсэнгүй. Чингээд Эрхэмбаяр аргагүй гар нийлсэн хамжаанд илт хавчигдаж байгаагаа ойлгов. Эрхэмбаяр хэд хожигдохдоо үе үе санаа алдаж, баруун гарынхаа долоовор хуруугаар хамрынхаа үзүүрийг оролдоод мөрийгөө нэмэх боловч хэтэрхий хордсон сэтгэлдээ болоод зогсохоо мэдэхгүй хий зүтгээд мөрийгөө алдаж байгааг ажсан Гарриман «Энэ золиг чинь хор шарандаа бүүр шатаж байх шив дээ. Ийм үед л алдсанаа олж авч чадна даа! Тоглоод байдаг хэрэг!» гэж бодно. Энэ өдөр Гарриманы мод гаргууд сайн байлаа.

Гол төлөв гурван тамга, хоёр ноён юмуу эсвэл дөрвөн ноён нэг тамга баригдаад байв. Эрхэмбаяр тав дахь удаагаа Гарримантай үлдэж мэрийсэн боловч мөрийгөө нэмэх тоолондоо алдаж байгаагаа ойлгоод санаа алдана. Энэ удаа мөн алдлаа. Тэгээд зургаа дахиа үлдээд нэг их бодолхийлсэн харцаар модоо ширтсээр долоовор хуруугаараа хамрынхаа үзүүрийг оролдохыг ажсан Гарриман «Бас муу мод ирж дээ. Мань хүн хорондоо бууж өгөхгүй бололтой. Миний мод гурван тамга хоёр ноён. Ингэхээр үзээд байдаг хэрэг!» гэж бодлоо. Ингээд Гарриман мөрийгөө бага багаар ахиулж, муу модтой хүн шиг уруу царайлж, сэтгэхүйн довтолгоо хийж, Эрхэмбаярт хожих нь гэдэг сэтгэл төрүүлэхээр тоглохыг эрхэмлэв. Ингээд хагас цаг болоход покер сонирхсон хүмүүс тэр хоёрын ширээг тойрлоо. Мөрий хоолойд тулсан хэмжээнд хүрчээ.

Эрхэмбаярын царай ягаарсан боловч хорондоо бууж өгөхгүй гэсэн шиг мөрийгөө хамаа намаагүй нэмнэ. Энэ бол нэг талаар хожигдсоноо мэдсэн хүний нэр төрөө хамгаалдаг сонгомол арга юм. Өөрөөр хэлбэл их алдсан ч хотойдоггүй баян гэдгээ үзүүлэх гэсэн эрмэлзлэлийн илрэл гэдгийг покерчид андахгүй. Тэгээд мөрийгөө төлөхдөө ийм хүмүүс «Та их азтай юм! Гэхдээ миний бүх бэлийг сэгсэрчих аз даанч алга даа» гэж хожсон хүний амыг асуудаг зуршилтай төдийгүй тас тас хөхөрч, бахархдаг уламжлалтай. Одоо Эрхэмбаяр нэгэнт

ийм байдалд орсон болохоор мөрийгөө өсгөхөөс сайхан арга байхгүй нь мэдээж байлаа. Гарриман хожил 100 мянгад хүрэх нь гэж ойлгоод,

- Бэлний хагас хуваарь нэмье гэж Эрхэмбаярын зүрхийг үхүүлэх санаагаар хэлэхэд Эрхэмбаяр Гарриманы хорыг малтах гэсэн шиг,

- Бэлийг бүтэн хуваарь нэмье гэхэд ширээ тойрч зогссон хүмүүс шуугиад явчихлаа. Хожил зуун арван мянгад хүрчээ. Эрхэмбаярын яв ягаан царайг харж суусан Гарриман «Би тэртэй тэргүй хожсоныг покерчид мэдэж байгаа. Одоо мөрий нэмбэл покерчид намайг гоочилж, яасан их шуналтай юм бэ? Одоо боль боль... Наадах чинь тэртэй тэргүй хожигдсон хүн! Хүнийг голгүй нүцгэлж болохгүй. Тоглоомын заяа гомдоно» гэж шаардана. Үнэндээ ширээ тойрсон хүмүүс тэгж шаардах нь зайлшгүй байлаа. Гарриманыг мөрийгөө нэмбэл үзэгчид «Бөөн шунал. Тоглоомын ёс мэдэхгүй бүдүүлэг. Авахаас өөр сүнсгүй цөөвөр чоно» гэж хочлох байлаа. Тиймээс Гарриман тоглоомын ёсыг эрхэмлэдэг нинжин сэтгэлтэй хүн болохын тулд Эрхэмбаярын хөзрийг үзье гэж санал гаргах ёстой. Ийм үед Эрхэмбаяр мөрий нэмэх эрхгүй бөгөөд хожигдсоноо мэдээд модоо дэлгэж бууж өгдөг. Ингэж бууж өгөн нүцгэрсэн хүнд хожсон хожлынхоо 0,05 хувийг мөрий дээр гар татаагүйн урамшил болгож өгдөг. Хожигдсон хүн их алдсандаа өш хонзон санахгүйн баталгаа болгож тэр урамшлын мөнгийг авдаг номтой. Гарриман хэсэгхэн бодож сууснаа,

- Ноён Эрхэмбаяраа, та бид чинь ямар өш хонзонгоор тоглож байгаа биш! Эр хүнийхээ нүнжгийг бодож, модыг чинь үзье гэхэд ширээ тойрсон хүмүүс «Гарриман зөв шийдлээ... Тэгэхгүй яахав дээ... Ямар тоглож үзээгүй залуус биш... Покерчин хүн, хүн чанараа эрхэмлэх ёстой» гэж ам амандаа шуугилдав.

Эрхэмбаяр уруулаараа үл мэдэг инээмсэглээд, долоовор хуруугаараа хамрынхаа үзүүрийг оролдсоныг ажигласан Гарриман «Тоглоомон дээр ингэж тоглодог хүн чинь хэн билээ. Эрхэмбаярын энэ чинь надад нэг их танил юм шиг санагдаад байдаг» гэж бодтол Эрхэмбаяр хөзрөө ширээн дээр дэлгэхэд покерийн хорхойтнууд дуу алдав.

Эрхэмбаярын мод нь дөрвөлжингийн дараалсан тав (тамга, ноён, хатан, боол, арав) байсныг мэдээд Гарриман хиртхийн цочихдоо олон жилийн өмнө нэгэн франц хүнийг ингэж хожсон залуу эрийг саналаа. Тэр хүн бол Хар чоно байсан аж. Гарриман, Эрхэмбаярын царай өөд гайхсан нүдээр хараад «Мөн байна. Хар чоно мөн байна. Тоглож байгаа байдал нь даанч танил байсан юм» гэж бодоод суудлаасаа өндийхдөө «Намайг мэхлэхийн тулд царайгаа зориуд улайлгаж байжээ. Хожигдсон хүн шиг тэгж царайлаад надаар мөрий нэмүүлж байсан заль! Үүнийг Хар чоно л хийж чадна» гэж сэтгэлдээ шивнэн хэлэв, Эрхэмбаяр покерчдын уламжлалыг дагаж мөрийнөөсөө Гарриманд оногдох хувийг нь өгөөд инээмсэглэхэд,

- Ноён Эрхэмбаяраа, та бид хоёр чинь үүний өмнө нэг тоглоход та хожиж билээ. Та ч аргагүй покерийн хаан юмаа гэхэд,

- Би олон хүнтэй тоглосон болохоор тэр бүгдийг яаж таньдаг гэх вэ гээд Эрхэмбаяр инээмсэглэв.

- Эрхэмбаяраа та, бид могой жилийн зун өдийд Харбинд тоглож билээ гэхэд Эрхэмбаяр

хэмээгдэгч Буд, Гарримантай нэг удаа тоглосноо санав.

...Жан Золинг нас барсны хойтон жил нь Харбинд ирсэн Хар чоно, орос, европын хэдэн худалдаачинтай нийлж гурван өдөр шөнө тоглож билээ. Тэгэхэд нэг франц, нэг америк залуу бараг нүцгэрэх дөхсөн юм. Хар чоно тэдний нэрийг тэр үед асууж байсан боловч эдүгээ түүнийг яахан санах билээ.

Эрхэмбаяр, хожлын мөнгийг ширээн дээрээс цуглуулаад цэнгээний газрын эзэнг дуудаж, ширээн дээр багсайсан мөнгө рүү заагаад,

- Үүнийг Иокогамма гингогийн дансанд шилжүүлчихээрэй гэхэд цэнгээний газрын эзэн толгой дохин тал засна. Тэр эзэн, Эрхэмбаярын мөнгийг тоо ёсоор банкинд шилжүүлээд зохих шагнал авдаг ажээ.

Эрхэмбаяр, цэнгээний газраас гарч гэрийн зүг алхахад Гарриман зам зуур хань болж баахан дагалаа.

- Эрхэмбаяр, та дандаа дагуултай явах юмаа гээд Гарриман гэдрэгээ санамсаргүй харлаа.

- Гарриман, та овоо ажигч юмаа даа гэж Эрхэмбаярыг хэлэхэд,

- Би таныг ажигласан юм биш. Покерчид таныг өдөрт нохойноос салдаггүй, үдэш болохоор эрэгтэй эмэгтэй хоёр хүн, ээлжлэн дагаж явдаг юм гэлцдэг шүү дээ. Шанхайнхан ажигч байгаа биз гэлээ. Үүнийг сонсоод Эрхэмбаяр сэтгэлдээ «Эмэгтэй нь яах вэ? Харин эрэгтэй нь юу юм бол? Тозияагийн даалгавраар намайг мөшгөж яваа нүд чихний өрөөсөн юм бол уу» гэж бодоод тоосон шинжгүй,

- Ноён Гарриман, та тоглохдоо жаахан зүрхшдэг болжээ гэлээ.

- Тийм их содон байна уу?

- Арван жилийн өмнө та надад мөрийгөө тоолж өгөөд ийм юманд хотойдог худалдаачин биш гээд яваад өгч билээ. Гэтэл одоо дагаж бараадаад нэг л ондоо байх чинь. Та чинь Шанхайн олон улсын банкинд яггүй танилтай гэл үү? Дам сонсвол Синьзинд байдаг нэг баян эмэгтэй та хоёр алтаараа банкныхны голыг зогоодог гэлцэх юм.

- Эрхэмбаяраа, Та хуучных шигээ бас банк сонирхсоор байна уу? Надад алт байхгүй. Харин тэр эмэгтэйн хувьд гэвэл мөрийтэй тоглоом хөөцөлдөөд над мэт муусайн амьтдыг нүцгэлж байх хойгуур чинь америк руу алтаа шилжүүлж амжина шүү гэж ямар нэг юм санасан бололтой хэлэв. Үнэндээ Гарриман, Эрхэмбаярын сонирхсон зүйлийг тодруулж өгөх замаар мөрийд алдсан мөнгөө эргүүлж авах ухаан бодож байжээ.

- Гарриман, би одоо худалдаачин болсон гэдгийг мартаж болохгүй.

- Худалдаачин гэдэг нэр чинь хулгай, дээрэм, тонуул бүхнийг халхалж чаддаг ид шидтэй шүү дээ.

- Би тэр ид шидийг сонирхдоггүй. Тийм хүсэл ч алга! Харин та мөрийнийхөө хойноос харамсаад байгаа бол түүнийгээ хэлчих. Би өнөөдөр уур уцааргүй болохоор таны аз дайрч мэднэ шүү.

- Эрхэмбаяр аа таныг мөрийтэй тоглоомонд нүнжигтэй гэдгийг би мэднэ. Одоо ч гэсэн та, надад нинжин сэтгэл гаргаж байна. Харин тан шиг ийм азтай хүн, мөрийгөө алт болгоод хадгалуулчихвал тэр хүүхнээс ч илүү баян болж болно шүү дээ. Тэр чинь халхаас авчирсан эрдэнийн чулуунуудаа худалдаж алт болгоод хадгалуулчихсан гэдэг юм. Гэвч үнэн эсэхийг банкны ерөнхийлөгч юм уу эсвэл түүний итгэмжилсэн туслахаас өөр хэн ч мэдэхгүй. Харин саянаас тэр эмэгтэйн итгэмжилсэн хүн ирж ерөнхийлөгчтэй уулзаад алтаа америк руу шилжүүлэх тухай тохиролцоод явсан гэдэг болсон. Гэхдээ ямар хүн гэдгийг нь ч хэн ч мэдэхгүй байгаа. Зарим нь эрэгтэй гэж байхад нөгөөдүүл нь эмэгтэй, гуравдахь нь орос гэж жиг жуг гэлцдэг болсон.

Эрхэмбаяр Гарримантай ингэж ярилцаж яваад салахдаа нэгэн эрэгтэй хүн холоос ажиглаж байгааг мэдэв. Тэгээд Гарриманаас салаад байшиндаа орохдоо хаалгаа дутуу хаалаа. Хаалганы заагаар хартал намхан нуруутай хятад хувцастай нэг хүн, Эрхэмбаярын байшингийн дэргэдүүр өнгөрч гудамж уруудсаар бараа тасарлаа.

Эрхэмбаяр өглөө босоод консулын газар очиж Сигэтотой уулзаж, өнгөрсөн долоо хоногт болсон байдлыг илтгэв.

- Гарриман өчигдөр надад олон мянган иень алдсан. Түүндээ хоргодоод байхаар нь тал хувийг нь буцааж өгье гэж амласан. Үүнийг сонсоод америкийн банкинд байгаа алтны талаар дурсаж байна. Гэхдээ миний мэддэгийг ярьсан. Гойд сонин юм яриагүй.

- Тэр чинь болж байгаа хэрэг. Өчигдөр Тозияатай ярьсан. Хэд хоногийн өмнө буухиа элчээр нэг хаяггүй захиа ирсэн юм. Түүнийг Тозияа танд явуулсан юм байна гээд нэг захиа гаргаж өглөө. Эрхэмбаяр тэр захиаг задалж уншив.

...Америкийн консулын газрын ажилтан ноён Клоусоны хүү Жек Клоусоноос анхаарлаа салгаж болохгүй. Клоусон бол америкийн банкны ерөнхийлөгчийн хамгийн дотны хүн! Түүнтэй Гарриманаар дамжуулж танилцах нь чухал! Жек Клоусоныг Шанхайн шалдан банди нарт зааж өгч, болзол тавь! Таны мэдэх гол зүйл бол Юкигийн эцгийн гэрээний эх, түүний хуулбар, агуулгыг олж авах, банкны хамгаалалтын систем, алтны нярав, түүний гэр орон, ахуй байдал, алдаа эндэгдэл, сул талуудыг судлах, хүүхдийг нь барьцаанд авах зэрэг ажиллагаанд бэлдэх хэрэгтэй.

Эрхэмбаярыг захиагаа уншаад дуусахад нь Сигэто тамхины үнсний сав дэргэд нь тавихад Эрхэмбаяр халааснаасаа шүдэнз гаргаад Тозияагийн захиаг шатаалаа.

- Эрхэмбаяр аа, та одоо жинхэнэ ажлаа эхлэх болно гээд Сигэто, ширээнийхээ шургуулганаас намбу маягийн гар буу гаргаж өгөөд,

- Үүнээс хойш та болгоомжтой байх хэрэгтэй! Нөгөө талаар та, энэ хэргийг уншаарай. Танд тусгай өрөө бэлдсэн гээд нэгэн хавтастай хэрэг өглөө. Энэ бол Жек Клоусоны намтар түүх,

алдаа доголдлын талаар цуглуулсан материал болй.

Шанхай хотын гадаадын худалдааныхан бөөгнөрсөн хэсэгтэй холбосон Гарден гүүрийн зүүн талаас урсаж ирсэн салаа голын эргийн тохойрсон хэсэгт нэгэн торго, бөс даавууны мухлаг байдаг. Энэ мухлагийн эзнийг Тайми Жун хэмээнэ. Тэрээр Шанхай дахь америкийн худалдааныханд талтай болохоор дөрвөн жилийн өмнө эхнэрийнхээ хамт Нью-Йоркоос ирэнгүүтээ энэ мухлагийг нээсэн билээ. Тэр хүн уг гарлаараа өвөр монгол хүн. Шилийн голын чуулганы Дархан вангийн хошууны тайжууд овгийн энэ хүний багын нэрийг Зундуй гэдэг боловч тэрээр хятад ёсыг дагаж овог угсааныхаа нэрний эхний үе, нэрийнхээ үеийг хураангуйлж Тайми Жун гэснийг хэн яахан мэднэ. Түүний эхнэрийн нэрийг Сарангэрэл гэдэг. Эр эм хоёрын хэн хэн нь мухлагтаа худалдаа хийдэггүй бөгөөд харин тэдний итгэмжилсэн нэг авгай торгоны мухлагт худалдаа хийнэ.

Акасай, хааяа энэ мухлагт ирж хятад торго сонирхдог агаад аахар шаахар зүйл худалдан авдаг. Оройн нар жаргаж байхад Акасай гүүрээр гараад баруун гар тийшээ эргэж Хуанпу мөрөнд цуггасан салаа голыг өгсөн, голын эргээс баруун тийш зурайсан гудамжны эхэнд байдаг торгоны мухлагт очлоо. Японоор халти мөлт ярьдаг авгай хөл алдан угтан инээмсэглэсээр,

- Акасай сан та торго сонирхож явна уу гэж тал засна. Акасай толгой дохиод авчирч өгсөн торгыг сонирхох зуур гудамжны байдлыг ажиглан зогсож байснаа,

- Би танай мухлагийн эзэн Гэрэлээ сантай уулзмаар байна гэхэд өнөө авгай гайхсан нүдээр Акасайг ажиглана. Тэгээд сэтгэлдээ "Энэ Япон эмэгтэй яагаад Сарангэрэлийн цээрлэсэн нэрийг мэддэг байна. Өнөө гайхал Тозияагийн гар хөлийн зарц байж мэднэ. Тэглээ ч гэсэн Сарангэрэлийн цээрлэсэн нэрийг мэдэх ёсгүй баймаар. Ямар сонин юм бэ?Манай эзэгтэйг Сарангэрэл гэж хэлэх үү. Энэ хүүхэн тэртэй тэргүй миний үгэнд итгэхгүй.Тэгхээр энэ хүүхнийг одоо эндээс гаргаж болохгүй" гэж бодоод хуурамчаар инээмсэглэн,

- Акасай сан, та ийшээ орж байхгүй юу гээд хажуугийнхаа өрөөний хаалга руу заалаа.Худалдагч авгай Акасайг захиалга авах өрөөнд оронгуут түгжээд гудамжны байдлыг ажиглангуут Сарангэрэлийн өрөө рүү алхав. Сарангэрэл өрөөндөө орж ирсэн авгайн царайг ажаад,

- Надтай хүн уулзахаар ирээ юу? Таны царай чинь хачин болчихсон байх чинь. Юу болоо вэ гэж асуулаа.

- Японы консулын газар ажилладаг нэг эмэгтэй таны цээрлэсэн нэрээр сураглаж ирлээ гэж үгээ эвлүүлж ядан хэлэв.

- Сандрах хэрэггүй. Юу ч гэсэн уулзъя. Миний цээрлэсэн нэрээр сураглаж ирэх хүн байхгүй юмсан гээд Сарангэрэл өрөөнөөс гарлаа. Сарангэрэлийг захиалгын өрөөнд орж ирэхэд голлуулан зассан ширээний хажуугаас боссон Акасай,

- Окусан(хатагтай) Гэрэлээ сан, таны амрыг эрье гээд гар цүнхнээсээ янжуур гарган ирэхэд Акасайгийн баруун гарын дунд хуруунд байгаа чулуун шигтгээтэй гурван цэнгийн алтан бөгжийг ажсан Сарангэрэл хэсэг балмагдав. Энэ бөгжийг арав гаран жилийн өмнө Цэен гүн

Гэрэлээд бэлэг болгон өгч байсан билээ. Сарангэрэл Цэен гүнгийн бөгжийг таниад биеэ барьж дуугүй зогсоход Акасай хуруунаасаа өнөө бөгжийг мултлаад өгөхдөө,

- Гэрэлээ сан, үүнийг Сайнжаргал сан танд гардуулж өгөөрэй гэж надад захисан юм гэж хэлэхэд шанааны нь үс үл мэдэг цайж яваа Сарангэрэл хэмээгдэх Гэрэлээгийн нүднээ нулимс цийлэгнэн, нимгэн ягаан уруул нь үл мэдэг чичирхийлэхийг Акасай ойлгож байлаа.

... Симоно Сойхара хоёрт хорлогдсон Гэрэлээ эгзэгтэй байдалд орсон тэр үед Сайнжаргалын сэтгэлийн хоёр дахь дарамт эхэлсэн юм. Сайнжаргал эцгээ нутаглуулсны дараа Баатар гүнгийн эхнэрийн ах Зундуйтай холбоо барьжээ. Чимэд Зундуйг маш нууц байдалд Мугдэнд авчирсны дараа Сайнжаргал эцгийнхээ ахын найзтай уулзаж учир байдлыг ярилцаад Гэрэлээтэй хамт Шанхай руу илгээхдээ цагдаагийн газрын удирдлагад багагүй хөрөнгө шидэж Тайми Жун гэдэг үнэмлэх бэлдүүлж билээ. Тэрээр Гэрэлээг Сарангэрэл гэдэг нэрээр эхнэрээ болгож аваад Шанхайд ирэнгүүтээ Сайнжаргалын алтны учрыг мэдэж байсан нэгэн томоохон хүнд бараалхаж Сайнжаргалын захиаг гардуулжээ. Чингээд Шанхайд тав хоносны дараа Гэрэлээг аваад далайн чанадад гарсан. Гэрэлээ Нью-Йоркод тасралтгүй таван жил эмчлүүлсний дараа эрүүл саруул болж,

Сайнжаргалын зөвлөснөөр Шанхайд зүс буруулан амьдрах болсон.

- Гэрэлээ сан, Сайнжаргал тантай уулзаж хэдэн зүйл дамжуул гэсэн. Би Шанхайд ирээд удаж байгаа ч тантай уулзах явдлыг тусгай шалтгаанаар хойшлуулж байсан. Би тэр шалтгааны учрыг олсон болохоор одоо цаг хугацаа алдаж болохгүй гэдгийг ойлгоод тантай уулзъя гэж шийдлээ гэхэд Сарангэрэл хэмээгдэгч Гэрэлээ,

- Манайд орж ярилцъя. Манай нөхөр ч байгаа гээд хацраа даган урсаж байгаа нулимсаа арчив. Акасай Сайнжаргалын заавраар Зундуй, Гэрэлээ хоёртой уулзан нэлээд ярилцав.

- Хар чоно гэдэг хочтой Буд гэдэг дээрэмчин Шанхайд ирсэн бөгөөд тэр хүн Тозияагаас даалгавар авсан байна Ойрын үед Жек Клоусоныг Хар чоноос холдуулах нь чухал! Нөгөө талаар Юкигийн алтны талаар тусгай хүн ирж уулзана гэсэн. Тэр хүн ямар ч нууц дохио хэрэглэхгүй. Эцэст нь хэлэхэд Хар чоныг Шанхайн зарим хүмүүс сонирхон дагах болсон байна. Тэгж дагаж байгаа хүмүүсийг консулын газрын Сигэто хянах тухай зааврыг тусгай хүмүүст өгсөн байна.

- Хар чоныг Гарримантай сүүж холбоод байхаар нь бид сонирхсон юм. Тэгэхээр ажиглалтыг зогсоож өөр шугамаар хянана. Энэ тухай цаг алдалгүй дуулгасан чинь тун сайн хэрэг гэж Зундуйг хэлэхэд Акасай буцахаар суудлаасаа бослоо.

Акасай торгоны дэлгүүрээс гарч Фантазио цэнгээний газар ирээд зоогийн газар ортол Гарриман, Жек, Эрхэмбаяр гурав сууж байлаа. Акасай оройн хөнгөн хоол захиалж зооглоод тэндээсээ консулын газар ирж өдрийнхөө ажиглалтын талаар Сигэтотой ярилцав. Сигэто ширээн дээрээс янжуур аваад,

- Акасай, ингэсхийгээд Тозияа сан ярина гэсэн. Түрүүн ярих гэхэд бид таныг сураглаад... гээд цагаа харснаа,

- Одоо ярих цаг болжээ гэхэд Акасай «Энэ лүд яагаад үгээ хагаслаж хэлэв. Намайг хайж миний хойноос хүн явуулсан хэрэг үү? Түүнийгээ нуухын тулд үгээр дүйвүүлж өнгөрөөлөө. Намайг торгоны мухлагт очсоныг мэдсэн хэрэг үү. Сонин юм. Намайг мөрдөж байгаа байх нь» гэж бодтол утасны хонх жингэнэв. Акасай сэнсэй багштандаа ажлынхаа талаар товч танилцуулаад Тозияагийн даалгаврыг хүлээж авлаа.

- Акасай, Эрхэмбаяр Шанхайн шалдир булдир банди нартай ямар холбоотой байна вэ? гэж асуулаа.

- Шанхайн гудамжны явган хулгай, дээрмийнхэнтэй холбоо тогтоогоогүй байна. Харин дайны жилүүдэд (1932 он) Шанхайн

Киокавакай нийгэмлэгт хамаарч байсан япон залуустай уулздаг болсон. Тэд Шанхайн Чампайн хэсэгт байдаг. Энэ тухай би Сигэто санд хэлсэн. Танд илтгээгүй юу?

- Чиний гүйцэтгэх ажлыг ганцхан би удирдана. Үүнээс хойш Сигэтоод далан булчирхайгаа тоочих хэрэггүй гэж Тозияа уурсав.

- Гакка, миний ажиллагааг зарим хүмүүс сонирхоод байгаа болохоор би өөрийнхөө аюулгүй байдлыг бодож зарим талаар зөв ойлголт төрүүлэхийн тулд тайлбарлах хэрэг гараад байна гэж Акасай эгзгийг нь тааруулаад Тозияад Сигэто болон түүний нөхдийн талаар чамбайхан танилцуулаад ажиллагаанд саад болж магадгүй байна гэж гомдол мэдүүлэв.

- Акасай ажиллагаагаа үргэлжлүүл! Сигэтоод илтгэдэг явдал чинь илүү хэрэг. Тэр чинь чиний ажилд хэрэгтэй үед онцгой эрхээр хангах үүрэгтэй гэдгийг ойлгож ав! гэж хатуухан тушаагаад хэсэгхэн дуугүй байснаа,

- Америкийн банкаар орж гарч байх хэрэгтэй. За ер нь би, Сигэтотой ярьж үүрэг өгье. Чи чинь банкны ажиллагааны талаар мэдлэгтэй байхаа... За ер нь Сигэтоог надтай яриулаадах гэлээ. Акасай утсаа Сигэтоод өгөхөд түүний царай ягаарчихсан байлаа.

- Сигэто, танайх банкнаас авдаг мөнгөнийхөө итгэмжилсэн төлөөлөгчөөр Акасайг ажиллуулах хэрэгтэй болж байна. Нөгөө талаар чи чинь Акасайгийн араас яагаад янз бүрийн сүүл тавиад байна вэ? Чиний энэ ажил чинь эцсийн эцэст Хар чонод сэжиг төрүүлж, банкны ажиллагааг унагана гэсэн үг! Нөгөө талаар өнөө Клоусоныг яах гэж бодож байна?

- Гакка, анхны туршилтыг өнөөдөр хийнэ. Би танд маргааш илтгэе.

- Сигэто, чиний ажил удааширч байна. Бусдын ажил руу хошуу дүрэхийн оронд өөртөө оногдсоноо биелүүлэхээ хичээсэн дээр шүү гэхэд Сигэтогийн духаар хөлс чийхарсан байлаа.

Сигэто, Тозияатай ярьсны дараа цагаа харвал оройн 21 цаг болох гэж байлаа. Чухам энэхэн үед Фантазио цэнгээний газраас гарч ирсэн хэсэг япон залуус, нэгэн согтуу хүнийг хаалганы дэргэд байгаа машинд суулгав. Суудлын тэрэг тэр дороо хөдөлж, хурдаа нэмсээр Шанхай дахь япон иргэдийн суудаг Чампайн хэсэгт ирлээ. Машинд суулгасан өнөө залуу нь Жек Клоусон ажээ.

Жек, ухаан ороод хаана байгаага ажвал нэгэн шавар байшинд хэвгэж байлаа. Босоо хүн адарт тулам тэр байшингийн жижиг цонхоор өглөөний нарны гэрэл туссаныг ажвал түүнийг хотын захад авчирсан нь илт ажээ. Жекийг өндийхөд өрөөнд байсан дөрвөн япон залуугийн нэг нь,

- Жекээ шараа тайл. Тэгээд ярилцъя гэж англиар цэвэрхэн хэлэв.

- Би хаана байна гэхэд өнөө залуу,

- Жекээ, чи байвал зохих газраа байна. Харин бидний сонирхсон асуултад хариулж, баталгаа гаргаж өгвөл хэн хэндээ хал балгүй шүү гэлээ.

- Энэ чинь сүрдүүлэлт үү?

- Юу болох нь чамаас шалтгаална гэхэд Жек залуусыг харвал тамирчдын бэлтгэлийн кимоно өмссөн агаад толгойгоо цагаан бөсөөр боосныг ажвал каратэ юмуу жиүдиүцүгээр мэргэжсэн залуус гэдэг нь илэрхий. Тиймээс Жек эсэргүүцээд нэмэргүй гэдгээ ойлгоод дуугүй суутал өнөө залуу,

- Жек ээ, 1932 оны I сарын 18-нд чи, Шанхайд байсан байхаа гэлээ.

- За тиймээ. Юу гээ вэ?

- Чи тэр үдэш хаана байснаа санаж байна уу? гэж англиар асуухад Жек тэр өдрийг үгүйлэн бодов. Жек юуны өмнө Шанхай руу японы усан онгоцноос гал нээснийг саналаа. Энэ бол 1 сарын 26-ны өдөр байсан. Үүнээс яг долоо хоногийн өмнө Жек, Шанхайн Иньшан гудамжинд байдаг алчуурын үйлдвэрийн хашааны хаалган дээр үйлдвэрийн эзний охиныг хүлээж байсан юм. Гэсэн ч Жекийн гэжүүд зан хөдлөөд,

- Хаана байснаа санахгүй байна. Бодвол гэртээ байсан байлгүй.

- Жекээ гэжиж, мэлзэх хэрэггүй. Тэр өдөр чи, Иньшан гудамжинд японы Мёхо сүмийн хоёр ламыг өөрийнхөө нөхдөөр буудуулсан шүү дээ. Уг нь таны гол зорилго бол тэр гудамжинд байдаг Нитирэн сүмд очиж эцгийнхээ буяныг санаж өргөл өргөх гэсэн Юкийг устгуулах ёстой байсан. Гэтэл чиний нөхөд Юкигийн биеийг хамгаалж явсан манай ажилтангуудыг танингуут гудамжинд явсан манай хоёр ламыг буудсан нь чамд Юкийг буудсан сэтгэл төрүүлэх гэсэн заль байсан. Та хоёр нөхрөө зугтаахыг харангуут алчуурын үйлдвэр рүү орсон биз дээ.

- Иньшан гудамжинд лам буудуулсан тухайд гэвэл тийм явдал болсон. Харин тэр гудамжинд Юки гэдэг эмэгтэй явж байсныг би хараагүй. Нөгөө талаар Шанхайд байсан танай цэргийн төлөөлөгч Танака, хотын дарга У Тисинд өгсөн мэдэгдэлдээ Юкийг хорлох гэсэн халдлагын талаар ганц ч үг дурдаагүйг би санаж байна. Тиймээс бид жинхэнэ албан ёсны баримт түшиж яривал учир нь олдохдоо амархан шүү дээ.

- Жек, та тэр өдрүүдэд хотын оюутан хятадуудтай болон англи, францын хамгаалах

отрядынхантай нийлж манай олон арван цэргийг устгасан. Харин үүнээс булзаарах зам байхгүй шүү гэхэд Жек,

- Би тэр будлианд оролцоогүй шүү гэлээ. Гэтэл англи хэлтэй залуу, хэд хэдэн гэрэл зураг үзүүлэв. Энэ нь Шанхай хотыг хамгаалж байсан сайн дурынхны дунд явж байгаа Жекийн хэд хэдэн гэрэл зураг байлаа. Жек үнэхээр баримттай энэ зүйлийг хүлээхээс өөр замгүй болов. Япончууд гарцаагүй баримтаас булзаарах гэвэл эрүү шүүлт хэрэглэх нь илтээ.

- Жекээ энэ баримтаар бол та манай олон арван цэргийн амь насыг бүрэлгэсэн учраас чамайг бид устгах ёстой. Гэсэн ч бид чамд өөрийнхөө амийг аврах боломж олгоё гэхэд Жек,

- Та нарын болзлыг сонсьё гэлээ. Үнэндээ япончууд Жекийг гудамжинд буудчихаад өөрөөсөө зайлуулж чадах нь зайлшгүй.

- Жек, чи олон жилийн турш Юкигийн хадгаламжийг сонирхсон. Тэгэхээр одоо бага сага баримт олоо биз! Түүнийг бидэнд өгвөл болох нь тэр!

- Юкигийн эцгийн хадгалуулсан түмэн лан алтны хувьд гэвэл тэр чинь огт найдваргүй зүйл! гэж Жек урам муутай хэллээ. Японы эзэмшил Шанхайд тогтсоны адилаар хэдэн сарын дараа бүх хятад оронд ноёрхох нь гарцаагүй болсныг сониныхон бие биенээсээ өрсөн мэдээлэх болсон явдлыг ажсан Жек, эдний болзлыг эсэргүүцэх нь утгагүй гэдгийг гадарлав.

- Яагаад тэр вэ? гэж англи хэлтэй залуу, Жекийн ам хэлийг сугалчих шахан шаллаа.

- Та нараас өмнө гоминдааныхан хэдэн жил сонирхсон юм. Гэтэл тэр их алтыг Шанхайн банкнуудад байдаг гэдгийг мэдэх, мэдвэл зохих хэмжээний томоохон хүмүүсийн хэн нь ч тэр байтугай манай эцэг ч мэдээгүй юм. Шанхайг эзэлсний дараа танай армийнхан тэр алтны сураг гаргахаар тусгай хэсэг хүртэл ажиллуулсан гэж шуугидаг байсан. Та нарын хэлж байгааг тэр цуурхалтай харьцуулбал тэр эмэгтэйн алт хаана ч байхгүй гэдэг нь тодорхой юм биш үү? Ингэхээр байхгүй алтаар болзол тавина гэдэг найдваргүй хэрэг! Тэгээд ч банкны зарим ажилтангуудын дунд байхгүй алтнаас болж амиа алдах нь гэдэг яриа гарсан шүү.

- Жек чиний үгэнд энэ удаа итгэе. Гэхдээ тэр алтыг байхгүй гэдгийг батлах албан ёсны баримт авчирсан цагт та бидний яриа хэн хэндээ өлзийтэй сайн зүйлээр төгсөнө. Тиймээс долоо хоногийн дотор баталж баталгаа олж өгвөл яриа дуусна гэж англи хэлт шаардав.

- Хугацаа нь дэндүү шахуу байна. Танай кэмпэйтэйн тагнуулчид ч гэсэн олон жил үр дүнгүй хөөцөлдөж байгаа алтны талаар би баримт олно гэдэг нэг л ойлгогдохгүй байна. Тэгэхдээ долоо хоногт шүү! Тагнуулын мэргэжилгүй надад бол дэндүү ахархан байна. Тэрүүнд орвол эндээ алуулчихсан нь дээр биз дээ.

- Жек битгий хэдэрлэ! Нөгөө талаар өөрийгөө үнэ хүргэх гэж чармайсанд орвол учир байдлаа үнэнээр ярилцах нь дээр! Та амиа биднээс худалдаж авах ёстой. Таны бууны суманд өртсөн япон цэргүүдийн нэрийн өмнөөс бид таныг хэзээ ч устгаж амжина. Харин та үнэн чанартаа үхэхийг хүсээгүй хүн. За тэгээд бид чинь үхэхийг хүсдэггүй хүнийг тонилгох ёстой юм. Үхэхийг хүсдэг хүн бол өөрийнхөө гараар өөрийгөө устгадаг болохоос хүнээр өөрийгөө

устгуулдаггүй юм. Таны энэ чинь үнэн бол та одоо өөрийгөө буудчих гээд англи залуу намбу буугаа Жекийн өмнөх ширээн дээр тавьтал түүний ард хоёр япон залуу ирж зогслоо. Тэр бууг ганцхан сумаар сумласан болохоор Жек ямар ч илүү хөдөлгөөн хийгээд нэмэргүй. Хайран амиа алдана. Жек өөрийгөө буудаад хэрэггүй. Тэгвэл япончууд Жекийн хүүрийг гудамжнаас оллоо гээд аваачаад өгчихнө. Шалгахад намбу бууны бариулаас миний хуруунуудын мөр ярайтлаа гарна гэдэг бодол Жект төрнө. Жек гарцаагүй барьцаанд орсноо ухаарлаа. Япончууд Жекийг сэтгэл санаа, хүсэл мөрөөдөл, тэвчээр зориг, авхаалж самбаа, заль мэхээр чамбайхан гэдгийг сайн судалсан болохоор англи хэлтэй залуу алхам бүртээ Жекийн амыг таглана.

- Жек ээ, бид чиний саналыг харгалзаж дахиад долоо хоногийн бололцоо олгоё гэхэд Жек арга буюу толгой дохив. Япон залуус Жекийг зүгээр суллаад явуулчихсангүй. Түүний нүдийг хар даавуугаар боож байшингаас гаргаад машинд суулгалаа.

Долдугаар сар. Японыхон үүнийг үхлийн сар гэж нэрлэжээ. Баян Цагааны нуруунд гарсан японы цэргүүд гол гарч чадалгүй тэр чигээрээ «диваажинд» очсон учраас тэдний хувьд чингэж нэрлэх нь самурайн ёсонд нийцэх ажээ. Нисэх хүчин ч зүгээр байсангүй. Диваажинд одож хойд насныхаа жаргалыг эдлэх ёстой 110 онгоцны нисэгчдийн нэрийг Ясукони сүм рүү явуулахаар бэлджээ. Харин Комацубара, шалгарсан хэдэн дивизийг байлдааны үеийн орон тоогоор шинэчлэн зохион байгуулаад даагаа нэхэх төлөвлөгөө гаргаж армийн штабт илгээсний дараа түүний төлөвлөгөөг жанжин штабаас баталсан ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинэчлээд жанжин штаб руу явуулсан мэдээ авчээ. Комацубара шинэ төлөвлөгөөтэй холбогдуулж шинэ мэдээ баримт цуглуулахдаа тагнуулынхны амар заяаг баржээ. Тэрээр монгол зөвлөлтийн армийн гүн ар тал фронтын байдалтай холбогдсон мэдээ баримт шаардана.

Тиймээс хороо дивизийн төдийгүй армийн тагнуулын газар ч нэлээн чармайлт гаргах авч амжилт муутай тул хүн бүхний сэтгэл түгшинэ. Баян Цагааны ажиллагааны дараа хэд хэдэн хүн тушаалаас огцорлоо. Үүний нэг бол Тогава байлаа. Тэрээр Баян Цагааны нуруунд болсон байлдааны талаар худлаа мэдээг Токио, Дайран, Мугдэн, Харбинд нийтлүүлсэн нь бурууджээ.

Комацубара, шинэ ажиллагааг эртнээс чамбайхан бэлтгэхийн тулд бүх дарга нараа цуглуулсан төдийгүй штабын тагнуулын газраас хүн урьсан болохоор Аяанаосу Хайларт ирлээ.

- Бид юуны өмнө улаан орос монголын ар талыг мэдэхийн тул агаар, газарт хийх тагнуулын ажиллагааг хүчтэй болгох нарийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Шинэ давшилтын төлөвлөгөөтэй уялдсан хэд хэдэн зүйлийг надад тодруулж өгөх хэрэгтэй!

Нэгд.Оросын хориглолт байлдааны штабын утсан болон радио холбоогоор өгч байгаа бүх удирдамжийг мэдэх, тэдний яриа, түүний хуулбар.

Хоёрт.Орос монголын цэргийн хүч, фронтын хориглолтын байдал, ар талын бэлтгэл, нөөцийн талаарх баримтууд

Гуравт.Оросын болон монголын цэргийн давшилт хэзээ хаагуур, ямар хүчээр эхлэх гэж байгааг тогтоосон баримтууд. Ялангуяа давшилтын бэлтгэлийг яаж, хэрхэн шийдсэн, цэрэг

зэвсгийн шилжүүлэлтийг ямар замаар хийх төлөвлөгөөтэй байгаа хийгээд намар, өвлийн ажиллагаа ямар төлөвтэй байгааг мэдсэн байх шаардлагатай гээд Комацубара яриагаа дуусгаад Симотогийн саналыг асуулаа.

- Гакка, би армийн өмнө тавигдаж байгаа зорилтыг ойлгосон цэрэг эрийн хувьд хэдэн зүйлийн санал хэлье. Миний саналын зарим нь бодит байдалд биелэхгүй юм шиг санагдаж магадгүй. Гэсэн ч ийм алхам хийхгүйгээр эзэн хааны замналыг монголд тогтоох ажиллагааг амжилтанд хүргэх боломжоор бага юм. Юуны өмнө монгол хэл мэддэг тусгай хэсгийг Харбинд зохион байгуулаад энд авчрах нь чухал! Аяанаосугийн шавь нарыг энэ ажилд бүрэн хамруулж болно. Үүнтэй уялдуулж германд үйлдвэрлэсэн «Сименс» маягийн радио пеленгатор арваас доошгүйг авчирч тоноглож төхөөрөмжилбөл орос монголын армийн удирдлагын болон фронтын анги хороо, дивизийн дарга нарын хоорондын яриаг бүрэн тэмдэглэн авч болно.

Орос монголын цэрэг зэвсгийн шилжүүлэлт болон ар талын бэлтгэлийг мэдэх, түүний хорлон сүйтгэх ажиллагааг эрчимжүүлэхийн тулд Харбины Сунгар-11 өртөөнд байгаа тусгай сургуульд бэлдсэн оросуудын хэсгээс хүмүүсийг сонгож улаан армийн цэрэг даргын хувцсаар хувцаслан монголын гүнд явуулж тагнуулын болон хорлон сүйтгэх ажиллагааг хийлгэж болно. Иймээс миний саналыг тунгаан бодит байдлын үүднээс дүгнэх байх гэж бодож байна гэж саналаа хэлэв.

Симотогийн саналыг сонссон дарга нар түүнийг дэмжсэн боловч цаг хугацааны хувьд зөрөөтэй санал гаргалаа. Жанжин штабаас шинэ довтолгоог хэзээ эхлүүлэхээр шийдвэрлэхийг тоймлох хүн байхгүй болохоор германы сүүлийн үеийн радио техникийг Халх голд авчирч амжих уу? гэдэг асуудал бүх юмны зангилаа болж тулгамдуулжээ. Үнэндээ цэргийн тагнуулын үйл ажиллагаанд зориулсан "Сименс" маягийн төхөөрөмжийг Харбинд ганцыг тавьсан боловч квантуны армийн нөөцөнд байгаа юу үгүй юү гэдгийг мэдэх хүн байсангүй. Нөгөө талаар Сунгар-11 гэдэг товлосон нэртэй цагаантны хорлон сүйтгэгч тагнуул бэлддэг түр сургуульд алс дорнод руу чиглэсэн ажиллагаанд ашиглах хүмүүсийг бэлдэж байгаа болохоор Дайранд байгаа атаман Семеновт дуулгаж, тэр талаар тохиролцоно гэдэг бол цаг хугацаа шаардагдах ажил байлаа. Дарга нарыг үг хэлж дууссаны дараа Уэдагийн туслахын нэг үг хэлэв.

- Тай са Симотогийн санал тун бодууштай санал байна. Ер нь жанжин штабаас довтолгооны цаг хугацааг урьдчилан мэдэж зохион байгуулах талаар дахин ярилцах нь чухал. Би энэ саналыг армийн удирдлагад яаралтай танилцуулж зохих шийдийг авч мэднэ. Тиймээс урьдчилсан ажлын талаар саналаа нэгтгэн боловсруулах нь дээр байх гэж бодож байна гэснээр Комацубарагийн өрөөнд болсон хурал завсарлалаа. Квантуны армийн удирдлага Симотогийн саналыг сонирхож түүнийг дэмжсэн тул монгол оросын армийн удирдлагын яриаг сонсох тэмдэглэх ажиллагаанд хэд хичнээн хүн ямар ямар радио төхөөрөмж хэдийг хэрэглэх тооцоо гаргахыг даалгалаа.

Аяанаосу, Хайлараас Синьзинд ирэхэд Ойдов Харбинаас ирчихээд түүнийг хүлээж байлаа. Үүнийг мэдсэн Аяанаосу, Ойдовтой уулзахаар номын төв дэлгүүрт очлоо. Аяанаосуг хаалгаар орж ирэхэд үйлчлэгч хүүхэн тосон очиж, амар мэндийг нь лавлаад,

Таны захиалсан номны нэг нь ирсэн шүү гэхэд Аяанаосу,

- Ямар нь вэ? гэж асуулаа.

- Гэнитиро Кавамурагийн «Ниппон тэйкоку но Сина ни тайсуру сейсаку буюу Хятадын харилцаан дахь Японы эзэнт улсын улс төрийн бодлого» гэдэг нь ирсэн.

- Танайхаар ямар шинэ номтой байна даа?

- Тэйзиро Сикамото гэдэг хүний бичсэн «Тай сохисэн то хогун хаттэн буюу Улаан армийн хөгжил ба дээрэмчдийн эсрэг явуулах дайн» бас Гэндай Сина но гайко сейсаку буюу Хятадын орчин үеийн гадаад бодлого гэдэг номууд ирсэн. Та авах уу? гэж лавлахад Аяанаосу,

- Юу ч гэсэн үзье гэхэд үйлчлэгч,

- Та жаахан хүлээхгүй юу гээд нэгэн явган ширээний дэргэд байгаа зөөлөн түшлэгтэй сандал руу заагаад,

- Аяанаосу сан, та «Тохо хёрон Дорно дахины тойм" сэтгүүлийн шинэ дугаар сонирхооч гээд ширээн дээрх сэтгүүлүүд рүү заалаа. Ийнхүү Аяанаосу захиалсан номоо хүлээсэн янзтай сууж байтал номын дэлгүүрийн эзний өрөөнөөс Ойдов гарч ирлээ. Тэрээр Аяанаосугийн барааг харангуут,

- Аяанаосу сан, яасан сонин хүн бэ? гэж дуу алдан дэргэд нь ирэв. Ойдов цагаасаа өмнө ирээд түүнийг хүлээж байсан ажээ.

- Ойдов сан, та чинь Харбинаас хэзээ ирээ вэ? Энд юу хийж явна гэж ерийн байдлаар дайралдсан хоёр шиг уулзав.

- Манай эзэгтэй хэдэн номын захиалга өгчихөөд ир гэсэн юм. Тэгээд дэлгүүрийн эзэнтэй уулзаж тохиролцоод буцах санаатай явна. Та одоо хаачих вэ? Штаб руу явбал хамт явъя гэхэд,

- Ойдов сан таныг хүлээлгээд яах вэ? Ажлыг чинь чирэгдүүлчихнэ. Би захиалсан номоо хүлээж байна гэлээ. Чингэж холбоочинтойгоо уулзсан Аяанаосу «Тохо хёрон» сэтгүүл урдаа барьж унших зуур Хайларт болсон уулзалтын тухай сэм ярьж, Комацубарагийн шинэ ажиллагаа Симотогийн санаачилгын талаар ярьж өглөө. Чингэж суутал үйлчлэгч ирж Аяанаосугийн захисан номуудыг авчирч өгөхөд тэрээр үнийг нь төлөөд дэлгүүрээс Ойдовтой хамт гарлаа.

- Комацубарагийн шинэ ажиллагааны товлосон нэрийг мэдэж чадсангүй. Харин Симотогийн яриаг бодит байдалтай харьцуулж үзвэл «Косэйтоку» гэдэг ажиллагааг квантуны армийн штабт боловсруулсан бөгөөд шинэ арми байгуулах янзтай байна. Тиймээс энэ тухай Рожусайд мэдэгдэж Косэйтоку ажиллагааг тодорхой мэдэх талаар ямар бололцоо байгааг мэдээд надад дуулгана биз! Нөгөө талаар төвтэй барьж байгаа холбооны цагийг тогтмол бус хугацаанд хийж байх талаар тохиролцох хэрэгтэй гэхэд Ойдов,

- Рожусай энэ тухай төвөөс удирдамж авсан. Нэвтрүүлгийн дараа цагаа өгч байхаар болсон.

Шинэ хуваарийн дагуу маргааш холбоо барина.

- За тэгвэл маргааш орой цэцэрлэгийн нуурын дэргэд уулзъя гээд Аяанаосу штаб руу алхлаа. Тозияагийнх штабаас холгүй болохоор Ойдов ч байшин руугаа эргэв. Аяанаосуг штабын хаалгаар орж ирэхэд ерөнхий жижүүр уулзаад Тозияаг сураглаж байсныг мэдэгдэв. Тэрээр өрөөндөө оролгүй шууд Тозияагийн өрөө рүү явлаа. Аяанаосуг туслахын өрөөнд орж ирэхэд тагнуулын газрын дарга хүлээсэн янзтай сууж байхыг хараад,

- Дэд хурандаа хоёулаа орох уу? гэлээ.

- Би өөр ажлаар яваа. Гакка чамайг Халх гол руу явуулах янзтай байсан. Надаас өчигдөр асуухад би татгалзаагүй шүү гэхэд Аяанаосу Тозияагийн сурагласан учрыг гадарлав. Тозияа, Аяанаосуг ороход хуйсгануур байсан боловч түүний авч яваа номуудыг сонирхоод нэлээн тайвширлаа.

- Сайн ном шиг байна... Би чамайг Халх гол руу явуулах санаатай байна. Чи чинь Симотогийн санаачилгыг сүрхий дэмжсэн юм шив дээ. Энэ чинь тун зөв! Миний шавь нар бие биенээ дэмжиж байх ёстой юм шүү. Жанжин штаб, Халх голын ажиллагааг хяна гэж тушааж байна. Тэгээд манай штабынхныг гоочлох царайтай байх шиг байна. Симототой холбоотой ажил бүрийг нууц шалгаж байгаа сэжиг гарч байна. Тиймээс чи, манай штабын тусгай төлөөлөгчөөр Халх голд ажиллана. Та хоёр сэтгэл санаа нийлдэг улс! Чи Симотогийн гаргаж болох алдаа, эндэгдлийг сайн ажиж цаг тухайд нь зөвлөж залруулж байхгүй бол цаадах чинь салгаж болохгүй занганд орчихож магадгүй. Би энэ талаар Симотоод жич дуулгана. Нөгөө талаар үл мэдэгдэх радио станц Синьзингээс зайдуу ажилладаг болсон байна. Тиймээс тэр радио станц Халх голын ажиллагаатай холбоотой эсэхийг цагийн хуваариар хөөж шалгаж болох юм. Энэ станц үүний өмнө Хайлар, Харбин, Ханширээд ажиглагдсан радио станцуудтай ямар нэг талаар холбоотой байх шиг санагдаад байгаа гээд хэрхэн ажиллах тухай заавар өглөө. Энэ уулзалтаас хойш тав хоноод Аяанаосу Жанжин сүм рүү явах гэж байтал Тозияа түүнийг дуудлаа.

- Өнөөдөр өглөө Синьзин руу явж буй галт тэргийг Халуун рашаанд очих гэж явахад Хянганы Богд уулын ойролцоо өнөө радио станц дахин ажилласныг орон нутгийн кэмпэйтийн болон армийн холбооныхон тэмдэглэж авсан байна. Би Комацубаратай яриад тэнд тусгай хүмүүс ажиллуулах болсон.

Тэгэхээр чи тэдэнтэй илрүүлсэн радио станцын цагийн хуваарийг харьцуулж өөрийнхөө саналыг надад хэлж бай гээд холбоо барьж байх цагийн хуваарь өглөө. Аяанаосу Тозияагийн өрөөнөөс гарч ирэнгүүтээ маргаашийн (оройн) галт тэргээр Ханширээ рүү гарч тэндээсээ Жанжин сүм рүү машинаар явахаар шийдээд Ойдовыг хүлээлээ. Ойдов, Хайлар явсан бөгөөд тэрээр Ханширээг дамжин ирж явах замдаа төвтэй холбоо барих ёстой байсан.

Тиймээс Ойдов маргааш өглөөний галт тэргээр Синьзинд ирэх нь илэрхий боллоо. Аяанаосу Ойдовтой уулзаж болсон байдлыг мэдэгдэх нь чухал гэж үзээд маргааш нь үд өнгөрөөгөөд хотын цэцэрлэгт очлоо. Ээлжит уулзалт тэнд хуваарьтай ажээ.

Аяанаосу, даргатайгаа уулзаад гарахдаа цагаасаа жаахан хожимдсон байлаа. Аяанаосуг

цэцэрлэгт ороход Ойдов цэцэрлэгээс гарахаар явж байлаа. Тиймээс Аяанаосу түүнийг тосон уулзахаар цэцэрлэгийн хашаан дахь зоогийн газар орлоо. Ойдов ч түүнийг харж амжжээ.

- Чи чинь Жанжин сүм явах болоо юу. Өнөө өглөө Рожусай надад энэ тухай мэдэгдлээ. Халх голын шинэ ажиллагааны төлөвлөгөө, эхлэх цагийг мэдэх нэг боломжийг Рожусай, Комацубарагийн штаб гэж үзэж байна. Тиймээс Симото, штабын дарга хоёртой үргэлж харилцаатай байхыг Рожусай чухалчилсан.

- Ойдов минь энэ ч яахав. Цаана чинь чиний араас хүчтэй мөрдөж байна.

Хайлар, Харбин, Халуун Рашаанаас дамжуулсан чиний нэвтрүүлэг бүгдээрээ армийнхны гарт орсон байна. Одоохондоо нэвтрүүлгийн түлхүүрийг тайлж чадахгүй байгаа. Тиймээс төвтэй барих холбооны системийг өөрчлөх талаар Рожусайтай ярилцаж удирдамж авах хэрэгтэй гээд ажил төрлөө хэрхэн тохируулах талаар ярилцаад салжээ.

Аяанаосу Синьзингээс гараад гурав хоногийн дараа Жанжин сүм дээр ирж, Симототой дарга нарын байранд уулзалтаа тэмдэглэв.

- Симото минь ажил чинь ямаршуухан байна даа.

- Ямар байх нь чамаас шалтгаалах бололтой. Одоо чинь чи, миний авралын тэнгэр болоод байна шүү дээ гээд Тозияатай ярьсан тухайгаа хэлэв. Тэгээд хундагатай сакэ балгах зуураа,

- Авралын тэнгэр минь, би бүх асуудлыг чамтай ярьж зөвлөж байх болно. Өнөө радио төхөөрөмжийг авчруулаад тусгайлан төхөөрөмжилсөн. Маргааш нөгөөдрөөс шалгаж хүлээж аваад ажиллуулна. Орос хэлэнд сайн хүмүүсийг дүрвэгсдийн товчоо бэлдэх болсон. Армийн удирдлага шуурхай арга хэмжээ авсан. Одоо ганцхан ажиллах л үлдээд байна. Тоног төхөөрөмжийн засварын хоёр ээлжтэй болсон. Одоо ингээд улаан орос, монголын дарга нарын хамаг нууц миний гарт орж ирэх болно шүү! Харин Синьзинд юу болоо вэ?

Баян Цагааны ажиллагаанаас болоод нэлээн хэдэн хүн толгой дээрээ дээлээ нөмөрч магадгүй байна. Армийн удирдлага яггүй асуудалд ороогдоод урдаа Тогавааг бариад байгаа. Тогава нь Ковороог бариад сүйд болж байгаа юм байх! Тогава, Синьзинд хэд хонохдоо надаас зугтсаар байгаад яваад өгсөн. Мөн янзын хүн шүү!

- Тэр чинь аймхай болохоор чиний нэрийг сонсоод чичирч байдаг амьтан. Гэхдээ их зальтай хүн дээ. Ухуулах хуудас энд хэвлэхэд Тогава яагаад Хайлар руу явсан гэж санаж байна. Надаас гуйгаад зогсоогүй, Комацубараад «Надад хонзонтой хүн байгаа юм. Байлдааны эгзгийг тааруулаад буудчихаж магадгүй хүн» гэж чамайг нэлээн муулсан байна билээ. Гакка надаас асуухаар нь түүнийг Хайларт ажиллуулсан дээр гэчихсэн юм. Тэрүүнтэй зууралдаж байх зав тэр үед надад байсан биш.

- Армийн хэвлэлийн товчооны даргаар шинэ хүн ирсэн.

- Хуучин дарга... өнөө Кавахарааг яасан бэ?

- Мэдэхгүй. Түүний чинь оронд Вато гэдэг хүн ирсэн дээ. Чамайг таньдаг гэж байсан шүү.

- За тэр яахав. Намайг цааш түлхэх хүний нэг дээ. Харин чи энд ирсэн чинь надад олз!
Ингэхээр хоёулаа маргааш Номон Хан, Бүрд-Овоо руу явна. Тэгэхээр эртхэн амарсан дээр
гээд эвшээлээ. Тэр хоёр уулзаад найман цаг гаруй ярьжээ.

Хоёр. Тулгамдсан өдрүүд

- Байна уу? Байна уу Монос оо?... моносоо... моносоо, моносоо... ?

- Би монос байна. Би монос байна. Байна уу... байна уу.

- Би харцага байна. Харцага сонсож байна. Даргаа яриулаарай.

- Мэдлээ... гэх баргил дуу чагнуурт хангинаад хэсэг хором өнгөрсөн хойно,

- Би байна. Харцага аа...

- Хурандаа, та командлалын тушаал хүлээж авсан уу?

- Хүлээж авсан. Хавсралтанд заасан жагсаалтын дагуу өвлийнхөө хувцсыг захиалаад байна. Ер нь энэ өвөлдөө эндээ байх байхаа даа.

- Намар өвлийн бэлтгэлийн талаар тушаал зааврууд ирж байгаа болохоор манайхан довтолгоо хийхгүй гэж шийдсэн байна. Манайхныг довтлоогүй байхад Баргын нутаг руу халдлаа гэж шуугиан тарьсан юм чинь довтолбол Токио руу монгол, зөвлөлтийн цэрэг дайрлаа гэх байлгүй. Тиймээс ч манай армийн удирдлага довтолгооны талаар удирдамж өгөхгүй байгаа юм. За наад мэдээгээ хурдан явуул! Жанжин штаб яаруулаад байна. Ер нь эртхэн өвлийнхөө хувцсыг авсан дээр...

Монголын хориглолтын нэг хорооны штабаас төв штабтай ярьсан энэ яриаг төдийгүй радио холбоо, цахилгаан нэвтрүүлгийг замаас нь хүлээж авах том хүчтэй төвийг Хайлааст голын зүүн салааны хавьд нууц байгуулсан Симотогийнхон, монгол зөвлөлтийн фронтын тэргүүн шугамд байгаа хороодын бүх зүйл тэр дороо Симотогийн гарт орж байлаа. Симото, тэр мэдээнүүдийг хооронд нь харьцуулж нягтлаад орчуулгыг Комацубараад мэдэгддэг байв.

Аяанаосу монголын штабынхны яриаг монголоос япон хэлэнд орчуулсан боловч Симотоод өгөхгүйгээр шийдэв. Гэтэл цагийн дараа хориглолтын шугам дээр байдаг хяналтын хэсгээс саяын ярианы тэмдэглэлийг Симотоод явуулсан байлаа. Гэвч үүнийг Аяанаосу мэдсэнгүй. Симото яриа чагнах төвөөс гадна фронтын тэргүүн шугам дээрх хориглолтын хороодын дэргэд салбар холбоо байгуулаад тагнуулын хэсэгт тушаажээ. Тиймээс яриа чагнах, нэвтрүүлгийн замаас барьж авах төвийн цуглуулсан материалыг фронтын тагнуулын хэсгийнхний тэмдэглэж авсан зүйлтэй Симото тулгадаг байлаа.

- Хошуучаа, монголын цэргийн дарга нарын ярианд дурдсан тэр тушаалыг ойрын өдрүүдэд олох буюу агуулгыг нь мэдээд надад илтгэ! гэж Симото хориглолтын тэргүүн шугам дээр байгаа хориглолтын тагнуулын хэсгийн дарга нарт тусгай үүрэг өглөө.

Симотогийн өгсөн энэ үүргийн дагуу фронтын тэргүүн шугам дээр байгаа тагнуулын хэсгүүд монгол, зөвлөлтийн хориглолт руу сэм довтлон дайрах арга сэдэв. Тагнуулын нэг хэсэг тэр оройдоо явган цэргийн ангиудтай хамтарч монголын цэргүүдийн хориглон хамгаалж байгаа нэг манхан руу дайрчээ. Тэгээд японы тагнуулууд, өөрийнхөө цэргийн гэнэдүүлэн довтолсон

довголгооны хүчинд эрсэдсэн хэсгүүд хажуугийнхаа манхан руу ухран шилжих үед холбооны албаны нэг бага дарга амь эрсдээд нуувчинд үлдсэнийг олжээ. Монгол цэргийн бага даргын зүүж явсан цүнхийг олзолсон японы тагнуулууд хэд хэдэн чухал баримт бичиг олжээ. Тэр даргын цүнхнээс нэг тушаал гарч ирснийг орчуулахад Симотогийн хайгаад байсан тушаал байлаа. Тиймээс тагнуулын хэсгийн дарга орчуулгыг Симотоод яаралтай гардууллаа. Симото, цаг хагасын дараа Аяанаосутай уулзаад өнөө тушаалын эхийг орчуулгатай нь хамт өгөөд,

- Наадахаа шалгаадахаач. Тушаалын орчуулгыг сайн хянаагүй бололтой гээд явжээ. Аяанаосу, тэр дороо тушаалын орчуулгыг шалган үзэхэд японыхны гарт орж болохооргүй нууц тушаал байлаа. Аяанаосу энэ бүхнийг эргэцүүлээд «Одоо тушаалын агуулга нэгэнт илэрсэн болохоор би тэр ярианы тэмдэглэлийг өөртөө хадгалж болохгүй. Симото давхар хяналт тавьдаг учраас ярианы тэмдэглэлийг өгөх нь үү гэж сорьж байгаа байж мэднэ» гэж бодоод Симото руу угасдаад ярилцах гэтэл Симото түүнийг өрөөндөө урилаа.

- Симото сан, энэ чинь тун чухал тушаал байна. Энэ тушаалтай холбогдсон ярианы тэмдэглэлийг бид хүлээж авсан. Би монголоос хятад руу орчуулаад япон хэл дээр болгосон хэсгийг уншаад шалгачихлаа. Энэ баримтуудыг Комацубараад илгээх хэрэгтэй.

Симото, Аяанаосугийн авчирсан ярианы тэмдэглэлийг тоож уншсангүй. Тиймээс ярианы тэмдэглэл Симотоод мэдэгдсэн нь илэрхий байлаа.

Аяанаосу, Симото хоёр ажил төрлийн талаар жаахан ярьж байгаад өрөөндөө орж ирсний дараа бүүр балмагдаж байгаага мэдэв. Аяанаосу, Симотогийн ярианаас монгол зөвлөлтийн армийн радио нэвтрүүлгийн шифрийг японы нууц тулхүүрийн мэргэжилтэнгүүд тайлж амжсаныг мэдлээ. Энэ тухай Аяанаосу төвд яаралтай мэдэгдэх ёстой боловч Рожусайтай холбоо барих аргагүй байлаа. Гэсэн ч хэд хэдэн янзаар бодож үзлээ. Аяанаосуд ганц боломж байгаа боловч тэр нь бүтэмж муутай. Нууц төвд ажиллаж байгаа хүмүүс монгол дарга нарын яриа, радио нэвтрүүлэг, цахилгаан холбоог замаас нь барьж аваад эхлээд хятад руу орчуулсны дараа япон хэлэнд хөрвүүлдэг байлаа. Тиймээс Аяанаосу ажлаа хөнгөвчлөхийн тулд монгол, орос хэлнээс шууд япон руу орчуулах хүмүүс олж ирэх нэрийдлээр Синьзин орж болох авч Симото өөр хүн томилж болох эгзэгтэй. Гэхдээ Аяанаосу Синьзин орох далим гаргах хэрэгтэй гэж үзлээ. Аяанаосу, нэг өглөө цахилгаан мэдээнийхэн дээр орлоо. Тэд нэгэн чухал нэвтрүүлгийг хүлээн аваад нууц түлхүүрээр задлаад уншчихсан байлаа. Цахилгаан нэвтрүүлэг хүлээн авах хэсгийн бага дэслэгч,

- Өчигдөр шөнө Халх голоос төв рүүгээ хоёр удаа цахилгаан нэвтрүүлэг хийсэн. Үүний нэг нь Халх голын цаад талд хориглож байгаа хориглолтын шугамын дагуу босгох өргөст торны захиалга байсан. Нөгөө нь төмөр замын асуудлыг шийдэж мэдэгдэх тухай байлаа гэж илтгэлээ. Аяанаосу үүнийг мэдээд гайхан балмагдав. Өдөр хоног өнгөрөх тусам зөвлөлт монголын армийн командлалын нууц японы армийн удирдлагын гарт орж байлаа. Аяанаосу, шифрлэсэн мэдээнүүд, шөнийн ярианы тэмдэглэлийг хүлээн аваад холбооны нууц төвийн байранд байдаг Симотогийн өрөөнд орж ирээд орчуулагчдын асуудлыг танилцуулахаар шийдлээ.

- Симото, бидэнд орос, монголоос шууд япон хэл рүү орчуулдаг хүмүүс чухал байна. Тиймээс би, Синьзин явж штабтай ярилцаж хэдэн орчуулагч олж ирье. Тэгээд ч бас... гээд хэлж

дуусаагүй байтал Симото

- Би ч бас тэгж бодож байсан юм. Ер нь чиний ажил нүсэр байгаа биз дээ. Чи энд орчуулагчаар ирсэн биш. Харин чамд боломж байвал хэд хоногтоо хүлээхгүй юу? Би Жанжин сүм рүү явах хэрэг гараад байна. Армийн зам харилцааны асуудал эрхэлсэн нэг дарга, Ойдовтой хамт Ханширээгээс наашаа гарсан байна. Би тэднийг хүлээж аваад Ганжуур сүм ч орж магадгүй байна. Тэгэхээр чи эндээ үлдсэн нь дээр байх. Хоёул хоёулаа байхгүй болчихсон хойгуур ямар нэг юм гарвал сүүлдээ дэмий хэл аманд ороолдчихож магадгүй юм гэхэд, Аяанаосу, Симотогийн саналыг зөвшөөрөөд,

- Тэгье л дээ. Ер нь энд эзгүй байлгаж болохгүй гэхэд Симото,

- Чи маргааш өглөө Жанжин сүм рүү очоорой. Ойдовтой гурвуулаа нийлж жаахан хөөрье. Буун дуу сонссоор байгаад уйдаж гүйцлээ. Жанжин сүм дээр япон хүүхнүүд ирсэн гэнэ. Тэдэнтэй жаахан наргиж сэтгэлээ сэргээе гэхэд Аяанаосу түүнийг нь зөвшөөрлөө. Симотоог явсны дараагаар Аяанаосу, хоёр ээлжинд суух хүмүүсийн хуваарийг шалгаад тэдэнд заавар өгөөд Авдар нуураас Жанжин сүм рүү гарлаа. Хил дээр байрлуулсан холбооны нууц төвд ажилладаг хүмүүсийг Авдар нуурын сууринд байрлуулдаг болохоор тэднийг машинаар зөөдөг байлаа. Харин Симото, Аяанаосу хоёр ажил ихтэй үедээ холбооны нууц төвд тусгайлан зассан хоёр өрөөнд хонодог аж. Холбооны нууц төвийг газар доор байгуулаад долгион хүлээн авах хэрэгслэлийг гурван бээрийн цаана байрлуулжээ. Аяанаосуг Жанжин сүмд ирсний дараа гурван найз уулзаж, Ойдов Юкигийн санаа бодлыг Симотоод тайлбарлан ярихдаа яриагаа овоо хачирлав.

- Манай эзэгтэй төмөр замын нэгдэлд хөрөнгө хоршихын тулд Ханширээ, Жанжин сүм, Ганжуур, Буйр нуурын чиглэлд тавих төмөр замыг сонирхоод бүр 1935 онд хийсэн зураг төсвийг архиваас олж аваад одоо нэмэлт зураг төсөв хийлгэх гэж байгаа юм. Хайлараас Буйр нуур хүртэл төмөр зам тавих нь Ханширээгээс тийш тавих төмөр замын зардлаас их давж байгаа юм. Харин бидний урьдчилсан тооцоогоор бол Ханширээгээс Буйр руу тавих нь хямд тусаж байгаа юм. Тэгээд газар дээр нь үзэх санаатай. Харин бидний саналыг Юки сан яаж хүлээж авахыг мэдэх биш дээ гэлээ. Гэтэл армийн штабын төлөөлөгч хурандаа Учида,

- Юкигийн нааштай бодлогыг ашигтайгаар шийдэх явдал Комацубарагийн ажиллагааны амжилтанд их түлхэц өгнө. Үүнийг ч Тозияа сан сайн мэдэж өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж байгаа юм гэснээ яриандаа залхсан бололтой.

- Симото сан, танай энд сэтгэлийн уйтгар гаргачих газар бий байхаа гэхэд түрүүнээс хойш шалтаг хүлээж суусан Симото,

- Бий шүү. Хоёулаа тийшээ очъё. Ойдов сан яггүй халчихсан байна. Аяанаосу, чи Ойдовыг хажуулуулаад бидний хойноос очно биз гээд Учидатай нийлээд өрөөнөөс гарлаа. Симото ойрын хоёр долоо хоног Жанжин сүм рүү гүйгээгүй болохоор тачъяалдаа тэсэж ядаж байсан тэр үед Ойдов ирсэн нь түүнд сайн далим болжээ. Тиймээс Жанжин сүм дээр армийн ахлах дарга нарт зориулж авчирсан нутгийн япон хүүхнүүдийн хамгийн хөөрхөн, нүд булааж, сэтгэлийн гижиг хүргэсэн сайхныг шилж, шинэ «шөл уухыг» хичээсэн Учидагийн эчнээний санааг мэдсэн Симото, эгзэгтэй далим хүлээж, Ойдовын ярианд залхаж байсан аж. Тэр

хоёрыг өрөөнөөс гарснаас хойш түрүүнээс хойш согтуу юм шиг царай гаргаж, далан хэл дэлгэж суусан Ойдов, Аяанаосу руу сүрхий хараад,

- Эндхийнхэн ямаршуухан байна даа гэж ажил төрлийн яриаг эхлэв.

- Эндхийн байдал хүнд байгаа. Цэргүүд нь сэтгэл санаагаар унасан төдийгүй дарга нар нь уймарч байна. Цэргүүд синто ёс, самурайн тангарагт бишрэмтгий болохоор үхсэн ч гэсэн диваажинд төрнө гэдэгт итгэдэгтээ тэсээд байна. Харин дарга нар бол дээд заяаны хүмүүс болохоор байлдаанд залхаад ор нэр байх явдал үзэгдэж байгаа. Ялангуяа баргын цэргүүд их тогтворгүй байгаа. Үүнээс гадна нэг аюултай зүйл дэгдээд байгаа юм гээд Аяанаосу, нууц холбооны төвд болж байгаа бүхнийг Ойдовт тайлбарлаж өглөө.

- Японы удирдлагад очиж байгаа тэр мэдээ цөмөөрөө тусгай зориулалтаар тарааж байгаа манай ажиллагааг далдлах мэдээнүүд байгаа юм. Үүнийг японы цэргийн удирдлагад үнэмшүүлэх талаар бололцоотой бүхнийг хийх тухай удирдамж ирсэн. Энэ удирдамжийг хэрэгжүүлэх явдлыг Рожусай танд давхар үүрэг болгож байна. Нөгөө талаар японы нисэх хүчин 7 дугаар сард томоохон ажиллагаа сэдэх гэж байгаа учраас томоохон дарга нар Хайларт цугларах гэж байгаа. Би ч гэсэн Хайларт очихыг бодно. Үүнтэй уялдуулж төв японы нисэхийн хээрийн буудлын байрлалыг сонирхож байна. Чи Хайларт уулзахдаа тэр талаар нарийн баримт олж очих нь чухал! гэхэд Аяанаосугийн сэтгэлд тээглэсэн бөөн хар юм эгшний төдийд сарниад алга болчих шиг санагдлаа.

Ойдов, Учида хоёрыг Жанжин сүмээс явсны маргааш нь Симото буцаж ирлээ. Тэгээд орос монголын цэргийн удирдлагын яриа чагнах ажилдаа ороход Аяанаосу үүргийн дагуу Халх голын наад талд байгаа японы цэргийн хориглолт, бэхлэлтийн ажиллагаатай танилцахаар галын тэргүүн шугам руу явлаа.

Үд өнгөрөөж Авдар нуурын суурингаас гарсан суудлын тэрэг Үзүүр нуур руу зурагсан дардан замаар хурдалж, зүүн тийшээ эргээд цагаан тоос татуулан хурдлав. Тэгээд Оройн хашаат гэдэг газар байгаа дивизийн бэлтгэл хүчин дээр ирээд тэндээсээ хөдөлж Фуй такаса өндөрлөг рүү чиглэв. Японы инженерийн хороод гурван ээлжээр ажиллаж байгуулсан бэхлэлтийг үзээд Аяанаосу гайхлаа. Бэхлэлтийн барилга байгууламж дээр ажилласан нэг инженер ахмад, Аяанаосуд макет үзүүлж бэхлэлтийн талаар тайлбарлав.

- Орчин үеийн байлдааны ар талыг байлдаан явуулж байгаа талбай дээр зохион байгуулах асуудлыг Фуй такасад байгуулсан манай бэхлэлтэнд тусгасан юм. Түүнээс гадна цэргийн хүчийг дайсанд мэдэгдэлгүй шилжүүлэхийн тулд зэвсэг хүчийг маневарлах онцгой хэлбэрийг сонгохдоо машин, техник, хуягт, танкны хөдөлгөөнийг бүрэн нууцлах зорилт тавьсан. Бэхлэлтийн энэ хэсэгт галт хэрэглэлийн агуулах, энэ хэсэгт эмнэлэг, тэр хэсэгт морьдын тэжээл, маллагааны газар, хүнсний агуулахууд байгаа юм. Энд

манай цэргийг цэвэр усаар хангах усны нөөц байгаа юм гэж газар доор байгуулсан худгуудыг заалаа. Фуй такаса өндөрлөгөөс Такасай өндөрлөг хүртэлх газрын байдлыг ашиглаж харилцах суваг бэлдсэн. Ийм бэхлэлтийг Хайлаастын нөгөө талд байгаа Элст манхан, Ногоон уул, Бойтог манхны хооронд байгуулж байгаа гэж илтгэв.

Аяанаосу тэр өдрөө Нэргүй өндөрлөг буюу Такасайд ирж, тэндээсээ Бойтог манхан руу явлаа. Элсэрхэг хөрсийг ухаж байгуулсан белиндаж бүхий газар доогуурх байгууламжийг цемент, бетоноор хийсэн болохоор тун бөх болжээ. Их бууны галын цэгийг хагас дугуй байдлаар хэсэгчлэн байрлуулсан агаад хонхор хотгор газрыг ашиглаж байгуулсан харилцах сувгууд нь маш сайн бэхлэгдсэн байлаа. Аяанаосу чингэж хориглолтын шугаман дээр байсан гурав хоногтоо орой бүр монгол зөвлөлтийн удирдлагаас японы нууц холбооны төвд зориулсан нэвтрүүлэг, яриаг сонсож түүнийг японы удирдлагад үнэмшүүлэх ажилд хамаг цагаа зориулав.

Аяанаосу, Бойтог манханд байгуулсан бэхлэлтээс холбооны нууц төвтэй ярихдаа,

- Симото сан, өчигдөр орой утсаар ярьсан яриа ямаршуухан санагдав гэж асуулаа.

- Бэхлэлтийн өргөст тор татах тухай юу?

- Тиймээ. Түүнээс гадна орос-монголын тал давшилтанд бэлтгэх бололцоогүй юм шиг байна.

Аяанаосу сан тийм баримт олоо юу?

- Симото, би тийм ч бодитой юм олоогүй. Гэхдээ илэрхий юм биш үү?

- Би ч гэсэн тийм бодолтой байна. Гэтэл Комацубара, бодит баримт шаардаад байна. Чи тийм баримт олбол командлагчид шууд илтгээрэй. Тэгвэл миний саналыг генерал ойлгох болно.

- Тайса дон оо, би эндээсээ Хайлар явна. Ер нь гаккатай уулзаж чиний ажил төрлийн талаар ярилцъя. Харин чи ямар зүйл дээр дэмжүүлмээр байна. Түүнийгээ надад хэлээч!

- Аяанаосу сан, ер нь манай төвийн боловсруулсан материалууд хөдөлбөргүй үнэн гэдгийг ойлгуулах нь чухал. Гакка Комацубара дотроо бидний баримтанд итгэхгүй байж мэдэх хүн! Ер нь дотуур тамиртай их муу санаатай хүн шүү дээ. Тэгэхээр манийгаа зөв ойлгуулах талыг бодно биз дээ.

- Симото сан, намайг Хайлар явсан хойгуур Тозияа сураглаж магадгүй тэгвэл аятайхан шиг аргална биз. Би хагас сайн өдөр гэхэд оччихсон байх санаатай гэхэд Симото,

Аяанаосуд Комацубаратай ярих зүйлийн талаар өөрийнхөө санаа бодлыг тайлбарлав. Чингээд Аяанаосу Бойтог манхнаас Хайлар руу гарлаа.

Намрын эхэн сар дөнгөж эхлэнгүүт Шанхайд усан бороо цутгаж эхлэв. Үд өнгөрөхөд бороо татрах тийшээ болж, гудамжны зам талбайн хашлаганд тулсан үерийн ус нэлийжээ. Эргийн Банд хэмээх гудамж хөндлөн гарсан Эрхэмбаяр, алгуур гэлдэрсээр банкны байшингийн нөгөө талын гудамжны эхэнд байгаа зоогийн газар орж хоол захиаллаа. Оройн 19 цагийн үед хоёр илжиг хөлөлсөн нэгэн хятад, илжиг тэргээ хөтөлсөөр банкны хашааны хаалгаар орж явааг харсан Эрхэмбаяр цагаа хараад,

- Яг цагтаа ирж байна шүү гэж өөртөө сануулаад хоолоо идэх зуур цонхноос харцаа үл

салгана. Тэгтэл 35 мөчийн дараа өнөө өвгөн хятад илжиг тэргээ хөтөлсөөр банкны хашааны төмөр хаалгаар гарч ирээд тэргэн дээрх төмөр савтай хогоо даруулсан олсоо татаж үзээд илжиг тэргээ нар зөв тойрон, тэрэгнийхээ арал дээр баруун хөлийнхөө гуяар тэгнэн суугаад жолоогоо дугтрахад хоёр илжиг сүүлээ мушгинуулснаа алгуурхан гэлдэрсээр гудамж тойрч бараагүй болов.

Эрхэмбаярыг чингэж суутал гаднаас хоёр япон залуу орж ирээд зэргэлдээх ширээнд суулаа. Тэгээд удаагүй байтал нэгэн туранхай, өндөр биетэй, шаргалдуу цайвар царайтай, гүн цэнхэр нүдтэй, цайвар шаргал үстэй америк залуу орж ирэхийг ажвал Жек байлаа. Тэр хоёр япон залуугийн дэргэд суулаа.

- Жекээ чи, өнөө баримтаа аваад ирэв үү? гэж англи залууг асуухад Жек,

- Би ямар ч баримт авчраагүй гэж хэлтэл өнөө япон залуу гартаа барьж байгаа «явагийн» цохиур модоо чанга атгав. Японы нударган зодооны цохилтын зарим хэлбэрийг цэргийн мэргэжилтэнгүүд гардан байлдаанд хэрэглэх, хүн алах хэлбэр болгож тусгай цохиур мод бэлтгэсэн аж. Тэр модыг хэрэглэдэг тусгай журамтай төдийгүй мэргэжсэн хүмүүс байдаг. Жек хоёр япон залуутай яриа тохиролцохгүй бол үл ялиг нударган зодоон гарч, Жек амиа алдах нь зайлшгүй аж.

- Жекээ арай даажигнахыг бодоогүй биз! гэхэд Жек,

- Энд тоглож даажигнасан юм алга. Яг үнэнийг ярьж байна. Юкигийн дуулиан дэгдээсэн тэр алтыг чинь байгааг байтугай байхгүй гэдгийг батлах хүн алга! Ер нь байхгүй юмыг яах болж байна?

- Ер нь алт хадгалуулах тухай ярьж байсан хийгээд хадгалахаас татгалзаж байсан хүний тухай сонссон хүн байх ёстой. Тиймээс тэр хүмүүсийг олж баталгаа гаргуулж авах ёстой юм.

- Аминаасаа уйдсан хүн тэр тухай ярих байх даа.

- Жекээ битгий маягла! Бид хэлсэндээ хүрдэг улс шүү!

- Харин та нар өөрсөндөө аюултай алхам хийж байна шүү! Та нар хэн болох нь надад төдийгүй Шанхай, Токиод байгаа манай элчин сайдын яамны ажилтангуудад илэрхий болсон. Тэгээд ч манай тагнуулын ажилтангуудыг ихэнх нь та бүхний орогнодог нүх сүв, туршуул, эзнийг чинь мэдэж байгаа. Тэр тусмаа, бидний хажуугийн ширээнд сууж байгаа хүнийг чинь дагаж байгаа. Тэгэхээр одоо хэн хэндээ хал балгүй салцгаая. Намайг энд хорлолоо гэхэд та нар эндээс амьд гарч чадахгүй. Амьд үлдлээ гэхэд цөмөөрөө баригдана. Ингэхээр цөмөөрөө бие биенээ танихгүй юм шиг явцгаая гэхэд хоёр япон залуу зоогийн газрын хүмүүсийг ажвал америкийн цэргийн төлөөлөгчдийн туршуул хэд хэдэн хүн зоогийн газар байгаа агаад Шанхай дахь америкийн консулын газрыг хамгаалдаг цэргүүд гудамжинд зогсохыг ажиглавал зоогийн газрыг бүсэлсэн янзтай. Жек, хоёр залуугийн байдлыг мэдэнгүүт суудлаасаа өндийхөд өнөө хоёр нь Эрхэмбаяр руу хартал тэрээр толгой дохин «Явуулчих» гэсэн дохио өглөө. Үүнээс хойш цагийн дараа Эрхэмбаяр, Тозияатай утсаар ярьж байдлыг илтгэхээр японы консулын газар руу явлаа. Тэгээд арван таван мөч Тозияатай ярилаа.

- Эрхэмбаяр сан, тэр залуугийн гарт ихээхэн баримт байх ёстой. Тэгэхээр айлгаж, сүрдүүлсний хэрэггүй ихээхэн барьц амла! Сүрдүүлэлт хүнийг айлгаж чаддаг боловч бат мултрах арга хүний сэтгэлд төрүүлдэг онцлогтой. Харин хөрөнгө бол хүний сэтгэлийг зөөллөдөг төдийгүй өөрийг нь бүрэн захирдаг шилдэг арга гэдгийг мартаж болохгүй.

- Тозияа сан, Жек баримт олж өгнө гэж амлаад байгаа болохоор би ая занг нь харья гэж бодоод нэг их шахаж шаардаагүй байгаа гэхэд Тозияа,

- Тэр чинь зөв байна. Тэгэхээр одоо хөрөнгө амла гээд түүнийг хэрхэн зохион байгуулах талаар зөвлөгөө өглөө. Тозияа, чингэж Эрхэмбаяртай ярьж байхдаа Акасайгаас бичсэн илтгэлийг уншиж, Эрхэмбаярын яриатай тулгаж харьцуулна.

...Эрхэмбаярын ажил төрөл бүтэмжтэй байгаа. Киокавайн залуусыг Жектэй уулзуулж байна. Жек, худалдааны танхимын нөлөө бүхий хүмүүс, банкныхантай өдөр бүр уулзаж байгааг ажвал Юкигийн алтыг мэдвэл зохих улсуудтай уулзаж байгаа нь нотлогдлоо.

Тозияа Акасайгийн энэ мэдээллийг Эрхэмбаярын яриатай харьцуулаад сэтгэл хангалуун, урам зоригтой байлаа. Тэрээр Эрхэмбаяртай ярьсны дараа Юкигийн сэтгэл санааг «тольдохоор» сурсан заншлаараа Юкигийн өрөөнд орж яриа дэлгэв. Банди хятадаас орчуулга хийж сууснаа тэр хоёрын ярианд саад болохгүйг хичээж өрөөнөөс гарлаа. Сувдааг нас барсны дараа Юки, Баатар гүн агчийн эхнэрийн хамжлага (гэрийн зарц нар) хүмүүсээс хэдэн хүн гэртээ авчирч аж ахуйн ажилд зарах болсны адилаар хятад хэлтэй, номонд нэвтэрхий хэд хэдэн залуу авчирсан юм. Бандийг гарсны дараа Тозияа,

- Юки минь Ойдовын ажил овоо шив дээ. Хайларт очоод Комацубаратай уулзаад бас Харбины төмөр замын удирдах газрын харьяанд байдаг зураг төслийн газрынхантай ярилцаж, Синьзингээс авч явсан зурагтаа нэмэлт хийлгэх талаар тохирсон байна. Ойдов үүнийг чамд хэлсэн үү? Үгүй юү гэдгийг Комацубара сан сонирхож байна гэж нэлээн бодолхийлсон янзтай асуулаа.

- Би тийм заавар өгсөн юм. Уэда саны ярианаас үзвэл 8 сард их найдвар тавьж байгаа юм. Надад ойлгогдож байгаагаар бол одоо дайны цагийн бүрэн орон тоогоор хангагдсан 4 дивиз бэлтгэх боломжтой байгаа гэнэ. Аягүй бол тусгай арми байгуулна гэсэн. Тэгэхээр би өөрийнхөө ажил төрлийг боддог хэрэг! Нөгөө талаар Ханширээ, Халуун рашаан, Ирэсигээр нутагладаг хятадуудыг Халх голын сав нутгаар нутаглуулах чимээтэй байна. Энэ үржил шим сайтай нутгийг тэдэнд өгсөнд орвол би, өөрийнхөө эзэмшил нутаг болгосон дээр! Надад ашиг өгсөн өгөөгүй нь хамаагүй. Ганцхан Халх голын сав газрыг хятадад эзэмшүүлэхгүй. Хүний нохой зулгаахаар өөрийн нохой идэг гэдэг үгтэй. Талийгаач аав минь үүнийг л эрхэмлэдэг байсан юм. Тиймээс монголын газар нутаг дээр хятадуудыг гишгүүлэхгүй гэж бодож байна гэхэд Тозияа Юкигийн үгэнд гайхлаа.

- Уг нь Халх голын асуудлыг шийдсэний дараа эзэмшил газар өгөөч гэж эндхийн хятадууд асуудал тавьж байсан. Японоос олон зуун мянган хүн Манжуурт ирж суурьших ёстой. Тэгэхээр манжуурт нутагладаг хятадуудыг өөр газар руу шилжүүлье гэж байсан юмдаг. Гэвч энэ талаар албан ёсны шийд гараагүй байгаа. Тиймээс би, чамд дуулгаагүй юм. Ер нь чиний бодол маш зөв! Төмөр замаа тавьчихвал эндхийн хятадууд чиний харьяанд ажиллах болно.

Тэгэхээр чи, Уэда сантай уулзаж саналаа хэлсэн нь дээр. Армийн удирдлага чиний саналыг ямар ч гэсэн дэмжинэ гэж Тозияаг зөвлөхөд Юки дуртай зөвшөөрчээ.

Найман сарын гурван. Пүрэв гариг. Халх голын дайн эхэлснээс хойш арван зургаа дахь долоо хоногийн өглөө тусгай шифрээр задалж унш гэсэн цахилгаан хүлээж авсан холбооны нэг ахмад түүнийг Уэдагийн туслахад өгөхөд тэрээр шифрийн хэлтсийн даргыг дуудлаа. Чингээд цагийн дараагаар нууцын хэлтсийн дарга тусгайлан лацадсан бичиг авчирч өглөө. Уэдагийн туслах шифрийн хэлтсийн дарга тусгай шифрээр задалсан цахилгаанаа ёс дүрмийн дагуу нууцын хэлтсээр дамжуулж байгааг мэдээд Уэдагийн өрөөнд дагуулж орлоо.

Квантуны армийн удирдагч, Тозияа Юки хоёртой ярьж сууснаа өнөө бичгийг авч гарын үсэг зураад гарсны нь дараа задалж уншаад инээмсэглэхэд нимгэн хөрстэй царайд нь баяр баясал тодорлоо.

- Юки сан, Халх голд хятадуудыг шилжүүлэх асуудлыг тантай ярилцаж байж шийднэ. Тиймээс та өөрийнхөө саналыг бидэнд бичиж өгөөрэй гэхэд,

- Уэда сан, та бид хоёр үүний өмнө уулзахдаа төмөр замын талаар ярьсан. Армийн дээд удирдлагад, төмөр зам тавих газраа сонгох, зураг төсөл захиалуулж хийлгэх ажил удааширч байгаа учраас үл ялиг бэрхшээлтэй болох нь илэрхий. Харин миний хувьд гэвэл би, Ханширээгээс Жанжин сүм, Жанжин сүмээс Халх гол руу тавих төмөр замын асуудлыг зохих байгууллагад тавьсан. Тэгэхээр одоо газар сонголтоо хийнэ. Харин та, миний хөрөнгө хоршсон нийгэмлэгт Хянганы хорих болон цэргийн инженерийн газраас зохих хүмүүс туслах байх гэж бодож байна. Бид ажлаа ер нь цэргийн зам барилгынхнаар гүйцэтгүүлэх нь дээр гэж үзэж байгаа гэж Юкийг хэлэхэд Уэда үл мэдэг инээмсэглээд,

- Би төмөр замын асуудлыг ойлгож байна. Тиймээс туслах болно. Харин Халх голын асуудлыг 8 сард шийдвэрлэх ёстой. Харин та хоёрт гэж хэлэхэд өнөө маргаашгүй «Косэйтоку» ажиллагааны бэлтгэлийг хангаад удирдлагад илтгэх болоод байна гэхэд Тозияа Уэдагийн үгнээс «Косэйтоку» ажиллагааг эхлүүлэх шийдвэр ирж гэдгийг мэдлээ.

Юки, Уэдатай уулзаж Халх голын сав газрыг өөрийн эзэмшил нутаг болгохын тулд зохих дэмжлэг үзүүлэхийг хүссэн энэ өдөр, оройн хоолны дараа асарсан эцэгтэйгээ ярьж суухдаа,

- Ааваа, Уэда саны хэлсэн косэйтоку гэдэг ажиллагааны косэй нь довтолгоо гэсэн үг мөн үү? гэж саваагүй зангаараа сонирхон асуулаа.

- Үгүй ээ. Эхний Ко бол Комацубарагийн нэрийн тэргүүн үе, сэй бол баруун зүг гэсэн үг буюу сэйёо гэдэг үгний эхний хэсэг. Току бол онцгой довтолгоо гэсэн үг гээд Тозияа суудлаасаа өндийж диван дээр суухдаа нэмакинийхээ (амралтын халаад) бүсийг чангалж уялаа.

- Юки минь Уэда сан энэ онцгой довтолгооны тухай дурсаа биз дээ гэв. Тозияа, халсан үедээ яриа дэлгэх дуртай хүн. Тэгээд орой бүр шил сакэ балгаад дэвэн дэлхийн юмыг хамж шимж гарна.

- Хамгийн шилдэг тав зургаан дивизээр ялалт байгуулахын тулд тусгай арми байгуулна гэж байсан шүү дээ.

- Тиймээ. Байлдааны үеийн дивиз гэдэг чинь 24,5 мянган цэрэгтэй, 150 танкаас бүрдсэн бригадтай, төрөл бүрийн их буу гэхэд 160 гаруй ордог юм. За тэгээд нисэхийн хоёр том отрядтай байдаг юм. Ингэхээр асар удахгүй 100 гаруй мянган цэрэгтэй арми монголын улаантныг оросуудтай нь хамт устгана. Ингээд Баян Цагаанаас Тамсаг хүртэлх газрыг хэдхэн хоногийн дотор улааны чөтгөрүүдээс чөлөөлнө гэхэд Юкийн сэтгэлд «8 сард чинь Синто ёсны шашны дайны тэнгэр Хатиманагийн тахилгын өдрүүд байдаг шүү дээ. Тэгэхээр яримацуригаар давхцах нь ээ» гэж бодогдлоо.

Японы цэргийн ёсонд эрин үедээ тодорсон дайчин самурай нарыг дараа дараагийн эрин үеийн самурай нарын өвөг дээдэс болгон алдаршуулдаг учраас өвөг дээдсийнхээ сүнсийг бишрэн тахих ёсыг хатимана бурхны тахилгын зан үйлийн дагуу үйлддэг хэд хэдэн онцлогийг баримтлан эрт үедээ их, бага, дунд баяр гэж хуваадаг байжээ. Бага тахилга үйлдэж дууссаны дараа 12 хоноод дунд тахилга эхэлдэг. Түүнээс хойш зургаан долоо хоноод их тахилга хийдэг ёстой байжээ.

Юки асарсан эцгийнхээ энэ үгийг хэдэнтээ эргэцүүлсний дараа дунд тахилгын үеэр «Косэйтоку» ажиллагааг эхлүүлэх эгзэгтэйг гадарлав. Тиймээс Юки, «косэйтоку» ажиллагааны эхлэх хугацааг зөв тогтоохын тул японы шашны зан үйл, төр ёсны баяр ёслолын түүхийн өдөр судартай холбогдох баримтуудыг олж үзэх шаардлагатай боллоо. Юки, асарсан эцгээ хажуулахаар өрөө рүүгээ явахад Ойдовын өрөөнд орж ажил төрлийн талаар нэлээн ярилцав. Тэгээд гарахын өмнө,

- Ойдовоо, чи ойрын үед Жанжин сүм рүү явна. Тиймээс ажил төрлөө сайн зохицуулаарай гээд өрөөнөөс гарахын даваан дээр ямар нэг юм санасан бололтой зогсоод,

- Чи одоо Банди, Тогтох хоёрыг дуудчихаач гэв.

Юки, өрөөндөө орж ирээд Тозияагийн бэлэглэсэн номын сангийн картыг шүүж байтал дуудсан хоёр орж ирлээ.

- Та хоёр энэ хэсэг картыг шүүгээд японы эртний зан заншил, баяр ёслолтой холбогдсон номуудын картыг ялгаарай гэлээ. Чингэж шүүсний эцэст Фузива Морихико гэдэг хүний бичсэн «Мэйзи зидай но фузоку буюу Мэйжийн үеийн зан заншил», «Нихонно мацури (японы баяр ёслол)», Сакутаро гэдэг хүний бичсэн «Нихон фузоку си буюу японы зан заншлын түүх» гэдэг номуудыг оллоо. Тэгээд Юки хоёр номыг Банди, Тогтох хоёрт өгөөд,

- Өнөө шөнийн дотор наад номоо уншаад японы баяр ёслолтой холбогдох сар, өдөр, ёс заншлыг тэмдэглээд өглөө надад өгөөрэй. Та хоёр гарахдаа өвгөн (Тозияа) унтаж уу, харчихаарай гэлээ.

Япончууд эрт үедээ 8 сарын 12-нд яримацури гэдэг баярыг ёслон тэмдэглэдэг байв. Энэ нь жадны баяр гэсэн үгнээс гаралтай бөгөөд хожим илд, жадны тахилга бүхий ёслол болон хувирч, эдүгээ цэргийн зэвсгийн баяр болсноор «Юмия хатимана буюу бидний зэвсгийг

Хатимана бурхан үзэг!» гэж тангарагладаг болсон болой. Энэ ёслолыг тэмдэглэхдээ хар өнгийн хувцас өмсөж, уртаараа 2 сяху (2,12, см) урттай найман сэлэм агсаж бас найман хүүхэд тэр хоёрыг тойрч бүжиглэдэг ажээ. Аяндын тэнгэр Сусано найман толгойтой могойн сүүлээр найман шидэт илд хийгээд Амагрэсаруд бэлэглэсэн бөгөөд тэр нь найман хүүхдэд тэр сэлмийг өгч газар дэлхийд илгээсэн хүч ажээ. Энэ ёслолын дараа 8 сарын 24-нд самурайн цог хийморь, сүр сүлдийг тахидаг баяр болдог. Сүлд тахисан баяраас хойш 42 хоноод гунсин мацури гэдэг баяр тэмдэглэдэг байлаа. Энэ нь үхсэн цэргийн сүнс тахиж гэсэн үгнээс гаралтай бололтой. Жил бүрийн 10 сарын 7-нд япончууд синтогийн сүмийн үүдэнд цугларч шөнийн тахилга үйлддэг бөгөөд цэрэг бүхэн цаасан дэн асаан барьж, тайлга үйлдээд дараа нь түүнийгээ шатаадаг төдийгүй уншлага үйлддэг ёстой болой.

Юки энэ шөнө нүд анилгүй ном шагайжээ. Тэгээд өглөө Банди, Тогтох хоёрын авчирч өгсөн түүврүүдийг уншаад, өглөөний цайг Тозияатай хамт уужээ.

- Ааваа, төмөр замын асуудлыг Ойдовт даалгаад Ханширээд суулгавал ямар вэ? Энд байхаараа энэ тэр юмаар хөөцөлдөөд цаг алдаад байх юм. Уэда сангийн яриагаар бол яаримацурийн дараа «косэйтоку» ажиллагааг эхлэх нь байна. Тэгэхээр би алгуурлаж болохгүй. Төмөр замаа тавиулах ажлаа яаравчлах хэрэгтэй! Ямар ч гэсэн хятадуудыг Халх голд нутаглуулахгүй. Халх голыг тэдний тарианы газар болгохгүй гэж хордсон байдалтай хэлэв. Тозияа цай оочилж суухдаа «Уэда сан ч Юкигийн үндэсний үзлийн эмзэг газрыг олоод авлаа шүү. Ингэхээр би санаандаа хүрэх цаг улам ойртоод байгаа хэрэг! Хятадуудыг Халх голд суурьшуулна гэдэг сургаар ингэж байгаа юм чинь тэднийг төв халхын нутаг гурван голын савд суурьшуулна гэвэл алтаа бүгдийг нь гаргаад чулуудаж мэдэх нь» гэж бодоод,

- Өнөөдөр чинь 8 сарын 5 билүү? гэснээ ширээн дээрээс янжуураа авч асаагаад Яаримацури бол энэрэнгүй ёсны бодь мөрийн баяр ёслол болохоор ертөнцийн амьтанд аз жаргал хайрлах ёслол учраас хатуу юм үйлдэхийг цээрлэдэг юм. Тиймээс энэ өдрүүдэд цаазлах хүнийг ч гэсэн амь хэлтрүүлж байсан гэдэг. Маш эртний самурайн энэ ёсоор бол яаримацуригийн өмнөх өдрүүдэд дайн байлдаан хийхийг хориглодог гэдэг сэн. Одоо түүнийг мэдэх хүн байх биш. Гэхдээ Уэда сан, жанжин штабын хэдэн егзөрүүд эртний ёсыг сайн мэддэг болохоор яаримацуригийн үеэр дайн хийх болов уу даа. Жанжин штабынхан тэртэй тэргүй Ясакуни сүмийн ширээт лам нараас косэйтокуг эхлүүлэх өдрийг тойруу замаар ч гэсэн асууна. Лам нар яаримацуригийн үеэр дайн дэгдээхийг хүлцэхгүй. Чи монголд дэлгэрсэн буддын шашны хайланг 45 хоног хүрдгийг мэднэ шүү дээ. Энэ бол монголд дэлгэрсэн энэрэнгүй ёсны нэг онцлог бүхий баяр юм.

Яг үүний эсрэг чиглэсэн нэг өвөрмөц ёслол бол синто ёсны дунд баяр юмдаг. Энэ баярыг эрт үедээ 42 хоног тэмдэглэдэг байсан гэдэг. Гэтэл хожуугийн ухаантангууд 42 хоногийн дараа тэмдэглэдэг болгосон юм гэнэлээ. Өөрөөр хэлбэл хатуу ёс буюу дайн байлдаанд таалал төгсөөд диваажинд одсон самурайн сүнсийг тахидаг өдөр болгож хувиргасан юм гэж хуучцуул ярьдаг сан. Оросуудын шашнаар бол Успенскийн баяр ёслолтой дүйцдэг. Христос шашны ёсноо тэнгэр заяатанг диваажинд одуулахын тулд 8 сарын 15нд их цайлга хийдэг шүү дээ. Энэ бүхнийг эргэцүүлбэл косэйтокуг 8 сарын 24-нд эхлүүлэх нь тохирууштай. Нөгөө талаар Халх голын дуулиан Пүрэв гаригт эхэлсэн. 8 сарын 24 бол Пүрэв гариг. Тэгэхээр сүйрэл учруулсан энэ өдөр сүлд тахиж нь бэлэг дэмбэрэлтэй өдөр гэлээ.

Тозияа энэ үгийг санаанаасаа зохиосонгүй. Харин Юки Уэдагийн амнаас ийм үг сонсвол 8 сарын 24-нд косэйтоку ажиллагааг эхлэх нь зайлшгүй байлаа. Тозияа, Юкитэй чингэж ярилцахдаа Ханширээд

Ойдовыг суулгах гэсэн саналыг эсэргүүцсэнгүй. Тэрээр жанжин штабаас баталсан Косэйтоку ажиллагаагаар монгол зөвлөлтийн армийн хүчийг бүрмөсөн устгана гэдэгт итгэж байсан болохоор Юкигээс байлдааны ажиллагааг нуулгүй харин түүний талаар ярьж итгүүлж чадвал богдын алт аяндаа гараад ирэх байхаа. Гэтэл Уэда, хожим ямар нэг хэрэг түвэгт унахгүйг хичээгээд Юкид косэйтокугийн талаар тодорхой ярьж танилцуулахгүй аргацаасаар байлаа.

...Уэда, өчигдөр Токиотой тусгай холбоогоор ярихдаа Тозияагийн саналыг дээд удирдлагадаа танилцуулахаар зүрхэлжээ.

- Гакка, миний бодож байгаагаар бол Юкид косэйтокугийн ажиллагааны талаар танилцуулж, зайлшгүй ялна гэдгийг үнэмшүүлэх нь чухал байх! Тэгвэл бид, Халх голоос Баянтүмэн хүртэл тавих төмөр замын стратегийн ач холбогдлыг бас нууцалж чадна. Юки, Харширээгээс Жанжин сүм, Халх гол руу төмөр зам тавьж барга нутгийн ард түмний хэрэгцээнд шаардлагатай зам харилцааны тулгамдсан асуудалд гар сунгаж, төмөр замын томоохон нийгэмлэгтэй холбоо тогтоож хувь нийлүүлэх гэж байна гэж нэлээн дорвитой шуугиан дэгдээд байгаа нь бидэнд маш ашигтай байгаа шүү дээ. Нөгөө талаар Юкийг хөрөнгө нийлүүлэх гэсэн сургаар армийн зам харилцааны ажиллагаанд хөрөнгө нийлүүлэх ёстой манай үйлдвэр банкны эзэд овоо идэвх гаргаж байна. Ингэхээр Юкид төрсөн итгэлийг улам гүнзгийрүүлэх нь зайлшгүй шаардлагатай юм.

- Уэда сан, та косэйтокугийн төлөвлөгөөг Юкид үзүүлэх санаатай байна уу?

- Гакка, энэ бол Юкид итгэл төрүүлэх аятайхан арга, нөгөө талаар Юки цэргийн боловсролгүй болохоор төлөвлөгөөг үзлээ ч гэсэн тодорхой ойлгож чадахгүй. Ер нь монголчууд нүдээр үзсэн юмаа ойлгож учир холбогдлыг нь мэдэж чадаагүй ч гэсэн итгэдэг сэтгэхүйтэй хүмүүс! Тиймээс нүдээр үзсэн бүхнийг үнэн, чихээр сонссон зүйлээ худлаа гэж үздэг онцлогтой шүү.

- Уэда сан, таны үгээр бол нүдээ баясааж, сэтгэлээ бадраана гэдэг болох нь дээ.

- Энэ чинь Зонховагийн үед боловсруулсан түвдийн гүн ухааны үндэслэл. Тиймээс түвдүүд бурхны урлагийн дээд хэлбэрээр монголчуудын нүдийг баясгаад зогсоогүй сэтгэлийг нь эзэмшиж, өөрсөндөө итгүүлж чадсан юм шүү. Энэ бол амьдралын нотолгоотой арга шүү дээ.

- Уэда сан, та энэ бүхнийг сайн судалсан бол төлөвлөгөөг үзүүлж болно. Гэхдээ нарийн тайлбарласны хэрэггүй биз! Харин асууж сонирхсон зүйлийг ингэс тэгсхийгээд өнгөрөөнө биз дээ гээд тусгай удирдамж өгөв.

Квантуны армийн удирдагч, жанжин штабаас ийнхүү чиглэл авсны дараа Юкийг урилаа.

- Юки сан, манай зам харилцааны асуудалд томоохон хувийн пүүс үйлдвэрийн эзэд хөрөнгө нийлүүлдэг. Гэтэл үйлдвэрийн эзэд, манай армийн удирдлагын хооронд заримдаа зөрчил

гардаг болохоор тэд бидний ажиллагаанд чөдөр болдог удаа байдаг юм. Харин та, армийн өмнө тулгамдсан ийм асуудалд биеэрээ оролцон туслахаар шийдэж идэвх санаачилга гаргасан явдал бол их алдар гавьяа юм.

Бид таны санаачилгыг дээд зэргээр дэмжиж байгааг та мэднэ.

- Уэда сан, 1932 онд Шанхайд хятадууд үймээн гаргаж японы иргэд, тэдний хөрөнгийг ихээхэн сүйтгэж билээ.

Тэднийг хамгаалах, аюулгүй байдлыг нь сахих зэрэг асуудлаар Токиогоос Шанхай руу гарах ёстой усан онгоцны зардлыг Токиогийн мицуи банкнаас гаргахдаа ихээхэн саад хийж байсныг би мэднэ. Тэгэхэд тэднийх 22 сая доллар дээр гар татаж билээ. Тиймээс Халх голын асуудлыг над ашигтайгаар шийднэ гэж үзээд төмөр зам байгуулах ёстой хувийн пүүснүүдтэй хоршихоор шийдсэн билээ. Хүсэл мөрөөдөл тэр бүр бүтэмжтэй биш байна. Гэхдээ миний горьдлого тасраагүй шүү гэхэд Уэда, Юкийн сэтгэлд итгэл төрүүлэх боломж олсондоо эчнээндээ багагүй баярласаар,

- Таны хүсэл мөрөөдлийг талаар өнгөрөөхгүй. Үүнийг би баталж чадна. Одоо хорь хоногийн дараа гэхэд манай арми, Халх голыг улаан орос болон монголын улаантны мэдлээс салгачихна. Тэр үед та яахаа мэднэ биз! Ямар ч гэсэн Халх голыг таны мэдэлд өгнө. Үүнийг би, ганцхан танд хэлж байгаа юм шүү! Учир нь манай арми өөрийнхөө ажиллагааг ганцхан Халх голоор хязгаарлахгүй. Тиймээс одоо 6 дугаар арми байгуулахаар болсон. Та манай армийн ажиллагаанд гар биеэрээ оролцож, дэмжиж байгаа жинхэнэ монгол хүн учраас бид танаас юу ч нуухгүй гээд нууцын шүүгээнээс газрын зураг гаргаж ширээн дээр дэлгэлээ. Юки тэр зургийг хайхрамжгүй харж байхад Уэда өрөөнийхөө үүд рүү эргэснээ,

- Юки сан та наад зургаа үзэж бай! Би... гээд үүдээрээ шагайж,

- Би хүн хүлээж авахгүй гэснээ туслахынхаа өрөө рүү орохдоо үүдээ гүйцэд хаасангүй. Хаалганы заагаар Уэда нэг генералтай уулзаад ямар нэг юм зааварлаж байгаа бололтой харагдана. Тэгээд арваад мөч болоод эргэн орж ирээд,

- Юки та ойлгож байна уу? гэж асуулаа.

- Уэда сан, би чинь газрын зургийн мэргэжилтэн биш. Надад бол нэг эрээн цоохор цаас л байна гэтэл Уэда,

- Би танд тайлбарлаж өгье. Энэ бол Халх голын наад талд байгаа армийн хориглож байгаа хэсгүүд юм. Манай цэргүүд одоо Фуй өндөрлөг, Такайсай, Бойтог манханд томоохон бэхлэлттэй болсон. Хайлаастын баруун зүүн талд манай 23, 7 дугаар дивизийн 26, 64, 72, 28, 71 дүгээр хорооноос гадна, баргын зургаан морин хороо, их бууны долоон хороо, танкийн хоёр хороо, инженерийн хоёр хороо оролцож байгаа юм. Зургадугаар армийг байгуулахаар бүүр ч их хүчтэй болно гэхэд Юки, Уэдагийн энэ ярианаас Баян Цагааны тулалдааны дараа хүчээ овоо шинэчилснийг мэдэж авчээ. Гэвч энэ бол хэн бүхэнд мэдэгдсэн баримт байлаа. Харин генерал зургадугаар армийнхаа талаар дуугүй өнгөрөхөөр шийдсэн нь илтээ. Уэда, хуучин хүчээ шинэ зүйл болгож тайлбарласны дараа,

- Та Жанжин сүмээс монголын хил рүү чиглэсэн төмөр замыг хаагуур тавина гэж бодож байна вэ? гэлээ.

- Мэргэжилтэнгүүдийн үзэж байгаагаар бол Муу өндөрлөг, Мухар уулын чиглэлийг ашигтай гэж байна. Харин хилээс цааших газрыг сонгоогүй байгаа. Ер нь Шар мод, Мухар уулнаас цаашаа Хулдын манхны зүүгээр Сүмбэр Цагаан нуурын чиглэлийг сонгох байх. Гэхдээ төмөр зам тавихад ямаршуухан бэ? гэдгийг мэдэхгүй байна. Нөгөө талаар бид хилийн цаад талын газрыг үзээгүй шүү дээ.

- Юки сан, та тийшээ очих гэж байгаа бол фронтын тэргүүн шугам дээр очих боломжоор хангаж болно гэхэд Юки,

- Би өөрөө очиж чадахгүй. Номондоо шамдаад байна. Ер нь тэгээд төмөр замын асуудлыг Ойдов хариуцаж байгаа. Тиймээс Ойдовыг тийш нь явуулах нь дээр. Үүнийг та, зөвшөөрнө биз дээ гэлээ.

- Бололгүй яах вэ? Би таны итгэмжилсэн хүнд бүх бололцоо тавьж өгнө шүү гээд хонхоо дартал туслах нь орж ирлээ. Тэгээд Уэда,

- Юки саны төлөөний итгэмжилсэн туслах Ойдовт, фронтын тэргүүн шугамд очих эрхийн үнэмлэх бэлд. Тэгэхдээ жанжин штабын тусгай төлөөлөгч нарт олгодог үнэмлэхийг олгох хэрэгтэй. Тэгээд тушаал гаргахдаа жанжин штабын удирдамжаар гэдгийг дурдаарай гэлээ.

Симотогийн санаачилгаар орос, монголын цэргийн удирдлагын яриаг чагнаж тэмдэглэдэг болсон нь их үр дүнд хүрсэнд Комацубара, сэтгэл хангалуун байлаа. Холбооны нууц төвд боловсруулсан мэдээг Аяанаосу хянан шалгасны дараа Комацубараад шилжүүлж, Синьзинд илтгэдэг болов.

Аяанаосу найман сарын эхээр Хуруу өндөрлөгт (Фуй такасай) очихдоо явган хорооны тагнуулын хэсгийн даргатай уулзав.

- Манайхан явган цэргийн нэг салаатай нийлж улаан оросын цэргийн нэг хориглолт руу дайрахад тэднийхэн ухарсан юм. Тэгэхэд бид энэ цүнхийг олсон юм гээд нэгэн цүнх үзүүлэв. Аяанаосу цүнхийг уудалж маш нарийн боловсруулсан хуурамч баримт байгааг мэдээд,

- Их сайн байна. Маш чухал бичиг олзолсон байна. Одоохон холбооны төв рүү явуул гэж тушаагаад Нэргүй өндөрлөгийн станц дээр ирж, фронтынхны болон цахилгаан нэвтрүүлгийн мэдээг сонирхлоо. Тэгээд тэндээсээ Хайлар руу гарлаа. Түүнийг ирэнгүүт Комацубара дуудлаа.

- Өчигдөр орой нэг радио нэвтрүүлэг хүлээж авлаа. Оросууд Халх голын цаад талд байгуулах бэхлэлтийн талаар гаргасан заавар байна. Ер нь та одоо бидний гарт ороод байгаа энэ баримтуудыг юу гэж үзэж байна гэж хартай, сэжиглэсэн байдлаар асуулаа.

- Бидэнд байгаа баримтуудыг фронтын тэргүүн шугамд байгаа улаан орос, монголын цэргийн хориглолтын байр байдал, хороодын тагнуулынхны нүдээрээ үзсэн зүйлтэй харьцуулахад энэ

намар, өвөл ар талаа бэхжүүлэх ямар нэг аргаар төмөр замтай болохыг эрхэмлэсэн нь илт бөгөөд цэрэг шилжүүлэх талаар аргаа барж байгаа нь илэрхий байгаа юм гэхэд генерал Аяанаосугийн саналыг нэлээн тунгаан бодож сууснаа,

- Юкигийн итгэмжилсэн хүн энд ирчихээд байгаа. Та түүнийг дагуулж байлдааны тэргүүн шугам дээр очих хэрэгтэй гэлээ.

- Гакка, тэр чинь байлдааны тэргүүн шугам дээр очиж үхсэнээ хийх гэж тийшээ саваагүйтэж яваа юм бэ? Фронт дээр очиж архи цуслаад гай тарьж мэдэх юм. Тэр чинь хөдөө хээр явахаараа архины лүү гэсэн үг гэхэд Комацубара,

- Тэгж болохгүй. Бид улаан оросоос түрүүлж Халх голын цаад талд төмөр зам тавих хэрэгтэй. Манай армийн зам харилцаанд хөрөнгөжүүлэх ёстой үйлдвэрийн эзэд урдаа Юкигийн алтыг бариад байгаа юм. Тиймээс арми дэмжихээс өөр замгүй. Чи юу ч гэсэн Ойдовтой уулз! Тэр чинь Халх голын Сүмбэр Цагаан нуур хүртэлх газрыг үзэх гээд байгаа юм.

Аяанаосу, зочид буудалд ирэхэд үйлчлэгч түүнийг та танимхайран уулзлаа. Аяанаосу, үйлчлэгчээр Ойдовын өрөөг заалгахаар сураглахад,

- Ноён хошуучаа би таны өрөөг бэлэн болгочихсон. Ойдов гуай 05 дугаар өрөөнд байгаа. Би дуудах уу? гэлээ.

- Хэрэггүй. Би өөрөө очиж уулзъя гээд Аяанаосу, өөрийнхөө өрөөнд оролгүй Ойдовын өрөө рүү алхав. Тэгээд Ойдовын өрөөнд орж ирээд түүнээс урьтаж,

- Ойдов сан сайн явж ирэв үү Та хаачих нь вэ? хэмээн албархуу асуугаад өрөөний адар руу заахад Ойдов сая учрыг нь гадарлан, тусгай чагнах багаж төхөөрөмжилсөн өрөө гэдгийг мэдэв.

- Сайн явж ирлээ. Би хотын холбоо руу очно. Би заваар муухан байна. Та надтай уулзаж ажил төрлөө тохирох гэж байгаа бол орой уулзах уу даа гэлээ.

- За яахав тэгье дээ. Би одоохондоо завтай байна. Хоёулаа замдаа ярилцсан ч болно шүү дээ гэхэд Ойдов дурамжхан маягтай,

- Та өөрөө мэд! гэлээ. Ойдов, Аяанаосу хоёр өрөөнөөс гарч Хайларын шуудан хороо руу явахдаа ажлаа ярилцав.

- Аяанаосу минь шинэ довтолгооны нэрийг тайлж чадсан. Эхлэх өдөр нь тодорхой болсон. Байлдааны зураг Уэдагийн нууц шүүгээнд байгаа юм байна. Түүний гэрэл зургийг яаралтай хугацаанд авч төвд дамжуулах болоод байна. Тиймээс Рожусай чамайг маш яаралтай хугацаанд Синьзинд ирэх шалтаг гарга гэж даалгасан! Нөгөө талаар фронтын хориглолтын тойм зураг, мөн цэргийн хээрийн нисэх буудал, бэлтгэл хүч байгаа газруудыг тэмдэглэж ирэхийг чухал гэж үзэж байна гэлээ.

- Хориглолтын зураг бэлэн байгаа. Харин Комацубара намайг чамтай хамт явалц гэсэн. Би эхэндээ жаахан дургүй дүр гаргасан. Өөрөө жаахан дурамжхан боловч дээрээс өгсөн шийд гэж бодоод байгаа бололтой байна.

- Би ямар хүн дагуулж явуулах бол гэж айж байсан юм. Одоо санаа амарлаа байна. Чи Хар чонын нэг танил Синьзинд байгааг мэдсэн үү?

- Түлхүүр хийдэг дархан уу?

- Тийм. Ашгүй чи мэддэг юм уу?

- Мэднэ. Харин надад Синьзин руу явах боломж гарахгүй. Намайг ганцхан Тозияа, Уэда хоёр л эндээс дуудах ёстой. Тэгэхээр эндээс тийм ч амархан явчихаж чадахгүй,

- Тэгвэл энэ чинь амжихгүй асуудал юм байна даа. Өөр арга бодож олох хэрэгтэй гэж хэлсэн боловч Ойдов ямар ч боломж гаргаж чадсангүй.

Аяанаосу шөнөжингөө бодсон боловч олигтой далим гаргах нөхцөлгүй байгааг ухаараад өөртөө цухалдав. Тэрээр Синьзинд очих нэг боломж бол Хар чонын ажиллагааг унагаж түүнийг ор сураггүй алга болгох хэрэгтэй. Тэгээд Тозияад Юкигийн алтны сургийг гаргаад оргосон байна гэж илтгэвэл Тозияа түүнийг дуудаад Шанхай руу явуулах аж. Ингэвэл эцсийн эцэст Рожусайн ажил унахад хүрэх аюултай! Тиймээс ийм алхам хийх тухай бодох ч хэрэггүй аж. Хоёр дахь боломж нь Симолагийн ажлыг унагах ёстой. Хориглолтын хэсэг дээр байгаа салбар станцуудыг дэлбэлээд оросын тагнуулууд ирж сүйтгэлээ гэдэг асуудал дэгдээгээд түүнийг шалгасан зүйлээ Уэдаад биеэрээ танилцуулахаар Синьзин руу шууд явж болох боломжтой аж. Тиймээс өглөө Комацубаратай уулзаад «Ойдов байлдааны тэргүүн шугам дээр очно гэж зөрөөд ятгалганд орсонгүй» гэж танилцуулаад түүнийг дагуулж Жанжин сүм рүү явах ёстой. Иймээс Аяанаосу хоёр дахь аргаа туршиж үзэхээр өглөө нь Ойдовтой хамт Жанжин сүм рүү гарлаа.

Аяанаосу, Ойдовыг Харбинаас яваа төмөр замын зургийн мэргэжилтэнтэй хамт дагуулж Жанжин сүм дээр ирэхэд Симо то угтлаа. Чингээд маргааш нь Муу өндөрлөг, Зүүн Мунын өндөрлөг, Мухар уулын чиглэлд тавих төмөр замын газар сонгохоор хөдлөв. Тэд үд өнгөрөөгөөд Шар модны чиглэлээр хилээр орж ирээд хилийн цэргийг удирдсан Моритогийн отряд дээр ирлээ. Гэтэл нар жаргах гэж байтал байлдааны түгшүүр японы цэргийн бүх хориглолт дээр зарлав.

Симото, харилцуур авч, Хайлааст голын зүүн талд байгаа Такасай өндөрлөг рүү ярилаа,

- Тайса доноо, оросын танкууд манай бэхлэлтийн чиглэлээр довтлох гэж байх шиг байна. Алсад онгоцны дуу нүргэлээд Фуй өндөрлөгийн хавьд бөмбөгний нүргээн гарч байна. Манайхан их бууны гал нээж тэдний довтолгоог няцааж байх шиг байна. Симото, тэр дороо 26 дугаар хороо, 64, 72 дугаар хороо руу ярилаа.

- Оросын танкууд Оонын манхнаас Хайлааст манхан руу давших чиглэлтэй довтолж байна. Гэсэн ч манайхан их бууны хүчтэй гал нээсэн тул довтолгоо зогсох шиг боллоо.

- Дайсны хичнээн танкийг устгасан бэ? Манай хохирол ямар байна.
- Манай талд хохирол байхгүй. Харин оросууд бараг утсан байх. Ухрах нь харагдсангүй.
- Та нар байдлыг сайн ажигла. Тагнуулууд гаргаж оросын хохирлыг гаргах хэрэгтэй гээд Симото, Ногоон толгойд хориглож байгаа 28 дугаар хороо руу утасдав.
- Тайса доноо, Нурын овооны чиглэлд танкнууд гарч ирж байгаа бололтой чимээ дэгдээд, Хайлаастын цаад руу их буу, онгоцны бөмбөгдөлт болж байх шиг байна. Бодвол ихээхэн хүч Халх голоор гарч ирсэн бололтой.
- Байдлыг над руу илтгэж байгаарай гээд Симото, Аяанаосу руу эргэж
- Хошуучаа, Ойдов та хоёр Халх гол руу явж болохгүй. Улаан оросын ихээхэн хүч голоор гарч байгаа бололтой. Тиймээс одоохон Жанжин сүм рүү буц. Бид байдлыг ажиглаад маргааш илтгэнэ гэхэд Аяанаосу, Симотогийн саналыг дэмжиж Ойдовыг ятгалаа.
- Ойдов сан, Симото бид хоёр энд үлдье. Байдлыг харзнаж байгаад маргааш очье гэхэд Ойдов арга буюу Жанжин сүм рүү буцлаа.

Аяанаосу, Симото хоёр тэднийг явсны дараа Бойтог манхнаас хөдөлж нууц холбооны төв дээр ирлээ. Тэгээд шөнийн чимээ чагнасан боловч ямар ч түгшүүр гарсангүй. Маргааш өглөө нь Такасай өндөрлөгтэй холбоо барихад оросууд урд шөнөжингөө энд тэндгүй шон зоож байгаа бололтой баахан чимээ дэгдээд байсан. Бодвол хориглолтын өргөсөн тор ирсэн юм байлгүй. Танкийн довтолгоо хийсэнгүй гэж илтгэв.

- Аяанаосу, чи үүнийг юу гэж бодож байна?

- Би гайхаад учрыг нь олохгүй юм. Ер нь оросууд замбараагүй юм уу даа. Эсвэл биднийг сүрдүүлж байгаа юм уу? Мэдэхээ байлаа. Аяанаосу, эд чинь бэхлэлт барьж байгаагаа нууцлах гэсэн юм бол уу.

- Бидэнд байгаа баримтаар бол оросууд довтолгоонд орохгүй нь илэрхий. Тэгэхээр биднийг айлгаж сүрдүүлснээрээ цэргүүдийн сэтгэл санааг алдуулж, эмх замбараагүй байдалд оруулах гэсэн байж болно. Түүнээс гадна оросууд төмөр зам тавиагүй цагт цэргээ Халх голд татна гэдэг тун бэрхшээлтэй асуудал.

- Аяанаосу минь чиний төсөөлөл ортой байх. Ер нь Ойдов саныг дуудах уу даа?

- Харин ээ. Гай болж тэнэмэл суманд өртчихвөл яана. Та бид хоёрыг хөөднө шүү. Ер нь хашир нь дээр байх. Өнөө маргаашдаа хүлээж байг! Жанжин сүм дээр хүүхнүүдтэй нийлж зугаагаа гаргаж байг!

Симото, Аяанаосугийн саналыг зөвшөөрөөд үдэш болтол Жанжин сүм рүү ярьсангүй. Гэтэл Оонын манхан, Хайлаастаар тагнуулд гарсан хэсгүүд ирснийг илтгэв. Симото тэдэнтэй утсаар ярилаа.--Оросын хориглож байгаа газраар тор татчихсан байна. Бид хэл барьж чадсангүй. Хэд хэдэн ухуулах хуудас, зааврууд олж ирсэн. Орчуулагч нарын нягталснаар бол

хориглолтын зорилтыг тодорхойлсон заавар байгаа бололтой.

- Наад заавраа тусгай холбооны цэргээр нааш нь өгч явуул! Аяанаосу тэр оройгоо Жанжин сүм дээр иртэл Ойдов явчихсан

байлаа. Тиймээс Аяанаосу, өөртөө ашигтай цагийг олж сонгох талаар бодсоор зүүрмэглэв. Гэтэл шөнө дунд өнгөрөөгөөд Симото түүнийг нойрноос нь сэрээв.

- Аяанаосу, өнөө танк, онгоц, их бууны дуу чимээний учрыг оллоо. Тусгай төхөөрөмжилсэн холбооны нэвтрүүлэг хийдэг хэд хэдэн тэрэг Халх голын эргээр явж танк, их буу, бөмбөгдөлтийн чимээ нэвтрүүлдэг байжээ. Одоо Дүйнхор овооноос Элсэн уул, Ногоон уулын чиглэлд дуу чимээ хадааж байна. Яг л довтолгоо хийж байгаа юм шиг шүү. Манай тагнуулууд холбооны тэр тэргийг олж харсан байна. Тиймээс устгавал дээр үү. Ер нь баривчлах нь дээр юм шиг санагдаад байна.

- Тайса доноо, энэ талаар Комацубараад илтгэв үү?

- Үгүй одоохондоо мэдэгдээгүй байна. Юу ч гэсэн хоёулаа түүний барааг олж харъя. Тэгээд ярилцаж байж шийдье гэлээ.

Аяанаосу тэр дороо хувцаслаад суудлын тэргээр холбооны нууц төв рүү хурдлуулав. Тэгээд үдээс хойш Симототой нийлж Элсэн манханд иртэл Элсэн уулын цаана дайн тулалдааны чимээ нүргэлж гарлаа. Тэд тэр зүг рүү дурангаар хартал Ногоон уулын харалдаа нэгэн ганганд нууж зогсоосон холбооны тэрэгнүүд тусгайлан бэлдсэн дуу чимээ дэгдээж гарах нь тэрээ.

Аяанаосу, холбооны тэрэгний барааг харж хонхордуу газар хэвтэхдээ «Үүнийг устгуулж болохгүй» гэж бодлоо. Гэтэл Симото түүний бодлыг мэдсэн юм шиг дурангаа арчих зуур,

- Эднийг цөмийг устгуулах уу? Олзлох уу гэлээ.

- Эднийг устгасанд орвол энэ дуу чимээг өөрсдөдөө ашиглавал яасан юм бэ? гэж Аяанаосуг хэлэхэд Симото,

- Яаж ашиглах юм бэ? гэж лавлав.

- Манай шинэ довтолгоонд хэрэглэх бүх техникийг энэ дуу чимээг ашиглаж, байлдааны тэргүүний шугам дээр авчирвал болох юм биш үү? Тэгэхээр тоохгүй юм шиг байх хэрэгтэй.

Аяанаосу, чиний наад санаа чинь ер нь зөв юм шүү. Манай цэргийн шилжүүлэлтийг энэ дуу чимээний доор хийхэд болох юм. Ер нь Комацубараад илтгэе гэхэд Аяанаосу,

- Би ч гэсэн армийн штаб руу мэдэгдье. Тозияа саны саналыг сонсьё. Тэр болтол энэ тэрэгнүүд ингээд явж байг Тиймээс хороодын дарга нарт сануулах хэрэгтэй. Тэгэхгүй бол тэд чинь устгаж мэдэх юм шүү гэхэд Симото тэр 23, 7 дугаар дивизийн удирдлагад мэдэгдэж анхааруулав. Ингээд Аяанаосу, холбооны төвд ирээд Тозияатай ярьж тусгай төхөөрөмжтэй тэрэгний дуу чимээг ашиглах саналаа Симотогийн санал болгож танилцуулав.

- Хошуучаа, Симотогийн саналыг дэмжиж болно. Харин ажил нь ямар байна?

- Гакка, би ер нь энд байх онц шаардлагагүй юм шиг байна. Комацубара санд Симотогийн ажлыг танилцуулж дэмжлэг авсан. Комацубара сан түүнийг юунаас ч хамгаалж чадах юм байна. Нөгөө талаар холбооны тэргийг ашиглах тухай гаргасан Симотогийн санааг баяжуулсан нэг төлөвлөгөө надад байна түүнийг Уэда санд танилцуулмаар юмсан гэхэд Тозияа түүний яриаг анхааралтай сонсоод,

- Аяанаосу сан, чи Шар модноос Халх хүртэлх газрыг аль зэрэг мэдэх вэ? гэж асуухад Аяанаосу, энэ бүхнийг Ойдов зохион байгуулж гэдгийг ойлголоо.

- Би ноднингоос хойш энд байсан шүү дээ. Ер нь нэлээн гадарлана шүү.

- Тэгвэл чи, наашаа ир! Ойдов сангийн аминд орохыг бодох хэрэгтэй. Юки газар орны байдлыг мэдэж чадаагүй ирлээ гэж үглэж уурлаад байна. Тэгэхээр чи ямаршуухан газар орон болохыг тайлбарлаж өг! Ер нь таван мянганы зураг дээр зааж өгөх хэрэг ч гарч магадгүй юм.

Аяанаосу, үүнийг дуулаад сэтгэлдээ "Ойдов минь ийм овжин ухаан гаргасанд баярлалаа. Жанжин сүмээс хэл чимээгүй явсан нь ийм учиртай байж дээ" гэж өөртөө хэлээд Симототой ярихаар шийдэв.

Аяанаосуг Синьзинд ирсний дараа өдөр ажил тарах гэж байхад түүнийг Уэда дуудлаа. Тэрээр фронтын байдал, тусгайлан төхөөрөмжилсөн холбооны машины талаар ярилцлаа. Тэгээд ярианы сүүлд,

- Аяанаосу сан, та түүнийг устгахгүй гэсэн чинь тун зөв болжээ. Харин түүнийг шинэ довтолгоонд ашиглах тухайд гэвэл нарийн судлах хэрэгтэй. За тэгээд энэ талаар хүн амьтанд дуулгасны хэрэггүй гэж захилаа.

Аяанаосу генералын өрөөнөөс гарч ирэхдээ тагнуулын газрын даргатай туслахын өрөөнд тааралдлаа. Тэрээр,

- Шиү са, чи миний өрөөнд очоод хүлээж бай гэлээ. Аяанаосу даргаа хүлээж туслахын нь өрөөнд сууж байтал гаднаас орж ирсэн хурандаа,

- Шиү са, шифрийн мэргэжилтэнгүүд тайлж чадахгүй радио нэвтрүүлэг баригддаг болсныг та мэдэх байхаа гэж асуулаа.

- Тиймээ. Би танаас дуулсан!

- За тэгвэл энэ асуудлыг хяналтандаа авах хэрэгтэй гэж үзэж байна. Бид түүнийг илрүүлэх талаар кэмпэйтийн төлөөлөгч нартай хамтарч ажиллах болно. Гэхдээ та давхар ажиглах нь бидний хувьд ашигтай. Нэвтрүүлэг хийсэн цаг хугацааг танд жич мэдэгдэж байна. Харин та нөгөөдөр штаб дээр байгаа тусгай холбооныхонтой ажиллах болно. Тиймээс маргаашийн баяраар хэтэрхий ууж, ядарч болохгүй гэж захих гэсэн юм гэлээ.

Аяанаосу ажлаасаа тараад цэргийн буудал руу явахдаа Ойдовын нэвтрүүлэг хяналтанд орсныг мэдлээ. Харбин, Синьзинд хийсэн нэвтрүүлгийн сүлжээг ажигласан кэмпэйтэйнхан, цэргийн тагнуулын газартай хамтрахаар тохирсон нь радио пленгацын ажиллагааг будлиантуулж болох нэгэн санааг Аяанаосуд төрүүлжээ. Аяанаосу энэ орой зочид буудалд Ойдовтой санамсаргүй дайралдлаа. Тэрээр маргааш болох яаримацури баярын дараагаар Тозияагийн дэргэд байсан дайлаганд урьсан урилгыг авчирч өглөө.

- Аяанаосу минь Рожусай хар чонын хүнтэй уулзаж нууц шүүгээний түлхүүр хийлгэх талаар тохиролц гэсэн. Нөгөөдөр өглөө түлхүүрийн хэвийг чамд өгнө гээд явлаа.

8 сарын 12-ны өдөр. Бямба гариг. Энэ өглөө Синьзин хотод суурьшсан квантуны армийнхан яаримацури баярт оролцлоо. Харин

Аяанаосу, өглөө баяр дээр очсоны дараа хотын зүүн хэсэгт байдаг Итунхэ голын эрэг дагуух гудамжны нэг байшинг эзэлдэг дархны газар очлоо. Дархны газар онгойгоогүй болохоор Аяанаосу хаалгыг балбатал удаж төдөлгүй дөч шахам насны нэгэн бадируун хүн хаалганы түгжээг тайлах зуур хараал тавин,

- Юу болоод учир зүггүй балбаад байна гэж хятадаар үглэсээр гарч ирснээ япон цэргийн хувцастай хошууч зогсож байхыг хараад ёс алдсанаа мэдээд нэлээн балмагдана.

- Эндхийн эзэн нь чи юу? гэж Аяанаосуг асуухад өнөө хүн хятадаар цэвэрхэн ярьдаг япон даргыг гайхаад үг хэлж чадалгүй толгой дохив.

Манжуурт тогтоосон японы дэглэмээр бол япон дарга нарын өөдөөс хятад хүн эгцлэн харж болохгүй агаад асуусан зүйлийг хариулахдаа тэргүүн бөхийлгөн хариулах ёстой. Энэ ёсоо алдсан хятадуудыг японы дарга нар Наран улсын Тэнногийн армийг хүндэтгээгүй гэж үзээд жанчиж цээрлүүлдэг ёстой. Тиймээс японы дээд тушаалын дарга нарт зориулсан тусгай шаахай (хүний хацар руу шавхуурдахад зориулсан нэгэн зүйлийн шириг ингэж нэрлэдэг) бэлджээ. Аяанаосу цэргийн дүрэм горимыг хүндэтгээгүй дархныг халааснаасаа гаргаж ирсэн алга дарам хэмжээтэй шаахайгаар хацар руу нь хэд буулгав.

- Энэ дархны газрын эзнийг нууц шүүгээний түлхүүр хийдэг гэсэн. Тэгвэл та тэр хүн байх нь ээ гэхэд,

- Эрхэм дээдсээ, намайг өршөөж хайрла! Би ёс алдсандаа өршөөл гуйя. Нөгөө талаар би, нууц шүүгээний түлхүүр хийж үзээгүй хүн гэлээ.

- Хэдэрлэх хэрэггүй. Тяньжин дахь английн банкны салбарын нууц түлхүүрийг чи Хар чонод хийж өгсөн биз дээ. Хэрэг хиртдэггүй, хууль хуучирдаггүй юм шүү. Английнхан таныг хайсаар байгаа. Хар чоно тантай уулзах гэж Синьзинд ирсэн! Тэгээд английн нууц туршуулуудад сэжиглэгдээд яасныг чи мэдэж байгаа.

Сайхь эр, Аяанаосугийн үгийг сонсоод бүүр сандарч гарлаа. Тэрээр Хар чонотой нэг удаа нууцаар уулзсан билээ. Түүнийг нь Тозияа мэдсэн аж. Харин энэ хүнийг Тозияа хэрэгтэй үедээ ашиглахаар шийдэж дуугүй өнгөрснийг Аяанаосу гадарлажээ.

- Ноён даргаа, би хийж чадах юм болов уу даа гэхэд, Аяанаосу,

- Чи хийж чадна! Хэрвээ гараа гаргаж хийвэл үнэ хөлсийг чинь өгнө. Тэгээд ч урьдын чинь явдлыг сөхөхгүй. Чамд ерийн байдлаар амьдрах бололцоо олгоно. Хэрвээ түлхүүр эх загвараасаа өөр болсон бол хэрэг явдал өөрөөр шийдэгдэнэ гэдгийг хатуу анхаарах хэрэгтэй! Нөгөө талаар оргох, зайлах, булгах гэсний хэрэггүй! Энэ цагаас хойш та байшингаасаа хэдийд хаашаа явсан, хэнтэй уулзсан, юу сонирхсон, ямар юм авсан зэргийг манайхан хянах болно. Тэгэхээр та номхон хүлцэнгүй байх нь дээр гэж хэлэхэд сайхь эр толгой дохино.

Аяанаосу, дархантай ингэж яриад гудамж уруудан явахад өнөө хүн, сэтгэлдээ «Энэ хошууч, намайг сорьж шалгахаар шийдлээ шүү. Тиймээс ямар ч түлхүүрийн загвар өгөлгүй явлаа» гэж бодоод хоцорчээ.

Аяанаосу орой Тозияагийн цайллаганд очлоо. Дайллага 2 цаг хагас хүртэл үргэлжлэв. Армийн удирдлагаас ирсэн ихэнх дарга нар өндөрлөсөн боловч Халх голын бэхлэлтийг удирдсан инженер генерал, Харбинаас ирсэн хурандаа Сафронов, армийн зам харилцааны асуудал эрхэлдэг хурандаа Учида зэрэг хэдэн хүмүүс үлдлээ. Харин Уэда дайллаагын ширээний хүндэтгэлийн суудал дээр сууж байснаа Тозияатай нийлж зочдын өрөөнөөс гараад түүний өрөөнд оржээ. Уэда согтсон үедээ Сэйёокогоос төвөгшөөдөг байлаа. Тэрээр архи ханхлуулчихсан үед, Уэдаг өвөртөө оруулдаггүй болохоор согтуу үедээ архиа гаргаж байж харьдаг номтой. Тиймээс Тозияагийн нэлээн сэржимдсэн Уэда, архиа гаргаж байж харих ёстой аж. Тозияа өрөөндөө орохын өмнөхөн Юкийг дуудаж ширээ засуулчихаарай гэсэн болохоор Тозияа өрөөндөө орж ирээд,

- Уэда сан, хоёулаа энд жаахан сууж хатуухан юм балгая гээд голланд жин задлав. Тозияа, Уэда хоёр ийнхүү тухтай сууж амарч байхад зочдын өрөөнд үлдсэн Аяанаосу цагаа харвал 24 цаг болох гэж байлаа.

- Эрхэм хүндэт дарга нараа одоо өндөрлөе. Цаг оройтлоо гэхэд дарга нар суудлаасаа бослоо. Бэхлэлтийн инженер их согтсон болохоор Юки,

- Моки сан, та эндээ хоноод явах уу даа гэж хэлтэл нэг ахмад,

- Би хүргэж өгнө гэхийг ажвал түүнийг хамгаалж яваа нь илт ээ.

- Та нар жаахан сууж наргицгаа л даа..Би аавд халуун цай оруулж өгөөд ирье гээд Юкийг гарахад ширээний араас боссон дарга нар буцаж сууцгаалаа. Чухам энэхэн үед үйлчлэгч нар орж ирээд ширээнийхээ идээ будааг солин шинэчилж, нөгөө өрөөнөөс бүжигчин, дуучин гэйша нар орж ирээд дарга нарын уйтгарыг гаргаж хөгжимдөн бүжиглэв.

Ийнхүү үргэлжилсэн наргиан 02 цаг хүртэл үргэлжлээд өнд өрлөв. Аяанаосу, хэдэн дарга нартай хаалгаар гарах гэтэл амандаа тамхи зууж явсан Ойдов,

- Аяанаосу сан, та шүдэнзээ гаргаач гэхэд Аяанаосу хаалгаар гарч байгаа дарга нараас яльгүй үлдэхийгээд Ойдовын янжуурыг асааж өгтөл,

- Хоёулаа өглөө 10 цагт тамхины дэлгүүрт уулзъя гэлээ. Аяанаосу өглөө аажуухан босоод штаб руу ярилаа. Сайн өдрийн ээлжинд сууж байгаа тусгай даалгавартай хүмүүс радио пеленгацын дэргэдээс холдоогүй ажээ.

- Аяанаосу сан, та 21 цагаас өглөөний 09 цаг хүртэл ажиллах ёстой. Та өөрөө ирэх үү? Унаа явуулах уу? гэж асуув.

- Би өөрөө очно гээд Аяанаосу цагаа тохируулав. Тэгээд Ойдовтой уулзахаар зочид буудлаас зайдуухан байгаа тамхины дэлгүүр рүү сажлав. Аяанаосуг нэг боодол янжуур авч байтал Ойдов орж ирлээ. Худалдагч авгай Ойдовтой хэзээний танил болохоор,

- Би таны захиалсан тамхийг бэлдчихсэн. Одоохон аваад ирье гээд хажуугийн өрөөний хаалга руу эргэв. Авгай өрөөндөө орсны дараа,

- Рожусай энэ хэвийг өгүүллээ. Үүнийг өнөөдрийн дотор хийлгэж бэлэн болгохыг даалгасан. Хоёулаа үдийн хоолноор зоогийн газар дайралдъя гэж хэлээд хотын захад байдаг нэгэн зоогийн газар цаг болзлоо. Аяанаосу тамхины дэлгүүрээс гарч дархны газар руу явлаа. Чингээд хагас цагийн дараа дархантай уулзаж,

- Би танд яггүй ажил авчирлаа. Үнэ хөлсөн дээр гар татахгүй. Ганцхан өнөөдөр багтааж авна. Тиймээс танд 1000 иень өгье. Одоо үүнийг авч бай гээд 500 иень өгөхөд дархан гайхсандаа нүдээ том болгон Аяанаосугийн царай өөд ширтлээ.

- Би хичээж хийнэ. Харин надад барагтайхан төмөр бий. Сайн төмөр олж ирдэг юм билүү? гэхэд Аяанаосу,

- Хэрэггүй. Байгаа төмрөөрөө хийчих гээд түлхүүрийн хэвийг өгөөд гарахдаа оройн 19 цагт ирж авна гэлээ.

Аяанаосу болзсон цагтаа зоогийн газар ирэхэд Ойдов түүнийг хүлээж байлаа.

Маргааш өглөөний 03 цагт штабын байшингийн доод давхрын бие засах газрын цонхны түгжээг сулласан байх хэрэгтэй! 03 цагаас хойш 15 мөчийн хугацаанд штабын дээд давхруудаар ганц ч хүн явуулахгүй байх хэрэгтэй. Ялангуяа Уэдагийн өрөө рүү хүн алхуулж болохгүй. Энэ хугацаанд тийшээ очсон хүнд саад болох нь чухал.

Хэрвээ зайлшгүй хэрэгцээ гарвал 20 мөчийн турш хамгаалах болно. Та миний цагтай цагаа тааруул! Би түлхүүрийг авахгүй харин та бие засах газрын энэ хаалганы усны дээд савны тагны дотор талын төмөрт өлгөсөн байх хэрэгтэй гээд нэгэн зураг гаргаж үзүүлэв. Ийнхүү яриагаа тохируулсан Ойдов зоогийн газраас гарч явахад Аяанаосу өглөөнөөс хойш юу ч идээгүйгээ санаад «Одоо чинь тухтайхан шиг хооллоё» гэж бодлоо.

Аяанаосу 19 цагт 10 мөч дутуу байхад дархны газар ирлээ. Гэтэл дархан түлхүүрээ хийж амжаагүй ажээ. Тэрээр долоон түлхүүрийн тав дахь түлхүүрийг хийж дуусгаж байлаа. Дархан Аяанаосуг хараад бүүр ч тэвдэж байгааг мэдэнгүүт тэрээр дарханд саад болохгүйг хичээж дархны газраас гарч зэргэлдээх гудамжны цэцэрлэгт очиж цаг нөхцөөлөө. Тэрээр цаг

шахам гадаа суусны дараа дархны газар руу орохоор бостол нэгэн хятад гудамжны хогийг шүүрдэж байгаа харагдлаа. Аяанаосуг орж ирэхэд дархан духныхаа хөлсийг арчаад,

- Дуусах нь дууслаа. Юу ч гэсэн шалгаадахья гээд хэвэнд барьж үзсэнээ,

- За айлтгүй яг таарсан байна гэхэд Аяанаосу таван зуун иень өгөөд,

- Танай эндхийн гудамжийг их эрт цэвэрлэдэг юм байна. Цэвэрлэгч нь их ажилсаг хүн юмаа даа гэлээ.

- Уг нь өдөр бүрийн 21 цагаас хойш цэвэрлэдэг юмсан. Өнөөдөр ажил гараад эртхэн цэвэрлэж байгаа биз дээ гэлээ.

- Та өнөөдрөөс эхэлж энд байсны хэрэггүй. Таныг армийн тагнуулын газрын удирдлага сонирхож байгаа. Тиймээс маргааш гэхэд та энэ хотод байж болохгүй. Тиймээс эртхэн өөрийгөө бодсон дээр! Оройтвол хожимдоно шүү гэж анхааруулан хэлээд дархны газраас гарлаа.

Шөнө дүл өнгөртөл пеленгацад ямар ч долгион баригдсангүй. Сүүлийн арваад хоног чингэж нойроо барж суусан хүмүүс залхаж гүйцжээ. Тэгээд уйдахын эрхэнд яриа дэлгэж «Нэвтрүүлгийн ээлжийг солиод хугацаагаа сунгачихсан байх» гэж нэг нь хэлэхэд нөгөө нь «Эзэн нь сэжиг аваад Синьзингээс дүрвэчихсэн юм байлгүй. Түүнээс арав хоноход хэл чимээгүй байна гэдэг сэжигтэй хэрэг» гэж сэтгэл санааныхаа төсөөллийг ярина. Ээлжилж сууж байгаа хүмүүс 02 цагаас хойш нойрмоглож эхэллээ. Тэгээд удаан сууж чилсэн биеэ амраахаар сандлын түшлэг налан нүдний хороо сэм гаргана. Ээлжийнхэн сүүлийн үед ингэж дасжээ. Аяанаосу 02 цаг 50 мөчид ерөнхий жижүүрийн дэргэд байгаа тусгай өрөөнөөс гарч бие засах газар руу явлаа. Түүнийг ажиглах сөгөөтэй хүн байсангүй! Аяанаосу бие засах газар ороод цонхны түгжээнүүдийг мултлан үл мэдэг зай гаргаад болзсон газраа түлхүүрээ хийгээд бие засах газрын гэрлийг унтраагаад гарлаа. Тэгээд ерөнхий жижүүрийн хажуугийн өрөөнд орж гудамжаар явж байгаа пеленгацынхантай холбоо бариад ерөнхий жижүүрийн өрөө рүү сэм ажиглаж суутал гэнэт утасны хонхнууд дуугарч хүлээж суусан нэвтрүүлэг ажиллаж эхэлснийг мэдээлэв. Чингээд төв пультенд жижүүрлэж байсан хүмүүс аппарат хэрэгслэлийнхээ араас өндийх завгүй ажиллаж гарлаа. Тэгээд нэвтрүүлэг хийж байгаа газрыг тодорхойлох гэж зогсоо зайгүй ажиллаж байтал нэвтрүүлэг зогсчихлоо. Нэвтрүүлэг ердөө долоохон мөч ажиллажээ. Хүмүүс гайхаж, бие биен рүүгээ харж, гудамжинд байгаа пеленгацынхантай ярилцаж байтал нэвтрүүлэг дахин ажиллаж эхлэв. Анхны нэвтрүүлэг хийсэн газрыг тоймлон анаж байсан мэргэжилтнүүд гайхав. Нэвтрүүлэг анх хотын баруун өмнөд хэсэгт илэрсэн гэтэл одоо зүүн хойд захад илэрлээ. Гэтэл ердөө таван мөч ажиллаад бас алга болчихлоо. Түүнийг өөр нэвтрүүлэг гэж үзэхийн аргагүй аж. Хотын баруун өмнөөс зүүн хойд зах хүрэхэд шулуун замаараа арваад бээр ажээ. Гэтэл анхны нэвтрүүлгээс хойш ердөө дөрвөн мөч болоод нэвтрүүлсэн энэ нэвтрүүлгийн газарт дөрвөн мөчийн дотор очно гэхэд хэцүү. Хоёр дахь нэвтрүүлэг хийсэн газрыг тодорхойлоод байтал өнөө нэвтрүүлэг дахин эхлэв. Гэтэл тэр нэвтрүүлэг холбооныхны мэддэг дуудлага өгөөд тасарлаа.

Аяанаосу, Ойдовын дуудлага чингэж ахархан хугацаанд байраа өөрчлөн ажиллаж байгаад бас гайхжээ. Үнэндээ Ойдов ингэж байраа сольж ажиллах хугацаа байхгүй. Гэтэл Рожусай

түүний нэвтрүүлгийг ингэж зохион байгуулсан нь маш нарийн хуваарилсан цагийн тооцоотой, гурван газраас зэрэг ажиллаж байгаа гурван станц гэдгийг Аяанаосу багцаалжээ. Ахар богино хугацаанд дараалан болсон энэ нэвтрүүлэг штабт байгаа хүмүүсийг байрнаас нь, хөдөлгөсөнгүй. Штабынхныг даажигнасан энэ нэвтрүүлгийг чагнаж байгаа дарга нарын хөдөлгөөнийг ажиж байсан Аяанаосу, Ойдовтой тохирсон хугацаа нэгэнт дууссан тул,

- За наад нэвтрүүлэг чинь толгой эргүүлж гүйцлээ. Сүүлчийн дуудлаганд хариу өгөөгүй болохоор дахиж ажиллахгүй. Юу ч гэсэн салхинд гарч толгойгоо нэг сэргээгээд ирье гээд өрөөнөөс гарлаа.

Аяанаосу гадаа гарч хэсэгхэн зогсоод хэдэн мөчийн турш дэнсэлж байсан сэтгэлээ тайвшруулаад орж ирэнгүүт штабын дарга нарыг ажвал байрнаасаа хөдөлсөнгүй ажээ. Аяанаосу бие засах газар орж ирвэл үл мэдэг үнэр сэнгэнэх шиг болсонд «Рожусай мөрөө баллаж чаджээ» гэж бодоод цонхнуудыг түгжээд буцаж орж ирэхэд кэмпэйтийн төлөөлөгч, тагнуулын газрын удирдлага цөмөөрөө ирсэн байлаа. Чингээд гурван станц ажилласан газрыг тоймлон тогтоосон мөрөөр ойр хавийн айл, байр байшингуудад үзлэг хийж тэндхийнхнийг мөрдөн шалгах албаныхан ажилдаа орлоо. Ингээд үд өнгөрч байхад шуурхай албаныхан болон холбогдох удирдах ажилтангуудыг Уэда цуглуулж толгой тархигүй загналаа.

- Синьзинд улааны тагнуулын гурван станц зэрэг ажиллаж байхад та нар яагаад өдий хүртэл мэдээгүй байна? Гурав хоногийн дотор станцуудыг илрүүлж учрыг нь олж чадахгүй бол энд байгаа бүх хүмүүсийг хариуцлагад татна гэдгийг хатуу ойлгох хэрэгтэй гээд дарга нарыг хөөгөөд гаргалаа.

Уэдагийн өрөөнд Тозияа, тагнуулын газрын дарга хоёр үлджээ. Тозияа болсон явдлыг эргэцүүлэн бодоод «Станцыг одоо олно гэдэг өнгөрсөн. Гурван станцыг нэг дуудлагаар ажиллуулдаг сонин юм. Яагаад тэр вэ? Энд хамаг учир байна. Улааны тагнуулууд өөрийгөө илчлэхийн тулд ийм аюултай алхам хийхгүй нь мэдээж! Тэгвэл ямар зорилготой вэ? Эсвэл штабын ажиллагааг сонирхсон юм уу? Тэгэхийн тулд хуурамч ажиллагаа бүхий станцуудыг богино хугацаанд ажиллуулж болно. Ингэснээрээ бидний санааг төөрөгдүүлэх гэсэн хэрэг! Зогс! Энд л эгзэг нь байна» гэж өөртөө сануулан сэтгэлдээ өөртэйгөө ярьж байлаа. Тозияа ингэж бодох тусам сэтгэлд нь ямар нэг үл ойлгогдох зөн совин эргэлдээд байгааг мэдэв.

...Улааны тагнуулууд яагаад энэ өдрийг сонгосон бэ? Баярын өдөр станцаа ажиллуулсан бол ашигтай биш үү? Баярын өдрүүдэд өнөөдрийнхөө ажлын бэлтгэлийг хангасан хэрэг үү?

Тозияагийн сэтгэлийг түгшээсэн бодлууд тархинд нь эргэлдэх тул бараг зүрх нь зогсчих шиг болно. Тэр тусмаа Тозияа зөн билгээрээ «Манайд болсон дайллага... Энэ хуурамч нэвтрүүлэг хоёр холбоотой юу?» гэж бодохоор дотор нь харанхуйлагдах шиг болно.

Уэда, уурандаа шатаж үхэх шахсан боловч фронт дээр хамаг анхаарал нь төвлөрч байсан тул өөрийгөө тайвшруулж,

- Тозияа, оросын цэргийн ар талд улаан цэргийн хувцсаар хувцасласан хэсэг хаяхыг Комацубара шаардаад байна. Би дүрвэгсдийн товчоотой ярилцаад тэднийг зохион байгуулах хүнээр туслаач гэж хүссэн юм. Оросынхон Сафроновыг сая Халх голд ажиллаж байсан явдалд

түшиглэн Сунгар-11 өртөөнд бэлдсэн хэсэг хүмүүсийг удирдан ажиллуулахаар явуулсан байна. Та ямар саналтай байна гэлээ. Тозияа хэсэгхэн бодлогоширч байснаа дэнсэлсэн сэтгэлээ тайвшруулаад,

- Би хувьдаа татгалзахгүй. Сарын өмнө Комацубара энэ саналыг надтай ярилцсан. Би Хатогийн саналыг асуугаад дургүйцэхгүй болохоор зөвшөөрсөн юм гэлээ.

- Тозияа сан, та Хатогоос юу гэж асуусан юм бэ? Шууд надад танилцуулаад шийдчихгүй дээ.

- Гакка, Хатогийн хамаатан нэг залуу Сафроновт тааруухан байдаг юм. Тэгээд түүний ажиллагаанд хяналт тавих явдлыг жанжин штабаар зөвшөөрүүлээд чирэгдэл тариад байдаг болохоор Хатод дуулгавал дүүгээ захирч, учрыг нь ойлгуулах болов уу гэж бодсон юм.

- Би үүнийг дуулсан. Хатогийн дүү тоглоомынхоо мөрийнөөс болоод Сафроновтой муудалцсан юм билээ.

- Тиймээ. Сафронов Юкитэй хамт Харбинд ирээд Цэен гүнгийн буянаар баахан туйлахдаа Хатогийн хамаатантай муудалцсан гэдэг. Тэгэхэд тэр нь кэмпэйтигийн төлөөлөгчөөр ажиллаж байсан.

- Тозияа сан, таны царай бүрсийгээд бие чинь тааруу байна аа даа?

- Уржигдар оройноос хойш тааруу байна. Даралт ихсээд байна.

- Та бид хоёр тэгэхэд нэлээн хэтрүүлчихсэн болохоор хэн ч үгүй даралт өөдлөх гээд байна. Та харьж хэвт! Сафроновын ажлыг энүүгээр зохицуулъя. Хайларт очсон хойно Комацубаратай өөрөө уулзана биз. Комацубара уржигдар ярихдаа бас шаардаад байсан.

Тозияа, Уэдагаас нэлээн зүйл лавлая гэж бодож байсан болохоор гэр рүүгээ төдий их яарсангүй.

- Уэда, косэйтокугийн төлөвлөгөөг танд байгааг олон хүн мэдсэн үү?

- Мэдвэл зохих ёстой таван хүмүүс мэдэж байгаа. Юу гээ вэ?

- Зүгээр. Манай штабынхан довголгооны өдрийг жанжин штабаас шийдсэн үү гэж бие биенээсээ асуугаад байгаа юм.

Тозияа, Уэдагаас өөр хэдэн юм асуух гэснээ тагнуулын газрын даргаас санаа зовоод тэр дороо генералын өрөөнөөс гарчээ. Үнэндээ косэйтокугийн төлөвлөгөөг мэдэж байгаа таван хүний нэг бол Тозияа билээ.

...Сафронов Синьзинд ирээд хэд хоносны дараа 8 дугаар сарын 14-нд Ханширээ орохоор галт тэргэнд суужээ. Түүнийг үдэж өгөхөөр даргынхаа заавраар Аяанаосу галт тэрэгний буудал дээр очлоо.

Мөн Тозияа, Ойдов, Юки гурав ч буудал дээр иржээ. Сафронов Харширээ ороод цаашаа

Жанжин сүм дээр очиж Симотогийн заавраар ажиллах ёстой ажээ. Намрын шар нар шингэх дөхөж байхад хөдөлсөн галт тэрэг хорин таван цагийн дараа Ханширээд ирлээ. Сафронов галт тэрэгнээс буугаад нэлээн согтуу байсан боловч цэргийн буудалд очиж байрлажээ. Сафронов шөнө халууцаад байхаар нь цагаан өмд цамцтайгаа гуйвж дайвсаар гадаа гарч баахан суужээ. Буудлын хүүхнүүд түүнийг хараад «Архинд шатаад өрөөнийхөө халуунд байж ядахдаа гадаа гарч байгаа юм байна» гэж бодсон ажээ. Тэгээд согтуу дарга нар тэдний үйл тамыг бардаг болохоор буудлын хаалгаар гарахад нь хойноос нь дуудаж барьсангүй.

Тэгээд Сафроновыг буудалдаа хэдийд орж унтсаныг хэн ч мэдсэнгүй. Харин өглөө Ханширээгийн япон цагдаагийн газрынхан ирж буудлынхнаас,

- Сафронов сан хэдийд буудлаас гарсан бэ? гэж шалгааж гарлаа. Тэгээд түүний талаар зохих ёсны зүйл лавласны дараа өрөөнд орж юмыг нь үзээд буцлаа. Цагдаагийн газрынхныг явсны дараа буудлын эрхлэгч орж ирээд өөрийнхөө хэдийн толгой дээр бууж гарлаа.

- Та нар тэр орос хурандааг анхаарч байхгүй яасан юм бэ? Тэр хурандаа согтуугаараа Хандгайт голын эрэг дээр унаад азаар амьд үлдсэн байна. Тэгээд эрэг дээр ухаангүй шахам байхад нь хилийн харуулынхан олж авчээ. Гай дайраад үхчихсэн бол яана гэж баахан загнажээ. Гэвч хэрэг явдал өөр байлаа.

Рожусай, Сафроновын үйл ажиллагаа, Харбин дахь нууц байгууллага болон алс дорнодын зөвлөлтийн зохих байгууллагатай холбоо ажиллаж байгааг мэдсэний дараа «Рожуганукай» ажиллагаанд оролцуулах зөвшөөрлийг Аяанаосуд өгчээ.

Сафронов Жанжин сүм рүү явах штабын энэ томилолтоор тусгай үүрэг давхар гүйцэтгэхийг Аяанаосу зааварлажээ. Тэрээр Ханширээгээс таван бээр зайтай байгаа монголын хилийн харуулынхантай уулзаад нэг зүйлийг дамжуулсны дараа Жанжин сүм рүү явах байжээ. Тэгээд Сафронов согтуу хүний дүрд жүжиглэж Хандгайт голын цутгал Халх гол руу Цагаан арлаар хил гарч, үүрээр мөн газраараа буцаж ирээд голын эрэг дээр хэвтэж байхад японы цагдаа, хилийн эргүүлийнхэн олсон ажээ! Ингээд хамаг хэрэг явдал үүссэн байлаа.

Гурав. Сүйрэл

Яаримацура баярыг тэмдэглэсний маргаашаас Халх голын хориглолтын дагуу тусгай төхөөрөмжилсөн тэргүүд урьдын адил дуу чимээ дэгдээж түүнийхээ далимаар хориглолтын шугамын дагуу тусгайлан бэлдсэн нэвтрүүлэг хийдэг боллоо. Симото тусгай нэвтрүүлэг хийдэг тэрэгний хөдөлгөөнийг хоёр өдөр тутамд Комацубараад илтгэдэг заншлаараа 8 сарын 15-ны өдөр утсаар илтгэв.

- Гакка, хагас сайн өдрөөс эхэлж өдөрт хоёр удаа тусгай нэвтрүүлэг хийж, мөн танкийн довтолгоо, их бууны болон бөмбөгдөлтийн чимээ дамжуулсан. Би ажиглалтаа нарийвчлахын тул гал нээсэнгүй. Энэ удаагийн ажигласан зүйл гэвэл Ооны манхны дагуу хамгаалалтын тор татсан учраас зоож байгаа гадасны чимээг далдлахын тулд их чимээ дэгдээсэн нь нотлогдов.

- Симото, Сафроновын бэлдсэн хоёр группээс хилийн цаад руу хүн явуулсан уу?

- Зургаан хүнийг улаан цэргийн дарга хувцсаар хувцаслаад гурван чиглэлээр гаргасан. Нэг нь Хуруу өндөрлөгийн зүүн тал Шилийн овооны худгийн чиглэлээр гаргасан.

Тэднийг Иокийн хүмүүс газарчилж яваа. Арван найманд ирэх ёстой.

- Өнгөрсөн сайн өдөр шашны баяр давхцаад цэргүүдээр тангараг өргүүлэх ажилтай зууралдаад бага дарга нарыг олигтой амрааж чадаагүй. Тиймээс 19, 20-ны өдрүүдэд бүх дарга нарыг амраах хэрэгтэй байна. Чи үүнийг юу гэж бодож байна?

- Тэргүүн шугам дээр байгаа дарга, баатарлаг байлдсан байлдагчдыг амрааж сэтгэл санааг нь сэргээх нь дамжиггүй зүйл.

- За тэгвэл бага дарга нарыг Жанжин сүм дээр чөлөөгөөр амруулж, тэндхийн хүүхнүүдтэй наргиулах хэрэгтэй. Харин ахлах дарга нарыг Хайларт цуглуулъя. Би тэдэнтэй уулзаж дараагийн пүрэв гаригт эхлүүлэх ажиллагааны талаар ярилцана. Миний энэ тушаалыг хориглолтын шугам дээр байгаа хорооны дарга нарт дамжуулаарай гээд утсаа тавилаа.

Симото генералынхаа ярианаас Халх гол руу чиглэсэн Косэйтоку ажиллагаа 24-ний пүрэв гаригт эхлэх болсныг гадарлав.

Шашны баяраас хойш хориглолтын шугам дээр ер бусын түгшүүртэй. Нэг үе танкны довтолгоо эхэлж байгаа юм шиг газар тэнгэр доргиулсан чимээ дэгдэж агаарт онгоцнууд хүнгэнэж энд тэндгүй бөмбөгний дэлбэрэлт нүргэлж гарлаа. Чингээд зогссонгүй өдөр шөнөгүй танкийн харжигнасан чимээ дэгдээж, цэргүүдийг сандаргахыг мэрийсэн боловч японы цэргүүд ажирсангүй. Тэр тухайд тасаг, салаа, суман, хорооны дарга нар цэргүүдэд учир явдлыг сайтар таниулж, цэргүүдийн сэтгэл санааны түгшүүрийг тайвшруулж чадлаа.

8 дугаар сарын 16-ны өдөр, Лхагва гариг. Үүрээр танкны харжигнасан дуу Халхын голын цаад талд нүргэлж өнөө их буу, миномёт, онгоцны бөмбөгний чимээ өглөөнөөс орой хүртэл нижигнэв. Харин япон цэргүүд түүнийг тоохоо больсон болохоор тайван байцгаалаа. Харин үдээс хойш Симото, орос монголын командын байрнаас ярьж байгаа яриаг сонсов.

- Улаан цэргийн хувцсаар хувцасласан нэг орос монгол цэргийн анги дээр ирж баригдлаа. Тэр орос хөлөөрөө шархадсан боодолтой байсан бөгөөд шархыг нь эмчилж өгье гэхэд эрс дургүйцсэн төдийгүй оргохыг завдсан учраас түүнийг сэжиглэн баривчилж авлаа. Түүнийг байцаахад хөл нь шархгүй болохыг хүлээсэн төдийгүй өөрийгөө Харбинд байдаг цагаантангуудын байгуулсан оросын фашист холбооны гишүүн гэж байна. Түүний ажлыг Харбинаас ирсэн Сафронов гэдэг хурандаа удирддаг бөгөөд улаан цэргийн дарга хувцсаар хувцасласан гурван хэсэг монголд орж ирсэн гэж байна гэж танилцуулав...

Симото энэ яриаг дууссаны дараа уур омогтоо шатаж «Аа муу бузар урвагчийг харж байна уу?» гэж үглэв. Чингээд Симото хэдэн цагийн дараа Сафроновын зургаан хүмүүс цөмөөрөө баригдсаныг мэдлээ. Энэ бүхнийг урвасан цэргээс шалтгаалсан гэж үзээд Комацубараад илтгэх гэснээ айлаа. Гэтэл Симотогийн сэтгэлд ямар нэг үл мэдэгдэх аймшиг хурна. Тэрээр үе үе Сафроновын тухай бодно. Яагаад ингэж бодоод байгаагийнхаа учрыг үл олно. Нэг мэдэхэд Сафроновтой танилцсанаас хойших зүйлийг бодчихсон байдаг байлаа. Шөнөжингөө Сафроновын тухай бодож байгаад унттал үүрээр түүнийг нойрноос нь сэрээлээ. Фронтын шугам дээрээс түүнтэй ярих хэрэг гарчээ.

- Симото сан өнөө шөнөжингөө танкны чимээ нүргэлж хонолоо. Ёстой армийн цэрэг зэвсгийг шилжүүлж байгаа юм шиг нүсэр их чимээ шуугиан дэгдсэн юм гэхэд Симото дургүйцэж,

- Та нар иймэрхүү юмаар цэргүүдийн сэтгэл санааг үймүүлж болохгүй. Ер нь ийм сэдвээр ярих байтугай, цухуйлгаж ч болохгүй гэдгийг мэдэж байна уу? Үгүй юу? гэж зэмлэж гарлаа.

- Тийм л байдаг байх даа гэж бодож байна. Ер нь цэргүүдийн хувьд гэвэл сэтгэл санаагаар тийм ч сайнгүй байгаа шүү дээ!

- Чи тэгээд цэргүүдэд хар тамхи өгье гэж бодож байгаа хэрэг үү?

- Харин ээ. Ер нь удирдлагад танилцуулбал болох болов уу?

- Энэ хагас сайн, бүтэн сайн өдрүүдэд бага дарга, тэргүүний цэргүүдийг Жанжин сүм явуулж ахлах дарга нарыг Хайлар руу чөлөөгөөр явуулах тул хүмүүсээ бэлдэж бай! гэж хэлэхдээ Симото Сафроновыг сэтгэлдээ бодож байлаа. Тэгээд «Энэ хар лүдийг чинь яагаад бодоод байна вэ?» гэж өөртөө сануулаад фуй өндөрлөгт байгаа Иокигийн отряд руу залгуулж ярилаа.

- Иоки танай чиглэлээр оросын тагнуулуудыг гаргахад Сафронов сан өөрөө очсон уу? Та нар удирдамж ёсоор гаргасан уу? гэж асуулаа.

- Манай хэсгийнхэн тэднийг Халх гол хүргэж өгсөн. Харин Сафронов сан өөрөө тэдэнтэй хамт Халх голын цаад эрэг дээр очоод буцаж ирсэн.

- Иоки, тагнуулынхаа хэсгийн ахлагчийг над руу явуулчих гэж Симотоог хэлэхэд тэрээр зөвшөөрлөө. Чингээд Симото, Жанжин сүм дээр Иокийн дагуулж ирсэн тагнуулын хэсгийн ахлагчтай уулзав.

- Сафронов саныг Халх голоор гарахад та нар хамгаалалтанд байсан хэрэг үү? гэж асуухад,

- Бидэнд өгсөн заавраар бол гурван оросыг Халх голоор гаргах ёстой. Харин газар дээрээ очсоны дараа Сафронов сан өөрийнхөө гурвыг өөрөө голоор гаргаж өгнө гэсэн. Тэгээд биднийг буц гэлээ. Гэсэн ч бид голын бургасанд хүлээсэн юм.

- Буцаж ирэхдээ аль зэрэг удсан бэ?

- Цаг гаруй болоод ирсэн юм. Бид хурандааг хамгаалалтгүй явуулсандаа болоод хүлээгээд байсан юм гэж тагнуулын хэсгийн ахлагч өөрийнхөө ажигласан зүйлийг ярилаа. Тэрээр ярианыхаа сүүлд,

- Тай са дон оо, Сафронов эргэж ирэхдээ сэжиглэмээр өө сэв байгаагүй. Гэхдээ хувцасны нь ханцуй дээр цус болчихсон байсан. Би боож өгье гэхэд миний үгийг тоолгүй «Би шархдаагүй» гээд яваад өгсөн гэлээ. Симото, Сафроновтой уулзахын тулд Талын манханд байгаа 23 дугаар дивизийн штаб руу ярьж Сафроновыг асуухад тэрээр Хайлар руу явсан байв. Тэгээд ямар хэргээр явсныг нь лавлахад хэн ч мэдэхгүй байлаа.

...Хато, Сафроновыг харддаг ч ортой юм биш биз. Ер нь бүх нууц ажиллагааны сүйрэл мань эртэй холбоотой болоод байдаг хачин хэрэг шүү! Сафронов Халх голын цаанаас буцаж ирэх хүмүүсээ дивизийн штаб дээр хүлээх ёстой. Тэгээд буцаж ирэхгүй гэдгийг мэдэж байгаа болохоор өөрөө зам буруулан ор сураггүй болохыг боджээ. Хайларт очсон болов уу?...

Симото чингэж бодсоор Хайлар руу гарлаа. Тэрээр цэргийн зочид буудалд орж ирэнгүүтээ ээлжийн ахлагчтай уулзаж,

- Намайг ирнэ гэдгийг танайд мэдэгдсэн үү? гэлээ.

- Тиймээ, ноён хурандаа... өрөө чинь бэлэн байгаа.

- Тэгвэл миний өрөөг цэвэрлэдэг эмэгтэйгээ солиорой гэхэд байлдааны тэргүүн шугам дээрээс ирсэн дарга нарын наана цаанахыг зохицуулж сурсан ахлагч Симотоог шинэ юм хийх гэж байна гэдгийг мэдээд,

- Хятад хүүхнээр үү? Нутгийн барга охидоор уу? гэж лавлав.

- Танай энд шилжиж ирсэн япон иргэд байгаа биз дээ гэхэд ахлагч эмэгтэй толгой дохиод өрөөнөөс гарах гэтэл,

- Танай буудалд Сафронов гэдэг орос дарга буусан уу? гэж асуусан Симото, ахлагч хүүхний бие галбирыг ажиглан зогсоно.

- Тайса доноо 57 дугаар өрөөнд одоо байж байгаа гэхэд Симотогийн сэтгэлд "Мань эр оргож амжаагүй юм болов уу?" гэдэг бодол харвалаа. Симото ахлагчтай хамт өрөөнөөс гарч ирээд Сафроновын өрөө рүү очлоо. Иван Степанович, хэзээний наргианч зангаар Симотоог угтан,

- Та чинь хэдийдээ хүрээд ирдэг байна аа? гээд амар мэндийг лавлав.

- Сафронов сан, танай хүмүүс өнөөдөр Халх голын цаанаас ирэх ёстой байхад та энд ингэж айвуу тайвуу байдаг чинь таарч байгаа юм уу? гэж хүйтэн байдлаар асуулаа.

- Маргааш үүрээр ирнэ. Би одоо эндээс явах санаатай байна гэж Сафроновыг хэнэггүй хэлтэл Симото,

- Сафронов сан ер нь та Халх гол руу очих хэрэггүй биз гэлээ.

- Яагаад хэрэггүй гэж!

- Яагаад гэдгийг та надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа! Сафронов, Симотоог өөр дээрээ зүгээр ирээгүй гэдгийг ойлгоод

«Халх голын цаана гарсан хэсгийг баригдсаныг энэ яаж мэдээ бол!» гэж бодоод

- Симото та намайг ингэж гоочлоод яах нь вэ? Ажлаа алдаж цагаа гарздахын нэмэр. Тэгээд наад тоглоомоо одоо зогсоосон дээр шүү гэж ууртай хэллээ.

- Таны бүх үйл ажиллагаа одоо надад ил болсон. Одоо яаж ч жүжиглээд ашиггүй. Харин үүнийг унш. Би танд зориулж орос хэл рүү орчуулуулсан юм гээд утасны ярианаас тэмдэглэж авсан зүйлийг өглөө. Иван Степанович түүнийг тайван уншаад,

- Симото, та тэгээд намайг баривчлахаар болоо юу? гэж сөргөлөө.

- Энэ бол хэн ч булзаж болохгүй зүйл. Тэр ч байтугай тантай урьд өмнө холбогдсон зүйлийг сэргээхэд хүрнэ. Тиймээс одоо бугаа надад хураалга гэж шаардлаа.

- Симото, та дэндүү зүрхтэй байна. Тэгээд наад санаачилга чинь өөрийг чинь толгойг ороох байлгүй. Хэрвээ та намайг баривчиллаа гэж үзэхэд таныг хэн ч хамгаалж чадахгүй баримт надаас гарна. Би түүнийг амархан батална шүү. Наад захын баримтыг гэхэд Цэен гүнг жанжин штабын заалтгүйгээр хорлосон. Тэгээд Юкийг хуурч, Тозиягийн нэрийг барьж армийн нууц хадгаламжаас хар тамхины хандтай тариа үнэ өртөггүй аваад түүнийг Кавасугаар Юкийд дамлуулж үнийг нь өөрөө ашигласан.

Кавасу Хайларын эмнэлэгт ажиллаж байгаа. Түүний баталгаа надад бий. Хамгийн гол нь Кавасу бол Хятадад урваж худалдагдсан тагнуул гэдгийг бодоорой. Та түүнийг армийн эмнэлгийн албанд шургуулснаас байлдаанд шархадсан олон цэрэг дарга нар энд түүний гарт амиа алдаж байна. Үүнтэй та шууд холбоотой! Харин монголын штабынхны ярианд миний талаар дурдсан явдал бол баригдсан хүмүүс намайг илчлэх зорилгоор мэдүүлсэн нь илт байна. Би улаантантай холбоогүй гэдгийг батлах наад захын баримт бол энэ шүү дээ! Хасу Тоиши, Мешанов хоёрын хувьд гэвэл кэмпэтайн тусгай комисс өөрснөө шалгаад хөдөлбөргүй баримтаар нотолсон. Тэр баримтыг та үгүйсгэх гэж бодож байгаа бол кэмпэтайнхан өөрсдийнхөө баталгааг хүчингүй болгохыг хичээхгүй нь илт! Харин та кэмпэтайн тусгай хүмүүсийг тагнан хагалж бутаргах гэсэн хэрэгт унах байх шүү. Тэгээд ч зогсохгүй таны амины гарз болно. Тэд ямар ч аллага хядлагыг зохион байгуулахдаа танаас илүү мэргэжсэн хүмүүс гэдгийг мартаж болохгүй шүү! гэхэд Симотогийн ар нуруугаар хүйт

оргиж, сэтгэлд нь ямар нэг аймшиг давхцна.

Симото, Сафроновт юу гэж хэлэхээ мэдэхгүй мухардаж дуугүй байтал ажваас арслангийн өөдөөс архираад зүрхээ хагартал айсан хав шиг өрөвдөлтэй агаад басхүү эгзэгтэй үед өөр рүү нь харвахаар биеэ эрчилсэн наж могой шиг хүйтэн зэвүүн царайтай аж.

- Симото, ийм иш мухаргүй юмаар намайг оролддог саваагүй зангаа татах нь дээр гэдэг нь одоо ойлгогдож байгаа биз дээ. Харин одоо та хожим хойтоо бодоод надтай тохиролцвол би танд эр хүн шиг хандана. Тиймээс ч өдий хүртэл таны талаар дээд удирдлагад ганц муу үг хэлж яваагүй юм шүү. За тэгээд шууд хэлэхэд манайхан Халх голоос үр дүн үзэхээсээ өнгөрсөн.

- Сафронов та юуны тухай яриад байна? гэж Симото урамгүйхэн асуув.

- Өнөө шөнө манай нэг туршуул хил нэвтэрч ирнэ. Тэр маргааш өглөө гэхэд Хайларт байх ёстой. Манай улсууд баригдахдаа зүгээр нэг баригдаагүй юм. Бас үүргээ гүйцэтгэж яваа. Энэ ярианд миний нэрийг санамсаргүй дурдсан юм биш! Энэ бол надад өгөх тусгай болзол дохио байгаа юм. Би танай энд тусгай холбоо байгуулагдаад улаан армийн удирдлагын яриа нэвтрүүлгийг хүлээн авдаг гэдгийг Аяанаосуугаас дуулсан. Тэгээд өөрсдийнхнийгөө баригдахад хүрвэл танай холбоогоор дамжуулж хэрхэж байгааг нь мэдэж болох юм байна гэж бодоод Халх голын цаад талд монгол оросын армийн цохилтын хүч ирсэн байвал тагнуулын ажлыг намайг удирдаж байгаа гэдэг мэдүүлэг өгөөрэй гэсэн юм. Ингэхээр Халх голд монгол оросын цохилтын хүч ирчихсэн байна. Гэхдээ маргааш ирэх хүн үүнийг бүр тодруулж өгнө гэхэд Симото Сафроновоос,

- За би явах уу даа. Тэгээд өглөө уулзъя гэж гуйлаа.

- Симото, та саяын ярьсан зүйлийг нууцлах биз! Тэгээд маргааш болтол монгол, оросын армийн тухай Комацубараад дуулгасанд орвол амаа жимийгээд байж байсан чинь ононо байх гэхэд Симото толгой дохиод гарлаа.

Симото, Сафроновын өрөөнөөс өрөөндөө орж ирэхэд залуухан япон хүүхэн шинэ танилаа тал засан угтлаа. Японы дээд тушаалын дарга нарыг харь нутгийн хүүхнүүдтэй сүүж холбохыг хориглодог нь нууц алддаг явдалтай холбоотой юм. Тиймээс японоос амьдрал ахуй, сэтгэл санаа, мэдлэг боловсролоор хоцрогдсон эмэгтэйчүүдийг хятад, манжууртбайгуулсаняпонызасагзахиргаанытомоохон байгууллагын тусгай үйлчилгээнд ажиллуулдаг байлаа. Симото, Сафроновын үгийг эргэцүүлэн бодохыг хичээх тул залуу хүүхэнтэй нялганах сөгөө байсангүй. Яаж ч бодсон Симото, Сафроновын гараас мултрахгүй болжээ.

...Сафроновын үгийг Юки үнэмшинэ. Юкигийн үгэнд Тозияа орох нь зайлшгүй! Тэгээд эцсийн эцэст Тозияа намайг нүд ирмэхийн төдийд устгуулна. Ингэхээр Сафроновтой харьцаагаа сайжруулах хэрэгтэй! Яасхийгээд хөлд нь сууж өөрийгөө аврах хэрэгтэй... Энэ зам мөрөө яаж гаргах вэ?...

Симото ингэж өөрөөсөө хэдэн удаа асуусан боловч яах учраа олсонгүй. Тэгээд орой болтол

гиюүрэн бодлогоширч, аргаа барж суухад өнөө хүүхэн Симотогийн сэтгэлийг тайтгаруулж хэдэн иень олж авахыг хичээхдээ түүнийг архиар дайлж, сэтгэл санааг нь засах агаад Симотогийн бие сэтгэлийн эчнээн бодлыг хөндөж таалагдахын тулд «Энэ ноёнтны хүсэл сэтгэлийн увдист шохоорхлыг хөдөлгөж чадвал ахиухан юм олно» гэж бодсоор эмэгтэй хүний найланхай уян, тачаангуй зан аашаар эрхлэн янаг сэтгэлийн ид шидийг уудлан гаргана. Симото сэтгэлээ шаналгасан бодлоос салахын тулд архи амсан амссаар, бүсгүй хүний янаг тачаангуйн цалманд ороогдож, сэтгэл зүрхээ шимшрүүлсэн бодлоо умартан, эмэгтэй хүний дулаан өвөр, бүлээн амьсгалд шатан, амьдын жаргал амсан тачаалын увдист мансуурчээ.

Үүрээр үүд балбах чимээгээр Симото цочин сэрээд «Хэн бэ?» гэж омогтойхон асууснаа хамаг юмаа дэлгээд ухаангүй хэвтэж байгаа бүсгүйн дээрээс хөнжлөө чулуудаад «Тачаалдаа ханасан амьтан ийм л байдаг байжээ. Мэгж шиг хамрынхаа самалдгийг сэтэртэл хухирч байгааг нь хараач» гэж унтууцан үглээд хаалга руу эргэв. Симото Сафроновын дуугаар хаалгаа тайлж өгтөл,

- Чиний унтлагын өрөөнд гадны хүн байгаа юм уу? гэснээ өөрөө түрүүлэн алхсаар буудлын үүдний өрөөний уужим танхимын нэг хананд байгаа диван дээр очиж суухад Симото нэмакинийхаа (амралтын хувцас) бүсийг уясаар Сафроновын дэргэд ирж суулаа.

- Миний туршуул ирсэн гэхэд Симото нүдээ жоотойлгон «Энэ золиг юу гэх бол? Бас нэг ухаан сийлж байгаа хэрэг үү?» гэж бодно.

- Симото улаан оросуудын довтолгоо эхлээд манайхныг бүслээд авчихсан байгаа бололтой гэхэд Симото гайхаж айсандаа балмагдсан дуугаар,

- Юу? Чи солиоров уу? гэж асуулаа.

- Энэ бол маргашгүй зүйл!

- Худлаа! Чи хутган үймүүлэх гэж байна. Улаан оросууд одоо байтугай намар ч довтолгоонд орохгүй!

- Симото, чиний наад хийсвэрлэсэн дүгнэлт чинь армийн удирдлагын тактик стратегийн бодлогыг төөрөгдүүлж, манай довтолгооныг хойшлуулснаараа эзэн хааны армийг орос монголын цэрэгт сүйрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна!

- Одоохон энэ тухай Комацубара санд мэдэгдэх хэрэгтэй. Чи хүлээж бай! Би хувцсаа өмсөөдөхье. Хоёулаа очиж танилцуулья гээд өрөө рүүгээ эргэх гэтэл Иван Степанович түүний гараас татаж зогсоогоод,

- Энэ тухай дуулгавал мэдсээр байж нуусан гэдэг ял чи бид хоёрын толгой дээр унана! Миний туршуулын мэдээ үнэн бол одоо ингэсхийгээд Комацубара өөрөө биднийг дуудна. Тэр үед юу гэж хэлэхээ бодсон дээр гэж хэлэхэд Симото санаа алдаад,

- Чиний боддог зөв байх гээд дуу муутай гонгинов. Сафроновын мэдээ үнэн байжээ. Халх гол дахь японы

хориглолтын шугам руу хүчтэй гал нээсэн тэр мөчөөс хойш 15 мөчийн дараа Комацубара, Хайларт ирээд байгаа бүх дарга нарыг өрөөндөө цуглууллаа. Тэрээр хөмсгөө зангидан, өлөн барын нүд шиг аймаар харцтай нүдээрээ дарга нарыг толгой дараалан ажиглаад,

- Дөнгөж сая фронтын шугам дээрээс утасдлаа. Орос, монголын армийн цохилтын хүч Баян Цагаанаас манайх руу... бүх хориглолтын шугамын дагуу их бууны галаар ширүүн довтолгоо хийж байна. Одоогийн байдлаар байдал эвгүй болж магадгүй байна гээд онигор нүдээ том болгоод оч шиг гялалзсан харцаар Симотоог ширтэнэ. Комацубара хэсэг дуугүй байснаа,

- Тай са Симото гэхэд тэрээр арга буюу суудлаасаа өндийв.

- Та орос монголын цэргүүд довтолгоонд бэлтгээгүй, намар өвлийн бэлтгэлд орж байна гэж тодорхойлоод байсан. Одоо тэгээд энэ бүхнийг юугаар тайлбарлах вэ? гэж омогдлоо.

- Гакка, орос монголын удирдлагын цэргийн жинхэнэ баримтанд бид түшиглэсэн шүү дээ гэтэл Комацубара уурандаа шатаж,

- Тэр чинь биднийг төөрөгдүүлсэн хуурамч баримт байсан байна. Таны үүрэг бол тэр баримтыг шалгасны дараа бидэнд өгөх ёстой. Орос монголын удирдлагын боловсруулсан хуурамч баримтыг та хянаж үзээгүй байна. Одоо явж фронтын байдлыг судлаад надад илтгэ! Энд байгаа дарга нар анги салбар дээрээ яаралтай оч! гээд цугласан дарга нарыг тараалаа.

Сафронов буудалд ирээд Симототой хэрхэх тухайгаа ярилаа.

- Симото одоо чи Халх гол руу явсны хэрэггүй. Тэнд очвол асуудал бүр хүндэрнэ. Тиймээс одоо өөрийгөө бодож самбаачлах хэрэгтэй!

- Ер нь хамаг юм сүйрч байгаа юм байна. Монгол оросын армийнхан хэдэн өдөр дуу чимээ нэвтрүүлдэг байсан нь армийн хүчийг шилжүүлэх үед сэжиглэгдэж болох чимээ шуугианыг далдалсан хэрэг байж! Тиймээс Халх голд ирсэн хүчээ уржигдраас эхлэн манай хориглолтын дагуу шилжүүлэн байрлуулж амжсан бололтой. Үүнийг нь бид өнөө нэвтрүүлэг хийж байна гэж үзсэн юм. Одоо би өнгөрсөн.

- Симото одоо ганц зам байна. Халх голд армийнхан ялагдвал Комацубара хэн рүү ял тулгах гэж байгаагаа сая илэрхийлсэн. Тиймээс чи Хайларт үлдэж байдлыг ажиглаад арми ялагдвал өөрийгөө аврах аргаа бод! Энэ явдалд Кавасуг ашиглах хэрэгтэй. Кавасугийн эмнэлэгт хэвт! Тэгээд сэтгэл санааны гэнэтийн цочролоос цус харвахад хүрээд байгаа гэдэг онош тогтоолгочих. Одоо Комацубара Хайлараас Жанжин сүм рүү явна шүү дээ. Тэгэхээр чамтай зууралдах зав гарахгүй.

- Тэр чинь зөв арга байна шүү гэж Симото хэлээд санаа алдсанаа утсаа авч Кавасу руу залгуулахаар шийдлээ.

...Хагас сайн өдрийн орой Жанжин сүм дээр байсан фронтын штабын дарга, нууц холбооны төв рүү ярьж оросын нэвтрүүлгийг сонирхжээ.

- Гакка, оросын радио нэвтрүүлгийн тэрэгнүүд манай хориглолтын хоёр жигүүрээр ажиллаж өглөөнөөс хойш их буу, онгоц, танкны чимээ нэвтрүүлсэн. Тэгэхдээ Хужир Цагаан нуураас Их элсний чиглэлд танкны дуу чимээ хүчтэй нэвтрүүлж яг довтлох гэж байгаа юм шиг нүргэлсэн. Бодвол орос монголынхон өнөө хориглолтын өргөст тор татахын тулд тэгж далдлан нууцлах аргаа хэрэглэж байгаа бололтой. Эд чинь ингэж байдаг болоод удаж байна гэж тоомсоргүй илтгэлээ.

Фронтын нэгдсэн штабын дарга, Жанжин сүм дээр авчирсан бага дарга, цэргүүдийн сэтгэл санааг сэргээж цэнгээх асуудлыг зохион байгуулаад шөнө дүл өнгөртөл унтсангүй. Тэгээд хажуулахын өмнө холбооны төв рүү дахин утасдаж байдлыг лавлав.

- Гакка оросууд одоо өөр дуу чимээ нэвтрүүлж байна. Манай хоёр жигүүрээр танк, хуягт машины дуу чимээ хүнгэнээд байна. Ингэсхийгээд онгоц, их бууны чимээ нэвтрүүлэх байх. Өнгөрдөг шөнө яг ингэж нэвтрүүлсэн. Одоо яг тэр цагтаа хуваарь ёсоор нэвтрүүлж байна гэлээ.

Шөнөжин шуугисан нэвтрүүлгийн чимээ үүр цайхаас өмнө нам гүм болжээ. Үүнийг ажигласан японы хориглолтынхон «Оросуудын залхуу нь хүрчээ. Одоо өөрснөө нэвтрүүлгийнхээ дуу чимээнээс халшраа биз» гэж бодож, ярилцах ажээ.

Тэнгэрийн алсын хаяанаа мэлтийсэн цагаан гэгээ улам тодорч алсын бараа танигдах төдий байлаа. Өглөөний, таван цаг 40 мөч гэхэд Халх голын хөндийд ямар ч анир чимээгүй боллоо. Шөнөжингөө архидсан япон цэргүүд үүр тэмдэгрэх үед нойрондоо дарагджээ. Гэтэл гэнэт их бууны гал нүргэлж газар тэнгэр нийлчихэв үү гэмээр сүртэй дэлбэрэлтүүд японы хориглолтын шугамын дагуу нэрмэж гарлаа.

Хайлаастын зүүнтээх манханд хориглож байсан японы 72 дугаар явган цэргийн хорооны ...дугаар сумангийн дарга, салаан дарга нар газар оромжноос ухасхийн гарцгааж салаа суман руугаа гүйлээ. Дэслэгч Хито газар оромжны ойролцоо дэлбэрсэн дэлбэрэлтээр орноосоо унаад тэр дороо босонгуут сая учрыг ойлгоод салаа руугаа гүйлээ. Гэтэл Хитогоос нэлээн зайдуухан их бууны сум дараалан дэлбэрч, тархи нь задарчих шиг санагдаад чих нь шуугиад явчихлаа. Хөрсөөрөө эргэсэн элс шороо агаарт цацагдан, зүүнээсээ өндийж буй нарыг халхалсан болохоор зузаан тоос шороог арай ядан нэвтэлсэн нарны гэгээ мэдэгдэх төдий сүүмэлзэж өнөө аюулт Раху гэгч нарыг залгичихав уу гэмээр аймаар ажээ. Их бууны гал цаг шахам үргэлжилсэн болохоор японы цэргүүд яахаа үл мэдэн нуувч руугаа шургах агаад самбаатай нэг нь их буу танк руугаа хурдлах авч оросын их бууны гал японы зенитийн их буу, пулемётын байрлал дээр оновчтой бууж агаарт зэр зэвсэгтэйтээ цацагдана. Хориглолтын дагуу нөмөрсөн шороон битүү хөшгөн дунд нуувчиндаа сүйрч байгаа япон цэргүүд ёлон гинших, орилон чарлах, амь нь тасарч байгаа хүний сэтгэл сэрхийлгэсэн хахир хашгиралт их бууны сумны дэлбэрэлтээс илүү хүчтэй сонсогдон цуурайтна.

Хито яах ухаанаа ололгүй нэгдүгээр суман руу гүйж явтал тэдний зэргэлдээх нуувчинд их бууны сум тусаж, бөөн шороотой холилдсон цэргүүдийн сэг өөдөө чулуудагдаад нүд ирмэхийн төдийд нөгөө сумангийн цэргүүдийн дээрээс унаж газартай нь тэгшлэн буллаа. Амьдаараа нуувчиндаа булагдан дарагдаж байгаа цэргүүдээ харсан Хито байдаг чадлаараа хашгираад газар сөхрөн унахдаа «Ингээд өнгөрдөг хэрэг үү? Ямар аймаар юм бэ? Бид

амьдаараа булагдаж, их бууны суманд яйчууллаа шүү дээ» гэж орилохдоо уйлж байгаагаа ухаарах сөгөө байсангүй. Айсандаа түүний ухаан зайлжээ...

Улаан армийн их бууны гал японы зенитийн их буу, пулемётын байрлалын дагуух бүх зүйлийг газрын хөрстэй хөмрөөд зогссонгүй хар угаа баагиулсан газрууд дээрээс харахад ов тов цоохортох ажээ. Энэ бол онгоцныхонд бөмбөгдөх ёстой байрлалыг тодорхойлж өгсөн баримжаа байлаа. Өглөөний 6 цаг 45 мөч гэхэд их бууны гал зогстол тэнгэрийг бүрхсэн тоос шороо арилж гүйцээгүй байсан тэр үед онгоцны бөмбөгдөлт эхэллээ. Хэдхэн мөчийн дараа Халх голын өглөөний агаарт бөөн хуйларсан гал дүрэлзэн галт луу тэнгэрт заларч байгаа юм шиг сүртэй дөл улаанаараа олгойдохыг харсан Хито, Фуй такасагийн баруун этгээдэд газар доор нөөцөлсөн шатахууны агуулах дээр бөмбөг туссаныг гадарлалаа. Японы 26 дугаар хорооны зүүн жигүүрт байсан Мицудогийнхан тэнгэр өөд олгойдсон галыг хараад айн мэгдэхийн эрхэнд «Ай хатимана минь» гэж залбирсаар нуувч руугаа шурган хэвтэнэ. Онгоцны бөмбөгдөлтийн дараа дахиад их бууны гал үргэлжлэв. Өглөөний 5 цаг 45 мөчөөс хойш 8 цаг 45 мөч хүртэл үргэлжилсэн гурван цагийн бөмбөгдөлт, их бууны галын дараа японы хоёр талын жигүүрээр танк хуягт явган цэрэг үерийн урсгал шиг хүч түрэн орж ирлээ. Зөвлөлт монголын хуягт, танкууд Фуй такаса (Хуруу өндөрлөг)-гийн баруун зүүгээр ороон японы хориглолт руу дайрч буй тэрхэн үед Хайлаастын баруун талд Их элсний чиглэлээр хөдөлсөн танк хуягтууд Бойтог манхны араар ороогоод Хайлааст чиглэлээ.

Улаан арми, монголын цэрэгт бүслэгдсэн цэргээ аврахын тулд Хайлараас яаравчлан хөдөлсөн хороодын дарга нар өөрснийхөө хороог аврах ямар ч боломжгүй болжээ. Өглөө эхэлсэн байлдаан оройн 17 цаг гэхэд бүр ширүүсжээ. Халх гол руу өнгөлзсөн японы армийн ажиллагаа эхэлснээс хойш 17 дахь пүрэв гариг буюу 8 сарын 10-нд байгуулсан зургадугаар армийн командлагч Огису Риппо хоёр долоо хоногийн дараа эхлүүлэх «косэйтоку» ажиллагаанд оролцуулах зэвсэг хүчээ фронтын тэргүүн шугаманд шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулж байсан энэ үед түүний зүрхээр хатгадаг өвчнийг хүндрүүлэхэд хүрсэн энэ дуулианаар өөрийнхөө мэдэлд байгаа дарга нарыг цуглуулж улаан арми, монголын цэрэгт өгөх сөрөг цохилтын талаар ярилцаад цохилтын гол хүчийг байлдааны тэргүүн шугамд авчрахаас өмнө онгоцны ширүүн довтолгооноор дайсны хүчийг сулруулах төлөвлөгөө гаргалаа. Чингээд Долт нуурт байгаа дөч гаруй онгоцоо агаарт хөөргөх тушаал өглөө. Японы онгоцнууд Номон хан, Бүрд-Овооны чиглэлээр монголын хилийг давгал оросын онгоцнууд өөдөөс нь гарч ирлээ. Японы нисэх отрядыг удирдан ниссэн хурандаа,

- Ситори миний командыг сонсож бай! Оросын онгоц чиний өөдөөс чиглэж байна. Тэд 2000 метр өндөрт нисэж байна. Чи өөрийнхөө хэсгийг авч эгц дээрээс нь довтлох хэрэгтэй. Тиймээс өндрөө 3000 метр хүртэл нэм!

- Хурандаа таны тушаалыг мэдлээ гээд Ситори өндөр авлаа. Энэ хүн бол Баян Цагааны нуруунд их бууны батарей удирдаж байгаад галзуурсан Такеругийн ах байлаа.

Ситори оросын онгоцнуудыг ажиглаж байснаа,

- Хурандаа, оросын онгоцнуудын дунд хоёр далавчтай онгоц байх шиг байна. Та олж харав уу?

- Чиү и Ситори, би харж байна. Лав шинэ маягийн бөмбөгдөгч онгоц шиг байна,

- Ситори, өндрөө авгал оросын онгоцнууд хамгийн тэргүүн эгнээд яваа түүний хэсэгтэй тулалдах янзтай бараг 3000 метрийн цаанаас маневрлаж эхэллээ. Эгшин өнгөрөх тусам Ситоригийн хэсэг рүү ойртож яваа онгоцны хамгийн түрүүний онгоцноос хар утаа баагиулсан нэгэн урт юм гарч ирээд Ситоригийн хэсэг рүү чиглэснийг гадарлангуут онгоцныхоо байрлалыг өөрчлөх тэрхэн эгшинд Ситоригийн түрүүнд баруун гар талд явсан хоёр онгоц нүд ирмэхийн зуур агаарт дэлбэрлээ. Агаарт онгоцны пулемётын сум сүлжилдэн, энд тэндгүй утаа савсуулсан онгоц шунгиналдахын зэрэгцээ өтгөн хар утаа баагиулсан өнөө урт нарийхан юмнууд японы онгоцнуудыг яах ийхийн зуургүй жагсаалаас гаргаж байлаа. Хомхой цурхай шиг хэлбэртэй, гялалзсан урт юмыг ажиглан зайлсхийж, болгоомжлон ниссэн Ситори байлдааны талбайд орохоос халшран гайхаж байсан тэр үед хурандаагийн дуу чихнээ сонсогдож,

- Сонсож бай! Сонсож бай! Аюул тулгарлаа... сонсож бай! Буудал руу буц... буудал руу буц гэх нь ямар нэг аюулт сүйрлээс болгоомжилсныг гэрчилнэ.

Японы онгоцнууд хурандаагийн тушаалаар Ирангын хээрийн буудал руу эргэж байлдааны талбайгаас тэр дороо гарцгаалаа. Тэгээд зам буруулан нисэж оросын онгоцноос зайлаад буудал дээрээ ирж бууцгаалаа. Дөч гаруй онгоцноос тал гаруй нь алга! Нисэгч нар гайхаж алмайрсан нүдээр бие бие рүүгээ харах нь «Хар утаа савсуулсан тэр юм юу вэ?» гэж бие биенээсээ лавлах мэт. Ситори хээрийн буудал дээр буунгуутаа өвсөн дээр суусан нисэгчдийн дэргэд ирж суулаа. Тэгээд хэсэг дуугүй байснаа,

- Та нар чинь яагаад ус балгачихсан юм шиг дүмбийчихээ вэ? Тэр утаа баагиулсан хар юмыг юу байсныг хэлээдэхээч! Би анхандаа оросын онгоц шатаж байгаа юм болов уу? гэж харсан юм. Гэтэл... гэж хэлтэл,

- Ситори чи айсандаа болоод бүүр эргүүтэж орхижээ.

Тэр чинь онгоц биш!Өөрөө харвадаг сум гэж мэдэмхийрлээ. Гэтэл нисэгчид түүний яриаг сонирхон бараг нэг зэрэг «Юу?» гэж гайхан дуу алдав.

- Миний нагац 1935 он хүртэл Москва дахь элчинд ажиллаж байгаад ирсэн юм. Түүнийг буцаж ирэхэд манай армийн хэдэн том хүмүүс уулзаж оросын зэвсгийн талаар ярилцаж байхад харвадаг сумтай онгоц хийсэн гэж ярьж байсан юм. Улаан оросууд 1930 оноос тусгай төхөөрөмжинд харвадаг сум байрлуулаад хойтон жил нь онгоцонд байрлуулж туршсан юм гэж хэлэхэд нэг нисэгч ярианд оролцож,

- Тийм байхаа тэр! Цахлай гэдэг онгоцоор хамгаалуулсан тэр хоёр далавчтай онгоцны доод талын далавчны доор нарийвтар урт цагаан юм зүүлттэй байсан. Би анхандаа бөмбөгийг ингэж зүүдэг онгоц байдаг юм байхдаа гэж гай-хаж байлаа. Хоёр талын далавчинд дөрөв дөрвөөр нь төхөөрөмжилсөн байсан. Тэгэхээр харвадаг сум гэдэг нь үнэн байж таарлаа гэж хэлтэл хурандаагийн онгоц бууж ирлээ. Нисэгч нар даргынхаа онгоцны зүг гүйлдэн очтол дарга нь онгоцноосоо бууж ирэв. Тэгээд өнөө хомхой цурхай шиг хэлбэртэй, гялалзсан өнгөтэй утаа савсуулсан юмны талаар ярилцав. Хурандаа цагаа харснаа,

- Тэгвэл оросууд анхныхаа харвадаг сумыг 17 цаг 27 мөчид тавьж дээ гэж хэлтэл онгоцны

буудал руу нэгэн суудлын тэрэг хар хурдаараа орж ирэхийг ажвал фронт командлагчийн тэрэг болох нь илэрхий. Чингээд хурандаа цагийн дараа 6 дугаар армийн төв штаб байрласан газар ирлээ.

- Улаан оросууд өнөөдөр анх удаа агаарын байлдаанд тусгайлан төхөөрөмжилсөн харвадаг сумыг хэрэглэлээ. Энэ сумны тавьж байгаа ойрын зай 1200 метр, алсын зай 2500 метрт багтаж байна. Тиймээс манай онгоцнууд агаарын байл-даанд амжилт олох нөхцөлгүй байлаа. Онгоцноос оночтой буудах зай минь 300 метр шүү дээ гэж илтгэхэд Огису Риппо хөмсгөө зангидан дуугүй зогстол Комацубара,

- Та бас Тогава, Коворо хоёр шиг хэтрүүлж байна уу? гэж шалгаав.

- Гакка та, өөрөө Москвагийн элчинд цэргийн атташегаар ажиллаж байсан болохоор надаас илүү мэднэ шүү дээ гэж арай ядан хэлэхэд дууны нь өнгө уйлах гэж байгаа хүүхэд шиг хоолой нь зангирсан байлаа. Чингээд хоёр цагийн дараа Комацубара Синьзин руу залгуулж Уэдаад байлдааны байдлыг илтгэж онгоцны талаар танилцуулав.

- Гакка, Улаан оросууд пуужинт зэвсэг туршиж байгааг би Москвад байхдаа мэдсэн юм. Оросууд 1931 онд пуужинт сум нисэх онгоцонд байрлуулаад туршсан юм. Уржнан жил (1937) шинэ маягийн онгоцонд пуужинт сум байрлуулсан гэдэг яриа гарсан юм. Тиймээс тай сагийн ярьдаг зүйлүүд үнэний хувьтай юм. Оросууд онгоцонд пуужинт сум байрлуулсан бол манай онгоцнууд түүнийг устгах бололцоогүй. Пуужинт сумаа тавьж байгаа ойрын зай нь 1200 метр байгаа болохоор аюултай байгаа юм гэхэд Уэда,

- Косэйтокуг амжилтанд хүргэх ёстой гэдгийг та толгойгоороо хариуцаж байгаагаа ойлгож байгаа биз! Оросуудын онгоцыг устгахын тул камиказе токкотойн хэсэг зохион байгуул! Тэр пуужинт онгоцыг камиказе нар устгаж чадна гэж толгой түрүүгүй загнахад Комацубара юу ч хэлэлгүй дуугүй чагнахдаа «Камиказе нарыг мөргөхөөс өмнө пуужинт сум өрсөнө гэдгийг ойлгохгүй хүнтэй юу ч ярих билээ» гэж бодно.

Дөрөв. Хар цагааны ялгаа

Хайлар дахь цэргийн эмнэлгийн хашаагаар намхан нуруутай, бүдүүн тарган биетэй нэгэн хүнийг орж ирэхэд эмнэлгийн сувилагч, эмч нар хүндэтгэн мэндэлнэ. Тэрээр бодлогоширсон тэргүүнээ бөхийлгөсөөр алхаж, эмнэлгийн байшинд орж ирээд өрөө рүүгээ алхана. Энэ хүн бол бидний танил Кавасу болой. Тэрээр цагаан халаадаа өмсөөд тарган биеэ дааж ядсан майга хөлөө зөөж ядан гэлдэрсээр армийн ахлах дарга нарыг хэвтүүлдэг тасалгаанд орлоо.

Симото хана руу харж хэвтсэнээ хөлийн чимээгээр эргэхдээ «Кавасу эмч ямар сонинтой ирсэн бол» гэж бодно. Тэрээр хоёр хоногийн өмнө Жанжин сүм рүү явж билээ. Кавасу Симототой мэндлээд нүүрээ үрчийлгэн,

- Симото чи Халх голд юу болж байгаа гэж санана. Ёстой махан овоо гэгчийг тэнд л үзлээ. Дайн гэдэг чинь хүний хүүрэнд цаддаггүй асар их ходоодтой мангас юмаа даа гэж яншаад санаа алдав.

- Манай арми бүрэн бүслэгдсэн байна. Фуй такасайд байсан Иокигийн хэсэг уржигдар 20-нд бүрэн устжээ. Хайлараас очсон 14 дүгээр явган бригад өчигдөр монголын хилээс 4 бээр зайтай газар Шар модны хавьд бөмбөгдүүлээд хүнд байдалд оржээ. Оросын цэргүүд манайхныг цагирганд оруулаад Номон Хан, Бүрд-Овооноос цаашаа алхуулахгүй байна.

Өчигдөр уржигдар хоёр оросын онгоцнууд Яньху, Авдар нуурт байсан манай бэлтгэл хүчийг бөмбөгдөөд тарамдчихсан. Жанжин сүмийг онгоцнууд үнсэн товрог болгочихлоо. Одоо генерал Огису Риппогийн зургадугаар арми байхгүй болсон гэхэд Симото,

- Манай онгоцнууд яачихсан юм бэ? гэлээ.

- Ай мэдэхгүй. Оросууд онгоцондоо нисдэг сум хийгээд манай онгоцыг яйчаад хаячихсан юм байх! Арми, Хайлааст голын хоёр талд бүслэгдээд одоо тэднийг гаргаж авахын тулд боломжтой бүхнийг хийж байгаа боловч ямар ч нэмэргүй болоод байна. Дарга нар байлдааны ажиллагааг түр зогсоолгож тэр хугацаанд нь Солонгост байгаа бүх хүчийг татах, армийг шинэчлэн зохион байгуулах санаатай боловч улаан оросууд байлдааны гал түр зогсоохгүй, бүрмөсөн бууж өгөхийг тулгасан байна. Үүнээс болоод армийн удирдлага дотроо хагарсан бололтой. Бууж өгнө гэдэг бол орос монголын армид онцгой эрх олгож дайны төлбөрийг төлөөд зогсохгүй фронтын бүх удирдлагыг Олон улсын шүүхэд шилжүүлж яллана гэж үзэж байхад зарим нь олон арван мянган хүнээ гарздаад бууж өгөх үү? Цэрэг, техникийнхээ хүчийг бага сүйрсэн дээрээ бууж өгөх үү гэдэг асуудлыг шийдэхийг армийн удирдлаганд тулгаж байна. Тэд үзэхдээ оросын улаан армитай ямар ч хүчээр үзэлцээд амжилт олохгүй гэж байгаа юм байна. Жанжин штаб бууж өгөхийг зөвшөөрөх шинжтэй байгаа гэнэ. Учир нь улаан армид бууж өгөхгүй бол манжуур, өвөр монголыг тэр чигээр нь алдаж, эзэн хааны арми умард хятадаас гарахад хүрнэ гэж үздэг бололтой!

- Энэ ч яах аргагүй боддог асуудал! Улаан орос монголын цэрэг байлдааны ажиллагааг үргэлжлүүлж Хянганаар давбал улаан хятадын арми гэгч мухар толгойтнуудыг хөдөлгөөд хамтарвал бид зүүн умард хятад, өвөр монголыг төдийгүй солонгосыг ч алдаж мэднэ. Тиймээс бууж өгнө гэдэг чинь болох асуудал. Улаан орос, монголынхонд бууж өгсний дараа

онцгой эрхийн дагуу монголын газар нутгийг эргүүлж өгөх асуудал босгоно. Харин зүүн умард хятад манжуур-өвөр монголоос манай армийг гаргах эрхгүй шүү дээ. Ингэхэд жанжин штаб стратегийн бодлого явуулахыг чухалчилж зөвхөн ар монголын асуудал дээр ялсан армийн онцгой эрхийг зөвшөөрөхөөр шийдсэн хэрэг! За тэр яахав, над хамаагүй асуудал.

Чи Сафронов сантай уулзав уу?

- Наашаа гарахын даваан дээр Сафронов өөрөө ирж уулзаад нэг захиа өгүүлсэн гээд энгэрийнхээ халааснаас захиа гаргахад Кавасугийн гар салгалан чичирч байлаа. Симото тэр зурвасыг задалж үзвэл «Бид ялна» гэсэн бай-лаа. Энэ бол Симото, Сафроновтой тохирсон нууц болзмол үг билээ. Симото, Кавасугийн яриаг сонсоод Хайларын штаб руу утасдаж асуудлыг хэрхэн шийдэх гэж байгааг мэдэхээр Комацубарагийн туслахтай ярих гэтэл болсонгүй.

- Симото саны даралт ихсээд, зүрхээр нь хатгуулаад ухаан алдаж унав. Тэгээд эмнэлэгт хэвгүүлээд ирлээ гэхэд Комацубара тэр дороо Кавасутай утсаар ярилаа.

- Гакка, айж их сандарснаас хямарч зүрх нь цохиод даралт нь хэт ихэдсэн байна. Ер нь тархинд нь цус харвах нөхцөл бүрджээ гэж илтгэхэд Комацубара утсаа тавиад «Зүрх гэж туулай шиг амьтан юм даа! Улаан оросын хуурамч мэдээнд мэхлүүлсэндээ хариуцлага хүлээх нь гэж айгаад сүнс нь зайлчих шахжээ» гэж боджээ...

Симото, Комацубарагийн туслахыг хүлээж ядаад орой тийшээ нэгэн танил даргатай санамсаргүй уулзаж байдлыг асуув.

- Симото сан, манай арми ялахаасаа өнгөрсөн. Өчигдөр Элсэн уул, Ногоон толгой дахь бэхлэлт эзлэгдсэн. Бойтог манхан дахь бэхлэлтийг 24-нд эзлээд авчихсан. Орос монголын арми бүслэлтээ бүр хумиад одоо Такайса (Нэргүй өндөрлөг буюу Ремизовын өндөрлөг) арай эзлэгдээгүй боловч ямар ч найдвар алга. Армийн тусгай төлөөлөгчид өчигдөр Мухар өндөрлөгт байгаа зургадугаар армийн штаб дээр ирсэн. Токиод бас сүйд болж байгаа гэнэ. Ерөнхий сайд Хиранумагийн засгийн газар огцрох янзтай. Уэдааг огцруулах нь илэрхий болсон гэлцэнэ. Мөн цэргийн яаманд өөрчлөлт гарах шинжтэй болжээ. Халх голд ялагдах эхний цуурайгаар ийм юм дуулдаж байгаа юм чинь ялагдвал манай хэдэн томчуул яланд унах байлгүй гэж хэлэхэд Симото гүнээ санаа алджээ.

Сафронов 8 сарын 2-нд Халх гол руу явахдаа Симототой уулзаж «Манайхан ялагдвал би чамд захиа явуулна» гээд нууц болзмол үг тохиролцоход Симото «Хэрэв ялагдвал бид ялна» гэж бичээрэй гэж билээ. Одоо юм бүхэн үнэн болжээ. Симото цонхны өмнө зогсоод «Харбин дайрч Иогамма гингогийн салбарт байгаа 80 мянган долларынхоо хадгаламжийг салгаад авчихвал уу. Намайг хятадын бөглүү нутгаас олж чадахгүй» гэж бодсоор оройн нар жаргахыг ширтэн ажлаа хэрхэн зохицуулахаа бодно.

Хорьдугаар зууны гучаад оны японы эзэнт гүрний улс төрийн гол зорилго бол Азийн орнуудыг өөрийн эзэмшил болгоход чиглэж байлаа. Чухам ийм нөхцлийг бий болгох нэг гогцоо бол халх голд хийсэн японы ялалтаар шийдэгдэх ёстой байв. Иймээс эзэнт гүрний улс төрийн бодлогод түүхэн гавьяа байгуулах эрхэм үүрэг засгийн газрын дипломатууд, армийн

генералуудын толгой дээр бууж, тэдний ажил хэрэгч чармайлтаас шалтгаалах тавилантай аж. Халх голд ялалт байгуулж улаан арми болон монголынхныг «ниргэчихвэл» Чан Кайшийн сэтгэлд эргэлт гарч, японы армид итгэх итгэл нь түүнийг захирах нь гарцаагүй гэдгийг японы жанжин штаб тооцоолсон байлаа. Тиймээс засгийн газар Номхон далайн орнуудын бага хурал гэгчийг зарлан хуралдуулж хятадын улс төрийн бодлогод шахалт үзүүлэхээр төлөвлөсөн байлаа.

Эзэн хаан Хирохитогийн хаанчлал сёвогийн 14 оны 6 сарын 20-нд японы улс төрийн бодлогын дүнд «энэ горьдлого» талаар өнгөрч, Халх голд квантуны арми сүйрэлд орсноос хойш найм хоноод ерөнхий сайд Хиранума сайд нарын танхимыг огцруулж цэргийн яамны бүрэлдэхүүнийг өөрчлүүлэхэд хүрлээ. Уэда, энэ бүхнийг ойлгоод гайхаш тасран мухардаж байхад Тозияа өөрийгөө эвгүй байдлаас авраад зогсохгүй эзэн хаанаас шагнал хүртэж, цол ахих эгзэг олчихоод түүнийгээ хэрхэн эхлэхээ бодож байлаа.

Тозияа сүүлийн хоёр долоо хоногт болсон бүх зүйлийг эхнээс нь аваад дэс дараатай эргэцүүлэн бодлоо. Тэрээр Синьзинд хуурамч нэвтрүүлэг хийсэн тэр гогцооноос эхэлж Уэдагийн нууцын шүүгээнд байсан «Косэйтоку» төлөвлөгөөг үзсэн гурван хүнийг нягтлаад кэмпэйтэйн төлөөлөгчдийн дүгнэлттэй танилцав. Тэд Уэдагийн нууцын шүүгээ, нууц бичиг баримт бүрийг тусгай гэрэлд оруулж шалгасан хийгээд байлдааны зурган дээр гарсан бүх мөрийг тодорхойлж, хэзээ хаана, хэдийд хэний зөвшөөрлөөр тэр зургийг үзэж, хурууныхаа хээг үлдээснийг нягтлан тодорхойлсон байв.

Тозияа, шинжилгээний баримтыг уншаад өөрийнхөө нууцын шүүгээг онгойлгоод өнөө баримтаа дотор талын шургуулганд хийхийн тулд шургуулгаа онгойлгох гэж оролдоод түлхүүрээ гацаачихаад хүчтэй мушгисан чинь хугарчихжээ. Тэгээд нууц шүүгээний мэргэжилтнүүдийг дуудаад хүлээж суухдаа Хар чоны хамсаатан дарханг саналаа. Тозияа хар чоныг байцааж, шалгаж байхдаа олон сүүл, сүүдэр тавьсан билээ. Хар чоно Синьзингээс явахын өмнө Аяаносугийн хүссэнээр хуучны танил дархантай уулзсан агаад «Нэг хүн ирнэ» гэж захиад явсан болой. Харин Хар чоныг дархантай уулзаад явсныг мэдсэн хүн бол гудамж цэвэрлэдэг өвгөн хятад байлаа. Тозияа, тэр хятадыг дуудуулав. Тэр өвгөнийг Тозияа «мөнгө» гэж хочилдог аж. Үзсэн харсан бүхнээ тэр ярих бүртээ «мөнгө» гэдэг зантай туршуултай ярьтал,

- Одоо чинь ямар мөнгө хурааж хадгалах нь дээр вэ? Хятадын өөрийн нь юань ч өнгөрлөө. Шинэ юань аль зэрэг удаан настайг хэн ч мэдэхгүй. Тэгэхээр ямар мөнгө хурааж хадгалах нь дээр юм бэ? гэдгийг мэдэх хүн ховор болчихлоо, Тозияа сан, та надад доллар өгөх үү? Шинэ юань өгөх үү. Би чинь бэлээр тасраад байна. Ер нь ямар мөнгө дээр вэ? гэхэд Тозияа,

- Би танд доллар өгнө. Танай дархнаар нэг түлхүүр хийлгэмээр байна. Та очиж ярилцаад ирээч? Болж өгвөл ойрын үед хийлгээд өгчихвөл надад сайн юмсан гэж гуйлаа.

- Гакка, тэр дархан надад тийм ч амархан хийж өгөхгүй. За тэгээд үнэрхээд боож гарна биз! Лав миний толгойны үснээс олон мөнгө нэхнэ. Харин танай штабын Аяаносуд бол зүгээр хийгээд өгөх байх шүү гэхэд Тозияа, уулын тагтад хэвгэж байгаа гахайн сүрэг дээр орчихсон анчин шиг баярлав.

- Юу? Эхнээс нь аваад дэс дараатай яриарай. Наадах чинь үнэ хүрэх мэдээ байна гэж сануулав. Туршуул Тозияаг сайхан аашгай байгааг гадарлаад «Овоо хэдэн юм өгч мэдэх нь» гэж бодоод санаандаа орсон бүхнийг тоочиж гарчээ.

- Аяанаосу, дархантай баяраар ирж уулзаад явсан. Түүнийг явсны дараа дархантай уулзаад «Чи чинь юун япон даргатай ороолдчихоо вэ?» гэтэл «Миний нэг танил явуулсан бололтой» гэж билээ. Баярын маргааш нь Аяанаосу гудамжинд сууж байгаа харагдлаа. Би түүнийг ажиглаж байгаад явсан хойно дархныд ортол тэр маань бөөн мөнгө тоолж байлаа. Тэгэхээр нь би танаар түлхүүр хийлгээ юү гэтэл уурлаад «Чамд огт хүртээлгүй» гэсэн юм. Би сэжиг авчихаж магадгүй гээд хурдан гарсан.

- Дархан одоо гэртээ бий юү?

- Гэртээ хэвтэж байгаа. Хэд хоногийн өмнө угаарт цохиулаад гэж байсан. Ойрдоо үзэгдэхгүй байсан. Ер нь хэвтэрт орчихсон байх. Тэр чинь өвдөхөөрөө хаалгаа түгжээд хэнийг ч оруулдаггүй зөрүүд хүн гэлээ. Тозияа, туршуулдаа хэр тааруу шан өгч явуулаад штабын тусгай шоронгийн даргыг дуудаад дархны хаягийг өгөөд,

- Тусгайлан хорь! Надаас өөр хүн, түүнийг дуудахгүй гэдгийг мэдэж ав! Нөгөө талаар үүнийг та ганцаараа мэдвэл зохино гэжээ. Харин хоёр цагийн дараа шоронгийн дарга Тозияад,

- Гакка, өнөө дархан оргочихсон байна гэж мэдэгдэв. Тозияа элдвийг бодлоо. Аяанаосу, жижүүрт гарахын өмнө

дархантай уулзсан төдийгүй түлхүүр хийлгэжээ. Түүнийг жижүүрт гарсан шөнө гурван станцыг зэрэг ажиллуулсан нь штабт байсан бүх хүний анхаарлыг ганцхан станцын ажиллагаа руу хандуулахад хүрчээ! Чухам ийм үед штабт орж ирсэн хүнийг хэн ч анхаарахгүй байх боломжтой. Тэгвэл Уэдагийн өрөөнд орсон тагнуул байлдааны төлөвлөгөөг нууцын шүүгээнээс хуулбарлан авсан хэрэг үү? Үгүй хугацаа нь хэтэрхий бага байсан шүү дээ. Ердөө арван таван мөчийн дотор буюу гурван станцыг ажиллаж байх хугацаанд амжих ёстой байсан. Тэгэхээр гэрэл зураг авсан хэрэг! Тэгвэл ширээний чийдэн асааж таарна даа. Уэда саны өрөөний цахилгаан тоолуурыг шалгуулъя. Уэдагийн өрөөнөөс байлдааны зургийг гэрэл зургийн аппаратаар авсан учраас улаан орос, монголынхон ерөнхий давшилтынхаа төлөвлөгөөг амжуулсан байна. Тозияа, Уэдагийн өрөөний цахилгаан гэрлийн тоолуурыг яаралтай шалгах үүрэг өглөө. Тозияагийн томилсон хүмүүс Уэдагийн өрөөнд асаасан гэрлийг нарийн хэмжжээ. Тиймээс Тозияа шалгалтынхны илтгэлийг анхааралтай уншлаа.

Тозияа чингээд зогссонгүй үл тайлагдах нэвтрүүлэг тэмдэглэж авсан өдрүүдийг Ойдовын ийш тийшээ явж байсантай тулгаж үзэхэд Харбин, Хайлар, Ханширээ, Жанжин сүм, Халуун рашаан, Халх гол руу буюу Синьзинд байсан хугацаатай яг мөргөж байлаа. Чингээд Тозияа, тагнуулын газрын даргыг дуудаж, Аяанаосуг далдаас ажиглаж байх тусгай даалгавар өглөө. Тэгээд Уэдагаас заалт авч Аяанаосуг баривчлах тухайгаа мэдэгдэхээр өрөөнд нь оров. Уэда, Тозияагийн бараанаар царайгаа үрчийлгэж,

- Тозияа сан, наашаа суу. Би сая Токиотой ярилаа. Сайд нарын танхим огцорч өнөө өглөө өнөө гайхал Нобуюки Абэ ерөнхий сайд болсон байна. Тэр чинь 1936 оны 2 сарын 20-ны өдрийн

будлианд оролцоод их дүвчигнэсэн болохоор цэргийн яамны сайд Кавасима, түүнийг яллуулахаар эзэн хаанд танилцуулаад амжаагүй юм. Гэтэл одоо ерөнхий сайд болжээ. Итакийг цэргийн яамны сайдаас огцруулсан бололтой. Ингэхээр жанжин штаб бидэнд ямар ч дэмжлэг үзүүлэхгүй нь илэрхий болсон. Шинэ ерөнхий сайд Халх голын дайныг зогсоох талаар Гадаад Яаманд үүрэг өгч, Москвад байгаа элчин Того улаан оросын гадаад яаманд бараалхсан байна. Ингэхээр одоо бидний хэн хэн маань буруутан болж байх шив дээ. Улаан орос,

монголын цэргүүд Такасай өндөрлөгийг эзлэн авсан учраас одоо бидэнд ямар ч тулгуур байхгүй болсон. Үүнийг мэдсэн зарим хүн хариуцлагаас мултрахын тулд одооноос нүхээ малтаж байна гээд Тозияа сүрхий ширүүн харлаа.

- Энэ чинь тун шударга биш явдал! Тийм хүнийг байлдааны цагийн хуулиар шийтгэх ёстой гэхэд Уэда,

- Тозияа сан, тэгвэл та өөрийнхөө шавь Симотоог устгах хэрэгтэй болжээ. Тэр чинь Хайларын эмнэлгээс сэм оргоод Харбины банкинд байсан хадгаламжаа аваад тонилсон байна гэж ууртай хэлээд Тозияа руу бууж гарлаа. Чингээд Тозияа руу сүрхий ширүүн харлаа.

Тозияа, Уэдагийн өрөөнөөс гараад хэд хэдэн даргатай утсаар ярьж байдлыг ажиглав. Тэд нар сайд нарын танхимыг албан ёсоор тараасныг мэдээд хар амиа боджээ.

Найман сарын 31-ний өдөр пүрэв гариг. Халх голын дайн эхэлснээс хойш 19 дэх Пүрэв гариг. Хайлааст голоос төдий холгүй байдаг Нэргүй өндөрлөг буюу япончуудын нэрлэснээр Такасай өндөрлөгт байсан японы сүүлчийн бэхлэлт дээр улаан туг хатгажээ. Тозияа цаг үеийн байдлыг ашиглаж чаддаг болохоор өөрийнхөө сэтгэлд эргэлдэж байгаа бүх төсөөллөө баримтаар нотлоод Манжуурт байгаа улааны тагнуулын бүлгийг илрүүлэх замаар Юкигийн алтыг шийдвэрлэхээр төлөвлөөд үүгээрээ өөрийнхөө амийг аварна гэж бодно. Тэгээд Тозияа тагнуулын хэлтсийн дарга руу утасдаад,

- Одоо ингэсхийгээд ороод ир гээд штабт байдаг тусгай мөрдөнгийн даргыг бас дуудлаа. Чухам энэхэн хугацаанд Тозияа «Одоо ээдрээ бүхэн тайлагдах эгзэг бүрэлдлээ. Ингэхээр Сафронов, Аяанаосу хоёрыг хойшлуулахгүйгээр барья. Тэгээд одоо байгаа баримтуудыг тулгаад Ойдовын нэвтрүүлэг бүрийг Синьзинээс явсан өдрүүдтэй харьцуулаад бүх баримтыг үзүүлж Уэдагийн өрөөг шинжилсэн баримт тулгачихаар болдог хэрэг» гэж бодлоо. Тозияа, тусгай мөрдөнгийн даргыг орж ирэхэд,

- Одоо ингээд хоёр хүн баривчилна. Тэднийг танай мөрдөнгийн тусгай өрөөнд байцаана. Гэхдээ энэ талаар мэдсэн буюу үзсэн хүн байж болохгүй. Энэ асуудлыг чамаас гадна ганц хүн мэднэ. Тиймээс тусгай өрөө бэлдээд тэнд нь чи өөрөө аваачаад байлгаж бай! Тэднийг хэрхэх тухай би өөрөө чамд оройхон хэрд хэлнэ. Тиймээс тэр хүртэл түүнтэй ганц ч үг ярьж, асуух хэрэггүй гэж чандлан тушаагаад гаргалаа.

Аяанаосу уржигдар Ойдовтой уулзах ёстой байсан боловч тэрээр болзоондоо ирээгүй. Ойдов Хайларт байгуулсан зураг төслийн товчоогоо тарааж, зохих ёсны хөлсийг төлөөд буцаж ирэх ажлаар явсан нь Аяанаосуд мэдэгдэж байлаа. Чухам ийм үед Аяанаосу, Рожусайн шууд

мэдэлд байдаг хоёр дахь холбоочинг олж уулзах ёстой аж. Тэрээр хотын цэцэрлэгт очив.. Аяанаосу энгийн хувцас өмсжээ. Тэр цэцэрлэгт орж ирээд яаралгүй алхаж явахдаа «Рожуганукай ажиллагааг амжилттай дуусгалаа. Халх голын байлдааны галыг зогсоож, япончууд бууж өгөх нь илэрхий боллоо. Тэгэхээр төв биднийг татаж авна. Рожусай энэ тухай төвөөс шийд авна гэсэн. Хурдхан шиг буцаж муу дүүтэйгээ, Сувдаатайгаа уулзах юмсан. Сувдаа минь ээжтэйгээ амьдарч байгаа гэсэн шүү дээ» гэж бодсоор цэцэрлэгийн баруунтай байдаг цөөрмийг чиглэв. Цөөрмөөс холгүй байгаа сандал дээр сууж байгаа хөгшчүүл наранд ээж, жаахан хүүхдүүд нууранд буй хун цэнг сонирхон, идэх юм чулуудан өгнө. Захын сандал дээр суусан нэг хижээл авгай, даавуун шаахай оёх агаад хажууд нь гурван нас өнгөрч яваа болов уу гэмээр хүүхэд эмээгээ тойрч наадна. Тэр авгай ачийнхаа аманд резин угжийг нь хийж өгөөд тоглоомон машин хөтлүүлээд тогло гэж байгаа бололтой ямар нэг юм хэлнэ.

Бяцхан хүүхэд машинаа чирч тэнтэр тунтар алхсаар цөөрөм рүү дөхнө. Авгай цөөрөмд ойртсон жаалын хойноос очиж түүнийг хөтлөөд сандал руугаа эргэлээ. Гэтэл өнөө жаал хүү эмээгийн гараас мултрад зугтаахад эмээ нь «Миний хүү нааш ир» гэж аргадан дуудах атал жаал хүү улам зугтаана. Тэрээр гүйсээр Аяанаосугийн дэргэдүүр өнгөрөхөд тэрээр хүүхдийг барьж аваад эмээд нь өгөхөд өнөө авгай Аяанаосуд баярласнаа илэрхийлээд хүүгээ тэврээд сандал өөдөө алхлаа. Харин эмээ хүү хоёр өнөө угжаа хэрхсэнийг үл анзаарна. Авгай Аяанаосуг ирж явааг хараад хүүгийнхээ угжийг аманд нь хийхийг ажсан Аяанаосу Рожусайн холбоочинг таниад баярласан. Тэгээд хүүг барьж, эмээд нь өгөх тэрхэн эгшинд өнөө угжийг нь авсан ажээ.

Аяанаосу нэлээн зайдуухан газар очиж нэг сандал дээр суунгуутаа авч явсан сонингоо гаргаж унших далимд угжны хөндий нүхнээс нарийхан хуйлсан цаас гаргаж дэлгээд унштал «Өрөө яаралтай дуусга. Рожусай» гэсэн байлаа. Үүнийг уншаад «Төвөөс шийд иржээ. Хэзээ буцаах бол» гэж бодтол Аяанаосугийн сэтгэл хөнгөрөөд явчих шиг санагдав. Үнэндээ Аяанаосу нэрээр харь газар, нам эх орон ард түмнийхээ даалгаврыг биелүүлж яваа Гунгаад "Самурайн ёс дэглэмийг эрхэмлэсэн самурай" байхын тулд сэтгэл санаа, ухаан бодол, зориг тэвчээр, хатуужил тэсвэр гаргах гэж хичээхдээ нөр хүч хөдөлмөр гаргасныг өгүүлэх юун.

Аяанаосу, цэцэрлэгээс гарч армийн штаб руу явав. Түүнийг штабын хаалгаар орж ирэхэд ерөнхий жижүүр,

- Чиү са, таныг Тозияа сураглаад байсан. Өрөөндөө хүлээж байгаа гэхэд Аяанаосу, генералын өрөө рүү алхав. Тэгээд өрөөг нь чиглэж явахдаа «Тозияа одоо өөрийгөө яая гэж байж надаар яах гэсэн бол? Нүглээ далдлах нүх сүв надаар олуулах арга олчихсон байх даа» гэж боджээ,

Аяанаосуг Тозияагийн өрөөнд орж ирэхэд тэрээр ерийн тайван нэгэн хавгаст хэрэг уншиж суулаа. Тэгээд түүнийгээ хойш тавиад,

- Аяанаосу минь Токиод эргэлт гарсныг дуулав уу? гэв.

- Гакка, энэ тухай манайхан жиг жуг гэлцээд байна. Ер нь хөл толгой нь мэдэгдэхгүй бүүр маанагтуулаад хаячихлаа. Бид чинь явж явж хариуцлага хүлээх болж байнаа даа гэхэд Тозияа,

- Хүлээх ёстой хүмүүс байдаг бол хүлээдэг юм байгаа биз. Би бол армийн удирдлагын тушаал

биелүүлсэн хүн! Сая надтай Токиогоос ярилаа. Халх голын асуудалтай холбогдсон хэдэн зүйлийг шалга гэж байна. Би Халх голоос хоёр хүн авчруулсан. Тэгээд чамд шилжүүлье. Тэдэнтэй уулзаад ярилц. Манай бэхлэлтийг оросууд болон монголын удирдлага мэдэж байсан байна. Түүнийг яаж мэдсэнийг тодруулах хэрэгтэй. Чи үүнийг нягтал! гээд ширээн дээрх нэг үнэмлэхийг авч Аяанаосуд өглөө.

Аяанаосу, штабт байдаг тусгай мөрдөнгийн газар нэвтрэх үнэмлэх болохыг ажаад гарын үсэг рүү нь харвал Тозияа зуржээ. Албан ёсоор бол Уэда энэ үнэмлэх дээр гарын үсэг зурах ёстой. Гэтэл Уэда тушаалаас огцрох нь илэрхий болсон тул Тозияа гарын үсэг зурж дээ гэдэг бодол Аяанаосугийн сэтгэлд буув. Цагийн өмнө ийм үнэмлэхийг Тозияа, Сафроновт өгсөн бөгөөд түүнийг тусгай мөрдөнд очиход шууд баривчилжээ. Гэвч үүнийг Аяанаосу хэрхэн мэдэх билээ. Аяанаосуг тусгай мөрдөнд очиход тагнуулын хэлтсийн дарга, тусгай мөрдөнгийн дарга хоёр шууд баривчлах хуудас үзүүлээд бяцхан өрөөнд хийж түгжив. Ингээд Тозияад илтгэлээ.

- Тозияа сан, Аяанаосуг баривчлахад түүнээс нэг зурвас гарсан. Тийм онц сонирхууштай юм биш. Өр авлага нэхэмжилсэн бичиг байна билээ.

- Нааш нь аваад ир! гэхэд мөрдөнгийн дарга.

- Би сая өгөөд тань руу явуулчихлаа. Танд тагнуулын хэлтсийн дарга аваачиж өгнө гэлээ. Гэтэл хэдэн мөчийн дараа өнөө бичгийг Тозияад авчирч өгөв. Тозияа тэр бичгийг уншаад сэтгэлдээ «Тун сэжигтэй бичиг байна. Рожусай гэдэг япон нэр байдаггүй шүү дээ» хэмээн бодсон боловч гэр рүүгээ яарлаа. Тэрээр Юкитэй уулзах онц хэрэгтэй ажээ.

Тозияа өрөөндөө орохын өмнө зочдын өрөөг цэвэрлэж байгаа авгайгаас,

- Юки гэртээ байна уу? гэж асуулаа.

- Бий. Түрүүхэн Банди, Тогтох хоёрыг загнаад байсан. Өглөө намайг загнаад зодох шахсан. Биднийг юу ч хийдэггүй хоолны туламнууд гээд байдаг болчихлоо. Тозияа сан та Юкитэй ярилцаж биднийг зөв ойлгуулахыг бодооч гэж гуйлаа. Юки сүүлийн үед гэрийнхээ үйлчлэгч нарт ялангуяа Банди, Тогтох хоёрт муу болжээ. Юм л бол тэднийг үзсэн цагтаа загнадаг болой. Тиймээс гэрийн үйлчлэгч нар хааяа Тозияад гомдол мэдүүлж царайчилна. Тозияа тэднийг өмөөрсөн хүн болж Юкийд зөөлөн ая зантай байхыг зөвлөдөг байлаа. Тозияа хувцсаа солиод нэмакигээ өмсөж бүсэлсээр Юкигийн өрөөнд орохын өмнө хаалгыг нь чимээ гаргалгүй нээгээд сэмхэн орж ирэхэд Юки, цонх руу хараад хаалганаас холгүй байгаа Банди, Тогтох хоёрыг толгой түрүүгүй загнана. Тозияаг орж ирснийг тэдний хэн нь ч мэдсэнгүй.

- Би та хоёрыг гуйж орчуулга хийлгэх гэж авчраагүй. Миний юу тушаасныг дор нь биелүүлэх ёстой гээд цонхноос эргэхдээ үүдэнд зогсож байгаа Тозияаг хараад дуугаа зөөлөн болгож,

- Аа та хүрээд ирэв үү гээд Банди, Тогтох хоёр руу гараараа дохиход тэр хоёр өрөөнөөс гарлаа.

- Юки, манай төрийн удирдагч өөрчлөгдсөн байна гэхэд Юки ширээн дээрх нэг сонин авч Тозияад өгснийг ажвал Дайран синбун байлаа. Тэр сонинд шинэ засгийн газрыг эмхлэн байгуулсан хийгээд квантуны армийн удирдлагыг багагүй зэмлэж, шинэ засгийн газрын улс

төрийн бодлогын чиглэлийг тайлбарласан байлаа. Квантуны арми Халх голд сүйрсэн явдал эзэн хааны армийн сүр хүчийг муутгаж, өнөө маргаашгүй бууж өгөх байсан Чан Кайшийг өөгшүүлж, түүнийг сэтгэл буруулах эгзэг гаргалаа гэж зэмлэсэн төдийгүй Англи, Америк хоёртой тохирч болох нааштай замд бул чулуу боллоо гэж буруутгажээ.

- Юки, манай арми Халх голд ялагдахад хүрсэн явдал бол улааны талд урвасан хүмүүсийн балгаас болсон юм. Би гэмт этгээдүүдийг барьсан. Маргааш жанжин штабтай ярилцаж хэрхэхийг шийднэ.

- Би таныг ямар ч үед зэмлэх ёсгүй. Гэтэл амьдралд ёсгүй ёс гэж байдаг байна. Миний эцэг танд найдвар тавьж хүний нутагт ясаа тавилаа. Би танд итгэж, Халх голыг эзэмшлээ болгохын тулд төмөр замын нийгэмлэгүүдэд хөрөнгөөр зусардаж багагүй хөрөнгө гарзасан. Харин аз болж эцгийнхээ алтанд хүрээгүй нь их юм. Тэгэхээр одоо өөрийнхөө замыг бодно. Японы засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорч, улс төрийн шинэ бодлого баримтлах нь илэрхий боллоо. Бүүр тодруулж хэлбэл хятадтай зууралдсан үйл ажиллагаа одоо арван жил болсон ч энэ хэвээрээ байх болно. Тэгэхээр шинэ засгийн газар Халх гол руу ямар ч алхам хийхгүй. Квантуны арми бууж өгвөл улаан оросууд ялсан армийн хувьд монгол руу японы армийг дахин чиглүүлэхгүй онцгой эрхийг зөвшөөрүүлэх болно. Японы арми ялагдсаны хувьд тэр шаардлагыг хүлээн авч онцгой эрхээр шийдэгдсэн бүхнийг дагаж мөрдөх болно.

- Юки, чиний боддог зөв байх. Гэхдээ сүх далайтал үхэр амар гэдэг үгтэй. Абэгийн засгийн газар, түүний улс төрийн бодлогыг армийн дээд зиндааныхан яаж хүлээж авах нь тодорхойгүй. Тэд Абээг буруутгая гэвэл нүд ирмэхийн зуур аваад хаячихна. Түүнээс гадна чи, өөрийнхөө нэр сүрийг бодох хэрэгтэй! Манайд баригдсан хоёр хүн, Халх гол руу чиглэсэн армийн ажиллагааны нууцыг Аяанаосу, Сафронов хоёроос авдаг юм байна. Тэгэхээр энэ талаар чи бид хоёр ярилцахгүй бол болохгүй. Тэд Ойдовыг холбоочин гэдгийг гэрчилж батлаад байгаа юм.

- Ойдовын хувьд гэвэл түүнийг та өөгшүүлсэн. Би таны сэтгэлийг бодоод бас давхар сүйрэх юм байна. Түүнийг анх ирэхэд нь бөөрнөөсөө ягаарчихсан бол яах вэ? гэж танаас асуусан шүү дээ. Харин Сафроновын хувьд та бид хоёр хоёулаа буруутай. Тиймээс түүнийг хамгаалах хэрэгтэй. Аав та хоёр эцэгтэй нь ах дүү шиг байсан улс. Аяанаосугийн хувьд гэвэл түүнийг Симото өөгшүүлсэн биз дээ.

- Манайхан тэдэнтэй уулзаж ярилцахад өөрснөө ч гэсэн нэг их эсэргүүцээгүй байна. Тэгэхээрээ асуудал хүндрээд байгаа юм гээд Тозияя, Юкигийн царай өөд харлаа.

- Ер нь тэд толгойгоороо хөлөө хийнэ үү? Хөлөөрөө толгой хийнэ үү надад ямар хамаа байна гэж Юки уцаарлангуй хэллээ.

- Сафронов өөрийгөө чамтай холбоотой гэж байгаа юм. Аяанаосу болохоор Сафроновоос даалгавар авч байсан гэж өчөөд байна.

- Тэгвэл тэд чинь намайг аварна гэж бодож л дээ. Эсвэл надад өширхсөн байна. Би тэдэнд гэм хийгээгүй юмсан. Сафронов хүний ятгалганд орж дээ. Түүнээс тэгэх ёсгүй.

- Юки, чи Сафроновыг ерөөсөө таньж чадаагүй. Тэр чинь Харбинд байсан улаан оросын нэг хүүхэнтэй нөхцөөд үүнийг нь Аяанаосу далимдуулсан байж болох юм. Энэ бүхэн тун ээдрээтэй байгаа юм гээд баримтуудаа тоочив.

- Юки минь өнгөрсөн баяраар эд нар манайд нэлээн орой болгосон. Тэгээд гакка бид хоёрын өрөөнд орж ирээд түлхүүрийн хэв тааруулж аваад Аяанаосуг жижүүртэй байсан тэр өдөр Уэдагийн өрөөнд орж, байлдааны төлөвлөгөөний гэрэл зургийг авсан байна. Үүнийг Уэдагийн өрөөнд асаасан гэрлийг тэмдэглэдэг тоолуураар хөөж олсон юм. Би тэднийг тусгайлан хорьсон. Кэмпэйтэйн төлөөлөгч тэднийг удирдаж байгаа хүний нэгд чамайг холбогдуулж сэрдээд байна. Тэгээд жанжин штабынханд тал засаж эртхнээс аргалчихвал тэдний хэн нь ч чам руу дайрч зүрхлэхгүй. Ялангуяа жаахан алт үзүүлчихвэл жанжин штабынхан эзэн хаанд айлтгаж чиний нэр төрийг хамгаалах учраас чиний улыг шагайсан хүмүүс өөрснөө хүзүүгээ ороосон асуудалд холбогдохгүйн тулд асуудлыг зөөлрүүлж дарна.

- Би одоо армийнхантай энэ тэр гэж сүйд болохгүй. Нөгөө талаар бүх алтаа америк руу шилжүүлэхээр шийдээд цахилгаан явуулчихсан. Энд эдний царай харж, яс горьдсон нохой шиг явсанд орвол америкт очоод үйлдвэр банкны эзэдтэй хоршвол дээр гэж хэлэхэд Тозиягийн тархинд цус харваж байгаа юм шиг нүд нь манантаад дотор нь эвгүйрхээд явчихлаа.

- Юки чи, цахилгаанаа хэзээ явуулсан бэ? гэж Тозия ууртай, шаардангуй асуухад Юки, Тозия руу нүдний булангаар хяламхийгээд,

- Та яах гээ вэ? Энэ бол миний хувийн хэрэг шүү гэлээ.

- Чиний хувийн бүх хэрэг японы армийн удирдлагын үйл ажиллагаатай шууд холбоотой. Тиймээс би чамаас Шанхай руу хэзээ цахилгаан явуулсан бэ? гэж асууж байна.

- Энэ чинь ёстой хойноос ирээд хот минийх, хотонд ирээд хонь минийх гэдэг болж байх шив дээ. Одоо байтлаа миний алхаж гишгэхийг цагдах болж байнаа даа?

- Юки би сайн санааны үүднээс хэлж байна шүү. Ер нь шууд хэлэхэд талийгаач эцэг чинь японы тагнуулын газрын төлөөлөгч байсан юм. Би бол түүний зөвлөхөөр ажиллаж байлаа. Тиймээс эцгийн чинь ажлыг чамаар үргэлжлүүлэхийн тулд армиас намайг чиний зөвлөх болгосон эчнээ шийдвэртэй юм. Харин Ойдов, Аяанаосу хоёр чамаас алтыг чинь салгаж монгол руу буцаахаар хуйвалдаж байгаа монголын тагнуулууд! Тиймээс чи алтаа Нихон гингогийн нэр дээр шилжүүлэх ёстой!

- Тозия сан, та дэндүү андуурсан байна. Аавын гэрээслэлийн хувьд гэвэл түүнийг би, өөрийнхөө гараар бичсэн юм. Харин та миний үгэнд хууртагдсаны адилаар таны үгэнд японы жанжин штаб молигодуулсан.

- Юки, чи ийм дээрээ хүрсэн бол манайхны сэжиг үнэн байна. Тиймээс одоо би чамайг баривчилна гэлээ. Тозия энэ үгийг Юкийд хэлэх ёсгүй. Гэтэл уурандаа болоод хэлчихлээ. Тозия үүнийг мэдсэний дараа өрөөндөө хурдхан шиг орохыг бодлоо. Тозия Юкигийн үгийг сонсоод өрөөндөө ороод ширээнийхээ товрууг дарахад хэдэн мөчийн дараа японы цэргүүд

Юкигийн орж ирэх байжээ. Тозияаг чингэж уурандаа багтран хашгирч орилон хэлсэн чимээгээр Юкигийн өрөөний хаалга нээгдэн Банди, Тогтох хоёр гаднаас орж ирээд Тозияагийн хоёр талд зогсчихлоо. Тозияа диван дээрээс босож болохгүй болсныг ойлгоод Юки рүү гайхсан нүдээр ширтэнэ.

- Тозияа та халааснаасаа буугаа гаргаад өгчих! Тэгээд хоёулаа ярилцъя. Надад тантай тохирох зүйл бий! гэхэд Тозияа арга буюу гар буугаа гаргаж Тогтоход өгөхдөө «Юкигийн гэрийн үйлчлэгч нар надад гомдол мэдүүлж, Юкийг загнаад байна гэдэг нь нарийн зохион байгуулсан зүйл байжээ. Юки гэрийн үйлчлэгч нарт худлаа ширүүлээд миний сэжгийг төөрөгдүүлчихээд харин намайг тэднээр хянуулдаг байсан байж!» гэж бодож суутал Юкийн дохиогоор Банди, Тогтох хоёр өрөөнөөс гарлаа.

- Тозияа байдал нэгэнтээ өөрчлөгдөж ийм болсон хойно одоо бие биенээ мэхлээд яах вэ? Харин миний тавьсан шаардлагыг зөвшөөрвөл та олон юмнаас өөрийгөө аврах болно. Түүгээр ч барахгүй эзэн хааны өмнө гавьяа байгуулсан самурайн хүндэтгэлийг хүлээж хойч үеийнхэндээ тахигдан бишрэгдэх болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

- Яагаад тэр билээ?

- Нэгд: эзэн хааны армийн нэр төрийг гутаасан хийгээд самурайн тангарагт үнэнч хандаагүй гэмт хэрэгтэн гэдэг ялт ажиллагаанд холбогдохгүй. Хоёрт: Халх голын байлдаан улаан орос, монголын ялалтаар дууссан тул тэд японы армийн болон засгийн газрын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийвэл, ялсан армийн онцгой эрхээ эдэлж та нарыг цэргийн гэмт хэрэгтэн гэж үзэх болно. Тэгвэл та, тэдний (цэргийн гэмт хэрэгтний) нэрийн жагсаалтанд өртөхгүй өнгөрөх боломжтой гэдгийг анхаарна биз! Гуравт: японы арми ялагдсанаа хүлээн зөвшөөрч хоёр талын хэлэлцээг зөвхөн орон нутгийн цэргийн эрхтний хэмжээнд тохиролцвол жанжин штаб, цэргийн яам, засгийн газар та нарыг (квантуны армийн удирдлагыг) самурайн бусидогийн замналаас ухарсан урвагчид гэж үзэх болно гэхэд Тозияа,

- Би тэд нартай адилхан урвагч биш гэж байдаг чадлаараа хашгирлаа.

- Та харийн хүмүүст квантуны армийн болон японы жанжин штабын нууц бичиг баримтыг дамжуулж байсныгаа цагаатгах гэж бодвол бусидо ёсоо баримталж өөртөө самурайн эртний дэглэмээр сеппуку үйлдэхээс сайхан зам байхгүй. Чухам ийм нөхцөлд японы жанжин штаб таныг урвагч биш гэдгийг ойлгож, шарилыг чинь Мэйжийн сүмд хүндэтгэн залж, мөнхлөх болно гэхэд Тозияа яах учраа ололгүй балмагдлаа.

Энэ чинь ёстой аймшигтай болзол байна. Би эзэн хааны өмнө мөнхийн гавьяа байгуулахын тулд армид 37 жил зүтгэсэн. Гэтэл энэ олон жилийн зүтгэл ингээд талаар өнгөрөх хэрэг үү? Юкигээс алтыг нь салгаж чадсан бол би томоохон хөрөнгөтэй банкны эзэн болох байсан. Тэгээд хожим өөдлөхөд миний хөшөөг хүрлээр босгож, армид байгуулсан гавьяаг хүндэтгэн Ясакуни, Мэйжийн сүмд шарилыг минь хүндэтгэн оршуулах ёстой. Би үүний тулд бие, сэтгэлээ зориулж яваа. Гэтэл энэ бүхнийг нүд ирмэхийн төдийд баллах эрлэг, миний бөөрөнд наалдчихсан байжээ. Одоо би яах ёстой вэ? Ер нь орос монголын хамтарсан энэ том бүлгийг удирдаж байгаа жинхэнэ эзэнтэй уулзах хэрэгтэй! Тэгвэл би өөртөө сеппуку үйлдэлгүй амьд гарч болно. Тэгэхдээ Сафронов, Аяанаосу хоёроор дэнчин тавьж болно. Тэгвэл Юкигийн

хэлж байгаа бүхнийг сөргөх хэрэггүй...

Тозияа, эгшний төдийд дэвэн дэлхийг бодож амжлаа. Тэрээр ахархан хугацаанд ашигтай арга олж амиа хоохойлж сурсан зангаараа,

- Юки би, өөртөө сеппуку үйлдэхгүй гэж бодъё. Тэгвэл ямар замаар танай эзэнтэй уулзаж болох вэ?

- Хэрвээ та өөртөө сеппуку үйлдэхгүй бол би, таныг одоо устгах болно!

- Юки! Би чиний өмнө буруугүй шүү. Тэгэхээр энэ чинь дэндүү шударга биш болзол байна гэтэл Юкийн харц гэнэт өөрчлөгдөж, царай нь цайгаад цээжинд нь багтаж ядсан уур хилэн, хорсол нүдэнд нь тодорлоо.

- Чи миний өмнө түмэн буруутай! гэж Юкийг хэлэхэд хоолой нь зангирч сэтгэлийн хорслоо илэрхийлсэн дууны өнгө Тозияагийн толгой дээр аянга ниргэх шиг сүртэй сонсогдов. Юки хэсэг зуур Тозияагийн улаан нүүр рүү галаар төөнөж байгаа юм шиг гялалзсан харцаар ширтэн дуугүй зогсоход нүдэнд нулимс цийлгэнэснийг мэдээд Тозияагийн зүрх өөрийн эрхгүй чичрэв. Юкигийн зовхинд торж ядсан нулимс хэлхээнээсээ тасарсан сувд шиг хацрыг нь даган бөмбөрөхөд Юки хөмхийгөө тас зууж байснаа сая гүн санаа алдав.

- Тозияа, чи миний өмнө нүглээ наманчилж өөртөө харакири үйлдсэн ч миний гомдол тасрахгүй гэхэд Тозияагийн нуруугаар хүйт оргиод явчихлаа. Тозияа, Юкийд «Чи чинь юу ярьж байна даа. Би чамд тун энэрэнгүй хандаж, эцгийн чинь оронд эцэг болж өдий хүргэснийг бодох хэрэгтэй! Би бас хүн шүү дээ» гэж хэлэх гэтэл дуу нь хоолой дээр тээглээд гарч өгсөнгүй. Гэсэн ч Юки Тозияагийн хэлэх гэсэн үгийг нүдний нь харцаар ойлгож байв.

- Буруугүй гэж өөрийгөө зөвтгөх гэж байна уу! Байтлаа шагнах ёстой гэж хэлэх чинь дугаа шив дээ! Би чамд шагнал онооно. Тэгэхдээ... гээд эхэр татан уйлж байгаа юм шиг харагдсанд Тозияа нүдээ аньтал 19 жилийн тэртээ хүрээний гандангийн өмнөх хүр рүү ойчихдоо дуу алдсан эмэгтэйн дуу чихэнд нь сонсогдох шиг боллоо. Тозияа айсандаа нүдээ нээтэл,

- Эхийг минь бороотой үдшээр өндөр ганга руу түлхэж, Баатар гүнгийн өвчнөөр далимдуулж эцгээс минь холдуулаад ах дүү хоёрыг хагацаахдаа буруугүй гэж бодож байсан уу? Эцгийг минь хорлож алуулаад зогсоогүй амьдралын тавилангаар заяасан ханийг нь (Гэрэлээг) хүртэл Симото, Кавасу, Сойхара нарын гараар хорлуулснаа буруугүй гэж бодож байна уу? Би энэ бүхнийг мэдсээр байж чиний дэргэд шүд зууж өдий хүрэхдээ ухаан санаа, бие сэтгэлээсээ хэтэрсэн дарамтыг мартахын тулд өөрийнхөө хорин жилийнхээ насыг алдсан. Миний үсийг хар гэж бодож байна уу? Миний толгойд ганц ч ширхэг хар үс байхгүй. Үүнийгээ мэдэгдэхгүйн тулд сар бүр үсээ будуулж байсан юм. Тиймээс чи дандаа үсээ будуулдаг явдалд гайхаж цөөнгүй асуудаг байсан. Одоо бодоод үз! Буруугүй гэж хэлэх эрх байна уу? гэж хэлэхэд Тозияагийн хамаг бие хөшөөд бадайрчихсан байлаа.

Юки цонхны дэргэд зогсож сэтгэлээ түр тайвшруулахыг хичээсэн бололтой цонх руу харж зогсохдоо ганц ч үг хэлсэнгүй.

Тозияа, энэ эгшинг ашиглаж диван дээрээс босохыг мэрийтэл тэрээр тэнхээгүй болтлоо тамирдсан байлаа. Тэрээр «Айсан хүн сүнсэндээ ороолгоод баглуулчихдаг юм гэсэн. Намайг сүнс минь баглаад мэдээгүй болгочихсон бололтой» гэж бодохоос улам айлаа. Айсан хүний тэнхээ алдардаг ажээ. Тозияа энэ бүхнийг ойлгоод «Явж явж нэр төргүй нохойн үхлээр үхэх нь ээ! Тэгж болохгүй! Тэгвэл тамд очиж тарчлах болно шүү! Одоо Юкийд андуу сэтгэлээр хандаж болохгүй. Тэгвэл ах дүү, эцгийнхээ өшөөг авах гэж байгаа Юки миний улаан гол, халуун амийг хайрлахгүй! Одоо Юкийн сэтгэлийн хорслыг буцалгах ганц ч үг хэлж болохгүй. Тэгэхээр өөртөө боломж гаргах хэрэгтэй! Энэ өрөөнөөс Юкийн гарт алуулчихгүй амьд гарах юмсан. Тэгвэл болох нь тэр!» гэж бодлоо.

Юки санаа алдаж сэтгэлээ тайвшруулсан болоод цонхны дэргэдээс эргэж Тозияа руу ойртоход түүний сэтгэл ерийн тайван саяхан галзуу бар шиг байсан догшин дүр төрх аль хэдийн алга болсныг ажвал сэтгэлээ тайвшруулж чаддаг асар их тэвчээртэй ажээ. Ийм чадал, сэтгэлийн хатуужил зориг тэсвэр хүнд байх гэдэг тийм ч амархан хэрэг биш гэдгийг Тозияа мэдэж байлаа.

- Тозияа сан, та өөрийгөө бодож байгаа бол Аяанаосу, Ойдов, Сафронов нарын асуудлыг хэн хариуцаж байгааг надад хэлж өг! Би тэднийг аварч, суллуулах ёстой юм гэдгийг анхаарах хэрэгтэй шүү гэж энгийн байдлаар хэллээ.

- Юки тэдний төлөө санаа зовох хэрэггүй. Би түр хорионд байлгаж байгаа болохоор хэн ч тэднийг миний зөвшөөрөлгүйгээр байцааж энэ тэр гэхгүй. Харин намайг тэдний ажлыг удирддаг эзэнтэй уулзуулж өгсөн үед би бүх зүйлийг нуулгүй ярина.

- Тозияа, тэгвэл тэдний амь нас, бие сэтгэл, эрүүл мэндэд ямар ч хор хүргэхгүй гэдэг талаар албан ёсны баталгаа гаргаж өгөх болно. Тийм нөхцөлд та, тэдний ажлыг удирдсан хүнтэй уулзаж болно.

Тозияа Юкийн энэ үгэнд сая хөлд орж байгаа хүүхэд шиг баярлана. Гэсэн ч сэтгэлд «Энэ өрөөнөөс гарч чадвал бүх хэрэг миний санаснаар болно. Тэгээд эд миний гарт орох нь тэр!... Үгүй ээ. Бодох хэрэгтэй. Өрөөндөө очоод ширээн дээрх товрууг дарахад юу байхав. Харин хожим яах вэ? Би өөрөө тагнуулын баримт дамжуулсан хэрэгт унаж хэрэгт холбогдвол яах вэ? Энэ чинь яаж ч болохгүй зүйл. Ялангуяа Уэдагийн нууцын түлхүүрийг алдах боломжийг би тавьж өгсөн! Энэ хэцүү!» гэж бодоод айлаа. Тозияа, өрөөндөө орж ширээний товрууг дарвал штабын жижүүр тэр дохиог авангуут цэргүүдээ Тозияагийнх руу явуулна. Тозияа эднийг барилаа гэхэд хоёр цагийн дараа кэмпэйтэйн төлөөлөгч Уэда дээр орж Тозияаг барих баримтаа танилцуулна.

Тозияагийн ятгалганд орж архидаад түлхүүрээ алдсаныг мэдэнгүүт Уэда, Тозияаг барих тушаал өгөөд өөрөө жанжин штаб руу ярьж өөрийгөө цагаатгах бүх зүйлийг хийнэ. Ингэхээр Тозияа, ширээний товрууг дарна гэдэг өөрийгөө хөөдөх зүйлийг хийх гэж байгаа хэрэг!» гэж бодоод «надад цаас» гэж хэлэх гэсэн боловч Юки ширээн дээрээс цаас аваад,

- Та баталгаагаа миний өрөөнд бичсэн дээр биз дээ гэх нь цаанаа ёжтой болохыг мэдээд «Эд чинь миний өрөөнд байгаа штабтай холбоотой дохиог хүртэл мэддэг байх нь ээ» гэж бодоод цаасыг авч баталгаа бичээд,

- Энэ баталгааг хэнд гэж хаяглах вэ? гэж асуулаа.

- Данжуур дахь японы армийн хуйвалдааныг илрүүлэх "Рожуганукай" ажиллагааг удирдаж байгаа Рожусайд гэж хаяглачих гэхэд Тозияа, Юки руу сүрхий хараад биеэ барилаа. Хоёр цаг шахмын өмнө Аяанаосугаас олдсон бичигт Рожусай гэж бичсэнийг эргэцүүлбэл тэр нь Аяанаосугийн удирдагч болох нь илт боллоо. Тозияа, монгол оросын тагнуулын бүлэг илрүүлсэн боловч түүнийг яаж ч чадахгүйгээ бүрэн ойлголоо. Тозияагийн бодлоор бол Юки, баталгааг аваад эзэндээ утсаар мэдэгдэж, түүнийг дуудах ёстой аж.

Юки Тозияаг гэртээ үлдээгээд явахгүй нь мэдээж! Юки баталгааг уншаад,

- Би үүнийг албан ёсны гэж үзээд зарим зүйлийг эрхийнхээ дагуу тодруулж өгье. Намайг хошууч Сайнжаргал гэдэг. Манай улсын тусгаар тогтнол аюулгүй байдлыг сарниулах гэсэн японы армийн генералуудын сэдсэн хуйвалдааныг илрүүлэх ажиллагааг удирдаж байгаагийн хувьд таны болзлыг хүлээн авлаа. Тиймээс болзлын дагуу би өөрийнхөө хүмүүсийг суллуулан авах ёстой! Түүгээр барахгүй тэдний ажиллагааг сэжиглэсэн хүний нэр, хаягийг танаар гаргуулж авах эрхтэй. Үүнийг та надаар хэлүүлэлтгүй мэднэ гэхэд Тозияа, диван дээрээс бослоо. Тэгээд ямар нэг юм хэлэх гэсэн шиг уруулаа хэсэгхэн өмөлзүүлснээ,

- Юу? Чи эднийг удирдаж байсан хэрэг үү? гэж арай ядан асуув. Тозияа өөртөө итгэж ядсан харцаар Юкийг харж алмайрахдаа «Ямар аймаар юм бэ? Сайнжаргал тэр тагнуулуудыг удирдаж байсан гэж үү? Би тэр жил үүнийг чинь эхтэй нь хамт устгаж болох байсан. Би тэгээгүй. Үүнийг чинь би өөрөө холын хамаатан дээр нь аваачиж өгч билээ. Тэгэхэд доожоо муутай чөргөр охин байсан... Би эхтэй нь хамт устгаж байхгүй даанч яав даа» гэж бодохоос дотор нь харанхуйлна. Тозияа, чингэж зогсохдоо тэр чөргөр охин хожим зүрх сэтгэлийг нь шимшрүүлсэн ийм хавханд хийчихээд өмнө нь ингээд зогсож байх юм гэдгийг яахан мэдэх билээ. Тэр үед Тозияа, монголд тагнуулын ажил үүсээгүй, түүний урлагийн талаар ямар ч мэдлэггүй гэж бодож байсан болохоор үндэсний үзэл мах цусандаа шингээсэн Цэен гүний охины үзэл санааг чингэж өөрчлөөд тагнуул болгочих юм гэдгийг бодох нь атугай зүүдлэх ч аргагүй байсан.

...Ардын журамт цэргийг хүрээнд ирсний дараахан Сүхбаатар Нанзадыг дуудаж тусгай даалгавар өглөө.

- Нанзад аа, Баяр гүнтэй холбоотой байсан цахрууд Богдтой нууцаар харилцан, ардын нам, засгийг устгах хуйвалдаан зохион байгуулж магадгүй байна. Чи Богдын хаалгачтай уулзаад энэ хадгийг барьж «Намайг мэнд лавлуулаарай» гээд нэгэн соном хадаг өгөөд,

- Ардын засгийн эсрэг чиглэсэн эсэргүү ажиллагаанууд Богдын сонорт хүрэлгүйгээр гарахгүй. Тиймээс хаалгачтай нягт холбоотой байх нь чухал! гэж даалгав.

Нанзад нэгэн шөнө Богдын хаалгачийнд бараалхаж, өнөө соном хадгаа барихад, хаалгач хадгийг авч үзсэнээ хэсэг дуугүй суухдаа уруул нь хэдэнтээ өмөлзөв. Тэгээд гүнээ санаа алдаж сэтгэлээ тайвшруулаад,

- Жанжинтны лагшин сайн, ажил алба нь өөдрөг биз дээ гээд хадгаа орныхоо толгой дээр

тавиад,

- Жанжинд тун сонор сэрэмжтэй бай гэж хэлээрэй. Аягүй бол амь насаа алдаж мэдэх юм. Богд тун «урт гартай» хүн! Цахар гүн Жамц, Дорж тайж Тогтох зэрэг хүмүүс Богдын ордонгоор эргэлдээд байгаа. Ер нь Баяр гүний хашаа байшинд үлдсэн нэгэн түшмэлээр дамжуулж ихээхэн буу зэвсэг цуглуулаад байгаа. Хүрээнд суудаг түвд хүмүүсийг Саж лам ятгаж хөдөлгөх янзтай байгаа учраас Баяр гүний цахрууд хүчин хавсарч магадгүй. Нөгөө талаар Богд, бадарчин Бадрахыг урагшаа хятад руу явуулах янзтай байгаа. Хатанбаатар, жанжин хоёрын хэн хэн нь Бадрахыг танина. Тэдний хэн нэг нь уулзвал нарийн юм ярих байх гэлээ. Нанзадыг явах гэж байтал хаалгач орны толгой дээрээс өнөө соном хадгаа авч Нанзадад буцааж өгөхөөр нь тэрээр учир холбогдлыг лавлажээ.

- Би ганц хүүтэй байсан юм. Түүнийг Норов гэдэг сэн. Богдыг гаминд баригдсаны дараа би нэг удаа цай хоол хүргэж өглөө. Богд надтай уулзаад Саж ламтай уулзаж гамингийн гараас салгахыг бод! гэж айлдлаа. Би гэртээ ирээд хүүгээ Саж ламынх руу явууллаа. Ингээд Богд, Саж лам, Барон гурвын холбоог Норов минь дамжуулдаг болсон. Барон хүрээнд ирсний дараа Норовыг өөртөө авч монгол цэргийн зуут захируулсан юм. Тэгээд хүрээнээс явахад нь би хүүдээ энэ хадгийг тарнидуулж өгөөд буунаас нь зүүлгэхдээ «Хүү минь монгол улсынхаа төлөө бие хайргүй зүтгэж яваарай» гэсэн юм. Миний хүү Бароны тарыг таниад ардын журамт цэрэгтэй нийлэх гэж байгаад нэг цагаантны хурандааг барьдгийн даваан дээр өөрөө баригдаж тамлуулжээ. Гэтэл улаан цэргүүд түүний амийг авраад Дээд-Үд рүү явуулан орос эмнэлэгт хэвгүүлж эдгээсэн байлаа. Норов минь тэгээд буцаж ирээд баруун замын байлдаанд явж байгаад дахин шархдаад шархныхаа халууныг даагаагүй юм гэсэн гээд хаалгач санаа алдав.

...Норовыг нас барахын өмнө жанжин уулзжээ. Тэрээр нэг хадаг, захиа хоёрыг өгөхдөө «Жанжин минь үүнийг өөрийнхөө гараар миний аавд өгөхийг хичээгээрэй» гэжээ. Жанжин хожим надтай уулзаж захиа хадаг хоёрыг өгсөн хүү минь захиандаа «Монгол улсынхаа төлөө зүтгэнэ гэдэг өөр юм байна. Ардын журамт цэрэг бол жинхэнэ монголын ард түмний төлөө, бидний тусгаар тогтнол эрх чөлөөний төлөө амь биеэ хайрлалгүй тэмцэж яваа хүмүүс шүү. Та монгол орноо, ард түмнээ гэж боддог бол ардын нам, засагт хүчин зүтгээрэй» гэсэн байлаа. Би жанжинд өөрийнхөө учир байдлыг ярьж «Би нас дээр гарсан, шашинд сүсэглэж ухаанаа төөрөгдүүлсэн хүн. Бурууг ухаарав ч гавьяа байгуулах насгүй болжээ. Жанжин болгоовол миний хүүгийн хадгийг авч, ачийг бодож, тусыг хичээж надад сургаал айлдаж хайрла» гэж гуйсан юм...

Нанзад хаалгачийн үгийг анхааралтай сонсоод жанжинд айлтгажээ. Жанжин Бадрахыг Мугдэнгээс буцаж ирсний дараа биеэрээ уулзаж ярилцав. Чингээд Бадрах, Хатанбаатартай уулзсаны дараа Сайнжаргалтай танилцаж, уулзах ярилцах далим гарган, дотно үерхэх болсон. Нэг удаа Сайнжаргалтай гудамжинд дайралдаж хашааны нь үүдэнд хүргэж өгөөд,

- Сайнжаргалаа, чи яая гэж бодож байна вэ? гэлээ.

- Бадрах аа, үнэнээ хэлэхэд би, яахаа мэдэхгүй байна. Аав минь Богдод итгэсэн итгэлдээ захирагдаад жинхэнэ үнэнийг олж хараагүй бололтой. Би сая нэг багштайгаа дайралдлаа. Тэр хүн надад манж, хятад япон хэл зааж байсан юм. Тэр багш минь Богдын талаар ярьж

байснаа нэг сонин юм дуулгалаа. Багш минь дайчин вангийн нэг хамаатны танил юм. Богд хаантан, цагаан хаант оросоос элэг буруулж японы эзэн хаантай харилцах болсныг Ханддорж ван мэдсэн юм байж. Тэгээд нэг удаа Богдтой муудалцаад өөрийн хамаатан дархантайгаа уулзжээ. Ханддорж чин ван өөрийнхөө улс төрийн бодлогыг тайлбарлаад «Да ламын оронд Сайн ноён ханыг бүгдийг захирагч сайд болгосонд өширхөж зандаг боллоо. Өөрийнхөө эрх дарх болон хаан ширээгээ монголын язгууртны үр хүүхдэд алдахгүйн тулд ямар ч хүнийг цааш нь харуулж мэднэ. Би ч Богдын гарт үхэхгүй юмсан гэж бодож байна, Ер нь Богд, хятадуудын гарт өртөхгүй байвал зүгээр юмсан. Чи надад дээлийн товч хийгээдэхээрэй гээд хорин лан мөнгө өгөөд явжээ. Тэгээд хэд хоносны дараа ирээд товчоо авахдаа нэг юм өгөөд «Үүнийг товчинд хийгээдэх» гэжээ. Дархан өгсөн юмыг ажиглаад хор байхаар нь буцааж өгөөд «Би ийм нүгэл хийж чадахгүй» гэжээ. Гэтэл Чин ван уурсаад «Чи тэгээд намайг богд, хятад хоёрын гарт үхэг гэж бодоо юу» гэж загнажээ. Тэгэхэд танил дархан нь «Хүний нутагт байгаа тэнэмэл улсууд тийм юм бодож байхад та өөрийнхөө амийг хорлох гэж явдаг зөв үү? Монголд төдийгүй гадаад улсад нэр төртэй хүний нэг, Богдын чинээтэй юм бодохгүй ингэж явбал монгол туургатныг хэн хамгаалах болж байна. Цувж явсан бар шиг хүний идэш болох хэрэг үү? Тэгвэл монгол орныг нэг талаас цагаан хаан, нөгөө талаас хятадын генералууд, тэдэнтэй өрсөлдсөн рийбин хамаг баялгийг нь хүн ардтай нь хувааж иднэ дээ! Амиа хорлохоос өмнө үүнийг бод!» гэж загнасан байна. Үүнээс хойш дайчин ван, Богдтой илэрхий тэмцэлддэг болсон гэнэ. Үүнийг сонсоод аав минь монгол орны төлөө биш харин монгол орныг минь хувааж залгих гэсэн хүмүүсийн гарт өртсөн байна.

- Сайнжаргалаа чи, үүнийг эргэцүүлэн бодож чадсан юм чинь жанжинтай уулзвал бүүр их юм ухаарах болно. Чи тэгээд хэзээ уулзъя гэж бодож байна вэ? гэж тулган асуулаа.

- Мэдэхгүй. Жанжин төрийн алба ихтэй. Тийм хүний хайран цагийг дэмий гарздаад яах ч билээ. Ажилд нь хар дараа болно шүү дээ!

- Чи тэгж бодож болохгүй. Ард түмнийхээ аз жаргал, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө шударга хүн бүхэн бие, сэтгэл, мэдлэг боловсролоо зориулах ёстой гэж хэлсэн жанжны үгийг чи сонсоо биз дээ!

- Жанжин хүрээнд ирсэн тэр өдрөө хүрээ цамын талбай дээр босгосон индрээс тэгж хэлснийг сонсолгүй яахав гээд хэсэг бодсоноо, Бадрахаа, чи жанжинтай хэзээ уулзуулахаа шийднэ биз. Би чиний үгнээс зөрөхгүй шүү гэж билээ. Сайнжаргал, жанжинтай уулзаж гурван цаг гаруй ярихдаа амьдрал ахуй, ёс суртахууны харанхуй манан дунд оюун санаагаа төөрөгдүүлж, мэдлэг боловсролоо явцууруулж, зөвхөн бор хоног өнгөрөөж явснаа ухаарсан төдийгүй эх орон, ард түмнийхээ төлөө бие, сэтгэлээ зориулсан хүн, нам төрийн өмнө ямар үүрэгтэй байдаг хийгээд улс орныхоо тусгаар тогтнол, бадрал хөгжлийн төлөө амьдралаа зориулдаг тавилантайг ухаарчээ. Чухам ийм л үйл хэрэг хүн болж төрсөн алдар нэрийг тодорхойлдог агаад аз жаргалыг нь нээж өгдөг ажээ. Сайнжаргал чингэж өөрийнхөө амьдралыг нам улсын үйл хэрэгтэй холбож чадсанаар Богд түүний гар хөлийн хүмүүс япон, хятадын цэргийн эрхтнүүдтэй хуйвалдаж ардын нам, засаг төрийг устгах гэж байгаа хуйвалдааныг илрүүлэх үйл хэрэгт өөрийн мэдлэг боловсрол хийгээд амь биеэ зориулахад хүрэх чухал үүрэг хүлээснээ юунаас ч илүү ухамсарлаж байлаа.

Сайнжаргал зүүн умард хятадад байгаа японы цэргийнхэн хийгээд хятадын генералуудын

цэрэг улс төрийн хуйвалдааныг илрүүлэх даалгавраа биелүүлэх бэлтгэл ажлаа дуусаж явахын өмнө жанжинтай уулзжээ. Бэлтгэл ажлын хугацаанд Бадрах сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн төдийгүй өөрийнхөө мэдлэгээр туслав. Тэрээр Богдын ордонд байдаг ч гэсэн сэтгэл санаанд нам, улс, ард түмэн гэдэг бодол шингээд түүнийхээ эрч хүчээр зүрх нь цохилж байлаа. Бадрах, Сайнжаргал хоёр жанжнаас авсан үүргээ биелүүлэх ажиллагааны талаар сэжиг төрүүлэхгүйн тулд ил үерхдэг болсонд Богдод тааламжтай байсан төдийгүй түүнийг эцэг рүү нь явуулах талаар Бадрахтай ярьдаг болжээ. Чингээд хүрээнээс Сэцэн хан аймгийн Үйзэн вангийн нутагт байдаг Алтан Очиртын хийд рүү гарахдаа Бадрахтай сүүлчийн удаа уулзсанаас хойш эдүгээ арван долоон жилийн турш сэтгэлдээ түүнийг хүсэн бодож явдаг болсон ажээ...

Юки хэмээгдэх Сайнжаргал энэ бүхнийг эгшний төдийд бодсоноо,

- Тозияя, та миний хэлсэн бүхэнд гайхах хэрэггүй. Таны зүтгэлтэй шавь Симоно, та хоёр японы цэргийн яам, жанжин штаб болон квантуны армиас манай орон болон зөвлөлтийн алс дорнод руу чиглэсэн хорлон сүйтгэх, тагнуулын бүх ажиллагааны баримтаар биднийг хангаж байсан юм. Ингэхээр та хоёрыг манай эчнээ тагнуул гэж үзэж болно. Иймээс Рожуганукай ажиллагааг удирдаж байгаагийн хувьд танд үүрэг өгөх ёстой гэхэд Тозияя лагс тарган биеэрээ диван дээр писхийтэл суугаад духаараа чийхарсан хөлсөө арчихад хуруунууд нь салгалан чичирч байлаа. Тэгээд нүдээ хэдэнтээ хий бүлтэгнүүлснээ,

- Аяанаосу, Сафронов хоёрыг тагнуул гэдгийг надаас өөр хүн мэдэхгүй. Тэр хоёрыг түр хорьсон боловч тэднийг хэн ч байцаах, эрүүдэх эрхгүй. Харин Ойдовын хувьд гэвэл Ханширээгээс ирсний дараагаар баривчилъя гэж бодож байсан гэхэд түрүүнээс хойш түгшин харанхуйлж байсан Сайнжаргалын сэтгэл сая онгойлоо. Тозияагийн үгний алдаа, зөрөөнөөс Сайнжаргалын ойлгосон нэг зүйл бол тэднийг мөрдөөгүй нь илэрхий. Тозияя, тэдэнд тулгах баримтаа Сайнжаргалаас дуулаагүй цагт тэдний хэнийг ч байцааж чадахгүй гэдэг нь илт болой. Тиймээс Тозияя, Сайнжаргалтай ярилцахдаа худлаа зүйлээр цохин асууж байгаа нь Сайнжаргалын хувьд инээдэмтэй өчүүхэн зүйл байжээ.

- Тозияя, баталгаанд хүлээсэн үүргийн дагуу тэднийг суллах гарын үсэг хийж өг! гэхэд Тозияя урдаа байсан цаасан дээр хэдэн зүйл бичиж гарын үсэг зурлаа. Сайнжаргал, Тозияагийн бичгийг уншиж байтал Банди, Тогтох хоёр хажуугийн өрөөнөөс орж ирлээ. Сайнжаргал Тозияагийн бичгийг нарийвчлан шалгахдаа «Ямар ч таних тэмдэг, болзмол дохио алга байх шиг байна. Тэгээд ч одоо Тозияя биднийг баривчилж хэргээ хүндрүүлээгүй нь мэдээж. Энэ хүн аминдаа хайртай!» гэж бодоод,

- Үүнийг аваад штабын жижүүр дээр очоод тагнуулын газрын даргад өг! Хэрвээ итгэхгүй бол утсаар ярь гээрэй гээд Бандид өгч явуулав.

Тозияя, одоо Сайнжаргалын гараас гарах замгүй болжээ. Тэгээд үхнэ гэхээс аймшигтай санагдана. Тэрээр яаж ч бодсон амьд гарна гэдэг найдваргүй зүйл. Харин түүний санаанд эргэлдэж байгаа олон бодлоос «Нэр төргүй үхэж болохгүй» гэдэг бодол юунаас ч илүү сэтгэлийг нь эзэмдэн шаналгана. Тозияя, квантуны арми сүйрэлд орж, удирдлагууд өөрчлөгдөх нь илэрхий болсон үед өөрөө хариуцлагад татагдаж нэр төрөө алдах нь гэж айж байсан. Гэтэл монгол оросын тагнуулуудын бүлэглэлийг илрүүлэх эгзэг гарч, түүний хувь

заяаг сайн сайхнаар шийдвэрлэх завшаан олдсон. Гэтэл энэ бүхэн бас бүтэлгүй зүйл байсан аж. Тозияа чингэж аргаа барж суутал утасны хонх дуугарлаа. Сайнжаргал утсаа аваад,

- Байна уу? Хэнтэй ярих вэ? Аавтай юу? Аав халуун усанд орж байна. За тэгвэл ааваас асуугаадахья гээд утасныхаа яриа дамжуулагчийг алгаараа дарж таглаад,

- Штаб дээрээс тагнуулын газрын дарга ярьж байна гээд утасны чагнуурыг чихэндээ ойртуулаад,

- Байна уу? Ааваас асуулаа. Жижүүрийнхэнтэй хамт наашаа явуулчих гэж байна гээд утсаа тавилаа. Тэгээд хэдэн агшин өнгөртөл гаднаас Тогтох орж ирлээ.

- Тогтохоо, штабын жижүүр Аяанаосу, Сафронов хоёрыг аваад ирнэ. Үүдэн дээр тосож аваад зочдын өрөөнд оруулаад хүрээд ир гээд Тогтохыг гаргалаа. Ийнхүү хэдэн мөч өнгөрсний дараа Банди орж ирэхэд Сайнжаргал түүнийг өрөөндөө Тозияатай үлдээгээд гарлаа. Тэгээд Тозияагийн өрөөнд ороод,

- Тогтохоо, Сафроновыг дуудаадах гэлээ. Чингээд Сайнжаргал Сафроновтай уулзаж байдлыг асуугаад,

- Иван Степановичаа, Аяанаосуг маргааш зочид буудлаас хаашаа ч гарч болохгүй гэж хэл! Штабаас сураглавал өвчтэй гэдэг шалтгаанаар хойшлуулаад утсаар ярь гэж хэл! Та Ойдовыг иртэл манайд байх болно. Тэгэхдээ Аяанаосуд өөрөө хэлж байгаа юм шиг хэлээрэй гэхэд Сафронов толгой дохиод өрөөнөөс гарлаа.

Тозияа шөнөжингөө Юкийн өрөөнд байлаа. Тэр хоёр нэлээн нарийн зүйлийн талаар ярилцжээ.

- Сайнжаргалаа, та нар Уэдагийн өрөөний түлхүүрийн хэвийг яаж авч амжсан юм бэ? Тэр шөнө би өрөөгөө сайн түгжсэн байсан шүү дээ.

- Тозияа, таны өрөөний номын шүүгээ чинь нууц хаалга юм. Түүнийг Ойдовын өрөөнөөс л онгойлгодог юм гэж хэлэхэд Тозияа, Сайнжаргал өөд бас гайхсан нүдээр харлаа. Сайнжаргал энэ удаа цай оруулж өгөхдөө цайны хандтай гүцэнд нойрны эм их тунгаар хийж хольсноо хэлсэнгүй.

Тозияа Уэда хоёр цайгаа ууж дуусалгүй нойрссоны дараа Ойдов, өрөөнд орж түлхүүрийн хэвийг авсан болой.

Тозияа дахин дуугүй суухдаа «Рожусай» гэдэг үгийг дотроо эргэцүүлэн юу гэсэн үг юм бол гэж бодно. Тэрээр янз бүрээр эргэцүүлсний дараа энэхүү товлосон нэрийн эхний үе нь япон хэлний жар гэсэн тооны нэр Рокожиу гэдгийг хураасан хэлбэр гэдгийг ойлгоод Сайнжаргалын нэрийн эхний Сай үеийг залгажээ гэдгийг мэдэв. Гэвч үүнийг асууж зүрхлэсэнгүй. Тозияа бүх зүйлээ эргэцүүлэн бодсоны эцэст «нэр төрөө гутаахгүй» байх ганц боломж үлдсэнийг ойлгов.

Энэ бол өөрийнхөө зорилго, бусидо ёсондоо үнэнч зүтгэж явсныгаа баталж квантуны армийн ялагдалд ямар ч буруугүй гэдгээ нотлохын тулд эртний самурайн ёсоор өөртөө сеппуку үйлдэх зам байлаа. Тозияя, квантуны армийг ялагдалд хүргэсэн гол буруутан нь стратеги тактикийн ач холбогдлыг дутуу үнэлсэн цэргийн яам, жанжин штабын удирдлага гэдгийг нотолж, квантуны армийн удирдлага, түүний дотроос өөрийгөө ямар ч буруугүй гэдгийг амиараа гэрчлэх боломжтой гэдгийг ойлголоо. Тэгээд бусидо ёсондоо үнэнч зүтгэж, чанад сахиж явсныг Сайнжаргал болон бусад хүмүүсээр гэрчлүүлэх хэрэгтэй гэдгийг ухаарав. Тиймээс Сайнжаргалын асуусан бүхнийг хариулж өөртөө найдвартай боломж олж авах хэрэгтэй байлаа.

- Аяанаосу, Сафронов хоёрыг баривчилсан явдлыг сэжиггүй болгох нь чухал. Тиймээс тагнуулын газрын дарга, тусгай мөрдөнгийн дарга нартай хэрхэн тохиролцохоо бодсон уу?

- Бодсон. Тэр хоёрыг хэрэгт татах баримтыг чамаас гаргуулж чадахгүйд хүрвэл тэр хоёрыг дуудаад Аяанаосу, Сафронов хоёрыг тусгай ажиллагаанд оролцуулахын өмнө шалгасан юм гэж хэлээд армийн нууцыг хадгалах баталгааг тусгай хуудсан дээр бичүүлж, гарын үсэг зуруулах хэрэгтэй. Тэгвэл тэдний хэн нь ч энэ тухай хэнд ч хэлэхгүй. Тэр тусмаа өдийд илүү дутуу зүйлийг хэн хүнд ярьж болохгүй гэдгийг мэдэж байгаа.

Тозияя, үүр цайтал элдвийг бодлоо. Тэрээр эртний самурайн бусидо ёсыг ёсчлон мөрдөх хэрэгтэй байлаа. Тозияя энэ шөнө Сайнжаргалын өрөөний диван дээр унтжээ. Өглөө өрөөндөө Сайнжаргалыг орж ирэхэд Тозияагийн дэргэд сууж хоносон Банди, Тогтох хоёр өрөөнөөс гарлаа.

- Би тагнуулын газрын даргыг дуудчихсан. Тэгэхээр тэр хоёрт Аяанаосу, Сафронов хоёрын талаар тайлбарлаж өгөх хэрэгтэй гэлээ. Тозияя, Сайнжаргалын бичгийн өрөөнд өглөөний цай ууж байхад өнөө хоёр нь ирлээ.

- Халх голын ажиллагааг мэдэж байгаа хүмүүсийн дотор урвалт гарсан учраас тэр хоёрыг шалгасан юм. Гэтэл Симото, энэ бүхний эзэн байсан байна. Тэгэхээр Аяанаосу, Сафронов хоёрын талаар хяналт хийх явдлыг зогсоосон.

Тэднийг Хөх хот руу тусгай ажлаар явуулах тул тэдний сэтгэл санааг гашилгах алхам хийж болохгүй гэж тушаалаа.

- Тозияя сан, өчигдөр Токиогийн кэмпэйтэйн удирдлагаас ярьсан. Симотогийн хүүрийг ч гэсэн ол гэж байна. Уэда санд танилцуултал тантай ярь гэж тушаасан гэлээ.

- Симото, Аяанаосуг сэрдээд байсан. Гэтэл бид жинхэнэ сэрдэх ёстой хүнээ алдчихаад байна. Би хэд хоногтоо ажилдаа очихгүй. Уэда сан ч намайг сураглахгүй биз. Шинэ командлагчаар Угаки сан ирэх сурагтай байна. Түүнийг жаахан хүлээх хэрэгтэй.

Тагнуулын газрын дарга Тозияагийн байгаа өрөөнөөс гарахдаа «Тозияя, Угакийн байдлыг харахаар шийджээ. Угаки ирээд царай өгөхгүй бол Тозияя нэр төрөө алдахгүйн тулд сеппуку үйлдэхээс өөр замгүй болно. Хэрвээ тэгэхгүй бол Симототой холбогдож нэр төргүй болно. Армийн сүйрэл бүхий ажиллагаанд өөрийгөө буруугүй гэж үзсэн самурай нар эртнийхээ

уламжлалт ёсыг баримталж сеппуку үйлдээд амьд гэрч үлдээдэг. Тэгэхээр штабын хэн нэгээр кайсяку (гэрч) болгох нь зайлшгүй. Ингэж сеппуку үйлдсэн дарга нарыг Ясакуни сүмд байгаа японы армийнхны сайдын хөшөөний дэргэд байгаа самбарт нэрийг нь мөнхөлдөг.

Тэгээд армийнханд хүндэтгэн дурсаж байх тухай тусгай тушаал гаргана шүү дээ» гэж боджээ! Харин Тозияа энэ бүхнийг шөнөжингөө тунгаасан болохоор сэтгэлдээ «Хойд насандаа тамд биш, диваажинд төрөхийн тулд бурхны шавийн ёсоор хойд насанд саад болох нүглээ цагаатгах хэрэгтэй! Ингэвэл үхсэн хойноо нэр төртэй, диваажинд жаргалтай байх болно. Тиймээс сеппуку үйлдвэл синто ёсныхоо шашны болон эр цэргийн бусидо ёсныхоо дагуу бэлдэх хэрэгтэй! Одоо бараг жар хүрэх гэж байна. Тэгэхээр хадан гэртээ нэр төртэй, хүндэтгэлтэй очих ёстой! Энэ хорвоод үлдэх ёстой сүнсэндээ нүгэл тарьж болохгүй» гэж шийджээ. Тэгээд өөрийнхөө саналыг Сайнжаргалд хэллээ. Сайнжаргалын гарт үхэхгүйг хичээсэн Тозияа, үүнээс сайхан замгүй болжээ.

Сайнжаргал, Тозияад өөрийнхөө хувийн өшөө хонзонгийн үүднээс биш нам, эх орон, ард түмний эрх ашгийн үүднээс хүлээсэн үүргийн дагуу харьцах ёстой гэдгийг хатуу ойлгодог болохоор,

- Би таны саналыг өөрийнхөө нөхөдтэй ярьж байж шийднэ гэхэд Тозияагийн царай хувхай цайгаад нүдэнд нулимс гүйлгэнээд уйлагнасан дуугаар гонгинон,

- Би танай ажилтангуудын амь насанд аюултай байдлыг зайлуулж чадсан. Тэгэхээр миний эцсийн хүсэлтийг ёсоор нь болгох ёстой бишүү гэв. Гэвч Сайнжаргал юу ч хэлэлгүй өрөөнөөс гарахад Тозияа ширээн дээр байсан архийг аваад шилээр нь хөнтөрлөө. Тозияа, зүрх сэтгэлээ шаналган шимшрүүлсэн аймшигт бодлыг дахин бодохгүйн тулд ингэхээс өөр арга байсангүй. Тозияаг архины аагинд нам цохиулаад ухаангүй хурхирч байсан тэр мөчид төвийн буухиа элчтэй уулзахаар явсан Ойдов буцаж иржээ.

- Сайнжаргалаа, Халх голын дайныг зогсоож квантуны армийг үг дуугүй бууж өгөх талаар Москвад хэлэлцээ хийж байгаа гэнэ. Дайны галыг зогсоох хил тогтоох асуудлыг газар дээр нь орон нутгийн цэргийн командлал шийдэх гэнэ. Төвийн буухиа элч танд бичиг өгүүлсэн гээд нэгэн бичиг өгөхөд Сайнжаргал түүнийг задалж нууц түлхүүрээр задлан уншлаа.

...Рожусайд. Рожуганукай ажиллагааны даалгасан үүргийг амжилттай биелүүлсэн танай бүлгийг байлдааны цусан гавьяаны одонгоор шагнасныг мэдэгдье! Рожусайгаас Төвд тавьсан асуудлыг хүлээн авч зөвшөөрлөө. Алтыг 9 сарын 14—16-нд буцах хаягаар хүлээж авна. Жич мэдэгдэх нь: Японы цэргийн яам, жанжин штаб болон сайд нарын танхим, фашист үзэл баримталж байгаа цэргийн генералуудын гарт орсныг харгалзан Аяанаосу хэмээгдэх Гунгааг квантуны армийн штабт ажиллуулах шаардлагатай. Тиймээс армийн шинэ удирдлага Аяанаосуд хэрхэн хандахыг судалж газар дээр нь шийдэхийг төв зөвлөж байна...

Азийн ард түмнийг төдийгүй дэлхийн олон орны ард түмнийг устгах бактерлогийн дайнд японы фашист генералууд бэлтгэж Харбинд томоохон төв байгуулсныг Рожусайн болон бусад мэдээ баримтаар баталсан төв, «Эрдэмтэн»гэдэг тусгай ажиллагаанд Аяанаосуг оролцуулж, тэдний хуйвалдааныг илрүүлэхийг чухалчилж байгааг Сайнжаргал хэрхэн мэдэх билээ.

Сайнжаргал шифрээр тайлж уншсан бичгээ шатаагаад олон жил хүлээсэн хүсэл мөрөөдөлдөө хүрч, нутаг орондоо буцах босгонд тулснаа мэдэв. Тиймээс ажил төрлөө маш нарийн тооцон тохируулах ёстой байлаа. Харин Сайнжаргалын сэтгэлийг түгшээсэн нэг зүйл бол Аяанаосуг үлдээх асуудал байлаа.

Сайнжаргал ажил төрлөө хэрхэн зохицуулахаа шөнөжингөө бодлоо. Алтыг банкныхантай байгуулсан гэрээний дагуух онцгой эрхээр буцах хоёр боломж бий. Түүнийг төвөөс «Буцах хаяг 1,11» гэж товложээ. Японы армийн төв команд-лал өөрчлөгдөж, квантуны арми ялагдал хүлээж удирдах ажилтангууд хариуцлагаас мултрахыг хичээж байгаа энэ үед алтыг авчруулах нь зохимжтой гэж үзлээ. Учир нь түүнийг мөрдөн мөшгөх ажиллагаа суларсан ажээ!

Сайнжаргал бүх бололцоог нарийвчлан үзвэл «Буцах хаяг-1» нь хугацаа их зарцуулах боловч найдвартай. Харин нөгөөх нь хугацаа бага зарцуулах боловч японы армийн хяналтын бүс нутгаар дамжих ёстой байлаа. Тиймээс нууцлан далдлах аргаа сайн хийж чадвал «Буцах хаяг —II» нь ашигтай байв. Сайнжаргал үүр цайтал ингэж бодоод өглөө нь өөрийнхөө төлөвлөгөөг Ойдовтой ярилцав.

- Сайнжаргалаа, ер нь Аяанаосутай ярьж байж шийдье гэхэд,

- За тэгвэл зочид буудалд очоод Аяанаосутай уулз гэж хэлээд,

- Сафроновыг үд хүртэл гадагшаа явсны хэрэггүй гээрэй гэж захилаа.

Ойдовыг явсны дараа Сайнжаргал Тозияагийн өрөөнд орж ирлээ. Тозияа, Сайнжаргалын хатуу хяналтанд байгаагаа мэдсэн боловч түүнд дургүйцсэнгүй. Тозияа эцсийнхээ горьдлогыг талаар өнгөрчих вий гэхээс айна. Тозияа өсөхөөсөө аваад өдий хүртлээ синто ёсны шашныг шүтсэн болохоор тамд унаж тарчлах вий гэхээс сүнс нь зайлчих шахна. Тиймээс хүлцэнгүй байхыг өөрийн зорилго болгожээ.

- Тозияа, Сафроновыг квантуны армид ажиллуулах хугацааг оросынхонтой хэрхэн тохирсон бэ?

- Тэднийх удаахгүй байхыг захисан юм. Гэхдээ Халх гол руу явах тул удаж магадгүй гэдгийг тайлбарласан. Ер нь тэд нар Сафроновыг манайд ажиллуулах дуртай байгаа.

- Сафроновыг энд тэгж удаах явдлыг яагаад чухал гэж үзсэн бэ?

- Хатогийн сэжгийг цайруулахын тулд тэгдэг юм. Сайнжаргалаа монголын тагнуулын байгууллага та нарыг ажиллуулахдаа Богдын алтанд түшиглэж байсан уу? Эсвэл өөр замаар санхүүжүүлдэг юм уу?

- Бидний хэн нь ч өндөр хөлс горьддоггүй. Харин энд зарцуулсан хөрөнгийн хувьд гэвэл ардын засгийг устгахын тулд миний эцгээр дамжуулж та бүхний гарыг цайлгахад зориулсан хөрөнгийг Мугдэн, Харбин, Синьзины япон банкны салбарт хадгалуулж арвижуулдаг. Ингэхээр японы банкнууд биднийг хөрөнгөжүүлж байгаа юм. Тийм замыг та, өөрөө зааж өгөөд эцгийн минь авчирсан зүйлийг борлуулж доллар болгож банкинд хадгалах аргыг, та сэдсэн биз дээ гэхэд Тозияа амандаа «Ёстой сүүхээтэй улсууд юмаа" гэж бодлоо.

Сайнжаргалыг Тозияатай ярилцаж байхад Ойдов орж ирлээ. Сайнжаргал Тозияаг, Тогтохтой үлдээгээд өрөөнөөс гарч Ойдовтой уулзлаа.

- Аяанаосу «Буцах хаяг—II» хувилбарыг хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Ялангуяа энэ ажиллагаанд Хар чоныг оролцуулах нь бүр найдвартай гэж байна гэхэд Сайнжаргал,

- Аяанаосу нэлээн нарийн зүйл сэджээ. Тиймээс чи өнөөдөр оройн галт тэргээр Харбинд очиж төвийн буухиа элчтэй уулзаад алт эрдэнэсийг Сулинхээрийн чиглэлээр гаргана гэдгийг мэдэгд. Тэгээд ажлаа, тохиролцоод 9 сарын14 гэхэд Харбин дахь бүх хадгаламжийг Мугдэн рүү шилжүүл. Бүх ажлаа дуусгаад 15 гэхэд Харбинд байж болохгүй! Төлөвлөлөсөн ёсоор нутаг буц! Радио станцыг Аяанаосуд үлдээх талаар ярилцаж тохир гэхэд Ойдов,

- Аяанаосу буцахгүй юм уу? гэж гайхан асуулаа.

- Ойдов минь Гунгаа гэртээ харина гэж их баярлаж байсан. Төвөөс ингэж шийдэхийг бидэнд зөвлөсөн болохоор өөр зам байхгүй! гэлээ.

Сайнжаргал үдийнхээ хоолыг Аяанаосу, Сафронов, Ойдов гуравтай идэв. Тэгээд ойр зуурын яриа дэлгэнэ. Үнэндээ энэ бол Рожуганукай ажиллагааг хэрэгжүүлсэн хүмүүс цуглаад ялалтаа тэмдэглэж байгаагийн зэрэгцээ Ойдовтой салах ёс гүйцэтгэж, үдэж өгч байгаа тэмдэглэлт өдөр гэдгийг Ойдов, Аяанаосу, Сафронов гурвын хэн нь ч үл мэднэ. Хоолны дараагаар Сафронов, Сайнжаргал хоёр хоолны өрөөнд үлдэж Ойдов, Аяанаосутай ажлаа ярихаар явлаа.

- Иван Степанович аа, би таныг Шанхай руу явуулахаас өөр аргагүй боллоо. Та тэнд очоод Гэрэлээ ажаатай уулзана. Таны гүйцэтгэх үүргийг ажаа хэлж өгнө гэхэд Сафронов,

- Гэрэлээ гуай амьд байгаа юм уу? гэж баярлан асуулаа.

- Бие нь бүүр эдгэсэн. Харин үүнийг чамд хэлээгүй өдий хүрсэн явдал манай ажиллагааг нууцлахтай холбоотой байсан юм. Тиймээс чи, намайг уучилна биз дээ. Гэрэлээ ажаа чамайг Шанхайд байгаа Эрхэмбаяр гэдэг хүнтэй уулзуулна. Шанхайд байгаа алтыг Хаалганд хүргэх асуудлын цаг хугацааг хэрхэн тохируулахыг ажаа мэдэж байгаа учраас тэнд тодорхой ярьж өгнө.

Сайнжаргал, Ойдовтой салах ёс гүйцэтгэж «Сайн явж хариарай. Удахгүй Улаанбаатарт уулзана. Харин тун болгоомжтой ажиллана шүү» гэж захиад Тозияагийн өрөөнд орж ирлээ. Тэрээр Сафроновыг Шанхай руу цэргийн тусгай онгоцоор явуулах талаар Тозияатай тохиролцох ёстой аж.

- Тозияа, таны хүссэн бүхнийг ёсоор гүйцэтгэхээр шийдсэн. Тэгэхээр та, хүссэн зүйлээ энэ байшинд хийж болно. Зочдын хажуугийн өрөө 18 метр ам дөрвөлжин. Ингэхээр бусидо болон синтогийн ёсоор сеппуку үйлдэх зан үйлд яг тохирно гэхэд Тозияа сэтгэлдээ залбираад «За ямай. Ямар ч байсан нэр төрөө сэвтүүлэхгүй, самурайн уламжлалт ёсыг сахивал миний хойчийн хувь тавилан, буяны замаар орж, бурхны бодь мөрийн хутгийг олох болно. Тиймээс Сайнжаргалын юу хэлснийг зөвшөөрөх ёстой! Хойдынхоо буян заяаны замд саад тотгор болох

зүйл хийж болохгүй. Тэгвэл хойд насны буян заяа гомдоод тамд унах болно» гэж бодоод «Сайнжаргал үүнийхээ далимд надаас юу шаардах бол?» гэж бодно.

- Тозияя, танаас нэг зүйлийг гуйя. Сафроновыг цэргийн онгоцоор явуулах тусгай үнэмлэх өгөөч. Тагнуулын газар ийм онцгой эрхтэй шүү дээ гэхэд Тозияя толгой дохин зөвшөөрлөө. Харакири үйлдэх нь нарийн дэс дараа самурайн үзэл баримтлалд үнэнч, цэрэг эрийн замналд бусидо, ариун нандин, шударга байж, эзэн хааны өмнө үүргээ биелүүлж байсныг батлах цэргийн дарга нар сеппуку үйлддэг болой. Самурай нар сеппукуг гэр орондоо үйлдэхдээ 12 ам дөрвөлжин даавуу бэлдэж түүнийгээ цагаан өнгийн даавуугаар хана шиг дөрвөлжин байдалтай засаад ёсоо гүйцэтгэнэ. Цагаан өнгө бол самурайн ёсонд гашуудлын өнгө билээ. Мөн өөрийнхөө үзэл баримтлал, тангарагтаа тууштай үнэнч байснаа батлахын тулд сеппуку үйлдэх ёстой самурай нэр синисозоку (үхлийн өмсгөл) гэж нэрлэдэг, цагаан торгоор хийсэн торгон өмсгөл өмсөх ёстой.

- Сайнжаргалаа, би жинхэнэ самурайн ёсоор сеппуку үйлдэнэ. Тиймээс надад синисозоку (сину—үхэл гэдэг үгээс гаралтай) бэлдэх хэрэгтэй. Нөгөө талаар намайг эзэн хааны мөнхийн үйлсэд үнэнч байсан явдлыг мөн бусидо ёсыг үхэн үхтлээ баримталсаар байсныг диваажинд очсон хойно үнэн зөвөөр тайлбарлаж өгөх хоёр гэрч кайсяку (кайшаку-тайлбарлагч, учрыг ойлгуулагч гэсэн үгнээс гаралтай) хэрэгтэй. Миний бодлоор бол тагнуулын газрын дарга, тусгай мөрдөнгийн дарга хоёр байвал болох нь тэр гэхэд Сайнжаргал тэднийг дуудуулав. Тозияя, өөрийнхөө нэр төрийг бодсон болохоор Сайнжаргалыг баллахгүй гэдэг нь илэрхий боловч Сайнжаргал хаширлаад хүмүүсээ зохион байгуулж, бэлтгэсэн аж.

Тозияя, гэрч кайсяку нартай уулзаж учир явдлаа тайлбарлахын өмнө,

- Тайса, Сафроновыг Шанхай руу явуулж, хар чонын үйл ажиллагааг шалгуулах нь чухал! Ер нь цаашдаа түүний ажиллагааг зогсоосон дээр. Юу ч гэсэн Сафроновыг өнөөдрийн дотор багтааж, цэргийн тусгай онгоцоор юмуу эсвэл тагнуулын албаны тусгай онгоцоор Шанхай руу явуул! Үнэмлэхийг нь шуурхай албаны шугамаар бэлдээд надаар гарын үсэг зуруул! Нөгөө талаар би та хоёрт самурайн тангарагийн дагуу нэг үүрэг өгнө. Эзэн хааны армийн нэр сүрийг гутаах алхам, квантуны армийн удирдлагаас шалтгаалаагүй.

Манай бүх дарга нар самурайн бусидо ёсондоо үнэнч байсан, түүнээс ганц ч алхам ухраагүй. Бидний нэр сүрийг ингэж гутаахад хүргэсэн алхмыг сайд нарын танхим, гадаад яамны ятгалганд орсон цэргийн яамны сайд, жанжин штабын дарга нарт оноох ёстой гэдгийг би өөрийнхөө амь насаар батлах болно. Тиймээс квантуны арми ялагдсан биш! Би өөрийнхөө бүх хөрөнгийг эзэн хааны армийн үнэнч дайчин, бусидо ёсоор Халх голд амь үрэгдсэн бүх цэрэг дарга нарын үйл хэрэгт гэрээсэлнэ. Тиймээс миний хөшөөг хүрлээр бүтээж Ясакуни сүмийн хашаанд мөнхлөхийг гэрээсэлж байгаа юм. Энэ учраас та хоёр миний кайсяку болно гээд сеппуку үйлдэх сар өдөр, цагаа хэлж өглөө.

Сайнжаргал, Тозияяг өөрийнхөө нэр төрийг аврахын тулд сеппуку үйлдэнэ гэдэгт итгэсэн боловч яг цагтаа яах бол гэж бодоод тагнуулын газрын даргыг өрөөндөө уриад,

- Би хөгшний чин зориг, ариун сэтгэлийг бодоод өрөвдөх юм. Тозияя сан, өөрийн шавь Итакийд итгээд Халх голын байлдааныг ялалтанд хүргэнэ гэдэгт их итгэдэг байсан. Би бас

тэгж бодоод урамтай байлаа. Тэгээд өөрийнхөө хүсэл мөрөөдлийг талаар өнгөрснийг мэдэнгүүт сүүлдээ Итагаки, Тозио хоёрыг харааж уур уцаараа барахдаа хэд хоног архидаад өөртөө сеппуку үйлдэнэ гэхээр нь хориглоод дийлсэнгүй. Болиулж болдоггүй юм уу? гэлээ.

- Гаккаг яаж ч ятгаад дэмий! Диваажинд одох хүний буяны замд саад тотгор хийхийг синто ёсонд хориглосон байдаг!

- Хөгшин өөрийгөө хий тамлачих бий дээ гэж бодоод өрөвдөх юм.

- Юки сан сеппуку бол харакири үйлдэж байгаа хүн шиг тарчилж, зовохгүйгээр нүд аньдаг өвөрмөц онцлогтой. Сеппукугийн ёсонд когайгаар гэдсээ бүлэнгүүт кайсяку нар шууд буудахаар тохиролцдог ёс байдаг юм. Гэсэн ч үүнийг хүн бүхэнд мэдэгдэх ёсгүй. Би чамд сэтгэлийг чинь зовоохгүйн тулд хэлж өглөө. Ингэдэг зан үйл бол маш өвөрмөц зүй тогтолтой. Өөрөөр хэлбэл өөрийнхөө үзэл баримтлал, сэтгэл санаа, зориг тэвчээр, мэдлэг боловсролоороо эзэн хааны кодо зарчимд үнэнч байсныгаа баталж байгаа хүний биеийг диваажинд саадгүй хүргэж, энэ ертөнцөд сүнснийг нь үлдээхийн тулд сеппуку үйлдэж байгаа хүнийг тарчилгаж болдоггүй юм. Тозияагийн сеппуку бол сайдын танхим, гадаад яам, цэргийн яамны болон жанжин штабын удирдах ажилтангуудыг буруутган яллах, Халх голын ажиллагаанд саад болж унагасан гэдгийг амь насаараа баталж байгаа самурайн үнэн итгэлтний цааз юм! Харин харакири бол өөрийнхөө үнэнч байх ёстой зүйлд хар буруу санаж, өөрийнхөө амласан тангараг, уламжлал бүхий хүндтэй ёс журмыг мулгуу, хүйтэн санаа сэтгэлээр зөрчиж нүгэл үйлдсэн хүн, өөрийнхөө нүглийг энэ насандаа эдэлж бие сэтгэлээрээ мэдрэх ёстой учраас хулсан, мохоо хутгаар өөрийгөө өөрөө тарчлааж, тамлаж, гэдсээ сийчин шаналгаа, өвчнийг нь мэдэрч, зовж байж нүд аних хуультай! Хөгшин бол гэдсээ бүлсэн өвчнийхөө зовлон, шаналгааг мэдэж чадалгүй хоромхон хугацаанд диваажинд залрах ёстой болохоор кайсяку нарт сэтгэлийнхээ эцсийн бодол санааг хэлж нууцлуулан хадгалуулдаг төдийгүй өөрийнхөө сеппуку үйлдсэн учир холбогдлыг мэдвэл зохих хүмүүст тайлбарлах гэрч, баталгаа болгодог ёстой гэж тайлбарлав. Тагнуулын газрын дарга Тозияагийн өгсөн эцсийн даалгавар ёсоор Сафронов тусгай үнэмлэх бэлдэж ирээд гарын үсэг зуруулснаас хойш хоёр цагийн дараа Сафронов Шанхай руу нислээ.

Тозияаг сеппуку үйлдсэний дараа квантуны армийнхан хүндэтгэлтэйгээр оршуулаад эзэн хаанд тусгай айлтгал илгээхдээ «Халх голын ажиллагааг унагахад цэргийн яамны сайд, жанжин штабын дарга нар саад болсныг чийү жёо (хошууч генерал) Тозияа, өөрийнхөө амиар баталж, сеппуку үйлдэж эзэн хааны кодо зарчимд үнэнч байсныгаа төгс нотлов» гэж үнэлжээ.

Сайнжаргал өөрийнхөө ажлыг төлөвлөсөн ёсоор зохицуулаад нэг өдөр армийн штаб дээр очиж тагнуулын газрын даргатай уулзаж Тозияагийн буяныг бодож, кайсякугийн үүрэг гүйцэтгэсэнд нь талархал дэвшүүлээд хоёр мянган иень барьж гарыг нь цайлгаад,

- Тайса (хурандаа), би ганцаараа гэртээ байхад хэцүү байна. Тиймээс Мугдэн рүү буцахаар шийдлээ. Би, Аяанаосу та хоёроос өчүүхэн зүйл гуйх гэсэн юм. Намайг явсны дараа миний барааг (ачааг) Мугдэн рүү явуулах талаар арга хэмжээ авч өгвөл зүгээр юмсан гэхэд хоёр мянган иень авсан хурандаа,

- Ачаа бараагаа баглачихсан бол одоо явуулж болно шүү гэхэд,

- Бүгдийг нь янзалчихсан гэж Сайнжаргалыг хэлэхэд хурандаа,

- Тэгвэл би, цэргийн тээврийн хэлтэс, галт тэрэгний буудал дахь төлөөлөгч хоёрт өнөөдөр багтаан явуулах тушаал өгөөдөхье. Та өөрөө хэзээ явах вэ? гэж асуулаа.

- Би маргаашийн онгоцоор явахаар болсон. Уэда сан цэргийнхэнд тушаал өгчихсөн байна билээ. Би одоо Аяанаосутай уулзаад харина. Та манайх руу утасдаад хэлчихнэ биз дээ гээд Сайнжаргал хурандаагийн өрөөнөөс гарлаа. Түүнийг Аяанаосугийн өрөөнд ороход тэрээр талархуу угтаж,

- Юки сан, та тийшээ суугаач гээд өрөөний диван руу урилаа. Сайнжаргал, диван дээр суухын өмнө гар цүнхээ уудалж, цоо шинэ аравтын доллар гаргаад,

- Би үүнийг задлуулах гэсэн юм гэж хэлэхэд Аяанаосу гайхсан нүдээр Сайнжаргалын царай өөд ширтэнэ.

...Гунгааг Буянтын нэрээр Манжуур руу явах тэр өдөр Дагва түүнийг Жанчивлин хийд хүртэл гаргаж өгөөд буцахдаа, цоо шинэ аравтын доллар гаргаж өгөөд,

- Чи Рожусайтай уулзах гэсний хэрэггүй. Та хоёрын харилцаа холбоочноор дамжих ёстой. Хэрэв онцгой хэрэг гарвал Рожусай өөрөө чамайг олж уулзана. Энэ долларын сүүлчийн тооны дараагийн дугаар нь Рожусайд байгаа. Рожусай чамтай уулзахаар очвол аравтын доллар гаргаад «Би үүнийг задлуулах гэсэн юм» гэж хэлэх ёстой. Чи түүнийг авч дугаарыг үзээд өөрийнхөө долларыг өгнө» гэж хэлээд хариу хэлэх үгийг нь хэлж өгч билээ...

Аяанаосу хэмээгдэх Гунгаа, Юки хэмээх Сайнжаргалын долларыг авч дугаарыг нь шалгасны дараа инээмсэглэсээр хэтэвчээ гаргаж өнөө аравтынхаа долларыг гаргаад,

- Би үүнийг задлуулж чадалгүй өдий хүрсэн юм гэлээ.

- Бид хоёр таарсан хоёроо. Уг нь би таныг хүлээх ёстой байсан гээд Аяанаосу нууц дохиог дэс дараалан хэлээд инээмсэглэв.

Эх орон ард түмний даалгавраар харь газар бурангуйн ёс дэглэмийг бие сэтгэлээрээ тэвчин арван долоон жил шахам болсон энэ эмэгтэйг хараад Гунгаа эчнээндээ бахархан, бишрэх сэтгэл төрж, хайрлан энэлэх сэтгэл нь өөрийн эрхгүй догдолсон тул амандаа "Рожусай» гэж шивнэж билээ. Тэрээр энэ нэрийг чингэж квантуны армийн албан тасалгаан дотор хэлэх ёсгүй билээ. Гэвч түүний баярласан сэтгэл өөрийн эрхгүй хэлүүлдэг ажээ.

Аяанаосу, Сайнжаргалтай Мүгдэн руу явуулах ачаа барааны талаар ярилцсаар түүнийг гаргаж өгөхөөр штабаас хамт гарлаа.

- Гунгаа минь биднийг нутагтаа буцах саналыг төв хүлээж авсан байна. Гэвч би чамайг үлдээхээр шийдлээ. Энд ганцаараа үлдэнэ гэдэг хэцүү! Гэвч бидний мэргэжил бол олон зуун мянган хүний сэтгэл, итгэлийг хүлээсэн, нам засаг, улс орныхоо хувь заяатай шууд холбоотой

учраас бидний хэн хэнд минь хувийн ашиг сонирхлыг бодох эрх байхгүй гэхэд Гунгаа,

- Би ойлгож байна гэж зориг эрэмгий хэллээ.

- Бид бүх боломжоо хянаж үзээд чиний гаргасан саналыг бололцоотой гэж үзсэн. Тиймээс Банди, Тогтох хоёрыг тагнуулын газрын тусгай албаны бүрэн эрхийн бичиг баримтаар Хаалган руу яаралтай явуулах хэрэгтэй. Тэд 9 сарын 12 гэхэд Хаалганд байх ёстой гэж хэлэхэд Гунгаа «Рожусайгаас» эцсийн даалгавар авч байгаагаа ойлгов. Сайнжаргал Гунгаатай салах ёс гүйцэтгээд,

- Чиний нэр дээр 150 мянган иень үлдээнэ. Үүнийг тагнуулын газраас сонирхож магадгүй. Тиймээс 100 мянгыг нь Шанхайд мөрийтэй тоглосон Эрхэмбаяраас гуйвуулж, үлдсэнийг нь Амисэгийн нэрээр гуйвуулна. Амисэ долоо хоногийн өмнө Дайрангаас Мугдэн орох гэж яваад галт тэргэнд хорлуулсан байна гэхэд Гунгаа,

- Үүнийг би сая сонслоо. Нөхрийнх нь даалгавраар кэмпэйтийнхан устгасан бололтой. Гэхдээ армийнхан Тогавагийн эртний өш хонзонд өртсөн гэдэг цуурхал гаргаад байгаа. Бодвол кэмпэйтийнхан өөрсдийнхөө ул мөрийг далдлах гэсэн хэрэг биз. Халх голд ялагдсан явдлыг Токиогийн сонингууд одоохондоо бичээгүй байна. Тиймээс Тогаваг баривчлах далим гаргахын тулд нөхөртөө хаягдсан Амисээг өширхөн устгасан хэрэгт холбогдуулж түүнийг баривчлах бололтой. Тогаваг далдалж чадвал сонингууд тодорхой зүйл Халх голын талаар хэвлэхгүй гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл сонин сурвалжлагч нарыг сүрдүүлж зүрхийг нь үхүүлэх гэсэн арга гэж учир явдлыг тайлбарлав.

Сайнжаргал, Гунгаатай чингэж ажил төрлийн талаар ярьж тохироод гэрийн зүг алхахад нүдэнд нь өөрийн эрхгүй нулимс бүрхжээ. Тэрээр хэдхэн мөчийн өмнө Гунгаад хүний нутагт үлдэх даалгавар өгсөн тэр эгшинд сэтгэлээ барьж чадсан атал «Хөөрхий минь хүн дүрстэй чонон сүргүүдийн дотор ганцаараа үлдлээ шүү дээ» гэж бодтол нүдэнд нь нулимс цайвартан манантав...

Сайнжаргалыг Мугдэнд ирсний дараа цэргийн төлөөлөгчийн газраас Харбин руу цахилгаан утас явуулав. Энэ бол Юкийг Мугдэнд ирснийг мэдэгдсэн цахилгаан байлаа. Хато цахилгааныг авангуут Харбинд ирсэн Ойдов бүх хадгаламжаа Мугдэн рүү шилжүүлж, Харбины төмөр замын удирдлагатай хийсэн урьдчилсан гэрээнүүдээ цуцалсан байлаа. Тэгэхдээ квантуны арми Халх голд ялагдсан явдлыг шалтаг болгосон явдлыг мэдсэн Хато сэтгэлдээ «Богдын алтны эзэд Мугдэн, Тяньжин, Шанхайн төмөр замын дагуу байрласан нь сэжигтэй хэрэг! Эрхэмбаяр хэмээгдэх Хар чоно тэнд байдаг? Эд нар алтаа Тяньжингийн банкинд шилжүүлэхгүй нь мэдээж! Тэгэхээр америк руу гаргахаар шийджээ. Үүнийг мэдэх нь чухал! Хэрвээ америк руу гарахгүй гэдгийг мэдэж чадвал Юкитэй харилцаагаа сайжруулж болно. Тэгсэн цагт бас Тозиягийн санааг хэрэгжүүлэх эгзгийг олж болно» гэж боджээ. Чингээд Хато, Шанхайд байгаа өөрийнхөө нөхөд рүү цахилгаан явуулж Эрхэмбаярын алхаа гишгээг ажиж байх тусгай үүрэг өгчээ.

...Намрын сар эхлэнгүүт Шанхайд орсон бороо зүсэрчээ. Эрхэмбаяр хэд хоногийн өмнө Сигэтотой уулзаж Тозияг таалал төгссөнийг мэдээд ажиллагаагаа зогсоох тухай санал тавьсанд тэрээр зөвшөөрсөнгүй. Ингээд Аяанаосугийн тө-лөөний хүнийг хүлээх ёстой

зоогийн газар ирж цонх ширтэн суухдаа «Ингэсхийгээд өнөө илжиг тэрэгтэй хятад ирнэ» гэж бодож байтал тас хар костюм өмсөөд, цагаан цамцан дээр эрвээхэй зангиа зүүсэн, гүн цэнхэр нүдтэй, ганган байрын нэгэн орос орж ирээд Эрхэмбаярын дэргэд буй сул сандалд суугаад халааснаасаа америкийн честрфильд хэмээх янжуур гаргаж тавиад,

- Өнөөдөр чинь хэд дэх өдөр билээ гэж монголоор асуулаа. Энэ хүн бол Иван Степанович Сафронов байлаа.

- Мягмар гариг биз дээ.

- Аа тийм нөгөөдөр хорин хоёр дахь пүрэв гариг байх нь гэхэд Эрхэмбаяр Аяанаосугийн төлөөний хүнтэй танилцав.

- Эрхэмбаяр гуай, Шанхай дахь алтны талаар ямар бодолтой байна даа гэж Сафроновыг монголоор хэлэхэд Эрхэмбаяр «Халхаар яасан цэвэрхэн ярьдаг орос вэ?» гэж бодлоо.

- Японыхон алтны талаар ямар ч баталгаа гаргаж чадахгүй гэж үзсэн. Гэхдээ америкийн худалдааны танхим банкныхнаас хяналтаа салгаагүй байгаа. Алтыг банкнаас мэдэгдэлгүй гаргах хэд хэдэн боломж бий. Хамгийн ашигтай нь гэвэл банкны хогийг аваачиж шатаадаг илжиг тэрэгтэй нэг хятад бий. Түүнийг ашиглах боломжтой. Одоо таван мөчийн дараа тэр харагдаж байгаа хаалгаар банкны хашаанд орох ёстой. Тэр тэрэгчин тогтоосон цагт ирж хогоо аваачдаг юм. Одоо ирэх цаг нь болжээ гээд банкны хашааны төмөр хаалга руу заалаа. Гэтэл удаж төдөлгүй илжиг тэрэгтэй нэг хятад гудамжны нөгөө талаас гарч ирлээ. Сафронов Эрхэмбаяртай цуг хоол идэж суухдаа энэ бүхнийг ажиглан, цаг хугацааг нь тэмдэглэн,

- Эрхэмбаяр гуай, хэрвээ бид энэ хятадыг ашиглаж алтаа хэнд ч мэдэгдэлгүй банкнаас гаргавал та маш яаралтай хугацаанд Хаалган руу явах болно. Өнөөдөр 9 сарын 5. Та арван хоёрон гэхэд хаалганд бэлэн байх ёстой. Хаалганы америкийн консулын байшингаас холгүй байдаг нарийн боовны дэлгүүрт таныг хоёр монгол залуу хүлээж байх болно. Та тэр хоёртой уулзаж ярилцаад «ачаа бараагаа» өвөр монголын Улаанцав чуулганы Баруун Согойн сүмд хүргэх болно. Өөрөөр хэлбэл тэр сүмээр монголын хил дээр очих юм. Тиймээс замаа буруулахын тулд Хаалганаас баруун Сөнөдийн Завсар, (Чансыр) хот хүрээд тэндээсээ Булт сүмийг дайрч Баруун Согойн сүмийн чиглэлээр хилд хүрэх ёстой. Хэдийгээр энэ зам найдвартай хамгийн дөт боловч Завсар хотод японы тагнуулын томоохон төв бий учраас нэлээн адармаатай. Гэхдээ нууцлалтыг сайн зохион байгуулж чадвал чоно үүрэндээ өлзийтэй байдаг шүү дээ. Гэхдээ бид алтыг Хаалганд хэрхэн хүргэх талаар банкныханд ямар боломж байгааг асууж, гэрээнд заасан бүрэн эрхийн дагуу Хаалганд хүргэж өгөх эсэхийг мэдсэний дараа шийднэ.

Завсар, Панчэн хотод байгаа японы тагнуулын газрын дарга нарын талаар надад тодорхой баримт хэрэгтэй байна. Тэгвэл энэ талаар арга бодож болно.

- Энэ талаар Хаалганд байгаа хоёр хүн танд маш тодорхой хэлж өгнө. Тиймээс тэдэнтэй ажлаа сайн ярилцах хэрэгтэй. Таны гол анхаарах зүйл бол Аяанаосугийн хүмүүсийг хамгаалж 15-ны өдөр гэхэд хил дээр хүргэсэн байх ёстой. Энэ бол цаад захын хугацаа. Тэднийг хүргэсний дараа та шууд Синьзин руу буцах ёстой гээд Сафронов, Эрхэмбаяртай

дахин уулзах өдөр цагаа болзоод зоогийн газраас гарч Шанхайн төв рүү алхлаа.

Сафронов Шанхайд ирэнгүүт Гэрэлээтэй уулзаад гадаадын худалдааны газрын бараа тээврийн зохицуулалт, төмөр зам, усан замаар зүүн умард хятад руу америк, английн пүүснүүд бараагаа хэрхэн хүргэдгийг судалж, Гэрэлээгийн нөхрөөс нэлээд зүйлийг сонсоод Сайнжаргалын өгсөн удирдамжийг «Буцах хаяг-11»-тай харьцуулж үзлээ. Тэрээр анхны хувилбар ёсоор Алтыг Тяньжинд усан замаар хүргээд тэндээсээ Бээжин Хаалганы чиглэлд төмөр замаар явах ёстой байлаа. Тиймээс Гэрэлээтэй уулзаж алт буцаах ажиллагааны талаар ярилаа.

- Алтыг Шанхайгаас гаргах анхны хувилбараар бол Тяньжин руу усан замаар явуулж японыхонд усан онгоцоор гаргалаа гэдэг төсөөлөл өгөөд Тяньжингаас төмөр замаар Хаалган оруулах асуудал юм. Ийм нөхцөлд би Тяньжин руу түрүүлэн гарч Эрхэмбаярыг Хаалган руу явуулах ёстой. Хаалганаас танай пүүсний итгэмжилсэн хүмүүс цаашаа явуулах унаа хөсгийг бэлдэх болно.

- Иван Степановичаа энэ тухай би бодож үзсэн. Ямар ч гэсэн японыхны анхаарлыг усан онгоц, төмөр замын тээвэр рүү чиглүүлэх хэрэгтэй. Гэхдээ банкны ерөнхийлөгчийн бие төлөөний хүнтэй уулзаж гэрээнд заасан онцгой эрхийн талаар тохиролцоогүй цагт энэ ажиллагааг эхлүүлж болохгүй гээд Гэрэлээ банкны төлөөлөгчтэй уулзахаар болзсон газар руугаа явлаа. Гэрэлээ үдийн хоолны цагийг тохируулж худалдааны танхимын зоогийн газар руу очлоо.

Зоогийн газрын эзэн Гэрэлээг хүлээн авч өрөөндөө зочилж суутал гаднаас өндөрдүү биетэй хижээл насны нэг хүн орж ирэхэд зоогийн газрын эзэн албан өрөөнөөсөө гарлаа. Энэ хүн бол Жон Клоусон ажээ.

Гэрэлээ дунд хуруунаасаа бөгжөө авч Жон Клоусонд өгөхөд тэрээр бөгжний шигтгээг сугалан аваад халааснаасаа томруулдаг шил гаргаж бөгжний шигтгээний таван суурийг ажиглана. Ноён Клоусон шигтгээн дэх нууц шифрийг тохируулж үзсэний дараа,

- Сарангэрэл гуай, бид алтыг зохих газар шилжүүлэх үүрэг хүлээсэн учраас гэрээ ёсоор алтыг хаанахын банкинд шилжүүлэхийг мэдэх ёстой! Тиймээс уул алтыг хүлээж авах банкны хаяг, даатгалын баталгааны талаар хэлж өгөхгүй юу? гэлээ.

- Бид алтыг бүгдийг нь гараараа хүлээж авна гэхэд Клоусон,

- Энэ чинь тун аюултай юм байна даа. Гэхдээ бид гэрээнд хүлээсэн үүргийн дагуу тэр алтыг хүргэж өгөөд шимтгэл авах ёстой.

- Алтыг шилжүүлэх нууцыг алдсанаас алтыг бусдын гарт өртөөвөл бид түүнийг алтаар нь төлөх учраас ямар замаар хаана гардуулж өгөх талаар тохирсон байх ёстой.

- Ноён Клоусон, бид алтыг танай тээврээр Хаалган хүргүүлмээр байна. Шимтгэлийн тухайд гэвэл өнөөдөр танай банкны нэр дээр Мүгдэнгээс мөнгөний гуйвуулга хийнэ. Иймээс 17 цаг гэхэд танайх шимтгэлээ бүрэн авсан байх ёстой гэхэд Клоусон хэсэг бодсоноо,

- Хагагтай Гэрэлээ гуай, бид алтыг өөрийнхөө нисэх онгоцоор Хаалганд хүргэж болно. Гэвч өөр нэг арга байна. Английнхан Хаалганд байгуулж байгаа хүнсний үйлдвэр рүү маргааш техник тоног төхөөрөмж тээвэрлэх ёстой. Тэгэхээр тэдний онгоцоор Хаалганд алтыг хүргэж болно. Харин таны сэтгэлд таацах уу? Үгүй юу гэдгийг би мэдэхгүй байна. Нэгэнтээ та нар алтаа авч байгаа болохоор түүнийг хамгаалах талаар ямар нэг арга хэмжээ авсан бол бидний энэ ажиллагаа түүнтэй уялдаж чадахгүй бол та нарт хүндрэлтэй болно гэхэд Сарангэрэл хэмээгдэх Гэрэлээ,

- Ноён Клоусон, тэгвэл бид өөрийнхөө нэг хүнийг тэр онгоцтой явуулна. Энэ хүн алтаа авч явах эрх бүхий хүн юм гэхэд Клоусон түүнийг зөвшөөрч Гэрэлээгийн төлөөний хүнийг английн онгоцтой хэрхэн явуулах талаар ярилцлаа. Гэрэлээг ийнхүү Клоусонтой ярьж байхад Сигэто өөрийнхөө нэг туршуултай ярьж байлаа.

- Сигэто сан, Эрхэмбаяр уржигдраас хойш хотод үзэгдэхээ больчихлоо. Байрандаа алга. Хотын нууц янхнуудын газрыг шалгасан боловч сураг гарсангүй!

- Эрхэмбаярыг хаана байгаа газраас нь ол! Хүүрийг нь ч олох ёстой. Одоо Акасайг дууд! гэж тушаалаа. Туршуулыг гарснаас хойш асар удалгүй Акасай Сигэтогийн өрөөнд орж ирлээ.

- Эрхэмбаярыг сүүлийн удаа хэзээ харсан бэ? гэхэд Акасай Сигэтоог сандрангүй байгааг ойлгоод,

- Өчигдөр орой усан онгоцны буудал дээр нэг хүүхэнтэй уулзаад зогсож байсан. Өнөөдөр банкны зоогийн газар үдийн хоолны үеэр очих ёстой. Гарриман тэр хоёр уулзах юм гэсэн гэж хэлэхэд Сигэто,

- Акасай, чи усан онгоцны буудал дээр очоод өчигдөр тэдний онгоцонд ямар хүн суусныг бүртгэлээр нь шалга. Би худалдааны танхимд очсон эсэхийг нь шалгана гээд дахин уулзах цагаа болзоод тарцгаалаа.

... Долоо хоногийн өмнө Сигэто, Хатогоос нэгэн цахилгаан авсан бөгөөд түүнд Эрхэмбаяр, Акасай хоёрын ажиллагааны явцыг илтгэхийг даалгасан байлаа. Сигэто цахилгааныг хүлээж аваад Юкигийн алтны сургаар бие биентэйгээ өрсөлдөж байгаа армийн генералуудын хооронд хов зөөсөн хэрэгт унаж магадгүй гэж болгоомжлоод дуугүй байхаар шийдсэн. Гэтэл одоо энэ хэрэг Сигэтоог хөдөлгөхгүйгээр баллаж мэдэх эгзэгтэй боллоо. Тэрээр Эрхэмбаярыг алдвал толгойгүй гэдгээ ойлгов. Тэгээд нэг туршуулаа дуудаж ярилцав.

- Өчигдөр орой америкийн усан онгоц далайд гарсан. Маргааш английн нисэх онгоц Хаалган руу тоног төхөөрөмж зөөх ёстой. Мөн америкийн нэг усан онгоц Кантон руу өнөөдөр гарах ёстой гэж худалдааны тээврийн хуваарийн талаар танилцуулав.

- Америкийн худалдааны бүх онгоцуудыг шалгах хэрэгтэй. Чухам ямар ачаатай, ямар хамгаалалттай явж байхыг мэдэх нь чухал гэж тушаав.

Сигэто, туршуулаа гарсны дараа Хатогийн цахилгааныг саналаа.

Юкигийн төлөөний хүмүүс Мугдэнд байгаа нь түүний анхаарлыг татав.

... Хато муу санаандаа алтаа ойрын үед шилжүүлж магадгүй гэж хардсан байсан. Тэгэхээр түүнийг ямар замаар Мугдэнд байгаа эзэнд хүргэх вэ? Банкныхныг манайхан сайн хянаж байгаа. Тэгэхээр алтыг банкаар гуйвуулахгүй. Мугдэнд тэр алтыг хүлээн авах том банк байхгүй. Тиймээс банкны гуйвууллагыг хүлээн аваад ор алтаар нь төлчих тийм бэлэн алттай томоохон банк байхгүй. Харин Тяньжин дахь английн банк алтны цахилгаан гуйвууллагыг хүлээн авч мэдэх юм.

Сигэтоог чингэж тархиа гашилгаж байсан тэрхэн мөчид Сафронов, Гэрэлээгийн заавраар америкийн худалдааны танхим руу явлаа.

Банкны хогийг ачсан илжиг тэрэгтэй хөгшин, банкны хашааны хаалгаар гарч ирээд, хогтой савныхаа ачлагыг татаж чангалаад гудамж руу гэлдэрсээр үдшийн бүрэнхийд ороод харагдахгүй боллоо. Түүнээс хойш цагийн дараа Сигэтогийн утасны хонх жингэнэв. Тэрээр утсаа авбал түүний нууц туршуулын чичирхийлсэн хоолой чагнуурт паржигнаж,

- Сая америкийн худалдааны усан онгоц, Янцзиныг уруудан Чунминда арлын чигт далайд гарлаа. Буудлын тавцан дээр саяхан банкны хог ачдаг илжиг тэрэгчний бараа харагдаж байснаа алга болчихлоо. Ойр хавиар хайгаад олсонгүй.

- Банкны дэргэд ямар нэг машин байсан гэнэ үү?

- Манайхан 15 цагаас хойш тэнд байгаа. Ганц ч машин үзэгдээгүй гэж байна. Харин илжиг тэрэгчин өнөөдөр гурван удаа хогоо зөөсөн гэнэ. Түүнийг зам зуур нь шалгахад сэжиглэгдэхээр юм байгаагүй. Банкныхны дотоод ажиллагааг ажиглаж байгаа хүмүүстэй уулзахад америкийн банкныхан өчигдөр өнөөдөр хоёр их цэвэрлэгээ хийж, архивынхаа хуучин бичиг баримтанд устгал хийсэн байна. Акасай болзсон цагтаа ирж уулзаагүй гэхэд Сигэто сэтгэлдээ "Эд нар чинь алтаа усан замаар Порт-Артур руу явуулчихав уу даа" гэж бодоод,

- Ажиглалтаа үргэлжлүүл гээд утсаа тавингуут туршуулуудын илтгэлийг дахин уншъя гэж бодлоо. Тэгээд хамгийн түрүүнд өнөө өглөө ниссэн Английн нисэх онгоцны барааг шалгасан мэдээллийг уншив.

... Английн нисэх онгоцонд Хаалганд барьж байгаа хүнсний үйлдвэрт тавих техник, тоног төхөөрөмж ачлаа. Харин онгоцыг хүргэж өгөхөөр худалдааны газраас хоёр хүн суусны нэг нь урьд өмнө английн худалдааны газруудаар үзэгдээгүй шинэ хүн байна. Холбогдох бичиг баримтыг шалгасан байдлыг хянавал Хаалганы үйлдвэрт очиж байгаа инженер Коппельман гэдэг герман хүн байсан. Гадаад байдал өндөрдүүхэн биетэй, гүн цэнхэр нүдтэй оросжуу царайны хүн байлаа.

Сигэто, мэдээллийг уншаад олигтой сэжиг гаргаж чадсангүй. Тиймээс квантуны армийн штабын тагнуулын газрын даргатай ярьж Эрхэмбаярын ажлыг хэн удирдаж байгааг лавлахаар залгуулав. Тэгээд нэг хурандаатай ярилаа.

- Би өчигдөр энэ ажлыг хүлээж авсан болохоор Эрхэмбаярын ажиллагааны талаар сайн мэдэхгүй. Түүний ажлыг шууд удирдаж байгаа хүн бол Аяанаосу гэдэг хошууч бий. Одоохондоо байхгүй байгаа гэхэд Сигэто, уур омогтоо шатаад,

- Тэр чинь бас оргочихоо юу? гэж асуулаа.

- Сигэто сан, чи юу яриад байна? Аяанаосу, Халх голын ажиллагааг зогсоох комиссын бүрэлдэхүүнд орсон. Хэрэг тохиолдвол тэндээсээ Токио руу явах ёстой. Үүнээс хойш болгоомжтой ярьж байгаарай гээд утсаа тавьчихлаа.

Сигэто бүүр алмайрлаа. Акасай бас алга болжээ. Тэгээд Акасайгийн сургийг яаралтай гаргахаар шургуу хөөцөлдсөний эцэст нисэх онгоцны буудлын байранд нэгэн хүнтэй уулзаж байсан сураг гаргалаа. Сигэто, Акасайг сүүлчийн удаа харсан консулын газрын ажилтантай уулзаж асуухад тэрээр уулзаж байсан хүнийг халти ажигласнаас цаашгүй. Тэр нь оросжуу царайтай өндөрдүүхэн биетэй цэнхэр нүдтэй хүн байжээ. Сигэто ийнхүү сандарч яахаа мэдэхгүй байсан боловч ухаанд нь "орос... Банкны нэг ажилтантай очиж уулзсан орос" гэж бодонгуут бас нэг мэдээллийг уншлаа. Энэ бол банкны үйл ажиллагааг ажиглаж мэдээ дамжуулдаг туршуулын илтгэл билээ. Тэгээд хоёр хоногийн өмнө өнөө өндөр оросжуу хүн банкны нэг нөлөө бүхий хүнтэй очиж уулзаад бараагүй болсныг мэдэв. "Орос, орос Английн онгоцонд суусан... Акасайтай уулзсан... банкинд очсон... орос" гэдэг бодол Сигэтогийн сэтгэлээс гарсангүй. Одоо тэдний мөрийг мөшгөөд нэмэргүй гэдгийг Сигэто ойлгоод Хато, Аяанаосу хоёрт хэрхэн илтгэхээ бодно.

Маш нарийн зохион байгуулжээ. Эрхэмбаяр, Акасай, Орос хүн цөмөөрөө оргох арга цагаа нарийн тохируулжээ. Бид нэгийг нь хөөж байхад нөгөө үлдсэн нь мөрийг нь баллаад оргож байсан байж таарлаа. Биднийг ёстой төөрөгдүүлж чадлаа. Ямар муухай санаатай новшнууд вэ. Тэгэхдээ бидний анхаарлыг усан онгоц руу хандуулсныг яана. Өнөө илжиг тэрэгчин бас эдний санаачилагаар зохион байгуулсан хуурамч зүйл. Түүнийг одоо худалдааны танхим, банкнаас асуувал тэр хүн чинь ажлаасаа гарчихсан. Одоо хаана байгааг мэдэхгүй. хуучин хаяг нь бидэнд байгаа гэж хэлнэ. Ингэхээр уржигдраас хойш хийсэн их цэвэрлэгээ, архивын устгалт цөм хуурамч, жинхэнэ зүйлийг далдалж нууцалсан баг. Сигэто ингэж бодсоор өглөө болгоод Хатоод илтгэхээр зорив. Тэгэхээр бүх асуудлыг болсон байдлаар илтгэхээр шийджээ.

- Гакка Хато сан, Юкигийн алтны учир олдохгүй байна. Тозияя саны даалгавраар ажиллаж байсан Эрхэмбаяр, Акасай хоёр алга болсон. Тэднийг хайгаад олоогүй. Тэд алтны сураг гаргаж чадахгүй болохоор зайлсан бололтой. Нөгөө талаар удирдаж байгаа хүнээ таалал төгссөн болохоор цөхөрсөн биз дээ гэж хэлэхдээ Аяанаосугийн нэрийг дурсахаас эмээжээ. Квантуны армийн тагнуулын газрын шинэ дарга Сигэтогийн зүрхийг шимшрүүлжээ. Тиймээс Аяанаосугийн нэрийг Хатоод ховлож болохгүйг ойлгоод хожим жанжин штабынханд нүд үзүүрлэгдэнэ гэдгээс айлаа. Хато, Сигэтогийн үгийг сонсоод яах ухаанаа олсонгүй. Генерал ингэж мухардаж байгаагүй.

Тэрээр Тозияя, Симото, Аяанаосугийн ажиллагаанд хяналт тавьж олсон баримтаараа Юкийг айлган сүрдүүлэх замаар өөртөө татна гэж тооцоолсон. Гэтэл Тозияя өөртөө сеппуку үйлдэж диваажинд одсон нь армийн шинэ удирдлага, сайд нарын танхимын шинэ сайд нар хуучин хүмүүсээ муулах замаар өөрсдийнхөө байр суурийг батжуулах далим болсон тул Тозияягийн

сеппуку үйлдсэн явдлыг орчин үеийн японы армид гарсан шинэ үеийн самурайн үлгэр дуурайлал гэж тунхаглаад армийн бүх удирдлагад Тозияагийн зориг хатуужил, бусидоод үнэнч чанарыг эрхэмлэхийг үүрэг болгожээ. Тэгээд зогссонгүй квантуны армийн шинэ удирдлага, Тозияагийн ганц шавьд Аяанаосуг оноогоод түүний алдар цолыг дэвшүүлэхээр зэхээд байлаа. Ингэхээр Юкийг айлгах гэсэн Хатогийн бодол талаар өнгөрчээ. Ялангуяа Шанхай дахь алтыг нарийн аргаар шилжүүлснийг мэдсэн Сигэто, түүнийг үнэнээр илтгээгүй учир Хатогийн сэтгэлд алтны сургийг алдлаа гэдэг сэтгэгдэл төрсөнгүй. Тиймээс Хато эцсийнхээ найдварт түшиглэн «Зугуухан замаар Юкигийн хөлд сууна» гэж бодоод Юки, Ойдов хоёрын хойноос хянаж байгаа нэг хошуучийг дуудаад,

- Харбин, Мугдэнд байгаа сүүл,сүүдрүүдээ Юки, Ойдов хоёроос салгаж болохгүй гэж тушаалаа.

- Гакка, тэр хоёрыг ор сураггүй алга болсон тухай сая мэдээлэл ирлээ. Юкигийн банкны хадгаламжийг шалгахад бүгдийг нь Шанхай руу шилжүүлсэн байна.

- Та нарын бүтэлгүй ажиллагаа надад ийм юм дуулгах байсан юм. Тэгээд чи Шанхай дахь өөрийнхөө хүмүүстэй ярилцав уу?

- Бүх асуудал их сэжигтэй байна. Шанхайд байсан Эрхэмбаяр, Акасай хоёр оргосон байна. Үүнээс үзвэл Сигэто танаас бүх зүйлийг нуусан байна.

- Тэгвэл энэ ч том хуйвалдаан болж таарлаа. Ийм хуйвалдааныг зохион байгуулж, өөрийнхөө хүмүүсийг нэг цаг мөчид зэрэг оргуулж ул мөрийг баллаж чадна гэдэг чинь жинхэнэ мэргэжлийн тагнуулчийн хэрэглэдэг шилдэг арга!

- Бүлэг тагнуулын эзэд өөрийнхөө үүргийг гүйцэтгэсэн явцад сэжиглэгдсэн хүмүүсийг аврахын тулд нэг цаг хугацаанд нууц байдалд оруулаад өөрөө хянаж байгаа хүмүүсийг ажиглаж гаргасан сэжгийг нь будлиантуулдаг номтой.

Хато өөрийнхөө шавийн төсөөллийг бодит байдалтай харьцуулж тунгаалаа. Түүний сэтгэлд Тозияа, Симото хоёр, Юки Ойдов, Эрхэмбаяр Акасай хоёр цугаараа зохион байгуулалттай юм шиг санагдлаа. Гэтэл Хатогийн сэтгэлд Аяанаосу, Сафронов хоёр буулаа. Ялангуяа Аяанаосуг анх монголын тагнуул гэж сэдэн нягталсан Симото урвагчийн замаар алга болсон хийгээд Сафроновыг сэжиглэсэн хамаатны нь үг генералын санаанд эргэлдэнэ. Ийнхүү бүгдийг эргэцүүлсний дараа Хатоод нэг боломж байгааг ойлгов.

- Хошуучаа, Акасай, Эрхэмбаяр, Ойдов, Юки нарын зургийг яаралтай олж зохих газруудад тараагаад Шанхай, Тяньжин, Мугдэн, Дайран, Порт-Артур зэрэг хотуудад тусгай шалгах хэсгийг гаргаж ажиллуулах тушаал бэлд! Нөгөө талаар английн онгоцонд суусан тэр оросжуу хүнийг дахин лавла! Ялангуяа гадаад байдал төрхөөрөө Сафроновтой адилсах зүйл байна уу гэдгийг гоц анхаар! Мөн өвөр монголд байгаа хээрийн цагдаагийн газарт тусгай цахилгаан явуул! Зам зуурын хүмүүсийг шалгах хэсгүүдийг гол гол замуудын дагуу гаргаж хоёр хоног тутамд илтгэж байхыг даалга гээд Хато Синьзин руу ярилаа. Тагнуулын газрын шинэ дарга эзгүй болохоор хэд хэдэн хүнтэй ярилаа. Гэвч тэдний хэн нь ч Хатогийн саналыг сонсох дургүй байлаа. Тэд цөмөөрөө хариуцлагаас мултрахын тулд «Түүнийг чинь сонсоогүй...

түүнийг чинь дуулаагүй... мэдэхгүй!... баримтгүй... баталгаагүй юм... надад шууд хамаарахгүй» гэдэг үгээр өөрснөөсөө холдуулаад байлаа. Тэгээд Хато аргаа барахдаа тагнуулын газрын шинэ орлогчтой ярилаа.

- Надад байгаа баримтаар бол Юкигийн гэр оронг нүүлгэхээр хоёр хүн танай тэнд үлдсэн байна. Тэр хүмүүс одоо наана чинь байна уу гэдэг сонирхолтой байна. Мугдэнгээс ирүүлсэн баримтаар бол тэднийг Банди, Тогтох гэдэг гэнэ. Эдгээр хүмүүс Мугдэнгээс өөр тийшээ явсан бол хэзээ, хаашаа, ямар хэргээр гэдгийг тогтоох шаардлагатай. Харин сануулахад тэдгээр хүмүүс Хаалган руу явж мэдэх сэжигтэй гэдгийг анхаараарай гэлээ.

...Есдүгээр сар эхлэнгүүт Цагаан хэрмээр халхлагдсан Хаалган хотод намрын нар шарж эхлэв. Хаалган хотод нэлээн алдаршсан нарийн боов худалддаг дэлгүүрийн эзэн намхан биетэй нэгэн хятад Бандитай уулзаад Шанхай дахь Сарангэрэл авгайн итгэмжилсэн түшмэл гэсэн бичгийг уншаад харцаа зөөллөн тал засаад,

- Хай би танай эзэгтэйг сайн танина шүү. Би тэр эмэгтэйг тун их хүндэтгэдэг. Хай, ёстой миний бурхан ваа. Би гурван жилийн өмнө Шанхайд багашигхан мухлагтай байсан. Гэтэл мухлагийг минь Шанхайн шалдан банди нар (хулгайчид) сүйтгээд шатаачихсан. Тэгэхэд танай эзэгтэй намайг аварсан гэхэд Банди, Аяанаосугийн үгийг саналаа. Энэ данжаадыг Ли овогт гэдэг. Тэрээр мухлагаа шатаалгачихаад аргаа барж явсан тэр үед нэгэн удаа Сарангэрэл авгайтай дайралджээ. Тэгээд санамсаргүй мөнгө зээлэхийг хүссэн юм. Зүс таних төдий харь хүнийг мөнгө өгнө гэдэгт Ли овогт итгэсэнгүй. Аргаа барсан хүн аавынхаа толгойг илнэ гэгчээр амандаа орж ирснийг хэлж орхижээ. Гэтэл Сарангэрэл авгай арван таван мянган иень зээлүүлжээ. Тэгээд Ли овогт Сарангэрэлтэй ярилцаж түүний зөвлөсний дагуу Хаалганд зүс буруулан суухаар шийдэж амтаны мухлаг нээхийг ашигтай гэж үзэв.

- Манай эзэгтэйн эцэг Балинмяогоор нутаглаж байсан боловч угтаа Баруун Согойн хүн учраас тэндээ ясаа тавихаар буцсан гэдэг. Эзэгтэй маань эцгийнхээ хойтын буяныг бодож, баруун Согойн сүмд өргөл өргөөрэй гэсэн юм. Би танайхаас баахан чихэр, жимс авна. Бас Долнуураас хэдэн бурхан, баахан судар залж ирсэн. Түүнийгээ Баруун Согойн сүмд дээр аваачиж зална. Дам сураг дуулбал танай тэндхийн нэг наймаа маргааш Чансыр руу хөдлөх чимээтэй. Тэдний жинчдийг хөлсөлбөл боломжтой юм. Гэтэл би хүн таних биш. Тэгээд ярилцаж чадахгүй явна гээд аргаа барсан янзтай хэллээ.

- Хай би, түүнийг сайн танина. Зовох хэрэггүй. Чи одоо надаас юу авахаа хэлчих. Өчигдөр энд байдаг америк худалдааны бараа онгоцоор ирсэн. Шинэ чихэр жимс ирсэн гэсэн. Би тэднийхээс багагүй юм авна гээд мөнгөө төлчихсөн. Тэгэхээр чиний хэрэгтэй юмыг бэлдүүлье. Харин чамаас нэг юм гуйя. Би танай эзэгтэйн өрийг нэг мөсөн өгч дийлэхгүй. Би байгаа бэлээ шавхаад нэлээн бараа авчихсан. Тэгэхээр бэлэн мөнгө багатай байна. Тиймээс өрөө жаахан хойшлуулбал сайн байна гэж аргыг нь олж хэллээ.

- Тэр бол таны л сэтгэл мэдэх хэрэг гэж Бандийг хэлтэл,

- За чи явж ачаа бараагаа янзал. Бид тэдэнтэй яриад чихэр боовыг чинь ачуулна. Бас чамд ачлага унаа бэлдүүлье гэхэд Банди хамт явах нөхөд ачлага унааны талаар тохирох зүйлээ

данжаадад хэлж өгөөд явав.

Бандийг ирэхэд Эрхэмбаяр түүнийг хүлээж байлаа. Хар чоно гэдэг энэ хүнийг Сайнжаргал туслахууддаа зааж өгсөн ажээ. Тэгээд Сайнжаргал Мугдэн рүү явахын урд шөнө Банди, Тогтох хоёртой уулзахдаа «Та хоёрт Аяанаосу үнэмлэх олж өгнө. Тэгээд Хаалган руу яваарай. Тэнд Хар чоно очиж та хоёрыг олж уулзана» гэж билээ. Түүнээс өмнө Банди, Тогтох хоёр Хар чонон талаар сайн юм бодож байгаагүй юм. Бандийг Хаалганы данжаадтай тохирсон тухай мэдсэн Эрхэмбаяр, Тогтох руу хараад,

- Өнөө шөнө данжаадтай уулзаж бурхан номоо ачуулна. Авдарнууддаа сайн тэмдэг тавиарай. Ямар ч нөхцөлд ачлаганаас

хараа салгаж болохгүй! Гар бөмбөг хэдийг бэлэн авч явах хэрэгтэй. Би одоо Чансыр руу гарна. Хаалганаас Панчэн хүртэлх замыг шалгадаг хээрийн цагдаа нарыг Кавато шалгадаг гэж та хоёрын хэлсэн чинь үнэн байна.

Би Каватоог сайн танина. Тэр лүд Аксакалтай нууц харьцдаг байсан юм. Хөх хотод очиж Тогавааг айлгах аргыг тэр лүд Аксакалд зааж өгсөн юм. Одоо хошууч болсон гэнэ. Ингэхээр би түрүүлж очиж Каватотой уулзаж, зам зуурын эргүүлийг ямаршуухан хяналттай байгааг мэдье. Хэрвээ та нар, зам зуур дайралдсан хээрийн цагдаа эргүүл нарт заавал шалгуулахад хүрвэл зөвхөн эргүүлийн ахлагчтай тусгайлан уулзаж Аяанаосугийн өгсөн үнэмлэхээ үзүүлээрэй. Тэгэхдээ манай барааг үзэх гэсэн тохиолдолд шүү. Өнөө орой Сафроновтой буудалд уулзаж төмөр хайрцагтай барааг авах талаар ярилцаарай. Одоохондоо бидний талаар сэжиг аваагүй байна. Гэхдээ сэжиглэгдээгүй гэж бодоод цалгардаж болохгүй! гээд Сафроновтой

уулзах цагийг хэлж өгөөд аян замдаа гарлаа.

- Хар чоно чи чинь одоо ямаршуухан цол гуншинтай байна даа гэж Каватоог асуухад Тозияагийн гарын үсэгтэй, квантуны армиас тагнуулын тусгай үүрэг гүйцэтгэдэг эрх бүхий удирдах ажилтанд өгдөг үнэмлэхийг үзүүлэв. «Уэда сан бас давхар гарын үсэг зуржээ. Ийм улсууд үүргийнхээ дагуу хээрийн цагдаагийн газрын ажлыг шалгах эрхтэй байдаг» гэж бодоод Кавато айхгүй ч гэсэн аягүй гэгчээр эмээж байлаа.

- Кавато сан, наана чинь миний нэрийг тодорхой бичсэн байгаа биз дээ гэж Хар чоноыг хэлэхэд үнэмлэхний зураг тамгыг ажигласан Кавато,

- Эрхэмбаяр... энэ чинь нууц нэр чинь биз дээ. Би өдий хүрэхдээ чиний жинхэнэ нэрийг мэдээгүй яваа шүү гэж гоморхов.

- Би албан ажлаар яваа тул юуны өмнө нэг зүйлийг чамд дотночилж хэлье. Уг нь чи энд байгаагүй бол хээрийн цагдаа нарын эргүүлийн ажлыг шалгаад үүрэг өгөх байсан юм. Тэгэхээр би чамд тэгж албархаад яах вэ? Хаалганаас Чансырын чиглэлд хэсэг жинчид яваа. Тэднийг зам зуур ямар ч саадгүй өнгөрүүлэх тухай өөрийнхөө эргүүлүүдэд мэдэгдэх хэрэгтэй. Армийн төвөөс монгол руу хоёр хүн гаргах ёстой учраас би Хулстайн сүмээр гаргах санаатай явна. Тэд жинчидтэй яваа учраас танай эргүүлүүд мэдэлгүй нэгжвэл эвгүй байдалд

орно. Тиймээс тэднийг хэл ам татлуулалгүй өнгөрөөх хэрэгтэй гэхэд Кавато,

- Чи Хаалган дахь ерөнхий газарт энэ тухай мэдэгдээгүй юм уу?

- Тэр тухайд гэвэл би, ажиллагааг чамаас ч нууцлах ёстой. Гэхдээ тусгай шугамаар мэдэгдсэн байж болно.

- Синьзингээс тусгай төлөөлөгч ирэх чимээтэй гээд байсан. Та нарын талаар жиг жуг гэлцэж байсан юм байхаа даа.

- Бидний талаар ердөө хоёр хүн мэдэх ёстой! Синьзингээс гарсан төлөөлөгч тусгай шугамаар жаахан саатсан. Тиймээс үүнийг би чамд хэлээд тохирч болох байсан юм. Одоо чамаас өөр хүн мэдэх шаардлагагүй гэхэд Кавато сэтгэлдээ «Мань хүн армийн тагнуулын газрын дээгүүр албаны хүн болжээ. Тиймээс туршлагатай тагнуул, нууц ажил удирдах дүрмийнхээ дагуу газар дээр нь арга хэмжээ авч байна. Тиймээс тусгай эрхээр хангагдсан үнэмлэхтэй яваа юм байна. Энүүнтэй чинь холбоогоо сэргээдэг хэрэг! Тэгвэл яваандаа цолоо ахиулж, тагнуулын байгууллагад ажиллаж болно. Одоо чинь манайхан танил талаа дэмжиж, барьц өгч, архидуулж чадсан нь хождог болсон үе. Энэ бол самурайн уламжлал шүү дээ» гэж бодно.

- За тэгвэл би, одоохон бүх холбооны хэрэгслэлээр дамжуулж үүрэг өгдөг хэрэг. Ийм том хүн хэлж байхад над шиг будааны хүүхэд үүнийг чинь үг дуугүй биелүүлдэг ёстой. Харин Халх голын талаар жаахан яриач! Тэнд чинь юу гээч болоод байгаа юм бэ? гэж асуулаа.

- Кавато минь, би буцахдаа танайхаар дайрч өнжөөд явна. Тэгэхдээ сайн хөөрье. Харин чи надад олигтойхон байр бэлдэж байгаарай гээд Эрхэмбаяр халааснаасаа тавтын дэвсгэрээр толгойлсон боодол юань гаргаж өгөв.

- Үүнийг манайхны дайралдсан эргүүлүүдэд үзүүлээрэй. Буцаад ирэхэд чинь захисан зүйлийг чинь бэлдчихээд хүлээж байя гэлээ.

Эрхэмбаяр ачаагаа зам зуураас тасалж Баруун Согын сүм рүү явах тул жинчдийг Хуадэ гэдэг суурин хүрэхээс өмнө тосон уулзахаар шийдлээ. Тэгээд шөнө Хуадээд ирэнгүүт цагдаагийн газрынхантай уулзахдаа Каватогийн бичгийг үзүүлээд жинчдийг сураглахад нэг дэслэгч,

- Эндээс хориод бээр хол буусан байх. Манайхан тэдэнтэй дайралдсан Кавато сангаас тушаал авсныхаа дараахан шүү дээ гэж дэслэгч учрыг тайлбарлав. Тэгээд Эрхэмбаяр тусгай эрхийн үнэмлэхээ үзүүлээд,

- Чи надад тэдний буусан газрыг мэдэх нэг цагдаа гаргаж өг гэхэд дэслэгч нэг цагдаа цэргийг дуудаад,

- Армийн штабаас яваа энэ ноёнтонг өнөө жинчид дээр хүргэж өгөөд ир гэж тушаалаа.

Шөнө дүл өнгөрч байхад Эрхэмбаяр, япон цагдаа цэргийг дагуулан жинчид дээр ирж даамалтай уулзлаа. Жингийн даамал, өчигдөр дайралдсан цагдаагийн эргүүлийг ахалж явсан цагдааг таниад гайхсан харцаар гөлөрч дуугүй сууна.

- Танай жинчидтэй яваа хүмүүсийг Хөх хот руу хүргэх тул хөсгийг чинь арав хоногийн дараа Чансырт байлгах болно. Та хөсгөө Чансырын цагдаагийн газраас аваарай. Тэндхийн даргыг хошууч Кавато гэдэг юм. Нөгөө талаар танай жинчидтэй яваа хоёр хүнтэй уулзъя. Та дуудуулчих гэлээ. Чингээд Эрхэмбаяр үүр цайх гэж байхад гурван морин тэрэгтэй ачаагаа аваад зам буруулан хөдлөхдөө жинчдийн даамлаас унааны морьдыг сольж, сайн морьд шилж авлаа. Тэгээд жинчдийн даамал эргүүлийн цагдаагийн ахлагчийг дагаж Хуадэ руу хөдлөв.

...Кватоог Эрхэмбаяртай уулзсаны нөгөөдөр шөнө нь Чансыр хотын цагдаагийн газрын дарга ирж түүнийг нойрноос сэрээжээ. Синьзингээс ирсэн тусгай төлөөлөгч Хаалган дахь цагдаагийн ерөнхий газрын дарга хоёр түүнтэй албан тасалгаанд нь уулзангуут хоёр зураг гаргаж үзүүлсний нэг нь Эрхэмбаярын зураг байлаа.

- Энэ хоёр хүний барааг харсан уу? гэж Хаалганы даргыг асуухад,

- Оросыг нь танихгүй юм байна. Харин энэ бол Хар чоно гэдэг хочтой Эрхэмбаяр байна гэхэд цагдаагийн газрын дарга хурандаа,

- Чи яагаад ийм урвагч, дээрэмчинд үнэмлэх олгосон бэ? гэж омогдов.

- Ноён хурандаа, тэр чинь Уэдагийн гарын үсэгтэй, жанжин штабын тусгай албаны хүмүүст олгодог онцгой эрхийн үнэмлэхтэй байсан. Тийм үнэмлэхтэй хүмүүсийг эргүүл саадгүй өнгөрөөхөөс гадна тэдэнд ажлаа шалгуулдаг ёстой. Бас тэр хүн... гээд дараагийнхаа үгийг хэлэх гэтэл Синьзингийн төлөөлөгч,

- Тайса, энэ хүнд буруу байхгүй. Энэ хүн ердөө тушаал гүйцэтгэсэн. Тантай тааралдсан бол бас тушаасныг та гүйцэтгэх нь хууль! Харин хаашаа явна гэж байсан бэ? гэж асуулаа.

- Хил рүү гэсэн. Хулстайгаар монголын хил рүү хүмүүс оруулах даалгавартай гээд кэмпэтайн баталгааны хуудсанд гарын үсэг зуруулж авсан гэхэд төлөөлөгч хурандаа руу эргээд,

- Хөх хот руу гэснийг та юу гэж бодож байна гэж шалгаан асуув.

- Тэр бол эргүүлийн ахлагч болон жинчдийг хуурсан хэрэг!

- Хулстай монголын хилд тийм ойрхон хэрэг үү?

- Тиймээ, ердөө долоо найман бээр зайтай байдаг юм.

- Тэгвэл та яаралтай хилийн отрядынханд мэдэгдээд надтай яриул гэхэд хурандаа Кватоогоос,

- Биднийг холбооныхон дээр хүргэж өг гэж тушаалаа.

Эрхэмбаяр, баруун Согын хийд дээр ирж мөргөл хийгээд хийдийн тэргүүн ламтай уулзаж өргөл барилаа.

- Оройн дээд багштан минь ээ. Өчүүхэн би Хулстайн хийдэд очих санаатай явна. Унаа морьд

минь эцэж орхилоо. Та хийдийн жасаас зургаан сайн морь өгвөл би үнэ хөлсөнд гар татахгүй гээд мянган иень, алд хадаг барилаа.

- Жа би, та нарын буяны зам мөрийг бодож жасын даамалд хэлье. Манай адуу ойрхон байгаа.Өнөө орой адуунаас морьд бариулж аваад үнэ хөлсийг нь өгөөрэй гээд жасын даамлыг дуудуулав. Эрхэмбаяр нар уулын чанадад орж байхад хийдийн адуунаас зургаан сайн морийг авсны дараа даамалд үнэ хөлсийг нь төлж гар цайлгалаа. Эрхэмбаяр хоёр нөхдийн хамт Баруун Согын хийдээс хөдлөөд шөнө дунд хүргэж Холбоо нуурын хөвөөнд ирлээ. Эндээс хил хүртэл ердөө таван бээр хэртэй билээ. Эрхэмбаяр морин тэргэнд яваа нэгэн том авдрыг задалж гар пулемёт, нэлээд тооны гар бөмбөг гаргаж аваад,

- Одоо бид хэл дээр байгаа японы харуулын цэргүүдтэй дайралдах нь гарцаагүй. Бидний талаар сэжиг аваагүй гэж үзэж болохгүй. Тиймээс хил дээр байгаа японы харуулынхантай тааралдсан үед хил талынхаа байрлалыг бараадаж бэлтгэх хэрэгтэй. Үнэмлэхээ өгөөд байдлыг ажигла. Хэрэв үнэмлэх хурааж авах янз байдал гаргаад байвал шууд үзэлцэхээс өөр аргагүй. Гэхдээ миний дохиог хүлээгээрэй. Намайг галла гэнгүүт буудна. Тэгээгүй цагт буу дуугаргаж болохгүй. Банди тэргэн дээрээс ямар ч үед бууж болохгүй.Хэрэг бишдсэн үед шууд л хил рүү зугтах хэрэгтэй. Бид хоёр чамайг хамгаалж үлдэнэ. Монголын хил рүү ороод дайралдсан цэрэгт "Хулстайгаас явж байна" гэж хэлээрэй. Тэр хүн Хулстайн сүмээс үү гэнэ. Түүний хариуд " Танай эндхийнх биш.Халх голынх гээрэй" гэхэд Банди сэтгэлдээ "Халх голд цутгадаг Хайлааст голын эртний нэр Хулстай шүү дээ" гэж бодлоо. Эрхэмбаяр хэсэг чимээ чагнаснаа,

- Хэрвээ бидний талаар сэжиг авсан бол хилийн япон цэргийн харуулууд энэ хавьд отоож байгаа. Энэ нуурын баруухан талд япон цэргийн хилийнхний байр байгаа. Бидний нэг найдах зүйл бол биднийг Хулстайгаар хил дамна гэдэгт итгэсэн болгон хүчээ Хулстай руу шилжүүлсэн. Тэр сум Монголын хилд маш ойрхон.Харин эндээс бол монголын хил нэлээн зайдуухан тул биднийг энүүгээр зүрхэлж ирэхгүй гэж үзсэн байх ёстой. Бандиа та хоёр гурван авдар дотроос жижиг төмөр хайрцагтай алтаа гаргаж өндөр тэвшгэй тэргэндээ ачаад өвсөөр дарж даруулаарай. Тэр дөрвөн жижиг төмөр хайрцагт бүгд 320 кг алт байгаа. Нэг нь 80 кг алттай.Тэгээд гурван морио тэр тэргэндээ хөллөчих. Би японы хилийн цэрэг рүү очиж байр байдлыг ажна. Би ирэхдээ тохиролцсон дохиогоор та хоёрт чимээ өгнө гээд явлаа.

Банди, Тогтох хоёр зүүн талын нэг хонхорт үлдэж тэргээ янзлаад байж байтал харанхуйд ямар нэг чимээ гарах шиг болсноо төдөлгүй уулийн дуу гарахад Банди, Тогтох хоёр Эрхэмбаярыг ирлээ гэж мэдлээ.

- Хилийн япон цэргүүдийн байраар анир чимээгүй тун сэжигтэй байна. Урьдынхаар бол энд нэг цаг тутамд нэг удаа харанга дэлддэг. Би яг харанга дэлдэх ёстой үеэр очсон чинь харангаа цохисонгүй. Огт хүнгүй юм шиг санагдлаа.Тэнд ердөө хэдхэн тооны цэрэг байраа харж үлдсэн бололтой.Бусад нь харуулд гарсныг бодоход бидний замыг хаагаад хилийн дагуу отчихсон юм шиг байна.Юу ч гэсэн нуурын баруун талыг барьж хил рүү дөхнө. Энүүгээр арай дөт байдаг юм гээд цааш хөдлөв. Тэнгэрийн дорнод хаяанаас үүрийн гэгээ манхайн цайсаар алсын бараа танигдах төдий боллоо.Гурван морь хөллөсөн тэрэгний урд талын суудалд суусан Банди эргэн тойрноо ажин шогшуулахад түүний урд талд суусан Тогтох, Эрхэмбаяр хоёр мориныхоо амыг татан шогшуулсаар элсэрхүү хотгорыг даган хил рүү

чиглэнэ. Тэд ингэж шогшуулсаар хилд 5 км хэртэй дөхөж очтол баруун талаас дөрвөн морьтой хүн тосон ойртож ирлээ. Үүрийн гэгээнээс тод харагдаж байгаа хилийн харуулын япон цэргийг ажигласан Эрхэмбаяр,

- Бандиа, тун анхааралтай байгаарай. Дохио өгөнгүүт мориндоо ташуур өгнө шүү. Наад гурав чинь чамайг хил хүргэчихнэ гээд ирж яваа морьтонгуудыг тосон очив. Тогтох Бандийн морь тэрэг рүү довглох замыг хаан гар пулемётоо бэлдчихээд байсан тэр үед Эрхэмбаяр,

- Тогтохоо, намайг сайн харж байгаарай гээд япон цэргийн харуулын дарга руу ойртон очиж мориноосоо буулаа.

1939 оны 9 сарын 16-ны өдөр. Бямба гариг. Оройн нар Их Хянганы салбар Богд уулын цаад руу гудайж, тэнгэрийн хаяанаа шингэж буй нарны шаргал туяа нүүгэлтэж байхад Хайлааст голын баруун гар талаар үргэлжилсэн элсэрхэг манхан дундуур зурагдсан бүдэгдүү замаар арав гаруй суудлын хар тэрэг цувран хурдалсаар Хайлаастын зүүн салаа голыг чиглэнэ. Зөвлөлтөд үйлдвэрлэсэн "М-2" маягийн суудлын хар тэрэгнүүдийн цуваануудын дунд хэрд нэгэн тэрэгний жолоочийн хажуугийн суудалд суусан Дагва зам ширтэн элдвийг бодож явахад арын суудалд суусан Сувдаа, суудлын тэрэгний цонхоор замын хоёр тал руу ширтэн хөмсөг зангидсаныг ажваас ямар нэг зүйлд сэтгэл түгшин зэвүүрхсэн нь илт.

Сувдаа энэ өглөө тэнгэрийн дорнод хаяанаас өндийсөн өглөөний тэргэл улаан нарыг хараад,

- Тэнгэр газрыг холбосон ямар ч сонин, аймаар, гайхмаар нар вэ. Ердөө л миний өлмий доороос мандах шиг боллоо гэж бодоод баяр баясгалантай байсан. Гэтэл оройн шингэж буй нарны цайвар гэгээнд элсэн толгодоор дүүрсэн хүн, морьдын сэг ундуй сундуй хөглөрч, үдшийн гэгээнд ёрдойн арзайж сэрзийсэн машин техник, их бууны тамтаг, танкны гинжинд тарамдсан элсэрхэг хөрсөнд гүн шигдсэн гинжний хэлбэрээр үлдсэн мөрүүд, цустай холилдон хар хүрэнтээд элстэй зууралдаж хатсаныг ажваас нар нуруу зоогоороо шатаж түлэгдээд хэвтэж байгаа хүний дутуу эдгэсэн шарх шиг аймшигтай харагдсанд нүдээ аньсан Сувдаа амандаа "Энэ чинь эх орны минь нэг хэсэг... дайн түүний тэнэгэр уужим зоо нурууг нь ингэж шархдуулдаг байна шүү. Яасан бузар юм бэ" гэж шивнэхэд түүний нуруугаар хүйт оргих шиг санагдав.

Суудлын тэрэгнүүд дарь хүхрийн эхүүн үнэр танар, бензин тостой холилдон шатсан гашуун хярвас ханхлуулсан утаа нь арилаагүй толгодын дундуур хурдалсаар их бууны сум, бөмбөгөнд өртсөн японы цэргийн бэхлэлтийн хажуугаар өнгөрлөө. Бэхлэлтийн блиндажийн бетонон хана, туурганы тамтагнаас төмөр торны бүдүүн хэрзгэр төмрийн хугархай сэрзийн сэрвийхийг харж явсан Дагва "Мөн сүрхий зузаан цул хана байна шүү. Японы бэхлэлтийн инженерүүд үүнийгээ ийм болно гэж хэзээ ч бодоогүй байх даа" гэж бодлоо. Энэ бол Бойтог манханд байгуулсан бэхлэлтийн ижил бэхлэлт бөгөөд энд Японы зургадугаар арми гэгчийн штаб байжээ. Японы жанжин штабаас "Косэйтоку" гэдгийг эхлүүлэхээр товлосон тэр өдөр (8 сарын 24-ний Пүрэв гариг) энэ бэхлэлт ниргүүлжээ.

Өнгөрсөн байлдааныг санагдуулах гэсэн шиг элсэн манхан толгодуудаар эвдэрхий их буу, танк, онгоцны сэгээр дүүрч, энд тэндгүй их бууны сум, бөмбөгдөлтөнд онгилогдсон гүн нүхний том амсар оройн шингэж буй нарны гэгээнд онгойж харлаад сэтгэл сэрхийлгэм

зэвүүн хүйтэн ажээ. Танкны гинжинд шудрагдсан, барзайсан хөрстэй замыг ширтэн яваа Дагва сэтгэлдээ "Гунгаа минь аль зэрэг өөрчлөгдсөн бол?...Бурангуйн ёс дэглэмийг сэтгэл санаагаараа тэсвэрлэнэ гэдэг санааны хэрэг бишээ.

Сайнжаргал маань нэлээд тураад, тас хар үс нь дун цагаан болсон байсан шүү дээ" гэж бодохдоо өчигдрийн болсон хэрэг явдлыг сэтгэлдээ бодож явлаа. Дагва сүүлийн долоо хоног монголын өмнөд хил, Сулинхээрийн чиглэлд хил дээр өнжиж билээ. Дагва хил дээр Эрхэмбаярыг хүлээж мухардаад сэтгэл нь түгшиж байлаа. Тэрээр болзсон хугацаандаа хил дээр ирсэнгүй.

... Эрхэмбаяр японы эргүүлийнхэнтэй дайралдангуут үнэмлэхээ үзүүлтэл харуулын ахлагч түүнийг дурамжхан байдалтай авахыг ажиглаад Эрхэмбаяр хос хосоор нь нийлүүлж барьсан гар бөмбөгөө дээр өргөөд,

- Хөдөлж болохгүй гэж японоор анхааруулан хэлээд шидэхээр зэхтэл Банди морин тэргэн дээрээсээ үсрэн буух тэрхэн агшинд Тогтох пулемётоо эргүүлийнхэн дээр онилчихсон байлаа. Үүнийг өглөөний нар битүү цагаан гэгээнд ажигласан японы эргүүлүүд өчүүхэн төдий эндэгдэл гарвал сүйрнэ гэдгээ гадарлаад хүлцэнгүй байлаа.

- Зэвсгээ газар хая гэж Эрхэмбаярыг захирангуй хэлэхэд харуулын цэргийн ахлагч буугаа газар руу чулуудлаа. Чухам энэхэн зуур Банди япон даргыг мориноос нь буулгаад морины нь жолоо цулбуурыг хүзүүнд ороож баглаад морь руу нь зааж,

- Хөдөлбөл амьгүй гэж мэдээрэй гэлээ. Чухам иймэрхүү тохиолдол болно гэдгийг тооцоогүй Эрхэмбаяр, бололцоогоо ашигласандаа дотроо баярлаад гар бөмбөгнүүдээ далд хийхэд Банди бусад японуудын зэвсгийг хурааж амжсан агаад тэднийг морины нь жолоо цулбуураар хүзүү биеийг нь баглачихсан байлаа. Банди японы морьдыг хэрээд Эрхэмбаярын дэргэд ирэхэд Эрхэмбаяр японы ахлагчаас,

Ноён бага даргаа, танай дарга нар биднийг баривчлах тушаал хэзээ өгсөн бэ?

- Өнөө шөнө өгсөн.

- Танайхан тэгээд биднийг яаж барихаар шийдсэн бэ?

- Манай ихэнх хэсэг Хулстайн сүм рүү явсан. Манай энд нэг салаа хоёр тасаг цэрэг үлдээд бие биенээсээ таван км зайтай байгаа нуувчинд очиж та нарын замыг отож байгаа. Эрхэмбаяр, япон бага даргаас нэлээн зүйл лавласны эцэст нуурын баруун талын толгойд байгаа нуувчинд хоёр цэрэг байгааг мэдлээ. Тэр нуувчнаас зүүн тийш таван км зайтай байгаа нуувчнаас цааш салаа цэрэг байрлуулсан гэдгийг хэлүүлж авчээ. Хилийн япон цэргийн харуулынхан тэднийг хилийн харуулын эгц араар хил давахгүй гэж үзсэн ажээ. Тиймээс байрныхаа арын толгодод буй нууц байрандаа хоёр цэрэг үлдээсэн байлаа. Харин хилийн цэргийн байрны баруун талын судгийг дагавал Эрхэмбаярт ашигтай ажээ. Тэр судгийг дагаж явбал нуувчинд мэдэгдэлгүй хүрэх байлаа. Эрхэмбаяр баригдсан японы цэргүүдийг ажиглан зогссоноо тэднийг тэр чигээр нь морин дээр нь мордуулж эмээлтэй нь баглаад нэгэн хонхорт морьдыг авчраад тушиж орхилоо. Чингээд нуувч руу чиглэсэн хонхрыг баримжаалан Тогтох,

Банди хоёрыг явууллаа. Харин өөрөө тэр хоёрын түрүүнд судаг дагасаар жижиг толгойн бэлээс өгсөн өнөө толгой дээр байгуулсан ажиглах нуувчинд дөхөж очоод мориноосоо явгалан явсаар нуувчинд хүртэл тэнд ганц ч хүн байсангүй. Эрхэмбаяр нуувчинд ороод хэсэг ажиглахдаа "Эд нар манай хоёрын барааг хараад отохоор явжээ" гэж бодтол хөлийн чимээ гарах шиг болов. Эрхэмбаяр хөдөлгөөний анирыг чагнавал нам гүм агаад түүнийг нуувчнаас гарах тэр агшинд япон цэрэг дайрахаар завдсан шиг санагдана. Эрхэмбаяр нуувчийн дотор байгаа юмсыг ажиглахад нэг боодолтой зүйлийг хана түшүүлэн тавьсныг хараад түүнийг авч хаалгаар чулуудтал Эрхэмбаярыг отон зогсож байсан цэрэг давхийн цочиж ухасхийх тэрхэн чөлөөнд нуувчаас үсрэн гарч газар унангуутаа байрлалаа өөрчлөн хөлбөрөх самбаандаа япон цэргийг буудаад газраас босож амжаагүй байтал хаанаас гараад ирсэн нь үл ойлгогдох нэг япон цэрэг гэдрэгээ хараад хэвтэж буй Эрхэмбаярын дээрээс буу тулгачихсан байлаа.

- Буугаа хая! гээд Эрхэмбаяр руу буугаа шагайн онилов. Эрхэмбаяр түүнийг сэрэмж алдуулахын тулд буугаа өөрөөсөө хол шидтэл өнөө япон буу шагайхаа болиод,

- Газраас өндийж бос бос гэж бардам байдалтай хэлэх нь «Одоо энэ муу намайг яаж ч чадахгүй» гэж итгэсэн нь илт байлаа. Эрхэмбаяр чухам энэхэн үед каратэгийн сонгомол арга хэрэглэж, гараараа газар руу түлхэн эгшний төдийд үсрэн босохдоо мавасэгиригийн (хөлөөрөө үсрэлтэн дунд цохих арга) хөдөлгөөнөөр нүд ирмэхийн зуур буутай гар руу өшиглөх ёстой байлаа. Эрхэмбаяр газраас өндийхдөө япон цэргийн буутай гар руу өшиглөсөнгүй харин түүний элгэн тушаа цохилтоо тааруулсан нь дүүрээг нь дэлбэ өшиглөн нам уна-гасан байлаа. Эрхэмбаярыг нуувчаас гарахад Банди, Тогтох хоёр толгойн бэлд ирчихсэн байлаа. Эрхэмбаяр тэр дороо хоёр нөхөр дээрээ очоод,

- Бандиа одоо шууд хил рүү яв гэж хэлтэл толгойн зүүн талаас арав гаруй цэрэг ирж яваа харагдлаа. Тэд Эрхэмбаярын бууны дуугаар сэжиг авсан нь эргэлзээгүй.

- Банди минь Тогтох та хоёр одоохон хөдөл. Би та хоёрыг хамгаалж үлдэнэ. Надад санаа зовох хэрэггүй гээд Тогтохоос гар пулемётоо авч нэгэн гүдгэр рүү амдан очлоо. Чингээд арван зургаан цэрэг рүү гал нээтэл тэдний хагас нь Эрхэмбаяртай буудалцан үлдэж зарим нь Банди Тогтох хоёрын араас хөдлөв. Эрхэмбаяр сайн байрлалтай байсан болохоор өөрийгөө бүслэхээр шийдсэн япон цэргийн буун чимээг чагнавал ердөө таван талд нь нэг нэг цэрэг байгаа нь илэрхий байлаа. Тиймээс Эрхэмбаяр пулемётынхоо галыг зогсоож тэднийг ажиглав. Харин Эрхэмбаярын баруун талд байгаа судагт ганц ч цэрэггүй болохыг мэдээд, тэр судгийг даган хил рүү дөхөж болохыг ажиглав. Тиймээс пулемётынхоо замгийг сугалан авч зарим эд ангийг битүү задлаад газар зоохдоо түүний доор хэдэн бөмбөг булчихлаа. Тэр пулемётыг авах буюу хөдөлгөх тохиолдолд дөрвөн бөмбөг дэлбэрэх ёстой ажээ. Эрхэмбаяр судгаар явсаар морин дээрээ очтол зүүн талаас нь хориод морьтой цэргүүд ирж яваа бололтой цагаан шороо манарна. Эрхэмбаярыг мориндоо дөрөөлөх тэрхэн үед гүдгэр дээр орхисон пулемётын дэргэд бөөн дэлбэрэлт болж, чих дөжрөөсөн чимээ дэгдээд замхарлаа.

Эрхэмбаяр гурав дөрвөн бээрийн зайтай тоос тагуулан ирж яваа японы цэргүүдийг дурандаад мориндоо ташуур өгч Банди, Тогтох хоёрын араас давхиулсаар хил давж буй тэрхэн үед, гүйцэн очтол Банди цээжээрээ шархадсан агаад Тогтох шанаагаа суманд хайруулсан байлаа. Бүхээгтэй тэргэнд хэвтүүлсэн Бандийн дэргэд Эрхэмбаярыг очиход,

- Чамаас мултарсан долоон цэргүүд бид хоёрыг хөөж гүйцдэгийн даваан дээр Банди тэрэгний хоёр талаар гар бөмбөг шидэж дөрвийг нь устгалаа. Тэгээд би мориноосоо салж, Банди маань шархдав. Харин би шанаагаа хайруулснаа тэр үед мэдээгүй юм гээд Тогтох юу болсныг Эрхэмбаярт тайлбарлаж өглөө. Эрхэмбаяр хоёр нөхрөө морь тэргэндээ суулгаад цаашаа хөдлөхдөө «Аргагүй дээ. Ийм хүнд ачаатай морин тэрэг японы морьдод гүйцэгдэлгүй яахав» гэж бодсоор явахдаа хилийн цаад руу ажвал өнөө япон цэргүүд монголын хилд бээрийн хэртэй ойртсон байлаа. Чухам энэ үед нэг жижиг толгойн баруун талаас монголын хилийн харуулын цэргүүд гарч ирлээ. Тэдний дунд явсан Дагва, Эрхэмбаярыг тосон уулзангуут нууц дохио лавлалгүйгээр шууд,

- Шархадсан хүмүүсээ яасан бэ гэж яаран асуулаа.

Дагва хил дээрээс дурандаж хилийн цаана юу болсныг нэгд нэгэнгүй харж байжээ. Тиймээс нууц дохио лавлаж албархах хэрэггүй байлаа. Эрхэмбаяр тэрэгний бүхээг рүү заахад Дагва тэргийг тойрч бүхээг рүү өнгийгөөд тэвшинд дэвссэн өвсөн дээр хэвтэж байгаа Бандийг харангуут,

- Одоохон застав дээр хүргэж шуурхай арга хэмжээ ав! гэж дэргэдээ байгаа нэг даргад хэлтэл цэргүүд түүнийг тэрэгний тэвшнээс өргөж гаргалаа. Чухам энэ үед нэгэн суудлын хар тэрэг ирсэнд, шархтангуудыг түүнд суулгав.

Дагва суудлын тэрэг явсны дараа сая,

- За бэлгээ үзүүлээч гэлээ. Эрхэмбаяр тэрэгний тэвшин дээрх өвсийг шууж бөөгнүүлтэл тэвшинд эгнүүлж тавьсан долоон жижиг төмөр хайрцаг Дагвын анхаарлыг татлаа. Эрхэмбаяр нэг хайрцгийг онгойлготол дөрөв дөрвөөр нь зэрэгцүүлсэн хоёр эгнээ алтан гулдмайн шаргал туяа өглөөний наранд өнгө тунаран хүн бүхний нүдийг гялбуулна. Алтан гулдмайн хэмжээг ажвал уртаараа арван таван сантиметр, өргөнөөрөө арваад сантиметр хэрийн хэмжээтэй ажээ.

- Зорилго нэгт нөхөд минь, та бүхэнд их баярлалаа гэж Дагвыг хэлэхэд Эрхэмбаяр үл мэдэг инээмсэглээд,

- Хайрцаг бүрдээ 80 килограмм алттай ийм хайрцаг дөрөв байгаа. Нөгөө гурван хайрцагт нь үнэт чулуу эрдэнэс байгаа юм гэнэлээ гээд төмөр хайрцагнуудын түлхүүрийг Дагвад өглөө...

...Дагва элсэн зам ширтэн дуугүй явахдаа энэ бүхнийг сэтгэлдээ болгоон бодож «Би өчигдөр өдийд Сулинхээрийн хязгаарт Будтай ярьж суусан. Тэгэхэд одоо Халх голд ирчихээд явж байдаг. Бид нар Аяанаосуг олж харж чадах болов уу?... Болдогсон бол гарыг нь нэг сайн атгах юмсан...» гэж өөртөө шивнэж байлаа.

Суудлын тэрэгнүүд цаашаа хурдалсаар зургадугаар армийн штабын бөмбөгдүүлсэн нуруунаас холгүй байгаа өндөрлөгийг чиглэв. Алсаараа товцог толгодоор хүрээлэгдсэн өндөрлөгийн өмнөд бэл, нэгэн хонхордуу газар японы цэргийн гурван жодгор босгожээ. Жодгоруудын даавуу салхинд дэрвэгнэж, найман талаас нь тэлүүрдсэн мяндсан татлагандаа татагдан, нар салхинд гандсан зэвхий цайвар даавуу дээвэр, туурга нэгэн үе пөмбийснөө эгшний төдийд

шалчийхыг ажваас эцсийнхээ удаа амьсгалан ядаж, гол нь тасрах гэж буй махчин үлэг гүрвэлийг санагдуулам агаад бусдын газар нутгийн баялагт шунан сувдагласан квантуны арми гэгч чухамхүү тэрхүү үлэг гүрвэлийг орлосон нь хэн хүний нүднээ илэрхий болой.

Машинаас Зөвлөлт-Монголын армийн төлөөлөгчдийг буухад квантуны армийн удирдлагыг орлосон орон нутгийн цэргийн комисс, бүрэлдэхүүнээрээ эгнэн зогсож байлаа. Эгнэн зогссон японы цэргийн төлөөлөгчдийн өмнө гурван генерал зогссон агаад тэдний дунд намхандуу давжаа биетэй, нүдэндээ зүүсэн шил нь үл мэдэг томдсон, царай хочгордуу байдалтай нэгэн хошууч генерал машинаас буугаад ирж яваа Зөвлөлт Монголын орон нутгийн цэргийн төлөөлөгчдийн тэргүүн нарыг хараад цайвар царайгаа улам хорчийлгон янз муутай зогсох нь Халх голд ялагдсан армийн сүр сүлд аль хэдийн тамд морилсныг илчлэх гэсэн шиг өнгө жавхаагүй болой. Ийнхүү царайгаа бүрсийлгэн, сэтгэлийнхээ гутралыг илрүүлэхгүйг хичээн зогсож буй орон нутгийн дээд командлалын захирагч шүү ёо Фузимотогийн араар японы цэргийн хэсэг дарга нар эгнэн зогссон агаад тэдний харц Зөвлөлт Монголын цэргийн төлөөлөгчдийн зүг ханджээ. Японы цэргийн төлөөлөгчдийн дунд нэгэн өндөрдүүхэн цагаан эр зогсохыг ажваас саяхан чиү са (дэд хурандаа) цол хүртсэн Аяанаосу байлаа. Дагва өөрийнхөө дэргэд зогсож байгаа Сувдаад,

- Гунгаа тэр зогсож байна. Чи харж байна уу гэж хэллээ.

- Тиймээ харж байна. Дэд хурандаа болчихсон байна гээд Сувдаагийн хоолой зангирлаа.

Зөвлөлт монголын цэргийн төлөөлөгчдийг тэргүүлсэн бригадын командлан захирагч Потапов, ардын цэргийн жанжин штабын дарга, дивизийн командлан захирагч Цэрэн нарыг Фузимото угтан очиж ёслол уулзаад гар барихад ялсан армийн удирдагчдын царайнд баяр бахархал илэрч, харин ялагдсан армийг төлөөлсөндөө сэтгэлийн уур хилэнгээ барьж ядан, гутрал гунигтаа буцалж байсан Фузимото, сэтгэлийнхээ шаналгааг нуухыг хичээхдээ арга буюу инээмсэглэн тал засахыг ядсан шинжтэй.

Аяанаосу хэмээгдэх Гунгааг орон нутгийн цэргийн бүрэлдэхүүнд орж японоос олзлогдсон хийгээд алагдсан цэргийн хүүрийг Халх голоос цэвэрлэх, хүлээлцэх асуудлыг тохиролцохтой холбогдон Халх голд ирснийг мэдсэн төв Дагвыг Сулинхээрээс Халх гол руу очих тушаал өгчээ.

Аяанаосу, энэ удаа Халх голд ирээд хэд хонохдоо сэтгэл нь яггүй түгшиж байлаа. Тэрээр Мүгдэнгээс нутаг руугаа явсан Сайнжаргалын цахилгааныг 23-нд хүлээж авчээ. Алтыг хил дээр бүрэн хүргэсэн эсэх талаар Эрхэмбаяр 16-нд цахилгаанаар мэдэгдэнэ гэсэн болохоор Аяанаосугийн сэтгэл дэнслэх нь аргагүй ажээ. Гэтэл хэдхэн мөчийн өмнө хил дээр ирсэн Зөвлөлт монголын цэргийн төлөөлөгчдийн дотор Дагва, Сувдаа хоёр инээмсэглэн зогсож байхыг хараад сэтгэл нь уужирчээ.

Аяанаосу, япон дарга нарын адил тэргүүн мэхийлгэн газар ширтэн зогсох авч сэтгэлд нь баяр баясал бялхаж байлаа. Тэрээр эчнээнийхээ баяр баяслыг Дагва, Сувдаа хоёртой хуваалцан зогсож байгаадаа магнай тэнэгэр байв. Аяанаосу малгайгаа авч, чанга атгаад өмсөхийг ажсан Сувдаа «Ялалтын баяр хүргэж байна даа» гэж бодоод Аяанаосугаас харц салгалгүй зогсохдоо «Миний сэтгэл зүрхний тал араатны дунд байдаг шүү дээ» гэж бодохоос нүдэнд нь нулимс

цийлэгнэн манантаад уйлмаар санагдсан авч тэрээр сэтгэлээ барилаа.

...Сувдаа, Мугдэнгийн нисэх онгоцны буудал дээрээс салахдаа сэтгэлийнхээ үгийг цухуйлгаж чадаагүй боловч хоёр биенийгээ нэвг цоргисон дөрвөн нүдний харцаар сэтгэлийн нандин бүхнийг ойлгож байсны адилаар гучаад алхмын цаанаас бие биенээ ширтэн зогссон хоёр амрагийн хос нүдний харц, тэдний зүрх сэтгэлийг холбож буй тэрхэн үед зөвлөлт монголын цэргийн төлөөлөгчид, япон цэргийн жодгор руу анхааралтай ширтэн баяр хөөртэй зогсож байлаа. Японы цэргийн сурвалжлагч, кино сурвалжлагч нар хоёр талын төлөөлөгчдийн зургийг авах агаад харин япон дарга нар тэргүүн бөхийлгөн хааяа санаа алдан, цэргийн жодгор руу нүдний булангаар сэм ширтэхийг ажваас харь нутгийн газрын хөрс хатуу болохыг ойлгосон боловч хар цагааны ялгааг ухаарахаас айж, хамаг биеэ хураан бээцийж доожоо муутай зогсох нь омог бардам самурайн сүлд хийморь аль хэдийн арилсныг гэрчилнэ.